ЧИНГИС ХААНЫ
НУУЦ ТҮҮХ

С. Жаргалсайхан, Л. Удвал

Чингис хааны нууц түүх

www.ibooks.mn

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БӨРТЭ

Тахир сэлэм шиг саран дотроос чоно улиж байв. Түүний бардам ихэмсэг дуу тэнгэрээс доошилж, уул гүвээ дамнан үргэлжилсэн их цэргийн цуваан дээгүүр хэсэг цуурайтаад газар шингэн замхрах ажээ. Аян дайны зам зуур чоно тааралдах нь ялалт олохын билэг тэмдэг гэж монголчууд үздэг тул хэдий чимээ гаргахыг цаазалсан ч бүгд баясан хамар дороо уухайлж явлаа. Хавирган сарны хүйтэн цэнхэр туяанд эргэн тойрны уулс тэнгэрийн хаяанд сүүдийж, дөрвөн түмэн агт морьдын туурайн чимээ битүү нүргэн, газар доргиж байх шиг санагдана. Онгон зэрлэг хээрийн ургамал цэцэгс талхлагдан анхилуун хурц үнэр нь морьдын хөлсний үнэртэй холилдон хамар сэтрэм ханхлах ажээ. Морьдын тургилах, их цэргийг цувааны дөрөө харших нь шөнийн цэнгэг сэрүүхэн агаарт тов тод сонсдох агаад энэ олон агтын хөлөөр бужигнасан улаан шороо агаарт дэгдэж нарийн тоос ам хамраар чихэн уушгинд очиж наалдана.

Тэмүүжин урьд нь ийм олон морьт цэргийн дунд явж үзсэнгүй тул өөрийн эрхгүй сүрдэн биширч байсан ч түүнийгээ аль болох нуухыг хичээж байлаа. Хэдэн уул гүвээ давж сарны цэнхэр гэрэлд сүр бараалан үргэлжилсэн морьт цэргийн цувааг харахад аварга том үхэр могой мушгиран эвхэрч байх шиг үзэгдэнэ. Бас замд саран дороос чоно улих сонсогдсон нь эрт бага насанд нь зүүдэнд нь үзэгдсэн өнөөх галт чоныг эрхгүй санагдуулсан тул сэтгэл нь тэсэлгүй ихээр догдолжээ. Гэвч Тэмүүжин өөрийн сэтгэлийн гүн дэх хувирал хөдлөлөө хэнд ч анзаарагдахгүйгээр тэвчин барьж сурсан билээ. Ийм занг өдгөө хүртэлх зовлонт амьдрал нь түүнд сургасан юм.

Анх Хонгирад аймгийн Дайсэцэний гэрт Есүхэй эцэг нь орхин явахад эргэж ч харахгүйгээр холдон одож буй эцгийнхээ араас гүймээр, хашгирч орилмоор байсан ч цийлэлзэн гарах нулимсаа тэвчин барьж, цааш шингээснээр барахгүй бүр хэнэггүй царай гаргаж чадсан билээ. Дотроо эцэгтээ гомдож, бүр харуусан гашуудсан ч амьдрал нэгэнт л ингэхийг шаардсан тул Тэмүүжин үг дуугүй түүний аяыг дагажээ. Нэр мэдэх ч зүс үзээгүй харийн аймагт, хүний гэрт ганцаар хаягдах юм гэж даанч санаагүй билээ. Эцэг нь салахдаа ядаж цөөн ч гэлээ урмын үг хэлж, уруул хүргэн үнссэн ч үгүй. Эцгийн нь ширүүн түрэмгий харц нэгэнтээ түүн дээр тусахад "Аав одоо намайг үнсэж элгэндээ тэвэрнэ дээ" гэж бодсонсон. Гэвч тэгсэнгүй билээ. Есүхэй эцэг нь мордохынхоо өмнө:

- Дайсэцэн, би Тэмүүжин хөвгүүнээ худ чиний хүссэнээр танайд орхилоо. Чи сайтар харгалзах биз. Хөвгүүн минь нохойноос цочимтгой юм. Чи хичээгээрэй гэж хэлэхдээ ч Тэмүүжинг хайрлаж, өрөвдөхгүй байх шиг санагдсаар байжээ. Бүр түүнийг танихгүй олны өмнө, тэр дундаа сүй тавьсан Бөртэ охины өмнө аймхай ичимхийгээр нь дуудаж, гутаан доромжилж байх шиг санагдсанд эрхгүй гомджээ. Ийн гомдсоноос болоод гэрт үлдсэн эх өөртэй дүү Бэгтэрт ихэд атаархаж, эцэг нь тэр хөвгүүндээ илүү хайртай юм байна гэж бодсон билээ. Гэрт үлдсэн дүү нар дотроос хамгийн ахмад нь Бэгтэр бөгөөд түүнээс ердөө ганцхан сараар дүү байсан нь ингэж бодоход хүргэв. Гэвч Тэмүүжин эцэгтээ гомдон хорсож болох эсэхдээ эргэлзсээр байлаа. Энэ явдал Тэмүүжиний эцэг эх хоёртоо итгэх сэтгэлд гүнзгий өөрчлөлт оруулж, анх удаа өөрийнхөө хувь заяаны тухай балчир ухааныхаа хэрээр эргэцүүлэн бодов. Амьдарч дассан гэр орноос нь, дүү нараас нь салгаж харь аймгийн танихгүй айлд сүй тавих нэрээр авчирч орхиод зугтаах мэт давхин одсон эцэгтээ гомдохоос

өөр арга дааанч байсангүй. Сүй тавих гэдэг юу болохыг мэдэж, ойлгож байсан ч хүний гэрт гэнэт ганцаар орхих болсныг нь зөвтгөн бодож чадсангүй. "Тэмүүжин хөвгүүндээ өөрийн садан төрлөөс эхнэр авч өгнө" гэж Есүхэй эцгийг нь шавдуулсаар байсан Өүлэн эхийнхээ байдлыг ч сэжиглэн эргэлзэхэд хүрчээ. Гэнэт эцэг эх нь бүгд хуйвалдан Тэмүүжинг өөрийн гэрээс холдуулсан мэт санагдана. Тийм бол яах гэж, юуны учир ингэв гэж шаналан гомдон боджээ.

Есөн настай балчир Тэмүүжиний сэтгэл үүнээс өөрийг олж ойлгож, онцолж бодож чадсангүй. Цасанд хучигдсан их талын гүнд эцгийн бараа тасран далд ороход орчлонд цор ганцаар хаягдан хоцрох шиг болоод тэвчин барьсан нулимс нь сул урсжээ. Нулимсаа тэвчин барих чадал гэнэтхэн ингэж үгүй болдгийг тэр анх удаа үзсэн нь энэ байлаа. Харин Тэмүжиний сэтгэлийн гүн дэх нууц хямралыг хамгаас илүү, өөриймсгөөр ойлгож эвийлэн дэмжсэн хүн нь арван настай Бөртэ охин байлаа. Эцгийнхээ хойноос гүйсээр бахардан унасан Тэмүжиний хүйтэн жаварт сарвайн бээрсэн гарыг нь халуун амьсгалаараа үлээн дулаацуулж, хацрыг нь даган урсч хөлдсөн нулимсыг зөөлөн дулаан гараараа арчин аргадсан хүн бол Бөртэ юм. Бөртэ охин Тэмүжиний хөлс үнэртсэн толгойг яг Өэлүн эх шиг нь элгэндээ наан тэврэн суухад энд ирснээс хойш тэдний хооронд байсан гэрэвшил, бишүүрхэл хоромхноо арилан үгүй болохыг тэд хоюул мэдэрчээ.Одоо энэ харь элгийн танихгүй хүмүүс дунд сэтгэлийн хань болох ганц хүн нь Бөртэ болохыг Тэмүжин ингэж зүрхний угаас мэдэрсэн билээ. Энэ мөчөөс хойш Бөртэд хандах ийм сэтгэл Тэмүжиний дотор үүрд салахгүйгээр хадагдан үлдсэн юм. Гэвч тэр цагт тэдэнд мэдэхгүй, ойлгохгүй зүйлс дааанч олон байжээ. Есүхэй эцэг нь зам зуурт татаарт хорлогдон үхсэн нь Тэмүжинг Бөртэд даалгаад одсон мэт, бүр хувь тавилангийн учрал тохиолыг урьдчилан тааж мэдээд нэгэнт амьсгалын тоо гүйцсэн тул нялх хөвүүнээ осол аюулаас зайлуулан холдуулж, хаа холын Хонгирад аймагт аваачиж орхих гэж яаран довтолгосон нь хожим нь Тэмүжинд санагддаг байв. Эцгийнхээ хөшиж, хөхөрсөн шарилын дэргэд сууж байхдаа Тэмүжин зарим нэг зүйлийн учрыг бүүр түүр гадарлаж эхэлжээ. Амьдралын элдэв учрал тохиолын цаад наад учрыг ухаж таахын аргагүй ч Тэмүжин Бөртэтэй учирснаа жирийн явдал, хувь тавилангаар учирсан эхнэр нөхрийн байдаг л нэг хэлхээ холбоо гэж огт ойлгодоггүй билээ. Ямартай ч гоо үзэмж төгс Бөртэ бүсгүй Есүхэй эцгийнх нь амь насны үнэтэйг мартахын аргагүй. Тийм учраас Бөртийг мэргэдээс буцааж булаан авах нь зүгээр нэг эр хүний нэр төрийн хэрэг төдий биү юм. Энэ бол Тэмүжиний хувьд хэн болохоо харуулах, үхэл үргэлж хатавч, хаяанд отон зогсож байх аймшигт амьдралд тэсч үлдэх, өөрийн үр удмыг үргэлжлүүлж, Есүхэй эцгийнхээ алдсан нэр төр, аймаг улсыг эргүүлэн авах их тэмцлийн эх байлаа.

Арван найман нас хүрмэгцээ Бөртийг эцгийнх нь гэрээс авчирч өөрийн өрх бүлээ үүсгэсэн нь эзэнгүй мэт болсон Есүхэйн удмын хувьд дахин сэргэж, тархаж одсон албат иргэдийнхээ дунд нэр хүндээ сэргээх цорын ганц боломж байлаа. Учир нь Есүхэйн удам өсч өндийн хүчирхэгжихийг битүүдээ хүсч байсан олон отог овог Боржигон аймгийхан дунд байгааг Тэмүжин мэднэ. Гэвч түүний бага нас, өөрийн хуримтлуулсан хүч баялаг үгүй байсан нь бүхэнд саад болж хүмүүсийг дагуулан манлайлахтай манатай, гагцхүү санамсаргүй таарсан малын хулгайч, эсвэл эцгийнхээ хуучин өстнүүдэд алуулчихгүй амиа хамгаалах нь гол байсан билээ.

Баян чинээлэг Хонгирад аймгийн нэртэй зүстэй хүний нэг Дайсэцэний охин Бөртийг

Тэмүжин гэргий болгон авсан тухай мэдээ тал нутгаар салхи адил хурдан тархсан нь Есүхэйн албатууд эргэн ирэх шалтаг, санаархлыг бий болгосон ч энэ нь зарим хүнд хуучин цагийн өс хонзонг сэргээн сануулсан явдал болжээ. Иймээс ч Тэмүжин, Бөртэ хоёрын жаргалант амьдрал хэдхэн сарын настай байлаа. Тэмүжиний нялх эмзэг гэр бүл, нэр төрийг бараадсан эхний нүүдэл ирээд бараг төвхнөж амжаагүй байхад Тогтоэбэхийн толгойлсон Мэргэд аймгийн гурван зуун цэрэг гэнэт довтлон ирж, үзэсгэлэнт залуу эхнэр Бөртийг нь булаан одов. Энэ үед эсэргүүцэх ямар ч хүчгүй байсан Тэмүжин зөвхөн өөрийн хар амийг хоохойлон гутамшигтайгаар зугтаахаас өөр арга байсангүй. Бөртийг булаасан нь мэргэдүүдийн хувьд урьд Өүлэнг Есүхэйд булаалгасны өшөөг авсан хэрэг байсан бол Тэмүжиний хувьд Бөртийг алдсан нь эцгийгээ хорлуулсантай дүйхүйц хүнд цохилт, сүйрэл байлаа. Мэргэдийн Их Чилэдүгийн ёсолж авсан эм Өүлэнг нэгэн цагт Есүхэй булаан авсны эс мартагдах өсм хонзон хожим ингэж Тэмүжиний хамаг зовлонгийн эх болов. Бөртэ бол Тэмүжиний хувьд гэр бүлийнхээ дунд толгойлогч нь байхын гол баталгаа байсныг тэр гэнэт ухаарчээ. Бас заналт мэргэдүүдээс Бөртийг даруй эргүүлэн булааж авах нь зөвхөн тэдний гэр бүлийн хэрэг биш, ерөөсөө Боржигон аймгийн нэр төр, хувь заяаны хэрэг болсныг Тэмүжин мэдэрч, энэ хэрэг явдалд яаж хандах, юу хийх ёстойгоо сайн тунгаан бодож шийдэх гэж оролдож байв. Гэвч бодоод бодоод бодын шийр дөрөв гэгчээр дагуулж мордох цэрэггүй, дуудаад ирэх нөхөдгүй болохоор санаснаа гүйцэлдүүлэх ямар ч аргагүй болж мухардана. Тэмүжинд хэдэн балчир дүү, Боорчи Зэлмэ хоёроос өөр хань байсангүй. Бас ганц чадах юм нь зугатаах, нуугдах л байлаа. Тэмүжиний энэ арга барагдсан байдал гаднаас нь харахад Бөртийг мэргэдэд алдсандаа огт харамсахгүй, бүр түүнийг буцаан авах санаагүй мэт сэтгэгдэл төрүүлэн дүү нарыг нь бухимдуулж, тэр бүү хэл хэзээд тайван тогтуун зантай байдаг Боорчийг хүртэл гайхашруулжээ. Нэн ялангуяа нэгэнд эрийн цээнд хүрч, харвах, цавчих нь хүнээс дутуугүй болсон, бяртай биерхүү Хасар Билгүтэй хоёр мэргэдийг сэм довтолж Бөртийг хулгайлан авахыг шаардаж байлаа.

Үнэхээр ч ингэж болох байв. Дүү нар болоод Боорчи, Зэлмэ бүгд хүч хавсарвал Бөртийг хулгайлан авч чадах билээ. Гэвч түр зуурын хөөрөл, нэр төрийн ашгийн төлөө хөөрхий гэр бүлээ сүйрүүлэхийг Тэмүжин хүсэхгүй байв. Учир нь Бөртийг булаан авсан нь мэргэдийг түр зуур тайвшруулсан болохоос тэд Тэмүжинг алахаас нааш санаа нь амрахгүй гэдгийг тэр сайн ойлгож байлаа. Тийм болохоор одоо Бөртийг булаан авахаас илүү өөрийн амийг хамгаалан хайрлах ёстой гэж Тэмүжин боджээ. Бөртийг буцааж хулгайлан авлаа гэхэд мэргэдүүд бүр их хүчээр довтлон ирж, тэднийг хүйс тэмтрэх нь өглөө болж нар мандахтай адил тодорхой хэрэг юм. Мэргэдийн цэргүүдээс зугтаах газар, эсэргүүцэх хүч Тэмүжинд байхгүй тул өөрийн болоод эх, дүү нарынхаа амийг аврахын тулд гашуун ч гэлээ хувь тавилантайгаа эвлэрэн нэг хэсэгтээ Бөртийг зөнд нь орхих ёстой байлаа.

Тэмүжиний сэтгэлийн гүн дэх энэ шаналалыг хэн ч ойлгож мэдрэхгүй бизээ. Хайртай Бөртийгөө хүчин мөхөсдөн булаалгасан нь өнчин, ядуу амьдралдаа түүний амссан хамгийн аймшигтай доромжлол, хүнд цохилт байлаа. Есүхэй эцгийнх нь өшөөг мэргэдүүд түүнээс ингэж нэхнэ гэж Тэмүжин даанч санаагүй билээ. Амьдрал өөрийн хатуу харгис хуультай болохыг, хүссэн хүсээгүй тэр жамыг дагах ёстой гэдгийг Тэмүжин ийнхүү эрт ойлгож авчээ. Тийм болохоор хамгийн зөв шийдвэр олохыг тэр хичээж байлаа. Бас эх, дүү нарынх нь амь амьдрал түүнтэй салшгүй холбоотой болохыг ч ухаарчээ. Ийнхүү нөхцөл байдал тааж мэдэхийн аргагүй хурднаар өөрчлөгдсөөр байлаа.

Мэргэдийг оролдож, тэднийг цаг бусаар хилэгнүүлэх нь яг одоохондоо амиа хорлосонтой адил хэрэг болох юм. Бөртийг булаан авахаар нэгэнт л зоригловол мэргэдийг дахин довтлохгүй болтол нь сөнөөх хэрэгтэй байв. Ингэж гэмээ нь Бөртийг авраад зогсохгүй, бас өөрийн амийг ч хамгаалах болно. Гэвч ийм хүч, боломж залуу Тэмүжинд даанч байсангүй. Харин түүнд нэгэн бодол байсан билээ. Зөв эсэх, бас бүтэх эсэх нь тодорхойгүй ч түүнд үүнээс өөр оновчтой арга байсангүй. Энэ бол Бөртийг булаалгаснаар шалтаглан мэргэдийн эсрэг хэн нэгэнтэй хүч хавсран довтлох тухай санаа юм. Чухам хэн түүнд тусалж болохыг олох гэж тэр их удаан бодсон билээ.

Есүхэй эцгийнх нь хуучин анд Хэрэйд аймгийн хан Тоорилыг Мэргэд аймгийн эсрэг хөдөлгөх гол санаа Тэмүжиний дотор боловсроод их уджээ. Бөртийн инжинд ирсэн булган дахыг хуримынхаа дараа Тоорилд аваачиж бэлэглэхдээ хожим энэ тухай яриа өрнүүлэх шалтаг болох юм гэж Тэмүжин тэр үедээ санасангүй билээ. Өөрийн хурим, гэр бүлийн хүндийг өргөх, бас олонд мэдүүлэх, хуучин найртай харилцаа хийгээд Есүхэй эцгийн хүргэсэн тусыг сануулах гэсэн Өэлүн эхийн ухаан, зааврaар Туулын хар шугуйд байх Тоорилын өргөөнд Тэмүжин очсон юм. Харин Тоорил хан хуучин анд Есүхэйн хөвүүн Тэмүжинг өгөөмөр сэтгэлээр угтаж өчүүхэн бэлгийг нь чамлалгүй авсан нь түүнийг хүн сайтай, бас ч гэж Есүхэйн тусыг мартаагүй гэдгийг баталсан билээ. Тэмүжин энэ бүгдийг олонтаа эргэцүүлэн бодсон ч Тоорилын хүрээнд дахин очиж түүнээс тусламж гүйх эсэхээ шийдэж чадахгүй эргэлзсээр байлаа.

Гэвч Тэмүжиний эргэлзээг тайлах гэж Тэнгэр түүнд элчээ илгээжээ. Зүүд мэт гэнэт гарч ирээд, бас манан мэт хормын дотор сарнин үгүй болсон тэр хүнийг ганц Тэмүжин биш, Хасар, Боорчи, Зэлмэ бүгд харж түүний "Тэмүжин" хэмээн тод дуудахыг сонсоцгоосон билээ. Бүр тэр Тэнгэрийн элчийн хөлөглөж явсан мухлаг тэрэг, унаа морьд тэдний нүдний өмнө харсаар байтал алга болж, буурин дээр нь адууны шинэ хомоол, галын халуун үнс, цог үлдсэнийг барьж үзсэн болохоор итгэхээс өөр зам үлдсэнгүй. Эхлээд тэд энэ хачирхалтай явдалд цочирдоэ алмайраад хэрхэх учраа ч олсонгүй. Цэнхэрийн голыг өгсөн гэнэт гарч ирсэн тэр баг иргэнийг сэм довтлон агт морьдыг нь булаан авахаар санаархан шөнө хүрч очсон нь эцэстээ Тэмүжин Тэнгэрийн элчтэй уулзсанаар шувтарчээ.

Үлгэрт гардаг шиг харсаар байтал алга болсон тэдний буурин дээр гайхан зогсож байхдаа яах аргагүй тэр хүнтэй уулзаж үг сольсон болохоор нь Тэмүжинээс хэнтэй уулзсаныг асуухад хүргэжээ. Тэмүжин хэсэг зуур дуугүй зогсоод, "Тэр Тэнгэрийн лч юм" гэж шивнэжээ. Нөхөд нь Тэмүжиний энэ үгэнд итгэхээс өөр зам байсангүй. Тэнгэрийн элчээс өөр хэн ингэж харахын хооронд мөргүй алга болж чадах билээ. Тэнгэрийн элч Тэмүжинд юу гэж хэлснийг хэн ч зүрхэлж асуусангүй. Тэмүжин ч энэ тухай дурдаж хэлсэнгүй олон хоног бодолд автжээ. Тэмүжиний хар багаасаа Тэнгэрт мөргөдөг байсан нь огт оргүй хоосон хэрэг биш болохыг Хасар сая л нэг ойлгов. Зарц Мэнлигийн солиотой хөвүүн Хөхөчүг дуурайн Тэнгэрт мөргөх болсон Тэмүжинг тэр ил далд бишгүй нэг шоолж дооглодог байжээ. Гэтэл одоо Тэнгэрийн элч Тэмүжинтэй ирж уулзахыг үзэв. Тэнгэрийн элч Тэмүжинг зорин ирж уулзсан нь түүнийг нөхдийн дунд товойлгон гаргаж, бүгд юу хэлэхийг нь дуугүй хүлээхэд хүргэв. Бас үүний хажуугаар Тэнгэрийн элч Тэмүжинд чухам юу гэж хэлсэн бол, мэдэхсэн гэхээс байж ядна. Тэнгэрийн элч ирсэн нь Тэмүжинд ч итгэмгүй санагдсаар байсан ч нөхдийнхөө өмнө ийм итгэлгүй байдал ерөөс үзүүлж болохгүй гэдгийг тэр сайтар ухаарч байлаа. Учир нь энэ явдал

Тэмүжинг Тэнгэрийн ивээлд багтсан хүн болохыг тэдэнд батлан харуулсан нь чухал байв. Ийм учраас тэр Тэнгэрийн элч чухам хэн байсан, бас түүнд юу гэж хэлж, юу өгсөнийг хэнд ч хэлэхгүй тас нуухаар шийджээ. Харанхуйд, тэгээд ч олон алхмын зайтай уулзсан болохоор тэдний юу ярилцсаныг солонго мэт сонор Зэлмэ ч олж сонссонгүй билээ. Аливаа нууцлаг зүйл өөртөө далд хүч агуулж байдгийг Тэмүжин ингэж анх ухааран мэдэрчээ. Ингэж нууцалснаар нөхөд нь Тэмүжинг бүр ч бишрэхэд хүргэнэ гэж түүний тооцсон нь зөв байлаа. Бусдын сэтгэлийг дагуулан захирахад Тэнгэрийн нэрийг ашиглаж болох нь ийнхүү Тэмүжинд тов тодорхой болжээ. Харин Тэмүжин Тэнгэрийн элчийн үгийг олон хоног бодсоны эцэст Хэрэйд аймгийн хан Тоорилынд очих цаг нь болж гэдгийг ухаарав. Гэвч ганц Тоорилыг хөдөлгөн мэргэдийг довтлох нь зөвхөн Бөртийг булаан авахаар төгсөж болох тул хуучин Боржигон аймгийн олонхи албат дэргэд нь очсон Жамухыг эл хэрэгт оролцуулах нь бас чухал байлаа.

Харин Жамуха Тэмүжинтэй багын анд боловч түүний үгийг анхаарч тоох нь юу л бол. Иймээс Мэргэд аймгийг сөнөөх өөрийн далд санааг хүчирхэг Хэрэйд аймгийн хан Тоорилын амаар хэлүүлбэл Жамуха юутай ч эсэргүүцэхгүй бөгөөд гол нь Мэргэд аймгаас олох олзоо алдахыг тэр яавч хүсэхгүй гэж Тэмүжин тооцжээ. Жамуха сэтгэл санаа хурц хувирамтгай, их хартай, олон ааштай, орон гаран хүн тул Тэмүжин өөрөө түүнд шууд хандан тусламж гуйх нь Жамухын ихэмсэг занг хөдөлгөхөөс гадна одоохондоо түүний мэдэлд байгаа Боржигон аймгийн иргэдийг Тэмүжин буцаан авахаар санаархаж байна хэмээн муу санаалан түүнд туслахаас татгалзаж ч мэдэх байв. Энэ бүгдийг олон хоног лавшруулан бодсоны эцэст анхны цас хаялсан нэг тогтуун өдөр өөрийн шийдвэрийг дүү нар болон Боорчи, Зэлмэ хоёр нөхөртөө хэлэхээр шийдэв. Тэгэхэд Тэмүжинийхэн Хэрлэнгийн эхэнд нэгэн нөмөр буйд эргийн дор намаржиж байлаа. Намаржааны хойд энгэрийн хадан дээр тэд сууцгааж байв. Тэмүжиний хэд хоногоор дуугаа хураасныг хүлцэж, юу гэхийг нь тэвчээртэй хүлээсэн нөхөд нь ямар нэг юм болно гэдгийг зөнгөөрөө мэдэрч байсан тул хамгийн түргэн омголон зантай Хасар хүртэл ахынхаа бодлогоширсон царайг дув дуугай цоо ширтэж суув. Ер нь Тэнгэрийн элч ирснээс хойш нөхөд нь түүнд онцгой хүндэтгэлтэй хандах болсныг Тэмүжин мэдэрч байв. Бүтдэг ч бүтдэггүй ч бодсоноо хийхээс өөр зам түүнд байсангүй. Мэргэдийн эргүүлийн баг цэрэг байн байн үзэгдэж, хуучин нутаг туурин дээгүүр нь эргэлдэх нь цаашид алгуурлан хүлээхэд аюултай болж байгааг илтгэж байв. Тэмүжиний малгайн дээр унасан намар эртийн цас тэр дороо хайлна. ТЭр идэр залуу нөхдийнхаөө царайг ээлжлэн ширтэж сууснаа:

- Морьдоо уяж хагсраа. Би хэд хоногоос явж Хэрэйдийн Тоорил ханаас тусламж хүсэхээр шийдлээ хэмээн эрс шулуун өгүүлэв.

Тэмүжин энэ хэдэн үгийг аяархан боловч зуунги агаад эрс тод хэлжээ. Хэсэг зуур нам гүм болов. Түргэн зантай Хасар аанай л түрүүлэн ам нээв.

- Ахаа, та ноднин жил Бөртийн инжний булган дахыг аваачиж бэлэглэхэд "Бутарсан улсыг чинь цуглуулж өгье" гэхэд нь хариу хэлэлгүй аманд орсон шар тосыг хэлээр түлхэв гэдэг болсон мөртлөө одоо дахин очиж Тоорил ханд амаа асуулгах нь дутав уу.

Хасар энэ үгийг хэлэхдээ хор шар нь буцалж байгааг Тэмүжин ажив.

- Хасар аа. Би үүнийг учрыг та нарт сайтар ухуулсан биш үү. Харин одоо энэ бол "Тэнгэрийн

зарлиг юм" гэж Тэмүжин товч хэлээд дуугүй болов. Дахин хэн ч дуугарсангүй. Тэмүжиний амнаас анх гарсан "Тэнгэрийн зарлиг" хэмээх шидэт үг нөхдийнх нь эсэргүүцэл, асуулт бүгдийг тэр дор нь нам дарахыг тэр тод харж байлаа. Тэр бүү хэл энэ үг ийм их хүчтэй болохыг үзээд өөрөө ч их гайхжээ. Хэрэв ингэж үгээ олж хэлээгүй бол тэдний дунд дахин бөөн маргаан дэгдэх байв. Ноднин Тоорил ханы хүрээнээс буцах замд Тэмүжин, Хасар, Билгүтэй гурвын дунд бөөн хэрүүл болж, уурсаж хорссон Хасар түрүүлэн давхиж одсон билээ.

Тоорил хан өнгөн дээрээ "Бутарсан улсыг чинь цуглуулж өгье" гэх авч цаанаа Тэмүжиний нэрийн дор өөрийн аймагт хүчээр нийлүүлэн авах санаа нь тодорхой байсныг ядуу ч гэлээ зөвшөөрч болохгүй байв. Есүхэй хорлогдож үхсэн, Боржигон аймаг хангүй болж тарж бутарсан нь тэдний дотоод хэрэг болохоос гадна хэн нэгний, тэр дундаа Хэрэйд аймгийн хүчээр шийдэж болохгүй гэж Тэмүжин сэтгэсэн билээ. Боржигон аймгийнхан өөрсдөө л удирдагчаа сонгож, нэгдэх ёстой гэж Тэмүжин бодно. Бутарсан аймгаа Тоорилын хүчээр нэгтгэн авлаа гэхэд хэзээ ч түүний мэдлийнх болохгүй гэдгийг ч тэр ойлгож байв. Тийм учраас өнгөндөө аятай сонсогдох Тоорилын үгийг Тэмүжин албаар хариугүй орхисон билээ.

Ингэх бас нэг учир байсан нь Боржигон аймгийн нэлээд хэсэг иргэд Жамухын мэдэлд байсанд оршино. Тоорил Боржигон аймгийн албатуудыг нэгтгэхээр цэрэглэн хөдөлбөл Жамухын эсэргүүцэлтэй тулгарч, гурван голын Монгол аймгуудыг хамарсан том дайн дэгдэх нь гарцаагүй бөгөөд үүний дунд ганцхан Боржигон аймаг л сүйрч дуусах төдийгүй эцсийн эцэст хэзээ ч сэргэхгүйгээр хэн дийлсний нь эрхэнд орох байв. Хэдийгээр Тоорил аман дээрээ "Бутарсан улсыг чинь цуглуулж өгье" гэж уриалгахан загнаж байвч яг цагаа тулахаар эртний нөхөр Жамухтай дайтахыг хүсэхгүй тул түүний энэ үг бэлэн амнаас цаашгүй, булган дахны хариуд хэлсэн булзаа хоосон үг байлаа. Тэмүжин энэ бодлоо дүү нартаа сайтар тайлбарласан боловч

- Маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушиг дээр гэдэг биз. Дндүү холыг бодов. Ухаантай хүн болох гэж ядав хэмээсэн омголон түргэн зантай Хасарын гашуун үгийг сонсож билээ. Гэвч Тэмүжин өөрийн бодлоос ухарсангүй. Харин одоо байдал арай өөрөөр эргэснийг дахин тайлбарлах шаардлага тулсныг нөхдийнхөө хүрлийсэн царайнаас тэр ойлгов. Энэ хэргийн чухлыг ойлгоход ганц "Тэнгэрийн зарлиг" гэдэг үг бас багадах ажээ.

- Мэргэд аймгийг довтлох шалтан Тоорил ханд тийм олон олдохгүй тул ийм боломжийг алдахыг тэр хүсэхгүй. Бас Тэмүжинд би туслах ёстой юм гэж өөрийгөө цагаатгах учир байгаа тул мэргэдийг довтлоход түүнд айж ичих зүйлгүй. Энэ хэрэгт Жамухыг оролцуулахыг би Тоорил ханаас гуйна. Хасар, Билгүтэй гурвуулаа явъя. Боорчи Зэлмэ хоёр гэрээ харгалзах үлдэгтүн хэмээсэн Тэмүжиний үг эрс хатуу, эргэлтгүй байсан тул хэн нь ч дахин сөргөж элдвийг асууж лавласангүй гэрийн зүг одоцгоов.

Тэмүжиний сонгосон энэ зам үнэхээр зөв байсныг одоо тэд гүн шөнийн тэнгэр дор Тоорил, Жамуха хоёрын нийлсэн дөрвөн түмэн цэргийн цуваанд явахдаа дор дороо, өөр өөрийнхөөрөө ойлгож байв. Учирч тулгарсан нөхцөл байдлыг зөв дүгнэсэн залуу Тэмүжинй овжиноор сэтгэсэн анхны дайн ийнхүү эхэлж байлаа. Өөрийнхөөрөө зүтгэж, тэднийг харсаар байтал Хэрэйд аймгийн хан Тоорил, Жадаран аймгийн Жамуха нарын дөрвөн түмэн цэргийг мэргэдийн эсрэг хөдөлгөж чадсан нь ийнхүү Тэмүжинг нөхдийн дунд тэргүүлэх суурind бат

зогсоож, түүний хэлсэн болгоныг "Тэнгэрийн зарлиг" гэж үг дуугүй дагах ёстойг гүн гүнзгий ухааруулсан явдал болжээ.

Тэмүжиний хувьд энэ явдал хүчирхэг байхын тулд цэрэг зэвсгээс гадна холч ухаан хэрэгтэйг харуулсан бөгөөд бас өөртөө итгэх асар их итгэл урам өгсөн юм. Энэ бол арван найман настай Тэмүжиний анхны том ялалт байв. Бөртийг алдсан нь Тэмүжиний амьдрал сэтгэхүйд эргэлт болж тэр өөрийн ухаан сууж байгааг алхам тутамдаа мэдэрч байлаа.

Олон агтны хөлийн чимээ толгой эргэж мансууруулмаар ч хэдэн өдрийн хойно өөрийг нь чухам ямар гашуун доромжлол хүлээж байгааг тэр мэдэхгүй хөөрч явав. Тэмүжин угаас түнэр харанхуйд өдөр мэт хардаг байлаа. Өмнө холд модтой хөтөл даван цэргийн цуваа түгжрэн зогсоход “Олон цэргийг явахын өмнө урьдчилан явах замыг нь үзэн сонгох хэрэгтэй юм. Тэгвэл саадгүй хурдан явна даа” гэж Тэмүжин тэрхэн зуур бодож амжив.

Ерөөсөө олон цэрэг жагсах, цувах, зогсох гээд бүгд түүнд сонин содон ажээ. Тэр эргэн тойрны хөдөлгөөн дуу чимээ нэг бүрийг бүр зүрх сэтгэлдээ шингээж авах гэж шуналтай, бахархалтай ширтэнэ. Түүний сэтгэл бахтай сайхан байлаа. Ганц санаа зовж байгаа зүйл нь Бөртийг яг хаана байгааг мэдэхгүй байгаа явдал юм. Цэрэг дахиад л урагшлав.

Ийнхүү хөдөлж ядан урагшилсаар үүр цайхын өмнө их цэрэг мэргэдийн Тогтоэбэхийн хүрээг нөмрөн оржээ. Тэмүжин нөхдөө дагуулан унтаа айлуудыг чиглэн давхилаа. Салхи энгэрт нь дүүрч зориг итгэл бадран хоолойныхоо байдаг хэрээр уухайлан хашгирч явлаа.

Мэргэдийн хувь тавилан Чилэгэр бөхийн ёрлон бодсоноор боллоо. Ханцуйгаа сугалдаргалаж, цус үзэж улайрсан эрс ёстой л хонинд орсон чоно шиг аашилж, маргааш орой нь гэхэд Тогтоэбэхийн хүрээний мэргэдүүд дарагдан сөнөж Хаатай Дармала, Дайр-Үсэн тэргүүтэй хэсэг нь хойт зүг Байгаль нуурын зүг зугтаажээ.

Дайны талбарт одоо олзлогдсон шархадсан эрс, эмс хөгшид, хүүхэд л үлджээ. Үнэтэй цайтай эд хогшил, морь мал бүгдийг нь булаан авав.

Тэмүжиний нөхөд ч хоцорсонгүй нэгэн хот айлын гадна олсон, долсон юмаа бөөгнүүлж бөөн баяр.

Энэ бол тэдний хувьд анхны тулаан, анхны ялалт, анхны олз байлаа. Бөртийг, асрагч Хуагчин эмгэний хамт шөнө олоод Хасар нэгэн гэрт оруулж асарсан бөгөөд Тэмүжин тэд шөнө юун тэднийг харгалзахтай мантай цааш тулалдан явцгаасан билээ. Харин маргааш өдөр нь Тэмүжинээс бусад нь эргэн ирэв. Тэмүжин энэ дайны гол холбоотны ёсоор Тоорил ханы хээрийн асарт очжээ.

Дайны хөлд сүйрсэн хүрээ, үхэл, цусыг Тэмүжин анх удаа үзсэн нь энэ юм.

Тэмүжин тэсгэлгүй ихээр хөөрөн догдолж байлаа. Ялалт байгуулах гэдэг дэндүү амттай ажээ. Тэмүжин одоо түүнийг Тоорил, Жамуха хоёр ихэд хүндэтгэн үзнэ гэж итгэсэн билээ. Гэтэл ялалтандаа сагсуурсан Тоорил, Жамуха хоёр дайны олзоо Тэмүжинээс дээрд үзэж Хэрэйдийн хот хүрээ хэсэхээр явсан тул Тэмүжин нөхөд рүүгээ буцахаас өөр аргагүй болжээ.

Тоорил хан болоод Жамухын зөвхөн олз олохын тулд цэргээ хөдөлгөсөн үнэн дүрийг Тэмүжин олж харав. Тэмүжин одоо л Бөртийг бодохтой болжээ. Алдсан түүнийгээ өст мэргэдүүдийг дайлан ялаад эргүүлж авсан гэхэд итгэмгүй байвч эргэн тойрны цус, гал түймрийг харахаар итгэхээс өөр аргагүй. Ус намаг, уул мод ихтэй ч үржил шим сайтай Мэргэд аймгийн нутаг одоо Тэмүжиний нүдний өмнө гал түймэр, утаа, үхэл, цусанд бүрхэгдсэн харагдана.

Олзлогдож, булаагдсан эмс охид орилолдож, ялсан цэргүүдийн хөхрөлдөн тохуурхах бас олзны эмсээ булаалдан хэрэлдэж,зодолдох үзэгдэнэ. Эм хүн уйлах сонсдоход л сая Тэмүжин ухаарч хайртай Бөртийгөө саналаа. Шөнө харанхуйд осолдохгүй л эрүүл саруул явааг мэдэж хальт тэвэрснээс цаашгүй. Бас олны нүдэн дээр нэрэлхээ ч биз. Харин одоо гэнэт санаад сэтгэл догдлон яарч морио гуядлаа.

Одоо түүнд Бөртөөс үнэтэй зүйл үгүй байв. Тэр түүнийгээ олжээ. Удалгүй гэрийн үүдэнд байсан цагаан тугаар нөхдийгөө төвөггүй таньж давхин очлоо. Мэргэдийн эзлэгдсэн хүрээний жижиг том олон гэр голын эргийн хясааны дор нуугдах мэт байрлажээ. Тэнд Тэмүжиний нөхөд олзоо цуглуулаад хүлээж байв. Адуу, үхэр голдуу олон малын захад эр эм нийлсэн олзны хүмүүс газар сөхрөн сууцгаахын дэргэд Боорчи, Зэлмэ, Билгүтэй гурав инээд алдсаар угтлаа.

-Бөртэ яасан гэж Тэмүжин яаран асуув.

-Бөртэ зүгээр. Хасар Хуагчин эмгэний хамт асарч байгаа. Мэргэдийн эмс их царайлаг юм. Чи хар л даа гэж Боорчи дүйвүүлсхийн хэлээд харцаа олзны эмс охидод тусган маасайтал инээж байв. Инээхэд нь хоёр нүд нь зураас адил үзэгдэхгүй болно.

Боорчийн ингэж талбиун сайхан инээхэд Тэмүжин туйлын дуртай. Найман шарга морио хулгайд алдаад бэдэрч явахад арван гурван настай Боорчи адууныхаа захад яг л ингэж чин сэтгэлээсээ хиргүй цагаанаар инээсээр угтсан билээ. Түүний энэ инээдэнд итгэл, бас тунгалаг ариун сэтгэл нь илрэн байдаг юм.

Тэмүжин ч өөрийн олзыг хараад тэсэлгүй баясав.

-Тэмүжин ах. Энэ бидний олз гэж Билгүтэй цус нь арилаагүй гараараа хүмүүс болоод хураасан эд агуурсыг зааж баяртай өгүүлнэ. Тэдний эзлэн авсан хүрээнд байсан айлуудын эмс голдуу зуу илүү хүнийг олзлон авчээ. -Эрчүүдийг нь цэрэг болгож авъя гэж Боорчи хэлээд овоолж цуглуулсан олзны захаас нэг бүс авч түүнд сарвайв.

-Май. Энэ алтан бүс. Мэргэдийн толгойлогч өнөө Тогтоэбэхийн бүс гэнэ. Чамд өгье. Чи зүүж яв. Чиний олз гэж Боорчи ёслол төгөлдөр хэлээд сарвайхад нь Тэмүжин баясан авч бүслэв.

Тэр Мэргэд аймгийн гурван удирдагчийн нэг, Бөртийг булаан авсан өст Тогтоэбэхийн алтан бүсийг бүслэх нь энэ.

-Тэр хаачив.

-Тогтоэбэх зугтаасан гэнэ. Бүр биднийг ирэхээс өмнө амжиж хойшоо Баргужин төхөм гэдэг газар оджээ гэж Боорчийг хэлэхэд Тэмүжиний дотор үзэн ядах, харамсах сэтгэл оволзож -Би түүнийг өөрийн гараар хороох байсан юм гэж сэтгэлийн дотор дүрэлзэн буй хорслын утааг хамраараа савсуулах мэт өгүүлжээ.

-Бөртэ яасан. Яагаад үзэгдэхгүй байна гэж өөрийгөө тайвшруулан асуухад Билгүтэй -Одоо ирэх биз гэж нам дуугаар хэлэв. -Бөртийг булаасан гурван зуун мэргэдээс олзлогдсон хүн байна уу? гэж Тэмүжинийг мартсанаа санах мэт хорсол дүүрэн шивнэхэд -Байсан хэдийг нь бид олоод цавчиж алсан гэж Билгүтэй шогшров.

Үнэхээр Тогтоэбэхийг дагаж Тэмүжинг довтлон Бөртийг булаан авсан гурван зуун мэргэдийг эрж олж хядаж дуусгах гэж тэд багагүй хөл болцгоосон билээ. -Үр удмыг нь ч бүү амьд үлдээ. Бас энэ олзноос юу ч бүү авагтүн гэж Тэмүжин яагаад уур нь шатаад байгааг өөрөө ч ойлгохгүй хашгирав. Боорчи, Билгүтэй хоёр айсан гэхээсээ илүү гайхсандаа таг гөлрөв.

Булаасан мал сүрэг, эд агуурс олзолсон эмс охидыг хараад бахархан хөөрч ханахгүй байсан тэднийг Тэмүжиний энэ үг нүүр лүү хүйтэн ус цацсан мэт цочоолоо. -Явцгаая. Бөртэ хаана байна. Очье… -Байз чи хүлээ… гэж Боорчийг хориглоход Тэмүжин гайхан харлаа. -Яав чи. Гэвч Боорчи хариу хэлж амжсангүй. Олон цэргээр хамгаалуулж сүрийг бадруулсан Тоорил хан давхин ирсэн нь тэр байв. Түүнтэй хамт Жамуха иржээ. Тэд олзоо цуглуулж яваа нь энэ юм.

Тоорил хан халамцуухан, өгөөмөр сайхан зантай харин Жамуха түүний сагсуу ойворгон аашнаас жаал санаа зовж ичсэн янзтай харагдана. -Тэмүжин. Хүү минь. Чиний олз ердөө энэ үү гэж Тоорил чанга дуугаар хашгирч энэ тэр юмыг ташуураар хатгаж, өшиглөж үзнэ. Тэр хэдийгээр тоохгүй царай эсгэвч шунаг сувдаг нүд нь олзны өнгөтэйд тусна.Тэмүжин түүнийг хүндэтгэн дуугүй зогсож байлаа. Тоорил Тэмүжиний олзыг шинжээд авчихмаар юм үгүйд эргэж ирэв.

-Тэмүжин! Чам шиг ядуу хүнд одоо эвдэрхий тэрэг, эцэнхий морь,эмээл хазаар ч байсан хэрэгтэй. Жамуха бид хоёр сая өөрийн олзыг сонгож авлаа. Харин Тэмүжин чи мэргэдийн эзлэгдсэн хүрээнд бидний үлдээсэн бүх юмыг хамж ав . Болно биз дээ Жамуха дүү минь гэж Тоорил хадан дээр суух өл халзан бүргэд хавших шиг тонголзон өгөөмөр зан гаргав.

-Тэмүжин. Чамд одоо юм бүхэн хэрэгтэй. Би чамд дайны олзны өөрийн хувийг өгье. Чи ав . Жамухын ингэж хэлсэн нь урьдын андын тангаргаа санахын хажууд Тоорилын хуншгүй занд хорсож эсэргүүцсэн хэрэг байлаа.

-Хэ хэ... Жамух дүү чи зөв сэтгэж байна. Тэмүжин хөвүүнд бүх юм хэрэгтэй шүү. Ав. Ав. Ахын хишиг дүүд олдохгүй гэдэг юм гэж Тоорил хөхрөв. Жамухын ингэж хэлсэн нь түүний авч ирсэн хоёр түмэн цэргийн нэг түмийг Есүхэйн хуучин албат иргэдээс цуглуулсныг ч бодолцсон хэрэг байв. Тэмүжин үүнийг тодорхой ойлгож байсан ч үг дуугарсангүй.

-Хан эцэг минь. Бүгд Тэмүжиний баярлаж биширсэн, халуун нулимс дүүрэн талархалын дотно үгийг сонсоно гэж итгэн таг дуугүй болж хүлээв. Тэмүжин энэ үгээ бүгдийг сонсохоор чанга хэлсэн билээ. Тоорил инээмсэглэн ихэмсэг зогсоно.

-Хан эцэг минь. Тэр дахин энэ үгээ давтав. -Жамуха андаа! Би та хоёрын ивээл, их цэргийн хүчээр эрснээ олж, алдсанаа авлаа. Би мэргэдэд булаагдсан Бөртийгөө буцаан авч сэтгэл минь амрав. Үүнээс өөр юм надад хэрэггүй. Би олз олох гэж дайн хийсэнгүй. Миний нөхдийн хураасан энэ олзыг би Хан эцэг танд өргөж байна. Тэгээд ч миний төлөө таны хийсэн даан ч их тул би танд өртэй үлдэв.

Тоорилын өмнө сөхөрч суугаад Тэмүжиний хэлсэн энэ үгс сонссон бүгдийг мэл гайхуулж, цэл хөхрүүлэв. Тоорил алгуур инээхээ больж Тэмүжинг тойрон явж хараад өмнө нь очив. Тэмүжин босож түүний өөдөөс эгц ширтэн зогсоно.

-Би хан эцэг танаас олз олъё туслаач гэж гуйсангүй тул би хэлснээсээ өөрийг хийж үл чадна. Тоорил хэсэг зуур Тэмүжинг гайхан харж байснаа уурсан хилэгнэж ногоон нүдэнд нь оч гялс хийлээ. Гэвч Тэмүжин айж дальдарсангүй. Тэмүжин өөрийн үгийг хамгийн холд зогсоо цэрэг ч сонсохоор чанга хэлсэн билээ. Тэмүжин хэдийгээр дайны олзны тухай ингэж хэлнэ гэж эртнээс бодож төлөвлөөгүй ч яг энэ мөчид Тоорилын харцны аяар байхыг хүсээгүй нь ийм үг хэлэхэд хүргэжээ.

Одоо энэ дайны олзноос авбал Тоорилын эрхшээлд үүрд орно гэж тэр үзжээ. Магадгүй ингэж бодох нь дэндүү хар санасан хэрэг байж болох авч Тэмүжин өөрийн бодсоноор зүтгэхээр шийдлээ. Авран тэтгэж, атаат дайсныг нь дарж, аваль эмийг нь авч өгсөн Тоорил ханы өөдөөс том дуугарч,толгой мэдэх нь барын сүүлнээс барьсантай адил хэрэг тул сонссон хүн бүгд цочин балмагдах нь аргагүй байв.

- Би сая ямар үг сонсов. Жамуха чи сонсов уу гэж Тоорил уурсан Жамухаас дэмжлэг эрэн хашгирлаа.

- Есүхэйн хөвүүн чи юунд найдна вэ. Бид олз олохгүй бол цэрэг хөдөлгөж,зэвсэг хангинуулахын хэрэг юун. Би өдий наслахдаа анх удаа ийм хачин үг сонслоо. Эцэг Есүхэй чинь байсан бол ч лав чиний турсгыг хуулах байсан даа. Чи юу гэж хэлэв гэнэ ээ. Тэмүжин.Чи дахиад хэлэгтүн.Би лав буруу сонссон биз. Тоорилын энэ үг сүрдүүлж заналхийлсэн өнгөтэй байлаа.

-Би сая таны сонссоныг хэллээ. Би алдсанаа олсон тул сэтгэл дүүрч, бодол ханав. Хан эцэг, Жамуха анд та хоёр дайны олзоо хуваагтүн. Надад юу ч хэрэггүй. Тоорилын хойно гүйн ирсэн Хасар тэссэнгүй Тэмүжиний бүснээс угзарч

-Тэмүжин ах гэж дуудав.

-Бүү дуугар! Гялсхийн харсан Тэмүжиний харцанд яахаас ч буцахгүй эрс шийдэмгий хурц зориг илэрсэн тул Хасар айж дуугарсангүй. Олзноос үүдсэн энэ явдал бүгдийг түгшүүлж, Жамуха хүртэл сэрэмжлэн хэрсэн бух шиг зогссон Тоорил,Тэмүжин хоёрт ойртон ирэв.

Тоорил ханы гар сэлэмний бариулыг атгаж тавих нь одоохон Тэмүжинийг тас цавчин хаях нь уу гэмээр. Үнэхээр Тоорил Тэмүжинг тас цавчихад бэлэн байв. Бардам зантай, өөрийнхөөрөө зүтгэгч энэ Тэмүжин гэгч балчир хөвүүн түүний уур цухлыг нэг мөсөн барав. Гэвч туслах гэсэн сайхан сэтгэлээ цусаар будах нь даанч зохисгүй тул Тоорил хүчээр биеэ барилаа.

-Би зөв сонсчээ гээд Тоорил өөрийгөө тайвшруулах гэсэндээ ихээр хөхөрлөө.

-Есүхэйн хүү чамайг би ийм баян хүн гэж даанч санасангүй гэснээ нүүр өөд нь өмхий шүлс үсчүүлэн ойртож

-Чамд эд хөрөнгө, морь мал хэрэггүй байж. Тэгвэл чи бэлбэсэн хоцорсон Өүлэн эх, өнчин дүү нараа аваад Туулын хөвөөнд миний хүрээнд ирж суугтүн. Тэгвэл чи ахиад эхнэрээ алдаж сандрахгүй болно. Эсвэл би чамд аймгаасаа эхнэр өгч хүү Сэнгүмтэй адил үзье. Эс тэгвэл чам шиг ядуу эрд эзэн хаана мундах вэ. Чи удахгүй дахиад л эхнэрээ булаалгаж намайг гуйх болно.Тэр үед чамд миний гарыг цайлгах юм юу байна. Хоосон зоримог үг чинь үү. Хадам эхийнхээ булган дээлийг ядаж буцааж авна уу гэж инээв. Тэмүжиний сэтгэлийн угт хорсон өвдсөөр авч тэр нүдээ ч цавчихгүй зогсоно.

Байдал гэнэт ингэж санаандгүй хурцадсан нь хүн бүхнийг түгшээж, Тэмүжиний нөхөд хөдөлж, дуугарч чадахгүй зогслоо. Тэмүжин яаж ч мэдэх тул ингэхээс ч аргагүй юм. Чухам юунаас болоод нэр сүр их Тоорил хантай хэрүүл зарга үүсгэснийг сайн ойлгоцгоосонгүй. Бүр хүн ав гээд байхад дайны олзноос татгалзсаныг гайхаж яджээ.

-Би Тоорил хан таныг Есүхэй баатар эцэг шигээ үзнэ. Би ядуу дорой, эцэггүй өнчин ч гэлээ өөрийн өрх гэрийг үүсгэхийг хүсч байна. Хүний хүчээр гэрээ бариад яана. Тэртэй тэргүй айлын гэрт сууж, тогоог нь өнгийсөн мэт байх биз. Тэмүжиний энэ ухаант үгийг бүгд сонсов. Тоорил ч энэ үгийг үнэлэв бололтой. Царай нь гийж нумарсан хөмсөг нь тэнийлээ. Эргэн тойрныхон бүгд сая л амьсгаа авч хураасан булчин шөрмөсөө суллаж атгасан сэлэм,хутгаа тавив. Залуу идэр Тэмүжиний итгэлтэй хэлсэн дээрх үг бүгдийн санаанд нийцэв. Тэр бүү хэл хэсэг бараан үүлний цаана нуугдсан нар цухуйж алтан шар гэрлээ тусгасан нь Тэнгэр хүртэл баясан тайтгарсан хэрэг байв. Гэвч нар ингэж гийснийг Тэмүжинээс бусад хүн анзаарч тоомсорлосонгүй. Харин Тэмүжин дотроо Тэнгэр намайг тэтгэж байна гэж боджээ.

Жамуха одоо л миний дуугарах цаг гэж тооцсон тул

-Тэмүжин. Чи зөв сэтгэжээ гэж бахтай хэлсэн нь бүр ч аятай юм боллоо. Тоорил хөгшин хашир хүн тул үнэнд гүйцэгдэж өөрийгөө олны өмнө тэнэг амьтан мэт харагдуулахыг үл хүсэх тул тэр дороо зангаа хувирган Тэмүжиний мөрийг алгадан инээж

-Тэмүжин. Би чам шиг хүнийг эс үзэв. Эцэг Есүхэй чинь яг л чам шиг ийм эрс шулуун зоригтой эр байв. Гэвч ганц эр зоригоор юуг ч үл дийлнэ. Их сайндаа хэд гурвыг үхүүлэх биз. Би чиний үнэн сэтгэлийн үгийг сонсож өршөөлөө. Би зоригтойгоос гадна ухаантай хүнд дуртай.Тэмүжин чи манай гэрт суух үеэсээ их өөр болжээ. Би чамайг их тоодог юм шүү. За яах вэ. Чи дураар бол. Сүүлд нь надад бүү гомдогтүн гээд эргэж цэргүүдээ

-Та нар Тэмүжиний олзыг хуваж авагтүн гэж хашгирав. Цэргүүд гүйлдэн ирж бүх олзыг хураан авч,хүмүүсийг туун одов. Төдөлгүй талбай хоосорч хэдэн биеэр үлдтэл хэн нь ч юу ч хэлсэнгүй. Хэн ч дахиж эсэргүүцэн Тэмүжинг шүүмжилэх үг хэлсэнгүй. Хэлээд ч нэмэргүй байв. Учир нь тэд бүгдээр Тэмүжинг нэгийг бодсоны учир ингэж хэлсэн гэдгийг мэдэж байв. Одоо тэд буруу ч зөв ч үгийг нь дагах ёстой удирдагчтай болсноо ойлгожээ. Тэр бол Тэмүжин юм. Харин Тэмүжиний бодол зорилго өөрт нь тов тодорхой байлаа. Мэргэдийг дийлсэн энэ

ялалт түр зуурынх тул олзны мэргэдийн эхнэр хүүхэд, эд хөрөнгийг авч өөртөө лай хураах хэрэггүй. Тэртэй тэргүй мэргэдүүд түүний эрхшээл дор удаан тэсэхгүй гэдэг нь дээр мэлтийх нартай адил тод байв. Тоорил ханд хэлсэн түүний үг Боржигин, Мэргэд аймгийн олон олон хүнд удахгүй сонсдоно. Тэр цагт сонссон хүн яавч Тэмүжинг муугаар үзэхгүй гэж тэр бодов.

Мэргэдүүд хамаг мал сүргийг нь дээрэмдэн хувааж авсан Тоорил, Жамуха хоёрыг дайснаа гэж санаж яваг. Тийм болохоор олзноос авах нь мэргэдийн өс хонзонг өөртөө татахаас өөр ашиггүй байв. Хэдий ядуу ч гэлээ шүд зуун шуналаа дарж түр зуурын бага олзноос татгалзах нь хожим хойчид өлзийтэй гэж Тэмүжин боджээ. Өнөөдөр залгисан өөх маргааш хоолойд яс болон торохыг яаж мэднэ. Нэгэнт л Бөртийгөө буцаан авсан минь боллоо гэсэн Тэмүжиний үгийг нөхөд нь ямар ч эсэргүүцэлгүй дэмжин хүлээн авчээ. Ядуу, хүч буурай үедээ золбин ноход руу ч болов чулуу шидэж хэрэггүй. Аль болох цөөхөн дайсантай байх нь хамгаас чухал гэдгийг Тэмүжин нөхөддөө ойлгуулж чадав. Ийм хэрсүү ухааныг энэ тулаанаас Тэмүжин олжээ.

Өнөөдөр түүний Хэрэйд аймгийн Тоорил ханд аймшиггүйгээр хэлсэн үг Жамухыг дагаж яваа Боржигон аймгийн цэргүүдийн дунд салхи мэт тархаж, бахдах сэтгэлийг нь өдөөснийг харин Тэмүжин тооцоогүй билээ. Ер нь бүх юмыг тооцон үзэх чадвар ухаан түүнд хараахан төгс бүрдээгүй үе байлаа.

-Одоо цөмөөрөө Бөртийг авч буцъя. Мэргэдийн хоосон буурин дээр дэмий зогсож юугаа хийнэ. Тэмүжиний энэ үг нөхдийг нь сүхээр цохисон мэт болгож бүгд газар ширтэн харц буруулав. Хамгийн зоригтой, омголон Хасар хүртэл харцаа нуух нь сэжигтэй санагдав.

-Юу болов та нар. Түрүүнээс хойш Бөртэ гэхээр л эг маг хийцгээгээд гэж Тэмүжин хэлснээ гэнэт нэгийг ухаарсан мэт үгээ таслан Хасарт ойртлоо. Хасар тэр хоёр шөнө цуг явж Бөртийг олсон билээ. Тэмүжин Бөртийг тэвэрсэн тэр мөчөө гэнэт саналаа.

Одоо бүх юм тодорхой болов.

Бөртийг бүдүүрч таргалжээ гэж санасаны учир ийм байж.

Тэмүжин гэнэт энэ тухай бодохоос түгшлээ. Сэтгэлээс нь хэн нэгний хүйтэн гар үнэтэй бүхнийг хүчээр суга татан авах шиг гол нь харлан зүрх нь шимширчээ. Түүний ялалтын үнэ цэн ийм байх ёстой байжээ. Тэмүжин юуг ч бодож шийдэж чадсангүй. Тархи толгой нь асар хүчтэй ажиллаж олон олон асуулт тавьж хариу эрж байвч тодорхой хариу олж ухаанаа цэгцэлж чадсангүй.

-Тэмүжин ах. Бид танд нэг зүйлийг хэлж чадахгүй байсаар бас яаж хэлэхээ мэдэхгүй шөнийг барж өглөө болголоо. Бөртэ хариугүй төрөх дөхсөн тулгар биетэй болжээ. Тэр мэргэдийн их Чилэдүгийн дүү Чилэгэр бөхийн эм байжээ. Хасар бүх үнэнийг хэлж санаа нь амраад зайлан холдов.

Энэ зовлонг Тэмүжиний зүрх сэтгэл ганцаар хүлээж авлаа. Бэлгүтэй, Боорчи, Зэлмэ гурав хэрэг хийсэн мэт хойшоо сэм ухарна.

-Чи юун дэмий үг чалчив. Бүү худал хэл. Тийм байх ёсгүй гэж Тэмүжин хашгирав. Голоод нь халуун гал өгсөж хоолойд тулаад уур уцаар нь дийлдэхгүй галзуурах гэж байлаа.

Тэр Бөртийг, ер хэнийг ч байсан цавчин хаяхад бэлэн байв. Тэмүжин Хасарын хойноос үсрэн очив. Одоо Тэмүжинг ухаан сэтгэл нь биш, буруутанг олж цээрлүүлэх гэсэн хэмжээлшгүй их өш хонзон хөтөлж байв.

-Чи худал хэлж байна. Би чамайг ална гэж солиорсон мэт орилон Хасарыг багалзуурдан авав. Бусад нь гүйлдэн ирж бушуу салгав. Салгахгүй бол Тэмүжин Хасарыг алахад бэлэн байв.

-Би тэр Бөртийг ална. Чилэгэр бөхтэй нь цуг ална гэж хашгирч зүтгэвч Билгүтэй, Зэлмэ хоёр тавьсангүй.

-Ахыг бүү тавигтун. Үгүй бол Бөртийг ч алчихна шүү гэж Хасар хашгирч эрүүнээс гоожих цусаа арчиж байлаа. Тэдний энэ орилоон хашгираанд гэрийн бууриний хог, өвдөл цөвдөл тоншиж байсан сүрэг шаазгай цочин дэрхийн нисэж одов.

-Бөртэ ..тийм байх ёсгүй гэж Тэмүжин хашгирсаар байв.

-Тэмүжин, Тэмүжин. Бөртийн ингэж хашгирах дуу бүгдийг ухааруллаа. Хүрээний захын эзгүй гэрт зүрх түгшэн хүлээж суусан Бөртэ тэдний хэрүүлийн чимээнээр гүйн иржээ. Тэмүжиний цамнан цовхчихыг бүгд нийлэн хориод дийлэхтэй үгүйтэй, харин Хасар Бөртийн өмнүүр хөндөлдөн хамгаалахаар бэлтгэв.

-Та нар Тэмүжинийг зүгээр орхи гэж Бөртэ тэдний дэргэд ирмэгцээ хашгирав.

-Чи юу ярина вэ. Ах чамайг алж орхино гэж Хасар хориглов.

-Зүгээр ээ. Та нар Тэмүжинг тавьж холдоцгоо. Та нар холд гэж Бөртэ хашгиран Тэмүжинтэй зууралдах Билгүтэй, Боорчи, Зэлмэ гуравтай ноцолдов.

-Тавьцгаа гэж Тэмүжин орилов.

-Тавиач. Биднийг орхи гэж Бөртэ хашгирав. Тэд яаж ч чадсангүй холдов. Тэмүжин Бөртийг албал ч алаг гэж хар зөнд нь орхихоос өөр арга тэдэнд үлдсэнгүй.

-Та нар холдоцгоо. Бүү намайг хамгаал. Бас бүү харагтүн. Явж үз. Би үхвэл Тэмүжиний сэлмэнд үхье гэж Бөртэ хашгирч байсан тул тэд аргагүй холдон гэрийн цаагуур оров. Тэмүжин их гэдэстэй Бөртийг тойрон харж явлаа. Тэр яг л дайсантай тулалдах гэж буй мэт сэлмээ атгажээ. Бөртэ түүнд ойртон очиж сөхрөн суув.

-Тэмүжин. Чи намайг буцааж авах гэж биш алах гэж ингэж хөл болж, цэрэг хөдөлгөж, цусан далай урсгасан юм бол одоо түргэн алсугай гэж хашгиран уйлав. Бөртийн дуунд эмгэнэл гомдол, бас уур хилэн дүүрэн сонсдоно. Тэмүжин таг дуугүй сэлмээ далайлаа. Гэвч арай буулгаж чадсангүй сэлэм нь агаарт чичрэн тогтов..

-Цавчаач. Тэмүжин чиний гарт үхэхэд надад харамсах зүйлгүй. Эм хүн хүчт

эйд нь булаагдаж, чадалтайд нь эдлэгдэж явах учиртай биз. Миний ёсолж авсан эр Тэмүжин намайг хүчинд автан мэргэдэд булаалгасан. Энэ миний буруу гэвэл алагтүн. Чи намайг аваль эхнэрээ гэж хайрлаж, хамгаалсан уу. Ядаж хулгайлан авах гэж оролдсон уу. Чамаас өөр олигтой эр байсан бол намайг аль эрт амьд үхсэн боловч булаан авсан байх биз. Чи намайг хайрлахаа больсон юм бол бүү ал. Хүүхдийг минь бүү алаач. Намайг тэр Чилэгэр бөхтэй цуг орхиж од. Намайг алав гээд чамд юу нэмэгдэнэ гэж Бөртэ халуун нулимсаа урсган хашгирав..

Тэмүжиний гар цуцаж сэлмээ шидлээ. Түүний уур хилэн алга болоод цөхөрсөн уйтгар гуниг сэтгэлийг нь эзэмдлээ. Олон жилийн өмнө Есүхэй Өүлэн эхийг нь мэргэдийн их Чилэдүгээс булаан авсан учир өнөөдөр Тэмүжин ийм зовлонд унаснаа ойлгов. Тэр дотроо мэгшин уйлж байв. Хувь тавилан түүгээр тохуурхаж хайртай хүнийх нь хэвлийд өст мэргэдийн үрийг цацжээ.

Тэмүжин өөрийгөө харааж зүхэж барахгүй байлаа. Бөртийг алдсан дороо сэм ирж хулгайлан аваад алсын алс ойн гүнд нуугдан одсонсон бол одоо ингэж зовж шаналахгүй байлаа.

Хасар, Билгүтэй хоёр дүүгийнхээ үгэнд орсон болоосой гэж гаслан бодов. Гэвч оройтжээ. Бөртэ ямар ч буруугүй гэдгийг ч ойлгов. Тэвчих, ганцхан сэтгэл зүрхэндээ л цусаа урсгаж, гадагш нь мэдэгдэхгүй байх ёстой байлаа. Тэмүжин нойтон газар хэвтэж хэвтэж өндийв. Хөөрхий Бөртэ сөхрөн суусан хэвээр, нөхөд нь холгүй зогсох нь зогсож суух нь суусан харагдана. Тэд түүнийг хэрхэхийг хүлээж байлаа. Тэмүжин бушуухан үсрэн босов. Газар ширтэн чулуун нөшөө мэт хөдөлгөөнгүй сөхрөн суусаар байсан Бөртэ толгойгоо өргөв. Ядарч туйлдсан Бөртэ бүр нүднээс гарч ямарч өнгө үзэмжгүй үзэгдэв. Тэмүжин түүнийг гэнэт ихээр өрөвдөн уярлаа. Дэргэд нь очиход Бөртэ өндийв.

-Тэмүжин. Чи намайг төрхөмд минь буцаачих. Би Хонгирад аймагтаа очиж Дай цэцэн аав, Цотон ээжийнхээ гэрт үйлээ даган сууя. Тэд намайг, миний үрийг яавч алахгүй. Чи намайг мартаж тайван амьдрагтун. Чи бид хоёр есөн настай балчир үедээ сүй тавиагүй юм шиг явья гэж Бөртэ шивнэв. Бөртэ үнэхээр энэ өш хонзон үхэл цус нүүрлэсэн Боржигон аймаг, Тэмүжиний дэргэдээс үүрд холдон зайлахыг хүсэж байв. Түүний амьдралд сайхан юм юу ч байсангүй мэт санагдана. Ганцхан Тэмүжинд дурласан сэтгэл нь бүгдийг нөхөж байсан билээ.

Гэтэл хайртай Тэмүжиний нь байгаа байдал түүнд гомдол,харуусал авчирчээ. Тэмүжин түүнийг тэврэв. Бөртийн нүднээс нулимс урсан эрүү хүзүүг нь халуу оргиулна. Ингэж чимээгүй тэвэрсэн нь хайр сэтгэлийн хамгийн нандин үеийг санагдуулжээ.Тэгэхэд яг ийм намрын сар байсансан.

Үхэж, үрэгдсэн мэт хэл сураггүй алга болсон Тэмүжинийг гэнэт хүрээд ирнэ чинээ санаагүй Дайцэцэнийхэн хөл болон сандарцгаажээ.Тэд Тэмүжинийг үхсэн гэж итгэцгээсэн байлаа.Гагцхүү Бөртэ охиныхоо сэтгэлийг бодоод Тэмүжиний тухай сөхөж ярихаас цааргалсаар байжээ.Тэмүжинд дурласан Бөртийн сэтгэлийг Дайцэцэн мэддэг билээ.

Үг дууцөөнтэй ч цаанаа нэг шазруун хорон зантай Тэмүжинг Дайцэцэн үзүүт тоожээ. Бас тэр Есүхэйг үнэн сэтгэлээс хүндэтгэн угтжээ. Боржигон аймгийн нэртэй цуутай баатар эр үе залгамжлах хөвүүнээ дагуулан ирсэн нь чухам тэнгэрийн хишиг гэж Дайцэцэн боджээ.

Түүнтэй ураг барилдах боломжийг алдаж болохгүй байлаа. Харин Есүхэй гэнэт үхсэн нь Дайцэцнийг цочоосон ч Тэмүжинд улам ч дотгоор хандах болгожээ. Дайцэцэн холын хэрсүү ухаантай хүн байлаа.Тийм ч учраас өнчин ядуу хоцорсон Тэмүжинд охиноо эргэлзэх юмгүй өгчээ. Уулзалгүй зургаан жил өнгөрсөн ч Бөртэ Тэмүжинийг нэг ч өдөр мартсангүй. Хоёр хөмсөгний хооронд гүнзгий босоо үрчлээтэй, наснаасаа оворжуу харагдах залууг Дайцэцэний уяан дээр буухад хэн ч Тэмүжин гэж танисангүй. Аяншиж харшсан морьтой Тэмүжин, Билгүтэй хоёрт тэдний ноход ч тоож давхисангүй.Дайцэцэний хүрээг олох гэж бэдэрсээр тэд морио зогсоох шахжээ. Харин тэр өдөр Бөртэ нэг их баярлах юм шиг совин татсаар байсанд гайхсан ч Алтан улсын худалдаачин ирэх төдийг таамагласан билээ.

Гэтэл Цотон эхийнхээ гэрт цай оруулж явснаа гэнэт нуруу хүзүү нь жирвэлзэн халуу оргиход тэсэлгүй эргэн харав. Холд уяаны дэргэд нэг хүн түүнийг ширтэн зогсож байхыг үзмэгц зүрх нь түргэн цохилж өөрийн эрхгүй Тэмүжин гэж шивнэжээ. Цайны мөнгэн гүц гараас мултран гэрийн үүдний чулуун шалан дээр хангинан унахыг ч сонссонүй.Үл таних тэр залуу өөрийг нь чиглэн түргэн түргэн алхлан ирэхэд хөдөлж чадсангүй. Энэ бол Тэмүжин болохыг түүний хурц шар нүд гэрчилнэ.

Тэмүжинг яаж их санаж мөрөөдөж байснаа Бөртэ сая л нэг гүйцэд ойлгосон билээ. Тэгээд одоо Тэмүжинээс хэзээч салахгүй гэж боджээ.

-Бөртэ би чамайг авахаар ирлээ гэж Тэмүжин шууд хэлэхэд олон жилийн өмнө уйлж салсан хөвүүн мөн ч юм шиг, биш ч юм шиг санагдаад өөрийн мэдэлгүй толгой дохив.Хүсэж хүлээсэн хайртай хүнтэйгээ учрахын жаргалыг Бөртэ тэгэхэд анх амссан юм.

Гэтэл тэр шөнө эр хүнд эдлүүлж,охин биеэ орхихдоо тачаадан чичирч,ухаан алдсан нь дур тавьсан хэрэг болохыг хожим Тэмүжиний гэрт аваль эмийн ёсоор ирснээс хойш ойлгожээ.

Бөртэ ингэж дур тавихдаа түр зуур ухаан алддагийг мэдэхгүй Тэмүжин ихэд айн сандарч Бөртийг үхэв гэж санаад учраа олохгүй нүүр нүдрүү нь үлээж,хацрыг нь алгадаад аргаа барахдаа хажуу гэрт унтсан Билгүтэйг дуудахаар гарах гэтэл ашгүй Бөртэ гэнэт урт амьсгаа аваад нүдээ нээжээ. Энэ хачирхалтай явдлын учрыг олж мэдээд тэд бие биеийг шоолон инээлдсэн билээ.

Харин Бөртийн ийм тачаангуй ааш Тэмүжинд туйлын их таалагддаг бөгөөд түүнийг хүссэн үедээ чих, хүзүүг нь халуун амьсгалаараа сэрвэгнүүлэн –Хоюулаа үхэж тоглох уу гэж шивнэдэг болжээ.

Дур тавиад ухаан алдан унасан үзэсгэлэнт залуу эхнэрээ ширтэн суух шиг аз жаргал Тэмүжинд байсангүй.

Гэвч өдөр шөнөгүй “Үхэж тоглосон” дэндүү их аз жаргал нь хэмжээтэй байжээ.

Хэмжээтэйгээр барахгүй аймшигт үр дагавартай байсныг тэд тааварласангүй. Одоо тэд хэтэрхий их аз жаргалынхаа өр төлөөсийг юу болохыг үзэв. Мэргэдийн сүйрсэн хүрээний захад ингэж суухдаа Бөртэ ,Өүлэнийг булаасан Есүхэйг,харин Тэмүжин Бөртийг хөл хүнд болгосон Чилэгэр бөхийг үзэн ядаж байлаа. Гэвч тэдэнд учирсан зовлон бол хэн нэгний өс

хонзон биш Дээд тэнгэрийн зарлиг,тэдэнд илгээсэн сорилт болохыг Тэмүжин ч, Бөртэ ч мэдэхгүй байлаа.

Тэдний тэврэлдэхийг үзээд Хасар, Билгүтэй, Зэлмэ гурав бие биеийг нудралцан баярлажээ. Тэмүжин тайвширсан нь тэдний хувьд үнэхээр баяр байв. Хэрвээ зөрүүд мугуйд Тэмүжин Бөртийг ална гэвэл тэд яаж ч чадахгүй байв.

Харин Тэмүжин Бөртийг алахаар шийдвэл Хасар Бөртийг гуйж авъя гэж дотроо шийдсэн билээ.

Үзэсгэлэнтэй,ухаантай Бөртэд ганц Хасар ч биш бүгд дотно сайнаар хандах бүлгээ.

- Харья даа хоёулаа гэж Тэмүжин Бөртийг тэвэрсэн чигээр шивэгнэв.

-Хаашаа гэж асуухдаа Бөртэ эргэлзэн итгээгүй ч Тэмүжэнээс салж хагацана гэхдээ хичнээн их харамсаж буйгаа мэдэрлээ.

-Бурхан Халдун ууландаа очъё. Тэнд гэр минь бий. Ээж минь тэнд хүлээж байгаа.

-Тэмүжин. Чамд хэцүү бол намайг энд орхиж од гэж Бөртэ хэлсэн ч баярласандаа чимээгүй уйлсаар ажээ.

Чилэгэр бөхөөс хөл хүнд болсноо мэдмэгц амиа үрэхээр хэдэнтээ оролдсон ч зүрхэлж чадаагүй билээ. Тэмүжин ямар бэрх шаналалд унасныг Бөртэ гашуудан мэдэрч байлаа. Бас түүнийг ямар их тэвчээр гарган биеэ барьж байгааг ч мэдэж байв. Тэднийг ийм гашуун хувь зохиол хүлээж байсныг урьдчилан тааж мэдэх аргагүй нь гачлантай. Одоо тэдэнд ганцхан тэвчих л үлджээ.

-Бүү уйл. Бөртэ. Би чамайг яаж орхино. Би чамайг л авах гэж ирсэн. Юмаа бэлд. Маргааш явцгаана гэж Тэмүжин хэлэхдээ өөрийнхөө ингэж тайвширсанд гайхжээ..

-Юу авах билээ. Замд төрвөл гэж л жаал зуул юм авъя. Тэгээд л явъя. Тэмүжин. Чи намайг бүү зэмлэ. Энэ хүүхэд чиний хүүхэд болно. Би амлаж байна.

-За гэж Тэмүжин дуулгавартай шивнэв.. Тэмүжин, Бөртэ хоёр ийн эвлэрэв. Бөртэ хоносон гэр лүү гүйн одлоо. Тэр шөнө Мэргэдийн эзгүй гэрт хонохдоо Тэмүжин ихийг бодов. Тайвширч, ядарсан Бөртэ галын элчинд цохигдон нам унтжээ.

Харин Тэмүжин галын дөл ширтэн бодолд автана. Амьдрал өдөр бүр түүнд хариу олоход бэрхтэй хүнд асуулт тулгах ажээ. Одоо яах ёстой вэ. Бүгдээс тод ойлгомжтой байгаа ганц юм бол Бөртийг алдаж болохгүй явдал гэдгийг мэджээ. Бөртийг ад үзэх юм уу, алах нь огт утгагүй хэрэг юм. Бөртийг буцаан авсан нь энэ тулаанаас олсон түүний хамгийн том олз юм. Тийм учраас түүнийгээ яасан ч алдаж болохгүй юм.Харин хөл хүнд болсон нь яах ч аргагүй түүнийг бухимдуулна. Гэвч Тэмүжинд үүнтэй эвлэрэн зохицохоос өөр зам байсангүй.

Мэргэдээс Бөртийг буцааж булаан авснаар Хэрэйд, Жадаран гэсэн хоёр хүчирхэг холбоотонтойгоо бүгдэд харуулсан нь Боржигон аймаг эргэн нэгдсэнтэй адил үйл явдал

болно гэдгийг Тэмүжин тааварлаж байсан тул биеэ барьж,тайвшрахыг хүчлэн хичээж байлаа. Амьдарлынхаа төлөө, ирээдүйн ялалтын төлөө ийм үнэ төлөх ёстой бол төлөхөөс өөр аргагүйг ухаарч байв. Сэтгэл нь онгойж тайвшраад нам унтах Бөртийг Тэмүжин галын гэрэлд удаан ширтэн ажиглав.

Тэр үнэхээр үзэсгэлэнтэй ч өст мэргэдийн Чилэгэр бөх гэгч эр түүнийг нь эдэлж байсан гэж санагдахуйд гол нь харлан шүдээ хэмхэртэл зууж, ширдгэн дээр шархадсан чоно шиг архиран өнхрөв. Түүнд Бөртийг хэмх балбан хөөж явуулах хүсэл тэвчишгүй ихээр оргиловч биеэ барьж дотроо гаслан уйлж байв. Түүний өш хорсолд хязгаар байсангүй.

-Тэнгэр минь. Намайг яасан гэж ингэж хатуугаар залхаана вэ. Юуны учир өст мэргэдийн үрийг өвөрт минь шургуулав. Түүнийг надаас зайлуулж өгөөч. Би одоо яах ёстой вэ? Хэлээч. Тэмүжин Мэргэдийн хүрээний захад хадан дээр гарч сөхрөн суугаад Тэнгэрээс ийн мөргөн гуйв.

Харанхуй тэнгэр дүлий юм шиг таг чиг. Сайн муу ямарч хариу эс сонсогдоно. Ухаан санаанд нь ямар нэгэн тодорхой шийд төрөхгүй мухардана. Тэнгэрт хандан үгээ хэлсэн тохиол бүрд түүний ухаан санаа нь гийж, зориг төгс болдог бол энэ удаа тэгсэнгүй нь гайхалтай. Лав түүний хэлсэн хүслийг тэнгэр таалсангүй бололтой.. Тэнгэрт таалагдахгүй хүсэл бас байдгийг Тэмүжин ухаарлаа. Ийм үед яах ёстой вэ. Үүр цайж гэгээ орохоос өмнө Тэмүжин шийд гаргах ёстой юм.

Тэнгэр түүнд туслахгүй нь ойлгомжтой болсон тул зөвхөн өөрийн зориг, ухаанд найдах ёстой болжээ.

Тэмүжин тэнгэрийн үгийг хүлээн сууж сууж, гомдолтойгоор бүсээ бүслэн бослоо. Одоо түүнд ганцхан өөрийн шийдвэрт итгэх үлджээ. Тэнгэр нэгэнт хариу хэлээгүй тул яаж шийдэх нь өөрийнх нь мэдэх хэрэг гэж тэр бодов.

Тэмүжин Есүхэй эцгийнхээ шарилын дэргэд суухдаа л тэнгэрийн дууг сонсож, түүнтэй ярьж үзэхсэн гэж анх хүссэн билээ. Түүнээс хойш сэтгэлийн дотор тодорхой шийд гаргаж чадахгүй болсон үедээ ингэж тэнгэртэй ярьж сурчээ. Ингэхэд нь Мэнлигийн дунд хөвүүн Хөхөчү уруу татсан юм. Хэн хаанаас түүнд ингэж тов тод үг хэлж ухааруулдгийг мэдэхгүй, бас үзээгүй ч тэнгэр л ингэж хэлдэг гэдэгт тэр итгэдэг бас Хөхөчү ч тэгэж хэлдэг байв.

Энэ нь тэнгэрийн үг биш харин өөрийнх нь ухаарал гэдгийг Тэмүжин мэдсэнгүй. Бас үүнийгээ нөхөддөө ч хэлдэггүй байлаа. Харин анх удаа тэнгэр түүнд ямар нэгэн хариу хэлж зөвлөсөнгүй нь Бөртийн бие давхар болсонд Тэмүжиний ухаан цочирдон самуурсных байв. Энэ бол ямарч үед ганцхан өөртөө л итгэх хэрэгтэй гэдгийг түүнд ухааруулжээ. Бас магадгүй газар орон нь өөр учир энд тэнгэр түүний хүслийг сонсоогүй ч байж мэднэ гэж Тэмүжин тэнгэрийг цагаатган боджээ. Өглөө болж нар тусахад Тэмүжиний сэтгэл шуударч шийдвэр төгс болсон билээ.

Мэргэдийн ихэнхийг сөнөөсөн Тоорил, Жамуха хоёр олзондоо цадаж ханаад Тэмүжинг ор тас мартжээ.

Тэд Тогтоэбэхийн их өргөөг эзэлж мэргэдийн бүсгүйчүүдээр зугаагаа гаргаж найрласаар ажээ.

Тэмүжиний нөхөд Боорчи, Зэлмэ Билгүтэй, Хасар нар түүний юу хэлэхийг биелүүлэхэд бэлэн хүлээж байв.

Тэмүжиний царайг яаж ч шинжээд юу гэж шийдсэнийг таах аргагүй. Өглөөний наранд шүүдрийн ус солонгорч Хилго мөрний эргээр мал бэлчээрлэж энд өчигдөр дайн тулаан болоогүй мэт амгалан байлаа.

Нүүдэлчин аймгийн амьдралд дайн тулаан гарах нь яг энэ нар мандах шиг, мал бэлчих шиг жирийн явдал билээ.

-Морьд бэлэн үү гэж Хилго мөрний зүг ширтэн бодол болон зогссон Тэмүжин Зэлмийг дэргэдээ ирэхэд шууд асуув.

-Сайхан амарч, хагсраад хаа ч хүрэхэд бэлэн болжээ Тэмүжин гэж Зэлмэ хэлэхдээ дайны олзондоо нэн ялангуяа мэргэдийн зүс гоо охиныг Тоорилд алдсандаа одоо болтол харамссаар байгаа нь илт мэдэгдэж байв.

Зэлмэ тэр олзны охиныг өөртөө авахаар Боорчитой тохироод байсан тул “Даанч хөөрхөн охин байсандаа” гэж харамсан боджээ.

-Тэгвэл мордоход бэлд гэж Тэмүжинийг хэлэхэд Зэлмэ хариу хэлсэнгүй холгүй аргамжиж хоносон морьд руугаа гүйлээ. Зэлмийн ингэж дуугүй явах нь уурласных юм. Зэлмийг харсан Билгүтэй, Хасар хоёр эмээл хазаараа авчирхаар хоносон гэрийн зүг явав. Тэмүжиний дэргэд тайван хэнэггүй Боорчи хүрч ирэв.

- Боорчи. Чи Бөртийг авч буц. Хасар бид хэд Тоорил, Жамуха хоёрыг эндээс хөдөлтөл цуг байх хэрэгтэй биз.

- За. Тэмүжин би явья гэхээс өөр үг Боорчи дуугарсангүй.

- Боорчи. Чи ч гэсэн олзондоо харамссаар байна уу гэхэд Боорчи дуугүй толгой сэгсрэв. Тэд хэсэг зуур чимээгүй зогсоцгоов. Боорчи үнэндээ мэш их харамсаж байсан билээ. Тэмүжин гэнэт Боорчид ойртон нүүрэнд нь тулан зогсож нүдрүү эгц ширтэв.

-Яав чи гэж Боорчи түгшин шивнээд эргэн тойрноо харж хойш алхам ухрав.

Тэмүжиний нүд ингэж аймшигтайгаар гялалзаж байхыг Боорчи урьд нь үзсэнгүй тул цочжээ. Тэмүжин урагш алхаж дахин нүүр тулан зогсоод

-Би чамд өргөсөн тангарагийг чинь сануулж нэг зарлиг буулгая гэж шивнэхэд нь Боорчи сая тайвшран инээмсэглэв. Энэ удаад тэр Тэмүжиний зарлиг буулгая гэхийг сонсоод инээсэн ч тэр дороо биеэ барин төв царайлж

-Би сонсож байна. Тэмүжин! гэж хөмсгөө зангидав. Тэр дороо залган

-Би чиний зарлигийг сонсое гэж хэлэхдээ Боорчи харин ч бахдах сэтгэл дүүрэн оргилохын мэдэрлээ. Итгэлт нөхрийнхөө зарлигийг сонсож бас биелүүлнэ гэдэг чухам ямар бахдалт хэрэг болохыг тэр ингэж анх удаа мэдэрч туйлгүй баясан догдлов.

Мэргэдийг сөнөөж Бөртийг булаан авсан нь Тэмүжинийг бишрэх Боорчийн сэтгэлийг хүчтэй болгох ажээ.

-Чи Бөртийг авч нутгийн зүг морины амыг таталгүй давхи. Боорчи, Тэмүжиний энэ үгийн цаад учрыг хормын дотор ойлгож түгшлээ. Гэвч Тэмүжин түүнд ам нээн эсэргүүцэх зав зав өгсөнгүй. Одоо тэр хоёрын хамрын үзүүр бараг тулж байв.

Голын эргийн ганц модны дээр суусан хэрээ учир зүггүй гуагалаж эхлэв. Тэр хоёр үүнийг анзаарч сонссонгүй. Харин ойр явсан Билгүтэй чулуу шидэж тэр муу ёрын хэрээг хөөж явуулжээ.

- Тэр хүүхэд хүн болох ёсгүй. Бөртэ орилж уйлсан ч бүү зогс гэж Тэмүжин эрс шаардав.

-Төрөх болбол яах юм бэ.

-Чи хүүхдийг нь замын хажуу руу шидэж орхи.

- Хүүхдийг алах гэж үү гэж Боорчи итгэл муутай эсэргүүцэв.

- Тэр хүүхэд амьд үлдэх ёсгүй гэж би чамд хэлж байна бус уу.

-Эцэст нь би хүүхдийг нь алсан болж Бөртэ намайг нэг нүдээр үзэхгүй биз

-Чи тангарагаа сана. Би энийг чамаас өөр хэнд хэлнэ. Чамаас өөр хэн үүнийг хийнэ гэж Тэмүжин өөрийн энэ аюулт санаагаа тэнгэрээс нуух гэсэн мэт шивнэв.

Тиймээ. Боорчи тангаргаа яаж мартах билээ. Харин андын тангараг тавьсан нь эцэстээ ийм хэрэг үйлдэхэд хүргэнэ гэж тэр даанч санасангүй. Гэвч Боорчи хөөрхий Бөртийг өрөвдсөн ч Тэмүжинг үзэн ядсангүй. Бөртийг буцааж булаан авсан ч Тэмүжин Чилэгэр бөхийн үрийг алахаар нэгэнт шийдсэнийг Боорчи яах ч аргагүй тул дуугуй толгой дохив.

Бас Бөртийн хүүхдийг алах нь гарцаагүй зөв гэж боджээ.

-За би тэр хүүхдийг амьд төрвөл хаяж орхъё. Харин Бөртэ замдаа төрөхгүй бол гэрт очсон хойноо чи тэр хүүхдийг өөрөө алаарай гэж Боорчи шивнээд инээв.

Бүх зүйл Тэмүжиний санаснаар болж тайвширч сатаарсан Бөртэ явахад бэлэн болжээ. Тэмүжиний хэлсэн үг болгонд Бөртэ итгэж, бас өрөвдөж байлаа. Бөртэ анх Тэмүжинг үзээд өрөвдөж,сүүлд нь хайрлаж,эцэст нь дурласан юм.

Арван жилийн өмнө есөн настай Тэмүжин Дайцэцэний гэрийн гадна эцэгтээ орхигдон хоцрохдоо хүнээс нуун нулимсаа арчихыг үзээд анх Бөртэ түүнийг голоо тасартал өрөвдсөн билээ. Үг дуу цөөнтэй, айсан мэт харцаа нууж явдаг тэр хөвүүн эхлээд Бөртэд огтхонч

таалагдаагүй юм. Гэтэл тэр дорой буурай төрхтэй Тэмүжиний дотор сэтгэлийн гүнзгий шаналалыг олж хараад ихэд өрөвдөн ойлгож,түүнд нэг насаараа тус дэм болж явахаа тангарагласан билээ.

Арван настай Бөртэ ингэж ганцаардаж, шаналсан хүн урьд өмнө ер үзсэнгүй нь Тэмүжинийг хайрлахад хүргэжээ. Тэмүжинийг харахад тэр хэмжээлшгүй их зовлон үзэх юм шиг совин татна.

Тийм болохоор Бөртэ, Тэмүжинд аль болохоор туслахыг хичээж яг л эгч шиг нь байсан билээ. Бөртийн совин үнэн болж Есүхэй татаарт хорлогдон үхсэн тухай аймшигт мэдээг зарц Мэнлиг хүргэж иржээ. Энэ мөчөөс хойш Тэмүжинг хэзээч орхихгүй гэж Бөртэ хатуу шийдэв. Бөртийн энэ шийдвэр хэдийгээр түүний сэтгэлийн хүсэл байсан ч чухамдаа Тэнгэрийн зарлиг болохыг тэдний хэн нь ч ойлгож мэдээгүй байв. Харин Есүхэй эцгийнх нь оронд би Тэмүжинд үлджээ гэж Бөртэ бодно. Тийм учраас Бөртэ бол Тэмүжинийг орхиж, хаяж чадахгүй цорын ганц үнэнч нөхөр нь юм.

Өнөөдөр тэдэнд учирсан бүх гай зовлонг ийм сэтгэлийн үүднээс Бөртэ ойлгож, Тэмүжиний үг ,үйлдэл бүрийг тэвчжээ. Бөртэ уг нь хамгаалж авалгүй амиа бодон зугатааж одсон Тэмүжинд туйлын ихээр гомдож байсан билээ.Мэргэдийг довтлон ирэхэд хөгшин эмгэн Хуагчины хамт явган нүцгэн орхиод өөрийн эх,дүү нарыг дагуулан зугатаасан Тэмүжинд яаж гомдохгүй байх вэ. Тэр үед Бөртийг сундлаад ч болов явсан бол ийм явдал болж,элгээ эмтлэхгүй байв.

Мэргэдүүд Бөртийг авчраад Өүлэний ёсолж авсан эр Чилэдүгийн дүү Чилэгэр бөхөд өгчээ.

Бөртэ хэдий сэтгэл чанга, зориг хатуу ч оногдсон заяагаа даган Чилэгэр бөхийн хүчинд автан эдлэгдэх болжээ.

Ийм үзэсгэлэнт эмийг үзээд дур тачаалаа тэвчин барих эр хүн гэж хаана байх билээ.

Тэр бүү хэл Увас Мэргэдийн толгойлогч Дайр-үсэн гэгч Бөртийг зуун шилдэг агтаар худалдан авах гэхэд нь өгөөгүйд Бөртэ дотроо Чилэгэр бөхийг журамтай эр гэж ихэд тоожээ. Ер нь энэ Чилэгэр бөх Бөртэд хамгийн дотноор хандаж, энхрийлэн асарч байжээ. Үнэндээ бол Тэмүжиний дэргэд Чилэгэр бөх царай зүс үзэсгэлэнтэй, бие хаа өндөр сайхан эр билээ.

Харин ч Бөртэ олзлогдож ирээд өтөл муу эрд эдлэгдээгүйдээ,өчнөөн эр дамжин зарагдаагүйдээ дотроо баярлаж байв.

Тийм учраас хэвлийдээ олдсон үрээ үзэн ядах сэтгэл түүнд огтхонч төрөөгүй ажээ. Зэлмэ, Билгүтэй хоёрыг морьдоо эмээллэж иртэл тэд дуугарцгаасангүй.Салахын өмнө Тэмүжин олон юм хэлсэнгүй,Бөртэ ч асуусангүй.Тэмүжиний занг мэдэх учраас Бөртэ ийм үед дуугүй байх нь дээр гэж боджээ.

Одоо Тэмүжин түүнийг бас хэвлийдэх үрийг нь өршөөсөнд Бөртэ итгэж байлаа.Тийм учраас Бөртэ тэнгэрт талархан мөргөсөн билээ.Мордохын өмнө Бөртийг ийн тэнгэрт удаан мөргөхийг Тэмүжин чив чимээгүй харж зогслоо.Тэмүжиний юу бодож байгааг ганц Боорчи л

мэдэж байв.

Удалгүй Боорчи, Бөртэ хоёрыг давхин явсан хойно Тоорилын баг цэрэг нэгэн хүлээтэй хүнийг Тэмүжинд авчирч тушаасан нь өнөөх Чилэгэр бөх байсан билээ. Ёстой бөх нэрэндээ таарсан, Тэмүжинээс даруй толгой өндөр булиа залуу огт айсан шинжгүй, тайван сайхан зогсох нь бүгдийг хачирхуулна. Тоорил хан бас тавин шилдэг агт өгчилгөсөн нь өөрийгөө арай ч хуншгүй зан гаргажээ гэж ойлгосных бололтой.

- Энэ өнөө Чилэгэр бөх гэгч гэж Тоорилын хүү Сэнгүм хэлээд

–Хан эцэг, хэрхэн шийтгэхээ Тэмүжин чамайг өөрөө мэд гэлээ гэж даажинтайгаар тас тас хөхрөөд давхин одов. Тоорил хан ямархан хүйтэн үгээр түүний сэтгэлийн шархыг хөндөн олзны тухай хэлсэн үгийн хариу авч байгааг Тэмүжин ойлгов. Бөртийн хэнээс үр тээснийг бүгд мэджээ.

Тэр бүү хэл Тоорил хан тэр хэрэг явдлаар дайрч доромжлон Чилэгэр бөхийг илгээж, одоо яаж тавлан инээж суугаа нь харагдах шиг болно.

Тэмүжин Чилэгэр бөхийг удаан ширтэв.

Есүхэй, Өүлэн хатныг мэргэдийн их Чилэдүгээс булаан авсны хариуд Бөртийг Чилэдүгийн дүү Чилэгэр бөхөд өгсний учир одоо хоёр залуу эр үхэл амьдралын заагт нүүр тулан зогсчээ.

Эцэг өвгөдийн хийсэн гэм нүгэл үр хойчид нь гай түйтгэр учруулдаг хатуу цагийн жамыг яалтай билээ.

Үзэсгэлэнт Өүлэнг булаан авснаар хожмын ямар гай зовлонгийн үрийг тарьснаа Есүхэй хэзээ ч мэдэхгүйгээр тэнгэрт оджээ. Тэмүжин болоод Чилэгэр бөхийн хооронд үүссэн зөрчил тэмцлийн буруутан үгүй болжээ. Бас зөв бурууг хэлэх ухаантан ч үгүй юм.Хувь тавилан тэднийг үхэл амьдралын орчлонд хэн нэгийг нь үлдэхийг тушаасан нь энэ байв.Харин энэ удаа Чилэгэр бөхийн хувьд тийм ч баярлахаар явдал болохгүй нь нэгэнт тодорхой байлаа.

Чилэгэр бөх анх Бөртийг түүнд өгөхөд гоо үзэмж төгс бүсгүйг хараад тачаадан шунаж дотроо бодсон бүх эргэлзээ ,муу совингоо мартаж үйлийн үрээ дуугүй дагасан билээ. Бөртийг авснаар түүнд сайн юм огт болохгүй гэдгийг ёрлосоор байсан мөртөө Бөртийг ямар ч болов алдаж болохгүй гэж шийдсэн нь түүний ухаангүй дурласан сэтгэлийнх байжээ.

-Чи наад эмээсээ болж үр удмаараа сүйрэхийг би үзнэ гэж атаархаж хорссон Дайр-Үсэн гэгч согтууран хашгирахыг ч юман чинээ бодсонгүй.

Дайр-Үсэн угаас хар муу санаатай, хорон гашуун үгтэйг бүгд мэдэх тул түүнийг Бөртийг зуун агтаар арилжин авах гээд өгөөгүйд уурласандаа тэгэж байна гэж бодсон ажээ. Гэнэт сураг ажиггүй алга болж,ядаж яс,хүүр нь ч үзэгдээгүй үгүй болсон их Чилэдү ахынх нь амины төлөөс болгон Бөртийг Чилэгэр бөхөд өгчээ. Гэтэл Дайр-Үсэнгийн муу үг үнэн болов.

Бөртийг булаан авсан нь ганц Чилэгэр бөхөд ч биш бүхэл Мэргэд аймгийн ирээдүйн

сүйрлийн эх болохыг хэн ч тааварласангүй.Чилэгэр бөх үйлийн үрээ даган одоо Тэмүжиний өмнө зогсож байв. Тоорил ханы цэрэг довтлон ирэх сургаар Чилэгэр бөх эмс хүүхдээ хаян зугатаасан ч гай болж зүв зүгээр байтал эмээлийн олом тасарч баригджээ.

-Тэмүжин ахаа. Үүнийг тас цавчин хаяая гэж Билгүтэй шивнээд сэлмээ сугалж хэрэв Тэмүжин толгой дохивол ухасхийн очиход бэлэн байлаа.

-Тэмүжин! Би чиний тухай олныг сонссон. Бөртэ ч манайд байхдаа чиний тухай эрүү ам хамхилгүй зөндөө л ярьсан. Чи зоригтой хүн биз. Гэвч чи намайг албал хүлгийг минь тайл. Сүүлд нь чамайг хүлэгтэй хүнийг алав гэж бүү муу хэлэг. Би Тэмүжин чамайг энэ Тоорил шиг олзонд нүдээ ухаад өгчих хүн биш гэж бодно гэж Чилэгэр бөх инээмсэглэн хэлжээ.

Тэр үхнэ гэхдээ огт харамссан, айсан шинжгүй байгаа нь гайхалтай. Чилэгэр бөх үхэл нь гарцаагүй ирснийг мэдмэгц тайвширчээ. Чилэгэр бөхийн царайг үзэж, ухаантай үгийг сонсоод Тэмүжин түүнийг өчигдрийнх шиг үзэн ядахгүй бас алах гэж тэгтлээ сүрхий хонзогнохгүй болсондоо ихэд гайхав.

-Харин Тэмүжин би чамаас нэг зүйл хүснэ. Чи Бөртийг төрөхөөр хөвүүн байвал бүү ал. Хэнд ч хамаагүй өгч орхи. Манай аймгийн хэн ч байсан миний үрийг авахаас татгалзахгүй биз. Хүн болбол хүслээрээ болог. Чилэгэр миний үр гэдгээ мартвал мартаг. Эр хүн болж төрсөн юм бол амьдарч үзэг. Түүний буруу гэж үгүй биз гэсэн Чилэгэр бөхийн үгийг сонсоод Тэмүжин гэнэт

-Үүний хүлгийг тайл. Хасар чи сэлмээ түүнд өг гэв. Тэмүжиний энэ санамсаргүй шийдвэрт дахиад л гайхан гөлөрцгөөв.

-Энэ чинь ёстой гайхам бахтай хэрэг байна. Чи ухаантай, зоригтой хүн гэсэн нь үнэн бололтой. Бөртэ чамайг дэмий нэг магтаагүй бололтой гэж Чилэгэр бөх бүр үнэн сэтгэлээсээ хэлэв. Зоримог, үнэн үгтэй энэ залуу Тэмүжинд таалагдаж байв. Гэвч эхнэрийг нь эдэлж бүр жирэмслүүлсэн түүнийг өршөөх учир байсангүй. Харин түүнтэй сэлмээр тулалдаж өөрийн гараар алахыг хүсэв. Бас ингэх нь зөв бөгөөд шударга явдал болно гэж боджээ.

- Тэмүжин ах. энэ муу мэргэдтэй би тулъя. Үгүй бол зүгээр л алж орхиоч гэж Хасар хашгирсан нь Тэмүжинг болгоомжлуулсан хэрэг байв.

- Чи сэлмээ өг гэж Тэмүжин хэлснээсээ буцахгүй дахин зөрүүдлэн хашгирав.

- Хасар! Чи муу мэргэд гэж юу хэлнэ. Бид бүгдээр адилхан тал хангай нутгийн Монгол аймгууд. Чи үүнээс хойш бусдыг бүү муу хэл. Би чамайг ер доромжилсонгүй шүү гэж Чилэгэр бөхийн хэлэхэд

“Бас ухаантай сүрхий эр юм” гэж Тэмүжин ихэд тоон бодлоо. Хасар яаж ч чадсангүй өөрийн сэлмийг Чилэгэр бөхөд өгөөд зай тавив. Тэмүжиний шар нүдэнд занал хорсол хурж сэлмээ урагш сунган алгуур тойрно.

Тэмүжин хэдийгээр сэлмээр тулалдах сургууль уйгагүй хийсээр авч нөхдийнхөө хэнд нь ч үл

хүрэх тул бүгд түгшин зовж байлаа.

Хасар, Билгүтэй, Зэлмэ гурав хормын дотор харц солилцон муу юм болбол хажуугаас нь дайран орохоор бэлэн болжээ.Гэвч тэд Тэмүжиний зөвшөөрөөгүй байхад ингэж зүрхлэхгүй билээ.Чилэгэр бөх сэлмээр тулалдахдаа сайн биш байж мэднэ гэж бодож байв.

Сэлэм агаарт хавиран хангинан дуугараад оч үсрэн тэд тулалдаж эхлэв. Чилэгэр бөх сэлэмдээ гарамгай үнэхээр гавшгай эр ажээ. Тэмүжинг илт дийлдэх янзтай болохоор нөхөд нь сэлмээ шүүрэн ойртлоо. Гэвч Тэмүжиний уурсаж, улайрсан царайг хараад хажуугаас нь орж арай л зүрхэлсэнгүй.Хэрэв хажуугаас нь орвол Тэмүжин цавчихаж мэдэх янзтай.

Тэд тулалдсаар Тэмүжин сэлмээ алдаж ухран зугтаах тэр агшинд Хасар Чилэгэр бөхийг цавчин унагав.

Хасар ингэж шаламгай хөдлөөгүй бол Тэмүжиний хүзүүнд Чилэгэр бөхийн сэлмийн ир буух байлаа.Улаан цагаан хоолойгоо тас хэрчүүлсэн Чилэгэр бөх дороо үхжээ. Тэмүжин юу ч дуугарсангүй амьсгаадан сууна.Зүрх нь тулалдсанаас биш айснаасаа түг түг цохилно.Үхэл дэргэдүүр нь гүйж өнгөрөхийг Тэмүжин харах шиг болов.Чилэгэр бөхийн хүүрнээс үхлийн үнэр ханхална.Үхэл ийм хурц содон үнэртэй болохыг анх мэджээ.Бүр бөөлжис цутгах аж.

-Их гавшгай юм гэж Хасар хэлээд Чилэгэр бөхийн тас атгасан гараас сэлмээ салган авав. Саяын тулаан бүгдэд нь таалагдсангүй ч бас Тэмүжиний буруу гэж хэлж зүрхэлсэнгүй. Гэвч Хасар тэссэнгүй,д уугүй суух Тэмүжинийг харж

-Зэлмэ, Билгүтэй та нар сонс. Үүнээс хойш Тэмүжин ахыг гардан тулахыг би хориглож байна. Боорчи хэдүүл ахын өмнөөс тулж байя. Мэдэв үү гэсэнд бүгд толгой дохин зөвшөөрөв. Тэмүжин үг дуугарсангүй.

Нөхөд нь түүний сэтгэлийг эмзэглүүлэхгүй гэсэндээ сэм холдон явцгаав. Одоо Тэмүжин Чилэгэр бөхийн хүүрийн дэргэд хоцров.

-Хөвүүн төрвөл чи бүү ал гэсэн түүний үг санагдана. Тэмүжин түүний энэ үгийг хүндэтгэж байлаа. Гэвч бид нэгэнт оройтож дээ гэж дотроо шивнэв. Үнэхээр Чилгэр бөх гэгч энэ үйлийн үртэй мэргэд залуу Бөртөөс хөвүүн төрөөсэй гэж чин сэтгэлээс хүсч байжээ. Гэвч тэр өөрийн хүслийг үзэж чадсангүй үхэв. Тэнгэрийн таалалд нийцээгүй Тэмүжиний хүслийн хариу энэ байжээ. Ямар ч болов Тэмүжин бүхнийгг өөрийнхөө ухаанаар шийдэв. Гэвч Чилэгэр бөхтэй хоёул нүүр тулсан бол Тэмүжин өдийд хүүр болон хэвтэх байснаа сэтгэлдээ зөвшөөрч байлаа.

Өөрөөсөө хүч илүү дайсантай хар зоригоор нүүр тулан халз үзэлцэх аминд хүрэх аюултайг голдоо ортол ойлгож бас гэмшиж суув. Одоохондоо Тэмүжин саяын хоёр хоногт болж өнгөрсөн явдлыг дүгнэх цэгнэх чадалгүй байлаа.Гэвч өнөөдөр Чилэгэр бөх тэдний хоорондболсон хэргийг хэзээ ч хэнд ч илчлэн задлахгүй байх ам тангарагийг Хасар,Билгүтэй,Зэлмэ гурваас авсны эцэст бага боловч тайвширч бодол санаагаа цэгцлэхийг оролдов.Тэмүжин өөрийн сул дорой байдлыг хүнд мэдэгдэхийг үл хүсчээ.

Тэмүжин хэдийгээр Чилэгэр бөхөд дийлдсэндээ хорсон шаналсаар бөйсан боловч харин нөхөд нь олсон, үзсэн ялалтандаа сэтгэл дүүрэн баяртай болцгоосон тул Тэмүжиний хэлсэн болгоныг үг дуугүй хүлээн зөвшөөрчээ.Тэд Тэмүжиний бүх нууцыг үүрд бат хадгалахад бэлэн байв.Энэ тангараг Тэмүжиний далд нууц түүхийн эхлэл болов.

Хэрвээ Бөртэ бие давхар болоогүйсэн бол Тэмүжинд гуниж,шаналах хэрэг үнэхээр үгүй байлаа. Мэргэдтэй хийсэн тулалдаанд ямарч байсан Монголын тал нутгийн хоёр том аймаг Хэрэйд, Жадараныг өөрийн холбоотноо болгож чадав. Булаагдсан эхнэрээ буцаан авч нэр бүтэн болов. Тарж бутарсан Боржигон аймгийн албатууд нь түүний хэн болохыг мэдэв. Тэмүжин Хасар дүүгийнхээ гавшгай хөдөлсний хүчинд Чилэгэр бөхийн сэлэмнээс аврагдан амьд үлдэв.Энэ явдлыг нууцлахыг чандлан захив.

Бас Бөртийн гэдсэн дэх хүүхдийг алахаар шийдэв. Тэр хүүхэд амьд үлдвэл эхнэрээ бусдад булаагдсан гашуун түүхийн гэрч болж, олны нүдэн дээр сануулсаар байх тул түүнийг амьд үлдээх шалтаг олдохгүй байлаа. Бөртэд хэцүү байж мэднэ.

Гэвч тэр үүнийг тэсэх ёстой. Тэмүжиний нэр төрийг хамгаалах үүднээс Бөртэ эх хүний хувьд тэсэх ёстой гэж шийдсэн билээ.

Магадгүй Бөртэ тэр хүүхдээ үхэхийг хүсч буй ч байж мэднэ гэж Тэмүжин өөрийгөө цагаатгах үүднээс бодож байв. Гэвч яаж эндүүрч байснаа хэд хоногийн дараа мэдсэн билээ.

Мэргэдийн сүйрсэн хүрээг цөлмөж, эд агуурсыг ачиж мал сүргийг тууж одсоны дараа Тоорил хан цэргээ авч Туул голын Хүн чулууны хөндийдөх өөрийг хүрээрүү буцжээ. Олз,ялалтандаа бялуурсан Тоорил ханы цэргийн цуваа цатгалан үхэр могой шиг хөдөлж ядан эвхэрсээр холдон одохыг Тэмүжин харж зогслоо.

Харин Жамуха Тэмүжин хоёр багадаа тавьсан андын тангаргаа баталж нэг дор амьдран суухаар тохироод Онон голын Хорхунаг Жубурын хөндийг чиглэн явав.Энэ явдлыг Өүлэн эхдээ мэдэгдэхээр Зэлмэ Хасар хоёрыг яаравчлан илгээв. Өүлэн эх удалгүй Хорхунаг Жубурын хөндийд нүүн очжээ.

Харин Тэмүжин Жамуха хоёрыг замдаа яаралгүй амарч тухласаар сарын дараа ирэхэд шинэ буурин дахь гэрийн гадна Бөртэ Өүлэн эхийн хамт угтав.

Өүлэн эх Бөртийн төрүүлсэн шинэ хүнийг тэвэрсэн байжээ.

Тэмүжин үүнийг хараад эхлээд нүдэндээ итгэсэнгүй.

Хэрэйд болон Жадаран аймаг нэгдэн Мэргэд аймгийг довтлон хагас хувийг нь булаан авсан сураг тэр дороо л Монгол аймгуудын нутаглах Алтайн нурууны чанадаас Алтан улсыг хүртэл тарж үүнтэй цуг Боржигон аймгийн залуу толгойлогч Тэмүжиний нэр түгэн бүгдийн чихийг дэлдийлгэж, сэтгэлийг гижигджээ.

Нэн ялангуяа дайны олзноос татгалзан Хэрэйд аймгийн Тоорил хантай аймшиггүй зөрчилдсөн залуу Тэмүжиний зориг, хийморийн тухай домог шиг яриа амнаас ам дамжин энэ

тулалдааны гол чимэг болж байлаа.

Тэмүжин тарж бутарсан Боржигон аймгийнхны төдийгүй сүйрч олзлогдсон Мэргэд аймгийнхны дунд ч чин шударга, дайчин эрийн үлгэр болон яригджээ. Талын нүүдэлчин аймгууд хамгийн эрэмгий зоригтой нэгнээ тодруулан түүний ивээл хамгаалал дор нэгдэн амьдрах боловч сонгосон толгойлогч нь харгис хэрцгий, шунахай дарлагч байх нь нэгэнт элбэг тул сонгосон удирдагчаасаа салан тусгаарлах хүсэл үргэлж бэлэн байх бүлгээ.

Аймаг, овог бүр ухаантай, хүчтэй, өгөөмөр, энэрэнгүй шинэ удирдагчийн мөнхийн эрэлд амьдарна. Бас өөрийгөө зоригтой эр чадалтайд тооцох эрс бүхэн бяцхан ч гэлээ удирдагчийн байр суурийг эзлэхийн төлөө мөнхөд өрсөлдөж бие биеийг хөнөөсөөр ирсэн ажээ. Есүхэй баатрын үхлээс хойш тал талд өөрийн садан төрөл ч юмуу, хамгаалж чадна гэж найдсан хэн нэгнийг даган тарсан Боржигон аймгийнхан, юуны түрүүн Есүхэйн хамаатан, хуучин албат боолууд нь эргэн ирэх болсон нь Тэмүжиний зориглон, төлөвлөснөөр хийгдсэн анхны тулааны хамгийн том олз байв. Эх болоод дүү нар нь Тэмүжинг бахдан биширч байлаа.

Тэмүжиний гэр бүл дахиад л албат, харц, агт морьтой болж, анх удаа Тэмүжин өөрийн мэдэлд хагас түмэн цэрэг дайчлах боломж бүрдлээ. Тэмүжинийг ер ийм ухаан гаргана гэж хэн ч санаагүй билээ.Олон бүгдээр хязгааргүй их баяр жаргалд автжээ.

Харин энэ баяр баясгалан дунд Тэмүжиний гэрт Чилэгэр бөхийн хөвүүн өсч торниж байлаа. Бөртийн төрүүлсэн хүүхэд хөвүүн байсан нь үхэж үрэгдсэн Чилэгэр бөхийн хүслийг тэнгэр таалсан хэрэг болжээ.

Бөртийн хүүхдийг алсангүйд Боорчийг Тэмүжин ер зэмлэсэнгүй.Бүр яагаад ингэх болсныг Тэмүжин хүний урманд сөхөж асуусангүйд Боорчи эхлээд гайхан алмайрчээ. Хэрэв асуусан бол Бөртийн хүүхдийг амьд үлдээснээ өмгөөлөх шалтаг Боорчид байгаагүй ч бас энэ хүүхдийг амьд үлдээсэндээ огт харамсахгүй байжээ. Тэр бүү хэл Тэмүжин уурсан хилэгнэж элдэв хэрүүл үүсгэвэл ямар боловч Бөртийн хүүхдийг хамгаална гэж хатуу шийдсэн билээ. Ингэх нь хэдий осолтой,бүр өөрийнхөө амийг алдахад ч хүрч мэдэх байсанч Боорчи өөрийн шийдвэрээс ухрахыг хүссэнгүй. Гэтэл Тэмүжин өөрийн нууц зарлигийг ор тас мартсан мэт байсан нь Боорчид аврал болжээ. Тэмүжиний эл хачин аашны учрыг Боорчи олсонгүй.

Харин Тэмүжин тэр хүүхдийн тухай хором ч мартсангүй ажээ. Өөрийг нь ялагч баатрын дүрээр ёслол хүндэтгэл дүүрэн угтан авсан Өүлэн болоод Бөртийг хармагц тэр үедээ Тэмүжин тулгамдаж нэрэлхээд энэ тухай яриа өдөөж төдсөнгүй билээ. Тэгээд ч Бөртийн төрүүлсэн хүүхдийг Өүлэн эх нь энхрий дотноор тэврэн зогссон нь яавч энэ хүүхдийг алж болохгүй гэдгийг Тэмүжинд шууд ойлгуулсан бас Өүлэн эхийн зүгээс тулгаж шаардсан хэрэг байв.

Тэмүжин үүнийг яаж ойлгохгүй байх билээ.Хэрэв түүний хэлснээр Боорчи энэ хүүхдийг замдаа хөнөөсөн бол одоо чухам юу болох байсныг Тэмүжин төсөөлөн бодоод өөрийн эрхгүй Боорчид баярлажээ. Хэрэв гай болж Бөртийн хүүхдийг хөнөөсөн бол Тэмүжин Өүлэн эхийнхээ дайсан болон хувирах байснаа мэджээ.

Тэр шөнө Тэмүжин Бөртэ хоёр үлдээд бие биендээ хүрч чадахгүй удаан сууцгаав.

Хагацсанаас хойш жил гаран өнгөрч тэдний хамтын амьдрал дахин эхлэв.Нярайлж тэнхэрч амжаагүй хэдий ч Бөртийн гоо үзэсгэлэн улам тодроод хувцсаа нэвт гэрэлтэн байх нь Тэмүжиний тэвчээр тачаалыг нэгэнт барагдуулж тэр хайртай Бөртийгөө тэврэн авчээ.

Зөвхөн Тэмүжиний ингэхийг хүлээж байсан Бөртийн дур хүсэлд хязгаар байсангүй.

Тэд хоюул яг л анхны шөнийнх шиг галзуурсан тачаалд автаж төдөлгүй Бөртэ дур хүсэл нь ханахдаа бахардан хашгираад ухаан алдан унав.

Бүх зүйл өөрчлөгдөөгүй мэт санагдаад Тэмүжин Бөртийн нүцгэн биеийг ширтэн суужээ. Бөртэ их удаж сэргэх шиг санагдав.

-Би ухаан алдсан уу гэж Бөртэ ичингүйрэн шивэгнээд Тэмүжиний толгой дохихыг үзмэгц түүнд гэнэн итгэмтгийгээр эрхлэн наалдаж -Би чамаас хагацсанаас хойш ер ингэж ухаан алдсангүй гэж инээмсэглэжээ.

Энэ үгэнд Тэмүжиний дотор унтаж байсан түмэн могой атиралдан сэрж зүрхийг нь хорт хэлээрээ хатган өвтгөсөнд тэр ухаанаа алдаад Бөртийн урт үсийг гартаа ороон атгаж түүнийг нэвширтэл балбаж гарчээ. Харин гайхалтай нь Бөртэ Тэмүжинийг яг ингэнэ гэж мэдэж байсан мэт зодуурыг ганц ч удаа ёо гэсэнгүй тэсч өнгөрөөжээ.

Сэтгэлийн мухарт хуримтлагдсан өшөө хорсол, шаналалдаа шатсан Тэмүжин Бөртийг алчихаж мэдэх байв. Гэтэл хүүхэд гэнэт цочин сэрээд айж түгшин учиргүй бархирсанд Тэмүжин ухааран Бөртийг орхиж холдов. Эхийнхээ хөхийг шуналтайгаар ховдоглон сорох улаан нялзрай тэр амьтанг Тэмүжин үнэн сэтгэлээсээ хорсолтой ширтэж сууснаа өнөө шөнө Бөртэ тэр хүүхдээсээ хөндийрэхгүйг мэдээд даруй хувцаслан гарчээ.

Хүйтэн харанхуй тэнгэрийн дор ганцаар зогсож байхдаа энэ хүүхдэд Бөртийгөө үүрд алдсан мэт харуусалд эзлэгдсээр байв. Гэвч Тэмүжинд Бөртийг хөөн явуулах юмуу түүнээс холдон зайлах газар даанч байсангүй. Бөртийн эелдэг урин зан,энхрий тачаангүй биед татагдан гэртээ буцан оржээ.

Шөнө бүр Бөртэтэй янаглан цэнгэхдээ мэргэдийн Чилэгэр бөхийн удмын бяцхан хөвүүний амьсгаа харцыг мэдэрч бухимдахдаа дур ханаж, бие хөлс хатсан хойноо Бөртийг хайр найргүй балбаж, хоёр хөхийг нь хөх няц болтол базаж тамалдаг байв.

Гэвч Бөртэ хүний урманд ёо ч гэж дуугарахгүй шүд зуун тэвчдэг нь эцэстээ Тэмүжинийг туйлдаж ядрахад хүргэж дэрэндээ нүүрээ шигтгээд гаслан хэвтэхэд Бөртэ түүний нүцгэн мөрөнд нүүрээ наагаад чив чимээгүй мэгшин уйлдаг билээ.

Тэмүжин тэр хөвүүнийг хүн гэж тоож харахаас нүд хорсдог,өөрийн ойр хэвтүүлэхээс ч цээрлэн жигшдэг байв. Тийм ч учраас Бөртийн хөвүүнд нэр өгсөнгүй, өгнө гэж бодсон ч үгүй.Бөртэ ч энэ талаар сөхөж ярисангүй. Харин Өүлэн эх шинэ хөвүүндээ нэр өгөхийг туйлбартай хатуу шаардсаар байсанд аргаа барахдаа

– Та өөрөө мэд гэжээ.

- Тэгвэл Зүчи гэж нэрлэе гэж Өүлэн эх хэлэв. Энэ нь зочин гэсэн үг байв. Энэ нэр Тэмүжинд таалагдав.

Мэргэдийн Чилэгэр бөхийн хөвүүн тэдний гэрийн зочин болог гээд бодоод тайвширч Бөртийн хөвүүнд Зүчи гэдэг нэр өгөв. Зүчи нэрийг өгсөн нь шинэ хөвүүнд Тэмүжиний гэрт амьдрах эрх олгосон хэрэг болов. Хэдийгээр жижиг ч гэлээ энэ явдал Тэмүжин Бөртэд ялагдан бууж өгсөний дохио,Бөртийн хатуужилтай эрэмгий занг тэнгэр ивээсэн хэрэг юм. Гаднаас харахад аз жаргалтай мэт боловч тэр гурав туйлын шаналгаат хайрын дунд амьдарч байлаа.

Гэрийн дотрох ил далд зовлон, сэтгэлийн гүн дэх шаналал хорсол нь Тэмүжинг гэрт тогтоход бэрх болгоход тэр сэм хол одож энэ тэр бүсгүйг эдлэн уур хорслоо тайлдгийг Бөртэ мэдэвч юу ч эс дуугарна. Бөртэ Зүчи хөвүүнээ эм арслан мэт өмгөөлөн хамгаалах тул Өүлэн болоод ер нь хэн боловч Зүчид их анхааралтай ханддаг байв. Хэрэв Өүлэн эх Бөртэ болоод бяцхан Зүчи хөвүүнийг хайрлан дэмжээгүй бол азгүй хөвүүний хувь заяа яаж эргэхийг таахын аргагүй юм. Тэмүжиний зан аашийг мэдэх Өүлэн эх нь Зүчийг хамгаалах болсон нь Тэмүжинг аймшигт үйлдлээс сэргийлж Боорчийг хүртэл хязгааргүй нүглээс аварсан билээ.

Хэрэв Тэмүжин Зүчийг хөнөөсөн бол тэр хэзээ ч өөдлөн дэвжингүй байсныг харин хэнч мэдэхгүй байлаа. Зүчи хөвүүний Тэмүжин Бөртэ хоёрт ирсэн учрыг Тэв тэнгэр бөө сүүлд хэлжээ. Зүчийг амьд үлдээсэнд нь Тэнгэрт бас Боорчид талархах ёстой гэж Тэв тэнгэр бөө батлан хэлсээр байсан ч Тэмүжин өөрийн сэтгэлийг тэр бүр тэвчин барьж дийлэхгүй бяцхан Зүчи хөвүүнээс тахалтай амьтан мэт сэжиглэсээр байв. Өүлэн эхийн илэрхий дэмжлэгийг олсон Бөртэ сэтгэл бага боловч тайвширчээ. Хэн ч Зүчийг мэргэдийн хүүхэд гэж хэлдэггүй бөгөөд хэрэв хэн нэгэн тэгэж гэмээ нь Бөртэ өршөөхгүйг бүгд мэдэх болжээ.

-Чи Зүчи хөвүүнийг минь ад үзвэл эхлээд намайг алчихаарай. Би хөвүүнээ ад үзэхээс бусдыг тэвчинэ. Харин хөвүүнийг минь ад үзвэл би тэвчихгүй шүү гэж Бөртэ ээлжит чимээгүй тамлалын дараа хатуу хэлсэн нь бий. Бөртэ үнэхээр хэлсэндээ хүрч маргааш нь Зүчи хөвүүнээ тэврэн огт юу ч болоогүй юм шиг инээд хөөр дүүрэн явахад нь Тэмүжин гайхан биширч өш хорсол нь дарагдах шиг болдог байлаа. Тэмүжинийг Боржигон аймгийн ханаар өргөмжилсөн нь байдлыг өөрчилж авгай хүүхний гашуун бодлыг өөрийн эрхгүй хойш тавихад хүргэж, өөрийн зан авир, үг үйлдлээ нягт хянан засах нь зайлшгүй болжээ. Тэмүжин өөрийн аймгийн албат иргэдийг хоёр хуваан баруун зүүн түмэн болгож ,үнэнч нөхөд Боорчи, Зэлмэ хоёроор ахлуулан олон хэргэм тушаалтныг томилж, Бөртийн хэлснээр гоёмсог өргөө бариулж, хөнгөн тэрэг ч хийлгэв.

Бүх хүмүүс Бөртийг түүний адил хүндэтгэдэг болсон нь өөрийн эрхгүй Тэмүжинд мэдрэгдэж байв. Бөртэ бол яг л Тэмүжинд тохирсон эрмэг зоримог бүсгүй байлаа. Тэд эвлэрч, их албын дараа шинэ өргөөндөө эрхлэн янаглах болсноор Зүчийн хойно Тэмүжиний цусны хөвүүн Цагадай төрсөн бүлгээ. Цагадай хөвүүнээ төрөхөд Тэмүжин Бөртийгөө дахин тамлан зовоохгүй гэж ил тодоор түүнд амлан тангарагласан билээ. Тэр энэ үгэндээ хүрсэн юм.

Тэмүжиний гэрт түүнийг залгамжлан Боржигон аймгийн хан болох ёстой хөвүүн төржээ. Цагадай хөвүүнээ төрсөнд Тэмүжин туйлаас баярлаж их хурим хийв. Энэ найранд Тэмүжинг аймгийн ханд өргөмжилсөн ихэс,язгууртнууд болох Хабула ханы үр сад,Хотула ханы хөвүүд,

Есүхэйн дүү гээд задран тарж явсан Боржигон аймгийн нэртэй хүндтэй бүхэн, тэдний албад иргэд бүгд цугларч, Жамухын ойр төрлийн хүн болох Хорчи анх удаа олны сонорт Тэмүжинийг Чингис хаан гэж өргөмжлөе гэж дуулгасныг олон бүгдээр зөвшөөрсөн билээ.

Чихэнд дасал болоогүй дэндүү сүржин энэ цол их асарын хоймор анх удаа Зүчи хөвүүнээ өвөр дээрээ тэврэн суусан Тэмүжинд огт таалагдсангүй ч олны үг саналыг дуугүй сонсож байлаа. Чингис хаан гэж нэр өргөмжлөгдөхөөс илүү чухал зорилго тэр үед Тэмүжинд байв. Олны өмнө тэр анх удаа Зүчи хөвүүнээ өвөр дээрээ тэврэн сууснаар Бөртийн сэтгэлд байсан гомдлын хар сүүдрийг арчин хаях ёстой гэж бодож байв.

Юуны өмнө өөрийн өрх бүлийг түвшитгэх нь өнөөдрийн гол зорилго юм. Цагадай хөвүүнээ хөхүүлэн суусан Бөртэ шиг аз жаргалтай хүн энэ найрын дунд байхгүй байв. Онон голын шугуйн дунд зассан найрын задгай талбай идээ будаагаар дүүрэн залуус охид бүжиглэн дуулж Есүхэйн үхлээс хойш Хиадборжигон аймгийнхан анх удаагаа нэгдэн сэтгэл тэнэгэр цэнгэх бүлгээ.

Ээж дүү нараа ийм сэтгэл баяртай харц дээгүүр байхыг Тэмүжин ер үзсэнгүй. Найрын дунд Өүлэн эхийнхээ нүдэнд гялалзах нулимсыг үзээд

– Хамгаас зовсон нь эх минь юмдаа гэж бодохдоо уярч Тэмүжиний нүд чийгтэж суужээ.

Дүрэлзэн асах их түүдэг галын утаа Ононы эрэг дагуу хөшиглөж, хуурын дуу хүнгэнэн эгшиглэх нь газрыг дүүргэнэ. Монголчуудын жаргал цэнгэл нь дуу бүжиг, найр билээ. Харин энэ найрын хамгийн хүндтэй зочин байх ёстой гэж Тэмүжиний тооцож урьсан Хэрэйд аймгийн Тоорил хан, Жадаран аймгийн Жамуха хоёр ирсэнгүй нь түүнийг түмэн бодол, мянган эргэлзээнд унагав. Жил хагас хамт амьдраад салж нүүсэн ч Тэмүжин Жамухыг анд нөхрөө гэж үзсээр ажээ.

Хамгийн ил тод зүйл нь Тэмүжиний санаандгүй олсон амжилт, Боржигон аймгийн ханд өргөмжлөгдсөн зэрэг нь хуучин холбоотнуудад нь таалагдсангүй. Өгөөмөр сэтгэлтэй хамсаатан нь нүдний нь өмнө өст дайсан болон хувирч байгааг Тэмүжин мэдэрч байв. Өөрийгөө хэн байсныг, одоо хэн болоод байгааг, тэдний адил эрх дархтай, цэрэг зэвсэгтэй бие даасан аймгийн хан болсноо тэдэнд үзүүлье гэж санасан ч тэд үүнийг түүнээс урьтан аль эрт мэдсэн, тэр бүү хэл одоо дайсан биш юмаа гэхэд өрсөлдөгчөө гэж үзэж байгаа нь илт. Энэ явдал нэг талаас бахтай ч нөгөө талаас хажуу хавиргандаа дайсантай амьдрах гэдэг чонын сүрэг дунд гар хоосон зогсоо юм шиг л санагдана. Жамухын дэргэд байсан Хиад, Боржигон тэр бүү хэл Тайчууд, Жүрхэн гээд хуучин овгууд бүгд салж Тэмүжинд ирсэн нь Жамухын эгдүүцлийг юу юунаас илүү төрүүлж байлаа.

Өдрөөс өдөрт өсч байсан Тэмүжиний нэр хүнд олон хүнийг түгшүүлж байв. Илүү нийтэч, ядуу зүдүү явсан, нөхдийнхөө гавьяа зүтгэлийг шударгаар харамгүй үнэлж чаддаг нь Тэмүжинийг бусдаас ялгаруулж, түүний нь амьд баталгаа болсон жирийн ардын хөвүүн Боорчи, боол Зэлмэ гээд олон нөхөд нь одоо хүндтэй ноёдын зэрэгт залагдан Тэмүжиний санаж сэдсэн бүхнийг удирдан хэрэгжүүлж Монголын тал нутагт байгаагүй содон сонин зохион байгуулалт бүхий аравт, зуут, мянгат цэргийг засч, суурин ордны ажлыг дэглэн хөгжүүлж байгаа нь бүгдийн нүдэнд илт байлаа. Тэмүжин Боржигон аймгийнхны хүсч

байсан шинэ удирдагч мөн нь гарцаагүй байв. Тэмүжиний үзэж өнгөрүүлсэн өнчин ядуу амьдрал, энгийн хээгүй занд олноор татагдаж байлаа. Зүчи хөвүүнээс үүдэлтэй Бөртэ Тэмүжин хоёрын зөрчил аймаг улсаа төвхнүүлэх их ажлын дунд дарагдан гэрийн дотор таатай уур амьсгал бүрдэж Зүчийн мэргэд гарлыг бараг мартаад байтал нэг ноцтой явдал болжээ. Тэмүжиний гэнэтийн олсон ялалтад атаархан өөрийн дэргэд байсан Боржигон аймгийнханаар ч зогсохгүй хамаатан саднууд нь хүртэл салж Тэмүжинд очиж нийлсэнд Жамухын хорсол туйлдаа хүрчээ.

Гэтэл энэ үед Жамухын дүү Тайчирыг адуу дээрэмдсэнээс болж Тэмүжиний талын хүн харваж алсан хэрэг мандав. Ийм явдал болсон нь дайсагнан довтлох шалтаг эрэлхийлж байсан Жамухад сайхан далим болжээ. Жамуха цаг алдалгүй шуурхайлан хөдөлж цэргээ засан Тэмүжиний хүрээг дайрав. Аймаг дотрох хүчээ бэхлэж амжаагүй дөнгөж нэгдэж тогтсон Тэмүжиний цэргийн хүч сул байгаа нь дороо л мэдэгдэж Боржигон аймагт үхлийн аюул тулсан билээ.

Жамухын дайтаж сурсан цэргийн өөдөөс Тэмүжиний цөөн цэрэг эсэргүүцэл үзүүлж чадалгүй хэдхэн хоногийн дотор цохигдон бутарчээ. Энэ тулааны үед Тэмүжин үлдсэн цөөн цэрэг,үнэнч нөхдийн хамт Ононы дээд биений Зээрэн хавцалд шахагдан оров. Харин Зээрэн хавцлын аман талд Жамухын цэрэг Тэмүжинг хавцлаас гарахыг хүлээн тайван бүслэн суув.Онон мөрний Зээрэн хавцал ингэж үхлийн уут,Боржигон аймгийн сүүлчийн авс болон хувирав. Энэ бол Тэмүжиний хувьд үхэл,Боржигон аймгийн хувьд сүйрэл болох юм.Жамухыг ингэж андын тангарагаа эвдэн довтлоно чинээ Тэмүжин санаагүй билээ.

Адуу хулгайлсан нь Жамухын дүү Тайчирын буруу атал ийм хэргээр шалтаглан довтолсон нь Жамухын далд хортой бодлыг илчилжээ.Жамуха Тэмүжинг даран сөнөөхийг хүсч байсан нь тодорхой болов.Жамухад итгэж болохгүй хүн гэж Бөртө өдөр тутам сануулсаар байхад түүний энэ сэрэмжлүүлэгийг эм хүний богино ухаан,бодлогогүй үг гэж үл тоомсорлож байсандаа харамсавч оройтжээ.

Үнэндээ Тэмүжин сэтгэлийн гүнд Жамухад итгэж бүр түүнээс салсандаа өөрийгөө буруутган зэмлэсээр байжээ.Жамуха бол хань болохгүй гай зовлон учруулах нөхөр гэж Тэв тэнгэрийн хэлсэнд ч итгээгүй юм.Жамухын гэнэт довтолсон нь Тэмүжинд сэтгэл санааны аймшигт цохилт авчирав. Ганц үнэнч холбоотноо гэж итгэж андгай тангараг тавьсан Жамуха адууны хулгайн өчүүхэн хэргээр шалтаглан довтолсон нь Тэмүжиний бодол санааг гүнзгий ихээр хувиргав.Тэр хэнд ч бат хатуугаар итгэн найдаж болохгүйг ухаарчээ. Жамухын довтолоход Тэмүжин гэр орон,хөвүүдээ золоор дүрвүүлэн зугатаалгаж амжив.

Тэгээгүй бол түүний хөвүүд Жамухын олз болоход ойрхон байсан билээ.

Тэмүжин ийм түгшүүрт мөчийг урьд нь үзээгүй мэт санагджээ. Гавшгай зоригтой боол Татугийн ачаар гэр бүлээ үхлээс зайлуулж чадаад Татуг түүнд илгээсэн Тэнгэрт талархан мөргөв. Жамухад цохигдон зугатсан Тэмүжин нар сураг тасраад удав.

Онон мөрний дунд хэрд уулын балар ойд Өүлэн эх, Бөртэ хоёр хэдэн хүүхдийнхээ хамт Зүчийн боол Татугийн хамгаалал дор орогнон хоргодож, хэзээ Тэмүжин үхэв гэж сонсдох бол гэж түгшин хоног өдрийг өнгөрүүлж байлаа. Энэ үед Зүчи арван гурван нас хүрч хөвүүдийн

бага Тулуй найман настай, гурван охин нь нялх, бага нь бүр хөхүүл байжээ. Зүчи Цагадай хоёр ойрхон зуур сум харвахтайгаа л болжээ.

Энэ балар ойн гүнд тэднийг хамгаалан яваа цөөн цэргийн толгойлогч загасан нүдэт Тату хэмээгч эр бол Тэмүжин өөрийн амь биеийг хамгаалуулахаар хамгийн анх сонгон авсан хамгийн шилдэг арван цэргийн нэг юм.

Харин хэдэн жилийн өмнө Тату осол гаргаж ашгүй Зүчийн гуйсны ачаар Тэмүжин түүнийг цаазаар авах ялаас өршөөж нэг насаар нь Зүчид боол болгон өгсөн бөгөөд одоо ч эзнийхээ амийг сахин суугаа нь энэ билээ.

Хэзээ ч үл анивчих, үл унтагч загас мэт нүдтэй энэ Тату үнэхээр туйлын ээдрээтэй хувь зохиолтой нэгэн юм. Харин түүний чин үнэнч зүтгэлд Зүчи бүү хэл Тэмүжин ч эргэлзээгүй итгэдэг байв.Тийм учраас Тэмүжин эх, эхнэр, хөвүүдийнхээ амь насыг ганцхан Татуд найдан даатгасан нь энэ юм.

Тату бол Зүчийн өмнөөс үхэх ёстой боол билээ. Тэр Зүчээс алхам ч үл холдоно. Татуг дэргэдээ байхад Зүчи бардам итгэлтэй байдаг бүлгээ. Жамухын цэргээс дүрвэхдээ авч гарсан жаахан хүнс нь барагдаж ашгүй Зүчи нэг гөрөөс алсан нь бөөн баяр болж байтал тэр үдэш ядарч туйлдсан Тэмүжин ганц Зэлмийн хамт үлгэн салган иржээ. Тэмүжиний шаналж зүдэрсэн царайг үзмэгц амьд үлдсэн нь яамай гэсэн бодол бүгдэд нь төрж байв. Тэмүжиний царайнаас харахад Боржигон аймгаа алдаж, тэдний гунигт өнчин амьдрал дахин эхлэжээ гэдгийг гадарласан Өүлэн үг сүггүй нулимс урсган дэмий л

– Дүү нар чинь яав гэж шивнэж чаджээ. Тэмүжин ингэж ганцаар хоцорсон байхад дүү нар нь лав үхээ биз гэж Өүлэн бодсон билээ.

-Дүү нар мэнд байгаа. Бид Жамухын цэрэгт хавчигдан Ононы доод биений Зээрэн хавцалд шургаад байна. Би нэг хэргийг Бөртэ чамтай зөвлөхөөр ирлээ гэж Тэмүжин аяархан хэлэв. Өүлэн энэ үгийн дараа бага боловч тайвширч Зүчи, Цагадай хөвүүдийг авч холдов.

-Чи нөхдөө орхиж юунд морио эцэж ирэв. Уймарч түгшсэн би чамд зөвлөх хэрэг юу билээ гэж Бөртэ болгоомжлон хэлэхдээ сэтгэлийн угт муу зөн совин ургахыг мэдэрлээ. Бөртийн зөн совин түүнийг хэзээ ч хуурч байсангүй нь түгших,айхын үндэс болжээ. Хүйтэн цай завьжаараа савируулан залгилах Тэмүжинг харахад сайн юм бодогдох аргагүй байв.Бөртийн доод зовхи хоюулаа зэрэг татаж эхлэв. Тэмүжин дуугарахгүй удах нь бүр сэжиглэлтэй.

-Ийм хэргийг би чамтай зөвлөхгүй яаж шийднэ. Одоо би эцэж цуцаж зориг мохсон цөөхөн цэрэгтэй хоцров. Яавч Жамухыг дийлэхгүй. Жамуха хавцлын аманд намайг өөрөө гарч ирэхийг хүлээн бардам сууж буй. Би нэг арга сэдлээ. Гэвч би үүнийг чиний зөвшөөрөлгүй хийж чадахгүй. Энэ бол Боржигон аймгийн төлөө юм шүү гэж Тэмүжин жаахан тайвшран цангаа тайлж хөлсөө арчин хэлэв. Тэр үнэхээр зориг мохож зүс царай алджээ.

Тэмүжиний ийм уруу дорой байхыг Бөртэ урьд нь үзсэнгүй. Тэмүжиний сэдсэн зүйл чухал гэдэгт Бөртэ огтхон ч эргэлзсэнгүй. Тиймгүй бол Тэмүжин юунд нааш цаг үрж, амиа золиослон ирэх билээ. Яг энэ мөчид анх есөн настай Тэмүжинг өрөвдөн харж байсан нь

өөрийн эрхгүй санагджээ.Тэгмэгц уймарсан олон бодлоо хүчээр хөөн зайлуулж Тэмүжинд туслах хүсэл нь оргилж

-Тэмүжин. Чи хэлэгтүн. Бүү санаа зов. Гэвч миний чадах юм юу байх билээ гэж Бөртэ хэлэхдээ сэтгэл нь яагаад ч юм бэ тайвширч чадахгүй түгшүүрлэсээр байхыг мэдэрчээ.Бөртийн зоримог байдал Тэмүжиний эргэлзсэн,болгоомжилсон сэтгэлийг амраав.

Хэрэгтэй үгийг яг цагт нь олж хэлж чаддаг Бөртийн энэ занг Тэмүжин мэдэж хүндлэдэг билээ.

-Бөртэ. Би Жамухад эртний тавьсан нөхрийн тангаргаа дахин нэг сануулж үүний баталгаа болгож хөвүүдийнхээ ахмадыг Жамухын хүрээнд илгээе. Тэр үүнд итгэнэ. Зүчийг тэдний хүрээнд байхад тэр лав намайг дайрна гэж бодохгүй.

Хөвүүдийнхээ ахмадыг илгээх нь тангаргийг сануулах эртний ёс юм. Тэмүнийг ингэж хэлнэ гэж даанч санаагүй тул Бөтрэ эхлээд цочин алмайрав. Тэмүжиний гуйсан, шаардсан эл үгсийг ойлгомогц Бөртэ сэтгэл, нулимс хоёроо тэвчин барьж дийлсэнгүй, эхэр татан уйллаа. Эм хүний охор ухаандаа тэр дийлджээ.

-Чи Зүчи хөвүүнийг минь юунд ад үзнэ. Чи түүнийг бүү үхүүлээч. Жамух та хоёрын тавьсан тангараганд Зүчи хөвүүн минь ямар хамаатай юм бэ. Зүчийг үзэв гээд Жамухын сэтгэл хувирна гэж үү. Чи юунд ингэж намайг зовооно вэ. Чи ядаж Зүчи хөвүүнийг минь өөрийгөө хамгаалах насанд хүргээч. Би гуйя. Би Зүчи хөвүүнээ явуулахгүй. Явуулъя гэвэл чамд дүү нар, нөхөд чинь байна. Чи юунд миний өнчин балчир хөвүүнийг онцлов гэж Бөртэ бухимдан нулимстайгаа холин шивнэв. Хэдийгээр Бөртэ сэтгэл бахардаж, ухаан уймарсанч хэрүүлийн муу үгээ ойрмог модны дор суух хөвүүддээ сонсогдохоор хашгирсангүй тэвчиж чаджээ.

Гэвч Зүчи, Цагадай, Өгөдэй,Тулуй дөрөв эх эцэг нь тэдний хувь заяатай холбоотой ноцтой яриа өрнүүлснийг мэдэрч чимээ гарвал хамар татан ухасхийн зугатаж одоход бэлэн зэрлэг гахайн торой шиг өндөлзөж,сэрвэлзэж сууцгаахыг Тэмүжин үзэж зүрх нь шимшрэн энэ хэдэн хөвүүн түүнд ямар их үнэтэйг дахин ойлгов.

-Бөртэ тайвшир. Хөвүүддээ нулимсаа бүү үзүүл. Энэ бол гагцхүү манай Боржигон аймгийн төлөө юм. Ам тангарагийн баталгаа болгож ахмад хөвүүнээ илгээхээс өөр арга надад алга. Би Зүчийг ад үзсэн зүйлгүй. Зүчи бол миний ахмад хөвүүн учир ингэж хэлж байна. Одоо л Жамухаас цэргээс амьд мултрахгүй бол би ч, чи ч, миний хөвгүүд ч, Боржигон аймаг ч үүрд үгүй болно. Боржигон аймгийн төлөө амиа өргөх нь тийм ч муу юм биш. Чи ингэлээ гээд бүү харамс. Боржигон аймгийн төлөө олон олон Зүчи амиа өргөх биз. Боржигон аймгийн төлөө амиа өргөвөл Зүчи харин ч жинхэнээс Боржигон аймгийн хүн болно гэж Тэмүжин Бөртийг ятгав.

-Тэгвэл би Зүчи хөвүүнтэйгээ хамт явна. Жамуха намайг үзээд лав тайвшрах биз. Би Зүчи хөвүүнийхээ төлөө юу ч хийхэд бэлэн байна. Ганцхан түүнийг минь, Зүчийг минь алчихвал яана гэж хэлэхдээ Бөртэ нулимсаа тэвчин барьж дийлэхгүй байлаа.Тэмүжин Бөртийн эсэргүүцэл,бухимдлыг сайн ойлгож байв.

Зүчи хөвүүн Бөртэд ямар үнэтэйг ч мэднэ. Тэмүжин Бөртийн сэтгэлийн хөдлөлийг дарагдтал дахин дуугарсангүй хэсэг чимээгүй суув. Үүнээс шилдэг аргыг тэр олсонгүй. Тэмүжиний хүнд байдлыг ойлгосон Зэлмэ хүүхдүүдийг сатааруулах гэж өөрийн нум сумаар бай харвуулан аргацаах ажээ.

-Тэгвэл. Бөртэ! Зүчи, Цагадай хоёрыг цуг илгээе. Чи зөвшөөрөх үү гэж Тэмүжин Бөртийг уйлахаа болимогц аяархан хэлэв.Бөртэ ийм үг сонсоно гэж санасангүй. Тэмүжин уярч ойлгоод Зүчийг явуулахаа болино гэж итгэж байсан билээ. Энэ бол Бөртийн амьдралдаа сонссон хамгийн аймшигт үг байв. Гэвч Тэмүжин чухам юуны төлөө ийм үг хэлж байгааг ойлгохыг хүчлэн оролдож байлаа.

-Хөвүүд чинь чамд хайран биш үү гэж Бөртэ өөр арга зам хайгаач гэхдээ итгэл муутай ч эсэргүүцэхийг оролдов.

-Тиймээ надад хайран байна. Аймшигтай ч байна. Сүүний үнэр арилаагүй нялх үстэй хөвүүдээ алдахад надад даан ч харамсмаар байна. Олж цуглуулсан цөөн улс минь Жамухын цэргээс сүрдэн тарж байна. Би л үхвэл одоо бүгд сүйрч Боржигон аймаг маань үүрд Жамухын олз болно. Одоо би ямарч үнээр хамаагүй Жамухын савраас мултрах хэрэгтэй байна. Надад нэг ч хором болов амь шиг үнэтэй боллоо гэж ний нуугүй үнэн бодлоо хэлэв.

-Тэмүжин. Бид энд өрх бүлээрээ эрүүл саруул, элэг бүтэн байна. Нуугдан суувал нэг учир биш үү.

-Чи дэмий үг бүү чалч. Бөртийн энэ тэнэг ухаангүй,аргаа барсан эм хүний үг зөөлөн хүлээцтэй байсан Тэмүжиний уур хилэнг гэнэт бадрааж тэр тэвчиж чадсангүй босон харайв.

-Чи намайг нөхдөө хаяж амиа бод гэв үү. Чи яаж ингэж хэлж чадна гэж өндөр дуугар хашгирсан ч ойртон ирж яваа Өүлэн эхээ үзээд Тэмүжин хүндээр амьсгаадан биеэ барилаа. Тэр хурдан тайвшрав.Одоо байдлыг хурцатган Бөртийн уур бухимдлыг дахин оволзуулахгүй байх нь зөв гэж боджээ.

- Би юу ч болсон хөвүүдээ Жамухын гарт зүгээр орхихгүй.

- Тиймээ. Зүчи, Цагадай хөвүүд минь үхэж үрэгдэж мэднэ. Гэвч надад дахиад Өгөдэй, Тулуй хоёр хөвүүн минь үлдэнэ. Бас Боржигон аймаг үлдэнэ. Боржигон аймаг надад хөвүүдийн минь амьнаас ч үнэтэй юм. Тэмүжиний энэ үг хатуу ч үнэн үг байв. Хэрэв Боржигон аймаг үгүй бол Тэмүжин Бөртэ хоёр хичнээн ч хөвүүдтэй байгаад юуны гавьяа билээ. Бөртэ удаан бодлоо. Тэмүжин ч тэвчээртэй хүлээв.Тэмүжин өөрийн шийдвэрээс хэрхэвч буцахгүй нь тодорхой байлаа. Тэр Бөртийн хоёр хөвүүнийг булаан авч үхэлд шидэж өгөхөөр нэгэнт шийджээ.

-Би шөнө буцаж очих ёстой гэж Тэмүжин унтарсан галын үнс хутгах зуур хэлсэн нь яарч буйгаа илэрхийлсэн хэрэг байв. -Хөвүүдээ дуудах уу гэж Бөртийг хэлэхэд Тэмүжин

-Бөртэ чи зөвшөөрч байна уу гэж баярлан дуу алдав.

-Тэмүжин! Би зөвшөөрч байна. Бидэнд бас Өгөдэй, Тулуй хоёр хөвүүн байгааг би мартжээ. Тэмүжин Бөртийг хайрлан тэврэв. Тэмүжин энд эцгийн нас барснаас хойш анх удаа уйлав. Чухам яагаад уйлснаа тэр мэдсэнгүй. Юутай ч халуун нулимс нь хацар даган урсч байв. Гэвч хатуу сэтгэлт Тэмүжин өөрийн нулимснаас огтхон ч ичсэнгүй. Магадгүй, хайртай хөвүүдээсээ хагацахад Бөртэд хичнээн хүнд болохыг ойлгоод тэр биз. Эсвэл голоос хайртай Цагадай хөвүүнээ явуулахад Тэмүжинд үнэхээр аймшигтай,харуусмаар байсан ч юм уу.Ер нь яагаад нулимс урсгасанаа ойлгосонгүй. Харин Зүчийг илгээхийн тулд хөлийг нь амандаа үнхэж өсгөсөн хайртай Цагадай хөвүүнээ золиослохоос өөр арга Тэмүжинд үлдсэнгүй.

Хэрэг явдал нэгэнт шийдэгдсэн тул Бөртэ Өүлэн эхийн хамт гөрөөсний мах шарж тэд халуун ам бүлээрээ хооллов. Зэлмэ нэгэнт хэргийн учрыг мэдэж байсан тул нэг ч үг дуугарсангүй холгүй модны ёроолд суугаад мах зулгааж байв. Зэлмэ угаас Есүхэйн унаган боол тул хэзээ ч илүү дутуу үг үл хэлдэг билээ.

-Хөвүүдээ дууд гэж Тэмүжин мах идэж цадаад булгийн хүйтэн ус залгилсны дараа хэлэв. Зүчи Цагадай хоёроо сүүлчийн удаа харж байж мэдэх ч Бөртэ ер шаналж харамссангүй. Түүний сэтгэл Тэмүжиний холын хатуу чанга зорилгыг ойлгож байлаа. Ийм юм үзэх гэж тэр Тэмүжинийг дагасан болохоор хөвүүдийнхээ үхэлд нэгэнт харамсан гашуудахгүй байхаар эрс шийджээ.

Өндөр биетэй Зүчи, бахим шаантаг шиг Цагадай хоёр нүдээ гялалзуулан эцэг эхийнхээ өмнө зогсоно.

Тэмүжин тэднийгээ хармагц гэнэт нялх балчир үрс нь өрөвдөлтэй, хайрлалтай санагдаад тэсэлгүй тэднийг элгэндээ наан тэвэрсэн билээ. Гэвч түүнд ухрах буцах зам нэгэнт үгүй болжээ. Хөвүүдээ элгэндээ тэвэрсэн Тэмүжинийг хараад Өүлэн Бөртэ хоёр нулимсаа барьж тэвчсэнгүй. Ямар гээч цаг үе хувь зохиолоор учирч төрсөн эцэг хөвүүд болохыг хэн яахан мэдэх билээ.

-Чиний хэлснээр Зүчийг ганцааранг нь явуулъя гэж Бөртийг хэлэхэд Тэмүжин удаан бодож суугаад

-Үгүй. Чиний хэлсэн зөв. Зүчийг ганцаар явуулбал Жамуха миний үгэнд итгэхгүй байж мэднэ. Зүчи, Цагадай хоёроо хамт явуулъя гэжээ. Ингэж Бөртэ хайртай хоёр хөвүүнээ үхэлд шидэж өгчээ.

Хөвүүд нь эцгийнхээ хэлэх үгийг цээжилж аваад эцгийгээ даган анд явж буй мэт бөөн баяр хөөр дүүрэн амьтад боол Татуг дагуулан мордоход Бөртийн хөлийн доорох газар цөмрөх шиг болсон ч хөвүүдээ айлгахгүйн тулд хүчээр инээж үдсэн билээ.

Тэмүжин ч удалгүй явав. Тэр шөнө Бөртэ уйлаагүй ч өөрийгөө энэ ертөнцийн хамгийн тэнэг эм гэж харааж хоножээ. Тэмүжинг Зүчийг ганцаар явуулъя гэхэд зөвшөөрч чадаагүй мөртөө Цагадайн хамт явуулъя гэхэд нь зөвшөөрч байдаг тэнэг эм надаас өөр үгүй биз гэж өнгөрсөн хойно өрөө өвтгөн шаналсаар байв. Гэвч хөвүүд нь эцгийнхээ өмнөөс үхэх ёстой бол үхэхээс гэж хатуу сэтгэл гаргаж байсан ч зүгээр хэвтэж эс чадаад босч Тэнгэрт мөргөж хөвүүдээ авран хамгаалахыг гуйжээ.Бөртийн Тэнгэрт мөргөн гуйсан нь талаар болсонгүй билээ.

Зээрэн хавцлын тулаан яг л Тэмүжиний санаснаар болов. Зүчи Цагадай хоёроор Тэмүжиний хэлүүлсэн үгийг Жамуха сонсмогц хоёр өдрийн дараа цэргээ татан одов.

Харин Тэмүжинийг гайхашруулж бүр бишрүүлмээр явдал болсон нь Зүчи хөвүүн нь Жамухын хүрээнд очоод хоёр хонохдоо нүд цавчилгүй байж чадаад дүүгээ дагуулан оргож ирсэн хэрэг юм. Энэ бол хэр баргийн овжин гавшгай цэрэг ч чадна гэхэд эргэлзмээр явдал тул Тэмүжин Зүчийг ихэд бахдан тоож, үүнээс улбаалан Зүчийн нэр олны дунд сүрхий алдаршчээ.

Гэвч Зүчийн ингэж чадсан нь боол Татугийн хүч байсныг хэн ч тооцсонгүй бөгөөд Тату ч Зүчи эзнээ аварснаа өөрийн гавьяа гэж дурдах эрхгүй байлаа.

Гэвч Зүчи үнэхээр гайхмаар сэргэлэн гавшгай залуу болон өсч буй нь Бөртийг нэг талаар баярлуулж нөгөө талаар түгшүүлнэ. Түгших учир түүнд байсан билээ.

Учир нь Тэмүжин өөрийн хөвүүн Цагадайг улаан цайм эрхлүүлж өөгшүүлэх бөгөөд Цагадайн зан ааш өсөж томрох тусам бардам дээрэнгүй, омголон догшин болж, Зүчийг ахыгаа гэж үл үзэн доромжлон дээрэлхэх нь энүүхэнд болсоор байв.

Зүчи, Цагадай хоёрын зөрчил хэрүүл Тэмүжиний нэр сүр өсөхийн хэрээр гүнзгийрч Зүчийн арван таван нас хүрсний хойно нэг өдөр Бөртийн тэвчээрийг барсан хэрэг боллоо. Ядаж энэ үед Тэмүжин Тоорил хантай нэгдэн Татаарын Мэгүжин сүүлтийг сөнөөгөөд эргэн ирж амжаагүй эзгүй байжээ. Эртний өст Татаарыг даран сөнөөсөн ялалтын их баярт тал нутаг тэр чигтээ умбаж байсан үе билээ. Урд жил нь Тайчууд аймгийн Аучу баатрыг дарж, олзлон авсан нум сумыг Тэмүжин Цагадайд бэлэглэсэн нь энэ хэрэг явдлын шалтаг болжээ.

Их гэрт Зүчи, Цагадай хоёр нум сум булаалдан хэрэлдээд сүүлдээ зодолдож эхлэхийг гэрийн гадна аарц шүүж байсан Бөртэ сонссон ч орж түвдсэнгүй. Учир нь насанд хүрч буй хөвүүд энэ мэт хэргийг өөрсдийн ухаанаар шийдэж сурах ёстой гэж Бөртэ үзэж байв. Тэр угаас олны нүдэн дээр Зүчийг илт өмгөөлөхөө больсон боловч гэнэ гэнэ хөвүүнээ өмөөрөхдөө гомдлоо тэвчиж чадахгүй зодож орхидог билээ. Зүчи ч эхийнхээ энэ сэтгэлийн чанад байдлыг гадарлах тул эхээс тохой өндөр болсон зодоход нь үг дуугүй эвхрэн хэвтэх юм уу зугатаан оддог байлаа. Тэгээд хүүгээ зодсондоо гэмшин шөнө Зүчийн духыг үнэрлэн гашуун нилимсаа асгаруулан чимээгүй уйлахыг сэрүүн ч гэлээ унтсан дүр үзүүлэх Зүчи мэддэг бөгөөд бас л сэтгэлдээ уйлж хэнээс ч юм бэ эхийнхээ нулимсны өшөөг авах хүсэлд шатаж хэвтдэг бүлгээ.

Зүчи хүүхэд гэхээргүй хэрсүү ухаантай, бас тэвчээртэй, холын далд язгуур бодолтой билээ.

Өөрийн хэн болох, юуны учир төрсөн, Цагадай яагаад өөрөөс нь илүү их бардам дээрэнгүй байдгийн учрыг Зүчи цөмийг мэддэг байв. Гэвч тэр Цагадайн адил Боржигон аймгийн ханы залгамжлагч болохыг туйлаас их хүсэх тул доромжлол бүгдийг тэсч ганцхан Тэмүжин эцгийнхээ итгэлийг олохыг л чармайна.

Эх нь ч ингэж сургадаг байв.

Хөвүүдийн хэрүүл туйлдаа хүрч Цагадайн

-Чи муу Мэргэдийн орхидос. Манай гэрээс зайл гэж хашгирч, дараа нь Цагадайн ёолох, Зүчийн орилохыг сонсоод Бөртэ гүйн орвол хэрэг нэгэнт өнгөрчээ. Зүчид цавчуулсан Цагадай мөрөө даран орилж, харин сүвээгээ сэт харвуулсан Зүчи цустай дээлээ тайлж байлаа. Хөвүүдийнхээ цусыг үзсэн Бөртэ ухаан алдах шахан юу хийх, хэнд нь түрүүлж хүрэхээ мэдэхгүй таг гөлрөв. Тэр хоёр хөвүүндээ адилхан хайртай юм. Гэвч юунд хөтлөгдсөн юм бүү мэд Цагадайгаа түрүүлэн тэврэн авсан билээ. Цагадайн шарх азаар хөнгөн, сэлэмний үзүүрт арьс нь зүсэгдсэн төдий аж. Харин сүүлд нь үзвэл Зүчийн шарх гүнзгий, цус их алдаж байв. Цусаа үзээд хөвгүүд ч цочирдон, эхийн хилэгнэхээс айж таг дуугүй гэрийн хоёр хаяанд хэвтэцгээв. Хэн нь ч юу ч хэлсэнгүй.

Бөртэ ч зэмлэх загнах үг унагасангүй. Тэр юу хэлэхээ ч мэдэхгүй байжээ. Хамгийн түрүүнд сэхээрч хэлсэн үг нь энэ явдлыг хэнд ч тэр бүү хэл, даан ялангуяа Өүлэн эхэд ч мэдэгдэж болохгүй хэмээн чанд захисан явдал байлаа. Бас хөвүүдийн хэрүүл зодооныг сонссон боол Татуг ч энэ тухай ам ангайхыг цаазлав.

Эзнийг нь шархдуулсан Цагадай хэрав Тэмүжиний хүү биш байсан бол, дээр нь Бөртэ хориглоогүй бол Тату тэр дээрэнгүй Цагадайг тас цавчихад бэлэн байв.

Тату үнэхээр Зүчи эзнийхээ өшөөг авахыг хүсчээ.Зүчи бол Татугийн хувьд зөвхөн амийг нь аварсан ачтан төдий биш,бүр түүний хамгийн хайртай хүн нь юм.

Хөвгүүд үйлдсэн хэрэгтээ их гэмшжээ. Мэргэдийн орхидос гэж Цагадайн хэлсэн үг Бөртийг гүнзгий цочроож, Зүчийг бүр ч ихээр гомдоож, тэр хөвүүн гэрийн тооныг нүд цавчихгүй ширтэн хэвтэхэд нулимс шанааг нь даган урсаж байхыг Бөртэ харж суулаа.

Зүчи хөвүүнээ юунаас болж ингэж чимээгүй уйлж хэвтээг мэдэх бүрт Бөртийн бүтэн бие нь хэмхрэх шиг болдог билээ. Гэвч хөвүүнээ яаж тайвшруулахаа мэдэхгүй байв.

Хүүхэд хүүхдээс онцгой ухаантай төрсөн, бүр дэндүү хүлцэнгүй номхон зантай,доромжлол,дарлал бүрийг тэвчин өнгөрөөж чаддаг Зүчи хөвүүнийхээ сэтгэлийн далд шаналалыг Бөртэ ойлгохгүй юм бол өөр хэн ойлгох юм билээ. Зүчи хөвүүнийхээ чимээгүй урсгах нулимсыг үзэх бүр Бөртэд “Ингэж байхаар үхчих минь яав” гэсэн хачин бодол үргэлж төрнө.

Тэмүжиний гэрийн дотор өөрийн хүн болон тооцогдохын тулд мэдээ орсон цагаасаа эхлэн Зүчи нэг хүний биед ахадсан зовлон амсаж байлаа.

Бөртэ шөнө нойргүй хонож, уйлж бөлцийсөн нүдтэй амьтан өглөө нь босмогц тэмээн тэргэндээ суун зүүн зүг Улз голыг чиглэн шуурхайлан одов. Хэн ч түүнээс зориглон асуугаагүй бөгөөд хаачиж явааг нь ганцхан тэр өөрөө л мэдэж байв. Зүчи хөвүүнээ ингэж тарчлан зовохыг Бөртэ дахин үзэхгүй гэж шийджээ.

Энэ цагт Тэмүжин Улз голын адагт Татаарын Хуст шүтээн хэмээх хүрээг эзлэн аваад цэргээ амраах зуур Татаарын Их Чэрэнгийн бага охин Есүгэн гэгч залуу үзэсгэлэнт эмтэй амраглан сэтгэл алдарч хорвоог мартан жаргаад сар шахсан ажээ. Эртний өст Татаар аймгийн нэг хэсгийг даран сөнөөсөн нь бүх монгол аймгуудын дунд дуурсахаар хэрэг байсан тул ганц

Тэмүжин төдийгүй түүний шадар нөхөд бүгдээр урамшин хөөрч багагүй бардамнан сатаарсан үе байв. Ялалт,олз гэдэг салахын аргагүй амттай ч хэтэрхий их согтуурвал аюул ослыг харах нүдийг сохлох аюултай билээ. Тэмүжиний цэрэг бүгдээр биш гэхэд ихэнх нь довтлох дайсан нэгэнт дуусан мэт амарч цэнгэжээ. Яг ийм дүр зураг Хуст шүтээний амыг өгсөн явахад Бөртийн нүдэнд үзэгджээ.Хэн ч Бөртийг зогсоож байцаасангүй.

Харин Тэмүжиний асарт ойр очиход харуул манаа чангарч өмнүүр эрх биш хөндөлдсөн ч Бөртийг танимагц гэдрэг ухарч зам тавьжээ. Тэмүжин, Бөртийг ийн гэнэт ороод ирнэ чинээ санаагүй тул бүр цочин босон харайж дээлээ эгэлдрэглэв. Тэмүжиний хээрийн өргөөг цэргүүд тойрон хамгаалж байсан ч харуулын хүмүүс Бөртийг таниад яаж ч хориглож дийлсэнгүй оруулчихжээ. Тэмүжин Бөртийг хараад эхлээд нүдэндээ итгэж өгөхгүй байв. Бөртийг ийн гэнэт ороод ирнэ гэж яаж санах билээ.

Анх удаа өөр бүсгүй хүнтэй нүцгэн хэвээр эхнэртээ үзэгдсэн нь Тэмүжинд айхгүй ч гэлээ аягүй гэдэг шиг юм болж хэлэх байхаа олж ядна. Харин Бөртэ хэдий гомдолтой ч тайван байгаадаа өөрөө ч гайхаж байв.

Тэр бүсгүй залуу тэгээд хэтэрхий үзэсгэлэнтэй байсан нь Бөртийг алмайруулахад хүргэжээ. Бүсгүй нүцгэн гоолиг биендээ хятад газрын торгон тэрлэг хөдөрч гарч гүйв.

Тэр бүсгүйн тэрлэг шиг тийм гоёмсог торгыг Бөртэ урьд нь үзсэнгүй. Одоо эр эм хоюул үлдэв.

Хэн хэн нь болсон явдалд тулгамдаад дуугүй суусаар удав. Гайхсан цочсон байдал нь Бөртийн сэтгэлээс алгуур холдож дотор нь эр нөхрөө хардах харамлах,гомдох хилэгнэх зэрэгцээд иржээ.Бөртэ өөрийн сэтгэлийг хүчээр тэвчин суулаа.Тэмүжинийг хардах харамлах нь ер шинэ зүйл биш юм.Боол Сорхон шарын охин Хадаан гэгчээс болж Бөртэ бишгүй нэг уур цухлаа оволзуулж,уушиг зүрхээ урсан билээ. Гэсэн ч хэрүүл хорын муу үг нэгийг ч атугай Тэмүжинд хэлж,түмний чихэнд унагасан удаагүй ажээ.

Одоо эр нөхрөө өөр эм өвөртлөн хэвтэхийг үзсэн ч тэвчих ёстой гэж өөрийгөө аргадаж байв. Ярих хэлэх юм хичнээн их,бүр аман дээр гарч ирээд байсан хэдий ч дуугарч төвдсөнгүй. Дуугарах л юм бол нулимс нь асгарах гээд байлаа.Ийм үед уйлж муугаа үзүүлэхгүй гэсэн хатуу бодол бас төрөх ажээ. Бөртэ Тэмүжинг дуугарахыг хүлээхээр шийдэв.

Харин Тэмүжин Бөртийн цочирдсон сэтгэл тайвшрахыг чимээгүй хүлээн байв. Татаараас олзлон авсан торгон дээлээр гангалсан Зэлмэ өөрийн биеэр идээ цай оруулж ирсний хойно ч хэн нь ч гар хүрсэнгүй дуугарсангүй суусаар түүнийг гаргажээ. Зэлмэ болсон хэргийн нарийн төвөгтэйг ойлгох тул аминдаа Тэмүжинд хань тус болох санаатай Боорчийн зөвлөснөөр орж иржээ.

Гэвч энэ бол эр эмийн хэрэг тул төдөлгүй гарахаас өөр арга олсонгүй.Боорчи,Хасар хоёр Зэлмийг нүдээ бүлтийлгөн хүлээж байжээ.Бөртийг ирэхийг үзээд бүгд л хэрүүл шуугиан дэгдэнэ гэж түгшиж байлаа.

Учир нь Тэмүжин татаар бүсгүйтэй ид цэнгэж байхад нь Бөртэ дээрээс нь орчихсон

билээ.Бөртэ яав ч тэсэхгүй гэж бүгд боджээ.Гэтэл хүний урманд аяга унах ч чимээ гарсангүй татаар бүсгүй ч орилж чарласангүй нь гайхалтай. Татаар бүсгүйг гарсны хойно ч чимээгүй таг чиг болсонд сэжиг төржээ.Тэд муу л юм боджээ.Тэмүжин ичиж цочихдоо юу ч хийж мэдэх тул Зэлмэ тулгагдан аргагүйн эрхэнд орсон билээ.

Бүгд Бөртийг өрөвдөж байв.

Залуу насны хайртай эр, хөвүүдийн нь эцэг Тэмүжин одоо нэгэнт өөр бүсгүй хайрлах болсныг Бөртэ өөрийн нүдээр үзлээ. Хэзээ нэгэн цагт болох байсан юм ашгүй тохиолдлоор гэнэт илэрч нүүр хагарав гэж Тэмүжин дотроо сэм баярлаж суув. Бас өөрийн гэрийн дэргэдийн харуул хамгаалалтыг бэхлэж, хэн ч байсан орж ирдэггүй хатуу чанд болгох, бас зөрчсөн хэнийг ч болов залхаах журам хэрэгтэй гэж дотроо шийдэв. Эр нь нэгэнт өөр эмтэй болсон нь хэдий гашуун гунигтай ч энэ цагийн эрийн ёс тийм хойно түүнийг үг дуугүй дагахаас өөр зам Бөртэд үгүй. Бөртэ удаан дуугүй сууж тэвчсэнгүй. Тэр аль болох тайван хэнэггүй зан гаргахыг хичээнэ.

-Тэмүжин. Энэ бүсгүйн нэр хэн бэ. Татаар хүн биз.

-Тиймээ. Татаарын Их Чэрэнгийн охин юм. Нэр нь Есүгэн гэдэг. Эцэг надад буун өгч охиноо бэлэглэсэн юм.

-Чамд нэгэнт таалагдсан бол хатны ёсоор хүндэтгэн аваач. Би бага хатанд чинь гэрийг нь бэлдүүлье. Яах вэ. Өнөө боол Сорхон-Шарын охин Хадаанаас дээр. Хаан хүн харь аймгийн хацар гоо эмийг авахгүй хаяаны харц боолынхоо эмтэй шалиглаж яаж болох вэ гэж Бөртэ хэлэхдээ Тэмүжинг анх удаа хаан гэж дуудав

.Яаж ийм үг олж хэлж чадсанаа хожим болтол Бөртэ өөрөө ч сайн ойлгоогүй билээ.Харин энэ үг Тэмүжинг баярлуулж бас ичээв. Хаан хүний тухай хэлсэн нь Бөртийн ухаан тэвчээрийг илтгэнэ. Бас Тайчуудад олзлогдож явахдаа учирсан Сорхон- Шарын охин Хадаантай одоо болтол нууцаар учирсаар байгааг мэддэг, бас боолынхоо охинтой самуурах нь зохисгүй гэж шүүмжилж хэлсэн нь Тэмүжинг ихэд ичээв. Гэвч Тэмүжин Хадааныг мартаж үл чадна. Яагаад гэдгээ ч тэр бас сайн мэддэггүй байв. Гайхалтай сайхан зүс царайгүй, тачаадан янаглах онцгой эрдэмгүй тэр ядуу бүсгүй түүний сэтгэлд яагаад тэгэж гүн шингэсэн юм бүү мэд. Өөрийн аймгийн боолын охин биш байсан бол Тэмүжин Хадааныг шууд л эхнэрээ болгон авах байлаа.

Гэвч тийм хувь зохиол тэдэнд байсангүй. Ийм үг хэлэхэд Бөртэд үнэхээр зүйрлэх юмгүй хэцүү байсан ч бас үүнээс өөр зам байсангүй.Эр нь өөр эм авав гэж санаа сэтгэл алдарч хүнд муугаа үзүүлж болохгүй гэж хатуужин боджээ. Сөнөөн дарсан дайсныхаа үзэсгэлэнт эмийг эзэмдэн авах нь угаасаа Тэмүжиний нэр төрийг хэрэг бас бахдалтай явдал гэж Бөртэ үзжээ. Ингэж татаар бүсгүй Есүгэний Тэмүжиний хатан болох хэрэг шийдэгдэв. Тэмүжин энэ явдалд ихэд баярлан Бөртэ хатныхаа ухаан тэвчээрийг гайхжээ.

Гэтэл үүнээс хойш бүр ч гайхалтай хэрэг болохыг тэр таасангүй.Харин Бөртийн юу бодож шийдсэнийг Тэмүжин гүйцэд ухааран ойлгож чадсангүй. Нэгэнт хэрэг ийм дээрээ тулж Бөртэ бүгдийг зөвшөөрсөн тул Тэмүжин тайвширч орон дээр нүцгэлэн хэвтэв. Одоо түүнд

Бөртийн энэ хол газар биеэ зовоож яах гэж ирсэн нь сонин байв. Лав үхэл зовлон ар гэрт нь учраагүй нь лавтай. Тийм байсан бол Бөртэ ирэнгүүт л хэлэх байсан биз. Миний дэргэдээс хэн нэгэн Есүгэний тухай хов зөөж тэгээд Бөртэ эм хүний атаархуу зандаа хөтлөгдөн иржээ гэж Тэмүжин тааварлаад тайвширчээ.

Үдэш болж холд адуу унгалдах бас ойрхон бүсгүй хүн мэгшин уйлах, бас гиншин янцаглах сонсдох нь Тэмүжиний шадруудын хэн нэг нь татаар бүсгүй эдлэж байгаа нь тэр. Учир нь Тэмүжиний гэрийн ойр Боорчи, Зэлмэ нар асраа барин тухалжээ.

Энэ тачаангуй чимээг сонсон тэр хоёр таг чимээгүй байцгаана.

Задгай галын гэрэлд Бөртэ ирсэн чигээр сууна.

-Чи яах гэж ирэв. Тэмүжин их л хайнга өнгөөр асууж бас эвшээсэн ч юу гэж хариулах бол гэж хүлээн догдолсон нь илт сонсдоно.

-Би чиний татаар эм эдлэхийг чинь үзэхээр ирэв. Санаандгүй ийм хачирхалтай үг сонсоно гэж даанч бодоогүй тул тулгамдаж

-Хэг гэж битүү дуу гаргахаас өөрийг Тэмүжин хэлж эс чадав. Хоёр хөвүүнээ зодолдож шархадсаныг, Цагадайн юу гэж хэлснийг өнөөдөр ярих хэрэггүй гэж Бөртэ боджээ. Зүчи, Цагадай хоёрын өрсөлдсөн тэмцлийг аятай шийдэх аргыг Бөртэ зам зуур энд иртэл хэд хоног явахдаа нэгэнт бодож олсон билээ. Гэвч өнөөдөр сэтгэл санаа нь огт өөр зүйлд эзлэгдээд тэр тухай хэлэхээ маргааш болтол хойшлуулахаар шийджээ. Ер түүнд яарах хэрэг байсангүй. Тэд хамт амьдраад арван зургаан жил болсон ч өнгөрсөн хугацаанд Тэмүжин өөр эмийг гэртээ оруулж байсангүй. Харин одоо аваль эр Тэмүжин нь залуу татаар бүсгүйтэй хэрхэн амраглаж байсныг Бөртэ өөрийн нүдээр үзэв.

-Чи миний дөрвөн хөвүүний минь эх, миний их хатан шүү гэж Тэмүжин Бөртийн тарган шалхгар харвин, унжсан хөхийг дуртай дургүй илбэхдээ шивнэж байв.

Энэ бол нэг талаас Бөртийг аргадсан нөгөө талаас ухаантайд нь талархсан сэтгэлийн үг юм.

Эхнэрээ илж таалж хэвтэхдээ Тэмүжиний сэтгэл догдолж, сэрэл хөдлөсөнгүй. Үүнд ер гайхах зүйлгүй юм. Үзэмж төгс, бие чанга, залуу татаар бүсгүйг өдөр шөнөгүй эдэлж түүний дур хүсэл ханаад одоо зөвхөн тайван сайхан унтахыг л хүсч байлаа.

Харин Бөртийн хувьд бүр эсрэгээр олон хоног эрээс хол байж хагсарсан бие нь Тэмүжиний эвэршсэн алга хүрэх бүр чивчрэн доргиж, дур хүсэл нь оргилж байж ядавч Тэмүжиний бие махбодь нойрмоглон унжийх нь уур бухимдлыг төрүүлнэ. Аваль эрийн ийм унхиагүй,дургүй байдал ямарч эмийн уур,эгдүүцлийг төрүүлэх нь гарцаагүй бизээ. Гэтэл энэ арга ядсан мөчид Бөртийн санаанд нэгэн бодол гялсхийлээ. Хор шар буцалсан Бөртэ байж ядахдаа олныг гүйлгэн бодов. Энэ мөчид нэгэн этгээд бодол төржээ. Эргэлзсэн хэдий ч бүр тэгэж лавшруулан бодох бүр эхлээд уур хилэн нь бадарч дараа нь дур хүсэл нь ихээр оргилов. Бөртэ өөрийн хэн болохыг Тэмүжинд бас тэр татаар эмд үзүүлэхийг туйлаас хорсон хүсч байв.

-Тэмүжин. Чи тэр татаар эмээ авчир. Нэгэнт чиний аваль эм болох тул гурвуул хамт янаглая.

Бөртийн атаархсан,уурлаж хорссон сэтгэлийн угаас гарсан энэ үг Тэмүжинд туйлын таалагдсан ч тэр дороо босон харайх нь дэндүү гэнэн хэрэг байлаа. Бөртэ сүрхий ухаантай,холын бодолтой хүн болохоор Тэмүжин түүний арга залинд уначихгүйн тулд хаширлан дуугүй байлаа. Хэрвээ тэгдэг юм гэхэд Бөртээр бүр сайтар гуйлгах нь зөв гэж тооцжээ. Бөртэ дур хүслээ тэвчиж дийлэхгүй үглэж, дээрхи хэргийг шаардсаар ажээ.

Нэгэнт Бөртэ Есүгэн хоёр адилхан түүний аваль эмс болох тул Бөртийн хэлснээр хийх нь ер болохгүй юмгүй мэт Тэмүжинд санагдавч тэвчин үг дуугарахгүй таг чиг хэвтсээр байв.Тэмүжин муу санаалан шууд зөвшөөрөн дэмжсэнгүй.

-Чи залуу эмийг үзмэгц хүсэл чинь бадрана. Дууд гэж Бөртэ шивнэнэ. Бүх юм үнэхээр Бөртийн хэлснээр боллоо.

Есүгэний нүцгэн бие сэргэр хөх, сэрвийн харлах умдагны үс зэрэг нь Тэмүжиний бие махбодийг хөвчрүүлж, чадал дур нь оргилов.

Есүгэн аваль эр эм хоёрын хамт хэвтэхээс өөр арга үгүй байв. Тэр гайхасхийн зог тусав.

Төрөлх татаар аймгийг нь дарж хүч түрэмгийлэн авсан Тэмүжиний аваль эм Бөртийн юу хүссэнийг биелүүлэхээс өөр зам Есүгэнд үгүй байв. Эс зөвшөөрвөл тэр хормын дотор үхэх билээ. Хэрвээ түүний хэлснийг дургүйцан эсэргүүцвэл тэр татаар эмийг алахыг шаардахаар Бөртэ нэгэнт шийдээд байжээ. Түүний хэлснийг Тэмүжин үг дуугүй биелүүлнэ гэдэгт ч бат итгэж байв.

-Би бол Чингис хааны их хатан, Чингис хааны дөрвөн хөвүүний эх Бөртэ байна. Нааш ир.Чи одоо надад юу чаддагаа үзүүл. Эс тэгвэл Чингис хаан чамайг өршөөхгүй цаазлах болно.Чи ингэхийг хүсч Чингис хаанд ирсэн биш үү гэж шалдан хэвтэх Бөртийн хэлэхэд Есүгэн эргэлзсэн хэвээр зогссоор байлаа.

Нэгэнт бие махбодь нь хөвчирсөн Тэмүжин Бөртийн шаардсанаар их хатнаа Есүгэнийг харж байхад эдэлж эхлэв. Бөртийн эрээ цээргүй шунал тачаалыг эсэргүүцэх чадал Тэмүжинд байсангүй.

Тэр мөчид Тэмүжин Бөртөөс үнэхээр айж,ал гэсэн бол Есүгэнийг ч эргэлзэхгүй алахад бэлэн байв. Гэтэл Бөртэ хүн санахын эрхгүй зам сонгон авчээ.Ингэж Бөртэ Тэмүжинээс Есүгэнээс өшөөгөө авч байна гэж өөрийгөө тайвшруулжээ.

Хөндлөнгөөс хүн харж байх нь туйлын хурц мэдрэмж, сэрэмж төрүүлдгийг Тэмүжин ч, Бөртэ ч, Есүгэн ч мэдэрлээ. Энэ бол тэдний хувьд цоо шинэ мэдрэмж байлаа.

Бөртэ ийн зовох юмгүй гиншиж, урьд үзээгүй тааламжтайгаар хөдөлнө.

Тэр хэзээ ч ийм дур тачаалтай байсангүй.Есүгэн тэвчилгүй ойртсоор тэдний нүцгэн биед хүрлээ. Одоо түүний дур оргилжээ. Дур хүсэл нь үхлийн тухай бодол айдсыг даван гарахыг

Есүгэн мэдрэв.

Дур нь ханаж ухаангүй гулдайн унасан Бөртийн нойтон биеийг орхиж, Тэмүжин Есүгэний чанга халуун биеийг хаман дороо хийлээ.

Удалгүй ухаан орж сэргэсэн Бөртэ тэдний янаглахыг гар биеэрээ мэдэрч байв. Эр нь өөр эмтэй болсонд энэ удаа харин Бөртэ харамссангүй. Харин Тэмүжинд юу ч хийсэн аймшигтай биш гэсэн итгэл оргилж байв. Бөртэ хязгааргүй итгэсэндээ ийм итгэмгүй ааш гараж байхыг Тэмүжин гэнэт ухаарчээ.

Ядарч цуцсан ч аз жаргалтай болсон Тэмүжин хоёр эмийнхээ дундуур үхсэн мэт унтжээ. Харин Бөртэ нойр хулжаан хоножээ. Есүгэн амьсгаа чанга авахаас айж хөдөлж чадахгүй үүр цайлгав.

Энэ өдрөөс хойш Тэмүжинг Чингис хаан гэж өргөмжлөх ёстой гэж тэр шөнө Бөртэ хатуу шийджээ. Одоо эр нөхөр Тэмүжин нь ганц түүнд хамаатай хүн биш болсныг Бөртэ зүрхээ шимшрүүлэн мэдэрч байлаа.

Тэмүжин гэдэг хүн нэгэнт үгүй болоод түүний оронд Чингис хаан гэдэг хэмжээгүй эрхэт эзэн бий болсныг ойлгов. Бүр монголын тал хангай нутагт хэзээ ч байгаагүй тийм агуу их хаан байгаасай гэж Бөртэ чин сэтгэлаас хүсчээ. Тэмүжинийг их хаан болгохыг тулд Бөртэ юугаа ч хайрлахгүй зүтгэж ирснээ сая л мэджээ.

Чухам юуны учраас Тэмүжинийг өрөвдөн хайрлаж,бас хязгааргүй ихээр зовж тарчилснаа ухаарч төрөл арилжих шиг болжээ.Чингис хааны их хатан байна гэдэг ямархан бахархалтай хувь тавилан болохыг Бөртэ ухаарч байв.

Тэмүжин өглөө нь Бөртэ Есүгэн хоёрын хамт татаарын Мэгүжин сүүлтийн алтан баганатай гэрт цайлжээ. Есүгэнийг гэрээс гарсны хойно ирсэн хэргийнхээ учрыг Бөртэ хэлэв.

Зүчи Цагадай хоёрын хооронд болсон явдлыг Тэмүжин үг дуугүй сууж сонсов.

-Өүлэн ээж мэдсэн үү гэж юунаас түрүүлэн асуусан нь Өүлэн эх Зүчийг илэрхий өмгөөлөн хамгаалах тул Тэмүжин ингэж болгоомжилжээ.

-Үгүй. Би хэнд ч бүү хэл гэж хэлсэн. Бас та нар Чингис хаан эцгийнхээ нэр хүндийг хайрлах ёстой. Хаан эцэг чинь яаж шийдэхээ мэднэ биз. Би бүтэн биеэ тасдаж, бүлээн цусаа урсгаж төрүүлсэн. Та нар өсч эрийн цээнд хүрэв. Энэ амь биеийг одоо Чингис хаан эцэг чинь мэдэг гэж би хэлэв хэмээн Бөртийн хэлэхэд

-Чи сайн хэлжээ гэж Тэмүжин тааламжтай мишээв. Чингис хаан гэж Бөртийн хэлсэн нь анх удаа сэтгэлд нь нийцтэй, бүр омог бахархал дүүрэн сонсдов.

Эртний өст Татаарын Мэгүжин сүүлтийн цэргийг дарсан ялалтын дараа Чингис хаан гэж өргөмжлөх нь үнэхээр зохиж байх шиг санагдав.

-Бөртэ чи үүнээс хойш хүний дэргэд намайг зөвхөн Чингис хаан гэж нэрлэж бай. Бас дүү нар,

Боорчи, Зэлмэ нарт ч тэгэж сурга. Би өөрийгөө өргөмжлөхийг яаж бусдад заана. Чи л хичээ. Яаж хэлэхийг юу хийхийг чи мэд.Би энэ тухай Тэв тэнгэр бөөтэй ярилцана. Энэ бол Тэмүжиний Бөртийг хэрхэн дотноор чухалчлан үзэж буйгаа шууд илэрхийлсэн халуун сэтгэлийн үг байв. Бас нэг гэрийн эр,эм хоёр адилхан зүйлийг хүсч,тэмцэж явдгийг тэдэнд ойлгуулжээ. Ганц эр зориг, цөөн тооны ялалт, багахан олз омог Чингис хаан хэмээх их нэр алдрыг бий болгоход хүчин дутаж байсан билээ.

Сая Бөртийн хөвүүддээ хэлсэн үгнээс хэрхэх ёстойгоо Тэмүжин ойлгожээ. Бүх нөхдийн дотроос хамгийн дотно нөхрөө гэж Бөртийг тооцдогоо сая илэрхийлэв. Бөртэ ч үүнийг сэтгэлийн угт сайтар ухаж ойлгов. Тэд нэг хүн болжээ. Бөртэ Тэмүжинд дөрвөн хөвүүн төрүүлж өгсөн юм. Тэгвэл одоо түүнээс огт дутахгүй нэгэн үйлийг тэр толгойлон удирдах ёстойгоо мэдэж байв. Энэ бол Тэмүжиний Чингис хаан алдрыг өргөх хэрэг юм.

-Би л чамайг яаж хүндэтгэж, яаж ёслол төгөлдөр өргөмжилж чадна бүгд түүнийг дагах болно. Үүнээс хойш би чамайг бүгдийн дэргэд Чингис хаан гэж дуудаж байх болно. Би эргэж харимагц, дүү нар, шадар нөхдүүдэд чинь юу хийхийг сайтар хэлнэ. Чи ч гэсэн үүнээс хойш Чингис хаан мэт байгтүн гэж Бөртэ хатуу хэллээ.

Үнэхээр маргаашнаас нь эхлээд Тэмүжиний гэрийн ойр орчмын дэг ёс хатуурч Боорчи, Зэлмэ хүртэл дуртай үедээ давхиж ордог хөг өнгөрөв. Тэр бүрийд угтан гарч ирэх Бөртийн амнаас Чингис хаанд би айлтгая. Хүлээгтүн гэсэн хатуу үг гарч гайхашруулна. Үнэхээр Татаарыг дарсны хойно хишигтэн цэрэг, хэвтүүлийн тухай Тэмүжин зарлиг буулгав. Бөртийн дэглэсэн ёс удаан ч гэлээ хэвшин тогтож Тэмүжинийг аандаа бусад нөхдөөс ялгарсан их хүндлэл, ёслол дагалдах боллоо.

Харин Зүчийн тухай Бөртийн хэлсэн үгийг нэг хэсэгтээ л Тэмүжин зөвшөөрч чадахгүй байв бодолд автсаар байлаа.

-Зүчи хөвүүн минь удахгүй арван таван нас хүрнэ. Түүнд цэрэг ахлуулж эргэлзэх юмгүйгээр тулаанд оруул. Алийн болгон цэргийн ачаа хөсөг дагаж ард хоцорч явах вэ. Би түүнийг хамгаалж өдий хүрлээ.

Одоо Зүчи өөрийгөө хамгаалах насанд хүрчээ.

Цагадайн суманд үхсэн дорвол дайсны суманд өртөж тулааны талбарт үхэг.

Тэгвэл би огт харамсахгүй гэж Бөртийн хэлсэн үг хэдэн сар цээжийг нь нухаж цэр шиг хоолойд нь торов.

Эх хүн хэлсэн гэхэд дэндүү хатуу ширүүн энэ үг бараг чи дагуулж яваад хороогтүн гэсэнтэй адил сонсогдоно. Бөртийн үг угтаа яг ингэж хэлсэн үг байв. Энэ огцом эрс хатуу шийдвэрийн цаана нуугдсан далд аюулыг Тэмүжин мэдэрсэн тул ингэж бодолд унасан билээ. Одоо түүнд Зүчийг үхүүлэх эрх байсангүй. Эм араатан шиг авран хамгаалсан хайртай үрээ гэнэт чи үхүүлбэл үхүүл. Дурааараа бол гээд Бөртийн хаяж орхисон нь Тэмүжинд бэрх зовлон авчрав.

Ингэсэн нь Тэмүжиний хүн чанар, хайрыг оргилуулж би яавч Зүчи хөвүүнээ үхүүлж болохгүй

гэж шийдэхэд хүрснээс гадна Бөртийн алс нарийн ухааныг ойлгож хүндлэхэд хүргэсэн билээ.

Зүчи хэрвээ гай болж тэнэсэн суманд өртөж үхвэл Тэмүжиний өөрийн нэр хүндэд ямар хор болохыг тэр ойлгожээ. Тэмүжин нэгэнт Чингис хаанд өргөмжлөгдсөн тул ганц өөрийн нэр төрийг ч биш хөвүүдийнхээ нэр төрийг ч эрхэмлэн хайрлах ёстой болжээ. Чингис хааны ууган хөвүүн дайсанд хорлогдон үхнэ гэдэг ямар их гарз, эсрэг этгээдэд яасан их баяр болохыг Тэмүжин ойлгов. Тийм учраас хөвүүдээ өөрийн адил хамгаалах цаг иржээ. Үүнээс өмнө ганц өөрийн хар толгой,халуун амиа эрхэмлэн хамгаалж ирсэн муу санаагаа ойлгож,ирээдүй хойчоо,үр хүүхдээ бодоход хүрчээ.

Тэгээд Боорчийг дуудан ирүүлэв. Учир нь тэд Тайчуудын үлдэгдлийг дарахаар удахгүй цэргээ хөдөлгөх гэж байсан билээ.

-Чи миний зарлигийг зөрчиж Зүчийг амьд үлдээсэн хүн. Одоо би тэр ослыг чинь сануулж Зүчийг амь шигээ хайрлахыг зарлиг болгое. Хэрэв Зүчи осолдвол би чамайг өчиггүй цаазлах болно. Чи Зүчитэй нэг амьтай болов гэж бод. Чи өөрийн мэдлээс Зүчид мянган шилдэг цэрэг гаргаж захируул. Түүнийг сургаж хүмүүжүүл гэж Тэмүжин хэлэв.

Энэ үгийг Боорчи хүлээж байсан мэт нүд нь гэрэлтэн ойртон суув.

-За би Чингис хаан таны зарлигаар болъё. Би Зүчид мянган цэрэг өгнө. Бас дэргэд нь Зэлмийн дүү Сүбээдэй ноёныг дагуулъя. Чингис хаан таны Зүчи хөвүүн өрх толгойлж цэрэг засах насанд хүрчээ. Зүчид бүү зовогтүн. Түүнийг надаас өмнө үхэхийг Чингис хаан та үзэхгүй гэж Боорчи жоготой инээмсэглэв.

Зүчийг амьд үлдээсэн нь хамгийн зөв шийдвэр байсанд ганц Боорчи ч биш,бүгдээрээ бүр Тэмүжин ч бат итгэлтэй болцгоосон билээ.Тийм учраас Зүчийн тухай сайнаар дурсагдах бүр Боорчийн сэтгэл яг намрын тал шиг цэлийж баяртайгаар инээдэг байв. Харин Тэмүжин зарлигийг зөрчин Зүчийг амьд үлдээсний учрыг дахиж асуугаагүй ч Боорчийг ингэв гэж хатуу чангаар буруушаан зэмлээгүй юм. Гэсэн хэдий ч Зүчийг амьд үлдээсэнд дотроо талархалтай явдгийг Боорчи таамаглаж, Тэмүжинг Зүчийн тухай дурдах бүрийд ингэж даажинтайгаар инээдэг бөгөөд Тэмүжин Боорчийн энэ хоргүй занг анзаараагүй мэт өнгөрөөдөг байлаа.

-За би тэгвэл сэтгэл ханалаа. Чи Зүчийг надад үнэнчээр зүтгүүл.Түүнийг хамгийн шилдэг баатар жанжин болго. Зүчийг бүү үхүүл. Би Бөртэд амалсан юм гэж Тэмүжин ширүүн дуугарч хөмсөг зангидав. Тэмүжин хэдийгээр Бөртэд ингэж хэлээгүй ч Зүчийг хэрхэвч үхүүлж болохгүй гэж дотроо хатуу шийдсэн билээ. Харин яагаад гэдгээ тэр Боорчид тайлбарласангүй. Ингэхийн хэрэг ч үгүй байв .Одоо бүгд Тэмүжиний юу хэлснийг ямарч тайлбаргүйгээр биелүүлж сурчээ.

-Би хаан танд амласнаа хийх болно гээд Боорчи хүндэтгэлтэйгээр ёсолж ухран гарсан хойно Тэмүжин бүр үнэн сэтгэлээсээ ганцаараа хөхөрч суув. Бүр нулимсаа гоожтол хөхрөв.

Учир нь хэнэггүй Боорчи яаж бөхийсөн, бүр үнэн сэтгэлээсээ мэхийн ёсолсон нь үзэгдээд болсонгүй. Түүний амьдрал эргэн тойрны бүх хүмүүс өөрчлөгджээ. Тэмүжин одоо өөрийн үзээгүй тэр ёс журмаар амьдарч сурч байлаа. Түүнийг их хаанд өргөмжлөх дэг ёсыг

Бөртэ,Тэв тэнгэр бөө болоод бусад нөхөд нь нэгэнт тогтоон хэвшүүлжээ. Бүх юм санаснаар болж байгаад сэтгэл сэргэж, баясгалант бодол төрнө. Одоо түүний өмнөх бүх юмс тодорхой аж.

Дайсан этгээдийн хүчийг нэгтгэхгүйгээр ганц ганцаар нь цохиж сөнөөх нь энэ цагт хамгаас чухал гэдгийг Тэмүжин нөхдийн хамт тодорхой ойлгосон учраас Алтан улсын цэрэгт хөөгдөн орох газраа олохгүй зугатааж явсан татаарын Мэгүжин сүүлтийг хажуугаас нь дайран сөнөөсөн билээ.

Харин удахгүй Тоорил хантай нийлж Жамухыг дарах болно. Бас Найман аймгийн Буйраг хааныг сөнөөнө. Тэр Буйраг хаан,түүний хөвүүн Таян хан бол Мэргэдийн Тогтоэ бэхийг хөвүүдийнх нь хамт орогнуулан тэтгэж байгаа улс юм. Найманаас өмнө том толгойтой Жүрхэнийг номхруулах ёстой.

Жүрхэн овгийнхон уг нь угсаа гарал нэгтэй Хабул хааны үр сад юм. Гэтэл тэд үргэлж эв эвдэж, бүр хэтрээд Татаарын Мэгүжин сүүлтийг хөөн дайтаж явах хойгуур Өүлэн эхийн хүрээг дайрч хүн алж, дээрэм хийсэн цадиггүй улс билээ. Тавьтар муутай,омог зүрх ихтэй Жүрхэнийг номхотгох хэрэг яг хоолойд тулжээ. Тэмүжиний тэвчээр барагдсан байв.

Харин одоо Зүчийн хэргийг Боорчид даалгаад сэтгэл амарч Бөртэ хатныхаа гэрт нүүр бардам очих болжээ. Бөртийн зөвшөөрснөөр Есүгэнийг хатан буулган авчирснаас хойш Тэмүжин ихэвчлэн залуу хатныдаа хонох бүлгээ. Гэвч хэд хоноод л Бөртийн урилгаар Есүгэний хамт очиж хононо.

Бөртийн санаачилсан тэдний хамт хурьцах тоглоом бүгдэд нь таалагдсан юм.

Бүр бүгдээр шунан дурладаг гэхэд хилсдэхгүй .Нэгэнт Чингис хаан өөр хатан буулгах нь тойрч гарч чадахгүй жам хойно Бөртэ хувь тавилантайгаа эвлэрч харин залуу хатдад эрх ямбаа булаалгахгүйн төлөө ухаан аашаа гаргах хэрэгтэй болсныг гүнзгий ойлгосон юм. Харин азаар хар нялхаас сүй тавин хуримлаж хувцасгүй ядуу үеэс хоёргүй сэтгэлээр ижилсэж,хартанд булаагдаж зовсон Бөртэтэй мөчөөрхөн тэмцэх эм хүйстэн Тэмүжиний ураг,удамд гарсангүй.

Энэ нь Бөртийн уужуу ухаан,хатуу тэвчээр,олны аяыг олох ялдам зангаас үүдэлтэй байв. Бөртийн өндөр нэр хүндийг Тэмүжин ч хүндэтгэн мэдэрдэг бөгөөд аливаа гэрийн хэргийг Бөртийн санаанд аль болохоор нийцүүлж түүний үгээр хийхийг хичээх бүлгээ. Тийм учраас Тэмүжиний бусад хатад аливаад ганц Бөртийн амыг хардаг болжээ. Бүх зүйлд Тэмүжин их хатнаа хөхүүлэн дэмжих тул тэдэнд Бөртийн үгийг дагахаас өөр зам үлдсэнгүй. Өнөө орой Тэмүжин, Есүгэн хоёр Бөртийн өргөөнд хононо. Тэр Бөртэд амалсан билээ. Хөгширч бас эрдээ гологджээ гэж Бөртийн гомдох сэтгэлийг ингэж төлөвшүүлэх нь Тэмүжинд тийм муу юм санагдсангүй билээ. Харин ч Бөртийг гомдоллох сэтгэл нимгэрч энэ нь хэн хэндээ амар байх болжээ.

Заримдаа өөртэй нь хурьцахгүй өнжиж удлаа ч Бөртэ гомдохгүй байдаг бөгөөд зүгээр л Тэмүжин Есүгэн хоёрын янаглахыг харж сонсож хэвтдэг байв.

Хөвүүд нь өсөж гараас гарсан нь Бөртийг улам бүр ганцаардуулна.

Арван настай Тулуй хөвүүн нь хүртэл байлдан дайтахаас өөр тоглоом, үг мэдэхгүй болжээ. Бас дээр нь Цотон ээж нь таалал төгсөж Бөртийг улам ч шаналгаж, сэтгэл дотрыг нь хоосруулжээ.

Хайртай эх эцэг,танил дасал болсон аымаг,нутгаа орхин Тэмүжинийг эргэлзээгүй дагасан амьдрал нь заримдаа Бөртэд тэвчин өнгөрөөхийн аргагүй хүнд бэрх,зовлонтой байсан ч одоо түүнд харамсах явдал үгүй болжээ. Харин ч Тэмүжиний дэргэд үлдээсэнд нь Тэнгэрт талархан мөргөдөг байв.

Үнэхээр Тэмүжиний есөн настайдаа Дайцэцэнийд очсон нь Тэнгэрийн зарлиг байсан гэдэгт Бөртэ итгэх болжээ.

Зүчи хөвүүндээ мянган шилдэг цэрэг захируулж,дэргэд нь дайсныг ялах ухаанд нэвтэрхий суралцсан гарамгүй баатар Сүбээдэйг дагуулахаар болсноо Бөртэд хэлэхэд Тэмүжинд үнэнхүү бахархалтай байлаа. Түүнийг ингэж Зүчид өгөөмөр хандсанд Бөртэ хязгааргүй баярлана гэж Тэмүжин бодож байв.Бөртийг баярлуулахсан гэж Тэмүжин хүсчээ.

Тийм учраас Тэмүжин залуу хатан Есүгэнээ үл анзааран Бөртэ хатнаа хантал цэнгүүлж тэр шөнө Бөртэ даруй дөрвөн удаа ухаан алджээ.Маргааш нь Тайчуудыг дайлах их цэрэг хуурай тэнгэрт шороон үүл босгон хөдлөв.

Зүчийг мянган цэргийнхээ өмнө баяртайгаар одсон тэр өдрийн шөнө Бөртэ овоонд гарч тэнгэрт мөргөв.

-Тэнгэр минь.

Намайг өршөө.

Би хөвүүнээ үхэлд хаяж өглөө.

Зүчи бол миний зовлонгоос төрсөн үр минь юм.

Түүнийг минь амьд буцаан ирүүлээч гэж уйлан гуйв.

Зүчийг үхүүлэх нь ганц түүний ч биш, Чингис хааны зовлонг нимгэлнэ гэж Бөртэ бат итгэж байв. Хөвүүд нь хоорондоо алалдсанд орвол Зүчи үхсэн нь дээр юм. Зүчид мянган шилдэг цэрэг захируулж,сүбээдэйг дагуулсан нь зөвхөн түүнийг тайвшруулах гэсэн Тэмүжиний арга гэж Бөртэ боджээ.

Гэвч түүнд шийдвэрээс ухрах хүсэл төрсөн ч тэвчжээ.Хэлмээр санагдан аман дээр гарч ирсэн ч дэргэд хэвтэх Есүгэн хатнаас болоод тэвчжээ. Бие сэтгэлээ барж хамгаалан өсгөсөн амин үрээ үхүүлэхээс өөр аргагүй болно гэж Бөртэ даанч санасангүй билээ. Зүчийг үхүүлэх нь хайртай үрээ зовлонгоос салгасан хэрэг болно гэж Бөртэ эцэст нь үнэн сэтгэлээс боджээ.

Хэрэв Зүчи Цагадай хоёрын зөрчил хэрүүл гүнзгийрсээр байвал Тэмүжин Зүчийг хүссэн хүсээгүй алах болно гэдэгт Бөртэ итгэнэ. Бөртэ Тэмүжинг ингэж зовоохыг хүсэхгүй байлаа. Тэмүжин ч Бөртэ ч Цагадай хөвүүнээ эцгийгээ залгамжилах ёстойг зөвшөөрдөг байв.Харин

өдрөөс өдөрт ухаан сууж өөртөө итгэлтэй болж олонд тоогдсоор байгаа Зүчи, Цагадайд байр суурриа тийм амар тавьж өгөхгүй болохыг Бөртөөс өөр хэн ч гүнзгий таамаглаагүй билээ.

Тэмүжиний өрх гэрийн тайван амьдралын төлөө,Цагадай хөвүүнийхээ ирээдүйн эрх мэдлийн төлөө,Чингис хааны их нэр сүрийг сайнаар дуурсгахын төлөө Бөртэ ямар нэгэн юм хийх ёстойгоо ухаарч байв.

Ийм үед хамгийн сайн арга нь Зүчийг хэл амгүй үхүүлэх явдал юм.Үүнийг ганцхан Бөртэ л хийж чадах билээ.Учир нь энэ газар дээр Зүчийн амийг мэдэх цорын ганц хүн бол Бөртэ юм. Зүчи хэмээх энэ азгүй хөвүүн амьдрах хугацаа нь дууссан бол үйлийн үрээ дагахаас өөр яалтай билээ гэж Бөртэ шийджээ.

Гэвч биеэ урж,цусаа урсгаж төрүүлсэн хамгийн хайртай ганц үрээ үхүүлнэ гэхээс Бөртийн гол тасарч байв. Болдогсон бол хөвүүнийхээ өмнөөс өөрөө үхмээр.

Болдог байлаа ч Бөртэ Цагадай,Өгөдэй,Тулуй хөвүүдээ орхиод үхэж чадна гэж үү.Бас Бөртэ дахиад бие давхар болсон байв. Гэвч Бөртэ дотроо Зүчийгээ амьд эргээд ирээсэй гэж голоо тасартал хүснэ. Харин энэ удаад Тэмүжин Зүчийг яавч амьд үлдээхгүй гэж Бөртэ боджээ. Учир нь Зүчи хөвүүнээ үхүүлэхийг Бөртэ зөвшөөрсөн билээ. Ингэх нь Тэмүжинд амар юм. Зүчийг үхвэл Тэмүжинг хэзээ ч буруутгахгүй гэж Бөртэ нэгэнт шийдсэн байв.

-Зүчи хөвүүнийг минь амьд ирүүлээч. Би гуйя гэж Бөртэ өөрийн шийдвэр, хүслийн эсрэг Тэнгэрээс гуйж шөнөжин мөргөжээ.Бөртийн сэтгэл хоёр хуваагдаад учраа олохоо больжээ.Зүчи хөвүүнээ үхвэл ганцхан өөрийгөө буруутгана гэж бат шийдэн Тэнгэрийн зарлигийг дуулгавартай хүлээв.

Харин энэ удаа Тэнгэр Бөртийн үгийг сонсов.Боржигон аймгийн мөнхийн өрсөлдөгч Тайчууд дарагдан сөнөжээ.

Тайчуудтай тулалдахаар мордсоноос хойш хэдэн сар өнгөрч нэг өдөр царай нь харлаж байргашин бүдүүрч, харц нь итгэлтэй гэрэлтсэн Зүчи хөвүүнээ цэргийн манлайд ирэхийг үзээд Бөртэ нүдэндээ итгэсэнгүй.

-Тэр Зүчи ах гэж Тулуйн хашгирахыг сонсоод Бөртэ муужран унаж, дэргэд байсан охид хүүхдүүдээ сандаргасан билээ. Энэ явдлаас үүдэн Чингис хаан Зүчи хөвүүнийг өршөөжээ гэж Бөртэ итгэв.

Тэгээд орой нь гэртээ Зүчийг өмнөө сөхрүүлж байгаад

-Зүчи! Хөвүүн минь сонс. Чиний амь насыг соёрхож өгсөн хүн бол Чингис хаан эцэг чинь юм. Чиний амь Чингис хаан эцгийн чинь гарт бий. Чингис хаан эцэг чинь хэзээ үх гэнэ. Тэр цагт үг дуугүй үхээрэй. Цагадайтай бүү өрсөлд, бүү хэмлэлд. Чингис хаан эцгийнхээ сайн нэрийг бүү гутаа. Санааг нь бүү зовоо гэж хатуу хэлжээ.

Зүчи үг дуугүй толгой дохино. Гэвч дотроо огт өөрийг бодов. Өөрийгөө Мэргэд цусных гэж дорд үзэхийг Зүчи хэзээ ч зөвшөөрөхгүй. Гэвч эхийнхээ сэтгэлийг хямраахгүй гэсэндээ л

толгой дохиж суув. Хайртай ганц эхийгээ гомдоож сандраахыг Зүчи хэзээ ч тэвчихгүй хүмүүжилтэй болж өсчээ. Тэнгэрийн дор хамгийн эрхэм дээд хүн нь Бөртэ эх нь юм.

Хэдийгээр эх нь үл зөвшөөрөх зүйл хэллээ ч дургүйцэн эсэргүүцэж буйгаа Зүчи хэзээ ч ил тод илэрхийлдэггүй байв. Саяын хагас жилийн тулаанд Зүчи хэнээс ч дутахгүй тулалдаж бас мянган цэргээ ягштал удирдан явсан нь Тэмүжин Боорчи хоёрыг гайхашруулж бас их баярлуулсан билээ. Зүчи гялалзсан баатар, жанжин болох нь илт байв

Үүнийг Тэмүжин Бөртэд үнэн сэтгэлээс бахдалтай хэлсэн бөгөөд бас Цагадайд ч цэрэг даалгах нь зөв гэдгээ дурсав. Зүчид цэрэг захируулснаас болоод Цагадайн хор атаархал туйлдаа хүрснийг Тэмүжин Бөртэ хоёрт бүү хэл харь элгийн хөндлөнгийн хүнд ч тодорхой байв. Цагадай хэцүү бэрх ааштай тул тэр яаж ч мэдэх юм.Тайчуудыг дарж ирээд Тэмүжин их хатныхаа өргөөнд тухлажээ. Энэ нь нэг талаас Зүчийн зоримог гавшгайг бахадсан хэрэг байв. Бас нөгөө талаас Есүгэн хатан нялх биетэй, Есүй хатан бие давхар байснаас ч болжээ. Эр нөхөр нь залуу хатад,татвар эмсээ умартан өргөөнд нь морилсонд Бөртэ туйлаас аз жаргалтай болжээ.

Тэр үдэш дөрвөн хөвүүн,охидоо тойруулан суулгаад халуун бүгээрээ зоог барижээ. Ингэж суух нь Тэмүжинд ихэд таашаагдсан тул тэр сэтгэл ханаад

-Би чиний дөрвөн хөвүүнийг булааж авах нь дээ гэж баясгалантай инээв. Бөртэ ч бахдалтай сайхан байлаа.

Учир нь Есүгэн хатнаас хөвүүн төрөөгүй бөгөөд Есүй хатны гэдсэн дэх хүүхдийг охин гэж Тэв тэнгэр бөө мэргэлсэн байжээ. Үзсэн зовлон, эдэлсэн шаналалыг нь тэнгэр тайтгаруулах гэсэн мэт Бөртэд дөрвөн сайхан хөвүүн заяасан байв. Одоо Бөртийн дөрвөн хөвүүн Тэмүжиний улсын өнө удаан оршин тогтнохын баталгаа дөрвөн бат бэх багана болох ёстой нь хэнд ч тодорхой, тэр дундаа Бөртэд бодоод ч ханамгүй бахдалтай байлаа. Харин өнөө маргаашгүй төрөх гэж буй үрээ охин гэдгийг Бөртэ зөнгөөрөө мэдэж байсан ч тэр харамссангүй. Охид нь өсөж том болоод Чингис хаан эцгийнхээ их улсын жолоо цулбуурыг бэхлэн харь улс аймгийн хан,эздийн хатад болон одно гэдэг нь нэгэнт тодорхой билээ.

Их хатан нь хариугүй төрөх дөхсөн тулгар биетэй,нөгөө хоёр хатны нэг нь нялх биетэй, нөгөө нь бие давхар байсан нь Тэмүжинийг дахин бага хатан буулгах бодолд хөтөлж байгааг Бөртэ зөнгөөрөө мэдэрчээ.

Тийм учраас эрийнхээ сэтгэлийг нэвтэрхий мэддэг эмийн ёсоор тэр шөнө татаар цусны онгон биетэй охин авчруулж Тэмүжинийг баярлуулахаар зэхжээ.Тэдний энэ нууц зугаацлыг хэн ч мэдэхгүй бөгөөд мэдлээ ч буруушаах зүрхтэн үгүй билээ. Бөртэ олзны эмсээс бие бүтэн,нүүр цэврийг сонгон өөрийн дэргэд байлгах болсон нь цаанаа олон зорилготой байв. Ингэж улс гэрийн амьдралд зовлон түгшүүр түр боловч арилжээ.

Тэмүжиний төрсөн хөвүүд болоод үеийнхэн дундаас ялгаран од мэт гялалзан тодорсонд нь Бөртэ Зүчи хөвүүнээрээ бахархан баясах хэдий ч олноос их онцгойроход нь “Богино настай байх бий”гэж бас түгшин бодох болжээ.

Тэмүжин Зүчийг яг өөрийн хөвүүн мэт үзэх болсон нь Бөртэд юу юунаас илүү сайхан байлаа.

Харин Тэмүжинд Зүчийн эр зориг,эрэмгүй чадлаас илүү түүний нэр нүүр олж итгэгдэхийг хүссэн чин үнэнч зан нь таашаагддаг байв. Угаас Тэмүжиний хэн хүнийг үнэлэх хэмжүүр нь үнэнч сэтгэл юм. Өөртөө үнэнч зүтгэх сэтгэлтэй хэнийг ч байсан итгэн нөхөрлөдөг билээ.

Тийм ч учраас Зүчийг хүү гэхээс илүү үнэнч нөхрөө болгохыг тэр хүсчээ.Тэмүжиний сэтгэлийн дотрох энэ нууцыг Бөртэ мэдсэнгүй.

-Чам шиг хатан надад дахиж учрахгүй биз гэсэн нь Чингис хааны чин үнэн сэтгэлийн бас Бөртийг, түүний төрүүлсэн дөрвөн хөвүүнийг бахархсан үг байв.

-Чингис хаан та юун ойрхон бодно. Газар дэлхий уужим, хацар гоо эмс охид хаа мундах вэ. Хаан таныг харийн өөр цусны эм таалаасай гэж би хүснэ. Та дахиад олон хөвүүнтэй болно гэж Бөртэ инээв.

Их гэдэстэй,нүүр сэвхтэй ч нүд хөмсөг нь үзэсгэлэнтэй хэвээр байх Бөртийн харц аальгүй, тачаангуйгаар гялалзаж байхыг Чингис хаан таалан харав. Бөртэ юу хүсч байгааг Чингис хаан төвөггүйхэн тааж байв. Есүгэн хатан бие давхар болсноос хойш тэдний тоглоом хаагдсан билээ. Харин Есүгэний эгч Есүйг Тэмүжин олж хатан болгож авсан ч хэцүү бэрх ухаан, хэрсүү үгтэй Есүйтэй Есүгэний адил харьцаж чадахгүй байсан билээ. Гэвч Тэмүжин Бөртэ хатнаа баясгах өөр аргыг төдөлгүй бодож олжээ.

Тийм болохоор

-Би чамд саяын тулааны олзноос Тайчуудын хорин гоо охин бэлэглэе. Чи үүдээ сөхүүлж, үсээ самнуул гэж Тэмүжин хэлжээ.

-Би тэгвэл охидыг өөрөө сонгон шилж авья. Харин хаан танд өнөө шөнө би үзэсгэлэнтэй татаар эм бэлэглэе. Та охин биеийг нь эвдэж үзүүлэгтүн гэж Бөртийг хэлэхэд энэ юу гэсэн үг болохыг тааж Чингис хаан зугаатайгаар хөхрөв.

- Тулгар биетэй би яах билээ.Таныг харж сууя гэж Бөртэ санаснаа хийсэн хүний ёсоор тачаангүй,эрхэлсэн харц тунаруулан шивэгнэжээ.

-Бөртэ! Би чамайг үхвэл яана гэж саналаа гэж Чингис хаан их хатнаа урамшуулав. Энэ бол Чингис хааны хатнаа бахадсан үг байв.

Тэр шөнө Чингис хаан Бөртэ хатныхаа хамт үзэсгэлэнт татаар охиныг уйлуулан эдэлж хүслээ хангаад өглөө нь зүгээр л цавчиж алсан билээ.

Учир нь тэр хоёрын энэ шинэ зугаацлыг сайтар нуух ёстой гэж Бөртэ шийджээ.Бөртэ хатны мэдэлд байдаг Тэмүжиний олон татвар эмсээс байсгээд л хэн нэг нь сураггүй алга болдгийн учрыг асуух зүрхтэн хэн билээ. Тайчуудыг дарж, буцаж ирснээс хойш нэг их удалгүй Бөртийн хүссэнээр Хонгирад аймгаас бэр буулган Зүчийг гэрлүүлж өрх гэр тусгайлан засч өгөв.

Зүчийг гэрлүүлэх хэргийг Бөртэ Тэмүжиний дэмжлэгийн дор хэнээс ч асуулгүйгээр өөрөө

мэдэн гүйцэлдүүлэв. Ингэж Зүчи Чингис хааны хүрээнд толгой даан амьдарч эхлэв. Энэ явдал Зүчийг Тэмүжиний ууган хөвүүн гэдгийг олны нүдэнд батлан харуулав. Зүчи хөвүүнээ гэрлүүлсэн нь Бөртийн хувьд зовж шаналсаны эцэст олсон жаргал,амьдралын нь их хүсэл биелсэн хэрэг байв.

Бүгдэд ил далд ад үзэгдэж хоёр ч удаа үхлийн зарлиг сонссон Зүчи хөвүүний амь нас одоо л нэг аюулаас ангижрах шиг болжээ. Ямар ч болов Бөртэ ингэж бодож,итгэж,баярлаж байв. Харин Бөртийн энэ тайван амгалан,жаргалтай амьдрал богинохон байсныг тэр мэдсэнгүй.

Бөртийг шинэ зовлон хүлээж байлаа. Тэмүжин Мэргэд аймгийг эзлэн дагуулж,Увас мэргэдийн толгойлогч Дайр-үсэнгийн охин Хуланг хатан буулган авчирсан нь Бөртийн хуучин амьдралын төгсгөл,шинэ зовлонгийн эх болжээ. Бас өнгөрсөн хугацаанд Бөртэ өөрөө хувирч шинэ хүн болсноо ч мэджээ. Бөртэ юуны төлөө хэрхэн тэмцэхээ сайн мэддэг болжээ. Түүний алмай бага насны гэнэн зөөлөн зангаас юу ч үлдсэнгүй. Өөрийнх нь эр нөхрийн өвөр ,үр хүүхдийн ирээдүйг булаалдагч хэнийг ч болов үзэн ядаж,тэр хүнтэй өширхөн тэмцэх зориг хүч,ухаан түүнд нэгэнт цогцолжээ.

Бөртэ одоо Тэмүжиний их улсын дотор хамгийн их эрх мэдлийг атгасан эмэгтэй болжээ.

Үүнийг үл зөвшөөрөх хүн нэг ч үгүй байв.

Мэргэд гарлын Хулан бүсгүйг иртэл ямар ч болов ийм байжээ.

Гоо үзэсгэлэн төгс,зан ааш хурц эрэмгий Хуланд хүйтэн хөндий хандах шалтгаан Бөртэд байсан билээ. Энэ нь ганцхан мэргэдэд булаагдсан гашуун түүхтэй ч холбоотой биш юм. Сэтгэлийн чанад нууц шалтгаанаа Бөртэ хэнд ч илчлэн мэдэгдсэнгүй. Тэмүжин их хаанд өргөмжлөгдсөнөөс хойш Бөртийнд ирж хонох нь илт цөөрч ирсэн ч дуртай дургүй илбэж таалж,эдэлж жаргаах нь бүр холджээ.

Насны жамаар дур тачаал дарагдсан хэдий ч эмийн ёсоор элдэвлүүлэн жаргах адын хүсэл нь буурсангүй нь Бөртэд бие сэтгэлийн шаналал нэмжээ. Эрдээ гологдож хоцорсон эм байхыг Бөртэ яагаад ч зөвшөөрч чадахгүй байв. Эзгүй тансаг өргөөнд эрээ хүсэмжлэн шөнийг барна гэдэг Бөртөөс өөр эм бол тэвчин тэсэхийн аргагүй тамлал ажээ.

Ийн ганцаар хэвтэхдээ халуун нулимсаараа дэрээ нэвтэлж үүр цайлгана. Гэвч Бөртэд гуниж гутарч,зовж шаналж байгаагаа хэнд ч мэдэгдэх эрх байсангүй. Ингэж эм хүний сэтгэл ааш гаргах нь Чингис хааны их хатанд үл зохих тул олны дэргэд хүчээр инээмсэглэж,ихэмсэглэн явахаас өөр аргагүй байлаа. Бөртэ ингэж хоёр амьдралаар амьдрах болсондоо ихэд шаналж ойлгож туслах сэтгэлийн хань эрэлхийлэх болсноо өөрөө ч мэдээгүй билээ.

Тэр сэтгэлийг нь ойлгон энхрийлсэн эр хүйстэн гарвал зүрхээ булиглуулан угтахад бэлэн болоод байв. Зүчийг ойн иргэдийг дагуулан сүр хийморoо бадраан буцаж ирсэн тэр жил Бөртэ дөчин долоон нас хүрчээ.

Бөртэ эхийнхээ ганцаардсан сэтгэлийг хамгийн тодоор ойлгосон хүн бол Зүчи юм.

Тэмүжин эцэг нь өөр эм авчран хатанд өргөмжлөхийг Зүчи хэзээ ч сайшаан дэмжиж байсангүй нь Бөртэ эхийгээ хайрласаных юм.

Гоо үзэсгэлэнтэй бас тэгээд мэргэд гарлын Хуланг хатан буулгахад эх нь яаж шаналж,түүнийгээ нуух гэж зовж байгааг мэдэрсэн хүн бол ганц Зүчи байв.

Хайртай эхийг нь хүч түрэмгийлэн булаасан мэргэдийг үзэн ядах сэтгэл Зүчийн дотор хэзээ ч салахгүйгээр бат шингэсэн билээ. Зүчи өөрийгөө мэргэд цустай гэдгийг хэзээ ч зөвшөөрдөггүйн адил мэргэд хүнийг өөрийн хамгийн өст дайснаа гэж үздэг болон хүмүүжжээ. Энэ бол Бөртийн Зүчи хөвүүндээ сургасан ухаан юм.

Тийм учраас мэргэд цусны Хулан бүсгүйг Чингис хаан эцэг нь хатан буулгасныг эхийгээ доромжилсон хэрэг,бас өст мэргэдийг өршөөсөн явдал гэж Зүчи тооцжээ. Чингис хаан эцгийнхээ итгэлийг олсондоо бардам зоригтой болсон Зүчи энэ санаагаа Бөртэ эхдээ шууд хэлж Хуланг Чингис хааны хүрээнээс үтэр түргэн зайлуулахыг шаарджээ.

Бөртэ хайртай,дуулгавартай хөвүүнээ танисангүй.Зүчийн бухимдал уур хилэн хязгааргүй байсан нь Бөртийг юу юунаас илүү түгшүүлжээ. Ухаан санаа нь байргашиж тогтоогүй хөвүүн нь хэдий зөв юм бодлоо ч өөрийгөө хөнөөх аюултай зам сонгосныг Бөртэ мэдлээ. Зүчийн эхийгээ өмөөрсөн сэтгэл эцэст нь үхэлд хүргэх нь гарцаагүй.

Хөвүүнийхээ догдолж оргилсон сэтгэлийг тайтгаруулж хэргийн цаад гүнзгий учрыг ойлгуулах нь хамгаас хэцүү байлаа. Хуланг хатан буулгасан нь Чингис хааны зарлиг тул Бөртэ эх нь ч зөрөх эрхгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөд Зүчид даанч хэцүү байсан билээ. Юуны төлөө ийм хэцүү бэрх доромжлол амсан амьдрах учиртайгаа ойлгох цаг Зүчийн хувьд арай болоогүй байв.

-Хөвүүн минь чи эхийгээ бүү бод.Би чамайг хүн болгох гэж яаж зовж шаналсныг чи мэднэ. Чингис хаан эцгийгээ хилэгнүүлж өөрийн хайран амийг бүү золиосло. Эм хүний хувь тавилан ийм хойно үүний төлөө дэмий бүү бухимд. Ганцхан өөрийгөө бод гэж уйлж хэлсэн эхийнхээ үгийг сонссон Зүчи тэсэлгүй нулимс унагав.

Зүчи эхийнхээ үнэн үгийг сонсоод өөрийн эрхгүй зөвшөөрөн уураа дарав.Үүнээс хойш Зүчи Хулан хатныг хоёр нүдээр тэгш харахгүй болжээ.

Эх хүү хоёрын хооронд болсон энэ яриаг харин хэн ч мэдсэнгүй. Зүчийг хэдий тайвшруулан ятгаж Чингис хаан эцэгтэйгээ ил зөрчилдөх аюулаас гэтэлгэсэн ч Бөртийн Хулан хатанд хорон санах нь өөрчлөгдсөнгүй билээ.

Тэмүжин мэргэдийн Хулан хатнаа үнэнхүү сэтгэлээр хайрлан Бөртэ болоод бусад хатдаасаа онцгойлон халамжлан энхрийлэх болсныг тэвчихэд хэцүү байв.

Бөртэ ингэж эм хүний атаа хорсолд автсан нь өөрийн болоод өрөөл бусдын олон олон зовлонгийн үүдийг нээжээ. Гэвч Бөртэ ямагт өөрийгөө өмөөрч зөвтгөн бодох учир өш хонзон авах нь түүнд баяр бахдал төрүүлдэг байв. Өш хонзонгийн үл тасрах хор Бөртийн сэтгэлд гүн шингэжээ.

Бусдаас илүү эрх мэдэлтэй хүчирхэг байхын амтанд нэгэнт автсан хэн боловч Бөртийн адил болох биз ээ. Зүчийг гэрлүүлсний дараа Чингис хааны сэтгэл нэг их ачаа авсан мэт хөнгөрч өөрийн юу хийсэн, цаашид хэрхэх ёстойгоо хэд хоног тунгаан шүүж бодов.

Тоорил хантай дахин эцэг хүү болж эвтэй найртай байгаа тул Жамухыг хавсран дарах цаг удахгүй болжээ гэдгийг ойлгож байлаа. Жамух ч энэ хугацаанд зүгээр суусангүй. Тэмүжинг, Тоорил хантай эвдрэлцүүлэх өчүүхэн боломжийг ч болов алдахгүй байлаа.

Харин Тоорил хантай эв эвдрэлцэхийг Тэмүжин огт хүссэнгүй.Худ ураг барилдаж угийн найртай холбоогоо бэхжүүлэх гэсэн Тэмүжиний бодол талаар болов.Зүчи хөвүүндээ Тоорилын охин Чаур бэхийг гуйсанд Тоорилын хөвүүн Сэнгүм зөвшөөрсөнгүй хирнээ харин Жамухатай эвсэн Тэмүжинг хороохоор тохирч “Ураг барилдъя” гэж хууран урьсныг мэжиглээгүй Тэмүжин цөөн цэргийн хамт Сэнгүмийн хүрээг зорижээ. Ашгүй замд хоног таарсан Мэнлиг эцэг хаширлан саатуулсан нь Чингис хааны амийг үхлээс аварсан явдал болжээ.

Хэрэв хууртаж очсон бол Жамуха Сэнгүм хоёр Тэмүжинийг буцалсан тостой нүхэнд унаган хороохоор бэлдсэн байв. Энэ гарцаагүй үхлээс аврагдсан нь Тэнгэрийн таалал байв хэмээн Чингис хаан бодоод их тахилга үйлдэн Тэнгэрт талархав.

Одоо түүний хамгийн заналт дайсан нь Жамуха болжээ. Жамухын эцсийн мөч нэгэнт ирснийг Тэмүжин ойлгов. Агажур бөөгийн догшин сахиус сахин хамгаалж байсныг Жамуха дааанч үл тоомсорлосон билээ. Гэвч Жамухын сүлд хийморь бууран доройтсон учрыг Тэмүжин нэгэнт мэдэхгүй тул бүх зүйлийг өөрийнхөө үзсэнээр шийджээ.

Тэмүжин нүүрнээс далд хуйвалдсан дайснуудаа тэдний огт санаагүй талаас довтлосон нь Хасарын гаргасан ухаан байв. Тэмүжинтэй эцэг хүү бололцон тангараг өргөсөн мөртлөө Тоорил хан, хүү Сэнгүмийнхээ үгэнд автан Тэмүжинээс далдуур Жамухтай эвсчээ. Тэмүжин цөөн цэргээ Хэрлэн мөрний Аргал хохиос хөдөлгөн довтолгосоор Зэгзгэр өндрийн Зэр хавцалд найрлан суусан Тоорил ханы хүрээг дайран орсон нь үүлгүй тэнгэрээс хур буусан мэт санаандгүй хэрэг болов. Хуурай хүү Тэмүжин нь ингэж довтолно чинээ Тоорил хан дааанч санасангүй. Гэвч энэ тал газарт хүнд итгэнэ гэдэг өөрийгөө хорлохтой адил хэрэг юм. Санаандгүй байсан Хэрэйдүүд сандарсан ч гурван өдөр гурван шөнө эсэргүүцэн тулалдаж эцэст нь дийлдэж, Тоорил хөвүүн Сэнгүмийн хамт баруун зүг Алтайн нуруу тийш зугатаж, хүчирхэг Хэрэйд аймгийн хагас нь сөнөж Тоорилын дүү Жаха Хамбу өөрийн албатуудын хамт бууж өгчээ. Хэрэйд аймаг хэдий бутарч сөнөсөн ч түүний үлдэгдэл Жамухтай нийлэн оджээ. Одоо Чингис хаанд Жамуха нүдэнд орсон хог шүдэнд орсон мах болж үлдэв.

Бас зүүн зүгийн арван гурван овог аймаг нийлж Жамухыг Гүр хаанд өргөмжлөн залсан нь Чингис хааны хилэнг бадрааж байв. Энэ бол 1201 оны хавар байлаа. Чингис хаан Жамухыг довтлохоо түр азнаж морьдоо таргалахыг хүлээхээр шийдэв.

Бөртийн ухаалаг шийдэмгий зангийн ачаар Тэмүжин ар гэр авгай хүүхний ажилд огтхон ч санаа зовох юмгүй байдгаа чухам тэнгэрийн хишиг гэж үзэх бүлгээ. Жамухатай байлдахын өмнө сайтар бодож бэлтгэхийг уйгагүй, хичээнгүйлэн шаардсан хүн нь Бөртэ байв. Жамуха бол итгэж болохгүй нөхөр гэдгийг Бөртэ үргэлж сануулсаар ирсэн бөгөөд Бөртийн энэ

хардлага зөв байсныг Тэмүжин олон удаа үзэж мэдсэн тул үгийг нь дагажээ.

Харин ингэхдээ Бөртийн хэлснээр Жамухыг довтлохоо болив гэдгээ хэнд ч мэдэгдсэнгүй билээ. Гэхдээ Бөртийг зөв зүйтэй үг хэлэв гэж Тэмүжин дотроо талархалтай байсан тул Хэрэйд аймгийн олзны олон иргэдээс эрд эдлэгдээгүй,энгэр зөрүүлээгүй зүс гоо охидыг шилэн Бөртэд бэлэглэжээ.

Хулан хатныг авчирснаас хойш Тэмүжин Бөртийг сэтгэлийн дотрох гуниг гомдлыг мэдрэх болсон тул Бөртэд аль болох тал засахыг хичээх болжээ. Бөртэ бол гомдоож мохоож болохгүй хүн гэдгийг Тэмүжин хэзээ ч мартахгүйгээр санаж явдаг бөгөөд үгийн далим алдахгүй хөвүүддээ захиж сургадаг байв.

Бөртэ бол Тэнгэрээс түүнд илгээсэн хамгийн үнэнч нөхөр нь юм гэдэгт Тэмүжин эргэлтгүй итгэх бүлгээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЖАМУХА

Тэмүжиний цэрэгт дийлдэж бутарсан Мэргэд, Хэрэйд, Ойрд Татаар, Салжиуд, Жадаран аймгийн үлдэгдэл одоохондоо бүрэн мэнд байгаа Найман аймгийн Таян ханыг бараадан нэгдээд байсан нь 1204 оны зун байлаа.

Тэдний нэгдсэн цэрэг Тэмүжинтэй Хэрлэн мөрнөөс урагш газарт тулж удирдлага, зорилго сул тул ихэд дарагдан цацсан шагай шиг таржээ.

Харин Жамуха Таян ханы цэргийн үлдэгдлийн хамт Алтайн нуруу тийш зугатжээ. Улсаа алдан доройтсон Жамуха өөрийн эцсийн сүйрэл ирснийг тов тод ойлгож байлаа. Гурван өдөр зогсолтгүй зугатааж нэгэн их хадтай уулын өврийн модтой, устай аманд түр буудаллах зуур Жамуха дуг хийхдээ нэгэн хачирхалтай зүүд зүүдлээд сэрлээ.

Дээр бүрхэг тэнгэр бүүдийж намрын нойтон бороо, цас холилдон орж байжээ. Харин Жамухын үнэнч боол Хантөмөр эзнээ цас, бороонoос халхлан элбэг хантаазаа тайлан бариад зогссоор байхыг үзэв. Дэргэдээс шарсан мах үнэртэж өлссөн ходоодыг дуудна. Жамуха сэрмэгц үсрэн боссонгүй. Сая үзсэн зүүдээ тогтоох гэж нэг бүрчлэн нэхэн санаж хэвтлээ...

...Тулалдааны дараа Жамуха амарч хэвттэл тойрсон олон харуулын хаагуур нь ороод ирсэн юм бүү мэд царай зүс нь юүдэн дороос үл харагдах нэгэн хүн дэргэд нь зогсож байхыг үзээд цочиж сэлмээ шүүрэн босчээ. Хамгаас түрүүлэн хорлох дайсан санаанд оров.

-Чи юун хүн бэ. Миний харуулын хаагуур нэвтрэв гэж Жамуха тэнхээ мэдэн орилтол дуу нь шивнэх шиг сонсдоно. Дуу нь ийм өчүүхэн болсныг мэдмэгц Жамуха учиргүй ихээр хирдхийн цочжээ.

-Чи хэн бэ гэж хулганын дуугаар шивнэв. Өнөө хүн юүдэнгээ тайлахыг үзвэл олон жилийн өмнө Дорнод монголын их талын дундах Халиун өндөр хэмээх өнчин толгойн оройд уулзсан арван найман настай Бөртэ байх ажээ. Жамуха хөгширч сахал үсэндээ баригдсан атал харин Бөртэ огт өөрчлөгдөөгүй цэл залуу, үзэсгэлэн гоо хэвээр байх нь гайхмаар.Огт хувирч өөрчлөгдөөгүй Бөртийг үзээд Жамуха сая л хичнээн хөгширч өтөлснөө мэдэв.

-Гүр хаан. Та намайг танихгүй байна уу. Хүйтэн агаарт Бөртийн ялдам дуу хуур хөгжим татах шиг уянгалав. Бөртийн зөөлөн уянгат дуунд уярах мэт цасан дороос цэнхэр яргуй суга суга ургахыг тэр харжээ.

-Тиймээ. Би чамайг таньж байна. Чи яаж энэ олон харуулыг нэвтрэн ирэв гэж Жамуха гайхсан хэвээр асуув.

-Би одоо ганцхан Гүр хаан танд харагдаж буй. Та санаа бүү зов гэж Бөртэ хэлсэн ч Жамуха эргэлзсээр байлаа. - Чи яах гэж ирэв. Тэмүжин чамайг явуулав уу гэж Жамуха гэнэт учрыг олж шивэгнэв.

-Үгүй. Би өөрөө Гүр хаан тантай уулзах гэж ирлээ.Та юунд ингэтлээ гайхна вэ.

-Юуны учир тэр вэ.Надад Бөртэ чамтай уулзах хэрэг ер үгүй шиг санах юм

-Гүр хаан. Та бол Монгол аймгийн дотроос тодорсон ухаан их, үг цэцэн, зоригт баатар. Үүнийг хэн үгүйсгэн няцаах билээ.Та олны дунд Жамуха цэцэн гэж алдаршсан биш үү. Тэмүжин таны үхлийг үл хүснэ. Та юунд ингэж амиа зольж, алдуул завхуул хулгайч шиг хүн хүний дэргэд очиж хөө шиг санаа өвөрлөж явна вэ. Та Тэмүжинд очиж чин сэтгэлээр зүтгэгтүн. Та хоёр нэгдэх аваас Монголын тал нутагт дийлдэшгүй хүчтэй болох биш үү. Таныг шадарлан очвоос Тэмүжин баяртай угтана. Би үүнийг хэлэх гэж танд ирлээ. Би анх Халиун өндрийн оройд уулзсан Жамуха таныг мартаагүй байна. Та бол цагаан цайлган, энэрэнгүй сайхан сэтгэлтэй хүн шүү. Одоо ч би таныг тийм хэвээр гэж санах тул дээрхи үгсийг хэлж байна гэж хэлээд үзэсгэлэнт Бөртэ инээмсэглэв.

Түүний ингэж ялдам инээмсэглэх нь Тэмүжинд ялагдан мөхөж байгаа Жамухыг тавлаж байх шиг санагдана.

-Бөртэ. Чи энэ үгийг хэнд хэлнэ вэ. Жадаран аймгийн Жамухад уу, эсвэл нэргүй, гэргүй болсон Гүр хаанд уу гэж шаралхаж уур нь шатсан Жамуха хашгирав.

-Би олон жилийн өмнө Халиун өндрийн оройд уулзсан Жамухад хэлж байна. Тэгэхэд бидний дээрээс мэлтийж байсан зуны дунд сарын арван тавны дүүрэн тэргэл сар хэвээрээ байна гээд Бөртэ тэнгэр лүү заахад үнэхээр дүүрэн сар түүний үгийг хүлээж байсан мэт үүлэн цаанаас сугаран гарч иржээ.Сарыг хүртэл гэрч болгохоор дагуулан иржээ гэж Жамуха гайхан бодлоо.

-Тэгвэл чиний таньдаг Жамуха нэгэнт үгүй болжээ. Харин чи Тэмүжиний сүйт бүсгүй Бөртэ мөн байна.Бөртэ чи огтхон ч хувирч өөрчлөгдөөгүй, арван наймтай хэвээр байхад би яагаад ингэж өөрчлөгдөнө вэ гээд Бөртэд ойртов. Харин Бөртэ Жамухын энэ заналт дуунаас ер айж цочсонгүй нь гайхалтай.

-Та үүнийг надаас бүү асуу. Та юу олох гэж, юуны төлөө ингэж үхэлдэн тэмцэнэ вэ.Тэмүжиний дэргэд очвол эрснээ олж та жаргалтай болох биш үү.

-Үгүй дээ. Бөртэ. Би нэг удаа өөрийн аз жаргалтай нүүр тулан учирсан юм. Тэгэхэд л би түүнийгээ алдсан. Би өөрийн аз жаргалыг алган дээрээсээ үргээж алдсан юм. Одоо би түүнийг хаанаас ч олохгүй.Одоо би Тэмүжиний дэргэд очлоо ч жаргал үзэхгүй болжээ…

Гэтэл хэн нэгэн хашгирч Жамуха сэрсэн билээ. Тэр сая үзсэн зүүдээ эргэн санаж хэвтлээ.

Харин очиж очиж Тэмүжиний хатан Бөртэ зүүдэнд ийм тод ордог нь юув гэж гайхан бодов.

Үлдсэн цөөн цэргээ амрааж хэд хонох тул түүнд юм бодох хугацаа хангалттай байлаа.

Хэдийгээр хамгийн ухаалаг зөв шийдвэрийг тэр бүрийд олж гаргаж чаддаггүй ч Жамуха өнгөрсөн болоод ирээдүйгээ тунгаан бодох дуртай билээ. Ингэх нь ганц Жамуха ч биш, ер өөрийгөө ухаантай гэж боддог хүн бүрийн зан юм.

… Бөртийг анх харсан нь одоогоос хорин таван жилийн өмнөх хэрэг билээ. Тэр үед Тэмүжин эцгээс өнчирч, аймгаас хаягдсан нэг муу золбин банди байлаа. Багадаа андгай тангараг тавьж үерхсэнээ Жамуха дурсав. Тиймээ. Жамуха бол Тэмүжинд туслах ёстой хүн юм. Тийм ч сэтгэлээр Хонгирад аймгийн нутгийг зорьж олон жилийн өмнө Тэмүжин хөвүүндээ авч өгөхөөр Есүхэйн сүй тавьсан Дайцэцэний охин Бөртийг үзэхээр одсон билээ.

Угаас Жамуха сониуч, хортой зантай тул баян Хонгирад аймгийн нэртэй хүний охин одоо юу гэж ядуу Тэмүжинд ирээ аж гэж бодсоноо хүнд хэлээгүй ч чухам дотроо өнөө Бөртийг эцэг нь өөр хүнд арилжин өгсөн байгаасай гэж хүсч явсан юм. Тийм байвал даруй Тэмүжинд хэлж яаж шаналахыг нь үзье гэж бодсон хэрэг.

“Арван найман нас хүрмэгц Бөртийг очиж авна. Тэр бүсгүй сар бүрийн арван тавны үдэш Халиун өндрийн оройд хүлээнэ гэсэн” хэмээн Тэмүжин Тоорил ханы гэрт хамт амьдарч байх үедээ Жамухад нуулгүй ярьсан билээ. Яг сая зүүдэндээ үзсэн шиг зуны дунд сарын арван тавны тунгалаг сартай үдэш Жамуха Халиун өндрийн оройд зогсож байгаад дүүрэн сарны гэрэлд Тэнгэрийн амьтан мэт үзэсгэлэнт Бөртэтэй уулзсанаа санав.

Цэцгийн цагаан тоос мэт суунаглан буух сарны гэрэлд Бөртийн гоо үзэсгэлэн хувцсаа нэвт гэрэлтэж байжээ.

Бөртийн биенээс нэвт цацрах гэрэлд сарны цагаан туяа хүртэл өнгө дарагдаад эргэн тойрон харанхуй мэт болжээ.

Ингэж өөрийн биенээс гэрэл цацруулагч үзэсгэлэнт эм зөвхөн үлгэрт гардгийг Жамуха сонссон болохоос ер үзсэнгүй билээ. Тэмүжин худлаа зохиож яриагүйгээр барахгүй, хүүхэд насны сүйт амраг нь нас бие гүйцэж амьсгалд хиртмээр цэвэрхэн бүсгүй болсныг, бас Тэмүжинд амалсан ёсоороо сар бүр болзоот газраа хүлээсээр байгааг Жамуха үзжээ.

Тэр үед Жамуха Тэмүжинд үхтлээ атаархаж, нэрийг нь сонсоод танимгайрхан Тэмүжинг сурж, амар мэнд гэдгийг нь дуулмагц уяран баярлах бяцхан бүсгүйг хүчээр эзэмдэх адын хүсэл нь шатсан ч тэвчин биеэ барьсан юм.

Бөртийн ид шидийн мэт гэрэлтсэн гоо үзэсгэлэнд сэтгэл хүсэл нь хүлэгдээд угийн зоримог шулуун, бардам дээрэнгүй зан нь үгүй болжээ.

-Би Тэмүжинг Тайчуудад алагдсан гэж сонсоод нулимсаа барчихсан. Харин одоо Жамуха танаас амьд гэдгийг сонсоод хэлэх үг огт олдохгүй баяслаа. Та түүнд туслаарай.Тэмүжинд танаас өөр нөхөр байхгүй. Тэмүжин Татаар аймгаас эцгийнхээ өшөөг авах ёстой хүн шүү. Та ганц сайн нөхрийнх нь хувьд Тэмүжинд туслах биз. Би танаас гуйя гэж Бөртэ түүнд итгэн сөхөрсөн нь Жамухын оволзон гарч ирэхэд бэлэн байсан зэрлэг догшин авирыг хазаарлан зогсоосон билээ.

Түүнээс биш Жамуха нүд булаасан эмийг зүгээр сул орхисон удаа ер үгүй тул энэ мэт балчир бүсгүйг бахаа ханган эдлэх нь юу ч биш юм. Гэвч бүсгүй түүнд элдэв хар санаагүйгээр итгэсэн нь, бас Тэмүжин тэр хоёр чин сэтгэлийн холбоотойг үзмэгцээ Жамухын хатуу сэтгэл уярч гэссэн билээ.

Харин саяын зүүдний дараа элдвийг эргэцүүлэн бодож хэвтэхдээ Бөртийг тэр үед өөрийн болгоогүйдээ дотроо хачин ихээр харамсаж явснаа мэдрэв. Тэр үдэш үнэнч шадар Хантөмөр нь хүртэл Бөртийг үзээд сэртэндэж -Тэмүжин одоо хаана, хэн болоод байгаа билээ. Энэ бол ядуу Тэмүжинд олдох бүсгүй биш байна. Эзэнтэн та зүгээр орхивол би хулгайлж авья. Үгүй бол хүчээр эзэмдэн дураа хангаад хаяж орхиё гэснийг Жамуха тас хориглов.

Энэ нь үнэндээ Бөртийг хамгаалахаасаа илүү Хантөмөрөөс харамласан хэрэг байжээ. Бодвол сая зүүдэндээ "Би аз жаргалаа алдсан хүн" гэж энэ явдлыг хэлсэн биз гэж тунгаав. Үнэндээ Жамуха тэр агшинд Бөртэд шунан татагдаж байсан юм. Буцах замдаа хэд хоног дуугаа хураан дүнсийсэн түүнийг шадар Хантөмөр нь ч ойлгож мэдэрч байв. Хантөмөр бол өсөх наснаас Жамухад шадарласан, хэлэх үгийг нь харцнаас нь ойлгодог боол тул эзнийхээ сэтгэлд ямар гээчийн шуурга оволзож байгааг хараад л мэдэв.

-Бөртийг ядуу Тэмүжинээс булаан авах тун ч амархан хэрэг биш үү. Та юунд нь эргэлзэж шанална вэ. Хүсвэл надад тушаагтүн. Би бэлэн байна… Ийм үгийг харьсан хойноо Хантөмөр хэлсэн билээ.

Гэвч ямар эм мундсан биш, нэг удмын Тэмүжиний сүйт бүсгүйг булаан авах нь туйлын зохисгүй явдал гэж Жамуха үзсэн тул Хантөмөрийн хортой үгэнд автсангүй. Бас Есүхэйн гэнэтийн үхэл Бөртэ, Тэмүжин хоёрын сүй тавьсныг олонд зарлаж мэдэгдсэн тул Бөртийг булаан авах нь одоохондоо түүний мэдэлд байгаа Боржигон аймгийн олон иргэдийн дургүйг хүргэх аюултай байв.

Есүхэйн оронд хан суух илэрхий хүчтэн байхгүй, бас Тэмүжин нялх байснаас болж задарсан болохоос Боржигон аймгийнханд эргээд нэгдэх эрмэлзлэл хүчтэй хэвээр байсан зэргээс үүдэн Есүхэйн хөвүүн Тэмүжиний эсрэг улаан цайм, ил тод хөдөлвөл юу болохыг Жамуха сайтар тооцсон билээ. Есүхэйн ууган хөвүүнийг шинэ толгойлогчоо болно гэсэн итгэл Боржигон аймгийнхны дотор хүчтэй хэвээр байгаа нь тод мэдрэгддэг байлаа. Гэхдээ Жамуха Есүхэйтэй холын удам угсаа нэг учраас Боржигон аймгийн хагас иргэн эхний үед түүнийг бараадсан юм. Тэднийг дэргэдээ барихын тулд Тэмүжин болоод Есүхэйн гэр бүлийнхэнд найрсаг биш юм гэхэд дайсагнан хандаж болохгүй, бас улаан цайм дэмжиж Тэмүжиний хүчийг нэмэх нь олсон иргэдээ буцааж алдахад хүргэх тул Есүхэйн албан ёсны залгамжлагч Тэмүжинг хөндлөнгийн хүний гарт үхээсэй гэж Жамуха хүсч явсан бөгөөд ийм ч учраас Тэмүжинг зөнд нь мартсан мэт орхисон билээ. Тэмүжин бол Жамухын хувьд багын анд боловч Боржигон аймгийн иргэд түүнд дагаж ирснээс хойш өрсөлдөгч нь болов.

Гэхдээ өнчин хоцорсон ядуу Тэмүжинг хоосон нэрнээс цаашгүй ёс төдий өрсөлдөгч гэж үзэж байв. Тэр үед Есүхэй эцгийнх нь хуучин их алдар нэрнээс өөр юм Тэмүжинд байгаагүй нь ингэж үзэхэд хүргэжээ. Тийм учраас Жамуха Тэмүжинд эхний үед өрөвч өгөөмөр агаад харамгүй тусч сэтгэлээр хандаж байлаа.

Харин энэ бол түүний уучилж болшгүй алдаа байсныг одоо тэр ойлгов.

Бүх юм Бөртийг Тэмүжинд өгснөөс болов гэж ухаарах бүр Хантөмөр гэх энэ тэнэг мунаг боолын гэнэ гэнэ хэлсэн үгийг дагах минь яав гэж харамсах сэтгэл хүчтэй төрж ыгалзуурулах шахна.

-Надад хоёр зуун цэрэг өгөгтүн. Би очоод тэр Тэмүжинг, эх өнчин дүү нарын нь хамт цавчин алаад Ононгийн мөсөн доогуур хийж орхиё. Таны шаналахыг хараад тэвчин сууж чадахгүй нь. Одоо Тэмүжинг алга болов, үхэв гээд хэн ч эрж сурахгүй. Тэгээд би тэр Бөртийг танд булаан авчирч өгье…

Хантөмөрийн ингэж хэлснийг зөвшөөрч цэрэг өгч мордуулсан бол өдийд ингэж үхэл, ялагдлаа хүлээн хэвтэхгүй байсан ч байж мэднэ. Жамуха энэ бүгдэд өөрийгөө буруутган яллах санаагүй байв. Харин чухам тэр үед яагаад Тэмүжинг алах санаа төрөөгүйг гайхав. Яагаад.Тэмүжин яагаад амьд үлдэв. Түүнд дайсан олон байсан. Жамуха биш юм гэхэд өөр хэн нэг нь Тэмүжинг яагаад алж орхиогүй юм бол.

Бүр олзлон аваачсан мөртөө тайчуудын Таргудай Тэмүжинг алж орхиогүйг гайхаад барсангүй.

Таргудай Тэмүжинг олзлон авсныг сонсоод “Тэмүжиний үхэл иржээ” гэж Жамуха итгэсэн билээ.Учирсан үхэл болгоноос могой мэт гулсан зугатаж оддог чадвар Тэмүжинд хаанаас бий болов гэж гайхан бодож хэвтлээ.

Зээрэн хавцалд Тэмүжинг оруулж хашсан тэр тулааныг эцэст нь хүргэж түүнийг үхүүлэхгүй орхисон нь бас л Жамухын буруу юм.

Тэмүжиний нууцаар ирүүлсэн Зүчи, Цагадай хоёр хөвүүнийг нь үзмэгц Жамуха бүр нулимсаа нуун байж уярсан билээ. Тоорил ханы гэрт цуг амьдарч байхдаа тавьсан тангаргаа сануулж хөвүүдээ баталгаа болгон ирүүлснийг үзээд Жамуха юунд ч юм хачин ихээр догдлон уярч, Тэмүжиний үнэнч сэтгэлийг бодохоос бүр ичиж, бас бахархсан билээ.

Нэг муу адасганы хулгайнаас болж андын тангаргаа эвдэн түрүүлж довтолсон буруутан нь яах аргагүй Жамуха байв.

Дээрх хэргийг зөвхөн шалтаг болгон цэргээ хөдөлгөн дайрсныг шүүмжилсэн Тэмүжиний үгийг Зүчи шингэн цээл дуугаар цангинуулан хэлэхэд Жамуха ичсэндээ нүүр улайсан билээ. Харин Зүчи Цагадай хоёрыг дагаж ирсэн цэргийн хачин этгээд загасан нүд одоо ч сэтгэлд нь хадаастай дүрлийтэл харц салгахгүй ширтсээр байсан нь үзэгдэх шиг болоход нүдээ анив. Гэсэн ч өнөөх загасан нүд огт цавчихгүйгээр өөдөөс нь ширтсээр байв.

-Нүд нь сохормор гэж Жамуха үүнийг тэвчиж эс чадаад хараал тавин нүдээ нээжээ. Түүнийг унтаж байна гэж санасан Хантөмөр эзнээ гэнэт дуугарсанд цочин давхийж дахин юу гэх бол гэж хүлээсэн ч Жамухын амнаас үг унасангүй.

-Тэмүжин заль мэх гаргаж байна. Бүү авт. Зээрэн хавцлыг цаг алдалгүй дайран оръе. Үгүй бол энд хэсэг цэргээ үлдээж Тэмүжинг өөрөө оготно мэт гэрч ирэхийг хүлээе гэж тайчуудын Бухдадар баатар шаардаж байсан билээ.

- Боржигон аймгийн мөхөл Жамуха чиний гарт байна. Хийснээ гүйцээгтүн гэхийг нь Жамуха бас л тоогоогүй. Андын тангаргийг сануулж Тэмүжиний цээжлүүлсэн үгийг Бөртэ эхтэйгээ гайхалтай адилхан нүд хөмсөгтэй Зүчи шингэн дуугаар давтан хэлэхэд Жамуха үнэхээр

нулимс унагасан билээ.

Харин Цагадай хөвүүн яг л Тэмүжиний арван настай үеийг санагдуулна. Тэр хоёр хөвүүний гэнэн, итгэмтгий царайг үзмэгц үүнээс илүү дотно хүсэлт, андын тангаргийн баталгаа гэж хаа ч байхгүйг Жамуха ухаарав. Бас Тэмүжиний тэнэг зоригийг, хөвүүдээ хайрлахгүй хатуу сэтгэлийг гайхав.

Юуны учир тэр ингэж Бөртийн болоод өөрийн хөвүүнийг үхэл рүү явуулсныг тэгэхэд ойлгоогүй юм. Харин одоо Бөртийг зүүдэлснийхээ хойно чухам юуны учир Тэмүжин ийм хатуу чанга зориг гаргасныг ойлгож байв. Тэр зөвхөн өөрийн амийг авч гарахын тулд ингэжээ. Хар амиа аврахын тулд Тэмүжинд юу ч хайран биш ажээ.Өөрийн өмнөөс хэнийг ч байсан золиослож чадах хатуу харгис зориг тэвчээр нь Тэмүжинг үхлээс аварчээ гэдгийг ойлгов.

Жамуха хоёр өдөр учрыг тунгаан бодоод эцсийн эцэст адуу дээрэмдсэнээс болж хийсэн энэ тулааны зорилго биелэв гэж тооцон Тэмүжиний найрамдах саналыг хүлээн авч цэргээ татан Зээрэн хавцлаас буцсан билээ.

Харин Зүчи, Цагадай хөвүүдийг нь авч гэртээ суулгаад Тэмүжиний хэрхэхийг нь хүлээхээр шийдсэн ч олибо оготно шиг Зүчи дүүгээ дагуулан өнөөх хачин загасан нүдэт дагуулынхаа хамт Хантөмөрийн хамар дороос оргон зайлжээ. Тэд чухам яаж оргож чадсаныг хэн ч мэдсэнгүй. Гэвч Жамуха үүнд харамссангүй. Учир нь чонын бэлтрэгийг суйлж гэртээ агуулах нь эх чонын дайралтыг өөртөө татах аюултай байдгийн адил Тэмүжин хөвүүдээ зүгээр орхихгүй нь ойлгомжтой. Энэ бол Тэмүжиний амь нас түүний гарт хамгийн ойрхон байсан тохиолдол юм. Гэтэл тэр Тэмүжиний ов мэхэнд хууртан сайхан боломжийг алдсанаа ухаарах тусам хорсон гашуудавч баршгүй байлаа.Тиймээ. Тэмүжин түүнийг хуурсан,бүр бүх насаар нь хуурсаар ирсэн мэт санагдаад болсонгүй.

... Тэмүжин сүй тавьсан Бөртийгөө авчирч хуримласан тухай мэдээг Жамуха сонсоод галзууртлаа уурлав. Түүний яагаад ингэж бухимдсаны цаад учрыг сайн мэдэх Гүрвэлжингоо хатан нь өөрийн атаач хортой зангаасаа болж туйлгүй ихээр хэлмэгдэн зовсон билээ. Тэр үед Жамуха Гүрвэлжингоог Найман аймгаас авчраад удаагүй байв. Анхны цаснаар авд цэрэглэн мордсон Жамуха сар гаран яваад эргэж ирэв.

Эрээс хагацаж хагсарсан Гүрвэлжингоо угийн тачаангуй зангаар эцэж ядарсан Жамухыг ноолж ноцож ханахгүй ажээ. Энэ турк цустай, өндөр хамартай бүсгүй угийн халуун янаг нь хэтэрхий билээ. Харин Жамуха ан хийх зуур Салжиуд аймгаас булаасан хэдэн бүсгүйг ээлжлэн эдэлсээр хамаг хүч шүүсээ барсан тул Гүрвэлжингоогийн янаглал түүнд үнэндээ ядаргаа зовиуртай байсан агаад уур уцаарыг нь хүргэвч шүд зуун тэсч хэвтэв.

Тэгэхэд Жамуха Харлаг ханы ард Хар тохойд өвөлжиж байлаа.Их цас газрыг нэвсийтэл дарж Жамухын өвөлжөөний эргэн тойрон нүдгүй дун цагаан болоод хар жавар тачигнаж, үхрийн сүүл хуга хөлдөж унасан хахир хүйтэн өвөл байлаа.Харин задгай гал өрдсөн давхар бүрээстэй гэрт халуу дүүгэн дээврийн цас хайлж уур савсана. Эр нь түүнийг эдлэх хүсэлгүй байгаа нь Гүрвэлжингоогийн сэтгэлд яахан нийцэх билээ. Хор шар, уур зэвүүцэл нь буцалж байвч бас яах учраа олохгүй тачаадсан, бухимдсандаа оволзтол амьсгаадаж хэвтэл гэнэт

сайхан санаа төрөх нь тэр. Гүрвэлжингоо эрийнхээ цээжийг дэрлэн наалинхай сайхан аашлана.Жамухын сэрэлгүй алмай байдлыг яаж эвдэн бусниулахаа тэр сайн мэдэж байв.

-Жамуха та сонсов уу гэж Гүрвэлжингоо уран нарийн хуруугаараа Жамухын нүцгэн цээжийг илбэж хурц харцаа царайд нь сэм сэм тусгана.

-Юу тэр вэ гэж Жамуха гэнэгүй гүнгэнэн дуугарав. Эм нь ашгүй түр зуурч болов халуун тачаалаа умартан сатаарсанд Жамуха баясаж гэнэн санамсаргүйгээр хариу дуугарчээ. Тэр юу юугүй унтах гэж байв.Өвдгөөр татсан цасан дунд олон хоног мацаж гахайн ан хийсэндээ бие нь буларч ядарсан ажээ.

-Өнөө танай садан Тэмүжин эхнэр буулгаж хурим найр хийсэн гэнэ. Эхнэр нь их үзэсгэлэнтэй, Бөртэ гэдэг бүсгүй гэнэ ээ гэж Гүрвэлжингоо өөрт нь огт сонирхолгүй байгаа мэт хайш яйш шивнээд амьсгаа даран хүлээв. Гүрвэлжингоо өөрийн энэ үгийг Жамухад яаж нөлөөлөхийг мэдэж байлаа. Учир нь Бөртэд Жамухын яаж ханддагийг Хантөмөр шадар нь Гүрвэлжингоотой нууцаар садарлаж байхдаа олон удаа хэлсэн байв.

Жамуха олон эмтэй, эмс нь ихэвчлэн гэр гэртээ уйтгарлан суух тул Гүрвэлжингоо Жамухын шадар Хантөмөрийг уургалан авсан билээ. Ингэх нь түүний өөрийгөө хамгаалах, бас Жамухыг сайтар танихад хэрэг болно гэж тэр боджээ. Хэдий эзний нь хатан боловч Жамуха эмс хүүхнүүдийг ер хүн гэж тоодоггүй огтхон эрээлэх цээрлэх юмгүй загнадаг тул Жамухаас ичиж эмээх явдал Хантөмөрт байсангүй.

Дур ихтэй бүсгүйг эзнийхээ нүд хариулан өргөө гэр, өвсөн дотор гээд хаана боломж гарна эдэлж байх болсоор уджээ. Харин ингэхдээ Гүрвэлжингоогийн далд санаа зорилгыг тааж мэдсэнгүй.Ийн янаглах зуур бүсгүй сонирхон асуух зүйл их ч Хантөмөр ер нууж хаах юмгүй элдвийг чалчина.

Зөвхөн үүнийх нь төлөө түүнд биеэ эдлүүлдэгийг, бас ингэхдээ огих шахан нүүр амаа буруулдагийг болхи толхи Хантөмөр анзаарах сөхөөгүй зүгээр л хормойг нь ярж хөлийг нь алцайлгахыг хүсэх бүлгээ.

Ийм нэг янаглалын үед Хантөмөр Бөртийн тухай саймшран буржээ. Түүнээс хойш Гүрвэлжингоо Жамухын сэтгэлийн угт тэр үл таних Бөртэ гэгч бүсгүй ямархан байр эзлэн оршдогийг эм хүнийхээ зөн совингоор гүнзгий мэдэж атаархах болжээ. Жамуха өөрийг нь сэтгэлийн угаас хайрлан үздэггүйг Гүрвэлжингоо сайн мэднэ.

Тэр Жамухын хувьд уйдсан үедээ зугаагаа гаргаж хүслээ хангах эм төдий юм. Гүрвэлжингоо бол Жамухын хувьд замд учрах хоньчин хүүхнээс огт ялгаагүй. Билчээр газар таараад царай зүс тааламжтай бол үг дуугүй хүчиндэж орхиод явчихдаг тохиолдлын хүүхнээс дээрдэх юм түүнд байсангүй. Найманы Буйраг хаан Хорезм улсаас бэлгэнд ирсэн татвар эмээсээ төрсөн Гүрвэлжингоог Жамухад нөхөрлөсний бэлэг болгон өгчээ.

Эр нь хэзээ хүснэ тэр үедээ л хэрэглээд хаяж оддог амны алчуур шиг амьдралаа тэр үзэн ядаж байв. Гэвч түүнд бас үүнээс өөр амьдрал үгүй юм. Тийм болохоор Жамухад хонзогнон аль таарсан эрчүүдтэй шалиглаж сэтгэлээ тайтгаруулах болжээ.Жамухын сэтгэлд гүнзгий

байр эзлэн орших Бөртийг хорлохсон гэж, Жамухын сэтгэлээс түүнийг хөөн зайлуулахсан гэсэн атаач эмийн хүсэлд автсаар уджээ.

Тийм учраас хорон санаалж яг өнөөдөр Тэмүжиний хуримын тухай дурдан Жамухын тарчлан шаналахыг үзэж сэтгэлээ тайтгаруулахыг хүссэн билээ. Гүрвэлжингоо үгээ хэлээд өндийхдөө түүний царай хэрхэн хувирахыг харах гэж хүсчээ.

Гэтэл Жамухын царай хувирсангүй унтсан мэт хэвтэнэ.Сая хэлсэн үгийг нь анхаарч сонсоогүй байсанд хор нь хөдлөн босч суугаад

-Тэмүжиний хуриманд манай аймгаас очсон хүн ч байгаа.Тэмүжин анд чинь чамайг залсангүй дээ. Юуны учир тэр вэ гэж Гүрвэлжингоо арай чанга хэлэв.”Бодвол Бөртэд сэтгэлтэйг чинь мэдээд тэр биз” гэж гүйцээн хэлэх гэснээ хэлээ хазан дуугүй боллоо. Ингэх нь арай ч хэтэрсэн хэрэг болох байв. Жамухын завьж таталдан нүүрэн дээрээ тавьсан гарынх нь булчин овойж зангирахыг Гүрвэлжингоо харлаа. Түүний үг байгаа оносны гэрч энэ юм. Жамуха гараа нүүрнээс холдуулж түүнийг цоо ширтэв. Гүрвэлжингоо түүний харцнаас айн цочив.

-Намайг юунд ингэж ширтэнэ вэ. -Чи яах гээд байгаа юм. Юу хүсээв хэмээн Жамуха гэнэт заналтай шивнэв.Жамухын ингэж гэнэт хилэгнэх нь ер сайн ёр биш билээ.

-Би… гээд Гүрвэлжингоо гүйцээн хэлэх гээд үг олдохгүй гацаж хэрэг бишдэж байгааг мэдмэгц айхдаа түүнд наалдан

-Миний дур хүрээд байна. Намайг эдлээд өгөөч дээ гэж ороо нь орсон гичий адил гийнан эвхрэв .

Үүнээс өөр арга тэр мөчид сэдэж чадсангүй. Гэвч буруудсанаа тэр дороо мэдлээ. Жамуха үсрэн босож түүнийг үсдээд үг хэлэхийн сөгөөгүй болтол балбаж гарав.

-Яаж байна аа… Ёо… Ёо …гэж Гүрвэлжингоо хашгирна.

-Чиний дур хүрч байна гэв үү. Би чиний дур хүслийг чинь хангаад өгье. Чамайг гаргаж цэргүүддээ өгч эдлүүлье… Яасан их дур хүсэлтэй хүн бэ чи… гэж Жамуха галзуурсан юм шиг хашгирч үүд рүү чирч аваачив.

Гүрвэлжингоо түүний хоёр хөлнөөс тас тэврэн -Өршөө …Би дэмий үг хэллээ. Дахиад хэзээ ч тэгэхгүй.Өршөө гэж нулимс урсган гуйв. Жамухын хорсол буцалсаар тул

-Би чамайг ална… Завхай эм… гэж Гүрвэлжингоог хайр найргүй өшиглөж нүдэв. Бүсгүйг муужран хөдлөхөө байтал тэр ийн хашгиран өшгөчсөөр байлаа. Үүнийг гадаа зогсох Хантөмөр сонссон ч орох зүрх хүрсэнгүй.

Хэрэв орсон бол Хантөмөр ч сайнаа үзэхгүй байв. Жамуха амьсгаадаж ядраад ширдэг дээр тэрийн унав. Сэтгэл санаа нь хоосорч эзгүйрээд уйлмаар санагдана. Гэвч тэр уйлсангүй тооноор мэлтийх сарыг ширтэн гөлөрч хэвтлээ.

Сэтгэлдээ сарны туяан дор биеийн дотроос гэрэл цацруулан зогссон Бөртийг бодож байжээ.

“Тэгэхэд яг ийм сар гийж байсандаа” гэж бодоход гол нь тасрах шиг шархиран өвдөж харамсаж гашуудсандаа гаслан хавханд ороод хөлөө тас хазсан чоно шиг архиран дэрээ хэмлэн өнхрөнө. Аманд нь эмтэрсэн шүд нь шажигнан элс шороо зажилж байх шиг сонсдоно.

Бөртэд хичнээн ихээр шунан дурлаж явснаа Жамуха энэ мөчид харамсан харамсан мэдэрчээ. Энэ бол түүний үзсэн хамгийн бэрх тамлал байсан билээ. Энэ өдрөөс хойш Жамуха Тэмүжинг хамгийн өст дайснаа гэж үзэх болов. Гүрвэлжингоогийн хорт үг хэргээ биелүүлж Жамухын дотор Тэмүжинээс өс авах галыг дүрэлзүүлж орхисон бөгөөд үүнээс хойш Гүрвэлжингоо энэ галыг хүссэн үедээ хөөрөгдөн асааж сурсан билээ.

Бэлбэсэн эм Өүлэний толгойлж асан Есүхэйн удамд Бөртэ ирснээр Тэмүжин бүтэн нэртэй болж Есүхэйн залгамжлагч хэн бэ гэдгийг бүгдэд сануулсан хэрэг боллоо. Дэргэд нь байсан Есүхэйн иргэд ч хөдөлгөөнд орж санаа сэтгэл хувирч байгаа нь өдрөөс өдөрт тод болох тул Жамуха сэтгэл нэн түгшүүртэй байх болов. Жамуха тэгэхэд Эргүнэ мөрний арвин дэнжид Хатиган аймгийн Цоорс-Энгүүр баянтай шадарлан намаржиж байв.Хэдийгээр намар цаг найр цэнгэлийн үе ч гэлээ амарч жаргах хүсэл Жамухад төрсөнгүй.

Тэгээд нэг өдөр -Сайн анд Тэмүжин маань өрх гэрээ үүсгэж байхад би яаж түүнд бэлэг барихгүй байж болох билээ гэж Хантөмөрт хэлжээ. Жамухын энэ үгний цаад учрыг олоогүй Хантөмөр ихэд баясан

-Та Тэмүжинд юу бэлэглэнэ. Би даруй хүргэж өгье гэж дуу алджээ…

-Чи ямар бэлэг өгвөл зүйтэй гэж санаж байна? -Эзэн минь. Би яаж мэднэ гэж Хантөмөр үнэнээ хэлэв. Олон долоон юм чалчиж, хэрэгтэй, хэрэггүй санаа бодол хэлж ухаантай зан гаргадаггүй, хүслийг нь дагаж. хэлснийг үг дуугүй биелүүлдэгт нь Жамуха Хантөмөрт дуртай тул түүнийг үргэлж дэргэдээ байлгах билээ.

Хантөмөрт өөрийн гэр орон, эхнэр хүүхэд гэж үгүй. Зөвхөн Жамухын халуун амийг хамгаалан сахих үүрэгтэй шадар цэргүүдийг ахлагч энэ эрийг бас хайрлахгүй байхын аргагүй юм. Хантөмөрөөс өөр хэн ч байсан Жамуха үл итгэнэ.

-Чиний ингэж толгой тархиа зовоохгүй хялбар амьдарч сурсан чинь надад их таатай байдаг юм гэж Жамуха үнэнээсээ хэлээд -Тиймээ.Тэмүжинд ямар бэлэг өгөхийг чи яаж мэдэх билээ. Харин би ямар бэлэг өгөхөө мэдэж байна гэж инээв.

-Морь уу, эсвэл алтан бүс үү.

-Хантөмөр чи үнэнч боловч тэнэг амьтан юм. Би Тэмүжинд бүх насаараа мартаж чадахгүй тийм л бэлэг өгөх ёстой.

-Алтан бүснээс илүү үнэтэй юу байдаг юм бэ гээд Хантөмөр юу юм бол, мэдэхсэн гэхээс байж ядна.

-Чи мэргэдийн Тогтоэбэхтэй очиж уулз. Намайг болзон таатай сайхан ярилцъя гэж хэл. Хаана, хэзээ уулзахыг тэр өөрөө мэдэг. Уулзах товыг чи ирэхдээ мэдэж ир гэж Жамуха зальтай хэлэв.

-Мэргэдийн Тогтоэбэх ээ.

-Тиймээ.Чи зөв сонсчээ. -За би мордъе.

-Битгий сүр болж олон цэрэг дагуулаарай Хантөмөр дахин юу ч асуулгүй мордсоноос хойш хоёр сарын дараа Тогтоэбэхийн болзсон газар болох Сэлэнгэ мөрөн Байгаль нуурт цутгадаг тэнүүн сайхан тохойд Жамуха түүнийг хүлээж байв. Мэргэд аймагтай илэрхий дайсагнах явдал ойрд үгүй тул тэдний уулзалт найрсаг болох ёстой юм.

Мэргэдийн толгойлогчдын нэг Тогтоэбэх Жадаран аймгийн Жамуха яавч зүв зүгээр нэг хэрэгт ийн хэл дол болохгүй гэж санан уулзахаар ирсэн ч Жамуха яаж ч мэдэх ааштай гэгдэх тул болгоомжлон цөөн биш цэрэг дагуулж байдлыг тандан хол зайтай хүлээн зогсоход Жамуха ганцаар угтан очив. Нэгэнт Жамуха ийм итгэлтэйгээр ирсэн учир Тогтоэбэх хүлээн зогсох нь эвгүй тул угтан хөдөлж болзсон хоёр өөрсдийн цэргээс тасран ойртон ирцгээв. Тогтоэбэх насаар ахмад бас уулзах хэл өгснөөрөө Жамуха эхэлж дуугарах ёстой байв. Жамухад Тогтоэбэхээс айх ичих зүйл үгүй тул тэр бардам ихэмсэг байлаа. Холын хол Хивчаг аймгаас авчирсан урт хүзүүтэй өндөр хөлтэй хээр азаргаа Жамуха гайхуулах мэт дор нь эргэлдүүлнэ. Цул алтан гулдмай өгч захиж авчруулсан энэ морь хавь ойрын нутаг усанд ховор тул Жамуха чухал айлчлал ёслолын үед л энэ хүлгээ унах бүлгээ.

Тогтоэбэх алтан бүсээ бүсэлж дайны бэдэрт буурал морио унасан ч тэнгэрт дүүлэн алдан дүүхэлзэх Жамухын моринд харц нь өөрийн эрхгүй унах ажээ.

Сэлэнгэ мөрний ус дэргэд мэлтэрч Байгаль нуурын зүгээс сэрүүн агаар сэнгэнэнэ.

-Тогтоэбэх. Та бүү гайхагтүн. Би чамд үргэлж сайн сэтгэл өвөрлөх тул уулзъя гэсэн юм гэж Жамуха айлын зайнаас хашгирч угтав.

-Надад хэлэх үгээ бушуу хэлэгтүн гэж Тогтоэбэх ширүүн бас ихэмсэг дуугарна. Тэдний юу хэлэлцэхийг хэн ч сонсохоргүй зайтай байв. Омголон морьд нь эргэцэж цэргүүдийн төмөр дуулганд нарны туяа ойн гялс гялс хийнэ.

-Би мэргэдүүд та нарын мартсаныг сануулж унтсаныг сэрээх гэж ирлээ Жамухын энэ хорон үг Тогтоэбэхийн ихэмсэг занг хөдөлгөж уурыг хүргэнэ.

-Жамуха би чамайг сул үгтэй зальхай хүн гэж сонссон. Чи юун дэмий үг чалчив.

-Бүү уурла. Тогтоэбэх. Хэдийгээс эхлээд мэргэдүүд та нар Есүхэйн Тэмүжинг ивээн хайрлах болов. Есүхэйн өнчин хөвүүн эхнэр буулгаж өрхөө үүсгээд удлаа. Тэр нэгэн цагт Есүхэй чиний дүү Чилэдүгийн эхнэр Өүлэнг булааж авсныг чи мартав уу. Аль эсвэл мэргэдүүдийн ухаан нь уландаа орж энэ явдлыг бүгдээрээ мартав уу… Тэгвэл би чамд сануулах гэж ирлээ Жамуха түүнийг юунд өдөөн хатгаж байгааг Тогтоэбэх шууд ойлгов.

Тэр дурдсан явдал бол өнөөг хүртэл мэргэдүүдийн цээжинд байгаа цэр, биенд ургасан ур мэт хонзон юм. Харин юуны учир Жамуха түүнийг өнөөдөр сануулав гэдгийг таах гэж Тогтоэбэх бодолд оров.

-Жамуха. Чи дэмий юм бүү чалч. Юу хийхийг бид чамаар заалгах болов уу. Өөр хэлэх юм байвал хэлэгтүн.

-Чи мартсан байж. Тэгвэл би Чилэгэр бөх дүүд чинь сануулъя. Чилэдү ах нь аваль эм Өүлэнгээ эдэлж энхрийлж ч амжилгүй Есүхэйд булаалгасныг тэр арай ч мартаагүй биз. Эсвэл мэргэдүүд та нар тийм хулчгар дорой улс юмсан уу. Хүч чинь хүрэхгүй гэж Тэмүжинээс айгаа юу.Тэмүжин одоо дөрөө харших нөхөргүй, дөмөг сайн моригүй, ууланд бүгэж, усанд шургаж яваа биш үү.Гэвч Тэмүжин одоо өдрөөр өсч, цагаар цадаж байна. Тэгэхэд та нар доромжлуулснаа ч мартчихаад ичсэн тарвага шиг унтаж байгаа биш үү гэж Жамуха хор малтан хэлж доогтойгоор чанга чанга хөхрөөд хариу үг ч сонсолгүй эргэн давхив.

Жамухын морины туурай газрын хөрсийг өм өм татаж шавар шороо нүүрэнд нь тусахад Тогтоэбэх хорсол заналдаа галзуурах шахав. Тэр Тэмүжинд биш, хуучин шархыг хөндөж аймаг омгоор нь доромжлон гутаасан Жамухад уурсав. Болдогсон бол цэргээ хөдөлгөн Жамухыг нэхэн очоод хорон хэлтэй түүнийг харван алах хүсэл оргилсон ч тэр тэгсэнгүй морио эргүүлэн гэдрэг буцлаа.

Энэ бол Жамуха л хэлж сануулсан болохоос биш уг нь олон удаа дурсагдан яригдсан, бас ч үгүй нэлээд халуун хэрүүл маргааны эх болсон хэрэг билээ. Есүхэй хүчирхэг байсан болохоор Өүлэнг эргүүлэн авах гэж оролдох нь мэргэдүүдийн хувьд үхэлтэй адил хэрэг гэж ихэнх нь үзсэн учраас эхнэрээ алдсан их Чилэдү мухардсан юм. Учир нь Өүлэнээс болж Боржигон аймагтай тулаан үүсгэхийг мэргэдийн нөгөө хоёр гол удирдагч Дайр-Үсэн, Хаатай Дармала хоёр дэмжээгүй учраас Тогтоэбэх ганцаардаад яаж ч чадаагүй билээ.

Тэгээд ч их Чилэдү угийн сэтгэл зөөлөн халирамхай хүн учир дахин дахин шаардаж нэхэхгүй орхисон тул нэгэнт хүний хэрэг болохоор бусад нь юу гэх билээ. далгүй Чилэдү өөр эм авч сатаарчээ. Харин Чилэдү Өүлэнг алдсанаас хойш арван хэдэн жилийн хойно гэнэт сураггүй алга болсон тул энэ явдал бүрч мартагджээ. Гэтэл бараг мартагдсан тэр явдлыг бүхэл бүтэн овгийн нь нэр төртэй холбон Жамуха хортой доромж үгээр нэхэн сануулав. Нээрээ ч Тэмүжин одоо мэргэдүүдийг эсэргүүцэж чадахгүй нь үнэн байлаа.Иймд түүнээс Бөртийг булаан авах нь ч бага хэрэг мэт. Харин Тэмүжинг олзлон авч өөрийн омогт авчран боолын ёсоор суулгавал ёстой нэг өсөө авсан болно доо гэж Тогтоэбэх бодов.

Учир нь одоо монголын тал нутагт Тэмүжинг өмгөөлөн хамгаалах хүн хүч нэг ч үгүй тул айх зүйлгүй ажээ. Эсвэл бүр түүнийг барьж Боржигон аймгийнхантай эртний өс хонзонтой татааруудад өгвөл их үнэ хүрэх магад гэж баясан бодоод Тогтоэбэхийн уур гарчээ. Буцах замдаа тэр Жамухын хорон үгийг мартаад Тэмүжинг эрж олохоор бат шийдэж морио гуядав.

Харин Жамуха гэрийн зүг баг цэргээ дагуулан инээд хөөр дүүрэн давхиж явлаа. Тэр Тэмүжинд хэзээ ч мартахгүй бэлэг барив хэмээн сэтгэл ханажээ. Харин түүнийг Мэргэд аймгийн дотрох гурван том овгийн нэг болох Удуйд мэргэдийн толгойлогч Тогтоэбэх хэмээгчтэй энэ алс хээр газар Байгаль нуурын эрэгт хүнээс далд түргэн зуур юу

хэлэлцсэнийг хэн ч мэдсэнгүй өнгөрөв. Тэр бүү хэл ам султай Жамуха энэ удаа үнэнч боол Хантөмөртөө ч юу ч эс дурдав.

Чухам юунаас ингэж айж болгоомжлоод байгаагаа Жамуха өөрөө ч ойлгосонгүй.Хоргодох гэргүй, хомроголох цэрэггүй яваа Тэмүжинээс айв гэж үү. Сая Тогтоэбэхтэй ярьсан зүйлээ тэгтлээ ингэж нууцлаад байгаа нь Тэмүжинтэй тавьсан андын тангаргаасаа урвав хэмээн сэтгэлийн гүнд шаналсаар байгаагийнх гэдгийг Жамуха зөвшөөрч чадахгүй байлаа. Юу болох гэж байгааг таах санаатай Хантөмөр эзнийхээ баясгалант царайг сэм сэм ажиж явав. Жамухын тооцсон зөв болж бардам зан нь хөдөлсөн Тогтоэбэх гурван зуун цэрэг дагуулан Бурхан Халдун уулын хаа нэгтээ байх сурагтай Тэмүжиний бяцхан хүрээг эрж олохоор мордсон билээ. Жамухын бэлдсэн бэлэг санамсаргүй ингэж бүтсэн бөгөөд түүний нууц хүслээр Бөртэ мэргэдэд булаагдаж Тэмүжиний гэрт мэргэд цусны Зүчи хөвүүн төрсөн байв.

Зүчи бол Тэмүжинд илгээсэн хуримын бэлэг гэж Жамуха дотроо дөвийлгөн бодох дуртай ч харин хашир хүн тул энэ тухай хэнд ч ам ангайсангүй. Учир нь Тэмүжин бол Тэмүжин шүү дээ. Тэр бага наснаас үргэлж Жамухыг юүхэн дээр ч болов давж гардаг сүрхий хүүхэд байсныг тэр яаж мартах билээ. Тоорил ханы гэрт жил гарны хугацаанд цуг суух үедээ хүртэл хар үүрээр босч Тоорилын аягаар айраг уучихдаг хөнгөн нойртой, хөл хурдантай адтай хүү байлаа. Тэмүжиний энэ шалмаг сэрэглэн байдлыг Тоорил хан ихэд тоон ил тод магтдаг байв. Тийм учраас Жамуха хүүхэд ахуйдаа Тэмүжинтэй андын тангараг тавилцахдаа туйлын урамтай бахархалтай байсан юм.Тэр тангараг тэдний хувьд хамгийн үнэтэй, мартаж эвдэж болохгүй ариун нандин сэтгэлийн илэрхийлэл байсан болохоор Жамуха хэдий хойно ч гэлээ Тэмүжинд илэрхий дайсагнахаас аль болох тойрохыг хичээдэг, бас Тэмүжин ч ингэж хичээж байхыг мэдэрдэг байв.

Мэргэдийн Тогтоэбэхийг хэн өдөөн хатгасныг Тэмүжин хэрэв сонсвол яав ч түүнийг өршөөхгүй гэж Жамуха итгэнэ. Өөрийн нь дэргэд байсан Боржигон аймгийн иргэд тэр дундаа Жамухын үнэнч анд гэгдэж байсан Хотула хааны хөвүүн Алтан, Нэгүүн тайжийн хөвүүн Хучир нар Тэмүжинд даган очиж түүнийг өргөмжилж, бүр Чингис хаан хэмээн нэрийдэж нийтэд тунхагласныг сонсож мэдмэгцээ Жамухын тэвчээр, итгэл нэгэнт алдарч үнэн сэтгэлээс хорсон атаархаад Тэмүжинийг жинхэнэ дайснаа гэж үзэх нь улам хүчтэй болов.

Бас Тэмүжиний нэр хүнд өсч албат иргэд нь олон болохын хирээр эртний холбоотон Хэрэйдийн Тоорил хан Тэмүжинг илэрхий дагаж, өмөөрч хамгаалан салбаганах болсон нь Жамухын уур уцаарыг нэгэнт баржээ. Тоорил хөгширч өнөө цагт нэгэнт үеэ өнгөрөөсөн удирдагч болсон байлаа. Харин тэрээр тал нутагт ил тод өрсөлдөх болсон Тэмүжин, Жамуха хэмээгч шинэ цагийн хоёр залуу удирдагчийн дунд гуйвж дайван ихэнх тохиолдолд хуучин ёс, ам тангараг, Есүхэй болоод Тэмүжиний үзүүлсэн тусламжийн хариуг бодон Тэмүжинг өөрийн хуурай хөвүүн нэрийн дор өмгөөлөн дэмжиж байв.

Ганц хөвүүн Сэнгүм нь эр чадал, ухаанаар тэднийг гүйцэхгүй, бас Жамухын ятгалганд автан Тэмүжинтэй дайсагнах нь их аюул учруулна гэдгийг хашир өвгөн гадарлаж эсэргүүцсээр байсан ч Жамуха, Сэнгүм хоёр түүнийг ятгаж чадсан билээ. Ингэж Жамухын эцсийн хүсэл биелж Тэмүжиний санаандгүй үхлийн өдөр ирлээ. Сэнгүмийг ятган Тэмүжиний эсрэг турхирах нь хамгийн хялбар зүйл байсан бөгөөд эвлэрэл нэгдлийн тэмдэг болгож урин

тачаангуй Гүрвэлжингоо хатнаа Сэнгүмд бэлэг болгон өгсөн юм.

Тоорил голоос хайртай ганц хөвүүн Сэнгүмтэйгээ төрхөмдөө эвдрэлцэхийг дааанч хүсээгүй тул өөрийн эрхгүй түүний үгэнд орж Тэмүжиний эсрэг Жамухын санаачилсан эвсэлд нэгдэхээс өөр үггүй болжээ.Тэмүжин шиг хүчтэй өрсөлдөгчөө дарж чадвал Монголын тал нутагт Хэрэйд аймаг хамгийн хүчирхэг болох нь гарцаагүй юм.Тэмүжинг хууран авчирч алах гэсэн Сэнгүм, Жамуха хоёрын санааг Тоорил эцэстээ зөвшөөрч Тэмүжинээс урважээ. Өөрийн төрсөн дүү нартай дайсагнан эвдэрснээс болж Тоорил хоёр ч удаа аймаг улсаа бүү хэл амиа алдахад хүрч байсан бөгөөд яг ийм үед нь хувь заяаны эрхшээлээр эхний удаа Есүхэй, дараа нь Тэмүжин түүнд сайхан сэтгэлээр туслан алдсан аймгийг нь эргүүлэн авч өгснийг тэр мартах эрхгүй хүн боловч түүнд өөр арга үлдсэнгүй.

Энэ удаа Тэмүжинийг гарцаагүй үхлээс хэн ч аварч зайлуулж чадахгүй мэт байлаа. Тэмүжин Зүчи хөвүүндээ Сэнгүмийн дүү Чаурбэхийг эхнэр болгохоор гуйсанд эхлээд ихэмсэглэн цааргалж байсан Сэнгүм гэнэт зөвшөөрөн сүй тавихаар урьсанд Тэмүжин цөөн цэргээ авч мордов. Тэнд Тэмүжинг очмогц барьж алахаар Жамуха, Сэнгүм нар тохироод хүлээж байв. Гэвч энэ удаа дахиад тэнгэр ивээж Тэмүжинг үхэл тойрон гарчээ. Сэнгүмийн хүрээнд хүрэх замд Мэнлигийнд хонож таарсан нь чухамдаа сайн сэтгэлийн үр гэхээс өөр аргагүй явдал байлаа.

Мэнлиг тэр шөнө эцэг хүн хүүгээ сургах адил санаа сэтгэл түгшин

-Тэмүжин хүү минь сонс.Чи Сэнгүмийн хэлж байсан үгийг мартав уу. Хэрэв миний дүү Тэмүжинийд очвол үргэлж хатавчинд сууж хоймор харах болно.Харин Тэмүжиний хөвүүн манайд ирвэл дандаа хоймор сууж үүд харах биш үү.Би өөрийн удмыг Тэмүжинд дарлагдахыг үл хүснэ гэж их үг хэлж байсан Сэнгүм өнөө болохоор юу болоод “Сүй тавья.Багалзуур ид” гэж урьж залах болов.Ийм хэргийг сэжиглэхгүй байж яаж болох вэ гэж Мэнлигийн ятган хэлснийг Тэмүжин удаан бодож суув.

Тэмүжинд Тоорил, Сэнгүм хоёртой дайсан болох хүсэл огт үгүй байсан тул ингэж эргэлзсэн билээ.Тоорил хантай худ ураг бололцвол Тэмүжин улам л хүчирхэг болох билээ.Тийм учраас ингэж хэт ихээр сэжиглэх нь Сэнгүмийг бүр илэрхий дайсагнуулах бий гэж бас болгоомжилж байжээ.

Тэмүжин шөнөжин бодож хоноод өглөө нь Мэнлигийн хэлснээр “Одоо хавар болж агт туранхай байна.Намар очъё” гэж хэлүүлэхээр Бухатай, Хиратай хоёрыг явуулаад өөрөө гэдрэг буцжээ.Тэмүжин замаасаа гэнэт буцсан нь Жамухыг юу юунаас илүү айлгаж харин Тоорил бүр салганан чичэрч

- Та нар намайг Тэмүжин хөвүүнтэй минь нэг мөсөн эвдрэлцүүлэв.Хэрэг нэгэнт ийм дээрээ тулсан болохоор Тэмүжинд амсхийх мөч бүү олго.Маргааш даруй цэргээ хөдөлгөн түүнийг баригтүн гэж бухимдан хашгирчээ.Тоорилд Тэмүжинээс урвах хичнээн хэцүү болохыг ганц тэр өөрөө л мэдэх билээ.Тоорилын хүрээнд байсан Тэмүжиний тагнуул Сэнгүм, Жамуха нарын нууц хуйвалдааныг илчлэн хэлсэн нь Тоорил, Тэмүжин хоёрын эцэг хүүгийн хуурамч, ёс төдий холбоог нэгэнт эвдэн хаяжээ.

Хэдийгээр тэдний далд хуйвалдааныг өглөө болохоос өмнө Тэмүжин мэдсэн ч нөмрөн ирэх аюулаас мултран гарч чадсангүй.Хэдхэн жилийн өмнө Жамуха ,Тэмүжин Тоорил хоёрын цэрэгт цохигдсон бол одоо тэр Тоорилтой нийлээд Тэмүжинг гэнэ алдуулан дайрчээ.Үнэнч нөхөр гэж даанч үгүйг энэ тулаан үзүүлсэн билээ.

Тэмүжин дийлдэн зугатааж Хасар олзлогдов. Бүтэл муутай Сэнгүм шархдан үүнээс болж Тоорил дайтахаа больсон нь Тэмүжинг зугатаалган алдахад хүргэв. Цөөн хэдэн цэргээс өөр юу ч үгүй хоцорсон Тэмүжинг сул орхисон нь юунд хүргэхийг тэгэхэд хэн ч таагаагүй билээ. Гэтэл Тэмүжиний хариу даан ч санамсаргүй байв.Хэдэн сарын турш их талын гүнд үхсэн амьд нь мэдэгдэхгүй сураг алдраад байсан Тэмүжин хэргийн эзэн Жамухыг биш харин санаандгүй байсан Тоорилын хүрээг гэнэт довтолсон нь хэний ч санаанд оромгүй дэндүү гэнэтийн явдал байлаа.

Тоорил бол Жамухын гол найдвар итгэл байсан юм. Тэмүжин ч үүнийг мэдэж байв. Мянга шахам бээрийн холд Халх голын орчим байсан Тэмүжин өөрт үлдсэн цөөн цэргийг хөтөлгөө морь сэлгэн зогсолгүй довтолгож хоёр өдрийн дараа гэнэгүй найрлан байсан Тоорилын хүрээг гэнэт дайрч сөнөөсөн нь түүний ямархуу арга ов, алсын ухаантай, аймшигтай дайсан болохыг хэзээ ч мартамгүйгээр нотолсон явдал болжээ. Энэ бол Тэмүжиний хувьд үхэх сэхэхээ үзсэн эцсийн тулаан, харин Тоорил, Жамуха хоёрын мөхлийн эхлэл байв.

Жамуха үлдсэн цэргийн хамт Найман аймгийн Таян ханыг бараадахаас өөр зам түүнд үлдсэнгүй. Хэрлэн,Туул, Сэлэнгэ, Орхон голын Монгол нутаг одоо бүгд Тэмүжиний мэдэлд очжээ.

Тоорил хан зуйгуул хулгайч шиг нэр төргүй замын хүнд алагдаж, түүнтэй хамт байсан мэргэдийн Тогтоэбэхийн хөвүүд ч зугатаж одов. Одоо энд Жамуха Таян хааны цэргийн захад толгой хоргодон Тэмүжиний хэзээ нэхэн ирэхийг хүлээн хэвтэж байгаа нь энэ. Тал нутгийн олон аймгийг дагуулж, нэгдсэн их цэрэгтэй болсон Тэмүжинг дийлэх хөг нэгэнт өнгөрснийг Жамуха ойлгож байлаа. Бас Найманы Таян хан угаас цэрэг байлдааны эрдэмд дулихан тул Орхон мөрний хөвөөнд дийлдээд нэгэнт эүрх зориг мохож, сүрдэн айж байгаа нь илт байв. Тэмүжинтэй хийсэн ил далд тулаан хорин жил шахам үргэлжилж Жамухын ялагдлаар төгсөж байгаа нь дээрээс лавших цасны ширхэг шиг тод үзэгдэнэ. Түүний ялагдсан, өширсөн сэтгэлийн тайлал болж Бөртэ зүүдэнд нь иржээ гэдгийг Жамуха ойлгов. Бөртийн хэлсэн үг нь угтаа түүнийх ч биш, Тэмүжиний язгуур санаа гэдгийг ч мэдэж байв.

Одоо Тэмүжинд бууж өгч очих аваас зүүдэнд Бөртийн хэлснийг сонсох нь тодорхой. Гэвч Тэмүжинд дагаж очих нь Жамухын хувьд туйлын гашуун доромжлол билээ. Одоо түүний өмнө Таян хааны цэрэгтэй нийлэн эцсээ хүртэл үзэлцэх эсвэл…”Байз. Байз… Сайн бодъе” гэж Жамуха өөртөө хэлсээр суув. Түүнд яарч догдлох хэрэг үгүй байв.

Учир нь түүний амьдралын сүүлийн өдрүүд өнгөрч байлаа. Хаана, хэзээ, юун дээр алдав гэж өнгөрсөн ч гэлээ шүүн тунгааж бодохыг хичээнэ. Үлдээд байгаа цөөхөн ч болов хоногийг утга учиртай, өчүүхэн ч бай зорилготой өнгөрөөх нь нэр төрийн хэрэг гэж Жамуха үзжээ.

Эргүнэ мөрний хөвөөнд Тэмүжинд нэгдээгүй үлдсэн зүүн зүгийн арван гурван аймаг,овгийн толгойлогчид үгсэн эвсэж Жамухыг Гүр хаанд өргөмжлөн Тэмүжинтэй байлдах үед алдав

уу…

Тэр бол Жамухын дор хамгийн их цэрэг цугласан үе байсан юм. Гэвч энэ үед Тэмүжин Тоорил хантай нийлсэн байсан бөгөөд харин Жамухтай эвссэн олон аймгийн цэрэг цөм өөр өөрийн эздийн дур хүслээр тулалдсан зэрэг нь ялагдалд хүргэснийг тэр ойлгож байв.. Тэд өөрийг нь ёс төдий л хаанд өргөмжилсөн болохыг мэдэж байсан ч Тэмүжинг ялахын тулд Тэмүжинд нэгдэхээс айж байсан тэдний айдсыг түр боловч ашиглахаар шийдсэн билээ. Жамухын цэрэг Тэмүжиний хүчтэй дайралтыг тэсэлгүй ялагдаж өнөө олон аймаг хүрээний цэргүүд тус тусын нутгийн зүг сүүл хавчин зугтааснаар түүний хаанчлал төгсөв.

Одоо түүнд Гүр хаан хэмээх хоосон цол л үлджээ. Одоо түүнийг ганц Хантөмөр л Гүр хаан хэмээн хүндэтгэн дуудах бүлгээ. Хантөмөрийн ийн дуудах нь хүндэтгэх гэсэн хэрэг биш зөвхөн эзнээ зоригжуулахын төлөө юм. Бодолд автан хэвтсэнээ сэхээ авч нэгэнтээ харвал цас бороо холилдон орох нь зогсч намар оройны нар тусчээ. Хантөмөр дэргэд нь байсангүй. Харин түүнд үлдсэн цөөн хэсэг цэрэг холгүй утаа уугиулж хоол хош эргэлдүүлэх аядаж байлаа. Энэ бол түүний шилмэл цэргийн үлдэгдэл юм.

Жамухын цэрэг алуулах нь алуулж амьд үлдсэн нь тарж зугатаад харин албат иргэд нь бүгд Тэмүжиний өмч болжээ. Одоо энэ Найман дарагдвал Алтай нуруунаас зүүн тийш Хянганы нуруу хүртэлх, их говиос хойшхи газар нутаг бүгд Тэмүжиний мэдэлд ирнэ гэсэн үг юм. Энэ газарт Тэмүжинээс өөр хүчирхэг хүн үгүй болов. Бүгд түүнд дийлдэн сөнөжээ.

Одоо Жамухын ээлж нэгэнт ирэв. Өөрийнх нь гунигт төгсгөл ойртсоныг мэдрэх бүр нэгэн хачин этгээд бодол төрөөд болсонгүй. Санаанд орох бүр хүчээр хөөн гаргавч хулгайч нохой шиг нэг л мэдэхэд сэтгэлд шургах, бүр гүнзгийрэн шигдэх энэ бодол бол “Хэрхэн үхэх вэ” гэсэн хачин асуулт байв.Гэвч одоо түүнд зөвлөж хэлэх шадар, хамжиж туслах анд нөхөд үгүй болжээ. Өөрийн хар толгой, ухаан мэдрэмжиндээ л найдах үлдэв. Жамуха одоо өөрийн үхлийг тод харж байлаа. Тэнэсэн зэрлэг суманд өртөж, эсвэл хэн нэг үл таних цэргийн сэлэмд амиа өгөхийг Жамуха үл хүснэ.

Энэ үхэл түүнд дэндүү амар хялбар, үнэгүй хямдхан санагдана.Тэр Монголын тал нутагт дуурсахаар, хожим хойно ч мартагдахгүй тийм үхлийг сонгохыг илүүд үзнэ. Хэдий аймшигтай ч бахархалтай, хожим хойно дурсагдахаар үхэхийг тэрээр хүсч байв. Гэтэл цаг нь болохоор үхэл тийм ч амар ирэхгүй бололтой. Уг нь цаг хугацааг товчлон амьдралыг тааж мэддэгсэн бол Тэмүжинг өнчин ядуу явахад нь л дүү нартай нь хамт хөнөөх байжээ. Энгийн боловч туйлын үнэн зөв байсан энэ санааг биелүүлэхэд Хантөмөр хэзээд бэлэн байснаар барахгүй ингэж хийхийг ч олон удаа сануулж шаардсан юм. Бурхан Халдун уул, Онон мөрний эх ой мод, намаг усаар хавчигдсан зэлүүд буйд газарт нуугдан суусны хүчинд амьд үлдсэн тэднийг олж хөнөөнө гэдэг уг нь Жамухад алга урвуулахын төдий зүйл байсан билээ. Гэвч ингэхэд нь юу саад болов.

Хамгийн түрүүнд хүүхэд насны үнэнч андын тангараг саад болов. Тэмүжинг дутуу үнэлж үл тоомсорлон хандсан нь гай болов. Тоорил ханы арга эвийг олж нөхөрлөсөн залуу Тэмүжиний хэрсүү ухаан саад болов. Тэмүжиний цаад нарийн ухааныг Жамуха одоо л гүйцэд ойлгож авчээ. Оройтсон ч гэлээ үнэнийг мэднэ гэдэг хэрсүү ухаан төрүүлдэг ажээ. Өөрийн алдагдсан нэр хүндийг сэргээх, Боржигон аймгаа эргүүлэн нэгтгэхдээ Тоорил хан, Жамуха хоёрын

хүчийг Тэмүжин нэн чадамгай ашиглажээ. Түүний гаргасан алдаа болгоныг Тэмүжин хэрхэн ашигласныг ухаарах тусам даан ч гомдолтой байлаа.

Дээдэс ноёдод долигнодоггүй, дорд харцад тал алддаггүй зан, сохрын газар сохор, доголонгийн газар доголон байж чаддаг тэвчээртэй чанар нь Тэмүжинг ийм амжилтанд хүргэжээ.

Жаахан шалтаг олмогц Тоорилыг урвуулан талдаа татаж Жамухыг довтолсон мөртөө Тоорилыг итгэл алдмагц цаг зав өгөхгүй довтлон сөнөөсөн нь чухам ганц Тэмүжинд байх аймшигтай онцгой чадвар бүлгээ. Жамуха ямар ч үед өөрийн тавьсан андын тангаргийг санахтай байв. Харин Тэмүжин тэр тангаргийг сануулах мөртөө ганцхан өөрий амь нас, эрх ашгийг эрхэмлэж байснаараа түүнийг ялж чадсаныг Жамуха ойлгов. Энэ бол дайнд нөхөр гэж байдаггүйг харуулсан хэрэг юм.

Хэн харгис хатуу, өршөөлгүй байж чадна тэр л ялдаг жамтай ажээ. Тэмүжиний энэ ялалтанд тус болсон нэг зүйл байсныг Жамуха ойлгосонгүй. Яагаад гэвэл тэр Тэмүжиний цэргээ хэрхэн засаж зохион байгуулсныг мэдэх боломжгүй байв. Аравт, зуут, мянгатаар хуваагдсан Тэмүжиний цэрэг нэг зорилго, нэгдмэл сахилга, нэн цэгцтэй шуурхай хөдөлгөөнийг бий болгож сурч байлаа.

Зөвхөн өөрийн омог, аймаг, бүлгийн удирдагчийн хүсэл зорилго, зориг чадвараар удирдагдаж байсан цэргээс энэ нь хичнээн хувь давуу, шинэ, уян хатан, нэг зорилгыг хэрэгжүүлэхэд илүү зохицож байсан юм. Бас нэгдсэн улс байгуулах хүсэл зориг, ялалт байгуулах чин эрмэлзлэлийг ч Тэмүжин бүгдэд нь түгээн халдварлуулж байв. Энэ бол Тэмүжиний давуу тал байсан юм.

Дайн тулаанд хамгийн илүү зориг хүч гаргасан тэр хүнийг язгуур угсаа үл харгалзан дайны олзноос хөхүүлэн шагнаж, алдаршуулан дэвшүүлж байсан нь олон, олон залуу зоригтнуудыг Тэмүжиний талд татаж үнэн сэтгэлээр зүтгэх үндэс болж байв.

Эзэндээ үнэнч зүтгэсэн дайснаа ил тодоор сайшаан өршөөн хэлтрүүлж өөртөө элсүүлдэг байсан нь жинхэнэ шударга, ардач шинэ удирдагчийн дүр төрхийг бий болгож энэ нь Тэмүжинийг дайснууд нь ч болов хүндэтгэхэд хүргэж байлаа.

Тоорилын огт санамсаргүй байгаад Тэмүжинд цохигдсон нь Жамухын үзсэн хамгийн харамсалтай ялагдал байлаа.

Төв Монголын нутагт оршиж байсан хамгийн хүчирхэг Хэрэйд аймгийн хан Тоорил сөнөж дарагдсан нь бусад жижиг аймаг, омгуудад том сургамж болж айж сандарсан тэд ээлж дараагаар Тэмүжинд дагаар оров.

Энэ явдал одоо Тэмүжинг эсэргүүцэн зогсож байгаа Найман аймгийн сүр хүчийг дороитуулж Таян хааны зүрхийг мохоожээ. Эртний нэр сүр их, хол ойрд цуутай Тоорил хан ингэж гэнэт цохигдон сүйрсэн нь Тэмүжиний эсрэг нэгдэн тэмцэх эцсийн ганц найдварыг нэг мөсөн үгүй болгов.

Тэмүжин нэгэнт үүссэн нөхцөл боломжийг дүүрэн ашиглаж, Таян ханд ухрах зугатах, хүчээ хуримтлуулах зав зай өгөхгүй нь лавтай. Тийм болохоор удахгүй бүр хоёр гурав хоногоос хэтрэхгүй энд Тэмүжиний цэрэг нэхэн ирэх нь гарцаагүй. Ганц Тэмүжин ч биш, хэн ч байсан тэгэх биз. Найманы Таян хан Тэмүжинийг дутуу үнэлж "Дорно зүгийн цөөн Монголчууд омогдох боллоо. Барын зулзагыг бага дээр гэдэг билүү" гэж их үг хэлэн цэргээ Алтайн нуруу давуулан Орхон гол хүртэл довтлон ирсэн нь галзуу чонын аманд гараа хийсэнтэй адил хэрэг болж одоо тэд улсаа түйвээж, өөрсдөө хоромсог саадгаа хураалгах дээрээ тулав.Амнаасаа болж улсаа золиослосон Таян хан харамсавч оройтжээ.

Жамухыг дагаж явсан албат иргэд нь зам зуураа эргэж Тэмүжинд очсоныг ч тэр одоо болтол мэдээгүй байлаа. Төдөлгүй алга болоод удсан Хантөмөр эргэж ирэв. Өглөөнөөс хойш өндийх ч үгүй хэвтсээр байгаа эзнийхээ дэргэд дуугүй сөхрөн суухад Жамуха эрхбиш дэргэд нь хүн ирсэн юм болохоор дуртай дургүй нүд нээн харжээ. Хантөмөр Жамухыг дуугарна гэж хүлээж байсан ч чухам юу гэж хэлэхийг нь таасангүй.

-Хантөмөр чи тэр жил Зээрэн хавцалд Зүчийг дагаж ирсэн тэр загасан нүдэт цэргийг санаж байна уу гэж Жамуха Хантөмөрийн огт санаагүй юмыг гэнэт асуув.

Тату гэгч тэр загас мэт үл цавчих хачин нүдтэй эрийг Хантөмөр тод санаж байсан тул гайхаж

-Юу болов .Эзэнтэн гэж асуув. Гэвч Жамуха хариу хэлэхгүй таг чиг байсанд

–Тэр цэргийг Тату гэдэг юм.Тэмүжиний хамгийн анхны арван торгон цэргийн нэг гэсэн.Та яагаад түүнийг асуув гэв.

-Яагаад түүний тухай асуусная би өөрөө ч мэдэхгүй байна гэж Жамуха үнэнээ хэлээд

-Чи хаана очив гэжээ.

-Би Таян ханы асарт очив гээд Хантөмөр үг дуугүй суув.

Дагаж явсан албат иргэд нь замдаа буцаж Тэмүжинд дагаж орсныг бас түүний дотор Жамухын залуу хатан Сүүнгэгээн Зүчийн олз болсныг Хантөмөр хэлж зүрхэлсэнгүй.

Гүрвэлжингоо хатнаа Сэнгүмд бэлэглэснийхээ хойно одоогоос хагас жилийн өмнө Жамуха арван зургаан настай үзэсгэлэнт охин Сүүнгэгээнийг авчирсан билээ.

Жадаран аймгийн харц гаралтай энэ охиныг Жамуха яагаад таалах болсны цаад нууцыг Жамухаас өөр хэн ч мэдэхгүй юм. Харцынхаа охиныг авах нь байж боломгүй хэрэг боловч Сүүнгэгээн охин, Тэмүжиний хатан Бөртийн залуу настай дэндүү адилхан бүр андуурам төрсөн билээ.

Гэтэл Жамухад Сүүнгэгээнтэй жарган суух өдөр ердөө л гуравхан заяажээ.

Түүний охин биеийг эдлэж онгон хальсийг нь цоолсноос цаашгүй юм.

Тэмүжиний цэрэг зай завсаргүй мөрдөн хөөх болсон нь тэднийг хагацуулжээ.

Сүүнгэгээнийг ямар учраас Жамуха эзэн нь сонгосныг тааварлах тул түүнийг Тэмүжиний хөвүүн Зүчи олзлон авсныг Хантөмөр хэлэхгүй өнгөрөөхөөр шийджээ.

-Чи юу болов. Юунд үг дуугүй гөлийж орхив гэж Жамуха бухимдсан мэт шивнэв.

-Гүр хаан. Би Таян хааныг ойлгож ядлаа. Тэр хамаг цэргээ уулын орой, хясаан дээр авируулжээ. Бас Тэмүжинийг ирвэл зад тайлж цас оруулна гэж бөө авчран бөөлүүлж байна.

-Тэр угаас тийм эм зантай үгнээс цаашгүй амьтан байж. Чи юуг нь ойлгож ядав.

-Тэр Гүр хаан таныг бүх цэргээ нэгтгэн засч Тэмүжинг тосч байлд гэнэ

Энэ үгийг сонсоод Жамуха өндийж бодол болон суув. Хантөмөр хичнээн хүлээгээд эзэн нь дахин үг хэлээгүй тул холджээ. Шөнө болж тэнгэр бүрхсэн ч цас орсонгүй. Харин Наху баяны хөндий дүүрэн түүдгийн гэрэл ассан нь газар тэр чигээр шатаж байх шиг үзэгдэнэ. Тэмүжиний цэрэг аль эрт нэхэн ирээд сахин буусан энэ ажээ. Яаж ийм хурдан гүйцэн ирснийг Жамуха ч гайхав.

Тэмүжиний хөнгөн морин цэрэг хөтөлгөө морьтой довтолгосоор тэднийг гэзэг даран ирж Хасарын тушаасан ёсоор хүн бүр таван хэсэг түүдэг гал асаасан нь ингэж хөндий дүүрч харагдсан байв. Таян хан зүрх нь дэлсэн айж Жамухын дэргэд давхин ирэв.Таян ханы сүлдтэй алтан дуулга нь хазайж хөө хуяг, сэлмэндээ түүртсэн түүнийг хараад Жамуха дооглон инээмсэглэв.

Энэ Таян хан хоосон ам, хий сүрнээс цаашгүй амьтан ажээ. Тийм биш бол юу боллоо гэж Тэмүжиний өмнө өөрөө гүйж ирэх билээ. Алтайн нурууны цаана Найман улсдаа сууж байсан бол Тэмүжин түүнийг довтолтол бас зайтай, хэдэн жил ч болж мэдэх билээ. Дайсныхаа хүчийг дутуу үнэлж цагаа олохгүй довтлосноос улсаа үрж Тэмүжиний бэлэн сайхан зууш болжээ. Гэвч энэ бүгдийг Таян ханд яаж хэлэх билээ. Таян хан шиг хүн өөрийн алдаа дутагдлыг үхэж байж сая ойлгох биз ээ.

-Жамуха.Чи Тэмүжиний занг мэднэ. Баатруудыг нь танина. Чи миний цэргийг удирдан байлдагтүн гэж Таян хан хэлжээ. Жамуха зөвшөөрч түүнийг явуулаад цэргээ засч Хантөмөрийг дэргэдээ дуудан ирүүлэв. Хантөмөр эзнийхээ ямар зарлиг буулгахыг хүлээн мах зулгааж зогсов. Тэр угаас үргэлж ам хуурайгүй хивж явдаг муу зантай билээ.

Жамуха эзэн нь Тэмүжинтэй халз тулан үхэх сэхэхээ үзэхээр шийджээ гэж бодов.

-Хантөмөр чи сэм морд. Тэмүжиний хүрээнд оч. Энэ үгийг сонсонгуут Хантөмөр зажилж байсан махаа амнаасаа унатал алмайрч орхижээ. Гэвч өнөөх л үг дуугүй байж сурсан зангаараа тэр юу ч үл асуув. Жамуха ч дараагийн үгээ хэлэхийн өмнө дахин гүйцээн тунгааж өөрийн зөв гэдэгт эргэлзээгүй итгэх хэрэгтэй байлаа. Энэ бол сүүлийн хэдэн хоног түүний толгойгоо гашилган бодсон олон асуултын нэгний нь хариу болох юм. Жамуха маргааш өглөө амьдралынхаа сүүлчийн тулааныг хийх цаг ирснийг гадарлаж байв.Гэвч тэр огт өөр санаа сэдэж байлаа. Тэмүжин уг нь түүнд хар багаас их л аятай сайнаар, бүр хүндэтгэлтэйгээр ханддаг байсныг яаж мартана. Тийм болохоор Жамуха энэ удаад ч гэсэн Тэмүжинд өөрийгөө

бас сайнаар дурсуулахыг хүсчээ.

Хаашдаа нэг л амьдарч өнгөрөх хорвоо тул ард үлдэгсэддээ сайхан сэтгэгдэл дурсамж үлдээх гэж хүсэх нь юу нь муу байх билээ. Бас Бөртийн сэтгэлд сайнаар дурсагдаж үлдэхийг ч хүсэв. Ингэх учир бас байсан юм. Бөртэ мэргэдийн Чилэгэр бөхөд булаагдан очсоны хойно чухам түүний ингэж булаагдсан нь Жамухатай холбоотой болохыг дам хүний амнаас сэм сонссон ажээ. Гэвч үүнд итгэсэнгүй атлаа эм хүний ёсоор энэ ховыг сэтгэлийнхээ мухарт хэзээ ч мартахгүйгээр хадгалан үлджээ. Тийм ч учраас Жамухыг их л сэжиглэнгүйгээр хардаг нь мэдрэгдэнэ. Гэмт хүн гилбэлзэнэ гэгчээр Бөртийн далд сэжиглэл Жамухад ч эвгүй тул “Тэмүжин мэдвэл яана” гэсэн түгшүүр сэтгэлд нь уяатай явдаг байлаа. Бөртийг мэргэдээс булаан авсны хойно Жамуха, Тэмүжиний хамт нэг хүрээнд жил гаран найрсан суусан юм. Энэ нь тэд андын тангаргаа батлахыг хүссэнийх байв.

Мэргэдийн савраас аварч тус болсон Жамухыг улаан цайм хардаж сэрдэх нь зохисгүй тул Бөртэ өөрийн сэжгийг дотроо хүчээр нуун мартагнасан ч тулгарах бүр харц дальдчих Жамухын байдал гайхшралыг нь төрүүлсээр байжээ. Энэ нууцлаг, далд хардлагын тайлал нь Жамухын зүгээр л малын билчээр бодож хэлсэн үг болсон билээ.

Адуу, хонь хоёрын хөл, билчээр таарахгүй нь тэднийг нэг дор удаан амьдрахад төвөгтэй болгож албат, шадрууд нь билчээр сэлгэн уул бараадан нүүхийг удаа дараа шаардсан тул Жамуха амьдралын энэ жирийн үнэнд гүйцэгдэн “Малынхаа билчээрийг дагаж салж нүүе” гэсэн үгийг Тэмүжинд түрүүлэн хэлэхэд хүргэжээ.

Шүлэг хэлхэн цэцнээр өгүүлэхдээ гарамгай Жамуха энэ удаад ч мөн тэр зангаар

-Тэмүжин анд аа

Ууланд шахаж бууя

Уургачин цаламчинд гэр болтугай

Ай зөв үү

Голд шахаж бууя

Хоньчин хургачинд хоол болтугай

Хориггүй биш үү гэжээ.

Тэр өдөр Тэмүжин Жамуха хоёрын нийлсэн их нүүдэл Хэрлэн мөрнийг өгсөн Дэлүүн болдогоос хойш уул нүүх мэт хөдөлж ядаж байв. Үхэр, адуу, хонь багширч ийм олон малын хөлөөр ногоон зүлэг тэр дороо элс шороо болон хувирч байхыг үзээд Жамуха ингэж хэлжээ. Малын идэш билчээр хомсдож нэг өдөр боловч хамт суухад хэцүү болсон нь хэнд ч ил байлаа.

Гэвч угийн далд санаатай, сэжиг хар ихтэй Тэмүжин Жамухын энэ жирийн уран үгийг шууд ойлгож эс чадаад эх, эхнэр хоёртоо хэлсэн билээ.

-Жамуха андыг олон санаатай гэдэг биз. Одоо биднээс уйджээ. Түүнээс салж нүүе гэж Бөртийн түрүүлэн хэлсэн нь Тэмүжиний дотоод бодолтой нийцсэн тул тэр шөнөө Жамухыг хаян нүүж одсон юм.

Бөртэ ингэж Жамухыг сэжиглэснийхээ хэргийг гаргаж Тэмүжинг салгаж чадсандаа ихэд хөхин баяссан билээ. Харин Бөртийн энэ үгийг хожим Жамухын тагнуул түүнд хэлжээ. Тэмүжин хэргийн учрыг тунгаалгүйгээр эмийнхээ үгэнд орж салж одсон билээ..

Харин яагаад ингэж хэлэх болсныхоо цаад учрыг Бөртэ Тэмүжинд хэлээгүй юм. Эм хүн гэгч хоёр эрийг заавал салгаж дайсагнуулах санаа мөнхөд өвөрлөж явдагт Жамуха итгэнэ. Учир нь түүний Гүрвэлжингоо хатан ам л ангайвал Тэмүжинг нэг бол магтаж, нэг бол муулж агшин зуур ч амар заяа үзүүлэхгүй Тэмүжингийн эсрэг өдөөн турхирдаг байв.

Ерөөс эм хүн эрчүүдийг хоорондоо цусаа урсган тэмцэлдэж байхыг л хүсдэг биз. Тэгээд ялж дийлснийх нь эрхэнд автан эдлүүлж байх хүсэлтэй байдаг ажээ.

Энэ нь тэдний хүч мөхөс, ухаан богиноо нуух, тэрхүү дутуугаа сэтгэлдээ ч болов нөхөх ганц арга төдийгүй язгуурын адгуус шинжээс нь үлдэж хоцорсон муу араншин юм. Бөртэ хэдийгээр ухаан зарж мэргэдтэй нуцаар эвссэн Жамухыг илчлээгүй ч түүнийг Тэмүжинээс салгаснаараа тэртэй тэргүй бат бэх биш байсан эртний нөхөрлөлийг нь эцэс болгож тэднийг өрсөлдөн дайсагналцах замд эргэлтгүй түлхсэн буруутан билээ.

Тийм болохоор бүсгүй хүнийг хүч мөхөс,ухаан богино гэж үл ойшоох нь туйлын мулгуу алдаа ажээ. Эмэгтэй хүнд эр хүнийг эзэмдэх урин тачаал, үзэсгэлэн гоо гэх хүчтэй зэвсэг буй. Бас хөвүүн төрүүлж хэзээ ч үл тасрахаар аргамжих учир бий. Тэмүжинтэй хар багадаа тавьсан онцгой тангараг эвдрэхэд Бөртэ, Гүрвэлжингоо хоёрын гай багагүй оролцсон гэж Жамуха итгэнэ. Эмийнхээ үгэнд хэтэрхий автсан эр хэзээ ч өөдлөхгүй гэж үзэх тул Жамуха эм хүнийг үл ойшооно. Хүний зүүдэнд цаанаа нэг учир бий. Ямар бодол тохиолын тэмдэг гэрч болж Бөртэ түүний зүүдэнд орсон юм бүү мэд.

Магадгүй өнөөг хүртэл Жамухын сэтгэлийн мухарт агуулагдсаар буй харуусал гэмшил, их эвлэрэл, авралыг эрсэн хүслийн үзүүр ч байж мэднэ.Жамуха сэтгэлийнхээ мухарт сүүмэлзэн байгаа амьд үлдэх, алдар нэртэй амьдрах чин хүслээ дарж дийлэх гэж зовж байлаа.Гэвч нэргүй амьд явснаас нэртэй үхэх нь дээр гэж шийдэв. Ийм нэгэн бодол одоохондоо Жамухын сэтгэлийг эзэмдэж Хантөмөрийн гайхшралыг төрүүлсэн “Тэмүжиний хүрээнд оч” гэсэн үгийг хэлэхэд хүргэжээ.

Шархдаж цусаа үзээд улайрсан араатан шиг өөд өөдөөсөө тулсан дайсныхаа ичээнд оч хэмээсэн Жамухын үг Хантөмөрт аймшигтай биш харин сонин, бүр эгдүүтэй санагдаж түргэхэн ёсоор болгох хүслийг өдөөжээ. Тэр үнэхээр Тэмүжиний хүрээнд очихсон гэж хүсэв. Учир нь үл олдох алмай бодолд дарагдан, сурч дадсан эрэмгий омголон зангаа алдсан Гүр хаан эзнээ Хантөмөр дуугүй ширтэн цааш нь юу хэлэхийг хүлээж суулаа. Энэ бол тэр хоёрын харьцааны жирийн нэг төрх юм.Жамуха эзэн нь яавч зүгээр нэг энэ үгийг хэлээгүй нь лавтай.Яг ийм үед амиа бодохоос өөр зам үгүй гэж Хантөмөр эзнээ зөвтгөн бодож байв.

-Хантөмөр. Гүр хаан Жамуха байж байж сая нэг юм ам нээсэн нь Хантөмөрийг баясгалаа.

-Би сонсож байна. Гүр хаан гэж хэлэхдээ хоолой нь догдолсондоо чичирч байв

-Чи одоо сэм явж Тэмүжиний хүрээнд оч гэж Жамуха давтан хэлсэн нь үүний хойно гарах үг хичнээн хэцүү хүнд болохыг баталж байх шиг, бас эзэн нь одоо хүртэл эргэлзсээр байх шиг Хантөмөрт санагдана.

-За… Жамухын ингэж хэлээд дуугүй болсон нь хийх гэж байгаадаа үл итгэснийх биш, Хантөмөрт цээжлэхэд амар үг олж хэлэх гэж бодолхийлснийх байв.

-Чи Тэмүжинд намайг хэлэв гэж дамжуулагтүн.

-Би сонсож байна. Гүр хаан. “Би чамд дагаж оръё” гэж хэлнэ гэж Хантөмөр таалаа.

Энэ үгийг хэлэхэд үнэхээр тийм амар хэрэг биш нь мэдээж. Тэр Жамуха эзнийхээ сэтгэлийн дотрох ширүүн шуургыг мэдэрч бас өрөвдөж байлаа. Дайсан этгээддээ бууж өгнө гэдэг хэнд ч байсан хэцүү нь мэдээж.Тэр тусмаа Жамуха шиг омог бардам хүнд бүр ч хэцүү байгаа биз. Хэрэв ингэвэл Хантөмөр ч бас амьд үлдэх нь гэж баярлан бодож амжив.

Үнэхээр Хантөмөрт үхэх хүсэл байсангүй.

Юу ч болсон Жамуха, үнэнч боол түүнийг зүгээр нэг үхэлд хаяж орхихгүйд итгэнэ.

Хүн юм болохоор Хантөмөрт нууц хүсэл мөрөөдөл бас байлаа. Тэр чин үнэнээсээ амьд явахыг хүсч байв. Үүнээс өмнө тэр Жамуха эзнийхээ төлөө амиа өгнө гэхэд огтхон ч эргэлзэж харамсаж байсангүй.Харин сүүлийн үед өөрийн амь нь дэндүү хайран санагдах болжээ.Хэдийгээр энэ нууц хүслээ эзэндээ ил тод илтгэж болохгүй ч бас түүнийг нэг мөч ч мартаж умартсан нь үгүй. Жамухын хэлэх гээд хоолойгоо давуулж чадахгүй байгаа тэр үгнээс олон хүний хувь заяа, амь нас хамаарч байгааг тэр мэднэ.

Энэ дотор хамгийн түрүүн Хантөмөрийн амь нас багтаж байв. Хантөмөр эзнийхээ хэлэх тэр үнэт үгийг хүлээн амьсгаагаа түгжин суув. Шаналгаат мөч үргэлжилж Жамуха дуугүй суусаар…

-Таян хаан чамаас айж

Тайга ууланд шургаж оров.

Хатан зүрх нь халиран чичирч

Хад асганд авиран нуугдаж

Зориг зүрх нь уландаа ороод

Зовхи нь буугаад хулчийж байна.

Тэмүжин чи шалавлан дайр

Тэд сандран дутааж байна.

Эдний царайг ажиж харахад

Эсэргүүцэн сөрөх сөхөөгүй байна

Үг яриаг нь сонжиж суухад

Үхлээс айгаад дагжиж байна

Омог зориггүй эднийг хараад

Ой той минь гутав

Сүр сүлд нь зайлсныг үзээд

Сүжиг итгэл минь алдрав

Араг даахгүй чавганц мэт

Арчаагүй дорой найманууудтай

Илд даахгүй эр мэт

Ичгүүртэй хулчгар эдэнтэй байхад

Хавсрах нөхөд минь хайран байна

Хар амиа хоохойлоогүй ч

Хайран нэрээ бодож байна .

Зодуурт дальдчих боол мэт

Золбин тэнэх ноход мэт

Зориг зүрхгүй тэднээс

Зоргоороо салахаар зориглов, би

Олхиогүй дорой тэднийг Орхиж явахаар шийдэв, би

Гүр хаан Жамуха би Гүйдэл суудал нийлэхгүйн учир

Түнэр шөнийн харанхуйгаар Түргэн эндээс зайлна

Урьд хождын ерөөл байвал Уулзах мөч энүүхэнд биз

Угийн заяасан тавилан ирвэл Уралцах цаг ч тохионо биз…

Цээжлэхэд хялбар гэж эзнийхээ ийнхүү шүлэглэн хэлсэн үгийг Хантөмөр сайтар ухаж ойлгоогүй ч угаас Жамуха цэцний ийм шүлгэн захиасыг нь олонтаа дамжуулсаар түргэн цээжилж сурсан тул үг үсэггүй цээжлэх ёстойгоо л нэн даруй сэхээрч хэдэнтээ давтан мартахгүй, андуурахгүй тогтоов.

Энэ хэдэн мөр шүлэгт Найманы Таян ханы сэтгэл болоод цэргийн байдлыг хэнд ч харагдаж ойлгогдохоор тодруулан хэлжээ. Бас Жамухын бардам дээгүүр зан, нэрээ хичээдэг чанар хийгээд Тэмүжиний өмнө тэгтлээ бөхөлзөхгүй гэсэн шазруун үгс ч цухалзах ажээ. Энэ бол чухамдаа Хантөмөрийн сонсоно гэж хүлээсэн үг биш байв. Жамуха чухам яах гэж буйг одоо таахад бэрх болжээ. -Чи морд. Тэмүжин чамайг лав алахгүй. Тэр дайсныхаа элчийг тэр дундаа Жамуха миний элчийг хороох учиргүй тул чи бүү эмээ гэж Жамуха Хантөмөрийн бодсоныг тааж хэлэв.

Хантөмөрийн гайхаж бухимдсан царайг хараад Жамуха түүнийг айв гэж санажээ.

-Би Тэмүжиний гарт үхэхээс өчүүхэн ч айхгүй гэж Хантөмөр худал хэлсэн ч дотор нь харлан харамссандаа зүрх нь шимшрэн өвдөж байв. Гэвч царайд нь тэр дороо зориг шулуудсаны шинж тодорч хөмхийгөө зууж хөмсөг зангиджээ.

-Хантөмөр. Жамуха өөрийн шүлгийг сүүлчийн удаа давтан хэлүүлж сонсоод ингэж хэлэв.

-Хантөмөр. Хэрэв чи Тэмүжиний дэргэд үлдэхийг хүсвэл түүнд шударгаар үнэнч зүтгэхээ хэлэгтүн. Тэмүжин чиний өндөр босгыг бэхлэж, өргөн хатавчийг хашиж суу гэж боол намайг Жамуха эзэн минь илгээв гэж хэл. Би одоо чиний төлөө үүнээс өөрийг хийж үл чадна. Надад гомдож өшихийг чинь үзмээргүй байнасанж. Бас дэмий сураггүй үхэхийг чинь ч хүсэхгүй байна. Чи надад зүтгээд эцэнхий морь, эзэнгүй үхлээс өөр юу ч эс олов. Хантөмөр.Би чамд төлж дийлэхгүй өртэй үлдэв. Одоо би чамайг Тэмүжинд өгье. Эзнийхээ үнэн сэтгэлийн үгийг сонсоод Хантөмөрийн чулуу мэт сэтгэл өмрөн уярав.

Энэ олон жилд тэд яаж дотносон дассанаа хэн хэн нь голт зүрхээ шимшрүүлэн мэдэрч байв. Хоёр эр хүний их нөхөрлөлийг, салж хагацахын уй гашууг үзсэн Тэнгэр цас бороогоор уйлж эхлэв.

-Гүр хаан. Би таныг яаж орхино. Та намайг дорд үзэж доромжлох үг юунд хэлнэ. Би үүр цайхын өмнө эс ирвэл үхэж гэж бодогтун. Би амьд байвал танд эргэж ирнэ гэж Хантөмөр эрс хатуу бас заналтай хэлээд нүдэндээ дүүрэн мэлтрэх нулимсыг нуун бушуухан эргэв. Хантөмөрийн энэ үг Жамухын хатуу чанга сэтгэлийг ч эрхгүй уяраажээ.

-Хантөмөр.Чи ингэж шийдвэл түргэн эргэж ир. Би чамайг ирмэгц өөрийн цэргээ авч шөнө дөлөөр Таян ханыг хаяж одно.

-За Хантөмөрийн сэтгэлд эзнийхээ төлөө амиа өгөх галзуурсан хүсэл зориг оволзож байлаа. Харанхуй тэнгэрээс том ширхэгтэй цас малгайлж эхлэв.

-Хантөмөр. Шалавлаж үз… Хантөмөр хэдэн цэргийн хамт харанхуйд уусч алга болов. Түүнтэй хамт Жамухын эцсийн итгэл найдвар үгүй болох шиг санагдана.Жамуха хэзээ ч ингэж ганцаардан гансарч байсангүй.

-Хантөмөрийг минь Тэмүжин бүү алчихаасай билээ гэж Жамуха Тэнгэрт мөргөв. Балчир идэр наснаас бараа болж зүтгэсэн Хантөмөрийн хувь заяаны төлөө анх удаа тэр ийнхүү үнэн сэтгэлээсээ санаа зовж шаналжээ.Одоо түүний хийж чадах ганц юм нь Тэнгэрт мөргөх л байв. Цас лавсан хаялах нүхгүй хар тэнгэрийн дор ингэж ганцаар хаягдахын төлөө Жамуха цусаа урсган цавчилдаж, цулбуур хумилгүй довтолгож явсан гэж үү. Одоо түүнд хэн хариу хэлж, хэрсэн бодлыг нь цэгцэлж туслах вэ.

Ааштай амтай, элдэвлэгч хорон санаатай гэж ад үзээд Тоорилын хүү Сэнгүмд бэлэглэж орхисон зүс гоо Гүрвэлжингоо хатнаа тэр хөөрхийлөн бодов. Хэчнээн тамлаж, зодож нүдлээ ч улам л золбоо төгс болж, гандахгүй цэцэг шиг өнгө ордог тэр харь цусны бүсгүй уулзсан учирсан олон эмсээс сэтгэлийн гүнд хамгийн гүнзгийгээр шингэн үлджээ. Тэр бүсгүй хортой үг хэлж хоёрын дунд яс хаян хамгийн ихээр өдөөн, сэтгэл зүрхийг нь урж сэвтүүлдэг байсан хэдий ч ингэж үгүйлэгдэн гансруулах юм гэж Жамуха санасангүй. Энэ зовлон түгшүүр дүүрэн амьдралд хичнээн их зүйлийг ойлголгүй өнгөрч, өчнөөн олон алдаа хийснээ ухааран мэдрэх бүр дахин хүн болж төрөхсөн гэсэн бодол Жамухыг асар хүчтэй эзэмдэх ажээ.

Ийм хачирхалтай шинэ бодолд автахын учир нь үхэл түүнд их ойрхон ирснийг улам тод гэрчилнэ. Одоо дэргэд нь Гүрвэлжингоо хатан нь байсан бол таарах үгийг аль эрт олж хэлээд Жамухын уур хилэн, бардам занг хөдөлгөж чадах байсан биз. Жамухыг бусдаас, тэр дундаа Тэмүжинээс сүр хүч мөхөс байхыг Гүрвэлжингоо тэвчиж чадахгүй бөгөөд эцсийн мөч ирвэл өөрөө ч сэлэм шүүрэн Тэмүжиний эсрэг тэмцэн босох нь тодорхой санагдана. Хаврын хувирамтгай салхи шиг үл тайвшрах, үргэлж тачъяадан тэмүүлэх сэтгэлийг Гүрвэлжингоо л түүнд халдварлуулан, үхлийн өрсөлдөөнд үргэлж уриалан дууддаг байсныг одоо л ойлгов.

Тэр бүсгүй Бөртийг, бас Тэмүжинг зүгээр нэг мухар атаархлаар үзэн ядсангүй, бүр устган сөнөөж өөртөө дагуулан авахыг хүсч байжээ. Энэ бас Жамухын хүсэл юм. Жамухын өөрөөсөө ч нууж явдаг энэ хүслийн амьд илэрхийлэл, асаан дэврээгч нь Гүрвэлжингоо байжээ.Тийм адын гал халуун хүслэнтэй түүнийг үл ойлгон зодож тарчлаан нулимсыг нь барж байсандаа харамсавч оройтжээ.

Баруун зүгийн Каспийн тэнгисийн дэргэдэх зөөлөн дулаан уур амьсгалтай нутгаас гаралтай харь цусны энэ бүсгүй чухам ямар үйлийн үрээр өвлийн хүйтэн жавар шигээ догшин ширүүн зантай Жамухад ирсэн юм бол. Гүрвэлжингоог дэргэдээ байсан бол Жамуха өвдөг сөхрөн өршөөл гуйхад бэлэн байв

Одоо гэвч тэр гал халуун сэтгэлт бүсгүй дэргэд нь алга. Сэнгүм сүйрч үгүй болсон болохоор Гүрвэлжингоо үхсэн, аль эсвэл Тэмүжиний шадруудын хэн нэг нь олзолж аваад, дур хүслээ хангаж хэвтээ ч юм бил үү. Үхсэн бол багахан шиг зовж шаналсан байгаасай гэж бодов. Харин Жамуха бусад хатад, тэр дундаас бага хатан Сүүнгэгээнд огтхон ч санаа зовсонгүй.

Толгой дээрээс цас лавсан орж, дэргэдүүр нь хүйтэн салхи исгэрч байв. Ямар төгсгөл, ямар хувь тавилан хүлээж байгааг Жамуха нэгэнт мэдэж байвч аяар доройгоор бууж өгөхийг

хүссэнгүй. Чухам юу хийх гээд байгаагаа өөрөө ч мэдэхгүй байлаа.

Наху баяны хөндийг уруудан Тэмүжиний цэргийн хүрээ рүү ойртох бүр Хантөмөрийн сэтгэл түгших нь нэмэгдсээр байв. Тэмүжин түүнийг хэрхэн угтах бол эзний нь үгийг хэрхэн хүлээж авах бол гэхээс тэр юм. Жамухын ааш зан, шийдвэр нь түүнд сайн ойлгогдохгүй бүр аргаа барж мухардсан хүний үйл шиг л санагдана. Жамуха харахад догшин сүрлэг ч сэтгэлийн цаад үзүүр нь уяруу зөөлөн гэдгийг Хантөмөр сайн мэднэ. Хориод жил Тэмүжинтэй амь өрсөн тулалдаж дайсагнасан мөртөө эцсийг хүртэл үзэлцэхээс зайлсхийн сүүлчийн холбоотон Найманы Таян ханаас салахаар шийдсэнийг бүр ойлгож ядав. Түүнээс салаад хаана очих юм бол.

Хантөмөр өөрөөсөө ингэж асуувч хариу үл олдоно

Энэ асуултын хариуг Жамуха эзэн нь ч өөрөө мэдэхгүй байгааг Хантөмөр гадарласангүй. Толгойн харуулын дэргэд очоод л Тэмүжин ямар зан гаргаж байгааг, Таян хан юунаас айж сүрдсэнийг Хантөмөр мэдлээ. Тэмүжиний цэрэг хүнээсээ олон түүдгийг хөндий дүүртэл асаасан нь Таян ханыг тэгэж айн сүрдэхэд хүргэжээ.”Жамухын элч” гэсэн үгийг харуулууд үг дуугүй сонсоод толгойд нь уут углаж хаашаа ч юм хөтлөн явав. Морины явдлаар тэр уул өгсөж байгаа нь мэдэгдэнэ. Явж явж мориноос буулгаад уутаа авлаа. Тэд модтой жижиг толгойн өвөрт барьсан асрын үүдэнд иржээ. Энэ лавтай Тэмүжиний асар буйзаа. Асрыг торгон цэргүүд шивээлэн тойрч зогсчээ. Тэд лавсан орох цасан дор огт хөдлөхгүй зогсох нь олон хүн чулуу эгнүүлэн тавьсан мэт санагдав. Асрын онгорхой үүдээр галын гэрэл улалзана. Хантөмөрийг хэсэг хүлээлгээд буцан гарч ирсэн хүн сэлмийг нь мултлан авч араас түлхсэн нь ор гэсэн үг бололтой. Асарт дулаан, гэрэлтэй ажээ. Асрын хойморт Тэмүжин хоол идэж сууна.

Арааны шүлс асгарч аманд нь дүүрэхэд өнөөдөр олигтой хоол идээгүй нь бодогдов. Баруун талд хуяг дуулгатай, хад чулуу шиг эр хүрлийн харагдах нь Хасар мөнийг тэр танив. Харин зүүн талд нь хорин хэдтэй, эмэгтэй хүн шиг үзэсгэлэнтэй царайтай, өндөр гоолиг биетэй Зүчи зогсож байх ажээ.

Тэмүжин Хантөмөрийг харсан ч дуугарсангүй. Хөл хүндтэй Бөртийг мэргэдээс буцааж булаан авсны дараа Тэмүжин, Жамуха нар жил хагас цуг амьдарсан тул Хантөмөртэй бүгд сайн танил. Бас Жамухын шадрын хувьд хүндэтгэлтэй хандаж байсан билээ. Тийм ч учраас Жамухын элч гэж түүнийг итгэж байлаа.

-Жамуха эзэн таньд шүлэг зарж намайг илгээв гээд Хантөмөр ёсоо даган сөхрөхөд хуяг дуулга нь хангинаж өвдөг дор нь газар доргих шиг болжээ. Хантөмөр бол сайн долоон тохой өндөр нуруутай хүдэр эр билээ. Хантөмөр уг нь” Гүр хаан Жамуха” гэж хэлэхээр аман дээр нь гарч ирсэн боловч Тэмүжиний дургүйцэл зэвүүцлийг төрүүлэх вий гэж эмээх учир ингэж төвдсөнгүй. Бас Чингис хаан гэж ч хэлсэнгүй. Жамухын цээжлүүлсэн шүлгийг Тэмүжин сонсоод үг хэлсэнгүй. Гарын тосыг дотуур хормойд арчин бодол болж чигчий хуруугаар шүдээ чигчийлнэ..

-Чи дахиад хэл .Чингис хаан сонсож байна гэж Хасар Тэмүжинг төлөөлөн дуугарсан нь түүний эрх мэдлийг илтгэнэ. Хасарын үг хэлэх, Тэмүжинд хандаж буй ёсорхог байдал зэрэг

нь цуг амьдарсан үеэс эрс өөрчлөгдсөнийг Хантөмөр сая л анзаарлаа. Өөрөө яах ёстойгоо ч ухаарав. Тэгээд өвдгөөр явж жаахан урагшлан Тэмүжинд ойртож анхаарлыг нь өөртөө татахыг хичээв. Харин Зүчи түүнийг ингэхэд сэлмээ сугалан өмнөө барив. Мэргэдийн энэ хөвүүн Тэмүжиний үнэнч итгэлтэй шадар болсон нь илт ажээ.

Харин Тэмүжин Хантөмөрийг хүн чинээ санаж дахин харц тусгасангүй.

-Чингис хаан. Жамуха эзэн танд ийн хэлүүлэв. Тэр Жамухын цээжлүүлсэн шүлгийг тодоор давтан хэлээд хариу хүлээн тонгойв. Нам гүм боллоо. Зөвхөн гал асч дөл нь дүрэлзэх төдий чимээ л сонсдоно.

-Чи дахиад хэл гэж Тэмүжин яг суусан чигээр гэнэт хэлэхэд Хантөмөр цочжээ.Тэмүжинийг ийм тод гэрэлтэй шар нүдтэй гэдгийг тэр ерөөс анзаараагүй билээ. Тэмүжиний хоолой сөөж дуу нь танигдахын аргагүй болжээ. Тэмүжин түүнийг харна.

Тэмүжиний энэ аймшигт харц нүдийг нь сохлох шиг болоход өөрийн эрхгүй харц дальдрав.

-Таян хаан чамаас айж Тайга ууланд шургаж оров…

Хантөмөр энэ удаа эхнийх шиг чанга биш, харин аажуухан бөгөөд тогтуун тод дуугаар нэг ч үг гээлгүй дуустал нь уншихдаа энэ шүлгийн цаана нуугдах учрыг ойлгох гэж хичээж буй Тэмүжинд тус болохоор аядуу уянгалагаар давтав. Түүнийг уншиж байхад “ Гүр хаан “ гэх үг сонсоод Тэмүжиний хараа улам хурц болох шиг болсны зэрэгцээ “Уралцах цаг ч тохионо биз” хэмээн дуусгах үед шанааны нь булчин гүрэлзэн зангирч шүд зуух нь анзаарагдсан тул Хантөмөр багагүй эмээжээ.

-Өөр юу гэж хэлүүлэв гэж Тэмүжин асуусан нь Жамухын салахдаа хэлсэн үгийг мэдэж байх шиг санагдаад Хантөмөр эргэлзэж эхлэв. Тэмүжинд юу ч нуух хэрэггүй гэж тэр хормын дотор шийдлээ. Учир нь Тэмүжин үнэнч хүнд дуртай гэдгийг олон удаа сонссон билээ. Харин Тэмүжин тэдний нууц яриаг мэдсэндээ ч биш, Жамухын хэлүүлснийг сайтар ойлгож ямар хариу өгөх вэ гэдгээ сэтгэж амжихгүй тул цаг хожих гэж л зүгээр нэг асуусан нь тэр байлаа.

-Хэрэв Тэмүжинг хүсвэл чи намайг орхиж түүний өндөр босгыг бэхлэж, өргөн хатавчийг нь хашиж суу гэж илгээв. Ингэж хэлээд Хантөмөрийн сэтгэл нэг мөсөн цэлмэн амрав.

-Харин чи юу гэж бодно. Тэмүжинээс ийм үг сонсох нь юу юунаас илүү тодорхой байсан тул зам зуур бодож явсан үгээ эрэмгий агаад бахархал дүүрэн сэтгэлээр

-Би Жамуха эзнээ уулын мухар, усны чанад ганцаар яаж орхино…гэж тод хэлэв.

Тэмүжин, Хасар хоёр дуугараагүй ч түүний үг тэдэнд таалагдсан нь илт байлаа.

-Харин би гэдрэг хурдан буцахгүй бол Жамуха эзэн минь намайг энд үлдэв хэмээн санаад орхин одох бий гэж эмээж байна. Хантөмөр үнэхээр ингэж айж байлаа.

-Тэгвэл чи үтэр буц. Очоод Жамуха андад ингэж хэлэгтүн гэж Тэмүжин сөөнгө дуугаар шивнэв. Анд гэж дуудсан нь Тэмүжиний найртай сэтгэлийн илрэл юм. Бүгд анхааран

хүлээлээ. Тэмүжин ч шийдсэн царайтай болжээ

-Жамуха анд чиний шүлгийг сонсов .

Нарны дор газрын дээр

Надаас чи хаа зайлна.

Мөнх тэнгэрийн зарлигаас гажиж

Мөхөс чи хаа холдоно

Гэмгүй цэргийн амийг

Гэсгээж бүү золигтүн

Дайсны хүрээнд суухаар

Даруй ирж шадарлагтун

Ухаан зориг гаргаж

Урьж залуулалгүй ирвээс

Урдын явдлыг чинь мартаж

Багын андын ёсоор

Бат найрсан сууя…

Тэмүжин хэдийгээр Жамухтай адил уран цэцэн үгсийг урсган шүлэглэж чадахгүй ч Хантөмөрт цээжлэхэд нь амрыг бодож дээрх үгсийг айзам холбон хэлжээ.

Хантөмөр Тэмүжиний хэлснийг давтан хэлж түүний толгой дохихыг үзээд бослоо. Хэн ч дахин дуугарсангүй тул гарахын өмнө эргэж харан Хасарт хандан

-Таян хан бөө авчирч тэнгэр задлан та нарын дээрээс цас мөндөр оруулах гэж байна. Үүнийг болгоогтүн гээд гарав.

Жамухын шүлэгт Найманы цэргийн байдлыг тодруулсан тул байлдах аргаа яаралтай боловсруулах хэрэгтэй байлаа. Элч ирүүлсэн нь Жамухын Тэмүжинд үзүүлсэн сүүлчийн тус биз ээ. Чухам яах гэж ингэв гэдгийн учрыг Тэмүжин ойлгосонгүй.

Тоорил, Сэнгүм хоёртой нийлж түүнийг довтлохдоо бас л ингэж нууц элч ирүүлж Тоорилын цэргийн байдлыг хэлүүлсэн билээ. Харин Хантөмөрийн хэлсэнчлэн Таян хан бөөгийн хүчээр тэнгэр задалсан бололтой. Салхи улам ширүүсч цасан шуурга тавьж эхэллээ.

Хантөмөрийг Хасар өөрийн биеэр гаргаж өгсөн нь Жамухыг хүндэтгэсэн хэрэг байв.

Хасар ч, Хантөмөр ч юм дуугарсангүй.

Харин тэднээс холгүй өнөөх загасан нүдэт Тату Зүчийн морийг барьж зогсоно. Татуг хармагц өдөр Жамухын хэлсэн санагджээ.”Нээрээ мартахын аргагүй хачин нүдтэй золиг юм” гэж Хантөмөр бодоод мордлоо.

Ононы Зээрэн хавцлын дэргэд тэр нэгэн шөнө энэ Тату түүний дуг хийхийг анаж байгаад Зүчи Цагадай хоёрыг авч зугатаасныг Хантөмөр мартаагүй байв..Жамуха тэгэхэд хилэгнээгүй нь аз болсон билээ.

Гэвч Хантөмөр одоо тэрийг санаж Татутай тооцоо бодохгой манатай. Даруй гэдрэг довтлон Жамуха эзэндээ хурдан очихыг тэр хүсч байлаа . Ингээд дөнгөж саяхан Чингис хааны өчүүхэн төдий дохио зангааны үзүүрт байсан түүний амь нас Жамухын гарт буцан очив.

Ширүүсч буй салхийг сөрөн Хантөмөр морины ам татахгүй давхисаар торж сааталгүй буцан ирвэл Жамуха унтаж байлаа. Түүний олон хоног нойргүй явсныг бодон хэсэг зуур сэрээж чадахгүй хүлээжээ. Гэвч Тэмүжиний үгийн чухлыг санавал үүр цайж гэгээ орохоос өмнө хөдлөх ёстой тул аргагүйдэн түүнийг сэрээв. Тэмүжиний үгийг сонсмогц Жамуха үсрэн босов. Хор шар, уур хилэн нь бадарчээ. Бөртэ зүүдэнд нь орж хэлсэн үгийг одоо түүнд Тэмүжин хэлүүлжээ.

Дотор сэтгэлдээ өөрөөсөө ч болов нууж байсан далд хүслийг нь Тэмүжин тааж мэдээд одоо бууж өгөн гутамшигтайгаар дагаж ирэхийг шаарджээ.Жамухыг буулган авах нь түүнийг алснаас амттай байх нь мэдээж. Ингэж бодсоноос Жамухын уур хилэн, хор шар оволзжээ.

-Цэргүүдээ босго. Мордъё. Хантөмөрт эзнийхээ үгийг дагахаас өөр арга байсангүй тул буцаж гүйлээ. Удахгүй Жамухын цөөн цэрэг Таян хааны хүрээнээс сэм гарч баруун хойт зүгийг чиглэн чимээгүй гулсах могой мэт холдон холдсоор харанхуйд уусан алга болжээ. Жамуха нэг ч үг дуугарахгүй хүрлэгэр царайлан цэргийн манлайд морин дээрээ унтсан мэт явна. Цэргүүд зүү дагах утас шиг хойноос нь довтолгоно. Тэд бол Жамухын төлөө амиа өгөх үйлтэй үнэнч нөхөд нь юм. Одоо юу болж хэрхэхийг хэн ч үл тааварлана. Энэ үед Борзонт уулын энгэрт Тэмүжиний асрын гадаа асаасан их түүдгийн дэргэд Тэв тэнгэр бөөлж, Таян ханы бөөгийн ирүүлсэн цас шуургыг хариулах засал хийн хэнгэрэг нь нижигнэж, түүнээс холгүй Тэмүжин нөхдийн хамт бүсээ хүзүүндээ тохоод хоёр гараа Тэнгэрт сунган дээш харан мөргөж суужээ. Тэв тэнгэр бөө ганцхан өөрөө л ойлгодог хэлээрээ Тэнгэртэй ярьж, бас аялгуулан дуулж аргадан гуйх ажээ. Тэв тэнгэрийн гайхалтай цээл хоолой харанхуй тэнгэрийн гүнд дээш цацран шингэж байв. Удалгүй салхи тогтов. Тэв тэнгэр түүдгийн дэргэд муужран унажээ. Түүнд хэн ч үл ойртоно. Тэмүжин ч бас хөдөлсөнгүй, өнөө л гараа Тэнгэр өөд сунгасан чигээр суусаар. Салхи зүгээ өөрчлөн хөндийгөөс уул руугаа сэв сэв үлээж эхэлснээ хормын дотор ширүүсэн цас хаялж эхлэв. Тэв тэнгэрийн үгийг салхи сонсчээ. Тэв тэнгэр сэргэмэгцээ ухасхийн өндийж хэнгэргээ шүүрэн аваад чанга чанга дэлдэж түүдэг тойрон дэвхцэж бүжив. Тэр одоо нэгэнт эхлэсэн цас шуургыг хөөргөдөн үлээж байгаа нь энэ. Тэмүжин Тэв тэнгэрийн хүчинд итгэнэ.

Үнэхээр асар хүчтэй салхинд үлээгдсэн цас уулын орой, хясаан дээр хоргодсон Таян ханы

цэргийн дээрээс шуургалан бууж, цэргүүд нь айж орилолдон хавцал руу нурж гулсан, нисч үхэцгээж эхлэв. Таян хан хүчит салхинд хийсч унасан асартаа дарагдаад

-Жамуха.Жамухыг дууд.Цэргээ засаг гэж ам тавих гэж буй мэт бачимдан орилно. Гэвч Жамуха түүний дууг сонсохоос нэгэнт өнгөрчээ. Цасан шуурганд хийссэн цэргүүд бие биеэ дарж тэдний аймшигтай их хашгиралдаан улин исгэрэх хүчит шуургатай зэрэгцэн сүнс зайлмаар цуурайлах ажээ. Харин энэ салхины исгэрээн, үхэж буй цэргийн орилолдооныг Жамуха сонсов.

Гэхдээ тэр чихэндээ биш зүрх сэтгэлдээ сонсчээ.Холын хол, харанхуй шуурган дунд Найман аймгийн цэргүүд үхэж, сүйрч байлаа.

-Хурдал… Морио гуядацгаа… гэж таг дуугүй явсан Жамуха гэнэт бүгдийг цочтол хашгирлаа. Жамухын сэтгэл түгшүүрээр дүүрчээ. Учир нь Таян хан сүйрлээ ч Тэмүжин түүнийг зөнд нь орхихгүй билээ.

Түүний бодсон үнэхээр зөв байлаа. Тэв тэнгэрийн ид шидээр эргүүлсэн цасан шуурга Таян ханы цэргийн дээрээс бууж, сандарч тэвдсэн тэдний үлдэгдлийг өглөө болмогц Хасар нөхдийн хамт хядаж дуусгана…

Харин Жамухын мөрөөр Тэмүжиний үнэнч нохой Боорчи шилдэг цэргүүдээ манлайлан гэзэг даран довголгож явааг Жамуха үзсэнгүй. Гэвч өөрийгөө аврах дадал, амьд үлдэх их хүсэл нь түүнээс гавшгайлан хурдлахыг шаардсан ажээ. Боорчи амаа ангайж олон морьдын хөлсний үнэрээр баримжаалан мөрдөж явлаа. Жамухыг амьдаар барьж авчрахыг Тэмүжин түүнд тушаасан тул Таян ханы цэргийг цохих ч завгүй Жамухыг мөшгисөн билээ…

Одоо тэдний хоорондох зай алхам алхамаар ойртож байв. Жамухын үхэл Боорчийн дүрд хувилаад түүнийг нэхэж явав. Гурав хоногийн дараа гэхэд Боорчи Жамухыг нэхэн гүйцэж тулаан эхлэсэн ч Жамуха энэ удаад үхлээс мултран гарчээ. Сар шахам муур хулгана шиг хөөцөлдөн нэхсэний эцэст Жамуха хэдхэн тооны цэрэгтэйгээ газрын гаваар орсон мэт алга болоход хэдийгээр гэмшиж, Тэмүжиний зарлигийг биелүүлж чадаагүйдээ түгшиж байсан ч үлдсэн цэрэг нь эцэж ядрахын туйлд хүрсэн тул Боорчи аргагүйдэн буцахаар шийдэв. Тэмүжин энэ үед Таян ханыг үхүүлж Найман аймгийн иргэд, эд хөрөнгийг хураан аваад Алтайн нурууны өвөрт нутаглаж байв.

Тэмүжин Таян ханы эх их үгт Гүрбэсү хатныг барьж авчран байцааж олон сар дотроо хадгалж явсан хорслоо тайлжээ. Найман аймагт байсан Тэмүжиний туршуул Удай гэгч эр Таян ханы эхийнхээ хамт хэлэлцэж байсан үгийг өмнө нь хэлсэн тул Тэмүжин энэ их үгтэй авгайд хорсон бухимдсаар байсан билээ.

Тэмүжинг Боржигон аймгийн хан болж Хэрэйд аймгийг мөхөөснийг дуулсан Найманы Таян хан

-Омог ихтэй болсон цөөн Монголчуудыг даруй номхруулъя. Тэд эртний сурвалжит хан Тоорилыг дутаалган үхүүлэв. Тэнгэрт зөвхөн нар сар хоёр байдаг биз. Гэтэл газар дээр хоёр хан байж яаж болно. Одоо бид тэр Монголчуудыг эзэлж авчиръя гэж ихэрхжээ.

Тэгтэл Гүрбэсү хатан эх нь

–Тэр Монголчууд чинь хар муухай хувцастай, ханхлах муу үнэртэй тул авчирч юу хийнэ. Холхон тэнд нь байлга. Гагцхүү шилдэг цэвэр охид, бэрүүдийг нь авчирч гар хөлий нь угаалгаж байгаад үнээ, хонь саалгавал яадаг юм гэхээс. Бусдыг нь хар гэрт нь нутагт нь үхүүлвэл таарна гэжээ.

Харин Таян хан

-За юу боловч бид Монголчуудын хоромсог, саадгийг нь хураан авчирч тэр Тэмүжинд хар навтас нөмрүүлж хамаг олны өмнө хашраан залхаая гэсэн байв.

Дэргэд нь байсан Найманы Хүгсэү Сабраг баатар

-Тэмүжинг яаж басамжилж болох вэ.Та хэтэрхий их үг хэлж байна.Хан та Хангайн нурууны Улаан хус гэдэг газар намайг Тэмүжинд яаж цохигдсоныг мартав уу гэж магнайн хөлсөө чийхартал сануулсан боловч Монголын нэртэй аймгийн Жамуха олон иргэд цэргийн хамт түүнтэй нийлнэ гэсэнд зоригжсон Таян хан өөрийн болчимгүй үгнээс буцалгүй цэргээ Алтайн нуруу давуулан хөдөлгөн монголын нутагт орж Орхоны хөндий хүртэл довтлон ирсэн нь ийнхүү үхэл, сүйрлээр дуусч өөрийнхөө болоод олон цэргийн амийг үрж Найман аймгаа мөхлийн замд хөтөлжээ.

Орхоны хөндийгөөс Алтайн нуруу давтал найманы цэргийн хүүр хөлөөр хөглөрч газрын хөрс улаан өнгөтэй болжээ.Найман аймгийн бүх иргэд, хөрөнгийг хураан авч Тэмүжин тэр их үгт хатан Гүрбэсүг барин авчирч хээрийн өргөөндөө ирүүлэв. Тэр Гүрбэсү нас тогтсон ч жавхаа үзэсгэлэн буураагүй нь нүдэнд унана.

-Чи Монголчуудыг муухай үнэртэй гэдэг билүү. Чи одоо юунд энд ирэв гэж Тэмүжин хөхөрч түүнд ойртон тарган эрүүн дээрээс нь татаж үзэв.

-Би чамайг өөрөө авна Гүрбэсү хатан их үгтэйн адилаар бас эм хүн гэхэд цөс ихтэй учир огт сандарч ичсэнгүй. Харин ч зориг төгс ихэмсэг зогсоод

–Тэмүжин.Би чамайг эцэггүй золбин, ижилгүй өнчин өссөн гэж сонссон. Чи эртний сурвалжит Тоорил ханыг дарж баян хүчирхэг, бичиг соёлтой манай Найман аймгийг мөхөөсөн нь нэг цагийн тохиол болохоос Тэнгэр мэт үүрдийнх гэж бүү эндүүр. Найман аймаг чамд дийлдсэн нь чиний гарамгайнх биш. Манай Таян ханы болчимгүй, чадваргүйнх болов. Бас чиний хуучин анд Жамухын угийн хуншгүй, урваач шарваач зан нэрмээс болов.

Чиний ингэж түр зуурын ялалтандаа хөөрч, орилж гуагачих чинь хээрийн зэрлэг хүн гөрөөс хоол олоод баясахтай адил байна. Би чамайг эзэнгүй гөлөгтэй адил үзэн үл тооно гэж басч доромжлох их үг хэлсэнд Тэмүжиний тэвчээр алдарч цэрэг дуудан түүний тарган шалхгар биеийг чармай нүцгэлэн хүчээр эдлэн бах таваа хангаад чирч гарган цэргүүддээ хаяж өгчээ.

Найман аймгийн олзны хүмүүсийн нэг Тататунга гэгч нэгэн тамга өвөртлөж явсныг Хасар олж Тэмүжинд авчран учрыг хэлүүлэв.

Хэрэг хөтөлж явуулахад энэ тамгыг хэрэглэх, мөн өөрсдөө бичиг сурах нь хэрэгтэй чухал болохыг Хасар сайшаан мэдүүлсэнд Тэмүжин дэмжиж тэр дороо хүн томилж Хасараар толгойлуулан бичиг үсэг заалгах болцгоож төвөггүй сурцгаасан билээ.

Найманыг дагуулсны хамгийн том олз нь Монголчууд уйгарын бичиг үсэг хэрэглэх болсон явдал юм.

Найманыг дарсны дараа Тэмүжин цэргийн хамт Алтайн нурууны өвөрт өвөлжиж байтал энэ мэт явдал болжээ. Жамухатай хөөцөлдсөөр цэргээ ядрааж, морьдоо эцэсэн Боорчийг гуринхалсан нохой шиг үлгэн салган ирэхэд Тэмүжин огт уурлаж хилэгнэсэнгүйгээр барахгүй түүнд Найманы иргэдээс маш олныг шагнан өгөв. Одоо Жамуха нүхний оготно шиг аюулгүй болж түүний толгой хоргодож байсан Найман аймаг нэгэнт сөнөсөн тул Тэмүжин тийн сэтгэл өөдрөг байлаа. Ер нь тэр Боорчид зэмлэж хилэгнэсэн хатуу үг хэлсэн нь тоотой. Тэгэж хэллээ ч энэ нь зөвхөн бусад нөхдөд анхааруулж, ухааруулахын тулд хэлдэг байв.

Үүнийг Боорчи мэдэх тул сэтгэл хангалуун байх бүлгээ. Найман аймгийн Таян ханы довтлох муу санааг хэлж ирсэн тэр Удуй гэгчийг Тэмүжин сайшааж хуучин Таян ханы эдэлж байсан өргөө гэр, тогооч, шивэгчидийг шагнан олгов. Тэмүжин өөрт нь хэрэгтэй чухал хов мэдээ хүргэж ирсэн хэнийг ч болов өгөөмөр сэтгэлээр шагнан урамшуулдгийг нь монголын тал даяар сайн мэдэх болсон тул өрсөлдөгч аймгуудаас туршуул тагнуул олох нь туйлын амар хялбар болсон билээ. Энэ аргаа тэр олонтаа хэрэглэж туршсаар бүр байнгын тагнан турших албыг Уханаар толгойлуулан байгуулжээ.

Хожим нь энэ алба монголчуудын их аян дайны бэлтгэлийг хангах, дайсны дунд өөрийн хүмүүсээ оруулж байлдааны гарз хохирлыг багасгах, ялалтыг түргэсгэх, дайснаа ямар ч хохирол тэмцэлгүйгээр буулган авахад чиглэсэн элдэв нууц ажил явуулга хийх зэргээр Чингис хааны болон түүний залгамжлагчдын их үйлсэд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн билээ Монгол аймгуудын хамгийн баруун талд орших Найман бол бусад аймгуудаасаа соёл ахуй нь түлхүү хөгжсөн, илүү баян чинээлэг, бүр өөрийн бичиг үсэгтэй байсан нь Тэмүжинд ихийг бодогдуулж Найманаас баруун тийш байх улсуудыг ихэд сонирхох болсон бөгөөд улмаар Уханыг худалдаа хийх нэрээр тагнуулд явуулжээ. Харин одоо цэргээ амарч дуусмагц хэдэн гол дамжин зугатсаар байгаа өст мэргэдийн үлдэгдлийг үр үндэсгүй болтол нь устган сөнөөх хэрэг тулгараад байв.

Тэднийг үгүй хийвэл Монгол аймгууд бүгд түүнд эзлэгдэн захирагдах бүлгээ.

Жамуха Боорчиос азаар амь мултран гарч бүр баруун хойт зүг нүүр буруулан зугатсаар Тагна ууланд хүрч сая нэг амсхийн хэдэн сарыг үджээ. Хоол хүнсгүй өлсөж цангаж олон ч хоног хэвтэв. Одоо түүний дэргэд Хантөмөртэй нийлээд таван цэрэг л үлдсэн байв. Сүүлдээ амь зогоохын тулд нутгийн айл амьтныг дээрэмдэх ч жирийн явдал болжээ. Өвөл өнгөрч хавар, бүр зун болов.Ууланд хөхөө донгодож, усанд хун галуу ирэн цэнгэж уран байгал бүхий л өнгөөрөө дэлгэрэн газар дэлхий дээр үхэл зовлон, үгүйрэл хоосрол ирэхгүй мэт баян үзэсгэлэнтэй зун боллоо.

Туранхай ч гэлээ аргаль алж шарж идсэн тэр өдөр Жамуха эцсийн үгээ Хантөмөрт хэлж энэ гунигт түүхээ төгсгөл болгохоор шийджээ. Шарсан мах идэж, гэдэс гарсан цэргүүд торгон

зүлгийн дээр ундуй сундуй тэрийн унаад хамраа сэтэртэл хурхиран унтана. Ганцхан Хантөмөр л эзэндээ мах шарж өгөх гэж түүдгийн дэргэд бөртийнө. Уг нь аргалын махыг харц боол хүн идэх ёсгүй юм. Гэвч ийм үед хэн хаан эзэн, харц боол гэж ялгах билээ. Өлссөн ходоод хүн бүрт адилхан тул түүхий махыг өнгө хувиргасан төдий болмогц улаан шүүсийг нь эрүү завьжаар савируулан чоно шиг булаалдан архирах нь холгүй уралдан идэцгээжээ. Харин Жамуха цэргүүдээ цадахыг тэвчээртэй хүлээн хоосон ходоодоо хоржигнон дуугарахыг сонсон суув. Хантөмөр өрц нь нуруундаа наалдатлаа өлссөн цэргүүдээс өрсөн салгаж авсан аргалын гуяа тухтайхан шарж байлаа. Сайтар болохыг хүлээн байн байн эргүүлж тойруулан шарна. Жамуха эзэнгүй бодолд автан түүдгийн гал ширтэн суув.Үзэсгэлэнт байгаль, шувуудын жиргээн дунд шарсан махны сайхан үнэр ханхлах нь ер диваажин мэт.

Хантөмөр хором боловч туйлын жаргалтай байлаа.

-Гүр хаан та шарсан махаа зоогло. Хантөмөрийн хэлсэн хоосон хүндлэлийн үг одоо томдсон хувцас мэт тээртэй санагдавч Жамуха дуугарсангүй бүснээсээ хутгаа сугалан авч шарсан мах руу дайран оров. Бүтэн гуяны мах идэж булгийн хүйтэн ус уугаад сая нэг цадсанаа мэдэж зөөлөн ногоон дээр хэвтмэгц нойр нь хүрч өөрийн эрхгүй нүд анилдана. Жамуха унтаж болохгүй гэж санаад өндийхөд эзэн нь нэг юм хэлэх гээд байгааг царайгаар нь гадарласан Хантөмөр түүнд ойртон суув. Амь өрссөн тулаан, үхэл цус бүгд ард үлдээд энд моддын дунд эргэн тойрон шарсан махны үнэр ханхлан нэн таатай, хэн боловч тайвшран нам унтмаар ажээ.

-Хантөмөр өө.Чамд ер нь үхэхэд харамсах зүйл бий юу гэж Жамуха гэнэт асуув.

Хантөмөр юу гэж хариу хэлэхээ тэр дороо бодож олсонгүй. Энэ үг амиа хорлож үхье гэсэнтэй адил сонсдоод байв. Ам нээхээс өмнө эзнийхээ ончирсон сэтгэлийг тайтгаруулж үхлийн тухай бодлоос салгахын тулд таарах аятай үг олох гэж хэсэг бодов.

-Гүр хаан. Би таныг үгүй болбол амьд яваад юу хийнэ. Үхэхэд хүндтэй шалтгаан хэрэгтэй биз

Хэрэв та нэгэнт амиа үрэхээр шийдсэн бол эхлээд намайг хороогтүн. Ийм үг сонсоод эзэн нь ухаарч уярна гэж Хантөмөр итгэжээ.

-Тиймээ. Хантөмөр чи зөв үгийг олж хэлэв. Жамуха надад амиа үрэх олон түмэн шалтаг буй.

Саар хүний үгээр

Сайн нөхрөөс урвав би

Саадаг нумнаас хагацаж

Сарних манан болов би

Ононы эрэгт өргөсөн

Оноо тангаргаа эвдэв би

Онцолсон нөхрөөс урваж

Осол ялд унав би

Атаат эмсийн үгээр

Андаас салж хагацав би

Асрах нөхөргүй хоцроод

Алжаан зүдэрч зовов би

Хураасан улсаа сандрааж

Хумхийн тоос болгов би

Цуглуулсан улсаа бутрааж

Цугийг үхдэл болгов би

Жамуха гүнзгий гуниг харуусал дүүрэн дуугаар ингэж шүлэглэн хэлэв. Бас зүүн нүднээс нь ганц дусал нулимс тасран хацрыг зүсэн доошлохыг Хантөмөр зүрхээ шархируулан харж байлаа. Хүчирхэг Жадаран аймгаа манлайлан олныг бишрүүлж явсан зүс гоо, бие өндөр, зориг их энэ эр одоо адгийн хулгайч, алдуул босуул шиг хээрээр гэр хийж, хэцээр дэр хийж бөөс хуурсанд баригдан бүлх шөрмөс зажилж явахыг үзэхэд нэн харуусал эмгэнэлтэй ажээ. Түүний нүднээс цус шиг дусал нулимс гарсан нь аргаа барсны, бас амиа үрэхийн эргэшгүй тэмдэг гэж Хантөмөр түгшив.

-Эзэнтээн. Энэ эзгүй ууланд элс мэт дарагдаж, эрэг мэт нурахын оронд даруй тэмцэн явж Алтан улсад очвол дээр биш үү. Эсвэл баруун тийш Уйгар, бүр болохгүй бол Тангуд улс, Харлагт ч очсон таныг баярлан угтах биш үү…

Хантөмөрийн зориглон хэлсэн энэ үг үнэн тул Жамуха эсэргүүцэн дуугарсангүйд тэрээр улам зоригжин үгээ үргэлжлүүлж бүр дэргэд очоод тулж суув.

Одоо тэд хаан, эзэн, боол албат биш халуун амь нэгтэй хайртай нөхдийн ёсоор амьсгаа нийлүүлэн суужээ. Дөчин жил дөрөө мултлалгүй дагаж, гучин жил гутал тайлалгүй зүтгэсэн эзэндээ хамгийн ойрхон суусан нь энэ байв. Тэдний хооронд одоо хуруу төдий зай үлдээд бараг хамрын үзүүр шүргэх ажээ

-Гүр хаан. Ингэж хүндэтгэл дүүрэн хэлсэн нь эзнээ сэргээх, хуучин золбоот үеийг нь санагдуулах сэтгэл санааг нь өргөх гэсэн түүний аргаа олж ядсан бяцхан заль төдий юм.

-Гүр хаан. Алтан улс Тэмүжиний хүчирхэгжихийг хэзээ ч үл таашаах тул таныг талархан угтаад зогсохгүй цэрэг хөдөлгөн тусалж ч мэднэ. Тэгвэл танд улс аймгаа буцаан авах сайхан боломж дахин ирэх биш үү. Урагш явж Тангуд улсаар дамжин Алтан улсад очвол болохгүй гэх газаргүй. Бидэнд хэдэн сайн морьд байхад л болно. Хантөмөр эзнээ дахин сэхээсэй,

хүчирхэгжин мандаасай гэж үнэн сэтгэлээс хүсэх тул ийн хэлэв. Бас Жамуха түүний энэ үнэн үгийг нь даган Алтан улсад одно гэж итгэнэ.

Жамуха түүний хэлснийг сонсоогүй мэт таг дуугүй гөлрөн суув. Гэтэл тэр шадрынхаа үгийг сонсохын сайнаар сонсч шар хор нь буцлав.

-Хантөмөр чи сонс. Чиний хэлсэн үнэн ч байж мэднэ. Алтан хаан надад цэрэг өгч Тэмүжиний эсрэг явуулж ч мэднэ. Тэмүжинг дарахсан гэж Алтан улс хүсэх нь лавтай. Гэвч чи муу модон толгой, дүлий годил минь нүдээ нээ. Чи юу үзнэ… гэж Жамуха огт санаандгүй байтал шүлсээ үсчүүлэн хорсон шивнэв.

Үүнийг үзвэл эзэн нь лав ухаан самуурч бодол ээдэв үү гэлтэй. Жамухын нүднээс хорсол занал нь бараг нулимс адил дусах нь үү гэмээр дүрэлзэв.

-Би юү үзэх ёстой гэж. Би одоо Гүр хаан таны гархилсан нүд, сайртсан нүүрийг харж байна. Би өөр юү үзнэ.Би таны хорсол заналдаа шатаж солиорохыг харж байна гэж Хантөмөр бас л өөрийн мэдэлгүй хорсон шивнэв.

-Алтайн нуруунаас, Хянганы нуруу хүртэл олон голын Монгол аймаг бүгдийг Тэмүжин хурааж дуусав. Би мөн ингэж хүсээгүй гэж үү.Одоо бүх монгол аймаг Тэмүжиний гар дор цуглав. Би Тэмүжиний дайсан болохоос Монголын дайсан биш тул яахин Алтан улсад очиж болно. Чи ийм завхай муу үг надад дахин бүү хэл. Харин одоо чи чихээ онгойлгож миний хэлэхийг сонс. Би чамд эцсийн зарлиг буулгая. Үүнийг Гүр хаан Жамуха би чамд хэлж байна. Сонсохоос ч дургүйцдэг Гүр хаан гэдэг үгийг Жамуха эзэн нь юуны учир хэлснийг Хантөмөр тэр дор нь ойлгосонгүй.

Жамухын хэлж ярих нь догшин сүрлэг болсон тул Хантөмөр хойш алхам ухрав. Харин Жамуха түүнд шахан ирж зогслоо. Нам унтсан дөрвөн нөхдөө хяламхийн харвал тэд яг л үхсэн мэт гулдайн хурхирах ажээ. Хантөмөрт тэдний адил нам унтах хүслийг шарсан мах дүүртэл чихсэн ходоод нь сануулна. Гэвч түүнд унтах зав олдохгүй байв.

-Хантөмөр чи сайн сонс. Бүү дуугар. Жамухын нүд загасных адил дүгрэг болсон нь хичнээн чухал юм хэлэх гэж буйг гэрчилнэ. -Тиймээ. Би Тэмүжинд дийлдээгүй бол бас л Монгол аймгуудыг нэгтгэхийг хүссэн.Гэвч миний хийж чадаагүйг Тэмүжин хийв. Одоо чи бид хоёр өнгөрснийг биш цөөхөн ч гэлээ үлдсэн маргааш өдрийг бодъе. Чи намайг барьж хүлээд Тэмүжинд аваачиж тушаа…

-Гүр хаан гэж Хантөмөр сонссон үгэндээ цочин хашгирав.

-Би чамайг бүү дуугар гэсэн биш үү. Чи миний үгийг бүү тасла. Чи юу ч бодож сэтгэх ёсгүй. Ганцхан миний хэлснийг хий. Би Тэмүжинд очихоор шийдлээ. Гэхдээ би гэмээ мэдсэн мэт харц буулгаж, хормой унжуулж,аврал эрж очихыг үл хүснэ. Харин чи надаас урваж намайг хүлж Тэмүжинд аваачиж тушаагтүн. Цэргүүдээ ингэж ятга. Би эзгүй хээр шархадсан чоно шиг жалгын мухарт үхмээргүй байна. Би үхвэл Тэмүжиний гарт үхье. Гэхдээ хүчинд автан очих нь нэрэнд цэвэр байх болно. Чи үүнийг хийх гэж надад шадарласан биш үү…

Жамухын энэ аймшигт үгс эрс шийдмэг, эргэлт буцалтгүй нь тодорхой тул Хантөмөрт дуугүй сөхрөн унахаас өөр арга олдсонгүй. Энэ бол миний төлөө чи үх гэсэн үг юм. Эзэндээ ингэж нохой мэт үнэнч зүтгэсний эцсийн шагнал нь түүний нэр хүндийг амиараа аврах ёстой болж байгааг Хантөмөр ойлгов. Жамуха эзэн нь гарцаагүй ганц зөв зам сонгосныг мэдлээ. Тэмүжин Жамухыг өршөөх нь лавтай. Харин хаан эзэндээ халдсан боолын ёсоор түүнийг Тэмүжин цавчин алах нь магад. Энэ бол одоо толгой халааж буй нартай адил үнэн тод хэрэг юм. Жамуха ч үүнийг ойлгож байв. Эзэндээ үнэнч зүтгэж өөдөөс нь амь өрсөн тэмцсэн олон дайснаа Тэмүжин сайшаан үнэлж, шадраа болгосныг мэднэ. Бас эзнээсээ урвасан барьж аваачиж өгсөн хэнийг ч болов өчиггүй цаазалдгийг сонссон. Өөрийн эзэндээ үнэнч байж чадаагүй бол хэн ч бай Тэмүжин итгэн нөхөрлөдөггүйг мэдэх билээ.

Тийм болохоор Жамухын сая хэлсэн үг Хантөмөрийн хувьд цаазлуулсантай адил хэрэг байв. Үхэх нь Хантөмөрийн хувьд дэндүү гаслантай, яавч зөвшөөрч болохгүй хэрэг юм.

-Гүр хаан. Та яасан гэж юунд осолдсон гэж намайг ингэж залхаана вэ. Би танд осолдож буруутсан удаа бий юу. Би тэжээсэн нохой шиг, тавьсан сум шиг л зүтгэв. Та юунд ингэнэ вэ. Та намайг одоо л тас цавчиж орхи. Би хаан эзэндээ халдаж яаж таныг Тэмүжинд хүргэж өгч чадах вэ. Түүнд орвол би эндээ үхье. Үгүй бол та намайг зүгээр л хөөж орхиоч. Би олдсон заяагаа дагаад хаа нэг газрын мухарт хүн шиг амьдаръя. Надад бас…

Гэвч Хантөмөр сүүлчийн үгээ хэлж дуусгалгүй таг гөлрөв. Тэр айсан сэтгэл хөдөлсөндөө дэмий олныг чалчсанаа ухаарсан ч нэгэнт оройтжээ.Хантөмөрт үхэж болохгүй шалтгаан байгааг ойлгомогц Жамуха түүний цээжиндээ үлдээсэн үгийг нэхэн шаардав. -Чамд бас юу бий гэнэ. Түүнийгээ хэлэгтүн. Бүү нуу. Хэлэхгүй явбал эцэст нь харамсах ч юм билүү…

Хантөмөр газар дэрлэн хэсэг хэвтээд өндийв. Үхэхийн өмнө хэнээс юугаа ч нуух билээ.

-Надад нэг бүсгүй бий юм. Тэр намайг хүлээж буй гэж Хантөмөр эцэгтээ зодуулахаас айсан хөвүүн шиг дальдчиж шилээ маажин хэлэв.

-Бүсгүй гэнэ ээ… гэж Жамуха гэнэт зугаатай болж тас тас хөхрөв

Түүний цангинасан инээд эртний жаргалтай сайхан үеийг санагдуулна.

-Үгүй ер. Хад чулуу шиг, хөлдүү мөс шиг чамд бас дассан бүсгүй бий гэнэ ээ. Хэлээч хэн юм бэ. Би лав таних биз

-Тайчуудаас авсан нэг хүүхэн юм. Одоо хаана явааг ч бүү мэд. Бас …хүүхэд нь төрсөн бол… Хүү юу, охин уу бүү мэд. Жамуха үүнийг сонсоод бүр ч баясав.

-Хүүхэд ээ… Чи бас сүрхий эр юм… Би чамайг дутуу ойлгожээ. Чи миний санасан шиг тэнэг толгой биш юм гэж Жамуха үнэнээсээ хэлжээ.

-Тиймээ. Түүнээс хүү гарсан байгаасай гэж би их хүснэ. Бүр өглөө болгон чулуу тасалж мэргэлдэг гээч.

-Тэгээд хүү юу…

-Заримдаа хүү, заримдаа охин гэж буугаад толгой эргэж гүйцээд сүүлдээ Тэмүжиний цэрэг алж орхиогүй бол хүү охин аль нь ч байсан хамаа юув гэж бодох боллоо гэж Хантөмөр үнэнээ хэлэв.

-Харц зарц юм бол Тэмүжин яав л гэж. Тайчууд бүгд Тэмүжинд дагаж очсон. Санаа бүү зов. Хэрэг нэгэнт ийм бол би чамайг үхүүлэхгүй байхыг Тэмүжинээс гуйна. Бүр чамайг сул ардын адил дархлан тавьж явуул гэж хүснэ. Чи тэгээд хүн шиг амьдрагтүн. Би амлаж байна. Чамайг хүүтэй болов гэсэн чинь сэтгэл уярч догдоллоо гэж Жамуха тайвшран инээмсэглэж суув.

Хантөмөр хэдий олон үг хэлж бүх нууцаа дэлгэсэн мэт байвч Жамухад хэлж болохгүй юм бас үлджээ.Хантөмөрийн энэ бүсгүй бол Жамухын Сэнгүмд бэлэглэж орхисон Гүрвэлжингоо билээ. Сэнгүмд очиж хэдэн жил болсны хойно хувцсаа сольж харцын даруу бүсгүйн дүрд хувилсан Гүрвэлжингоо нэг л үдэш гэв гэнэт тэнгэрээс буусан мэт Хантөмөрийн асарт хүрч иржээ. Сэнгүмийн дэргэд байх нь үхлээ дуудсан хэрэг гэдгийг ойлгосон Гүрвэлжингоо бүх үнэнээ хэлж үнэнч байхаа амлан дэргэдээ нуун авахыг хүсч сөхрөхөд Хантөмөр угаас түүнд талтай учир үг дуугүй зөвшөөрч бүсгүйг өөрийн итгэлтэй айлд аваачиж суулгасан билээ. Тэмүжиний цэрэгт хөөгдөх хүртэл Хантөмөр шөнө бүр тийш давхиж Гүрвэлжингоотой янаглан дассан юм.

Харин одоогоос жилийн өмнө сүүлчийн удаа уулзахдаа бие шалтагтай болсноо хэлсэн билээ.. Энэ үгийг сонссоноос хойш Хантөмөрийн сэтгэл санаанд огцом өөрчлөлт гарч Гүрвэлжингоог үргэлж дурсан хүсэмжлэх болж бүр зарим шөнө хүүхдээ тэврэн тоглож эрхлүүлж байна гэж зүүдлэж, цочин сэрээд хүйтэн нойтон тэнгэрийн дор олонтаа уйлсан билээ. Түүнд одоо үрээ үзэж, үзэсгэлэнт Гүрвэлжингоогоо олохоос өөр хүсэл үгүй юм. Тийм болохоор Жамухыг Тэмүжинд бууж өгөөсэй, эсвэл үхээсэй гэж дотроо шаналан хүссээр байсан билээ.

Гэтэл одоо бүх юм түүний хүссэнээр болж Жамуха Тэмүжиний дэргэд очихоор болсон ч өршөөл энэрэлгүй Тэмүжин, хаан эзэндээ халдсан түүнийг тэр дор нь цавчин алах биз. Жамухын энэ зарлиг “Би үхэхээр чи үх” гэсэнтэй утга нэг юм. Боол харцын амь нас хаан эзний хүсэл, гар хоёрт явдаг цаг хойно яалтай билээ. Огт санамсаргүй үүссэн хүүхдийн тухай яриа Жамухын сэтгэлийг донсолголоо.

Энэ бол түүний хамгийн эмзэг шаналал, үргэлж нууж явдаг гуниг нь юм.

Газар дээр төрсөн ганц хөвүүн нь энгийн гэмгүй ангийн үеэр мориноос унаж осолдсон нь түүний үзсэн хамгийн аймшигт явдал байсан юм. Тэр хөвүүн хүн хүнээс онцгой сэргэлэн гавшгай байсан нь магтаал, цагаан хэл аманд идэгдэхэд хүрч, Жамуха түүнийгээ хамгаалж чадалгүй алдсан билээ.

Түүнээс хойш Тэнгэр түүнийг цээрлүүлж хатад эмсээс нь хүү төрсөнгүй, хүсэхэд хясна гэдэг болжээ. Тэр эмэгтэй хүнийг угаас хүн гэж үл тоох тул Тэнгэр цээрлүүлж хүссэн хүсээгүй л энэ газар дээр Жамухын үр удам тасарч байгааг мэдрэн гунигладаг юм. Гэвч хавьтсан,

хүчирхийлсэн олон эмсийн хэн нэг нь тохиолдлоор хөвүүн төрүүлсэн байхыг тэр бас үгүйсгэж үл чадна. Тэгвэл ч яах вэ.

Түүний цустай, амь биений нь тасархай болсон хөвүүн хэн нэгний бүлд амьдарч хорвоогийн тоос хөдөлгөж яваа биз гэж тайвшрах ч бий. Угаас эр хүнд үр удмаа үлдээх гэж нэг зовлонт үйл байдгийг тэр мэддэггүй биш мэдэж, ухаарахын дээдээр ухаарах тул харамсан гашууддаг нь нэн их ажээ. Гэвч дээд Тэнгэр түүнд ийнхүү хөвүүний эцэг байх хувь заяа хайрласангүй.

Харин өчүүхэн муу тэнэг боол Хантөмөрт ийм дээд соёрхол хүртээснийг сонсоод уур уцаар буцлавч биеэ барив.

Одоо нэр төртэй, омог бардам үхэл л түүний бүх гомдол харууслыг орлоно гэж бодов. Тийм учраас Хантөмөрийн сэтгэл эргэж хувирахаас сэргийлж

-Чи бүү санаа зов. Би чамайг үхүүлэхгүй.Чи удахгүй тэр бүсгүйтэйгээ, бас хөвүүнтэйгээ уулзана гэж давтан хэлэв. Өөр зам байхгүйгээс хойш Хантөмөр эзнийхээ хүслийг биелүүлэх л үлджээ. Жамуха унтахаар хэвтэв. Харин Хантөмөр унтаж чадахгүй нойр нь хулжиж элдэв бусын бодол тархи толгойд нь эргэлдэнэ. Түүний амьдрал чухам юуны учир үрэгдэж өнгөрснийг ойлгох гэж оролджээ.

Одоо унтаж хэвтээ Жамухыг хороож орхиод Гүрвэлжингоог, бас үзээгүй мөрт сэтгэл зүрхэнд бүлээн дулаан илч түгээж хайр хүргэх бяцхан үрээ эрж одохсон гэсэн хязгааргүй их хүсэл оргилно. Энэ бол хялбархан зүйл юм. Гэвч тэр ингэж яаж чадна. Бас Жамуха унтаагүй, нүдний булангаар хяламхийн хэвтээг, баруун гар нь хутгаа атгаастай байгааг ч гадарлаж байв. Одоо ганцхан Жамуха эзнийхээ үгэнд итгэх л үлджээ. Үхдэг байлаа ч ингэж хийхээр шийдэв.

Амиа аврах олон боломж түүнд байсан ч Хантөмөр үйлээ дагаж эмзэг залуу наснаас эргэлтгүй зүтгэсэн эзэндээ үнэнч үлдэхээр шийджээ. Өсөхөөс өвгөрөх хүртлээ зүтгэсэн, хавирга нимгэн наснаас хаан болтол нь хамтарсан эзнээ орхиж амиа бодох нь яавч эрийн шийргүй хэрэг гэж тэр үзжээ. Хэрэв Тэнгэр ивээж амьд үлдэх аваас эзнийхээ хэлснээр амьдаръя гэж санав.

Ингэж эргэлтгүй шийдсэн тул тэсэлгүй өндийн Жамухыг харав. Жамуха унтах мэт хэвтсэн ч Хантөмөрийн ингэж ширтэж суутал гэнэт

-Чи юунд намайг ингэж ширтэнэ гэж гэнэтхэн асуужээ…

Хантөмөр үг дуугүй мөлхөж замдаа хоёр өвс таслан атгаад дэргэд нь очив.

-Чи яав гэж Жамуха хартайгаар асуухад гарт нь хутга гялсхийв.

-Гүр хаан та энэ өвсний нэгийг сугал

-Юу юм бэ гэхдээ ч хутгаа тавьсангүй.

-Хэрэв урт өвс сугалвал хүү гарсан байгаа. Та надад нэг үзэж өг.

Жамуха энэ гэнэн тэнэг үгийг сонсоод инээд алдав. Сугалсан өвс нь урт байсан нь Хантөмөрийг тэгэж баярлуулах юм гэж санасангүй.

-Гүр хаан та хараач.Хөвүүн байна.Би бүр тэгнэ гэж итгээд байсан юм аа.

Нэгэнт Гүр хаан та мэргэлсэн юм чинь би хөвүүнтэй болжээ гэж Хантөмөр бүр босон харайж баярлав. Түүний баяр хөөр хязгааргүй ажээ. Хантөмөрийг хэзээ, хаана ингэж баярлаж байсныг Жамуха санасангүй.

-Гүр хаан. Би өнөө шөнө нөхдөө босгож таныг барьж аваачна. Та нэг ч үг бүү дуугар. Харин Тэмүжинд очсон хойно миний амийг бүү хороолго. Би гуйя. Би хүүтэй болсон тул үхэж яаж болно гэж Хантөмөр хүүгээ үзсэн мэт баясан шивнэв.

-Чи бүү ай. Тэмүжин миний хэлснээр хийх болно. Чи тэгээд дахиад миний нүдэнд өртөхгүй алга болж үз. Тэр эм чинь амьд байвал олж аваад газрын мухарт очиж амьдар. Чи тэгэхийг хүссэн биш үү. Ингэж хэлэхдээ Жамуха өөрөө ч Хантөмөрийг хөвүүнтэй болсонд итгэх шиг болжээ.

-Тиймээ. Би үхэхгүй аваас яг таны хэлснээр хийх болно. Би танд дахин гай болохгүй газрын гаваар орсон мэт, галд шатаж, салхинд хийссэн мэт үгүй болно. Хожим хойно хаан таны их бие эвдэрч, эрэг мэт нурж унаваас би хөвүүд үр садаа дагуулан ирж мөргүүлээд таны хэн байсныг, Хантөмөр гэгч ядуу эр ямар гээч их хүний шадар явсныг хэлэх болно. Тэр болтол би таны дэргэд ирэхгүй. Та ингэв гэж надад бүү гомдол санал хэлэгтүн. Би үгээ дуусч, үсээ зулгартал нэгэн чигт сэтгэлээр зүтгэв. Би танд осолдсон удаа байвал одоо хэлж зэмлэж зүхэгтүн. Би таны үгийг насандаа мартахгүй санаж, ясандаа салгахгүй хадаж авъя.

Ийм үнэнч сайхан сэтгэлийн халуун дулаан үг сонссон Жамухын сэтгэл догдлон донслов.

Хамгаас үнэнч Хантөмөр минь

Хар нүдээ нээхэд

Хажууд зогсогч хань минь

Халуун нар, хүйтэн салхинаас

Хаацайлж халхлагч нөхөр минь,

Хатан сэлэм, харвах сумнаас

Хамгаалагч бамбай минь.

Харь нутгийн хүйтэн ууланд

Халаан дулаацуулагч гал минь

Халуун амь бүлээн сэтгэлээ

Харамгүй хуваагч анд минь…

Жамуха сэтгэл хөдлөн шүлэглэн урсгаж хэллээ.

Түүний цэцэн цэлмэг уран үгсийг сонсох нь уулын тагтад хөхөө шувуу донгодох мэт яруу билээ.

-Хар Хадаан эцгийн

Хуваж өгсөн нөхөр

Ухаант Хуйлар эцгийн

Ууган хөвүүн минь ээ.

Жадаран аймгийг Бүтэн ахуйд ижилдэв, бид

Жалгын мухарт Хоюул үлдтэл зүтгэв, чи

Зориг хурцлах анд Зовлон нимгэлэх нөхөр

Зоргоор явахад дагуул

Зожгирч ганцаардахад түшиг

Хатууг зөөллөлцөж

Хатгалдахад хамжилцаж

Хамаг бүхнээ хуваалцсан

Хантөмөр чамайг би

Загнаж зэмлэе гэвч

Үг үл олдоно.

Засаж сургая гэвч

Алдаа үл олдоно

Зүйгүй мунхаг би

Зөвийг засаж үл чадав.

Зүтгэсэн чиний хүчийг

Зүгийн салхинд хийсгэв.

Одоо би чамд

Олон үгийг яахин хэлнэ.

Онцгой нөхөр чамд

Оновчтой зөвийг яахин заана

Үнэнч зүтгэсэн сэтгэлийн чинь хариуд

Үгнээс өөр шагнал алга Бүхнээ зориулсан итгэлийн чинь хариуд

Бүснээс өөр бэлэг алга

гэж аялгуулан шүлэглээд Жамуха алтан бүсээ тайлж өгөв.

-Гүр хаан та яахин ингэж болох вэ. Боол би алтан бүс бүслэвэл айлын нохой арслангийн дүрд хувилах мэт тул алдас болж Тэнгэр хилэгнэх биз гэж Хантөмөр шууд эсэргүүцэв.

-Олон үг бүү ярь.Хэн чамайг одоо боол гэнэ. Хөвүүн чинь чамайг давж баатар сайн эр болох биз. Хөвүүндээ намайг өгөв гээд эр болоход нь зүүж өг.Гүр хаан Жамухыг сайнаар дурсаж яваг. Жамухын энэ үг үнэн тул Хантөмөр сая эргэлзэлгүй авч бүслэв.

Харин ч хөвүүн минь өсөхөд бэлэг дэмбэрэлтэй юм болов гэж хөөрөн боджээ.

-Үүнээс хойш чи өөрийгөө боол гэж бүү хэлэгтүн. Чөлөөт сул иргэн болов гэж сана. Би ингэж тушаая…

-Жа.Би таны хэлснээр явъя. Та одоо тайван сайхан унтагтүн. Шөнө дөлөөр би бүгдийг таны хүссэнээр хийж одно.

-За тэгвэл сайн болов. Одоо хоюул нөхрийн ёсоор салъя. Тэд духаа нийлүүлэн удаан зогсов.

Үүний хойно Жамуха газар хэвтээд нам унтжээ.

Сүбээдэй баатар Мэргэд, Найман аймгийн үлдэгдэл цөөн этгээд зугатсаныг дарахаар Эрчис мөрнийг гатлаж хөөн одсон хойно Жамуха таван нөхөртөө баригдан Тэмүжиний хүрээнд ирсэн нь бөөн шуугиан дэгдээв.

Энэ үед мэргэдүүд үймэрч самуун дэгдээсэн тул Тэмүжин эсэргүүцэгчдийг хядаж үлдсэн мэргэдийг зүг зүгт тараан хуваж дахин сэхэхгүйгээр үгүй хийн дуусгаж ирээд төв өргөөндөө сар гаруй амарч байлаа. Хэрлэний Хөдөө арлын Долоон болдогийн дунд сүндэрлэх Тэмүжиний их ордон үзсэн олны бахархал бишрэлийг өөрийн эрхгүй төрүүлнэ. Их ордныг тойроод Тэмүжиний ёслолын болоод албаны их өргөө хатад хөвүүдийн гэр байрлажээ. Тэмүжиний ёслолын их өргөөний хоёр талд хар цагаан их сүлдийг залжээ. Харин их ордны гадуур уужим зайтай бат бэх модон хашаа барьж дөрвөн өнцөгт нь харуулын цамхаг босгосон нь алсаас тод үзэгдэнэ.

Олон сар ууланд бүгэж зэрлэгшсэн Хантөмөрт Их ордны энэ нүсэр ихэмсэг агаад сүрлэг дүр байдал туйлын сонин байжээ. Хантөмөр эзнийхээ хэлсэн ёсоор түүнийг Тэмүжиний ордны хашааны гадна харуулд тушаан өгөөд нам чимээгүй хүлээн зогсов.”Гүр хаан Жамухыг Тэмүжинд хүргэж явна” гэсэн үг тэднийг монголын уудам нутгаар саадгүй нэвтрүүлж энд авчирсан нь Жамухын нэр сүрийг биш, харин Тэмүжин хэрхэн хүчирхэгжиж алдаршсаныг батлах ажээ.

Жамуха эзэн нь хэлсэндээ хүрч зам зуур нэг ч үг амнаас унагасангүй. Бүтэн сарын турш ингэж загас шиг таг дуугүй байж уур цухал, уйтгар гуниг хийгээд хилэн хорслоо дотроо түгжиж чадсанд Хантөмөр үнэхээр гайхаад барсангүй. Тэр урьд нь Жамуха эзнийгээ хамгийн тэвчээргүй хүн гэж тооцдог байжээ. Гэтэл огт тийм биш аж. Жамухыг хашаан дотрох гэрүүдийн зүг авч явсан боловч түүнийг барьж ирсэн цэргүүдийг нь дотогш оруулсангүй тул тэд хашааны сүүдэрт хоцорчээ.Тэдний зэвсгийг хурааж дэргэд нь харуул тавьсан сүрлэг эр бол Тэмүжиний өргөмөл дүү Борохул байв. Борохул өнөөдрийн харуулын албыг ахлаж байжээ. Хантөмөр хэдийгээр Борохулыг таних ч амьтан хүнтэй ярьж хөөрөх ч хүсэлгүй байв. Түүний амь нас, амьдрах үхэх нь одоо Жамухын хэлэх үг, Тэмүжиний зарлиг хоёрын дэнсэн дээр байлаа. Сул иргэн болж Гүрвэлжингоогоо эрж одохсон гэхээс тэр аргаа баран Жамуха эзэн нь сураггүй удахад сэтгэл түгшин тэвчиж ядна. Мөч хором гэгч хичнээн удаан өнгөрдгийг тэр одоо л өөрийн биеэр үзэж гайхаш тасран хүлээсээр…

Хантөмөр эзнийхээ эцсийн зарлигийг биелүүлсэн тул тэр өөрийнхөөрөө эрх чөлөөтэй амьдрахыг тэсч ядан хүсэхдээ шинэ амьдралдаа яаран тэмүүлж байлаа. Үнэнч зүтгэлээр олсон нүүр бардам, аз жаргалтай амьдрал эхлэнэ гэж санахад үнэхээр сайхан байлаа. Тэр хэзээ ч ийм аз жаргалтай байсангүй. Бас амьдралд ингэтлээ шунан дурлаж, үнэ цэнийг нь ухааран ойлгож явсангүй. Бусдын амь амьдрал ч өөрийнхтэй нь л адил үнэтэйсэн биш үү гэж бодохоос түүний сэлэмний ир, сумны үзүүрт хичнээн хүний аз жаргал, хүсэл мөрөөдөл, хувь тавилан гэнэтийн салхинд үлээгдэн унтрах зул мэт бөхсөнийг бодоод дотор нь харанхуйлах шиг болсон билээ…

Албат боолдоо баригдаж ирсэн Жамухыг хамгийн захын гэрт аваачжээ. Борохул Жамухын хүлгийг тайлахыг тушаав. Гэтэл Жамуха үүнийг зөвшөөрсөнгүй.

-Хар хэрээ халтар нугасыг барих болов.

Харц боол хаан эзэндээ халдав.

Бор элээ борлог нугасыг барих болов

Боол зарц бодот эзэндээ халдав гэж уур хилэнгээ бадруулан, уушиг зүрхээ бултaлзуулан хашгирч

-Борохул.Чи Тэмүжин андын хайртай дүү биз.Тэмүжин анд хаан эзэндээ халдсан боолыг хэрхэдгийг чи надаар хэлүүлэхгүй. Чи надад халдсан эдгээр боолыг одоохон миний нүдэн дээр алагтүн. Хожим хойчид сургамж болог. Түүний дараа чи намайг Тэмүжин андад минь тушаагтүн. Тангаргаа няцсан боолыг харж байхад минь үхүүлбэл би үхэхэд харамсах зүйлгүй гэж туйлгүй хорсож жигшсэн байдлаар шаардаж тулгаад хүлгээ тайлуулсангүй. Жамухын энэ

үг Борохулыг бишрүүлжээ.

-Хаан эзэндээ халдсан хүний ураг төрлийг нь хүртэл устгаж бай гэж Чингис хаан сургадаг юм. Би одоохон таны хүслийг биелүүлнэ гэж Борохул хэлээд гарав.

Чингис хаанд хүргэгдэн очмогцоо яг ингэж хэлэхээр Жамуха олон хоног бодсоны эцэст шийдсэн билээ. Бүх зүйл санаснаар болсонд тэрээр түр зуур тайвшрав. Жамуха өөрийн цэрэгт баригдан ирсэн мэдээ Тэмүжиний их хүрээгээр салхи мэт тархаж жижиг том бүх хүнийг гэрээс гаргажээ.

Жамуха бол Тэмүжиний хамгийн өст дайсан гэдгийг энд мэдэхгүй хүн үгүй билээ. Өст дайснаа хэрхэн цаазлах бол гэж олон хүн баясан хүлээж байв. Харин Жамухыг барьж авчирсан хэдэн цэргийн хувь заяа хэнд ч сонин биш тул Жамуха тэднийг хамгийн түрүүнд цаазлахыг хилэгнэн шаардсаныг сонсоод олон бүгдээр сайшаан бахархжээ.

Жамухын цэргүүдийг цаазлах хэргийг залуу хөвүүдэд дасгал сургууль болог гэсэн үү, эсвэл эзнээсээ урвагсдыг жигшин үзэж зориг зүрхээ хурцлаг гэж бодсон уу, ямартай ч Зүчи, Цагадай хоёрт даалгасан билээ. Хаан эцгийн зарлигийг гүйцэтгэхээр тэд нөхдийн хамт тэр даруй гүйлдэн гарчээ. Эзэндээ халдсан боолыг Зүчи, Цагадай нараар цаазлуулсан нь анхных болохоор тэд туйлын их хөөрчээ. Тэдний сугалсан сэлэм, сугалдрагалсан ханцуйг хармагц Тэмүжин юу гэж шийдсэнийг Хантөмөр төвөггүй ойлгож царай нь хувхай цайлаа. Хэрэг явдал Хантөмөрийн санаснаас даан ч дэндүү хурдан болсонд тэр юу ч хэлж, асууж амжсангүй. Зүчийн хурц сэлэм агаарт гялсхийнгээ дуут сум мэт шунгинан дуугарахыг л сонсож амжжээ. Олон морьдын хөлс шингэсэн туурайн тамгатай газрыг мөргөн унахдаа “Хүү болов уу, охин болов уу” гэж үхлээс өрсөн гялсхийн бодож амжсан нь Хантөмөрийн эцсийн бодол нь байв.

Бас Зүчийн дагуул өнөөх загасан нүдэт Татуг гайхах мэт ширтсээр харц нь алгуур унтрахад Тату

-Энэ Хантөмөр надад нэг юм захих гэж хүсчээ.Гэтэл Зүчи эзэн та хүүе гэхийн завгүй алчихлаа даа гэж харамсан шивэгнэв.

-Одоо асуу.Юунд оройтох вэ гэж бах тав нь ханасан Зүчи инээгээд сэлэмнийхээ цусыг ногоонд арчина.

Үнэхээр Хантөмөрт Татугаас асуух юм байсан билээ. Суллагдмагц хамгийн түрүүн Татутай уулзаж Гүрвэлжингоогийнхоо сургийг гаргана гэж санасан байв. Гэвч бүх хэрэг өнгөрч Хантөмөр гэгч энэ зовлонт эр газар дээр үлдсэн ганц үрээ хүү, охин аль нь болохыг ч мэдэж чадсангүй хорвоог орхив.

Хөөрхий түүний биенээс тэр даруй сүнс нь зайлан хаа нэгтэй байгаа Гүрвэлжингоогоо хайн одов.

Жамухын таван цэргийг цавчин алж хүүрийг нь хол эргэнд булж орхиод Зүчи, Цагадай хоёр нөхдийн хамт буцаж эцэгтээ энэ тухай илтгэв. Харин Жамуха өөрийн санаснаар Тэмүжиний

дэргэд нэр бүтэн, бас түүний заналт дайсан хэвээр хүчинд автсан мэт очно гэсэн зорилгоо үнэнч боол Хантөмөрийнхөө амиар үрэн байж биелүүлж чаджээ.

Үнэн үгээр магтаж байсан үнэнч боол нь нэгэнт үгүй болохыг тэр түүний эцсийн удаа хашгирах дуугаар нь мэдсэн билээ. Харин хөөрхий түүнийг амь тавихдаа эцсийн удаа чухам юу гэж хашгирсаныг Жамуха ойлгосонгүй. Гэвч түүний энэ дуу дэндүү гашуун эмэгнэлтэй, хорсол занал дүүрэн байсныг Жамухаас гадна Тату ойлгожээ.

“Хантөмөр чи тэвчин хүлээ. Бүх юм удахгүй төгсөнө. Чи Тэнгэрт гараад намайг хүлээж бай” гэж Жамуха шивнэв. Хантөмөрийн үйлт үхлийг Жамуха эртнээс төлөвлөсөн тул сэтгэл онц ихээр харууссангүй. Гэвч гэмшив гээд яах билээ. Нэгэнт шийдсэн зам тул эцсээ хүртэл явахаас өөр аргагүй. Одоо Жамухад олон хоног, бүр сүүлийн жил гаран оргодол дээрэмчин шиг амьдрахчаа аядаж явахдаа өдөр өнжилгүй, шөнө алгасалгүй тувт эргэцүүлэн бодсоор байж шийдсэн эцсийн хүслээ биелүүлэх л үлдэв.

Түүнийг тансаг тохитой гэрт оруулж тараг айраг сөгнөн идээлж будаалж асарсан атал гагцхүү Тэмүжин ирсэнгүй. Ингэж хүн ирж, нохой хуцлаа ч гэж үзэхгүй байгаа нь Жамухыг байж суух аргагүй болгож байлаа. Гурав хоног хүлээсний эцэст гэнэт Боорчи орж ирэв. Зүүн чихнийхээ омогноос баруун эгмээ хүртэл, “яаж амьд үлдэв” гэмээр гүнзгий урт соривтой Боорчи хэмээх тэрхүү намхан балтгар биетэй, шаантаг шиг дөрвөлжин эр илүү дутуу чимэг үггүйгээр Тэмүжиний үгийг уламжлав.

Боорчи, Тэмүжиний хэлүүлсэн үгийг шүлэг болгон зохиосон билээ.

-Олон жил бид Ойр нөхөр явсан билээ.

Осол цалгай чи Олон санаанд хөтлөгдөж

Орог боохой шиг зуйгаж Олойрт адгуус шиг цанхалж

Танхил балчир насны Тангараг үгнээс няцаж

Хамхуул мэт хийсэн Харах бараагүй одсон бус уу.

Өнөө болоход чи Өнхрөх модон тэрэгний

Өрөөсөн арал болоод Өөдгүй муу боолынхоо

Өөш идэш болж Өөрийн дураар ирээгүй тул

Өнө багын анддаа Өст санаа агуулахгүй биз

Өнгөрснийг мартаж Өшөө хорслоо тайлж

Хамт хоюул нийлж Харилцан найрамдаж

Умартсанаа сануулж Унтсанаа сэрээж явъя

Өргөс мэт явсан боловч Өлзийт сайн Нөхөр минь билээ,

чи Өшилдөн байлдахын цагт ч Өр зүрхээ Өвтгөдөг билээ, чи

Ангид замаар явсан боловч Анд сайн өхөр минь билээ, чи

Улайран байлдахын цагт ч Уушги зүрхээ 68 Өвтгөдөг билээ, чи

Хуурмаг үгийг хэлсэнгүй, би Хуучин нөхөрлөлөө дурдав, би

Хэрэйдийн хан Тоорилтой Хэн нь дийлэхээ үзэлцэж Хэнхдэг цээжээ уралцаж

Хийсэх үсээ зулгаалцах гэж Хар халзан элээтэд Хатгалдах цаг болоход

Тоорил ханы санааг Товтой хэлж тусласан билээ, чи

Овилгогүй Найманыг цохиход Ончит үгээр зөвлөж Ов ухаанаар мухардуулж

Үгээрээ үхтэл сүрдүүлж Амаараа аюутал сандаргаж

Аливаа байдлыг нь мэдээлж Ач тус хүргэсэн билээ, чи

Андын тангаргаа сэргээе Ач тусаа өгөлцье

Мөнх тэнгэрийн хүчин дор Мөр зэрэгцэн явъя

Зангидсан гараа тэнийлцэж Зангирсан хүчээ нэгтгэж

Нэгэн тугийн доор Нэгдэж хоюул явсугай гэж Тэмүжиний хэлүүлснийг сонсоод Жамуха огт баярлаж хөөрөөгүй нь Боорчийг ихэд гайхашруулжээ.

Жамуха бодол болон зогссоор байв. Тэмүжин түүнийг өршөөсөн нь ер гайхах зүйл биш юм. Энэ бол Тэмүжиний хувьд Жамуха ядаж дүйцэх дайсан нь ч биш, ер хэн ч биш болсны гэрч байлаа. Үгүйсэн бол ядаж өөрөө ирж үүнийгээ хэлэх нь яав. Тэмүжин ингэж хуучин андын ёсоор хүргэсэн тусыг дурдан хэлүүлсэн нь ачийг санасан мэт болж зөвхөн өөрийн нэр нүүрийг бодсоноос цаашгүй хэрэг гэж Жамуха ухаараад бухимдав.

Тэр ганцхан Тэмүжинтэй нүүр тулан уулзахыг хүсч байв. Харин түүнийг өдөөн ирүүлэх арга мухардаж байлаа.

-Боорчи чи сайн сонс. Би хуучин анд Тэмүжиний Халуун нүүрийг харж Хатуу үгийг сонсъе. Түүний эцэст намайг үхүүлэгтүн гэж Чингис хаандаа айлтга гэж Жамуха урьд Борохулд хэлснээсээ ухарсангүй.

-Жамуха чи олон үг бүү ярь. Чингис хаан чамайг энэрч өршөөв. Чи хүсвэл одоо дуртай зүгтээ гарч одогтүн. Чингис хаанд зүтгэвэл би чамд тусалъя. Эсвэл чи зүгээр өөрийн тааваар энд сууна уу. Энэ гэр чинийх. Харин Их эзэн Чингис хаанд олон үг хэлж түүнийг бүү бухимдуул.

Ингэх нь чамд осолтой ч байж мэднэ гэж Боорчи түүнд зөвлөжээ.

-Чи миний юу хийх, юу хэлэхийг заах уу.Хирээ мэд. Гар гавтай, хөл хүлэгтэй гэж чи бүү бас. Жадараны Жамуха, Гүр хаан би чамаар хэлэх хийх үйлээ заалгахгүй

Чи тэр Тэмүжинд очиж хэл.Намайг үтэр түргэн үхүүлэгтүн. Би хаан хүн. Ганцхан Чингис хаантай л уулзаж түүний үгийг сонсоно.

-Боорчи чамайг үгүй байхад

Болсон хоолоо хувааж Бозлог зурам агнаж явлаа, бид

Хан Тоорилын тогоог өнгийж Харвах намнах сургууль хийж Ханилж нөхөрлөж явлаа, бид

Хөндлөнгийн хүнд үг дайж Хөндий царайлсан түүнтэй

Улаан нүүрээрээ уулзаж Учир начраа хэлэлцэнэ, би

Ийм атал чи надад Их үгийг хэлэх буюу гэж Жамуха уурсан хашгирав.

Боорчийг заран ирүүлж түүнийг харц зарцын хэмжээнд үзсэнд Жамуха бухимдан эгдүүцжээ. Өөрийнх нь ойр шадруудын дотроос уран цэцэн үг хэлээрээ Жамухатай өрсөлдөж чадах нь Боорчи байсан тул Тэмүжин зөвхөн ийм хэргийн учир түүнийг илгээснийг Жамуха ухаарсангүй дорд үзэв хэмээн дэмий харджээ.

Харин Боорчи Жамухын хэлэхийг сонсоод

-Жамуха чиний хаана юу хийж явсныг би бас мэдэх юм.Чи хэлэх үг байвал хэлсүгэй. Би бүгдийг Чингис хаанд уламжлая .Үүнийг чи миний тус гэж бодогтүн гэв. Одоо түүний хэлэх үгнээс Тэмүжин түүнд яаж хандах нь хамаарах тул сэтгэлийг нь уяраахаар тийм сайхан үгийг олж хэлэх ёстойгоо Жамуха сая л ойлголоо. Жамухын санаанд Тэмүжинд илгээх шүлэг урсан орж ирэв.

Түүний сэтгэл догдлон хөдөлжээ. Тэр хэзээ ч ингэж чин сэтгэлээсээ шүлэг зохиож байгаагүй мэт санагдав.

Өнгөрүүлсэн амьдрал,өнө эртний явдал нүдний нь өмнө жирэлзэн үзэгдэхүйд тэрээр

Энхрий бага насанд Эртний заяагаар учирч

Хорхунаг Жубурын хөндийд Хосгүй нөхөд бололцож

Эрхий хуруугаа эсгэлцэн Эрхэм тангараг тавилцан

Хаан заяат чамтай Халуун анд болсон билээ л.

Үл шингэх идээ идэлцэж Үл мартах үг хэлэлцэж

Нэг хөнжил нөмөрч Нэг санааг санаж явлаа

Хөндлөнгийн хүнд хөөдөгдөж Хөнөөх үгэнд автагдаж

Хажуугийн хүнд хатгагдаж Хардах үгэнд автагдаж

Хаан анд чамаас Хагацан салснаас хойш

Халуун нүүрнийхээ арьсыг Халцалж хуулсны адил

Хаан анд чиний Хатуу царайг харахаас Халшран зовж явав.

Умарташгүй хэлэлцсэн Урьдын үгийг санаж

Улаан нүүрнийхээ арьсыг Уруулж өвчүүлсэний адил

Уужим сэтгэлт андынхаа Ухаант царайг харахаас Ухран зовж явав.

Хаан анд намайг Хайрлан соёрхож Хамтран нөхөрлөе гэжээ.

Нөхөрлөх цагт Нөхөрлөсөнгүй би Нөхцөхийн өмнө Нөхөрлөөд яахав

Үерхэхийн цагт Дайжсан би Үхэхийн цагт Дайгдаад яахав

Тэнгэр заяат Тэмүжин чи Эзэн заяат Их хаан та

Түмэн улсыг Төвшин болгож Харь улсыг Хамтатган захирч

Хамгийг эзэлсэн Хаан болоод Дэлхий дахин Өлмийд тань байхад Дэмий надаар Юугаа хийх вэ

Харанхуй шөнийн Зүүд болж Гэгээн өдрийн Гэмтэн болж

Хаан андыг Зовооно би

Энгэрийн чинь бөөс Эгэмний чинь өргөс

Өлмийд чинь бартаа Мэлмийд чинь шороо Болох биз би.

Атаат эмийн үгээр Андаас салаад Алжаан зовж Аргаа барав

би Энэ насыг элтэл Эцсийн амьсгаа тасартал

Эрхэм тангаргаа санаж Энхэр танхил насны Эндүүгүй үгээ бодож

Хар нүдээ аньж Халуун амьсгаа хураавал Харин миний жаргал биз.

Урьдын анд Тэмүжин чи Ургах нарнаас аваад Шингэх наран хүртэлх

Уужим дэлгэр нутагтай Улс даяарт алдаршиж

Толгойтныг бөхийлгөж Тойгтныг сөгдүүлэв.

Сэргэлэн баатар чамд Сэцэн эх заяажээ.

Эрэлхэг баатар андад Эрдэмт дүү нар төржээ.

Далан гурван хүлэгтэй Дайчин өрлөг нөхөдтэй

Дархан баатар алдартай Далай Чингис хаанд Дарагдаж мөхөв, би .

Өөжий бага насандаа Өнчин бие хоцроод

Итгэх сайн нөхөргүй Идтэй сайн дүүгүй

Илүү дутуу үгтэй Их домогч эхнэртэй

Ийм л тавилантай явснаас Тэнгэр эцгээс заяатай Тэмүжин чамд дийлэгдэв би.

Хаан та соёрхож Халуун амийг минь тасалбал Ариун зүрх чинь амарч Амгалан жаргах болно .

Анд чи соёрхож Асгарах цусыг минь гаргалгүй

Ариун ёсыг сахин Алж өршөө намайг Үхэж үрэгдэх бие минь

Үйрч бутрах яс минь Үржилт газар шингэж Үүрд орших болтугай

Үтэр тасрах амь минь Үхтэл шимшрэх зүрх минь Итгэлт андын ургийг Ивээж тэтгэх болтугай…

Илүү дутууг бодолгүй Ийм ерөөлийг тавъя Өнчин заяат би чинь

Өндөр төрөлт андын Өмөг сүлдэнд дарагдав.

Өөрийн хүслээр үхье

Хэлсэн үгийг минь бүү марттугай

Хэзээ ямагт дурдаж явтугай … гэж уянгалуулан хайлав.

Жамуха цэцний билэг танхай шүлгийг дутуу цээжилж үг, санаа орхигдуулах вий гэж бүр анхнаасаа бодсон Боорчи хэдийнээ арга сэдэж Шихихутагийг дуудан авчраад байсан тул Жамухын энэ урт шүлгийг нэгд нэгэнгүй бичүүлээд Чингис хаанд уншуулж сонсгов. Чингис хаан Жамухын үгийг сонсоод удаан бодол болон суужээ.

Жамухын энэхүү чин сэтгэлийн үгсийг сонссон хэний ч болов зүрх догдолж самсаа шархирах

ажээ.

Тэмүжин тээнэгэлзэн эргэлзэж эхлэв. Тэрээр Жамухатай уулзахгүй гэж нэгэнт шийдсэн байлаа. Жамухын үгийг дагаж нүүр тулан уулзах нь өөрийн дайсныг хэтэрхий хүндэтгэн үзсэн болох юм. Харин Жамухыг буулган авч өөртөө зүтгүүлбэл олны нүдэнд ялалтын дээд ялалт, бахдалын дээд бахдал болох билээ. Өөрийн цэргүүдэд баригдан ирэх шиг гутамшигт ялагдал хаана ч байхгүй гэж Тэмүжин сэтгэх тул одоо нэгэнт хорхойд хоргүй болсон Жамухыг өршөөхөөр шийдсэн байжээ.

Гэтэл дандаа оньсого мэт ааш гаргадаг Жамуха дахиад л гайхшруулав. Магадгүй тэр өөрийн харъяат, тэх тусмаа хамгийн итгэлт шадартаа баригдан агт морины ачаа, ажсан хүний тохуу болон хөл гар хүлээтэй хүний эрхэнд ирсэндээ ичээд ингэж амьд явснаас үхсэн дээр гэж шийдсэн байж болох юм. Гэтэл бодоод байхад Хантөмөр эзнээ барьж өгөх хүн биш гэж санагдаад болсонгүй.

“Энэ Жамуха юу сэдэв” гэж Тэмүжин бодоод бодоод учрыг олоогүй тул сурсан зангаараа Тэв Тэнгэрийг дуудуулав. Тэв Тэнгэр өөрийн хүрээнээс иртэл хоногийн зайтай тул түүнд бодох цаг хангалттай байлаа. Ер нь Жамухын үг, үйлдлийг шулуун хялбараар ойлгоход хэзээд төвөгтэй байдаг билээ. Тиймээс ч Жамухын энэ аашнаас Тэмүжин үргэлж зэвүүцэн болгоомжилдог юм. Тэмүжин хариу үг хэлэлгүй таг чиг болсонд Жамуха харин ч баяртай болжээ.

Тэмүжинийг өөрийнхөө байгаа энэ гэрт ирүүлэхийн тулд тэрээр сайн сайхан үг хайрлалгүй зарсан билээ. Үүнээс өмнө түүнийг хэн ч ингэж үг хайрлалгүй магтаагүй биз гэж бодов. Тэмүжин багын магтаалд дуртай хүүхэд байсныг тэр яаж мартах вэ. Гэрийн үүдэнд харуул манаа байхгүйг үзвэл “Дуртай бол хаашаа ч явж болно” гэж Боорчийн хэлсэн үнэн бололтой. Гарч зогсвол ойролцоох гэрүүдийн үүдээр сониуч хүмүүс дүүрэн харагдсанд бушуухан оржээ. Түүнийг ингэж огт хайхрахгүй мэт орхисон нь Тэмүжиний хорон санаа гэдгийг Жамуха тааж байв. Санасандаа хүрэхийн тулд тэвчээртэй байх ёстой. Ингэж чадаж гэмээ нь Тэмүжин тэсэлгүй ирэх болно.

Түүний хэлүүлсэн шүлгийг сонсоод уярахгүй байна гэж үгүй хэмээн Жамуха тооцоолж байлаа.

Жамухын хоригдож буй гэрт Тэмүжин өөрөө ирэх юм уу, эсвэл өргөөндөө аваачих аваас сая Жамухын санаснаар болох билээ. Ингэвэл Жадараны Жамуха гэж хэн болохыг олон бүгдээр харах болно. Тэгээд дараа нь ...гэж Жамуха сэтгэл хөдлөн ганцаар ярьж гэр дотроо холхино.

”Одоохон. Хантөмөр чи хүлээж бай.Чи намайг юу хийж чаддаггийг үзэх болно” гэж тэр Тэнгэрт хандан шивэгнэж байв. Үнэхээр түүний санаснаар болно гэж итгэсээр ажээ. Тэв Тэнгэр бөө ирж Тэмүжиний хэлэхийг дуугүй сонсов. Түүний нэг нүд тооно өөд , харин нөгөө нүд нь Жамухын байгаа гэрийн зүг харж байв.

-Хөхөчү чи үз.Миний санахад Жамуха үхэхийг хүсэх учиргүй юм. Тэр ямар заль зохиож, чухам яах санаатай байгааг би мэдмээр байна гэж Тэмүжинийг хэлэхэд Хөхөчү өврөөс зэс толио гаргаж шившин онгодоо дуудаж эхлэв.

Ингэхэд нь их үс нь нүүрлүү нь бүрхэж тал хэнгэргийн дуу нижигнэнэ.

Хөхөчү босож эргэлдэн үсэрч гэрийн унь дамжин толгойгоо доош харуулан гүйв. Тэгээд газраас алд өндөрт, хий агаарт завилан сууж таг болов. Тэгснээ ширдгэн дээр алгуур доошлон буугаад зэс толио гөлрөн суув.

-Чингис хаан та сонс. Тэнгэр ингэж хэлэв. Чиний анд Жамуха чамд үнэн сэтгэлийн үгээ хэлжээ. Гэвч тэр чамтай уулзахыг хүсч байна. Түүнд бас чамд хэлээгүй үг үлджээ.

-Жамухын үхэх цаг болж үү.

-Болоогүй байна гэж Тэнгэр надад хэллээ гэж Хөхөчү шивэгнэв.

Түүний энэ үгийг Тэмүжинээс өөр хэн ч сонссонгүй.Хөхөчүг явснаас хойш Тэмүжин ганцаар удаан сууж сууж эцэст нь хэнд ч мэдэгдэлгүй шөнөөр сэм очиж Жамухын үгийг сонсох нь зөв гэж шийдэв. Тэднийг уулзахад ганцхан Боорчи л хамт байж, бас Жамуха яаж ч мэдэх ааш зантай тул элдвээс сэргийлэн хатавчинд зогсоод ямар нэг юм болбол довтлон ороход бэлэн байлаа. Цагаан эсгий ширдгэн дээр тарайж хэвтсэн Жамуха харанхуйд орж ирсэн хүнийг огт тоосонгүй. Харин өнөөх хүн бамбараа дээш өргөхөд л сая өндийжээ.

-Би Тэмүжинг өөрөө ирэхээс нааш хэнтэй ч уулзаж ярихгүй гэсэн биш үү гэж Жамуха хашгирав.

-Би чиний юу хэлэхийг сонсъё гэсэн хариу сонсоод Жамуха босон харайжээ. Түүний санаснаар болов. Гэвч Тэмүжин хар санаалан хэнд ч мэдэгдэхгүй гэж дүн шөнөөр ирсэн нь Жамухыг гонсойлгов. Тэртээ хорин жилийн өмнө салж одсоноос хойш дайсагналцаж явсан хоёр нөхөр ийнхүү хувь заяаны уулзварт нүүр тулах нь энэ ажээ. Энэ уулзалтад хоюул сэтгэл санааны хувьд бэлтгэлтэй, бүр хэлж ярихаа төлөвлөсөн байсан боловч хэн хэн нь тулгамдаад ам нээж чадсангүй. Гэвч Тэмүжин түрүүлэн дуугарав.

-Жамуха. Би чамайг өршөөж дахин шадарлан явья гэв. Гэтэл чи зөвшөөрсөнгүй гэнэ. Бас надтай уулзахын учир юу вэ. Би чиний надад хүргэсэн тусыг чинь бодож чамтай уулзахаар ирлээ. Харин одоо чи өөр юу хүсэв. Үхэхийг хүснэ гэв үү. Эсвэл би буруу дуулав уу.

Түүний хоолойн өнгө огт танихгүй хүнийх шиг өөрчлөгдөж хувирчээ. Ер нь урьдын залуу Тэмүжиний танил төрх бүгд үгүй болжээ. Ганцхан нуруу нь өсөөгүй Жамухаас толгой намхан хэвээр хоцорчээ. Тийм хэдий ч тэрээр цаанаа л нэг сүрдэж бишүүрхэм, жавхаа хийморьтой үзэгдэнэ.

-Чи миний гавьяаг гэж бүү дурс. Би чиний өмнө гэм үйлдсэн үү гэхээс өөрийг юу хийв. Гэгээн царайг чинь харж гэмгүй үгийг чинь сонсъе гэсэн юм. Одоо миний сэтгэл ханалаа. Жамухын хэлье гэж хэлсэн энэ үгийг Тэмүжин царайгаа огт хувиргахгүйгээр сонсох нь чихнийхээ хажуугаар өнгөрөөж байх шиг санагдана.

-Би чиний адил Монгол аймгуудыг нэгтгэхийн төлөө байсан юм. Гэвч энэ цагийн эрхэнд анд чамд дарагдлаа. Одоо би амьд явахын хэрэг нэгэнт үгүй болжээ. Чи Найманы Таян ханы

үгийг сонсоо биз. Энэ газар дээр хоёр хаан байж яаж болно гэсэн биш үү. Анд чамтай эвдрэлцэж, амь сөрөн тэмцсэн нь зөвхөн эмс охид, эд малын төлөө биш юм. Анд чи Тэнгэрийн ивээлд багтаж, том жижиг аймгийг сөхрүүлэн авчээ. Одоо чи намайг үхүүл. Би чиний хамгийн өшт дайсан хэвээр үлдмээр байна. Тэгэх ч болно.

Үр удам чинь Жадараны Жамуха бол Есүхэйн Тэмүжиний хамгийн заналт дайсан байв гэж хараан зүхэж байг.

Чи намайг хамгийн аймшигтайгаар олны өмнө тамлан хороож, хүүрийг минь талаар нэг тараан цацагтүн. Би элс шороо, салхи бороонд хувилъя.Хэмжээгүй энэ орчлонд хумхийн тоос болъё. …

Жамухын энэ сонсголонгүй аймшигт үгс Тэмүжинийг цочоов. Тэр ингэж хэлнэ гэж санасангүй.

Урьдчилан таахад бэрхтэй Жамуха дахиад л таахад бэрх оньсого шиг үг хэлэв. Дийлдэн мөхсөн ч Жамуха огт хувирч өөрчлөгдсөнгүй. Ам нээхийн өмнө Тэмүжин үгээ сайтар тунгаан бодов.… Хүн бүр амьд явахын төлөө үхэн хатан тэмцэж байхад нэр алдар төгс Жамуха яагаад үхлийн мууг сонгох гэж хүсэв. Жамуха ямар заль гаргах гэж буйг таахад бэрх юм. Үйлдсэн гэм ялыг тооцвол Жамухыг өчиггүй цаазлах ёстой юм. Гэтэл Жамуха бол түүний багын анд, бас ч гэж тэр андгай тангаргаа мартдаггүй нөхөр байв. Жамуха бол Тэмүжиний хувьд дайсан мэт нөхөр, нөхөр мэт дайсан байв. Тэр энэ үгийг Жамухын баригдан ирснийг сонсоод Боорчид хэлсэн билээ.

Жамуха бол Мэргэд шиг, Найманы Таян шиг, Татаар шиг нэг чигийг барисан заналт дайсан биш юм.

Тэмүжинийг үхүүлж болох, бас сөнөөн дарж болох боломж шалтаг Жамухад олон байсан боловч тэр тэгээгүй. Гэвч үргэлж түүнийг өдөөн дайрч нөхрийг нь дайсан болгон нэг мөч ч тайван суулгаагүй билээ. Жамухын юу хийх, хаанаас хэнтэй нийлж довтлохыг таахад бэрх. Энэ нь Тэмүжинг байнга хурцалж цаг ямагт сонор сэрэмжтэй, ухаан сэргэг, ов зальтай байхад сургасан ч байж мэднэ. Уг нь Жамуха шиг хүчтэй, нэр төртэй, ухаантай нөхөр дэргэд нь байвал олон талын тустай гэж Тэмүжин бодсоны учир түүнийг хуучны андын ёсоор нөхөрлөж явъя гэсэн билээ.

Гэтэл тэр зөвшөөрсөнгүй.

Нэгэнт аймаг иргэдээ алдаж оргуул босуул хулгайч шиг, алдуул гүйгүүл морь шиг болж өнчирч ганцаардсан түүнийг алах нь огт ашиггүй бөгөөд утгагүй зүйл байв. Энэ бүхэн л Тэмүжинийг бодолд унагав.

Жамуха түүний ивээлд өөрөө гуйн багтаж орвол тэр их олз, бүрэн ялалт болох билээ. Гэтэл Жамуха түүнд бууж өгч, дагаар орохгүй гэж нэгэнт шийдсэн нь илт байлаа. Гэвч Тэмүжин Жамухыг буулган авахыг хүссээр ажээ.

-Тэмүжин чи одоо нэгэнт Чингис хаан болжээ. Гэтэл би Гүр хаан. Эх газар, эзэн тэнгэрийн

дор хоёр хаан байж болохгүй…

Жамуха Чингис хааны сэтгэл дотрох эргэлзээг тайлах гэж ийн хэлсэн нь түүнээс эцсийн үгээ хэлэхийг шаардсан хэрэг байв.

-Жамуха чи сонс. Надад туслах сайн нөхөд, түших сайн дүү нар бий нь үнэн. Гэтэл сайн нөхөр олдоно гэдэг ховор чухал. Би багын тавьсан андгайгаа санаж, биеэр үйлдсэн тусыг чинь үнэлж чамайг найрсан явъя гэтэл чи үл зөвшөөрөв. Гэвч би чамайг үхүүлэхэд хүндтэй шалтаг хэрэгтэй. Анх чи адууны хулгайн ялимгүй шалтгаанаар цэрэглэн довтлож намайг сандаргасны чинь төлөө, бас одоо нөхөрлөе гэвч зөвшөөрөөгүй тул би чамайг хүслээр чинь болгож хаан хүний ёсоор цусгүй үхүүлж хамгийн дээр оршуулъя.

Тэмүжин энэ үгсээ тайван, ер хилэгнэж бухимдсан зүйлгүй хэлээд гарах гэв.

Жамуха бас л тайвширч ханах болоогүй байжээ.

-Байз, хүлээ. Миний үг дуусаагүй байна… Жамуха ингэж хашгирсан нь Тэмүжинийг бүү хэл гадаа хатавчинд зогссон Боорчийг цочоож сэлмээ шүүрэхэд хүргэв.

Жамуха түүнд ойртон ирж нүүр тулан зогсов. Тэмүжин хормойн цаана нуусан хутгаа тэмтрэнэ.

-Тэмүжин. Есүхэйн Тэмүжин чи сонс. Чи намайг хэн гэж санав… Чи …чи… хайртай Бөртийгөө мэргэдэд алдаад хожим нь мэргэдийн гөлгийг өвөртөө өсгөснөө сана.

Энийг чи мэргэдийн молхи болхи Тогтоэбэх хийсэн гэж санав уу.

Чи эндүүрч. Би түүнийг хатгаж явуулсан юм. Би Өүлэн ээжийг чинь булаан авсан эртний өсийг мэргэдүүдэд сануулж Бөртийг булаалгасныг чи мэдэхгүй биз..

Зүчи бол миний чамд зориулсан бэлэг юм… Жамуха ингэж хашгираад галзуурсан мэт тачигнатал хөхрөв.

-Би чиний сэтгэлийн дотрох ариун шүтээнийг чинь булаан авсан юм. Чи намайг үзэн ядахгүй байна гэж үү.Чамд өрөвдөж хайрлах сэтгэл алга гэж үү. Чиний зүрх сэтгэл өвдөж шаналахгүй байна уу.Чамд зүрх сэтгэл гэж ер нь байна уу гэж Жамуха хорсон хашгираад үг дуугүй таг гөлрөн зогсох Тэмүжинг харж улам бачимдан их дуугаар орилов.

Тэмүжиний уур омгийг бадрааж, хэрцгий догшин занг нь хөдөлгөх гэж Жамуха чармайн оролдож байв. Энэ бол Жамухын эцсийн ганц хүсэл байлаа.

-Чи ..чи… Бөртийг мэргэдийн Чилэгэр бөхөөс хөл хүндтэй болсонд өш санаж ханцуйгаа салж, хаагаа ханзартал мэргэдийн толгойг цавчсаныг чинь би тод санаж байна. Одоо чи намайг үхлийн муугаар үхүүлж өшөөгөө авагтүн. Чамайг амьдын там, арилж унтрахгүй сэтгэлийн зовлон шаналалд унагасан дайсан чинь би байна.

Намайг далан агтны дэл сүүлнээс зүүж элэг бөөрийг минь газраар нэг тарааж хаяач…Би

үүнийг хүсч байна. Миний аймшигт үхлийг бүгдэд үзүүлээч. Залуус хөвүүдэд сургамж болог гэж Жамуха чулуун хөшөө шиг хүрлийн зогсох Тэмүжинг тойрч хашгична.

Тэмүжиний дотор гашуун оргин хуучин эмзэг шарх нь хөндөгдөөд уур хилэн нь буцалсан ч Жамухын хүссэнээр хийж яавч болохгүйг нэвт мэдэж байсан тул тэвчсээр байв. Жамуха өөрийн алдагдсан нэр төрийг аймшигт үхлээр аврахаар тооцжээ. Тэмүжин өөрөө түүнийг сүр дуулиантай, хатуу хэрцгийгээр цаазлах аваас Жамуха Тэмүжинтэй адил зиндааны хүнд тооцогдон үхсэн ч нэр сүр нь нэмэгдэх билээ.

Жамухын түүнтэй уулзах гэж олон сайхан үг Боорчиор дайсны учир энэ ажээ.

Хүчирхэг дайснаа хорсолтойгоор хороох нь дайсныхаа сүр хүчийг нэмэхээс цаашгүй тул одоо Жамухын мэхэнд унахгүй тэвчих ёстой байлаа.Жамуха үхэхдээ ч түүнийг хуурахаар шийдсэнийг ойлгов. Шадар цэргүүддээ баригдан ирсэн нь ч түүний заль болохыг Тэмүжин таамаглав.

Тэгмэгц оргилон оволзох уур хилэнгээ арайхийн тэвчин барьж

-Жамуха чи сонс. Чи өөрийн үйлдсэн муу үйлийнхээ төлөө нэгэнт хүссэн үхлээ ч сонгох хувьгүй болжээ. Одоо би чиний үхлийг сонгоно гэж заналтай хэлээд гарч явлаа.Энэ гэрт Жамухын дэргэд нэг мөч ч тэвчин байж чадахгүй болжээ. Жамуха түүнийг гарсан хойно сөхрөн унав .

-Тэмүжин би чамайг таньсангүй. Би чамайг хүн гэж итгэж явлаа. Гэтэл чи хүн биш байж … хэмээн Жамуха туйлын гашуудалтайгаар, газар шаан, үсээ үгтээн байж гашуунаар мэгшин уйлав.

Жамуха гэрээс гүйн гарч

-Тэмүжин.Чамайг Тэнгэр гэсгээж чи нэг л өдөр яг над шиг өөрийн үхлийг сонгох ч эрхгүй болно. Тэр цагт чи Жамуха намайг санана.Би чиний хүссэнээр үхэвч сүнс минь чамаас салахгүй гэж мэдээрэй хэмээн шархадсан араатан шиг бархирсаар байлаа

.Гэрээс холдон явж байхдаа Жамухын энэ гашуудалт дууг Тэмүжин Боорчи хоюул сонссон атал хэн ч, юу ч хэлсэнгүй Хэрэв Жамуха хойноос нь гүйн ирвэл түүнийг цавчин алахаар Боорчи сэлмээ бэлэн барьж явжээ. Харин Жамуха амьдаараа зүрхээ сугалуулж буй мэт орилсоор байсан ч гэрийн үүднээс өндийсөнгүй.Түүнд тийм чадал ч үгүй болжээ. Жамухын энэ аймшигт дуунд Тэмүжиний их хүрээнд унтаж байсан бүх хүн цочин сэржээ.Жамухын гүн гашуудалт дуу яг шархадсан хүн гөрөөс орилох шиг сонсогдсоор байв.

Маргааш нь Жамухын үхлийг нүдээр үзэхгүй гэж Тэмүжин хээр тал руу давхин одов.

Түүнийг явсан хойно Боорчийн зааврaар Зүчи Жамухыг чирч ирэв. Ард олны нүдэн дээр аймшигт цаазаар хороолгож нэр төртэй үхэх далд хүсэл нь ийнхүү талаар болж муулах гэж буй мал адил түүнийг чирч ирээд хэдхэн хүн байлцуулан үхүүлэхээр болсонд Жамуха айсандаа бус уурсан хилэгнэсэндээ бараг амиа тавих шахаж байв.

Тэмүжиний зарлиг болгосноор Жамухыг ширэн тулманд хийн бүтээж алах болжээ. Энэ бол язгууртан ихэст ногддог хүндэтгэлтэй үхэл юм. Түүний бие амьсгал давхцан тэлчилж, орилохыг зөвхөн их хааны нөхөд, хөвүүд л харах ёстой байв. Тэмүжиний хор шарыг байдгаар нь малтаж, хамаг эмзэг хөндүүр болгоныг нь үгийн хорт жадаар төнхөн хилэгнүүлээд өөрийгөө аймшигтайгаар цаазлуулах гэсэн Жамухын эцсийн хүсэл ийнхүү талаар болов.

Салхи мэт явсан Жамухын амьдралыг Зүчийн гараар дуусгах гэж Тэмүжин шийджээ. Энэ бол Жамухын гашуун үгний санаатай ухаантай хариу болохыг Жамуха хараад ойлгожээ. Эцгийн зарлигийг Зүчи баяртайгаар гүйцэтгэж Жамухыг тулманд чихэн оруулаад өөрийн гараар амыг нь боожээ. Жамуха Зүчид ямар нэгэн хорон үг хэлмээр байсан ч яагаад ч юм тийм үг түргэн зуур санаанд нь орсонгүй. Анх удаа ингэж хэл ээдэрч,үг гацахыг Жамуха үзжээ. Удалгүй Жамуха үхэж, сүнс нь биенээс хагацсан ч явахгүй эргэлдсээр байлаа.

Жамуха амь тасрахдаа аймшигтайгаар хашгирсан бөгөөд энэ дуунд муу хүний сүнс зайлж морьд шээс алдаж байв. Харин Зүчийн шадруудын нэгэнд олзлогдон очсон Жамухын бага хатан Сүүнгэгээний төрүүлсэн хөвүүн хэзээ ч өөрийн эцгийг мэдэхгүй байх хувь заяатай байжээ. Жамуха ч хүслэн болсон хөвүүнээ төрснийг мэдэж чадсангүй.

Хэрэв тэр үүнийг мэдсэн бол хэзээ ч үхэхийг хүсэхгүй байв. Гэвч энэ бүх гачлант нууцыг Тэнгэр л мэдэх билээ. Жамухыг үхсэний хойно энгэр газарт хүндэтгэлтэйгээр оршуулав. Харин оршуулахыг нь Тэмүжин шадар нөхдийн хамт харж зогслоо. Тэдний хэн нь ч дуугарсангүй. Тэмүжин урьд өмнө хэн нэгнийг үхэхэд ингэж харуусан гашуудаж байснаа санахгүй байв. Дайснаа үхэхэд гүн харамсал төрөхийг тэр анх удаа мэдрэв.

Одоо Жамуха гэгч тэр цэцэн цэлмэг үгтэй, хувирамтгай олон ааштай хүн үгүй болж оронд нь том гэгчийн чулуу л газар дээр хоцров. Тэмүжиний хувьд Жамуха одоо ч үхээгүй хаа нэгтээ амьд яваа мэт санагдана. Ингэж бодогдсоны учир нь Жамухын сүнс түүний толгой дээгүүр нь эргэлдэж байгаагийнх юм. Гэтэл Тэмүжин үүнийг үзэхгүй ажээ. Тэрээр Жамухын тухай гашуудан бодож зогсов.

Жамуха бол дэндүү хүчтэй, дэндүү ухаантай дайсан байлаа. Жамухын дайсагнах, нөхөрлөхийг ялгах гэж Тэмүжин олон жил ухаанаа ухсан билээ. Жамуха харин нөхрийнхөө андгайд үнэнч явсан юм. Түүний энэ эргэлзээтэй, зөөлөн, үнэнч сэтгэлийг Тэмүжин дандаа мэдэрдэг байв. Жамуха бол хортой, аюултай, хүчтэй дайсан байсан ч түүнд хэзээ ч эргэлт буцалтгүйгээр дайсагнаагүй билээ. Андын үнэнч андгайгаа мартаж чадахгүй зөөлөн халирамтгай сэтгэлийнхээ золиос болж Жамуха ялагдав.

Хаан болоход хатуу сэтгэл, хатан сэлэм хоёроос өөр нөхөргүй гэдгийг Тэмүжин энэ олон он жилүүдэд бат ойлгож авсан билээ. Хүнийг, ер хэн ч байсан өрөвдөж хайрлаж, итгэх л юм бол өөрөө нэг өдөр хорлогдон Жамухын адил болохыг тэрээр бодож зогсов. Өөрөөсөө өөр хэнд ч хатуу батаар итгэж болохгүй. Хаан болох хүсэл, хүчирхэг байх мөрөөдөл хүн бүрийн сэтгэлд явдаг тул хэнийг ч басч, багаар үзэж болохгүй.

Хөндлөнгөөс үзвэл Жамухыг өршөөж, эцэст нь түүний хүслээр үхүүлж хүндтэй оршуулсан гэж Тэмүжинийг журамтай хүний ёсоор магтаж, бахдахыг тэр сайн мэдэж байв. Харин нэг насаар түүнтэй хэн нь илүүгээ үзэх гэж өрсөлдөж тэмцэж, Тэмүжинийг бага балчраас

авхуулаад өдий хүртэл ирлэж хурцалж явсан эрэлхэг дайчин Жамуха үгүй болж түүний зай энэ газар дээр болоод Тэмүжиний амьдрал сэтгэлд харлан онгойж хоцров.

Үүнийг хэн ч, юу ч, хэзээ ч нөхөж чадахгүй биз ээ.Одоо энэ гайхалтай оньсого мэт хүмүүний сүнс л Тэнгэрт гомдолтойгоор хоргодон эргэлдэж энэ эзгүй уулын энгэрт Жамухыг орлосон сүрлэг том чулуу чив чимээгүй хоцров.

Гэвч энэ чулуу Тэмүжиний ялалтын билэг тэмдэг биш гэдгийг тэр ойлгож байв.Харин хүнд өөрөөс нь илүү аюултай дайсан байдаггүйг Тэмүжин ойлгон бодож байлаа. Яг энэ үед Жамухын сүнсийг хөөн зайлуулах гэж Тэв тэнгэр хэнгэргээ дэлдэж эхлэхэд бүгд холдон явцгаав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЭВ ТЭНГЭР

Өөрийн байнгын аюулт өрсөлдөгч багын анд Жамухыг цаазалснаар хаяа хаяагаа дэрлэн амьдрагч хамаг Монгол аймгуудыг нэгтгэх зорилгоо Тэмүжин үндсэнд нь биелүүлэв. Энэ бол 1205 оны намар болжээ.

Тэмүжин өнгөрсөн хорин таван жилийн хугацаанд Монголын уул тал нутагт удам дамжин тэмцэлдсээр ирсэн Хэрэйд,Мэргэд,Тайчууд,Татаар,Жүрхэн,Найман зэрэг аймаг овгуудтай зургаан том дайн олон арван жижиг тулалдаан хийжээ. Олон жилийн өмнө анх Боржигон аймгийг эргүүлэн нэгтгэхэд түүнд өргөмжилсөн “Чингис хаан” цол нь бүтнээр, омог бардам дуурсах цаг нэгэнт ирснийг Тэмүжин ойлгож байв. Жамухыг оршуулаад буцах замд ард үлдсэн Тэв Тэнгэр бөөгийн хэнгэргийн нижигнээн, аялгуулан дуулах, бөөлөх нь алс холд цууриатсаар,хишигтэн цэрэг эрс бүгд дуугаа хураан бишрэл хүндэтгэл дүүрэн сонсож яваа нь Тэмүжиний нүдэнд илт үзэгджээ.

Ер нь Тэв Тэнгэрийг хүндлэн бишрэхгүй хүн өнгөрсөн хугацаанд Тэмүжиний улсад ховор болжээ. Шадар нөхдийн дундаас омголон бардам Хасар л Тэв тэнгэрийг үл тоомсорлодог хэвээр байв. Одоо Тэв Тэнгэрийн ийн бөөлж байгаа нь Жамухын сүнсийг хөөн зайлуулахын тулд юм. Цаг нь болоогүй байхад биенээс хагацсан Жамухын сүнс Тэмүжинд ямар гай учруулахыг усан нүдтэй хүмүүн мэдэхийн аргагүй билээ. Үүнийг Тэв Тэнгэр бөөгөөс өөр хэн ч үл мэднэ. Жамухын сүнс Тэмүжинд хоргодох аюултайг Тэв Тэнгэр мэдсэн тул хамаг ид шидээ гаргаж,онгод сахиусаа дуудан хожим учрах гай зовлонгоос хамгаалах гэж бөөлж байлаа.

Жамухын сүнсийг тэмүжиний биенээс зайлуулж дахин эргэхгүйгээр дарсан нь тэв Тэнгэийн Тэмүжинд үзүүлсэн хамгийн их тус болохыг одоо хэн ч гадарлахгүй байлаа. Харин Жамухын сүнсийг дарах гэж Тэв Тэнгэр үнэн санаанаас чармайн бүх хүч чадлаа шавхжээ. Ингэхийг түүнд Тэнгэр даалгажээ. Тэмүжин ,Тэв Тэнгэрийн ид шидийг үзэж мэдсэн тул дотроо эмээж, түүнтэй их л аятай зөөлөн, хүндэтгэлтэй харьцахыг хичээнэ.

Ингэх зайлшгүй учир шалтгаан Тэмүжинд байсан билээ. Есүхэйн харц Мэнлигийн хөвүүн Хөхөчү, Тэмүжинээс хоёр насаар дүү бөгөөд эцгийгээ дагаж Жамухын харъяанд очсоноосоо хойш Тэнгэртэй ярьж, өөрийн ид шидээр цас, бороог хариулж, өвчин хуучийг эдгээн гай зовлонгоос зайлуулж чаддаг хүчээрээ олны дунд шүтэгдэн дархлагдсан нэртэй бөө болж Тэв Тэнгэр цолыг олжээ. Мэнлиг хар багаас Есүхэйн агтны албанд зарагдан тэдний хаяаг сахиж явсан тул хөвүүд нь Тэмүжин, Хасар нартай тоглож өссөн юм. Есүхэйн үхсэнээс хойно Өүлэний албатуудыг салж нүүх гэж байхад очиж болиулах гэж ятгаснаасаа болж Тайчуудын толгойлогч Таргудайд жадлагдсан Мэнлигийн эцэг Чирха өвгөнийг хэвтэрт ахуйд нь Тэмүжин эргэж очив. Өөрсдийн нь төлөө яваад үхлийн шарх олсон хөөрхий өвгөнийг үзээд Тэмүжиний бяцхан зүрх анх удаа хүний тусыг хэзээ ч мартаж болохгүйг гүнзгий ухаарсан билээ.

Есүхэй эзэндээ үнэнч Чирха өвгөн дэмий юм хийжээ.Боржигон аймгийн хавсрага болж явсан Тайчуудад Есүхэйн үхэл дахин олдошгүй сайхан боломж олгосон тул тэд уяанаас алдуурсан ноход мэт зугатаан оджээ.Тэдэнтэй ихэд зууралдан хуучин явдлыг сануулан буцаах

гэж оролдвол хэн ч байсан алуулж болох байв. Энэ цагт Тэмүжин арван нас арай хүрээгүй байжээ.Есүхэй үхэхдээ дэргэдээ ойр байсан өөрийн зарц Мэнлигт өнчин хөвүүдээ, бэлбэсэн эмсээ асарч явахыг гэрээслэн үлдээсэн нь тэр цагийн ёсоор бол Мэнлиг, Өүлэн болоод Есүхэйн нөгөө эхнэр Сочигалын хууль ёсны эр нөхөр болох эрхтэйг баталсан хэрэг байв. Энэ явдал олны дунд Мэнлигийн нэр хүндийг өсгөж,тэдний гэр бүл, үр хүүхдийн хооронд онцгой дотно харьцааг үүсгэжээ.

Мэнлигийн долоон хөвүүдийн дундах нь болох Хөхөчү угаас этгээд сонин ааштай, заримдаа ухаан мэдрэл муутай мэт үзэгддэг тул Хасар Билгүтэй хоёр бүр ч үздэггүй, тоож хамт тоглодоггүй байв. Харин Хөхөчү Тэмүжинд хар багаас онцгой элгэмсүү,өөриймсөг ханддаг байсан бөгөөд Тэмүжин ч Хөхөчүтэй өрөвдөн энэрэх сэтгэлээр харьцаж үргэлж бусдаас өмөөрөн хамгаалж иржээ.

Тэмүжин эхэн үедээ Хөхөчүг зүгээр л ядруу дорой, ухаан санаа нь самуунтай, өрөвдөлтэй хүүхэд гэж үздэг байлаа. Мэнлигийн эцэг Чирха өвгөн Тайчуудын Таргудайд жадлагдаад шархаа даалгүй үхэж бүгд уй гашуу болов. Чирха өвгөний үхэлд Тэмүжин гүн цочирдон яагаад ч юм бэ түүний үхэлд өөрийгөө буруутган ихэд уйлжээ. Нэн ялангуяа Чирха өвгөний ярьдаг үлгэр домгийг дахин сонсохгүй гэхэд дэндүү харамсалтай байв. Үнэхээр Чирха өвгөн шиг үлгэр домог хэлэх хүн Есүхэйн хүрээнд байхгүй билээ. Өвлийн урт шөнө жижиг томгүй Чирха өвгөний гэрт чихэлдээд Боржигон аймгийн түүх шаштир, эрэлхэг өвгөдийн байгуулсан гавьяаг магтсан домгийг үүр цайтал ангайн сонсоцгоодог байжээ. Харц ядуу Чирха өвгөнийг Боржигон аймгийг ихэс дээдэс бүгдээр хүндэтгэн үздэг нь чухам үүнтэй холбоотой байв. Чирха өвгөнийг хамгийн ихээр бахдан бишрэгч нь Тэмүжин, Хөхөчү хоёр билээ. Тийм учраас Тэмүжин ихэд харамсан гашууджээ. Хөндлөнгийн харц өвгөний үхэлд Тэмүжин хөвүүнээ ингэж эмэгнэн,шаналан харамсахад Өүлэн ихэд гайхжээ. Тэр үед Хөхөчү дэргэд нь ирж чимээгүй хэсэг сууснаа

-Тэмүжин. Чи аан гээч гэж дуудав. Тэмүжин сурсан зангаар түүний үгийг анхааран сонсох хэрэгтэй болж нусаа татан нулимсаа арчиж сэхээрэв. Холгүй байх Чирха өвгөний гэрийн үүдэнд гашуудаж гунигласан томчуул бөөгнөрч Мэнлигийн уйлах сонсодсоор ажээ.Чирха өвгөний үхэлд гашуудаж харамсаагүй хүн тэдний хэдэн гэрт байсангүй.

-Тэмүжин чи бүү уйл. Харин чи өвөг эцгийн үхсэнд баярлах хэрэгтэй шүү гэж шивнээд Хөхөчү өөрөө ч баясгалантайгаар цангинуулан инээж байв. Өвөг эцгээ үхсэнд баярлан инээж байдаг хүн Хөхөчүгээс өөр үгүй биз. Тэнэг Хөхөчүгийн үгэнд орж инээж баясан, настангууд болон ойрмог байх хүүхдүүдэд мэдэгдэх бий гэж эмээхдээ Тэмүжин түүнийг хөтлөн гулдачсаар үтэр түргэн холдов. Ээж нь мэдвэл юу болохыг Тэмүжин таамаглаад их айжээ. Энэ бол тун осолтой тоглоом байж мэдэх байв.

Хөхөчүгийн учиргүй хөөрч догдолсон дүрэлгэр нүд,шүлс,хөлс нь гоожсон царайг үзэхэд түүнийг эрүүл ухаантай гэж хэлэх аргагүй ажээ.

-Чи үнэмшихгүй байна уу. Тайчуудын Таргудай уг нь Тэмүжин чамайг алах байв. Харин одоо өвөг эцэг чиний оронд үхсэн тул чи амьд үлдэв гэсэн итгэхэд бэрх солиотой хүний үг Хөхөчү хэлсэн нь Тэмүжинг бүр ч гайхашруулав.

-Хэн тэгэж байна гэж Тэмүжин түүний энэ үгэнд итгэсэндээ биш харин эсэргүүцэн мохоох гэж хэлэв. Хөхөчүг хэлэх үггүй болно гэж санатал түүний дараагийн үг бүр ч гайхалтай байлаа.

-Тэнгэр надад хэллээ. Би Тэнгэртэй ярьсан юм. Чи хэнд ч бүү хэл. Харин чи Тайчуудад дахиад баригдана. Тэд чамайг зүгээр орхихгүй гэнэ. Гэхдээ чамайг тэд алж зүрхлэхгүй. Чамайг Тайчуудад бүү алуулаач гэж би Тэнгэрээс гуйсан. Хөхөчүгийн хоёр нүд эрүүл биш өнгөөр гялалзаж зүрх нь дэлсэж лугших нь Тэмүжинд тод сонсдов. Хүний зүрх ингэж чанга цохилохыг Тэмүжин анх удаа сонсчээ. Хөхөчүгийн зүрх яг л хэнгэрэг дэлдэх шиг тод дуугарч байжээ.

Хөхөчү тохойноос хоёр гараар атгасан нь Тэмүжинг хөдлөхгүй яг зогсоож, толгой нь хачин дүнгэнэн дуугарч гараар нь дамжин Хөхөчүгийн зүрхнээс халуун цус биед нь юүлэгдэх шиг болов. Тэр бүү хэл ээж нь дуудахыг сонссон ч хөдөлж чадсангүй газарт зоогдсон мэт зогссоор байв.

-Ээж чинь дуудав. Ингэж хэлээд Хөхөчү гараа тохойноос нь авахад сая бие нь хаа нэгтэйгээс эргэн ирж хөлөө зөөхтэй болжээ. Бүр тэр шөнөжингөө тохой нь Хөхөчүгийн барьсан хэсгээрээ халуун оргисоор хоножээ. Өглөө нь үзвэл зузаан дээлтэй байсан мөрт буглаган дээр нь Хөхөчүгийн гарын ормоор улаан гөвдрүү үлдэж хорссоор байв. Энэ явдлаас хойш Тэмүжин Хөхөчүг өөрөөр үзэх боллоо. Тэнгэртэй ярив гэсэн Хөхөчүгийн хөөрүү үг Тэмүжинд ингэж хүчтэй нөлөөлнө гэж тэр таасангүй. Үнэн ч бай,худал ч бай Хөхөчү өөртөй нь адил Тэнгэртэй ярихыг хүсдэг болохыг мэдсэн нь чухал байв.

Өөрт нь байхгүй далдын хүч Хөхөчүд байгааг Тэмүжин мэдэрчээ. Гэнэ гэнэ нэг зүг ширтэн гөлөрч орхидог Хөхөчүгийн хачин этгээд зангийн далд учрыг Тэмүжин таамаглаж эхлэв. Гэвч учрыг нь үл ойлгох тул тэр нь юу юм бол гэхээс байж ядах бүлгээ. Гэхдээ өөрийн юу таамагласныг Хасар, Бэгтэр ер нь хэнд ч хэлж болохгүйг бас мэдэж байв.

Хөхөчүгийн далдын хүчийг ганцаар мэдэж байх, түүнийг өөрийн үнэнч нөхөр болгох санаа Тэмүжинд төржээ. Ингэвэл тэр өөрийнхөө эцэг нэгтэй, эх өөртэй дүү Бэгтэрийн дээрэнгүй зангийн эсрэг тэмцэж болно гэж хамгийн түрүүнд тооцжээ. Есүхэйн үхлийн дараа хөвүүдийн хооронд хэрүүл зодоон байнга үүсч тэр бүрийд Тэмүжин илт дийлэгдэх болсон нь түүнийг ийн бодоход хүргэжээ.

Хэрэв Хөхөчү үнэхээр ид шидтэй байвал Тэмүжинд аврал ирнэ гэж итгэжээ. Тэмүжиний зөн совин түүнийг хуурсангүй.

Удалгүй Тэмүжин Хөхөчүгийн олон ид шидийг үзэв. Онон мөрний усан дээгүүр живэх нь бүү хэл хөлөө ч норгохгүйгээр гүйн гарч чаддагийг үзэв. Хадан хясаанд аалз шиг авирахыг үзэв. Бас мах болтлоо улайдсан чулууг гартаа зүв зүгээр атгаж үзүүлэв. Хөхөчү энэ бүх ид шидээ ганцхан Тэмүжинд л нууцаар итгэн үзүүлсэн бөгөөд азарган бороонд хув хуурай явж чадахаа үзүүлсний хойно Тэмүжин бүр нэгмөсөн түүнийг бишрэн шүтэв. Бас Хөхөчүгийн адил хоёр нүдээр хоёр тийш зэрэг харж чаддагийг сурах гэж нүдээ эцтэл оролдоод эцэст нь дотор харанхуйлан муужран унажээ. Яагаад ингэж чаддагаа Хөхөчү тайлбарлаж үл чадна. Ганцхан Тэнгэрээс гуйсан юм нь бүтдэг гэхээс цаашгүй. Хөхөчү бүсээ хүзүүндээ тохоод

Тэнгэрт гар сунган нүдээ аниж удаан суух бүлгээ. Энэ үед тэр хажуудахаа үл сонсоно. Тэмүжин түүнийг дуурian сууж Тэнгэрт мөргөх авч хариу сонсох нь бүү хэл хувцсаа нэвт норсон байхад дэргэд нь суусан Хөхөчүд бороон дусал хүрэхгүй, толгой дээр нь хэн нэгэн үл үзэгдэгч хүн халх барьсан мэт хув хуурай үлдэнэ. Бороон дуслууд Хөхөчүгийн толгойноос алд хирийн зайд ирмэгцээ налуу юм даган урсах шиг хазайн түүний хажуугаар газарт асгарахыг Тэмүжин тод хардаг байв.

-Чи яаж ингэж чадаж байна вэ. Чи зааж өг гэвэл Хөхөчү инээж

-Чи өөрөө Тэнгэрээс гуй хэмээх бүлгээ. Тэмүжин Хөхөчүг дуурайн Тэнгэрээс гуйхаараа нэг болсон билээ. Гээд тусыг эс олсонд Хөхөчүд атаархсандаа үхэх шахна.

-Би гуйсаар цөхөрлөө. Гэвч Тэнгэр юу ч хэлсэнгүй. Чи Тэнгэрт хэл. Тэмүжинг надтай адил болгооч гэж гуй. Тэгвэл би чамд юугаа ч хайрлахгүй өгнө гэж Тэмүжин чин үнэнээр гуйдаг байв. Ид шидтэй болох нь Тэмүжиний ганц хүслэн болов.

Тэмүжинд яг одоо л Хөхөчүгийнх шиг ид шид хэрэгтэй байлаа. Тэгвэл Тэмүжин Бэгтэрт хэзээч дийлдэхгүй болно гэж боджээ. Хөхөчү түүний хүссэнээр Тэнгэрээс олонтоо гуйсан боловч Тэмүжинд өчүүхэн төдий ч ид шид бий болсонгүй. Ядаж Онон мөрний усан дээгүүр гүйж гардаг чадал ч олдсонгүй. Энэ нь хичнээн их харамсалтай, бас атаархалтай явдал билээ. Бусдаас дорд дорой, чадал мөхөс байхын зовлонг Тэмүжин ханаж цадатлаа амсч байлаа. Гэвч Тэнгэр түүнийг таалсангүй ч Тэмүжин цөхрөлтгүйгээр гуйсаар байв. Ид шидтэй болтлоо Тэнгэрээс гуйна гэж Тэмүжин дотроо хатуу шийджээ. Тэр Бэгтэрээс, Хөхөчүгээс чадал мөхөс байгаагаа тэвчиж чадахгүй байв. Үргэлж л Тэнгэрт мөргөх болсон Тэмүжиний эл хачин занг дүү нар нь гайхдаг боллоо.

Дайцэцэний гэрт түр очоод байсан Тэмүжинг буцаж ирсний дараахан үргэлж цуг, айл саахалт амьдран суусан, Өүлэн эхтэй нь дотно сайхан харьцаатай Мэнлиг гэнэт салж, Жамухын зүг нүүсэн нь Тэмүжиний хувьд санамсаргүй хүнд цохилт боллоо. Учир нь Хөхөчү Тэмүжиний сэтгэлд итгэл бишрэлийг төрүүлж,бас гаднын аюулаас хамгаалдаг шиг санагдан, түүний хирээр Тэмүжин зүрх зориг, дүүрэн байснаа мэджээ. Хүний сэтгэлд итгэл, бишрэл төрүүлж чадвал хүчтэй, зоригтой болдог энгийн үнэнийг Тэмүжин өөрийн биеэр анх удаа ингэж мэдсэн билээ. Хөхөчүд ч Тэмүжинээс салж нүүх нь хэцүү байв. Учир нь Тэмүжин бол түүнийг жинхэнэ ёсоор үнэлж,хүндэлсэн анхны анд нь үргэлж тусалж хамгаалагч нөхөр нь билээ.

Салж хагацахын өмнө тэд удаан дуугүй зогсов. Тэр хоёр хэзээ дахиж уулзахыг Тэмүжин мэдэхгүй, бүр дахин уулзахгүй мэт санагдахад үнэхээр аймшигтай байжээ. Харин Хөхөчү түүний энэ бодлыг таасан мэт

-Тэмүжин чи бүү санаагаа зовоо. Чамайг би хамгаална. Харин чи Бэгтэрийг заавал алаарай. Үгүй бол тэр чамайг ална. Та хоёрын хэн амьд үлдсэн нь Есүхэй эцгээ залгамжлах болно. Амьд үлдсэн нь хан болно. Чамайг Бэгтэрийг алж Боржигон аймгийн хан болохоор би буцаж ирнэ гэж халуун нулимсаа халтар нүүрлүүгээ урсган урсган шивнэжээ. Хөхөчү нэг нүдээр Тэмүжинг, нөгөө нүдээр холдон одож буй ачаа хөсгийг ширтэж байгаад ийн хэлэхэд Тэмүжин ч мөн адил гашуун нулимсаа урсгаж зогслоо.

Хөхөчүгийн зүүн нүд түүнийг өрөвдсөн бас зоригжуулсан мэт гялалзан ширтэнэ. Ийм сэтгэлд дотно дулаахан харцыг Тэмүжин урьд нь үзээгүй байв.

Есүхэй эцэг нь үхэхэд Тэмүжин яг ингэж ганцаардаж,айж түгшиж,бас хэнд ч юм бэ хязгааргүй ихээр гомдон уйлсан билээ. -Тэмүжин.Чи Тэнгэрт мөргөж гуй.Битгий цөхөр. Чамайг заавал сонсоно гэж Хөхөчү түүний уйлахыг үзээд сэтгэлийг засч хэлэв. Хөхөчү хоёр буглаг дээрээс нь халуу оргиулан атгаад гүйж одлоо. Тэмүжиний биенээс зөвхөн Хөхөчүгийн атгасан хэсэг газар л өөрт нь мэдрэгдэж, бие нь хов хоосон болжээ.

Гэтэл тэрэгний дэргэд хүрч явсан Хөхөчү гэнэт эргэн гүйж ирэхэд Тэмүжин ер нь харсан бүгд ихэд гайхжээ. Хөхөчү Тэмүжиний дэргэд ирмэгц түүний нүүр лүү эгц ширтээд

-Тэмүжин чи юу ч болсон үхэж л болохгүй шүү.Энэ бол Тэнгэрийн зарлиг гэж шивнээд эргэж гүйв. Учир нь нүүдлийн дэргэдээс Мэнлигийн уурсан хашгирах сонсоджээ. Тэмүжин амьдралдаа анх удаа сонссон “Тэнгэрийн зарлиг” хэмээх үгийг тэр даруй ухааран ойлгосонгүйтэй адил Хөхөчү ч өөрийн хэлсэн үгний цаад наад учрыг олохгүй уджээ. Цөөн тэрэг цуварсан Мэнлигийн хөнгөн нүүдэл зүүн дөрөлж даван далд ортол Тэмүжин зогссон газраас хөдөлсөнгүй. Нүүдлийг даган явсан Бэгтэр, Билгүтэй, Хасар нарыг буцаж иртэл байрандаа хүн чулуу адил зогссоор байхыг үзээд бүгд гайхжээ. Гэсэн ч Хөхөчүгийн хэлсэн үг болоод түүний сэтгэлийн дотрох нууцыг хэн ч таасангүй.Харин ганц Өүлэн эх толгойг нь элгэндээ наан чимээгүй тэвэрсэн нь Тэмүжиний гашуудлыг ойлгосных байв.

Мэнлигийнх нүүж одсоны дараа эргэн тойрон эль хуль,нам гүм болоод тэр ид шидтэй Хөхөчү сэтгэл зүрхэнд нь хичнээн гүнзгий шингэж нэвтэрснийг Тэмүжин мэдэрсэн билээ. Хэдий зуны дэлгэр цаг ирж уран байгал зуун өнгөөр алаглан байснаа гэнэт бүх юмс хормын дотор өнгөө алдан сүүдэртэн харлахыг Тэмүжин анх удаа үзжээ. Харин Хөхөчүд яг ингэж харагдсаныг тэр мэдсэнгүй. Хөхөчүг явснаас хойш түүний адил ид шидтэй болж Тэнгэртэй ярих гэсэн Тэмүжиний хүсэл нь дарагдсангүй харин ч бүр илүү хүчтэй болсон юм. Өөрийн дуу хоолойг Тэнгэрт сонсгох гэсэн Тэмүжиний хичээл зүтгэл тусыг олоогүй ч тэр нэг ч өдөр өнжиж саатсангүй,Хөхөчүгийн захиснаар тэвчээртэйгээр мөргөсөөр байсан тул ингэж Тэнгэрт мөргөх, түүнд сэтгэлийн дотрох хүсэл зорилгоо илчлэн ярих нь нэг л мэдэхэд жирийн өдөр тутмын амьдралын дадал болон хэвшив.

Гэнэт хэнд ч дийлдэшгүй хүч чадалтай,ид шидтэй болж,өөрийн бяцхан амьдралдаа бүгдийг захиран суух мөрөөдөл хүсэл нь Тэмүжинг ингэж уйгагүй мөргөн залбирахад түлхэх бүлгээ.Бас ингэж мөргөхийн хажуугаар Тэнгэрт хандан хэлсэн үг хүслийнхээ хариуг сэтгэл бодлоосоо эрж олоод өөрөө өөртөө хариу хэлж сурчээ. Энэ дадал хэвшил нь Тэмүжиний сэтгэл, оюун ухаанд сайхан дасгал болж аажимдаа өөрийнхөө бодлыг Тэнгэрийн үг мэт ойлгож, хүлээн авч сурч байв.

Бас өөр нэг цоо шинэ чухал зүйл үүнтэй хамт бий болсон нь Хасар болоод дүү нар нь нээрээ Тэмүжин ах Тэнгэртэй ярьдаг байх гэж эргэлзэнгүй ч гэлээ итгэх болсон явдал билээ. Энэ нь Тэмүжиний цорын ганц давуу тал болжээ. Бусдыг зэр зэвсэг, хүч чадлаар биш, өөртөө итгүүлэн бишрүүлэх аргаар дагуулан авч болохыг мэдсэн нь туйлын чухал олз байв. Ингэхийн тулд Тэнгэрийн нэрийг ашиглаж болох зам байгааг ойлгож эхлэсэн нь балчир Тэмүжиний сэтгэлд Хөхөчүгийн ургуулан бий болгосон ид шид юм. Тэмүжин ид шид гэгчийг хаа холын

өндөр Тэнгэрээс эрсээр байсан тул өөрийнхөө сэтгэл санаанд гарсан гүнзгий өөрчлөлт,итгэл зоригийг мэдэрсэнгүй.

Хэдийгээр Хөхөчү яг хэзээ болохыг тодорхой заагаагүй,Тэмүжин ч ингэнэ гэж хатуу итгээгүй ч тэр Бэгтэрийг харван алсан бөгөөд Есүхэйн үхлээс хойш эзэнгүйдсэн гэр бүлийн дотрох эрхийн төлөө эх өөртэй хөвүүдийн тэмцлийн эцсийн шийдвэрлэх цэг болж, анх удаа зориглон хийсэн аллагынхаа хүчээр Тэмүжин гэрийн дотор ахмад нь болж чаджээ. Бас Тайчуудын толгойлогч Таргудай түүнийг аймагтаа олзлон аваачиж дөнгөлөөд бүтэн жил айл айлд байлган зовоосон ч Сорхоншар гэгч боолын ачаар суллагдаж амь мултарсан билээ. Энэ явдлын дараа Тэмүжин,Бурхан халдун ууланд гарч Хөхөчүгийн нэрийг дурдан Тэнгэрт анх удаа тайлга өргөж аварсанд нь талархан үнэн сэтгэлээс мөргөсөн юм. Учир нь Хөхөчүгээр дамжин түүний үг, хүсэл бүхэн Тэнгэрт хүрч байгаа гэж Тэмүжинд санагджээ. Үнэхээр алс хол амьдарч байсан ч Хөхөчү Тэмүжинд учирсан зовлон бүхнийг мэдэрч, тэр бүрийд Тэнгэрт мөргөн аварч, асрахыг гуйдаг байсан бөгөөд түүний хүчээр Тэмүжин амьд үлдэж чадсан гэж итгээгүй ч Тэмүжинд тус болох хүсэл хязгааргүй их байсан билээ. Учир нь Тэнгэр нэгэнтээ Тэмүжин улсын хаан болохыг Хөхөчүд хэлсэн юм.

Тэнгэрийн энэ үгэнд Хөхөчү бат итгэж байв. Жамухын дэргэд эцэг,ах дүү нарын хамт амьдарсаар байсан Хөхөчү арван зургаан насандаа гол усандаа нэртэй бөө болон тодорсон билээ. Өвчилж шаналсан хүмүүсийг өөрийн ид шид, Тэнгэрийн хүчээр эдгээж, бороо цас хариулж, ган зудыг зайлуулж нэрд гарчээ. Бас тэрээр хүний хувь тавиланг урьдчилан зааж хэлэхдээ ч гаргууд сайн болов. Мэнлигийн ядуу амьдрал Хөхөчүгийн ачаар дэвжин дээшилж, хир баргийн хүн халдаж дайрч чадахгүй нэр хүндтэй ,баян чинээлэг болжээ. Хөхөчүд, Тэв Тэнгэр буюу Тэнгэрийн элч хэмээх цол өргөмжилж, энэ нэр нь олны сайн ам дамжин, хаврын урин салхи шиг сэм сэмээр тархан ,алдаршиж эхлэсэн байв. Тэмүжин өөрийн сүйт бүсгүй,Хонгирад аймгийн Дайцэцэний охин Бөртийг авчран өөрийн өрх гэрийг үүсгэснийг сонссон тэр өдрөөс хойш Хөхөчү,Жамухаас салан даруй нүүж Тэмүжинд буцаж очихыг эцгээсээ шаардаж эхлэв.

Тэмүжин, Тэнгэрт ивээгдсэнийг Хөхөчү нэгэнт мэдсэн тул ингэсэн билээ. Хөхөчүгийн төлгөнд бууснаар Бөртийн ирсэн нь Тэмүжиний хүчирхэгжин мандахын үндэс, эхлэл болох ажээ.Тэнгэр яг ингэж хэлсэн тул Хөхөчү нэг өдөр ч болов тэвчин сууж чадахгүй болжээ.Тэмүжинг хүчирхэгжин мандахыг Хөхөчү чин сэтгэлээсээ хүсч байлаа. Гэвч эцэг нь түүний энэ санааг огтхон ч сайшааж дэмжсэнгүйгээр барахгүй

-Өнөөдөр Тэмүжиний дэргэд очих нь өрх бүлээрээ амь алдан сүйрэхэд хүргэнэ.Тэгээд ч Өүлэн биднийг яаж угтах нь бүү мэд.Тэмүжин өөрийгөө ч хамгаалж чадахгүй байгаа.Ийм санаагаа бусдад бүү мэдэгд. Жамуха мэдвэл биднийг амьд үлдээхгүй. Наад бодлоо тархи сэтгэлээсээ авч хая гэж хатуу хэлжээ. Өүлэн болоод Мэнлиг хоёрын хооронд бий болж сүүлд нь салж одоход хүргэсэн нууц харилцааны цаад наад нарийн учрыг балчир байсан Хөхөчү тэр үедээ ойлгоогүй өнгөрсөн тул эцгийгээ шавдуулан хүчлэх эрх байсангүй.

Ойр орчмын хэдэн голын иргэд Хөхөчүг Тэв тэнгэр бөө гэж уйлах, дуулах бүрдээ урьж залах боловч тэр эцгийн хүрээнээс тасран биеэ даах болоогүй байлаа. Бас өөрсдөө гүйж ирчихээд юу юуны туханд хүрэхгүй буцаж нүүх нь Жамухыг хилэгнүүлж болох тул хайран амиа золиослохоос болгоомжилсон эцгийнхээ үгийг дагахгүй байхын аргагүй юм. Тэнгэр хэдий

хүчтэй ч амьдралын зөрчил тэмцэл,цэрэг зэвсэг,мал мөрөнгө, олон хүний санаа сэтгэл нийлэхээр түүнээс илүү хүчтэй байдгийг ойлгоход Хөхөчүд бас цаг хугацаа хэрэгтэй байсан билээ. Учир нь Хөхөчү хэдийгээр Тэнгэртэй ярьдаг ч бүхнийг хүссэнээрээ хийх чадал үгүйгээ цаг ямагт мэдэрч байсан учир амьдралын хатуу үнэний өмнө гомдолтой ч хүлцэнгүйгээр бууж өгөхөд хүрчээ. Хэрвээ өөрийн бодлоор Жамухаас салж нүүвэл Тэмүжиний хүрээнд хүрэхээс өмнө Хөхөчү өөрөө биш юм гэхэд эцэг, ах дүү нар нь Жамухын илгээсэн цэргүүдийн гарт үхэх нь тодорхой. Учир нь өөрөөс урван салж бусдыг дагаж одсон аймгийнхнаа итгэлгүйд үзэн шууд өчиггүйгээр цаазалдаг нь ганц Жамухын ч биш ерөөс талын бүх Монгол аймгийн хатуу ёс юм. Үүнийг дагахгүй байх эрх хэнд ч үгүй.Яг ийм гунигт түүх тэдний Хонхотон овгийнхонд тохиосныг Мэнлиг мартаагүй байлаа.

Мэнлигийн бага ахуйд авга Ажай нь Хэрэйд аймгийн Тоорил ханы дүү Эрх-Харыг илүүд үзэн дагаж очсоноос болж Есүхэй баатар хилэгнэж цэрэг хөдөлгөн Ажай нарын үр удмыг нь үлдээлгүй цөмийг хүйс тэмтэрсэн билээ. Энэ явдалд Есүхэйг буруутган шүүмжилсэн хүн нэгээхэн ч гараагүй бөгөөд харин ч олон овог аймагт сургамжтай хэрэг гэж үзэцгээжээ.Түүгээр ч зогсохгүй энэ хэргээс хойш Хонхотон овгийнхны нэр хүнд Боржигон аймгийн дунд ихэд унаж тэднийг итгэлгүй хүмүүст тооцох болсон юм.

Харин ч Есүхэй өөрийн албат Чирха болон түүний үр садад ивээнгүй хандаж дэргэдээ үлдээсэн ажээ. Үнэндээ Чирха өвгөний цэцэн билэгт ухаан,Хонхотон овгийг гарцаагүй мөхлөөс аварсан юм. Ийм учраас Мэнлиг,Хөхөчү хөвүүнийхээ шаардлагыг дагах аргагүй,бас Хөхөчү ч эцгийнхээ үгийг дагахаас өөр замгүй болжээ.

Нэгэнт Тэмүжинг дагаж очих нь одоохондоо найдваргүй болсон тул Хөхөчү цаг алдалгүй өөрийн чадварыг бэхжүүлж, тэнгэр, нар салхины зан ааш, хувирах зүй тогтлыг ашиглан өвөл зуны цас бороо ямар болохыг урьдчилан тааж мэдэх, өвчтэй хүнийг эдгэрүүлэх гээд бүхий л сургууль дадлаа гүнзгийрүүлсээр байв.

Гэтэл Хөхөчүгийн таагаагүй нэгэн явдал болжээ. Бөртийг авчран өөрийн өчүүхэн өрх гэрийг үүсгэн суусан Тэмүжиний баярт амьдрал жилээс хэтэрсэнгүй. Удуйд Мэргэдийн толгойлогч Тогтоэбэх Тэмүжинг довтолж Бөртийг булаан авсан тухай гашуун мэдээ Мэнлигийн хүрээнд ирэхэд бүгд хуучин танилын ёсоор цочирдсон ч Мэнлигийг тэгэж ихээр эмэгнэн гашуудаж бүр эхэр татан уйлахыг үзээд олон бүгдээр алмайрч хоцров. Өөрийн эцэг Чирха өвгөнийг үхэхэд ч Мэнлиг ингэж гашуудаагүй юм шиг Хөхөчүд санагджээ.

-Хүү минь Хөхөчү. Чи юу чадна. Бүгдийг гарга. Одоо тэр зовлонт эх хөвүүн хоёрт тусал. Би чамаас гуйя.Дээд тэнгэрт хичээнгүйлэн мөргөж үз гэж эцэг нь үг сөггүй шаардах болов. Гэнэт өөрчлөгдсөн эцгийн эл хачин байдалд Хөхөчү эргэлзэн гайхав.Тэмүжинд туслах нь гарцаагүй боловч бас алс хол байгаа тэдэнд яаж туслах учраа эхлээд олсонгүй билээ. Гэхдээ л Тэмүжиний төлөө бүхнийг хийх ёстой гэж Тэнгэр түүнд хэлжээ. Энэ үед Тэнгэр түүнийг зөвхөн Тэмүжинд тусал гэж илгээсэн мэт Хөхөчүд санагдсан билээ. Угаас Бөртийг мэргэдэд булаалган алдсан нь Тэмүжинд учирсан хамгийн аймшигтай хөнөөл болохыг Хөхөчү өөрийн мэргээр үзэж мэджээ.

Тэнгэрийн зарлиг болгосноор Бөртийг алдсан нь Тэмүжиний сэтгэлийг асар ихээр хувирган өөрчлөх бөгөөд хэрэв Бөртийг буцаан авч чадахгүй аваас Тэмүжин хэзээч дахин сэхэхгүй

ажээ. Тэмүжиний чухам ямар хүн болохыг Тэнгэр шалгаж туршихаар ийм зовлонд учруулсан байв. Гэтэл хэргийн цаад нарийн учрыг Тэмүжин мэдэхгүй байгаа нь Хөхөчүг юу юунаас илүү түгшээжээ. Тэмүжин Бөртийг буцаан авч чадахгүй юм уу эсвэл зүгээр орхих аваас тэр хэзээ ч хан болохгүй байж мэдэх ажээ. Өнгөрсөн хэдэн жилд Хөхөчүгийн олж мэдсэн нэгэн чухал нууц бол Тэнгэрийн тухай шинэ бодол юм. Бага байхдаа Тэнгэр гэж дээр цэнхэртэгч хоосон орчлон юм гэж хар таамгаар ойлгодог байсан бөгөөд Тэмүжинд ч тэгэж хэлдэг байжээ. Харин одоо бол бага сага зүйлийг тодруулан ойлгож чаджээ. Түүнтэй харилцан ярьж сэтгэл санаанд нь тодрон буудаг Тэнгэр бол толгойн дээр цэнхэртэгч энэ хоосон хий орчлон биш гэдэг нь нэгэнт тодорхой болжээ. Тэр бол зүгээр л Хөх тэнгэр юм. Харин Мөнх Тэнгэр хэмээн нэрлэж Монголчуудын эрт дээр цагаас шүтэж биширч ирсэн тэр зүйл бол харин энэ Хөх тэнгэрээс ангид байх бөгөөд зөвхөн хүмүүний сэтгэлд оршигч тэр их орчин ахуйг хэлж болохыг Хөхөчү ойлгож мэдсэн хэрэг байлаа. Хүмүүний сэтгэл оюуныг Мөнх Тэнгэр гэж монголчууд үздэгийг мэддэг болжээ.

Өвөг эцэг Чирха дэмий нэг үлгэр домог хуучилж суугаагүй ажээ. Амьдралын үйл,тохиолын нарийн учир холбогдлыг ойлгох бүр өвөг эцгийн ярьсан итгэхэд бэрх сонин хачин үлгэр домгийн нууц утга тайлагдах бүлгээ. Хэн ч хэзээ ч үзээгүй тэр үлгэр домгийн хачин аймшигт төрхтэй мангас,чөтгөр шуламсууд, сайхан сэтгэлтэй ид шидтэй эрэлхэг баатрууд чухам хаанаас гарч ирдгийг Хөхөчү одоо мэдэж байв. Тэнгэр гэгч нь угаас хоосон бүрхүүл гэсэн үг юм. Хөх хоосон бүрхүүл буюу Хөх тэнгэр нь дээр цэнхэртэгч агаар огторгуй мөн бөгөөд харин Мөнх хоосон бүрхүүл буюу Мөнх Тэнгэр нь хүний өөрийнх нь сэтгэл оюун бүлгээ.

Тийм болохоор Тэнгэртэй ярьж буй нь өөрийн дотоод сэтгэлтэй л ярьж буй хэрэг гэдгийг мэдсэн нь Хөхөчүд олон олон зүйлийн нуущыг тайлах түлхүүр болжээ.Хөхөчүгийн ойлгож мэдсэнээр энэ орчлонд хүний нүдэнд үл үзэгдэгч зүйл гурав байх ажээ. Эхний хоёр нь хэтэрхий хурдан,хэтэрхий жижигхэн зүйлс юм. Харин хүний нүдэнд үл үзэгдэх гуравдагч юм нь хүний сэтгэл байв.Эхний хоёрыг нь хүний нүд зүгээр л харж гүйцдэггүй учир тэднийг огт байхгүй мэт санана.

Харин хүний сэтгэл эднээс огт өөр. Хүн эрүүл ухаантай л бол өөрийн сэтгэл санааг байгааг мэдэх бөгөөтөл даанч өөрийн сэтгэл санааг хэзээч олж харж,ойлгож таниж мэддэггүй бас удирдан залж чаддаггүй ажээ. Хөхөчү хэтэрхий хурдан бөгөөд жижигхэн зүйлсийг үздэг бөлгөө. Үүнийгээ сая л мэдсэн юм биш. Харин бусад жирийн хүмүүс л түүний үздэгийг олж харж чаддаггүйг мэдсэн хэрэг билээ. Нүд нээсэн цагаас хойш дэргэд нь эргэлдэж,дээгүүр нь нисэгч тэр олон хүмүүс бол ердөө л үхэгсдийн сүнс,бас элдэв дээдийн хэлбэртэй бусад амьтад нь сахиус,савдаг,буг чөтгөр болохыг Хөхөчү мэдэж авчээ.

Эцэг, ах дүү нар нь эдгээр хачин хүмүүс болоод дүрснүүдийг байна гэж огт тоохгүй өшиглөж унагаан,өвөртөлж унтахыг харж өссөн Хөхөчү анхнаасаа л дасаж,тэднийг хүн бүхэн үздэг гэж боддог байсан тул тоодоггүй байлаа.Эдгээр хий дүрс,сүг сүүдрийг яг л жирийн хүн,амьтны адил үзэж дасчээ. Харин ч бүр зарим эвгүй төрхтэйгээс нь ихэд айдаг байжээ. Гэтэл эцэг эх,ах дүү нар нь энэ дүрснүүдийг үздэггүй болохоор ийм зоригтой байдгийг мэдэж авчээ. Энэ сүнснүүдээс болоод заримдаа элэг хөшмөөр инээдтэй юм болно.Хөхөчүг ганцаар тачигнатал хөхөрч явахыг үзээд ах дүү нар нь гайхдаг билээ.

Үнэндээ шалдан хүүхэн үүрчихсэн тэгээд морь уначихсан яваа хүнийг хараад инээхгүй

тэвчих гэдэг бэрх юм. Бүр өнөө нүцгэн хүүхнүүд ах дүү нарын нь шодойноос атгаад хөтөлж явахыг харвал элэг нь хөшөөд уначихдаг байжээ.

Хөхөчүгийн эл хачин зан түүнийг ухаан солиотой мэт харагдуулдаг байлаа. Энэ нүцгэн бүсгүйчүүл бол Хөхөчүг нялх үед гэртэйгээ шатаж үхсэн, Есүхэйн татвар эмсийн хоргодсон сүнс болохыг тэр эхлээд мэдэхгүй байв. Юуны учир тэднийг ингэж шатааж алсныг тэр үед хэн ч мэдээгүй бөгөөд татаар аймгийнхны хийсэн хэрэг биз гэж үзсэн тул Есүхэй цэргээ авч өс авахаар мордсоныг Хөхөчү бүүр түүр санадаг билээ. Хөхөчүгийн нүдэнд үзэгдэгч энэ сүнс сүүдрийг жирийн хүмүүс олж харж чадахгүй боловч сүнс сүүдрүүд цөм хүмүүсийн сэтгэл буюу тэдний дотрох Мөнх тэнгэрт оршсоор байдгийг Хөхөчү мэддэг болжээ.

Тэд хэн нэг учир мэдэхгүй жирийн хүнийг хорлон үхүүлье гэвэл чадах ажээ. Хүний сэтгэлийг тэд дотроос нь хорлон бусниулж ингэсэн хүн учир битүүлгээр ухаан самууран үхэхийг үзсэн билээ. Өвчин зовлон бүхэн ямар нэг муу сүнсний хорлол байдаг юм. Сүнснүүд тийм ч гэмгүй амьтад биш ажээ. Хөхөчүгийн анзаарч ойлгосон бас нэг чухал юм нь Мөнх тэнгэртэй ярихад юу түүнд тус болдгийг мэдсэн явдал байв. Тэнгэртэй ингэж ярихад нь газрын гүнээс оргилох их хүчин түүнд тус болж байгааг Хөхөчү ойлгов. Монгол нутгийн газар усны гүнээс асар их хүчтэй, илбийн гэмээр халуун урсгал оргилон гардгийг тэр өөрийн биеэр дамжуулан мэддэг болжээ. Ийм газар тэр бүр элбэг биш харин өвөг дээдсийн үеэс их уулс,өндөр даваany оройд босгосон овооны орчим газрын гүнээс оргилогч тэр хүч илүү ихээр мэдрэгддэг байв. Тиймээс их овоог тахиж түүний доороос оргилох их хүчийг эзэмдэж чадвал хүний сэтгэлд нэвтрэн бодсон санасныг нь мэдэж өөрийн хүссэнээр удирдах, цас бороог хариулан буцаах юм уу эсвэл дуудан ирүүлж дуртай газраа оруулж болохыг Хөхөчү үзэж мэджээ.

Газрын гүнээс оргилогч хүчийг өөрийн биед шингээн ашиглах онцгой чадвартай байснаараа Хөхөчү бусдад ид шидтэн мэт үзэгдэн хүндлэгдсэн билээ. Газрын гүнээс оргилох тэр хүчийг шингээн авсан хэд хоногт өвчтэй хүнд хүрэх төдий л шарх эмгэг нь эдгэрч хөл дээрээ босох бүлгээ.Бас газрын хүчийг шингээн авсан хэд хоногт өнөөх олон сүг сүнснүүд түүнээс зугатан холдох бөгөөд зарим нь бүр Хөхөчүгийн бараа сургаар галд хөдөс шатахын адил умран үгүй болох ажээ.

Хуримтлуулсан хүч нь дуусмагц Хөхөчү жирийн хүнтэй адил болж хэд хоног үхсэн мэт унтана. Газрын тэр далдын хүчийг биедээ шингээх, цааш дамжуулан зарах нь биеийн тэнхээг туйлгүй ихээр барагдуулах тул бөөлж дуусмагц мах болтлоо ядрах нь энүүхэнд бас зүрх уушиг нь дэлсэж өвдөх нь элбэг. Гэвч Хөхөчүгийн зовлонг ойлгож мэдэх хүн нэгээхэн ч үгүй билээ. Тэмүжинээс өөр түүнийг чин үнэнээр ойлгон хайрласан хүн учраагүй мэт Хөхөчүд санагдана. Тэр өөрийн зовлон шаналалыг залуу биеийн эрч хүчээр туулан давах ажээ. Харин Тэмүжинд туслах нь Тэнгэрийн зарлиг байсан тул Хөхөчүд ухрах буцах газар байсангүй.

Гэвч хэрхэн туслахыгаа сайтар бодож зөв зүйтэй хийхгүй бол хамаг хэрэг талаар өнгөрч Тэмүжинд бүр тус биш хор хүргэж болох учир Хөхөчү болгоомжилж байв. Гэвч цагийг хүлээн алмайран зүгээр сууж бас болсонгүй. Бас юу хийхийг нь зааж зураад өгөх ухаантан байсангүй.Бүх зүйлийг ганцхан өөрийн ухаан мэдрэмж,Тэнгэрийн хүсэлд захируулжээ. Эцэст нь өөрийн чадлын хирээр газрын хүчийг хуримтлуулж Тэмүжинд илгээх замыг сонгон авч бэлтгэж эхлэв. Энэ бол өвчтэй хүнийг эмчлэх, хэдэн өдрийн өмнөөс тэнгэрийн аашийг тааж мэдэхээс огт өөр хэрэг, урьд өмнө хийж үзээгүй тул Тэмүжинд тус дэм болох эсэхийг

урьдчилан таахын аргагүй явдал юм. Газрын хүчийг хэт хуримтлуулах юм уу зөвөөр зарж гадагшлуулж чадахгүй бол өөрөө хорлогдон үхэх нь энүүхэнд тул ингэж зориглон шийдсэн нь туйлын осолтой хэрэг байв..

Гэвч Хөхөчү үүнийг бодож айсангүй. Ойр орчмын уулаар явж газрын хүч хаана их оргилж байгааг олох гэж эцэж цуцталаа мацсаар хэдэн сар өнгөрч өмссөн дээл гандаж,өвдөг тохой цоорчээ. Эцэст нь тийм газрыг олсон нь уулсын ноён оргил ч биш тэдний зуслангаас холгүй Төмөртэйн амны жижиг булгийн тархиний, өнчин ганц мод байсан нь гайхмаар. Газрын гүний хүч өндөрт гарах тусам ихэсдэг гэж боддог байсан нь эндүүрэл болохыг ингэж мэджээ. Булгийн тархины ганц модыг онголж, дэргэд нь хавь орчны уул болгоноос, ус болгоноос чулуу авчруулан их овоо босгож, туг хиур хийсгэв. Энэ бол газрын их хүч эндээс оргилон байгааг тэмдэглэж байгаа хэрэг юм. Үүнийг ганц Хөхөчү мэднэ. Энэ ганц модны дэргэд ирэхэд үс нь ширхэг ширхэгээр босч,өвдөг тохой нь ирвэгнэн халуу оргисон билээ. Хаана газрын хүч ихээр оргилон гарна тэр орчмын ус булагний ундарга арвин, өвс ургамал өндөр сахлаг, араатан жигүүртэн элбэг олон,хүн зон нь цовоо гавшгай байдаг ажээ. Овоо босгодог нь газрын их хүчний урсан гарах өрхийг хааж, газарт шингээн хадгалах, бас учир мэдэхгүй хүн цохигдон хорлогдох зэргээс сэргийлдэг өвөг дээдсээс уламжлагдан ирсэн арга болохыг Хөхөчү сая л өөрийн биеэр үзэж мэджээ.

Хэтэрч хэмжээ нь ихдэхгүй л бол газрын хүчний урсгалд богино хугацаанд орох нь хүний бие болоод сэтгэлд хоргодон шингэсэн муу ёрын сүнс сүүдрийг зайлуулж ариусгадаг учиртай тул Монголчууд овоог гурваас илүү тойрдоггүй ёс бүр Хүннү гүрнээс өмнөх үеэс тогтсоор ирсний учрыг Хөхөчү сая л ухаарав. Харин газрын тэр хүчийг биедээ шингээн захирагч хүн нь бөө болдог учрыг бас ойлгож авчээ.

Бага наснаас ганцхан өөрт нь байсан хачин этгээд чадвар, ааш зан,нүдэнд нь үзэгдэгч хий юмс бүхэн Хөхөчү чухам газрын хүчийг биедээ шингээж чаддагийн үр байсан билээ. Өглөөний шүүдэр буусан өвсөн дундуур хөл нүцгэн туучих, газарт нүцгэн өнхрөх бүр инээд нь хүрч бие нь сэргэн, хүч тэнхээ урам зориг нэмэгддэгийн учир бас л энэ газрын гүний далд хүчтэй байлаа.Газарт унан өнхөрч тас тас хөхрөх Хөхөчүг харсан хэн боловч түүнийг ухаан самуунтайд эргэлзэхгүй итгэдэг байлаа.Гэвч ингэх бүрдээ Хөхөчүгийн харц очтон гэрэлтэхийг хэн ч анзаардаггүй байжээ. Одоо тэр өөрийн хүч чадал нь хаанаас эхтэйг мэддэг болсон боловч харин ухамсар зорилготойгоор яаж ашиглахаа сайн ухаарч ойлгоогүй, туршиж үзээгүй байв. Тэмүжинд туслах гэсэн нь ерөөс анхных юм. Тийм болохоор бүх зүйлийг маш болгоомжтой хийх ёстой болжээ. Хөхөчүгийн хийж байгаа бүхэн гаднаас харахад хүүхэд тоглож байгаа юм шиг санагдахаар байлаа. Хөхөчү Төмөртэйн амны булгийн эхний ганц модыг тахих гэж байгаа сураг дороо л ойр хавьд тархан сонирхсон, бас түүний ид шидийг үзэж,шүтэн биширсэн хүмүүсийн хөл ихсжээ. Ид шидэнд итгэдэггүй,өөрөө ид шидтэй болж үхэлгүй мөнх,үгүйрэлгүй баян амьдрахыг хүсдэггүй хүмүүн гэж нэг ч үгүй бизээ.

Гэвч хүмүүн бүрт ийм хувь тавилан заяахгүй болохоор өөрөөсөө илүү хүчтэн,бага боловч ид шидтэнд итгэн биширч,ивээл авралд нь багтахыг хүсдэг нь мах цусанд төрсөн жирийн хүмүүний ёс юм.

Газрын хүчийг хуримтлуулан чухам юунд шингээж Тэмүжинд илгээхээ Хөхөчү олон өдөр бодов. Олон хоног янз янзаар бодож үзсэний эцэст жижиг хүрэл зэвэнд шингээж Тэмүжинд

сахиус болгон өгөхөөр шийджээ. Мэнлигийн хүссэнээр Хөхөчүгийн хийх гэж буй энэ хэрэг хожим хойшид Тэмүжинд яаж тус болохыг одоо хир таахын аргагүй юм. Ганц итгэл төрүүлж буй явдал нь Тэмүжин Тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдсэн хүн байсан нь юм.

Үүнийг Хөхөчү хар багаас үзэж мэдсэн ч хожуу ухаарсан билээ. Олон хөвүүд дундаас тэр хоёрын дотносон ойлголцож нөхөрлөсөн нь чухам Тэмүжин,Хөхөчү хоюул Тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдсэнийх байсныг тэр одоо мэддэг болжээ. Тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдэнэ гэдэг нь тэнгэрийн аянга, газрын хүчинд орвол оюун ухаан, бяр хүч нь сэлбэгдэн тэтгэгддэг жамтай, тийм хүчинд хорлогдож, үхэх аюулаас хамгаалагдсан байдаг ажээ. Харин тэр хоёрын ялгаа нь өөрсдийн энэ учрыг Хөхөчү мэддэг, Тэмүжин огт мэддэггүйд л байлаа. Махан бие, усан нүдтэй хүмүүнд үл харагдах шар гэрлийн хүрээ өөрийг нь тойрч байдгийг Хөхөчү мэднэ. Харин Тэмүжинг хамгаалагч тэр шар гэрлийн хүрээ Хөхөчүгийнхийг бодвол хүч сул зөвхөн үл мэдэг үзэгдэх төдий байдаг юм. Үүнийг Тэмүжин харж чаддаггүй бөгөөд хэргийн учир нь тэр Тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдэх одонд төрсөн болохоос Хөхөчүгийн адил Тэнгэр газрын хүчийг ашиглах чадвартай болж төрсөнгүйнх билээ. Тэмүжинг тойрон байх, хүний нүдэнд үл үзэгдэх тэр шар гэрлийн бүрхүүл бол Хөхөчүгийн мэдэх Мөнх Тэнгэрийн хүчний буюу Тэмүжиний сэтгэл оюуны дотоод их хүчний ялгаруулсан тэмдэг юм.

Олон жилийн тэртээ салж одох үед эргэн харж явахдаа гэрийн гадаа гунигт автан нулимс урсган зогсох Тэмүжиний дээгүүр бүдэг шар гэрэл солонго мэт татсан байхыг анх харсан билээ. Тэр үед энэ чухам юу болохыг ухаарсангүй. Харин хожим,Жамухын дэргэд ирснээс гурван жилийн дараа зуны хүчтэй аадар бороноор аймшигтай хурц гэрэл цахилан тэнгэр нурах шиг болоод галын урсгал Хөхөчүг бүрхэн буужээ.

Тэгэхэд Мэнлигийн хөвүүд бүгдээр унагаа уяж байсан юм. Хөхөчүг тэнгэрийн галд автан харагдахгүй болоход айсан,цочсондоо болоод тэд дуугарч амжсангүй. Гэтэл өнөөх оволзсон их гал хормын дотор урсан үгүй болоод харин Хөхөчү юу ч болоогүй мэт инээн зогсохыг үзээд бүр ч гайхжээ. Хөхөчүгээс арван алхамын зайтай байсан хэдэн унага даага аянганд ниргүүлэн үхжээ. Харин Хөхөчүг бүрхэн буусан тэнгэрийн галд газар шатаж үнс болоод ганцхан түүний хөлийн дорхи тохмын чинээ газар л ногоон хэвээр хоцорчээ. Ингэж Хөхөчү аянганаас хамгаалах шар гэрлийн бүрхүүлтэйгээ анх мэдсэн билээ.

Аянга буухын өмнөх тэнгэрийн тас хийх дуутай зэрэгцэн нүд гялбам гэрлийн урсгал Хөхөчүг бүрхэхийг Мэнлиг хараад хөвүүнээ нэгэнт үхэв хэмээн хашгирчээ. Гэтэл Хөхөчү зүв зүгээр үлдсэнээр барахгүй сайн дөрвөн хуруу өндөр болж,дээлийн ханцуй нь татайгаад,бас үс нь төө урт ургасан нь үнэхээр гайхалтай хэрэг байв.

Утаа уугих газарт инээсээр зогсох Хөхөчүд ойртон

–Хөхөчү.Хүү минь чи зүгээр үү гэж Мэнлиг дуудав.

-Та юунд намайг Хөхөчү гэнэ вэ. Би Тэнгэрийн элч байна гэж үснээс нь утаа савсах Хөхөчүгийн гайхалтай цээл хоолойгоор хашгирахад Мэнлиг газарт нам унаж хөвүүнийхээ хормойноос адис аван мөргөжээ. Тэнгэрийн галд шатсан газрын халуун үнс,нурман дээр унаснаас Мэнлигийн өвдөг тохой түлэгдэн цэврүүтсэнийг Хөхөчү ганц долоогоод оргүй эдгээсэн билээ.

Түүнээс хойш Мэнлиг төрөл арилжсан Хөхөчү хүүгээ шүтэх болж, гадуур дотуур уулзаж учирсан хүн бүрт дээрх тохиолыг ярисаар Хөхөчүгийн алдаршин бөө болох үүд нээгджээ. Удалгүй Тэнгэрийн элч буюу Тэв Тэнгэр нэр нь олны дунд тархсан билээ. Харин аянганд цохиулснаас хойш Хөхөчүгийн шар гэрлийн бүрхүүл үргэлж түүнтэй хамт цуг байх болсон бөгөөд түүний ид шидийг сонсоод ирсэн Жадаран аймгийн алдарт Агажур бөө усан биш билгийн нүдтэй тул Хөхөчүгийн гэрлийг үзмэгц үг дуугүй түүнд сөхрөн мөргөсөн нь олныг бүр ч бишрүүлжээ.

Агажур бол Жадаран аймгийн хамгийн нэр хүндтэй өндөр настай бөө бөгөөд Тэмүжиний дээд өвөг Тумбунай цэцний унаган боол Начин төрийн удам юм. Начин төр Урианхай аймгаас олзлогдон ирсэн боловч бөөгийн ид шидээр бусдыг айлган боолоос чөлөөлөгдсөн ч удалгүй овгийн дотор эрх булаалдан тэмцэлдээд Тумбунай цэцэнд алагдаж, үр хүүхэд нь зугатан Жамухын дээд өвөг Жажирдайн хөвүүн Тугудайн дэргэд очсоноос хойш таван үеэрээ энд суусаар иржээ. Начин төрийн бөөгийн увидас дараа үеүддээ тасарч харин Агажуртай хамт дахин төрсөн нь энэ байв. Агажурыг Жамухын эцэг Хар Хадаан үл тоомсорлодог байсан ч Татаартай хийсэн нэгэн тулаанд хүнд шархдаж хэд хоног үхлүүт хэвтсэнд түүнийг нэгэнт үхэв хэмээн шинэ гэрт ганцааранг оруулсан хойно Агажур ирж бөөгийнхөө ид шидээр Хар Хадааныг босгосноор тэр Жадаран аймгийн дотор хамгийн нэр хүндтэй хүний нэг болжээ. Энэ явдлаас хойш Агажурыг үхсэнийг амилуулагч шидтэн гэж олон бүгдээр шүтэх болжээ. Харин Хөхөчү гэгч ид шидтэй хөвүүн гэнэт газраас ургах мэт гарч ирээд ийн олныг бишрүүлэх болсон нь эхэндээ Агажурын уур, зэвүүцлийг төрүүлсэн ч эрхбиш түүнийг хүрээлсэн шар гэрлийн их хүчийг үзмэгц өөрийн эрхгүй бишрэн дагахад хүргэжээ.

Агажур энэ яваа насандаа ихийг үзсэн ч газар, тэнгэрийн хүчийг Тэв Тэнгэр шиг хуримтлуулж чадсан бөөг мэдэхгүй байв. Ийм учраас тэр Хөхөчүг бишрэхээсээ илүү түүнээс айн сүрдсэн билээ. Тэв Тэнгэр ч Агажур бөөд туйлын хүндэтгэлтэй хандаж залуу хүний омголон бардам зан гаргасангүй, түүний өвдөгнөөс адис авч мөргөсөн нь зөв болжээ.Хөхөчү нутгийн алдартай бөөгөөс өөрийн эрхгүй сүрдэж айн сандарсан билээ. Агажур илбэ шид ихтэйгээс гадна ухаантай хүн тул энэ уулзалтын дараа Тэв Тэнгэрийг Жамухын дэргэд өөрийгөө залгамжлуулан суулгах хүсэлтэй болжээ. Учир нь Агажур үргүй байв. Агажур бөөг шүтэх болсон Хар Хадаан дайн тулааныхаа олзноос үзэсгэлэнт эмс,охид бэлэглэсээр хорь гучин эм болсонч нэгнээс нь ч үр хүүхэд унасангүй. Харин нэг эм хөвүүн төрүүлсэн нь өөрийнх нь үр бишийг Агажур мэдсэн тул усанд хаяж хөнөөлгөжээ.

Үүнээс хойш залгамжлах үргүй хувь зохиолоо нэгэнт мэдсэн Агажур өөрийн догшин сахиусыг хэнд өвлүүлж үлдээх вэ гэж үсээ зулгаан үгээ барж байтал ашгүй энэ Мэнлиг хөвүүдээ дагуулан, Есүхэйн бэлбэсэн эм Өүлэнээс салж ирсэн нь Дээд Тэнгэрийн зарлиг ажээ. Агажур бөө,Хөхөчүгийн тухай, нэгэн шидтэй хөвүүн байгаа гэж сонссон ч уулзахаа хүлээсээр байсан билээ..

Учир нь тэр балчир хөвүүн өсч эрийн цээнд хүрч бүх эрдэм чадал нь тодрохыг харзнасан хэрэг юм. Харин сүүлийн үес эрлэгийн элч сүнсийг нь ээрч зовоох болсон тул хүлээж сууж болохгүй болоод тэр Хөхөчүг үзэхээр ирсэн билээ. Агажур бөөгийн амьдралд тоотой хэдхэн хоног үлдсэн байв. Ингэж Хөхөчү Жадаран аймгийн хамгийн хүчирхэг бөөгийн сахиусыг өвлөн авах учир бүрджээ. Агажурын догшин сахиусыг өвлөн авснаар Хөхөчү Жадаран аймагт

үүрд суух ёстой юм. Агажурын догшин сахиус Хөхөчүд ирснээр Хэнтий ноён уул, Хэрлэн эх голын хоёр сахиус нэгдэж Тэв Тэнгэр бүхнээс хүчтэй бөө болох ажээ. Энэ бол газар, тэнгэрийн хүч нэгдэнэ гэсэн үг юм. Хоёр жилийн өмнө Агажур бөө тэнгэрт халихдаа Тэв Тэнгэрт өгсөн сахиус нь зэв хэлбэртэй байсан тул Тэв Тэнгэр мөн ийм зэвэнд тэнгэр газрын хүчийг шингээж сахиус болгон Тэмүжинд илгээхээр шийдсэн билээ. Агажурын ирээд буцсаны маргааш тэнгэрийн баруун хаяанд шөнө дөлөөр их гэрэл цацарч нар тусах шиг болсонд хүмүүс үүр баруунаас цайв гэж айж сандрахад учрыг нэгэнт мэдсэн Хөхөчү хэнгэргээ шүүрэн авч овоон дээр очоод бөөлж эхлэвХөхөчүгийн хувирч өөрчлөгдсөн яруу цээл хоолой хангинан тэр дороо дуу нь тэнгэрийг дүүргэж,газрыг бүрхжээ.

Тэнгэрийн баруун хаяанаа цацрах өнөөх их гэрэл удалгүй нэг цэгт цугларан сар адил бөмбөлөг болоод наашилж яг Тэв Тэнгэрийн дээр иржээ.Бөөлсөөр байхад өнөөх гэрэлт бөмбөлөг задран утаа шиг суунагласаар Тэв Тэнгэрийн биед шингэхийг олон хүн харж,сүрдэж айхдаа газарт нам унажээ.Тэв Тэнгэрийн бие шатах мэт хэсэг зуур гэрэлтээд эргэн тойрон дахин таг харанхуй болжээ. Харин Тэв Тэнгэр бөөлж суусан газраа хэвтээд гурав хоног нам унтсан юм.

Гурав дахь өдрийн өглөө тэр юу ч болоогүй юм шиг босч ирэхдээ даруй сөөм өндөр болж, мөр нь тэгшрэн тэвхийсэн байхыг Мэнлиг, хөвүүдийн хамт үзжээ. Тэв Тэнгэрийн нэр сүр тэр дороо л тархаж аврал тусламж эрэгсдийн цуваа тасрахаа больж Мэнлигийн хүрээ өргөжин, одоо тэдний хүрээний голд Тэв Тэнгэрийн хар сүлдтэй өргөө байрлах болжээ. Харин Агажур бөө үхэж, түүний догшин сахиус, нэр нөлөө Тэмүжиний харц Мэнлигийн хөвүүн Хөхөчүд шилжсэнийг Жамуха огт таашаасангүйгээр барахгүй Агажурыг үхсэний дараа өөрийн дэргэд Бух хатир бөөг залж суулгасан нь түүний ялагдал, сүйрлийн эхийг тавьсан хэрэг байв.

Энэ нь Тэнгэр газрын нэгдсэн далдын их хүчийг Тэмүжинд шилжүүлэхэд хүргэв. Жамуха өөрийн нэр төр, сүр хүчийг бөөгийн ид шидээс ямагт дээгүүрт тавих тул ингэж шийдсэн хэрэг юм. Бух хатир бол илбэ шид бага, зөвхөн Жамухын хүссэнийг л хийх тул энэ нь Жамухад хэрэгтэй гэж үзжээ. Ерөөс бөөгийн удам үгүй, харц Мэнлигийн хөвүүн хүчтэй бөө болно гэхэд итгэл багатай, бас тэгээд Боржигон аймгийн тэр дундаа Есүхэйн гэрийн зарцын хөвүүнийг өөрийн дэргэд өргөмжлөхийг тэр хүссэнгүй билээ. Ингэх нь Жамухад гарцаагүй зөв байсан биз. Жамухын энэ шийдвэр Тэв Тэнгэрийн Тэмүжинд туслах хүслийг нэгэнт шуудруулж өгсөн явдал болжээ. Одоо Жамуха түүний хүчийг авахгүй нь тодорхой болсон тул Тэв Тэнгэр Төмөртэйн амны овоог тахих их тайлгаа нягт нямбай,түргэвчлэн бэлдлээ. Тайлга, Тэмүжин Бөртийг Мэргэдэд булаалгаснаас хойш яг зуун ерэн есөн хоногийн дараа болох ёстой гэж Тэв Тэнгэр шийдэв. Нэг зуун ерэн ес гэдэг бол Тэв Тэнгэр өөрийн бөөгийн ид шид,онгодоор дуудан тусламж, хүч эрэх уул усны савдаг, эзэн сахиусны тоо юм.

Тэр одоо нэгэнт өөрийн Мөнх Тэнгэрээр дамжуулан Монголын уул,усны зуун ерэн есөн савдаг, эзэн сахиустай ярьдаг болсон байлаа. Тэр бүгдийн хүчийг нэгтгэхийг Тэв Тэнгэр хүсч байлаа. Энэ зуун ерэн есөн савдаг, эзэн сахиусны эзэмших гол мөрөн, уул ус бүгд Монголын их тал хээр,түүний залгаа өндөрлөг нутагт орших бүлгээ. Хэрэв энэ бүх савдаг, эзэн сахиусууд Тэмүжинг ивээхээр зөвшөөрвөл тэдний эзэмшилд байгаа газар нутагт Тэмүжин үхлээс зайлж, их ялалт олох болно. Харин тэд эс зөвшөөрвөл Тэмүжинг юу ч хамгаалахгүй болж тэр жирийн хүний адил эрлэгийн элчийн хүссэн цагт л үхэх хувь тавилантай хэвээр

үлдэх юм. Тэв Тэнгэрийн ганц итгэл найдвар нь Тэмүжинг хүрээлэгч бүдэг ч гэлээ шар гэрлийн солонгыг харсан явдал байв.Тэмүжиний толгой дээгүүр татагч шар гэрлийн солонго бол түүнийг Тэнгэрт тэтгэгдэж,газарт ивээгдсэн хүмүүн болохын гэрч тэмдэг гэдгийг Тэв Тэнгэр мэдэх болжээ. Энэ гэрэл одоо Тэмүжинд байгаад, түүнийг нь савдаг, эзэн сахиусууд үзэх аваас тэд Тэмүжинг өөрийн ивээлд авах нь гарцаагүй гэж итгэнэ.

Чингэвэл Тэмүжин хэнд ч дийлдэхгүй баатар хүчтэй , баян ухаантай их хаан болно гэж Тэв Тэнгэр итгэж байв. Хэдийгээр урьд өмнө хэн гэгч ингэж Тэнгэрт тэтгэгдэж,газарт ивээгдэн их хаан суусныг Тэв Тэнгэр сонсож,мэдээгүй ч Тэмүжинг чухам тийм хүн болоосой гэж чин үнэнээр хүсч байсан билээ. Тийм ч учраас энэ ажилдаа улайран, нойр хоолгүй зүтгэж байв. Сахиус дуудах шүлгээ зохиож дуусав. Бас аялгуу нь ч бэлэн болов. Бүх савдаг ,эзэн сахиус сонсмогц уяран дурлах,үзэхээр яаран ирэх тийм уран тансаг аялгуутай,утга төгөлдөр дуу,шүлэг зохиожээ. Тэнгэрээс унасан солирын хэлтэрхийгээр хийсэн зэв хэлбэртэй сахиус ч дархлав. Намрын эхэн сарын нар сар тэнцсэн зохиролт сайн өдөр болжээ. Төмөртэйн амны их овоонд Тэв Тэнгэр үүр шөнийн заагаар ганцаар очлоо.

Түүнийг уул усны савдаг, эзэн сахиуснуудтай ярилцахыг усан нүдтэй хүн харах учиргүй юм. Их түүдэг дүрэлзэн асч хавь орчныг гэрэлтүүлнэ.Энэ их түүдгийн мод мөчир бүрийг хавь орчны ойгоос ширхэг ширхэгээр нь түүн авчирчээ. Тугалын арьсыг могойн тосонд чанаж хийсэн хэнгэргийн дуу тэнгэрт хадна. Бүх уул ус хэнгэргийн дуунд сэрлээ. Тэв Тэнгэрийн бугын урамдлага шиг нарийн цээл хоолой ийн дуулж эхлэв.

Газрын догшдыг урия

Ганцыг ч бүү үлдээе

Тэнгэрийн эзнийг хурайлая

Түүнийг ч бүү үлдээе…

Эцэг Тэнгэр сонсогтүн Хурай хурай

Эх газар мэдэгтүн Хурай хурай

Умраас урагш дуудъя

Учирсан эзэн сахиус та минь сонс

Зүүнээс баруунш дуудъя

Зүүдлэгдсэн онгод догшид бүгдээр сонс

Төрсөн дүү чинь

Төөрсөн хөвүүн чинь

Төгс их хүчийг тань хурайлам за

Тэв Тэнгэр миний хэлэхийг сонсоцгоо

Унасан цагаас

Унаган наснаас

Учирсан анд

Уулзсан нөхөр

Тэнгэрээс заяат

Тэмүжин баатар

Хортонд хорлогдож

Хүчтэнд автагдав

Хэлье гэвч эцэггүй

Хэцүү бэрхтэй тулам за

Хавсаръя гэвч цэрэггүй

Хатуу бэрхтэй учрам за

Хөдөө хөхөрч Хөөрхий болов

Гадаа гандаж

Гаслан болов

Хөрст газар дэвсгэртэй

Хөх тэнэгэр хөнжилтэй

Уулаар нөмөр хийж

Усаар унд хийж

Холын холд хоцрав

Газрын гавд ганцаардав

Хөлдөө газраас өөр тулгуургүй

Гартаа тэнгэрээс өөр тэмтрүүлгүй

Морьгүй явган

Дээлгүй нүцгэн үлдээд

Газар дэрлэж

Тэнгэр хөдөрч явна

Сэр сэр Ир ир

Гарсан цагаас

Гар сунгасан

Өсөх наснаас

Өмгийг тань түшиж

Өвдөг сөхөрсөн

Өнчин дүү чинь

Хартанд хадруулж

Ханиа булаалгав

Ганц мод шиг

Гансарч хоцров

Шар гэрлийн тэмдэгтэй

Шүтэн дээдлэх сэтгэлтэй

Бөртэ чонын удам

Бодончир богдын сүнс

Есүхэй эцгийн хөвүүн

Өүлэн эхийн үр

Өсөх идэр Тэмүжин

Ирэх цагийг эзлэж

Их хаан сууна гэнэ

Газар орныг нэгтгэж

Гарын дор захирна гэнэ

Сэр сэр Хар хар

Дайсны сумнаас Далдлагтүн

Даль жигүүрээрээ Халхлагтүн

Далайсан сэлэмнээс Зайлуулагтүн

Далд хүчээрээ Хамгаалагтүн

Муу бүхнээс сэргийлэгтүн

Мунхаг үхлээс тойруулагтүн

Биеийг нь бэхлэгтүн

Сэтгэлийг нь сэргээхтүн

Бодлыг нь хурцлагтүн

Болгоомжийг нь нэмэгтүн

Дайснаа дарахад

Зориг бологтүн

Дагасныг захирахад

Ухаан бологтүн

Нэр нь бүрэн болтугай

Бие нь бүтэн болтугай

Ухаан нь уужим болтугай

Улс нь их болтугай

Ир ир Хар хар

Газар газрын догшин сахиусаас

Ганцыг ч бүү үлдээе

Тэнгэр эцгийн онгон сахиус

Түүнийг ч бүү үлдээе…

Эцэг Тэнгэр сонсогтүн

Хурай хурай

Эх газар мэдэгтүн

Хурай хурай

Умраас урагш дуудъя

Учирсан эзэн сахиус та минь сонс

Зүүнээс баруунш дуудъя

Зүүдлэгдсэн онгод догшид бүгдээр сонс

Төрсөн дүү чинь

Төөрсөн хөвүүн чинь

Төгс их хүчийг тань хурайлам за

Тэв Тэнгэр миний хэлэхийг сонсоцгоо

Эртний ерөөлөөр ирсэн

Эзэн Тэнгэрээс ивээгдсэн

Их хаан гэдгийг Эргэлзэлгүй санаж

Эргэлтгүй бодож

Ивээлдээ авагтүн

Угаасан ус нь эс хайрлаваас

Удамгүй хүний гарт эндэх бий

Улс гүрэн нь хохирох бий

Унасан газар нь эс хамгаалбаас

Ухаангүй тэнэгийн хорлолд унах бий

Угийн зорилгоос ухрах бий

Хаан суудалд хүртэл

Хаана явсан газарт нь

Хамгаалан авагтүн

Хамгийг захиран суутал

Хатуу чанд зорилгод нь

Хавсран туслагтүн

Хонзон ихтэй Мэргэдэд

Хожим сүйрэхийг сануулагтүн

Хүйтэн дотортой тэднийг

Хүний гараар мөхөөгтүн

Хөөрхий Бөртэ хатныг

Хүчтэний гэрээс булаагтүн

Онон мөрний хөвөөнд

Очуулж буцааж өгөгтүн

Ир ир Хар хар

Хурай хурай Хурай хурай…

Тэв тэнгэрийн гайхалтай нарийн цээл хоолойгоор дуулах энэ үгс хэнгэргийн огцом түргэн хэмнэлт аялгууг хөлөглөн үүлтэй тэнгэрийн доогуур, үзүүртэй модны дээгүүр дөрвөн зүг найман зовхист нисэн одлоо.

Одоо түүний үгийг Монгол газрын нэг зуун ерэн есөн савдаг,сахиус сонсож байгааг Тэв Тэнгэр мэдэрч байв. Тэв Тэнгэрийн биед Төмөртэйн амны овооны дороос оргилох газрын хүч шингэн одоо тэр зүг зүгээс уул усны эзэд савдаг сахиуснууд нисэн ирж түүдэг галыг тойрон эргэлдэхийг олж үзжээ. Тэд хэлбэр дүрс бүгд өөр хийсч ирэх зүг чиг ч өөр ажээ. Ирсэн сахиус савдаг бүр их түүдгийн дээр агаарт хий тогтоосон хүрэл зэвийг шүргэн өөрийн хүчийг шингээгээд буцан нисэж одох бүлгээ. Ингэсээр нэг зуун ерэн найм хүрээд үүр цайжээ. Харин нэг газрын савдаг ирсэнгүй. Эсвэл замд нь үүр цайсан тул буцав уу. Хаанахын ямар газрын савдаг ирээгүйг Хөхөчү мэдэж чадсангүй.

Агаарт тогтоосон хүрэл зэв газар газрын эзэн савдаг,сахиуснуудын шингээсэн хүчний илчэнд улайдан час улаан болжээ. Үүр цаймагц агаарт хий тогтоосон хүрэл зэв доош газарт унахад өвс шажигнан түлэгдэж утаа уугихыг Тэв Тэнгэр харлаа. Төмөртэйн амыг өтгөн манан бүрхэж наргүй мөрт долоон өнгийн битүү дугуй солонго татсаныг олон иргэд гэр гэрийн гадаа зогсоод бишрэн харж байв. Бүтэн дугуй солонго анх удаа татсан нь энэ билээ.

Үүний өмнө хэн ч үзээгүй энэ хачирхалтай солонго бол Тэв Тэнгэрийн олсон их хүчний баталгаа юм. Тэв Тэнгэр туйлын хөөр баяртай байлаа. Учир нь Тэмүжин эцэг Тэнгэрт тэтгэгдэж, эх газарт ивээгдсэн хүн болох нь нэгэнт тодорхой болжээ.

Ямарч болов Монгол нутгийн нэг зуун ерэн найман сахиус,савдаг Тэмүжинг ивээлдээ авчээ. Энэ бол Тэмүжинд туслахыг газар, тэнгэрийн бүх сахиус, савдаг Тэв Тэнгэрт итгэн даалгаж буй хэрэг, Тэнгэрийн зарлиг гэдгийг тэр сайн ойлгож байв.

Тэв Тэнгэрийн зорилго тодорхой болов. Одоо Тэнгэрийн зарлигийг биелүүлж нэг зуун ерэн найман савдгийн хүчээ шингээсэн сахиусыг Тэмүжинд хүргэж өгөх үлдэв . Тэр өдөр нутгийн олон иргэд Төмөртэйн аманд цугларан ирж овоогоо тахив. Олон үхэр, хонь нядалж ,лус баярлаж, ус долгилтол их бүжиг, цэнгэл хийхэд үүлгүй тэнгэрээс зөөлөн бороо намирч бүгдийг бишрүүлжээ. Мэнлигийн удирдан зохицуулсан найрын хойморт их овооны өмнө зассан нарсан сэнтийн дээр Хөхөчү хүндэтгэлтэйгээр заларчээ. Энэ тайлгын эхэнд Мэнлиг Хөхөчү хөвүүнийхээ Тэв Тэнгэр алдрыг зарлан тунхагласанд олон бүгдээр бишрэн сөхөрч Тэв Тэнгэрийн ивээлд багтахаар хүн бүр олон адуу мал өргөн барьснаар Мэнлигийн өрх нэгэн өдрийн дотор ихээр баяжив. Тэв Тэнгэрийн ивээл тусыг олох гэж хүн бүр өөрийн хөрөнгө зоорь,итгэл бишрэлтэй дүйхүйц өргөл барьц өгчээ.

Маргаашнаас эхлэн Мэнлигийн намаржиж байсан Нарийн Тээлийн хөндий Тэв Тэнгэрийн ивээлд багтах гэсэн олон иргэний нүүдэл, өргөл барьцны малын хөлийн тоосонд бүрхэгдэв. Жамухын дэргэд салж очсон Боржигон аймгийн ихэнх энд цугларчээ.Тэдний ганц итгэл,найдвар Тэв Тэнгэр болов. Харин Тэв Тэнгэрт тэдэнтэй уулзах зав байсангүй. Өвчилж шаналсан,үгүйрч зовсон,өрсөлдөж ялагдсан,үхэлд ээрэгдсэн гээд аврал тусламж хүсэгчидийн цуваа гүвээ даван оджээ. Тэв Тэнгэр ах дүү хоёроо бас дагаж ирсэн иргэдээс бие ихтэй, хэдэн залуусыг дагуулан Бурхан Халдун уулын хаа нэгтээ байх Тэмүжиний өнчирсөн хүрээг эрж олохоор мордлоо. Цувааны тэргүүнд Тэв Тэнгэр бөө заларч явааг илтгэсэн бага хар сүлдийг барьсан морьтон явах ажээ. Харин Тэв Тэнгэр Найман аймгаас худалдаж авсан нумтай хөнгөн тэргэнд заларч явлаа. Арваад жил хөл тавиагүй унасан газар угаасан усандаа очих нь Тэв Тэнгэрт хүслэнтэй сайхан санагдана. Дүүгүүрийн чулуу шиг хаа очсон нь үл мэдэгдэх Тэмүжинг балар их ой хөвч,уулсын дундаас олно гэдэгтээ Тэв Тэнгэр огтхонч эргэлзэхгүй байв. Учир нь одоо түүний өвөрт яваа хүрэл сахиус нь Тэмүжиний байгаа газар ойртох бүр халуун оргих ёстой юм. Түүний мэргэнд Тэмүжиний байгаа газар бараг тодорхой буусан билээ. Гэвч үүнийгээ тэр хэнд ч хэлсэнгүй.

Намрын нар жигдэрч налайгаад зам зуур таарах айл амьтан тайван налгар үзэгдэх нь энэ газарт ер хахир өвөл болоод дайн тулаан болдоггүй мэт ажээ. Одоо нүдний өмнө харагдаж буй Улз голын өргөн дэнжээр долоон жилийн өмнө шөнө дөлөөр нүүж явснаа саналаа. Тэгэхэд Тэв Тэнгэр есөн настай, сүнс, сүүдэр хоёрыг ялгаж мэдэхгүй, хүн болгонд дорд үзэгдсэн ядуу амьтан байсан бол одоо тэр арван долоон нас хүрч, айл аймагт нэр нь түгсэн

бөө болсон байлаа. Ухаан орсон цагаас өрөвдөж туслаж,өмөөрч хамгаалж явсан ганц нөхөр Тэмүжинээс хагацах шиг гашуун зовлонг Хөхөчү хэзээ ч амсаж эдлээгүй тул нүүдлийн замд нүдээ бөлцийтөл уйлж үүнээс болж Мэнлиг эцэгтээ уургын хуйваар тас шавхуурдууж давхар зовлон эдэлсэн билээ.

Нүүдлийн хойноос хонио тууж нулимс урсган гэлдрүүлж явахдаа сэтгэлийн дотор хамгаас дотно ганц хүн нь Тэмүжин болохыг ойлгожээ. Хар элгийн түүнийг яагаад тэгэж санах болсноо тэр үед мэдээгүй ч одоо тэр хоёр Тэнгэрийн зарлигаар учирсан нөхөд болохыг мэдэж авчээ. Харин уургын хуйваар ороолгуулсны улаан гүвдрүүг шүлсээ түрхсээр тэр дор нь эдгээгээд өөрөө ч ихэд гайхжээ. Зулзган могойн дайтай тэр улаан гүвдрүү харсаар байтал алга болохыг ах дүү нар нь харж эцэгтээ ховложээ. Нааш нүүхэд Өүлэн хүний урманд тоож үдэж өгөөгүйд уурлан хорссоор явсан Мэнлиг хүүхдүүдийн энэ үгийг анзаарч сонссонгүй.

Харин ээж нь ядуу дорой,сэтгэлийн өвчтэй Хөхөчү хөвүүнээ хайрлан үргэлж өмөөрөн хамгаалах тул Мэнлигийн харцнаас нуун хөлс,нулимстай хацрыг нь үнсжээ. Ээжийгээ ийн хайрлахад Хөхөчү тийм ч дуртай байсангүй. Учир нь ингэж өрөвдөх нь түүнийг ах дүү нарын дэргэд дорд ядруу амьтан мэт үзсэн хэрэг гэж боддог байжээ. Тийм учраас ээжийгээ хайрлах бүр даруй зайлан холддог билээ.

Хөхөчү хөвүүнээ ингэж ухаан самуунтай болсонд ээж нь өөрийгөө буруутган боддогийг Хөхөчү үл тааварлана. Хөхөчүг гэдсэнд олдсоноос хойш удаагүй байтал Мэнлиг, Есүхэй эзнээ даган Хэрэйд аймгийн Тоорил хааныд очоод жил болжээ.

Энэ хугацаанд хуучин залуу цагтаа сэтгэл алдарч явсан нэг аймгийн эр татаж чангаан сэртэндэх болсонд бүсгүй тэсэлгүй түүнд биеэ эзэмдүүлжээ. Гэтэл сэтгэлд дотно тэр эр нь эмийг эдлэхдээ ёстой нэрнээс цаашгүйг үзэж гутарчээ. Аваль эр Мэнлиг нь гайхамшигтай чалхтай эр болохыг сая л нэг ойлгожээ.

Мэнлиг эхнэрээ бие шалтаггүй бол шөнө алгасахгүй эдлэж, эдлэхдээ эм биеийг нь эцэж цуцтал эрхтэнээ салгахгүй үүр цайлгах билээ. Үнэхээр Мэнлигийн эм, эрдээ эдлүүлж, түүнд хөвүүн төрүүлж өгөхөөс өөрийг хийдэггүй байв.

Нэгэнт дур тачаалыг нь эр нөхрийн нь адил хангаж чадаагүй ядруу дорой эрийг хөөн явуулснаас өнөөх нь ихэд хорсон хараах болжээ. Гэтэл тэр эр богино настай муу үйлтэй нэгэн байсан бололтой Хөхөчүг мэндэлсний дараа шөнө галзуурч үхжээ. Харин сүүлд Хөхөчү хөвүүнээ ухаан самуунтайг мэдээд өнөө заяа муут эрийн муу хараал,хорлолоос ийм болов гэж сэжиглэн түүнд бие давхар үедээ шалиглан эдлүүлсэндээ харамсаад ч барахгүй болжээ.

Хөхөчү хөвүүнээ өөрийн шалиг зангаас болж ёсгүй эрийн точигонд бузартсан гэж бодох тул дайралдсан бөө бүрээр аврал засал хийлгэсэн боловч хөвүүн нь илааршин эдгэрсэнгүйд улам ч шаналан зовох бүлгээ.Хөхөчү эхийнхээ шаналлыг мэдэрдэг бөгөөд цаад нарийн учрыг таамагладаггүй ч ихэд өрөвдөх ажээ.Харин өнөөх эр эхийн хэвлийд байсан Хөхөчүгийн ид шидийн хүчинд хорлогдон үхсэнийг хэн ч мэдэхгүй билээ. Энэ мэт хуучин цагийн дурдатгалд автан сэтгэл хөдөлсөн Тэв Тэнгэр нэг нүдээр урд замаа, нөгөө нүдээр хажуугаар өнгөрөх үзэсгэлэнт нутгийг харж явлаа. Алсад Бурхан Халдун сүүдэртэн сүглийж, тэр зүгээс урин

хонгор салхи сэм сэм үлээх нь бушуул бушуул гэж дуудах шиг сонсдоно. Тайчуудын нутагт яваа тул айж ичих зүйл үгүй юм. Тэгээд ч бас хориод идэр залуус зэвсэг агсан дагаж явааг хэлэх үү. Гэвч цувааны магнайд заларч яваа хар сүлд нь түүнийг аюул бүхнээс хамгаална гэдэгт итгэлтэй байх тул сэтгэлд ер муу бодол төрсөнгүй. Учир нь ийм хар сүлдийг зөвхөн бөө хүн л хэрэглэхийг тал нутаг даяар бүгдээр мэдэх билээ. Тэнгэрийн ивээлд багтсан бөөд хэн ч зориглон халдаж үл зүрхлэнэ. Өөрөө хэнээс ч илүү хүчтэй гэдэгтээ итгэж бардамнах муу зан аль эрт Тэв Тэнгэрийн сэтгэлд ургажээ.

Одоо энэ газарт түүнтэй эн зэрэгцэх хүчтэн үгүй мэт Тэв Тэнгэр санаж явлаа.Сэтгэлийн гүнд ургасан муу өвчин Хөхөчүгийн зан аашийг эвдсээр байгааг тэр өөрөө даанч мэдэхгүй байлаа. Бардам зан бол хүний цустай хамт төрдөг өвчин юм. Агажур бөөгийн догшин сахиусыг өвлөн авсан нь Тэв тэнгэрийн ид шид ,хүч чадалтайнх биш ганцхан Жамухын бардам зангаас болсон билээ. Жамуха хэрвээ бардам зангаа дарж өөрийн дэргэд Агажурын орыг залгамжлуулан хэн нэг бөөг суулгасан бол бүх зүйл огт өөрөөр эргэх байжээ.

Жамуха ядаж Хөхөчүг Есүхэйн боолын хүү гэж үл тоомсорлолгүй өргөмжилсөн бол тэр өөрөө Агажур бөө болоод Тэв Тэнгэрийн догшин сахиусны хүчийг авах байсан юм.Одоо малгайнхаа оройны сампинд зүүж яваа догшин сахиусны нь эзэн Агажур бөөгийн өвөг Начин төр бөөг Тэмүжиний элэнц өвөг Тумбинай цэцэн үхүүлснийг Тэв Тэнгэр мэдэхгүй бүлгээ.

Цэнхэрийн голыг өгсөн мухлаг тэрэгтэй баг иргэн ирж явааг харсан Тэмүгэ айн сандарч,ойн цоорхойд нуугдсан гэртээ морио хөлөргөн давхиж ирэхэд ан авлахаар явсан Тэмүжин, Хасар, Боорчи, Билгүтэй дөрөв эзгүй, ганцхан Зэлмэ гурын хүзүүгээр хийсэн бугуйл элдэж байжээ. Өүлэн эжий бага хүүхдүүдийн хамт загасанд тавьсан тор эргэхээр яваад ирээгүй байв. Бөртийн хамт Билгүтэйн эх Сочигал, гэрийн асрагч эмгэн Хуагчин нар хамт мэргэдэд булаагдсан тул Тэмүжинийхэн хэдхэн биеэр хоцорсон нь энэ байв. Айж,сандарч, нуугдах нь тэдний амиа хамгаалах ганц арга болоод байлаа.

Тэмүгэгийн үгийг сонсмогц Зэлмэ мордож урд шилийг даван өндөр газарт гарч сэжигтэй тэдгээр хүмүүсийг тагнахаар одов. Удалгүй Зэлмэ өнөө баг хүмүүс Цэнхэрийн голын эрэгт бууж жодгороо босгож утаа май уугиулан байхыг үзжээ. Тэд лав энэ оройдоо хөдлөхгүй тухлах янзтай, бас мухлагт тэргийн оройд хатгасан хар сүлдээр нь бөө хүн заларч явааг таав. Зэр зэвсэг, хуяг дуулга үгүйг бодвол энгийн ардууд голдуу бололтой. Харин унаа морьд нь сульдаж эцсэнийг бодоход алсаас энд зорьж ирсэн нь илт. Хэдий тиймч Зэлмэ шууд давхин очиж зүрхэлсэнгүй. Янзыг нь үзэж нэлээд ойртож очоод гэдрэг буцахад нь хэн нь ч араас нь нэхэж хөөсөнгүй, харин нааш ир гэж даллан хашгирахыг үзсэн ч сэжиглэн очсонгүй.

Зэлмэ тэр дороо зүгээ буруулан явж гэртээ ирээд үдэш хоёр гур алж ганзгалан ирсэн Тэмүжин нарт үзсэнээ дуулгав.Бөртийг булаалгаснаас хойш энэ ойн гүнд шурган суугаад үзэх, ирэх хүнгүй хэдэн сар тайван байтал гэнэт эдгээр хүмүүс хүрч ирсэн нь өст Мэргэдийг санагдуулан түгшүүлжээ.

Эдгээр сэжиг бүхий хүмүүс ийм хол бөглүү газрыг зорьж ирсэн нь хачирхалтай. Наашаа энэ шавар усан дундуур зүтгэх учир хэнд ч байхгүй мэт. Хэн ингэж явах учиртайг тэд яаж ч бодоод олсонгүй. Өүлэн эх ч таамаглан хэлж чадсангүй. Хар сүлдтэй бөө хүн яваа нь бүр ч хачирхалтай ажээ. Хэрэв тэд энгийн ард бол довтлон очиж олзлон авч болох байв. Гэтэл бас

мухлагт тэрэгтэй, хар сүлдтэй гэхийг сонсвол тэд яавч энгийн Мэргэд,Тайчууд биш бололтой. Тэгвэл энэ газрын мухарт хэрэгтэй хүн л зорьж ирэх нь тодорхой учраас сонссон дороо Тэмүжин хэрхэхээ шийдэж эс чадаад ямартай ч өөрийн нүдээр үзэх нь зөв гэж боджээ.

Тэгээд шөнө болмогц Тэмүжин нөхдөө дагуулан мордлоо. Хэрэв тэд нэмэгдэж олуул болсон байвал даруй буцан ирж зүг буруулан нүүх, үгүй бол ядаж хэн гэгч ямар хэргээр ирснийг олж мэдэх хэрэгтэй болжээ. Тэр даруй үлдсэн хэд гэр орноо хөнгөлж, шар тэргээ хөллөн нүүдэлд бэлдлээ. Өүлэний хэдэн хөвүүд нүүж сууж, нуугдаж явсаар ийм ажилд хэнээс ч илүү гаршсан тул хэдхэн хормын дотор Хачиун, Тэмүгэ хоёр нүүхэд бэлэн болгов. Одоо ганцхан Тэмүжиний ирэхийг эсвэл хэн нэг нь хэл хүргэн давхиж ирэхийг хүлээн тэргэн дээр сарны гэрэлд сэрүүн хэвтэж байлаа. Үнэхээр Зэлмийн хэлсэн үнэн байв. Сэжигтэй тэр хүмүүс өдөр буусан чигээр амарч унтсан бололтой нам гүм ажээ. Мухлаг тэргийн ойрмог хориод агт хэрээтэй идээшилж байв.

Бас галын утаа,шарсан махны хиншүү тэдний зүгээс салхиар туугдан ирнэ. Мухлаг тэрэг болоод морьдын дэргэд харуул манаа гэх юм үзэгдсэнгүй.

-Сэм очиж морьдыг нь авч зугатъя. Явган тэд хаа очих вэ гэж Зэлмэ хэлэхэд бүгд дэмжив. Гэвч Тэмүжин урагш дуугүй ширтсээр байсан тул тэд тэр дороо ухасхийн явж чадсангүй. Агтны дэргэд манаа байхгүй байсан нь тэдний шүлсийг гоожуулж шуналыг хөдөлгөнө. Бөртийг булаалгаснаас хойш Тэмүжин нар ердөө л тавхан морьтой хоцорсон байв

Харин энэ хүмүүсийн гайхалтай тайван хэнэггүй байдал Тэмүжинд сэжигтэй санагдсан тул нөхдийн саналыг дэмжсэнгүй. Гэтэл харанхуйд мухлаг тэрэгнээс нэг хүн гарч шууд тэднийг чиглэн ирэв. Бүгд сэрэмжлэн эрэг дор хэвтүүлсэн морьдоо босгоход бэлдлээ. Бие засах гэсэн биз гэж эхлээд санасан боловч өнөөх хүн зогссонгүй явсаар тэднээс ердөө хэдхэн алхмын зайтай зогсоод нааш ширтэнэ. Нөхөд нь яах вэ гэж Тэмүжинг харав. Харвахдаа хамгийн мэргэн Хасар сумаа онилон тавихад бэлэн болжээ. Тэмүжин толгой дохив. Сум сэрүүн агаарт шунгинан одов. Өнөө хүн цээжийг нь чиглэн очсон сумнаас тэр дороо зайлснаар барахгүй сумыг агаарт барьж авсаныг тэд харж чадсангүй. Харвуулсан хүн унаагүйд Хасар ч бусад нь ч дахин харвахаар онилов.

Гэтэл өнөөх хүн

-Тэмүжин гэж дуудсан нь бүгдийг нам болгов. Тэр хүний дуугарсан нь сэрүүн агаарт тэнгэрээс хашгирах шиг сонсдов. Энэ санамсаргүй явдалд бүгд цочирдон алмайрчээ.Энэ үнэхээр цочиж мэгдмээр явдал байлаа. Хэн ингэж дуудсаныг мэдсэнгүй.

-Хэн бэ чи гэж Хасар бүгдээс түрүүлэн сэхээрч, өндийж хашгирав. Ингэхээс өөр арга байсангүй.

-Тэмүжин гэж өнөө хүн дахин шаардангуй, бүр та нарыг таниж байна гэсэн шиг өөриймсөг дуугарчээ. Өсөж өөрчлөгдсөн Хөхөчүгийн дууг тэдний хэн нь ч танисангүй. Бас Хөхөчүг байна гэж хэн ч санасангүй. Харин Тэмүжиний дотор сэрдхийн өндийлөө. Тэр хэдийгээр Хөхөчүг гэж таамаглаагүй ч, сэтгэлд нь нэгэн гэрэлт совин татаад өөрийн мэдэлгүй өндийн босчээ. Хасар,Билгүтэй хоёр түүний бүснээс татсан ч дийлдсэнгүй. Тэмүжинг ийм их бяртай

гэж санаагүй нөгөө хоёр гайхжээ.

-Тэмүжин. Би чамайг харж байна. Би чамтай уулзахаар ирлээ гэж үл таних хүн баясан хашгирч байв.

-Хэн бэ чи. Нэртэй бол нэрээ хэл гэж тэд зоригжин зэрэг зэрэг хашгирав. Тэмүжин тэднийг дуугүй гэж дохиод урагш алхав. -Хэрэггүй.Тэмүжин гэж Боорчи хэлэв. Тэмүжин тэдний хорихыг тоосонгүй. Шууд өнөө хүн рүү алхан очив. Ард нь үлдсэн хэд харвахаар нумаа татаж бас дайран ороход бэлэн байсан ч хэн нь ч хөдөлсөнгүй.

-Хөхөчү чи юу гэж Тэмүжин дөхөн очоод зөвхөн түүнд сонсогдохоор шивнэв. Тэдний яриаг нөхөд нь даанч сонссонгүй.

-Тиймээ. Тэмүжин. Би Хөхөчү байна гэж Хөхөчү хариу шивнэв.Тэмүжиний сэтгэл зөв зөгнөжээ. Энэ бол зарц Мэнлигийн хөвүүн Хөхөчү байв. Тэр одоо Тэмүжинээс дутахгүй өндөр эр болжээ.

-Чи надад нийлэхээр ирэв үү гэж Тэмүжин хэлэхдээ олон жилийн өмнө салж нүүхдээ Хөхөчүгийн хэлсэн үгийг санажээ.

-Үгүй ээ. Би чамд Тэнгэрийн сахиусыг хүргэж ирэв. Тэнгэр чамайг тэтгэж, газар чамайг ивээжээ. Тэнгэр чамайг их хаан болно гэж хэллээ. Энэ сахиус. Энэ сахиус бол бүхнийг номхотгогч Тэнгэрийн сум юм. Энэ сахиусанд Монгол нутгийн нэг зуун ерэн найман газар усны бүх эзэн савдгийн хүч ивээлийг би шингээв.

Үүнийг биенээс бүү салга. Энэ сахиус чамайг муу бүхнээс хамгаалж, мунхаг үхлээс сэргийлэх болно. Ийм сахиус тэнгэрийн дор ганц юм.Чи үүнийг зүүмэгц хэнд ч үл дийлдэх их хүч,ухааныг олох болно. Хариу хэлэхийн завдалгүй Хөхөчү өнөө сахиусыг Тэмүжиний хүзүүнд зүүж орхив. Хөхөчүгийн хөөрүү үгийг гүнзгий итгээгүй ч Тэмүжин юутай ч эргүүлж буцааж татгалзсангүй. Сахиусыг барьж үзвэл галаас гаргасан юм шиг халуун байх тул дуу алдан гараа үлээв.

Хөхөчүгийн өврөөс гаргасан зэв галд хийсэн мэт халуун байсан нь яавч жирийн хэрэг биш гэж бодогдоод хэлэх гэсэн үгээ буцаан залгиж амаа хамхижээ.

-Чи их том эр болжээ. Хөхөчү гэж Тэмүжин талархан хэлэв.

-Тэмүжин чи сонс.Одоо Мэнлигийн хөвүүн Хөхөчү нэгэнт үгүй болсон. Харин түүний оронд би Тэв Тэнгэр бөө чамтай уулзахаар ирлээ. Чи үүнээс хойш намайг Тэв Тэнгэр гэж нэрлэгтүн. Тэнгэр намайг элчээ болгон Тэмүжин чамд туслуулахаар илгээлээ.Тэмүжин чамд би Тэнгэрийн зарлигийг уламжлан дуулгаж байх болно гэж Хөхөчү омог бардам хэлжээ.

Түүний энэ үг Хөхөчүг огт хувирч өөрчлөгдөөгүйг батална. Тэмүжин түүний энэ үгэнд цочиж гайхсангүй. Хөхөчүг хүүхэд байхдаа шүтдэг, итгэдэг байсан боловч олон жил уулзаагүй удсан тул түүнийг бөө болсон гэхэд нэг л үнэмшихгүй ажээ.Гэвч бөө гэж ямар ид шидтэй,нэр нөлөөтэй хүн байдгийг Тэмүжин сайн мэдэх тул илүү сул үг хэлсэнгүй.

- Наадах чинь хэн бэ гэж тэвчээргүй Хасарын хашгирах сонсдов.

- Хасар,Билгүтэй,Зэлмэ гурвыг би таниж байна.Харин хажуудах нь хэн бэ гэж Хөхөчү харанхүйд нэвт харан асуув.

-Тэр миний нөхөр Боорчи гэдэг.

-Тэмүжин чамд энэ Боорчийг Тэнгэрээс илгээжээ. Чи сайн нөхөртэй болжээ гэж Хөхөчүг хэлэхэд

-Чи манайд оч. Дүү нар хүлээж байна. Ээж ч баярлана. Манайх эндээс холгүй бий. Би чамайг ирснийг мэдээгүй болохоор шөнө болгож ирлээ гэж Тэмүжин тал алдахгүй найрсгаар өгүүлэв.

Хөхөчү ингэж гэнэт ирсэнд тэр үнэхээр баяртай болсондоо Тэмүжин ихэд гайхав. Түүний сэтгэлд чухам ямар өөрчлөлт гарсныг таасангүй. Тэмүжин хормын дотор хөөрч догдлоод зүрх нь учиргүй дэлсжээ. Тэр Дайцэцэнийд очоод олон жил уулзаагүй Бөртийг хараад яг ингэж чичрэн догдолсон билээ.

-Би даруй гэдрэг буцах ёстой. Би урьд Тэмүжин чамд амласан ёсоор чамайг Боржигон аймгийн хан болохоор ирнэ гэж Хөхөчү эрс татгалзсан нь Тэмүжинийг гайшруулав. Хөхөчүг түүний дэргэд үлдэхгүйг мэдээд Тэмүжиний сэтгэл тэсэхийн аргагүй харамсан шаналж өөрийн мэдэлгүй

-Би Бөртийгөө булаалгаад зовж байна гэж тусламж,аврал гуйх мэт дуу алджээ. Хүүхэд насанд нь байсан хуучин итгэл бишрэл эргэн сэргэсэн нь энэ ажээ. Хөхөчүгийн хэлсэн зүйл бүгд үнэн болж Тэмүжин Бэгтэрийг алж бас Тайчуудад баригдсан билээ. Харин Боржигон аймгийн хан болох эсэх нь эргэлзээтэй.

-Тэмүжин. Чи бүү санаа зов. Чи нэгэнт Тэнгэрт ивээгдсэн тул чи удахгүй Бөртийгөө буцаан авна. Харин хэрхэн бүтээхийг чи мэдэх биз. Тэмүжин дахин үг хэлж амжсангүй. Одоо түүний өмнө Хөхөчү ч алга. Бас мухлаг тэрэг, идээшлэх морьд ч нүд ирмэхийн зуур зэрэглээ адил алга болжээ. Гагцхүү Хөхөчүгийн сүүлчийн үг чихэнд нь хангинасаар байв. Нуугдан суусан нөхөд нь бүгд хашгиралдан гүйлдэж ирээд хоосон болсон газрыг тэмтэрч,мөлхөж,дэвсэлж,маажиж үзэцгээв. Тэд харсаар байгаад харанхуй тэнгэрийн дор хоосон газарт хоцорчээ. Хэн нэгэн ийм юм хэлсэн бол хэзээ ч үнэмшихгүй байлаа. Гэтэл мухлаг тэрэг,агт морьд,утаа гээд харагдаж,үнэртэж байсан зүйлс бүгд Тэв Тэнгэрийн хүч байжээ. Яг үнэн хэрэгтээ Тэв Тэнгэрийн мухлаг тэрэг эндээс хагас өртөө газар зогсож бас морьд нь идээшилж байв. Өдөр Зэлмийн тагнаад буцсаныг харсан Тэв Тэнгэр өөрсдийн хий дүрийг тэдэнд үлдээгээд зайлж явсан билээ. Саяын дүрснүүд Тэв Тэнгэрийн дүртэй хамт алга болсон нь энэ байв. Харин Тэмүжин хүзүүн дэх сахиус нь халуу оргиулсаар байсан ч нөхөддөө үзүүлж, дурдсангүй билээ. Түүдэг галын ором, шинэхэн хомоолыг харж тэд дув дуугүй зогсов. Тэд энэ хий үзэгдлийн учрыг олсонгүй ч Тэмүжинг юу хэлэхийг хүлээж байв.

-Энэ юун хүн бэ. Яах аргагүй таныг дуудаж уулзсан биздээ гэж газраас өөрийн харвасан сумыг эрж олоод Хасар хашгирав.Түүний тэвчээр барагджээ. Юу гэж хэлэхээ Тэмүжин

бодсоор байсан билээ.

Бүгд дуугүй болж Тэмүжиний үгийг хүлээцгээв. Тэмүжиний юу гэж хэлэхээс цаашдын хэрэг хамаарах болжээ.

-Тэр Тэнгэрийн элч юм. Тэмүжиний энэ үгэнд хэн ч хариу хэлсэнгүй. Тэрүүхэн үедээ чухам юуны учир ингэж хэлснээ Тэмүжин ч өөрөө мэдсэнгүй.

-Юу гэж хэлэв.Тэр тэнгэрийн элч гэж Боорчи хачин нам гүмийг эвдэн болгоомжтой асуув.

-Би тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгджээ. Харин энэ үгийг Тэмүжин санаатай хэлэв.

-Энэ чинь юу гэсэн үг вэ гэсэн асуулт тэр даруй нэхэгдэн гарав.

-Би ч бас сайн ухсангүй.Тэнгэрийн элч ингэж хэлэв гэж Тэмүжин чин үнэнээр өчжээ. Үнэндээ бүх учрыг Тэмүжин тов тодорхой ойлгохгүй байлаа. Гэвч цээжинд нь халуун оргиулан байх сахиус л саяын явдал болж өнгөрснийг үнэн гэдгийг гэрчилнэ. Гал мэт халуу дүүгүүлэх сахиусаа гаргаад үзүүлчихмээр хүсэл тэсэлгүй бэрхээр оргилсон ч Тэмүжин асар их тэвчээр гарган өөрийгөө захирч чадлаа. Хэдийгээр Хөхөчү хүнд хэлж болохгүй гэж хэлээгүй ч Тэмүжин энэ нууцыг ганц өөртөө хадгалахаар шийджээ. -Буцацгаая гэсэн Тэмүжиний үгийг бүгд дагав. Тэд мордон гэрийн зүг явцгаав. Нэг бодоход зүүд юм шиг, гэтэл саяын үзсэнээс болж бөөн маргаан дэгдээж яваа нөхдийн дуу сонсогдох нь сэрүүн байгааг эрхгүй итгүүлнэ. Харин Хөхөчү хэлсэн үгэндээ хүрч Тэмүжинг Боржигон аймгийн ханд өргөмжлөгдсөний хойд жил Жамухаас хагацан эцэг, ах дүү нарын хамт түүнд ирж нийлсэн билээ.Жамухаас салах нь Мэнлиг болоод Тэв тэнгэрт тийм ч амар хэрэг байсангүй.

Өөрийг нь дагаж байсан олон овог аймгийн иргэд хулгайгаар нүүн Тэмүжиний дэргэд очсоор байсанд Жамуха уурсан хилэгнээд тэртэй тэргүй дэлбэрэх гэж байлаа. Гэтэл олны дунд алдаршсан бөө Тэв тэнгэр, Тэмүжинг дагахаар явсныг сонсоод тэвчиж байж чадсангүй цэргээ хөдөлгөв. Тэв тэнгэр, Жамухын чухам ингэхийг мэрэглэж мэдээд догшин сахиусныхаа хүчээр түүнийг зогсоохыг оролджээ. Жамухын цэргийн замд таарсан хуурай сайр гэнэт үерийн оволзсон усаар дүүрч үлээсэн тулам хэрэглээд ч гатлах аргагүй болсон байв. Уг нь энэ сайраар ус урсахыг үзсэн хүн үгүй болоод удсан ажээ.Жамухын дэргэд дагаж явсан Бух хатир бөө мэрэглэж үзээд энэ нь Тэнгэрийн муу үйлийн дохио тэмдэг болохыг хэлсэн нь Жамухыг эрхбиш хойно урдах явдлаа сэхээрч уур омгоо татахад хүргэв.Тэв Тэнгэрийг үл тоомсорлож болохгүйг Бух хатир бөө сайтар ухуулсанд Жамуха цэргээ татан буцсан нь Тэв Тэнгэр Тэмүжинд тусалсан хэрэг болов.

Хэрэв Жамуха, Бух хатир бөөгийн үгийг тоолгүй Мэнлиг болоод Тэв Тэнгэрийг довтолсон бол энэ тулаанд Тэмүжин хүссэн хүсээгүй татагдан орж дөнгөж нэгдээд байсан Хиад Боржигон аймагт мөхөл дахин нүүрлэх байв. Есүхэйн боол Мэнлигийн хөвүүн Хөхөчүг үл тоомсорлож өөрөөсөө холдуулан Тэмүжинд алдсандаа Жамуха анх удаа ихэд харамсжээ. Жамуха, Тэв Тэнгэрийн ид шидээс огтхон ч айгаагүй бөгөөд харин Тэмүжиний нэр сүр өсөн нэмэгдэж байгаад бухимдаж явжээ. Гэвч Жамухын бардамнах өвчин Тэв Тэнгэр өөрт нь яаж хор учруулахыг таамаглан сэжиглэхэд саад болж байв.

Тэр бүү хэл Хар Хадаан эцэг нь зүүдэнд нь орж тэнгэрт халиад удсан Агажур бөөгийн догшин сахиусыг нэхэж гэрээс нь гарахгүй суусаар байсныг Жамуха их юманд бодож тоосонгүй. Тэр энэ зүүднийхээ тухай ядаж Бух хатир бөөд хэлсэн бол удахгүй учрах аюулаас сэргийлж болох байжээ. Гэвч энэ хэргийн учрыг хэн ч мэдэх ёсгүй байсан бололтой. Тэв Тэнгэрийг дагаж олон аймаг,овгийн иргэд, харъяат нар Тэмүжинд ирсэнд Тэмүжин, бас Өүлэн эх нь туйлгүй баясаж Ононы шугуйд их найр хийв. Үнэхээр Мэнлигийн буцаж ирсэн нь Өүлэн эхэд баярлалтай хэрэг юм. Мэнлиг бол Есүхэй эцэг нь амьсгал хураахын өмнө сүүлчийн гэрээсээ итгэж хэлсэн, Өүлэн эх нь сэтгэлээсээ дотносдог хүн гэдгийг Тэмүжин сайн ойлгоно.

Бас хөвүүн Хөхөчү нь алдар нэрээ цуурайтуулсан нэртэй бөө болсон нь Хонхотон овгийн Мэнлигийн гэр бүл Тэмүжиний дэргэд шадарлан суух үндэс болов. Их Монгол улс байгуулж итгэлт нөхдөө сайшааж урамшуулах үедээ хамгийн эхэнд Мэнлигийг эцэг гэж олны өмнө хүндэтгэн дуудаж анх дугаар мянганы ноёноор өргөмжилсөн нь тэдний удмыг Чирха өвгөн, Мэнлиг эцэг, Тэв Тэнгэр гээд гурван үеэрээ Есүхэйн удамд зүтгэснийг нь үнэлсэн явдал байлаа. Бас Өүлэн эхийнхээ сэтгэлийг ч бодсон билээ.Тэмүжинг ингэж шийдсэнд Өүлэн туйлын баяртай болж,хүүгийнхээ уужим ухаанд бахархжээ.

Тэв Тэнгэрийн ирсэн өдрөөс хойш удалгүй Тэмүжин түүнийг онцгойлон үзэж газар нутаг зааж суулгаад,аливаа татвар,төлөөснөөс үүрд чөлөөлж,дархлан хүндлэл үзүүлэв. Мөн түүнд сайн дураар дагаж ирсэн иргэдийг захиран суух онцгой эрх олгожээ. Түүнийг ингэж өгөөмөр сэтгэлээр шагнасан нь Тэв Тэнгэрийн үзүүлсэн тусыг Тэмүжин шудрагаар үнэлж үзсэн хэрэг байв.

Бас Хөхөчүгийн нууцаар илэрхийлсэн хачирхалтай хүслийг ч биелүүлэхээ амлажээ.

Хөхөчү бага наснаас охид эмсэд гологдон ад үзэгдэж байснаас үүдэн нэгэн эвгүй мөрөөдөлд автсан байв. Энэ нь газар газрын, янз янзын овог, аймгийн эмсийг цуглуулж эхнэрээ болгон эдлэх явдал юм.

Гэвч Хөхөчүгийн энэ адын хүсэл зөвхөн бага насны гомдолтой нь холбоотой биш байсныг Тэмүжин огт гадарласангүй.

Хөхөчү эрийн цээнд хүрч эм биеийн нууцад нэвтэрснээс хойш өөрийн хэмжээ хязгааргүй хуял,тачаалтайг олж мэджээ.

Бөөгийн их нэр сүр нь хүссэн, таашаагдсан эмсээ эдлэх боломж олгодог нь түүний далд хүслийг бүр гааруулжээ.

Тэв Тэнгэр бүх аймаг улсаас үзэсгэлэнт эмсийг авчран эдэлж өөрийн адил олон олон Тэв Тэнгэрийг төрүүлнэ гэж мөрөөддөг болжээ.

Түүний анхны эм нь Хонхотон овгийн жирийн бүсгүй байв. Гэвч тэр бүсгүй Хөхөчүгийн хэтэрхий их дур тачаалыг хангаж эс чадаад бие сэтгэлийн их зовлонд унажээ.

Шөнө,өдөргүй, цадаж ханахаа мэдэхгүй хурьцах нь эхний үед таашаалтай байсан ч эцэст нь

эр нөхрийнхөө эрүүл биш гаж донтойг мэдээд нэг шөнө амиа бодон зугатжээ. Гэтэл ухаан солиорсон Хөхөчү хөөрхий бүсгүйг орхисонгүй.

Соёолон азарганых мэт сэлдий унжуулсан Хөхөчү нүцгэн шалднаар хөөн ирэхэд бүсгүй эцсийн аргаа хэрэглэн голын гүн цүнхэлд үсрэн оржээ. Учир нь Хөхөчү уснаас үхтлээ айх ажээ. Бүсгүй усанд живж үхээд харин Хөхөчүг орилж хашгирч ирэхэд нь Мэнлиг хүүхдүүдийнхээ хамт түүнийг дарж арайхийн тайвшруулсан билээ. Хөхөчүг ямар их шаналан зовж байгааг харсан хүн нүд халтирмаар байв. Тэгэхэд Хөхөчү шархадсан баавгай шиг бархирсаар үүр цайлгасан билээ.

Хамгийн шилдэг соёолон азарга ч Хөхөчү шиг эцэж цуцахгүй байж чадахгүй бизээ. Тачаалаа тайлж, үрийн сунгаа гадагш гаргахгүй бол Хөхөчүгийн бүх бие тэсэшгүй бэрхээр өвддөг бөгөөд ийм үедээ шархадсан араатан шиг орилж бархирч,барьсан хүрснээ хэмх цохиж,хүн харж,ойртохын аргагүй болно. Хөхөчүгийн энэ аймшигт зовлонг ах дүү нар нь болон бусад хүмүүс түүний бөөгийн онгод,ид шидтэй холбон ойлгох учир үл ойшооно. Харин ганц Мэнлиг л эцэг хүний ёсоор төрсөн үрийнхээ гай зовлонг таамаглажээ.

Даруу, урин ааш зантай тэр бүсгүйн нойргүй хонож ядарсан царай, өдөр, шөнийн цагт Хөхөчүгийн гэрээс сонсдох эр, эм хоёрын тачаалын дуу айл саахалт хүртэл дуулддаг байсан болохоор Мэнлиг хөвүүнийхээ адгуусанд ч баймгүй их тачаалтайг таамаглан мэджээ.

Жирийн тэр эм яагаад Хөхөчү хөвүүний нь дэргэд байж тэсээгүйг ч ойлгов. Хөвүүнээ аймшигтайгаар зовж шаналахыг харж тэсэхгүй болоод аргаа барахдаа нэгэн санаа сэдсэн нь хэрэг болжээ. Мэнлиг Хөхөчүтэй ний нуугүй ярилцаж түүний яагаад ингэж зовдгийн учрыг хэлэв.

Хөхөчү эцгийнхээ энэ үгийг сонсоод гашуунаар уйлахад Мэнлиг хөвүүнээ өрөвдөн нулимс унагажээ. Хөхөчүд эцгийнхээ үгэнд орохоос өөр арга үлдсэнгүй. Мэнлиг уулын хойш харсан мухар аманд жижиг жүчээ нууцаар бариулж тэндээ шинэ байдсан гүү авчран Хөхөчүд гишгүүлснээр хөвүүнээ зовлонгоос түр боловч хагацаажээ.

Чухам ийм явдлын улмаас Мэнлиг Хөхөчү хөвүүнээ олон эм авч өөрийн үр удмыг үлдээхийг зөвлөсөн билээ. Мэнлиг Хөхөчү хөвүүн шигээ ид шидтэй үр ач олонтой болохыг хүсч байв.

Байдсан гүүг яг л азарга шиг сөхөрч унатал нь гишгих хөвүүнээ хараад нэг шөнө арван эмийг ч болов цувруулан эдэлж чадахыг мэджээ. Харин азаар Хөхөчүгийн энэ гаж дон онгод хөдлөх үедээ л үе үе оргилдог нь эцэг хүү хоёрын хүмүүн бусын үйлдлийг сониуч олны нүднээс нууж нэр цэвэр үлджээ.

Тэмүжин Хөхөчүг газар газрын эмсээс сонгон авахыг зөвшөөрсөн тул одоо Хөхөчү өөрийн дэргэд хорь гучин эмтэй болж байдсан гүү гишгэх хэрэггүй болсон ч гэнэ гэнэ эцгийгээ зовоож хүний нүднээс далд өнөөх жүчээрүү явдаг ажээ.

Хөхөчүг ингэж ихээр хүндлэн шагнасан нь Хасар,Өүлэн эх,бүр Бөртэд ч таашаагдаагүйг Тэмүжин мэдэж байсан ч Хөхөчүгийн ид шидээс айх сэтгэл хүчтэйгээс гадна түүний хүч чадлыг өөрийн хэрэгт ашиглана гэж бодсон тул ингэж хийсэн билээ..

Ингээд Тэв Тэнгэр, Боржигон аймгийнхны дунд нэр алдар нь түгэж олон ардаар хүрээлүүлсэн хүн болов. Жамухын болоод Тайчуудын нэгдсэн цэрэгтэй Хүйтэн уулын өвөрт байлдаж байгаад Тэмүжин хүзүүндээ шарх олж амь алдах шахсан нь ямар учиртайг Тэв Тэнгэр түүнд хэлсэн билээ. Тэмүжиний зүүж явсан сахиусанд ганц савдаг ирж хүчээ шингээгээгүй нь тэр Хүйтэн уулынх байсан бөгөөд түүний ивээлд багтаагүйн учир Тэмүжин ингэж шархаджээ. Бас Хүйтэн уулын тулааны үеэр Тэмүжин шархадан унасныг алсад байсан Тэв Тэнгэр мэдэж туслаагүй бол Тэмүжин, Зэлмийн хамт Тайчуудад олзлогдон алуулах байжээ. Тэмүжин, Тэв Тэнгэрийн хэлсэнд итгээгүй ч бас л эсэргүүцсэнгүй.

Хүйтэн уулын тулаанд Тэмүжиний шархадан амь насаа алдах шахсан нь Жамуха нэгэнт Тэмүжиний дайсан болсныг Тэв Тэнгэрт батлан харуулжээ. Гэтэл Тэмүжин Жамуха хоёр сэтгэлийн холбоотой анд байсан нь Тэмүжинд хор болж байгааг Тэв Тэнгэр хэлжээ. Гэтэл хэдий дайсагнаж байгаа ч гэсэн Жамухатай анд бололцсоноо цуцлах нь харин ч аюултай хэрэг болно гэж Тэмүжин үзэж байв. Ингэж Тэмүжин, Тэв Тэнгэр хоёрын хооронд зөрчил бий болж эхлэв. Үнэн хэрэгтээ Тэв Тэнгэрийн хэлсэн үгийг Тэмүжин үл тоомсорлон орхижээ. Дуулгавартай хүлээцтэй Тэмүжин хэрхэн хувирч өөрчлөгдөж байгааг Тэв Тэнгэр мэдэрчээ.

Тэр байтугай улсын чухал хэрэг зөвлөлдөхдөө түүнийг оролцуулахгүй байгааг ч тэвчишгүй явдал гэж Тэв Тэнгэр бодох болов. Өөрийн үгний зөв болохыг батлан үзүүлэх ганц сайхан арга нь Жамухыг Тэмүжинтэй дайсагнуулах явдал гэж тэр тооцжээ. Энэ санаагаа хэрэгжүүлэхийн тулд Жамухыг түүнээс холдуулах гэж бүх ид шид, муу аргаа хэрэглэв.

Үүнээс болж Тэмүжин шөнө бүхэн Жамухыг зүүдлэн хар дарж сэрэх болжээ. Гэтэл Тэмүжин Жамуха хоёр түүний хүссэнээр болохгүй, нүүр тулан галзууран уралцахаас зайлсаар байгаагийн учрыг Тэв Тэнгэр ойлгосонгүй. Эцэст нь анх түүний өгсөн тэнгэрийн сахиус Тэмүжинг хамгаалж байгааг таамаглажээ. Гэвч Тэв Тэнгэрийн хүсэл биелж Тэмүжин Жамухыг цаазлав. Энэ бол тэдний андын холбоог тасласны гавьяа гэж Тэв тэнгэр өөрийгөө тайвшруулан бодсон билээ. Ингэхийн тулд Тэв Тэнгэр олон жилийн турш хүчээ заржээ. Гэвч Жамуха Мэнлигийн хөвүүн Хөхөчүг тоохгүй хэвээр түүнийг өөртөө хэрхэн гай болсныг мэдэхгүй хэвээр үхжээ.

Жамухыг үхүүлсний дараа түүний сүнсийг хөөн зайлуулаад Тэв Тэнгэр Тэмүжиний өргөөнд ирэв.

Цээж нүцгэн явахад ч амьсгал давхцан, хар хөлс цутгах зуны аагим халуун өдөр хэдий ч азарган чонын толгойтой арьсан өмсгөл битүү өмсөн явах Тэв тэнгэрийг харахад эхлээд гайхах дараа нь эрхгүй хүн биш гэж бишрэх сэтгэл төрнө. Онгод орж бөөлөх үедээ Тэв тэнгэр үнэхээр хүн биш болдог билээ. Жамухын сүнсийг хөөн зайлуулах нь хэцүү бэрх байснаас Тэв Тэнгэр бүр ч харахын эцэсгүй төрхтэй болжээ.

Нүд нь мах шиг улаанаараа эргэлдэж шүлс цус завьжаар нь савирна. Цээжин дотроо дүрэлзэн асах онгодын их халууныг дарах гэж түүхий мах бүхэл бүхлээр залгина. Энэ шөнө арван эмийг нойргүй эдэлж үрийн сунгаа асгаж байж сая нэг тайвшран жирийн хүний адил болж хэд хоног үхсэн мэт унтах болно. Харин түүнийг өөрийн хүрээрүү биш Тэмүжиний өргөөрүү яах гэж гэнэт очих болсны учрыг хэн ч тааж мэдсэнгүй.

Мэнлиг дув дуугүй Тэв Тэнгэрийг дагаж явав. Зам зуур тааралдсан айлын нялх хүүхэд түүний бараанаар уйлж, ноход түүнээс сүүл хавчин гаслан зугатаах ажээ. Уяатай морьд үргэн тасдуулж дээр доргүй бөөн хөл үймээн болжээ. Ямарч зоригтой эр өөрийн эрхгүй харц буруулан зайлж байв. Тэв тэнгэр явсаар Тэмүжиний өргөөнд хүрэхэд тэр шадар нөхдөө цуглуулаад улсын хэрэг хэлцэж байжээ.

Тэв Тэнгэрийг харуул,хэвтүүлүүд хориглож эс чадав. Гэрийн үүд шидэгдэн час улаан нүдтэй, энгэр бие нь цус шүлсэнд нэвт норсон Тэв Тэнгэр унь унагаан гуйван орж ирэхэд гэрт айгаагүй,цочоогүй, сэжиглээгүй хүн нэг ч үлдсэнгүй. Түүнийг харахад хоёр хөлтэй чоно ороод ирэв үү гэмээр байв. Хэн ч ухааран дуугарч амжсангүй.

Тэв тэнгэр их тулганы өмнө сөхрөн суухад ганцхан Тэмүжиний өмнөх хултай айраг цалгин асгарахыг бүгд үзэв. Хэн ч энэ явдлыг сайн ёр гэж бодсонгүй сэжиглэжээ. Гэвч хэн ч Тэмүжинээс урьтан дуугарсангүй.

-Чингис хаан та согсогтүн гэж Тэв тэнгэр хананы үдээс тасартал хашгираад тэр дороо унтсан мэт таг чиг болов. Угаас Тэв тэнгэрт талгүй, түүнийг үл тоомсорлон хялайж явдаг Хасар өндийж үг хэлэх гэхэд Тэмүжин түүнийг занган дуугүй суулгав. Тэв Тэнгэрийн хүндэтгэлтэй хэлсэн

-Чингис хаан гэсэн үг бүгдийг өөрт нь бишрэх сэтгэлийг хүчтэй төрүүлж байгааг Тэмүжин ойлголоо. Тэв Тэнгэрийн хүчийг юунд ашиглаж болохыг нэгэнт мэдэх болсон Тэмүжин түүнд саад болохыг үл хүсэн хэлцэж байсан улсын чухал хэргээ хойш тавив.

Тэд одоо байгуулсан улсаа хэрхэн нэрлэхийг тогтохоор хэлцэж байсан билээ. Ийм үед Тэв тэнгэрээс өөр хүн ингэсэн бол тэр хормын дотор хүүр болох байв. Тэв тэнгэрийн цааш юу хэлэхийг хүлээн гэрт түгшүүртэй нам гүм боллоо. Гэтэл Тэв тэнгэр их үст толгойгоо унжуулан унтах мэт суусаар. Хасар мэт тэвчээргүй заримын хэл загатнан өндөлзөвч Тэмүжиний Хөхөчүд онцгой дотно ханддагийг мэдэх тул тэвчинэ. Тэв тэнгэр гэнэт толгойгоо өргөв. Одоо түүний нүд хурц цэнхэр өнгөөр гэрэлтэж байхыг Тэмүжин үзжээ.

Тэв тэнгэр нэг нүдээр тооноор тэнгэр ширтэж нөгөө нүдээр гэрт суугсадыг тойруулан харав. Тэв тэнгэрийн нүднээс цацрах гэрэлд хултай айраг цөмөөр цэнхэр өнгөтэй үзэгдэв. Ямар нэг гайхалтай үйл явдал болох совин Тэмүжиний сэтгэлд төржээ.

-Чингис хаан та сонсогтүн. Олон нөхөд, хөвгүүд та нар мөргөгтүн. Би сая Дээд тэнгэрийн үгийг сонслоо. Эцэг тэнгэрт тэтгэгдэж, эх газарт ивээгдсэн Тэмүжинг их улсын эзэн болго гэнэ. Та нар Тэнгэрийн зарлигийг дагагтүн. Чингис хааны үгийг Тэнгэрийн зарлиг гэж бишрэгтүн. Хэн Чингис хаанд тэрслэнэ. Тэр Тэнгэрийн цаазанд унаж Жадараны зальхай Жамухын адил хүүр болно. Чингис хаан Дээд тэнгэр шиг мөнх орших болно. Олон бүгдээр сонсож бишрэгтүн. Мөнх тэнгэрийн хүчин дор ертөнц бүхлээр амгалан оршино. Их Монгол улсыг, энэ ертөнцийг Чингис хаан захиран сууна гэлээ.

Дээд тэнгэрийн зарлигийг хөлтэй нь сөхөрч сонсогтүн. Хөлгүй нь хэвтэж сонсогтүн гэж Тэв тэнгэр сүрлэгээр бүр алс газар агт тууж явсан эр сонсож зог тусахаар хэлсэн нь сонссон хэн боловч сүрдэж бишрэм ажээ. Бүгд Тэв тэнгэрийн шидэнд автан сөхөрч Тэнгэрт мөргөн

зарлигийг угтан авав. Хэн ч албадаж шаардаагүй мөрт өргөөнд байсан бүх хүн өнөөх цэнхэр гэрэлд илбэдүүлсэн мэт болохыг Тэмүжин өөрийн нүдээр үзжээ.Ганц Тэмүжин л хөдлөлгүй суусаар байв. Харин Тэмүжиний сууж байсан нарсан сэнтий газраас тохой хөөрснийг тэр анзаарсангүй.

Тэв Тэнгэрийг дээрх үгийг хэлж байхад хүзүүн дэх сахиус нь гал мэт халуу оргихыг Тэмүжин мэдэрч байв. Энэ бол Тэв Тэнгэрийн үг үнэн болохыг баталсан хэрэг юм. Тэв тэнгэр мөлхөн ирж Тэмүжиний хормойноос адис аваад

–Хөвүүд, дүү нар, шадар нөхөд бүгдээр Тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдсэн их Чингис хаанд мөргөгтүн гэж хашгирахад зөрөх хүн нэг ч гарсангүй нь мэдээж билээ. Тэмүжиний сэтгэл хязгааргүй ихээр бахдан баясав. Боржигон аймгийн хан болоход өргөмжилсөн Чингис хаан цол одоо Тэнгэрийн зарлиг болж мөнхөд соёрхогдов. Тэр шөнө Чингис хаан Тэв Тэнгэрийг урьж үлдээн шөнөжин ярилцжээ. Чингис хаанд дээд тэнгэрийн үгийг сонсох хүсэл оргилж байлаа. Өнөөдөр Тэв Тэнгэрийн уламжилсан Тэнгэрийн зарлигийг анд нөхөд, алтан ургийн хөвүүд л сонсов. Харин одоо энэ зарлигийг хурааж цуглуулсан бүх аймаг улс, нутаг оронд дүүртэл сонсгох хүсэл Чингис хаанд төржээ. Бүх хүн бага балчир, балай зөнөг бүгдээр дээд тэнгэрийн зарлигийг үнэн сэтгэлээр бишрэн дагах аваас Чингис хааны сүр хүч нэмэгдэж ертөнцөд дуурсах билээ. Хүний сэтгэлд орших итгэл бишрэл гэдэг цэрэг зэвсгээс дутахгүй их хүч гэдгийг Чингис хаан сайтар ойлгож авчээ.

Үүнийг Тэв Тэнгэр түүний нүдний өмнө батлан харуулж байв. Тийм ч учраас Чингис хааны сүр хүчийг улам нэмэгдүүлэх, иргэд олныг өөртөө бишрүүлж нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгүүлэхэд Тэв Тэнгэрийн тус их хэрэгтэйг ойлгосон тул түүнтэй бусдаас илүү хүндэтгэлтэй ханддаг байлаа. Түүнтэй адил ид шид, далдын хүч, Тэнгэртэй ярих чадвар үгүй тул үүнээс өөр шилдэг аргыг Чингис хаан бодож олж чадсангүй. Ер нь өөрөөс илүү хүч, чадалтантай арсалдан дайсагнах биш, аргадан нөхөрлөхийг илүүд үздэг нь Тэмүжиний хар багын ухаан билээ. Тэмүжиний энэ хүндэтгэл Тэв Тэнгэрт таатай байв. Тэр шөнө тэд Тэмүжинийг их хаанд өргөмжлөх ёслолыг хэрхэн хийх, түүнээс өмнө Тэв Тэнгэр өөрийн ид шидийг хэрэглэн Чингис хааныг алдаршуулах, түүнд итгэн бишрэх сэтгэлийг түмний дунд түгээхэд хүчин зүтгэхээр тохиролцов. Үүний нь төлөө Чингис хаан Тэв Тэнгэр болоод Мэнлиг эцгийн үр удмыг үүрд ивээлдээ авч аливаа татвар гувчуур, цэрэг дайны албанаас чөлөөлж,хааны сангаас хишиг хүртээн ивээж байхаар болжээ. Тэдний хийсэн энэ тохиролцоо хэн хэнд нь ашигтай байсан тул нууцыг чандлан үнэнч зүтгэхээр андгайлав. Их Монгол улсыг байгуулж Чингис хааныг өргөмжилсөн их хурилдайн үеэр олныг бишрүүлж хүндлэл хүлээсэн хүмүүс бол Чингис хаан, Тэв Тэнгэр хоёр байлаа.

Тэмүжинг Их монгол улсын хаанд өргөмжилсөн ёслолын үеэр Тэв Тэнгэр ид шидээ үзүүлж үүлгүй тэнгэрээс бороо оруулж, Чингис хааны өргөөний дээгүүр их солонго татуулсанд олон бүгдээр Чингис хааныг бишрэн шүтэхэд хүргэжээ.

Цурам хийн унтах завгүй, цулбуур жолоогоо татах сэхээгүй хийсэн дайн тулааны дараах энх амгалан амьдрал аятай сайхан ч өөрийн гэсэн зовлон бэрхшээл дүүрэн байдгийг Тэмүжин их хаанд өргөмжлөгдсөний дараа жилээс үзэж эхлэв.

Энэ бол Зүчи хөвүүн нь Ойн иргэд олныг их улсдаа дагуулан оруулсны хойт жил байлаа.

Их улс байгуулж элдэв муу самуун дарагдан гар газар, хөл хөсөр жаргах цагт дайн тулаан, баатар жанжны нэр сүр баахан дарагдаж мартагдаад өвчин зовлон, цас зуд, мал билчээр гэх аж амьдрал,амь зуулгын аар саар зүйлсэд хүмүүсийн анхаарал төвлөрч ивээлд нь багтаж албат нь болбол үхэлгүй мөнх, үгүйрэлгүй баян амьдрах гэнэ гэж Тэв Тэнгэрт очиж дагагсад өдрөөс өдөрт нэмэгдэж, шүтэн бишрэгчид олшрох бүр Хонхотны Мэнлигийн хөвүүдийн ааш зан хувиран, Чингис хаан түүний алтан ургийн хөвүүд, дүү нартай эн чацуу мөчөөрхөх болсон билээ.

Энэ бол Чингис хааны урьдчилан тааж мэдээгүй улсын дотор улс үүсгэж,олны сэтгэлийн дотор муу үйлийн үр суулгасан явдал, гэрийн дотор дэрний дэргэд дайсантай болсныг илрүүлсэн хэрэг байв..

Дайсан гэгч хэлж ирдэггүй,яг л өвс ногоо шиг хөлийн дороос чив чимээгүй ургадаг ажээ. Тэв Тэнгэрийн хүчийг үзэж мэдсэн тул түүнтэй хэрхэн яаж тэмцэхээ Чингис хаан тэр даруй шийдэж эс чаджээ. Бас анхнаас ганцаараа түүнийг нууцаар шүтэн хүндэлсэн тул хэн хүнээс асууж зөвлөхөд саадтай бас айж байлаа.

Тэв Тэнгэр бол давхиж очоод цавчаад алчихаж болохгүй сэтгэлийн дотрох дайсан юм. Бас түүнийг Тэнгэр хамгаалж байгаа нь хийх бүхэнд саад болж хэлэх үг, хөдлөх мөчийг хорьж байв. Чингис хаан цэрэг засаж,гучин жил амь өрсөн тулалдахдаа довтлон сөнөөх арга олдохгүй дийлэхэд бэрх дайсныг ингэж анх үзэв. Бас энэ дайсан нь хар нялхаас ивээж тэтгэсэн бишрэлт нөхөр нь байсан нь яг л Жамухын адил түмэн бэрх шаналалд унагав.Мэс далайж,морь унасан дайсантай тулах туйлын хялбар хэрэг байсныг Тэмүжин сая л ойлгов. Дөч гарч тавь шахтлаа юу эсийг үзэв. Тэгвэл түүний амьдралд хамгийн ихээр итгэл бишрэл төрүүлж асан нөхөр нь одоо өрсөлдөн тэмцэгч болоод зогссонгүй бүр өшөөт дайсан нь болов. Харин тэр дайсан нь хатавч үүдийг нь довтолж, хүйтэн мэс далайсангүй. Зүгээр л өргөн их алдар нэрийг нь өдөр өдрөөр хумсалж албат иргэдийг нь цөөн бүлээр урвуулсаар байгаад улсын дотор улс шиг болсон байлаа.

Тэв тэнгэрт дагаж очигсдыг Чингис хаан өстний цэрэг адил үзэж өрөвдөлгүй довтлон хөнөөж болохгүй юм. Тэд амар тайван, өвчин зовлонгүй амьдарья гэж хүссэнээс цаашгүй болохоор Тэв Тэнгэрийг дагагсадыг залхаан цаазлах үндэс бүр ч үгүй нь Чингис хааныг бухимдуулна. Ирт сэлэмнээс итгэл бишрэл илүү хүчтэйг Чингис хаан өөрийн бие дээр эрхгүй үзэж мэджээ..

Эцэст нь бүр Чингис хааны дүү Хасар,Тэмүгэ нарын зарим албат Тэв Тэнгэрийн дэргэд нүүж очсоноос болж тэдний хооронд үүссэн хэрүүл зодоон Их Монгол улсын түр зуурын тайван амьдралыг цочоолоо. Мэнлиг эцгийн хөвүүд Хасарыг зодож, хөөж явуулсныг сонсмогц Чингис хаан асар ихээр балмагдан цочсон ч үүнийгээ илрүүлэн мэдэгдсэнгүй. Харин Хасар хүн болсоор ингэж дээрэлхүүлж зодуулж үзээгүй учир тэсэлгүй бэрхээр өширхөн гомдож бас хилэгнэжээ.Гэвч Чингис хаан Тэв тэнгэрийг илт халамжлан ивээх тул Хасар Тэв тэнгэрийг арай ч алж зүрхэлсэнгүй.

Хасарын хувьд Тэв тэнгэр бол Есүхэйн удмын унаган боол Мэнлигийн солиотой хөвүүн Хөхөчүгээс цаашгүй юм.Түүнийг алж орхиход Хасарт эргэлзэж,айх зүйл өчүүхэн ч үгүй,ёстой алга урвуулахын төдий хэрэг ч Тэмүжин ахыгаа дэмий хилэгнүүлэхээс

болгоомжилжээ.

Хов мэдүүлж уйлж ирсэн Хасар,Чингис хаан түүнийг өмөөрч дэмжинэ гэж итгэн хүлээж суув. Гэтэл тийм явдал болсонгүй. Энэ өглөө Чингис хаан хилэнтэй байжээ. Их улсыг байгуулаад зүтгэж тэмцсэн шадар нөхдөө урамшуулж, мянганы ноёдыг томилохдоо өөрийн төрсөн дүү нарыг мянганы ноёнд өргөмжлөлгүй хоцроон, гадуурхан үзсэнээс болоод Өүлэн эх, Чингис хаан хоёрын хооронд хэрүүл зөрчил үүсээд байлаа.

Өнгөрсөн өдөр нь Өүлэн эх өргөөнд нь ирж Чингис хааныг энэ тухай хатуу үгээр зэмлэн донгодсон нь түүнийг ингэж хилэгнүүлсэн байв. Бас Өүлэн эхийн шүүмжлэн хэлсэн нь үнэн тул Чингис хаан улам ч уурсжээ. Чингис хаан төрсөн дүү Хасар, Тэмүгэ , Билгүтэйн алиныг ч мянганы ноёноор өргөмжилсөнгүй нь Их улсыг хураахад тэдний зүтгэснийг хөсөр үзсэн явдал болжээ. Бүр Өүлэн эх, отгон дүү Тэмүгэ хоёрынхоо дунд нэг түмэн иргэн өгсөн мөртөө Бөртийн мэргэд цусны хөвүүн Зүчид есөн мянган иргэн өгсөн нь Өүлэн эх болоод Тэмүгэд оногдох таван мянгаас даруй дөрвөн мянгаар олон болсон нь гомдол, хэрүүлийн эхийг тавив. Хэрэг үүгээр төгссөнгүй.

Өөрийн хөвүүн Цагадайд найман мянга, Өгөдэйд таван мянган иргэн өгснөөр зогсохгүй хэлгүй нялхаас хэвийх нас хүртлээ биеэ үрж бяраа баран зүтгэсэн дүү Хасартаа эр болж гэр бариад удаагүй Тулуй хөвүүндээ өгснөөс даруй мянгаар цөөн дөнгөж дөрөвхөн мянган иргэн хуваж өгсөн нь Өүлэн эхийн тэвчээрийг нэгэнт алдагдуулжээ. Чингис хаан үнэн сэтгэлээр,үг тайлбаргүй зүтгэсэн дүү нараа арай ч хялбар үзэж талийгаач дүү Хачиуны хөвүүн Алчидайд хоёр мянга, эх өөртэй дүү Билгүтэйд бүр мянга таван зуухан иргэн хуваан өгсөн байв. Өүлэн эх нь энэ бүгдийг дурдан бүрэн улсаа бүрдүүлж, бүтэн биеийг нь хамгаалж явсан дүү нараа дорд үзэж буйг ил шударгаар шүүмжилэн Бөртийн нүүрэн дээр зэмлэхэд үнэнд гүйцэгдэн хэлэх үггүй болсондоо Чингис хаан ингэж шаралхан уурласаар байжээ.

Мөн өөрийн хийсэн гавьяанд үл тохирох дөрвөн мянган иргэн өгснийг чамлаж уурсахдаа

–Их Монгол улсад надтай өрсөлдөж,намайг дийлэх хэн байна. Би юу хүссэнээ өөрийн чадлаар олж авахыг харагтүн гэж согтуу Хасарын агсамнан хашгирсныг мэдсэн тул Хасарын Тэв Тэнгэрт дарлагдсан гомдлыг сонсоод бүр ч хилэгнэж

-Чи хэнд ч дийлддэггүй хүн гэсэн биз. Одоо юу болов гэж тавласанд Хасар уурлан үүд шидэн гарчээ.

Хасарын хувьд үнэхээр уурсан, гомдохоор явдал олон болжээ. Өнчин балчираас аваад өргөн их улсыг байгуулах хүртэл харах нүдээ хамхилгүй, халуун биеэ амраалгүй зүтгэсэн түүнийг хаа холын хүргэд, харц боол гаралтай Зэлмэ, Боорчиос доогуур үзсэнд Хасар туйлын гомдолтой болсоор уджээ. Их улсыг байгуулж тунхаглаад зүүн баруун гарынхаа захирагчаар чухам Боорчи, Зэлмэ хоёрыг сонгосон нь тэсэвч тэвчихийн аргагүй хэрэг юм. Миний зүтгэл тэднийхээс юугаар дутна гэж бодох бүр Хасарын нугас тархи дүйрч,нуруу бие нь шархиртал гомдоно.

Өтөл муу Хөхөчүг өрөвдөн өршөөсөн нь зөвхөн Чингис хааны их нэр сүрийг бодсоноос болсон тул Хасарыг гомдох аргагүй ажээ.Тэмүжинд гомдох сэтгэл Хасарын бие сэтгэлийн

эдгэшгүй өвчин болсоор удсаныг Өүлэн эх мэдэж байв..

Өүлэн эх голын хайртай Хасар хөвүүнээ өмөөрөн дэмжиж Чингис хаанд гомдол санал хэлсэний учир энэ юм. Хасарын төлөө үг хэлж,өмөөрч тэмцэх ганц хүн бол Өүлэн эх билээ.

Чингис хаан болоод түүний эх, дүү нарын хооронд үүсэж өвсний түймэр мэт дүрэлзсэн хэрүүлийг Тэв Тэнгэр алган дээр тавьсан мэт тодорхой харж байлаа. Тэв Тэнгэр өөрийн чадал, ид шид, Чингис хааны олгосон өргөн эрх дархынхаа хүчээр одоо улсын дотор Чингис хаанаас дутуугүй өргөн нэрийг олжээ. Тэв Тэнгэрийн үг Чингис хааны зарлигтай адил хүчтэй болсныг тэр өөрөө мэдрэх бүр улсын эзэн болох угийн хүсэл улам ч тодорно. Чингис хааны хөвүүд Зүчи, Цагадай идэр залуу, Чингис хаанд үнэнч зүтгэж ивээгдсэн Боорчи, Зэлмэ нар хаан удамгүй харц гаралтай тул Тэв Тэнгэртэй өрсөлдөж үл чадна. Харин Тэв Тэнгэр өөрийгөө Тэмүжинг их сууринд суухад тэнгэрийн хүчээр хамгийн их тусыг хүргэсэн гэж үзнэ. Үүнийг Чингис хаан үл эсэргүүцдэг нь Тэв Тэнгэрийг омогшуулж, бас ах дүү нар нь хөөрөгдөн турхирч байв. Зарц Мэнлигийн юм үзээгүй хөвүүд ийн оодорч ахуйг Хасар аль эртнээс мэдэж,тэвчин сууж чадахгүй болжээ. Мэнлиг болоод түүний хөвүүдийг Хасар хэзээ ч тоож үзэхгүйгээр хүмүүжсэн нь Хасарыг тэдний хамгийн аюултай дайсан болгосон билээ.

Үүнийг Тэв тэнгэр тодорхой мэдэж байлаа.Гэвч Чингис хааны их алдар,сүр хүч, хүндлэл Хасар,Тэв тэнгэр хоёрын далд тэмцэл,зөрчлийг дарагдуулсаар уджээ.Гэтэл дайран дээр давс гэгчээр Хасарын албатуудаас Тэв Тэнгэрт дагаж очсон хэрэг гарсан нь бугласан битүү шархыг хага татан гадагш илрүүлсэн мэт хэрэг болжээ. Хамаг улс Тэв Тэнгэрийг дагаж, тэр бүү хэл отгон дүү Тэмүгэ ноёны захирах, хаан сангийн агтны хорооны албатууд хүртэл очсон нь Чингис хааныг бодолд унагав. Хаан эзнээ амьд сэрүүн ахуйд харц иргэд нь хаяж одно гэдэг Тэв Тэнгэрийн нэр сүр хэтэрхий их болсныг шууд гэрчилжээ.Гэвч тэднийг Тэв Тэнгэр булааж авсангүй, сайн дураар нүүсэн тул энгийн биш явдал гэдгийг Чингис хаан мэдэж байлаа.

Хүүхэд наснаас хүчээ өгч,хүчрийг даралцсан Хөхөчү ингэж Тэмүжинг хуучин шарх сэдрэх мэт шаналгаж эхлэв.Ийм хэрэг явдал болно гэж Тэмүжин дааанч санаагүй билээ.Ер хүмүүн гэгч дайн тулаангүй энх амар, тайван жаргалтай, өвчин зовлонгүй, өнөр баян амьдралыг хүсдэг болохыг тэр ойлгов. Энэ мөнхийн хүслийг биелүүлэгч гэж итгэсэн тул одоо Тэв Тэнгэрт очицгоох болов. Тэнгэрийн хүчний ивээл дор амьдрахыг хүн бүр л хүсч Тэмүжинийг улаан цайм орхин одох болжээ. Тэв Тэнгэрт Чингис хаанаас илүү их хүч байсны илрэл энэ байв. Тэв Тэнгэр нэгэнт Чингис хааны дайсан болжээ. Гэвч тэр зүгээр нэг сэлэм далайж, саадаг үүрсэн усан нүдтэй,цусан зүрхтэй дайсан биш юм. Хүмүүс Тэв Тэнгэрийн ид шид, их хүчинд итгэн тойрон хүрээлж байв. Ийм учраас Тэнгэрийн хүслийг дамжуулан уламжлагч Хөхөчүтэй Чингис хаан өөрөө нүүр тулан дайсагнан эвдрэлцэхээс зайлсхийх хэрэгтэй байлаа. Тэв Тэнгэр олон ардын сэтгэлд аврагч Тэнгэрийн дүрээр гүн шингэсэн тул улс гүрнээ сандрааж, ус мөрнөө цалгиулахаас эмээнэ. Чингис хаан ч өөрөө Тэв Тэнгэрт итгэн биширч, бас ч айх тул эрс хатуу тэмцэл хийж зүрхлэхгүй байсаар Мэнлигийн хөвүүдийг бүр оодруулсан ажээ. Одоо тэдний зан аашш,шунал хүсэл өөрсдөд нь ч захирагдахаас өнгөрчээ.Ингэж их Монгол улс дайнгүй амар суусан эхний жилдээ л тэнгэрт тэтгэгдэж, газарт ивээгдсэн хоёр хаантай мэт болов.

Чингис хааны өөрөөс нь айж болгоомжилсон байдлыг Тэв Тэнгэр ойлгож,ашиглахыг санаархаж байв.

Тэв Тэнгэрт их Монгол улсын хаан суух боломж түүнээс олон хувь давуу шунал хүсэл байлаа. Хонхотон овгийнхон хэзээ ч ийм алдар нэртэй,хүч чадалтай байсангүй. Тэмүжинг хаан суудлаас зайлуулж эзэн суух бүх боломж нээгдсэн мэт санагдаад өөрийн чадал ид шид, газар тэнгэрийн их хүчийг Тэмүжиний эсрэг хэрэглэхээр Тэв тэнгэр бэлтгэж эхлэв.

Гэтэл Тэмүжин урьдын адил Тэв Тэнгэрийн ид шидэнд жолоодогдохгүй болжээ. Учир нь түүнийг Монгол нутгийн нэг зуун ерөн найман савдаг сахиус хамгаалж байв. Чингис хааны хүзүүндэх зэв хэлбэрт сахиуснаас түгэх их хүч хараал хорлол үл нэвтрэх цайз болон хамгаалах тул Тэв Тэнгэр нэгэнт хүчин мөхөсдсөнөө мэдэж байсан ч далдын хүслээсээ ухарсангүй. Хэрэв Тэмүжиний хүзүүнээс тэр сахиусыг салган авч чадвал Тэмүжинг жирийн хүний адил үхүүлэх арга захаас аван замаас эхлэн олдох билээ. Хэрэв ийм сахиусгүй бол Тэмүжин мориноос унаад үхчихэд ч гайхах хэрэггүй юм. Гэвч энэ сахиусыг Тэмүжиний хүзүүнээс салган авах арга нэгэнт үгүй болжээ. Хамаг сүр сүлд,амь нас нь тэнгэрийн сахиусанд шингэснийг хэлж хэзээ ч биенээс салгаж болохгүйг аминчлан сургасан хүн нь Тэв тэнгэр өөрөө байв. Бас тэр сахиусанд хүрвэл хорлогдон үхэх аюултайг мэдэж байсан нь саад болсон ажээ.

Гэтэл их Чингис хааны биенд халдан сахиусыг авчрах зоригтон Монгол улсад нэгэнт үгүй байлаа. Чингис хааныг Боорчийн захирах торгон цэргүүд завсаргүй даган хамгаахаас гадна өргөөний нь үүдэнд хамгийн шилдэг үнэнч цэргүүд нүд салгахгүй сахин зогсдог билээ. Энэ бүх байдал өөр арга сүвэгчлэхийг Тэв тэнгэрээс шаарджээ.

Тэв тэнгэрийн дотор өөр хорон санаа боловсорч байлаа. Хэргээ бүтээхийн тулд Тэв тэнгэр хэнийг ч хайрлахгүй хауу сэтгэлтэй болжээ. Харин Тэв Тэнгэрийн хаан суух далд хүслийг хамгийн тод ойлгосон хүн бол Хасар юм. Ингэх учир түүнд байсан билээ. Улсын дотор Чингис хааны дараагийн суурийг гарцаагүй эзлэх ёстой атал шударга бусаар зайлуулагдаж гадуурхагдсан Хасар Чингис хаанд ойртон шадарлагч хэнийг ч байсан үзэн ядаж байв. Тэдний дотроос Есүхэйн удмын боол Мэнлигийн хөвүүн Хөхөчү ингэж их нэрийг олсон нь Хасарын хувьд хамгийн доромлолтой,тэвчишгүй хэрэг болжээ. Хасар бол эр зоригтой юунаас ч үл шантрах хүн тул Тэв Тэнгэр түүнээс яг галзуу нохойны адил айж байв.

Хасар хэзээ ч хаанаас ч хамаагүй ирээд зуугаад авч мэдэх галзуу нохой шиг хүн гэж Тэв тэнгэр үзжээ.

Хасар чухам юуны учир өөрийг нь үзэн ядаж байгааг ч Тэв тэнгэр тодорхой мэдэж байлаа.Түүнийг санаснаа хэрэгжүүлж улсын эзэн суухад Чингис хаанаас илүү саад тотгор учруулах хүн Хасар болжээ.Гэвч Тэв тэнгэр Хасартай олны нүдний өмнө зөрчилдөн тэмцэлдэхээс аль болохоор зайлсхийж байв.Хасартай муудалцах нь Тэв тэнгэрийн их нэрийг олны дотор унагахаас гадна ,тэр өөрийгөө зөвхөн Чингис хаантай эн тэнцүү гэж үзэх учраас Хасарын эгдүүцэл,эсэргүүцлийг аль болохоор тэсвэрлэн өнгөрөөж,үл тоомсорлосон дүр эсгэж байв.Ингэх нь хамгийн зөв арга байсан билээ.

Бас Есүхэйн бэлбэсэн эм Өүлэн Хасар хөвүүнээ илэрхий өмгөөлөн дэмждэг нь Тэв тэнгэрийг өөрийн эрхгүй болгоомжлоход хүргэжээ.Өүлэн бол Их Монгол улсын дотор хамгийн их нэр хүндтэй,нөлөө ихтэй эм билээ.Хасартай өрсөлдөн тэмцэх нь Өүлэнтэй дайсан болоход шууд хүргэх тул Тэв тэнгэр өөрийн эрхгүй айж байв.Ингээд олон хоногоор

бодож боловсруулсан хорон санаагаа хэрэгжүүлэх өдрийг сонгон авчээ. Чингис хааны хувьд хамгийн үнэтэй зүйл нь одоо хаан суудал, алтан ураг нь болоод байсныг ашиглаж ах дүү хоёрыг алалдуулахаар Тэв тэнгэр шийдсэн байв.

Чингис хааны үйлс хазайж,сэтгэл санааны нь эрч хүч буурсан час өдрийг сонгон авч хорт сум мэт үгээ хэлжээ.Шөнө нь өөрийн сахиусыг дуудан Тэмүжиний сэтгэл санааг бухимдуулах арга хийжээ.Чингис хаан тэр шөнө Хулан хатныхаа өргөөнд морилосон бөгөөд ялихгүй зүйлээс Хулан хатантайгаа марган хилэгнээд тавгүйрхэн нойргүй хоножээ.Түр зуур дуг хийсэн ч аль эрт үхэж үрэгдсэн Чилэгэр бөхийг зүүдлээд цочин сэржээ.

Энэ зүүднээсээ ихэд сэжиглэж тэр Чилэгэр бөхийг Хасарын гараар үхүүлдэг байж гэж ихэд харамсан бодсоор үүр цайлгажээ.Ингэж тавгүй хоносон Чингис хаан өглөө их уцаартай дээшилсэн тул урьд шөнө Бөртэ хатны тухай таагүй үг хэлж түүнийг хилэгнүүлэв гэж Хулан их айж эмээжээ. Ашгүй Чингис хаан тэр тухай үг сөхөхгүй цайлж дуусаад ямбаныхаа их өргөөнд морилжээ. Түүнийг тэнд Тэв тэнгэр хүлээж байв.

-Би урд шөнө дээд Тэнгэртэй ярилаа. Тэнгэр надад ийн хэлэв. Тэмүжин улсын эрхийг барина. Нэгэн удаа Хасар улсын эрхийг барина гэв. Хасараас эс болгоомжилбол юу болохыг хэн ч үл мэднэ гэжээ. Цагийг нь олж хэлсэн түүний энэ үг Чингис хааны зүрхэнд яг үхлийн сум шиг гүн зоогдохыг Тэв Тэнгэр харж байлаа.

Бүр Тэмүжиний дуу алдан ёолох ч сонсодсон билээ.Сэтгэлийнхээ гүнзгий цочролыг Чингис хаан гаднаа мэдэгдсэнгүй.Тэв Тэнгэрийн эл хортой үгийг огт сонсоогүй мэт суужээ.Тэмүжин огт тоохгүй бүр түүний хортой үгэнд хүний урманд хариу хэлээгүй өнгөрөөсөн нь Тэв тэнгэрийг өөрийн эрхгүй гайхашруулжээ.Тэмүжин хор шар,уур хилэнгээ ямар хүчээр тэвчин барьж байгааг тэр ойлгосонгүй.Зүрхэндээ үгэн сум тийм гүнзгийгээр зоолгочихоод огт ажиггүй суух нь Тэмүжинг хүмүүн биш мэт санагдуулжээ.

Тэв тэнгэр гэдрэг буцаж харимагц өөрийн хорон санааг гүйцэтгэхээр их түүдэг ноцоож догшин сахиусаа дуудан Тэмүжинг муу үйлд дагуулахаар илгээхээр шийджээ. Хэлсэн үг нь Чингис хааныг муу үйлд хөтлөж чадахгүй мэт санагдаад болсонгүй.Тэв тэнгэрийн хэлсэн үг Чингис хааныг аймшигтайгаар шархдуулжээ. Хасарын тухай Тэв тэнгэрийн хэлсэн нь Чингис хаанд цоо шинэ,цочмог санагдсангүй ч ганцхан өөрийнхөө дотор хадгалан нууж явсан сэжгийг Тэв тэнгэр ингэж батлан хэлсэнд маш их түгшин бодолд унав. Чингис хаанаас их мэдэл, эзэнт улсыг нь булаан авах хүчтэн бол ганц Хасар гэдгийг Тэмүжин хэнээр ч хэлүүлэлтгүй мэднэ. Хасарт ийм хүсэл байгаад ч итгэж явсан билээ. Гэтэл Хасарын энэ далд хүсэл Тэнгэрийн зарлиг байсан нь өөрийн эрхгүй айдас, сандралыг төрүүлжээ.

Удтал ганцаар сууж бодов. Алтан ургийн хөвүүдийнхээ ирээдүйн эрхийн төлөө Хасарыг үхүүлэх цаг гарцаагүй мэт санагдсаар байсан ч Чингис хаан шийдэж чадахгүй эргэлзсээр байлаа. Хэдий Хасарыг тэнгэр тэтгэж нэгэн удаа улсыг захируулна гэсэн ч өсөхдөө өгсөн тангаргаа тэр яавч эвдэхгүй гэж санасан тул Хасарыг юутай ч энэ удаа зүгээр орхихоор шийдэв. Учир нь Хасар улаан цайм эрх булаалдан дайсагнаагүй байв. Бас Өүлэн эхийнхээ сэтгэлийг эрх биш бодолцох ёстой ажээ. Гэтэл шөнө тэвчин хэвтэж чадсангүй. Хасарыг одоо л үгүй хийхгүй бол маргааш өглөө гэхэд л дийлдэшгүй хүчтэй болж өөрөөс нь хойш хөвүүдээс улсыг нь булаан авах мэт санагдаад тэвчилгүй босон харайжээ. Энэ бол Тэв

Тэнгэрийн илгээсэн сахиусны хүчинд автан муу үйлд дуудагдсан хэрэг юм. Хийвэл бүү ай, айвал бүү хий гэдэг үг байх тул яг ингэж хийхээр шийдээд Боорчийг дагуулан шөнжин давхисаар Хасарынд очив.

Нэгэнт өөрийн санаснаар хийв гэж бат итгэсэн Тэв Тэнгэр гэртээ өргөн ханзан дээр эгнэн хэвтсэн эмсээ ээлжлэн эдэлсээр үүр цайхад сая нэг онгод нь гарч тайвшран ядраад сэрэлгүй гурав хоног унтжээ. Түүний догшин сахиусны хүчинд автан Тэмүжин, Хасар дүүгээ хөнөөнө гэдэгт Тэв тэнгэр эргэлзсэнгүй билээ. Гэвч унтаж, унтаж сэрээд бүх зүтгэл нь талаар өнгөрснийг олж мэдмэгц хилэгнэн хавь ойрныхноо хядах шахжээ.

Хамгийн ойр байж таарсан Түбэгэн аймгийн бүсгүй Тэв тэнгэрийн гарт өртөн амиа алдав.Өөрийн эмсийн дотроос хамгаас илүү үзэн хайрлаж үргэлж дэргэдээ дагуулан энхрийлдэг бүсгүйгээ Тэв тэнгэр аймшигт хилэнд автсандаа хоолойг нь тас хазан хөнөөжээ. Ингээд ч тайвширсангүй.Нүүр ам,энгэр цээж нь нил цус болсон Тэв тэнгэрийн амнаас цувах хараал зүхлийн үгийг сонссон бүхэн айн зугатаж байхад Мэнлиг л хөвүүнээ ахин муу үйл хийхээс сэргийлэн дэргэд нь тэсвэрлэн үлджээ. Болохгүй бол уургалан авч эсгийд боон хүлж тайшруулахаар зэхэж байтал ашгүй Тэв тэнгэр шүтээнийхээ гэрт шурган ороод таг болжээ. Тарж зугатан яасан хүмүүс эргэн ирэв.

Гэвч Тэв тэнгэрийн шүтээний гэрт ойртон очих зүрхтэн үгүй байлаа. Хэлмэгдэн үхсэн бүсгүйн хүүрийг даруй нүднээс далд болгожээ.

Хасар амьд төдийгөөр барахгүй Тэмүжиний отгон дүү Тэмүгэ элч ирүүлж дагаж очсон албатаа буцаан явуулахыг Тэв Тэнгэрээс шаардсан байв. Чингис хааны сэтгэл тэнгэрийн хүчинд автаагүй нь түгшмээр явдал болжээ.Яагаад Хасар амьд үлдсэнийг, ямар гээчийн агуу хүч аварч тусалсныг Тэв тэнгэр ойлгож ядав. Мэргэлж үзээд ч мэдэж цөхөв. Чингис хаанаас дутахгүй эрх мэдэлтэй болсон Тэв Тэнгэрийн ах дүүс албатаа нэхэж өөрөө ирсэн Тэмүгэ ноёныг унтаж буй Тэв Тэнгэрт мөргүүлж, эмээлийг нь үүрүүлэн явган хөөж буцаажээ. Тэв тэнгэрийг унтаад сэрэхийн хооронд энэ мэт явдал болж Чингис хаан болоод Тэв тэнгэрийн хоорондох зөрчил тэмцэл огт санаандгүйгээр илрэн туйлдаа хүртэл хурцадсан байв.Тэв тэнгэр үүнийг мэдмэгц яаж ч хилэгнээд, ах дүүгээ буруушаан зэмлээд ч урсаж өнгөрсөн цаг хугацааг ухрааж буцааж чадахгүй болжээ. Тэв тэнгэр буруудсанаа ойлгов.

Өөрийнх нь их алдрын дор сагаж даварсан ах дүү нараа хараах муу үг тэр олсонгүй. Тэв тэнгэр болсон хэрэг явдлыг тунгаан үзээд даруй тэнгэрт мөргөн аврал тусламж хүсчээ.

Есүхэй эцгийн нь голомтын галыг сахин суугч отгон дүү Тэмүгэг нь Есүхэйн боол байсан Мэнлигийн хөвүүд ингэж доромжилсон нь шууд Чингис хааныг үл тоомсорлосон хэрэг, үнэн хэрэгтээ түүнээс илүү эрх мэдэлтэйгээ үзүүлсэн явдал байв.Мэнлигийн хөвүүд уучилж болшгүй алдаа хийжээ. Тэнгэр газар, од эрхэс, нар сарны тохиол шиг тэр өдөр Чингис хаан, Бөртэ хатныхаа өргөөнд хоносон билээ.

Өглөө Чингис хааныг дээшлээгүй байтал Тэмүгэ дүү нь орж ирээд уйлан байж Мэнлигийн долоон хөвүүн доромжлон гутааж хөөж явуулсныг хэлэв. Бүр Тэв Тэнгэрийн хөлд сөхрүүлэн мөргүүлэв гэжээ. Чингис хаан сонссон зүйлдээ цочирдоод тэр дороо хариу хэлж чадсангүй. Харин Бөртэ Тэмүгэг уйлахыг үзэж, хэлэхийг сонсоод өндийв. Тэмүжиний дүү нарын отгон

Тэмүгэг Бөртэ өөрийн хөвүүдийн адил үзэж бусдаас илүү хайрлан эрхүүлж өсгөжээ. Хайртай Тэмүгэ дүүгээ ингэж гутарч, уйлахыг хараад Бөртэ тэсэлгүй нулимсаа урсгав.

Тэр Хонхотныхон яасан

Тэрслүү хэцүү улс вэ.

Урд Хасарыг зодож занчихыг

Уучлан өнгөрөөсөн байтал

Одоо бас Тэмүгэг

Очсон хойно нь мөргүүлжээ.

Энэ ямар ёс вэ.

Юуны учир тэд

Ойн нарс мэт

Олон сайхан дүүгий чинь

Олны нүдний өмнө

Онцгойлж ингэж дарлана вэ.

Үүнээс хойш тэд

Үүл мэт биеийг чинь

Үгүй болж одвол

Үлдсэн их улсыг чинь

Үр хүүхдээр чинь мэдүүлэх үү

Сүүлийн цагт тэд

Сүлд гэгээн биеийг чинь

Сүүдэр болж одвол

Сүрэг их улсыг чинь

Сүйтгэхэд хүрэх биш үү

Өндөр уулын нарс мэт

Өнөр сайхан дүү нарыг чинь

Өшин дарлагч тэд

Өсөж бойжиж амжаагүй

Өчүүхэн хэдэн хүүхдэд чинь

Өргөн улсыг мэдүүлэхгүй биш үү

Ял зэмээс ч үл аюух

Яасан хэцүү хонхотон нар билээ

Өсгийг чинь даран унасан

Өнчин хэдэн дүү нарыг чинь

Өмгөөлж хамгаалах хүнгүй мэт

Өслөн дарлаж байхад

Өндөр заяат хаан чи

Өчүүхэн төдий ч зовохгүй юу

Ураг саднаа дарлуулж

Удамт алдраа гутаалгаад

Унхиагүй эм мэт суух ахул

Улсын хаан гэх үү, чамайг

Хаан Чингис чиний

Хаяаг чинь бараадаж

Хатавчийг чинь сахих учиртай

Харц муусайн боолууд биш үү, тэд

гэж Бөртэ хилэн,занал дүүрэн хашгирчээ.

Бөртийн ингэж хилэгнэн уурлахыг урьд нь хэн ч харсангүй тул нам гүм боллоо.Бөртийн ийн хашгирахыг гадаа зогссон харуулын цэргүүд,шивэгчин эмс бүгд сонсов.Бөртэ амьдралдаа анх удаа эр нөхөр Тэмүжинээ уурлан зандарсан нь энэ юм.

Бөртийн уур хилэн Чингис хааныг гэнэт ухааруулжээ. Бөртэ энэ үгийг Тэмүгэг уйлахыг үзээд сая санаж хэлсэнгүй. Сүүлийн жил, сард болж өнгөрснийг олон хоног бодсоны эцэст үнэн байдлыг зүгээр нэг өнгөрөөж нэгэнт болохгүй болсны учир хэлсэн хатуу үг байв. Айж ичиж, хийж зориглохгүй явсан энэ хэргийн учрыг шийдвэрлэх энгийн үнэн санааг Бөртэ Тэмүжинд ухааруулав. Харц Мэнлигийг хийсэн гавьяаг дурдалгүй,хөвүүн Хөхөчүг нь хүчирхэг бөө гэж тооцолгүй тэднийг хэрээс хэтэрч хаан эзэндээ халдсан боол мэт үзэж айж өрөвдөлгүй цээрлүүлэхийг Бөртэ ил тод шаардаж байв. Үүний цаана хойш тавьж болохгүй хаан суудлын нэр хүнд, хайртай хөвүүдийн нь ирээдүйн амьдрал,хамаг их улсын хувь заяа байгааг ч ойлгуулав. Тос дотроосоо өтвөл аюултай гэдэг энэ ажээ. Хар бага наснаас итгэж,үнэмшиж дассан үзэл,хүмүүжлээ сэтгэлийн дотроос авч хаях хэрэгтэйг Бөртийн шаардсан үг сануулж,бас ухааруулж байв.

Тэв Тэнгэрийн бөө гэдгийг мартах хэрэгтэйг Чингис хаан ойлгов.

Тэр бол Мэнлигийн хөвүүн Хөхөчү хэмээгч жирийн нэг албат боол биш үү. Түүнээс айж ичихийн хэрэг юу билээ. Нэгэнт үүссэн галыг Тэмүгэгийн гараар унтраалгах сайхан боломж нээгдсэнийг Чингис хаан гэнэт олж хараад Бөртэ хатныхаа цэцэн үгэнд бахдав. Сүүлийн сард ирээгүй Бөртэ хатныдаа энэ шөнө хонож,хагссан биеийг нь эдлэн жаргаасан нь лав Тэнгэрийн ивээснээр болжээ гэж итгэв. Хэрэв залуу гоолиг Хулан хатны өргөөнд байсан бол Бөртийн дайны үгийг Хулан хаанаас хэлэх билээ.

Тийм болохоор Бөртийн энэ үг бол Тэнгэрийн зарлиг биз гэж бодсон Чингис хаан орноос түргэн өндийж отгон дүүдээ:

-Би Тэв Тэнгэрийг ирүүлье. Харин чи яаж өшөөгөө авахаа мэд гэв.

Тэмүгэ хэдий отгон хөвүүн гэж Өүлэн эхдээ эрх өссөн алмай наазгай ч нэг зориглон дайрвал үхлийн цаана гарч төгсдөг эртэй хүн байв.

Тийм учир тэр Чингис хааны үгийг Тэв Тэнгэрийг үхүүл гэсэн үг гэж ойлгов. Үүнээс өөр арга нэгэнт үгүй болжээ.Чингис хаан тэр даруй Тэмүгэг дагуулан ямбаныхаа их өргөөнд орж хоюул удаан ярилцжээ.

Тэгээд ахмад хөвүүн Зүчийг Тэв тэнгэрийн хүрээрүү илгээв. Чингис хааны гэнэтийн урилга Хонхотны хөвүүд тэр дундаа Тэв Тэнгэрийг цочоон гайхуулав.

Чингис хаан өргөөндөө урьсан нь ер гайхаж бишүүрхмээр хэрэг биш боловч ойрын өдрүүдэд болсон олон явдал Чингис хааны сонорт хүрээгүй гэхэд итгэмгүй тул бүгд Тэв Тэнгэрийн үгийг хүлээцгээв. Тэв Тэнгэр шүтээнийхээ өргөөнд орж хонины дал шатаан мэргэлж үзэв. Чингис хаан өөрөө түүнд шууд хор хийх бодолгүй гэж буусан нь Тэв тэнгэрийг тайвшруулав.

Чингис хаанаас өөр түүнд хор хөнөөл учруулах зүрхтэн Их Монгол улсад нэгээхэн ч үгүй гэж бат итгэх тул айх зүйл байхгүй мэт.

Бас очихгүй цааргалах нь хардлага сэжгийг улам нэмэгдүүлэх аюултай учир очихгүй байх аргагүй болжээ. Гэвч Мэнлиг эцгийн муу санаалан хаширласан ёсоор Хонхотныхон

эцгийнхээ хамт ах дүү бүгдээр очихоор шийдэв.

Гэтэл Тэв Тэнгэрийн сэтэрт буурал морь хүн хүрээгүй мөрт цулбуур нь алдуурч тал руу давхин одсон нэг хэрэг мандав. Мэнлиг эцэг уурлаж агтчиныг занчив.

Энэ бол Тэнгэрийн сэрэмжлүүлсэн дохио болохыг Тэв тэнгэр ойлгов. Чингис хаан түүнд хор хүргэхгүй гэсэн атал Тэнгэр ингэж дохио ирүүлсэнд Тэв тэнгэр их гайхлаа. Одоо өөр хэн түүнд хор хүргэнэ.Хасар уу. Чингис хааны дэргэд Тэв Тэнгэрт үг хэлж, үйл сөргөх зүрхтэй хүн байхгүй биз.

Харин Чингис хаан Хасар дүүгээ өмөөрч үг хэлвэл түүнд хэлэх хариу бэлэн байлаа.

Тэв тэнгэрийн үгийг олон бүгдээр,түүний дотор Чингис хаан ч Дээд тэнгэрийн зарлиг гэж сонсох тул цугласан олны нүдэн дээр түүний хэлсэн үгийг Чингис хаан яагаад ч эсэргүүцэж чадахгүй гэж тэр тооцжээ.

Тийм учраас хэрэг явдал өөрийнх нь эсрэг эргэвэл:

-Чингис хаантан. Би танд Хасар дүү чинь улсын эрхийг хэн барихаар хулгайгаар санаархаж буй тухай Тэнгэрийн зарлигийг дуулгасан. Гэтэл та түүнийг эс биелүүлэв. Түүнээс хойш Тэнгэр хилэгнэж өөрийн зарлигийг сануулан дүү нарыг чинь надтай хэрэлдүүлэх болов. Дээд тэнгэр өөрийн зарлигийг хэрэгжүүлэхийг надаар дамжуулан шаардах боллоо.Та эс бол би Тэнгэрийн зарлигийн биелүүлсүгэй. Тэнгэрийн зарлигийг хэн үл дагана.Тэр хүн тэнгэрийн гэсгээлд унаж, улсаа алдаж үгүйрэх биш үү гэж хэлэхээр шийджээ.

Улсын эрх,хаан суудал бол Чингис хааны хамийн үнэтэй эрдэнэ,амин сүнс нь тул үүний төлөө Чингис хаан юугаа ч хайрлахгүйг Тэв тэнгэр сайтар мэдэж байв.

Үнэхээр Тэв Тэнгэр ийн хэлэх аваас Чингис хаан санаа шулуудан Хасарыг тэр бүү хэл Тэмүгэ дүүгээ ч цаазлахад бэлэн билээ. Ийн бодоход Тэв Тэнгэрт айх эмээх зүйлгүй санагдав. Дээд тэнгэрийн зарлиг,өөрийн сахиустаа итгэн, бардам зандаа хөтлөгдсөн Тэв Тэнгэр мориндоо мордов.

Замд гарсан хойно Мэнлиг эцгийн унасан морь чөдөртэй мэт догонцоод явж өгөхгүй зовоожээ.Гэтэл Мэнлигийн морины хөлөөс Агажур бөө,өчигдрийн үхдэг хайртай эмийнх нь сүнс ирж зууралдаад байгааг Тэв тэнгэр харжээ.

Унасан морь нь хий тушагдаад урагш гишгэхгүй байсанд Мэнлигийн сэжиглэх нь нэмэгдээд даруй буцахыг шаардав.

Харин Зүчийг мэлтийтэл харсаар Тэв тэнгэр байхад буцаж төвдсөнгүй.Хэрэв тэд зам зуураас буцвал Зүчийн үгийг сонссон Чингис хаан Хасарыг цэрэглэн мордуулж Хонхотныг даруулахыг Тэв тэнгэр таамаглаж байлаа.Яг ийм санааг тэр Зүчийн нүднээс олж уншжээ.

Тийм учраас даруй очиж Чингис хааныг Хасарын эсрэг турхиран хөдөлгөхөөс өөр аргагүй байв.Одоо ухарч буцах нь түүнд үхэлтэй адил гэж Тэв тэнгэр хатуу итгэжээ.

Тийм болохоор шившин даллаж, өнөө эцгийнхээ морины хөлийг тушсан сүнснүүдийг хөөн зайлуулаад цааш явжээ.Тэдний өмнө Зүчи өөрийн боол загасан нүдэт Татугийн хамт эргэн эргэн харж явав.Хонхотныхон буцвал тэд даруй морио давиран ухасхийн давхихад бэлэн ажээ.Учирсан байдлыг бодож үзээд Мэнлиг Хөхөчү хөвүүнийхээ үгэнд орж морио гуяджээ.Мэнлиг эцсийн эцэст Тэв Тэнгэрийн хүч чадалд итгэжээ. Гэвч бүх юм Тэв Тэнгэрийн бодож хүлээснээс огт өөрөөр болох ёстой байв.

Түүнийг Чингис хааны өргөөнд орж сөнгийн баруун этгээдэд сууж ч амжаагүй байтал Тэмүгэ үсрэн ирж заамдан аваад үүд рүү чирэв.

-Өчигдөр чи намайг наманчлуулсан бил үү. Одоо гарч хүчээ үзье гэж ТЭмүгэ хашгирч байв. Энэ бол Тэв Тэнгэрийн хувьд огт санамсаргүй хэрэг болов. Гэвч тэрээр бяртай, Тэмүгэгээс үл айх тул шууд л барицалдан авчээ.

Энэ мөчид түүнийг бөөгийн увидас, тэнгэрийн хүч биш зүгээр л Хөхөчүгийн унаган зан төрх жолооджээ.Гэнэт цочоовол хажуудаа байсан хүнтэй барицалдаж авдаг багын зан нь гэнэт өөрийн эрхгүй сэргэжээ. Тэд шууд л гэрт барилдаж эхлэхэд Тэв Тэнгэрийн малгай Тэмүжиний голомтын гал дотор дээш харан унасан нь харамсаад ч хожимдсон хэрэг байлаа.

Ганц Тэв Тэнгэрийн ч биш ер нь Монгол хүний хийморь сүр хүч нь малгай бүсэнд байх тул малгай нь гал дотор дээш харан унахад Хонхотныхон бүгд сүрдэн цочжээ.

Мэнлиг эцэг дүрэлзэх гал дотроос Тэв Тэнгэрийн малгайг улаан гараар шүүрэн авсан боловч малгайн оройны хүрэл зэвэнд шингэсэн сахиусны сүр хүч нэгэнт галын дөлөнд хийсэн одсон байлаа. Барилцаж авангуут бүхнээс түрүүлэн Тэв Тэнгэрийн малгайг гал руу дээш харуулан авч хаяхыг Чингис хаан Тэмүгэд хатуу сургаснаар тэр Тэв Тэнгэрийг заамдан авч нэг гараар малгайны нь бүчийг тас татан галруу шиджээ.Энэ бол Тэв Тэнгэрийг хор аюулгүй үхүүлэх ганц арга байв.

Өөрийгөө хялбар үхүүлэх энэ аргыг Тэв тэнгэр Тэмүжинд итгэн хэлсэн нь одоо түүний аминд хүрэх болжээ.Энэ нь хэдэн жилийн өмнө болсон яриа боловч Чингис хаан Тэв тэнгэрийн хэлснийг марталгүй санасаар тул өнөөдөр Тэмүгэд хэрхэхийг зааж хэлжээ.

Тэв тэнгэр хэдий ид шидтэй ч Чингис хаан Тэмүгүгийн гараар түүнийг хорлохоор зэхсэнийг тэр дааанч таасангүй.Бас ихэмсэг,бардам зан нь түүнийг үхэлд хөтлөн авчирав.

-Та нар гарч бөхийн хүчээ үзэгтүн гэж Чингис хаан бэлдсэн ёсоор хашгирав. Чингис хаан Тэв Тэнгэр хоёрын зөрчил ингэж хамгийн энгийн шударга тэмцэлдээний хэлбэр бөхийн барилдаанд шилжсэн нь Тэв Тэнгэрийн хорсол зүхлийг Чингис хаан өөрөөсөө зайлуулах арга,сайхан боломж байлаа.

Тэд зууралдан гарахад Тэмүгэгийн урьдчилан бэлдсэн гурван бөх тосон авч Тэв Тэнгэрийг эсэргүүцэх сэхээ өгөлгүй нурууг нь өвдөглөн хугалж алаад угсраатай тэрэгний үзүүрт хаяж орхив. Энэ бүхэн нүд ирмэх зуур болсон тул Мэнлиг болоод бусад ах дүүс нь гэрээс гарч ирж амжсангүй.

Харин Тэмүгэ буцаж орж ирээд

-Тэв Тэнгэр намайг доромжлон наманчлуулж байсан мөртөө одоо хүчээ үзье гэхэд баашлан босохгүй хэвтэж байна гэж хэлжээ. Хэрэг учир юу болсныг Мэнлиг хормын дотор тааж их дуугаар уйлж

-Уужим их газрыг

Довын төдий байхад

Уулзаж нөхөрлөсөн билээ

Усан их мөрнийг

Горхийн төдий байхад

Учирч танилцсан билээ

Гэтэл Тэмүжин чи юу хийнэ вэ гэж хашгирав. Тэр үед болсон хэргийн учрыг ойлгосон Мэнлигийн бусад зургаан хөвүүн Чингис хааныг дайран алахыг завдахад амжиж гэрээс гарсны хүчинд торгууд, хишигтэн цэргүүд бүслэн хамгаалж Мэнлиг тэргүүтэй Хонхотныг барьж хүлжээ.

Одоо тэдэнд ч үхэл нүүрлэв. Харин Чингис хаан Тэв Тэнгэрийн хүүрт хүрэхийг хориглож дээр нь гэр барьж орхиод тэр дороо буурь сэлгэн нүүн явжээ. Одоо Чингис хааныг Тэв Тэнгэрийн үхэлд хэн ч шууд буруутгах аргагүй болов. Тэмүгэ, Тэв Тэнгэр хоёрын хооронд үүссэн жирийн хэрүүл Тэв Тэнгэрийн үхэлд хүргэсэн мэт харагдахаар ажээ.Чухам ингэж бодсоноор болсон тул Чингис хаан хамгийн ойрын, хамгийн аюултай дайснаа дарж амрав.

Мэнлигийн бусад хөвүүд Тэв Тэнгэр шиг ид шид үгүй тул тэднээс айх аюул үгүй юм.Гэвч Тэв тэнгэрийн хүүр болон үлдсэнийг өөрийн нүдээр үзсэн атал түүнээс айх сэтгэл арилсангүй харин ч нэмэгдэх мэт болсонд Чингис хаан тайвширч үл чаджээ.

Жамухыг үхэхэд Чингис хаан ихэд харамссан бол Тэв тэнгэрийг үхсэнд ихэд айжээ.

Тэв тэнгэр үхсэн нь амьд байснаасаа илүү аймшигтай санагдаад одоо хаанаас ирж юу хийж хорлох бол гэж санагдаад нойргүй хонох болов.Энэ бол Чингис хааны урьд өмнө амсаж эдлээгүй зовлон байлаа. Тэв Тэнгэрийн хүүр хуучин бууцанд үлдсэн ч тэр амьд мэт санагдаад бүр гэрт орж ирэх нь үзэгдээд хоёр хоног Чингис хааныг амраасангүй билээ.Тэв тэнгэр Чингис хааны гэрийн үүдэнд суугаад час улаан нүдээрээ түүнийг гомдолтойгоор ширтсээр байгаа нь харагдаад хөөгөөд ч явахгүй бүр аргаа баржээ.

Гуравдах өдрийн шөнө Чингис хаан Тэв Тэнгэрийн хүүрийг үзэхээр очжээ. Бүдэг сарны хүйтэн хөх гэрэлд Тэв Тэнгэрийн хүүрэн дээр барьсан гэр нүднээ үхээрийн газрын өнгөтэй үзэгдэнэ.Чингис хаан зориглон очиж чадсангүй зайтай зогсжээ.Түүнийг зуун шилдэг торгон цэрэг хүрээлэн хамгаалж байв.Чингис хаан ямар ч дайснаас ингэж ширвээтэн айж байсангүй билээ.Түүний хажууд зогссон Боорчи энэхүү зэвүүн хүйтэн гэрэлд сүрдсэндээ зүрх нь түг түг

цохилж байжээ.

Гэнэт холгүй чоно улих нь Тэв Тэнгэр амилаад Чингис хааны ирснийг үзээд хашгирч байх шиг зэвүүн сонсдоно. Энэ дуунд Чингис хааны үс босож айсандаа нуруугаар нь түмэн шоргоолж гүйх шиг болов.Үзэгдэхгүй мөртөө чоно яг морины хөл дороос ульж,бүр сүрэглэн дайрах гэсэн мэт эргэн тойрон шуугилдсан нь дөрөө сэтэрч,жолоо алдуулмаар аймшигтай ажээ.Чоно нэг дор ийм олноор сүрэглэхгүй нь мэдээж тул энэ чононууд Тэв тэнгэрийн сүнс болох нь гарцаагүй. Тэгээд дэмий юмаар оролдов хэмээн өөрийгөө зүхэн даруй буцахаар шийджээ.

Гэрийн үүдийг сахигч цэргүүд байр байрандаа унтсан мэт суусаар байсан нь тэд бүгд үхсэн мэт санагдаад тэднийг дуудаж уулзахаа болив. Гэтэл Чингис хаан нүдэндээ үзсэндээ итгэхгүй зогтуслаа. Гэрийн тооныг бүтээсэн өрхний завсраар бүдэг хөх гэрэл цацарч байлаа.

Удалгүй хачин шуугих исгэрэх мэт чимээ гэрийн дотроос сонсогдоод бүтээсэн өрх сөхөгдөж түүгээр өнөөх үхлийн хөх гэрэл урсан гарч иржээ. Зулзган лууны дайтай хөх гэрэл тэнгэрт хөөрч хэдэн алд сунаад төгсгөл нь тоононоос салан эргэлдсээр яг л бүргэдэд шүүрүүлсэн могой адил атиралдсаар дээш хөөрч удалгүй оддын дунд шингэн үзэгдэхгүй болов. Дараа нь чоно ч улихаа больж эргэн тойрон нам гүм,тас харанхуй болов.Тэнгэрт ёлтойж байсан сар хүртэл бамбар адил унтарчээ.Чингис хаан санаа амран тайвширлаа. Тэр Тэв Тэнгэрийг эргэн ирэхгүйгээр одохыг үзсэн тул гэрлүү очиж үүдийг нээлгэв. Үүд дараастай, бас хүн холдолгүй сахиж суусан тул итгэв. Үнэхээр Тэв Тэнгэрийн хүүр үгүй болжээ.

Тэр тэнгэрт гарахдаа хүүрээ хүртэл чирч явжээ. Тэв Тэнгэр үнэхээр тэнгэрийн үгийг сонсож,зарлигийг уламжлагч байсанд Чингис хаан сая л нэг чигт сэтгэлээр итгэв. Энэ итгэл нь өөртөө эргэлзээгүй итгэхэд хүргэв. Одоо Тэнгэрийн өмнөөс үг хэлэх эрх ганцхан Чингис хаанд үлдсэн нь тодорхой байлаа. Маргааш нь Мэнлигийг хөвүүдийнх нь хамт суллан өөрийн өмнө ирүүлэв. Нар тусаж тэнгэрийн өрхөнд тогтсон малгайн чинээ үүлнээс нялх бороо шиврэх нь Тэв Тэнгэрийн харууслын нулимс байлаа.

Мэнлигийг ирмэгц Чингис хаан догшиноор шүүмжлэн хэлэв.

-Мэнлиг эцэг та сонс. Та хөвүүдийнхээ авир аашийг ятгахгүй байсаар тэд чинь миний дүү нартай тэмцэлдээд Тэв Тэнгэрийн толгойг алдлаа. Таныг ийм зан гаргахыг мэдсэн бол аль эрт Жамуха, Алтан, Хучир нарын адил болгох байв. Гэвч би өсөхөөс зүтгэсэн сэтгэлийг чинь бодож есөн удаа ялнаас хэлтрүүлье гэсэн. Би яаж өглөө хэлснээ үдэш эвдэнэ. Тэгвэл би яаж хаан болно. Урьд хэлснээ хатуу барьж өршөөе. Авир ааштай явсан бол Мэнлиг эцэг таны урагтай эн тэнцэх хэн билээ.Уг нь хөвүүдээ засч хүмүүжүүлж чадаагүй Мэнлиг эцэг таныг хожим хойчид сургамж болгон хороох ёстой юм.Гэвч би өөрийн зарлигийг санаж,эрт цагт миний өмнөөс амиа үрсэн Чирха эцгийг чинь бодож амьд үлдээе.Үүнээс хойш хичээгтүн.Осолдвол надад бүү гомдогтүн гэж тэнгэр эвхэрч, газар хотойтол хэлэв.

–Тэмүжинтэй тэмцэх нь Тэнгэрт авирахтай адил гэж сана.Таны хөвүүд миний дүү нарт гар хүрч, хоорондн нь хутган эвдрэлцүүлэх хорт муу үг хэлсэн тул Тэнгэрийн таалалд эс нийцэж Хөхөчүгийн амь бие хоёрыг Тэнгэр авч одлоо гэжээ. Энэ бол Тэнгэрийн өмнөөс хэлсэн Чингис хааны хатуу үг байлаа. Хөхөчүг тэнгэр авч одсоноос хойш Мэнлигийн хөвүүд

номхорч, харин Чингис хааныг тэнгэрийн элч хэмээн олон бүгдээр итгэн хүрээлж Их Монгол улс ил тодоор цорын ганц Чингис хаан эзэнтэй болжээ.

Тэв Тэнгэрийн түүхээс сургамж авсан Чингис хаан алтан ургийн хөвүүдээ дуудаж хожим хойно шидтэй зайран хэнийг ч болов төрийн хэрэгт хутгалдуулж хэтэрхий нүүр өгөхөөс сэрэмжлэн явахыг зарлиг болгожээ. Үүнээс хойш Их Монгол улс даяар,иргэд албат бүгдээр Чингис хааны үгийг Тэнгэрийн зарлиг хэмээн сонсож дагах болжээ. Цэрэг засаж төрийг жолоодох нь нэг хэрэг, харин түмний сэтгэл, оюун санаа, итгэл үнэмшилийг эзэмдэн дагуулах нь ямар их хүч болохыг сайтар ойлгосон Чингис хаан энэ явдлаас хойш олон ардын сэтгэл санааны байдалд ихэд чухалчлан анхаарах болжээ.

Ардын сэтгэл амар тайван, хаандаа итгэлтэй байвал улс төр бэхжин, олны хүчийг төгс авах учрал бүрддэг ажээ. Тэв Тэнгэр өөрт нь байхгүй Тэнгэрийн их хүчийг мэдрүүлж, Тэнгэрийн хүчийг үзүүлсэн ч, яаж хэрэглэхийг зааж өгсөнгүйгээр одсон нь даанч харамсалтай ч түүнийг нэгэнт үхүүлсэн хойно хэлсэн болгонд нь үнэмшин итгэж байв.Хөхөчү Их хаан болно гэж хэлснээр тэр их хаан болов.

Ер түүний хийсэн тусалсан бага биш. Найманы Таян ханы цэргийн дээрээс их цас хүйтэн салхи шууруулж хясаа руу нураан унагаж сүйрүүлэхийг ганц Чингис хаан биш бүгд л харсан билээ. Тэв Тэнгэр шиг бөөтэй байхад аливаа дайсан аюултай биш юм. Гэвч өөрөөсөө илүү хүч чадалтай нөхөртэй байна гэдэг хол байгаа хоёр дайснаас ч илүү аюултай болохыг сая мэдэв. Их улсыг байгуулах нь эцсийн хүсэл байсан биш үү. Гэтэл их улсыг байгуулж,энгүй эрхийг олмогц ижилдэж явсан итгэлт нөхөр,ихэр мэт төрсөн дүү нь дайсан болон хувирч байгааг Чингис хаан ойлгов.Хасарын тухай хэлсэн Тэв тэнгэрийн үгийг үнэн гэж итгэнэ. Өвдөж хэвтэх завгүй,өлсөж суух цаггүй явж,ядарч явж,зүдэрч байгуулсан их улсынхаа жолоог өөрийн хөвүүдээс тэр дундаа Бөртэ хатны хөвүүдээс өөр хэнд ч өгөхийг тэр үл хүснэ. Үүний тулд их хаан болмогц нэг цусны дүү нараа төрийн чухал хэргээс хол байлгахыг эрхэм болгосон нь зөв болжээ.

Энэ бол тэр нэгэн шөнө мөн л Тэв Тэнгэрийн хэлсэн үг билээ. Одоо түүнтэй улсын дотор өрсөлдөх нь Тэв Тэнгэрээс хойш ганц Хасар л үлджээ. Хасар бол Тэмүжинээс бяр ихтэй, мэргэн харваач, бас бичиг үсэг мэдэх, ер чөтгөр шиг хүн билээ.

Түүний өөртөө итгэлтэй, бардам зоримог аашийг хэн ч хориглож үл чадна.

Бас Өүлэн эх өөрийн өндөр нэр хүндээр Хасар хөвүүнээ өмгөөлөн хамгаалах нь Чингис хааны хэлэх үг, хөдлөх гарыг хорих бүлгээ.

Түүнээс биш Хасарыг үхүүлэхэд айх ч юм үгүй, бас Хасар үхэв гээд хохирч гачигдах юм өчүүхэн ч үгүй билээ.

Өүлэн эх үгүй бол Хасарыг үхүүлэх олон шалтаг Чингис хаанд аль эрт олдох байв. Эхийн нүд бүлтийтэл харж байхад яаж Хасарыг үхүүлж чадах билээ.

Хар нялхаас эцэггүй өнчирч ганц Өүлэн эхийнхээ хайр халамж,хатуу сургаалийн дор хүмүүжиж өссөн нь Чингис хааныг эхийгээ хүндэтгэх гүнзгий сэтгэлтэй болгосон билээ.Тэв

тэнгэрийн хорт үгэнд итгэн,хүчит сахиусанд хөтлөгдөн Хасарыг алахаар очоод амжиж ирсэн Өүлэн эхийгээ үзмэгц айж буцсан нь Өүлэн эхийн үрээ гэсэн сэтгэл Дээд тэнгэрийн хүслээс илүү хүчтэйг гэрчилнэ.

Өүлэн эх нь яг цагаа олж амжин очоод Хасарын амийг Тэмүжиний гараас булаан аварсан нь Дээд тэнгэрийн зарлиг биз гэж Чингис хаан бодоод тайвшран Хасарыг өршөөхөөр шийдсэн билээ.

Өүлэн эхийгээ харж байхад,амьд сэрүүн ахуйд Хасарыг алж болохгүйг,бас алж чадахгүйгээ Чингис хаан ингэж өөрөө үзэж мэджээ.

Үрээ хайрлах эхийн сэтгэл Дээд тэнгэрийн зарлиг,хүсэлтэй эн тэнцүү бүр илүү хүчтэй болохыг Тэв тэнгэр мэдэхгүй байсан нь түүний үхлийн шалтгаан байлаа.Өүлэн эхийн үрээ хайрлах сэтгэлийн далд совин туслаагүй бол Есүхэйн хөвүүд хоорондоо алалдан ертөнцийн шившиг болох байв.

Түмний шившиг болоод ч зогсохгүй байгуулсан их улсын жолоог Тэв тэнгэрийн гарт алдаж ужгирсан дайн самуунд нэрвэгдэн монгол үндэстэн мөхөх байв.Тийм учраас Тэмүжин Өүлэн эх болоод Бөртэ хатныхаа ухаан сэтгэлд талархах ёстой болжээ.Гэвч Чингис хаан болж өнгөрсөн бүгдийг ганц өөрийн гавьяанд тооцжээ.

Тэмүжин мэргэдийн Чилэгэр бөхийг үхүүлсэн мөчөөс эхлэн бардам зангийн өвчинд хэзээ ч эдгэхгүйгээр нэрвэгдсэн билээ. Мэнлигийн хөвүүн Хөхөчүгийн мэдэж чадалгүй үхсэн бас нэг учир байв.Энэ нь түүний үргүй байсан явдал юм.

Хөхөчү хөвүүнээ мөнх наслах юм шиг итгэж,түүнээс илүү хүчтэн энэ хавтгай газар дээр байхгүй мэт сэтгэж явсан Мэнлиг хөвүүнээ үхсэнээс хойш хоол унднаас гарч яг л хар даран зүүдэлж байх шиг хэдэн сарыг элий балай өнгөрөөжээ.

Харин Өүлэнг ирж уулзсанаас хойш сая л нэг эргэн тойрноо эрүүл ухаанаар харахтай болов.

Хөөрхий Хөхөчү хүүгээ Тэнгэрийн элч гэдгийг мэдэлгүй балчир насанд нь элдвээр гоочлон зодож занчдаг байснаа санах бүр голоо тасартал гомдон харамсах болжээ.Хөвүүн минь эцэгтээ яасан их гомддог байсан бол гэж санахаар үхмээр хүсэл төрнө.Мэнлигийн гомдол харамслыг тайтгаруулах ганц зүйл нь Хөхөчүгийн олон эмсээс үр үлдээсэй гэсэн горьдлого байлаа.Мэнлиг шөнө бүр тэнгэрт мөргөн гуйсан боловч Хөхөчүгийн олон эмсээс нойтон сормуустай үр унасангүй жил тойрч эцэст нь тэр хорвоогийн гашуун үнэнтэй эвлэрэхээс өөр аргагүй болов.Газар тэнгэрийн их хүчийг эзэмшсэн бөө,ид шидтэнгүүд ихэвчлэн үргүй байдаг нь тэнгэрийн хүсэл болохыг Мэнлиг даанч мэдсэнгүй.

Тэнгэр өөрийн хүчийг хүний мэдэлд үүрд шилжүүлэн алдахгүйн тулд ингэдэг бүлгээ.Ид шид,далдын их хүчийг Дээд тэнгэр соёрхон хуваах болохоос хэн ч хэзээч эцэг эхээс зүв зүгээр өвлөн авах учиргүй ажээ.Мэнлиг Өүлэний хэлсэн үгийг олон хоног боджээ. Эцэст нь Тэмүжинийг үүрд дагахаар шийдэж,энэ тухайгаа Өүлэнд хэлсэн билээ.Тэв тэнгэрийн үхсэний дараа түүний албат иргэдийг Чингис хаан хураан авч Тэмүгэд өгчээ.

Мэнлиг үлдсэн хөвүүдээ бодон Хөхөчүг үүрд мартахаар шийдэв.Үүнээс өөр зам түүнд үлдсэнгүй.Тэв тэнгэрийн сахиус,бөөгийн эдлэл хэрэглэлийг Мэнлиг Бурхан халдуны ян их байцад хүний нүднээс далд газар онголон тахисан бөгөөд ингэх нь Монголчуудын эртний ёс билээ.Бас өнөөх гүү гишгүүлж байсан жүчээг шатаажээ.Тэв тэнгэрийн эдлэж хэрэглэж байсан бүхнийг нүднээс далд болговол сая нэг санаа амрах мэт санагдсан тул Мэнлиг ингэж хийжээ.

Бусад хөвүүд нь ч үүнийг эсэргүүцсэнгүй.Хөхөчүгийн эмсийг Мэнлиг хөвүүддээ хуваан өгөв.Харин богино настай Хөхөчү хөвүүнийхээ ачаар Мэнлигийнхэн хүнээс гуйхааргүй баяжжээ.

Чингис хаан хэлсэндээ хүрч Мэнлиг болоод түүний хөвүүдийг дахиж ер хялайж харж,харилхаж хатуурхсангүй.

Чингис хааныг ингэж шийдэхэд Өүлэн эхийн нь хэлсэн үг хүчтэй нөлөөлсөн билээ

Гэвч Чингис хаан энэ тухай хэнд ч мэдэгдсэнгүй.

Ерөөс Өүлэн эх нь Мэнлигт онцгой дотно ханддаг учрыг Тэмүжин тааварлаж мэддэг ч ингэлээ гэж эхийгээ буруушаан үздэггүй байв.

Өүлэнд Мэнлигийг дотночилон үзэх шалтгаан үнэхээр байсан юм.Үүний далд нарийн нууцыг ганц Өүлэн л өөрөө мэдэх билээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ӨҮЛЭН

Хабул хааны ач,Бартан баатрын хөвүүн Есүхэй баатрын гэнэтийн үхэл Боржигон аймгийн задралаас авахуулаад албат иргэдийн зовлон гуниг дүүрэн амьдрал хүртэл олон олон явдлын эх шалтаг болов.

Тэдгээрийн дотроос таван балчир хүүхдийнхээ хамт өнчирч, удалгүй унаган албат иргэддээ хаягдан хоцорсон Өүлэн хатан хамгийн их гамшгийн амссан юм.

Боржигон аймгийн хүчинд автан олон жил тэдний дор захирагдан суусан тайчууд,жүрхэн гээд олон овог аймаг толгой даан салж одсон нь зөвхөн ганц Есүхэйн үхэлтэй холбоотой биш ч гэлээ үнэнхүү Тэнгэрийн гэсгээл гэмээр амьдрал Өүлэнг тоссон билээ.

Эрт багын амьдрал нь Өүлэний хувьд хамгийн аз жаргалтай байжээ.Эргэх цагийн эрхээр хүүхэд хонгор нас нь нэг л мэдэхэд элэн одоод эхийн өвөр эцгийн гэрээс холдож эрийн энгэр түшихдээ ч Өүлэн гуниж харамсаагүй юм.Хайртай дуртай сэтгэлд дотно хүн нь түүнийг аваль эмээ болгон авах ховор аз түүнд тохиосон бөгөөд тэр нь мэргэд аймгийн их Чилэдү хэмээх булиа сайхан биетэй, зөөлөн хонгор ааштай, уяхан сэтгэлт эр байв.Хоёр хүүхдээ нийлүүлж удам угсаагаа үргэлжлүүлэхийг эцэг эхүүд нь дэмжин сайшаажээ.Хайртай эрдээ очих ховор аз тохиосон Өүлэнгийн тухай хавийн эмс охид ам хуурайгүй шагширч атаархан магтсаар түүнд олны цагаан хэл ам хүрчээ.Уг нь учрыг мэдээд гэр бүл болохоо сайтар нууцалсан бол тэд аз жаргалтай амьдрах байв.Тэднийг Тэнгэр ивээсэнгүй.Дэндүү санаан зоргоор хүн бүрийн атаархалыг төрүүлсэн хувь заяа нь Өүлэнд ямар аймшигт бэлэг бэлдсэнийг тэр үед хэн нь ч таасангүй.

Бүсгүй заяагаа даган Өүлэн хүний нутагт очих өдөр иржээ.

Гэтэл Мэргэд аймгийн нутаг Сэлэнгэ мөрний адагт их Чилэдүгийн гэрт хүрч амжаагүй явтал Боржигон аймгийн Есүхэй гэгч зэрлэг догшин эр болжмор шүүрэх бүргэд адил довтлон ирээд аваль эр Чилэдүг нь айлган хөөж,Өүлэнг булаан аваачаад хүчээр эзэмдэн эхнэрээ болгожээ.

Хайртай Чилэдүгээс хагацсандаа гансран шаналж олон ч хоног сэвлэгээ хийсгэн уйлсан боловч аврал ирсэнгүй билээ. Эм хүн, цагаан зээр хоёр нутаггүй гэдэг болж Тэмүжин хөвүүнээ төрмөгц Өүлэн энэ амьдралдаа үнэнч зүтгэхээр хоёргүй сэтгэлээр шулуудсан юм.

Өүлэн жирийн нэг сул эрд булаагдсангүй.

Монгол аймгуудын дунд зартай баатар эр Боржигон аймгийн Есүхэйд тоогдсондоо бас ч үгүй бахархаж, олны хүндлэлд тайтгаран харин ч Хасар хөвүүнээ төрсний хойно мэргэдүүд өөрөөс нь болж дайн самуун үүсгээгүйд баярлах болжээ.Тийм учраас их Чилэдүг эргэн ирээгүйд дотроо сэм талархах болсон билээ. Гэвч хэргийн учир их Чилэдүд биш харин Есүхэй баатарт байлаа. Их Чилэдү бол Мэргэд аймгийн дотроо нэр хүнд, эд хөрөнгө их биш тул хэн ч түүний төлөө цэрэг хөдөлгөн зориг хүч төгс Есүхэйтэй дайсагнахыг хүсээгүй байжээ.Их Чилэдү угийн номхон томоотой хүн учир өөрөө ч зориглон хөдөлж чадсангүй нь Өүлэнг Есүхэйн гэрт тайван амьдрах болгожээ.Боржигон аймагт ирснээр Өүлэн аз жаргалтай байлаа.

Тэмүжин, Хасар, Хачиун,Тэмүгэ дөрвөн хөвүүн төрүүлж Есүхэйн удамд дархлагдав.

Тэмүлэн охинтой болсон нь бүр ч баясгалан болов. Гэвч гэнэ гэнэ их Чилэдүгийн зөөлөн бор нүдийг санах бөгөөд тэр бүрийд өөрийн эрхгүй салаа гэзэгнийхээ зүүнийг эгэмрүүгээ унжуулж санаа алддаг билээ. Мэргэдийн тэр уян ааштай залуутай жаргалтай амьдрана гэж санасан юм.

Хэн нэгэн ингэж аз жаргалыг нь булаан авна чинээ санаагүй залуу эр эм хоёр хэдий зуны найртай цэцгийн улирал гадаа хээр хоюулхнаа боловч эгмээ нийлүүлж эрхтэнээ золгуулж ч чадалгүй дэмий л инээмсэглэн ширтэлцэж явсаар хүрэл царайт Есүхэйтэй учирсан билээ.

Есүхэй олзны гоо эмээ гэртээ авчирмагц тэр дор нь нүцгэлээд эдэлж үзвэл Өүлэн охин зүстэй онгон биетэй байсанд ихэд бэлэгшээн чухам Тэнгэрийн хишиг гэж тоожээ.

Хэрэв булаан авсан эм нь онгон биегүй байсан бол Есүхэй түүнийг дүү нарынхаа нэгэнд нь өгч орхих байжээ.Өүлэн Есүхэйд ирээд дараалан дөрвөн хөвүүн төрүүлсэн нь чухам Тэнгэрийн хишиг гэдэг нь үнэн болохыг баталсан юм. Хөвүүн төрүүлнэ гэдэг эм хүнд олдохгүй хувь заяа бөгөөд энэ явдал Өүлэний нэр нөлөөг Боржигон аймгийн дунд бэхжүүлжээ. Гэтэл үүлгүй тэнгэрээс үер асгарч үзүүртэй мод булгаран унах шиг Есүхэй гэнэт татаарт хорлогдон үхэв.

Тал нутгийн нүүдэлчин омгийн амьдралд адууны эрэлд яваад алагдах нь энүүхэнд хэрэг боловч бүтэн нэртэй Боржигон аймгийн хан баатар Есүхэйн гэнэтийн үхэл арай ч хэрээс хэтэрсэн явдал байв.Гэвч Есүхэйн гэнэтийн үхэл Хиад Боржигон аймгийн хуурамч нэгдэл, ёс төдий эвлэрэлийг эвдэн хаяжээ.

Угаас аймгийн эрхийг барихын төлөө далдуур өрсөлдөгч олон байсан нь Боржигон аймгийг бутраав.Энэ нь Есүхэйн залгамжлагч тодроогүйгээс биш, харин хүч тэнцүү олон өрсөлдөгч байснаас болсон билээ. Хамгийн эхлээд Боржигон аймагт хүчээр нэгдсэн Тайчууд өнийн хүслээ гүйцээж салан одов. Дараа нь Есүхэйн өнчин нялх хөвүүдийг дагаж явах нь хүчтэй нэгний олз болох аюултай тул үлдсэн албатууд нь өөрийн садан төрлийн Жадаран аймагт очив.

Одоо Өүлэний дэргэд үнэнч зарц Чирха өвгөн,түүний хөвүүн Мэнлиг гээд харц хамаатан цөөн айл хоцров.

Тэдний дотроос Чирха өвгөний хөвүүн Мэнлиг бол үлдэх ёстой хүн юм.Учир нь Есүхэй үхэхдээ өөрийн ургийн унаган харц Мэнлигт Өүлэн болон хөвүүдээ асрахыг даатган гэрээслэсэн билээ.

Их бага хоёр хатнаа Мэнлигт асрахыг гэрээсэлсэн нь тэднийг эм болгон өөрөө авахыг зөвшөөрсөн хэрэг ч Есүхэй ингэж хүсээгүй юм. Гэвч үхэл түүнд өөр сонголт үлдээсэнгүй.

Нүд бүрэлзэн амьсгал хураах үедээ бачимдан хашгирах цагт Есүхэйн дэргэд агтач Мэнлиг хэмээх залуу эрээс өөр хэн ч байсангүй. Ард үлдэх Өүлэн, Сочигал хатдаа нялх хөвүүдээ хэн нэгэнд захиж хэлэхгүйгээр яаж үхэж болох билээ.

-Дэргэд минь хэн байна.

-Би Чирха өвгөний хөвүүн Мэнлиг байна. Бүрэлзсэн нүдэнд Мэнлигийн царай цаана наана болж манарч үзэгдэнэ. Гэвч түүнийг тоохоос өөр арга цаг үлдсэнгүй нь харамсалтай.

-Хүү минь Мэнлиг чи сонс. Хөвүүн минь балчир байна. Тэмүжин хөвүүнийг урагт хүргээд буцах зуур татаарт хорлогдов. Дотор муу байна. Өнчин хоцорсон дүү нараа, бэлбэсэн бэргэдээ асрахыг чи мэд. Тэмүжин хөвүүнийг даруй явж авчир. Хайрт Мэнлиг минь. Энэ бол Есүхэйн сүүлчийн үг байв.

Ид хүчтэй идэр насандаа татаарын өгсөн хорт идээнд хорлогдон үхсэн нь даанч харамсалтай бөгөөд Есүхэйн нулимст нүд уур хилэн гэхээсээ илүү уй гашуу дүүрэн байв. Есүхэйн сүүлчийн гэрээс үгийг Өүлэн,Сочигал нар сонссон билээ. Гэвч тэр үед тэд уйлахаас өөрийг хийж эс чадав. Харин Мэнлигт Есүхэйн үг Тэнгэрийн цааз юм.

Мэнлиг эзнийхээ гэрээслэлийг бат санан Өүлэний хаяанаас холдохгүй байсаар ганц гэрээр үлджээ. Мэнлиг бол Өүлэнээс насаар хэд дүү бас олон нялх хөвүүдтэй хүн билээ. Эцэг Чирха нь Өүлэнийг хаяж нүүж буй албат зарц нарыг буцаах гэж ятгаж очоод тайчуудын Таргудайд жадлагдан шархаа даахгүй үхсэн нь тэднийг улам ч дотносон ойртуулжээ.

Есүхэйн үхлийн дараа Өүлэний бүх амьдрал санаанд оромгүйгээр хувиран өөрчлөгдөв.

Мэнлигийнх Өүлэний хамт нүүж суусаар хэдэн сар болов.Хот айлын дундах ганц эрийн ёсоор хэдий харц ч гэлээ хамаг эрх мэдэл аажмаар Мэнлигийн гарт шилжсэн нь Өүлэний сэтгэлд нийцсэнгүй.

Гэвч яаж ийгээд л эр хүн тул давуу байдалтай болсон билээ. Өүлэний хуучин цагийн нэр сүрээс юу ч үлдсэнгүйгээр барахгүй Мэнлиг түүнийг асран авсан эрийн ёсоор шөнө ирж өвөр түрийг нь маажих болжээ.

Хэдэн шөнө дараалан дур хүсэлдээ тачъяадаж шатсан Мэнлигийг өврөөсөө хөөн гаргаж дийлсэн боловч харц зарцдаа хаяж одсон Есүхэйг хараан зүхэж гашуунаар уйлж нойргүй хонодог байжээ.

Зарцдаа эдлэгдэнэ гэж санахаас ой гутаж үхмээр.Харин Мэнлиг шөнө ирэхээ гэнэт больжээ. Бүр сар ирсэнгүй. Өдөр айраг тараг гэж орж гарах боловч Өүлэнг ер эм хүн гэж тоож үзэхгүй болсон нь хачирхалтай байлаа.

Гэтэл хөвүүд загасанд явсан намрын өдөр Өүлэн нэгэн явдлыг үзэж сэтгэл санаа нь дэнслэв.

Эзэнгүй хот айлын хойдох Есүхэйн нөгөө хатан Сочигалын гэрээс гэнэт янаглан яраглах эмийн дуу ихээр гарахыг дэргэдүүр нь өнгөрч яваад сонсож тэсэлгүй гайхан тотгоор нь очиж шагайжээ. Дүрэлзэх галын цаана хоймрын ширдэг дээр мөнөөх Мэнлиг залуу биеийн эр чадлыг гайхуулах шиг Сочигалыг дуу алдуулан эдэлж байхыг үзжээ. Мэнлигийн таг чиг болсны учир энэ ажээ. Өүлэн даруй зайлан явж гэртээ оров.

Саяын үзсэн дээрх явдал түүнийг ингэж олон зүйлийн эрээн бодолд унагаж нойргүй хонуулна чинээ санаагүй билээ.

Есүхэй үгүй болоод жил өнгөрсөн тул эм бие нь эрийг хүсэмжлэн хагсарч гундсаныг хамгийн түрүүн мэдэв. Энэ үед Өүлэн дөнгөж гучин нас өнгөрч байлаа.

Нүдээ аних бүр Сочигалын тэсч ядан тачъяадан гиншиж байсан нь үзэгдээд Мэнлигийн залуу идэр,булчин шөрмөс зангирсан бие өөрийн эрхгүй хүсэгдээд бүр хамаг сэрлийг өдөөн тарчлаах ажээ. Өөрийгөө эрийг ингэж ихээр хүсэмжлэнэ чинээ санасангүй билээ.

Нөгөөтэйгүүр зарцтайгаа шалигласан Сочигалд уур зэвүү зэрэг хүрэх боловч санааны мухарт атаархалын бяцхан гал сүүмэлзэн цаг өнгөрөх бүр тодрон зүрхэн тушаа газар нь халуу оргиулсаар байлаа.

Тэр шөнө тэлээ бодолд урхилагдан тэлчилж хоносдоо юу ч шийдэж чадаагүй бөгөөд хүсэл тачаалаа хангах хамгийн ойрын бодол дийлэх ажээ.Эм хүн амьдралын хүндэд шаналж ганцаардахдаа эр хүйстний хатуу зориг, халуун энхрийллийг юунаас ч илүү эрхэмлэн хүсэмжилдэг болохыг өөрийн эрхгүй ойлгожээ.

Хоосон цэвэр нэр нүүрээ бодох нь Мэнлигийн сэтгэл биеийг түрүүлж эзэмдсэн Сочигал, Есүхэйн өнчирч хоцорсон эзгүй хүрээнд ч гэлээ илүү эрх мэдэлтэй болох илэрхий аюулд хүргэж байгааг сүрхий тод чухал биш ч гэлээ мэдэрсэн нь Өүлэний бодлын үр байсан юм. Эр нь үхсэний дараа үлдсэн эмс нь гэрийн дотрох эрх мэдлийн төлөө тэмцдэг тэр жамыг Өүлэн ойлгож авчээ.

Сочигал Хасар, Тэмүжин хоёртой нас чацуу Бэгтэр, Билгүтэй хөвүүдтэй. Ахмад хөвүүн Бэгтэр нь зан ааш түрэмгий биеэр өсгөлүүн тул Тэмүжинийг илэрхий дарлан дээрэлхэхийг үзсэн болохоор хөвүүдийнхээ төлөө өөрийн дур тачаалыг хангахаас илүүтэй санаа тавьж бодох ёстойгоо мэдлээ. Өүлэнд үүнээс өөр зөв зам үгүй мэт санагджээ. Мэнлигт түрүүлж биеэ эдлүүлснээр Сочигал ямар давуу тал олж болохыг хожимдсон ч ойлгожээ. Есүхэйн үхэхдээ хэлсэн гэрээс үг ядуу эр Мэнлигийг ингэж үнэд оруулна чинээ Өүлэн санаагүй билээ. Гэвч хэдхэн хоногийн дараагаас Есүхэйн гэрээсийг дагаж Мэнлигийн хүслээр болоогүйдээ ямар их алдаа хийснээ Өүлэн үзэж эхлэв.

Сочигалын номхон төлөв зан эрс хувирч бүгдийг ээрч омогдох нь илт болжээ. Бас Мэнлигийн дэмжлэг, эхийнхээ ивээлийг олсон Бэгтэр өөрийгөө энэ гэрийн эзэн болох хүн гэж илэрхий үзэж,Тэмүжинг өчүүхэн зүйл дээр ч болов дарлан дээрэлхэх нь зовлон дээр зовлон болж эхэллээ.Тэмүжин хөвүүн нь бяр хүчээр Бэгтэрээс хол дорой учир эрс хатуу эсэргүүцэн зодолдож үл чадна.Хөвүүнийхээ гомдол, хяслын нулимс гялалзах хонзонт шар нүдийг харах бүр Өүлэний сэтгэл сэмрэн урагдана.Хөвүүдийнхээ хувь заяаны төлөө Өүлэн амьдралтай эвлэрэн бууж өгөх ёстойгоо ойлгов.

Гэвч том болж эр эмийн элдэв учрыг аль эрт гадарлах болсон хөвүүдийнхээ дэргэд зарц харцтайгаа шалиглахыг тэр тэвчихгүй тул хөвүүддээ тусад нь гэр засч төвхнүүлсэн нь Тэмүжин, Хасар хоёрыг тэгэж их баярлуулна гэж бодоогүй билээ. Энэ нь хүүхдийн гэнэн сониуч зан төдий биш болохыг Өүлэн үзэж мэдэв.Тэмүжин хөвүүн нь бие дааж, толгой мэдэн

амьдрахыг хүсч байгаагийн илрэл байлаа.Бага балчир Тэмүгэ хүртэл ах нарын хамт шинэ гэрт унтах болов.Одоо Өүлэний хамт хоёр настай Тэмүлэн охин нь л үлджээ. Мэнлиг, Сочигал хоёрын холбоог зүгээр нэг эрийн галиг эмийн шалиг гэж үзэж болохгүй болсон тул ингэхээс өөр зам Өүлэнд үлдсэнгүй.

Тэмүжинг ирээдүйн худ Дайцэцэнийд хүргэж өгөөд буцаж ирсэн Мэнлигийг Өүлэн идээ будаа бэлдэж гэртээ урив.

Угаас Тэмүжинг худындаа буцааж хүргэж өгнө гэж амалсан байсан ч Есүхэйн үхлээс болоод жил тойрон амжил болоогүй билээ. Бас балчир хөвүүнээ хүний гэрт тэвчин илгээж чадахгүй хайрласаар байжээ. Гэвч гэр оронд бий болсон явдал хөвүүнээ Бэгтэрийн гарын шүүс болгож, доромжлогдон явахаас зайлуулж худындаа түр боловч илгээхийг Өүлэн зөв гэж үзэв. Худындаа очно гэдэг Тэмүжиний хувьд Бэгтэрээс дээрд үзэгдэх ганц боломж байсныг ч Өүлэн бодсон билээ. Учир нь Есүхэй нас чацуу Бэгтэр, Тэмүжин хоёр хөвүүнээсээ сараар ах Тэмүжинг сонгон бэр буулгаж сүй тавьсан нь өөрийн орыг Тэмүжинд гэрээслэсэн хэрэг гэдгийг Өүлэн тэдэнд мэдүүлэхийг хүссэн юм. Өрх гэрийн дотор эрх мэдэл булаалдсан энэ үед Тэмүжинг хэн болохыг Сочигал Бэгтэр хоёрт сануулахын тулд хэцүү, хайрлалтай ч гэлээ хөвүүнээ хүний гэрт илгээхээс өөр арга Өүлэнд байсангүй. Мэнлиг, Тэмүжин хоёрыг бүгд цуглан хүндтэйгээр үдэн мордуулав.

Ингэж Тэмүжин хэдий арван нас дөнгөж өнгөрч буй ч том хүний орыг эзэлж, гэрийн дотрох ахмад хөвүүнд тооцогдохын тулд нулимсаа тэвчин Өүлэн эхийнхээ хатуу чанд сэтгэлийг үг дуугүй дагасан билээ. Өүлэний гэрийн дотор гал дүрэлзэж халуу дүүгээд архинд халамцсан Мэнлиг Дайцэцэн Тэмүжинг яаж баясан угтсаныг ярьж суув.

Үдэш болж тэнгэрт сар гийжээ.

Өүлэн Тэмүлэн охиноо Хасар ахынх нь өвөрт унтуулаад орж ирэв.Өүлэн өөрийн хувцсыг нимгэлж уран гоо гуя хасаа нэвт гэрэлтүүлэн явж суух нь Мэнлигийн угийн хүслэнт сэтгэлийг гал дээр тос асгасан мэт дүрэлзүүлж тэвчин ядан суулаа.

Мэнлиг өнөө шөнө Өүлэнг хүчээр эзэмдэхээр эргэлтгүй шийджээ.

Ингэхийг л Өүлэн хүссэн тул улам ч уян наалинхай аашилж байлаа. Гэвч үүний өмнө Өүлэнд хэлж ярих үг олон байв. Тийм учраас бас Мэнлигийн дур тачаалыг тэслэн дэлбэлэхийг, хормын дотор асгаран тайвшруулахыг хүссэнгүй.Илэрхий ойртон дотносож гуя хасаа илбүүлж байвч Мэнлигийн эцсийн хүслийг гүйцэлдүүлэхээр оролдох агшинд шалтаг олж могой мэт гулсан холдоно.Өүлэн Мэнлигийг өөрийн үг, харцаар нэг мөсөн дагуулахыг боджээ. Тэр цаг болов.

Мэнлиг хүсэл тачаалаа тэвчиж эс чадаад Өүлэний өмнө сөгдөн уйлав. Түүний амнаас хайр уяралын уран үгс урсаж гарчээ. -Өүлэн. Чи намайг сонс. Би зөвхөн Есүхэй баатрын гэрээслэснээр гул барьж чамайг эзэмдэхийг үл хүснэ. Би өөрийн сэтгэлийн чанад байгаа хайр сэтгэлээр чамайг эзэмдэхийг хүснэ.Есүхэй баатар чамайг авч ирэхэд би арван гуравтай хөвүүн чиний тэргийг даган гүйж явлаа. Тэгэхэд л би чиний гэрэлт царай, гэгээн биенд чинь үхэн дурласан юм.Би чамайг надад өгөөч гэж дээд Тэнгэрээс хичнээн ч гуйв. Одоо Тэнгэр

миний үгийг сонсч чамайг надад өглөө. Чи бүү харамс. Өүлэн. Эр чинь нэгэнт үгүй болов. Би чиний хөвүүдийг яавч өөрийнхөөс гадуур үзэхгүй. Хүсвэл би чамайг хөвүүдийн чинь хамт авч алс хол одъе.Ганцхан чи л намайг хайрла. Би чамайг хүчээр эзэмдэхийг үл хүснэ гэж уйлжээ. Өүлэн Мэнлигийн сэтгэлийн үгийг ойлгон сонсов.

Мэнлигийн харц хэрхэн өөрт нь тусч яаж сэм харцаа нуудгийг олон жил мэдэрсээр ирсэн билээ. Өүлэнд шунан дурласан сэтгэл нь Мэнлигийг одоо болтол энд аргамжсан юм.

-Мэнлиг минь сонс. -За би чиний хэлснээр хийе. Өөрийн хүсэл биелэгдэхэд ойртсоныг гадарласан Мэнлиг Өүлэний бэлхүүсээр тэврэн авав.

-Байз. Чи хүлээ. Эхлээд миний хэлэх үгийг сайтар сонс. Биднийг Есүхэй баатар эзний сүнс харж байгаа. Энэ үг Мэнлигийг түр зуур цочроож, төлөв царайг олж өөрийн суудалд суулаа.

-Мэнлиг. Чи бол Есүхэй баатар эзнийхээ толгойг түшиж, тоотой үгний нь эцсийг сонссон хүн. Эзэн чинь чамд эм намайг, өнчин хөвүүдээ даатгасан. Энэ бол ганц намайг чиний гэрт суухыг хэлсэнгүй. Өөрийн амь өрсөн явж сүй тавьсан Тэмүжин хөвүүнээ хэлсэн хэрэг юм. Чи эзнийхээ алтан гэрээсийг бүү март.Тэмүжин Есүхэй эцгийнхээ ард эзэн суух ёстой юм. Чухам ингэхийг л Есүхэй баатар эзэн чинь хүссэн билээ.

Гэтэл чи Сочигалд унаж, түүний хөвүүн Бэгтэрийг ивээх болжээ. Тэгээд юу болов.Нэг эцгийн хөвүүд эвдрэлцэж салхи хөдлөх шиг шалтгаангүйгээр үг сөрөх боллоо.Дор сууж, доор мэхийх ёстой Сочигал чиний точигонд халуурч чихгүй мэт аашлаж дөргүй мэт зүтгэх боллоо.Чи юунд Есүхэй баатар эзнийхээ сүнсийг уурлуулж сайн ясыг нь өндөлзүүлэв.Урд шөнө Есүхэйн баатрын сүнс ирж надтай олон зүйлийг хүүрнэн суув. Одоо ч тэр бидний үгийг сонсож сууна. Өүлэн ийн хэлээд тооно өөд харлаа.

Мэнлиг хэдий тооно өөд харж юу ч олж үзээгүй ч архи нь гарч аймшиг дүүрэн чичрэв. Үнэхээр тэр ёсгүй боол мөртлөө хан эзнийхээ хатдын халуун биенд хүрч юу хийснээ гэнэт ойлгов.

-Эзэн минь өршөө. Боол би осолджээ. Намайг үхүүлбэл таарна. Би ганцхан таны захиснаар л хатад хөвүүдийг тань асрая гэж чин сэтгэлээр санасан билээ гэж айн балмагдсан Мэнлиг ихээр уйлан газар мөргөв. Нээрээ л Есүхэйн сүнс тоонон дээрээ сууж байсныг Мэнлиг харсан мэт айлаа.Тэр сүнс яг Есүхэйн адил цоо ширтэх догшин харцтайг үзэх шиг болжээ.Харин Өүлэн Есүхэйн сүнстэй ярилцаж зовж шаналсан сэтгэлээ сэргээж, зориг итгэл олдог байв. Тэр ёсоор одоо ч гэсэн Өүлэн дээрхи хэдэн үгний хойно сэтгэл нь амран тайвширчээ.

Эзнийхээ сүнснээс айж сүрдсэн Мэнлиг ширдгэн дээр хэвтсэн чигээр таг чиг болжээ.

-Мэнлиг босогтүн. Одоо Өүлэний үг хатуу чанга сонсдоно.

-Есүхэй эзний чинь сүнс нэгэнт тайвшраад явж одлоо. Чи өндий. Чи нэгэнт Тэмүжин хөвүүний төлөө амь тавин зүтгэе гэв үү. Чи сая эзнийхээ сүнсэнд тэгэж хэлэв үү.

-Тийм ээ. Би амлав. Би Тэмүжин хөвүүнд чин үнэнч зүтгэнэ. Өүлэн хатан та юу гэж хэлнэ. Би таны хэлснийг хийе. Би сая тэгэж амалсан билээ.

-Чи амалснаа эс биелүүлбэл эзний чинь сүнс лав чамайг зүгээр орхихгүй биз.

-Би хэзээ ч үгнээсээ үл няцна.

-Чи энэ өдрөөс хойш миний үгийг Есүхэй эзнийхээ үг гэж сонсогтүн. Сая тэр сүнс надад ингэж хэллээ гээд Өүлэн тооно өөд харлаа.Мэнлиг ч харав.Харин Есүхэйн сүнс Өүлэнд үзэгдсэнгүй.

Энэ нь Есүхэйн сүнс Өүлэний сэтгэлдээ шийдсэнийг зөвшөөрсөн хэрэг байв.

-Жа би хэлснээр тань хийх болно гэж Мэнлиг сэтгэл түр боловч амсхийн шивнэв. Чингэхдээ тэр үнэн сэтгэлээс хэлсэн билээ. Одоо түүнд Өүлэний биенд шунан тачаадах сэтгэл үгүй болжээ. Хэдэн өдөр моринд агсагдсан бие нь буларч ядраад гэртээ орж аваль эмийнхээ өвөрт шурган нам унтах хүсэл л төрнө. Есүхэйн аймшигт сүнс Өүлэнийг сахин суух юм гэж санаагүй тул эндээс бушуухан зайлан одсугай гэж шийджээ.

Тэр явах гэж бослоо.

-Чи хаачна.

-Би харъя даа.

-Сочигалынд очих нь уу гэж Өүлэн даажинтай бас тачааж өдсөн өнгөөр хэлсэнд Мэнлиг гайхаж бас сэмхэн тооно өөд хяламхийв. -Сочигал лав чамайг шөнө ирнэ гэж хүлээж буй биз.

-Би түүнд дахиж ойртохгүй.

-Чи үнэн хэлж байна уу.

-Тиймээ үнэн хэлж байна. Энэ үгийг Мэнлиг Есүхэйн сүнсэд дуулгах гэж тооно руу хашгиран хэлэв.

Харин Өүлэн инээд алдав.Жаахан халамцаж хацар нь ягаарсан Өүлэн дэнгийн гэрэлд адын үзэсгэлэнтэй үзэгдэнэ.

-Нааш ир.Мэнлиг минь. Өүлэний энэ үгсийг Мэнлиг тэр дороо ухаж ойлгосонгүй, таг гөлрөн үүдний тэнд зогссоор байв.

-Яав. Би Сочигалаас дор үзэгдэнэ гэж үү гэж Өүлэн дөхөн ирж гарыг нь атган хөхөн дээрээ тавив.Тэгмэгц Мэнлигийн сэтгэлээс Есүхэйн аймшигт сүнс хийсэн одоод зөвхөн Өүлэний зөөлөн булбарай бие, зүрхний цохилтыг л мэдэрч байв.Өүлэн ингэж Мэнлигийг бүрэн эзэмдэн авав. Өүлэний дур хүсэл тэсэлгүй бэрхээр оргилон буцлах тул дуу алдан гиншиж бүх биеэр Мэнлигт наалдан, түүнийг татан зөөлөн дэвсгэр дээр хамт унажээ.

Мэнлиг нэгэнт ухаан алдав. Одоо түүний бие сэтгэл зөвхөн байгалаас заяасан адгуусанд ч байх дадал, сэрэмжиндээ хөтлөгджээ. Өүлэн ч түүний адил ганцхан тачаал, хүсэлдээ захирагдав. Мэнлиг үнэхээр эр биений чалх гайхалтай эр байжээ. Жил сараар эрийн бараа үзээгүй Өүлэн түүнээс дутахгүй ханаж цадахыг мэдэхгүй мэт аашилна.

Тэд дахин учрахгүй хагацах амраг шиг шөнөжингөө бие салгалгүй янаглаж тачаалын хурыг хэдэнтээ асгаруулжээ.

Үүр цайсны хойно Мэнлиг хамаг тэнхээ шүүсээ барсан мөртөө соёолон азарга шиг хүч түрэмгийлэн эдлэсээр байсныг Өүлэн тэсэлгүй хөөж явуулжээ.Мэнлигийнх ойр саахалтын зайтай зусаж байлаа.Өүлэн нэгэнт санасандаа хүрсэн тул өдөржингөө нам унтсан билээ

Өлссөн Тэмүлэн охин нь уйлж татсан ч сэрсэнгүй.

Мэнлиг хэд хоног үзэгдсэнгүй. Харин хэд хоногийн дараа нэг үдэш ирэхдээ Өүлэний дургүйцлийн үгийг сонссонгүй шууд л өөрийн эм мэт үзэн хүчээр хувцсыг нь тайчин хүчирхэн эдэлж дур ханаад гэрийн эзэн мэт унтаад өгчээ.

Өүлэн түүний сэрэхийг хүлээж хоол хийж шөнө дунд хүргэв. Мэнлиг босч бэлдсэн хоолыг идчихээд

-Маргааш би Улз голын Өлөн тагт одно. Жаал хүнс бэлд. Би Жамухын тэнд очиж өөрийн аймгийн ах дүүстэй уулзана. Бид энд ганц гэрээр сууж болохгүй. Нэгэнт Сочигал та хоёр миний асарч авсан эм болсон тул хаашаа нүүж, хаана гэрээ барихыг чинь би мэдье.Өүлэн чи маргааш намайг явахад талийгч эрийнхээ алтан бүсийг надад гаргаж өгөгтүн.

Би хамаатан садандаа Есүхэй баатрын эмс хүүхдийг өөрийн болгож авснаа зарлаж мэдүүлье.Бас Жамухатай уулзаж нутаг заалган ивээлд нь багтан амар айван сууя гээд хариу хэлүүлэлгүй гарч Сочигалынд очиж хоножээ.

Өүлэн эхлээд эм хүний өчүүхэн атаархалдаа хөтлөгдөн Сочигалын гэрлүү очив.

Гэрээс Сочигалын тачаалдаа шатан орилох сонсдоно.Есүхэйн амьд сэрүүн үед Сочигал ингэж тачаадан орь дуу тавьж байхыг Өүлэн ер үзэж сонссонгүй билээ.Харц Мэнлиг эмийг эдлэн жаргаахдаа гаргууд ажээ.Тэр шөнө Өүлэн бодоогүйгээ бодож, нөгөө эхнэрийндээ хоносон эрээ хүлээх мэт нойргүй хөлбөрч өнгөрөөв.

Алдуул малд эзэн мундахгүй гэдэг шиг эзэнгүй газар өнчин хөвүүдийнхээ хамт суух үхлийн аюултайг Өүлэн сайн ойлгож байлаа.Тийм болохоор Мэнлигийн хэлсэн үгийг дагамаар. Мэнлигийн ингэж хэлсэн нь ер буруугүй юм. Учир нь тэр өөрийн эзэн Есүхэйн гэрээсийг биелүүлж байгаа хүн.Одоо тэр Есүхэйн ард үлдсэн эмсийг нь эзэмдэн авснаар энэ өрх зөвхөн түүний нэрээр дуудагдах болов. Хаашаа нүүж, хаана гэрээ барихыг тэр заах болов. Есүхэйн нэгэнт Мэнлигт тэгэж гэрээслэсэн болохоор түүнийг дагахаас өөр үггүй болжээ. Эрээ үхүүлж иргэд албаттаа хаягдан хоцорсон бэлбэсэн эм үүнээс өөр яах билээ. Бүх эмс эрээс өнчирвөл амьддаа захисан тэр хүнд нь очдог нь тал нутгийн амьдралын хатуу хууль юм.

Эс тэгвэл хэн нэг хүний хүслийг дагана. Үгүй бол ядуурч өлбөрөхийн туйлд хүрэх билээ.Есүхэйг дагаж байсан түүний унаган иргэд албатын тэн хагас нь Жамухын дэргэд очсон тул тэдний дунд Өүлэнг харж хамгаалах хүн бий л биз. Гэвч Есүхэй их зэрлэг догшин зан авиртай,үнэн сэтгэлийн анд үгүй, туйлын ганцаардмал хүн байсан нь Өүлэн ингэж хөвүүдийнхээ хамт олонд хаягдахын шалтаг болсныг тэр ойлгож байв. Есүхэйн юунаас ч үл айх хатуу зориг, харгис зангаас айх сэтгэл л олныг түүний дор барьж байсан билээ. Иргэд албатынхаа сэтгэлд шингэж хайр хүндэтгэлийг татаж чадаагүйг нь батлан цуглуулсан улс нь тарж оджээ.

Есүхэйг үхмэгц ихсийн тайлгын идээг Өүлэнд хүртээлгүй загнаж байсан Амбагай хааны хөгшин хатад Орбай, Сохатай хоёрын их үгийг яаж мартана. Тэд Есүхэйн нэр алдрыг огт хүлээлгүйгээр

-Урьж чамд өгөх ёсгүй

Учирвал чи ирэх ёстой

Хүргэж чамд өгөх ёсгүй

Хүртвэл чи идэх ёстой гэж загнасан нь Есүхэй үхсэн тул чи хэн ч биш гэж хэлсэн үг билээ.

Бас Өүлэний сонсоогүй нэг зүйлийг тэд цугларсан олонд хэлжээ.Олон жилийн өмнө Есүхэй баатар Өүлэнийг мэргэдийн Чилэдүгээс булаан авсан учрыг хашир хөгшин хатад олонд сануулж

-Одоо нэгэнт Есүхэй үхээд эмс хөвүүдийг нь хамгаалах хүнгүй болжээ.Мэргэдүүд энэ цагийг ашиглан Өүлэнийг булаалгасныхаа өшөөг авах нь гарцаагүй.Тийм болохоор одоо Өүлэнийг өмөөрч түүний дэргэд байх нь мэргэдийн өш хонзонгийн золиос болж үгүйрч сүйрэхийн үндэс болно гэж ятгажээ.

Тэднийг ийн хэлснийг сонсож, үзсэн бүгд нэгэн дуугаар Өүлэнийг хаяж нүүсэн билээ. Бусдын үгийг үл тоож, бүхнийг ганц өөрийн хар зориг, хатуу итгэлээр шийдэж байсан Есүхэйн зан авир олны сэтгэлд хүрээгүйн илрэл болж бүгд Өүлэнг орхин одов.

Гэтэл одоо Мэнлиг түүнийг Жамухын дэргэд дагаж очихыг шаарджээ. Шөнөжин бодовч Мэнлигийн үгийг дагахаас өөр арга олдсонгүй. Өглөө нь Мэнлиг эргэж ирэв.

-Та нар нүүхэд бэлдэж бай. Би Жамухын тэнд очиж нутаг сонгоод мөд эргэж ирнэ. Даруй нүүхгүй бол тайчуудын Таргудай “Есүхэйн хөвүүд өссөн гэнэ. Очиж үзье” гэж тавлаж байна гэж хүн хэллээ.

Тэр Таргудай угийн хорон санаатай бас чамд шунан тачааддаг тул Тэмүжин, Бэгтэр хоёрт муу юм хийж мэднэ. Би мордъё.Чи Есүхэйн бүсийг гаргаж өг гэж Мэнлиг тулган хэлжээ. Өүлэн таг чиг гөлрөн суухад Мэнлиг гайхаж

-Яав чи гэж зандрав.

-Урьд шөнө Есүхэйн сүнс тооноор сарны гэрэл хөлөглөн бууж өвөрт минь орж ирээд

–Алтан бүсийг минь Тэмүжин хөвүүнээс өөр хэнд ч бүү өг гэж хэллээ.Тэр бүс гоёл биш.Тэмүжиний сүр сүлд нь болох ёстой гэнэ гэж Өүлэн хэлэв. Хэн ингэж хэл гэсэн юм бол гэж Өүлэн өөрийн үгийг сонсоод гайхан бодов. Лав Есүхэйн сүнс түүнд ингэж шивнэжээ.Мэнлиг эргэлзэв.

Уг нь татаарын Дарбай бөхийг үхүүлж олзлон авсан арслантай цул алтан бүсийг зүүж, Есүхэй баатрын хатад, хөвүүдийг асарч яваагаа олонд гайхуулах хүсэл Мэнлигт туйлын их байлаа. Гэвч Өүлэний хэлсэн үг түүнийг айлгажээ.

-Би Тэмүжинг өөрийн хөвүүн шиг санана. Бид эцэг хөвүүд болно биз гэж Мэнлиг итгэлтэй хэлэв.

-Тэр чинь Есүхэйн хөвүүн шүү. Чи Есүхэй эзнийхээ гэрээсийг яаж хөсөрдүүлж болох билээ гэж Өүлэн түүний үгийг няцаав.Тэмүжин хөвүүн нь Мэнлигийн хөвүүн болно гэхээс Өүлэний дотор давчдаад ирлээ.Тэр яагаад үүнийг өмнө нь бодсонгүй вэ. Мэнлигийн дээр хэлсэн үг Тэмүжин хөвүүнээ хэн нэгэнд алдах мэт сэтгэл төрүүлж бүр айж орхив.

Одоо ч гэсэн харьд одсон хөвүүн нь нэгэнт харьж ирэх нь өнгөрсөн мэт совин татаад нулимс сул асгарав.

-Мэнлиг чи даруй явагтүн. Тэмүжин хөвүүнийг минь авчир

-Чи юу ярина вэ. Худынд хүргэж өгөөд хоёр гурван сараас хэтэрсэнгүй. Биднийг хэлсэн үгээ эргээд мартдаг, гуйвамтгай хүмүүс гэж санаад сүйгээ цуцлавал яана. Хонгирад баян аймаг. Бидэн шиг ядуу улсад олдохгүй худ шүү. Бас охин Бөртэ нь царайлаг…

-Үгүй ээ Мэнлиг. Чи Тэмүжинг даруй авчир. Би үүнийг хэлсэнгүй. Есүхэйн сүнс хэлэв.Тэмүжинд хэлэхгүй яаж нүүж болно. Өүлэний амнаас гарсан “Нүүнэ” гэсэн үг Мэнлигийг зөвшөөрөхөд хүргэв.

Юутай ч Есүхэйн алтан бүсний тухай одоохондоо дахин дурдахгүй өнгөрөхөөр шийдэв:

-Би Жамухын тэндээс цааш явж Тэмүжинг авчиръя.Харин Дайцэцэнд юу гэж хэлнэ. Бас хөвүүнийг ирүүлэхгүй гэвэл яана. Өүлэнд тэр даруй хэлэх үг олдсонгүй.

-Эцэг Есүхэйн сүнсийг тахих өдөр болов гэж хэл. Үүнийг өнгөрмөгц буцаан хүргэж өгье гэж хэл.

-За би Өүлэн чиний хэлснээр хийе.

-Чи хурдалж үз.Тэмүжин хөвүүнийг минь бушуу авчирч өг. Өүлэний сэтгэлд төрсөн хар сэжиг, муу совин түүнийг тайван суулгаж тухтай унтуулахгүй болжээ. Тэмүжин хөвүүнээ дахин үзтэл чилийсэн гурван сар өнгөрөхийг тэр даанч мэдэхгүй байлаа. Мэнлиг Жамухын тэнд очих, бас цааш явж Хонгирад аймаг орохоор яваад сураг тасрав.

Өүлэний хамгийн зовлонт өдрүүд эхэллээ.Өрөвлөг нь хатаагүй ангаахай шиг нялх хөвүүнээ зүс үзэж, үг солиогүй аймагт өгч явуулсандаа өөрийгөө харааж зүхээд барахгүй байлаа. Одоо түүнд хань болж буй ганц хүн бол арван настай Хасар юм. Хасар хөвүүн нь өсгөлүүн том биетэй, үг хэл хурц, эцэг шигээ омголон догшин төрхтэй болон өсч байлаа.Хасар гэрийн дотрох хамаг хэргийн учрыг ухаарч эхийн шаналалыг ойлгон дэргэдээс нь холдохгүй бүртэлзэх ажээ.

-Ээж ээ би яах вэ гэх Хасар хөвүүнийхээ аргадсан зөөлөн дууг сонсох бүр уяран баярлаж, бас түүнийг өрөвдөн шаналсандаа нулимс нь тэсэлгүй асгарна.

-Ээжээ та бүү уйл. Тэмүжин ах зориг тэвчээр ихтэй. Юу ч болсон тэсээд хүрээд ирнэ гэж Хасар эхийн сэтгэлийг засах ажээ.Хасар бол эхдээ хачин дотно, сэтгэл дотрохоо нууна гэж үгүй тул Өүлэн энэ хөвүүндээ онцгой халуун хайртай бүлгээ.

Хасар бол хэлсэн үгэндээ хүрдэг хатуу хүмүүжилтэй хөвүүн юм. Харин Тэмүжин үгний хариуг шууд ил цагаанаар хэлэх нь ховор . Хэдий хойно өнгөрснийг санан давах гашуун үг хэлж байдаг давхар муу санаатай хүүхэд ажээ.

Тийм болохоор Тэмүжин барагтай бол хүнтэй тулж зодолдохгүй ч бас шууд бууж өгөх дургүй. Бэгтэрт доромжлогдон зогсохдоо харц нь гүн хорсол заналаар дүүрч, уур хилэнгээ асар их хүчтэвчээрээр барьж өнгөрөхийг нь үзэх бүрдээ сүүлд нь энэ хөвүүн юу хийх бол гэж өөрийн эрхгүй түгшин боддог билээ. Ер нь Тэмүжин бол юу ч хийж чадах зориг цөс ихтэй гэдэг нь ил юм. Гэвч харин хэзээ юу хийх гэж буйгаа хэнд ч үл хэлж, ямарч сэжиг авахуулахгүй байж чадна. Энэ нь Тэмүжинг бусдаас давуу болгодог зан байв. Хасар бол Тэмүжинээс түрүүлэн хэлэх гэснээ хэлэх тул бүхний нүдэнд өртөж дэггүй сахилгагүйгээрээ дуудуулж, муу үг сонсож, мухар алганы амт үзэх билээ. Гэтэл хэргийн эзэн, хэнгэргийн цохиур болох Тэмүжин аанай л таг дуугүй ард нь сугаран хоцорсон байна. Өүлэн хөвүүдийнхээ хэн нь хэн бэ гэдгийг сайн мэднэ.

Тэмүжинээс өөр хүн байсан бол эцгийнхээ үхлийн хойно Дайцэцэний гэрт яавч очихгүй байсныг Өүлэн бас ойлгоно. Хасар хэрэв чингэсэн бол нэг дуу газарт нөгөө дуу тэнгэрт хадаан орилж уйлж бөөн явдал болох нь мэдээж. Бүр явах ч үгүй биз. Харин Тэмүжин хорон харцтай шар нүдэндээ нулимс мэлтрүүлсэн ч үг дуугүй мордон Мэнлигийг даган торойсоор одсон нь үзэгдээд одоо амьд ирвэл хөвүүнээ хэзээ ч хааш нь ч явуулахгүй гэж Өүлэн сэтгэлдээ тангараглав.

Есүхэйн нас барж тайчууд салж одсоны дараахан өөрийн иргэд нь хаяж нүүгээд Чирха өвгөн үхлийн шарх олж амьсгал хураасан шөнө Өүлэн амьдралдаа анх удаа сэтгэлийн тэнцвэр алдан нуурын усанд үйж үхэхээр гүйсэн нэг явдал болсон юм. Чирха өвгөн үхмэгц түүнд энэ амьдралд өмөг түшиг болох юм юу ч үгүй мэт болоод хүүхдүүдээ унтсан хойно нуурын эрэгт хүрчээ. Үзсэн зовлон доромжлолоос даруй хагацах ганц хүсэл л түүнд үлджээ. Нуурын эргийн бяцхан хадан цохионы хөлд хэдэн алд хөлгүй гүн ус сүүдэртэнэ. Тэгэхэд үхэл түүнээс ердөө л алд хагасын зайтай байлаа. Алд хагасын цаана түүний үзээгүй, одоо нэгэнт Есүхэйн очсон тэр амьдрал хүлээж байв.

Урагш хэд алхахад л Өүлэн амар тайван нөгөө ертөнцөд очиж Тэнгэрийн ивээлд багтах

байв.Энэ зовлонт амьдралд тэр нэгэнт ялагдан бууж өгчээ. Сар дув дуугүй мэлтийж, өвс ногоо суга суга ургасан цагаан шөнө байлаа. Бурхан халдун уулын суганд шигдсэн эл бяцхан нуурын эрэгт очиж усны нь мандлыг ширтээгүй хүн лав энэ гайхамшигт нам гүмийн үзэсгэлэнг хэзээ ч мэдрэхгүй бизээ.

Бүр Өүлэн сая эргэн тойрныг хараад ийм үзэсгэлэнг анх удаа үзээд гайхжээ.Өүлэн энэ нам гүм үзэсгэлэнг дахин үзэхгүйгээ ойлгов. Сарны цагаан гэрэл тэнгэрээс сул асгарч, нуурын мандал дээр үсрэн буцалж байлаа. Эргэн тойрны өвс ургамал цөм ургаж бас хорхой шавьж нам унтжээ. Одоо Өүлэнд хагас алхам үлдэв.Тэр эцсийн энэ зайг туулахаар хөлөө өргөн биеэ чангаллаа. Гэвч тэр амжсангүй. Учир нь агаар хөдөлж чимээ гараагүй ч ард нь хэн нэгэн хүрч ирсэн нь мэдрэгдлээ. Өүлэний сэтгэлд айдас түгшүүр дүүрч хамгийн түрүүн чоно санаанд орлоо.Түрүүхэн ойрмог чоно улих сонсодсон билээ.

Чононоос айхыг бодоход Өүлэнд амьдрал, амь нь бас хэрэгтэй л байгаа ажээ. Өүлэн аажуухан эргэн хараад гайхсандаа дуу алдлаа. Түүнээс ганцхан алхамын цаана цээж нүцгэн Тэмүжин гараа сунган зогсож байлаа.

-Хүү минь Тэмүжин ээжийнхээ энгэрт толгойгоо наан халуунаар амьсгална. Толгой, үснээс нь сүү, адууны хөлс үнэртэнэ. Өүлэний нулимс хэлхээ нь алдарсан сувд шиг асгарчээ: Тэр энэ хөвүүний төлөө амьд явах учиртай үхэж болохгүйгээ сая л ухаарав. Бас ганц аврагч нь Тэмүжин хөвүүн нь болохыг ч ойлгов. Үнэхээр тэр шөнө Тэмүжин таг унтсан бол юу болохыг хэн мэдлээ. Тэнгэр Тэмүжинг түүнд илгээсэн гэдэгт Өүлэн ингэж итгэсэн юм. Тэмүжин тэр шөнөжингөө нуурын эрэгт эхийнхээ дэргэд таг дуугүй суусан билээ.

Хөвүүн нь нэг ч үг дуугараагүй мөрт харцанд нь үхэх гэсэнд нь хилэгнэж уурласан, бас хэрсүүжиж өршөөсөн өнгө зэрэгцэн байсан бөгөөд яагаад ч юм бэ Тэмүжин хөвүүнд нь юунд ч үл дийлдэх хүч сарны гэрэлтэй хамт шингэж байх шиг, хөвүүн нь сарны гэрлийг бүгдийг дотроо сорон шингээж байх шиг харагдаж байжээ.

-Хөвүүн минь. Тэмүжин минь. Чи ижийгээ хамгаалаарай гэж сэтгэлдээ гуйж мөргөжээ. Энэ шөнөөс хойш Өүлэн үхэх тухай бодлоо сэтгэлээсээ үүрд авч хаясан билээ. Өөртөө итгэж амьдралынхаа төлөө тэмцэх ёстойгоо тэгэхэд баттай ойлгож эрс хатуугаар сэтгэлээ чангалсан юм. Маргаашнаас нь Өүлэн төрөл арилжиж, өөрийн сул дорой зангаа ялж гарчээ. Энэ бол Есүхэйн үхлийн дараа Өүлэний амьдралд гарсан хамгийн том өөрчлөлт юм.

Тэмүжинээр дамжиж ирсэн Тэнгэрийн хүч сэтгэл зөөлөн, зүрх дорой эм түүнийг итгэл их,зорилго чанга болгон хувиргасныг Өүлэн мэдэхгүй байлаа. Харин түүний хатуу чандаар ойлгож авсан зүйл нь Тэмүжин хөвүүнээ хэний ч дор оруулахгүй хүн болгон өсгөхийн тулд амиа золиослохоос бусдыг хийх ёстой гэсэн зорилго юм. Тийм ч учраас Тэмүжин хөвүүнээ хүний гэрт очуулсандаа ингэж ихээр харамссан билээ. Гэтэл Бэгтэрийн дарлалыг үзэхгүй байх нь дээр гэж бодсоны учир чингэсэн болохоор бас бодол санаа нь хоёрдох бүлгээ. Одоо ирж гэмээ нь яах ёстой билээ.

Мэнлигийг дагаж түүний асрамжинд багтан Жамухын дэргэд очих нь зөв ч байж мэдэх юм. Энэ нь нэг хэсэг аюулаас зайлуулж болох авч бас тэнд түүнээс ч олон дайсантай болохыг яаж мэднэ. Есүхэйн үр удмыг үзэх, түүнтэй цуг амьдрах хүсэлтэй нь хэд бол. Өдрөөс өдөрт өсч

томрох хөвүүдийг нь нүдэнд орсон хог, шүдэнд орсон мах мэт үзэх бий гэж зовно. Идэр зоримог хөвүүд элдэв маргаанд өртөж ирт мэс зөрүүлэх болно. Тэр цагт хэнд ч үхэхгүй, шархдахгүй гэх баталгаа үгүй. Тэмүжин хөвүүнээ алдвал Есүхэйн удам сүйрч боолын боол босгоны шороо болно.

Тиймийн тул тэр хөвүүнийг болдог бол амандаа үмхэж өсгөх ёстой билээ.Гэтэл өнчин ганц гэрээр өлөн хоосон, өвсөнд нуугдаж амьдрах нь чоно нохойнд идүүлэхээс өгсүүлээд цочсон хүн хүртэл харваад алчих аюул элбэг. Өөрсдийгөө хамгаалах чадал мөхөс тул арван хүн ирвэл айж зугатаахаас өөр нөхөргүй явах нь Жамухын дэргэд дагаж очихоос дор мэт.

Бас ингэж чихнээс өөр дэргүй, гуянаас өөр хучлагагүй мэт амьдрал хөвүүдийнх нь зан хүмүүжилд яаж нөлөөлөхийг ч бас мэдэхгүй. Гуйлгачин, тэнүүлч амьдралд өссөн хүнд гавьяат эцгийн гэрээсийг биелүүлж эзэн суух хүсэл хүмүүжил хүчтэй төрөх эсэх нь эргэлзээтэй.Ийн мянган салаа бодолд унаж шөнө төөрсөн мэт байтал ашгүй Тэмүжин хөвүүн нь эсэн мэнд инээд алдсаар давхин ирэв.

Хэдхэн сарын дотор Тэмүжиний өөрчлөгдсөн нь гайхалтай. Хөдлөх хэлэх нь яг л том хүн шиг товч тодорхой болжээ.

-Хөвүүн минь. Би чамайг дахиж хааш нь ч явуулахгүй. Энэ үгийг Өүлэн нулимс урсган хэлэв.

Өүлэний сэтгэл бүтэн болж гэрийн хоймор дүүрчээ.

Одоо энэ янхигар том гэрт Тэмүжинээс өөр эзэн байхгүй.

Хайран бие нь элж хатан амь нь эрсдэвч Есүхэйн өрх гэр Тэмүжинээр овоглох ёстойг Өүлэн ойлгов.

Тийм ч учраас энэ удаа Мэнлигийг баруун хаяанаас дээш гаргалгүй дөрвөн хөвүүнийхээ дор суулгасанд Мэнлиг үг дуугүй гарч явжээ. Мэнлиг сая Өүлэний сэтгэлийн чин үнэн санааг мэдсэн тул уурсан бухимджээ.

Өүлэнг хүүгээ үзээд түр зуурын сэтгэл хөөрсөн биз гэж санасан ч маргаашнаас Мэнлигийг хүн гэж тоохгүй болжээ. Энэ явдалд уурсаж хилэгнэсэн бас шаралхаж гомдсон Мэнлиг хэд хоногийн дараа Өүлэнийг хаяж Жамухын тийш нүүж оджээ.Өүлэн нүүхэд нь тоож очсон ч үгүй.Харин хөвүүдээ очихыг хориглосонгүй. Учир нь хөвүүдээ дайсан нөхрийг ялгаж ойлгож сурцгааг гэж бодсон билээ.

Ингээд Есүхэйн хоёр хатан долоон хүүхдийнхээ хамт талд хоцров.

Одоо тэд зөвхөн өөрсдийн хүчинд итгэж амьдрах ёстой болжээ.Энэ бол Өүлэний Тэмүжин хөвүүнийхээ төлөө сонгон авсан таахад бэрх хүнд хүчир амьдрал байлаа.Тэр өөрийн өчүүхэн сэтгэл өмсөж эдлэхийг бодсонгүй.Өүлэн өөрийн шийдвэрт туйлбартай бас баяртай итгэл төгс байлаа.Энэ бол Тэнгэрээс түүнд зааж өгсөн амьдрал гэж Өүлэн итгэжээ.Гэвч гаднаас халдан ирэх аюул холдсон мэт боловч дараагийн зовлон гэрийн дотроос урган гарчээ.Есүхэйн цусаар нэгдсэн хөвүүдийн өрхийн дотор эзэгнэх эрхийн төлөө зөрчил бага зэргийн ангийн олз, айраг

цагааны хуваарь зэрэг дээрээс гэнэ гэнэ үүсэх хэрүүл зодооноор илрэх боловч амьдрах хүсэл, нэг орчин тэднийг хүссэн хүсээгүй салахын аргагүй нэгтгэн барьж байв.

Тэмүжин Бэгтэр хоёрын далд тэмцэл ил тод болж тэд өдөр өнгөрөх бүр өст дайснууд болон хувирч байгааг Өүлэн түгшин харж байлаа.Гэвч Өүлэн яах ч учраа олохгүй дэмий л эвлэрүүлэхийг оролдох ажээ.Үүнээс өөрийг хийх чадал түүнд байсангүй. Гэтэл энэ зөрчил тэмцлийг Тэмүжин гэнэт огцом хурцаар шийдсэн нь тааж ойлгоход бэрх явдал болжээ.

Өүлэн Тэмүжин хөвүүнээ хэн болсныг ойлгож мэдээгүй явснаа сая л ойлгов. Нэг муу өчүүхэн загас болжмор булаацалдсанаас болж, эцэг нэгтэй дүү Бэгтэрийгээ эргэлзэхгүйгээр харваж алсныг Өүлэн мэдмэгц ухаан балартах шиг болжээ. Тэмүжин ганц өөрөө биш дүү Хасарыгаа ч энэ хэрэгт оролцуулж Бэгтэрийг хойно урдаас нь харваж алжээ. Нуруу, элгэнд нь сум зоолттой Бэгтэрийн хүүр суугаа чигээр байхыг үзээд Өүлэн сая л болсон явдалд итгэв.

Хөвүүдийн хоорондох хэрүүл маргааныг Өүлэн үргэлж эвээр зохицуулахыг хичээж Тэмүжин, Хасар хоёрыг ойлгуулж, ухааруулахыг зорьсон юм.”Үргэлж ингэж дарлагдаж, олзоо булаалгаж яаж амьдарна” гэж Тэмүжин эрс эсэргүүцэн хэрэлдээд үүд шидэн гарснаас хойш эхийнхээ үгийг сонсохоо больж тэгээд удалгүй энэ аймшигт хэрэг болжээ.

Үүнээс хэд хоногийн өмнө Өүлэн нэг эцгийн хөвүүд эвтэй байхгүй бол хэн та нарт туслана гэж учирлахдаа Алангуа эхийн таван хөвүүний тухай домгийг ярьж өгчээ.

Эрт цагт Тэмүжиний дээд өвөг Добу мэргэн Хорь түмдийн Хорилдай мэргэний охин, Ариг уснаа төрсөн Алангуа хэмээх үзэсгэлэнт эмийг гэргий болгож Бүгүнүтэй, Бэлгүнүтэй гэдэг хоёр хөвүүнтэй болжээ. Тэр домогт өгүүлснээр удалгүй Добу мэргэн үхэж, Алангуа хатан бэлбэсэн бөгөөтөл дахиж Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг гэдэг гурван хөвүүн төрүүлжээ. Тэр үед Добу мэргэнийг амьд ахуйд төрсөн Бүгүнүтэй, Бэлгүнүтэй хоёр Алангуа эхээсээ ангид ингэж хэлэлцжээ. Бидний эх ойр төрлийн эрэгтэй хүнгүй гэрт, эргүй бөгөөтөл энэ гурван хөвүүнийг төрүүлэв. Гэрт ганцхан Малиг баяуд овгийн ганц зарц эр байна. Энэ гурван хөвүүн лав түүний хүүхэд биз гэж ярихыг Алангуа сонсчээ.

Хаврын нэг өдөр хонины борц чанаж Бүгүнүтэй, Бэлгүнүтэй,Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг таван хөвүүнээ зэрэгцүүлэн суулгаад хүн бүрд нэг нэг сум өгч “Хугал” гэвэл тэд хялбархнаа хугалжээ. Бас таван сумыг баглаж “Хугал” гэж өгвөл хэн нь ч эс чаджээ.

Алангуа үүнийг үзээд

–Бүгүнүтэй, Бэлгүнүтэй та хоёр юу хэлцсэнийг би сонсов. Та хоёр намайг энэ гурван хөвүүнийг яаж төрүүлэв гэж сэжиглэж байна.Ингэх чинь зөв биз.Гэвч та нар учрыг мэдэхгүй. Шөнө бүр цагаан шар хүн гэрийн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд түүний гэрэл миний хэвлийд шингэх бүлгээ.

Тэр хүн сар жаргамагц гарч одно.Түүнийг үзвэл эд лав Тэнгэрийн хөвүүд биз. Харц хүнтэй адилтгаж яаж болно. Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ. Та нар тавуул миний хөвүүд. Миний хэвлээс цуварч төрсөн биш үү. Та нар ганц нэгээр салбал нэг сум мэт хэн хүнд хялбар дийлдэнэ. Та нар эв эеэ нэгтгэвэл багласан сум шиг бат бэх болж хэнд ч

хялбар дийлдэхгүй болно гэсэн домгийг Өүлэн өөрийн дөрвөн хөвүүндээ сайтар ухуулан ярьж өгчээ.

Хөвүүд нь бодолд автан дув дуугүй сууцгаав. Ам түргэн Хасар ч дуугарсангүйд Өүлэн хөвүүд ухаарч мэдэв гэж баясжээ. Гэтэл тэр дэлэм эндүүрснээ хожим ойлгосон билээ. Энэ домгийг Тэмүжин тэгэхэд анх удаа сонсжээ. Бодончар богдоос хөөн бодож үзвэл Тэмүжиний уг гарвал Алангуа эхэд олдсон Тэнгэрийн үр сад болох ажээ. Энэ л Тэмүжинд туйлгүй дотно үнэмшилтэй санагдав. Үнэхээр тэдний удам Тэнгэрээс төрсөн бол тэр өөрөө хэн болох билээ. “Хожим хойно хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ ” гэж Алангуа эх хэлжээ.

Хожим хойно гэдэг нь хэзээ вэ. Хамгийн хаад гэж хэнийг хэлнэ. Есүхэй эцгээс өмнө тийм хамгийн хаад байсныг тэр бас тодорхойлж мэдэхгүй байлаа. Эцгийн ярианаас сонссоноо бодвол татаарт баригдаж Алтан улсад хороогдсон Амбагай хааныг эс тооцвол ер их хаан үгүй мэт. Гэтэл энэ домогт яах аргагүй түүний удам “Хамгийн хаан сууна” гэж хэлжээ. Эцэг нь лавтай их хаан болсонгүй. Бүр Боржигон аймгаа ч алджээ. Одоо Тэмүжин бол яах аргагүй эхийн өгүүлсэн домгийн ёсоор Тэнгэрээс гаралт хүмүүн Бодончар богдын үр удам, залгамж болох ажээ.

Түүнийг муу явах аваас хожим энэ мэт өгүүлж ярих ёстойг тэр үнэн тодоор мэдэв. Тэр яавал хожим хойно сайн сайхнаар дурсагдах билээ гэж голын эргийн зөөлөн ногоон дээр хэвтээд тэнгэрт эргэлдэх бүргэдийг харан бодож хэвтэв. Одоо түүний амьдрал огт өөр зорилго учиртай мэт санагджээ. Түүний өмнө огт хүртээлгүй анзаардаггүй зарим нэг зүйлсийн утга учир тодрох шиг санагдана. Мэнлигийн дунд хөвүүн балчир Хөхөчү ч бас түүнийг”Хаан болно” гэж хэлсэн билээ.

Гэтэл тэр Хөхөчүгийн үгийг Алангуа эхийн домогт хэлсэнтэй холбон бодож үзвэл нэн бахархалтай учрыг тодруулах мэт. Ер нь Хөхөчүгийн гайхалтай этгээд чадвар нь хэлэх үгийг нь үнэмшилтэй болгодог билээ. Хөхөчүгийн хэлснийг сонсоод Тэмүжин өөрийгөө нэг ихэд тоож бодоогүй ч мартахгүйгээр санаж авсан билээ. Харин сая эхийн өгүүлсэн домогт гарах тэр Бодончар мунхаг бол яах аргагүй түүний өвөг, бас Тэнгэр заяат хүн болох ажээ. Бас хожим хойно гэдэг нь лав Тэмүжин өөрийг нь хэлсэн мэт санагдаад их зүйлийг боджээ. Магадгүй Тэнгэр Хөхөчүд хэлсэн нь үнэн байж мэднэ. Тийн бодвол Алангуа эхийн домогт лав Тэмүжиний тухай өгүүлсэн байвал яана гэж бодогдоод болсонгүй.

Гэрээс гармагц Тэмүжин хөвүүн нь голын зүг дув дуугүй явж одохыг Өүлэн эх хойноос нь харж зогсов. Алангуа эхийн өгүүлсэн эв нэгдлийн тухай домгийг ухааран ойлгож, гэмшлийн бодолд автжээ гэж таахдаа Тэмүжин хөвүүнийхээ ухаан сийрэгт бахдав. Харин үдэш хэдэн агтаа идээшлүүлж ирээд хотны захад Тэмүжин Хасар хоёр удаан сууж нэгэн зүйлийг чухалчлан ярилцахыг үзвэл бүр том хүн болсон гэмээр.Өүлэн аз жаргалтай болов. Хөвүүд нь хоорондоо хэрэлдэж зодолдохгүй нь лавтай болов гэж баярлажээ. Гэтэл Өүлэн хичнээн хол андуурснаа маргааш нь мэдсэн билээ.

Тэмүжин тэр үдэш Бэгтэрийг алахгүйгээр Есүхэйн өрх нэг ч өдөр оршиж чадахгүй болсныг Хасарт хэлж түүнийг харвахыг шаардаж тэд ийн удтал сууцгаасан ажээ. Хасар насаар дүү бас ээжийнхээ сэтгэлийг ихэд хүндэтгэн айх тул Тэмүжиний шаардлагад тийм амар хялбар автсангүй ч аргагүйдэн зөвшөөрөв. Гэхдээ Тэмүжин Тэнгэрийн удам болоод “Хамгийн хаан”

болох тухай бодлоо Хасарт дурдсангүй.

Бас Бэгтэрийг алах хэрэгтэй гэж Хөхөчүгийн хэлснийг ч цухуйлгасангүй.Хасар угаас Хөхөчүг үл тоодог билээ. Ганцхан гэрийн дотрох эрхийг авмагц Хасарыг өөрийн хамгийн үнэнч нөхрөө гэж үзэн удаах эрхийг олгох тухай л амлажээ. Хасар үүнийг зөвшөөрч тэд маргааш нь Бэгтэрийг харван алсан билээ. Хөвүүдийн хоорондох зөрчил ийн шийдэгдсэн нь цочир эмэгнэлтэй байсан ч яваандаа энэ нь гарцаагүй зөв байсныг Өүлэн ойлгож нялх бага гэлтгүй Тэмүжиний зориг, ухаанд бишрэв.

Үнэхээр Тэмүжинд Алангуа эхийн домгийг хэрэгжүүлэхэд нь саад болсон анхны дайсан нь Бэгтэр байв.Бэгтэрт өөрийн хувь зохиолыг алдаж болохгүйг Тэмүжин ухаарч ийм эрс зоригтой, бүр аймшигтай зэрлэг гэмээр үйл хийснийг Өүлэн ойлгоогүй юм. Тэр хөвүүнээ уурын цочирд хийв гэж гэж санасан билээ.

Сочигалын уй гашууг тайтгаруулах хэцүү байсан ч өнчин ганц үлдсэн Билгүтэй хөвүүнээ дахин алдахгүйн тулд Тэмүжинд бууж өгөхөөс өөр зам тэр эмд үлдсэнгүй.

-Чи үргэлж надад үнэнч зүтгэнэ гэж андгайлбал бид чамайг амьд үлдээе. Үгүй бол чамайг Бэгтэрийн адил үхүүлье гэж Тэмүжин Билгүтэйд хэлжээ.Энэ үгийг Өүлэн, Сочигал хоёр хоюул сонссон билээ. Ингэж арван гурван настайдаа Тэмүжиний анх удаа хийсэн аллагын хүчээр Есүхэйн өрх гэрт хэрүүл зөрчил үгүй болов.

Бас энэ хэрэг домогт өгүүлсэн шиг түүнийг Тэнгэрээс заяатай болохыг нь нотолсон мэт Тэмүжинд санагджээ. Өрх гэрийн дотор түүнийг эсэргүүцэн тэмцэх хүнгүй болсон нь сайн хэрэг ч нэр төр, хүч чадалтай болно гэдэг өөрөө олон олон дайсныг хөлийн дорхи ногоо шиг ургуулан төлжүүлдгийг Тэмүжин мэдэх болоогүй байлаа.

Өүлэн Мэнлигээс салснаар хамаг зовлон бэрхшээлийг өөрийн ядруу биед үүрсэн ч юугаар ч сольж үнэлж болохгүй Есүхэйн нэр төрийг Тэмүжин хөвүүндээ өвлүүлэн үлдээж чадсандаа бахархалтай байлаа. Одоо ганцхан амьд үлдэх, хөвүүнээ өөрийгөө хамгаалах чадалтай болгох л үлджээ.Мэнлиг гэнэт нүүж одсонд өөр бас нэг учир байсныг Мэнлиг уурссандаа хэлэлгүй одсон билээ.

Энэ бол тайчуудын тухай юм.Дайцэцэний гэрээс Тэмүжинг дагуулан буцах замд тэдэнтэй хуучин Есүхэйн агтач байсан Турхай өвгөн таарч гэртээ харина гэхээс байж ядан түрүүлэн давхиж одсон Тэмүжиний хойноос харж зогсоод

-Есүхэйн хөвүүн хурга шиг бойжиж төлөг шиг төлжжээ. Удахгүй Таргудай барьж аваачиж зарцлана даа чамайг гэж хэлсэн билээ. -Мэнлиг минь. Би чиний эцгийн хамт Есүхэйн агтны догшныг сургаж, тарсныг хурааж явсан тул чамайг хөвүүн шигээ санаж юу ч үл нууна. Би сая чамд Таргудай Тайчуудын ихсийн найран дээр хэлснийг сонссоноо хэлэв. Тэр Таргудай Есүхэйн эрхэнд явснаа өс санаж одоо хөвүүдийг нь амны алчуур, адсаганы шороо болгохыг хүсч байна.

Чамайг тэдэнтэй хамт байхыг үзвэл лав амьд үлдээхгүй биз. Хүү минь чи сайн бодогтүн гэсэн билээ. Өвгөн Турхайн үг туйлбаргүй үнэн тул Мэнлиг хэнд ч хэлэлгүй амиа бодон

оджээ.Хэн түүнийг ингэв гэж шүүмжлэх билээ.Үнэхээр Турхай өвгөний хэлснээр Таргудай тайчуудаа дагуулан ирж Тэмүжинг барьж одов.

Тэмүжинийг нэн их гайхуулсан зүйл нь бүх хэрэг хэдэн жилийн өмнө Хөхөчү салж одохдоо хэлсэн ёсоор болсон явдал юм. Хөхөчүгийн хэлснээр тэр Бэгтэрийг алж, дараа нь Таргудай довтлон иржээ. Хэрэв Хөхөчү үнэн хэлсэн бол Таргудай түүнийг алахгүй ажээ.

Хөвүүнээ алдсан хойно Өүлэн дахиад л өөрийн шийдвэр зөв эсэхэд эргэлзэж өөрийгөө харааж зүхэх болов. Юунд Тэмүжинг Дайцэцэний гэрээс дуудан ирэв. Тэгээгүй бол хөвүүн нь зүв зүгээр эсэн мэнд байх байв. Өүлэн хэргийн бүх буруу булхайг өөртөө авчээ. Бүр Хасар хүртэл эхийгээ зэмлэх болов.

Одоо түүнд Таргудай хэдий харгис хахирч гэлээ хөвүүнийг нь арай алахгүй биз гэсэн хагас дутуу итгэл горьдлого үлджээ. Одоо тэр хаана очиж хэнд хэлэх билээ.

*****

Аяншиж туйлдсан морьтой, ангаж ундаассан царайтай нэгэн эр гөрөөсний жим даган балар ойн дундуур гэлдрүүлж явлаа.

Тэр эр толгой унжуулан энэ орчлонгийн эрээн бараан амьдрал өөрт нь огт хамаагүй мэт, бас морины явдалд таг унтсан мэт явснаа гэнэт цочин өндийж, морины амыг татан зогслоо. Эцсэн морины буусан чих солбин хайчилж эзний адил чимээрхэн чагнана.Үнэхээр модон дотор хүн хашгирах сонсодсон ажээ. Гэвч энэ их балар их хөвчийн яг хаана нь хашгирч байгааг ялган мэдэх аргагүй.Юутай ч хүний дуу сонссондоо тэр баясан сэргэжээ.

Морь нь ч урамтай болж хүч бяр нэмсэн мэт ухасхийн шогшлоо. Үүнийг үзэхэд хүн морь хоёр ямар ч болов үхэх гээгүй, амьдрах гэж зорьж тэмцэж яваа нь илт ажээ. Удалгүй утаа үнэртэж, нохой хуцах сонсодлоо. Голын намаг руу түрж орсон хушуу модыг нэвтлэн гарахад холгүй ойн цоорхойд хүний нүднээс нуугдуулан барьсан хэдэн гэр үзэгдлээ.

Энэ бол Тэмүжинг Тайчууд барьж явснаас хойш тэднийг дахин довтлон ирэхээс сэргийлэн нүүж ирээд байсан Өүлэнийх байв. Хөвүүд ан хийхээр яваад гэрт ганцхан Өүлэн, Тэмүлэн охины хамт үлджээ.

Харин Сочигал гогод түүхээр оджээ.Ойн захаас гэнэт гарч ирсэн үл таних хүнийг үзмэгц ноход хуцан давхиж одоход Өүлэн гарч ирэв. Энэ эзгүй буйд газарт гэнэт хүн ирсэн нь Өүлэнг айлгаж цочоов.

Ядаж Хасар Билгүтэй хоёр байхгүй нь бүр ч түгшээлээ. Тэмүжин хөвүүнийг нь Тайчууд довтлон барьж одсоноос хойш өнчин хөвүүд нь амь алдах аюул нүүр тулсныг гүнзгий ойлгосон Өүлэн ингэж сэжиглэн айлаа. Морь, хүн хоёр өвдгийг нь үнхэх шахам үсчин боргох нохдоос ер цочсон янзгүй гэлдрэх нь туйлдаж ядарсных гэдгийг Өүлэн мэдээд ашгүй бага боловч тайвшрав. Гэвч ханцуйд нуусан хутгаа авсангүй уяаны дэргэд хүлээлээ. Уяаны шон түшүүлэн тавьсан муна ч ойрхон үзэгдэв. Өнөөх морьтон гэлдрүүлэн дөхөж ирээд толгой өргөн түүнийг харснаа гэнэт шүд гэрэлтүүлэн инээмсэглэхэд нь Өүлэний нуруу хотосхийн

цочиж өөрийн эрхгүй дуу алдлаа.Тэр андуурсангүй.

Энэ аяншиж харласан царайтай, өгөршиж гандсан дээлтэй хүн бол өөр хэн ч биш, арван хэдэн жилийн өмнө Есүхэйгээс айн зугатааж одсон аваль эр Чилэдү нь дүрээр мөн байв.

-Чилэдү… Чи мөн үү гэж Өүлэн өөрийн эрхгүй шивнээд айсан мэт хойш ухрав.

-Тийм ээ. Өүлэн. Би Чилэдү байна. Би чамайг олох гэж энэ их уулын суга, жалга болгоныг нэгжиж эрлээ.

Чилэдү мориноос буух гээд зүгээр л ууттай унгас шиг газар хөлбөрөн унав. Түүнд хөл дээрээ зогсох тэнхээ үлдсэнгүй. Өүлэн түүнийг гөлрөн ширтсээр дэргэд нь сөхрөн суув. Тэр яах гэж ирэв гэж хамгийн түрүүн боджээ.Харин Чилэдү өтлөх янз орж улам ч сүрлэг ханхар болжээ. Ганцхан зөөлөн урин харц нь л өөрчлөгдсөнгүй. Үдэш болж ангаас ирсэн Хасар Билгүтэй хоёр танихгүй хүнийг хялалзан сэжигтэйгээр орж гарах нь тэднийг тухтай яриулахгүй байлаа.

Чилэдү ярих юм их л байгаа бололтой түг яг хийж хүүхдүүдийг харж сууна.Үүнийг ч Өүлэн ойлгож хөвүүдийг “Хойд гэрт ор” гэж гаргасны дараа тэд галын хоёр талд бие биеийг ширтэн хоцров.

-Чи яах гэж ирэв. Чилэдүг анх танимагц түгшин бодсон зүйлээ сая л асууж Өүлэний санаа амарчээ. Чилэдү ч ийм асуулт хүлээж байсан тул хариулах гэж яарсангүй.Шар тос самран халааж өгсөн архинд толгой нь эргэж нойр нь хүрч суужээ. Гэвч Өүлэний цочмог асуулт Чилэдүг сэрээв. Амраг залуу насны өдрүүд өөрийн эрхгүй дурсагдан нүднээ үзэгдэх ажээ. Ангир хонгор зүстэй Өүлэнг гэргий болгон аваад хэнийг ч үл дагуулан гэр хүрээгээ зорьсон зуны найртай өдөр санагдана. Юу нь ч гэнэн томоогүй явдал байв. Ядаж ах дүүгээ дуудан дагуулсан бол Есүхэйд тийм ч амар булаалгдахгүй байсандаа гэж Чилэдү одоог хүртэл голоо тасартал харамсан боддог бүлгээ.

Өүлэн нас бие гүйцэж намба төрх нэмээд улам ч хүслэнтэй үзэсгэлэнтэй үзэгдэхэд энэ харуусал улам гүнзгийрнэ.

-Би чамайг үзэхээр ирэв. Чилэдүг ийн зөөлөн хэлэхэд Өүлэн түүнийг сэтгэлийн угт мартаагүй өнөөг хүртэл үгүйлэн санасаар явснаа мэдэрлээ. Чилэдүгийн энэ үгэнд сэтгэл нь учиргүй догдлон чичирч нулимс асгарчээ. Чилэдү түүний нулимсыг үзмэгц даруй босон ирж дэргэд нь сууж тэврэн авав.

Өүлэн хөдөлж босож чадсангүй.

Өүлэн хормын зуур ухаан мэдрэлээ алдаж нэг мэдэхэд л Чилэдүгийн чийрэг гарын аяыг дагасан байлаа. Эсэргүүцэн өндийх гэвч оройтжээ.Чилэдү дээлийн товч бүсийг хурднаа тайлан нүцгэлж, даран унахад Өүлэн өөрийн дур хүсэлд дуулгавартайгаар буун өгч, бие биеийг хүссэн шунаг тачаалын галд автав.Бүх юм аянга цахилгаан гялбахын адил гайхалтай хурдан болж өнгөрөв.

Гадаа Хасарын хашгирах сонсдоход ийн хэвтэх нь зохисгүй тул тэд өндийж хуучин янзаар

галын хоёр талд сууцгаав.

-Чи яах гэж ирэв. Өүлэний ийн дахин асуухад Чилэдү энэ удаа сурсан зангаар зөөлөн сайхан инээмсэглэж

-Би чамайг авахаар ирлээ гэжээ. Түүний дууны өнгө огт тоглож наргисан янзгүй байлаа. Өүлэн тэр даруй хариу хэлсэнгүй.

-Би Тэмүжин хөвүүн чинь Тайчуудад булаагдсаныг сонсоод чамайг авахаар ирлээ. Есүхэй нэгэнт тэнгэрт хальж, аймаг улс нь тарж одлоо. Одоо чи өнчин нялх хөвүүдтэйгээ үнсэнд хаягдсан шалз шиг хоцорлоо. Чи нас залуу, зүс гундаагүй байна. Чи манай аймагт очиж суу. Би чамайг, чиний хөвүүдийг хэнд ч муу үзүүлэхгүй. Би чамайг золгүй амьдарч, сураггүй үхээсэй гэж үл хүсэх тул энэ хол газар биеэ зовоож,морио эцэж ирэв. Чи бид нэгэн цагт ёсолж сүй тавьсан эр эм явлаа. Би чамайг өөрийн эмсээс, хөвүүдийг чинь өөрийн хүүхдээс ер дутуу үзэхгүй. Би морь мал багагүй. Лавтай чамайг, хөвүүдийн чинь хамт тэжээж чадна. Би тэр цагт хүчтэй байсан бол юунд чамайг Есүхэйд алдах билээ. Даанч ядруу намайг Мэргэд аймгийн ихэс дэмжсэнгүй. Есүхэйн өөдөөс зориглон довтлох хүн олдсонгүй тул чи бид Тэнгэрийн багтсангүй. Одоо чи бид хоёрыг хэн буруушаана.

Би одоо ч чамд сэтгэл татагдсан хэвээр. Чи ч мөн адил болохыг би сая үзэж мэдлээ. Чи бид хоёрт дахиад үр хүүхэдтэй болох нас цаг байна. Би чамайг өөрийн авсан эмсийнхээ дээр суулгаж их эхнэрээ болгоно гэж Чилэдү эрс шийдмэг хэлснийг Өүлэн, гэрийн гадна сэм чагнаж зогссон Хасар ч сонсов.

Сэтгэлийн дотроос хайртай эх нь ямархан нууц агуулж явсныг сонссон Хасар мунаар дэлсүүлсэн мэт цочиж, үл таних тэр бүргэд хамарт, хар царайтай эрийг учир зүггүй үзэн ядаж, үеэ мултартал, шүдээ эмтэртэл уурсжээ. Харин Өүлэн ийм үгийг сонсоно гэж хүлээж байсан мэт огтхон ч гайхаж цочирдсонгүй.

Үзэж өнгөрүүлсэн зовлон зүдүүр нь түүнийг ухаантай, уужуу тайван сэтгэхийг шаардсаар тул аливаад хөнгөдөж түргэдэх нь ховор болжээ. Чилэдү бол яах аргагүй түүний сэтгэлтэй, анхны эр нөхөр нь мөн. Гэвч тэд одоо нэгэнт хувь зохиол төөрчээ.

-Чилэдү минь. Би одоо нэгэнт Боржигон аймгийн хүн болжээ. Есүхэй баатрын ууган хөвүүн нэгэнт арван дөрөв хүрчээ. Одоо Тэмүжин хөвүүн минь эцгийнхээ орыг авсан тул би юу ч мэдэж шийдэж үл болно. Харин энд ингэж зүрх зориг гаргаж ирсэн чинь амиа алдаж ч болох явдал шүү. Чи намайг одоо ор тас мартагтүн. Миний хувьд Чилэдү чи, чиний хувьд Өүлэн би нэгэнт үгүй болжээ. Залуу цагийн сүй тавьсан явдлыг зүүд байсан гэж сана. Зүүд мартагддаг биз. Түүн шиг сана. Чи энд бүү уд. Маргааш хөвүүдийг сэрж босохоос өмнө шөнө явж үз. Морь чинь амарсан биз гэж Өүлэн эрс хэлжээ.

Хөвүүдийг нь булаан авахыг хүссэн хэнтэй ч болов Өүлэн өшөрхөн тэмцэхэд бэлэн байлаа.

-Чи үхэхийг хүсчээ. Өүлэн би чамд хайртай сайн учраас туслая гэж л ирсэн. Би чамайг ингэж ганцаар чинь хаяхгүй. Би чамайг дургүйцлаа ч хүчээр аваачна. Чи эцэст нь надад баярлах болно. Надад одоо чамайг авахад олон цэрэг хэрэггүй. Би цөөн нөхдийн хамт эргэж ирнэ. Би

чамайг өвсний налсанаар явж хаа ч очсон олно. Би чамайг өнгө үзэмж төгс хэвээрийг чинь үзэж, эдэлж мэдлээ. Өнөө шөнө хоюул ёсолсон эр эмийн адил янаглаж цэнгэж хоноё. Харин би үүрээр мордоно. Тэгээд эргэн ирж чамайг хөвүүдийн чинь хамт дэргэдээ аваачина. Хүчээр аваачина. Би Есүхэйд чамайг нэг алдсан. Одоо бол алдахгүй. Би хоёр эхнэртэй. Тэд чам шиг ийм урин тачаангуй биш. Би хэзээ ч чам шиг ийм тачаангуй дуу ихтэй эм эдэлж үзээгүй юм. Тийм болохоор чи минийх. Чи бид хоёр хагацсаны дараа учирч ингэж жаргах байсан биз.

Өүлэн би чиний сэтгэлийг ойлгоно.Тэмүжин хөвүүндээ бүү санаа зов. Би түүнийг ад үзэхгүй. Хүсвэл би түүнийг өөрийн ууган хөвүүн гэж тооцъё.Чи юу гэнэ.Чиний хөвүүн Тэмүжин намайг залгамжлахад би ер татгалзахгүй.Чамайг буцааж авахыг манай аймгийн ах дүүс минь ч шаардах боллоо.Чамайг аваачих нь нэгэн цагт алдсан нэр төрөө сэргээж буй хэрэг болно гэж Чилэдү халамцуухан хашгирчээ.

Өүлэн дуугарсангүй удаан бодол болов. Эхийн юу гэж хэлэхийг Хасар гэрийн гадаа зүрх түгшин хүлээж суув. Учир нь үл олдох түгшүүр авчирсан тэр хар царайтыг үзэн ядах нь улам нэмэгдэж биеэ барьж дийлэхгүйд хүрчээ. Гэвч Хасар боссонгүй гэрээ налсан чигээр суусаар байв.

-Чилэдү. Эхийнхээ дууг сонсоод Хасар ухаан орлоо.

-Чилэдү. Чи миний хэлэхийг сонс. Хэн ч байсан надаас хөвүүдийг минь булаан авч чадахгүй. Миний нүд харж, зүрх цохилж байгаа цагтаа тэднийгээ хэнд ч өгөхгүй. Чилэдү. Мэргэд аймгийн чамд хөвүүнээ өгнө гэж яаж санав. Чи эндээс даруй далд ор. Хөвүүд чиний үгийг сонсвол чамайг амьд үлдээхгүй нь лав. Би чамайг үхүүлэхийг хүсэхгүй байна. Явж үз. Эхийн ухаант, зориг төгс үгийг сонсоод Хасарын халуун нулимс асгаран гарлаа.

Энэ үгсийг эх нь Хасар өөрт нь хэлсэн мэт хүлээн авч тэр мэргэдийн Чилэдү гэгчийг алахаар хатуу шийдэв...

-Өүлэн би чиний үгийг тоож сонсохгүй. Чиний үгийг одоо хэн ч нохой хуцсаны дайтай тоож сонсохгүй.

Би чамайг авахдаа л авна.Эргүй эм эзэнгүй гэр хоёр адил биш үү.Тэнд хэн дуртай нь орж унтдаг биз.Чи тийм амьдралыг хүсэв үү гэж Чилэдү хөхөрч архи гуд гуд залгилах сонсдов.

-Чилэдү чи согтжээ. -Тиймээ. Би эрт багын янаг чамайг үзээд согтжээ. Чамайг шөнөжин эцэж цуцталаа эдлэх хүсэл минь шатаж байна. Чи миний хөвүүнийг төрүүлэх ёстой.

Чи эмийнхээ жамыг дагаж эрийн дор янцаглах болно гэж Чилэдү агсамнаж хашгирав.

Нээрээ их биет Чилэдү архи даадаггүй бас их агсам ажээ.

-Би морь харж ирнэ.Чи хувцсаа тайлж намайг хүлээ. Би чамайг хичнээн шөнө эдэлсэн ч үл ханана. Чилэдү гэж ямар азарга болохыг би чамд үзүүлнэ. Чамайг би байдсан гүү шиг чарлуулах болно гэж үглээд гарч яваа бололтой үүд самардах сонсдов.

-Чилэдү чи шалиг юм бүү ярь. Тэнгэр сонсож байна. Есүхэйн сүнс чамайг харж байна.

-Хэ. Би үхсэн Есүхэйн сүнснээс айна уу. Ёстой нохойн чал. Чи намайг хүсэж байгаа биз. Түрүүхэн чи өөрөө л дурлаж гиншээд байсан одоо юу болоод олон үг хэлэв. Эмс та нарын ааш яг адилхан юм. Дараа бол гэж түлхэх мөрт дараад авахаар тэврээд л угтдаг шүү та нар гэж Чилэдү инээж гэрээс гарав.

Хасар сэм гүйж угсраатай тэргэн дээр тавьсан Тэмүжиний бага алдын нумыг авч эргэв. Чилэдү аргамжаатай агтны зүг морь харах санаатай тэнтэр тунтар алхах нь харанхуйд бүртэлзэнэ. Хасарт олон юм бодох цаг байсангүй. Гол нь алдаж харвахгүй л юмсан гэж шаналан тархи нь лугшина.Чилэдү морь харчихаад босож эргэхэд нь ердөө таван алхамын цаана зогссон Хасар сумаа тавьж орхив. Хасар юу ч сонссонгүй. Их биет Чилэдү түүний өөдөөс гуйван алхах нь оноогүй бололтой. Дахин сум онилох гэтэл гарт нь юу ч үл баригдав. Одоо энэ Чилэдү багалзуурдан алах байх гэж бодсон ч хөдөлж зугатаж чадсангүй. Чилэдү түүнд яг тулж ирээд гараа сунган нүүрэнд хуруу нь хүрснээ гэнэт тас гэдэргээ саван писхийн унав. Хасарын сум Чилэдүгийн зүрхэнд гүн зоогдож тэр ийнхүү хормын дотор үхжээ.

Чилэдүгийн шаардлага, согтуу хөлчүү үгэнд автан учраа олохгүй хоцорсон Өүлэн битүү хачин чимээ гаргахыг сонсоод гүйн гарав. Холгүй нэг хүн зогсоно. Түүнийг төрхөөр нь Хасарыг гэж хармагц таниад

-Хасар… гэж дуудвал огт хөдлөхгүйд хөвүүндээ гэнэт санаа зовнин гүйн очжээ. Зүрхэндээ зэв зоолгосон Чилэдү дөрвөн мөчөө алдлан үхжээ. Харин Хасар нулимс нь урсан халуурсан мэт чичирч зогсжээ.

-Хөвүүн минь. Хасар минь Хасар нэгэнт эхээсээ өндөр болжээ.

-Нааш ир. Битгий ай. -Ижээ гэж Хасар шивнээд сөхрөн сууж энгэрт нь нүүрээ наан гашуунаар уйлав. Энэ бол нялх хөвүүнд нь дэндүү ахадсан хэрэг болохыг Өүлэн ойлгож Хасарыг тайвшруулан хөлстэй духыг нь олонтоо үнсэн аргадав.

Хасар ч удалгүй тайвширч эх хүү хоёр Чилэдүгийн хүүрийг жалганд аваачиж хаяад, маргааш өглөө нь буурь сэлгэн нүүв. Анх хайр сэтгэлээ өгсөн хүнээ Өүлэн ийнхүү үхүүлж эзгүй жалганд хүүрийг нь булах ёстой байжээ. Энэ бол хэний ч зүүдэнд орж зүрхэнд таагдахгүй хэрэг билээ. Ганц Өүлэн бэрх хатуу сэтгэлтэй бардам чанад зорилготойдоо ийм зовлонг дааж өнгөрөөсөн биз ээ.Эх хүү хоёр болж өнгөрсөн явдлын тухай хэн нь ч ам нээсэнгүй.

Хөвүүнээ зөв зүйл хийсэн гэж сайшаасан ч үгүй бас зэмлэсэн ч үгүй. Хасар ингэж анх удаа хүн алж, Тэмүжин ахынхаа эзгүйд эхийгээ хамгаалах чадалтайгаа үзүүлсэндээ туйлын баяртай итгэл зоригтой болжээ. Түрүүлж харваж, өрсөж алах нь амиа хамгаалах ганц арга гэдгийг ч ойлгов. Чилэдүг Хасар харваж алсан нь нууц үлдсэн ч Өүлэний сэтгэл тайвширсангүй. Чилэдүг үхсэнд харамсмаар ч дахиад хэн нэгэн өөрт нь тачаадан шунаж болохыг, ингэвэл хөвүүд нь золиос болон үрэгдэж болох аюул бийг тод мэдэв. Эм хүн болж төрнө гэдэг яасан их гачлант хувь зохиол болохыг Өүлэн бүрэн амсч байлаа.

Түүний амь амьдрал нь өнчин балчир хөвүүд нь бөгөөд тэд эхийгээ хэний ч доромжлолд

өртүүлэхгүй хамгаалж чадахыг сая үзэж Хасар хөвүүнийхээ чанга хатуу зориг цөсийг биширчээ. Хасар гэрийн гадна чагнаж суусныг ч гадарлав. Хасарын харцыг ажихад эхийгээ өрөвдөж дэмжсэн сэтгэл их байх нь Өүлэнд сайхан санагдана. Чилэдүг алсны хойно Хасар тун их өөрчлөгджээ.

Эхийгээ үүрд хайрлан хамгаалах тангараг өөртөө тавьсныг харин Өүлэн мэдсэнгүй билээ.

Гэвч Хасар эхдээ онцгой дотно хандах болсныг үзэхэд урьдын омогтой, уур уцаартай хөвүүн мөн үү гэмээр. Хэдий булаан аваачих гэсэн дайсныг хөнөөсөн санагдавч эхийгээ үг дуугарахгүй, тэр явдлыг мартсан мэт байхад нь тайтгаравч алсыг ширтэн санаа алдах, үдэш гал ширтэн бодолд дарагдан суухыг нь үзээд Хасар харамсан, дэмий юм хийв гэж халаглан бодох боловч Мэргэд аймагт хүчээр аваачна гэснийг санаад тайвшрана.

Бас эх нь таг дуугүй боловч цаанаа дэмжин сайшааж байгааг мэдрэх бүлгээ.

Энэ явдлаас хойш Хасар Өүлэн хоёр бүр ч онцгой дотно болсон юм.

Болсон хэрэг хийсэн үйлээ Хасар Тэмүжинг тайчуудын олзноос зугатаж ирсэн хойно ч нээж хэлсэнгүй. Үүнд нь эх нь ихэд талархалтай байгааг мэдээд Хасар хэлэхээ нэгэнт больжээ. Уг нь тэр мэргэдийн их Чилэдүг хэрхэн оночтой харваж үхүүлснээ Тэмүжин болоод Билгүтэйд хэлмээр бүр тэсэлгүй хэл нь загатнаж байсан ч эхийнхээ нууцыг үүрд чанд хадгалахаар шийджээ. Өүлэнг дэмий л уйлж суухаас цаашгүй хэдэн сар өнгөрөөж байтал турж эцсэндээ өндөр ч болсон юм шиг Тэмүжин эцсэн морио хөтөлсөөр мөлхөх шахам ирсэн нь тэднийг Онон мөрний эх Химурга горхины дэргэд Бэдэр хошууны Хорчихуй булагт байхад болжээ. Тэмүжиний хоёр хөмсөгний хооронд босоо гүнзгий үрчлээ нэмэгджээ. Энэ бол Таргудайн хүрээнд Тэмүжиний үзсэн зовлонгийн хэзээ ч үл арилах гүн тамга юм. Таргудай Хөхөчүгийн хэлсэнчлэн Тэмүжинг алсангүй.Тайчуудын нэртэй зүстэй толгойлогч хүн нас гүйцэж яс бэхжээгүй хөвүүнийг өс санаж хороох нь зөөлөн сэтгэлтэй олны сэтгэлд сэв суулгахаас цаашгүй гэж Таргудай боджээ. Энэ балчир хөвүүн өсөж өндийж өөрт нь дайсагнатал хаа ч юм бэ.Таргудайн гол хүссэн нь Тэмүжинг засаж хүмүүжүүлэн өөрийн гарын дор итгэлтэй хүн болгох явдал байв.

Ингэж гэмээ нь одоо Жамухын дэргэд очсон Есүхэйн хуучин албат иргэдийг өөртөө нэгтгэхэд алсдаа хэрэг болно.Алс хожим Тайчууд, Боржигон хоёрыг нэгтгэн аймгийн хан болох хүсэл Таргудайд байлаа.Энэ зорилгоо хэрэгжүүлэхэд Тэмүжинээр дамжуулан Есүхэйн нэр хүндийг өөртөө ашиглах бодолтой тул Тэмүжинг өөрийн дэргэд хүчээр авчирсан билээ. Тэмүжин хөвүүнийг дөнгөлөн өөрийн хүрээний айл болгонд нэг нэг хонуулж залхаасан нь түүний зүрхийг үхүүлэх, бас Есүхэйн хуучин өндөр нэр хүндийг мартуулах тайчуудыг боржигон аймгийнхнаас дээрд үзүүлэх гэсэн санаа байв.

Гэтэл Тэмүжин Таргудайн бодсон шиг хялбар дорой хүн биш ажээ. Түүний санасан шиг уйлж унжин, аврал өршөөл эрсэнгүй, бүр чармай нүцгэлж тэргэн дээр тэлж залхаасан ч дор үг хэлсэнгүй нь Таргудайн уур цухлыг баржээ. Гэтэл өдөр бүр балчир хөвүүнтэй зууралдах нь зохисгүй тул түүнийг айл айлд хонуулж тэдэнд харгалзахыг даалгасан нь Тэмүжинд зугатаах боломж олгожээ. Олны найр задгайрахын цагт манаж байсан хялбар хөвүүнийг цохиж унагаад Ононы усанд хэвтэн нуугдсан Тэмүжинг үзсэн Сорхоншар гэгч хэлсэнгүй, харин ч

дараа нь унаа, хүнс өгч явуулжээ. Тэр Сорхоншар гэгч нь Тайчуудыг дагаж явсан Сүлдүсэн овгийн боол хүн тул дотроо Тэмүжинг тэгэж дарлагдахад дургүй байжээ. Ийн Тэмүжиний гавшгай, зоримогийн ачаар амиа авран ирсэн нь тэдний гэр бүлд дэвжин дээшлэхийн дохио болсон мэт Өүлэнд санагджээ.

Хөвүүн нь ирмэгц өрх гэрийн амьдрал тэгшрэн дүүрэх шиг болж ярилцаж зөвлөөд Тэмүжиний хэлснээр даруй нүүж тайчуудын дахин олохгүй газар нуугдах нь зөв гэж шийджээ. Энэ бол Өүлэний хувьд анх удаа Тэмүжиндээ өрхийн дотрох эрхийг бүрэн шилжүүлэн өгснөө илэрхийлсэн явдал болжээ. Үүнээс хойш Өүлэн зөвхөн Тэмүжинд зөвлөх л эрхтэй хоцорчээ. Тэмүжиний гаргасан шийдвэр ёсоор нүүж, Хасар Билгүтэй бүр Хачиун Тэмүгэ ч балчир гэлгүй харвах цавчих сургуулийг өдөр бүр хийх болжээ. Тэмүжиний удирдлагын дор ингэж хэдэн жил амар суув. Тайван амгалан, нууцгай амьдралдаа дасаж одоо түүнээс хэн ч хөвүүдийг нь булаан авахгүй юм шиг, бас өсөж, булчин шөрмөс чангарч харваж цавчих нь мэргэн шаламгай болсон хөвүүд нь хэнд ч дийлдэхгүй юм шиг Өүлэнд санагдах болжээ.

Энэ бол зөвхөн эх хүний үрээрээ бахархах сэтгэлээс өөр юу ч биш байлаа. Харин Өүлэн Тэмүжин хөвүүнээ үүрд алдана гэж санасангүй. Дайцэцэний охин Бөртэ Тэмүжинд ирснээр амьдрал нь тийм их өөрчлөгдөнө гэж Өүлэн таасангүй.

Тэмүжин хөвүүнийг нь Хэрэйд аймгийн Тоорил хан өөрийн гэрт жил гаран суулгахад ч Өүлэний сэтгэл санаа ингэж хувираагүй билээ. Одоо Тэмүжин Өүлэний хүү биш, Бөртэ гэгч харь цусны бүсгүйн эр нөхөр болов. Эхтэйгээ ярьж уулзах нь цөөрч Өүлэн Тэмүжиний хувьд Бөртийн дараагийн зиндааны хүн болон хувирсан нь гомдолтой ч энэ нь ганц Тэмүжинээс болсонгүй. Хөвүүд нь бүгд хүний хүн болон эхийгээ мартана гэдгийг мэдэж байлаа. Дагахаас өөр аргагүй амьдралын жам боловч өрсөлдөн тэмцмээр, өмчирхөн булаацалдмаар гомдол, харуусал гэнэ гэнэ төрдөг байв.

Хүний хүүхэнд эр бэлдэж өгөх гэж шөнөжин нойргүй, өдөржин завгүй амьдарсан мэт санагдсан нь нэг биш. Гэвч аз жаргалтай яваа Тэмүжинг харахад юу ч хэлж эс чадна. Тийм эрх эх хүнд үгүй юм. Төрүүлсэн үртэйгээ аз жаргал, амьдрал булаацалдан мөчөөрхөх эх гэж хаана байдаг билээ. Хүүгээ гэрлүүлсэн эх хүн бүрт баяр бахдалтай хамт ийм нэгэн гуниг нууцхан төрдгийн учрыг Өүлэн ч үзэж мэдэрчээ. Тэмүжин өдөр өдрөөр эхээсээ холдсоор байлаа.

Бөртийг мэргэдээс буцааж булаан авч, Боорчи дагуулан ирэхийг үзээд Өүлэн Тэмүжин хөвүүндээ гомдох сэтгэлээ хүчээр мартахад хүрэв. Нааш ирэх замд төрсөн улаан нялзрай хүүгээ тэвэрсэн Бөртийг цурхиран уйлж сөхрөн суухад нь чухам энэ хөөрхий эх, хүү хоёрыг одоо мэргэдээс биш Тэмүжинээс хамгаалах хүн нь ганцхан өөрийгөө гэдгийг Өүлэн ойлгов. Залуу хүний хар хор, гуниг шаналалаар өвчилсөн Тэмүжинээс Зүчи, Бөртэ хоёрыг хамгаалан эрс тэмцсэн хүн нь Өүлэн байв.

Өүлэний энэ гайхалтай хатуу чанд эсэргүүцлийн үрээр Бөртийг бас мэргэдийн цустай Зүчи хөвүүнээ Тэмүжин уучилсан юм.

Өүлэн Зүчийг яг л өөрийн төрүүлсэн үр шиг өсгөсөн билээ.

Тэмүжинг уярааж зөөллөхийн тулд Өүлэн түүнээс юугаа ч нуусангүй. Бүр бүх хөвүүдээ суулгаж байгаад өнөөг хүртэл нууц явсан өөрийн түүхийг өгүүлэв. Бүр мэргэдийн их Чилэдү ирснийг түүнийг Хасар харван алсныг ч нуулгүй хэлэв.

-Бөртийн үзсэн зовлон шаналалд ганц би л буруутай. Есүхэй эцэг чинь намайг булаан авснаас бүх хэрэг үүсэв. Тийм болохоор Тэмүжин чи ганц намайг зэмлэ гэж эхийнхээ хатуу хэлсэнд Тэмүжин туйлгүй цочиж гэмшсэн билээ.

Бөртэ Зүчи хоёрыг хамгаалахын тулд Өүлэн өөрийн болоод Есүхэйн нэр төрийг хайрласангүй. Энэ явдал Бөртэ Зүчи хоёрын хувьд аврал болжээ

-Эцэг эх биеийг төрүүлэхээс сэтгэлийг үл төрүүлнэ. Чи л энэ Зүчи хөвүүнд ямар сэтгэгдэл төрүүлж чадна, тэр яг тийм хүн болно гэж Өүлэн бүгдийн өмнө Зүчийг тэвэрч суугаад хэлэхэд хэн нь ч хариу үг хэлж чадсангүй. Зөвхөн Бөртэ л уярч баярлахдаа мэгшин уйлж суув.

-Та нарт одоо өөрийн үнэнч нөхөд хэрэгтэй. Ганц хүн ч ганцдахгүй. Тэмүжин чи удахгүй өөрийн үртэй болно. Тэр цагт Зүчи чиний ууган хөвүүн болно. Үүнийг бүү март гэсэн Өүлэний үгийг хэн ч буруутгаж эсэргүүцэхийн арга байсангүй.

Тэр тусмаа Тэмүжинд бүр ч хэлэх үг олдсонгүй билээ. Тэмүжин эхийнхээ хэлснийг хүлээн зөвшөөрөв. Ингэж Өүлэн өрх бүлийнхээ дотор алдсан эрхээ бага боловч эргүүлэн олов. Хамгийн гол нь Есүхэйн удамд Бөртэ үүрд үлдэж, Тэмүжин түүнийг нэг үзүүрт сэтгэлээр хайрлах болсонд Өүлэн их баяртай болжээ.

Бөртийг нэгэнт Тэнгэрийн зараалаар Есүхэйнд ирсэн хүн гэдгийг ойлгуулж чадсан нь Өүлэний гавьяа юм. Бөртэ ирснээр Тэмүжиний өрх гэр үүсэж, Зүчи төрснөөр өсөж үржих үүд нээгдэв.

Харин Бөртэ Өүлэний бодсоноос хавьгүй ухаантай, гайхалтай тэвчээртэй бүсгүй байжээ.

Өүлэнг төрсөн эхийн адил хүндэтгэж асардаг хүн нь эцэст нь ганц Бөртэ болсон билээ.

*****

Амьдрал гайхалтай хурднаар өөрчлөгдөж зарим нэг тохиол учралын цаад наад нарийн учир явдал, шалтгаан үр дагаврыг Өүлэн тэр бүр ухаж, мэдэж урьдаас тааж чадахгүйгээ нэгэнт ойлгов. Өдөр өнгөрөх бүр түүний мэддэг юмс хялбархнаа хувиран өөрчлөгдөж одоо тэр тээж төрүүлсэн хөвүүдээ, туулж өнгөрүүлсэн амьдралаа ойлгож танихад бэрх болсоор байв. Хөвүүд нь өрвөлгөө хийсгэсэн өрөвдөлт ангаахай биш, өд сөд, жигүүр даль нь ургаж гүйцсэн хүчирхэг бүргэд шувууд болжээ.

Тарж бутарсан Боржигон аймгийн хагас нь Тэмүжиний дэргэд цугларч түүнийг хан өргөмжилсөний хойно Өүлэн анх удаа болж буй явдлыг, бас ирэх өдрийн төөрөг тавиланг өөрийн эрхгүй тунгаан бодоход хүрчээ. Түүний гэр бүлийг тойрон Боржигон аймгийн арван түмэн иргэд бөөгнөрчээ. Энэ бол бага юм биш. Гэхдээ мах зуусан гөлөг хэзээд л том нохдын аманд хоолоо булаалгах тавилантайн адил Тэмүжинг одоо зэргэлдээ Хэрэйд, Мэргэд, Тайчууд

аймаг довтлон ирэх нь гарцаагүй болжээ. Үхэж болохгүй бас бууж өгч болохгүй тийм цаг үе ирснийг Өүлэн ойлгов. Баян хүчирхэг болох тусам олз булаалдах дайсан олон болж, бас үүнтэй зэрэгцэн бусдаас булаан авах хүсэл шунал ч цуг нэмэгдэх ажээ. Тэмүжин болоод Хасар бусад хөвүүд тэдний нөхдийн нүднээс айдас, түгшүүрээс илүү авах булаах шуналын гал хүчтэй дүрэлзэхийг Өүлэн тод үзсэн нь түүнийг ингэж бодолд унагасан билээ. Өүлэний цорын ганц гэгээн хүсэл нь үр хүүхдээ амар мэнд харж элэг бүтэн тайван амьдрах явдал юм. Тэр Есүхэйд булаагдан ирснээс хойш ер нэг өдрийг ч болов сэтгэл амар өнгөрүүлсэнгүй мэт.

Тэмүжин хөвүүнийг нь Хабул хаан,Хотула хаан, Нэгүүн тайшийн үр сад нийлэн Боржигон аймгийн ханд өргөмжилж “Чингис хаан” хэмээх сүр хүч дуурссан цол соёрхон наадам цэнгэл хийхүйд найрын хойморт хөвүүнийхээ зүүн гарт сууж ахуйдаа Өүлэн нэн их жарган уярч өөрийн эрхгүй нулимс унагав.

Түүнд анх Тэмүжин хөвүүнээ төрүүлсэн үеийнх шиг бахархалтай байлаа. Энэ бол үхлийн дунд амьд үлдсэний их баяр байв. Бас өнгөрүүлсэн зовлонт амьдралын төгсгөл, шинэ оньсого шиг таахад бэрх амьдралын эхлэл байв. Есүхэйн амьд сэрүүн ахуйд энэ дайны найр наадам бишгүй үзсэн мөртөө юу ч үзээгүй залуу охин шиг догдлон чичирчээ. Тэмүжинг Боржигон аймгийн ханд өргөмжилж

-Олон дайнд

Оройлон явж

Онц гуа Охидыг олзолж

Ордон сайхан

Гэрийг авч

Олны хаан Тэмүжинд өгье

Харийн иргэнийг

Халдан довтолж

Хацар гуа Хатдыг олзолж

Хатир сайт Агтыг хөөж

Авчирч өгье

Ороо гөрөөсийг Авлах цагт

Отож ойртуулж Өгье бид

Хээрийн гөрөөсийг Агнах цагт

Олж гаргаж өгье бид

Хатгалдах дайн Болох цагт

Хан Тэмүжин чиний Хатуу зарлигийг

Хайхрахгүй явбал

Хатан эмээс Хагацуулан салгаж

Хамаг юмыг Хаман авч

Хар толгойг минь Хаяж одогтүн

Энх цагт Эзэн Тэмүжин чиний

Эе зарлигийг Эс дагах аваас

Эзэлсэн ардыг авч Эм хөвүүдийг булааж

Энэ биеийг минь Эзгүй газар Хөөж орхи гэж Алтан, Хучир, Сачабэх гурав угсаат хүмүүний ёсоор олныг төлөөлөн бүсээ хүзүүнд тохож, өвдөг сөхрөн суугаад дээрх хатуу тангаргийг өндөр дуугаар өчжээ.

Тайчуудын олзонд жил тойрон байгаад ирэхэд нь хоёр хөмсөгний нь хооронд тогтсон гүн үрчлээ Тэмүжиний царайг огт өөр хүн шиг харагдуулах бөгөөд тэдний сүржин тангаргийн үгийг сонсохгүй мэт хэнэггүй царайлан зогсохыг үзээд Өүлэн их гайхав.

Харин Тэмүжинээс сөөм өндөр нуруутай Хасар бахдалтайгаар инээмсэглэн эдгээр хүмүүс чухам түүнд тангараг өргөж байгаа юм шиг үг бүгдийг шуналтайгаар залгиж зогсов. Хоёр хөвүүний эл ялгаатай байдлыг үзвэл Тэмүжинг биш Хасарыг ханд өргөмжилж байгаа мэт ойлгогдохоор ажээ.

Тэмүжиний наснаасаа оворжуу харагдах царайнаас түүний сэтгэлийн дотрох баяр бахдалын шинж өчүүхэн ч үл илрэнэ. Тэр багын дотуур тамиртай хүнд сайн муу боловч өөрийн нууцыг дэлгэх дургүй хачин гөжүүд хүүхэд байсан юм.

Харин Хасар яг түүний эсрэг сэтгэлийн хөдлөл нь харц, хөдөлгөөн, царайд нь агшин төдий зуур илэрдэг, ил шулуун үгтэй, баярлаж гомдох, тайтгарах тайвшрах нь хурдан, хоргүй цагаахан сэтгэлтэй билээ. Хэдий ийм үзэгдэх царай, үг хэл өөрч хоёр хөвүүнээ яг адил хүсэл тэмүүлэлтэйг мэдээд Өүлэн цочсон билээ. Хасарын царайд илэрсэн хан болох оргилсон хүслийг Өүлэн харжээ. Тэмүжинд атаархсан сэтгэлээ Хасар тэвчин нууж байсан ч эхийн нүдэнд ил өртөв. Чухам энэ явдал Өүлэнг түмэн бодол мянган эргэлзээнд унагав. Өүлэний түгшүүр, совин үнэн болохыг, бас хөвүүдийн нь хооронд гүн гүнзгий далд зөрчил үүсэхийг мэдэрчээ. Үүнийг удаан хүлээх хэрэг байсангүй.

Тангараг өргөж, их найр задгайрахын цагт өглөөнөөс хойш олны гайхашралыг төрүүлэн

хүрэл царайлан таг дуугүй суусан Тэмүжин босож гараа өргөв. Энэ бол хан болоод анх удаа үг хэлэх гэж буй хэрэг тул олон бүгдээр анхааран таг дуугүй болцгоов. Тэмүжин нэгэн хэсэг дуугүй зогсов. Түүний юу гэж хэлэхийг хэн ч,түүний дотор Өүлэн ч таасангүй. Угаас Тэмүжин ийм тайлагдашгүй оньсого шиг хүн билээ.

-Өнөөдөр та нар Есүхэйн ууган хөвүүн Тэмүжин намайг сонгож Боржигон аймгийн ханд өргөмжилсөн нь дээд Тэнгэрийн зарлигийг дагасан хэрэг биз. Бидний дотор Тэнгэрийн зарлигийг дагахгүй хэн байх билээ. Би ч Тэнгэрийн зарлигийг дагаж та нарын андгай тангаргийг хүлээн авлаа. Хэлснээ хийж, хэлцсэнээ сахигтүн. Тэгвэл бид цөөхүүл, өчүүхэн буурай ч ихийг хийж, олныг дагуулах болно. Ангайсан ам, андгайлсан үгээ буцсан хэн боловч Тэнгэрийн гэсгээл амсаж, толгой биенээс хагацах болно. Нэгэнт та бүгдээр дээд Тэнгэрийн таалал ёсоор намайг ханд өргөмжилсөн тул миний үг зарлигийг Тэнгэрийн зарлиг гэж хүлээн авч дагагтүн. Тэмүжиний энэ үгийг бүгд нам гүм сууж сонслоо.

Энэ бол Тэмүжиний сүүлийн хэд хоног хэлэх гэж бодоод олоогүй үгс юм.Y нэхээр Тэмүжин ханд өргөмжлөгдөөд юу гэж хэлэхээ мэдэхгүй тулгамдсаар байлаа. Түүний дэргэд тэг гээд зөвлөчих хүн байсангүй. Эцсийн мөчид Алтан, Хучир, Сачабэх гурав тангараг өргөж байхад гэнэт Хөхөчү санаанд нь орсон билээ. Хөхөчү санаанд нь ормогц түүнтэй хамт дээд Тэнгэрийн зарлиг гэсэн үг сэтгэлд нь тодрон буужээ. Мэнлигийн хөвүүн ид шидэт Хөхөчү хол байгаа ч одоо яг дэргэд нь суугаад хэлэх үгийг нь зааж байх шиг Тэмүжинд санагджээ. Тийм ч учраас Тэмүжин дээрх үгсээ хэлэхдээ өөрийн эрхгүй хоёр гараа өргөн Тэнгэрт сунгав. Тэнгэрт ингэж хандахыг тэр Хөхөчүгээс сурсан билээ. Хичнээн удаа Хөхөчүг дууриаж Тэнгэрийн үгийг сонсохыг хүссэн боловч чадаагүй юм.Г этэл одоо хэн нэгэн түүнд хэлэх үгийг нь шивнэж байлаа. Энэ бол Тэмүжин Тэнгэрийн үгийг сонсов уу гэлтэй, сонссондоо итгэмгүй тийм явдал болжээ. Тэнгэрийн хүслийг сонсож болно гэж Хөхөчү худлаа хэлээгүй ажээ.

Үг дуу цөөнтэй түг таг яриатай Тэмүжин хөвүүнээ гэнэт ийм гайхалтай уран гүнзгий үг хэлж хурсан олныг хормын төдийд бишрүүлэн эзэмдэхийг Өүлэн гайхан харж, Тэмүжин хөвүүнээ даган өөрийн эрхгүй хоёр гараа дээш сунгав. Хурсан олон бүгдээр Тэнгэрийн далд хүчинд автан нэгэн зэргээр сөхрөн сууж Тэмүжинд мөргөжээ. Анх нуурын эрэгт амиа үйн үхэхээр ирэхдээ Тэмүжин хөвүүнээсээ мэдэрсэн тэр далд ид шидийн хүчийг Өүлэн дахин мэдэрчээ. Тэмүжин хөвүүн нь Тэнгэрийн зараалаар мэндэлсэн болохыг Өүлэн дахин үзэж итгэв. Тэгэхэд сарны гэрэлтэй хамт Тэмүжиний биед шингэж байсан хүч одоо Тэмүжинээс түгэн эргэн тойрондоо гэрэлтэн цацарч байхыг Өүлэн харав.Бас энд суусан бүх хүмүүс үзэж буй гэдэгт ч итгэжээ.

Тэмүжиний биенээс цацарсан гэрэл тэнгэрт гарч солонго болон тогтсон нь Тэмүжиний үгийг Тэнгэрийн зарлиг гэж итгэн, бишрэн дагах сэтгэлийг хүчтэй болгох ажээ. Ингэж Тэмүжин хөвүүн нь ганц хормын дотор Тэнгэрийн ивээлд багтсан түмний эзэн болон тодрохыг Өүлэн үзэв. Тэмүжиний биенээс цацарсан гэрлийг Өүлэнээс өөр хүн олж харсангүй. Харин тэнгэрт татсан солонго бүгдэд үзэгджээ.

Гэвч сэтгэл хөдөлгөсөн энэ баяр хөөр удаан үргэлжилсэнгүй. Учир нь Хасар хөвүүн нь өөрийн атаархал хүслийг эхийнхээ нүднээс нууж эс чадаад найрын талбайгаас холдон явахад Өүлэн ихэд айжээ. Хасар хөвүүнээ тайвшруулан сэрэмжлүүлэхгүй бол хөвүүдийн нь атаархал

хүсэл эцэстээ юунд хүргэж болохыг Өүлэн бүрэн таамаглаагүй ч ирэх аюулыг мэдрэн түгшжээ. Гэвч Тэмүжиний юу гэж шийдсэнийг даанч таах аргагүй билээ

.Хасарыг ямар цохилт хүлээж байсныг Өүлэн ч Хасар ч мэдсэнгүй. Үдэш болж найр өндөрлөхийн өмнө өдөржин Зүчи хөвүүнээ тэврэн таг дуугүй суусан Тэмүжин дахин босч гараа өргөсөнд халамцсан согтсон олон тэр даруй нам гүм болжээ. Тэд шинэ эзнийхээ үгийг ийм амархан сонсож сурсан гэхэд хараад ч итгэх аргагүй ажээ.

-Боржигон аймгаа эргүүлэн нэгтгэсэн нь Тэнгэрийн зарлигаар болжээ. Би аймгаа хоёр хуваан баруун зүүн гарын түмэн болгохоор шийдэв. Миний төлөө хамаг ихийг хийж зүтгэсэн багын үнэнч нөхөд Боорчи Зэлмэ хоёроор баруун зүүн түмнийг захируулж аймгийн дотрох бүх хэргийг миний хоёр нөхөр надтай зөвшин шийдвэрлэх болно. Миний энэ үгийг Тэнгэрийн зарлиг гэж дагагтүн гэжээ.

Энэ бол ганц Хасарыг биш сонссон бүгдийг гайхан алмайруулсан гэнэтийн явдал болов. Бэгтэрийг алахад оролцвол гэрийн дотрох удаах эрхийг өгөхөөр амалсан нь эрт багын хэрэг болов ч тавьсан тангараг элэгдэж хуучрах ёс монголчуудын хувьд үгүй тул Хасар яг ингэж итгэн нэгэнт Тэмүжин аймгийн хан болсон болохоор түүнд аймгийн дотрох удаах эрх ногдоно гэж догдлон хүлээж байсан нь талаар болов. Гэтэл Тэмүжин Хасарыг хүн гэж тоосонгүйгээр барахгүй түүнийг өргөмжилсөн Сачабэх Алтан Хучир нар болоод ахмадууд юу гэхийг ч бодсонгүй. Энэ шийдвэр Тэмүжиний хувьд санамсаргүй буюу гэнэтийнх биш байв.Ингэж шийдэхийг тэр ганц энэ найрын дундуур бодож олсонгүй. Бас Тэнгэр ч түүнд хэлсэнгүй. Аймгийн олон албат ойр дотно нөхөд ахмад хүмүүсээс Тэмүжинд эргэлзэхгүй үнэнч зүтгэх хэлснийг нь шүүмжлэхгүйгээр хэрэгжүүлэх хүмүүс нь чухам Боорчи Зэлмэ хоёр гэж тэр сонгожээ.

Тэмүжин өөртөө үнэнч шударга нөхдөөрөө өөрийгөө хүрээлүүлж санасан хэргээ биелүүлэхээр шийдсэн билээ. Энэ гэнэтийн цочмоор шийдвэр нь хожим хойшдийн их үйлийн гарцаагүй зөв эхлэл болохыг ч мэдэж байв. Ийм ч учраас Өүлэн эх болоод Хасарын гомдлоос айсангүй. Амбагай хаан,Хотула хаан,Нэгүүн тайшийн үр удмын зүгээс гаргаж болох эсэргүүцэл эгдүүцлээс, бүр тэд салж явахаас ч айсангүй билээ. Шинэ бөгөөд зөв шийдвэр ямагт эсэргүүцэлтэй тулдгийг Тэмүжин мэддэг болжээ.

Өүлэн эх нь учирлаж сануулан дуугүй ширтэхийг, Хасар найрын дундуур явж одохыг харсаар болов ч анзааараагүй мэт суужээ.Өүлэн эх нь хамгаас ихээр шаналан зовохыг ч мэдэж байв. Гэвч Тэмүжинд өөр зам байсангүй. Тэмүжин Боржигон аймгийн ханаар өргөмжлөгдсөн нь Есүхэйн удам албат иргэдийн баяр бахдалыг бадраасан хэрэг болов ч Өүлэний сэтгэлийн зовлонгийн эх болжээ.

Нэг мах цуснаас урган төлжиж унаж төрсөн хоёр хөвүүн нь зан ааш эрс тэс өөр тэр бүү хэл өрсөлдөн тэмцэлдэх нь илэрхий болсон нь ингэж зовоход хүргэв. Тэмүжиний хорон нууцлаг зан төрх Хасарын ил цагаан түргэн ааштай яг өдөр шөнө шиг яг л гал ус шиг харшлах ажээ. Тэмүжин Боржигон аймгийн хан болсон нь Тэнгэрийн зарлиг болохыг Өүлэн нэгэнт мэдэрч ойлгов. Гэтэл Хасар үүнийг үл ойлгох бөгөөд юухан дээр ч болов ахтайгаа өрсөлдөн мөчөөрхөх болсон нь чухам Тэнгэрийн гэсгээл гэмээр байв.

Аймгийн дотрох хамаг хэргийг Тэмүжин өөрийн үнэнч шадрууд болох Боорчи Зэлмэ хоёрт даалгасан нь Хасарын гомдол хорслыг бадраасныг Өүлэн тодорхой мэдэж байв.

Тэмүжиний энэ шийдвэр үнэхээр ноцтой осол гаргаж мэдэх тул аймгийн бүх ихэс ахмадууд бүү хэл жирийн ардын тэр дундаа Боорчи Зэлмэ хоёрыг ч гайхашруулсан билээ. Харц боол Зэлмийг, хөндлөнгийн ардын хөвүүн Боорчийг ингэж өргөмжилсөн нь Боржигон аймгийнхны хувьд урьд өмнө үзэж сонсоогүй хэрэг байв. Алтан Хучир Сачабэх гээд удам судартай угсаа гарвалтай ахмад настай баян чинээлэг хүмүүс олноор байтал туу гэх нохойгүй чүү гэх морьгүй шахам тэднийг өргөмжилсөн нь дөнгөж нэгдээд байсан Хиад Боржигон аймгийнханд эргээд задрах аюулыг илэрхий бий болгожээ.

Олон хүн муу ёрлон бодсон нь ёсоор болж аймгийн дотор их эрх эдлэнэ гэж бодсон Сачабэх Алтан Хучир нар салж явжээ.

Гэтэл Тэмүжиний хариу санамсаргүй бөгөөд аймшигтай байлаа.Сачабэх Алтан Хучир нарыг барин авчирч Ханд өргөмжлөхдөө өргөсөн тангаргийг нь сануулж байгаад олны өмнө цаазалжээ. Хэн ч тэднийг өмөөрөн боссонгүй. Тэмүжин ингэж өөрийн байр суурь нэр төрийг бэхжүүлэн авчээ. Энэ цаазнаас хойш ахмадуудын зүгээс Тэмүжинг үл тоомсорлох байдал тасарчээ. Хиад Боржигон аймгийн хуучин ихэс дээдсийн дунд хамгийн их нэртэй гурван толгойлогчийг цаазалснаар Тэмүжин Боржигон аймгийн хэмжээгүй эрхэт эзэн болсноо батлав. Залуу Тэмүжиний гараар бутарсан аймгаа нэгтгээд эцэст нь өөрийн болгоно гэж тохиролцоод байсан тэдний далд санаа талаар болж амиа алдацгаав.

Тэд үнэхээр өөрсдийн ирээдүйн эрх мэдлийн төлөө Тэмүжинээр хүндийг үүрүүлж хүчрийг туулуулахаар үгсэн тохироод Есүхэйн хөвүүнийг ингэж уриалгаханаар өргөмжилсөн билээ. Харин Хасарыг ядаж боол Зэлмийн оронд өргөмжлөхийг хүссэн хүлээсэн хүн цөөнгүй байлаа. Гэтэл Тэмүжин ингэхийг хүссэнгүй. Тэмүжин хөвүүнийхээ далд нарийн санааг Өүлэн сайн ойлгож байлаа. Тэмүжин аймгийг дотрох эрхийг хэнтэй ч хуваахыг хүссэнгүй ажээ. Тэмүжиний нууцгай дуугүй төрхийг цаана ямар гүнзгий бодол санаа нуугдаж байгааг Өүлэн бүрэн тааж мэдэхгүй ч яг ингэж ойлгожээ.

Тэмүжин урьд өмнө хэний ч явж байгаагүй замаар явж бүгдийг цоо шинээр хийхийг хүсч байгаа нь илт байв. Өөртөө хамгийн үнэнч, амиа ч өргөхөд бэлэн Боорчи Зэлмэ хоёрыг өргөмжилсөн нь үүнийг батална. Тэмүжинг ханд өргөмжилсөн найр өндөрлөж бүгд чив чимээгүй тарж одсон билээ. Өөрийгөө Боржигон аймгийн дотор нэр нөлөөтэй гэж бодсон бүхэн урамгүй буцахыг Өүлэн харж хоцорчээ.Тэмүжин хөвүүн минь энэ гэнэтийн шийдвэрийнхээ золиосонд яах бол гэж шаналан бодож байлаа.Учирсан зовлон бүгдийг эв нэгдлийнхээ хүчээр хамтран туулж ирсэн гэр бүлийг нь Тэмүжиний энэ шийдвэр эвдэн бусниулж хаясан шиг Өүлэн гашуудал түгшүүр дүүрэн болжээ.

Найрын дараа Хасар өөрийн албат хүрээгээ нүүлгэн тусдаа суухаар одсон нь Өүлэнг амьдаар нь тамлан үхүүлсэн мэт санагджээ.Хасарын нүүсэн нь аймгийн дотор онцлох эрх олгоогүйд эгдүүцэж хорссон сэтгэлийн илрэл байв.Гэвч Хасар ингэж ил тодоор хэлээгүй ч Тэмүжин болон бүгдээр тэгэж ойлгожээ.Өүлэн яах учраа олохгүй болов.Хоёр хөвүүн нь салж нүүсэн нь жирийн нэг билчээр газрын хуваарь төдий хэрэг биш байв.Одоо хоёр хөвүүн нь уулзвал үг биш илд зөрүүлэхэхэд бэлэн болжээ.Хасарын ингэж салан нүүж тусгаар суух болсныг

Тэмүжин огт эсэргүүцэн шүүмжилсэнгүйгээр барахгүй дэмжин сайшаасан ч дотроо юу гэж бодож буйг таахын арга байсангүй.

Өүлэн Хасар хөвүүнээ Тэмүжиний далд аюултай санаанаас хамгаалах уу эсвэл Тэмүжинг Хасарын эсэргүүцэл дайралтаас хамгаалах уу гэдгээ шийдэж эс чаджээ.

Тэмүжин Хасар хоёрын хэн нь түрүүлэн дайрахыг мэдэх арга даанч алга байв. Хасар тэвчээргүй түргэн омголон зантай тул гэнэдэн Тэмүжиний хорон санааны золиос болох нь хялбар санагджээ.

Зовж зүдэрч туулж ирсэн хүнд хүчир амьдрал нь төгсөж үрийнхээ ачыг үзсэн мэт жаргасан эхнийхээ жилд ийм аймшигт тамлалд унана гэж Өүлэн санасангүй. Ийн аргаа барагдахад тэрээр сэм явж Есүхэйн онгонд очиж мөргөжээ.

-Есүхэй чи сонсооч. Тэмүжин Хасар хоёр минь салж одлоо. Би тэднийг адилхан хайрлаж өсгөсөн юм. Одоо хөвүүд минь алалдан хөнөөлдөхөд бэлэн болжээ. Тэмүжин Хасар дүүгээ гэнэдүүлэн алах бий гэхээс элэг зүрх минь урагдаж энэ бие минь үйрэх шиг болно.Чи хэнийг, ямар амьтдыг надад үлдээгээд ганцаар минь хаяж одох чинь энэ вэ гэж аргаа баран уйлжээ.

Есүхэйн сүнс түүнд огт хариу хэлсэнгүй зөвхөн гунигт харцаар ширтсээр байжээ. Есүхэйн сүнсийг ийм гунигтай байхыг Өүлэн ер үзсэнгүй билээ.

-Хасар хөвүүн минь хиргүй цагаан бодолтой, халуун уян сэтгэлтэй юм. Тэр Тэмүжин ахдаа гомджээ. Гэтэл Тэмүжин аймгийн дотор удаах эрхийг амалсан ёсоор Хасар дүүдээ өгсөнгүй. Уг нь Тэмүжин дүүгээ өргөмжлөнө гэж тангаргаласан боловч тангаргаа няцжээ. Тэр хөвүүн юуны төлөө ингэнэ вэ. Есүхэй.

Би Тэмүжин хөвүүнийг чинь ойлгохгүйд хүрлээ. Түүний юу хийх гэж буйг надад хэлж өгч туслаач. Тэр арай Хасар дүүгээ хөнөөхөөр шийдсэн биш байгаа. Тэмүжиний харц сэтгэлд юу нуугдана вэ. Тэр дуугүй гөлгөр хөвүүн чухам юуг хүснэ вэ. Би тээж төрүүлж тэвэрч хөтөлж өсгөсөн хөвүүнээ танихгүй болжээ.

Надад хөвүүд минь бүгдээрээ хэрэгтэй юм. Хачиун хөвүүн чинь хүнд өвчтэй .Тэмүгэ хөвүүн чинь нялхдаад би ганцаардаж шаналж байна.

Өүлэний энэ үгийг Есүхэйн сүнс сонсоод хариу хэлсэнгүй нь тэр ч бас Өүлэний адил аргаа барсных байв. Ингээд Өүлэнд туслаж зааж зөвлөх хүнгүй болжээ.

Тэр бүх хэргийг өөрийн ойлгож мэдэрснээр шийдэхээс өөр аргагүй болжээ.

Есүхэйн онгонд мөргөж ирээд Өүлэн нүүж Хасар хөвүүнийхээ хүрээнд очиж суухаар шийдсэнээ Тэмүжинд хэлжээ.

Тэмүжин эхийнхээ үгийг сонсоод удаан дуугүй суув. Өүлэн ч дуугүй тэвчээртэй хүлээжээ. Өүлэн эх нь яагаад гэнэт ингэж нүүхээр болсныг Тэмүжин гадарлаж байв.

Энэ бол Хасарыг өмөөрсөн эхийн сэтгэл гэж ойлгов.

Ийм үед эхийнхээ үгэнд хариу олж хэлэх Тэмүжинд их хэцүү байлаа. Гэвч дуугүй суугаад байж болсонгүй:

-Ижээ Тэмүжин аль болохоор эелдэг зөөлөн дуугарахыг хичээж байв.

-Ижээ. Таны ингэж хэлсний учрыг би сайн ойлгож байна. Гэвч та төв хүрээнээс нүүж Хасарын хүрээнд очиж сууж яахан болох билээ. Та эвтэй бол хүчтэй гэж сургасаар ирсэн биш үү. Гэтэл хэлсэн үг сургаалаа няцаж юунд ингэнэ вэ. Таныг Хасарын дэргэд очвол харсан үзсэн бүхэн юу гэх вэ. Та бид хоёрыг эвдрэлцэв гэх бус уу. Эхдээ хаягдсан намайг хэн тоох билээ. Би хан сууж Есүхэй эцгийнхээ гэрээсийг биелүүлэхээс өөр хүсэлгүй. Хасарын гомдох нь цаг зуурынх биз. Ижий та аятай хэлж аашилж сургавал Хасар та бид хоёрын үгнээс гарахгүй. Өүлэн ижий та л миний үгийг сонсож үйлийг дэмжихгүй бол өөр хэн намайг дагах билээ. Таныг явчихвал миний улыг шагайж үхлийг хүссэн бүгдийн баяр болох биш үү. Та Хасар дүүд санаа бүү зов. Хасарын тусдаа сууж хүрээгээ засах чинь ер хүний ёс биз. Есүхэй баатрын үр сад өсөж хүчирхэгжиж буйн баталгаа болно. Та бол Есүхэй баатрын их хатан. Боржигон аймгийн хатан ижий юм. Та байх ёстой газраа сууж хэлэх ёстой үгээ хэлж байгтүн гэсэн нь Өүлэнийг хэлэх үггүй болгожээ.

Тэмүжин яагаад ийм ухаан сийрэг уран цэцэн болсоор байсныг Өүлэн ухаарсангүй явжээ. Үнэхээр сүүлийн жилд Тэмүжин огт танигдахын аргагүйгээр өөрчлөгдөн хувирчээ.

-Ижээ.Та бэлд. Хоюул өнөөдөр Хасар дүүгийнд айлчлан очъё. Надад түүнтэй уулзаж зөвлөх хэрэг байна гэсэн билээ.Тэмүжин ямар нэгийг бодож шийдсэн нь илт байв.Өүлэн ч Тэмүжиний үгийг дагажээ.

Тэднийг ингэж гэнэт ирнэ чинээ санаагүй тул Хасар Борогчин хоёр сандран хөл болжээ.

Хасарын хүрээ өргөжиж тэлээд одоо Тэмүжинийхээс ер дутах юмгүй хөндий дүүрчээ.Хасарын тусгаар суух болсноос хойш эх ах хоёр нь анх удаа цуг ирсэн нь энэ тул Хасар найр хийв.Тэмүжин ч яарч сандаргасангүй айвуу тайвуу суув.Найрын дараа их түүдгийн дэргэд гурвуул хоцорч удаан хууч хөөрчээ.Ингэж суухыг Тэмүжин хүсчээ.

Хэзээ ч ингэж олон үг хэлдэггүй Тэмүжинг бага нас, өнгөрсөн амьдрал,Есүхэй эцгийгээ дурсан бүр хоолой зангируулахыг үзээд Өүлэн Хасар хоёр уяран нулимс унагажээ. Үнэхээр хөвүүдийнх нь дотроос Тэмүжин шиг зовсон нь үгүй тул хөвүүнээ ихэд өрөвдөн хайрлажээ.Гашуун идээнээс нэг их хойш суугаад байдаггүй Хасар энэ үдэш огт уусангүй нь Өүлэнийг түгшээж хөвүүд нь яах гээд байгааг бүр мэдэхээ больжээ.

Түүдгийн оч тэнгэрт цацарч найртай сайхан дулаан шөнө эхлэжээ. Тэмүжин зүгээр нэг түүдгийн дэргэд сууж хууч хөөрөх гэж ирээгүй нь лавтай. Үнэхээр ч тийм байв.

-Хасар аа.Би чамтай нэгэн хэргийг зөвлөх гэж ирлээ гэж Тэмүжин гэнэт хэлэв. Хэн ч дуугарсангүй.

-Надад Бэрлүүд, Онгуд, Бэсүд гээд хэдэн овгоос дагаж ирэгсэд нийлээд хоёр тум хол илүү хүн болжээ. Тэдний цэрэг эрсийн тоо даруй хагас түм хүрнэ. Би энэ иргэдийг чамд өгье. Чи

цэрэг татаж засч сурга. Одоо Есүхэйн хөвүүд бид өөрийгөө хамгаалах биш өстнөө довтлон дарах их цэрэг засах цаг иржээ. Байлдах тулалдахдаа чамаас илүү хэн билээ. Боржигон аймгийн их цэргийг Хасар дүү чи засч удирдагтүн. Ийм эрхийг би чамд олгоё. Ижий ч ингэж бодож буйгаа надад хэлэв.

Тэмүжиний энэ санмсаргүй үг Хасарыг суусан газраас үсрэн бостол баярлуулж Өүлэнг цочоов.

Гэвч Тэмүжиний үгийг сонсоод дуугүй толгой дохижээ.Үүнээс өөрөө ч яах билээ.Тэмүжиний үгэнд баярлахгүй байхын аргагүй байв.

Хөөрч догдолсон Хасар хэлэх үгээ олохгүй болжээ.

-Хасар чи яваандаа миний их цэргийн жанжин болно. Би дүү чамаас өөр хэнд итгэж энэ хэргийг даалгах билээ. Есүхэйн хөвүүд эвтэй явбал хэнд ч дийлдэхгүй гэж ижий та сургадаг биш үү гэж Тэмүжин инээжээ .Өүлэн чимээгүй уйлж суув. Хасар гайхаж -Ижээ.Тэмүжин ах ийм баяртай үг хэлсэнд та юунд уйлав гэж хөхөрнө.

-Ижий нь та хоёрыг ингэж найртай суухыг хараад баярласандаа уйлав гэж үнэнээ хэлжээ.

-Ижээ.Та өнгөрсөн явдлыг март.Би Тэмүжин ахад ер гомдож санасан зүйлгүй гэж Хасар үнэн сэтгэлээс хэлсэн билээ.”Хасар хөвүүн минь даанч итгэмтгий гэнэн хүндээ” гэж бодсон ч дуугарсангүй. Хасарын хэлсэн үг нь чухам Тэмүжиний сонсох гэж хүссэн үг юм. Тэмүжиний гэнэт ингэж шийдсэн нь Өүлэнг гайхашруулжээ. Гэвч тэр Тэмүжиний ухаанд итгэж байв.

Өөрийнхөө ганц өрсөлдөгчид гэнэт их цэргээ засах эрхийг өгч дэмжсэн нь ойлгоход бэрх хэрэг байсан ч бас Тэмүжинд үүнээс өөр зам байсангүй билээ. Хасарын гомдсон сэтгэлээс ямар ч үйл гарч болохыг Тэмүжин мэдэж байлаа. Үүний хажуугаар Өүлэн эх нь Хасар хөвүүнээ илэрхий өмөөрөн дэмжиж байгаа нь ингэхээс өөр аргагүйд хүргэжээ. Бас шинэ хан Тэмүжинд гомдсон ахас ихэс түүнийг зайлуулахыг хүсэхдээ Хасарыг ашиглах нь илт тул ингэж шийдэхэд хүргэв. Хасарын өргөөнд хэн очиж юу гэж ярьсаныг ч Тэмүжин мэдэж байв. Хасарын албатын дотор итгэлтэй тагнуулаа суулгахаа Тэмүжин мартаагүй билээ.

Өрсөлдөгчид болон хорон санаатнууд Хасар тэдний хооронд үүссэн зөрчлийг ашиглан дөнгөж нэгдээд байгаа Боржигон аймгийг бутрааж түүнээс хан суудлыг нь булаан авахыг санаархаж байгаа нь илт байв.

Ийм үед тэдний энэ санааг таслан зогсоох ганц арга нь буулт хийж Хасарыг өөртөө татах явдал байсан билээ.Хасарыг Боржигон аймгийн цэргийн жанжинаар томилохоос өөр сайн аргыг Тэмүжин олсонгүй.

Энэ бүгдийг Өүлэн эхийнхээ нүүрэн дээр хэлсэн нь ч учиртай юм.

Хасарт Өүлэн эхийн үг ямар нөлөөтэйг бодолцсон хэрэг байв.Өүлэн түр боловч сэтгэл амарч Хасар Тэмүжиний даалгасан ажилд итгэл төгс урам зориг дүүрэн оржээ.

Хасартай буулт хийх замаар тэмцэж өөрийн хэрэгт ашиглах ёстойг Тэмүжин хан суусан эхний жилүүддээ сайтар ойлгож авчээ.

Хасарыг алдвал аймгийнхаа хагасыг алдсантай адил хэрэг болж давж дийлэшгүй дайсантай болохыг тэр сайн мэдэж байв. Ийм учраас цаг алдалгүй ингэж зоримог шийд гаргажээ.

Хасар эргээд дуулгавартай үнэнч сэтгэлтэй дүү болон хувирч цэрэг засах ажилдаа шуударчээ.

Цэрэг засах байлдаж тулах нь Хасарын төрмөл ухаан авъяас бөгөөд түүний чадварыг бүгдээр хүлээн зөвшөөрч удалгүй Хасар шилдэг хоёр түмэн цэргийг засжээ. Тэмүжин өөрийн шийдвэрийн зөв гэдэгт итгээд цэргийн бүх хэргийг голчлон Хасартай зөвлөх болжээ .Боржигон аймгийн дотор Есүхэйн хөвүүдийн дунд үүссэн аюулт зөрчил намдсан нь олон овог аймгийг айлгаж эхлэв.

”Есүхэйн хөвүүд та нар эвтэй байвал хэнд ч үл дийлдэнэ” гэж Өүлэн эхийн хэлдэг үнэн болоход одоо бүгд итгэв.

Өүлэн жаргалтай болжээ. Тэрээр Тэмүжин хөвүүнийхээ гайхалтай мэргэн ухаанд ихэд биширч түүнийг тоож хүндлэх нь нэмэгджээ. Тэмүжин одоо нэгэнт түүний хөвүүн биш болсныг ойлгов. Тэмүжин хөвүүн нь түүний нүдэн дээр эрх мэдэл дүүрэн шинэ эзэн болон хувирч байхыг Өүлэн бахархан харж байлаа.

Гэвч Өүлэн эхийнхээ үг сэтгэлд урьдын адил хүндэтгэлтэй ханддаг нь өөрчлөгдсөнгүйд тэр их баярладаг байв. Тэмүжин хөвүүнээ Тэнгэрийн зарлигаар мэндэлсэнд одоо Өүлэн бүр бат итгэх болжээ.

Анх төрөхөд нь ингэж бодсон боловч хатуу итгээгүй билээ.

…Тэмүжинг төрөхөд Есүхэй баатар эзгүй,татаартай тулалдахаар одсон байжээ.Тэмүжин эхийнхээ гэдсэнд олдсон цагаасаа л гайхшралыг нь барсан хүүхэд байв.

Энэ үед Есүхэйн бага хатан Сочигал бас бие давхар байсан нь эмсийн хооронд далд бяцхан өрсөлдөөнийг үүсгэжээ.Есүхэй зэрэг шахам бие давхар болсон хатдынхаа дундуур хэвгээд цодгор гэдсийг нь илбэн баяр хөөр дүүрэн байх үедээ хүүхдүүдээ дуудан эрхлүүлдэг байжээ.Тэгэхэд Сочигалын гэдсэн дэх хүүхэд эцгийнхээ дууг сонсоод хөдөлж байхад харин Өүлэний хүүхэд үхсэн мэт таг чиг байдаг нь даанч атаархалтай санагддаг байв.

-Сочигал.Чиний хүүхэд лав түрүүлж гарах байх.Эцгийгээ таниж хөдөлж байхыг нь үзвэл сүрхий баатар эр төрөх биз гэж Есүхэй өгүүлж бага хатнаа энхрийлж халамжлах нь улам нэмэгджээ.Тэгэхэд нь Өүлэний атаархал хорсол бадарч нээрээ гэдсэн дэх хүүхэд нь амьгүй мэт санагдаад шөнө бүр уйлж хонодог байв.Өүлэний байдлыг гадарласан асрагч эм Хуагчин нь

-Өүлэн санаа бүү зов.Чиний хүүхэд зүгээр.Харин ч ингэж дуугүй тэвчээртэй байгаа нь баатар эр төрөхийн шинж гэж тайвшруулдаг байжээ.

Өүлэн их хатны хувьд түрүүлж төрөхийг, түүний хөвүүн Есүхэйн ууган залгамжлагч болохыг туйлаас хүсч байв.Гэтэл хүсэхэд хясна гэгчээр хүүхэд нь хөдлөх ч үгүй байх нь гачлантай.Есүхэйг татаартай байлдахаар явсны дараа Сочигал байн байн өвдөх болсон нь Өүлэний хүсэл биелэх хувьгүйг батлаж хүрээ даяараа ганц Сочигалыг тойлж Хуагчин асрагч нь хүртэл Сочигалыг сахин хонох болжээ.Өүлэн хээр гадаа ганцаар хаягдсан мэт гунигт автав.Тэр одоо бага хатан Сочигалаас сүүлдэж хүүхэд төрүүлэх нь тодорхой болжээ.

Тэр шөнө Хуагчин урьдын адил Сочигалыг сахихаар явсан тул Өүлэн гэртээ ганцаар хэвтэж байв.Гэтэл гэнэт гадаа сар гарах шиг тооноор гэрэл тусах шиг болжээ.Өүлэн зүүдэлж байх шиг сананагджээ.Өнөөх хичнээн сар үхсэн мэт байсан хүүхэд нь хөдөлж бүр гарах гэж бачимдан дотроос түг түг балбаж байжээ.Баярлаж хөөрөхийн завгүй гэнэт бие нь эвгүйрч хашгирч хүн дуудах сэхээ ч байсангүй.

Хормын дотор түүний хэзээ ч үзэж мэдээгүй явдал болжээ.

Өүлэнг өнөө хүүхэд нь хөтөлж удирдаж байх шиг санагдав.Өүлэн нэгэнт өөрийн биеийг мэдэхээ болиод хүүхдийнхээ аяыг дуулгавартайгаар дагажээ.Гэнэт хоёр хөлийн хооронд аравгар улаан амьтан унаад учиргүй чангаар бархиран уйлж эхлэхэд л сая сэхээрч ухаан оржээ.Хүүхэд нь гарахад өчүүхэнч өвдсөнгүй нь хачирхалтай.Өүлэн ч хүүхдээ даган уйлжээ.Ингэж Тэмүжин төрөхөөсөө л эхийнхээ гайхшралыг барж эхэлсэн билээ.

Эхийнхээ яарсан сэтгэлийг ойлгоод Тэмүжин Сочигалын Бэгтэрээс даруй сарын өмнө төрсөнд Өүлэн хөвүүнээ Тэнгэрийн зарлигаар төрөв гэж бодоход хүрчээ.Үхсэн мэт таг чиг байснаа яг хүссэн үед нь төрсөн Тэмүжин хөвүүн нь өнөө ч оньсого мэт зантай хэвээр өсжээ.

Эх хүү хоёрын уйлах их чимээнээр сандран гүйж ирсэн Хуагчин үнэхээр үзсэнээсээ болоод ухаан алдах дөхжээ.Ус цусанд холилдсон эх хүү хоёр хүйгээ ч таслалгүй тэврэлдэж сууж байв.

-Би чамд хэлээгүй юу гэж Хуагчин уйлан шивнээд хүйг нь тас хазаад гэзэгээ сугалан боож өгсөн билээ.Төрмөгцөө нүдээ нээж энэ тэрийг оноож хардаг тийм хүүхдийг урьд өмнө үзээгүй Хуагчин бяцхан хөвүүнийг ихэд биширчээ.Хөвүүнийг угааж өлгийдөөд Хуагчин гарч бүгдийг сэрээн Есүхэй баатар залгамжлагчтай болсныг зарлаж хүрээ даяар бөөн баяр хөөр болж байхад л Өүлэн сая нэг сэтгэл нь тайтгарч тэгшрээд хөвүүн төрүүлсэндээ итгэж Тэнгэрт талархан мөргөжээ.

Тэнгэр Өүлэний хүслийг тааж тэр Сочигалаас түрүүлэн хөвүүн төрүүлжээ.Харин шинэ төрсөн хөвүүний нь өлгийний энгэр заамаар гэрэл цацарч байхыг хараад ихэд гайхан яаран задалж үзэв.Хөвүүний нь тас атгаастай зүүн гараас тэр гэрэл цацарч байжээ.Нарийхан эмзэг хуруунуудыг нь салгаж тэнийлгэн үзвэл алганд нь галт улаан чулуу гэрэлтэж байлаа.Тэр чулуу хүн хармагц гэрэл нь унтраад тэр дороо бяцхан нөж болон хувирсанд Өүлэн ихэд айж дэмий юм хийв гэж харамссан ч хожимджээ.Энэ бол Тэнгэрийн тэмдэг болох нь гарцаагүй байв.

Хуагчин орж ирээд хөвүүний атгаж төрсөн нөжийг хараад баясан догдолж

-Хөвүүн хүүхэд нөж атгаж төрөх нь эр зоригтойн шинж гэдэг юм гэж тайвшруулсан билээ.

Тэмүжин ингэж төржээ.Харин Хасар бол тэс өөр бүр гэдсэнд байхын хачин их хөдөлгөөнтэй нойрон дунд өшиглөж тийчигнээд сэрээж орхидог бяртай хүүхэд байжээ.Хасарыг төрүүлэх гэж Өүлэн бэрх ихээр өвдөж шаналсан билээ.Олон хоног нойр хоол алдуулан өвдөж зовоосондоо тэр юм уу Хасар эхдээ учиргүй дотно хайртай болж өсжээ.

Хасар шиг зовж төрүүлсэн нь Өүлэнд үгүй байв.Хасарыгаа харах бүр “Энэ хөвүүн миний зовлонгийн үр байх” гэж өрөвдөн боддог билээ.Хамгийн ихээр зовж төрүүлсэн үрдээ Өүлэн хамгаас илүүгээр хайртай болжээ.Хасарын багад

-Миний хөвүүн ижийгээ их зовоож төрсөн шүү гэхэд нь тэрээр омогтой цоглог нүдээрээ ширтэж эхийгээ зовоосондоо хачин ихээр харамсаж байгаа нь илт мэдрэгддэг байжээ.

Харин Тэмүжин гэдсэнд байхын л эхийнхээ хүслийг чив чимээгүй ойлгож мэддэг билээ.Тэмүжин хөвүүнийхээ атгаж төрсөн Тэнгэрийн тэмдгийг осолдож нөж болгон хувиргасандаа Өүлэн ихэд харамссан тул бодсоор хэрхэн хадгалах арга сэдэж олжээ.Харин хөвүүнээ Тэнгэрийн галт тэмдэг атгаж төрснийг Есүхэйг дайнаас буцан ирэхэд хэлсэнд тэр огт үнэмшсэнгүй. -Чиний ухаан балартаад буруу зөрүү хараа биз гэж хөхөрч өнгөрөөсөн нь гомдолтой ч Өүлэнд үзүүлэн батлах баримт нэгэнт үгүй тул дуугүй болжээ.Гэвч Өүлэн одоо хүртэл Тэмүжин хөвүүнээ Тэнгэрийн зарлигаар төрсөнд итгэсээр билээ.Түүний нь баталгаа болж өнөө ч Тэмүжин эхийнхээ сэтгэлийн шаналанг ойлгож мэдээд Хасар дүүдээ цэргээ захируулжээ.

Үүн шиг ухаантай мэргэн шийдвэрийг Өүлэн урд нь мэдэхгүй мэт байлаа.Өүлэн хязгааргүй аз жаргалтай болжээ.Олширч нэмэгдээд зах нь харагдахгүй болсон хүрээндээ өөрийн гэрт таатай сайхан амьдарч байв.Тэнгэр тэтгэж Тэмүжинг хүчээ нэгтгэн бэхжүүл гэх шиг халдан ирэх аюулгүй хэдэн жил өнгөрөв.

Хасар Тэмүжин хоёрын хэрүүл тэмцэл бүр мартагдаад байтал санаандгүй нэгэн хэрэг мандав. Нэг өглөө агтны тооллогоор явсан Тэмүгэ давхин иржээ.

-Ижээ.Тэмүжин ахаа.Хэрлэн өгсөөд Мэнлиг ах олон албатынхаа хамт ирж явна.Би уулзлаа.Тэднийх их баяжиж бүр нүүдлийнх нь төгсгөл харагдахгүй хөвөрч байна гэж Тэмүгэг хэлэхэд Өүлэний сэтгэлийн мухарт нэг утас доргин дуугарах шиг болоод гар нь зүрхтэйгээ адил чичирч аягатай цайгаа цалигуулжээ.Тэр өглөө Тэмүжин Хасар хоёр эхийнхээ гэрт цайлж суув.Өүлэн түрүүлэн дуугарсангүй.Учир нь тэр одоо Тэмүжиний амыг харж сурчээ.Тэмүжин дуугарсангүй.

Ер Тэмүжин түрүүлэн дуугарах зангүй тул Өүлэн хүлээжээ.Харин Хасар дуугүй суух эх ах хоёроо хэсэг хараад тэссэнгүй.

-Тэр боол Мэнлиг.Хаяж явчихаад одоо ямар нүүрээрээ эргэн ирэв.Би цэрэглэн очиж ял асууя.Дагаж ирэгсдийг нь хураан авъя.Эзнээ хаясан боолыг гэсгээх нь зөв биз.Бусдад нь үлгэр болог гэж чанга хэлжээ.Тэмүжин тэр дороо дуугарсангүй ч харц нь гэрэлтэн Хасарын үгэнд уур хилэн нь дүрэлзсэнээ алгуур унтрахыг Өүлэн түгшин харжээ.Тэмүжиний хаанаас нь энэ их тэвчээр гардгийг Өүлэн бодоод олсонгүй.

-Хасар аа.Чи нэгэн зүйлийг мартжээ.Есүхэй эцгийн үхлээс хойш биднийг хамгийн сүүлд орхиж одсон хүн бол Мэнлиг юм.Түүнийг урвасан гэж үзэх үндэс үгүй биз.Мэнлигийг хүндэт зочны ёсоор угтаж авна гэж хэлээд Тэмүжин эхийгээ харжээ.

Тэмүжин эхийнхээ хүслийг энэ удаад ч алдалгүй таав.Өүлэн догдолж баярласандаа доош тонгойв.Тэр Мэнлигийг ирнэ гэж хичнээн их хүлээж хүсэж байснаа сая л мэджээ.Үүнийг ч Тэмүжин мэдэж буйг ойлгов.

-Би тэр боолыг хүндэт зочин мэт угтаж эс тэвчинэ гэж Хасар зөрүүдэлсэнд Тэмүжин чимээгүй инээмсэглэжээ. -Хасар хөвүүн минь.Мэнлиг бол Есүхэй эцгийн чинь унаган боол.Эцсийн гэрээсийг нь сонсож толгойг нь түшиж ясыг нь барьсан ганц хүн шүү.Бүү тэгэж хэл.Одоо түүнийг боол гэж бүү дуудагтүн.Боол мэт бүү үзэгтүн.Мэнлигийг боолоос чөлөөлж дураар явуул.Есүхэй эцгийн чинь сүнс чингэхийг хүсч буй гэж Өүлэний хэлсэнд Хасар үг хэлэлгүй уурлан гарч оджээ.

-Тэмүжин хөвүүн минь.Хасар дүүгээ бүү буруутга.Бага насандаа өнчин хаягдсан гомдол нь арилахгүй байгаа биз.Дүү чинь түргэн зантай ч хорон муу санаагүй,цагаан цайлган хүн шүү.Хасар ер худал засдаг зан гаргадаггүй хүүхэд.Бодсоноо л хэлэв.Мэнлиг биднийг хаяж явсан юм биш.Би түүнийг хөөж явуулсан билээ.

Харин Мэнлиг надад гомдолгүй биднийг гэж эргэн ирсэнд ээж нь баяртай боллоо гэж Өүлэн үнэнээ хэлжээ.

-Ижээ.Мэнлиг ахыг би дүү нарын хамт хүрээнээс гарч замд нь угтан авъя.Харин та өргөөндөө хүлээгтүн.Тэд танд ирж мөргөг гэж Тэмүжин хэлжээ.Хасар эх ах хоёрынхоо үгийг дагахаас өөр аргагүй болов.Хүрээний захаас хол Учиртайн даваany овоон дээр Тэмүжин дүү нар шадар нөхдийнхөө хамт Мэнлигийг угтан хүлээж байсан нь Мэнлигийг цочоож бас гэмшүүлсэн нь туйлгүй болжээ.Мэнлиг хуучин эзнийхээ үр сад, Өүлэн хатны нүүрийг яаж харна гэхээс гол харлан эмээж явжээ.Харин Сочигал нэгэнт үхжээ.Гэвч түүнд бас үүнээс өөр арга байсангүй.Тэмүжиний дэргэд очихыг Хөхөчү хөвүүний нь шаардах байх суух аргагүй болгожээ.Эндээсээ удвал эзнээ хаяж одсон түүнд үхлээс өөр юу ч олдохгүй болохыг Хөхөчү сануулсан нь нүүхэд хүргэсэн билээ.

Харин Тэмүжинг ингэж хөл болон замд угтана гэж бодсонгүй.Эцэс төгсгөлгүй үргэлжилсэн их нүүдлийн тэргүүнд бөөгийн хар сүлдтэй хөнгөн сүйх ирсэн нь Хөхөчүгийнх ажээ.Мэнлиг долоон хөвүүнээ дагуулан ирж Тэмүжинд түрүүлэн мөргөжээ.Тэмүжин түүнийг сугадан босгоод

-Мэнлиг эцэг минь гэж хэлсэнд бүгд гайхжээ.Тэмүжиний энэ хэтэрхий их хүндэтгэл боол Мэнлигт зохихгүй гэж Хасар бухимдан хялалзаж зогсов.

Ийнхүү “Эцэг” гэж хүндлэн дуудсанд Мэнлиг ч цочирдон алмайрчээ.

-Мэнлиг эцэг минь.Та бол өнчин хоцорсон биднийг авран хамгаалж ирсэн ачтан юм.Энэ өдрөөс хойш та миний аймагт хамгийн хүндтэй суудалд сууж надад шадарлаж байх болно гэж өвдөг сөхрөн мөргөв.Хасар золтой л хашгирсангүй ажээ.

-Дүү нар.Миний нөхөд та нар Мэнлиг эцэгт мөргөгтүн гэсэн Тэмүжиний үгнээс зөрөх зүрхтэн гарсангүй цувран мөргөжээ.Хасар хамгийн сүүлд мөргөв.Мэнлигийг дагаж ирэгсэд нь Хөхөчүгийн ид шидийг шүтэж түүний аврал ивээлд багтагсад ажээ.Тэмүжин түүнийг мэдэж байсан тул Мэнлигт ингэж их хүндлэл үзүүлснийг гадарласан хүн байсангүй.

Учир нь Тэмүжин болоод Хөхөчүгийн хооронд болсон явдлыг хэн ч мэдэхгүй байв.Тэмүжин Мэнлигт бүх хүндлэлийг үзүүлж Хөхөчүг анзаарахгүй мэт байжээ.Мэнлигийг ирсэнд Тэмүжин их найр хийв.

Найрын эхэнд Мэнлиг хөвүүдээ дагуулан Өүлэнд мөргөжээ.Найрын турш Өүлэн Мэнлиг хоёр үг сольсонгүй.Тэмүжин Мэнлигийг эхийнхээ дэргэд суулгажээ.Хаяж одоод сая эргэн ирсэн боол Мэнлигийг ингэж ихээр хүндэтгэснийг олон хүн гайхжээ.Энэ бол Тэмүжиний далд санааны илрэл гэдгийг Өүлэн мэдэж болгоомжилж байв.Учир нь Мэнлигийг ингэж ихээр хүндэтгэж бүр “Эцэг” хэмээн дуудаж буй нь Өүлэний сэтгэлийн чанад нууцыг Тэмүжин мэдэж байгаагаар зогсохгүй бүр түүнийг зэмлэж баалж байх шиг санагдаад балмагдсандаа Мэнлигтэй дуугарахгүй биеэ барихад хүрчээ.Тэмүжин дотроо юу гэж бодож буйг таах аргагүй тул айж байв.Мэнлигийг өвөртөө оруулж шалигласныг Тэмүжин огт мэдэхгүй гэж бодож явсан нь их л гэнэн хэрэг байсныг мэдэж их ичжээ.

Ингэж бодохоор Тэмүжиний өмнө буруутсан мэт санагдаад дотор нь муухайравч бас гэнэ гэнэ тулгарах Мэнлигийн харц түүнийг төөнөх мэт болж бүр дур хүсэл нь оргилж эхлэжээ.

Энэ бол Өүлэний хэзээ ч үзэж мэдрээгүй явдал болов.

Дэргэд суусан Мэнлигээс дур тачаал оргилуулах хачин содон үнэр ханхалж байхыг Өүлэн анх удаа мэдэрчээ.Тэр үнэрт Өүлэн согтсон мэт болоод ганцхан Мэнлигтэй цэнгэж байсан өнөөх шөнийн дурсамж хачин тодорхой сэргээд аль эрт мэдрэлгүй мэт болсон хөх нь чинэрэн чим чим өвдөж байжээ.

Өнчин хоцорсон хөвүүдийнхээ төлөө тэр дундаа Тэмүжиний төлөө зарц боол Мэнлигт биеэ эдлүүлсэн гэж өөрийгөө цагаатган өмөөрч явсан бөгөөд харин одоо эм бие нь хагсарч Мэнлигийг хүсэмжилэн тачьяадаж явсанаа гэнэт ойлгожээ.

Сэтгэлийн дотор ийм их дур хүсэл хадгалагдан явжээ.

Өүлэн өөрийн дур хүслийг тэвчин барьж эс дийлээд толгой өвдсөн нэрээр гэртээ шурган ганцаар асгартал уйлж арайхийн тайвширчээ.Тэр өөрийн сэтгэлийг ойлгохоо болив. Мэнлигийг дагаж ирсэн иргэдийг түүнд өгч тэдэнд нутаг заан суулгахаар Тэмүжин зарлиг буулгасан нь Боржигон аймагт Мэнлигийн удам хамгийн их хүндлэл хүлээн дархлагдсан хэрэг байв.Мэнлиг албатаа дагуулан заасан нутагруу нүүж оджээ.Мэнлиг Өүлэний гэрт тусгайлан орж бараалхсангүй.Харин Хөхөчү хөвүүнийхээ хамт Тэмүжинтэй удаан сууж ярилцаад нүүдлийнхээ араас морджээ.Өүлэн түүнийг ороод ирнэ гэж бодсон тул гэрийхээ гадна далд ортол харж зогсов.Гэтэл зарц Мэнлиг эргэж ч харсангүй явсанд гомдол нь хорслоор солигдох шиг болжээ.

Энэ зун Өүлэн дөчин гурван нас хүрсэн ч эрийн нүд сэтгэлийг татах үзэмж нь бууraагүй

байлаа.Өүлэн хэзээ ч өнөөдрийнх шиг эрийг хүсэн тачаадаж байсангүй.Хаана нь нуугдаж явсан их тачаал юм бүү мэд.Түүнээс хойш шөнө бүр ганцхан Мэнлигийг хүсэмжлэн тарчилж дур тачаалдаа шатан нойргүй хонох болжээ.Хөвүүдийнхээ нэр нүүр, Есүхэйн алдар хүндийг бодон эр хүнтэй ойртож хавьтахыг цээрлэн олон жил дур хүслээ хүчээр хориглон тэвчиж ирсэн нь түүний сэтгэлд ийм өвчин үүсгэснийг Өүлэн гадарласангүй.

Түүний урт амьдралд биеэ өгсөн гуравхан эр байлаа.Эр нөхөр Есүхэй.Хуучин нөхөр Чилэдү.Тэгээд энэ зарц Мэнлиг ажээ.Тэр одоо азгүйгээр үхсэн Сочигалд атаархаж байв.

Сочигал Есүхэйн үхсэнээс хойш Есүхэйн нэр хүндийг бодолгүйгээр ганц өөрийн биеийн жаргалыг хөөж таарсан эрчүүлтэй дур чөлөөтэй шалиглаж байсныг Өүлэн ихэд үзэн ядаж загнаж хориглосон нь олон ч “Чамайг эр тоохгүй бол дуугүй байгтүн” гэж загнаснаас хойш үг хэлэхээ болисон билээ.Сочигал Бөртийн хамт Мэргэдэд булаагдаж очоод мэргэдийн олон эрчүүлд эдлэгдэж байсандаа ичин модонд боомилон үхсэнийг дуулаад муу завхай үйлийнхээ горыг амсав гэж бодсон билээ.

Гэтэл одоо санахад харин Өүлэн л жаргал цэнгэл үзсэнгүй насыг үрсэн нь хохирч цээрлэл амссан мэт ажээ.

Ийн сэтгэл бие нь хямарснаа ганцхан Мэнлигийн эр биеийн чалх сайтайг, эрт дээр тэр шөнө учрахдаа хэрхэн эдлэн жаргаасныг дурсан санаснаас болов гэж бодоод ингэсгээд өнгөрч мартагдана биз гэж өөрийгөө тайвшруулахыг хичээжээ.Гэтэл өвчин нь түүний санасан шиг амар хялбар эдгэрч илааршсангүй улам хүндэрч бүр эрийг хүсэмжлэн солиорох дөхжээ.

Өүлэн шөнө унтахгүй шахам болсоор удав.Нүд нь гархилж эцэж турж эхлэсэн нь хүүхдүүдийг нь сандаргав.Хэдийгээр өөрийн энэ өвчнөө яаж эмчлэн эдгээхийг Өүлэн сайн мэдэж байсан ч олны хэл ам хов живнээс айж цааргалсаар байв.

Гэвч энэ маягаар өдөр хоногийг өнгөрөөж тэвчихэд улах бүр хүнд болсоор ажээ.

Тэмүжин Хасар нар Тайчуудын захын иргэдийг сэм довтлон хурааж өвөлжих билчээр нутгаа чөлөөлөн авахаар цэрэглэн мордсон тэр өдөр Өүлэн яг ухаан солиорсон мэт болж зөвхөн өөрийнхөө мэдрэмжинд хөтлөгдөн явжээ.

Мэнлигийн хүрээ намаржиж байсан Цэнхэр мандалын хөндийд хүрч ирсэн хойноо л морины амыг татжээ.Өмнө нь олон гэртэй баян хүрээ үзэгдэнэ.Ухаарсан ч түүнд ухарч буцах хүсэл төрсөнгүй.Тэр явсаар Мэнлигийн гэрийн гаднах уяан дээр очиж буужээ.Ингэнэ гэж олон хоног төлөвлөн бодсон тул эргэлзэн тээнэгэлзэх зүйл түүнд байсангүй.

Гэнэт чив чимээгүй орж ирсэн Өүлэнг үзээд Мэнлиг цочин босож харайжээ.

Дэргэд нь байсан бага эхнэр нь Өүлэнг үзмэгц сүрдэн год үсрэн гарав.Мэнлигийн хөвгүүд түүний албат эрчүүд бүгд Тэмүжиний цэрэгт явсан тул хүрээ даяар эль хуль эмс голдуу үлдээд байжээ.Харин Мэнлиг ахмадын ёсоор хүрээгээ захиран хоцоржээ.Өүлэн яг ийм үеийг тааруулах гэж тэвчин хүлээсэн билээ.

Тэр юу ч ярьж хэлж чадсангүй.

Амьдралыг оюун ухаан биш хүсэл мэдрэмж хөтөлдөг тийм цаг иржээ.

Тэднийг хэмжээлшгүй их хуял тачаал хөтөлж байв.Мэнлиг ч учрыг олж ухаан зарж чадахгүй болжээ.

Ганцхан эр хүний ёсоор бүгдийг өөрийн хүслээр эхлэн хийхийг Өүлэний харц шаардаж байхыг л мэджээ.Мэнлиг ухаан алдав.

Тэр яг л зэрлэг адгуус мэт аашилж Өүлэний хамаг хувцсыг урж тасчин тайлж хаяв.Одоо Өүлэн тэд эхээс төрсөн нүцгэн биеэр хоцорчээ.

Мэнлиг Өүлэнийг яг л азарга шиг хүчээр нухчин эзэмдэв.

Хичнээн олон жил ганцхан энэ л мөчийг хүлээж байсан мэт Өүлэн Мэнлигийн гар, хөдлөгөөн, хүслийг тааламжтайгаар дагаж байв.Энэ бол Тэнгэр ичмээр галзуу дур тачаал байв.Тэд гурван өдөр шөнө бие салгалгүй цэнгэн жаргаад сая л нэг ханаж цадаад бүтэн өдөр шөнө нам унтжээ.

Харин маргааш өглөө нь Өүлэн эв эрүүл сав саруул болон эдгээд сэржээ. Тэрээр бүч товч нь тасарч урагдсан дээл хувцсаа эгэлдэрэглээд гарав.Мэнлиг сүхээр цохиулсан мэт нам хэвтсээр хоцорчээ.

Өүлэний галзуурсан тачаалыг хангах гэж Мэнлиг хамаг тамир тэнхээгээ шавхжээ.Мэнлигээс өөр чалх муутай эр байсан бол лав тэсэхгүй ичгүүртэйгээр хөөгдөн зугатаах байсан биз.

Өүлэнг гарахад гадаа дөнгөж үүр хаяараад харин уяан дээр эмээлтэй морь нь үзэгджээ.Өүлэн юу ч бодсонгүй мордон явав.Түүний тархи толгой бие хаа нь хоосорч эзгүйрчээ.Бага гэрийн үүдэнд Мэнлигийн хоёр эхнэр түүнийг гуниг дүүрэн нүдээр ширтэн зогсож байхыг анзаарч харсангүй.Мэнлигтэй дахин уулзахгүй гэж Өүлэн хатуу шийджээ.Тэр дэндүү их зориг гаргаж яг л галзуу хүн мэт аашилжээ.

Гэвч Өүлэн хийсэн хэрэгтээ ер харамсаж шаналсангүй.Харин өөрийг нь шаналгасан өвчин нь оргүй арилаад урьдын ухаалаг итгэлтэй төрх нь эргэн иржээ.Өүлэн тавьсан тангаргаа бат сахин Мэнлигийг өөртөө дахин ойртуулсангүй.Өүлэний энэ үл ойлгогдох хачин занд Мэнлиг ихэд цочирдож түүнийг маш ихээр хүсэмжлэн шаналах болсныг Өүлэн гадарлавч царай өгөөгүй билээ.

Өүлэний Мэнлигийн гэрт очиж гурав хоносныг Бөртэ мэдсэн ч Тэмүжинд хэлсэнгүй өнгөрөв.Үүнд нь Өүлэн бэрдээ ихэд талархжээ.

Ингэж Өүлэний өвчин илааршиж Мэнлиг тэр хоёрын хачин харицаа эгнэгт тасарчээ.

*****

Боржигон аймаг Тэмүжиний дор нэгдэн улмаар хүчирхэгжээд Тэмүжиний алдар нэр түгэж

амьдрал ахуй нь дээшлэн жаргал дүүрэн мэт болсон ч Өүлэний сэтгэл амар тайван байх өдөр ховор болжээ.

Түүний эргэн тойрны амьдрал хүмүүс таньж мэдэхийн эрхгүй түргэнээр хувиран өөрчлөгджээ.

Эрх мэдэл сүр хүч нь нэмэгдэх тусам Тэмүжиний зан авир таахын эрхгүй өөр болж байлаа. Дуугүй зөрүүд хөвүүн нь зоргоороо дураараа эзэн болон хувирч байв. Тэмүжиний хийж буй зүйл тэр бүрий Өүлэнд таашаагдахгүй ч эхийнхээ үг саналыг сонсох нь ховор болжээ. Өүлэний хуучин эрх мэдлээс өчүүхэн ч үлдсэнгүй бүгдийг Тэмүжин Бөртэ хоёр алгуур булаан авчээ.

Өүлэн хүмүүсийн дунд мөртөө ганцаардаж эзэд нь хаяж нүүсэн хүрээ, хоосон ханхай гэр мэт болоод гансрах болжээ.

Мэнлигийн хөвүүн Хөхөчүг Тэмүжин ихэд тоон нөхөрлөх болсон нь Хасарын уур эгдүүцлийг юу юунаас илүү хүргэж түүний тэвчээр барагдаж байгааг Өүлэн мэдэрч түгшүүр муу совин татах болов.Гэвч Тэмүжин зальтай тул Хасарын сэтгэлийг элдэв зөөлөн аргаар сатааруулан хуурч сурсан байв.Хасар улам бүр ахаасаа хөндийрч тусдаа суусаар нэг л өдөр түүнээс эгнэгт салж одох мэт Өүлэнд санагдах болжээ.Бас Тэмүжин төрсөн дүү нартаа их эрх өгөхгүй товойлгон өргөмжлөхгүй жирийн шадар албатын зиндаанд үздэг болсон нь түгшүүр төрүүлэхээс өөр аргагүй байлаа.

Яг ийм үед нэгэн хэрэг манджээ. Тэмүлэн охин нь арван найман нас хүрч эрд очих болоод байтал Буйр нуурын хавиар нутаглагч Ихэрэс аймгийн Буту гэгч эр нөхдийн хамт ирж олон агтаар инж болгон Тэмүлэн охиныг нь бэр буулгахаар гуйжээ. Гэхдээ тэр Буту гэгч Өүлэнээс биш Тэмүжинээс дүү охиныг нь гуйсан нь хэрүүл уруулын эх болов. Буту бол Ихэрэс аймгийн нөлөө бүхий толгойлогчдын нэг тул Тэмүжин тэднийг найртай угтан дайлж саналыг нь сонсжээ. Баян чинээлэг Ихэрэс аймагтай худ ураг болох нь зүүн талдаа дайсагнах аюулгүй амар байхын үндэс болно гэж бодоод Тэмүжин дотроо дуртай байжээ. Ихэрэс аймаг санаа нэгдэн холбоотон болох аваас дүү охиноо өгөхийг Тэмүжин хүсжээ. Ихэрэс аймгийнхан нэр нь түгэж буй залуу Тэмүжинтэй найртай байхыг хүсэх тул Тэмүжиний үгийг зөвшөөрчээ.

Гэтэл Тэмүлэн Бутуд очихоос эрс татгалзав. Өүлэн хайртай ганц охиноо аз жаргалтай өөрийн хүссэнээр амьдрахыг хүсэх тул хөөрхий түүнээ уйлж унжихыг харах үнэхээр хэцүү байлаа.

-Ээж минь. Та намайг танихгүй холын аймагт бүү өгөөч. Би сэтгэлтэй хүнтэй. Түүнийг минь Тату гэдэг. Хасар ахын Борогчин хатны төрсөн дүү юм. Тэмүжин ахын амь хамгаалагч шадар цэрэг. Та Тэмүжин ахаас гуйгаач гэж Тэмүлэн шөнөжин уйлжээ.

Уйлж уйлж цөхрөөд унтсан хөөрхий охиноо орхиод Өүлэн гарвал харанхуйд Тэмүжиний ямбаны өргөөний тооноор гэрэл гарч байсанд тэр уулзахаар очжээ. Гэтэл хэвтүүл цэргүүд ойртуулсангүй. Гэрт Тэмүжин Тэв тэнгэрийн хамт байгаа гэжээ. Өүлэн хүлээхээр шийдэж гэрийнхээ гадаа намрын шөнийн сэрүүнд дагжин суусаар байв.

Гэрт орж Тэмүлэн охиныхоо шаналант царайг харж чадахгүй байв. Ингэж шөнө дөл болтол

Тэв тэнгэрийн хамт юу ярьдаг бол гэж гайхан боджээ. Лавтай чухал хэрэг хэлцэж байгаа биз гэж таажээ. Тэмүжин Тэв тэнгэрийн хамт үнэхээр чухал хэрэг хэлцэж байжээ. Хийх үйл, хэлэх үгээ Тэв тэнгэртэй зөвлөж түүгээр мэрэг төлөг тавиулах нь Тэмүжиний зан болоод байжээ. Энэ удаад Жүрхэн овгийнхныг хэрхэхийг тэд ярилцаж суужээ. Жүрхэнүүд татаартай байлдахад цэргээ гаргаагүйгээр барахгүй эзгүй хойгуур хүрээ рүү нь довтолж хүн алж дээрэм хийсэн байв.

Одоо Жүрхэнийг залхаах нь хойшлуулшгүй болжээ. Тэд яг хоолойд яс мэт тээглэжээ.

Гэвч Жүрхэнүүд угсаа гарвал нэгтэйгээс гадна зориг зүрх омог овор ихтэй нь эрхгүй болгоомжлоход хүргэжээ.Тэмүжин тэднийг номхотгох хялбар мэргэн арга хайж байв. Тийм учраас ингэж Тэв тэнгэрийг залж нойроо хугаслан суужээ. Тэв тэнгэртэй ярих бүр ухаан санаа нь цэлмэн гийх шиг болдог билээ. Тэв тэнгэр нэг нүдээр Тэмүжинг нөгөө нүдээр тооно өөд ширтэн суугаад ингэж хэлэв.

-Тэмүжин. Аливаа улс аймгийг эзлэх, ухаан зориг ихтэй дайснаа дарахад эрх биш нэг нарийн учрыг ухаарвал зохино гэж Тэнгэр хэлжээ. Аливаа аймаг улсад тэдний сүр сүлд сүнс хийморь болсон хэн нэгэн хүн юм уу дээдлэн бишрэх шүтээн буй. Хамгийн түрүүнд энэ сүр сүлд сүнс, хийморийг нь үхүүлэх юм уу булаан авахыг хичээх хэрэгтэй. Чингэж гэмээ нь үлдсэн үйл болоод иргэд нь аандаа чамайг дагах болно. Энэ бол дайснаа дарах Тэнгэрийн арга болно гэхэд нь Тэв тэнгэрийн энэ үг туйлын зөв санагдсан тул зөвшөөрөн толгой дохиж суужээ.

-Ийм сүлд хийморь баатар хүн бүрд бий.Т эмүжин чиний сүр сүлд миний чамд өгсөн Тэнгэрийн сахиусанд оршино. Харин Тэв тэнгэр минийх энэ малгайн оройдох сахиусанд буй гэж Хөхөчү өгүүлээд түүнийг анхааруулан хоёр нүдээр эгц ширтжээ.

-Одоо Тэмүжин чи сайн сонс. Жүрхэн овгийн сүр сүлд нь тэдний хүчит баатар Бүрибөхийн биенд оршжээ. Чи түүнийг хуурч урин авчирч барилдуулан гэнэгүй байхад нь алагтүн. Тэгсэн цагт үлдсэн Жүрхэнийхний омог хүч нь дарагдаад аандаа чамд дагаж ирнэ. Харин хэрхэн хийхийг чи сайтар бодогтүн. Тэнгэрийн итгэлийг бүү алдагтүн гээд Хөхөчү суусан чигээр хурхирч эхлэжээ.

Тэв тэнгэрийн энэ мэт гайхалтай ааш,ид шид, урьдчилан тааж мэдэх чадварт Тэмүжин нэгэнт автаад байлаа. Тэв тэнгэр унтсанд түүнд саад хийхгүйн тулд Тэмүжин биеэ тэнийлгэхээр гадаа гарчээ.Холгүй шөнийн харуулууд үзэгдээд үүр цайж гэгээ оржээ. Харин түүний гарсан даруйд Өүлэн эх нь хүрч ирсэнд их гайхаж айжээ.

-Ижээ. Та яав гэж Тэмүжин сандран асуув. Өүлэн эхийгээ ингэж үүр цүүрээр явахыг ойрын хэдэн жилд үзээгүй тул ингэж гайхжээ.

-Хүү минь. Дотогш оръё

-Ижээ. Энд Тэв тэнгэр бөө унтаж буй. Түүнийг сэрээж яах вэ гэсэн нь Өүлэнг их гайхуулжээ.

Хөхөчү Тэмүжинтэй ингэж шадарлаж байгаа нь ер сайны ёр мэт санагдсангүй ажээ. Гэвч одоо Өүлэнд энэ тухай шүүмжлэн бодох зав байсангүй.Тэгээд

-Хөвүүн минь.Тэгвэл манайд оч гэжээ.Тэмүжин эхийгээ дуугүй дагав.

Гэвч гэртээ орж болохгүйгээ Өүлэн замын дунд ухаарав.Тэгээд зог тусаж

-Хөвүүн минь. Тэмүлэн дүү чинь өөр хүнд сэтгэлтэй гэнэ. Би ганц охиноо аз жаргалтай амьдраасай гэж хүснэ. Тэмүлэнг Ихирэс аймгийн Бутуд бүү өг.Охин минь хүслээрээ болог гэж Өүлэн шууд хэлжээ.

Тэмүжин өнөөх сурсан зангаар тэнгэрийн хаяа ширтэн дуугүй зогсов.

-Ижээ. Та бид Боржигон аймгийн төлөө амиа үрэн зүтгэсээр ирсэн биш үү. Ихэрэс аймаг бол баян хүчирхэг аймаг. Ихэрэс аймагтай хүчээ нэгтгэх нь Тэнгэрийн ивээлээр болсон хэрэг юм.Нэг бүсгүй хүн ийм үнэ хүрнэ гэдэг гавьяатай явдал болно. Миний дүү охин Ихэрэс аймгийн нэг толгойлогчийн эхнэр болно гэдэг бахдалтай хэрэг юм. Одоо бид бүгдээр хар биений жаргалыг биш улс аймгийнхаа ирээдүйг бодох ёстой. Ийм учраас би Тэмүлэнг Ихэрэс аймгийн Бутуд өгнө. Би амласнаасаа хэрхэн буцах билээ. Та намайг юун хялбар бодов. Үүнээс хойш ижий та энэ мэт хэрэгт оролцож өөрийгөө бүү чилээ гээд Тэмүжин түүнийг гэрийн гадна орхиод яваад өгчээ.

Тэгснээ эргэн ирж

-Тэмүлэний тэр хүн хэн гэнэ гэж тулган асуув. Тэмүжиний дууны өнгө заналтай болжээ. Өүлэн дэмий юм хийснээ гэнэт ойлгон түгшив. Тэмүжин чухам яах гэж ингэж асууж байгааг Өүлэн төвөггүй мэдэв. Тэгээд Тэмүжиний асуусанд хариулсангүй уурлан гэртээ оржээ. Өүлэн болсон бүх явдлыг Тэмүлэн охиндоо хэлж ахынхаа хэлснээр хийхээс өөр аргагүйг учирлажээ. Гэвч Тэмүлэн эрх охины омголон зангаар бууж өгөхийг хүссэнгүй.Тэр үдэш Тэмүлэн Бөртэд бүх үнэнээ хэлж аврал тусламж гуйжээ. Одоо Тэмүлэнг аврах ганц хүн бол Бөртэ байв. Өүлэн хэдийгээр Бөртэд юу ч хэлж болохгүйг хатуу хориглосон боловч Тэмүлэн эхийнхээ үгэнд орсонгүй. Тэр шөнө Өүлэн унтаж чадсангүй.

Харин Бөртэд итгэсэн Тэмүлэн аз жаргал дүүрэн тайван нойрсож байлаа. Шөнө дөлөөр Хасар өөрийн хүрээнээс давхин ирж Тэмүжиний өргөөнд орохыг Өүлэн сонсож хэвтлээ. Түүний сэжиглэн бодсон тэр аймшигт хэрэг нэгэнт биелэж эхлэхийг тэр мэдэрчээ. Гэвч тайвшран итгээд нам унтаж буй хөөрхий охиноо сэрээхээс айжээ. ”Ядаж ганц шөнө ч болов эхийнхээ өвөрт сайхан унтаж, амттай зүүд зүүдлэгдээ” гэж Өүлэн бодов. Тэмүлэн охин нь зүүдэндээ инээмсэглэж байхыг үзээд Өүлэний халуун нулимс асгарчээ. Одоо түүнд болж буй хэргийг хориглон зогсоох арга даанч байсангүй.

Бүх хэрэг Өүлэний сэжиглэн бодсоноор болжээ. Ихэрэс аймагтай эвсэх нь гарцаагүй чухал болохыг Хасар хэлүүлэлтгүй мэдэж байсан тул Тэмүлэний хайртай хүн шадар цэрэг Татугийн хувь заяа үүр цайхад нэгэнт шийдэгдсэн билээ.

Харин Тэмүжинд Татуг алах санаа угаас төрөхгүй байсаар тул Тэнгэр ивээж энэ хэргийг Зүчи хөвүүн нь гүйцэлдүүлэн Татуг аварч авсан юм.

Энэ хэргээс хойш Тэмүжин Зүчи хөвүүндээ их л сайнаар хандахыг хичээх болсонд Бөртэ их

баяртай болжээ.

Бүх хэрэг Зүчийн ачаар Тэмүжиний хүссэнээр болж Тэмүлэн Бутуг даган Ихэрэс аймагт уйлсаар одоход Тэмүжин Татуг Зүчи хөвүүндээ боол болгон өгчээ. Харин Өүлэн Тэмүлэн охиноо харьд одсоноос хойш туйлын ихээр ганцаардаж өөрийгөө Тэмүжиний хүрээнд хэнд ч тоогдохгүй хүн болсон мэт санах болжээ. Үнэхээр хөвүүд нь эзэн сууж хүчирхэгжихийн хирээр Өүлэн авч болохгүй хаяж болдоггүй хуучин хувцас шиг болжээ. Бас Тэмүжинд түүний үг санал ямарч үнэ цэнгүй мэт болсонд тэрээр туйлын ихээр гутран гомджээ. Гэвч энэ сэтгэлээ ер илрүүлэн мэдэгдсэнгүй.

Ухаантай, айхтар алс санаатай Бөртэ эвгүй хэргээс, элдэв хэрүүлээс сэргийлэн Өүлэнг хүндэтгэн асрахаа хэзээ ч мартсангүй билээ.

Тэмүлэн болоод Татугийн хувь заяа Бөртийн хэлснээр шийдэгдсэнийг Өүлэн сэжиглэн таамаглаж байв.

Харин Өүлэний хайрлан тэвэрч өсгөсөн ач хөвүүн Зүчи угийн сэрэглэн зангаараа хөөрхий тэр загасан нүдэт Татуг аварч гарчээ. Бөртийн мэргэд цустай энэ хөвүүнд Өүлэн үнэн сэтгэлээс хайртай бөгөөд энэ явдлаас хойш бүр ч ихээр тоох болжээ.

Харин болсон хэрэгт Тэмүжин хөвүүнээ буруутгасангүй. Ихэрэс аймагтай холбоотон болж ураг барилдах нь Тэмүжинд хичнээн чухал болохыг ойлгож байв.Тэмүжин хөвүүн нь хүн хүнээс онцгой илүү хүсэлтэй болохыг нэгэнт мэдэх болсон нь Өүлэнийг алгуур өөрчлөн хувиргажээ.Т эмүжин хөвүүнээ чухам юу хүсэж юунд зорьж байгааг Өүлэн өдөр хоног сар жил өнгөрөх бүр улам гүнзгий тодоор ойлгох болжээ.Тэр үнэхээр хүмүүн биш хөвүүн төрүүлжээ.Өүлэний бүх туулж ирсэн зовлон бэрхшээл ганцхан Тэмүжиний хүслийг биелүүлэхийн төлөө байсанд одоо эргэлзэхгүй болжээ.Ингэж бодоод Өүлэн өнгөрсөн амьдрал үзээгүй жаргалдаа харамсахгүй байхаар шийджээ.

Тэр одоо өөрийн үлдсэн насыг Тэмүжин хөвүүнээ их хаан суухад зориулахаар шиидэв.Яг ийм сэтгэлээр Хасарт хандах болов.Хасарыг өмөөрөв хэмээн Тэмүжин эхдээ гомддог биз гэж Өүлэн боддог байжээ.

Гэтэл Өүлэн Хасарыг биш Тэмүжинийг л хамгаалан өмгөөлж ирснээ мэдэв.

Харин хоёр хөвүүнээ алалдахыг тэр хэзээ ч хүссэнгүй.Ингэхийг ер ямар эх хүсэх билээ.Тэр нэгэн аймшигт шөнө Тэнгэрийн авралаар Зүчи хөвүүн нь хашгиран гүйж ирж хэлээгүй бол Өүлэний хүсээгүй тэр хэрэг гарах нь гарцаагүй байв.

Тэв тэнгэр бөөгийын муу ёрын ид шидэнд автагдсан Тэмүжин Хасар дүүгээ яг алах гэж байсан билээ.Гэвч Өүлэний үрээ гэсэн эхийн хайр сэтгэл нь Тэв тэнгэр бөөгийн муу ёрын сахиуснаас хүчтэй болохыг тэр үзжээ.Тэмүжин эхийгээ үзмэгц муу сэтгэлийн үрээ дарж чадаад Хасарыг орхин явсан билээ.Өүлэн ингэж хоёр хөвүүнээ үхлээс аварчээ.Гэвч Хасарын үхлийг зайлуулж дараа нь Тэмүжин Тэв тэнгэр бөөг үхүүлсэн ч энэ муу ёрын сахиусны хорлол дуусахгүйг Өүлэн мэдэж байв. Ийм учраас тэр Тэмүгэ Хасар Тэмүжин гурвыг гэртээ дуудан ирүүлжээ.Хачиун хөвүүн нь өвчнөөр өөд болоод хэдэн жил өнгөрчээ.Тэмүжин Хасар

хоёрын зөрчил нэгэнт эхийнхээ сэтгэл ухаанд захирагдан дийлдэхгүй болсоор байгааг Өүлэн сайн ойлгож байв.Улс байгуулж хаан суусан Тэмүжин, дүү нартайгаа улсаа хуваалцахыг хүсэхгүй байхад бас Хасар өөрийн зүтгэж, олсны хирээр хувь хүртэхийг хүсэх нь зүйн хэрэг юм.Хөвүүдийн энэ хүсэл хяслын зөрчил тэмцлийг нууж хаах арилган цайруулах хүч хүн нэгэнт үгүй байлаа.Өүлэн аргаа баржээ.

Тэр өдөр Есүхэйнхэн Өүлэний гэрт халуун бүлээр цуглаж энгүүн сайхан найрлаж ганц биш хундага тогтоожээ. Өүлэнд хөвүүддээ ярья гэж санасан нэг домог байв.Хөвүүдээ ухааруулж гэгээрүүлэхийг тэр хүсчээ.Ингэх нь цус урсган алалдахаас сэргийлж болох ганц арга гэж Өүлэн итгэнэ.Тэр хөвүүдээ өөрөөсөө илүү ухаантай гэж бодно.

Тэр домогт ийн өгүүлдэг ажээ.

…..Энэ газар дээр анх ерөөс Хархорум нэртэй ганц уул л байжээ.Хархорум уулын суганаас нэгэн их уст мөрөн ундран гардгийг Мөнх гол хэмээнэ.Хархорум уулын энгэр бэл Мөнх голын эрэг дэнжээр билэг эрдэм төгс Буянтай хэмээх өвгөн амьдран иржээ.Буянтай өвгөн Хорхун, Хонун, Хэрлүн, Тугулун, Сэлэнгүн хэмээх таван хөвүүнтэй ажээ.Тэдний үр сад өсөж үржсээр ганц Мөнх голынхоо хөндийд багтаж цөхжээ.Тэднийг Мөнх голынхон гэх бөгөөд яваандаа зүгээр л Монголынхон Монголчууд гэх болжээ.Үр ач нарт нь нутаг билчээр хэрэгтэй болсныг мэдсэн Буянтай өвгөн Тэнгэрийн хүчийг агуулсан Хархорум уулаа таван их уулсад хуваж бас Мөнх голоо таван их гол болгоод таван хөвүүндээ өмчлүүлэн өгчээ.Хонун хөвүүний нутаглах ус Онон гол болов.Хорхун хөвүүний нутгийг Орхон гол гэнэ.Хэрлүн хөвүүний нутаг Хэрлэн мөрөн болжээ.Тугулун хөвүүний голыг Туул хэмээжээ.Сэлэнгүн хөвүүн өөрийн усыг Сэлэнгэ гэж нэрлэжээ.Ингэж Монголчууд энэ их таван голын савд тархан нутаглэж иржээ.Харин хуваж өгсөн Хархорум уулын оронд үлдсэн жаахан уулыг хөвүүд нь эцгээ дурсан Их монгол уул гэж нэрлэхээр тогтжээ…

Энэ домгийг яриад Өүлэн араас нь ямар нэгэн тайлбар сануулга хэлсэнгүй.

Өүлэний далд санаа дэндүү тод байв.Энэ их таван голын улс аймаг нэг язгууртай болохыг хэлснээс гадна Тэмүжин Хасар нарын багтах шингэх газар нь хичнээн ихийг ухааруулан хэлжээ.Бас юуг булаалдаж өвөр хоорондоо өстөн болоод байгааг ч ойлгуулав.Энэ газар дээр Есүхэйн цөөн хөвүүд бүү хэл хамаг Монголчууд багтаж ирснийг хэлжээ.Хөвүүд нь эхийнхээ ярисан домгийг сонсоод удтал бодолд дарагдан суужээ.

Анх Бэгтэртэй муудалцаж ахуйд Алангуа эхийн домгийг хөвүүддээ ярьж өгснөө санав.Хөвүүдээ эвтэй байлгахын тулд ярьсан тэр домгийг хөвүүд нь яаж ойлгож хүлээн авсныг тодорхой мэдэхгүй ч Тэмүжин Бэгтэрийг алсан билээ.Харин одоо энэ домог тэднийг ямар үйлд хөтлөхийг сайн мэдэхгүй ч хөвүүд нь яг Буянтай өвгөний хөвүүдийн адил энэ газрыг хуваан эзэлж суугаасай гэж Өүлэн хүсч байв.Тэдэнд хоорондоо алалдахын хэрэг огт үгүй юм.Хөвүүд нь тэр үдэш эвгүй сөөлжүү үг ер хэлээгүй бөгөөд Өүлэн ч сэтгэл тэнэгэр болжээ.Хэрвээ Өүлэн энэ газрыг эзэгнэн сууж байсан бол яг л Буянтай өвгөний адил хийх байв.Тэгээд Монгол газрын хамгийн их ус, уулс хөвүүд болоод Есүхэйн нэрээр үүрд нэрлэгдээсэй гэж хүсч байв.

Эхийнхээ юу хүсэж энэ домгийг хүүрнэснийг хөвүүд нь ойлгожээ.

Тэд эхийнхээ ухааныг бахдан сайшааж байгаа нь харцнаас нь илт байлаа.Тэр дундаа эхийнхээ ярьсан тэр домгийг Тэмүжин ихэд тоож олон хоног боджээ.Буянтай гэгч тэр өвгөн тал нутгийн гол усыг хөвүүддээ хуваан өгсөн нь дуурайлтай санагдсан ч энэ домогт гарсан тэр Их Монгол уулын нэр ихэд таалагдаж түүний байгуулах улсын нэр болохыг мэдэрчээ.Ингэж Өүлэн эх нь Тэмүжин хөвүүнийхээ байгуулах их улсын нэрийг хэлсэн нь Тэнгэрийн хүсэл байжээ.

Хөвүүдээ эвлэрүүлэх гэж ярьсан домог Тэмүжинг бүр алс холын их зорилгод дуудаж бас эргэлтгүй зөв замаар урагшилж байгааг нь батлах шиг санагдсан билээ.Үнэхээр Хархорум уулын тухай домогт гардаг шиг Хархорум эхтэй Их Монгол улс байгуулахыг энэ домогт зөгнөн зааж өгүүлжээ.Өүлэн эх нь чухам ингэж ухаараасай гэж хүссэндээ энэхүү домгийг ярьсан гэдэгт тэр итгэв.

Тэмүжин ингэж бодоод эргэлтгүй зоригжин шулуудаж Хасарыг дуудан цэргээ засаж Найман улсыг дайлахад бэлдэхийг тушаажээ.Хасарын сэтгэл ч цэвэршин урьд олзлогдсон татаар иргэдийг цаазлахаас болж үүссэн гомдлоо мартаж их цэргээ засаж эхлэжээ.Өүлэний ярьсан домог ингэж огт санаандгүй үр дүнд хүргэснийг тэр таамагласангүй.Ямарч болов Тэмүжин Хасар хоёрын дунд үүссэн аймшигт хэрүүл аятай намдсанд баярлажээ.Өүлэний аз жаргалын үндэс хөвүүдийн нь эв нэгдэл байв.

Их монгол улсыг байгуулж хэл нэгтэй нүүдэлчин аймгууд Тэмүжиний дор нэгдсэн нь Өүлэний болоод Есүхэйн эцсийн хүсэл байлаа.

Гэтэл Тэмүжин болоод Хасарт үүнээс холын их хүсэл байгааг үзээд Өүлэн бахардан цочжээ.Монголын их цэрэг Тангуд улсыг дайлаад зогссонгүй бүр хүчирхэг Алтан улсад довтолж Цагаан хэрмийг давахаар бэлтгэж эхлэсэн нь Өүлэнг асар ихээр цочирдуулж хөвүүдийнхээ ирээдүйд санаа зовиноход хүргэв.

Алтан улсад довтлох нь Мэргэд, Найман аймагтай байлдахаас огт өөр амиа үрж мэдэх аюултай хэрэг гэж бодогджээ.

Алтан улс бол тэдний дэргэд арслан барс мэт хүчирхэг,үй түмэн цэрэгтэй, өндөр их хэрэмтэй, дийлнэ гэж санахад даанч итгэмгүй санагджээ.Үхэл нь ирсэн хулгана муурын сахлаар оролддогийн үлгэр болно гэж эмээж байв.Монгол аймгуудаа нэгтгэн өөрийн их улсыг байгуулав.Одоо үүнээс илүү яана.Дайсан этгээдээ хилэгнүүлэлгүй амар тайван амьдрахыг Өүлэн хүсч Тэмүжин хөвүүнээ ятгаж нэг үзэв.Хөгшин настай болсноороо далайлган, үхэхээрээ айлгаж нэг үзээд тусыг эс олжээ.Тэмүжин болоод түүний нөхдийг эргээн тогтоох хүч нэгэнт үгүй болжээ.Эцэст нь Тэмүжинг их дайн хийхээс ятган ухраах биш харин ялалт байгуулахад нь дэмжин зоригжуулах хэрэгтэйг ойлгожээ.

Гэвч өндөр настай болсон Өүлэн юухан хийж чадах билээ.Яг энэ үед л өнөөх энгэрийн мухарт оёсон Тэнгэрийн тэмдэг санаанд нь оржээ.Зүрчидийн Алтан улсыг дайлан сөнөөнө гэдэг даанч алс хол хүршгүй зорилго мэт санагдсан ч нэгэнт Тэнгэрийн тэмдгийг атган төрсөн баатар эр тул Тэмүжин хөвүүн нь зориглосон л болно чадна гэж итгэжээ.Ганц эргэлзээ төрүүлсэн зүйл нь нас нь хүрэхгүй байх бий гэсэн бодол байв.Тэмүжин хөвүүнээ өст Алтан улсыг мөхөөж алдраа мөнхлөөсэй хэмээн Өүлэн туйлын ихээр хүсдэг

болжээ.Тэгээд хөвүүнийхээ энэ их үйлд өөрийн үлдсэн богино насаа зориулахаар шийдэв

.Тэмүжин хөвүүн нь Тэнгэрийн хүсэл зарлигаар төрснөө мэддэггүй юм биш биз гэсэн бодол сүүлийн үед төрөх болжээ.Өүлэн Тэмүжиний атгаж мөрсөн Тэнгэрийн тэмдгийн тухай Есүхэйгээс өөр хэнд ч хэлээгүй өдий хүрсэн билээ.Харин одоо энэ тухай Тэмүжинд хэлэх эсэхээ шийдэж чадахгүй тээнэгэлзэж байв.Тэмүжинг төрсний дараа өнөө нөж болон хувирсан Тэнгэрийн тэмдгийг өөрийн бодож олсон аргаар хадгалан хямгадаж иржээ.Харин одоо Тэнгэрийн тэмдгийг хэрхэх тухай шийдэж эс чаджээ.Тэмүжин хөвүүний нь их үйлсэд ямар ч болов хэрэг болно гэж итгэж байв.Бас буруу зөрүү хэрэг хийж Тэнгэрийг хилэгнүүлэхээс эмээх тул яах ч учраа олохгүй болжээ.Уг нь ид шид ихтэй тэгээд Тэмүжиний ихэд хүндэтгэн шүтдэг Тэв тэнгэр бөөгөөс асуумаар санагддаг байсан ч цааргалсаар байтал Тэмүжин Тэв тэнгэр бөөг үхүүлсэн билээ.

Тэв тэнгэр бөө улсын дотрох эрх булаалдаад алагдсанаас хойш Өүлэн энэ тэр бөө зайранд итгэл алдарсан юм.Гэтэл хөвүүнийхээ атгаж төрсөн Тэнгэрийн тэмдгийг нууж ирснээрээ Тэмүжиндээ тус болов уу, ус болов уу гэдгээ мэдмээр санагдаад болсонгүй.Яагаад ч юм бэ энэ Тэнгэрийн тэмдэг цаашид Тэмүжинд хэрэг тус болох мэт санагддаг байлаа.

Юутай ч энэ Тэнгэрийн тэмдэгийг Тэмүжинээс өөр хүн эзэмшиж эдлэж болохгүйг ойлгож байв.Тэгээд бодоод бодоод бодын шийр дөрөв гэдэг болж атгаж төрсөн Тэнгэрийн тэмдгээ хэрхэхээ Тэмүжин өөрөө мэдэг гэж шийджээ.Ингэж шийдсэн нь Тэмүжин бүх цэргээ нэгтгэн засаад Алтан улсад довтлохоор хөдлөхийн урд болжээ.Тэнгэрийн тэмдгийг хадгалж ирсэн нь зөв гэдэгтээ Өүлэн эргэлзэхгүй байв.Үүнээс хойш ч түүнийг Тэмүжинээс өөр хүн үзэх ёсгүй гэж боджээ.Өүлэн тэр тэмдгийг дахин хадгалж чадахгүй болжээ.Учир нь Алтан улсад одох гэж буй Тэмүжин хөвүүнтэйгээ тэрээр дахин уулзахгүй гэж шийдээд байв.

Өүлэн Тэмүжин хөвүүндээ илүү ачаа болохыг хүссэнгүй.Холын их аянд гарч буй хөвүүнийхээ ачааг хөнгөлөхөөс илүү тусыг Өүлэн үзүүлж чадахгүй гэдгээ мэдэж байв.

Одоо Алтан улстай хийх их тулаанд хөвүүдээ үхэхийг үзэх хүсэл түүнд дааны байсангүй.Хөвүүдээ тулаанд үхэхийг бас дийлдэж ялагдахыг үзсэн дорвол үхсэн нь шулуун билээ.Хөвүүдээ Тэнгэрт даатган үлдээх ганц зам түүнийг хүлээж байв.Өүлэн Тэнгэрт гарч Есүхэйн дэргэд суухаар шийджээ.

Тэр өөрийгөө дэндүү их зовов.Бас дэндүү их жаргав гэж тооцжээ.

Гэвч Өүлэний үхэл ирэх болоогүй ажээ.

Өүлэнд дахиад чилийсэн хоёр жилийн амьдрал үлдээд байгааг тэр даанч мэдэхгүй байлаа.

Цаг нь болоогүй байхад үхлийг хэн ч дуудан ирүүлж чадахгүй бизээ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХАСАР

Өүлэн эх тэнгэрт халив гэсэн хэл мэдээ гэв гэнэтхэн ирэх бий гэхээс Хасарын сэтгэл зүрх өдөр шөнөгүй түгшин төв улсаас хүн хар ирэх тоолонд хамгийн түрүүнд муу юм л бодогдох болов.

Монголын их цэрэг Алтан улсыг байлдан дагуулахаар мордсон тэр үдэш сүүлийн үед бие лагшин ихэд доройтож хэвтэрт голдуу байх болсон Өүлэн эх нь бяцхан өндийж хамгаас хайртай Хасар хөвгүүнээ эмгэнэлтэй, өрөвдөлтэйгөөр ширтээд

– Хүү минь. Би чамтай дахиж уулзахгүй байх. Ийм л их муу үйлтэй хүн байж хэмээгээд чимээгүйхэн уйлахад нь өтөл болсон эхээ хайрлахдаа өөрийн эрхгүй зүрх өмрөн нулимс унагасан билээ.

Эхийгээ орхин гарсан тэр өдрөөс хойш хоёр жил өнгөрөв.

Монголын их цэрэг Алтан улсын нутаг болох Шар мөрнөөс хойшхи газрын ерэн зургаан хот балгасыг дайлан эзэлж арвин их олз омог хураажээ.. Чингис хааны удирдсан төв замын цэргийн дунд Хасар өөрийн хоёр түмэн цэргийг удирдан явж байлаа. Эртний өст Алтан улстай дайтаж Амбагай цэцэн хаан өвгийнхөө өшөөг авах хүсэл Тэмүжин болоод Хасарын сэтгэлд өсөх цагаас хойш өнөөг хүртэл хадаатай явсан билээ. Амбагай цэцэн хааныг татаарууд барьж аваад Алтан улсад зулгуйдан өгсөн бөгөөд талын монгол аймгийн хаан Амбагайг зүрчидүүд модон илжгэнд тэлүүрдэн хадаж тамлан алсан ажээ.Тэдний багад Есүхэй эцэг нь архинд халамцах бүртээ энэ эмэгнэлт,хорсолт түүхийг нулимс унаган ярьж өшөө авахыг хөвүүддээ нялх гэлгүй захиж байсныг мартах аргагүй билээ.

Өст Татаар аймаг аль эрт Тэмүжин, Хасар нарт дарагдан сөнөөд одоо Алтан улсын үйл нэгэнт ирж Есүхэй эцэг нь олонтаа ярьдаг байсан өнөөх алдарт түмэн газрын Цагаан хэрэм тэртээ ард хоцорчээ.Хэзээ ч дийлдэшгүй их хүчний билэгдэл болж асан Цавчаал боомтыг Зэвийн цэрэг эзлэн авсан нь Алтан улсын мөхлийн эхлэл болжээ.Цагаан хэрмийг Монголын цэрэг давснаас хойш өвөл, хавар өнгөрч зуны халуун шатаад энэ хятад газарт амьд амьтан тэсэхийн аргагүй болж байв. Удахгүй Хасарын дөчин есний жил орох гэж байлаа.

Энэ үес Алтан улсад түүнтэй хамт Егү, Есөнхэй хоёр хөвүүн нь цуг дайтаж явав.

Харин отгон хөвүүн Туху нь Тангуд улсад анх довтлох үед алуулжээ.

Гэнэн томоогүй хөвүүн нь Тангудын олзны цэргүүдийн зэр зэвсгийг хураалцаж явтал өс санасан дайсан түүнийг амин газраар нь хутгалж орхижээ.Монголын цэрэг Тангуд улсад анх удаа довтолсонд тэд дийлдээд гүнжээ бэлэглэн найрамдахыг хүссэн элч илгээсэн билээ.Тангудыг эсэргүүцэл,гарз багатайгаар дагуулан авав гэж Хөх нуурын эрэгт их найр хийж суутал энэ аймшигт мэдээг Зэлмэ Хасарт дуулгажээ.

Арван гуравхан настай нялх балчир хөвүүний нь ам ангалзсаар амьсгал тасарч байхад гашуудан хилэгнэсэндээ ухаан мэдрэлээ нэгэнт алдсан Хасар хөвүүнийг нь алсан Тангудын цэргээс даруй тавин хүнийг цавчин алаад сэлэм нь хугарч унахад бас хорин хүнийг

багалзуурдан алж уй гашуугаа тайлсан билээ.

Гэвч өнөөг хүртэл Туху хөвүүн нь

-Аав аа.Амнаас урссан цусыг минь арчиж орхиорой.Нойр минь их хүрч байна.Намайг сэрэхээр та шархыг минь боож өгөөрэй.Одоо унтлаа.Та намайг бүү сэрээгээрэй гэж гэнэн агаад итгэлтэйгээр инээмсэглэн шивнэсэн нь үзэгдэж сонсогдоод зүрх нь урагдах шиг болдог ажгуу. Хайртай хөвүүнээ дайсанд алуулснаас хойш Хасар огт өөр хүн болчих шиг санагджээ.Туху хөвүүн нь хүн хүний хайр татсан хачин гавшгай хүү байв.

Түүнийг үхсэнд харамсаагүй хүн байхгүй бөгөөд Тэмүжин хүртэл харамсан гашуудсандаа эхэр татан уйлжээ.Учир нь Хасарын шинэ хөвүүнд Туху нэрийг хайрласан хүн нь Тэмүжин билээ.”Туху хөвүүн минь Цагаан хэрмийг үзэх хувьгүй байжээ” гэж Хасар гашуудан бодож зогсов.

Цавчим хадан хясаан дээр зогсоход өлмий дор нь Алтан улсын шавар балгас утаа, майнд дарагдан үзэгдээд,тэндээс хиншүү, өмхий үнэртэнэ.Хасар тэрхүү шавар балгасын өмхий бүгчим үнэрт тэсэж чадалгүй энэ хясаан дээр давхин гарч ирсэн нь энэ билээ.Зуухан дотор байх мэт халуун агаартай ч энэ өндөрлөг дээр эрхбиш сэвс сэвс салхи үлээх нь сэтгэл гэгэлзүүлж ард хоцорсон эхээ,амь үрэгдсэн хөвүүнээ эрхгүй дурсан санахад хүргэв. Бөртэ, Тэмүгэ нарын захиран сууж үлдсэн Тэмүжиний төв ордноос хэл ирсэнгүй даруй хоёр сар болоод байлаа. Шар мөрнөөс хойшхи хятад газрыг эзэлсэн монгол цэрэгт одоо өмнөд далай хүрэхэд Зүрчидийн Алтан улсын хаан саад болох нь бүү хэл яаж ийгээд өчүүхэн амиа аврах л үлджээ. Гэвч хятад газрын бүгчим халуун цэрэг, морь хоёрыг туйлдуулж байлаа. Алт эрдэнэ, хоргой торго, амуу тариа ачсан олзны их цуваа хойт зүг, өндөрлөг хясаан дээр орчноо харж зогсоо Хасарын өлмий доогуур хөвөрнө. Энэ бол дайны олз юм.Өдөр шөнө,өглөө үдэш нэг хором ч үл тасрах энэ их ачаа хөсгийг хараад Хасарын гунигт автсан сэтгэл бага боловч сэргэж бахдалтай болжээ. Гэвч энэ бүгд түүний юм биш. Бүх олз Чингис хааных. Дайны бүх олзыг улсын санд тушаах журмыг бүр анх татаартай байлдахад тогтоосноос хойш алгасалгүй мөрдсөөр иржээ. Өнөө ч тэр ёсоор олзыг Чингис хааны санд хүргүүлж буй нь энэ.

Нэгэнтээ авга ах Даридай олзонд шунан зам зуур сатаарч байлдаанаас хождоод арай л амиа алдалгүй мэнд өнгөрсөн билээ. Эрхгүй Есүхэй эцгийн нь отгон дүү, ургийн гэрээслэл мэт үлдсэн авга тул Тэмүжин түүнийг алсангүй. Харин Даридай авгыг зарлиг журам эвдэв хэмээн өчиггүй цавчин алсангүй гэж Хасар их уурссан билээ. Гэвч уур цухлаа тэвчин барьж Тэмүжиний үгийг эрхгүй дагажээ. Нэгэнт байлдааны цагт олзонд шунаж цалгардваас цаазаар аваачна гэж хатуу чанд тогтсон атал үүнийгээ зөрчин Даридайг авга ахаа гэж амийг нь өршөөхийг Хасар эсэргүүцсэн юм. Зөрчих аваас журам тогтоож яана.

Даридай олз цуглуулж цэргээ тулаанд оруулаагүйгээс болж Хасарын цэрэг олноор үрэгдсэн билээ. Гэвч Даридай авгыг өршөөсөн Тэмүжиний үгийг дагахаас өөр аргагүй болсондоо Хасар туйлын их бухимджээ.Бас энэ үеэр Боорчи,Мухулай хоёр Даридайг өмөөрч Тэмүжиний талд орон олон үг хэлсэн нь Хасарыг юу юунаас илүү уурлуулжээ.Тэмүжин түүний үгнээс илүүтэйгээр Боорчи,Мухулай нарын үгийг зөвшөөрөн дагасан мэт санагдаад Хасар байж яджээ.

Зүй нь бол Тэмүжин харц боол тэднийг биш, Хасарын үгийг хүндэтгэн сонсох ёстой билээ.

Ерөөс Тэмүжиний буруу үгийг дагах нь Хасарт тун бэрх зовлон болдог байв.Ингэх гарцаагүй учир ч байлаа.

Өөрийн хүсэл, үзлийн эсрэг Тэмүжиний үгийг өөрийн эрхгүй зөвшөөрөн дагах хэрэг гарах бүрт уур хилэн нь байж ядтал оволзож баруун гарын эрхийний өндөг часхийн өвддөг ажээ.

Хасарыг арван настай байхад Тэмүжин тэр хоёр анхны тангараг тавьжээ. Тэр үед эх өөртэй дүү Бэгтэр, Билгүтэй хоёрын эсрэг юу ч хийсэн хамтрахыг Тэмүжин шаардаж, үнэнч зүтгэх аваас гэрийн дотор удаах эрхийг Хасарт өгнө гэж тохирсны баталгаа болгон баруун гарын эрхийний өндгийг зүсч цусаа нийлүүлэн ёслосон билээ. Энэ бүгдийг Тэмүжин санаачилж бүр өөрөө түрүүлэн өндгөө эсгэж цусаа үзүүлжээ.Цусаа нийлүүлэн үгээ батлах нь эртний ёс юм.

Энэ нь Хасарт хэдий аймшигтай байсан ч үнэнч байхын тангараг тавих энэ цуст ёслол жинхэнэ зоригт эрсийн шинж шиг санагдаад өөрийн эрхгүй өндгөө зүсч орхижээ. Гэвч тэр дэндүү гүнзгий зүссэн учир шарх нь эдгэхгүй өчнөөн хоног зовоосон бөгөөд хожим уурлаж бухимдах бүр час часхийн өвддөг болжээ. Цусаараа баталсан гэнэн бага насны тангарагтаа тэр өнөө хүртэл үнэнч яваа бөгөөд Хасар бол за гэвэл ёогүй хүн юм. Харин Хасарын үзэхэд Тэмүжин арай л тийм биш ажээ.

Зарим зүйлийг хэлсэн дороо мартах мэт зөрчдөг, бас огт хэрэггүй үгийг мартахгүй хонзон санадаг Тэмүжиний ааш Хасарыг гайхашруулна. Хүүхэд ахуйдаа Хасар Тэмүжинтэй барилдахдаа насыг нь тоолон хаядаг байлаа. Үүнд Тэмүжин ихэд шаралхан барилдаж, бас хаяж чадахгүй болохоороо үхтлээ уурлан чичирч байхыг үзээд түүнтэй барилддаггүй болжээ.Тэмүжиний энэ хор шар эцэст нь өш хонзон болон хувирах мэт санагдаж айжээ.

Харин Бэгтэрийг харван алснаас хойш тэдний хооронд хачин сонин эвлэрэл, ойлголцол ,итгэл тогтож тэр нь Хасарт өнөө хүртэл мэдрэгдсээр байдаг билээ. Бэгтэрийг алъя гэж хэлээд эргэлзэх юмгүйгээр түрүүлэн харваж орхисон Тэмүжинг Хасар үнэн сэтгэлээсээ тоож биширсэн юм.Харин Хасар тэгэхэд тавьсан тангарагаа санан харвахаас өөр үггүй байв. Ядаж байхад зүссэн эрхий нь өвдөөд нумаа олигтой татаж чадахгүй байхад Тэмүжиний суманд оногдсон Бэгтэр тэлчлэн орилж, бас Тэмүжиний

–Хасар аа.Харваач чи гэж аймшигтайгаар хашгирах сонсдоод, Тэмүжин сумаа дахин онилохыг үзмэгц түүнд харвуулахаас айж ёстой л нэг харвасан шиг болж билээ. Ашгүй түүний салгалсан сум Бэгтэрийн даланд пүдхийн зоогдож, тэр хөдлөхгүй болжээ.

Харин хөлс нь урссан Тэмүжин алдлан татсан сумаа яг Хасар луу чиглүүлсэн мэт үзэгдсэн билээ. Хасар тэгэхэд анх удаа үхэл тийм ойрхон байхыг, Тэмүжин түүнийг цаг нь ирвэл огт эргэлзэхгүйгээр харван алж чадахыг хэзээ ч мартахын аргагүй гүн бат ойлгосон юм. Тэгэхэд Тэмүжиний солиорсон мэт дүрлийсэн шар нүднээс гялсхийсэн оч түүнийг уурлахад өнөө ч заримдаа үсчих шиг болдгийг Хасар харж, нуруу руу нь түмэн шоргоолж гүйх шиг болно. Гэвч энэ нь зөвхөн тэр эртний дурсамжийг санагдуулахаас бус айдас биш байв.

Тэмүжин хэдий хүч бяр, бие хаа дутуу ч хэзээд түүний ах байлаа.

Дүүгийн хувьд, бас тангараг тавьсан нөхрийн ёсоор Тэмүжиний үг, зарлигийг дагаж хүндэтгэн хандах авч Хасар хэлье гэснээ хэлдэг, ингэхдээ ер айж ичих зүйлгүй байдаг нь олны өмнө Тэмүжинг эсэргүүцэн тэмцдэг ганц хүн нь тэр мэт сэтгэгдлийг бусдад төрүүлдэг байв.Бас Тэмүжин Хасар хоёрыг өрсөлдүүлж тэмцэлдүүлэхийг далдуур хүсэгчид ч тийм цөөхөн биш байлаа. Есүхэйн гэрт ана мана хэрэлдэж зодолдож өссөн ах дүү хоёр эр бие гүйцэж ид хаваа гайхуулсан баатар эрс болсон ч хоорондоо өрсөлдөн мөчөөрхөх зан нь хэвээр үлджээ Хасарын хувьд Тэмүжинээс ялгарах бас нэг юм нь үг, сэтгэлийн хөдлөлөө нууж чаддаггүй түргэн зан байлаа.

Хасар хөвүүнийхээ энэ хурц түргэн зангаас Өүлэн ихэд болгоомжлон ая эвээр хүмүүжүүлж сургасаар ирсэн боловч төрөхөөс цусанд шингэсэн чанарыг юу ч өөрчилж үл чадах ажээ.Хөвүүдийн хооронд үл ялих маргаанаас үүдсэн зодоон болох нь энүүхэнд.

Тэр үед Хасар нулимс урсган хамаг үнэнээ хэлж орилж, хашгирч байхад Тэмүжин хорсол занал шингэсэн харцаар нэвт шувт ширтсээр таг дуугүй зайлан оддог байлаа. Хэсэгхэн хугацаа өнгөрмөгц нулимсны нь халтар арилаагүй Хасар нэг дуу газарт нөгөө дуу тэнгэрт хадан өнгөрсөн зодооныг мартчихсан дэгдэж явахад Тэмүжин догшин шар нүдээ гялалзуулан хөмхий зуусаар байдаг ажгуу.

Тэмүжиний гомдол мартагдах нь удаан тул заавал хорслоо тайлж, ороо авч байж тайтгардаг зантай. Зулай зулайгаа гишгэн төрсөн нэг эцгийн хөвүүд ингэж эрс өөр зан авиртай болж өссөний учрыг Өүлэн олсонгүй. Гагцхүү Тэмүжин бол Бодончар богдын сүнс, харин Хасар нь Бартанбаатар өвгийнхөө сүнс болохыг тэр яахин тааж мэдэх билээ.

Ер нь удам угсаа, төрөх үхэхийн нарийн учир зүйг Тэнгэрээс өөр хэн мэдэхсэн билээ.

Харин Хасар, Тэмүжин хоёрын бас нэг ялгаа нь Тэмүжин өөрийгөө Бодончар өвгийнхөө сүнс гэдэгт итгэдэг, Алангуа эхийн ярьсан тэр домогт гардаг шиг Тэнгэрийн язгуурт төрөлтэй гэдгээ хүлээн зөвшөөрдөг явдал байв. Тийм учраас Хасар болоод Тэмүжиний зан ааш, үйл хөдлөл эрс ялгаатай болсон юм. Хасар хэдий хурдан догшин зантай, хурц мэргэн үгтэй ч гэнэ гэнэ юу болов гэмээр бодолд автан зогсдог зантай . Ийнхүү бодолд автсан үедээ л ахтайгаа ялгаж танихын аргагүй адилхан үзэгдэх бүлгээ. Хасар энэ удаа Жүндү хотоос өртөө зайтай байх Дайду балгасын хойт хясаан дээр зогсоод алт эрдэнэс ачсан их хөсөг монголын тал нутаг, Чингис хааны хээрийн хүрээ рүү хөврөхийг харан яг ингэж бодолд дарагдан зогсож байв.

Энэ Дайду балгас хэдий жижиг ч Алтан хааны зуны өргөө байдаг тул баян, чухал боомт бүлгээ.

… Өүлэн эх минь амьд сэрүүн л байгаасай гэж Хасар сэтгэл зүрхээ өмөлзүүлэн бодож зогсов. Өүлэн эх нь Хасарын хувьд энэ ертөнцийн ганц эрхэм хайртай хүн нь бөгөөд эхийгээ үхвэл чухам яахаа тэр бодож олохгүй байлаа. Гэвч Өүлэн эх нь удаан тэсэхээргүй болсон нь даан ч тодорхой байсан билээ .Харин ч эхийг нь Тэнгэр тэтгэж өдий насалжээ. Эхийнх нь үхэл Хасарт одоо өмнө үзэгдэгч Дайду балгас шиг, хойт зүг хөврөгч тэрэг хөсөг шиг гэнэтхэн тов

тод төсөөлөгдөв.Өүлэн эхийнх нь үхэл ганцхан Хасарт л хамаатай мэт түүнд санагдана. Хачиун дүү нь өвчний учир эрт үхэж, Тэмүгэ, Тэмүлэн хоёр нялх балчир, дээр нь Тэмүжин ах нь эсвэл олзлогдож, үгүй бол Дайцэцэнийд юм уу Тоорилынд очиж суусаар гэртээ байсан нь ховор тул чухамдаа Хасар л Өүлэн эхийнхээ ганц итгэл, зовлонт амьдралд нь түшиг тулгуур болж явсны учир хамгийн ихээр дотносон хайрласан хүү нь билээ.

Бусад хэнтэй ч болов хэрэлдэн уралцахад бэлэн байдаг Хасар эхийгээ үзэж, үгийг нь сонсмогц хайлсан тугалга шиг болж, эхийнхээ үгнээс зөрж гажихыг мэддэггүй байлаа. Хасар шиг ийм түргэн догшин ааштай хүнээс гармааргүй уяхан зөөлөн занг эхдээ гаргадагт нь харсан үзсэн хүн бүү хэл Өүлэн ч өөрөө гайхшран уярах нь олон. Тэртээ зун гэнэт тэнгэрээс унах шиг хүрч ирсэн мэргэдийн их Чилэдүгээс Өүлэн эхийгээ авран авч чадсан нь чухам Тэнгэрийн зарлиг байсан бөгөөд түүнээс хойш эхийгээ хайрлах, хамгаалах хүн нь ганцхан өөрөө гэдэгт Хасар бат итгэсэн юм. Энэ итгэл Хасарын амьдралынх нь үзэл,үг үйлдлийнх нь гол суурь болжээ. Юухан дээр ч болов тэр юуны өмнө “Ээж юу гэх бол, ээж яах бол” гэж бодож сурчээ. Дайнаас ирэхдээ тэр гэртээ биш эхийндээ л түрүүлж очно. Өүлэн ч Хасар хөвгүүнээ ирнэ гэж хүлээж суух бүлгээ. Ээжтэйгээ хамгийн олон жил хамт амьдарсан, бас ээжийнхээ сэтгэлийн нандин нууцыг бусдаас илүү мэддэг түүний хувьд ээжийгээ өмгөөлөн хайрлахаас өөр эрхэм зорилго үгүй юм.

Өүлэн эхийгээ өст мэргэдийн их Чилэдү гэгчид дахин автах аюулаас хамгаалан авч чадсаныгаа Хасар хамгийн ихээр бахархана. Бяр чадалтай, байлдах эрдмийг бусдаас илүү төгс эзэмшсэн нь Хасарыг өдрөөс өдөрт бардам дээрэнгүй, омогтой хурц болгож байсныг тэр анзаарсангүй. Бүхнийг эр чадал,омог зоригоор дийлэх юм шиг санаж, дийлэхгүй хүчтэн үгүй мэт сэтгэнэ. Бөртийг буцааж булаан авах үед мэргэдийн Чилэгэр бөхийн сэлмэнд үхэх аюулаас Тэмүжинг аварсан нь түүнийг бүр ч гааруулсан билээ. Энэ хэрэг явдлаас хойш хэсэг хугацаанд Тэмүжин Хасарт их урин зөөлөн, аясаар нь дуулгавартай ханддаг байв.Энэ явдлаас үүдэн Хасар гэрийн дотор Тэмүжиний удаах эрхтэй, зарим үед түүнээс ч илүү эрх мэдэлтэй юм шиг болжээ. Боорчи, Зэлмэ хоёр ч Хасартай маргалдаж сөргөлдөхөөс илт зайлсхийнэ. Эргэн тойрны энэ хүндлэл Хасарт туйлын амттай байв.Гэвч Хасарын аз жаргал тун ч богино настай байлаа. Хасар бяр чадал, байлдах эрдмээр өөрөөс нь илт давуу гэдгийг Тэмүжин аргагүй хүлээн зөвшөөрсөн, түр зуур буулт хийсэн үе байсныг Хасар тэгэхэд тодорхой ойлгож мэдээгүй билээ. Цагийн эрхээр, Хасарын хүчийг бүрэн ашиглах, бас түүнийг бага боловч урамшуулах гэсэн бодлын үүднээс Тэмүжин зулай даран төрсөн өрсөлдөгчдөө бяцхан зай тавьж өгсөн хэрэг байв. Харин яваандаа ямар цохилт хүлээж байсныг Хасар мэдсэнгүй.

Тэмүжинг хорин настайд Боржигон аймгийн ханд өргөмжлөв. Алтан ургийн үе залгамжлах эрхтэйн хувьд Тэмүжин Хасар хоёулхнаа энэ тухай ярилцсан билээ. Харц боол гаралтай Зэлмэ болоод Боорчи нар тэдний юу ярьсныг мэдсэнгүй. Есүхэйн цусанд төрсөн ахмад хөвүүний ёсоор Тэмүжин Боржигон аймгийн хан болох ёстой гэж Хасар хатуу шаардав. Харин үүнийг нь Тэмүжин эрс эсэргүүцсэнд Хасар гайхаад бүр ухааныг нь олсонгүй. Нэгүүн тайшийн хөвүүн Хучир, Хотула ханы хөвүүн Алтан, эсвэл Бартанбаатарын хөвүүд Сача бэх, Тайчу хоёрын хэн нэгийг хан болгоё гэж Тэмүжин хэлжээ. Хасар тэгэхэд амьдралдаа анх удаа Тэмүжинг үзэн ядаж билээ. Хэрэв Тэмүжиний оронд байсан бол Хасар эргэлзэх зүйлгүйгээр Боржигон аймгийн хан болох байлаа.

Өөрөөс нь ахмад настай,нэр хүнд хөрөнгө зоорь ихтэй, угсаа залгамжилсан эдгээр хүмүүс чухам ямар шалтгааны улмаас Боржигон аймгийн хан болохоос цааргалсаар байгаагийн учрыг Тэмүжин нарийн тодорхой мэдсэнгүй. Харин Мэнлигийн хөвүүн Хөхөчүгийн хэлсэн үгийг, бас Тэнгэрийн сахиусыг хүргэж ирснийг Тэмүжин мартсангүй. Хөхөчүгийн үг хан болоход нэмэртэй цорын ганц шалтаг байсан тул Тэмүжин айж байлаа.

Энэ үед Хасар анх удаа Есүхэйн ууган хөвүүн болж төрөөгүйдээ харамсчээ.

Тэмүжиний ганц давуу тал нь түүнээс урьтаж төрсөн явдал л юм биз гэж тэр жөтөөрхөн бодсон билээ.Гэвч Хасарт Тэмүжиний үгийг дагахаас өөр арга үлдсэнгүй. Харин бүх юм Хасарын хүссэнээр болж өнөөх Алтан, Хучир, Сачабэх, Тайчу нарын хэн нь ч хан болохыг хүссэнгүй нь бүр хачирхалтай явдал болов. Тарж бутарсан, нэгдсэн хүчгүй, эн тэнцүү олон овог,эзэнтэй Боржигон аймгийг нэгтгэн хан суух гэдэг үнэндээ хүсэх юм биш, хүзүү толгой салгах хэрэг гэдгийг Хасар ойлгож чадахгүй байв.

Харин эрх мэдлийн төлөө олон жил ил далд өрсөлдөж долоо шархадсан чоно шиг хаширсан тэд Есүхэйн залуу хөвүүнийг цуст тэмцлийн золиос болгон хаяж өгөхөөр шийдсэнийг Хасар ч , Тэмүжин ч мэдсэнгүй.Боржигон аймгийн хан болгоё гэсэн тэдний саналыг Тэмүжин эцэстээ зөвшөөрсөн нь Хасарыг гайхуулсангүй, харин ч баярлуулсан нь тоймгүй.

Хасар ганцхан үүнийг л хүсч байсан билээ.

Хагас дутуу ч гэлээ цугларсан Боржигон аймгийн ханд Тэмүжин өргөмжлөгдсөнд Хасар өөрөө л хан болсон мэт үнэн сэтгэлээсээ хөөрөн догдолсон билээ.

Бүр нүдний нь нулимс цийлэгнэж зүрх нь бэрх чангаар цохилж зогсжээ.Тэмүжин ингэж Боржигон аймгийн ханд өргөмжлөгдсөн нь Хасарын тээж явсан холын их мөрөөдлийн биелэх эхлэл мэт түүнд санагджээ.Гэвч түүний энэ хүслийг одоохондоо хэн ч мэдэхгүй байлаа.

…Хасар угаас хачин мөрөөдөмтгий хөөрүү дэврүүн хүүхэд байлаа. Хөөрүү дэврүүн зантайнхаа хирээр гуньж гутрах нь ч амархан юм.Боржигон аймгийн шинэ ханыг өргөмжлөх ёслолын үед Тэмүжиний хэлсэн үгийг сонсоод Хасарт цэлмэг тэнгэрт аянга ниргэх мэт болж нэг хэсэг нүд нь бүрэлзэн юм харахгүй болжээ.

“Аймгийн дотрох хамаг хэргийг бүхнээс урд ирж надтай нөхөрлөсөн тул Боорчи, Зэлмэ хоёр ахална“ хэмээн Тэмүжин цугларсан ихэс, ахмадууд, бүр Өүлэн эхийн нь нүүрэн дээр ил тодоор зарлан тунхагласан нь ерөөс Хасарыг чухал хүн гэж үздэггүйг нь нотлох мэт санагджээ. Боржигон аймгийн ханд өргөмжлөгдөөд Тэмүжиний буулгасан анхны энэ зарлиг ганц Хасарыг ч биш, Тэмүжинийг ханд өргөмжилснийхөө шанд эрх ямба горилж суусан бүх хүнийг цочоожээ.

Бас энэ зарлиг үнэнч нөхдөө харц ядуу гаралтай байсан ч бүхнээс илүүд үзнэ гэсэн Тэмүжиний тунхаг байв.Тэмүжин ханд өргөмжлөгдвөл би хэн болох билээ гэж Хасар тодорхой зүйл төлөвлөж бодоогүй ч, гэрийн доторх зарцын хэмжээнд байвал зохих Зэлмэ, Боорчи хоёроор бүх хэргийг ахлуулахаар шийдсэн нь яав ч байж болшгүй хэрэг гэж тэр үзжээ. Өүлэн эх нь ч ийм бодолтой байхыг тэр олж харав. Эх нь Тэмүжиний үгэнд гайхаж цочсон,

бас Хасарыг аргадаж тайтгаруулсан харцаар ширтсээр байсанд Хасар хөдөлж, дуугарч чадсангүй. Угаас хөдлөх гээд хаачих, дуугарах гээд юу хэлэхээ тэр үнэндээ мэдэхгүй байлаа. Хэдий нь тэр арван найман нас хүрсэн тул Хасар өөрийгөө нялх балчир хүүхэд гэж үзэхгүй байсан билээ. Энэ явдлын хойно гэрийн доторх Хасарын эрх мэдэл өөрчлөгдөж буурсан зүйлгүй боловч Тэмүжинд гомдох сэтгэл нь эдгэсэнгүй. Харин Тэмүжинтэй ямагт өрсөлдөх, түүнээс даван гарах зовлонт хүсэл нь улам оргилохыг тэр мэджээ.

-Боржигон аймгийнхаа дотор Хасар чи Тэмүжиний л адил Есүхэйн хөвүүн тул хэнээс айж юугаараа дутна.Чамайг хүсвэл би туслах болно гэж Тэмүжинийг хан болсны хойтон жилийн зун Жамуха нэгэнтээ хэлж билээ. Уг нь яг ийм үгийг Жамуха үүнээс гурван жилийн өмнө бас Хасарт хэлжээ.

”Мэргэдийг дайлж Тэмүжинд туслая.Жамуха чи өөрийн албатаас хоёр түмэн цэрэг авч Ботгон боорчид ирэгтүн” гэсэн Тоорил ханы үгийг уламжлахаар Хасар Жамухын хүрээнд очоод байхдаа сонссон дээрх үгийг ухаарч үзсэнгүй билээ. Гэтэл түүнээс хойш гурван жил өнгөрч олон зүйл өөрчлөгдөв.Одоо Хасар эхнэр авч жижиг боловч өөрийн хүрээгээ үүсгэж, цөөн боловч цэргээ захиран толгой даан суух болсон байлаа.Тийм учраас Жамухын үгэнд арай өөрөөр хандах болжээ.Үнэхээр Жамуха хүсвэл хоёр байтугай хэдэн түмэн цэрэг гаргаж чадахыг мэргэдийг дайрах үед Хасар өөрийн нүдээр үзсэн тул Жамухын энэ үгэнд эргэлзэн гуйвж байтал Өүлэн эх бүхнийг нэвт харах шиг мэдээд сэрэмжлэн ятгасан юм.

Бас Тэмүжин тангараг тавьсан нөхрөө гэдгийг сануулж, “Есүхэйн хөвгүүд эвтэй явбал хэнд ч үл дийлдэнэ” гэж сайхан үг хэлээд ах дүү хэдүүл халуун амиар эхийнхээ хамт найрлан сууснаас хойш Хасар Жамухын хорт үгийг сэтгэлээсээ авч хаясан билээ. Хуучин аймаг овгийн ахмад хүмүүс болох Алтан, Хучир, Сачабэх, Тайчу гээд бүгд л бага боловч эрх мэдлийн төлөө хүүгээ алж, ханиа худалдахад ч бэлэн байгааг Хасар сайтар ухаарч мэджээ. Тэр бүү хэл Тэмүжиний эсрэг түүнийг турхиран цэрэглэж хөдлөхийг улайм цайм шаардахыг ч үзэв.Хасарын өмнө Тэмүжинтэй хамт үлдэх үү, эсвэл Тэмүжиний эсрэг тэмцэх үү гэдгийн аль нэгийг сонгохыг хатуу амьдрал, авилгач хүмүүс цаг ямагт тулган шаардах болжээ. Үнэхээр Боржигон аймгийн дотор Тэмүжинтэй эн тэнцүү өрсөлдөж чадах хүн бол ганц Хасар юм.

Тэр өөрөө ч үүнийгээ сайн ойлгож байв. Гэвч зовсон эхийн сэтгэл, өнчин ядуу амьдралын дунд бие биенээ түшин халуун итгэл, хатуу тангаргаар гагнагдсан Тэмүжин, Хасар хоёрын ах дүүгийн сэтгэл ийнхүү өрсөлдөж өрвөлзөх санаанд нь саад болж эцэст нь Хасар хоёр замын тэг дунд тэлээ хурга шиг эргэж буцаж байлаа. Нэр төр олох, Тэмүжиний адил эрх мэдэлтэй болж эзэн суух хүсэл нь заримдаа дийлдэмгүй ихээр оргилно. Хасар ийнхүү эргэлзэн тээнэгэлзэж, цаг хугацаа өнгөрсөөр байх зуур Тэмүжин улам хүчирхэгжиж байлаа.

…Гэнэт хүн хашгирч Хасарын бодлыг тасалдуулав. Тэр нүд хараатай боловч юу ч үзэхгүй зогсож байжээ. Ухаан санаа нь тэгширч нүдний өмнө дахиад л утаат Дайду балгас тодров. Олзоо ачсан тэрэг хөсөг хөвөрсөөр,түүний хажуугаар эмс, боолууд толгой гудайлган цуварна. Цэрэг бүр Алтан улсын залуу эмс,гарын уртай эрсийг олзолсныхоо хэрээр гэр орондоо илгээж буй нь энэ билээ.

Саяын хашгирсан хүн бол Егү хөвүүн нь байжээ. Хөвүүн нь одоо гуч дөхсөн гунхсан сайхан

эр болж бас ч болоогүй өтлөх янзтай. Егү дагуул шадруудаа орхин мориноос бууж дэргэд нь гүйн ирэв. Хөвүүний сандарсан хөдөлгөөн Хасарын дотрыг түгшүүлж дахиад л эхийн үхлийг санагдуулахад өөрийн эрхгүй айсан мэт ухрав…

-Юу болов гэж Егүг гүйн ирэхэд түрүүлэн асуув.Егү нүд эргэлдүүлэн инээмсэглэж байх нь яав ч үхлийн тухай мэдээ биш бололтой.Тэр ер нь эцгийгээ дуурайсан сэтгэлийн хөдлөл ихтэй хөвүүн юм.

-Мухулай жанжин таныг түргэн ирнэ үү гэж байна. Алтан улсын Юнжи хаан элч ирүүлжээ.Бүгд цугларaад хэрхэхээ хэлэлцэхээр таныг хүлээж байна гэж Егү инээмсэглэв.

Их улсыг дийлсэн, ялсан цэргийн бахархал, сүр жавхаа хөвүүнд нь дүүрэн тул Хасар таатай инээмсэглэв. Монголын их цэрэг Алтан хааны суугаа Жүндү балгасыг дайран эзлэхээр бэлтгэж байсан билээ.Алтан улсын хааны толгой хоргодон суугаа Жүндү балгас хүртэл ердөө ганцхан өртөө зай үлдсэн нь Хасарын хувьд шүлс хаях газар байлаа.

-За одоохон очъё… Тэд мордон давхицгаав. Хот хүртэлх зам дагуу толгодын жалга сувгаар Алтан улсын хядуулсан цэргийн хүүр дүүрэн чихээстэй, цэвэрлэх зөөх хүмүүс хотоос туугдан ирж яваа нь зөрнө. Алтан улсын хаан өөрийн зуны өргөө гэгдэх энэ Дайду балгасыг орхин өмнө зүг зугатсан тул монголын зүүн замын цэргийн удирдагчид зүрчидийн Алтан улсын хаан Юнжийн зуны сэрүүн ордонд цугларчээ. Хасар тэдний дунд хамгийн нэр хүндтэй ахмад нь юм.

Мухулай, Зэв, Сүбээдэй, Зүчи, Цагадай, Өгөдэй гээд ордон дүүрэн хүн Хасарыг баяр хөөртөйгөөр хүлээж байв.Монголчуудын дунд хөөрч догдлоогүй хүн нэг ч үгүй байв.Ихийг үзсэн Мухулай хүртэл сахлаа байн байн илбэж цааш нааш холхих ажээ.Эртний хүчирхэг зүрчидийн Алтан улсын хаан буун өгч найрамдахыг хүсчээ.Алтан улсаас өшөө авах нь монголчуудын олон үеийн хүсэл билээ.Алтан хаан хүчин мөхөсдөж найрамдахыг гуйж шалдаа буухыг тэд ийнхүү үзжээ.

Ийм чухал хэргийг Чингис хааны төрсөн дүү Хасарт дуулгахгүй байх эрхтэй, зүрхтэй хүн энд үгүй байлаа.Түүнийг ахмадын ёсоор хүндэтгэж хэлэх үг, хэрхэх бодлыг нь сонсох гэж хүлээсэн нь Хасарт таалагдсан тул тэр их баяр бахдалтай байв. Зүчи түүнийг угтсаар яаран хүрч ирэв. Тэр залуу бас л хөөрч бүр холоос гүйх шахам яваа харагдана.

Чингис хааны ууган хөвүүн учир ийм чухал хэргийг Хасартай зөвшин хэлэлцэх ганц хүн гэдгээ олонд үзүүлэхийг Зүчи бас хүсчээ.

-Хасар авга аа. Догдолсондоо Зүчийн дуу чичрэв.

-Алтан улсын хаан найрамдахыг хүсч элч илгээжээ. Бид хэрхэх билээ гэж асуух Зүчийн дуунаас ялалт, бахдалын омгорхол илт сонсдох ажээ.

-Элч нь хэн юм бэ гэж Хасар шууд асуув. Хэнийг элчээр зарснаас хэргийн учир бэлхэнээ тодорно гэж Хасар түргэн зуур бодов. -Вангин Чансан гэнэ хэмээх Сүбээдэйн дуу хүнгэнэн сонсдов. Алтан улсын хаан Юнжи Жүндү хотод орогноод байснаа цааш өмнө зүгт зугатаасан

нь өөрийн хар толгойг цусдах өдөр холгүй болж утсан чинээ улаан амиа аргагүй бодох цаг ирснийг тэр ойлгосон нь гарцаагүй бололтой. Вангин Чансанг Хасар болоод монголчууд сайн таньж байв. Энэ бол Алтан улсын өмнөх хаан болоод одоогийн хаан Юнжид их нэртэй, ордны том шадар сайд юм. Вангин Чансан бол Татаар аймгийн Мэгүжин сүүлтийг хавсран дарав гэж Тоорил ханд ван,Тэмүжинд Чаутхари цол шагнаж байсан тэр ихэмсэг этгээд билээ. Монголчуудын сайн мэдэх,тэр дундаа Тэмүжинтэй хавсран татаарыг даралцсан Вангин Чансанг илгээсэн нь Алтан хаан үнэхээр мухардаж амиа бодон эцсийн аргаа хэрэглэснийх гэж Хасар үзэв. Гэвч түүнд цэргээ буцаах хүсэл байсангүй.Учир нь Алтан хааныг дарж дархан цолоо мандуулан алдарших сайхан боломж яг одоо түүнд нэгэнт бий болоод байгаа билээ. Алтан хааны их цэрэг монголын гурван замын цэрэгт цохигдон бутарсан тул нэгдэн байлдах чадалгүй болсноор Алтан улсын нутгийн ихэнх хэсэг эзлэгдээд өмнө зүгийн хэдхэн хот үлджээ.Ийм үед найрамдан цэргээ татна гэдэг хожмын дайснаа зүгээр тавьж явуулсантай адил хэрэг болох байлаа. Тэгээд ч эртний өст дайснаа яавч өршөөж болохгүйг Хасар бат мэдэж байв.Алтан улс бол монголчуудын хувьд мартахын аргагүй гай учруулсан дайсан юм.

Жил өнжөөд л их цэрэг ирүүлж монгол аймгуудыг довтлон эрчүүдийг нь хөнөөн,хүчийг нь цөөлөх хорт бодлого явуулж ирснийг нь яагаад ч мартаж болохгүй.Ийм өст дайснаа өршөөн найрамдана гэвэл Чингис хаан хэзээ ч зөвшөөрөхгүй биз.Алтан улсын хаан Юнжи заль зохиож цаг хожин цэргээ цуглуулахын тулд ийм арга сэдсэн нь тэр бөгөөд үнэндээ үүнээс өөрийг сэтгэсэнгүй билээ.Тийм ч учраас монголчуудтай эрхбиш эртнээс аятай харилцаатай гэгддэг Вангин Чансанг сонгон илгээсэн нь илт ажээ.

Бүгд Хасарын үгийг хүлээж байв.Вангин Чансан хуучин хааныхаа өргөөнд хөл тавьж эхлээд энэ олон монголчуудын хэнд нь эхэлж ёслохоо мэдэхгүй алмайрсан ч хашир хүн тул дорхоноо сэхээрч Хасарт ойртон дор мэхийв.Вангин Чансан урт үг нуршсаныг Кидан хэлмэрч уламжилж дуустал хэн ч дуугарсангүй.Бүгд одоо Хасарын үгийг хүлээх ажээ.Вангин Чансан найрсгаар инээмсэглэж баг өмссөн мэт хуурамч мишээл нүүрэндээ тодруулан ихэмсэг зогсоно.

-Түүний үгийг бүү сонс. Маргааш олзны хөсөг явж дуусмагц Дайдү балгасыг гурав хоног цэргүүдээрээ талуулагтун.Тэд дайны олз хишгээ өөрийн чадал самбаагаар олж авцгааг.Тэгээд Жүндү хотыг дайрч тэр Алтан хааны ичээг эвдэн дуусгая.Тэр одоо Жүндүг бидэнд өгөхгүй хаашаа зайлна гэж Хасар өөрийн санааг товч бөгөөд эргэлт буцалтгүй хэлэв. Хасарын сэтгэлд ялах дийлэхийн их хүч оргилж байлаа.Алтан хааныг нэг мөсөн даран сөнөөхийг Хасар хүсч байв.

-Алтан хааны элч би зөвхөн Чингис хаанд бараалхах хүсэлтэй. Бас Чингис хаанд бэлэглэхээр Алтан хааны гүнжийг авчирсан билээ. Чингис хаан тусгаар улсын элчид онцгой хүндлэл үзүүлдгийг Вангин Чансан би сайн санаж байна.Татаарын Мэгүжин сүүлтийг хавсран дарж явахдаа Чингис хаан бидэнд хоёрхон биеэр ярилцаж зөвлөсөн зүйл ч бий юм гэж Вангин Чансан хэлжээ. Сүбээдэй хоолой засав.

Энэ бол Сүбээдэйн болгоомжлуулж буй дохио байлаа.Учир нь Сүбээдэй аливаа бүх хэргийг ганц Чингис хааны таалалд нийцүүлэн гүйцэлдүүлж сурсан тул ингэжээ. Сая л хэргийн учрыг бүрэн ойлгосон Хасар түргэдсэнээ мэдлээ.Чингис хааны зарлиг саналыг сонсоогүй байж их үг хэлж болчимгүй зан гаргаснаа ойлгов.Гэвч оройтжээ.Омголон зан нь бууж

өгөхийг хүссэнгүй.Хасар хэлсэн үгнээсээ буцалгүйгээр Алтан хааны элчийг гаргав.Харин Чингис хаанд илгээсэн Алтан хааны гүнжийг хэрхэх тухай Вангин Чансан асуусан нь бүгдийг бодолд оруулав.

Энд байгсадын дотор Чингис хааныг төлөөлөн бэлгийг хүлээн авах зүрхтэн үгүй байв.Вангии Чансан ч үүнийг сайтар мэдэж байсан тул сахал дороо мушилзаж зогсов.

-Вангин Чансан чи Алтан хааны бэлэг гэж юу ярина.Газар нутаг,хатад,гүнж нь удахгүй бүгд Чингис хааных болох тул чи Чингис хааны гүнжийг өөрт нь бэлэглэж байгаа хэрэг бус уу.Би удахгүй танай тэр Алтан хааныг өөрийн гараар сөнөөнө.Тэр цагт Чингис хаан өөрөө дуртай гүнжээ таалах биз.Вангин Чансан чи монголчууд бидний хэрэгт бүү оролц.Бид чамтай чамгүй хот улсыг чинь эзэлж их хаандаа хацар гоо эмсийг авч өгч дөнгөнө гэж Хасарын хэлсэн нь бүхэнд таашаагдаж харин Вангин Чансан хэлэх үггүй болжээ.

Хасар үнэхээр ингэнэ гэж бодоод итгэл төгс хэлсэн билээ.

Түүний зориг дүүрэн хэлсэн эдгээр үгс эндээс гурван зуун бээрийн цаана байсан Чингис хааны өргөөнд тэр шөнөдөө хүрч маргааш өдрийн морин цагт “Алтан хааны элчийг нааш илгээн бараалхуулагтүн.Хасарыг даруй ирүүлсугэй” хэмээсэн зарлиг иржээ. Хасарын үгийг шувуу зөөсөн мэт түргэнээ хүргэсэн элч одоо Чингис хааны зарлигийг уламжлахаар өмнө нь зогсож байв.

Сүбээдэй нууцаар элч илгээснийг Хасар гадарласан ч түүнд ер гомдож уурласангүй.

Сүбээдэй эс тэгвэл өөр хэн Чингис хаанд үнэнч зүтгэх билээ.

Хасар угаас өөрийн бодлыг зөв гэж итгэх тул тайван байжээ.Тэртэй тэргүй Чингис хаан Алтан хааныг нэг мөсөн сөнөөх зарлиг буулгана гэдэгт эргэлзсэнгүй.Чингис хааны элч ирснийг уламжлахад Хасар Дайду балгасын төвд Алтан хааны зуны сэрүүн өргөөний гадна морь харж байв. Элчийн өгчилгөсөн шар дугтуйт бичгийг Хасар огт гайхсангүй авлаа. Дугтуйн гадна Чингис хааны тамгыг даржээ.

Дугтуйг задлавал Чингис хааны бичгийн түшмэл Тататунга өөрийн гараар “Зарлигийг авмагц даруй хээрийн өргөөнд ирэгтүн“ гэж бичээд мөн л Чингис хааны тамгыг даржээ. Хасар бичгийг төвдөлгүй уншаад инээмсэглэв.

-Чингис хааны зарлиг шувуу мэт нисдэг болжээ гэж Хасар энгүүн тайван хэлээд инээмсэглэв.Ойр ойрхон зайтай буухиалуулан байгуулсан өртөөг дамжин морь сэлгэн давхих монгол элч шиг түргэн шуурхай холбоо хаана ч байхгүй болжээ.

-Егү… Есөнхэй… гэж хашгирахад нь шадар нь гүйн ирэв.

-Хөвүүд арай дээшлээгүй байна гэж шадар хулмалзана.

-Өчигдөр хятад бүсгүйчүүл эдлэж хоносон биз гэж Хасар ивээнгүйгээр хэлээд

–Морь бэлд.Би Чингис хааны өргөөнд хүрэх боллоо. Егү, Есөнхэй бүгдийг босго. Цэргээ

жагсаа гэж тушаав.Эцгээсээ сүүлдэж боссон хөвүүдийн төлөө санаа зовсон шадар гүйж одов.

Алтан хааны элч Вангин Чансанд хэлсэн үгний нь төлөө Чингис хаан хилэгнэн дуудсан биз гэж Хасар таамаглаагүй ч сэтгэл нь гэнэт цухалдуу болжээ.Гэвч нэгэнт үнэн зөв үг хэлсэн тул ухрах няцах зүйлгүйгээр тэр өдрөө шадар торгон цэргээ дагуулан яаравчлан довтолгов. Тэр үед Чингис хаан Тулуй хөвүүний хамт Цагаан хэрмийн өмнө этгээдийн Шар тээгийн хөндийд буудаллаад байжээ. Хасарын баг цэрэг давхиан дунд ундалж хооллон хөтөлгөө морио сэлгэн унасаар зогсолтгүй довтолгон үдэш сар хөөрч од түгэж байхад Чингис хааны өргөөнд дөхөж эхний хэвтүүлд ирснээ мэдүүлж байв. Тэд үнэхээр нисэх мэт явсан билээ. Чингис хааны их өргөөг хэвтүүл, хишигтэн цэргүүд эргэн тойрон гурван давхар бүслэн хамгаалжээ. Шар тээгийн хөндийг дүүртэл цэргийн майхан эгнэж морь мал багширна. Саахалт яваад л харуул таарч үзэж байцаана.Энэхүү олон давхар харуул хамгаалалтыг Хасар тулдаа түргэн нэвтэрсэн ч Дайдугийн захаас Шар тээг хүртэл явснаас удах шиг санагдсан нь түүний яарсан сэтгэлийнх юм.Чингис хааны их өргөөний ойр түүнийг Боорчи өөрийн биеэр тосон авчээ. Тэд мэндийн цөөн хэдэн үг солилцоод гэрт орцгоов.

Их өргөөнд Тэмүжин, Тэмүгэ хоёр сууж байлаа. Тэмүгэ Хасар ахыгаа үзмэгц золгохоор босон харайв. Тэд уулзалгүй хоёр жил өнгөрчээ. Дүүгээ үзмэгц Хасар уяран догдолж бас эхийн тухай түгшин бодов.

-Ээж яаж байна гэж Хасар Тэмүжинд ёсолсны дараа шууд залган асуугаад суув.Тэмүгэ үг дуугүй Тэмүжин ахаа харжээ.Тэмүжин, Тэмүгэ хоёр ийнхүү сэжигтэйгээр огт дуугарсангүйд Хасарын дотор харанхуйлан нулимс нь асгараад ирэв. Хахир ёхир зантай хад чулуу шиг Хасарыг уйлна гэж санаагүй тул ах дүү хоёр нь сандрав.

Тэднийг ингэж балмагдан хэлэх үггүй байхыг үзсэн Хасар бүр эхэр татан мэгшин уйлжээ. Энэ нь үнэхээр гайхмаар явдал болсон тул Тэмүжин, Тэмүгэ хоёр ч Хасарыг аргадаж тайтгаруулах учраа олсонгүй. Тэд ер нь уйлж байгаа хүн аргадаж үзээгүй байжээ.Хасарын уйлах нь чоно архирах шиг ,чулуу хад нурах шиг сүртэй агаад элэг эмтрэм ажээ.

-Хасар ах аа гэж сандарсан Тэмүгэ дэргэд нь очиж түүний тохой дээрээс үгтээн байж сая нэг юм үг сонсохтой болгов.

-Та сонс. Ижий гайгүй. Гэхдээ бие нь их дор орсон гэж Тэмүгэ хэлэхийг сонсоод Хасар сая л юу болов гэх шиг эргэн тойрныг харжээ.Эхийнхээ үхлийн тухай цаг үргэлж бодсоор явсан мөртөө ингэж цочирдоно гэж тэр ер санасангүй билээ.

Хасар дүүгийнхээ энэ арчаагүй эмэгнэлтэй төрхийг үзээд Тэмүжин тэсэлгүй инээд алдав.

- Бидэнд хэл бол гэж Тэмүгэг Бөртэ явуулжээ хэмээн Тэмүжин хэлээд Боорчийг харав. Ах дүү гурвын ярианд саад бүү бол гэсэн Тэмүжиний дохиог тэр дор нь ойлгосон Боорчи лагс нүсэр биетэй гэмээргүй хөнгөнөөр хөдөлж шаламгайлан гарсны хойно тэд хэсэг дуугүй сууцгаав.Тэд гурвуул адилхан эхийнхээ тухай бодож байлаа.

Алтан улсын тухай бодол алс одоод ганцхан хайртай эхийг нь ээрсээр байх болсон үхэл бүх сэтгэлийг нь эзэмджээ.

-Ижий маань насныхаа тоог гүйцэв гэж мэджээ. Тэгэвч хүүхдүүдийг бүү дууд гэсэн гэнэ.Бүр Тэмүлэнд ч бүү хэл гэжээ. Харин хэрхэхийг намайг мэд гэж Бөртэ Тэмүгэг ирүүлж… хэмээн Тэмүжин бодол болон үгээ зөөж хэлэв.

-Ижий хэзээ үхэхээ мэддэг болоо юу гэж Хасар шазруун маягтай асуув.

- Тийм ээ. Ижий үхэх өдрөө хэлсэн гэнэ.Өүлэн эх минь яавч ийм үгийг зүгээр хэлэх хүн биш гэж Тэмүжин итгэлтэй хэлэв.

-Тэгээд тэр нь хэзээ гэнэ гэж Хасарын асуухад

-Энэ намрын адаг сарын сүүлээр гэж Тэмүгэ аяархан дуугарав. Өүлэн эх нь худал хэлээгүй гэдгийг Хасар ойлгов.

-Би чамайг гэртээ буцаахаар шийдлээ. Ижий минь бид гурвыг дэргэдээ байгаасай гэж хичнээн их хүсч байгааг би мэдэж байна. Гэвч би Алтан улсын элчийн бараалхахыг хүлээлгүй орхиод яаж гэдрэг буцна. Тэгвэл тэдний цэрэг Чингис хаан айв, өвчлөв ер юу гэхийг хэн ч үл таана. Бүр их зоригжин тэмцэж ч мэднэ. Харин Хасар чи даруй яв. Ижий чамайг хүлээж байгаа. Нэг ч өдрийг бүү алд.Алтан улс ер нүүчихгүй.Чамайг буцаж иртэл хүлээх биз.Харин ээж минь чамайг хүлээж чадахгүй байж мэднэ.Чи даруй явж үз.Бүү алгуурла.Үүнээс яаруу чухал хэрэг гэж ертөнцөд үгүй.

Тэмүжиний энэ үг үнэн агаад,чин сэтгэлийнх байсан тул Хасарт эсэргүүцэх сэтгэл огт төрсөнгүй. Тэр даруй босон харайж Хэрлэн мөрний зүг давхихад бэлэн байв.Өүлэн эхдээ очно гэж санахад яарах нь хэмжээгүй болжээ. Бүр Хэрлэн голын намуун урсгал,хээрийн салхинд найгах өвс нүдэнд үзэгдэх шиг болоод гэрийнхээ үүдэнд саравчлан зогсох эхийгээ харсан мэт өндөлзөж

- За.Би явья.Тэмүгэ чи …гэтэл Тэмүгэ нүдээ анивчин зөөлөн дуугарч

- Тэмүжин ахаа, намайг энд хэд хоног үлдэхийг зөвшөөрөөч. Би ер нь Алтан улсад ирж үзсэнгүй Би хятадын шавар балгаст орж ганц ч болов хятад цавчин алж сэлэмнийхээ ирийг шалгамаар байна.Би эмс хүүхдийн дунд Монголдоо суусаар уйдаж гүйцлээ гэхэд Тэмүжин, Хасар хоёул зугаатай хөхрөлдөв.

Ах дүү гурвын хооронд тийм гэхийн аргагүй дотно дулаан амьсгал бий болжээ. Энэ бол тэднийг төрүүлж өсгөсөн Өүлэн эхийн гайхамшигт сайхан сэтгэл болохыг тэд цөм гүнзгий мэдэрч байлаа. Хятад газрын амтат идээ ундаагаар хоёр дүүгээ дайлж хундага өргөж суухдаа Тэмүжин ах хүний ёсоор сэтгэл дүүрэн баяртай байв.Өүлэн эх нь одоо энд, Алтан улсад ирээд хөвүүдийнхээ хамт суугаад цайлж байх шиг, үг сургаалаа хайрлаж байх шиг санагджээ.

Алтан улсын хааны элч Вангин Чансаны үгийг сонсоод хэлсэн үгний нь төлөө Хасарыг ихээр зэмлэн буруушаая гэж уг нь түүнийг дуудсан байв. Гэтэл Дайду балгасыг зорьсон элчийн тоос арилаагүй байхад Хэрлэнээс Тэмүгэ ирсэн билээ. Чингис хааны дуудсан зарлигийн учир ингэж өөрчлөгдсөнийг Хасар мэдсэнгүй. Вангин Чансаны талаар Тэмүжин ам ангайсангүй.

Маргааш өдөр нь Тэмүгэ үлдэж Хасар нутгийн зүг мордов. Тэр ийн мордохдоо эхдээ, эмс хүүхдүүддээ өгөх бэлэг сэлтийг сайтар базаахаа мартсангүй. Хасарыг мордоход Тэмүжин саахалтын газар үдэж

-Чи намайг Алтан улсыг дагуулан авав гэж Өүлэн эхэд хэлэгтүн.Сэтгэл нь амраг.Харин миний очиж чадаагүй учрыг сайтар ойлгуулж хэлээрэй.Би Алтан улсын хааны элчийг бараалхуулж түүний найрамдъя гэснийг хүлээн авахаар шийдлээ гэж хэлжээ.Нэгэнт Чингис хаан ингэж шийдсэн тул яаж ч чадсангүй.Хор шар дүүрэн үгсээ буцаан залгиж бас эхийнхээ сэтгэлийг өвтгөхгүй гэсэндээ Тэмүжинтэй сөргөлдөн хэрэлдсэнгүй тэвчин морджээ.

Хасарыг ийн төв улс руу буцсаныг тэднээс гадна ганц Боорчи л мэдэж байв. Тэсэхийн аргагүй өмхий үнэртэй хятад газраас зугатаах мэт Хасар морио гуядан довтолгож явлаа. Тэр удалгүй торгон цэргээ манлайлан давхисаар Цагаан хэрмийн дээр гарч ирэхэд нүдний өмнө монголын хүслэнт тал нутаг цэнхэртэн үзэгдэв. Цагаан хэрмээс хойш Чингис хааны уугуул нутаг эхлэх бүлгээ.Өүлэн эхийн суугаа Хэрлэний хөдөө арал хүртэл эндээс даруй зуу хол илүү өртөө газар буй. Ийм газрыг туулж байж монголын уугуул нутгийн төвд хүрэх юм. Тэд хоёр жилийн өмнө монголын цэрэгт эзлэгдсэн Цавчаал боомтыг орхин хойт зүг давхилаа.Хасарын чихэнд газар дэлдэх морьдын туурайн чимээ яг дуу хуур шиг сонсдоно.

*****

Хэрлэний хөдөө аралд амьдрал хувирч өөрчлөгдсөөр ажээ. Их цэрэг Алтан улс руу мордсоноос хойхно Чингис хааны их суурин ордыг энд барьж эхэлсэн билээ. Энэ ажлыг Кидан гарлын мужаан Бүхүдэй удирдан хийлгэж байтал төдөлгүй хятад газраас олзны мужаан урчууд болоод ажлын боол хүмүүсийг олноор авчирсан тул энэ хэрэг даруй түргэнээ бүтэж эхлэв.Чингис хааны их ордон,ёслолын болоод хатдын өргөө,бас эд агуурс, хааны санг хадгалж хураах зоорь агуулах,агтны жүчээ,торгон цэргийн байр,зэвсгийн агуулах,харуулын цамхаг,гадна их хашаа аль эрт сүндэрлэж холын зочдын харааг булаах болжээ. Мөн олзны эд агуурс, охид эмсийг хүргэсэн хөсөг ирэх нь өдөр бүр тасрахгүй тул хөл хөдөлгөөн дүүрэн.

Их цэрэг Алтан улсад явсан тэр цагаас хойш монголын айл бүр торго, дурдангаар гэрээ бүрж,ороо бүтээж эмс охид нь шүр сувд гялалзуулан явах болжээ. Амуу тариа, чихэр жимс нэн арвин ирэх тул хүүхдүүд бялуурч ноход хүртэл тоож шиншлэхгүй болсоор удав. Алтан улсын олон хот, балгасыг эзэлсэн монголын цэрэг, жанжнууд олз омог ихтэй болж ар гэрийнхэн нь ч бүгд л аян дайны ид хав,амт шимтийг үзжээ.

Үнэт эдлэл, боол, эмс хүргэж ирсэн аяны цуваа болгон үхэл хагацлын мэдээг хамт хүргэн ирэх тул уйлж унжиж, алагдаж үрэгдсэн эрийнхээ, эцгийнхээ, хүүгийнхээ хойноос харуусан гашуудагсад ч тоогоо алдав. Ийм л баяр хөөр, харуусал гашуудал зэрэгцсэн дуу, нулимстай амьдралын дунд Өүлэн эх ажин түжин суусаар хоёр жил болжээ.

Тэр хүүхдүүдтэйгээ Тэмүжин, Хасар хоёртойгоо уулзна гэж хатуу чанга санаагүй ч хүрээд ирнэ дээ гэж дотроо битүүхэн горьдсоор, чимээгүй харуулдсаар байлаа. Их цэрэг хятад газрыг зорьсны дараа ард үлдсэн цэрэг цөөн тул тэд аль болох нэгдэн суух нь аюул багатайг бодож Өүлэн эхийг Бөртэ өөрийнхөө дэргэд хүрээндээ авчирч асарчээ. Харин Хасарын ар гэрийнхэн, эмс охид, албат иргэд нь хуучин ёсоор өөрийн хүрээнд тусгаар амьдарсаар

ажээ.Төв улсыг Тэмүгэ ноён захирч байв. Чингис хааны алдар суу нэгэнт холд түгсэн тул халдан ирэх дайсан ховор атал бас ч тийм тайван байх үндэс үгүй байлаа. Хөвүүдээ дайнд мордсоноос хойш Өүлэний үг яриа цөөрч ихэвчлэн хэвтэх юм уу, дулаан өдөр гэрийн хаяанд алс тэртээ дорно зүгийг ширтэн ганцаар суух болжээ.

Өүлэн эхийн биеийн байдал урьдын адил сайнгүйн дээр хятад газраас ирсэн домч ч нааштай үг хэлээгүйд сэтгэл түгшсэн Бөртэ Тэмүжинд даруй хэл өгөхийг хэдэнтээ шаардсан боловч Өүлэн халгаасангүй. Харин ч бүр гайхмаар үг хэлж ихэд цочоожээ. -Бөртэ. Би үхэх болоогүй байна. Үхсэн ч энэ намрын адаг сарын сүүлч хүргэнэ. Харин чи гадна дотны энэ олон хүмүүсийн дэргэд хөл хөнгөн, гар ганган, эрд очоогүй эм шиг дээл хувцастай явах чинь яавч зохихгүй. Чи Чингис хааны их хатан болохоос биш Есүй,Есүгэн,Хулан хатадын шивэгчин бус.Намайг үхээд өгвөл чамд ийм үг хэн хэлнэ. Насны эцэст над шиг ингэж бүү хаягдаж хоцор. Би л үүгээрээ дуусая. Харин чи… ингэж явж яаж болно.Чиний эр нөхөр амьд бий.Чи эр нөхрийнхөө их нэрийг бодож,Чингис хааны их хатан мэт явагтүн… Бөртэ эхлээд түүний эл үгийг сайн ухсангүй.

Гэвч бодож бодож яавч Өүлэн эхийн үгийн аяар байж болохгүйг ухаарч Тэмүгэг Алтан улсад сэм илгээсэн билээ.

-Намайг үхэхэд хэнд ч бүү хэл. Бүр Ихэрэс аймагт суугаа Тэмүлэн охинд ч бүү хэл гэснийг нь Тэмүжинд уламжлуулжээ. Тэмүгэ хэдий эр зоригтой ноён хүн ч гэлээ эхийгээ хайрлахын хажуугаар бас ах нарын их үйлийг цалгардуулах бий гээд Тэмүжин ахдаа хэл хүргэх учраа эс олжээ. Ийм үед Бөртэ л Чингис хааны их хатны ёсоор хатуу зоримог шийд гаргахгүй бол болохгүй гэдгийг Өүлэн эхийн үгнээс ухаарав.

-Тэмүгэ чи өөрийн биеэр Чингис хаанд оч.Бөртэ хатан намайг явуулав гэж хэл. Намайг илгээв гэхэд Чингис хаан лав зэмлэхгүй. Эс тэгвэл чи бид хоёр бүхний эцэст зэм ял сонсох бий гэсэн нь Тэмүгэг Алтан улсад явахад хүргэжээ. Бөртийг Есүхэйн гэрт ирсэн өдрөөс хойш Тэмүгэ үнэн сэтгэлээр хүндэтгэн хайрлах болсон тул ямагт Бөртийн үгийг дагах билээ

Энэ удаад ч Бөртийн үгийг дагажээ.Тэмүжин ах нь их хатан Бөртэдээ ихэд хүндэтгэлтэй ханддаг учир түүнд айж эргэлзэх сэтгэл төрсөнгүй. Харин Тэмүгэг Алтан улсад одсоныг Өүлэн эхэд хэлэлгүй өнгөрөв.

Тэмүгэгийн хувьд Алтан улс бол чухам хүслийг татсан, үзэхийг мөрөөдсөн газар нь юм. Өмнө газраас элч ирэх бүр дайн тулааны тухай мэдээг Бөртэ тэр бүрийд Өүлэн эхэд дуулгаж алаг торго, амтат бурам зөөх бүлгээ. Бөртийн орж ирэх тоолонд Өүлэний зүрх чичирч Хасар хөвүүн нь үхэв гэх бий гэж түгшин уттана. Гэтэл Хасар хөвүүн нь эсэн мэнд байсаар ажээ. Намрын дунд сарын налгар шар өдрүүд үргэлжилж, жимс ногоо, идээ будаа дэлгэрээд Хэрлэний хөндий хахаж бялхаж байх шиг. Энэ өдөр Өүлэн гэрийн гадна зассан тавцан дээр сурсан зангаар дорно зүг ширтэн суув.Хэрлэн мөрний эрэг дагасан их замаар алсад бараан дүрс тодрон төдөлгүй бүлэг морьтон улс довтолгон айсуйг ус гүйж хавагнасан нүдээ чилээн чилээн хараад сэтгэл нь нэг л хачин болохыг тэр анзаарав.

Нүдний нь хараа муудсан ч холоос яаран давхисаар айсуй морьтой улсыг их холоос харжээ. Өүлэний сэтгэлийн угт хаа нэгтээ өвдөх шиг болж, зүрх нь түгшүүр баяр хоёроор зэрэгцэн

дэлдэв. Дал шахам жил амьдарсан түүнд ганц үзээгүй юм нь үхэл биз. Хөгширч муудсан зүрх нь ингэж баярлаж догдлох юм гэж санаагүй явсандаа Өүлэн бүр гайхжээ. Үнэхээр тэр баярлан догдолж анх Есүхэйг дайнд алс яваад амьд мэнд ирэхийг харсан шигээ зүрх нь омголоноор булгилахыг үзэв. Ерөөс хүний зүрх хэзээ ч хөгширдөггүй ганц эрхтэн биз ээ. Бүлэг морьтон ойртсоор бүр хүрээний харуулын дэргэд хүрч бяцхан зогссоноо шууд их өргөөг зүглэн ойртохыг үзвэл эрх мэдэл ихтэй хүн яваа ажээ.

Тэр цувааны голд нэг сүрлэг сайхан баатар эр ирсэн нь танил ч төрх шиг, бүр үзсэн ч хүн шиг. Өүлэн өндийх гээд чадсангүй. Өнөөх эрийн сүрлэг хүрэн царай дуулган дороос үзэгдэхэд

–Есүхэй, Есүхэй гэж Өүлэн дуудав. Үнэхээр Есүхэй инээмсэглэн мориноос үсрэн бууж гэр тэрэгний шатаар хөнгөхөн өгссөөр дэргэд нь ирээд сөхрөв.

-Есүхэй. Чи амьд байжээ.Намайг ганц биеэр орхиод юунд ингэж удав гэж Өүлэн шивнээд нүдээ анив.Эргэн тойрноос Есүхэйн танил дотно үнэр ханхлах шиг болжээ.

-Ижий минь, би ирлээ… гэж Хасар эхийнхээ бууралтсан сэгсгэр үс, нулимст нүд, үрчлээт нүүрийг ширтэн шивнэв. Хасарын нүднээс нулимс асгарч шороо тоосонд дарагдсан нүүрэн дээгүүр нь зам татуулан урсах ажээ. Өүлэний нүдэнд үнэхээр Есүхэй үзэгдсэн юм. Татаарт хорлогдож үхсэн Есүхэйн сүнс Хасар хөвүүнээ даган Өүлэний дэргэд ирээд буцжээ. Харин одоо өтөлж харласан царайтай, өвгөрч эхэлсэн Хасар өмнө нь сөхрөн мэлмэрүүлж суухыг Өүлэн үзэв. Эхлээд өөрийгөө зүүдэлж байна уу даа гэж санажээ. Хасарын танил хоолой сонсдож нумын хөвч, сэлэмний бариулд эвэршсэн хуруугаараа мойнийсон гарт нь зөөлөн хүрэхэд Өүлэн сэрүүн зүүднээсээ сэрэв.

Есүхэйн сүнс хөвүүн Хасарыг нь хол газраас түүнд дагуулан авчирч орхиод тэртээ тэнгэрийн оронд одохыг тэр тов тод харах шиг болжээ Хөвүүн Хасар нь үнэхээр иржээ. Эх хүн холд одсон үрээ эргэн ирэхийг үзээд яаж баярладгийн адил Өүлэн яг л тэгэж баярлав.Халуун нулимс нь сул асгарч эцэж ядраад мах мариа нь шуугдсан Хасар хөвүүнээ үзэнгүүт зүрхээ шимшрүүлэн өрөвджээ.Юуны төлөө хүү минь ингэж эцэж цуцталаа зүтгэнэ вэ гэж бодов. Баярласандаа байдаг хүчээ шавхан байж өндийн босох гээд шургачихад Хасар шаламгайлан тосч түшин аваад хөөрхий эхийгээ хүүхэд шиг тэврэн гэрт оржээ.

Чингис хааны их хүрээний өдөр тутмын эх адаггүй нүсэр ажлын нүргээн дунд эх хүү хоёрын энэ уулзалт огт анзаарагдаагүй билээ.Мужаан дархчуулын ажил ундарч алх сүхний дуу хадна. Тэдэнд хэн ч саад болсонгүй. Тэр бүү хэл Өүлэн эхийн гэрт үргэлж орж гарч явдаг Зүчийн том хөвүүн Бат, Цагадайн том хөвүүн Бүри хоёр ч орж ирсэнгүй.

Өүлэний гэрт хятад газрын өмхий агаар, ялзарсан ногоо нэлхийн үнэртэв. Энэ бол Хасарын алс газраас тээж ирсэн үнэр билээ.Халуун бүгчим хятад газрын үнэр Хасарт бүр нэвт шингэжээ.

-Ээж нь чамтай уулзаж чадахгүй биз гэж санасан юм. Гэтэл хүү минь чи их дайн, ижил цэргээ орхиод иржээ. Эзэнгүй цэрэг чинь эндэж осолдох бий. Егү,Есөнхэй хөвүүд чинь нялх шүү. Одоо эхийн чинь санаа амрав. Буцаж үз гэж Өүлэн Хасарыг хул айраг ууж дуусаагүй байхад хөөх шахам хэлэв. Хасар эхийн гэрт ийн суухдаа аз жаргалтай байлаа.

-Би таныг Тэнгэрт хальчихаагүй байгаа даа гэж түгшин сандарч явлаа хэмээн Хасар хэлээд муухан инээв.Тэр үнэхээр ингэж бодож явсан билээ.

- Ээж нь удахгүй үхнэ. Хөвүүн чамайг амьд мэнд эрүүл саруул явааг үзэж сэтгэл ханалаа. Одоо би юундаа хоргодох вэ. Энэ амьдралд хоргодох юм надад нэгэнт алга болжээ. Над шиг хоолны сав, дээлийн гол ингэж хорвоогийн зай эзлэж, хоол цай хороож суухын хэрэг үгүй биз гэж Өүлэн эх гунигтай өгүүлнэ. Өнгөрсөн хоёр жилийн дотор Өүлэн эх нь танигдахын аргагүй өтөлж, өөвийсөн, жижигхэн эмгэн болон хувирчээ. Эхийгээ ингэж түргэн өтлөнө чинээ санасангүй.

-Чи ер нь яагаад хүрээд ирэв гэж Өүлэн гэнэт мартсанаа санах мэт асуув. Хасар хариулахынхаа өмнө бодолхийлэв.Өүлэн эхийн энэ үгэнд Тэмүжин, Хасар хоёрыг муудалцсан бий вий гэх битүү хардлага, бас Хасар хөвүүн минь зугатааж ирээгүй байгаа даа гэсэн түгшүүр илт. Хасар хариу хэлэхийн өмнө эхийгээ удаан ажиглав

.Өүлэн эх нь угийн чийрэг хатуужилтай хүнсэн . Цаг хугацаа гэдэг даанч харгис хатуу ажээ.

-Чингис хаан намайг төв улсаа эргэж тойрохыг зарлиг болголоо гэж Хасарын хэлэхэд Өүлэн эх нь огт итгэсэн янзгүй ус гүйсэн цийлгэр нүдээрээ удтал ширтэв. Гэвч юм дуугарсангүй ч нүүрнээс нь үл итгэх байдал арилжээ.

-Чи тэгвэл хэзээ буцна гэж туршсан янзтай асуув.

-Хэд хонох биз дээ.Тэгээд таны бие гайгүй бол буцалгүй болохгүй гэсэнд -Тэгвэл би яарахгүй бол болохгүй нь ээ гээд Өүлэн бодолхийлэв.

-Ижий та юунд яарах гэж

-Би чамайг явахаас өмнө үхэх минь. Эхийнхээ энэ хүүхдийн мэт үгийг сонсоод Хасар үнэн сэтгэлээс хөхрөв.Хасарын ийн хөгжилтэй инээх нь гадаа яваа хүн зог тусан чагнахаар чанга сонсдох ажээ.

-Хөвүүн чи гэртээ харьж гурав хоноод ир.Би тэгээд үхнэ. Хасар гайхсан атал огт санаандгүй “За тэгье” гэж эхийнхээ амыг дагуулав.

Эх нь уймарч, бас түүнийг үзээд уярч тунирхаж л байна гэж Хасар санажээ. Эхийн бие барагтай ч сэтгэл санаа нь амарсныг үзэж тайвширсан Хасар үнэхээр гэр лүүгээ яарч байлаа. Түүний хүрээ эндээс зүүн хойш гурван өртөө газарт Саарь хээрийн талын Хүрэн нугад намаржиж байлаа. Тэнд түүнийг хатад, эмс, албат, иргэд нь хүлээж буй. Түүий хүрээг Боржигон аймгийн энгийн сул ардын охин,Хасарын их хатан Борогчин ахлан сууж байгаа билээ.

Бөртэ хатан Хасарыг Чингис хааны их өргөөнд залж нутаг орны байдал, алс газар дайнд яваа эр нөхөр, хөвүүдийнхээ тухай шалгаасаар шөнө дөл болгосон тул тэр үүр хагаслан гэрийн зүг довтолгов. Хасарыг Алтан улсаас гэнэт ирсэн тухай хэл мэдээ нэгэнт түүний хүрээнд хүрсэн тул хатад, албатууд нь эзнээ угтах гээд хөл хөөрцөг болцгоож мөн л нойргүй хоносон

билээ.Алтан улсад яваад удсан эзэн нь ирсэнд бүгд баяр хөөр болцгоожээ.

Хасар ёсолж авсан гурван хатантай юм.

Эзгүй билчээр газарт нүд хөмсөг дүүрэн Борогчин охинтой санаандгүй учирсан нь Хасарын бие даан амьдрахын эхлэл болжээ.

Тэмүжинг Боржигон аймгийн ханд өргөмжилснөөс хойш удалгүй Хасар өөрийн хүрээг үүсгэн тусдаа сууснаас хойш өдий болтол бие даан амьдарсаар билээ. Энэ нь хүн болоод малд ч амар юм. Монголчууд малынхаа аяыг харж амьдрах тул олноор нэг дор суурьших боломжгүй, газрын энгээр нэг тархан билчээр ус хөөн нүүцгээдэг нь тэднийг тархай бутархай байлгахад хүргэдэг билээ.

Тэмүжин, Хасар хоёр хэдий нэг аймаг, төрсөн ах дүүс боловч мөн л дөрвөн цагийн эргэлтэд цагийн аясаар нүүж сууж холдож ойртож явлаа. Хоёр жил ирээгүй Саарь хээрийн тал энэ жил өвс ногоо халиурч, болжмор шувуу жиргээд нозоорсон биеийг сэргээж нойр алжаалыг үлдэн хөөх шидтэй. Энэ талын элгэнд бяцхан толгой байхыг Өндөрхан гэх бөгөөд энэ Өндөрханы өвөрт Хасар олон жилийн өмнө татаар бүсгүй Хуаржинг авч хуримласан билээ.Хасар энэ үед Борогчиноос гадна Түмүхэй хатнаа авчраад байв.

Тэмүжин тэд Хэрэйд аймгийн Тоорил хантай хавсран Алтан улсын Вангин Чансаны цэргээс дайжиж явсан татаарын Мэгүжин сүүлтийг дайран сөнөөх үеэр Хасар Хуаржинг булаан авсан юм. Хуаржины эцэг нь Мэгүжин сүүлтийн анд татаарын зартай баатар Цахиа- Үгэ байв. Харвалдах дайсны өмнө халирч үзээгүй баатар эр Цахиа-Үгэтэй тулсан нь Хасарын хийсэн хамгийн аймшигт гардан тулаан байлаа.

Гэвч Хасар залуу биеийн чадал, гавшгай зоригийн хүчээр Цахиа-Үгэг алж түүний эмс охид, албат иргэд,мал хөрөнгийг өөртөө авах эрхийг олжээ. Цахиа-Үгэг үхүүлсэн нь Хасарын эр биеийн хүч, зоригоо гайхуулан баталсан бас нэг том ялалт байсан бөгөөд түүний ид хав, хүч чадал, зориг жавхааг бүгд хүлээн зөвшөөрсөн билээ. Цахиа-Үгэ бол зүгээр нэг алуулчих эр биш тул Хасарын гарын булчин, нурууны шөрмөсийг шархдуулж тэр хэд хоног ялалт хөөрөө мэдрэх сөхөөгүй шархандаа халуурч хэвтсэн ажээ. Гэвч түүний дайны олз, ялалтын баяр бахдал Хасарыг түргэнээ тэнхрүүлж хөл дээрээ босжээ.

Цахиа-Үгэ бол эр зоригтойнхоо хирээр баян нэгэн байжээ.Хасарыг тэнхэрч бостол Цахиа-Үгэгийн өмч хөрөнгө, албат иргэдэд бүү хүр гэж Тэмүжин тушаасан нь Хасарыг ихэд баярлуулав. Ингэж баярлах нь аргагүй юм. Энэ нь Хасарын ялалт, хүч зоригийг Тэмүжин хүлээн зөвшөөрсөн явдал байв. Асгаруулсан цусныхаа үнэнд Цахиа-Үгэгийн бүх эзэмшлийг бусадтай хуваалгүй ганцаараа авахыг Хасарт Тэмүжин зөвшөөрөв.

Ингэж Хасар анх удаа өөрийн цус, эр зоригийн шагналд баян татаарын хөрөнгийг эзэмшсэн билээ. Түүнийг ийнхүү шагнасан нь Хасарыг бусдаас онцгойлон үзсэний илрэл байснаас гадна баатарлан тулалдаж гавьяа байгуулсан л бол ямар ч хүн хамгийн үнэтэй олзыг авах ёстой гэсэн Тэмүжиний хатуу шийдвэрийн биелэл байв. Энэ хатуу журам өөрийнхөө эр зоригтой, эрэмгий чадалтайг харуулах хүсэл сэтгэлийг бүгдэд оргилуулж баяжих шуналд хөтөлдөг билээ.

Агт морьд, амбан шар, өсөхийн буянтай хонь, өргөө цагаан гэрээс гадна Хасар анх удаа өмнө газрын тансаг эд хөрөнгөтэй болж хагартлаа баяжжээ. Цахиа-Үгэгийн зарц, боол, эд хөрөнгийг бүгдийг Хасарт өгсний дотор хамгийн ихээр догдлуулан баярлуулсан олз нь Цахиа-Үгэгийн залуу хатан болон түүний арван зургаатай гоо охин Хуаржин хоёр байв.

Хуаржины эх охиноосоо дутахгүй үзэсгэлэнтэй, Хасараас хэдхэн эгчмэд эм байлаа. Тэдний гоо үзэсгэлэнг хараад Хасар яах ч учраа олохгүй баярлан тэвдэж бараг барьж үзэх нь холгүй хөөрөн догдлов. Гэвч эмсийн гоо үзэсгэлэнгээс гадна Хасарын сэтгэлийг хөөргөсөн нэг нууц бодол байв. Энэ нь Есүхэй эцгийг нь хорлосон татаараас эм авах нь эцгийн өшөөг авч буй хэрэг гэж санагдсан явдал юм. Харин эх охин хоёрыг хэрхэхээ сайтар шийдэж чадсангүй.

Уг нь Хасар эх охин хоёрыг хоюуланг нь эзэгнэн авахыг хүсч байв. Эх охин хоёрыг эм болгон авах нь чухам хиймортой эрийн хэрэг билээ. Гэвч бодож бодож Тэмүжинээс асуухаар шийдэв. Хасарын хэлэхийг сонсоод Тэмүжин тэр дороо дуугарсангүй. Учир нь татаарын Мэгүжин сүүлтийг сөнөөсөн нь бахдалтай ч Хасарын олсон олз түүний атаархлыг хөдөлгөсөн билээ. Мөн Хасарын өмчид зүй ёсоор очсон эх , охин хоёр дэндүү үзэсгэлэнтэй байсан нь Тэмүжинг бүү хэл бусад нөхдийн нь хор, дур хоёрыг зэрэг гозгонуулж байсныг Хасар ойлгосонгүй. Гэвч Тэмүжиний дуугарч цөхөх байдал Хасарт сэжиг төрүүлж, ийм их олз олсонд нь дургүй байгааг мэджээ. Гэнэт ийм их олз олсон нь бусад нөхдийн атаархал дургүйг хүргэж байгааг нэгэнт мэдэрсэн тул

-Ахаа. Би Цахиа-Үгэг ганц биеийн хүчээр үхүүлсэнгүй. Надаас энэ чинээхэн цус урсах бага хэрэг. Би өөрийн олзыг нийтийн олзонд тушаая. Та хэрхэхийг шийдэгтүн. Би өөрийн олноос Цахиа-Үгэгийн хатныг ах танд өгье. Харин Хуаржин охиныг нь би өөрөө авна гэж чин сэтгэлээс хэлэхэд Боорчи, Зэлмэ бүгд баясаж, энэ үгийг сонссон Тоорил хан бүр ихэд сайшаан Хасарын ухааныг шагшин магтсан үг хэлсэнд Тэмүжин дотроо дургүй байсан ч түүнээ мэдэгдсэнгүй.

Төдөлгүй Цахиа-Үгэгийн эмс, албат, мал хөрөнгийг хуваан авав. Харин том гэр, торго чимэг болсон хувцас хунар, чамин хийцийн зэр зэвсгийг нь гоо үзэсгэлэн төгөлдөр Хуаржины хамт Хасарт өгсөн тэр шөнө Хасар Хуаржинтай дэр нэгтгэн түүний охин биеийг эдэлсэн билээ. Хасар үзэсгэлэнт татаар бүсгүйд үнэн сэтгэлээс татагдан дурласан байлаа. Харин Хасарын найр тавин өгсөн Хуаржины эх хатанг Тэмүжин нэг шөнө эдлээд маргааш нь олны нүдэн дээр цавчин алж орхисон нь Хуаржинг бүү хэл Хасарыг цочирдуулжээ. Хасарын өгсөн бэлгийг авах нь өөрийгөө дорд үзсэн хэрэг гэж Тэмүжин бодсон учир тэр эмийг албаар алав. Тэмүжин угаас ийм алсуур бодол, явуур нарийн санаатай тул хэн ч түүнийг шүүмжилсэнгүй. Ингээд алчихыг нь мэдсэн бол өөрөө авдаг байж гэж Хасар харамсан бодсон ч ам нээсэнгүй. Тэмүжинг хэн хорих билээ.Хөөрхий бүсгүйг орилуулан чирч хүрээнээс холдуулаад цавчиж орхижээ.

Тэмүжиний энэ харгис аллагад дургүйцсэн, айсан Цахиа-Үгэгийн албатууд удалгүй удам угсаа нэгтэй цагаан Татаар аймгийнхан нутаглах Буйр нуураас цааш зугатан оджээ. Харин хөөрхий Хуаржин хойтон жил нь төрсөн охиноо орхиод явж эс чадав. Ингэж Хуаржин ,Хасар хоёрын зовлонт амьдрал эхэлсэн билээ. Хуаржин Хасарт сэтгэлгүй байв. Үүний өмнө Хасар хоёр эхнэр ёсолж авсан атлаа хэнийг нь ч Хуаржин шиг хайрладаггүй билээ. Эхийгээ, эцгийгээ алсан хүний гэрт үр хүүхдийг нь төрүүлэн амьдрахдаа Хуаржин бүсгүй гомдол

саналын үг ганц удаа ч болов унагасангүйд Хасар одоо болтол гайхсаар ажээ. Эхний үед, өссөн төрсөн Татаар аймагтаа бусдын адил зугатан очих хүсэл лав байсан биз ээ.

Гэвч 1202 оны намар Тэмүжин нар цэрэглэн цагаан татаар, алчи татаар, тутауд татаар, алахуй татаартай Далан Нөмөргөд байлдаж сөнөөснөөр Хуаржины эх нутаг, элгэн садны тухай хүсэл мөрөөдөл үнс чандруу болон хийсчээ.

Өст татаар аймгийг даран сөнөөсний дараа Тэмүжин, Хасар хоёрын хооронд анхны том ил тод хэрүүл үүсэв.

Учир нь татаарын амьд үлдсэн, олзлогдсон иргэдийг хэрхэх тухай зөвхөн алтан ураг, журамт нөхдөө цуглуулан зөвлөлдөөд Тэмүжиний саналаар бүгдийг хядан хүйс тэмтрэхээр болов. Харин Тэмүжиний хадам болох татаарын Их-Чэрэнгийн удам угсаа, албат иргэдийг өршөөхөөр тогтжээ. Гэтэл Хуаржины хамт олзлогдоод сүүлд зугатааж одсон Цахиа-Үгэгийн удам, үр сад, албат иргэд нийлсэн мянган хүн бас олзлогдон ирснийг хэрхэх тухай асуудал нэхэгдэв.

-Нэгэнт биднээс зугатааж одсон тэднийг дурдах хэрэггүй.

Тэднийг Хасар чи өөрийн гараар хүйс тэмтэрвэл зохино.

Эр, эм гэлгүй тэрэгний булнаас өндрийг нь ал.

Бидний эцэг өвгөдийг хорлосон, тэр дундаа эцэг Есүхэйг хорлон хөнөөсөн энэ татааруудыг тэнгэрт мартуулж, газарт булж үгүй хийгтүн. Үлдсэн эхнэр хүүхдийг үүдтэй болгонд тараан хуваажнэргүй, гэргүй болгогтүн. Амьд үлдсэн татаар эрсийг хорт өвс адил үзэж нэг нэгээр түүж устгагтүн гэж бухимдан хашгирав.

Энэ үгийг хэлэхдээ Тэмүжин учир зүггүй хилэгнэсэн нь татаарт өсөрхсөндөө бус харин өөдөөс нь эсэргүүцсэн Хасарт уурласаных, бас татаарын нэртэй баатрыг үхүүлж үзэсгэлэнт охиныг нь авсанд одоо болтол атаархсаар явсных байв. Хасар тэсч сууж чадсангүй.

- Их-Чэрэнг хэн гэж амьд үлдээж, Хуаржины удам төрлийг хэн гэж үхүүлнэ. Тэд татаар бол татаар, албал бүгдийг алъя. Үгүй бол тэднийг адил үзэж амьд үлдээе гэж биеэ барьж тэвчилгүй бас дүрсхийн босов.

Татаарыг үхүүлэхгүй гэж өмөөрч бухимдсангүй, зөвхөн Тэмүжин түүнийг өөрөөсөө дорд үзэж, дорой бодсонд Хасарын уур дүрэлзжээ. Ах дүү хоёрын хэрүүл ингэж татааруудаас болон асч, тэдний хооронд байсан зөрчлийг ил гаргав.Тэмүжин Хасар хоёр хэрэлдээд зогсохгүй барилцаж авахад ч бэлэн болжээ. Гэвч нөхөд нь тал талаас хоригложээ. Тэмүжиний үг олонд нөлөөтэй, оночтой байв.

- Хасар чи. Хаана, юу гэж ярихаа мэдэж ав. Энэ Их-Чэрэн өөрөө надад сайн дураар даган орж охиноо өгөв. Харин чи Хуаржиныг булааж авсан биш үү. Цахиа-Үгэг үхүүлээгүй бол Хуаржин чамд өөрөө ирнэ үү.Тэдний албат иргэд сүүлд нь надаас зугатааж одсон. Одоо тэднийг хэн өршөөнө гэхэд бусад нь Тэмүжинг дэмжиж Хасарыг буруушаав. Бүгд түүнийг хаяж гарцгаав.

Тэмүжиний онож хэлсэн үнэн үгэнд Хасар аргагүй гүйцэгдээд хараал тавьсаар хоцров. Харин ганц Билгүтэй үлдээд:

-Татаарыг бүгдийг хядах нь буруу юм даа гэж шивэгнэсэн билээ. Гэвч Билгүтэй ийн бодоод татааруудыг хядах болсон тухай Их-Чэрэнд үг алдсанаас болж хаашдаа үхэхээ урьтаж мэдсэн татаар эрс улайрч амийг амиар солин олон монгол цэргийг алжээ.

Үүнээс болж сул амтай Билгүтэй ургийн зөвлөлгөөнд орох эрхээ хасуулж Хасар хэдий дургүйцсэн ч Хуаржинг бараадан Хасарын дэргэд ирсэн мянган татаар иргэний таван наснаас дээшхи бүх эр хүйстэн алуулжээ.

Татаарыг алснаас хойш ч Хасарын уур хилэн дарагдсангүй.

Тэмүжинд гаргасан уураа түүний худ болох Хонгирад аймгийн иргэдэд гаргах болсон нь ах дүү хоёрын зөрчил тэмцлийг бүр ч хурцатгав. Хэсэг Хонгирад иргэд Бөртэ хатныг бараадан Онон Хэрлэний хооронд суусаар удсаныг Хасар талж, охид эмсийг булаан авч Хуаржин болоод өөрийн эмсийн үүдийг сөхүүлж, үсийг самнуулах болгов. Хонгирадууд Тэмүжинд гомдол гарган Хасарын хийсэн гэмийг мэдүүлж ял зэмд унагахыг хүсчээ.

Ингэнэ гэдгийг Хасар мэдэж байсан ч тоосонгүй, юу л болбол болог гэж боджээ.Хэрэв Тэмүжин худаа өмөөрч зарга цааз үүсгэвэл эрэгчин эмэгчинээ үзнэ гэж бат шийдсэн байжээ. Харин Тэмүжиний шийдвэр Хасарын сэтгэлийг ихэд гайхуулжээ. Хонгирадуудын гомдлын хов үгийг Тэмүжин нохой хуцсаны дайтай тоосонгүй.

Харин ах дүүсийн хооронд хов хутган хэрүүл өдөв гэж тэднийг хөөн гаргасан байв. Үүнд нь гомдсон Хонгирад иргэд удалгүй Тэмүжинээс салан Буйр нуурын зүг нүүжээ. Тэглээ гээд Тэмүжин Хасарыг ганц үгээр боловч зэмлэсэнгүй. Тэмүжин санаандгүй ийм зан гаргасанд Хасар төдөлгүй уяран ахтайгаа дэмий хэрэлдэв гэж өөрийгөө зэмлэх болжээ.

Тэмүжин, Хасар хоёрын хооронд үүссэн зөрчил ашгүй намдаж Найман аймгийн Таян хааныг дайлах их цэргийг Хасараар удирдуулахаар Тэмүжин шийдсэн нь хэргийг бүр ч цайруулав.

Ялих ялихгүй атаархлаас болж Хасарын уур, омгийг дэврээхгүй байхыг Тэмүжин хичээж, түүнийг тайвшруулах, ах дүүсийн эв нэгдлийг үзүүлэх зорилгоор Найман аймагтай хийх дайныг Хасарт даалгасан билээ.Энэ бол Тэмүжиний алсын хараатай,гүнзгий ухаантай шийдвэр байлаа. Зориг цөс ихтэй, ил шулуун үгтэй, дурааараа Хасар уярч баярлах нь их амарханыг Тэмүжин мэдэх тул ингэж шийдэв. Бүх зүйл Тэмүжиний санаснаар болж Хасар дахиад л урьдын дуулгавартай, итгэлтэй дүү болон хувирав.

Татааруудыг, тэр дундаа Хасарын худ ургийнхныг бүгдийг хядсаныг Өүлэн эх огт таашаасангүйгээр барахгүй “Ханиа хазагсад,харцаа барагсад” гэж зэмлэсэн нь Тэмүжинг өөрийн алдааг ойлгож засахад хүргэжээ.

Бэгтэрийг алснаас хойш Өүлэн эх нь ингэж уурлаж хилэгнээгүйд Тэмүжин их самгардаж билээ. Эхийнхээ энэ үгнээс Хасарыг одоо цааш нь түлхэж болохгүй гэдгийг тэр хатуу ойлгов.

”Хасар бол Тэмүжин чиний бүтэн биеийн тал, бүрэн улсын хагас шүү” гэж Өүлэн эх хатуу хэлснийг тоохгүй өнгөрөөх учиргүй байлаа. Хасар бол байгуулсан улсын хагасыг авах эрхтэй хүн гэж үздэгээ Өүлэн эх ингэж ил тод ойлгуулсан нь Тэмүжинд ихийг бодуулжээ. Олонд хүндтэй Өүлэн эх Хасарын талд байгаа нь Тэмүжинд ашиггүйгээр барахгүй, аюултай хэрэг юм.

Ийм ч учраас буулт хийж Найман аймгийг дайлах хэргийг Хасарт найр тавин өгөхөөс өөр аргагүйд хүрчээ. Найман бол Монгол аймгуудын дотроос хамгийн баян хүчирхэгт орно. Алтайн их уулсын өмнө биеэр нутаглах найманууд баруун зүгийн өөр хэл шашинтай Хорезм, Хивчаг, Уйгар, Тангуд, Хар кидан, Харлаг улсуудтай хил залган олон жилээр худалдаа арилжаа хийсэн тул ихэд баяжжээ. Тийм болохоор Хасар сэтгэл дүүрэн баяртайгаар цэргээ засах ажилд орсон билээ.

Түүний хамгийн анх хийсэн нь морьдын зүс ижилсүүлэх шийд байв.

Гурван замд хуваагдсан Хасарын цэрэг цагаан, шарга, бараан зүсмийн өнгө ижилссэн морьдтой болсон нь анх удаагийнх бөгөөд Тэмүжин үүнийг ихэд сайшааж, үүнээс хойш монголын цэрэгт бат мөрдөх болжээ.

Тэмүжинд дийлдсэн Жамуха болоод бусад овог аймгийн үлдэгдлийг Найман аймаг ивээлдээ авсан нь ингэж цэрэглэн хөдлөх шалтгийг үүсгэв.

Найманы хөгшин хаан Буйраг хэдийгээр эрх мэдлээ хүү Таяндаа алдаад байсан ч Тэмүжинг дарахаар цэргээ бэлтгэж эхлэснийг тагнуулууд илтгэжээ... …

Гэрийнхээ барааг харан хартлаа морины явдал дунд энэ мэт хуучны бодолд ээрэгдэн явсан Хасар нохдын чимээнээр толгой өргөв. Түүний хүрээ Өндөрханы өвөрт анх Хуаржинтай хуримласан тэр газарт намаржиж байгаа нь нүднээ ил тусахад сэтгэл хөдлөн морио давирав. Эзнийхээ аяар ергүүлж явсан морь цочин ухасхийж, түүнийг даган баг цэрэг нь тоос манаруулан давхилаа. Хүрээний дотроос мөн арваад морьтон эрс угтан давхих нь үзэгдэв. Их өргөөний нь үүдэнд ургийн цагаан сүлд залаастай хэвээр. Харин бүх гэрүүд цагаан бүрээстэй улаан торгон хажилгатай болсон нь нүд булаана.Хүрээний гадуур их хашаа босгосон нь хятад газрын жижиг балгасыг санагдуулна.

Хүрээн дотор их л цэвэр цэмцгэр бөгөөд харин хашааны гадуур мал билчжээ. Хасар гэрээс гарснаас хойш хоёр жил болоод эргэн ирж буй нь энэ. Хүрээний гадна их хатан Борогчин бусад эмс хатдын хамт аваль эрээ угтан авлаа. Харин угтагсдын дунд сэтгэлийн хүслэн болсон Хуаржин нь үзэгдсэнгүй. Алтан улсад дайтсан хоёр жилд тэр Хуаржин хатнаа хичнээн их үгүйлэн санаснаа сая мэдэв. Хасар олон үггүй бууж ёсыг даган Борогчины гэрт оров. Дөч нэлээн гарч таргалсан Борогчин бол анхны нь аваль эм, Егү, Есүнхэй, Туху гурван хөвүүний нь эх тул яах аргагүй хүндтэй хатан нь юм. Удаах эхнэр Түмүхэй ч түүнээс юугаараа дутахав гэх шиг нас залуу зүс тунгалагаа гайхуулан хөнгөн нимгэн хувцастай орж гарч угийн урин янаг төрхөөрөө даллана.

Харин хамгийн үзэсгэлэнтэй, хайрлаж байгаа, үзэн ядаж байгааг нь Хасар одоо болтол тааж мэдэж чадаагүй Хуаржин л угтаж авсангүй, орж ч ирсэнгүй. Эхнэрүүд нь ч түүний тухай үг

цухуйлгасангүйд Хасар гайхаж сууснаа тэссэнгүй

-Хуаржин юунд эс үзэгдэнэ гэж асуужээ.

-Таныг Алтан улсаас арван шивэгчин эм ирүүлснээс хойш Хуаржины сэтгэл хямарч одоо гэртээ хэвтэж буй. Юу болсныг та очоод үзэх биз гэж Борогчин битүү хатуу үг хэлээд дахин дуугарсангүй, Хасарын хир тоосыг угаах гэж том модон суулганд халаасан ус хийж хөшиг татах бүлгээ. Хасар босов.

-Та Хуаржинд очих гэж байгаа бол маргааш болно уу. Би их эхнэр тань байна. Хуаржины бие чилээрхүү болохоор таны хүссэнээр болохгүй биз. Би ч бас эм хүн гэдгийг та мартав уу. Аль эсвэл хөгшин гэж голно уу гэж Борогчин аалигүйтэв.

Нээрээ ч Борогчин нүцгэн биен дээрээ нимгэн торгон дээл хөдөрснийг Хасар сая л нэг анзаарч түүний сэргэр хөх,бүдүүн гуяыг хармагц дур хүсэл нь бадарчээ. Хасарт их гэрээс зугатах хүсэл төрсөнгүй. Аян дайнд явах, ирэх бүртээ их гэртээ хонож дассан ёсоо одоо ч дагахаар шийдэв. Маргааш нь Түмүхэй эхнэрийндээ хононо. Тэгэж байж Хуаржинтай уулзах ажээ. Анхилуун үнэртэй усанд булхаж угааж аваад Хасар хятад газрын зөөлөн торгон дэвсгэр дээр Борогчины халуун янаг тачаалд автан хөлбөрөв.

Удаан яваад ирэх бүр Борогчин ингэж янаглан тачааддаг билээ. Тэр ер хөгширч, бие сэтгэл хөрөөгүйгээ батлах гэсэн мэт аашилна. Харин Түмүхэй бүсгүй эр нь өнөөдөр түүнд олдохгүйг нэгэнт мэдээд гэртээ харив. Түүнд бас дахин нэг урт шөнийг өнгөрөөх үлджээ. Түмүхэй бол Хэрэйдийн Тоорил ханы дүү Жуур-Цагааны охин билээ.Тоорил,Хэрэйд аймгийны хан болоод Жуур-Цагаан дүүгээ хөнөөж эмс охидыг нь авчээ.

Харин Түмүхэйг хол далд санааны үүднээс Хасарт зулгуйдан өгсөн бөгөөд Хасар ч нэртэй аймгийн хантай ураг барилдах нь сайн хэрэг гэж үзээд Тоорилд талархсан билээ. Харин Түмүхэй их эрх танхи өссөн, бас сэтгэл хөнгөн,тачаал ихтэй тул эр нөхрийн эзгүйд царай зүс цэвэр торгон цэрэг,худалдаачидтай хормой хот орооцолдох энүүхэнд тул Борогчин түүнийг хааш нь ч хөдөлгөхгүй цагддаг байлаа Хасарын бусад хоёр эхнэрийг . Борогчин яг л өөрийн охид шиг удирддаг нь Хасарт тааламжтай байв

. Түүнд дайн тулаанаас олзноос шилэгдсэн, бэлгэнд ирсэн гуч гаруй татвар эмс байдгийг бас л Борогчин ягштал удирдан өөр өөр хэл устай тэдний хийх ажил, идэх хоолыг хуваарилж гэрийн элдэв үйлэнд сургаж хүмүүжүүлэх ажээ. Алтан улсаас Хасарын шилж ирүүлсэн арван сайхан охидыг тэр үнээ саах, гэр орон цэвэрлэх ажилд сургаад зугаатай сайхан байгаа билээ.Хэдий Борогчин шиг эрх мэдэл бүхий эм Хасарын хүрээнд үгүй ч татвар эмсээс хэзээ хэнийг нь эдлэх нь Хасарын дур юм.Хасарын сонгосон татвар эмийг угааж ариутган биеийг нь бэлдүүлж их гэрт оронд оруулж өгөөд өөрөө бага өргөөндөө унтах нь Борогчингийн хувьд жирийн л үүрэг байв.

Ингэв гээд уурлаж гомдсон удаа түүнд үгүй. Гэвч татвар эмс хэзээ ч ёсолж авсан эхнэр шиг хөрөнгө мэдэж хүүхэд төрүүлдэггүй билээ. Хүүхэд гарвал хүнд өгч орхино. Бас тэднээс цэрэг, албатдаа шан болгон өгөх юм уу, гадагш зарж худалдана. Ийм таван бүсгүйгээр Хасарыг ирэхээс өмнө Борогчин нэгэн хөнгөн сүйх тэрэг арилжиж авсан билээ. Тэр таван

бүсгүй нь бүгд Зүрчид цусных байлаа. Энэ мэт гэр орны явдлыг Борогчин тачаал ханасан хойно эрдээ хөврүүлэн хүүрнэж хэвтэв.

Эр нь дайнд явж олз омог их олох нь ард үлдсэн эмсийн хүсэл жаргал агаад Алтан улсаас ирэх олз арвин , үзэмж тансаг тул бүгд л сэтгэл хангалуун байх болжээ. Монгол цэрэг Алтан улсыг дайлаар явснаас хойш Хасарын хүрээний охид хүүхэд шүр сувдаар тоглож, орон гэрээ хивс торгоор бүрж, ачаа бараагаа хүртэл бөхийг нь бодон торгоор татаж, хоргой торгыг үүдэндээ дэвсэх нь холгүй болжээ. Хэл ам нь ойлгогдохгүй зарц шивэгчинтэй болж, бас оргож зугатсан хэдэн Зүрчид, Нанхиад боол алуулжээ. Харин гарын уртай хэдэн боолоор гэр тэрэг хийлгэж байгаа аж. Борогчины хувьд гэр орны ажлыг муу эрээс дутахгүй зохион байгуулах нь аль эртнийх тул Хасар яахав ийхэв гэж огт санаа зовдоггүй байв.

Харахад эрэмгий гүжирмэг энэ бүсгүй эрийнхээ өвөрт бол хэн хүнээс ч илүү эевэр янаг, энхрий ялдам аашилдаг нь гайхалтай билээ. Хаанаас нь ийм урин тачаангуй ааш гардгийг Хасар гайхаж цөхнө. Тийм ч учраас өдий болтол Борогчиноос уйдаж хөрдөггүй, учрах бүр улам их таашаал бахдал хүртдэг аж. Энэ шөнө ч тийм л байлаа.Сэтгэл, дур ханасан хойно бие тавирч хэвтэхдээ тэр анх Борогчинг харснаа дурсан санав.

Борог бойтог хувцасласан ч идэр гоолиг биетэй,хүн хүнээс онцгой том хөхтэй, бүдүүн гуятай бор охин Хэрлэний эргээр ишиг хургаа хариулж явсан нь Борогчин байсан билээ.Харц ядуу ч чийрэг золбоотой, шим шүүс нь нэвт гэрэлтсэн Борогчинг Хасар харуутаа таалж эрээлж цээрлэх юмгүй барьж авчээ. Гэтэл Борогчин бусад эмс охид шиг уйлж орилж урж маажсангүй.Харин ч хүслэнт амрагаа хүлээсэн мэт угтан тэвэрч уруул, биеэ найр тавин өгөөд урьд үзээгүй ихээр тачаадан хөдөлсөн нь Хасарыг нэг мөсөн алмайруулсан төдийгүй тэр дороо л урхидан татсан билээ.

Хасар үүнээс өмнө ийм ил шулуун зантай, их тачаалтай эмийг үзээгүй явжээ. Салж явахад нь

-Хасар чи хэзээ дахин ирэх вэ гэж асуухад

-Маргааш гэж Хасар итгэлтэй хэлсэн юм. Хасар үнэхээр худлаа хэлсэнгүй.Харин маргааш нь ирэхдээ “Ээждээ чамайг аваачиж үзүүлнэ” гэсэнд Борогчин ч дуугүй толгой дохижээ. Харц гаралтай ч нэр бүтэн, ажилсаг хичээнгүй, олон ааш зангүй Борогчин охин Өүлэнд их таалагджээ. Энэ охин Хасар хөвүүний нь заяаны хань гэдгийг Өүлэн, эх хүний зөн совингоороо мэдсэн билээ.Хэрэйдийн Тоорил ханд олзлогдон суухад энэ Борогчин эхнэрийн нь хатуу бэрх зориг Хасарыг аварсан юм. Тэр явдлыг Хасар яахин мартаж болох вэ.

Тэгэхэд ганц Хасарын ч биш, Тэмүжиний ч амь нас хутганы ирэн дээр байлаа.

…Жамуха, Сэмгүм нар Тоорил ханыг ятган мунхруулж, тэд Тэмүжинг сэм довтлон барихаар шийдээд бэлтгэж байгаа тухай Тоорилын агтач Бадай, Хишилэг хоёр шөнө дөл хэл мэдээ хүргэж ирэхэд Тэмүжин тэр шөнөдөө гэр бараагаа орхин зугатсанаар гарцаагүй үхлээс аврагдаж, харин гэнэгүй байсан Хасарын хүрээг хэрэйдийн цэрэг маргааш нь эзлэн авчээ. Энэ үед Хасар Тэмүжинийхээс өртөө илүү хол зусч байлаа.

Хасар өөрийн дэргэд зуу ч хүрэхгүй цэрэгтэй, тэгээд ч Тоорилыг дайрна гэж санаагүй байсан

тул гараа ч хөдөлгөж чадсангүй баригдав. Тоорил хан Тэмүжинтэй эцэг хүү бололцсон тул ийн дайрна гэж хэн ч санасангүй билээ. Тоорил Хасарт болоод эм хөвүүдэд нь гар хүрээгүй ч түүний эд хөрөнгө, цэрэг агтыг хураан авав.

Хасарын эхнэр Түмүхэй Тоорилын ургийн хүн тул тэр эрхбиш нэр нүүрээ бодсон хэрэг биз.

- Хасар, Би чамд муу юм хийхгүй. Чи бол миний хүргэн шүү. Чи надад зүтгэ гэж тулгажээ. Эсэргүүцэх юм уу, эгдүүцвэл амиа алдах тул Хасар Тоорил ханы үгийг өнгөн дээрээ зөвшөөрч, түүнийг дагаж ивээлд нь багтан амьдрахаа батлав. Үүнээс өөр зам ч түүнд үлдсэнгүй. Харин Жамуха, Сэнгүм нар Тэмүжинтэй байлдаж дийлэн алдсан ч Сэнгүм шархдаж тулаан зогссоныг далимдуулан Тэмүжин цөөн нөхдийн хамт зугатаан алга болсныг мэдээд Хасар их баярлажээ. Ашгүй Жамуха, Тэмүжинг хөөсөнгүй.Даруй нэхсэн бол Тоорил, Жамуха, Сэнгүм нарын нийлсэн цэрэгт унаа мориноос өөр сэлгэх агтгүй Тэмүжин шонхорт хөөгдсөн болжмор шиг л сүйтгүүлэх байв. Чухам Тэнгэрийн аврал болж тэд Тэмүжинг хөөлгүй Сэнгүмийн шархыг илааршуулахаар болж цэргээ татжээ.

Энэ үед Тэмүжиний үхэл яг ар шилэн дээр нь сууж байсан билээ. Хэрэв тэд Тэмүжинг нэхэхээр хөдлөх гэвэл Хасар өөрийг нь харгалзагч цэргийн зэвсгийг булаан авч ойр байх Тоорил, Жамуха, Сэнгүм нарыг шууд ална гэж шийдсэн байв. Гэвч азаар тэгсэнгүй. Тоорил сураг эрэл тавивч Тэмүжин чухам газрын гаваар орсон мэт, галуу болж ниссэн мэт алга болжээ. Тоорил, Хасарыг эмс, хөвүүдийн нь хамт өөрийн хүрээнд харгалзан хааш нь ч хөдөлгөхгүй байсан боловч хуучин албат, зарц, шивэгчдийг нь үлдээжээ. Харин бүгдийнх нь зэвсэг, агтыг хураан авснаа буцааж өгсөнгүй. Энэ нь Тэмүжиний дүү Хасарыг олзлон авснаа бүгдэд мэдэгдэх, бас Хасарыг дэргэдээ байлгаснаар Боржигон аймгийн Тэмүжинээс бусад нь Хэрэйд аймагт автав гэж олонд харуулах гэсэн санаа байв.Тэмүжин цөөн нөхдийн хамт сураггүй алга болсон нь Боржигон аймгийн салж сарнисан иргэд өөрийн эрхгүй Тоорил, болоод Жамухыг дагахад хүргэв. Энэ бол Тэмүжинд тохиосон хамгийн хэцүү үе байсан юм. Нэг өдөр Сэнгүм Хасарыг хүрээндээ урив. Олзны хүн үгүй гээд хаана очно. Элчийг даган Сэнгүмийнд очжээ. Сэнгүм тогтсон тодорхой үзэлгүй,оргож бултсан олон ааштай,тавьтаргүй хүн гэдгийг Хасар сайн мэдэх тул юуны учир ингэж урьж залсныг тааж ядаж явлаа.

Харин очсон хойно хэргийн учир тайлагдсан агаад тэнд Жамуха Хасарыг хүлээж байжээ. Жамуха хундага өргөж, хоолоор дайлсны хойно

–За Хасар аа. Би чамд эрт хэлсэн нэг үгээ сануулах гэж дуудлаа. Бөртийг булаан авахад цэрэг гаргаач гэж Тоорил ханы хэлсэн үгийг надад дамжуулж очиход чинь Ханхайрханы өвөрт миний хэлснийг чи сана. Чи бол Тэмүжиний адил Есүхэйн хөвүүн. Би чамайг хүсвэл туслана гэсэн биз. Одоо чамд тийм цаг ирлээ. Тэмүжин ах чинь хаяагаа хадарч, харснаа хаздаг хүн. Монгол ах дүүс биднийг мухируулж, муудалцуулж байна. Чиний аймгийг чамд мэдүүлэхгүй өдий хүрэв. Одоо Тэмүжин хаана байна. Сүүдрээсээ сүрдэж, сүүлнээсээ үргэж одлоо. Эцгийн чинь зовж зүдэрч цуглуулсан аймаг эзэнгүй тарж, эрэггүй урсаж байна. Чи олсон, долсон түмнээ мэдэж авагтүн. Би чамд цэрэг өгье. Тэмүжинг долоон уулын цаанаас ч, дов шороон доороос ч бай олж тонилгож үз. Тэгээд аймгаа захиран суу. Хэн чамайг хорино. Чи чинь Есүхэйн хөвүүн хавт Хасар биш үү. Харвах шигээ сэтгэж үз. Тэмүжинг алах аваас чи хаана ч хүрэх биз. Би чамд хавсрана. Сэнгүм ч хавсрана.Чоно баавгай хоёр нэг ичээнд багтахгүйн үлгэр Тэмүжин та хоёрт иржээ.Бүү алмайрч ахдаа автагтүн гэжээ.

Жамуха ухаантай хүн тул палхийтэл хэлсэн ийм гэнэтийн үгэнд ямар ч хүн цочирдоно гэдгийг сайн мэдэх учир тэр даруй хариу нэхэж сандаргасангүй. Учир нь тэр Хасарын санааны мухарт яргаж байсан нууц бодлыг яв цав тааж хэлснээ мэдэж байжээ. Хасараас хэлсэн даруйдаа хариу нэхвэл халуун цочмог зантай тэрээр гэнэт дүрэлзэн босоод сэлэм жадандаа хүрч санасан хэрэг хаашаа ч эргэж мэдэх тул Жамуха маш их айж болгоомжилж байв. Үүнийгээ ч Хасар бас сайн мэдэж байх тул дахин энэ мэт үг ярьсангүй байсаар буцжээ.

Үнэхээр Жамухын амнаас анх гарсан дээрх үгийг сонсоод Хасарын царай хэрхэн хувирч нударгаа зангидсаныг тэд харж байлаа. Энэ үед Жамуха тэр дор нь яриагаа өөрчилж чадсан нь аврал болжээ. Харин замдаа Хасар эргэлзэж эхлэв. Жамухын бодол зөв юм. Боржигон аймгийн хан болох бүрэн боломж Хасарт анх удаа нээгдэв. Тэмүжинг ялна гэвэл Хасарыг л түүний эсрэг хөдөлгөх хэрэгтэй гэдгийг Жамуха олон жилийн өмнөөс мэдэж аажмаар баттай итгэх болсон билээ. Хасар ингэж өөрийн хүсэл, Жамухын занга хоёрт давхар унав. Одоо Тэмүжинг хороож хан суухад хэн ч түүнийг зэмлэхгүй нь лавтай. Хэн эсэргүүцнэв, тэр үхнэ биз.Ер нь их хэргийг гүйцэлдүүлэхэд үхэхгүй амь,үрэгдэхгүй хань гэж үгүйг Хасар ойлгоно.

Анх арван настайд Бэгтэр ахыгаа алснаа санав. Тэр үед Тэмүжин зориглон Бэгтэрийг алаагүй бол одоо Боржигон аймгийн хан Бэгтэр болчихсон байхыг хэн ч үгүйсгэж үл чадах биз. Гэтэл Хасар яагаад Тэмүжинээс дорой байж, доогуур сэтгэх ёстой билээ. Тэмүжинээс дутах юм түүнд үгүй. Харин ч илүү биз. Сэнгүмийн хүрээнээс Тоорилын хүрээ орох замдаа үерийн ус шиг оволзсон бодолд ийнхүү автжээ. Харгалзагч цэргүүд түүний ойр дагалдан аяар явцгаана. Хасар амьдралынхаа хамгийн эрс хатуу шийдвэрийн өмнө зогсож байгаагаа мэдэрч байлаа. Энэ хэрэг бол арван настайдаа Бэгтэрийг алахаар Тэмүжиний зориглон шийдсэнтэй яг утга адил явдал байв.

Гэтэл Хасар яаж ч бодоод эцсийн хатуу шийдвэрт хүрч чадахгүй байжээ. Тэмүжинг алж Боржигон аймгийн хан суухад чухам юу ингэж саад болж шаналган зовоогоод байгааг тэр сайн ойлгосонгүй. Тэмүжиний эсрэг хөдлөхөд одоо бүх юм бүрэлдэн цогцолсон мэт. Тэмүжинд хөөгдсөн,цохигдон бутарсан бүх овог аймаг түүнийг даган дэмжих нь гарцаагүй. Бас Тоорилын хүчирхэг Хэрэйд аймаг туслах болно. Ийм тохиолыг алдвал хожим хойно миний үр сад намайг лав өршөөхгүй биз гэж Хасарт бодогдоно. Айвал бүү хий, хийвэл бүү ай гэдэг үг санагдана. Эцгийн улсыг элэг бүтэн, энх амар суулгах хүсэл түүнд байгаагүй гэж үү. Хэрэв Тэмүжин аймаг улсаа хамгаалан явж нэгэнт чадахгүй болсон бол Есүхэйн хөвүүн Хасар би эс чадвал өөр хэн чадна.

Тэмүжин хар амиа бодон зугатааснаас болж би Тоорилд олзлогдсон биш үү. Одоо Би Тэмүжинд сайн санаж юу хийнэ. Аягүйдвэл Тэмүжин бид хоюулаа амиа алдах болно. Тэгвэл Боржигон аймаг хэзээ ч сэргэхгүйгээр мөхөж, Жамухын, эсвэл Тоорилын идэш болно.Ийм үед Хасар би юунд эргэлзэж тээнэгэлзэнэ. Хэн хүчтэй нь эзэн суудаг Тэнгэрийн зарлигийг дагасугай гэж хатуу шийдээд морио гуядан давхилаа. Хурдлан давхих бүр зориг шулуудан, өмнөөс үлээх салхитай хамт урам итгэл сэтгэлд дүүрэх ажээ. Гэрийн гадна буухдаа Жамухын цэргийг удирдан Тэмүжинг нэхэхээр Хасар хатуу шийдсэн байв. Харин Боржигон аймгаа эргүүлэн авмагц Жамуха нарыг гэнэт довтлон дарна гэж дотроо товлов. Гэтэл огт санаандгүй зүйл болжээ.

Учир нь Тоорилын цэрэг дайрсан шөнө Тэмүжиний хүрээнд байсан Хасарын албат Чилгутай

түүнийг гэртээ ороход сууж байв. Чилгутай бол Тэмүжин хан болмогцоо Хасарт хувааж өгсөн гурван илдэчийн нэг юм. Чилгутайн эмс, хүүхэд бас энд Тоорилд олзлогдон байгаа билээ. Тэмүжин Чилгутайг Хасарт элч болгон илгээсэн байв. Тэмүжиний:

Есүхэй эцгээс нэр заагдаж

Өүлэн эхээс бие заагдаж

Дээрээс минь унаж төрсөн

Дээлээ хуваалцаж өссөн

Хавт Хасар дүү минь чи

Хартанд автаж зовно уу

Харьд сууж чилнэ үү

Хайран бие чинь зүдэрнэ үү

Энд харин бид чинь

Энэрэлт Өүлэн ижий чинь

Элгээ эмтэлж Элээ халаг гэлцэн сууна

Ахыгаа үгүй болвол

Аавын нэрийг дуурсгах

Ачит дүү чамайгаа

Алмайрч дайсанд алдаад

Асралт эхийнхээ өмнө

Арвин нүгэлд унав би

Мэгдэж чамайгаа орхиод

Мэхтэн дайсанд автаад

Мэргэн эхийнхээ өмнө

Мянган алдаанд унав би

Цус нэгтэй дүү минь чи

Цалгардаж, хортны үгэнд унавзай

Хавтай төрсөн дүү минь чи

Хартай дайсны мэхэнд автавзай

Ухаант дүү чамтай

Ургийн минь нэр

Аймгийн минь хагас

Амины минь тал бийг

Амьсгаагаа тасартал

Аргаа барагдтал

Бүү март гэж хэлүүлснийг Чилгутай давтан хэлэв.

Эхийнхээ тухай дуртган хэлсэн Тэмүжиний дээрх үгэнд Хасар уяран догдолж, бас ичиж удаан дуугүй суув. Тэмүжин түүний бодсоныг үзэж, сонссон мэт таагаад Чилгутайг илгээжээ. Тэмүжиний хэлүүлсэн шүлгийг сонсоод Хасар тэр дороо муу бодлоосоо буцаж юу ч болов Өүлэн эх ,Тэмүжин ахыгаа олж уулзахаар хатуу шийдэв. Үхсэн ч, сэхсэн ч ахтайгаа, бас Өүлэн эхтэйгээ хамт байхаар шийджээ.Хасар эх, ах хоёртоо үнэн сэтгэлээс хайртайгаа дахин нэг ухаарав.

Гэвч яг юу хийхээ мэдсэнгүй. Тэмүжинээс салаад даруй сар гаран болсон тул одоо хаана байхыг Чилгутай хэлж мэдэхгүй байв. Тэмүжиний зүг сэм одох нь туйлын осолтой байв. Харин Чилгутайн хэлснийг Хасар Борогчинд хэлсэн ч явна гэхэд Тоорилын хүрээнд үлдэх эмс болоод хөвүүддээ санаа зовох ажээ. Хасарыг оргосныг мэдвэл Тоорил тэднийг амьд үлдээхгүй нь лавтай. Хасарын арга мухардав. Харин энэ үед Борогчины сийрэг ухаан тус болсон билээ.

- Чи Тоорил ханд “Би Тэмүжин ахыгаа эрж олоод хаана байгааг нь танд хэл өгье. Би таны дэргэд эм, хөвүүдээ үлдээх тул та надад итгэх биз” гэж хэл хэмээн Борогчин шууд Хасарын хэлэх үгийг зааж өгсөн нь зөв болжээ.

Тоорил хан Хасарын үгийг сонсоод их л өгөөмөр зан гаргаж дуртай зөвшөөрсөн нь Жамуха болоод Сэнгүм нар Хасарт юу гэж хэлснийг тэр мэдээгүйнх ажээ. Тоорилд Хасарыг алах бодол огт байсангүй тул түүнийг явахад цааргалсангүй. Тэгээд ч эм, хөвүүдээ үлдээсэн Хасар хаа холдох вэ гэж бодов. Ингээд Хасар цаг алдалгүй тэр шөнөө итгэлт хэдэн шадраа дагуулан сэм мордож Тоорилын хүрээнээс хойт зүг гарсан ч удалгүй зам буруулан дорно зүг явсан билээ. Цааш юу болохыг, эхнэр, хөвүүд нь хэрхэхийг ч бодсонгүй ганцхан Борогчины цэцэн ухаанд даатган орхив. Тэр үхэвч сэхэвч Тэмүжиний хамт байхаар шийдээд сэтгэл нь цэлмэн уужирчээ. Тэмүжинээс яавч урваж болохгүй, бүр чадахгүйгээ ингэж Хасар анх удаа гүнзгий мэдэрсэн билээ.Түүнийг очвол Өүлэн эх нь хамгаас ихээр баярлана гэж санахад

үнэхээр сэтгэл дүүрэн болжээ.

Эхийгээ яаж шаналж зовж байгааг Хасар тод харж, мэдэрч явлаа. Харин Чилгутайг яаравчлан зарсан нь Тэмүжиний болгоомж хардлага ихтэй, холын бодолтойнх төдийгүй, бас хэрэг явдлын болзошгүйг зөнгөөр тааж мэдсэнийх байлаа. Хэрэв Тэмүжин элч зараагүй бол Жамухын арга заль, атгаг хорт үгэнд автсан Хасар дийлдэшгүй дайсан болон хувирах байв. Хасарын хүрээг Тоорил хан эзлэн авсныг мэдмэгц л Тэмүжин цаашид юу болохыг ойлгож ихэд түгшсэн билээ. Тэрээр удахгүй довтлон ирэх дайсныг хэрхэхээ бодохоос илүү дайсны мэхэнд хууртаж мэдэх дүү Хасарынхаа юу хийж чадахыг эргэцүүлэн бодсоор гүнзгий түгшүүрт автжээ.

Үнэхээр Хасар дайсан этгээдтэй сүлбэлдвэл чонотой нийлсэн гэрийн нохой шиг хамгийн аюултай дайсан болох билээ. Олзлон авсан ч Хасарыг Тоорил хан лав алахгүй. Алчихвал тэдэнд ашиггүй, бүр хор болно. Харин Хасарыг Тэмүжиний эсрэг турхирч чадвал хамгийн том олз гэдэг нь нь хэнд ч ойлгомжтой байв. Сэтгэл санаа тогтворгүй атлаа өөртөө дэндүү итгэлтэй, бардам зантай Хасарын Боржигон аймгийн эзэн суух хүслийг дэвэргэн хатгахад туйлын хялбар бөгөөд Жамуха ч энэ зэргийг санаж сэдэхтэйгээ хүн тул Тэмүжин яаравчлахгүй бол болсонгүй.

Юуны өмнө Хасар үгийг нь итгэн хүлээж авахуйц элч олох хэрэгтэй болов. Ашгүй түүнтэй хамт Хасарын шадар Чилгутай явсан нь аз болов. Тоорил,Жамуха нарт цохигдсон Тэмүжин цэргээ ухрааж зайлан одох зуурaа Чилгутайд үг дайж Тоорилын хүрээнд илгээсэн нь энэ болжээ. Тэмүжин хэргийн учрыг сийрэг тайлж, Чилгутайг цаг алдалгүй илгээж ухаантай, оночтой үг хэлүүлсэн нь Хасарыг урван тэрслэхээс сэргийлж ингэснээрээ өөрийгөө аврав. Чухмыг хэлбэл Тэмүжин, Хасар хоёрын ухаан биш харин Өүлэн эхийн хөвүүдээ хайрлан өсгөж чадсан агуу сэтгэл тус болсон билээ.

Тийм ч учраас Хасарын олзлогдсонд өөрийгөө буруутгасан ухаарлын үгийг эхийнхээ сэтгэлийг санах учрын хамт нэн тод өгүүлэн хэлж явуулсан нь онов. Тэмүжин хоол ундгүй, ядарч эцсэн цөөн нөхдөө дагуулан Халх гол уруудан явж байхдаа Чилгутай очиж чадалгүй алуулсан, аль эсвэл Хасар түүний үгийг тоохгүй Тоорилын талд орсон байвал яана гэж түгшин бодсоор явав. Амь наана, там цаана зугатааж олон хоног морины явдалд агсагдаж ядарсан ч гомдлын ганц үг үл унагах Өүлэн эхийгээ харах бүр яг өөртэй нь адил Хасарын тухай бодолд автан шаналж яваа нь илт ажээ.

Хасар хөвүүнийхээ занг Өүлэн гаргууд мэдэх тул Тэмүжин хөвүүнийхээ юунаас ингэтлээ айж түгшиж явааг сайн мэдэж байв. Гэвч хамаг хэрэг муугаар эргэж Хасар хөвүүн нь ахыгаа довтлон ирвэл Өүлэн Тэмүжингээ үхтлээ хамгаална гэж хатуу шийджээ. Эхийгээ нүдээ бүлтийтэл харж байхад Хасар арай ч ахдаа муу юм хийж зүрхлэхгүй биз гэж бодсондоо Тэмүжинээс өдөр , шөнө ялгалгүй алхам ч холдсонгүй. Тэмүжин хөвүүнд нь одоо хамгийн бэрх хэцүү цаг мөч ирснийг, түүнийг үхэл ялагдлаас авран хамгаалах хэрэгтэй болсныг Өүлэн, эх хүний зөн совингоороо мэдэрчээ. Тоорилын дэргэд очсон Хасар довтлон ирвэл Тэмүжинг гарцаагүй үхлээс аврах ганц хүн бол үнэхээр Өүлэн юм.

Тэмүжин ч гэсэн Тоорил, Жамуха хоёроос айсангүй, харин тэдэнтэй нийлсэн Хасараас айж харанхуй шөнө ч хар нүдээ хамхихгүй явжээ.Хасар дайран ирвэл түүнтэй зориглон тулах хүн

гарах эсэх нь эргэлзээтэй. Зоригт Жорчидай ч айн зайлах биз. Эцэст нь Тэмүжин л үлдэж таарна. Ингээд Есүхэйн хоёр хүү эрэгчин эмэгчнээ үзэлцэж хэн амьд үлдсэн нь эзэн суух болно. Тэмүжин Хасарыг дийлэхгүй гэж бодовч үүнд хүргэхийг огт хүссэнгүй. Хасарыг түүнд эргүүлэн явуулахыг Тэнгэрээс олонтаа гуйв. Үнэхээр энэ удаа Тэнгэр дахиад л түүний үгийг сонсчээ.

Балжун нуурын дэргэд буудаллаад байтал хойт талаас гурван морьтон гуйван гэлдрүүлсээр айсуй.

Удаан хүлээсний эцэст эцэж ганхсан морьтой арайхийн ирсэн тэр хүн бол Хасар болохыг Тэмүжин танив. Турж эцээд гуринхалсан нохой шиг болсон Хасар ах болоод эхийгээ үзмэгц хаанаас нь гарав гэмээр дүүрэн нулимс цувруулахад Тэмүжин Хасар дүүгээ уяран хайрлаж тэврэн авсан билээ.

- Би Чилгутайн үгийг сонсомогцоо

Өчүүхэн хөвүүдээ эхтэй нь орхиод

Өүлэн ижийгээ тэмцэн зорьж

Өршөөлт ах таныгаа эрж

Өчүүхэн амиа золин зүтгэж

Одтыг нөмөрч

Орвонг дэрлэж

Хэц түшиж

Хээр хонож

Шир зажилж

Шөрмөс идэж

Унтах нойроо хасч

Унах морио эцээж явсаар арайхийн ирэв гэхийг сонсоод Хасар дүү нь түүнд юугаар ч сольж болшгүй үнэтэйг Тэмүжин сэтгэл дотроо өөрийн эрхгүй хүлээн зөвшөөрсөн билээ.

Өүлэн эх нь Хасар хөвүүнээ үзээд өрөвдөн хайрлахдаа хатуу ширүүнийг давж, халуун хүйтнийг туулж, өнчин ядуу явж, ядарч зүдэрч байснаасаа ч илүү шаналан зовсон мэт гашуунаар уйлахыг үзсэн бүгдийн элэг эмтэрч сэтгэл шимшрэн дагаж уйлав. Тэр үед Тэмүжинд ердөө явган нүцгэн хоёр мянга зургаан зуун хүн үлдсэн байв. Тоорилын гэнэтийн дайралтад өртсөн бусад цэргүүд нь хоцорч тараад тус тусын нутгаас ирж амжаагүй тул Тэмүжин одоо ямар ч дайсантай тулгарсан ялахад бэрх болжээ.

Унд хоолгүй, унаа морьгүй цэргүүд юун түрүүнд сэтгэлээр үхэж байгаа нь бүхнээс хэцүү байлаа. Тоорил болоод Жамухын

довтолгоог тэсэж амьд мэнд мултрах сайн арга Тэмүжинд бодогдохгүй олон хонож байв.

Хасарыг ирэв гэж тарган хулан алан махыг нь чанаж идээд

Балжин нуурын усыг архины оронд өргөж

Атаат дайснаас зугатаж

Амь зулбан явахын цагт

Хаяж орхиж явалгүй

Халуун амиа дэнчигнэн

Халх нөмөр бололцож

Хамаг зовлонг хуваалцсан

Үнэнч нөхөд та нарын

Өгүүлж баршгүй тусыг би

Газарт мөнхрөвч мартахгүй

Тэнгэрт гаравч умартахгүй гэж Тэмүжин хоолой зангируулан байж тангараг тавихыг үзээд уйлахгүй хөшүүн дотортон энд нэг ч үгүй болжээ.

Үдэш нь Хасар, Тэмүжин хоёр цаашид хэрхэхээ ярилцав. Хасарын ирсэнд Өүлэний сэтгэл цэлмэж санаа уужраад залуу болсон шиг үзэгдэнэ.Омголон зантай Хасар хөвүүн нь ер санаа сэтгэл хувирсангүй, амьд мэнд эргэн ирээд одоо Тэмүжин ахынхаа хамт инээлдэн зогсохыг үзэх шиг аз жаргалыг Өүлэн үүнээс өмнө амсаж мэдрээгүй мэт болж хөвүүдээрээ бахархах хайр нь оволзож байв.

Хасар ч энд ирсээр ах,эх хоёртоо хичнээн үнэтэй хүн болохоо мэдэрч өөрийн эрхгүй уяраад үнэнч зүтгэх хүсэл нь буцалжээ. Цаашид хэрхэхээ Хасарын хэлснээр хийхийг Тэмүжин эхлээд зөвшөөрөөгүй бөгөөд хэрэг явдал тэгж санасан зоргоор бүтнэ гэхэд дэндүү итгэлгүй санагдаад болсонгүй. Хасарын тавьсан гэнэтийн зоримог саналыг Тэмүжин удаан бодов. Сарны гэрэлд Балжун нуурын ус долгиолж хөлийн өлмийг долооно. Тэмүжин элдвийг эргэцүүлэн бодож хариу хэлэхгүй зогссоор ажээ.Тэр Хасарт итгээгүйдээ ингэж удаан шүүн бодсонгүй. Хасарын сэдсэн санаа дэндүү зоримог, аюул осол ихтэй байлаа. Бас Тоорил хан Хасарын үгэнд итгэх эсэх нь ч эргэлзээтэй. Хасарын хэлсэн санал бол угтаа эхнэр Борогчины нь санаа юм. Бүх юм муугаар эргэвэл Борогчин болоод Хасарын бусад эмс, хөвүүдийг Тоорил өс санан алах нь гарцаагүй тул Тэмүжин эргэлзэж байлаа. Гэвч Хасар огт айсангүй. Бүр эмс хөвүүдээ алдахад ч айж харамсах зүйлгүй гэж амлав.

Үнэхээр Хасар нэг л ингэж хэлсэн бол юунаас ч айж буцахгүй хүн билээ .Бас Хасарын хэлснийг эс зөвшөөрвөл байдал ямраар ч эргэж цаашдаа юунд ч хүргэж мэднэ гэж Тэмүжин болгоомжлов. Гэтэл Тэмүжиний төлөө ингэж тэмцэх хүн тийм ч олонгүй болоод байсан үед айж эргэлзэж цаг алдах нь үхэхтэй адил байлаа. Олон санаат оргож чадахгүй гэдэг болох биз гэж эцэст нь ухаараад бүгдийг Хасарын хэлснээр хийхээр шийдэж Боорчи, Зэлмэ хоёрыг дууджээ.Тэмүжиний хэлснээр Тоорилд Хасарын үг гэж элч илгээхээр тогтов. Тоорил ханд итгэлтэйг нь бодолцон сая Хасарыг дагаж ирсэн Халиудар,Чаурхан хоёрт товчхон шүлэг цээжлүүлэн мордуулжээ.

Хан эцгээс салаад

Хайртай ахаа хайж

Халамжит ижийгээ санаж

Харанхуй шөнө ч унтахгүй

Хүн боловч цуцах биз

Хүлэг боловч эцэх биз гээд

Уул даваг өгсөж

Ус голыг уруудаж

Хад асгыг хажиж

Хайн эрсээр боловч

Хайран ах минь

Харагдах бараагүй

Хайлан уйлавч

Хариу чимээгүй тул

Хасар би Хаачихаа мэдэхгүй

Гэргүй хонож

Дэргүй унтаж явна

Харин миний эм хөвүүд

Хан эцгийн дэргэд тул

Хасар би одоо Хаашаа одох билээ.

Эцэг минь та ивээж

Итгэмжит элчээр

Энэрлийн үгээ илгээвэл

Эрэл мухардсан би

Эргэж очих билээ

Эвсэн зүтгэх билээ

Хан эцэг та

Халамжит үгээ хэлж

Хатамжлах сургаалаа айлдаж

Хариу элчээ ирүүлбэл

Хайж эрэхээ болиод

Харьж би буцсугай гэж Тоорил ханд хэлүүлжээ.

Хэрвээ Хасар ингэж орох оронгүй, оочих аягагүй ядарч зүдрээд нэгэнт Тэмүжинтэй уулзах итгэлгүй болжээ гэдэгт үнэмшүүлж чадвал Тоорил Борогчин болоод хөвүүдэд нь заналхийлэхгүй болно. Түүнийг ингэж сэрэмж алдуулах нь л Хасарт чухам хэрэгтэй байв.

Үүний өмнө Хасарыг ирэхийн урьд Тоорил, Жамуха, Сэнгүм нарт Тэмүжин тус тусад нь элч зарж тэдэнд эртний хийсэн тус, эвлэж тавьсан тангаргаа сануулж ер дайтах санаагүй гэдгээ мэдүүлснээс болж Тоорил, Сэнгүм, Жамуха гурав дотроо хагараад байсан билээ. Элчийг явмагц Тэмүжин цөөн цэргээ аван нууцаар нүүж тохиролцсон ёсоор Хэрлэний Аргал хохид очиж буув. Элчийн үгэнд Тоорил хан итгэж Хасарыг дагаж ирэхийг зөвшөөрч Итүргэн гэгчийг баталгаа болгон илгээжээ. Ингэж бүх юм Хасарын хэлснээр болов. Итүргэнийг Аргал-хохид ирмэгц Хасар үг сонсолгүй цавчин алав. Элчийн хэлснээр одоо Тоорил хан, хүү Сэнгүмийн хамт Жижээр өндрийн Жэр хавцалд алтан тэрэм босгон ямар ч сэжиггүй найрлаж байгаа ажээ.

Тэмүжин Хасар нар зөвхөн хөтөлгөө морьтой хөдөлж шөнөжин давхиад тэднийг гэнэгүй байхад үүрээр довтлон оржээ. Энэ бол Хасарын санаа байв. Гурван шөнө, гурван өдөр Хэрэйд аймгийн цэрэгтэй цөөн хүчээр тулалдаж тэднийг буулган авсан ч Тоорил, Сэнгүм хоёрыг зугатаалган алдсандаа Хасар учиргүй харамсч байв. Гэвч Жамухыг биш Тоорил ханыг түрүүлэн цохихоор бодож олсноо өөрөө удирдан зоримгоор хэрэгжүүлсэн нь Хасарын байгуулсан нэг том гавьяа төдийгүй энэ ялалт үнэндээ Хэрэйд аймгийн мөхөл болохыг Тэмүжин шударгаар үнэлжээ.

Харин Борогчин хөвүүдтэйгээ бусад эмсийн хамт амьд үлдсэнийг сонсоод бүгд түүний сэргэлэн ухаанд бахдав. Борогчин гэрт байсан идээ цагааны хоосон модон торхонд хөвүүд болон бусад эмийг хийж харанхуйгаар газрын уруу өнхрүүлэн холдуулсаар тэднийгээ Тоорилын цэргийн хүрээнээс гаргаж чадсан байв.

Үнэхээр эм хүн боловч Борогчин бол олныг гайхуулсан эрэмгий гавшгай бүсгүй ажээ. Хөвүүдийнхээ хамт Тоорилынд барьцаанд үлдэж, Хасарыг явуулснаар Тоорил ханыг цохих бололцоо олгосон Борогчинг Тэмүжин ихэд сайшааж, Хэрэйд иргэнээс маш олныг шагнан өгчээ.Бас Тоорил ханы бүх татвар эмс, гэрийн шивэгчдийг ч мөн Борогчинд өгөв. Борогчины саруул ухаан, сэтгэл зоригийн ачаар Тэмүжин бас Хасарт ч их итгэлтэй болжээ. Хасар ч Борогчингоо урьдынхаасаа илүү сайнаар үзэж хүндэтгэн хайрлах болсон юм. Тэмүжин энэ явдлаас хойш Борогчины хөвүүн Егү, Есөнхэй, Туху гуравт ч онцгой дотно хандах болжээ.

Ингэснээрээ Тэмүжин эм хүний гавьяа зүтгэлийг боловч эрийнхтэй нь тэнцүү зөв шудрага үнэлж чаддагаа харуулсан явдал олонд их үнэлэгдэж түүнийг улам хүндлэн хайрлахад бас хэрэг нэмэр болсон юм. Хэрэйдийг ялсны гавьяаг тэрээр ганц Хасартай шууд холбон үзээгүй ч дараа нь Найманы Таян хааныг дарах дайныг Хасараар удирдуулах болсон нь нэг ёсондоо Хасар дүүгийнхээ онцгой их гавьяаг үнэлсэн хэрэг байлаа. Тэртээ залуу омголон үедээ Тоорил хан Жамухын дагуулан ирсэн Агажур бөөгөөс “Миний үхэл хэзээ бол” гэж тохуутайгаар асуусан билээ.

Тэгэхэд Агажур бөө Тоорилын энэ илт басамжилсан үгийг тоолгүй дал шатааж үлээгээд

-Хан та үхэл рүүгээ өөрөө гүйж очих юм байна даа гэвэл

-Хэзээ тэр вэ гэж Тоорил хан их хөхөрчээ.

-Тэр өдрийг Тэнгэрт ивээгдсэн нэг баатар эр заах ажээ гэж Агажур бөө огт наргиан болголгүй өгүүлэхэд угийн ийм мэргэ төлгөнд сүжиг багатай, бас Христийн номлол сургаалийн нөлөөнд сүрхий автсан Тоорил Агажур бөөгийн үгийг төдийлөн тоож үзэлгүй орхисон ч хэзээ хойно болтол “Агажурын хэлсэн тэр баатар эр хэн бэ” гэдгийг мэдэх гэж өөрөө дал шатааж, бас чулуу таслаж бишгүй л мэргэлсэн байжээ.

Харин Агажур бөөгийн хэлсэн тэр хүн нь Тэмүжинг байх гэж Тоорил дараа нь сэжиглэн бодох болжээ. Тоорилын мэргэ тэр энэ гэж оноож мэдээгүй ч Тэмүжинтэй тэрсэлдэж болохгүй гэж шийжээ. Тийм ч учраас хэдий хэцүү ч залуу Тэмүжинтэй аль болох эвтэй найртай явахыг хичээсээр авч олон ааштай, хүний үгэнд автамтгай, хөнгөн хуумгай зантай ганц хөвүүн Сэнгүм нь үргэлж Тэмүжинтэй арсалдан үйлийг нь барсаар байгаад эцэст нь өвгөн Тоорил өөрийн эрхгүй Сэнгүмийнхээ үгийг дагаж Тэнгэрийн гэсгээлд унав.

Тоорил хан, хүү Сэнгүмийн хамт Тэмүжинээс дутаан гараад Найман аймгаас аврал хайж зорин тэмцсээр олон хоног явсны эцэст ам ангаж ус эржээ. Гэтэл Дидиг сахлын Эхийн ус гэдэг газар таарч Сэнгүмийн хориглосоор атал Тоорил хан тэр ус руу очоод

– Би Тоорил хан гэж хэлсээр атал тэнд таарсан найманы хилийн харуул тоолгүй алжээ. Ингэж Тоорил хан Агажур бөөгийн үгийг үл тоомсорлосныхоо горыг амсаж Есүхэйн хөвүүн

Хасарын заасан өдөр өөрийнхөө үхэл рүү гүйж очжээ. Монголын хамгийн том хүчирхэг Хэрэйд аймаг мөхөж хан Тоорил нь нэртэй газар, нэргүй үхэв.

Хэрэв Хасар зориглон өөрийн эмс,хайртай хөвүүдээ үхэлд хаяж өгөн байж Тоорил ханыг уран аргаар ялаагүй бол Боржигон аймгийн мөхөх сэхэхийг Тэмүжин ч, Хасар ч батлан хэлж чадахгүй билээ.Энэ тулаан Тэмүжин болоод Хасарын хувь заяанд эргэлт болсон юм. Үнэхээр Хасарын гавьяаг олон бүгдээр шагшран магтжээ. Тоорилын үхлийн өдрийг зааж өгөх учиртай тэр Тэнгэрт тэтгэгдсэн баатар эр нь Хасар байх юм гэж Агажураас өөр хэн ч таамаглаагүй хэрэг. Энэ учрыг бас Тэмүжин ч, Хасар ч мэдэхгүй. Хувь заяа үйлийн үрийн ийм нарийн учрыг мэдэхгүйн улмаас Жамуха, Сэнгүм хоёр Хасартай буруу өдөр үг эвссэнээс болж Тоорил хан үхжээ.Уг нь Тоорил ханыг ийм хялбархан үхнэ гэж хэн ч санаагүй бөгөөд тэр дундаа эцэг, хүү бололцсон Есүхэйн хөвүүдийн гарт үхнэ гэдгээ тэр өөрөө зүүдлээ ч үгүй билээ.Тал нутгийн хамгийн хүчирхэг аймаг хэрэйдийн Тоорил ханы үхэл монголын тал нутагт Есүхэйн хөвүүдийн алдраа дуурсгахын бат нотолгоо болон түгжээ.

Ийм эмгэнэлтэй гэнэтийн үхлийг тал нутагт тийм ч олныг үзсэнгүй. Угаас Тоорилын хувь зохиол тийм байжээ. Тэмүжинг эсэргүүцэн тэмцэгчдийн ганц өмөг түшиг,сүнс сүлд нь Тоорил хан байв. Нэгэнт сүр сүлд нь үгүй болсноор тэдний тэмцэл дарагдан сөнөх цаг нь иржээ. Тоорил үхсэнээр Жамуха өнчин ганц хайлаас шиг, өчүүхэн муу хулгайч шиг хоцорчээ.

Тоорил хан Найман улсын хилийн харуулд алагдсан яг тэр өдөр Тэмүжин нар Туулын шугуйд Тоорилын их өргөөний буйран дээр найрлаж ялалтаа тэмдэглэн олзоо хуваав. Найраас түр гадаалсан Тэмүжин Туулын мөнгөн урсгалыг сарны гэрэлд ширтэн зогсоход Хасар дэргэд нь очив. Тэмүжиний ийм гунигтай байхыг үзээд Хасар ихэд гайхаж учрыг асуужээ. Тэмүжин дув дуугүй удаан зогсов.

-Энэ нутагт Хэрэйдүүд нутаглаж, Тоорил хан эзлэн сууж байв. Тэр өвгөн одоо нэгэнт үхжээ… гэж Тэмүжин шивнэв.

-Тоорилыг үхэв гэж танд хэн хэлэв.Тэр зугатаж одсон биш үү. Одоо аягүй бол Тангуд улс, эсвэл Таян ханд очоод тэндээс цэрэг авч биднийг дарна гэж их санаалж суугаа. Сэнгүмийг амьд байгаа цагт би юунд ч үл итгэнэ. Би Тоорил ханыг Сэнгүмийн хамт олж өөрийн гараар алахгүй бол сэтгэл яаж амрана гэж Хасар хэлэв.

-Тоорил хан үхжээ гэж Тэмүжин шүдний завсраар сийгүүлэн хөндий хүйтэн аясаар хэлэв.

-Та яаж мэдэв Тэмүжин дахиад л үл ойлгогдох зангаа гаргаж таг дуугүй тэнгэр өөд дээш ширтэв. Хасар дээшээ харвал дээр нь од түгсэн тас хар тэнгэрээс өөр зүйл олж үзсэнгүй.

- Хасар чи нэг зүйлийг санаж ав. Би мартах юм уу, амжихгүй үхэж мэднэ. Тэгвэл чи хийнэ биз…

-Юу тэр вэ. -Хэрэйдийн Тоорил ханд зориулж гэрэлт хөшөөг энд, сууж байсан газарт нь заавал босгож мөнхлөх гэсэн юм. -Дайснаа мөнхлөх гэж үү… гэж Хасар эсэргүүцэв.

-Тоорил хан миний дайсан байсангүй. Би ч түүнийг алсангүй. Тэр Тэнгэртэй тэрсэлсэн тул

гэсгээлд нь унажээ.Тоорил хан хэнтэй дайсан болоод, хэрхэн юуны учир үхсэнийг хожим хойно бидний үр сад мэдэж санаж яваг гээд Тэмүжин яваад өгөв.

Хасар Тэмүжиний эл үгийг үнэн гэж дэмжсэнгүй ч бас худлаа гэж эсэргүүцсэнгүй. Ийм битүү далд үг хэлдэг нь Тэмүжиний гэм биш зан тул Хасар бас гайхсангүй. Харин Тэмүжиний үл ойлгогдох энэ занд түүний дийлдэшгүй хүч нуугдаж байх шиг анх удаа сэтгэгдэхэд хойноос нь удаан ширтэн зогсож билээ. Сарны гэрэлд Тэмүжиний бөгтийсхийн алхаж яваа нь үзэгдэнэ. Түүний урт хар сүүдэр Хасарын хөлд хүрч байсанд гэнэт сэжиглэн хөлөө хойш татжээ. Яагаад ч юм, тэр сүүдэр хөлд нь хүрэхдээ хүйтэн жавар шиг, бүр мөс шиг хайрчээ. Ийм хачирхалтай явдлыг Хасар өмнө нь ер үзсэнгүй.Хүний сүүдэр тийм хүйтэн байх юм гэж санасан ч үгүй. Гайхаж эргэлзсэндээ дахиж туршин үзье гэж бодсон ч Тэмүжин нэгэнт асарт орж үзэгдэхгүй болжээ.

Тоорилын хүрээнд хоригдон суух үед Борогчины гавшгай, сийрэг хөдөлсний ачаар Хасарын өрх гэр элэг бүтэн үлдэж, одоо Егү,Есөнхэй хөвүүд нь Алтан улсад эцгийн хамт дайтаж яваа билээ.

Энэ явдлыг дурсан санахгүй байхын аргагүй, дурсан санах бүр Борогчинг хүндэтгэн хайрлахгүй байхын аргагүй болдог юм. Тооноор тусах сарны гэрэл ширтэн нойроо хулжаасан Хасар ийн бодож хэвтэв.

Эрийнхээ өвөрт эм биеэ жаргааж гүн нойронд автсан Борогчиныг харвал их л аз жаргалтай үзэгдэх агаад тэр бүсгүй харц дорд гаралтай ч ер Тэнгэрийн ивээлд багтсан гэмээр жаргах гавьяатай эм авай.

*****

Хуаржин Хасарыг ирэхэд гэрээс ч үл цухуйн хачин загнасан хийгээд Борогчин ямар нэг зүйл хэлж ядан нуугаад бөйсны учир маргааш нь тайлагдав. Тэр эм Хасарын эзгүйд хөндлөнгийн эрээс бие давхар болсон байв. Үүнийг мэдмэгц Борогчин түүнийг хөл хорьж бусдын нүднээс далдалсан нь Хасарын нэр нүүрийг бодсон хэрэг юм. Гэвч Хасар Хуаржинд гүнзгий хайраар ханддагийг мэдэх тул чухам юу гэж хэлэх учраа ололгүй өнжсөн билээ. Харин Борогчин адилхан эм заяанд төрсний хувьд Хуаржиныг өрөвдөн ойлгож байв.

Хуаржин Хасарт ирэхдээ ямар их зовлон амссаныг Борогчин мэдэх тул түүнийг туйлаас хайрлан өрөвддөг ажээ.Бие давхар Хуаржин хар цагаан дуугүй гөлрөн хэвтэхээс цаашгүй, сайн муу нэг ч үг эс хэлнэ. Харин хэнээс хүүхэд олсныг таах гэж,олох гэж Борогчин ойр хавийн орж гардаг агтчин, тэрэгчин,торгон цэрэг,худалдаачин наймаачин гээд эр сүвтэй бүгдийг сэм байцааж үзэв. Хасарын өндөр нэр хүнд, өргөн их алдраас айлгүй, хайртай хатны нь сэтгэлийг урвуулах тийм зүрхтэн хүрээ хотонд нь байсан гэхэд үнэмшимгүй. Хуаржин аваль эрийнхээ дайнд мордсон эзгүй хойгуур завхайран бие шалтагтай болсон нь Борогчинтой ч холбоотой бөгөөд, их эхнэрийн хувиар түүнийг хатуу чангаар харгалзаж чадаагүйдээ тэр их л гэмшжээ.

Уг нь Борогчин Хасарыг ийм гэнэтхэн ирнэ чинээ санаагүй билээ. Уг нь Хуаржинг амаржсан даруйд хүүхдийг нь төөрүүлж орхихоор шийдсэн байжээ. Гэтэл түүнд ийм боломж

олдсонгүй. Алтан улсад одоод хоёр жил болсон эр нөхөр нь гэв гэнэтхэн хүрээд ирсэн нь хөөрхий Хуаржинг Хасарын гарт сул орхихоос өөр аргагүйд хүргэв.

Хасарыг Хуаржины гэр лүү орохоор явахад Борогчин яаж ч чадахгүй дэмий л сандран хоцров. Лав сайн юм болохгүй нь тодорхой. “Хасар Хуаржинг багалзуурдан алах биз. Одоо яая гэх вэ. Хормойгоо бэхлэж чадаагүй завхай эм хохь нь” гэж бодсон ч түүнийг өрөвдөн түгшсээр аварч өршөөхийг гуйн Тэнгэрт мөргөжээ.

Гэтэл Хасарыг орсноос хойш Хуаржины гэрээс орилж хашгирах нь бүү хэл, ор дэр хөдлөх чимээ ч сонсодсонгүй хэсэг зуур таг чиг болов. Тэгснээ унь хана шажигнах шиг болсноо чимээ тасарсан тул Борогчин сэтгэл жаахан онгойв. Хасар нэгэнт л Хуаржинг үзүүт дүрсхийн хилэгнээгүй бол гайгүй гэсэн үг юм. Борогчин олон жил ханилсан эрийнхээ занг мэдэх билээ.

Бодвол их гэдэстэй эмээ хараад хэлэх үгээ олоогүй биз хэмээн таамаглажээ. Хайртай эхнэр нь өөр эртэй нууцаар садарлан бүр бие давхар болсныг үзсэн эр хүн тэвчин тэсэхгүй нь лавтай. Хасар урьд нь ийм явдал болно гэж санаж байсангүйдээ үнэхээр цочин мэлэрчээ. Аварга биетэй Хасар унинаас зуурч, гэрийн хоймор нөмгөн зогсох хэтэрхий гоо үзэсгэлэнт Хуаржин хатнаа үзээд гөлрөв. Гэхдээ Хуаржины үзэсгэлэн гоог бахадсандаа биш, харин бүсгүйн хариугүй төрөх дөхсөн тулгар биетэйг үзээд ийн цочирджээ. Хэлэх үг тэр дороо олдсонгүй дэмий л ам нь ангалзана.

Голыг нь халуун галаар зурах шиг гомдол, гуниг өгсөж, яагаад ч юм бэ өвдөг нь шархиран өвджээ. Өөрийн эрхгүй хөл нь нугаран сөхөрч суумаар болсонд Хасар гэрийн унинаас зуурч зогсов. Гэрийн унь хана шажигнан доод бүслүүр нь тас үсрээд нурж унах нь уу гэмээр болсон ч ашгүй тогтов. Харин Хуаржин сэтгэл тайван зориг төгс байв. Учир нь хэвлийд нь олдож бие сэтгэлтэй нь хамт бүрэлдээд одоо нэгэнт хөдөлж эхэлсэн энэ амьтанг түүнээс өөр хамгаалах хүн үгүй, бас хамгаалах ч ёстой гэдгээ хатуу ухамсарлан мэдэрсэн тул Хасарын эсрэг үхтэл тэмцэхээр шийдсэн байв. Хасарыг гэнэт ирснийг сонсоод эхлээд айж цочсон боловч хаашдаа зугатаах газаргүй тул хэлэх үгээ бэлдэж тайвширчээ.

Эцгийг нь хөнөөж, хайртай эхийг нь Тэмүжинд өгч алуулсан, хоёр охины нь эцэг энэ уул мэт биет догшин эр одоо нэгэнт түүний эр нөхөр биш, өст дайсан нь болжээ. Эцэг эхийгээ хөнөөсөн өст дайсны өвөрт хэвтэж түүний дур тачаалыг ханган бас үр хүүхдийг нь төрүүлж өсгөх хатуу хувь зохиол Хуаржинаас өөр хичнээн эм хүйстэнд заяасныг хэн ч мэдэхгүй билээ. Хасарт булаагдан ирж гэрт нь аваль эмийн ёсоор суухдаа түүнд дутаж гацсан зүйл үгүй ч төрөлх Татаар аймаг, цус нэгт удмынхан нь толгой дараалан хядуулан дуусахад сэтгэлийн гүнд бий болсон өшрөлөө тас нуухаас өөр аргагүйд хүрсэн билээ. Хуаржин Хасарт булаагдан ирсээр арван таван жил болж түүнд хоёр охин төрүүлэн өгчээ.

Хасар түүнийг бусдаас илүү хайрладгийг ч тэр сайн мэднэ. Хамаг биеийг нь эзэмдэн эдлэж дур ханаад бие алдарч бөх нойрсох Хасарын хоолойг нь хэрчин алах хүсэл шөнө дундын үед гэнэ гэнэ тэсэшгүй ихээр оргилдог ч өөрийн болоод түүний мах цусны тасархай болсон охидоо бодоод тэнэг хүслээ хүчээр хөөн зайлуулдаг байв.Ууган охиноо төрөөгүй байхад нэг бол Хасарыг хөнөөнө, эсвэл амиа егүүтгэнэ гэж боддог байжээ.

Гэвч үрээ үзээд Хуаржины өс хонзон дарагдан хувь заяагаа дагажээ. Алтан улстай мөчөөрхөн тэмцэлдсээр тэднийг айлгаж, хүчирхэг баянаараа гайхагдаж байсан Татаар аймаг Тэмүжин, Хасар нарын гарт хүйс тэмтрэгдэн мөхөхийг нүдээрээ үзсэн Хуаржин өөрийгөө татаар гэдгийг мартах шахаж байтал энэ явдал болсон билээ.

Монголын их цэрэг Алтан улсыг зориод жил шахаж байсан өнгөрсөн намрын найртай сайхан нэг өдөр Хуаржин охидын хамт Хэрлэний усанд умбаж, халуун торгон элсэн дээр хөлбөрөн зугаацаж байв. Намрын налгар халуунд ийн зугаацах нь ерийн хэрэг билээ. Хэрлэний эргийн бургас тэднийг түмний нүднээс хаах ажээ. Тэдэнд айх аюул, түгших зовлон байсангүй тул охид нь бургасанд мойл түүж бараагүй болсон ч тэдний хашгирах инээлдэх сонсдоод Хуаржин халуун торгон элсэн дээр нойтон биеэр хөлбөрч сэтгэл тайван зүүрмэглэжээ.

Тэр гэнэт зүүдлэх шиг болов. Өмнө нь элсэн дээр урт үс нь мөрөө давж, өгөршсөн хувцаснаас нь өвдөг тохой нь цухуйсан залуу эр сөхрөн сууж байв. Бас тэр танихгүй эр

– Хуаржин гэж дуудаж байх ажээ. Хэдий хувирч өөрчлөгдсөн ч Хуаржин түүнийг танив. Энэ бол эхийн нь холын хамаатан Хорису нагацын ганц хөвүүн Эгэлдүр байлаа. Түүнийг яаж танихгүй байх билээ. Тэмүжиний толгойлсон аймшигт монголчууд довтлон ирэх хүртэл тэд нэгэн довонд тоглож нэгэн хөнжилд унтаж өссөн байв. Нас чацуу ч үеийнхэн дотроо өсгөлүүн биетэй нүд хөмсөг дүүрэн Эгэлдүр бол охид болгон дагаж, олон бүгд шохоорхсон хөвүүн юм.Хуаржин ч үеийн охидын элдэв ярианд автагдан Эгэлдүрт эр хүнийх нь хувьд сэтгэл алдарч байжээ.

Эгэлдүр Цахиа-Үгэ эцгийн нь бусад албатуудын адил Хасарт олзлогдон ирсэн билээ. Гэвч Тэмүжиний зарлигаар хийсэн их хядлагын үеэр хүүрэн дунд цусанд хутгалдан амьгүй мэт хэвтсээр амьд үлдсэн Эгэлдүр Цахиа-Үгэгийн мянган албат балчир хүүхдээс бусад нь хэрхэн амь эрсдэн үхэхийг үзэж өнгөрөөжээ.Түүний эх эцэг, ах дүү нараас хэн ч амьд үлдсэнгүй.

Архинд халамцсан цэрэг цээжий нь нэвт хутгалав хэмээн андуурч орхиогүй бол Эгэлдүр өдийд бас л өвс ургамалд хувиран элс шороонд шингэх байсан биз. Гэвч тэр амьд үлдэв. Уул хадаар хэрэн тэнэж, жимс ургамал түүж хооллон зэрлэг араатан шиг хэдэн жилийг үзэв. Гэвч ганцаар амьдрах хэцүү тул дайн дажин намжиж татаарыг мартагнах үеэр уулнаасаа бууж нутгийн сайн санаат айлд зарагдан суусаар өдий хүрчээ.

Гэвч тэр Цахиа -Үгэ эзний нь охин Хуаржинг Тэмүжиний дүү Хасар гэгч баатар эр авсныг мэдэх тул эрсээр амь алдахаас ч айлгүй хүрч ирсэн нь энэ байв. Тэдний уулзалт баяртай гэхээс илүү түгшүүр аймшгаар дүүрэн байлаа. Гэвч Хуаржин ч, Эгэлдүр ч хагацаж салахыг хүссэнгүй. Тэр шөнө Хуаржин, Эгэлдүрийг хүний нүд хариулан гэртээ оруулж угааж цэвэрлэж,хувцаслаж хооллон хууч хөөрч хоножээ.

Хасарын хүрээнд ингэж зүрх зоригтой загнах нь яг үхэлтэй адил хэрэг байсан боловч тэд айсангүй. Тэд зуны энэ шөнө төрөл арилжиж хоёр дахиа төрөв.Татааруудыг хүйс тэмтэрсэн аллагаас азаар амьд үлдээд дахин ийнхүү учирсан нь тэдний үйлийн үр байв.Хуаржин Эгэлдүр хоёр үйлийн үрээ дагаж дахин сэтгэл цэвэршин төрөл арилжиж шинээр төрөхдөө хуучин дүрээр татаар хүн болон хувирсан билээ. Сөнөсөн татаарын үр удмыг сэргээх, орчлонд татаар хүн дахин төрүүлэх далдын их хүслэн тэр хоёрыг учруулсан гэдэгт тэд итгэжээ.

Домогт гардаг шиг Хуаржин, Эгэлдүр хоёроос татаар аймаг дахин төрнө гэж бодоход солиормоор бахархалтай санагдах бүлгээ. Тэдний хүсэл мөрөөдөл, хайр сэтгэл,шунал тачаалд хязгаар байсангүй.

Хасартай арван хэдэн жил хамт амьдарч хоёр охин төрүүлэхдээ Хуаржин хэзээ ч ийм их дур тачаалтай,цадаж ханахгүйгээр өдөржин шөнөжин янаглаж үзсэнгүй билээ. Тэр Эгүлдүртэй учирснаар эм хүний хувьд анх удаа дур хүсэл ханан жаргахдаа учиргүй ихээр эхэр татан уйлжээ. Гэвч энэ нулимс гомдол баярын алин болохыг Хуаржин мэдсэнгүй. Харин аз жаргалтай мэт өдрүүд удаан үргэлжилсэнгүй. Хуаржины гэрт хэн орж хэн гарах нь түмний нүдэнд ил, бас Хасарын хүрээний харуул, хамгаалалт чанга бөгөөд хэдий хичээсэн ч нэг шөнө Эгэлдүр буцаж ирсэнгүй.

Харин түүнийг харуулын цэрэг харваж алаад огт танихгүй хүн тул жалганд хаяж орхисныг Хуаржин мэдсэнгүй.Эгэлдүр Хуаржинг эрж олж уулзсан нь өөрөө үхэл рүүгээ зорьж очсон хэрэг байжээ.Ингээд татаар залуу Эгэлдүр үгүй болж оронд нь Хуаржины хэвлийд цэвэр татаар цусны шинэ хүн бойжиж байв. Хуаржин хүн болсоор анх удаа тэр шинэ олсон үрээ амь шигээ хайрлах сэтгэлтэй болжээ. Хасарын охидыг хэзээ ч ингэж хайрлаж байсангүй. Шинэ үр нь хөвүүн байх ёстой гэж тэр бат итгэж байв.Тийм ч учраас хөвүүн нь Татаар аймгийн сэргэн мандах эх үндэс болно гэж бодохоос нэн бахархалтай байв.

Хуаржин энэ бодолдоо хөтлөгдөн өдөр тутмын жирийн амьдралаас тасран өнгө өнгийн мөрөөдлийн ертөнцөд очих ажээ. Одоо Хуаржин өөрийгөө шинээр үүсэх Татаар аймгийн эх боллоо гэж бат итгэв. Хэрэв Борогчин учрыг эрт гадарлаж Хуаржинг гэрт хориогүй бол тэр Эгэлдүрийг эрж хаашаа ч хамаагүй одоход бэлэн байсан билээ. Сэтгэлийн дотор ийм гүн өөрчлөлт орсон тул Хуаржин Хасараас огтхон ч айж эмээсэнгүй, харин ч үрээ харамлан эсэргүүцэн тэмцэх зориг дүүрэн хүлээж байжээ. Хойморт, ташаа тулан гэдсээ цондойлгон гайхуулах мэт дүрлийн зогсох Хуаржиныг үзээд Хасар түүний гал мэт дүрэлзэх гэрэл нэвт цацарсан харцнаас цочив. Хуаржины харц өөрчлөгдөж нэг л эрүүл бус болжээ.

Хийсэн хэргээсээ эмээж айхдаа Хуаржины сэтгэл үймрэн солиорчээ гэж Хасар тэрхэн зуур бодов. Тийм учраас Хуаржинг цочоож бухимдуулахгүй тайван байлгах нь зөв байсан тул Хасар таг дуугүй хэсэг болов.Бас даруй хэлчих үг санаанд орохгүй мухарджээ.Хэсэг хугацаа өнгөрч Хасарыг үзээд цочирдсон Хуаржины түгшүүр алгуур дарагдаж хоймор сөхрөн суув.Хасарыг орсны хойно сэтгэл түгшин гэрийн ойр чагнаж зогссон Борогчинг гайхшируулсан нам гүм ингэж үүсчээ.

Хасар хэдийгээр омголон цочмог зантай ч гэсэн нэг өрөвдөн хайрлах юм бол хэнд ч баймгүй уяхан зөөлөн сэтгэлтэй тул одоо Хуаржинг өршөөв гэж Борогчин итгэхийг хүсч байлаа. Гэтэл гэрийн дотор сэжигтэй нам гүм хэвээр.

- Хуаржин. Хасарын ийн аяархан дуудахад Хуаржин хүүхдээ булаагдахаас айсан мэт хоёр гараар гэдсээ тэврэн үсрэн босов.Харц нь нэг газарт тогтохгүй гүйж амьсгаа нь давхцан халуурсан мэт чичрэв.Тэр үнэхээр эрүүл биш болжээ…

-Хуаржин. Чи надаас бүү ай. Би чамайг яах ч үгүй гэж Хасар түүнийг тайвшруулан аргадангүй шивнээд гараа сунган урагш алхав.

- Би чамаас айхгүй ээ. Айхгүй… Айгаа ч үгүй… гэж Хуаржин Хасараас харц дальдчин шивнэв. Айснаасаа болж тэр солиорох шиг болов. Хасар түүний дууг таньсангүй. Урьдын ялдам энхрий хоолой сонсогдсонгүй.

-Хуаржин. Чи надад юу хэлнэ… Чи намайг яажшуухан хүлээж суув даа гэж Хасар өнөөх л аргадангуй аясаар шивнээд алгуур ойртон яг л омголон догшин агт чөдөрлөх гэж байгаа хүн шиг Хуаржины дэргэд мяраасаар очив. Хасарын энэ үгэнд Хуаржин дахин цочсонгүй. Харин ямар нэгэн нууц зүйл хэлэх гэсэн мэт хуруугаа уруулдаа хүргэв.

-Хасар чи… Тэмүжин ахтайгаа хамт манай Татаар аймгийг сөнөөсөн. Харин би татааруудыг дахин төрүүлэх гэж байна гэж Хуаржин хэн нэгнээс нуух шиг шивнэв.Ингэж хэлээд Хуаржин Хасарын өөдөөс гэнэт эгц ширтжээ. Хуаржины тэр солиотой харцыг үзмэгц Хасарын нуруу хотосхийн цочиж бие нь арзайгаад өөрийн эрхгүй

-Юу гэнэ ээ. Чи татаарыг төрүүлнэ гэнэ ээ… гэж дуу алдав. Энэ удаад Хасар биеэ барьж эс чадаад уур нь дүрсхийн асч үсрэн холдов.

-Чи татаарыг төрүүлнэ ээ… Наад зулбасгын чинь эцэг татаар юм уу гэж уурсан хашгирах Хасарын дуунаас Хуаржин огтхон ч айж цочсонгүй.

-Тийм ээ. Би татаар хөвүүн төрүүлнэ. Тэгээд Татаар аймаг дахин сэргэнэ. Чи татаарыг хядсан. Харин би дахин төрүүлнэ. Би чамд энэ хүүхдийг өгөхгүй. Энэ бол чиний хүүхэд биш. Чи хоёр охиноо ав. Би энэ татаар хөвүүнээ авна.Тэгээд би алс хол газар очно.Намайг хаана очсоныг чи ч, чиний ах Тэмүжин ч мэдэхгүй.Миний төрүүлсэн татаарууд удахгүй өсөж үржиж олон болно.Тэр цагт би хүүхдүүдээ дагуулан ирж татаар аймгийнхаа, эх эцгийнхээ өшөөг би чамаас, Тэмүжинээс ч авна гэж Хуаржин Хасарын нүүрэнд нүүрээ тулгаж байгаад гэнэт зэрлэг догшноор хашгирчээ.

Хасар нэг мэдэхэд Хуаржинг алгадан унагасан байв.Гэтэл Хуаржин цус нь урсавч дуугүй болсонгүй улам чангаар бархирсаар байв.

-Чи миний татаар хүүг авч чадахгүй. Чадахгүй. Энэ бол минийх. Татаар хүүхэд гэж нэгэнт ухаан солиорсон Хуаржин хүрээ даяар бүх хүнд сонсогдтол хашгирсаар байхад нь Хасар түүнийг багалзуурдан авлаа. Сая л нэг Хуаржины дуу гарахгүй болов. Хасарын хүчирхэг гарт зовлонт татаар бүсгүйн амь тасарч байв. Хасар Хуаржинд хэдий их хайртай ч ийм доромжлолыг яахин тэвчих билээ. Өрөвдөж хайрлах сэтгэлээр Хуаржинг амьд үлдээн авсан нь эцэст ийм тамлалд унагана гэж санасангүй. Хуаржины гэрэлт бор царай өнгөгүй цагаан болж, харц нь гөлийсөн ч тавласан, бахархсан мэт үзэгдэнэ. Гэнэт Хасар цочин айж бүр хашгиран босч харайлаа. Хуаржины алцайсан хөлний хооронд нэг юм хөдлөв.

Хасар амьдралдаа анх удаа үсээ босч, үнхэлцгээ хагартал айв. Эхийнхээ бачимдан амь тасрах үед хүүхэд нь төржээ. Ус цусанд хутгалдсан тэр нялзрай амьтан уйлах ч үгүй арвалзаж байсан нь яг л чөтгөр шулам шиг үзэгдсэнд Хасар ухаангүй гарч гүйлээ. Түгшсэн Борогчин ойр хүлээж байв. Хасар юу ч хэлж чадсангүй амаа ангалзуулан гэр лүү заана. Юу болсныг Борогчин ойлгомогц гүйн оров. Удсан бол хүүхэд нь бүтэж үхэх байжээ. Борогчин шалавлан ам чихрүү нь үлээсэнд хүүхэд уйлж эхлэв. Хасар хүүхдийн уйлах дууг сонсмогц мориндоо

мордоод Хэрлэний зүг зугатаан давхихад амь хамгаалагч үнэнч цэргүүд нь түүнийг дагажээ. Хэдхэн хормын дотор болж өнгөрсөн бүхэн яг л зүүд шиг ажээ. Хасар сэтгэлээ тайтгаруулах гэж Хэрлэний долгионыг ширтэн өдөржин суув. Хэн ч зориглон түүний дэргэд ирж саад болсонгүй.

Хасар юу ч шийдэж, бас ойлгож чадахгүй байв. Ингэх ч хэрэг байсангүй. Ганцхан тод зүйл нь тэр хүн алчихаад анх удаа харамссан явдал юм. .” Чи юунд Хуаржинг алав” гэж гашуудан бодсоор ажээ. Хайртай Хуаржингаа өөрийн гараар багалзуурдан ална гэж яаж санах билээ. Гэвч бүх юм болдог жамаараа болж өнгөрсөн хойно яав ч харамсаж гашуудсан дүр үзүүлэх ёсгүйг Хасар ойлгож байв.Тийм болохоор хатуужин гэртээ буцах хэрэгтэй. Нэгэнт самуурч өөр хүний хүүхэд тээсэн эм үхэхээс өөр яах билээ. Хасар эцэст нь өөрийгөө зөвтгөж чадав. Хуаржинг шударга ёсоор үхүүлжээ. Харин шинэ төрсөн тэр хүүхдийг ч алах нь зөв гэж шийдэв. Ер нь Хуаржинг бүгд жигшин зэвүүцэж,бас энэ татаар бүсгүй Хасарын амьдралд байгаагүй мэт мартагдах ёстой болжээ. Харин охидыг нь Борогчин өсгөнө биз. Би ер нь сэтгэлээ тайтгаруулж дахин зүс гоо эхнэр буулгах нь зөв гэж бодсоор харив. Хасарыг бүх хүрээ даяар ер юу ч болоогүй мэт угтав. Харин Хуаржины гэрийг, шарилын хамт хүрээний гадна гаргажээ. Энэ нь Борогчины хийсэн ажил тул Хасар огтхон ч шүүмжилсэнгүй.

-Гэртэй нь шатааж орхи гэснээс өөр үг Хасар хэлсэнгүй Түмүхэйн гэрт очжээ. Ингэхдээ бас “Хүүхдийг нь цуг шатаа” гэхээ ч мартсангүй.

Хасар Хуаржинг алсандаа ялаа алсны дайтай сэтгэл өвдөөгүй мэт дүр эсгэж байсан ч залуу хатан Түмүхэй нь хэрхэн дур тачаалдаа автаж бие сэтгэл нь тавирсныг ч анзаарах сөхөөгүй дотроо шаналж байжээ. Харин Борогчин бүгдийг Хасарын хэлсний дагуу хийж Хуаржины гэрийг шатаалгасан нь тэр шөнөжингөө,бас маргааш өдөржингөө, Хасарыг Өүлэн эх рүүгээ яван явтал хар утаа баагиж, хярвас хиншүү үнэртээд хавь ойр хүн тогтохын аргагүй болж, Хасар зугатаах мэт мордон явжээ. Түүний ард Хуаржин утаа, хиншүү болон хувирч байв. Харин Борогчин Хуаржины татаар хөвгүүнийг хэнд ч хэлэлгүй авч үлджээ.

Энэ тухай Хасар хэзээ ч мэдэхгүй биз.Өүлэн эх татаарын нутгаас олсон Шихихутагийг хэрхэн сайтар засаж хүмүүжүүлэн өсгөсний адил Борогчин Хуаржины үрийг өөрийн хөвүүн болгон өсгөхийг хүсчээ. Түүнийгээ хэнд ч хэлсэнгүй.Хуаржин үрээ хөвүүн гэдгийг мэдэж байжээ. Сэтгэлд нь гэнэт хүчтэй төрөх харуусал гунигийг Хасар хүчээр хөөн зайлуулсаар эхдээ очив. Энэ өдөр Өүлэн эхийн царай зүс гэрэлтэй, тэнхлүүн ер үхэх хүний янзгүйд Хасар баясаж даруй Алтан улс руу буцахаар шийдэв.

Ер нь энд нэг ч хоног тэсч суухад хэцүү байжээ. Өүлэн эх нь бүр босч суух бөгөөд үг яриа тод, инээж хөхрөөд зугаатай байх нь сэтгэл сэргээнэ. Хасарын зангирсан хөмсөг, бодолд дарагдсан царайнаас ямар нэг юм болсныг Өүлэн эх түвэггүй таажээ. Сэтгэлийн гүн дэх гуниг шаналалаа Хасар яаж эхээсээ нууж чадах билээ.

- Юу болов. Гэр хүрээнд чинь золгүй явдал болов уу гэж Өүлэн эх яг тааварлан асуусан нь Хасарыг шаналгав.Гашуудал зовлон, харуусал гэмшил нь нүүр царайд нь нуух аргагүй тодорхой байгаа ажээ.Өүлэн эх нь юу болсныг дуулахаас нааш санаа сэтгэл нь амрахгүй нь мэдээж. Уг нь тэр эхийнхээ сэтгэлийг зовоогоод яах вэ гэж бодож иржээ. Одоо гэтэл нуух аргагүй болов.

- Би өчигдөр Хуаржинг өөрийн гараар хороолоо. Тэр миний эзгүйд бие давхар болжээ гэж Хасар сэтгэлээ хөндүүрлүүлэн байж шивнэхдээ гол нь тасрах мэт харуусан шархирахыг мэдрэв. Харин Өүлэн ийм юманд гайхаж цочих нь нэгэнт үгүй болжээ.

-Чи юунд Хуаржинг орхиж явав. Алтан улсад авч явсангүй нь чиний буруу биш үү.Тэр бүсгүйг дэмий алжээ. Хуаржин гэмтэй ч охидын чинь эх биш үү гэж Өүлэн санаандгүйгээр Хасарыг зэмлэв. Хасар таг дуугүй доош гөлрөн суув.

-Эр нь хэн юм бэ…

-Нуугдаж үлдсэн татаар гэнэ. Манай цэргүүд түүнийг алчихаж.

- Дэмий юм хийж, охидоо өнчрүүлээд яана чи…

-Охид яах вэ.Би тэднийг хүнд өгч орхино. Эм хүн нутаггүй гэдэг биз…

Хасар ингэж эхийнхээ зэмлэлд хайш яйш үл тоомсорлосон үг хэлэвч сэтгэл нь өвдсөөр байв.

-Хүүхэд нь яав. Хөвүүн үү, охин уу.

-Хэн мэдлээ. Эхтэй нь цуг шатааж орхисон…

-Хөвүүн бол өсгөж авахгүй яав даа. Чи юун гэнэн хөдлөнө. Надад хэлсэн бол би Борогчинд өгч өсгүүлэхгүй юу.

Чамд биш гэхэд Егү, Есөнхэй хөвүүдэд чинь хэрэг болно. Миний өсгөсөн хөвүүдийг хар. Шихихутаг, Хүчү, Хөхөчү, Борохул дөрөв Тэмүжин та нарт ямар их тус өгөв. Та нарт үнэнч нөхөд л хэрэгтэй болохоос уйгар уу татаар уу юуны ялгаа. Ухаангүй гэдэг нь.Хүнд хүн хэрэгтэй.

-Тэд Тэмүжинд л тустай юу гэхээс би тэднээр ямар хоолоо зөөлгөж, хөлөө хучуулах уу гэж Хасар Өүлэн эхийн өргөмөл хөвүүдийн тухай ярихаас илт цааргалан унтууцав.

Угаас Тэмүжин Өүлэн эхийн өсгөсөн хуурай хөвүүдийг өөрөөс нь илт илүү үздэгт Хасар дургүй билээ.

Гэвч Тэмүжиний ингэж үздэг нь ганц түүний хүсэл зориг биш юм.Өөрийн өргөмөл хөвүүдээ Өүлэн эх үнэхээр гарамгай хүмүүжүүлсэн нь тэднийг ингэж хүндэтгэхэд хүргэдэг билээ.

Татаарын Шихихутаг, жүрхэний Борохул,тайчуудын Хөхөчү,мэргэдийн Хүчү дөрвөн хөвүүнийг Өүлэн нялх балчираас нь олж өвөртөө хийж өвдгөө түшүүлж өсгөн хүмүүжүүлсэн нь Чингис хааны дөрвөн их баатар сайд болсон билээ.

-Би даруй буцна. Ээж таныг үзэж тайтгарлаа. Би ч таныг эргэх биш, Хуаржинг алах гэж иржээ. Ирсэн нь сайн боллоо. Сүүлчийн татаарыг би хороох ёстой байсан бололтой гэж Хасар хүчээр инээв.

-Хөвүүн минь. Чиний явах зөв. Уг нь би та нарын нүднээс далд үхье гэж бодсон юм. Гэтэл Бөртэ дэмий юм хийж, чиний албыг алдуулав. Эхийгээ үхмэгц явж үз. Нэгэнт ирснийх чи намайг газарт авслаад булж орхиод яв. Аягүй бол эд бунхан овоо босгож бултыг бужигнуулах биз. Би олон хүн үймж, үнэн худал уйлж дуулахыг үзэж сүнсээ зовоохгүйг хүснэ. Чи намайг үхмэгц хүнд хэлэлгүй, хэнд ч үзүүлэлгүй мориндоо дүүрч яваад Бурхан Халдуны баруун суганд нэг тэмдэгт газар бий, тэнд булж орхиорой. Дэлгэр булгийн тархинд очмогц үзнэ биз…

Тэр газрыг ах дүү хоёроосоо өөр хүнд бүү хэл. Эхийнхээ энэ үгийг сонсоод Хасарын инээд хүрэв. Эсэргүүцэж, бас элэглэж болохгүй энэ үгсийг Хасар бараг л чихний хажуугаар өнгөрүүлж суув.

-Миний үхсэнийг хүн мэдэхгүй бол бүгд л амьд мэт санах биш үү. Их ёслол болж олон амьтан цугларвал үлдэж байгаа та нарт сайхан болохоос тармагц мартах тул надад хэрэг юун. Чи эхийгээ олон хүн сайнаар дурсаасай гэж хүсч байгаа бол миний үхсэнийг өрхийн доторх цөөн хүнээс бусдад бүү мэдэгд. -За… гэхээс өөр үг Хасарт олдсонгүй.

Үхэх гэдэг мордоод явах адил амархан мэт үгсийг эх нь хэлэх ажээ.

-Надаас хойш Тэмүжин ахынхаа үгийг миний үг гэж сонсож мөрдөж яв. Ах чинь одоо алдар нь түгсэн хаан боллоо. Чингис хааны үг бол Тэнгэрийн зарлиг .Ах чинь хийж хэлэх нь хэцүү бэрх ч гэлээ сэтгэлийн мухарт дүү нартаа хайртай юм шүү. Энэ үгийг Алтан улсад морилохдоо надад яг одоо чиний сууж буй шиг сууж байгаад аминчилж хэлсэн юм. Хасар хөвүүн минь чи хичээ. Ахынхаа зарлигийг бүү зөрч. Ёсчлон дагагтүн. Хөвүүддээ ч захь. Есүхэйн хөвүүдээс хаан болох нь болж хавсарч хүчээ өргөх нь өргөх ёстой юм.

Чингис хааны их хүч,эзэнт улсын талыг Хасар дүү биеэрээ бүтээж, сэтгэлээрээ дүүргэв гэсэн нь Чингис хаан хэлсэн үг шүү.

Ийм үгнээс илүү гавьяа шагнал, алдар хүнд гэж хаана байна.Чингис хаан Хасар чамаас өөр хэнийг ингэж үнэлэн магтах билээ. Би Чингис хааны чамд хэл гэснийг дамжуулав. Амь чинь ахын чинь гарт бий шүү. Хөвүүн минь. Хасар минь. Бүү осолд. Олон үг хэлсэндээ Өүлэн ядарч орондоо буцаж хэвтэв. Өүлэн эхийн сая хэлсэн үг үнэн тул Хасар хүндэтгэн сонсчээ.

Гэвч тэр энэ үгсийг Тэмүжин хэлээгүй, эх нь хөвүүдээ эвтэй байлгах гэсэндээ зориуд зохион хэлснийг мэдсэнгүй билээ. Өүлэнд үүнээс өөр арга үгүй байлаа.Тэр эцсийн аргаа хэрэглэв. Эцсийн үгээ ч хэлэв. Хайртай Хасар хөвүүнийхээ амийг өөрт нь, бас Тэмүжинд даатган орхихоос өөр арга Өүлэнд үлдсэнгүй. Үхэл одоо яг гэрийн тоононы цамхаг дээр ирээд цагаа хүлээн сууж байв. Цагаа тулахаар үхэх гэдэг аятай таатай жаргал биш ч гэлээ айж сүрдэж аргаа бараад байхаар зовлон ч бас биш ажээ.

-Алив ээж нь үнсье. Чамайг ах, дүү хоёрын чинь өмнөөс ч үнсье. Бас Тэмүлэн охиныхоо өмнөөс үнсье гээд мойнийж тохийсон гараа эх нь сунгав.Хасар одоо ч эхийгээ тоглож байх шиг санасаар байлаа.

Сүүний танил үнэртэй эх нь духан дээр нь хүүхдийнхээ тоогоор таван удаа үнэрлэн үнсэхэд

Хасарын дотор цээж урагдан халуун нулимс нь урсав.

-Бүү уйл. Хасар чи хүүхэд байхын нулимс хурдантайсан. Одоо тавь шахаж эр болсон ч хэвээр шив дээ гэж эх нь ихэд голжээ. -Одоо явж үз. Одоо Тулуйн хөвүүн Хубилайг дууд. Тэр золигт хэлэх үг байна. Намайг үхмэгц хэнд ч бүү мэдэгд гэж Бөртэд хэл. Тэгээд миний хэлснээр хийнэ шүү. Би чамайг Тэнгэрээс харж байна. Миний хэлснээр эс хийвэл би уурлаж дахин эргэж төрөхгүй одно шүү. Чи яг ёсоор хийвэл би гуч хөвүүн Хубилайд хүү болж төрөх юм шүү. Чи хичээгээрэй… -За… Эхийгээ үхнэ чинээ санаагүй Хасар эргэж ч харсангүй гарч явахад Өүлэн

-Нялх юм даа гэж өрөвдөн бодож хэвтэв. Тэр гэр дотрохоо тойруулан харав.

Далан жил хэрэглэж эдэлсэн гэр бараа хувцас тавилга нь одоо Өүлэнд огт танигдахгүй, хүнийх мэт харагдав.Өүлэний сүнс удахгүй биеэс ангижирч эхлэхийн дохио энэ юм. Одоо түүнд хоргодох юмгүй болжээ. Хүсч байснаар Хасар дүүгээ явуулсан Тэмүжин хөвүүндээ бас дахиад баярлах ёстой юм. Үнэхээр тэнгэр шиг ухаантай хөвүүн төрүүлсэндээ Өүлэн бахархаж байлаа.

Тэмүжин хөвүүн нь хаадын хаан болжээ.

Одоо Өүлэнд үхэх л үлдэв. Хасарт ч санаа нь зовсонгүй “Чингис хаан юу гэж соёрхоно түүгээр л болох биз. Өүлэн би ч Чингис хааны зарлигийг дагах ёстой билээ” гэж бодоход сэтгэл цэлмэн гийжээ. Үлдэж буй хүмүүс хагацаж буй ертөнц бүгдээр Чингис хааны зарлигийн дор орших ёстойг үхэхийн өмнөх их гэгээрэл Өүлэнд мэдрүүлжээ.

Удалгүй гэрэл цацарсан харцтай Хубилай гүйн орж ирэв. Хубилай бол Өүлэний хамгийн хайртай гуч хөвүүн юм. Дөрвөн настай Хубилай хүү хожим Чингис хаан өвгөөсөө илүү алдар цуутай их хаан болно гэдгийг Өүлэн совингоороо мэдэрдэг байв. Тийм ч учраас хожим Хубилайд хөвүүн болон төрж хойд насандаа их хаан суух хүсэл Өүлэнд байсан билээ.

-Нааш ир миний хүү… Өндөр эмгийн дэрэн доогуураасаа гаргаж үзүүлсэн тоглоом их сонин ажээ.

- Өндөр эмэг нь өөх идмээр болоод залгиж чаддаггүй. Эмгийнхээ хоолойд энэ өөхийг сайн чихээд өг гэж Өүлэн үе сүүл, мөлжсөн шагайт шаант гаргаж ирэв. Эмэг эхдээ өөх идүүлэх шиг сайхан үйл байхгүй гэдгийг балчир Хубилай сайн ойлгов. Тийм учраас өндөр эмгийнхээ хоолой руу үе сүүлийг чихэж араас нь шаант чөмгөөр гудчин бүр сайтар оруулж өгчээ. Эмэг нь эхлээд түүнийг дэмжин хамжиж байснаа өөхөө далд ормогц удалгүй унтаад өгөхөд хичнээн татаж дуудавч сэрсэнгүйд сая гарч гүйжээ.

- Би өндөр эмэгт өөх идүүлээд унтуулчихлаа гэж балчир Хубилай баясан хашгирсанд сая л Хасар учрыг олж гэрт орвол нэгэнт оройтжээ. Үе сүүлэнд хахаж үхсэн эх нь хүссэнээ хийсэн дүртэй амгалан нойрсчээ. Хасар уйлсан ч үгүй. Хашгирч хүн дуудсан ч үгүй. Ширдгэн дээр унасан шаантны ясыг авч өвөрт нь хийв. Тэгээд эхийнхээ хоёр гарыг засч элгэн дээр нь байрлуулаад дэргэд нь суугаад гашуунаар мэгшин уйлжээ.

Өүлэн эх нь ямар их тэвчээр зоригтой хүн байсныг Хасар сая л нэг үзэж мэдэх шиг болов.

Хамгийн хайртай ачийнхаа гарт хахаж үхдэг нь монголчуудад бүр Хүннү гүрний үеэс уламжилж ирсэн ёс юм. Хамгийн их буянтай хүнд л ингэж үхэх хувь тохиодог билээ. Өүлэн эх нь Хубилай хөвүүндээ хүү болон эргэж төрөхийн тулд амиа Хубилайн гарт өгчээ.Хасар ч гэсэн Өүлэн эхийгээ эргэн төрөөсэй гэж чин үнэнээсээ хүсч байв. Өүлэн эхийн үхсэнийг Бөртөөс өөр хэн ч мэдсэнгүй. Өүлэн эхийнхээ сүүлчийн их хүслийг биелүүлэхээр сүнс зайлж, цогцос нь хөрсөн хойно Хасар эхийн шарилыг дүүрч Бурхан Халдуныг зорьжээ. Тэр эхийнхээ хөрсөн цогцосыг элгэндээ тэврээд ингэж цор ганцаар нутаглуулна чинээ санаагүй билээ. Халуун цусаа хөртөл, хатан биеэ элтэл зүтгэсэн эхийнхээ сүүлчийн захиас зарлигийг зөрчиж, өөрийн дураар аашлах зориг хүсэл Хасарт байсангүй. Бөртэ ч үг хэлсэнгүй. Хүн төрлийг дахин олж Хубилайд хүү болон төрөх эхийн хүслийг хүндэтгэж байв. Бас эргэн төрөөсэй гэж хүсч байсан тул эхийнхээ сүүлчийн хүслийг яг өөрийнх нь хэлснээр гүйцэлдүүлэв.

Эхийн хэлсэн өнөөх газар хүртэл тэр маргааш нь өдөржин шөнөжин явж өглөө нар туссан хойно арайхийн барааг нь харжээ.Үнэхээр Бурхан Халдуны баруун суганы хойшоо харсан аманд дэлгэр устай булгийн тархинд тэмдэгт газар байх ажээ. Хэн нэгэн хүн булгийн усанд хаалт хийж ёроолыг хэсэг газар ил гаргасны тэнд нүх ухжээ. Мөнхийн нар тусдаггүй энэ амны булгийн усан доорх газар зуны цагт ч мөс адил хөлдүү ажээ.Турь муутай гараар арай ядан хонхойлсныг үзвэл эх нь ухсан биз ээ. Эхийнхээ санааг тэр ойлгов. Эх булгийн усан доорх мөнх хөлдүү нүхэнд үүрд хэвтэхээр шийдэж энэ газрыг сонгожээ. Эхийн шарилыг нүхэнд хийж булаад усны хаалтыг зайлуулахад булгийн ус газрыг бүрхэн хуучин голдиролоор дүүрэн урсаж, мөнхөд жирвэлзэх усны дор хэн ч үзэхгүй газарт Өүлэн эх нь шингэн алга болжээ. Булгийн усны дэргэд суугаад сая л нэг ичиж нэрэлхэх юмгүй хавийн уул модыг цуурайттал хэнгэнүүлэн уйлав.

Хасарын уйлах нь хад нурж хайлаас булгарахтай адил болоод хавийн амьтан гөрөөс бүгд үргэн зайлжээ.Хасар эхийгээ орхин явж чадахгүй шөнө болгов. Харин өглөө нь гал түлж цай буцалган дээжийг нь модон аягандаа хийж эхдээ өргөөд мордов. Өүлэн эхтэйгээ цайгаа хуваж уусан сүүлчийн тохиол энэ болов. Хасар сэтгэлийн дотрох хагацлын гунигаа дарж эргэж харахгүйгээр морио гуядан давхижээ. Эхийнхээ сүнсийг дагахаас тэр ингэж болгоомжилсон юм. Эс тэгвэл Өүлэн эхийн сүнс Хасарыг даган түүний очсон газар бүрт тэнүүчлэн зовох билээ. Эхийнхээ сүнсийг Тэнгэртээ түргэхэн шиг залраасай гэж Хасар хүсэх тул Бурхан халдун уулын бараа тасартал морины ам татахгүй давхив.

Өүлэний сүнс Хасарыг даган хэсэг ниссэнээ хүүгээ эргэж ч харсангүйд тайвшраад буцсаныг харин Хасар мэдсэнгүй.

Хасар ганц удаа эргэн харсан бол Өүлэний сүнс хүүгээ өрөвдөн үүрд газар дээр үлдэх байв. Ингэвэл хэн хэн нь амар тайван амьдралыг үзэхгүй билээ. Энэ учрыг монголчууд мэдэх тул үхэгсдийг нутаглуулаад буцахдаа үхээрийн газар руу эргэн хардаггүй бөгөөд ирсэн замаа буруулан явж хариад тэр өдөртөө буурь сэлгэн нүүх бөлгөө.

Ингэж дагасан сүнсийг төөрүүлж орхих тул харин төөрч будилсан сүнс аргаа бараад Тэнгэртээ эгнэгт одох ажээ. Тэнгэрт одсон үй түмэн сүнснүүд дундаас тун цөөхөнд нь аз

тохиож эргэж хүмүүн заяанд төрдөг билээ.Харин эргэж төрөх нь хүний хүсэл зоригийн хэрэг биш ганцхан Мөнх Тэнгэрийн соёрхол болохыг хэн ч үл мэднэ. Маргааш нь Хасар юу ч болоогүй мэт гэртээ буцаж очоод тэр шөнөдөө үүр хагаслан Алтан улсыг зорив

.Борогчин сурсан зангаар юу ч асуусангүй дуугүйхэн цацлаа өргөсөөр үдэв. Хасарыг явснаас хойш Бөртэ, Өүлэний гэрт яг хуучин тогтсон цагтаа хоол ундыг нь зөөж оруулж явахыг бүгд харсан билээ. Ингэж Өүлэн эх өөрийн хүслээр байгаа ч юм шиг, бас байхгүй ч юм шиг болжээ. Өүлэн эхийн үхсэн нь Хасарын сэтгэлийг дэмий хүлээснээс чөлөөлж тэр омголон зориг бадрангуй болсноо замд гармагцаа мэдэрлээ. Одоо түүнд Алтан улсын хот балгасыг эзлэн авах эцэсгүй их хүсэл оргилж шувуу мэт нисч явлаа. Тэр одоо арван хэд хоногийн өмнө энэ их замаар Хэрлэнг зорьсон Хасар биш болсон байв. Сүүлийн арав хоногийн дотор түүний үзсэн хоёр үхэл Хасарын сэтгэл, ухааныг бүрнээ өөрчлөн хувиргав. Морины давхил дунд бодол нь ундарч шинэ шинэ санаа, ухаарал хойно хойноосоо төрсөөр ажээ. Үүнээс өмнө Хасар зөвхөн өөрийн нэр төр, сайн сайхныг бодож явжээ. Гэтэл хүн юуны төлөө зүтгэж амьдарч үхдэгийг тэр үзэж мэдэв.

Өүлэн эх нь зөвхөн үр хүүхэд тэднийхээ төлөө эцсээ хүртэл бодсоор зүтгэсээр үхэв. Голоос хайртай Хуаржин хатан нь өөрийн хүслээр олсон татаар үрийнхээ төлөө түүний гарт амиа алдав. Ингэж Хасар өөрийнхөө хар биений нэр төр,өмсөх зүүх,өмчлөх эдлэхийн төлөө амьдрах биш, ард үлдэх Егү, Есөнхэй хөвүүдийнхээ төлөө амьсгаа хураатал, амиа тасартал зүтгэх учиртайг сая л нэг голдоо ортол ухаарч авчээ.

Ингэж бодоход түүнд Тэмүжиний их нэр сүр юу ч биш мэт санагдана.

Хэрэв Хасар дорой ядуу, дор суудалтай явбал хэн түүний хөвүүдийг хүн гэж үзнэ. Хэн тэдний үгийг тоож сонсож,тонгойж дээш суулгах вэ.Хасарыг үгүй болвол Тэмүжин болоод түүний үр сад Егү, Есөнхэй хоёр хөвүүнийг нь боол зарц мэт, босгоны шороо мэт үзэх нь ойлгогдов.

Тэр жил хэрэв Өүлэн эх нь амжиж ирээд уурлаж хилэгнэн ухаант үг хэлээгүй бол Хасар Тэмүжиний гарт үхэх байсан юм. Тэгэхэд Тэмүжиний харц ямар аймшигтай байсныг Хасар олон хоног мартаж чадаагүй билээ. Тэмүжин Бэгтэрийг алахдаа яг тэгэж хорсол дүүрэн ширтэж байжээ. Хасар тэр шөнө Түмүхэй хатныхаа өргөөнд хонож байхад энэ явдал болжээ. Тэмүжинг арай ч ингэж хартан дайсан шиг харанхуй шөнөөр гэтэн ирнэ чинээ санаагүйсэн. Энэ санаандгүй явдал Хасарт ухааран бодох, уужуу сэтгэх зав өгсөнгүй.Тэмүжин түүнийг хашраан залхаахаар биш алахаар ирсэн нь илт байв. Хасар учрыг олж хужрыг тунгаая гэж бодсон ч үгүй амиа амиар солих галзуу хүсэлд хормын дотор автжээ.

-Тэмүжин чи.Гар хоосон хүнийг алдаггүй билүү.Боорчи чи сэлмээ өг. Би үзэлцээд үхье. Та нар бүгдээрээ надтай тулалдагттүн. Тэгвэл би өөрийгөө тулалдаанд үхэв гэж тооцъё гэж Хасар газар доргитол бархирч арван хүнд дийлдэхгүй тал тал тийш авч шидэлж байжээ.Хасарын ингэж гомдол хорсол дүүрэн хашгирахыг сонсоод Тэмүжин арайхийн биеэ барьж зугатаачихалгүй шиг тэсч зогсжээ.

Хасарын ингэж галзууран хашгирч олон хүнтэй орилолдон ноцолдохыг сонирхож зогсоо мэт алмайрчээ. Хасарыг хүрээнээс нь сэм авч гарч чадсангүй төдөлгүй Хасарын албат цэргүүд бүчин иржээ. Тэд эзнээ хамгаалан дайран ороход бэлэн сэлмээ сугалан ирсэн ч Тэмүжинг

үзээд гайхан зог тусжээ .Яг энэ үед байдал Тэмүжинд аюултайгаар эргэлээ. Тэмүжинг Боорчи аравхан цэргийн хамт дагаж иржээ. Одоо Хасар ганц үг хэлэхэд л Тэмүжин амь алдах байв. Хасарын албат цэргүүд бүслэн ирсэн тул Боорчийн цэргүүд ч учраа олохоо байж алмайрчээ.

Ийм нам гүм удаан үргэлжлэх шиг болсон ч үнэндээ бол тэдний хөлөөр боссон тоос суунагласаар байжээ. Гэнэт алсаас хэн нэгэн “Тэмүжин”,”Тэмүжин” гэж хашгирах сонсдон агаарт үзэгдэж байсан үхлийн аюулыг саринууллаа. Энэ бол Өүлэн эх байв.

Өүлэн эхэд бүгд хүндлэл үзүүлэн зам тавьж, цагаан тэмээ хөллөсөн хөнгөн сүйх олны дунд давхин орж ирэв. Өүлэн эх энгэр задгай хөл нүцгэн үхээрээс айсан мэт хувхай цагаан царайтай амьтан сүйхнээс ухаангүй унажээ. Гэвч тэр ухаантай байжээ. Унасан дороо өндийж Тэмүжиний зүг мөлхөн очиход Тэмүжин сандран эхийгээ өргөн босгожээ.

Өүлэн эх юу ч хэлсэнгүй гөлрөн зогссоноо Тэмүжинг алгадаад авав. Настай хүнээс гарамгүй их хүчээр алгадсан тул Тэмүжин арай л уналгүй хөл дээрээ тогтов.

-Тэмүжин чи сонс.Урьд чи эцэг нэгтэй ах Бэгтэрийгээ алсан.Одоо чи эцэг нэгтэй эх цугтай дүүгээ хөнөөх чинь дутав уу гэж Өүлэн хашгираад энгэрээ ярж

-Хар чи.Та нарын хөхөж өссөн хөх энэ байна. Би чамд дутуу хөхүүлэв үү. Дундуур хооллов уу. Хасарыг би ихэд үзэж илүү хөхүүлэв үү. Та нарт алалдах дайсан дутав уу. Агаар тэнгэр багадав уу. Амьтны шившиг, амны зугаа биш үү. Халуун бүл дотроо хамт амьдарч чадахгүй чамайг хэн хаан гэнэ гэж нүүрийг нь улалзтал, нүдийг нь гөлөлзтөл хэлсэнд Тэмүжин таг дуугүй эргэн явжээ.

Харин Хасар тэр шөнөжингөө тайвширч чадсангүй тарчилжээ.

”Ах чинь чамайг яасан гэж алах билээ.Тэв тэнгэрийн хорт үгэнд автан ингэж түр зуур хилэгнэсэн биз.Хасар хөвүүн минь ахдаа муу юм бүү сана” гэж ухуулсаар байсанд Хасар өөрийн эрхгүй эхийн сайхан сэтгэлийг бодоод Тэмүжинд гомдож өс санахаа хүчээр больсон билээ.

Бас Тэв тэнгэрийг үхүүлсэн нь Тэмүжин үнэхээр түүнийг хөнөөх бодолгүй байсанд итгэхэд хүргэжээ.

Тэр үед эх нь аргаа барж ятган сэнхрүүлээгүй бол, Тэмүжин Тэв тэнгэрийг үхүүлээгүй бол Хасар амиа хамгаалан эсэргүүцэн босож цэрэглэн тулахаар шийдсэн байв.Тэмүжиний хүрээг довтлон сөнөөхөөр шийдэж үнэнч нөхдөө цуглуулан сэм бэлтгэж байтал бас л өнөөх Өүлэн эх нь зөнгөөрөө мэдээд хүрээд иржээ.

Эхийгээ яаж ч ятгасан одоо зорьсон санаснаас ухрахгүй гэж боджээ.Тэмүжинд өс санах шалтаг Хасарт мундахгүй олон байлаа.

Их монгол улсад мөхлийн аюул, үүрд үл тасрах цуст дайны хөнөөл ирснийг Өүлэн мэджээ.

Түүний төрүүлсэн хөвүүд нэгэнт алалдах нь тодорхой болж хэзээ ч үл тасрах өш хонзонгийн үр боловсорчээ. Өүлэн уйлж ятгасан ч Хасар түүний үгийг сонссонгүй.Харин Тэнгэрийн аврал болж Тэв тэнгэрийг үхүүлэв гэж Тэмүгэ ирж хэлсэн нь ашгүй Хасарыг тайвшруулжээ. Эхийгээ уйлахыг үзээд Хасар Тэмүжинг довтлохоо болихоор шийдээд байтал Тэмүгэ иржээ.

Ухаант Өүлэн эх нь Их монгол улсыг сүйрлээс аварсныг Хасар дотроо зөвшөөрч байсан ч харин одоо санахад эх нь ганцхан Тэмүжинг аварсан мэт санагдаад болсонгүй.Гэтэл Хасар хэн билээ. Адилхан л Есүхэйн хөвүүн биш үү. Хасарын ухаан санаа өөрчлөгдөж чөлөөлөгдөхийн хирээр улам л тодорсоор байгаа зоримог хортой бодлууд чухам түүнд юу авчирахыг тэр тааж мэдсэнгүй билээ. Эхийн сэтгэл, эцгийн их нэрийг бодож Тэмүжинд зөвхөн хавсарга болж явснаа тэр ойлгов. Одоо нэгэнт эх нь үгүй болсон тул тэр юунаас эмээж, хэнээс айх билээ.

Тэмүжиний итгэл өгч, их цэргийг удирдуулсан Боорчи, Сүбээдэй, Мухулай бүр Тэмүжиний идэр залуу хөвүүд Зүчи, Цагадай, Өгөдэй,Тулуй нараас Хасар юугаар дутаж, юунд гацах билээ. Энэ мэт зөрүүд бодол Цагаан хэрмийг давж, Чингис хааны хээрийн өргөөнд очих хүртэл салсангүй. Ер нь Хасар нэг юм санавал хэлж байж, хийж байж сая санаа нь амарч унтдаг зантай тул Тэмүжинд хэлэх үг хоолойд торж, хэлний үзүүрт бултализаж явлаа.Санаснаа дуустал хэлж, чаддагаа бүрдтэл хийе гэж хатуу шийдсэн байв.

Гэвч бүх зүйл дахиад л Хасарын санаснаар болсонгүй.

Эхийнээ үхлийн тухай сонсоод Тэмүжин тэгэж ихээр эмэгнэн гашуудна чинээ санаагүй тул Хасар хэрүүл уруулын үг хэлэхтэй манатай болжээ.

Хасарыг уяан дээр буугаад эргэхэд л Тэмүжин яг дутуу сүхдүүлсэн үхэр шиг болж үдшийн турш үг хэлж өндийж зогсож чадсангүй.Шөнө болж од түгтэл Тэмүжиний өргөөнд нам гүм байлаа.Гал ширтэн гөлөрч суух Тэмүжинг хараад Хасар ч юу ч хэлж чадсангүй.

Гэнэт Тэмүжин ухасхийн гарахад Хасар дагав. Тэмүжин, Хасар хоёрыг чив чимээгүй мордон Дайду балгасын өмнөх Дэрэд уулын оройд гарахад торгон цэрэг уулыг хоёр давхар бүслэн хамгаалж зогсчээ. Холгүй уулын бэлд Алтан хааны суугаа Жүндү балгас сүүдэртэн үзэгдэнэ. Одоо тэр Жүндү балгасын арын замыг Архай Хасарын тэргүүлсэн таван мянган шилдэг морьт цэрэг бүслэн хаажээ.

Харин Жүндү балгасанд хамгийн ойр очоод байсан Хасарын цэргийг Тэмүжиний зарлигаар хойш татсаныг Хасар мэдээгүй байлаа.

-Хэд хоногийн өмнө ижий минь зүүдэнд орсон юм. Би ижийгээ ер зүүдэлдэггүй байлаа гэж Тэмүжин гүн харуусалтай шивнэв.

Энэ бол Хасарын ирснээс хойш бүтэн үдшийн турш Тэмүжиний анхлан хэлсэн үг байв. Чухам юу гэж зүүдэлснийг Хасар асуусангүй. Тэмүжин ч дэлгэрүүлж ярьсангүй. Хэл нь татсан мэт таг чимээгүй суусан Тэмүжин ам ангайж хэдэн үг хэлсэнд Хасарын сэтгэл жаахан онгойж

-Би ижийг хэлсэн ёсоор усны ёроолд оршуулав.Ижий тэр газрыг өөрөө олж бас өөрөө нүхээ ухжээ. Би бүгдийг ижийн хэлснээр хийв. Ижийн үхлийг хэн ч харсангүй,хэн ч сонссонгүй.Ижий тэгэж хүссэн билээ гэж шивэгнэв.

-Ижий минь энэ бүгдийг яаж бодож олов. Хасар чи зөв хийжээ. Би ч байсан бол яг ингэж хийх байлаа. Ижий минь чи бидний сэтгэлд үлджээ. Одоо лав Есүхэй эцэгтэй уулзаа биз. Эцэг эх хоёр минь бидний сайн яваг лав харж байгаа гээд Тэмүжин сөхрөн сууж тэнгэрт гараа сунган мөргөхөд Хасар хачин их уярав.

Бүр нулимс цийлэгнүүлжээ. Тиймээ, тэд эцэг эхээ баярлуулж яваа нь гарцаагүй.

Тэдний их цэргийн өмнө Алтан улсын Жүндүгээс бусад бараг бүх хот балгас эзлэгдэв. Алтан улсын хаан Юнжи бууж өгье гэхдээ хөвүүнээ зуун нөхдийн хамт бэлэг болгон илгээсэн байв. Үүнээс илүү их ялалт гэж хаана байна. Бас Уйгар, Тангуд, Харлагийн улсууд дагаар оржээ.

Тэмүжин босож Хасарын өөдөөс харж зогсоод

-Хасар чи ижийн хэлсэн үгийг нэгийг ч орхилгүй хэлэгтүн. Би ижийнхээ сэтгэлийг мэдэхийг хүснэ. Энд ижийн үгийг салхинаас өөр юу ч үл сонсоно.Би Өүлэн ижийнхээ эцсийн үгийг Тэнгэрийн зарлиг гэж дагана гэж шивнэв.

Тэмүжин юуны учир энэ уулын оройд гарч ирснийг Хасар сая л ойлгов. Тэр эхийнхээ сүүлчийн үгийг сонсох гэж хүсчээ. Тэгэхдээ гэрчтэй сонсохыг хүссэнгүй. Магадгүй эх нь сүүлийн мөчид зөвхөн Хасар тэр хоёрт хамаатай үг хэлснийг Тэмүжин таасан биз.

Нэгэнт ийм тул Хасар эхийнхээ хэлснээс нэг ч үгийг засах буюу орхисонгүй. Бүр “Амь чинь ахын чинь гарт буй” гэдгийг ч дуустал хэлжээ. Тэмүжин үг дуугүй удаан зогсов.Тас аньсан нүдний нь зовхин дороос өнчин ганц сувд шиг ширхэг нулимс бөмбөрөн их сахалд хүрч тогтохыг Хасар сарны гэрэлд харж байлаа.

Уйлахгүй гэхдээ Тэмүжин асар их тэвчээр гарган биеэ барьж байгаа нь илт мэдрэгдэнэ.

Бусдын өмнө нулимс урсган сул дорой байдал үзүүлэхгүйн тулд энэ эзгүй ууланд ирсэн ажээ.Харвал Тэмүжин сэтгэлийн дотор асгаруулан уйлж байх шиг Хасарт санагдахад “Ижийтэйгээ уулзаж чадаагүй шүү дээ” гэж өрөвдөн боджээ.

Удалгүй Тэмүжин тайвшрав.

-Хасар. Чи миний нулимсыг дахиж үзэхгүй биз гэж Тэмүжин дотно сайхнаар инээмсэглэв. Хүний нутгийн хүйтэн тэнгэр дор ах дүү хоёр гунигт автан явлаа.Үнэхээр гүн хар тэнгэрийн өрхнөөс Өүлэний сүнс хөвүүдийнхээ ярилцахыг харж байлаа. Буцах замдаа Тэмүжин гэнэт морины амыг татан зогсоод

–Хасар чи чин үнэнээр хэлээч. Би ижийгээ их зовоосон уу гэж гэнэт тулган асуув. Хасар энэ асуултад яг юу гэж хариулахаа олсонгүй хэсэг дуугүй болжээ.

- Ижий маань зовсон гэж нэг ч үг дуугарсангүй гэвэл Тэмүжин дуугүй хэсэг явснаа

-Ижий минь зовсон ч зовов гэж хэлэхгүй хатуу бэрх сэтгэлтэй хүн л дээ гэж бодол болон шивнэхийг үзвэл өтөл эхээ өрөвдөхдөө харуусан гашуудаж, өөрийгөө зэмлэж байгаа нь илт байв.

Замын бяцхан толгойн оройд тэд хэсэг саатав. Хөндий дүүрэн их цэрэг хуарагнан бууж их гэрэл дүрэлзэнэ. Энд даруй олзны цэрэгтэй нийлээд гучин түмэн цэрэг лав буй ажээ.

-Хасар аа. Би их цэргээ татаж Алтан улсын хааны найрамдахаар гуйсныг зөвшөөрөхөөр шийдлээ. Гэвч би чамайг ямар үг хэлснийг санаж байна гэж Тэмүжин гэнэт огт өөр зүйл хэлэхийг үзвэл эхийн төлөө шаналсан нь худал мэт тэр дороо дүр нь хувиран өөрчлөгджээ.

- Одоо бид энэ эрчээр Жүндү балгасыг эзэлбэл зохино. Алтан хааны зугатаж очсон Бянжинг ч эзлэн авъя. Алтан улсад амсхийх зай өгч одоо найрамдвал өвөг дээдсийн сүнс биднийг лав таашаахгүй. Алтан улсыг дагуулан авах цэргийг надад өг гэж Хасар эрс хатуу хэлжээ..

-Хасар чи түр хүлээ.Би өөрийг бодож байна.Алтан хааны орогнон суугаа Бянжин боомтыг эзлэхэд тийм хялбар биш. Миний цэрэг ялсаар ядарч байна. Цэргүүдэд олзондоо сэтгэл ханан бахархах цаг хэрэгтэй байна.Энэ хүртэл тэмцэж эрүүл биеэ зовоосон тэдэнд ялалтаа амтархан хүлхэх боломж олгоё. Дараагийн дайнд тэд улам ч эрч хүчтэй, шунаглан орох болно.Алтан хаан үлдсэн цөөн балгасаа сахин хамгаалж тэндээ түгжигдэн сууж байг. Үүний муу гэж үгүй. Алтан хаан хүссэн хүсээгүй энэ Жүндүг надад өгөх болно. Гуйлгаж авбал амттай бусуу. Харин би чамд зүүн гарын цэргийг өгье. Чи далайн эргийг хижин явж Алтан улсын Бухуна их боомтыг дайлан авагтүн.

Түүний өмнө Алтан улсын хойт нийслэл Бэйгин балгасыг дайлагтүн.Тэгээд цааш байлдан эзлэмээр байвал хүссэнээр явагтүн. Дагаж элссэнийг бүү түйвээ. Хэдий татвар авахыг чи мэд. Би эндээс буцна. Чи өөрийн хүслээр явж хятад газрын зүүн хойно үлдсэн бүх нутаг, хот балгасыг эзлэн аваад их ордондоо буцаж ир.Бид чамайг хүлээж сууя.

Хасарын царай гийж,Тэмүжиний энэ үгийг сэтгэл догдлон талархан хүлээн аваад тэсэлгүй ихээмсэглэв. Тэмүжинд хэлнэ гэж замдаа цээжилж ирсэн бүх үгс хормын дотор хийсэн мартагдав. Энэ бол Тэмүжин Алтан улсын зүүн хойт нутгийг Хасарт найр тавин өгсөн хэрэг байв.

Хасарын эхийнхээ толгойг түшсэний шан, бас Тэмүжин Өүлэн эхийнхээ эцсийн үгийг ухаарч ойлгосны баталгаа энэ юм.

Ийм зарлиг буулгаснаар юутай ч Тэмүжин дүү Хасарын өмнө буруутайгаа хүлээж мөн энэ буруугаа цайруулах чин хүсэлтэй байгаагаа илэрхийлжээ. Тэмүжинд үүнээс өөрөөр буруугаа гэмших арга олдсонгүй. Тэмүжиний энэ цаад далд санааг Хасар шууд ойлгон баярлав.

Тэмүжин Хасарт хэзээ ч ингэж өгөөмөр загнаж байсангүй.

Зүүн хойт Хятадыг өөрийн дураар эзлэхийг зөвшөөрсөн нь Хасар болоод түүний хөвүүдийн гавьяа зүтгэлийг үнэлсэн хэрэг байлаа. Алтан улсын эзлэгдсэн нутгийг хөвүүдийн хамт эзэмшин суухыг Тэмүжинээс шаардахаар Хасар сая ирэх замдаа хатуу шийдсэн байв. Гэтэл

түүний энэ санааг Тэмүжин гайхалтай таажээ.

Хасар туйлын баяртай болж бүр тэсэлгүй тэр шөнөө ойр байсан өөрийн хүрээ рүү давхижээ.Ийм баярт мэдээг Егү,Есөнхэй хоёртоо дуулгах гэхээс тэр байж яджээ.

Харин Тэмүжин өөрийгөө Хасарт өртэй гэж үнэн сэтгэлээс бодсон билээ. Тэгэж бодсон учраас гурван хөвүүнээ цэрэг захируулан мордуулахаар шийдсэнээс ухарч зүүн хойт Хятадыг Хасарт найр тавин өгчээ. Хасарын амь насыг Тэмүжинд даатгаж түүнийг хэзээ үхүүлэхийг Чингис хааны хүсэл зориг мэдэх хэрэг гэсэн нь Өүлэн эхийн сүүлчийн гэрээс юм. Энэ бол одоо Хасарыг үхүүлэв гээд Өүлэн эх нь хэзээч Тэмүжинг зэмлэхгүй гэсэн үг байв. Ингэж үзсэнээс Тэмүжин Хасарт ийн өгөөмөр загнасан билээ. Үүнээс өөр зөв зам Тэмүжинд байсангүй.

Өүлэн эхийн үхэл Тэмүжин болоод Хасарын сэтгэлийн дотор гүн өөрчлөлт гаргажээ. Эхийн бие сэтгэлийн хүчээр гагнагдаж байсан ах дүүгийн холбоо харилцаа тасрах аюул илэрхий болохыг Тэмүжин ойлгож байв. Сэтгэл нь хямарсан Хасар яаж ч аашилж мэдэх тул бууж өгөх нь ганц зөв зам юм. Мөн Хэрлэний эрэгт байх Хасарын хүрээнд болсон Хуаржины үхлийн тухай мэдээг Бөртэ тэр дор нь Тэмүжинд илгээсэн билээ. Эхийн болоод Хуаржины үхэлд Хасар их цочирдож хямарсан нь түүний хэлэх үг, хөдлөх байдлаас илт харагдаж байлаа.

Яг ийи үед Тэмүжин Хасарын аяыг дагаж, түүнд найр тавин бусдаас дээгүүрт үзсэн нь үнэндээ Хасарын хэлье гэснийг хааж, хийе гэснийг зогсоосон цагаа олсон гарцаагүй зөв шийдвэр юм. Хятадын зүүн хойт нутгийн хотууд тэртэй тэргүй эсэргүүцэн тэмцэх хүчгүй, Алтан хааны их ялагдлын дуулианд дагаж орох нь гарцаагүй. Хасарыг ингэж өргөмжлөн явуулж гэмээ нь Өүлэн эхийн сэтгэл амирлан баясна гэж Тэмүжин итгэжээ.

Шүлсээр боловч ундалж, шөрмөсөөр боловч хооллон байж өсгөж өдий зэрэгт хүргэсэн Өүлэн эхийнхээ ачийг хариулах нь Хасарыг өргөмжлөн үзэхтэй яг адил болохыг эхийнхээ сүүлчийн үгнээс Тэмүжин ойлгож мэджээ. Эх нь хэдий үхсэн ч Тэмүжин, Хасарыг алах санаанаасаа түр боловч ухрав.

Гэвч эхийн сэтгэлээс гадна Хасарын өргөсөн их хүчийг үнэлэхгүй байж яаж болох вэ.

Ер нь Тэмүжинд хамгийн ихээр зүтгэсэн нь ганц Хасар юм.

Хасартай эн тэнцэх хүн үгүй боловч дэндүү хүчтэй, бүр өөрөөс нь илүү хүчтэй өрсөлдөгчийг дэргэдээ байлгах нь амиа үрэх шиг аюултайг Тэмүжин хормын төдий ч мартсангүй явжээ

Тэмүжиний хэлэх үг, хийх үйлийн хэмжүүр шалгуур нь Хасар билээ.

Өүлэн эхийн их алдар хүнд одоо Хасарт шилжин ирснийг Тэмүжин мэдэрчээ. Өүлэн эх үгүй бол Хасар ганцаардаж хүчгүй гарын дор болно гэж Тэмүжиний бодож явсан нь ямар их эндүүрэл байсныг мэдэв. Харин Хасарын эсэргүүцэн тэмцэх, өрсөлдөн мөчөөрхөх их хүслийг хазаарлан барьж байсан хүн нь Өүлэн эх нь болохыг Тэмүжин голдоо ортол ойлгож байв.

Одоо Хасарт айх хүн, ичих зүйл нэгээхэн ч үгүй болжээ. Эхийгээ үхмэгц Хасар яаж хувирч өөрчлөгдөхийг ухаант Өүлэн эх нь мэдэж байсан тул “Амь чинь ахын чинь гарт бий”гэж сэргэмжлүүлэн хэлжээ.

Тэр ухаант эх хөвүүдийнхээ бодол сэтгэлийг өөрийн амь бие шигээ нэвт мэддэг байсныг Тэмүжин ойлгоод одоо тэр өмгөөлөн хамгаалагч эх нь үгүй болсонд харамсахдаа өргөөндөө ганцаар үлдээд чив чимээгүй асгаруулан уйлжээ.

Хасарын омог зориг өрсөлдөх аюулаас авран хэлтрүүлсэн ачтан бол Өүлэн эх нь байжээ. Тийм учраас ачтай эхийнхээ эцсийн хүслийг биелүүлэх гэсэндээ Тэмүжин өнөөдөр зүүн хойт Хятадыг Хасарт өгөв.

Үүнээс өөр чадах юм Тэмүжинд байсангүй билээ.Тэмүжин ингэж өөрийн хүүхэд нас, хүн чанарынхаа өмнө түр зуур бууж өгсөн ч холын язгуур санаагаа мартсангүй.Тийм учраас Хасарын хамт өөрийн хамгийн үнэнч ноход болох Жорчидай, Алчи, Толун чэрби гурвыг хамт илгээжээ.

Тэр гурав зүүн замын цэргийн ялалт, амжилтыг батлахаас гадна Хасар болоод түүний хөвүүдийг хянан сахих үүргийг нууцаар хүлээжээ. Тэмүжинг дохих төдийд төрсөн эцгээ боловч урж тасдахад бэлэн үнэнч хүмүүжилтэй тэд хэзээ ч Хасар болоод түүний хөвүүдийг хөнөөхөд бэлэн байлаа.

Гэвч Тэмүжин Хасарыг алах санаанаасаа ухарчээ. Одоохондоо Хасарыг алах хурц шалтгаан харагдахгүй байв.Бас Хасарыг тайвшран дуулгавартай болно гэж итгэж байв. Учир нь Тэмүжин Хасарын хүссэнээр түүнд Алтан улсын зүүн хойт нутгийг өгсөн билээ. Хасарын толгойлсон зүүн замын цэрэг Жүндүгийн дэргэдээс зүүн зүг далайн эрэг чиглэн гурван хэсгээр цувран хөдөлж байв. Их цэргийг холдсон хойно Хасар Тэмүжинд ёслоод цэргийн зүг давхин одов.

Чингис хааны гол замын цэрэг ч эх нутгийн зүг хөдөлжээ.Хойт зүгээс нүүх үүл мэт нөмрөн ирсэн Монголын их цэргийн гол хэсэг Хятад газраас алгуур боловч холдон сэрүүн салхит хээр тал нутгаа зорьжээ.Их цэргийн манлайд Тэмүжин явж байв. Харин Хасар урагшлах тутам улам бүгчим болсоор байгаа хятад газрын салхи залгин зүүн зүг явж байв.Түүний ард Егү,Есөнхэй хөвүүд,олон дайнд хамт орж шалгарсан шадрууд,шилдэг цэрэг нь эцэсгүй үргэлжилжээ.Удалгүй өмнө нь их далай цэлийн үзэгдэв.Одоо Монголын цэрэг далайн эрэг даган хойш эргэх ёстой болжээ.

Хасар ертөнцийн зүүн хязгаарт хүрчээ. Үүнээс цааш газар үгүйг тэнгэртэй нийлсэн их ус батлах ажээ.Чингис хааны их улсын зүүн хил энэ болжээ.Их Монгол улсын зүүн хил хязгаар болсон далайн эрэг дээр Хасар мориноос буув.Хасар монгол хүний ёсоор далайн уснаас духандаа хүргээд амсаж үзэв.Харин далайн ус ийм сүрхий гашуун гэдгийг амталж үзээгүй тул сандарч тургиж сүйд болов.Дагаж явсан хөвүүд шадрууд нь шоолон инээлдэж Есөнхэй бүр элэг нь хатаж халуун элсэн дээр эвхэрч унан хөхөрчээ.Хасар үүнээс өмнө далайн ус ууж явсан биш, гашуун гэдгийг сонссоноос цаашгүй тул ингэж цочих нь аргагүй билээ.Далайн ус яг нулимс адил шорвог болохыг сая мэдээд энэ их ус хичнээн хүний нулимс байгаа бол гэж хөнгөхөнөөр бодож зогсжэ

э.Хасар аз жаргал зориг тэмүүллээр дүүрэн байв.Тэр өнөөдөр Тэмүжинд үнэнч зүтгэснийхээ хүчинд зүүн хойт Хятадыг байлдан дагуулах их цэргийг толгойлох болжээ.Ингэж Хасарын эрт бага насны цорын ганц хүсэл мөрөөдөл биелэх ойртжээ.Эртний өст Алтан улсыг мөхөөн дарж,өвөг дээдсийнхээ өшөөг авч, өшөө аваад ч зогсохгүй бүр Алтан улсыг эзлэн сууна гэдэг Хасарын хар багын их мөрөөдөл байлаа.

Гэвч тэр өнөөг хүртэл энэ нууцаа хэнд ч задласангүй билээ.Харин одоо Егү,Есөнхэй хоёртоо хэлэх цаг нь болжээ гэж бодож зогслоо.

Хасарыг дохио өгөхөд түүний их цэрэг Тэнжин тохойгоос хойш эргэж далайн эрэг хижин умрыг зорин хөдлөв.

Тэдний өмнө Алтан улсын Бухуна боомт тосч байв.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ХУЛАН

Тэмүжин дөчин хоёр нас хүрч, 1204 оны намар болж байлаа. Найман аймгийн Таян ханыг мөхөөж, Найманы иргэдийг бүгдийг хураан авч дуусгав. Найман аймгийг дарсны хойно нэгэн шинэ, сонирхолтой ажил өрнөсөн нь найманаас олзлогдсон Таян ханы ордны түшмэл Тататунга гэгч Тэмүжиний зарлиг ёсоор уйгар үсгээр монгол хэлийг галиглан бичиж үүнийг сурахаар олон залуус шамдан сонирхох болсныг угийн сониуч Хасар манлайлж байв.

Тэмүжин харин бичиг сурах гэж хичээсэнгүй. Түүний сэтгэлийг найманы Таян ханы дэргэд очоод байснаа баригдалгүй цааш зугатаж одсон мэргэдийн үлдэгдэл Тогтоэбэх болон түүний хөвүүдийг дарах хүсэл эзэмджээ. Тэмүжин найманыг эзлэн авснаар олон цэрэгтэй болж, Боорчи, Зэлмэ, Хасар Сүбээдэй нарын удирдсан гол цэрэг нь нэгэнт байлдаж сурчээ. Одоо түүнд Тогтоэбэхийг хүлээх биш дайран сөнөөх цаг ирж, хүч хуримтлагдсаныг ойлгов.

Харин Тогтоэбэхээс салсан мэргэдийн үлдэгдэл Туул Орхоны завсарт одоо болтол суусаар байсныг эхлээд хураан авах хэрэгтэй байлаа.Ингээд зуны эхэн сараас эхлэн сэм бэлдсэний дүнд мэргэдийн үлдэгдэл орогносоор байгаа Саарь хээрийн талыг зорин хөдлөхөд бэлэн болжээ. Гэвч өмнө олзлогдон ирсэн мэргэд иргэдийн зарим нь Тэмүжиний довтлох чимээг тэдэнд хүргэж амжжээ. Тэмүжиний довтлох мэдээ мэргэдийн удирдагчдын дотор хагарал үүсгэж хар толгой, хамаг хөрөнгөө бодсон увас мэргэдийн толгойлогч Дайр-Үсэн Тэмүжинд бууж өгөхөөр шийджээ.

Ойр зуурын хамаг монгол аймгуудыг сөнөөн дарж хүчирхэгжсэн Тэмүжинг эсэргүүцэн тэмцэх хүч мэргэд аймагт нэгэнт үгүй болсон нь сохор дүлий хүнд ч ойлгомжтой бөгөөд энэ байдал мэргэд хүн бүрийг амиа бодоход хүргэжээ..

Дайр-Үсэн ухаантай сүрхийдээ ингэсэнгүй.

Энэ бүгд түүний охин Хуланы санаа сэдэл байлаа.

Тогтоэбэхээр толгойлуулсан хэсэг мэргэд олон жилийн өмнө Бөртийг булаан авснаас үүдсэн өс хонзонг Тэмүжин өнөө болтол мартсангүй. Харин салхинд үлээгдсэн талын түймэр шиг хүчирхэгжсэн Тэмүжинтэй Мэргэд аймаг ганцаар илэрхий дайсагнахаас тойрч байсан ч түүний эсрэг нэгдэлд ямагт оролцож байжээ. Гэвч Тэмүжинг эсэргүүцэгчдийн тарсан хүчийг нэгтгэн гол тулгуур болж байсан Найман аймаг санаандгүй хурднаар дарагдан сөнөсөн нь монголын тал нутагт Мэргэд аймгийн эцсийн өдөр ирснийг зарласан хэрэг болов. Мэргэдүүд нэг бол Тэмүжинд дагаж орох, эсвэл эсэргүүцэн тэмцээд эцсээ үзэх ёстой цаг иржээ. Тэд Тэмүжинг довтлох зориг хүч нэгэнт үгүй тул дэмий л хүлээсээр хэсэг хугацаа өнгөрч одоо Тэмүжин довтлон ирэх нь тодорхой болов.Тэмүжин мэргэдийг дарахыг туйлаас хүсч байв.Учир нь мэргэд бол түүний хувийн өстэй дайсан билээ. Дайр-Үсэний охин Хулан хэдий арван наймтай ч эцгийн гэрт эрх танхи өссөн дураар омголон зантай, хол ойрыг ухан бодох чадалтай, сэргэлэн овтой бүсгүй юм. Тиймдээ ч Мэргэд аймгийг нөмрөн ирэх аюулыг мэдэрч бас эцэг өвгөдийн муйхар эсэргүүцлийн уршгаар алагдан үгүй болохыг хүсэхгүй байлаа.

Хамгийн гол нь тэр үл танигч Тэмүжин гэгчтэй хамт тал нутагт цоо шинэ амьдрал, цоо шинэ цаг үе ирж байгааг Хулан ухаантай залуу хүний ёсоор ойлгож мэдэрсэн явдал юм.

Мэргэдүүд Тэмүжинтэй сөрөн байлдах бэлтгэлээ базааж, шивээ, хороо байгуулсаар байхад Хулан эцэг Дайр-Үсэндээ нэгэн зүйлийг гуйж, сүүлдээ шаардах болов. Дайр-Үсэн эхний үед Хуланы үгийг эм хүний хөөрүү сэтгэлийн хоосон үг гэж үл тоосон ч дөхөн ирж буй аюул эрхгүй түүнийг элдвийг эргэцүүлэн бодоход хүргэжээ.Мэргэд хүн бүр үхэх сэхэхээ үзэх цаг болж эр бүр нум сум, илд, хутгаа бэлдэн бужигнах үед Дайр-Үсэн есөн өнгийн бодолд ээрэгдэн мухар нүхэнд орсон зурам шиг болжээ. Арван найман настай охин Хуланы хэлсэн үг дэндүү осолтой, хатуу шаардлага байв.Эцгийгээ Боржигон аймагт бууж өгч, бууж өгөөд зогсохгүй өөрийгөө Тэмүжинд бэлэглэхийг Хулан хатуу шаарджээ. Хуланы энэ шаардлагыг шүүрэн авч биелүүлэхэд осолтой хэрэг байв. Хэрэв Дайр-Үсэнг юу хийх гэж буйг сэжиглэж мэдвэл нэг аймгийнхан нь түүнийг урвагчид тооцон шууд алах биз.

Гэнэн охины хөөрүү үгэнд автан гэндвэл хар толгойгоо алдаад зогсохгүй, хожим хойно үр удмаараа урвагчид тооцогдон жигшигдэх билээ. Мэргэд аймгийн мөхөл ирсэн гэдгийг Дайр-Үсэн хэрхэвч зөвшөөрөхгүй юм. Бас төрөлх аймгаас урваж Тэмүжинг дагах нь амиа аврах эцсийн арга гэж тэр үзэхгүй байлаа. Тийм учраас Хуланы шаардлагыг хүлээн авахгүй цааргалсаар ажээ. Гэтэл Тэмүжиний их цэрэг нөмрөн ирж явааг хоёр өдрийн газраас үзэж давхин ирсэн харуулын үгийг сонсоод байдал нэгэнт тодорхой болмогц Дайр-Үсэн эргэлзэж тээнэгэлзэхийг больж бууж өгөхөд сэмхэнээр бэлтгэж эхлэв.

Үхлийн өмнө хар толгойгоо аврах эцсийн замыг тэр сонгов. Ингэхдээ бусад албат иргэдээс хав нууж,Тэмүжиний цэргийг хүлээжээ. Тэмүжинг угтан хөдлөх нь өөрийнхний гарт үхэхэд хүргэх, бас дайран ирэх дайсанд санаандгүйгээр алуулах аюул байх тул албат иргэддээ ч сэжиглэгдсэнгүй, дотор нууцаа хадгалан суужээ.Мэргэдийн хүрээ аймшигт сандралд автаж эх толгой, зохион байгуулалтаа алдан ундуй сундуй зугатаж эхлэв.

Дайр- Үсэн түгшүүр дүүрэн суухад харин Хулан Тэмүжиний цэргийг мөч тоолон баярлан хүлээнэ. Бүсгүйн хүсэл биелэхэд ойртжээ. Түүний санаснаар болно гэдэгт Хулан итгэлтэй байжээ. Учир нь Мэргэдийн их бөө Бүтэнбэх “Чи Тэмүжиний хатан болох аваас жаргалын туйлд хүрнэ” гэж хувь заяаг нь мэргэлээд хэлсэн билээ. Бөртийг буцаан булааж авснаас даруй хоёр жилийн хойно төрсөн ч өдий арван найм хүртлээ Хулан Тэмүжиний тухай үлгэр домог шиг яриа олныг сонсож, тэр баатар эрийн хий дүрд дурласан байв. Хулан ямар ч үнээр хамаагүй Тэмүжиний хатан болохоор шийджээ.Сониуч эмс болоод настай цэрэг эрс,хөгшдийн амнаас сонссон болгоныг сэтгэлдээ хадгалсаар Хулан Тэмүжиний хий дүрийг зүрхэндээ баттай босгон шингээж зүүдэндээ үзээд таньдаг болжээ. Олны ярихаар Тэмүжин харгис догшин, аймшигтай үлгэрийн мангас мэт амьтан ажээ. Хатан Бөртэг буцааж аваад өс санан, тэдний удмын олон хүнийг цавчин алсан аймшигт түүхийг одоо болтол ахмад хүмүүс ярисаар байх билээ. Хавь ойрын аймаг, овгийг нэгтгэн авч, царай гоо эмс хатдыг булаан эзэмддэг Тэмүжиний тухай яриаг сонсох нь Хуланд юугаар ч сольшгүй, урд өмнө амсаж үзээгүй жаргал болдог байв.

Тэмүжин, Хуланы сэтгэлд эр бяртан, эзлэн сөнөөгч, эмс охидыг эдлэн жаргаагч, домгийн хүчит баатар болон сэтгэгдэж барааг нь харж, биеийг нь мэдрэх хүсэл оргилоход бүх булчин шөрмөс нь зангиран чивчирч, давсаг, нууц эрхтэн нь чим чим шархиран өвдөж туйлын амттай мэдрэмж төрдөг юм. Хуланы өдрийн бодол шөнийн зүүд нь Тэмүжин байв. Тэмүжиний тухай үнэн худал нь үл мэдэгдэх чимээ сураг үл тасарна. Татаар аймгийг сөнөөж олон сайхан охид

эмсийг авсан гэж ярина. Бас найманаас олон хатад эмс олзолжээ.

Гэрийн дотор гурван их хатантай мөрт гэрийн гадна хорь гучин татвар эмс байлгадаг ханаж цадашгүй хуял тачаалтай, нэг өдөр арван эм эдлэвч ханаж ядардаггүй гэнэ гэж эмс хүүхнүүд сэм шивэр авир ярихыг сонсох бүр тэсэн тэвчиж болмооргүй дур хүсэл нь оргилдог билээ. Хулан ийм зовлонт дурлалынхаа хүчээр Тэмүжинд бууж өгөхийг эцгээсээ хатуу шаардсан билээ.

Эхээс өнчирч хоцорсон Хулан охиндоо Дайр-Үсэн туйлын хайртай ч өөрийн амь нас хар толгойдоо түүнээс илүү хайртай учир Тэмүжинд бууж өгөхөөр шийдсэнийг Хулан гадарлахгүй өнгөрчээ. Хуланд санаархсан, тэчъяадсан эрс олон байв. Бүр харуй бүрийгээр хүчээр эзэмдэх гэсэн нэг их санаат эрийг жижиг хутгаар улаан суга руу нь дүрж биеэ аварсан явдал ч бий юм.Хулан өөрийн зоримог хурц зангийн ачаар олон эрийн чивэлт хүслээс аврагджээ.

Хэрэв эцэг нь түүний хүслийг эс дагавал Тэмүжинг ирэхэд шууд өөрөө очно гэж тэр шийдсэн байв. Энэ их осолтой хэрэг юм.Гоо үзэмжит бүсгүй ганцаар дэл сул явах нь Тэмүжинд очихын өмнө өөр эрийн хүчинд автан эм биеэ эдлүүлэн булаагдах аюултай тул эцгийн өндөр нэрийн хамгаалал дор очих замыг сонгосон нь зөв байв. Гэтэл ашгүй Тэмүжин Мэргэд аймгийг хүчээр дагуулан авах нь тодорхой болж Хуланы сэтгэлийг гийгүүлжээ. Мэргэдүүд бүгд айсуй сүйрэл, мөхлийг мэдрэн уйлж унжиж тарж зугатаж байхад ганц Хулан л дуулах нь холгүй баяр хөөр дүүрэн байв. Хулан Тэмүжинтэй учрахын тулд бүх Мэргэд аймгийг сөнөөхөд ч бэлэн юм. Угаас одоо нэгэнт хүчин мөхөсдсөн үед Тэмүжинтэй тэмцсэнээс буун өгч дагаар орох нь зөв гэж Хулан бодно. Гэтэл мэргэдийн толгойлогчид ахмадууд болоод эцэг нь ингэхийг хүсэхгүй байгааг тэр үл ойлгожээ. Огт утгагүй зүйлийн төлөө хайран амиа үрж хамгаа алдах гээд байгаа нь харамсалтай. Гэвч үнэндээ хэн үхэх, үлдэх нь Хуланд огт хамаагүй бөгөөд, хүслээ биелүүлж хүчирхэг Тэмүжиний эхнэр л болох ёстой гэж бодно. Тэр онгон биеэ ганц Тэмүжинд өгнө гэж шийдсэн билээ. Хуланг удуйд мэргэдийн нэг эр зуун агтаар худалдан авах гэж эцэгтэй нь тохирсон боловч ашгүй Тэмүжин довтлон ирэх сураг гарснаар тэдний энэ бодлыг тасалдуулжээ. Үүнийг Хулан Тэнгэрийн аврал гэж ойлгоод Тэмүжин ганц өөрийг нь авах гэж Мэргэд аймгийг дайлах гэсэн мэт сэтгэн Тэнгэрт мөргөж, хурдан ирүүлэхийг хүсэх болжээ.Удалгүй Хуланы бүтэн зунжин хүлээсэн өдөр болж намрын сарын дундуур Тэмүжиний цэрэг довтлон ирж мэргэдүүд ихэд эсэргүүцэж төдсөнгүй ундуй сундуй зугатаав. Дайр-Үсэн аймгийнхнаасаа улайм цайм хоцорч үл чадах тул хамт зугатааж хэд хоногийн дараа Тэмүжиний цэрэгт Саарь хээрт гүйцэгдэн, Тогтоэбэх, Худу, Чулуун хөвүүдийн хамт эмс, эхнэрээ ч орхин зайлж бусад нь бүгдээр олзлогджээ.

Хулан дайсны цэрэг довтлон ирсэн өдрөөс хойш хэд хоногийн турш Тэмүжинг олж харах гээд чадсангүй.Хэрэв Тэмүжинг үзэгдвэл даруй гүйж очиход бэлэн байв.Гэтэл дайсны зэрлэг цэрэг довтлон ирсэн ийм үед Хулан мэтийн цэвэр охид ил задгай явах нь ерөөс үхсэнтэй адил тул Дайр-Үсэн охиноо тас нуужээ.Тэмүжин хан хүн тул жирийн цэргүүдтэй хутгалдан байлддаггүйг Хулан мэдээгүй билээ.Толгойд нөмөрсөн алчуур дороос хаа холд бие хаа өндөр сүрлэг эр харагдвал энэ Тэмүжин биз гэж бодох авч бас л биш байх ажээ. Хулан дотроо Тэмүжинг даруй зургаан тохой нуруутай, зурмал хар хөмсөгтэй, том хар нүдтэй, тогтуун сайхан харцтай эр байна гэж бодох билээ.

Харин Дайр-Үсэн хашир хүн тул арга эвийг олж байгаад түүний албатыг олзлон авсан нь Тэмүжиний цэргийн ноён Наяа гэгчтэй уулзаж амжжээ.

- Би Хулан нэрт охиноо Чингис хаанд үзүүлэх хүсэлтэй гэтэл Тэмүжиний нэр алдрыг сонссон Наяа

-Чи тэгвэл манайд түр хүлээ, ганцаар явбал зам зуур цэрэг ардууд охиныг чинь хүчирхийлж мэднэ. Би Чингис хаанд цуг очъё гэхэд Хулан тэр биерхүү сайхан эрээс бишүүрхэн айж бас дотроо энэ ноён садарлах гэвэл яана гэж түгшсэн ч тэдэнд үүнээс өөр зам үгүй тул үгийг нь дагажээ. Удалгүй энэ Наяа ноёны ивээлд орсон нь завшаантай хэрэг болохыг тэд үзэв. Тэмүжиний цэргүүд мэргэдийн зүс гоо эмс охид бүгдийг тал тал тийш хуваан аваад үгүй болжээ. Арай дор шигийг нь айж ичих юмгүйгээр хүчирхэн эдэлж, мал хөрөнгийг үлдээлгүй талж авав. Харин энэ Наяа ноён Хуланд хэдий харц унагавч ер шалиглах санаа өвөрлөсөнгүй төлөв нуруутай эр байсанд Хулан талархалтай болжээ. Гурван өдрийн хойно Наяа ноён, Хуланг эцгийнх нь хамт Тэмүжинд үзүүлэхээр явлаа.Хуланы сэтгэлийн догдлол хязгааргүй болжээ

.Бэлдэж зэхсэн хувцсаа өмсөж энгэсэг тавихаа ч мартсангүй. Боржигон аймгийн цэргүүд бүгдээр Тэмүжинг Чингис хаан гэж хэлэлцэх нь Хуланд дотно сайхан байлаа. Саарь хээрийн талын хойморт гадна нь их хар сүлд мандуулсан хөнгөн асрыг тойроод хэдэн давхар цэрэг бүслэн хамгаалсан нь үзсэн хүний зүрхийг үхүүлж эрхгүй айж сүрдэм ажээ. Хулан сүрдэж бишрэх хийгээд хүсэн хүлээх сэтгэлд автахдаа ихээр догдлон чичрэв. Бүх юм зүүд мэт ажээ. Одоо тэр зүүдний хүслэн болсон баатар эр Тэмүжинтэй учрах цаг иржээ. Өргөөний гадна зогсох уул хад шиг олон эрсийн чухам аль нь Тэмүжин бол гэж харц хяламхийж явжээ. Мэргэд цусны үзэсгэлэнт бүсгүйг харсан эрсийн шохоорхон шунасан нүд духан дээрээ гарахыг үзээд Дайр-Үсэн охиноороо бахархан урам зориг оржээ. Хулан сэтгэлийн хүслэн болсон Тэмүжинг таних гэж баатар эрсийг толгой дараалан ширтэв. Бүгд л Хулангийн өөдөөс дуулганыхаа дороос урхинаар ширтэх ажээ.

Өргөөнөөс нэг хүн гарч ирээд Наяа тэднийг -Ор гэсэн тул Тэмүжин дотор байгаа нь ил болов. Одоо хэдхэн алхаад Тэмүжинтэй нүүр учирна. Бүхнийг дийлэгч хүчит баатар Тэмүжинд таалагдах гэж олон жил хүссэн тэр мөч Хуланд ирлээ. Хулан,Наяа болоод эцгийгээ даган өргөөнд орлоо.Асрын дотор харанхуйвтар тул нүд дастлаа Хулан хэн нь хэнийг ялгаж эс чадав. Гэрийн хоёр талаар бас л сайхан эрс дүүрэн суужээ. Харин Наяа ноён ёслохыг бас эцэг нь сөхрөхийг үзвэл өргөөний хоймор цагаан эсгийгээр бүтээсэн суудал дээр нэг хүн суух нь Тэмүжин бололтой гэж таав. Дуулга духдуулсан тул түүний царай нь үл үзэгдэнэ. Наяа ноён Хуланг эцгийн нь хамт дагуулан ирсэн хэргийн учрыг тод хэлэв. Хэн ч тодорхой дуугарсангүй ч “Хулан нэрт охиноо Чингис хаанд үзүүлэхээр ирлээ” гэхийг сонсоод асарт битүү дуу нүргэжээ.

Хулан үүнийг сайшаасан шоолсон алин болохыг мэдсэнгүй.Тэмүжин дуугарахгүй удсанд Хулан түгшүүрт автав.Тэр Тэмүжинд таалагдсангүй бололтой гэж айжээ.

-Чи Хулан гэв үү. Нааш энэ гэрэлд гарч зогс гэж хэн нэг хүн сөөнгө дуугаар хэлж бас нэг нь нурууруу нь түлхэв. Хүмүүс инээлдэж Хулан тэр дороо асрын өрхөөр туссан нарны гэрэлд түлхэгдэн гарч гялбан зогсов. Хоймор суугч хүн дуулгаа авч дэргэдэх хүндээ өгч босоод түүнд

ойртон ирэв.Тэр хүний царайг нарны гэрэлд сая л нэг тод хараад энэ лав Тэмүжин биш биз гэж Хулан түргэн зуур бодов.

Намхан нуруутай, даахирч ширэлдсэн үстэй, бууралтсан өтгөн сахалтай тэр хүн дэргэд ирээд ширтэх нь даанч аймаар, бүр дух хацрыг нь өрөмдөх шиг болжээ.Тэр хүнээс морины хөлс, галын утаа үнэртэж байв. Өнөө хүн гэнэт хуурай ширүүн гараар эрүүг нь татан нүд рүү нь харав. Харц тулах тэр агшинд гэнэт “Тэмүжин” гэсэн хачин сэрэл мэдрэмж бүх биеэр нь гүйгээд өөрийн эрхгүй -Чингис хаан гэж шивнээд сөхрөн суужээ.

Юу чухам ингэснийг Хулан хожим болтол ойлгоогүй билээ.

Тэмүжиний догшин харц хачин шар нүдээр нь дамжин зүрхэнд нь нэвтрэн орж бүр халуу оргиулах мэт санагджээ.Тийм мэдрэмжийг Хулан өмнө нь үзсэнгүй. Тэмүжиний тухай бүх дурсамж, бодол мөрөөдөл, дүрслэлийг энэ хачин хүн хормын дотор арчин хаяж, хачин халуун урсгал бүх биеийг нь эзэмдэн авахыг Хулан дуулгавартайгаар дагав. Түүний өмнө Чингис хаан зогсож байсан нь энэ юм. Эрүүнээс нь барьсан газар халуун оргино.

Чингис хаан гэнэт өөрөөс нь холдон явахад Хулан харц өргөв. Бахдаж, шүлэнгэтсэн олон эрийн харц Хуланы бие дээр нь асгарч байв. Чингис хаан ганц алхаад баганын дор зогссон Наяагийн өмнө очжээ. Түүний сөөнгө дуу заналтай, араатны авиртай сонсдов.Хөдлөх бүрд нь хөө хуяг сэлэм нь харшина.

-Наяа. Чи хаан эзэндээ бэлэглэсэн энэ эмийг яах гэж гурав хоног гэртээ агуулан саатуулав. Чи миний итгэлийг эвдэж сэтгэлийг гутаав. Чи лав энэ эмтэй шалигласан биз. Би одоо үүгээр яана. Чамайг хаан эзнийхээ эмд халдсан гэж цавчин ална. Энэ эмийг ч мөн адил алагтүн гэж Чингис хаан хилэгнэхэд гэрт байгсад бүгд хэлмэгдэн чичрэхийг Хулан үзэж чухам ямар араатан мэт аймшигт хүнтэй учирснаа мэдрэв.

Гэмгүй Наяа ноён сайн сэтгэлийнхээ төлөө амиа алдах боллоо. Хуланг гурав хоног гэртээ агуулснаа орж ирүүт нэгэнт хэлсэн тул Наяа ноён үхлээс зайлахгүй нь тодорхой болохоор хөөрхий тэр хэрхэн хариу хэлж биеэ өмөөрөх учраа олсонгүй. Түүнийг дагаж Хулан ч үхэх болов. Хулан ингэхийг яав ч зөвшөөрөхгүй тул ухасхийн алхаж ер эрээлж айлгүйгээр Чингис хааны өмнө очив. Бүгд гайхсандаа алмайрчээ.Харин Хуланд айж ичих учир шалтгаан өчүүхэн ч байсангүй.

Дайр-Үсэн амьсгаа хураах шахжээ.

-Чингис хаан. Та сонс. Энэ Наяа ноён ер надад шалиглах санаа агуулсангүй. Харин Наяа ноён асрамжлаагүй бол юу болохыг хэн мэдлээ. Хаан та үл итгэвэл бие мах бодийг минь шалган сорьж үзэгтүн. Бие минь онгон биш байвал би үхье гэж Хулан эрс чанга хэлжээ.

Тэмүжин ийм зориг төгөлдөр эмийг өмнө нь үзээгүй тул гайхан хойш ухрав.Хойшоо ухраад Хуланг толгойноос хөл хүртэл дахин сайтар ажиглав.

Хулан Тэмүжинээс өндөр нуруутай ажээ.

Тэмүжин чимээгүй инээмсэглэв.Олон бүгд амьсгаа аван уужрав. Бүгд Тэмүжиний юу хэлэхийг хүлээлээ. Өд шиг хөнгөн, эмзэг энэ бүсгүй ингэж өөрийн биеийг тулган тушаасан нь Тэмүжинд гайхагдсан ч бас бага бишээр бахдуулсан тул инээмсэглээд

-Чи үхэхээс айхгүй юу гэв. Тэмүжин ингэж хэлсэн нь энэ зоримог бүсгүй түүнд таашаагдсаных юм.

-Би өөрийн биеийг мэдэх тул ингэж хэлэв гэсэн Хуланы үг Тэмүжинд бүр ч таашаагджээ.

-Чи хэдэн настай вэ.

-Охин минь арван наймтай юм гэж орж ирснээс хойш үхсэн мэт сөхрөн суусаар байсан Дайр-Үсэн сая л нэг амьсгаа авч уужраад боломж гармагц үг хавчуулж амжив.

- Би Увас мэргэдийн толгойлогч. Өөрийн охиныг Чингис хаан танд сайн сэтгэлээр өргөж таны ивээлд багтая хэмээв гэж бөхийжээ. - Охин чинь худал хэлсэн байвал Увас мэргэдийн Дайр-Үсэн чи ч бас үхэх болно гэж Тэмүжин хашгирав.

Харин Наяа хэрэг учир жаахан тайвширсныг үзээд сөхөрч гараа дээш өргөн сунгаад

Хамаг олны эзэн

Хаан Чингис чамайг

Хайрлаж хүндлэхээс өөр

Хар санаа надад үгүй

Харь улсаас олзолсон

Хацар гоо хатад

Хатир сайн морьдыг

Хаан чиний юм гэж

Халдалгүй харж

Хавиралгүй сахьдаг билээ.

Үүнээс өөрийг сэтгэж

Үнэн санаа гажиж

Үйлдсэн буруу байвал

Үхэхэд би гомдолгүй гэж тангараглав.

Энэ бол Наяагийн үнэн сэтгэлийн үг байсан тул Тэмүжин түүнд хүндлэл үзүүлж дээш нь суулгав. Хором агшны дотор үүссэн аюул занал Хуланы зоригт үгийн ачаар сайнаар шийдэгдэж Чингис хаан тайтгарсанд тэнд байгсад бүгд баясан хөөрөлдөв. Үүний дундаас Дайр-Үсэн илүүтэй ихээр, бүр амьдралдаа үзээгүй ихээр баярлажээ. Тэр даруй Хуланыг гаргаж тусгай гэрт оруулан хооллож ундлав. Чухам юу гээч болох гэж буйг Хулан тод мэдэж байв.

Чингис хаан түүний хэлснээр бие махбодийг нь сорьж үзэх болжээ.

Эр эмийн янагийн үйлийг өөрийн биеэр үйлдэж үзээгүй боловч үзэж сонссон нь тийм ч бага биш билээ. Хулан зорьсон санааныхаа талд нь хүрчээ. Тэр ямартай ч Тэмүжиний гэрт ирж их зоригийн хүчээр энгэр зөрүүлэх цаг болов. Тэмүжинд таалагдаж бие сэтгэлийг нь эзэмдэж чадах аваас түүний мөрөөдөл бүрэн биелэх юм. Тэмүжин түүний бодсон шиг өнгөлөг жавхаатай эр биш байсан нь бага зэрэг гомдолтой ч түүний хүсч хүлээсэн ганц хүн нь мөн гэдэгт тэр огтхон ч эргэлзсэнгүй.

Балчир бага охин нь ямар ихийг зориглон шийдсэнийг Дайр-Үсэн үзэж гайхаж бишрээд барсангүй. Тэр зоригт охиныхоо ачаар энэ удаа Тэмүжиний цэргүүдэд алуулсангүйгээр барахгүй, амины албат иргэд, мал хөрөнгө нь үрэгдсэн ч ихэнх нь түүний мэдэлд үлджээ. Хэрэв Чингис хаан Хулан охиныг таалж соёрхвол Дайр-Үсэн хүчирхэг Чингис хааны хадам болох аз иржээ. Дайр-Үсэн Хулан охиныхоо ухаан, зоригтойг үзэж итгэв. Хулан яах ёстойгоо сайн мэдэж байлаа.

Мэдэхээс илүү их хүсэл, тачаал оргилох ажээ. Хуланы эх түүний багад мориноос унаж осолдсоноос хойш тэр эцгийнхээ татвар эм хэрэйд цусны бүсгүйн асрамжинд өссөн юм. Тэр асрагч эм угийн урин тачаангуйн дээр холын ухаантай бүсгүй байлаа. Асрагч эх нь Хуланд яг найз бүсгүй шиг нь байж эр эмийн янагийн үйлийн бүх учрыг багаас нь таниулж ойлгуулсан нь Хуланг ийм энгийн биш хүсэлтэй болоход нөлөөлсөн билээ.

Эр хүн хүч чадалтай, эр зоригтой боловч эмс охидтой энгэр зөрүүлэх үедээ эмийн эрхэнд ордог учрыг тэр Хуланд сайтар ойлгуулсан бөгөөд нэг гэрт хонох үедээ эр эмийн янагийн үйлдлийг Хуланы дэргэд ичих эрээлэх юмгүйгээр бусадтай хийж үзүүлдэг байв.

Тэр асрагч эм угаас төрөлхийн цадаж ханашгүй дур тачаалтай тул нэгэн шөнө хэдэн эртэй цэнгэн жаргаж чаддагийг Хулан үзсэн билээ. Эм хүний хамгийн хүчтэй зэвсэг бол эрийн хүслийн оргилуулагч урин тачаангуйн увидас болохыг бас яаж эрийг эзэмдэн татах аргыг асрагч эм нь өөрийн биеэр олонтоо үзүүлсэн юм. Дайр-Үсэн эцэг нь ч тэр асрагч эмийн урин тачаангуйн увидаст бүрэн автсан хүн болохыг Хулан бас л үзжээ. Тэр асрагч эм хэрхэн янаглахыг,яаж дуугарч хөдлөхийг, эрийн унтсан бие махбодийг яаж сэргээн босгохыг Хулан олон удаа дээлийн зах доогуур харж сонссон нь одоо л хэрэг болох цаг нь иржээ.

Хоёр жилийн өмнө эцэг нь асрагч эмийг агтач эртэй шалиглав хэмээн усанд үйж алахад Хулан эхийгээ алдсан мэт өчнөөн хоног толгой өндийлгүй уйлж гашуудсан билээ. Хайртай эмээ дэмий хардаж алсандаа Дайр-Үсэн ч ихэд харамсан өөрийгөө хараажээ. - Эрийг эзэмдэхэд ганц гоо үзэсгэлэн үл хүрэлцэнэ. Чи эрийг эзэмдэж, өмнөө сөхрүүлье гэвэл аймшиггүй зоригтой, алмай ичгүүргүй байх хэрэгтэй гэж асрагч эмийн хэлдэг нь үнэн

болохыг өнөөдөр Хулан Чингис хааны өргөөнд үзэж итгэжээ.

Одоо түүнд айх, ичих зүйл өчүүхэн ч үгүй болжээ.

Үдэш болж алс холын үймээн, хүн малын дуу дарагдсаны хойно өөрийн биеийг угааж арчилж бэлдсэн Хулан гэрт ганцаар нүцгэн биен дээр нимгэн дээл хөдрөөд Тэмүжинг хүлээж байв.

Өнөө шөнийг хэрхэн өнгөрүүлэхээс, Хуланы яаж эм хүн шиг аашилж аяглахаас түүний амьдрал бас амь нас хамаарах болжээ. Тэр энэ замыг нэгэнт өөрөө сонгосон тул эргэлзэж тээнэгэлзэх юмгүй харин ч баяр хөөртэй байлаа.Хулан асрагч эмийнхээ яаж хөдөлж дуугардагийг тов тодорхой санаж байлаа. Бүр юу хийхээ ч бодож төлөвлөжээ.

Одоо ганцхан Тэмүжиний ирэх л үлдэв.Үүд гэнэт чив чимээгүй сөхөгдөн өдрийн уулзсан догшин шар нүдтэй хүн сүүдэр шиг орж ирэв. Байлдааны хуяг дуулгаа тайлж энгийн хөнгөн нимгэн дээл өмссөн Тэмүжин улам ч бөгтөр давжаа жижигхэн болчихсон юм шиг үзэгдэв. Олныг бишрүүлж, айлган довтлогч, хамгийг дийлэгч их Чингис хаан гэхэд даан ч гологдмоор царай муутай онигор хар хүн өмнө нь зогсож байлаа.

Гэвч түүний догшин шар нүднээс дүрэлзэх омог бардам гал энэ хүн бол өөр хэн ч биш Тэмүжин гэдгийг гэрчилнэ.Нүднээс нь ингэж их гал дүрэлздэг хүнийг Хулан ер үзсэнгүй билээ. Хулан босч даруухнаар мэхийн ёслов. Тэмүжин суусангүй түүнийг ширтсээр зогсоно.

Хулан огцом хөдөлж нүцгэн биендээ хөдөрсөн дээлээ тайлан хаяв.

Галын бүдэг гэрэлд Хуланы сэргэр хөх уян боловч шөрмөслөг гоолиг биенээ галын улбар туяа тусч өнгийн чулуун сийлбэр шиг үзэгдэв. Тэмүжин хүчээр биеэ барин хэнэггүй царайлж байхыг Хулан мэдэрлээ. Тэмүжинг шууд байлдан дагуулж эрхэндээ оруулахыг Хулан хүсч байлаа.

-Чамайг эцэг чинь надад хүчээр авчирч өгөв үү. Энэ бол тун аюултай сорьж туршсан асуулт байлаа. Юу гэж хариулахаа Хулан тэр дор нь олов. Таалагдахгүй үг хэлбэл тэр маргааш өглөө алуулах юм уу, аль эсвэл Тэмүжин хэн нэг цэрэгт хаяж өгөх байв. - Аав минь намайг танд өгөх, бас танд дагаж ирэх дургүй байв. Харин би хаан танд ирэхийг эцгээсээ гуйж шаардсан билээ гэж Хулан үнэн үг хэлэхдээ эцгээ ер өрөвдөж хайрласангүй.

-Чи өөрөө надад ирье гэсэн гэнэ ээ. Чи юу хүснэ гэж Тэмүжин зэвүүн шивнээд нэг алхам ойртов. Харин Хулан байрнаас хөдөлж ухарсангүй түүнийг эгц ширтэж байгаад сэтгэлийн дотор байдаг хамгийн их хүслээ шууд дуржигануулан өчжээ.

-Хаан та гурван их хатантай гэсэн. Би таны дөрөв дэх их хатан болохыг хүснэ. Та намайг эдэлж сорьж үзэгтүн. Эс таалагдвал өглөө намайг алж орхи. Надад таны хатан болох эс чадвал үхэхээс өөр хүсэл үгүй гэж тод хэлжээ. Энэ омголон зоримог мэргэд бүсгүй Тэмүжинд таалагдаж байсан ч өөдөөс нь ингэж ач тач үг хаях нь хилэнг нь хөдөлгөв.

Тэмүжин энэ дэндүү шулуун задгай, эрээ цээргүй гэмээр үгэнд уурссандаа Хуланг зэрлэг догшиноор угз татан тэврэн авсан нь зүгээр л шууд хүчирхийлэн эдлэе гэж бодсоных байв

.Гэтэл бүгд санасны эсрэг болжээ.

Бүсгүй огтхон ч эсэргүүцсэнгүй ингэнэ гэж хүлээж байсан юм шиг гарын аяар наалдан ирээд зогссонгүй бүр Тэмүжинг ширдгэн дээр түлхэн унагаад даран авчээ. Тэмүжин ийм юм үзээгүй тул эхлээд амиа хорлуулах бий гэж сэргийлэн түлхсэн боловч хожимджээ.

Хулан бүсгүйд тийм санаа үгүй тэр дороо ойлгогджээ.

Учир нь Хуланы савхан хуруунууд аль эрт шалмаг хөдлөн нууц эрхтэнг нь илбэн таалж эхлэхэд Тэмүжин цочиж ичсэн ч эм хүн ингэж тачаадан довтлох нь харин ч таатай санагдаад биеэ суллан Хуланы гарын аяыг дагахдаа

– За яах вэ. Чи их зоригтой бүсгүй юм. Маргааш хүссэнээр чинь би алж орхьё гэж бодсон билээ…

Шөнө болж Саарь хээрийн хөндийд ялсан, олзлогдсон олон хүмүүс унтах нь унтаж, ууж наргих нь ууж наргиж, янаглаж амраглах нь ч янаглан амраглаж байв. Энэ шөнө олон олон хүүхэд эхийн хэвлийд олдож бас олон олон хүн үхжээ.

Тэмүжин мэргэдийн Дайр-Үсэнгийн охин Хулантай жарган цэнгэхийг бүгд үзэж сонсов. Тэмүжиний гэрээс холгүй байсан майхныхаа дэргэд Зүчи бодолд автан удаан зогсов.

Эцгийгээ ингэж элдэв эмс охидтой самуурах бүр Зүчийн сэтгэл тэсэлгүй өвдөн шаналж, холд суугаа Бөртэ ижийгээ өрөвдөн хайрладаг билээ. Өнөө ч яг ингэж зогслоо.

Хулан хэмээх мэргэд эмийн тачаалт дуу ойр орчмыг сэргээж, адгуусны ч болов сэрлийг өдөөхөөр ажээ.

Эцгийнхээ энэ шалиг явдлыг Зүчи ер сайшаан бодсонгүй.

Тэр дундаа мэргэд эмтэй самуурах нь бүр байж болшгүй хэрэг байв.

Учир нь мэргэд аймаг бол Бөртэ эхийнх нь бас Зүчийн хамгийн заналт дайсан билээ.Ингэж бодох нь эхийгээ өрөвдөхөөс болдог байв.Бөртэ эх нь Зүчийн хувьд энэ ертөнцийн хамгийн их зовж шаналсан хүн юм.Хулан нэрт их тачаалт эмээс болж эх нь дахин зовох юм шиг гунигт бодол төрөөд Зүчийг унтуулсангүй.

Харин Хуланд эдлүүлж нойргүй хоносон Тэмүжин маргааш өдөр нь аажуу өндийхдөө урьд үдшийн хатуу бодол шийдвэр өөрчлөгдсөнд ихэд гайхав. Тэр Хуланг алах нь бүү хэл их зориг, хэмжээгүй тачаалыг нь үнэлж гайхан бишрэхдээ хатан буулгахаар шийдэж эл хэргийн учрыг эхлээд Өүлэн эхэд уламжлуулахаар Боорчийг Хэрлэн мөрний тийш төв өргөө рүү илгээв.

Өүлэн эхэд түрүүлж хэлүүлсний учир нь Бөртийн сэтгэлийг эмзэглэх бий гэж санаа зовсных тэр юм. Учир нь Хулан бол Бөртийг булаан аваачиж бие сэтгэлийн зовлонд учруулсан мэргэд аймгийн хүн байсных билээ. Ийм явдлыг Бөртэ сайшаан угтахгүй нь лавтай. Харин Өүлэн эхдээ түрүүлэн учирлавал эв зүйг нь олж зөв найртайгаар шийдвэрлэх нь гарцаагүй гэж Тэмүжин итгэж байв. Аливаа хүнд бэрх үед зөвийг хэлж эвийг олдог нь Өүлэн эх юм.

Боорчийг илгээсэн цаад наад нарийн учрыг Өүлэн эх гадарлан ухаарах нь мэдээж тул Тэмүжин тайван сууж, олзлогдсон мэргэдийг хэрхэх тухай хөвүүд болоод Хасарын хамт зөвлөлдөв. Бас үдэш нь Хуланы эцэг Дайр-Үсэнг урьж дайлахаа ч мартсангүй. Тэмүжин угаас юмыг жижиг гэж орхидоггүй зантай юм.

Хуланы Тэмүжинд таашаагдсан нь олзлогдсон мэргэдийн хувь заяаг нааштай эргүүлж, тэднийг хүрээ хотод нь үлдээн зүүн өрх тутам ахлагч томилж, бүх мэргэдийг Дайр-Үсэн ахална гэж Тэмүжин зарлиг буулгав. Хуланг шударгаар асран авчирч өгөөд бас үнэн үгээ хэлсэнд Наяаг нөхөрлөж болох хүн гэж ихэд тоожээ.

*****

Тэмүжиний их хүрээнээс холгүй тусдаа намаржиж байсан Өүлэн эх гэнэт дуудуулсанд Бөртэ ихэд цочин гайхжээ. Энэ үед Бөртэ хөдөө гэрт зарц шивэгчид болоод татвар эмсийг цуглуулан эсгий хийх унгас саваадуулж байжээ.

Энэ бол намар цагт талын нүүдэлчдийн хийдэг хамгийн чухал ажлуудын нэг бөгөөд удахгүй ирэх хахир өвлийн бэлтгэл юм.Өүлэн эхийн ийн гэнэт дуудсан нь туйлын сэжигтэй санагдсан тул Бөртэ их өргөөгөөрөө орж хувцасаа ч солилгүй дан мориор дагуул шадраа шавдуулан давхисаар Өүлэн эхийн хүрээнд очжээ. Мэргэдийг дайлахаар явсан хөвүүд нь хамгийн түрүүн бага балчир Тулуй хүү нь санаанд орж муу л юм бодогджээ.

Дайны талбараас Боорчи ирж Өүлэн эхтэй уулзсаныг шивэгчдээс олж сонсоод бүрч сэтгэл зовжээ.Өргөөнд нь бараалхан ормогц сайтар ажигласан ч Өүлэн эхийн царайнаас муу сэжиг илэрсэнгүйд тайвшрав.Харин Өүлэн эх мэндийн үг солиод цай идээ тавьж зарц шивэгчид гарсаны хойно -Чи Чингис хааны их хатан мөртөө харц зарц шиг энгийн хувцаслаж, эзэнгүй мэт явах чинь юу вэ. Чамайг ингэж явахад Есүй, Есүгэн хатад яах вэ. Хаан хүнийг хатны нь явдал суудлаар хэмждэг юм гэж зэмлэх үгийг хамгийн эхлэн хэлэхийг сонсоод дэмий яарсандаа харамсавч оройтжээ. Өүлэн эх уурлаж загнавал муу юм хэлэхийн дохио билээ.

Тийм ч учраас Бөртэ Өүлэн эхийн зэмлэхийг сонсоод дахин түгшүүрт автав.Өүлэн эх ямар нэгэн муу мэдээг хэлж чадахгүй нууж байх шиг санагджээ.Бөртийн мэгдэж сандрахыг үзсэн Өүлэн гэнэт түүнийг өрөвдөн хайрлан тэвэрчээ. Энэ хачин байдал Бөртийг эхлээд гайхуулсан ч бас ихэд уярааж, Цотон эхээ нас барснаас хойш ганцаардан шаналж явсан сэтгэл нь урагдан сэмэрч тэсэлгүй нулимс асгаруулав. Эхийнхээ энгэрт толгойгоо наагаад асгартал уйлах хүсэл бүсгүй хүнд хичнээн их байдгийг Бөртэ сая л мэдэв. Эхгүй өнчинд уйлах ч хүн олддоггүй ажээ. Бөртийн үнэн сэтгэлийн нулимс Өүлэнг ч уяраав.Тэмүжинийд ирж зовлон түгшүүр баяр баясгалан аль аль нь дүүрэн амьдарсаар ирсэн ч төрүүлсэн эх Цотон нь нас нөгчсөнөөс хойш яаж ихээр ганцаардаж явснаа Бөртэ мэдсэнгүй ажээ.

-Иш чааваас даа. Охин минь. Уйл уйл. Ижлээсээ төөрч хоцорсон өнчин унага шиг, хөхнөөсөө гараагүй янзага шиг амьтан манайд ирсэндээ чи. Хайртай аав ижий, өссөн, дассан нутаг усаа орхиод ядуу Тэмүжинг минь дан дээлтэй, даавуу гэртэй гэж гололгүй ирсэн охин үр минь. Би чамайг яасан ч их зовлонд унагав даа.

Чи Тэмүжин хөвүүний минь төлөө бүлээн сэтгэлээ зарж бүтэн биеэ үрсэн. Ижий нь чамайг

ойлгож байна. Төрсөн эцэг эх рүүгээ буцмаар үе чамд олон байсан биз. Би ч чамайг өрөвдсөндөө буцаасай гэж санасан үе олон бий. Гэвч чи яаж буцах билээ. Би чамайг яаж ч буцаах билээ. Тарж сарниж хагацаж өнчирсөн Есүхэйн удам, Боржигон аймгийн нэрийг бүтэн болгож, бүр ургуулж төлжүүлсэн нь Бөртэ чи юм шүү дээ. Чиний гавьяа зүтгэлийг хэн ч хэзээ ч үгүйсгэн буцааж үл чадна. Тиймээ, чи надаас болж мэргэдэд булаагдсан. Буцаж ирснээс чинь хойш Тэмүжин чамайг яаж хардан, хажиглаж зовоосныг би л мэднэ. Өөр хэн ч мэдэхгүй. Чи надад гомдлын ганц үг ган гэж дурсаагүй ч өглөө бүр би чиний нулимс нэвчсэн харцнаас чинь зовлонг чинь мэддэг байлаа. Гэвч чи даанч дэндүү тэвчээртэй хүн дээ охин минь.

Чи бол миний дээлтэй төрсөн охин үр минь юм шүү. Миний амьдрал ганцхан хар бараан сүүдэр шиг байсан. Гэтэл ижийнхээ өврөөс ч гараагүй шахам, өрөвлөг нь хатаагүй ангаахай шиг охин Тэмүжин хөвүүнтэй минь хамт уяан дээр буугаад инээгээд ирэхэд чинь олон жил уйлахгүй гэж хураасан нулимс сул асгараад ухаан балартсан юм. Чиний гар тэр үед ийм ширүүн байгаагүй. Хөөрхөн булбарай зөөлөн алга чинь духанд хүрч “Ижээ” гэж дуудахад би сэрсэн. Чи яг л ижий минь эргээд ирэх шиг үзэгдсэн шүү. Чи миний охин мэт, бас ирэхгүй одсон ижий мэт ирсэн юм даа. Есүхэйн удмыг амьд үлдээх гэж, амьдруулах гэж, өсгөж үржүүлэх гэж чи бид хоёр зүтгэлээ.Би өөрийгөө зовов.Хэн нэгний төлөө амьдрав гэж хэзээ ч бодож байсангүй. Энэ бол чи бид хоёрын биелүүлэх ёстой Тэнгэрийн зарлиг биз.

Чи бид хоёр одоо нэг нь хаан хүүтэй,нөгөө нь хаан эртэй боллоо. Чи ирээдүйн монголын их хаадын эх болжээ. Тэгэхээр чи нулимсаа арчиж үз, хааны хатан шиг байж үз.Монгол угсаатны төлөө байгуулсан гавьяагаа бодоод Бөртэ чи, бас Өүлэн би хэний ч өмнө уруу дорой явах эрхгүй болжээ. Өүлэн энэ бүх үгсийг Бөртийг зорижуулах гэж хэлж буйг тэр ойлгов. -Есүй хатныг ирснээс хойш чи биеэ тордож асрах чинь багасаад нэг л алмай алгуур болжээ.Шинэ хатны өмнө чи хэзээд омог төгөлдөр их хатан байх ёстой юм шүү. Чи над шиг эмгэн болсон биш, нас зүс чинь идэр сайхан хэвээр байна.Бөртэ чамайг олон бүгдээр харж биширч дагаж байна.

Чи одоо Чингис хааны их хатан болжээ.Удахгүй улсын их хатан болно. Өүлэн эх чухам юу гэж хэлэхээр дуудсаныг Бөртэ гэнэт тааварлав. Зүрх нь түргэнээ цохилж гомдол нь буцлаад ирэв.Гэвч жирийн нэг гэрийн эм шиг атаархаж хорсох цаг нас биш гэдгийг мэдэж байв.Гэвч эм заяанд төрсөн юм болохоор хардаж харамлахын зовлонгоос ангид байсангүй.

-Ижий минь та хэлэгтүн. Би одоо цочиж түгшихээ больсон. Би таны хэлснээр биеэ тордохоо ч анзаарна гэж Бөртэ сэтгэл зориг шулуудан үсээ илбэж суудлаа засч хэлэв.

- Бөртэ. Тийм бол чи сонсогтун. Өүлэн үгээ үргэлжлүүлэхийн өмхө түр азнан бодолхийлэв.Есүгэн,Есүй хатдыг авчирахад Бөртэ тийм ч дуртай байгаагүйг Бөртэ сайн мэдэх учир үгээ цэгнэх ёстой болжээ.

Гэвч Чингис хааны хүслийг эсэргүүцэх юм уу эгдүүцэх нь төрийн ёсонд харш болно гэж Өүлэн бат итгэх бүлгээ.Гэвч бүсгүй хүн хэзээд л бүсгүй хүн байх ажээ.

- Чингис хаан нэг бүсгүйг хатан өргөмжлөх гэнэ. Энэ тухай намайг чамд хэл гэж элчээр зарлиг болгожээ. Тэгээд чиний зөвшөөрлийг хүсчээ.Энэ үгийг хэлэхэд надад ч хэцүү

байна.Гэвч би Чингис хааны зарлигийг чамд уламжлахаас өөр яах билээ гэж Өүлэн хэлэв.Бөртийн дотор нэг юм өгсөөд иржээ.Гэвч аль болох тайван байхыг хичээв -Залуу сайхан бүсгүй биз. Надаас зөвшөөрөл хүсэх юув гэж Бөртэ тэсэлгүй унтууцав.

-Чи бүү уурла. Учир нь тэр бүсгүй нь мэргэд хүн юм байна.Увас мэргэдийн толгойлогч Дайр-Үсэн гэгч хүний Хулан гэдэг охин гэнэ гэсэн Өүлэний үг хэлэхэд ч сонсоход ч хэцүү байлаа. Бөртэ шүд зуун асар их тэвчээр гаргаж тэвчиж суув.Юм ч дуугарч чадсангүй.

-Тэгээд Хулан хатны өргөөг хаана барих, хэзээ тосч авахаа их хатны хувьд чамайг хэлэгтүн гэжээ. Чингис хаан нэгэнт чамайг мэд гэсэн тул чи их хатны хувьд хариу хэлж элчийг буцаах болжээ гэж Өүлэн тушаах аргадах хослуулан хэлэв.

-Чингис хаан нэгэнт зарлиг буулгасан хойно би юу гэх вэ дээ. Ижий минь. Би өргөөг нь бэлдэж бариулъя. Харин Чингис хаан хэзээ морилохоо өөрөө мэднэ биз гэж элчид хэл дээ гэж Бөртэ арайхийн хэлж чаджээ.

Тэмүжинд гомдсон Бөртийн сэтгэлд хязгаар байсангүй.

-Чи өөрөө наад үгээ Боорчид хэл. Чингис хааны их хатан Бөртэ чи шүү гэж Өүлэн эх хэлэхэд түүний дуунд бүхнийг Бөртэ чи үүрэх тавилантай юм шүү гэсэн хатуу шаардлага тод сонсдох ажээ.Бөртэ ч хатуу заяагаа дагаж үүнээс хойш хүний урманд хөмсгөө зангидсангүй.Өүлэн эхэд хэлснээс нэг ч илүү үг Боорчид хэлсэнгүй. Бөртийн хэлсэн үгийг Боорчи Тэмүжинд үгчлэн дамжуулав.

Бөртийн хэлүүлсэн үгийг сонсоод Тэмүжин өдөржингөө хэнтэй ч уулзсангүй ганцаар бодол болон суужээ.Тэмүжинг шийдвэрээ өөрчлөх гэж байна гэж Боорчи таамагласан ч тийм юм болсонгүй. Хулангийн Тэмүжинд ирсэн учир ийм юм. Харин Бөртэ илүү дутуу өөлсөн үг хэлж, залуу Хуланг ад шоо үзэж, аашилж загнадаггүй ч мэргэд цусны тэр дундаа Дайр-Үсэнгийн охиныг хатан буулгасанд их дургүй байсан билээ. Учир нь Дайр-Үсэн Бөртийг Чилэгэр бөхөөс худалдан авахаар ихэд сүр далайлган тулгаж Бөртэд шунан тачаадаж байсныг бүр Чилэгэр бөхийн эзгүйд ирж хүчирхийлснийг Бөртэ яахан мартах билээ.Тэр үед Бөртэ Чилэгэр бөхөөс хүүхэд олчихсон байсан тул хүний аймагт эзэнгүй хаягдах эсвэл эр дамжин зарагдахаас айж энэ явдлыг тас нуужээ.Үүнээс өөр зам түүнд байсангүй.

Харин охиноо дагаж ирсэн Дайр-Үсэн Бөртийн нүдэнд өртөхөөс үнхэлцгээ хагартал айх тул Тэмүжиний хүрээгээр үл үзэгдэнэ.

Харин Зүчи Хуланг нэг нүдээр үзэхгүй болсон нь Бөртийг багагүй зовлонд учруулсан билээ.Гэвч Бөртэ дотроо нэгийг бодсоор байлаа.Энэ бол Дайр-Үсэнгээс өшөө авах хүсэл юм.Гэтэл бүх зүйл огт санаандгүйгээр эргэв.Хуланг ирснээс хойш хэдхэн сар болоод байтал олзлогдсон, дагаж ирсэн мэргэдүүд үймрэн самуурч салж нүүсэн тул Тэмүжин дахин цэрэг хөдөлгөж тэднийг дарж толгойлогчдыг алсан ч Дайр-Үсэнг алж арай төвдсөнгүй.

Нэгэнт бие сэтгэлийг бүрэн эзэмдэн хамгийн хайртай хатан нь болж чадсан Хуланг гомдоож цочоохыг тэр хүссэнгүй тул хадам эцэг Дайр-Үсүнг өршөөхөд бэлэн байжээ.Харин Дайр-Үсэнг амьд үлдээсэнд Бөртэ маш их дургүйцэн шүүмжилжээ.

Тэмүжин Бөртийн сэтгэлийн цаад учрыг мэдэж байсан ч Хуланг бодоод урван тэрсэлсэн Дайр-Үсэнг өршөөхөөр шийджээ.Гэтэл Хулан үүнийг огт зөвшөөрсөнгүй, эцгийгээ бүр өшрөлт дайсан мэт үзэж “Урваж тэрсэлсэн хүнийг юунд өршөөв” гэж эрс эсэргүүцсэн нь Тэмүжинг хамгийн ихээр бахдуулжээ.

Нэгэнт Хулан, эцгийгээ шударгаар цээрлүүлэхийг шаардсан тул Тэмүжин эргэлзэх юмгүй болж Дайр-Үсүнг алжээ. Ингэж Хулан санасандаа хүрч Тэмүжиний гэрт ганцаар үлдсэнээр барахгүй олны дунд зориг зүрх,шударга шулуунаараа багагүй алдаршин тэдний итгэл хүндлэлийг олжээ.Тэмүжин үүнээс болж Хуланг улам ч дотно хайрлах болжээ. Эргэж буцсан, шийдвэр сул эцгээ дахин гай болохоос Хулан сэрэмжилсэн тул түүнийг даруй алахыг шаардсан учиртай билээ. Эцэг нь нэгэнт дагаж ирчихээд удалгүй мэргэдүүдийг босгон үймүүлсэн нь өөрийн хар толгойгоор зогсохгүй Хуланд ч аюултай хэрэг байсан тул тэр ингэж эцэгтээ хайр найргүй хандсан юм.

Тэр бүү хэл үлдсэн мэргэдүүдийг нэгдэн хүчирхэгжих замыг хааж, тэднийг айл бүрт хуваж тараан өгөхийг ч Хулан санаачлав. Энэ урин тачаангуй, ялдам зөөлөн бүсгүйн хаанаас нь ийм хатуу ширүүн үг, харгис зан гардгийг Тэмүжин таасангүй. Хулан хэдий ихээр гайхуулнав

Тэмүжин өдөр ирэх бүр түүнд улам ихээр татагдан дасах ажээ. Хуланы ганц хүсэл энэ юм. Харин Тэмүжинг ингэж бага хатандаа онцгой дотно байхыг бусад хатад таашаахгүй ч үг хэл хэн гаргах билээ.Харин Бөртэ Тэмүжинг Хулангийн хамт өргөөндөө урихгүйд Тэмүжин их гайхна. Уг нь тэр ийм тоглоомд их дуртайсан.Залуу үзэсгэлэнт хатнаа үзүүлэх хүсэл их байвч Бөртийн хуучин шарх сэдрэхээс болгоомжлон Тэмүжин Бөртийн өргөөнд очихдоо Хуланг ер дагуулдаггүй байв.Хулан бол мэргэд цусных гэдгийг Бөртэ ч, Тэмүжин ч адил нэг ч өдөр мартаагүй билээ.Дайр-Үсэнг үхүүлж мэргэдийн хэрэг нэг тийш шийдэгдсэний дараа нэг өдөр Чингис хаан Бөртэ хатныдаа хоножээ.

Хулан хатныг ирснээс хойш тэдний хооронд үүсэж бий болсон хүйтэн хөндий байдал Дайр-Үсэнг үгүй болсноор бага боловч дулаарсан нь ил байлаа.Тэмүжинг ингэж хоногоор ирсэнд Бөртэ их догдлон залуу бүсгүй шиг улайж уусан дарсандаа ялимгүй согтуурч тас тас хөхөрч жаргалтай суужээ.”Ашгүй Бөртийн гомдол арилжээ” гэж Тэмүжин баясан бодоод өнөө шөнө явахгүйгээр шийдэв.Уг нь тэр Есүй хатныдаа хонъё гэж бодож байсан билээ. Есүйг амаржиж охин төрүүлснээс хойш ер очиж хоносонгүй сар шахаад байжээ.Гэвч Бөртийн ийм аз жаргалтай байхыг Тэмүжин ойрд үзээгүй тул түүнийг орхин явж гомдоохыг хүссэнгүй.Тэр шөнө Бөртийн янаглаж тачаадах нь хязгааргүй болоод Тэмүжин ч гайхжээ.

Учир нь тэд нэг гэрийн эр эм хоёр шиг бие золгуулж учралгүй даруй таван сар болсон тул Бөртийн хагсарч ганцаардсан нь их байлаа.Шөнийн турш загас наадуулж Тэмүжин бүр ядарч хоцров.Тэгэвч “Залуу хатнаа бодов” гэж Бөртийг уурлах бий гэж болгоомжлон шүд зуун тэсэж байжээ.Үнэхээр ч дөч гарсан насны Бөртэ залуу Хулантай хэрхэн дүйцэх билээ.

Харин Тэмүжин Бөртийн янаглалд ядраад дотроо Хуланг бодож хэвтэв. Хулан хатан нь гайхалтай халуун биетэй эм ажээ.Түүний хатад дотор ийм халуун биетэй хүн үгүйг Тэмүжин сая мэдээд гайхжээ. Хулангийн омголон зоримог байдал ер биенээс нь оргилох тэр халуунтай холбоотой болохыг мэджээ. Анх учрахдаа Хулангийн нүцгэн халуун биеийг хүрмэгц ихэд гайхаж цочсон билээ.Бас шатаж байгаа мэт тэр халуун биенд дасахгүй байсан боловч харин

одоо Бөртийн өвөрт хэвтэхдээ Хуланг хүсч мөрөөдөж сэтгэлээ баясгаж байлаа.

Хуланг бодохгүйгээр Тэмүжиний дур сэрэл огт хөдлөхгүй болжээ.Бөртийн хамт янаглаж хэвтэвч Тэмүжин дотроо Хулантай хамт байна гэж сэтгэж өөрийгөө хуурч байв.Бөртэ гурвантай дур тачаалаа асгаруулж байж сая л нэг Тэмүжинг орхиж амраав.Тэмүжин ер түүнээс уйдаагүй мэт тэвэрч хэвтэхэд хуртсан Бөртэ наалинхайтаж

-Тэмүжин би нэг зүйл бодов.Чи юу гэж санана гэж чихэн дээр нь шивнэв.Тэмүжинд энэ хэргийг сонирхох хүсэл огт үгүй байсан тул дуугарсангүй.

-Хулан хатан залуу хүн болохоор төр ёсны аливаа хэрэгт осолдож эндэх нь элбэг.Тийм болохоор би Хуланг аливаа хэрэгт нарийн зааж сургахаар шийдлээ.Ю-Унчиг би Хулан хатны дэргэд шадарлуулъя.Та төрийн ёс хүндлэлд Хулан хатнаа байлцуулах дуртайг мэднэ.Чингис хааны хатан ямар байвал зохих вэ .Тийм байдлаар Ю-Унчи Хулан хатныг сургаг.Би бүх зүйлийг Ю-Унчид сайтар хавсран захина.Ингэж хийвэл чамд ямар санагдана гэж Бөртэ хэлжээ.

Энэ үг Тэмүжинийг нойрноос сэртэл баярлуулав. -Бөртэ чи юу гэж шийднэ.Түүгээрээ хий.Би зөвшөөрөхөөр барахгүй баяртай боллоо.Чи үүнээс хойш Хуланг өөрийн охин мэт үзэгтүн.Тэгвэл миний санаа амарч жаргах болно.Чи Хуланг мэргэд хүн гэдгийг март.Мэргэд гэж өнөө үгүй болсон.Чи тайван сайхан амьдар.Чиний уужим ухаанд би их талархах ёстой юм гэж Тэмүжин үнэн сэтгэлээс хэлжээ.Бөртэ Хуланг өршөөсөнд Тэмүжин хамгаас ихээр баярлав.Мэргэд цусны хатан буулгаж Бөртийн сэтгэлийг шархлуулсандаа Тэмүжин өнөө болтол шаналсаар байжээ.Ядаж байхад Өүлэн эх нь хушуу нэмж

-Хүү минь чамд мэргэдийн энэ хүүхнээс өөр эм хүйстэн олдсонгүй юу.Нүд чинь сохорч болно.Харин сэтгэл чинь сохорч болохгүй дээ.Бөртийг чи хэнд булаалгасанаа мартав уу.Харин Бөртэ үүнийг хэзээ ч мартахгүй биз гэж зэмлэсэн нь Тэмүжинг улам ч зовоожээ.Тэглээ гэвч Тэмүжинд Хуланг буцаан алдах сэтгэл өчүүхэн ч байсангүй билээ.Бөртэ ухаан зарж одоо Хуланг мэргэд хүн гэдгийг мартахаар шийдсэнийг үзээд Тэмүжин сая нэг санаа амарчээ.

Ю-Унчи гэгч тайган эрийг ордны бусад тайганууудын хамт Татаар аймгийг дарахдаа олзлон авчраад Бөртэд өгсөн бөгөөд тэд Чингис хааны их өргөөнд алба хашин суух болжээ.Ю-Унчи гэгч нь хамгийн ахмад туршлагатай бүр Зүрчидийн Алтан улсын хааны ордонд алба хашиж байсан хүн юм.Тэр Ю-Унчи одоо Бөртийн дэргэд шадарлаж Чингис хааны ордны дотоод хэргийн их даамал болсон ажээ.Тийм болохоор Ю-Унчиг Хулан хатанд шадарлуулан өгөхөөр шийдсэн нь Бөртэ Хулан хатанг өөрийн зиндаанд үзэж буйгаа илэрхийлсэн хэрэг гэж Тэмүжин ойлгоод машид баярлаж өглөө нь энэ тухай Хуланд өөрөө дуулгажээ.

Хулан тэр өдөр үнэхээр баяртай байлаа.Учир нь тэр Тэмүжинээс бие шалтагтай болжээ. 1-Хулан чи өөрийгөө мэргэд хүн гэдгийг март гэсэн Чингис хааны үг Хуланг тэр тайган Ю-Унчигаас илүүгээр баярлуулжээ.Харин Хулан өөрийнхөө мэргэд удмыг бүгд мартаасай гэж шунан хүсч байсан тул Чингис хааны дээрх үгийн дараа өөрийгөө дагаж ирсэн бүх мэргэд шивэгчин, зарц нараа бусдад тараан өгчээ. Тэр ямар нэг мэргэд удмын биш, ганцхан Чингис хааны хатан байхыг туйлаас хүсч байв. Түүний мөрөөдөмтгий, ухарч няцашгүй сэтгэлд нь

дийлдэн сөнөсөн мэргэд аймгаас гаралтай байх нь тэвчишгүй доромжлолтой мэт санагдана.

Хулан Чингис хааны өвөрт түүний дур хүслийг эзэмдэн хэвтэхдээ ер ичиж айх зүйлгүйгээр энэ мэт зүйлийг хэлдэг билээ.Тэмүжин Хулан хатныхаа хөнгөн бодол хөөрүү гэнэн үгийг сонсоод элэглэн хөхөрсөн ч дотроо Хуланы цаад санаа зорилго их бөгөөд зөв болохыг мэдэж улам ч хайрлан тоох болжээ.

Хулан бол бүхнээс онцгой содон илбэ шидтэй мэт бүсгүй байв.

Энэ бол ганц түүний гоо үзэмж биш юм. Ойр хавийнхны эмс хатдын дунд Хасарын Хуаржин хатан гоо үзэмжээр онцгой бөгөөтөл Хулан түүнээс ер дутахгүй харин ч давах тул Тэмүжин сэтгэл ихэд ханадаг байлаа. Бас Хуланы эм хүнд байтугай, эр хүнд ч цөөн байх эрс хатуу зориг, зорьсон санасандаа хүрэхийн тулд цуцалтгүй тэмүүлэх чанар нь Тэмүжинг бүр бишрүүлсэн юм. Хулан бол ганц Тэмүжинд зориулан Тэнгэрээс илгээсэн хүн биз гэж заримдаа бодогдоно. Харин Хулан Тэмүжинд ирээд хөл хүнд болсон ч гай болж үр зулбаснаас хойш дахин хүүхэд олохгүй болсон нь хөөр жаргал дүүрэн амьдралын ганц бараан сүүдэр, Хуланы сэтгэлийн шаналал болжээ. Есүй, Есүгэн хоёр охидтой бол Хуланд охин ч заяахгүй байгаа нь Тэнгэрийн цээрлэл шиг болж үүнд Хулан бүү хэл Тэмүжин ч шаналан зовж үрийн хүслэн болсон хөөрхий Хуланг өрөвдөх бүлгээ.

Дөрвийн дөрвөн хөвүүн төрүүлж Чингис хааны алтан ураг,Их монгол улсад дархлагдсан их хатан Бөртийн илэрхий дээгүүр дээрэнгүй харц дийлдэн дарлагдаж сураагүй Хуланг байж суухын аргагүй болгоно.

Мэргэдүүд нэгэнт булаан авсан юм бол Бөртэ хэмээх энэ бүдүүн авгайг алчихгүй яав гэж заримдаа үзэн ядахдаа шаналан боддог болжээ. Их хатан Бөртэ болоод Есүй, Есүгэн хатныдаа Тэмүжинг хоноход Хулан боож үхмээр, тэр эмсийн гэрт нь дайран орж алалдан тэмцмээр Тэмүжинг түүнээс булаагч эмсийг урж тасчин хаямаар ер солиормоор болно.

Тэмүжинг ингэж бусад эмтэй хуваан хэрэглэхийг, бас тэднээс дорд үзэгдэхийг Хулан арайхийн тэвчиж байв.

Тэр дундаа бүдүүн Бөртийнд очиж хоноход нь бүр галзуурах дөхнө. Хорсол, занал, үзэн ядалтаа дараа нь Тэмүжинд гаргаж тачъяадсан дүр үзүүлэн мөр хүзүүг нь улаан эрээн болтол хазаж орхих билээ. Нулимс урсган орилж чарлаж хазаж маажиж байгаа түүнийг Тэмүжин дур тавьж тачаадаж байна гэж бодохоос цаашгүй. Харин Хуланы дотор өш хонзон, уур цухал дүрэлзэн шатаж байдаг билээ.

Хулан үзэн ядсан, өрсөлдөн тэмцэх хүслээсээ болж заримдаа хэн нэгнийг тэр дундаа Бөртийг багалзуурдан алах бий гэж өөрөөсөө ч айх болжээ. Хуланы энэхүү сэтгэлийн хямралыг Тэмүжин сайн мэдрэх боловч бас яаж ч эс чадна.Хүүхэд гаргахаараа зүгээр болно гэж бодсоор байтал олон жил өнгөрчээ.Бас дээр нь Алтан улсыг дайлаар мордохдоо Чингис хаан Есүй хатнаа дагуулан явсан нь Хуланг ястой галзууруулжээ.

Алтан улсад дайлаар явахдаа өөрийг нь дагуулна гэж дотроо бат итгээд бүр өмсөх зүүхээ хүртэл бэлтгэн хүлээж байсан билээ.Гэвч Хуланд хувь заяагаа дуугүй дагахаас өөр арга дааанч

байсангүй.Учир нь тэр өөрөө л энэ амьдралыг сонгосон билээ.Тэмүжинээс дахин хүүхэд олоогүй нь түүний Тэмүжинд гологдох шалтаг болов гэж өөртөө гомдон өргөөндөө уйлж хэвтэх нь олон болжээ.Ийм үед түүний дэргэд өнөөх тайган Ю-Унчи дув дуугүй зогсож байх бөгөөд хөөж туусан ч тэр явахгүй бүлгээ.Хулан түүнийг хавь ойрын гартаа тааралдсан болгоноор нүүлгэж байгаад тайвширдаг байв.Харин Ю-Унчи шидсэн юмсыг түүж буцааж тавьдаг билээ.Хулангийн зовлон шаналалыг Чингис хааны Алтан улсаас ирэхдээ авчирч өгсөн их бэлэг өчүүхэн ч тайтгаруулсангүй.

Энэ бүдүүн бөгст татаар эм Есүйг юунд нь болж ингэж сар жилээр аян дайнд дагуулж явдаг юм бол.Би түүнээс юугаараа дутав гэж хорсон бодох нь багасаж нимгэрсэнгүй.Алтан улсаас ирээд Чингис хаан Хулан хатныхаа хамт хаашаа ч явалгүй жил суусан нь ч бас шинэ орд өргөө байгуулах газар нутаг сонгохоор үзэсгэлэнт гол усыг хэсэн явсан нь ч өчүүхэн ч тайвшруулсангүй.

Харин Хуланд тайвшрах нэгэн шалтаг бий болсон нь монголын их цэрэг баруун зүгийн Хорезм улсыг дайлахаар болж, Тэмүжин Хулан хатнаа дагуулан явахаар амалсан явдал байв.Хулан энэ үгийг сонсоод маргааш өглөө л явах гэж буй мэт хөөрөн догдолж, шөнөжин нойргүй хонохыг үзээд Тэмүжин анх удаа Хуланг асар ихээр хөөрхийлөн өрөвдөж билээ. Хэрэв Алтан улсад явсан шигээ Хуланг дахин орхин явбал тэр тэсэхгүй амиа бүрэлгэж мэдэхийг Тэмүжиний дээрх үгийг сонсоод дүрэлзсэн харцнаас нь үзэж түүнийг орхихгүйгээр шийджээ.

Гэвч Хорезмд хэзээ явахаа Тэмүжин ч сайн хэлж мэдэхгүй байлаа.

Хулан лав хоёр жил хүлээх байв.

Гэвч ганцаардаж зовж шаналснаас хоног тоолон хүлээж суух нь Хуланд хамаагүй дээр гэж Тэмүжин боджээ.Бас энэ бол одоохондоо ганцхан Хулан чи бид хоёрын мэдэх нууц шүү гэж хэлсэн нь Хуланг баярлуулж тэр одоо хичнээн жил ч хүлээсэн чадах болжээ.

Алтан улсад Есүй хатнаа авч явснаас болж Хулан эгдүүцэл гомдлын сайн муу үг олныг хэлснийг Тэмүжин мартахгүй санаж явсны учир энэ билээ. Хатад дундаас хэн нэгийг нь илэрхий дээгүүр үзэж, онцгойлохыг Тэмүжин хүсдэггүй байв. Харин Бөртэ бол хөвүүдийн эх, их хатан учир ганц Тэмүжин ч биш бүх хүн бүр улс даяараа Бөртэд онцгой хүндлэл үзүүлнэ. Ингэх ч ёстой юм.Энэ бол их улсыг байгуулахад хамгаас их зүдэрсэн нь чухам Бөртэ хатан гэж Чингис хаан үздэгийн баталгаа гэрч билээ.

Алтан улсаас олзолж, булаасан эд агуурс,алт эрдэнэ,амуу будаа,албат боол цэрэг бүрийн ар гэрийг баяжуулаад зогссонгүй, бас дахин үүнээс ч илүү их олз олох, түүний тулд дайн хийж,шинэ газар орныг эзлэн авах булаан дээрэмдэх их хүслийг оргилуулж, олон ардын энэ их шунал хүслийг Чингис хаан нэгтгэн зангидаж нэг зүгт чиглүүлж байлаа.

Их Монгол улс бүхлээрээ олзны төлөөх шуналд эргэлтгүй автаж, дийлж ялж сурсан их цэрэг нь юунаас ч айж эмээхгүй омог зоригоор шатаж байв.

Одоо тэд Чингис хаан юу гэж зарлиг буулгахыг хүлээн гар дохивол дайран ороход бэлэн

даланд хашигдсан үерийн их ус шиг оволзож байлаа.

Асар их шунал тачаал агуу их хүчийг бий болгодгийг Чингис хаан мэдэж авчээ. Хэдийгээр монголын их цэргийн дайны онгод ид орж хүч чадал нэгэнт зузаараад хэзээ хэзээнээсээ илүү хүчирхэг болоод байсан ч Чингис хаан цэргийн хүчээ яаран ашиглахыг хүлээзнэж байв. Тэрээр дайлан эзлэхээр завдаж буй улсынхаа ард олны амьдрал байдал, сэтгэл санаа хийгээд эздээ хэр итгэн хүрээлж буйг урьдчилан сонирхож цаг улирал, аж ахуйн нь талаар хэл мэдээ авах, ер Чингис хааны суу алдар, сүр хүчийг аль хэр мэдэж буйг нь тандаж мэдэхийг чухалчлан энгийн худалдаачдын дүрээр олон олон тагнуул туршуулаа илгээх болжээ. Арга чаргаар буулган авч болохгүй аваас амь өрсөн тулалдах үед анд холбоотон нь хэн бэ гэдгийг сураглан мэдэж болзошгүй холбоотныг эв найр, эд баялаг, эмс охидын нүүрээр өөртөө татахыг эрхэмлэж байлаа. Ийнхүү тагнуул туршуул урьдчилан илгээж олж цуглуулсан мэдээ зангийг өөрийн хөвүүд, өрлөг жанжин, үнэнч баатруудтайгаа зөвлөлдөх журам тогтоожээ. Их цэргийн сүр хүч, Чингис хааны суу алдраар далайлган цус урсгалгүй буун өгч дагаар орохыг тулган шаардаж эвийн бодлого, цэргийн сүр хүчийг хослуулан эрх мэдэлдээ оруулах алтан аргамжийн арга ухааныг хэрэглэж байлаа.

Шашин шүтлэг, амьдрах арга өөр Хорезм улстай болгоомжтой харьцаж, эхлээд худалдаачны дүрээр олон зуун тагнуулчаа янз янзын замаар цувуулан илгээсээр хоёр жил болжээ.

Хорезмийн хаан Мухамедад “Би чамайг хүү шигээ үзнэ” гэсэн үгтэй баахан дээрэнгүй бардам захидал илгээсэн нь тэдэнд таалагдсангүй бололтой. Гэвч элч илгээж найртай явахыг хүсэмжилсэн нь яах аргагүй Чингис хааны сайн санааны үр байсан боловч Хорезмийн хааны эхийн садангийн хүн Сыр-Даръя мөрний эргийн Ортар хотын захирагчжанжин Хажирхан гэгч Чингис хааны илгээсэн худалдаачдыг алсан хэрэг мандав. Хорезмоос дутахгүй их газар нутгийг эзэлж өөрийн их сүр, хүч чадалдаа эрдсэн ч болгоомжлон найртай харилцахыг чармайсан дүр үзүүлж байсан Чингис хааны тэвчээр алдарч энэ хэрэг харин ч сайхан далим болов. Чингис хаан цэргээ сурган бэлтгэхээ эрчимжүүлж урьд нь дагаар орсон Тангуд улсыг Хорезмыг дайлахад зүүн гар болон цэрэг гаргахыг сануулав.

Гэтэл их санасан газар есөн шөнө хоосон гэгчээр Тангудын хааны жанжин Жаха-Хамбу гэгч “Хүнээс цэрэг гуйвал дайтахын хэрэг юун” гэж их үг хэлээд цэрэг гаргасангүй нь Чингис хааны хилэнг оволзуулж золтой л Тангуд руу цэргээ гуравдахиа хөдөлгөсөнгүй.

-За яахав. Би даан ч их хэрэгт зориглосон тул энэ удаа хойш тавъя. Тэнгэрт ивээгдэж их ялалт авч ирээд Буур хаан чамаас ял асууя гэж Чингис хаан арайхийн тайвшрав. Хорезм улсыг дайлах бэлтгэл бүрэн хангагдаад цэргийн агт морь, идэш хоол, зэр зэвсгийн нөөц ачсан их хөсөг баруун зүгийг чиглэн өдөр бүр хөдөлсөөр байлаа.Их дайны бэлтгэл агт, хүнс зэвсгийн нөөц Чингис хаанд дагаж орсон Харлаг, Хар Кидан, Уйгар улсуудад ийнхүү бөөгнөрч дуусав.

Хулан дайнд явна, үзээгүй улс гүрэн үзнэ гэхээс нэг ч хоног тайван унтаж чадахгүй байлаа. Энэ насны нь ганц хүсэл дайн тулаан байсан юм шиг хөөрч догдлоод хоол унднаас ч гарав. Өмсөх зүүх хувцас, суух сүйх гээд түүнд зориулсан бүх зүйл бэлэн болов. Зөвхөн Хулан хатныг хамгаалан авч явах шилдэг зуун цэрэг эгнэн жагсав.

Бас зам зуур хэрэглэх хоол хүнс, өргөө майхан, өмсөх зүүхийг Ю-Унчи ажлаа мэддэг тайган

хүний ёсоор жин тан болгожээ.Үүнийг үзээд Хулан бахдан хөөрч дэмий нэг төрсөн эцгээ, цус нэгт мэргэд аймгаа сөнөөгөөгүйг ойлгов. Тэдний амь насны оронд энэ их хүндлэлийг түүнд үзүүлж байх шиг санагджээ. Морь унахад нь зориулж хөнгөн хөө хуяг, дуулга сэлт хийж өгсөн нь хамгийн ихэд таалагдаж, цэрэг болж сэлэм агсахад ч бэлэн байв. Сэтгэл санааны бухимдал сатаарч хүүхэд шиг хөөрч догдолсон Хулан хатнаа хараад Чингис хаан баярлаж ажээ.

Хорезм бол хүчирхэг том гүрэн тул Тангуд, Уйгар, тэр бүү хэл Алтан улстай зүйрлэн үзэж болохгүй юм. Дайны бэлтгэлийн хажуугаар Чингис хааны дараа хөвгүүдээс хэн нь хаан сууринд өргөмжлөгдөхийг хатад нь тэр дундаа Бөртэ илэрхий шохоорхон асууж, Цагадайг өргөмжлөхийг шаардах болсон нь Чингис хааныг зовоож байлаа.

Есүй, Есүгэн хатад хөвүүн төрүүлээгүй тул тэдэнд энэ талд өрсөлдөх, санаа зовох зүйл байсангүй. Гэтэл Тэмүжинд ирээд арван зургаан жил болсон бага хатан Хуланд Чингис хааны дараа Зүчийг хаан ширээнд залгамжлуулах хүсэл илт байв.

Чингис хаан Хуланы энэ этгээд хүслийг мэдсэн боловч цаад нарийн учрыг тааж ойлгохыг хүссэнгүй.

Ерөөс Хулан бол үргэлж элдэв дээдийг сонирхож, оролцож байдаг эцэж цуцдаггүй омголон, сониуч зантай хүн тул түүний энэ шохоорхолыг сүрхий чухалчлан бодсонгүй орхив. Гэвч Хулан хатны бодсон нь Тэмүжиний санаснаас илүү хол гүнзгий явдал байлаа. Хулан анхилам үнэрт дэрээ тэврэн эзгүй ганцаар хонох бүртээ өөрийн амьдрал, ирээдүйг үргэлж бодож төлөвлөх зантай болжээ. Зорьж зүтгэж явсаар тэр суут Чингис хааны бага хатан болов.

Гэтэл Тэнгэр түүнийг ивээж үр хүүхэд заяасангүй нь гуниг, түгшүүрийн үндэс үүсгэсэн билээ. Бөртэ, Есүй,Есүгэн хатад тэр бүү хэл олон татвар эмс нь Тэмүжинээс үр хүүхэд төрүүлсэн байхад харин Хулан Тэмүжинд ирээд арван зургаан жил болоход анхны үрээ золгүй тохиолдлоор зулбаснаас болж дахин хүүхэд олсонгүй ажээ.Алгаараа илбэхэд мэдрэгдэж амьсгаа нь хүртэл сонсогдом байсан үр нь гэнэт түүнээс зугатах шиг үхдэл болон зулбасныг одоо ч санахад хар дарсан аймшигт зүүд мэт санагдана.Хулан ер өвдөж хордолгүй, тэнхлүүн эрүүл саруул байсан мөрт үр нь зулбасаныг муу санаатны хорлол болов гэж өнөө ч Хулан итгэсээр билээ.Хэрэв тэр хөвүүн нь эсэн мэнд төрсөн бол Хуланы амьдрал огт өөрөөр эргэх байв.

Нас залуу цус шингэн түүнийг дахиад нэг байтугай олон хүүхэд төрүүлнэ гэж бүгд тайвшруулж бас Хулан ингэж горьдсоор энэ олон жилийг баржээ.Одоо Хулан Тэмүжинээс хүүхэд олно гэдэгтээ бараг итгэл тасарчээ.Хуланы үр төрүүлдэггүй байдал түүнийг олны өмнө тэр дундаа дөрвөн хөвүүн төрүүлсэн Бөртийн дэргэд өчүүхэн дорой нэргүй эм болгон хувиргадаг нь тэвчиж болшгүй доромжлол байлаа. Хулан үргүйдээ гутаж гуних нь хязгааргүй болжээ.Гэтэл нас залуу цус шингэн хатнаа өвгөрч жар дөхсөн эр нь эдлэн жаргаах нь өдрөөс өдөрт холдож, өврийг гийгүүлж хонож өнжлөө ч эрхэлж янаглахаас илүү, эрт унтахыг хүсэмжлэх болсон нь үнэн юм.

Тэмүжиний хатан болно гэж тэмцэж ирэхдээ ийм зовлонт шаналал үзнэ чинээ Хулан санасангүй. Тэмүжин тэд дахин үртэй болохгүй нь нэгэнт тодорхой болсныг хүлээн зөвшөөрч, хувь заяагаа дагах нь түүнд дэндүү харуусалтай тул олон шөнийн нойроо баран

элдэв янзын арга замыг сүвэгчлэн ухаанаа ухаж,учрыг бодох болжээ. Чингис хаан нэгэн өдөр тэнгэрт халих нь хэнд ч ойлгомжтой, тэр муу өдрийн хойно Хулан хэн болж хоцрох билээ гэсэн ганц бодол түүнийг хамгаас илүүгээр тарчлаах болжээ.Төрүүлсэн үргүй түүнийг хэн хүн гэж тооно. Төрөлх аймаг нь устан мөхөж, дуугарах хүнгүй, дуурсах нэргүй болов. Хулан тэгвэл хаана очиж яаж амьдрана.

Хулан бол үл тайвшрах догшин сэтгэлтэй тул Тэмүжинг өнөө маргаашгүй үхэхээр сэтгэж чадах ажээ. Нээрэн Чингис хаан элс мэт хийсч, мөс мэт хайлж одвол түүнд юу үлдэх билээ гэдэг бодол Хуланг өдөр шөнөгүй зовоох болжээ. Хорезмд дайлаар мордохдоо түүнийг дагуулан явахаар Чингис хаан зарлиг болгосон нь зөвхөн сэтгэл санааг засах, зовлон шаналалыг нь мартуулах гэсэн арга төдий болохоос юуг ч өөрчилж эс чадахыг Хулан сайн ойлгож байв.

Харин Хуланы ирээдүйн амьдрал Чингис хааны хойно хөвүүдээс хэн нь хаан сууринд суухаас шууд хамаарах нь хэнд ч тодорхой билээ.

Ингэж бодсоны учир Чингис хаан өөрийн залгамжлагчаар хөвүүдийнхээ хэнийг сонгохыг илт сонирхох болжээ.Хөвүүдийн дотроос үзэсгэлэн төгс зүс царай, гоолиг өндөр нуруутай Зүчийг Чингис хааны залгамжлагч болоосой гэж Хулан хамгийн ихээр хүсч байлаа.

Хулан өөрөөс нь хэдхэн ах энэ идэр эрд дотроо татагдан дурлаж байв. Бас Зүчийг мэргэд цустай болохыг мэдсэнээс хойш бүр ч илүү дотно болжээ. Адилхан мэргэдийн удам болохоор Зүчи хаан болбол түүнийг лав хатнаа болгож авах биз гэж итгэнэ. Учир нь хөвүүд нь төрсөн эхээсээ бусад хатдыг эцгийгээ өөд болсны хойно өмчлөн авах эрхтэй билээ.

Хэрэв Зүчи хаан сууж, Зүчийн их хатан болбол Хуланд сая нэг насаар их хаадын хатан байх хувь тохиож болох байв. Тийм бодлоор Хулан Зүчийн нүдэнд өртөж, сэтгэлд унах боломж, өөг алдахгүйг хичээнэ.

Зүчид би яахин таалагдахгүй байх билээ гэж Хулан бодох ажээ.

Гэтэл Зүчи Хуланг хүн байна чинээ тоож хардаггүй байв.Хулан зорилгоо хатуу ухаарах тул юу ч хийхээс үл буцна. Тэр хэрэв Зүчи хаан сууринд суухыг мэдвэл Зүчид өөрийгөө өгөхөд бэлэн байв. Зүчи ч түүнийг хүсэмжилэх болно гэж итгэнэ.

Гэвч эр нөхрийнхөө хүүд улайм цайм санаархах нь аминд хүрэх аюултай тул хормой шүргэх бүү хэл, харц тулахаас ч сэргэмжлэх ёстойг Хулан бас мэдэх билээ.Гэтэл Чингис хаан өөрийн залгамжлагчаар хэнийг сонгохыг хэн ч мэдэхгүй байв.

Гэтэл Хулан яаж ч элдэвлэж хичээгээд Чингис хааны залгамжлагч хэн болохыг тэр хэлүүлж чадсангүй.

–Ууган хөвүүн Зүчийг хаан ширээнд суулгах биз гэх асуух юм уу эсвэл суулга гэж тулгах нь өөрийн дотоод бодлыг илрүүлэх аюултай тул дэмий л үг өдөж сэртэндэхээс хэтрэхгүй байв.

Гэвч яг энэ бодолд Чингис хаан эзлэгдсэн болохыг мэдэж чаджээ. Хорезмтой хийх их дайнаас

өмнө хөвүүдийн дундаас нэгийг сонгон өөрийн залгамжлуулахаар зарлах нь гарцаагүй хэрэг болжээ.

Алтан улсад байлдахдаа Зүчи, Цагадай, Өгөдэй гурван хөвүүнээ хамт нэг замын цэрэг удирдуулан явуулсан нь хэн нь ямар чадвартай, ухаантай болохыг нэг нөхцөл байдлын дүнд үзэж мэдье гэсэн зорилготой байлаа. Хөвүүд нь бүгд л биесээс дутахгүй жанжин болж чадсан нь илт ч хэн нь олныг удирдан дагуулж чадах вэ гэдэг нь хамгаас чухал юм. Дайн хийж хот балгас эзлэх нь амар хэрэг биш ч хурсан олны сэтгэлийг залж дагуулахын дэргэд өчүүхэн хэрэг гэж Чингис хаан үзэж байв. Олны сэтгэлийг эзэмдэн дагуулах нь энэ ертөнцийн хамгийн их хүчийг олох ганц арга зам гэдгийг Чингис хаан Тэв Тэнгэрээс бөөгөөс сайтар ойлгож мэдсэн билээ.

Тийм учраас их хаан болох нь юуны өмнө олны сэтгэлийг дагуулахтай утга нэг тул хөвүүдээсээ хэн нь чухам ийм чадвар илүүтэйг сонгож танихыг хичээх тул цаг алгуурласаар байжээ.Түүнээс биш Бөртийн хүссэнээр бол аль эрт Цагадайг өргөмжлөх байлаа.Цагадайг эцгийгээ залгамжлан их хаан оронд суухыг үзэх нь Бөртийн ганц насны хүслэн байв.

Цагадайг төрж мэдээ орсон цагаас Бөртийн сургамжлан захисан ганц зүйл нь энэ юм.

Тэмүжин ч анхандаа Бөртийн үгээр болж үнэхээр Цагадай хөвүүн нь түүнийг залгамжлана гэж итгэж үүнд огтхон ч эргэлздэггүй байлаа.Гэтэл хөвүүд нь өсч томрохын хирээр түүний бодол өөрчлөгджээ.Одоо үзэхэд хаан сууринд суухад Цагадайн зан ааш туйлын тохиромжгүй нь мэдэгджээ.

-Миний хөвүүдээс хаан суудалд өргөмжлөхөд хэн нь илүү тохирох вэ. Ийм асуултыг Чингис хаан шадрууд болон хатаддаа хоёр биеэр суух үедээ тавьж, тэдний санаа бодлыг сонсож үзжээ. Тэдний санааг нэгтгэн авч үзвэл Зүчи болоод Цагадайг нэрлэсэн нь хувь тэнцүү байлаа.

Шадрууд нь ихэвчлэн Зүчийг нэрлэсэн нь тэд түүнийг мэргэд удмынх гэдгийг нэг их чухалчлан үзэлгүй зөвхөн түүний цэргийн жанжины чадвар болоод зан аашийг үнэлсэн бас ахмад хөвүүн эцгийг залгамжлах ёстой гэж үзэгсэд байв.

Харин Цагадайг нэрлэсэн нь гол төлөв Чингис хааны цусан төрлийн дүү нар, түүний гэр бүлд ойрхон өсч хүмүүжсэн шадрууд, ихэвчлэн Зүчийг мэргэд цусных тул хаан ширээнд суулгах ёсгүй гэж үзэгсэд юм.

Цагадайг хаан сууринд өргөмжлөхийг хамгийн ихээр хатуу шаардаж буй хүн нь Бөртэ байв. Энэ бол Чингис хааны алтан ургийн хөвүүдийн ахмад нь Цагадай гэж төрүүлсэн эхийн хувьд үздэг болоод мэргэдээс олсон Зүчи хөвүүнийг нь алаг үзэлгүй өсгөж амжилт, ялалтын замд дагуулсанд нь Тэмүжинд талархсан сэтгэлийн нь илрэл юм. Чингис хаан Бөртийг ойлгож байлаа. Үүнээс үзэхэд Цагадайг хаан ширээнд өргөмжлөх нь гарцаагүй зөв мэт санагдана.

Учир нь түүнд Зүчийг өргөмжлөх бодол огт байсангүй. Гэвч Зүчийг оргүй мэт орхиж, чихгүй мэт ярьж болохгүйг ойлгоно. Чухам мэргэд цустай төрсөн л болохоос Зүчи бусад талаар хаан сууринд суулгахад тохирно гэж үзэгсэд нилээд байгаа болохоор Зүчийг улайм цайм зайлуулах

нь хөвүүдийн хооронд их эвдрэлийг үүсгэж ойрмог зуур цочмог хэрүүл үүсч,энэ хэрүүлээс үүдэн элдэв аюул илэрхий нүүрлэж мэдэх юм. Цагадайг шууд өргөмжлөх нь Зүчийг илээр гутаан доромжилсон хэрэг болно.

Чингис хаан эхний үед Цагадайг өргөмжлөхөөр хатуу шийдсэн байсан боловч аажмаар энэ бодлоосоо ухарч ядаж ая эвтэй арга олж шийдэх хэрэг тулгарсан тул ингэж алгуурласан билээ. Зүчи хэрэв үгүй бол Цагадайн зам шулуун байв. Гэвч Чингис хаан Зүчийг сэтгэлээсээ зайлуулж үл чадав. Бас тэр тэнэсэн сум, хальтарсан сэлмэнд өртөх дорой эр биш болсон тул түүнийг гомдоохоос болгоомжилж байлаа.Бас Цагадайн хатуу догшин авир нь олон хүнд, тэр дундаа жирийн цэрэг болоод иргэнд төдий л таатай биш болохыг Чингис хаан сонсож,мэдсэн нь нэг мөр шийд гаргахад нөлөөлж байв.Хэрэв Зүчи байгаагүй бол Алтан улсад дайлаар мордохын өмнө Цагадайг дэвшүүлэн зарлах байлаа.

Гэвч Чингис хаан Алтан улсаас эргэж ирээд Цагадайг яаран өргөмжлөөгүйдээ ихэд баярлан Тэнгэрт мөргөсөн билээ.Харин Алтан улсад явж байхдаа бодсон зүйлийнхээ гарцаагүй зөв гэдэгт эргэлзээгүй итгэхийн тулд дахиад хэдэн жил хэрэгтэй болжээ.Энэ бол Өгөдэйн тухай бодол байв.

Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх тухай санаа төрөөд удсан ч Чингис хаан энэ тухайгаа Бөртэд ч, Боорчид ч хэлсэнгүй өдий хүрчээ.

Харин цэцэн цэлмэг үгтэй, аливаад гүнзгий бодол сэтгэлээр ханддаг Есүй хатан нь огт санаандгүйгээр “Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх нь зөв” гэж хэлсэн нь Чингис хааны нууц бодолд итгэл өгсөн хэрэг болов. Ер нь тэрээр Есүй хатныхаа үгийг сонсож цайг нь ууж суух дуртай билээ. Есүй бол Бөртэ шиг олон хөвүүдийнхээ дунд ухаан хайр нь хуваагдаагүй, Есүгэн шиг аливаад алмай зүйлэг ханддаггүй, Хулан шиг ганц өөрийн сэтгэлийг эрхэм болгодоггүй,эр эмийн ажилд шунан дурлаж элдэвлэдэггүй үргэлж учиртай бодож, утгатай үр хэлдэг тул үгийг нь эм хүнийх гэж тоолгүй өнгөрдөг ч хожим нь заавал эргэн бодож үздэг байв. Энэ маягаар түүний Өгөдэйн тухай хэлснийг дахин дахин тунгаан бодож үзжээ.

Гэрт нь очоод сэтгэл санаа тайван амар хэвтэж болдог ганц хүн бол Есүй юм.Түүнээс юу ч асуудаггүй бас юу ч шаардаж нэхдэггүй нь Есүйн сурсан зан билээ. Үнэхээр Есүй түүний далд бодлыг таажээ.

-Чи яагаад Өгөдэйг дэвшүүлэхэд тохирно гэж бодов гэж асуухад яг л Чингис хааны бодож явсан үгийг Есүй хэлсэн билээ. Өгөдэйг дэвшүүлэх нь Зүчи, Цагадай хоёрт гомдолтой ч эсэргүүцэж үл чадна. Өрсөлдөгч нь ч биш болохоор Өгөдэйг дэвшүүлэхэд тэдэнд татгалзах эсэргүүцэх үндэс шалтгаан үл олдоно. Дээр нь Өгөдэй бол аливаа хэргийг эв зүйгээр учрыг нь олж шийддэг, зөөлөн алгуур зантай нь хоёр ахтайгаа эвтэй байх шалтаг болдог билээ.

Өгөдэй бол хар багаас уужуу тайван сэтгэлтэй, уяруу зөөлөн ааштай хүн юм. Дайны үед баатарлаж их зүрх, хатуу зоригийг үзүүлж чадах мөрт ерийн үед энгүүн даруу байж чаддаг нь олны сэтгэлд нийцдэг нь илт. Өгөдэйд муу санах хүн ховор байв. Энэ нь хаан сууринд суухад их л тохирно. Гэвч алс хэтийн бодлого барьж их улсыг жолоодоход түүнд ухааны бяр, хатуу итгэл дутаж мэднэ. Бас алгуур тайван зан нь хор болж ч мэднэ. Өгөдэйн хамгийн давуу чанар нь хоёр ахынхаа дэмжлэгийг олж чадах явдал байв.Хөвүүдийн эв нэгдлээс их улсын ирээдүй

шууд шалтгаалах тул Чингис хаан Өгөдэйг сонгохоор шийдэв.

Гэвч Өгөдэйг өргөмжилөх гол шалтгаан үндэс нь энэ бас биш байв. Харин чухам яагаад Өгөдэйг хаан сууринд өргөмжлөх болсноо хожим Өгөдэйг гарцаагүй хаан сууринд суух болоход нь ганцхан түүнд өөрт нь хэлнэ гэж Чингис хаан шийдсэн байв.Учир нь одоо ийм явдлыг олонд дэлгэх нь ашиггүйгээр барахгүй хор болно гэж Чингис хаан үзэж байв.

Өөрийн залгамжлагчийг тодруулах нь хойшлуулж болохгүй хэрэг болсныг Чингис хаан Хулан хатныхаа үг, шохоорхолоос нэвт мэдэрсэн билээ.

Чухам Чингис хааныг хэн залгамжлах тухай улс даяар хүлээж байгаагийн тод жишээ бол Хулан юм.Хулан шиг хүн яавч зүв зүгээр энэ хэргийг сонирхоогүй нь лавтай.

Гэвч түүнд Хулангийн юу бодсоныг таахаас илүү зовлонтой хэрэг тулгараад байв.Өгөдэйг өөрийн биеэр сонгон зарлах нь Зүчи, Цагадай болоод бусад олон хүнээс тэр дундаа Бөртэ хатны зүгээс хариу тайлбар нэхэх аюул үүсгэхийг Чингис хаан ухаарав. Тэгвэл түүнд чухам яагаад Зүчи болоод Цагадайг хаан сууринд суулгаагүйгээ олонд тунхаглах хэрэг гарна.

Энэ нь Зүчи, Цагаадай хоёрыг олны өмнө доромжлон гутаахтай утга нэг бөгөөд тэр юу ч гэж хэлсэн тэд эцгийн үгийг эсэргүүцэх нь лавтай. Ингэвэл Чингис хаан ахмад хөвүүдтэйгээ дайсан болно. Энэ нь Зүчийг үхүүлж, Цагадайг өргөмжилснөөс долоон дор хэрэг юм. Чингис хаан удаан бодсоны эцэст Өгөдэйг өргөмжлөх, ингэхдээ үүнийг хөвүүдээр өөрсдөөр нь олны өмнө хэлүүлэх замыг сонгон авлаа.

Энэ бол дөчин жилийн өмнө Тоорил хан, Жамуха хоёрыг мэргэд аймгийн эсрэг дайнд татан оролцуулахаас хавьгүй зовлонтой аюултай хэрэг байв. Энд хөвүүдийнхээ сэтгэл санаа, зан авирыг нэвт мэддэг нь хэрэг болов. Хүний сэтгэл хурмын дотор хувирах осолтой тул хөвүүдээр хүссэн үгээ хэлүүлж чадна гэсэн бүрэн итгэл бас байсангүй. Гэвч үүнээс илүү найдвартай, хамгийн гол нь өөрийн болоод улсын нэр сүрд хожим хойно аюул багатай зам үгүйг ойлгов. Энэ бол Чингис хааны явуулсан олон цусгүй дайны хамгийн төвөгтэй, аюултай нь юм. Залгамжлагчаа тодруулах нь Хорезмийг дайлахаас дутахгүй осол аюултай, буруу эргэвэл хожмын уршиг ихтэй, сэтгэлийн дайн байв.Тийм болохоор бүх зүйлийг нарийн тооцож алдаагүй бэлдэх хэрэгтэй болжээ. Юуны өмнө энэ хэрэгт Бөртийг байлцуулах шаардлагагүй гэж үзэв. Мөн Есүй хатанд зарлиг болгож хэзээ юу гэж хэлэхийг даалгав.

Ийм хэргийг даалгахад Есүйгээс өөр тохирох хүн байсангүй.

Есүгэний үгийг ахмадууд анхаарч ойшоож үзэхгүй.

Хулангаар ийм үг хэлүүлэх нь хүүхдийн тоглоом мэт санагдана.Тэгээд ч Есүй, Өгөдэйг өргөмжлөхийг дэмжиж буй.Бас энэ хэргийг Бөртэд мэдэгдэж сэжиглүүлэхгүйгээр хийх ёстой тул Боорчи, Мухулай хоёртой ч зөвлөж тэдний яах ёстойг тогтов.Хөвүүдийн дунд гэнэт үүсэж мэдэх хэрүүлийн үед хэн юу гэж хэлэхийг Боорчитой чухалчлан захиж хэлэх үгээ бэлдэхийг даалгажээ. Зүчи, Цагадай хоёрын эсрэг хийх Чингис хааны цусгүй дайны бэлтгэл ийнхүү хангагдав. Одоо бүх зүйл ганцхан Чингис хааны хэлэх үг, гаргах аашнаас шалтгаалах байв. Урьд шөнө нь Чингис хаан тэр нэгэн цагт Тэв Тэнгэрийн зааснаар дал шатаан мэргэлж үзвэл

бүх юм санаснаар бүтэх төлөг буусанд бүр сэтгэл амарч олон зүйлийг бодож үзээд Бөртэ хатныхаа гэрт хонохоор морилжээ.

Тэмүжин Бөртийнд очиж хонолгүй хоёр сар болжээ.Бөртэ лав баярлана гэж бодов.

Маргааш өдөр морин цагт Чингис хааны ёслолын их өргөөнд ахмадууд болоод шадар жанжинууд цугларч Хорезмтой хийх дайны бэлтгэл болоод бусад зүйлсийг хэлэлцэж зөвлөлдөв. Энэ зөвлөгөөнд хатдаас Есүй, Хулан хатад суусан нь олныг нэг их гайхшруулсангүй.

Зөвлөлгөөний эцэст хундага өргөхийн өмнө Есүй хатан Чингис хаанаас зөвшөөрөл авч олны анхаарлыг өөрт хандуулаад: Өршөөлт эзэн хаан та

Өндөр алдраа мандуулсаар

Өгсүүр даваг давж

Өргөн мөрнийг гаталж

Ужиг холыг туулан

Урт аянд морилохдоо

Улс иргэнээ захирахыг

Урьдал болгон сэтгээсэй

Төрсөн бие төлбөрөх

Түмэн амьтны хуулийг

Төгс саруул ухаандаа

Түвдэлгүй санаасай

Уул мэт бие чинь

Нурж одвол

Улс олон Монголыг чинь

Хэн захирах юм бэ

Тулгуур мэт бие чинь

Туйвж одвол

Туг их сүлдийг чинь

Хэн өргөх юм бэ

Төрсөн дөрвөн хүүгээс чинь

Төр барих нь хэн бэ

Хан хөвгүүд, дүү нар

Харц олон ард

Хатад бид бүхэнд

Хариу айлдах эсэхийг

Хааны зарлиг мэдтүгэй гэж цэлмэг тунгалаг хоолойгоор цэцэн шүлэг хэлэхэд өргөөнд ялаа нисэх ч тод сонсдохоор нам гүм боллоо. Хулан юу болох гэж буйг таамаглаад тэсэлгүй өөртөө бухимдав. Иймхэн хэдэн үг олоод хэлчих ухаан олоогүйдээ уурсаж бас сүйхээтэй сэрэглэн Есүйд үхтлээ атаархав.

Гэвч тэр нэгэнт хожимджээ.

Есүйн үгийг сонсож суухдаа Чингис хаан туйлын тааламжтайгаар толгой дохин суухыг хараад ингэж атаархсан билээ. Харин одоо Чингис хааны юу гэж хэлэх л чухал учир Хулан атаархалаа хормын дотор мартав. Чингис хаан гүнзгий бодолд автжээ.

Зэрэгцэн суусан Бөртийн дөрвөн хөвүүнийг хараад Хулан гэнэт өөрийн золгүй хүүгээ санаж гол нь харлаад явчихжээ. Тэр хүү нь мэнд төрсөн бол одоо арван тав хүрч бас эдэнтэй зэрэгцэн суугаад хаан эцгээ залгамжлана гэх байхсандаа гэж бодогдоход гэнэт дотор нь бачуурч орилж хашгирмаар болсон ч тэвчин биеэ барилаа.

Хулан хатны нүднээс нулимс мэлтрэн дүүрээд урсахыг анзаарч харах хүн даанч байсангүй. Чингис хаан хэдий санаа сэтгэл бэлэн байсан ч хэргийн учир будилаантай, уршиг дагавар их тул бас бяцхан сандарч бодолд унав. Тэр юу гэж хэлэхээ тооцон хэсэг суув.

Бүгд түгшин, хөвүүд сандарч улайн сэтгэл догдлов.

Чингис хааны амнаас гарах үг хүн бүгдэд хамаатай юм. Бүгдийн өөр өөрийнхөөр сэтгэж хүлээсэн мөч ирснийг ойлгов. Чингис хаан удаан дуугүй суув. Энэ нь хаан ширээ залгамжлагчийг тодруулах нь хир хэцүү хүнд, хариуцлагатай хэрэг болохыг мэдрүүлэх зорилготой ажээ.

Эцгийн үгийг хүлээсэн гол өрсөлдөгчид Зүчи, Цагадай хоёрын хувьд сэлэмний дор толгой тавьсан мэт болжээ.

Хаан эцгийн үг тэдний ирээдүйн хувь заяаг шийднэ. Бас тэднийг хэн болохыг олонд үзүүлэх юм. Үүнээс илүү түгшүүрт, бас хүсэмжит мөч гэж хаана байна. Цагадайн сэтгэл түгшивч эцэг нь түүнийг өргөмжлөнө гэдэгт бат итгэлтэй байв. Гэтэл Чингис хааны дуугүй удах нь

сэжиглэлтэй. Цагадайн сэтгэлээ барих тэвчээр барагдаж байв. Чингис хаан Цагадайн нүүрэнд харц тусгав. Цагадай эгц өөдөөс нь шаардсан, итгэсэн харцаар ширтэн байв.Харин Зүчи сэтгэлийн хөдлөлөө нууж доош ширтэнэ.

Зүчид хаан эцгийгээ залгамжлах хувь дутахыг тэр мэдэж байсан хэдий ч бас горьдлого төрж догдолсоор байжээ.

Гэвч хаан эцэг нь Цагадайг өргөмжлөвөл шууд дэмжинэ гэж бодож суужээ.Энэ бол Бөртэ эхийнх нь хатуу сургаал юм. Өгөдэй энэ явдал өөрт нь тийм ч их хүртээлтэй биш тул тайван сууна. Харин Тулуй бүр ч тоомжиргүй суусан ч хаан эцэг нь ах нарын нь хэнийг сонгохыг сонирхон дотроо тааж ядах ажээ.

Зүчи үү Цагадай юу. Олон бүгдээр ингэж бодож байлаа.

Чингис хаан одоо үгээ хэлэх цаг болсныг мэдлээ. Чингис хаан үгээ хэлэхийн өмнө яагаад ч юм Хулан хатнаа харжээ. Хулан хатан нулимстай нүдээр инээмсэглэж суухыг үзээд чухам яагаад түүний уйлсныг шууд л ойлгов.Чингис хаан ч гэсэн тэр золгүй хүүгийн тухай боджээ.

-Хатан боловч Есүйн хэлдэг зөвөөс зөв. Хүү нар, хөвүүд та нар, бас Боорчи, Мухулай та нарын аль нь ч ийм үгийг надад дуртган хэлсэнгүй.

Өвгөдийн хойноос одохгүй мэт

Өөрөө ч үүнийг мартсан байж.

Үхэл надаас тойрох мэт

Үнэхээр түүнийг санаагүй явж

Их улсдаа мөнх суух шиг

Эзэн ширээнд үүрд залрах шиг

Эрчит суманд оногдохгүй мэт

Илдний үзүүрт өртөхгүй мэт санажээ гэсэн Чингис хааны үг Есүй хатны хэлснийг сайшаагаад зогсохгүй залгамжлагчаар хэнийг томилохоо хэлнэ гэсэн итгэлийг үүсгэж олон бүгдийн сэтгэлийг хөвчрүүллээ.

- Хөвүүдийн минь ахмад Зүчи юм. Чи юу гэж бодно. Чи хэл гэж Чингис хаан Зүчид хандан хэлэхдээ Цагадайг хяламхийлээ.

Хөвүүд зэрэгцэн тохой зайтай сууж байв.Эцгийн энэ санаандгүй үг хором зуур Зүчийг алмайруулж чухам юу хэлэхээ олсонгүй. Чингис хааны Зүчид эхлэн хандсан нь зарим хүнд тэр дундаа Цагадайд Зүчийг шууд өргөмжилсөнтэй утга нэг санагдав. Хулан эхлээд сонссондоо итгэсэнгүй. Тэр Чингис хаан Зүчийг өргөмжлөв гэж ойлгоод баярласандаа өндөсхийлөө. Гэвч тэр буруу сонсжээ. Цагадайг үсрэн босохыг хараад Хулан юу болсныг

ойлгосонгүй. Цагадай үнэхээр биеэ барьж чадсангүй.

Зүчийг өргөмжлөх нь Цагадайг гутаан доромжилсонтой адил юм. Цагадай хаан эцгээ залгамжлах ганц хүн гэдгийг Бөртэ эх нь шууд баталдаг билээ. Гэтэл хаан эцэг нь юу санаад ийн хэлэв. Цагадайн уур омог дүрэлзэн шатаж бараг хамраараа утаа савсуулан байж:

- Зүчийг үг хэл гэх нь юув. Зүчийг юунд томилох гэж ингэж онцлов. Энэ мэргэдийн орхидост бид захирагдах гэж үү гэж хашгирахад хаан эцэг, хамаг олны өмнө ийн гутамшигтайгаар доромжлогдсон Зүчи ч үсрэн босч Цагадайг заамдан авав.

- Хаан эцэг намайг гадуурхаагүй байхад чи намайг яагаад ялгаж үзнэ. Чи надаас ямар эрдмээр илүү билээ. Чи ганц догшин омгоороо илүү биз.Харвалцаад чамд дийлдвэл би эрхийгээ огтолж хаяъя.Барилдаад унавал унасан газраасаа үл босъё. Би чамд юугаараа ч үл дийлдэнэ. Гэвч би хаан эцэг таны зарлигийг л дагана гэж хашгиран ноцолдоход Зүчийн гараас Боорчи, Цагадайн гараас Мухулай татаж салгав.

Чингис хаан тэр дороо дуугарсангүй, бүр уурлаж хилэгнэсэнгүйд гайхацгаав. Чингис хаан санасандаа хүрч өөрийн хэлэх гэснийг Зүчи, Цагадай хоёроор өөрсдөөр нь хэлүүлж чадсандаа сэтгэл хангалуун дотроо инээмсэглэж, гаднаа хөмсөг зангидаж суув.

Харин Хулан Цагадайн үгэнд хацар руугаа алгадуулсан мэт цочиж харц буулган тонгойв.

Мэргэдийн орхидос гэсэн нь бас Хуланг хэлсэн хэрэг байв.Даанч эндээс зайлан гарах шалтгаан Хуланд байсангүй.Энэ өргөөнд юу гээч болж байгааг Хулан ойлгов.

Энд мэргэд хүн хэн ч биш ажээ.

Зүчи, Цагадай хоёр нам гүмийн дунд хүндээр амьсгаадан суухдаа хэн хэн нь түргэдэн гэндсэнээ ойлгов.Харин хаан эцгийнхээ тавьсан мэхэнд унасанаа мэдэхгүй байлаа. Ийм хэрүүлийн дундаас хаан эцэг нь тэдний хэнийг ч сонгохгүй нь ойлгомжтой болжээ. Хэрэв дуугүй суусан бол гэж Цагадай өөрийгөө хараавч хожимджээ.Хэдий үнэн ч гэлээ ингэж бүх улсын ихэс дээдсийн өмнө элдвээр гутаан доромжилсон Цагадайг яав ч өршөөхгүй гэж Зүчи хилэгнэн бодож суув.Гэнэт дүрэлзсэн хэрүүлийн хойно Чингис хааны хилэгнэхээс болгоомжлон дахин үг дуугарах зоригтон одоо байхгүй болжээ.Бүгд Чингис хааны юу хэлэхийг хүлээж байлаа.

Чингис хааны тушааснаар одоо Боорчийн ээлж иржээ.

Түргэдэж буруудсан Зүчи Цагадай хоёрыг зэмлэн буруушааж омгийг дарах сайхан боломж олдов.Боорчи юу гэж хэлэхээ сайхан мэдэж байв.Боорчи Тэмүжиний хөвүүдийг хамт өсгөлцсөн тул Чингис хаан болоод хөвүүдийн сэтгэлийг сайтар ойлгох билээ.

Цанх нь хөдөлсөн адгуус мэт

Цагадай чи юунд яарав

Хаан эцэг чинь чамд

Хамгаас илүү итгэдэг бус уу

Алтан ургийн нэрийг сэвтүүлэх

Атгаг хорон үгийг хэлж

Адайр догшин аашлах

Амтай нь ганцхан чи бил үү

Хатуу цагийн эрхэнд

Хамаг бүхнийг туулж

Хаан суудалд суутлаа

Хайран нэрээ бодож

Хатамжин тэмцсэн эцэгтээ

Хамаг олон бидэндээ

Хайрт ах Зүчидээ

Халтай үгийг хэлэх нь юув

Өндөр тэнгэрээс заяатай

Өршөөлт эзэн Чингис хаан

Өөрийн улсаа байгуулж

Өрөөл бусдыг хураахын өмнө

Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлон булаалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв.

Эргэлзэн бодох чөлөөгүй

Элбэлдэн зүтгэж явав.

Ухран дутаах газаргүй

Урагшлан байлдаж явав.

Амар жаргах аргагүй

Алалдан тэмцэж явав.

Хаан эзэн эцгийнхээ

Хатан сайхан эхийнхээ

Халуун элгийг хөргөж

Хайрт зүрхийг гомдоож

Тос шиг санааг царцааж

Сүү шиг сэтгэлийг ээдүүлэх

Чалчаа муу үгийг Цагадай чи хэллээ.

Бүлээн элэг нэгтэй

Бөртэ хатны хүүхдүүд биш үү

Халуун элэг нэгтэй

Хамт төрсөн үрс биш үү

Зүрхний хайрт эхийн

Зүтгэсэн ачийг мартаж

Зүйгүй үгээр гомтговол

Гэмшивч нэгэнт хожидно.

Хэвлийдээ тээсэн эхийн

Хэтэрхий ачийг мартаж

Хэдэр үгээр гомтговол

Хэзээ ч цайруулж чадахгүй

Хаан богд эцэг чинь

Хамаг улсыг байгуулахдаа

Хар толгойгоо хайрлахгүй

Халуун цусаа гамнахгүй

Гарын ханцуйг дэрлэж

Гадаад хормойгоо дэвсэж

Шүлсний хөөсөөр хооллож

Шүдний махаар хооллож

Магнайн хөлсийг дусалтал

Махарч чармайж явахад

Улны хөлсийг урстал

Улсаа хурааж явахад

Хатан эх чинь та нарыг

Хамаг аюулаас хаацайлж

Халуун бөөрөндөө дулаацуулж

Хатуу зоригоор хүмүүжүүлж

Хамт зовж явсан бус уу.

Оюун төгөлдөр эх чинь

Оёдолт дээлээ огшуулж

Онгох зүсээ харлуулж

Омог зоригоо чангалж

Хөвүүд та нарыг өсгөхийн тулд

Хүч чадлаа шавхаж

Залгих хоолны шимтэйг

Заяасан та нарт идүүлж

Уух ундны дээжийг

Урьдаар та нарт амсуулж

Өдий зэрэгт хүргэх гэж

Өлсөж ядарч явлаа.

Эгмээс чинь татаж

Эрийн зэрэгт хүргэсэн

Эрхэм ачийг санацгаа

Хүзүүнээс чинь татаж

Хүний зэрэгтэй болгосон

Хүндэт ачийг бодоцгоо

Бохирыг чинь арилгаж

Борвийг чинь тэнийлгэж

Эрийн зэрэгтэй болгож

Эмээлийн дөрөөнд хүргээд

Энхрий хөвүүд та нарын

Эрхэм сайныг үзье гэж

Эх чинь одоо бодож байна.

Эцэг чинь одоо санаж байна

Наран шиг гэгээн ухаант

Навч шиг дэлгэр сэтгэлт

Элбэрэлт хатан эхийнхээ

Элгийг бүү эмзэглүүл

Өндөр тэнгэр шиг ачтай

Өмөг нөмөр ихтэй

Өршөөлт эзэн эцгийнхээ

Өрийг бүү өвдүүл гэж Боорчи уянгатай, утга төгөлдөр уран үгийг уламжлан хэлэхэд Цагадай ичиж, Зүчи уяржээ.

Боорчийн үнэн бөгөөд уран үг олонд таашаагдаж бүгд дүнгэнэн түүнийг дэмжсэн нь Зүчи, Цагадай хоёрын магнайн хөлсийг урсгаж маш их айлгаж гэмшүүлжээ.

Чингис хааны сэтгэл ханаж Цагадайд:

-Чи Зүчийг тэгэж хэлж яаж болно.Хөвүүд та нарын ахмад нь Зүчи юм. Хожим бүү тэгэж хэл гэж зөөлөн хэлсэн нь нэг талаас Цагадайг тайвшруулсан ч нөгөөтэйгүүр Зүчийг мэргэдийн хүүхэд гэдгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болов.

Цагадай эцгийн үгийн цаад санааг ойлгож

Амаар алсныг

Ачиж болдоггүй

Үгээр үхүүлснийг

Өвчиж болдоггүй

Аавын хөвүүдийн ахмад Зүчи бид хоёр биз.

Хаан эзэн эцэгтээ Хавсарч хүчээ өгье.

Далдиран зайлсан этгээдийг

Тас цавчин шийтгэе

Салж хөндийрсэн хэнийг ч

Салбартал цавчиж байя

Өгөдэй дүү өршөөлтэй тул

Өндөр сэнтийд залж

Өргөн олныг захируулж

Өргөмжлөн хүндэлж болно

Хаан эцгийн дэргэд

Хамт ойр байлгаж

Бараат их малгайг

Бариулан мэдүүлж болно гэжээ. Цагадайд үүнээс өөр зам үлдсэнгүй. Ахмад хөвүүдийн хэрүүл зөрчлийн байдал хэнийг нь ч хаан сууринд өргөмжлөх аргагүйд хүргэв. Өргөөнд цугларагсад бүгд үүнийг ойлгож байлаа. Энэ бол Чингис хааны хүссэн явдал байв. Түүний бодсоноор Зүчи, Цагадай хоёр өөрөө өөрсдийг тодруулж Өгөдэйг өөрсдөө цохон нэрлэв. Ингэж хамгийн төвөгтэй хэргийг Чингис хаан өөртөө ял, зэм багатайгаар шийдвэрлэсэндээ баяртай байлаа.

Өгөдэйг өргөмжлөхийг Зүчи дуун дээр дэмжив.

-Цагадайн хэлсэн ёсоор бид хоёр хаан эцэг танд хавсарч хүчээ өгье. Өгөдэйг өргөмжлөе гэжээ. Чингис хаан сэтгэл дүүрэн инээмсэглэж:

-Хавсрах юу вэ. Эх дэлхий агуу уужим, ус мөрөн олон. Та хоёрыг харь улс эзлүүлэн тусад нь суулгая. Өөр өөрийн нутгийг өргөтгөж явагтүн. Харин Зүчи, Цагадай та хоёр хэлсэн үгэндээ хүрч ардын инээдэм, амьтны тоглоом болохгүй эвтэй явагтүн. Эрт цагт Алтан, Хучир нар энэ мэт үг амлаад эцэст нь хэлсэндээ хүрэлгүй няцаж, хэнд яаж цаазлагдсаныг та хоёр үзсэн. Одоо би та хоёрт “Алтан, Хучир хоёрын харьяат нарыг хувааж өгнө.Тэднийг үзэж цээрлэл болон санаж явагтүн“ гэжээ. Хөвүүдийн хэрүүл тэмцэл харин ч аятай зүйгээр шийдэгдсэнд бүгд баяртай болжээ.Өгөдэйг түүний хөвүүд залгамжлахыг зарлиг болгож Өгөдэйн хөвүүд хаан сууринд тохирохгүй аваас алтан ургийн хөвүүд дотроос хэн тохирохыг өргөмжилөх зарлиг буулгасныг Шихихутаг хөх дэвтэрт бичиж хөвүүдэд үүрд мөрдүүлэхээр өгчээ. Энэ явдал Чингис хааныг шаналгаж байсан олон зүйлийг байранд тавьж, осол эндэгдэлгүй шийдэв.

Чингис хаан Зүчийг нэгэнт мэргэд цустайг олонд тунхаглаж, түүнээс хойш Зүчийн үр сад хаан ширээнд суух ёсгүйг хатуу ойлгуулж чадав. Мөн зөвхөн Чингис хааны төрсөн хөвүүдийн үр садыг алтан ураг гэж тооцон үе залгамжлуулах журмыг батлав. Төрсөн дүү Хасарын эрх булаалдах явдлыг энэ зарлигаар үгүй болгов. Хамгийн гол нь хаан суудлын төлөөх хөвүүдийн тэмцэл дундаас Чингис хаан олны өмнө нэр цэвэр, сүр бүтэн гарч чадав. Одоо хэн ч гэсэн Зүчийг мэргэд цусных гэдэгт эргэлзэхгүй болсон ч Зүчи хөвүүнээ ад үзсэн гэж Бөртэ түүнийг хэлэхгүй болов.

Хорезмтой хийх их дайны өмнө Чингис хааны залгамжлагч тодорсон нь түүний сүр хүч амжилтыг бэхжүүлэв. Одоо тэдний өмнө эргэлзэх юм үгүй болж нэгэн чигт зорилгоор дайтах үлдэв. Гаднаас харахад хялбархан санаснаар шийдэгдсэн энэ хэрэг араасаа ямар үр уршиг дагуулж болохыг Чингис хаан таамагласангүй нь удахгүй ил болжээ. Зөвхөн алтан ургийн хөвүүдийг хаан суудалд суулгах Чингис хааны зарлиг лавтай хоёр хүнд таалагдсангүй. Адил тэгш эрхтэй Есүхэйн хөвүүн атал Хасар болоод түүний хөвүүдийг ийн бусдын адил ялган

үзсэн нь Хасарыг уурлуулж энэ байдал нь түүний үг хөдөлгөөн бүрт илрэх болсныг Чингис хаан мэдэж байв.

Мөн Өгөдэйг өргөмжилсөн нь Хуланд огтхон ч таашаагдсангүйгээр барахгүй түүнийг мэргэд удмаар нь гутаан доромжилсон хэрэг гэж тэр үзжээ. Өгөдэй бол Хуланг Тэмүжинд ирснээс хойш дургүй гэдгээ шууд илэрхийлсэн цөөн хүний нэг байв.

-Энэ муу мэргэдийн зальт эм, үнэгэн шулам гэж хараадгийг шивэгчин нь олонтаа сонсож хов зөөсөн билээ. Эхийнхээ үзсэн зовлонгоос үүдэн Өгөдэй мэргэд хүнийг илт үзэн ядах болжээ. Гэтэл одоо Өгөдэй хаан суудалд суух болсон нь Хуланг мухардуулав.

Хэнээр хаан суурриа залгамжлуулах гэж буйгаа нуусанд нь Хулан Тэмүжинд их гомджээ.Тэмүжин түүнд нэгэнт хайргүй болжээ гэж Хулан гомдон уйлахад Ю-Унчи өдөрт тогтмол уулгадаг үзэмний нялуун шүүсээ барисаар зогсож байв.Түүнд үнэхээр дээш тэнгэр хол, доош газар хатуу гэгч л болох ажээ

Үзэмний шүүсээ уучихаад Хулан гэнэт Ю-Унчийн энгэрт наалдан асгартал уйлжээ.

Хулан хатны энэ ааш Ю-Унчид сонин биш тул тэр зүгээр л хүн чулуу шиг хөдлөгөөнгүй зогсож байв.Харин Хулан түүнийг тайган гэдгийг мартжээ.Хулангийн эсэргүүцэл дургүйцэл уйлах уйтгарлах төдийгөөр дууссан бол Хасарын гомдол юунд ч хүргэж болох билээ.Алтан улсын зүүн хойт нутгийг бүрэн дагуулаад олз омог дүүрэн ирснээс хойш Хасар Тэмүжинтэй их л найртай сайхан харилцаатай байсан билээ.

Хасар одоо Хянганы нурууны ард нутаглаж шинээр эзэлсэн нутгаа хамааран суугаадаа сэтгэл хангалуун байжээ.Харин Хорезм улсыг дайлахын эсрэг байснаас болж их хурилдайн үеэр Тэмүжин Хасар нарын хооронд багагүй зөрөлдөөн үүссэн ч нэгэнт олонхиор шийдсэн тул Хасар дахин эсэргүүцсэнгүй билээ. Гэтэл огт санаандгүй байтал хэрүүлийн үр дахин дэлгэрчээ.Хасар болоод түүний үр удмын Их монгол улсын төрийг барилцах эрхийг хүчээр булаан авч бүр зарлигаар хориглосныг Хасар тэвчсэнгүй Тэмүжиний өргөөнд давхин оржээ. Тэд юу ярилцсаныг хэн ч үзэж сонссонгүй.Удалгүй Хасар торгон цэргээ дагуулан нутагтаа буцжээ.Харин үүнээс гурван сарын дараа их цэрэг Хорезмруу хөдлөхөөс хоёр сарын өмнө Хасар гэнэт нас эцэслэсэн нь Тэмүжин тэдний үүрдийн зөрчил тэмцлийг төгсгөл болгосон билээ.

Хасарын нас эцэслэсэн тухай мэдээ Чингис хааны өргөөнд ирэх үед тэр Хулан хатныдаа байжээ.Чингис хаан шууд хувцаслан гарчээ.Юу ч хэлсэнгүй. Харин Хулан түүний царайг ажаад Чингис хаан Хасар дүүгээ үхсэнд тэгтлээ их хармсахгүй байгааг мэджээ.Хасарын үхлийг сүр дуулиан болгон их гашуудал зарлахыг Чингис хаан хориглосныг Хулан ихэд гайхаж тэсэлгүй асуужээ.

Чингис хаан түүний үгэнд хариу хэлэлгүй удаан дуугүй суусанд Хулан дэмий юм асууж хилэгнүүлэв үү гэж ихэд айжээ.Гэтэл Чингис хаан огтхон ч хилэгнэсэнгүй

–Хулан чиний ингэж асуух чинь түмэн зөв.Ганц чи ч биш.Олон хүн яг чам шиг ингэж бодож асууж байна.Гэтэл би хайртай дүүгээ, хамаг ихээр зүтгэсэн ганц нөхрөө алдав.Надад хайран

биш гэж чи санана уу.Одоо түүний хойноос хамгаа алдсан мэт их гашуудал үйлдэж болохгүй юм.Би одоо их дайнд мордох гэж байна.Би дайсандаа муугаа үзүүлэхийг үл хүснэ.Хасарыг үхэв гэж ихээр гашуудвал дайсан итгээд зоригжин баясаж харин манай цэргийн санаа итгэл мохох аюултай биш үү.Надад Хасараас үл дутах баатар эрс олон байна.Би юунд харамсана.Дайсан ч тэгэж санаад зориг мохоосой гэж хүснэ.Би буруу зүйл бодсон бол чи шууд хэл гэжээ.Тэмүжин энэ үгээ харамсал гашуудал дүүрэн хэлсэн нь Хуланг

–Тиймээ.Хаантаан та зөв боджээ гэж хэлэхээс өөр аргагүй болгожээ. Хасарыг нас эцэслэсний дараа хоёр хөвүүнийг нь дуудан ирүүлж их хуралдайг зарлан хийлгээд Чингис хаан яг саяын үгээ хэлэхэд тэнд байгсад бүгдээр хүлээн зөвшөөрсөн билээ.

Бүх зүйл Чингис хааны зарлиг ёсоор болж Хасарыг үхсэнийг төв хүрээнд л мэдсэн төдийгөөр нам гүм болжээ.Хасар дүүгээ үхсэнд харамсан гашуудах эрхгүй байгаа Тэмүжинг Хулан ихэд өрөвдөн түүнд гомдохоо болижээ. .Чингис хааны цэргийн түрүүч Хорезмийг зорин ээлж дараалан мордсоор байв.

Хамгийн түрүүнд Зэвийн их цэрэг баруун зүг оджээ. Түүнээс сарын хойно Сүбээдэй баатар өөрийн цэргийг дагуулан Зэвийн араас тоос манаруулан мордов. Гуравдугаарт Тогочарыг илгээв. Харин гол замын цэргээ Чингис хаан өөрөө манлайлан хөдлөх сайн өдрийг товложээ. Үүний өмнө Чингис хаан Бурхан Халдун уулыг тахиж, Тэнгэрт их өргөл барьж мөргөв. Тэгэхэд Бурхан Халдуны оройд Чингис хаан ганцаар харанхуй тэнгэрийн дор сууж мөргөв. Уулын бэлд хорин түмэн цэрэг жагсаад эцэс нь үзэгдэхгүй хөвөрнө. Цэргийн манлайд хөнгөн сүйх тэргэнд Хулан баяр хөөртэйгөөр сууж байв. Их цэрэг эзэн хаанаа Тэнгэрийн үгийг сонсч ирэхийг хүлээж байв. Чингис хаан бууж ирэв. Тэнгэр түүнийг тэтгэж Хорезмийг дагуулна гэж хэлжээ. Их цэрэг бахдал дүүрэн хөдлөв.Хорезмийн зүүн хилийн хот хүртэл их цэрэг алгуур уужим хагас жил явах зам буй ажээ. Хорин түмэн цэрэг ачаа хөсгийн хамт замд гарах нь уул нүүж,ус урсаж байх шиг Монголын тал нутаг хоосрон үлдэх шиг гунигтай, эцгээс салсан хүүхдийн уйлаан, эхээс төөрсөн унаганы янцгаан тэнгэрт хадаж байв. Бүх үлдэгсдийг, бүх дуу чимээ, хагацлыг их цэргийн тоос цас шиг даран үгүй хийх бүлгээ. Чингис хаан урьд өмнө үзээгүй харь орныг зорьж явна. Нэгдэж хүчирхэгжсэн, лалын шашинтны их улс Хорезм түүнийг эсэргүүцэл төгс хүлээж буй. Алтан улсад байсан их цэргийг татаж, тэнд гоо ван Мухулайг цөөн цэргийн хамт үлдээгээд бүх хүчээ Хорезмд хаяв. Түүний байгуулсан их улсад түүний хөвүүдэд шинэ газар орон, их олз омог, агуу алдар нэр, ялалт хэрэгтэйг Чингис хаан ойлгож байв. Тэр одоо өөрөөсөө илүү хүчтэн, алдар суутай хаан бий гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй болжээ. Тийм их улс их хаан байх аваас түүнийг даран мөхөөж эрхэндээ оруулахыг хүснэ. Алтан улсын их хаан буун өгч хөвүүнээ зуун нөхдийн хамт алба хаахаар ирүүлсэн нь одоо Тулуйн дэргэд яваа нь юутай бахархалтай хэрэг билээ.

Тэр өөрийн улсад Ойн иргэд, Уйгар,Кидан, Харлагийг нэгтгэж Тангуд, Алтан улсыг дагуулав. Одоо өмнө зүгт Сүн улс, харин их цэргийн нь замд баруун талд Хорезм буй. Хорезмийн их улс, түүний их үгт хаан Мухамедийн тогтох, орших хоног хугацаа тоотой болжээ. Чингэх ёстойг сая мөнх Тэнгэр Чингис хаанд хэлсэн билээ. Тэмүжин чи баруун зүгт их ялалт байгуулж буруу шашинтныг дагуулна гэж мөнх Тэнгэр хэлэхийг Чингис хаан сонсчээ.

Тийм болохоор Чингис хаанд эргэлзэж тээнэгэлзэх зүйл үгүй байв.

*****

Хорезм улсын хамгийн нэртэй зартай, баян тансаг Самарканд хотыг Чингис хааны цэрэг эзлэн авч хамаг алт эрдэнэс, өнгөтэй өөдтэйг нутаг руу ачуулж хот утаа үнсэнд умбаж хоцрохыг Хулан эхлээд соиучирхан дараа нь харамсан харсаар байлаа. Түүний нүдний өмнө өнгө өнгөөр тунарч солонго шиг алаглан байсан үзэсгэлэнт хот сарын дотор шатсан хожуул шиг болж үлдэх гаслант өдөр холгүй болжээ..

Самарканд бол перс хэлээр “Үржил шимт өгөөмөр баян хот“ гэсэн утгатай үг юм. Хорезмийн хотууд Чингис хааны их цэргийн өмнө дараалан нурж эцэст нь Самарканд л үлдэв. Самаркандыг Хорезмийн шилдэг арван нэгэн түмэн цэрэг сахиж хамгаалж байв. Самаркандыг авахын тулд Чингис хаан өөрийн бүх замын цэргийг Самаркандын ойр цуглахыг тушааж өөрөө хотын ойр Хөх сарайд хээрийн хүрээгээ байгуулж тухлан суув. Цэргээ амрааж, юуны өмнө тэдний их ялалтын хий хөөрлийг даржээ.

Самарканд бол хамгийн их бэхлэлттэй яг л төмрөөр цутгасан мэт бат бэх хот юм. Хорезмийн эзлэгдсэн нутгаас бүх залуу эрсийг дайчлан зохион байгуулсан “үхэл“-ийн гэж нэрлэх цэргийн ангиудыг довтолгооны тэргүүн эгнээнд явуулж хотын хана хэрмийг эвдүүлэхээр бэлтгэж байв. Нутгийн иргэдийг дайчлан эхний эгнээнд амьд бамбай болгон өмнөө давшуулах аргыг Чингис хаан Алтан улсыг дайлахдаа хэрэглэж сурсан юм. Нутгийн цэргүүд хоорондоо тулж бие биенийг алахдаа зориг хүч нь хялбархан мохон дийлддэг нь өөрийн цэргийн хүчийг хэмнэхэд туйлын ашигтай билээ.Тийм учраас аливаа хотыг эзлэн авмагц залуу эрсийн эсэргүүцсэнийг шууд алж, сайн дураар дагагсдыг өршөөн “үхлийн анги“- д хуваадаг байлаа. Одоо ч тэр аргаа хэрэглэн эзлэгдсэн бууж өгсөн хотуудаас үхлийн цэргүүдийг дайчлан авчирч тэднээр Самаркандыг бүслүүлжээ.

Самаркандыг бүслэсэн “үхлийн цэргийн” тоо хорин түм хол давжээ. Харин Чингис хааны шилдэг цэргүүд тэдний ард байрлана. Амьд бамбай хэрэглэж, нутаг орны бүх эд баялгийг дээрэмдэн хураасан Монгол цэргийг ялна гэсэн итгэл хэнд ч төрөхгүй ажээ. Хотыг яаж тонох, хэрхэн сүйтгэх зэрэг нь уг хотынхон яаж эсэргүүцэн тэмцэж, Монголын цэргийг сүйрүүлэн хохироосон хэмжээнээс хамаарна. Өөрийн дураар бууж өгсөн хотыг зөвхөн албан татвар төлөх хэмжээг тогтоон цэрэг дайчлах, хүнс, агт гаргуулах зэргээр шийдэж, эвдэлгүй орхидог байлаа. Харин эсэргүүцэн тэмцсэн хотыг эвдэн сүйтгэж газрын хөрстэй тэгшлэх нь ч бий.

Жилийн өмнө Хорезмийн хамгийн том хотуудын нэг Бухарыг яг ийм хувь тавилан дайрчээ.

Чингис хааны цэрэг довтлон ирэхийн өмнө хэдэн түмэн хүн бужигнаж, баян тансагаараа зард гарч байсан Бухар хотын суурин дээр одоо үнс чандруу бужигнасан туурь үлдээд тэнд золбин муур л орилолдож байгаа. Чингис хаан өөртөө дагаж орсон лалын шашны тэргүүн имамуудаас нэр хүндтэй олны танил хамгийн алдартайг нь сонгон авч эзлэн авах хотод элч болгон илгээж Тэнгэрийн гэсгээл үзэхээсээ өмнө сайн дураар бууж өгөхийг шаарддаг байв. Тэгээд бууж өгсөн хотыг зүгээр орхиж эсэргүүцэн тэмцсэнийг эвдэж сүйтгэдэг нь Хорезмийн нутгаар нэг илэрхий болсонд түрэг хүмүүс олонх суудаг олон хот ийм маягаар ээлж дараалан бууж өгсөн билээ.

Хорезмийн султан хаан эхнээсээ л Чингис хаантай байлдахдаа буруу арга хэрэглэсэн нь ч ялагдан сүйрэхэд дэм болжээ. Хот болгон өөрийн эзэн, жанжин цэрэгтэй, тэд зөвхөн хар амиа бодон өөрийгөө л хамгаалахыг сэтгэх тул хэн нь ч Чингис хааны худалдаачдыг алсан Отрар хотын захирагч Хажирханы төлөө амиа үрэхийг хүссэнгүй. Султан Мухамедийн нэгдсэн цэрэг байгуулах оролдлого бүтэлгүйтэн зугатааж түүний оронд суусан Желаладдин султаны үед мөн л хот бүр зөвхөн өөрийгөө хамгаалах арга хэрэглэсэн нь Чингис хаанд нэг нэгээр аятай тайван эзлэн авах боломж олгосон бөгөөд Хорезмийн их улсыг ердөө дөрөвхөн жилийн дотор сүйрэн мөхөх үндэс болов.

Самарканд хотыг хамгаалан суугч Мухамедийн шилдэг торгон цэргүүд одоо Чингис хааны өмнөх эцсийн саад болж үлдэв. Энэ цэрэг Мухамед султаны эцсийн найдвар байв. Монгол нутгаас гарснаас хойш Уйгарын Идүүд хаан, бас Харлаг улсын Арслан хааны цэрэгтэй нийлсэн Монголын их цэрэг анх Чингис хааны худалдаачин элчийг алсан Отрар хотод хүрч бүслэн хааж зогсоход Хулан хатан туйлгүй ихээр догдлон хөөрсөн билээ.

Отрар хот шиг ийм тансаг үзэмжтэй балгасыг тэр урд нь үзсэнгүй билээ. Нүүдэлчин иргэдийн нутагт их л сайндаа хэдэн зуун гэртэй их хүрээ л байхаас наранд гялбах алтан дээвэрт ордон өргөө сүндэрлэсэн чулуун хот хаана нь байх билээ. Хотыг дөрвөн зүгээс нь шивээлэн хаасан их цэргийг харахад өөрийн эрхгүй Чингис хааны агуу сүр хүчинд бахдан бишрэх сэтгэл төрөх ажээ.

Харин Чингис хаан Отрар хотыг эзлэхийг хөвүүддээ даатгаад өөрөө цэргийн хамт Хорезмийн нутгийн гүн рүү Сыр даръя, Аму даръяа мөрний хөндийг чиглэн явжээ. Гэтэл Хулан дараагийн хотыг үзмэгц андуурснаа ойлгов. Түүний үзэж бахархсан Отрар бол өчүүхэн жижиг суурин болохыг мэджээ. Чингис хааны цэрэг Нур хотыг буулган авч 1220 оны гуравдугаар сард алдарт Бухар хотын дэргэд очсон нь энэ байв. Эрдмийн хот нэртэй Бухар бол үнэхээр өчүүхэн Отрар цайзтай зүйрлэх юмгүй том хот учир Хулан гайхахаас аргагүй байв. Хүний гараар ийм тансаг, агуу их хотыг бүтээн босгосон гэхэд итгэж үнэмшимгүй санагдана. Хулан хатан энэ үзэсгэлэнт хотыг өөрийн болгож энд үүрд суухыг хүсэв. Бас эвдэн шатаахгүйгээр энэ хотын гудамж зээлээр зугаацан цэнгэхийг хүсчээ.

Хулан зам зуур үнс, чандруу болсон хот, тосгод олныг үзсэн тул дайн, ялалтын хий хөөрөл нь дарагдаж амьдралыг үнэн бодитоор үзэх болсон байв.

Чингис хааны бэлэглэсэн Перс газрын үнэт эдлэл, алт эрдэнэсийг түүний хөсөг арайхийн дааж явжээ. Хуланд эдгээр үнэт эдлэл нэгэнт сонин санагдахгүй болжээ. Тэр одоо энэ Хорезмийн үзэсгэлэнт хотыг өөрийн болгохыг хүсч байлаа. Тийм учраас Чингис хааны цэргүүд хүний гараар цогцлон бүтээсэн гайхамшгийг эвдэн сүйтгэж байгааг дотроо эсэргүүцэх болов.Гэтэл Хулан яаж ч эсэргүүцээд энэ их эвдрэл сүйрэл үхэл цусыг зогсоож чадахгүй ажээ.Харин Чингис хаанаас гуйвал ядаж ганц хотыг ч болов бүтэн үлдээх болов уу гэж бодох болсон нь эцэстээ нэгэн шинэ хүслийг төрүүлжээ.

Хулан энэ шинэ хүсэлдээ бүр шунан дурлаж ганц ч өдөр тайван сууж чадахгүй болсоор бас энэ хүслээ Чингис хаанд хэлж төвдөхгүй байсаар Самаркандын дэргэд иржээ.

Үзэсгэлэнт Самаркандыг хараад одоо цаг алдан алгуурлаж болохгүйг ойлгожээ.Магадгүй

дээд Тэнгэр ганцхан энэ хүслийнх нь төлөө түүнийг Тэмүжинтэй учруулсан ч юм бил үү. Хорезмийн зүүн нийслэл гэгдэх тансаг баян Самаркандыг эзлэн суувал Хуланы нэр алдар түгэн дуурсах юм шиг бодогдоно.Олон түмэн хүнтэй Самарканд хотыг Чингис хааны цэргүүд эвдэн сүйрүүлэхээс аварч чадвал Хуланг энэ нутгийнхан үеийн үед сайнаар дурсан санаж эцэстээ Самаркандыг “Хулан хатны балгас” гэж нэрлэвэл хичнээн бахархалтай билээ.Ийм шинэ бэрх хүсэлд автсан Хулан солиорох гэж байлаа.Тэр угаас нэг юм санавал цаана нь гарч байж санаа нь амрах зантай тул нэг мөч тайван сууж эс чаджээ.

Хулан хатныхаа эл хачин жигтэй байдлыг Чингис хаан ч гадарлажээ.Хулан ингэж өөрийгөө алдаршуулан бүхнээс дээгүүр суух гэж хүсэх болсон нь бас нэг учиртай билээ.Одоогоос хоёр жилийн тэртээ Чингис хааны их цэрэг Хорезм руу хөдлөхийн өмнөх нэгэн үдэш Бөртэ хатан Хуланг өргөөндөө урьж зоог барьжээ. Ганц биед нь ингэж анхаарал хүндэтгэл тусгайлан үзүүлсэн явдал урьд нэг их олон гараагүй тул Хулан их цочирдож балмагджээ. Алс газар одох болов гэж энэ биз хэмээн бодовч нэг л сайн зүйл төсөөлөгдсөнгүй билээ.

Энэ гэрт Тэмүжинд анх ирснээс хойш их хатан Бөртэ түүнд онцгой дотно хандаагүйг Хулан мэднэ. Тэр бүү хэл атаархан хорсох байдал ч илрэх шиг санагддаг байв.Ерөөс Хулан анхнаасаа л их хатан Бөртэ гэгч хөгшин авгайг дотор сэтгэлдээ ихэд үзэн яддаг байлаа.Тэр хөгшин хатан Чингис хааны дэргэд хамгийн их эрх мэдлийг эдлэх нь гачлантай. Бас дээр нь Чингис хаан өөрийн дөрвөн хөвүүндээ амиа тавьдаг тул Бөртэ яах ч аргагүй Хуланаас дээгүүр зиндаанд байх нь гарцаагүй агаад үүнийг хүн бүгд мэдэж Бөртийг хүндэтгэх нь Хуланд огтхон ч таалагддагггүй билээ.

Ядаж түүнээс үр хүүхэд гарсангүй.

Хэрэв түүнд хөвүүн үр заяасан бол Хулан Чингис хааны хамгийн хүндэт хатан болж,хөвүүн нь их хааны суудлыг залгамжлах нь гарцаагүй байхсан гэж бодох бүр хувь заяандаа ихэд гутрах болжээ. Гэтэл тэр үдшийн зоог дээр Бөртэ хатны хэлсэн үг туйлын хортой гашуун байсныг Хулан хэзээ ч мартахгүй гэж өөртөө тангарагласан билээ. Бас энэ үгийг Чингис хаан болоод дөрвөн хөвүүнийхээ нүүрэн дээр зориуд хэлснийг яана.Бөртийн энэ үгс Хуланг эхлээд цочоож, сүүлд нь гунигт автуулж одоо улам үзэн ядахад хүргэв. Чингис хааныг дайнд мордоход нь их хатны хувиар Бөртэ ингэж эр нөхөр, хөвүүдээ дайлж үддэг ёстой ажээ.Энэ тогтсон ёсоор тэр үдэш Бөртийн их өргөөнд Чингис хаан, Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй бас Хулан нар зэрэгцэн сууж байв.

Тэр үдэш Бөртэ хатны хэлсэн уран найруу үг бүгдийг эзэмдэж тэр дундаа Чингис хаан бүр их бахдалтай сонсохыг үзээд Хулан, дөрвөн хөвүүн төрүүлсэн Бөртэд үхтэлээ атаархсан билээ. Хуланд залуу наснаас өөр Бөртөөс дээр үзэх юм үгүйг мэджээ. Хулан Өгөдэйтэй нас чацуу, харин Тулуйгаас хоёр эгч бүлгээ.

Бөртэ хатан тэр үдэш олон хундага өргөж сайхан үг хэлсэнд бүгд сэтгэл сэргэжээ. Харин Хуланд хүндага барьж зориулан үг хэлэх хүртэл тайван сайхан байв. Бөртэ ээлжит хундагаа өргөөд ийн хэлэв.

-Хулан хатан. Чингис хааны зарлигийг дагаж чи хол аянд олон жил сараар явах тул бид уулзахгүй удах биз. Тийм болохоор би цөөн хэдэн үг хэлье.Увас мэргэдийн Дайр- Үсэнгийн

охин Хулан чи Чингис хаанд ирээд арван тав зургаан жил өнгөрчээ.Одоо чи увас мэргэдийн Дайр-Үсэнгийн охин Хулан биш, Чингис хааны хайртай хатан Хулан болжээ. Чи Чингис хаанд ирэхдээ арван наймтай байсан.Тэмүжин намайг очиж авахад би ч бас арван наймтай байсан.Цаг хугацаа гэгч энэ ертөнцийн бүх зүйлсийг хувирган өөрчилж чадна.

Нэгэн цагт танай Мэргэд аймаг Боржигон аймаг, Чингис хаанд дайсагнаж Бөртэ намайг хүртэл булаан авч байсан нь үнэнтэй. Гэвч муу үйл муу үйлээ л дагуулдаг аж. Одоо танай Мэргэд аймаг үйлээ даган Чингис хаанд дарагдан сүйрч нэгэнт үгүй болов. Харин Дайр-Үсэнгийн охин Хулан чи гоо сайхан төрснийхөө хүчинд амьд үлдэв. Чи өөрийгөө олон мэргэдийн дотроос хамгийн азтайд тооцох ёстой юм. Чингис хаан чамайг соёрхон таалаагүй бол чи өнөөдөр манай улсын хэний нь хөнжлийг бүлээцүүлж, хөлсийг арчиж явахыг хэн мэдлээ. Бүр сураг үгүй хумхийн тоос ч болсон байж мэднэ. Ийм үг хэлэв гэж чи надад гомдож туних зүйл үгүй.

Би энэ үгийг худал гэж санахгүй байна. Би хэлье гэж хэлж байна. Би бол Есүхэй эцэг сүй тавьж, Чингис хаан ёсолж авсан анхны нь хатан. Дөрвөн хөвүүн төрүүлж өгсний хувьд би ийм үг бардам хэлэх эрхтэй хүн. Би дөрвөн хүү төрүүлсний учир алтан урагт дархлагдаж Боржигон удмын хүн болсон юм. Харин чи мэргэд хүн гэдгээ хором ч бүү март. Чи гэнэ гэнэ хэн болохоо мартдаг тул би чамд үүнийг сануулж байна. Чи мэргэд хүн гэдгээ хэзээ ч мартахгүй санаж явбаас Чингис хаан чамайг соёрхон тэтгэж хавиргандаа авсны их ач, агуу сэтгэлийн үнэ цэнийг ойлгох болно.

Чингис хааны чамайг ивээлдээ багтаасан энэ их соёрхол танай мэргэд аймгийн олон олон хүн, тэр дотор төрсөн эцэг Дайр-Үсэнгийн чинь амь насны үнэтэй юм. Чи эцгийнхээ болоод энгийн мэргэд иргэдийн халуун амийг үрсний хүчээр Чингис хаанд иржээ. Тийм болохоор Хулан чи эртэй сайндаа их хатан болов гэж бүү эрд. Чингис хааны өмнө бүү осолд. Чи залуу хүн. Сэтгэлээ бөхөл. Хатан хүнд ямар журам байх ёстой гэж Чингис хаан сургасныг би чамд давтан хэлье. Чи лав сонссон биз. Гэхдээ миний амнаас сонссонгүй.

Миний хэлэхийн учир нь Чингис хаан энэ сургаалаа миний охин Алалтун бэхид хэлсэн учиртай. Чингис хаан Уйгур улсын хаан Идүүдийг эсэргүүцэлгүй дагав гэж сайшаан Алалтун бэхи охиноо өгөхдөө түүнд ингэж сургасан юм. Хатан хүнд гурван эр бий. Анхны эр нь алтан төр болно. Түүний дараах эр нь ариун нэр болно. Удаах эр нь авсан эр болно. Алтан төрийг хатуужиж дагавал ариун нэр бэлэн болно. Ариун нэрийг бэхэлбэл авсан эр ангид үл одно гэсийм.

Би Тэмүжинтэй арван настайдаа учирсан юм. Түүнээс хойш өдий болтол би Чингис хааны энэ сургаалийг дагасан билээ. Тийм болохоор Хулан чи ч энэ сургаалийг бүү март. Хатад бидэнд өөрийн гэх юм юу ч үгүй. Бүгд Чингис хааных. Ариун бие, алдар нэр, алаг үр бүгд Чингис хааных. Үүнийг ургэлж санаж яв. Миний хөвүүд чамаас ах.Тэд дөрвүүл цэрэг засаж улс эзэлсэн их жанжин болцгоожээ.

Гэвч эд бүгд Чингис хааны өмч юм. Чи одоо хол газар хаан эзнээ дагахаар сонгогдов.Ачаа нь хөнгөдсөндөө чамайг дагуулсангүй.Тиймийн тул эр нөхрөө асран халамжлахаа хичээ. Хаан хүний дэргэд хатан байхын учир юу вэ. Хоолыг нь халаах, хавиргыг нь дулаацуулах төдий юу.Үгүй ээ. Ариун нэр, алдар сууг нь бөхлөх гэж хатан байдаг юм. Бас алтан ургийг нь үлдээх

гэж хатан байдаг юм.Чи залуу байна.Нэгэн өдөр хөвүүн төрүүлэх биз.Чи хөвүүн төрүүлж хөнжилдөө хуурайлж үзээгүй болохоор үр хүүхэд гэж хичнээн үнэтэйг мэдэхгүй биз.

Яах вэ Сүүлд чи өөрөө үзэж мэднэ.Хулан минь холын замд харийн нутагт хичээ. Бөртийн энэ үгийг Чингис хаан болоод Хулан, бас хөвүүд нь бүгдээр нам гүм сууж сонсов. Сонсоход сургамжтай мэт боловч цаад санаа нь Хуланг илт тохуурхан доромжилж, доорд үзэн дарласан үг байлаа. Гэтэл Бөртийн энэ үгсийг Чингис хаан толгой дохин туйлын сэтгэл ханамжтайгаар сайшаан сонсохыг үзсэн Хулан тэр гэрт сууж чадахгүйд хүрэв.

Гэтэл Бөртэ хахсан дээр нь нудрав гэгчээр

-Хулан хатан. Та миний өргөөнд морилон саатсанд талархалаа. Би одоо эр нөхөр, хөвүүдийн хамт халуун амиар хэсэг зуур хөөрөлдье хэмээн найртай үгээр Хуланг шууд хөөн гаргав.

Арван тавны сарны сул цагаан гэрэл дор Хулан тэгэхэд гашуунаар мэгшин уйлсаар харьсан билээ. Бөртийн хэлснээр, түүний үзэж буйгаар Хулан бол Боржигон аймгийн дайсан мэргэд удмын, дээр нь өөрөө гуйж ирсэн, аймаг болон эцгийн амийг үрж золиослон байж өөрөө үлдсэн, Чингис хаанд хөвүүн төрүүлж өгөөгүй, хатан нэрнээс цаашгүй эм ажээ.

Бөртэ, Хуланг яг ингэж үзэж байсан бөгөөд Чингис хааны сургаал үгээр халхавчлан бүгдийн нүдний өмнө түүнийг сэтгэлээ ханатал доромжлон гутааж авчээ. Энэ бол Бөртийн олон жил хүлээсэн ясны өш хонзон, эм хүний хор шар, мэргэдэд булаагдсаны Хуланы эцэг Дайр-Үсэнд хүчирхэгдэн доромжлогдсоны хорсолоо тайлсан хэрэг байлаа.Бас өөрийн болоод Тэмүжиний нэр сүрийг бодоод Дайр -Үсэнд хүчирхэгдэн дарлуулснаа нууж өнгөрүүлсэн их шаналалаа тайлсан хэрэг байв.

Эр нөхрийг нь булаасан мэргэд цусны үзэсгэлэнт эм Хуланг Чингис хааны өмнө, өөрийн хөвүүдийн нүдэн дээр гутаан доромжилж сэтгэлээ тайтгаруулахын тулд Бөртэ хайртай хөвүүн Зүчиэ ч бодсонгүй, түүний мэргэд цустайг ч мартав.

Дайр-Үсэнг үхүүлэв гээд Бөртэ түүнийг өршөөж тайвшраагүй бөгөөд эцгээ ч үл хайрлах Хуланы цаад санааг тааж мэдээд Хулангаас өс авахаар шийдсэн билээ.

Зүчийгээ ч бодолгүй хатуу үг хэлсэн нь эм хүн өш санавал юугаа ч хайрлахгүй болдгийн жишээ энэ юм. Энэ хортой үгсийн дараа хэн Хуланг Бөртэтэй жишин үзэх билээ.

Хуланы итгэл найдвар, аз жаргалыг Бөртэ ингэж ганц удшийн дотор нураан сүйрүүлж чаджээ. Хулан үр төрүүлж Бөртийн зиндаанд хүрч чадаагүй заяандаа гомдон тэр шөнө анхилам үнэрт дэрээ нэвт уйлсансан. Чингис хаан тэр шөнө нь ирсэнгүй нь Хуланы гомдол шаналалыг улам гүнзгийрүүлж, хорсол хилэнг бадраажээ. Чингис хаан тэр шөнө их хатны дэргэдээс холдох сэтгэлгүй байжээ. Сүүлийн жилд тэр Бөртийн өргөөнд хоносон нь тоотой ажээ.

Харин энэ удэш их хатны цэцэн үг, саруул ухаанд биширч, өсч эрийн цээнд хүрч их жанжин болсон дөрвөн хөвүүнээ үзэж хөөрөөд ингэжээ. Шөнө дарсанд халамцсан эр эм хоёр хорин настай хонгор сэтгэлтэй хос шиг жаргаж цэнгэсэн бөгөөд үүндээ ч тэд их гайхсан билээ.

Хөлс хатаан хөнжил ярж хэвтэхдээ эрээ Хуланд өгч явуулах нь Бөртэд жаахан харамсалтай санагджээ.

- Тэмүжин чиний явах зам хол, хугацаа удаан, ядарч чилэх нь их тул залуу хатан тань уйдаж, хагсрах бий. Хаан та асрамжлахаа хичээж бүү мартагтүн. Ер нь эм хүн эр нь үргэлж л дэргэд нь эргэлдэж дэнгийн эрвээхэй шиг дэрвэлзэж байхыг хүсдэг юм. Хулан ч тэгдэг биз.

Хаан та бид хоёр одоо жар хүрэх ойртов. Хорезмоос ирээд гэртээ амар сууж, их дайнд хөвүүдээ мордуулж байгтүн гэж шивнэв. Энэ бол нэг хүн мэт болсон эхнэр хүний халуун сэтгэлийн үг тул Чингис хаан уярав.

-Тийм ээ. Бөртэ. Би хөгширч байна. Эмийг эдлэх хүсэл эр биеийн чалх чадал буурчээ. Би яг үүнд чинь сэтгэл зовно. Гэтэл Хулан ёстой гал мэт дүрэлзсэн тачаалтай юм. Гэвч би түүнийг нүдэндээ харж, дэргэдээ дагуулахыг хүснэ. Өөр шашинтай, өрнийн тэр улс намайг ямар гоо хатантайг үзэг гэж бодно

-Хаан та зөв боджээ. Гэвч Хуланаас үзэсгэлэнт эм Хорезмд лав буй. Та тэндээс Хулангаас ч гоо хатан авагтүн

-Одоо чи бид хоёр тэгэж хоёр биенд зовлон чирэгдэл учруулж яана гэж Чингис хаан үнэнээс өгүүлжээ.

-Тэмүжин.Залуу хатан таалах чинь хар биений чинь хэрэг биш.Хаан нэрний чинь хэрэг шүү гэж Бөртэ эрс шулуун хэлэв.Бөртийн энэ үг Чингис хааныг үнэхээр бишрүүлжээ.

-Бөртэ.Ингэж хэлэхийг чинь үзвэл би биш харин чи хаан суувал таарах байжээ.Би ганц биеийг амрыг бодож хэлснээс биш чам шиг ингэж хол бодсонгүй шүү.Хатан гэдэг чинь үнэхээр хаан суудлын хэрэг юм.Бөртэ.Би чам шиг хатантай тул ийм их нэр сүрийг олжээ гэж Чингис хаан хэлэв. Бөртэ Чингис хааны энэ үгэнд талархан түүнд бүх биеэр наалдав. Гэвч тэдний хуял тачаал дахин оргилосонгүйд хоёул гунигт бодолд автсан билээ.

Залуу нас, халуун цус нэгэнт холдон одсоныг ингэж мэдрэх нь хүн бүрт л гуниг шаналал авчирдаг биз ээ. Харин тэр шөнө Хулан нойргүй хонохдоо олон зүйлийг эргэцүүлэн бодсон боловч эцэст нь тэр нэгэнт л Чингис хааны хатан болохоор тэмцсэн тул юу ч тохиосон эрс хатуу тэмцэх ёстойг ухаарав.Нэгэн шөнийн дотор Хуланы сэтгэл бодол өөрчлөгдөөд шинэ хүн мэт болжээ.Одоо тэр хоосон мөрөөдөгч хорсон уйлагч байх нь дэндүү гэнэн бөгөөд өчүүхэн хэрэг болохыг ойгож авчээ.

Тэр хэтэрхий дорой үхээнц байгаа учраас Бөртэ түүнийг ингэж уландаа гишгин доромжилжээ.Бөртэтэй эрх мэдэл булаалдан тэмцэх хүчтэй зэвсэг байгаа нь түүний залуу нас, гоо үзэсгэлэн болохыг тэр санав.Одоо нэгэнт жар дөхсөн тэр хөгшин хатан Бөртэ хэзээ болтол наслах билээ.

Гэтэл Хулан одоо дөнгөж гуч гарч байлаа. Залуугийн гоо үзэсгэлэн, цог заль нь хэвээр харин ч нас тогтон байргашиж бүр ч эрийн хүслийг татах болно. Бөртэ лав үхнэ. Тэр цагт Хулан хэрхэх вэ гэдгээ бодох ёстой болжээ.Чингис хаан түүнд хайртай. Тийм учраас хатдынхаа

дотроос түүнийг сонгож шинэ аян дайндаа дагуулсныг ч ашиглах ёстой гэж шийдэв. Маргааш өглөө гэхэд Хулан огт өөр үзэл бодол зорилготой болж эрс хатуугаар шийдсэн байв.

Ер нь Хулан хар багын зориг, цөс ихтэй бүсгүй юм.

Түүнээс биш өөр хүн байсан бол Бөртэ болоод бусад хатдын нэр сүр, хор шаранд аль эрт дарагдан мартагдах байсан биз. Харин Хулан зовох бүр, хүн өөрийг нь гутаан доромжлох бүр өнгө орж, зориг чангардаг зантай билээ. Тэр ч янзаар Бөртийн хэлсэн гашуун үгийг хүлээн авч өөрийнхөөрөө эсэргүүцэн тэмцэхээр шийдэв. Ингэх гэж, Чингис хааны хайртай хатан болох гэж алдар нэрээ мандуулахыг хүсч амиа үл хайрлан зориглон тэмцэж ирсэн биш үү.Тэр яав ч Бөртээс дор суудалтай доогуур нэртэй байж болохгүй гэж шийдсэн билээ.

Хорезмд ирсэн хоёр жил өнгөрөхөд олон хот үгүйрч балгас болохыг үзээд Хуланы бодол сэтгэл өөрчлөгдөв.Бас өөрийн хүсэл тэмцлийн зорилгыг ч ойлгов.Энэ нь суурин амьдрагч иргэдийн олон жилийн хүч, ур чадлаар бүтээсэн их хотыг үзээд тал нутгийн тэнүүлч нүүдэлчин амьдралдаа гутан, голох сэтгэл байлаа.

Тийм ч учраас Хорезмын энэ үзэсгэлэнт хотыг эзэмшиж үүрд сууж алдар сүрээ мандуулах хүсэл түүнд улам хүчтэй төрөх болжээ. Яг ийм үед Чингис хааны цэрэг Самарканд хотын дэргэд ирсэн нь энэ байв. Сыр-Даръя, Аму даръя мөрний дунд орших цаг агаар нь дулаан зөөлөн,хөрс шороо нь нэн баялаг энэ гайхамшигт хот Хуланы сэтгэлийг татжээ.

Тэр Самарканд хотод үүрд суухаар шийдэв.

Мөхөж сүйрсэн мэргэд аймаг, Бөртэ хатны чимээгүй дарлал дор буцаж очихыг тэр хүссэнгүй.

Нутгаас гарснаас хойш даруй гурван жил шахам болоход Хулан нэгэнт өөр хүн болон хувирчээ.

Монголд байхгүй баян тансаг нутаг, нүд булаам орд харш, үнэт эрдэнэс, баялаг байхыг тэр үзэж, эдлэв. Одоо түүнд үүнээс өөр юу ч үл хүсэгдэх ажээ. Тэр энд персийн хивс торгонд хөлбөрч, Бухар дарс шимж, Самаркандын амтат идээ зооглож, Багдадын алтан эдлэл зүүж байв. Монголын тал нутагт түүнийг татах зүйл өчүүхэн ч үгүй мэт. Одоо энэ газарт Чингис хааны их цэргийг эсэргүүцэн тэмцэгч хүч үгүй болж, Хулан энэ газарт хамгийн алдар цуутай хатан болов.

Гэвч Хуланы сэтгэл үргэлжийн шаналал, харууслаар дүүрэн байх ажээ. Нас идэр, дур хүсэл их бүсгүйд цэрэг дайны их үйл, аян замын алжаалд туйлдан ядарсан угаас нас ахиж өвгөрсөн Чингис хааны эр хүний халамж энхрийлэл багадаж, хагсарч гундаад үүнээс үүдэн сэтгэл санаа тогтворгүй, уур уцаар ихтэй болжээ.

Үүний учрыг ч Чингис хаан мэдэх бөгөөтөл үнэн сэтгэл гарган түүнийг хайрлахын оронд перс, иран, түрэг цусны залуу охидтой цэнгэн самуурахыг урьтал болгоно. Чингис хааны энэ цэнгэлийг тэвчиж өнгөрүүлэх нь Хуланд бэрх байвч их хааны хүслийг эсэргүүцэн хорих хүн хэн билээ.

Хулан нэг талаас үзвэл тансаг эдлэл, үнэт эрдэнэстэй адил хөнгөн ганган сүйхний амьд ачаа болон хувирав. Заримдаа Чингис хаан юуны учир Хуланг дагуулан гарсныг гайхна. Залуу идэр бүсгүйд эр нөхөр нь үл тоомсорлохыг үзэж мэдрэх шиг гачлан доромжлол хаа байх билээ.

Гэвч Хулан тэвчин явав. Чингис хаан Хуланы шаналал зовлонг ойлгож байв. Гэвч залуу хатнаа хэн нэгэнд сэтгэл алдрах, биеэ эзэмдүүлэхээс үргэлж сэргийлж хар нүд үл хамхих итгэлт хүмүүсийг дагалдуулан харгалзуулжээ. Хулан хүн торонд хоригдсон тогос шиг суух аж.

Чингис хаан Хуланг зүгээр нэг дагуулж яваагүй юм.

Хорезмийн их хотуудаас элч ирж дагаар орох бүрт Хулан хатнаа дэргэдээ суулган тэднийг хүлээн авч үгийг сонсох бөгөөд ганцхүү энэ үед л тэр Чингис хааны хатан мэт байна. Чингис хаан Хуланг өмгөөлөн хамгаалах гэж, хайртай сэтгэлийн үүднээс түүнийг дэргэдээ авч Хорезмийг дайлахаар мордсон билээ. Учир нь тэр өөрийгөө Хуланд өртэй мэт боддог байв.

Залуу Хулан үр зулбаж, түүнээс хойш дахин хүүхэд олохгүй болсныг Чингис хаан өөрийн буруугаас болсон гэж бодох ажээ. Тийм учраас Хулан хатныхаа нэг насны шаналалыг нимгэлэн сэтгэлийг нь тайтгаруулан баясгах гэж Хорезмд дагуулан ирсэн билээ. Олон жилийн урт аян дайнд Хулан хатан нь уйдаж, ганцаардаж байгааг ч тэр мэднэ. Тийм ч учраас Хулан хатны элдэв этгээд хүсэлд хүндэтгэл анхааралтай хандах бүлгээ.

Самарканд хотыг эвдэн сүйтгэхгүйгээр эзлэн авч өөртөө бэлэглэхийг Хулан хатан Чингис хаанаас хүсчээ. Бас энэ хотод насан үүрд сууна гэхүйд Чингис хаан инээмсэглэж

-Хулан минь би чамд Самаркандыг өгье гэж дуртай зөвшөөрснөөр барахгүй Хулан хатныхаа эцэс төгсгөлгүй хүсэл сэтгэлд бахдалтай байв. Хулан ингэж хүссэн нь Чингис хааны их нэр сүр, хүч чадлын билгэдэл, биелэл мэт санагджээ. Түүнээс өөр ямар хаан хатандаа их хотыг бэлэглэсэн юм бүү мэд. Хуланы энэ хүсэл Чингис хааны сэтгэлд яв цав нийлж өөрийн хөвүүдэд Самаркандыг эвдэн сүйтгэхгүйгээр эзлэн авахыг тушаав. Гэхдээ Чингис хаан цаад зорилгоо сурсан зангаар тас нуусан билээ. Зүчи, Цагадай, Өгөдэй,Тулуй дөрвөн хөвүүний удирдсан их цэрэг Хорезмийн эзлэгдсэн хотоос дайчилсан үхлийн цэргүүдтэй нийлээд газар хөдлөж, өвс найгах мэт олон хүн Самаркандыг эргэн тойрон бүсэлж бараг агаар салхи нэвтрэх зайгүй шивээлсэн нь хотынхны зүрхийг үхүүлэх ажээ. Гэвч Хорезмийн эцсийн цайз Самаркандыг хамгаалагч арван нэгэн түмэн цэрэг хотын иргэд жанжин Албарханы удирдлагын дор нягтраад үхэлдэн тэмцэх зориг төгс байснаас гадна хот гурван давхар хэрэмтэй, эргэн тойрон усан хамгаалалттай байлаа. Хотыг нэгэнт эвдэхгүй авахыг Чингис хаан зарлиг болгосон тул Монголын цэргүүд шатаагч сум хэрэглэж чадахгүй болсон нь хэрмийг давахад саад болно. Гэвч тэдэнд үүнээс өөр зам байсангүй. Чингис хаан эхлээд лалын шашны нэртэй лам Хажиб Имамыг бичиг бариулан өөрийн элч болгож Самаркандад суугч Хорезмийн султан Мухамедад илгээв.

Бичигт “Чингис хаан миний бие дээд тэнгэрийг зарлигийг сонсгох гэж энэ газарт морилов. Найрсаг сэтгэлийн илэрхийлэл болгон миний иэлгээсэн элчийг алсны гэмийн хариуд Мухамед чамаас ял асуухаар би ирлээ. Чиний улсын ихэнх хот балгас нэгэнт минийх болов. Одоо чи Самаркандыг надад зүгээр өгөгтүн. Би чиний лалын шашинт иргэдийн амийг хөнөөхийг үл хүснэ. Миний их цэргийн өөдөөс сөрвөл сүйрэх амь, үгүйрэх хотын нүглийг чи

л Тэнгэрийн өмнө хариуцна. Хэн надад бууж өгнө, би түүний үр удмыг үл хөндөнө. Хэн миний өмнөөс эсэргүүцнэ түүний үр удам үүрд сөнөх болно. Чи миний үгийг эс дагавал чамайг чиний аллах тэнгэр чинь өршөөхгүй биз” хэмээн бичиж тамга дарсан байв. Чингис хааны бичгийн утгыг Мухамед мэдсэн дороо цочин сандарч өөрийн оронд өөрийн хөвүүн Желаладдинийг хаан суулгахыг тушааж, өөрийн хатад, хөвүүдээ аван газар доорх нууц хонгилоор Самаркандаас зугатан оджээ. Хаанаа хотод бий гэж итгэх цэрэг болоод иргэд үхтэлээ тэмцэхээр шийдсэн ажээ. Тэд Чингис хааны элчийн үгийг огт сонсож мэдсэнгүй. Харин Чингис хаан Самарканд хотод суух Түрэг гаралтай иргэдийн толгойлогч Имам Падешварт нууц элч илгээжээ.

“Монгол түрэг бид нэг гарал, удамтай ах дүүс биш үү. Бид Түрэг та нарыг Тэнгэрийн ивээлд багтаахаар тэр холоос ирэв. Та нар Мухамедийн төлөө хайран амиа үрэх хэрэг юу билээ. Хэрэв та нар удам гарлаа бодож хотын үүдийг нээж өгвөл би ах дүү Түрэг та нарыг өмгөөлөн авч амь болоод эд хөрөнгийг эвдэхгүй үлдээх болно“ гэсэн Чингис хааны бичгийг авсан түрэгүүд урваж Самарканд хотын гадагш гардаг найман их хаалганы нэг Намасхахыг нээж өгснөөр Чингис хааны их цэрэг хотод цутган оров. Хорезмийн цэргүүд хотын дотор байлдахдаа гаргуун, Монгол цэргүүд шатаах сум хэрэглэх хориотойгоос дэндүү олноор хядагдан, эсрэг талын харвасан шатаагч тосонд монголчуудын эзэлсэн байшин шатахад тэд олноор түлэгдэн үхэж байвч ухарсангүй.

Самаркандыг эвдэхгүй авах Чингис хааны эл хачин зарлигийг зөрчих эрхгүй ч өөрийн хайртай цэргүүд дэндүү олноор үхэж үрэгдэхийг үзээд Зүчи тэвчиж эс чадаад эцэст нь цэргийн амь дааанч хайран тул Самаркандын дунд хэрмийг шатаахыг тушаав. Үүнээс үүдэн Чингис хааны хөвүүдийн дунд хэрүүл үүслээ. Самаркандыг эзлэн авбал тэр хотыг Өгөдэй авах санаатай байсан бөгөөд Чингис хааны хотыг эвдэхгүй байхыг тушаасныг ингэж таамагласан тэрээр Зүчийг эсэргүүцэн хэдий цэрэг үхсэн ч хотыг шатааж болохгүй гэжээ. Цагадай гэнэт Өгөдэйг дэмжсэн нь хэрүүлийг улам дэвэргэж Зүчи -Би тэгвэл Самаркандаас өөрт оногдохыг шатаасугай гэжээ. Гэвч Өгөдэй арга олж Чингис хаанаас асуухаар шийдэв.

Хөвүүд Самаркандыг эзэлж чадахгүй маргалдан хэний үгийг дагахыг асуусанд Чингис хаан бодож төвдсөнгүй -Өгөдэйн үгээр бологтүн гэж тушаажээ. Галт зэвсэгтэй Хорезмийн цэргийн өөдөөс сэлэм барьсан монголчууд түрэн орж дэмий олноор үхэх болов. Зүчи уурлан цэргээ хойш татлаа. Хулан хатныхаа хүслийг биелүүлэх гэсэн Чингис хааны зарлиг эцэст нь олон түмэн монгол цэргийн амийг үрж, хөвүүдийг нь хагаралдуулахыг тэр тааж мэдсэнгүй.

Сэм оргож одсон Мухамед хаанаа бий гэж санан тэмцсэн хорезмын торгон цэргүүдийн эсэргүүцлийг дарахын тулд эцэст нь хотыг галдан шатаахаас өөр арга үлдсэнгүй. Монголын цэрэг Самаркандыг эзлэх гэж бүтэн дөрвөн сар болж нутгаас гарсан хоёр түмэн монгол цэрэг үхэв. Самарканд бүрэн шатжээ.Хотыг хамгаалагч цэргүүд хааны ордонтой цуг шатаж үхэхдээ хоосон ордон хамгаалан тэмцсэнээ сая мэджээ.

Гэвч өөрийн уугуул нутаг, суугуул хотоо аврах гэж яаж тэмцдэгийн үлгэр жишээг Самаркандчууд үзүүлэв. Бууж өгсөн түрэгүүдээс бусад залуу эмс, уран дархчуул хоёр түмэн хүнийг ялган цэргүүддээ хуваан өгч алт эрдэнэсийг монгол руу ачуулав. Эсэргүүцэн тэмцэгчдийн үр удмаас ташуураас өндрийг нь алсан нь гурван түм шахжээ. Хайран цэргүүдийнхээ амийг дэмий золиослосондоо Чингис хаан уурсан хилэгнэж Самаркандыг

газрын хөрстэй тэгшлэх зарлиг буулгасан боловч эцэст нь тэнд сайн дураар бууж өгөгсөд үлдсэнийг бодолцоод арай ингэсэнгүй. Арван түмэн өрхтэй байсан Самаркандын иргэдийн долоон түмэн өрх нь дүрвэн зугатаж үхэж үрэгдэн сүйрчээ.

Самаркандыг авах гэж удаж дэндүү олон цэргийн амь үрсэн бурууг Чингис хаан хөвүүддээ тохож, тэдэнтэй уулзахгүй ихэд хилэгнэсэн нь урьд хожид үзэгдээгүй муу үр дагавар авчирч мэдэх аюул бий болгосон тул Боорчи үгээ олж ядан Чингис хааныг ятгажээ.

Чингис хааны хөвүүдийн хооронд үүсэх болоод удсан хэрүүл зөрчил нь хөвүүд хийгээд Чингис хааны дунд үүсвэл улс бутрах аюул илэрхий болох билээ. Боорчийн үгийг сонсоод Чингис хаан дуугүй сууж сууж сая хөвүүдээ өөрт нь бараалхахыг зөвшөөрөв.

Гэвч Чингис хаан өөрийгөө буруу зүйл тушаасан гэж огтхон ч бодоогүй бөгөөд “Хөвүүд зүрх зориг мохож зорилго хүсэл цалгардах биш үү”гэж Боорчийн учирласнаар тэднийг өршөөжээ. Хэдийгээр Самаркандыг эвдэн сүйтгэлгүй бүтэн авч Хулан хатандаа өгч чадаагүй ч Сыр-Даръя мөрний эргийн хавцалд хясаа авируулан барьсан Нур балгасыг буулган авч Хуланд бэлэглэв.

Нур балгас бол хоёр түм илүү иргэдтэй, сэрүүн агаарт цэцэрлэгтэй, султан хааны зуны өргөө байх гоёмсог үзэсгэлэнтэй хот байлаа.Хулан хатанд үйлчлэх албат, зарц, шивэгчид мянга илүү болж хотыг бүх талаас нь байнгын цэргээр харгалзуулж, зөвхөн тусгай зөвшөөрөлтэй хүн л нэвтрэх журам тогтоов.

Бас Хорезмийн хотуудаас үнэт тавилга, алтан эдлэл, торго, дурдан, идээ будааг байнга нийлүүлэх болжээ. Хулан хатны өөрийн хоттой болж энэ газар үүрд суух хүсэл нь биелэв. Энэ бол 1222 оны өвөл байсан ч Нур балгаст цэцэг дэлгэрч, шувуу жиргэж байсан билээ. Хулан хатныхаа хүслийг бага боловч биелүүлсэндээ сэтгэл ханасан Чингис хаан түүнийг балгас ордонд нь орхиод цэргээ авч Инд мөрнийг уруудан Желаладдиныг хөөсөөр Энэтхэг газар одож эргэж ирэлгүй жил өнгөрөхөд Хулан ганцаар суусаар Нур балгасын хуучин нэр мартагдаж олон бүгдээр Хатан балгас гэх болжээ. Бүтэн хот эзэгнэн суусан нь Хуланд төдөлгүй сонин биш болоод харин ч ганцаардмал амьдралаа өөрөө хүсч олсон мэт санагдах болжээ. Жаргалыг олох гэж хүсэх мөрт зовлон нэмэгдэх нь Хуланы хувь тавилан шиг санагдах тул зарим өдөр галзуурч солиормоор.

Ерөөс тэр султан хааны зуны тансаг өргөөнд ганцаар байсаар галзуурахад ойрхон болж байлаа. Чингис хаан ялалтандаа улайраад эргэж ирэхгүй удах нь бүр ч гачлантай. Нур балгасын ордны дотоод үйлчилгээнд зөвхөн перс, иран, түрэг эмс хүүхнүүд зарагдаж харин Хулан хатны ёслол, хүндлэл, хоол унд гээд бүх л хэргийг Ю-Унчи хуучин хэвээр эрхлэсээр ажээ. Хуланы нүдэнд ойр үзэгдэх ганц эр хүйст нь тэр болно.Ю-Унчи урьд нь Зүрчидийн Алтан хааны Жүндү балгас дахь их ордонд яг ийм албыг эрхэлж байхад Алтан хаан түүнийг найрамдалтай байсан Татаар аймгийн ханд бэлэглэсэн билээ.

Татаар аймаг Чингис хаанд дарагдахад их ордонд үйлчлэх ёс дэгийг сайн мэдэх гучин тооны тайган хүнийг Чингис хаан Бөртэд бэлэг болгоход тэднийг толгойлон анх Монголын талд ирж зүтгэх болжээ. Бөртэ хатан Ю-Унчийг Хулан хатны дэргэд томилон суулгасан нь Чингис хаанд таашаагдсан тул тэрээр Хулан хатны ордон, өргөө, ёслол, хүндлэл бүхнийг эрхлэн

Хорезмд иржээ. Хулан хатан эхлээд өөрийн дэргэд эр хүн зогсож үйлчлэхэд дасахгүй хэцүү байсан ч Чингис хааны үгнээс зөрж эс зүрхэлжээ.

Тайган хүнд эр эм хүн ер ялгаагүй хүн л бол хүн, эзэн л бол эзэн гэж үзэх тул Хулан төдөлгүй дасч одоо Хулан юу хүснэ, Ю-Унчи бүгдийг биелүүлэх боловч бас тэр Ю-Унчийн зөвшөөрөлгүй нэг ч зүйл дураараа хийж болохгүй хатуу ёс тогтжээ. Хулан арваад жил болоход Ю-Унчи хэмээх хэдий жар шахсан ч залуу сайхан царайтай, бие хаа тэгш энэ хүнийг эр хүн гэж бодохоо больжээ. Ю-Унчийн дэргэд нүцгэн шалдан явахыг ч юманд үл тооцно. Учир нь тайган хүнд эмийг үзээд сэртэндэх хүсэл нэгэнт үгүй болсон байх аж.

Чингис хаан болоод түүний хатдын ёслол хүндлэл, дэг жаягийг Ю-Унчи анх тогтоон мөрдүүлсэн тул их тэр хүндлэлийг олжээ. Ордон өргөөний дотоод дэг ёсыг сахиулах өөрийн үүргийг Ю-Унчи хэнээр ч хэлүүлэлгүй чин шударгаар ёсчлон гүйцэтгэх нь олонд тэр дундаа Чингис хаанд ихэд таашаагдана.

Харин Бөртэ хатан чухам ямар далд санаагаар Ю-Унчийг Хуланы дэргэд шадарлуулсныг Хулан бүү хэл, Чингис хаан ч сэжиглэн тааварлахгүй ажээ.

Морь унаж, амь сахихч цэргээ дагуулан Сыр-Даръя, Аму-Даръя мөрний эргээр салхи татуулан давхих нь Хуланы ганц зугаацал юм. Бас хүсвэл перс бүсгүйчүүдийг авчирч өргөөндөө дуулуулж бүжиглүүлж болно. Ганцхан эрд эрхэлж, эм биеэ зугаацуулах боломж л үл олдох ажээ.

Хулан энэ хэрэгт нэг их шохоорхон дурлахгүй болсонд өөрөө ч гайхан хэдий дөнгөж гуч гарч байгаа мөрт дур хүсэл ингэж үгүй болсны учрыг үл олон өвчин эмгэг тусав гэж сэжиглэн Ю-Унчид хэлжээ.

Ю-Унчи түүнийг сонсоод инээмсэглэж:

-Хатантан.Газар ус, хоол хүнс солигдох нь эм хүний биед их өөрчлөлт үүсгэнэ. Та эргэлзэж элдвийг бүү бодогтүн. Чингис хааныг буцаж морилон ирмэгц та өөрийн эрүүл гэдэгт итгэх болно гэжээ. Хулан дахин өөрийг хэлсэнгүй түүний үгийг дагав. Гэвч Ю-Унчийн өдөрт гурван удаа ёс шиг өгдөг үзэмний шүүсэн ундаанд биеийн хөөрөл, сэтгэлийн хүслийг дарагч эм хийдгийг тэр мэдсэнгүй.

Энэ эм Хуланд үйлчилж тэр өдөр өнгөрч сар жил улирах бүр үзэхэд л үзэсгэлэнт эмээс цаашгүй хүйтэн цэвдэг болсоор байгаа билээ.Үүнийхээ цаад нууцыг мэдсэнгүй.

Ер нь Хулан Чингис хаанд өөрөө хүсч ирснээс хойш олон олон зүйлийн нууцыг мэдсэнгүй өнгөрчээ. Чингис хаанд тоогдож хатан суусан нь Хуланы эм хүн бүрийн амсаж эдлэх аз жаргалаас үүрд хагацуулсныг тэр мэдэхгүй байв. Зөвхөн өөрийн азгүй хувь зохиолдоо гомдон шаналахаас өөр арга байсангүй. Чингис хааны хүрээнд ирж суусан эхний ганц жил л эмийн ёсоор жаргасан байжээ.

Чингис хааны үрийг тээж өгүүлшгүй их жаргал баяраар бялхаж бас Чингис хаан дөч гарсан хойно нь гарах шинэ үрдээ хичнээн их баярлаж байсныг одоо санах бүр гол нь тасрах шиг

өвдөнө.

Гэвч тэр азгүй бяцхан амьтанд Чингис хааны ургийг залгамжлах хүн болох заяа олдсонгүй. Бие хаа нь эрүүл саруул байсаар атал цагаасаа өмнө гэнэт эвгүйрхэн үр зулбаж амьгүй хөвүүн төрүүлсэн нь Хулан, Чингис хаан хоёрыг хэрхэн цочирдуулсныг үгээр илэрхийлэх аргагүй байсан билээ.

Зулбасан үр нь хөвүүн байсанд Чингис хаан бүр ч их харамсан гашуудаж шөнө дөлөөр нулимс унагахыг Хулан үзээд харуусал, шаналалаа тэвчин түүнд дахин хөвүүн төрүүлж өгөхөө амласан юм.

Хэрэв тэр хөвүүн хүн болсон бол Чингис хааны голын хайртай үр нь болж одоо даруй арван найман нас хүрч хаан эцгийн суудлыг гарцаагүй залгамжлах байв.Ингэж санах бүр хэнд гомдохоо олж ядахдаа бүр Тэнгэрт ч болов өсөрхөн хорсох болжээ.

Хулан хатныхаа энэ гашуун зовлон, шаналалыг Чингис хаан үнэн сэтгэлээс ойлгож өрөвдөнө.

Гэтэл тэд яаж ч хичээгээд Хуланд дахин үр тогтсонгүй өдий хүрчээ. Лав үр зулбаснаас болсон эмгэг биз гэж Ю-Унчид хэлж элдэв газрын домч, төлөгчдөд үзүүлж эм, дом хүртсэн ч тусыг олоогүй юм. Ингээд ганц хувь заяандаа гомдох л үлдсэн билээ

. Энэ эмгэнэлт хэргийн цаад нарийн учрыг Хулан болоод Чингис хаан бас л тааварласангүй.

Залуу үзэсгэлэнт Хулан хатан өст мэргэдийн цустайгаас гадна жирэмсэлснээс нь хойш Чингис хаан ганц түүнийг энхрийлэх болсон нь Бөртэд яавч зөвшөөрөн сайшааж болохгүй хэрэг байв.

Энэ үед эм хүний сэтгэлийн мухарт байнга нуугдан байх атаа жөтөө нь түрэн, ухаан санааг нь мухардуулж хоолонд нь жүр цэцгийн ханд хольж өгснөөс Хулан үр зулбасан билээ. Ингэж Бөртэ дөрвөн хөвүүндээ аюулт өрсөлдөгч бий болох замыг хааж мэргэдэд булаагдсан,Дайр-Үсэнд хүчирхэгдэн дарлуулсны өсөө авав гэж тайвширчээ.

Бас Бөртийн зааврааp Ю-Унчи Хулан хатны бүх дэр жинтүүнд хүдрийн заар шингээснээс болж Хуланд дахин үр тогтохгүй болжээ.

Эр эмийн янагийн үйлийн үед эмийн бөгсөн дор ивэх жинтүүнд шингээсэн хүдрийн заар эрийн үрийн сунг хормын дотор үхүүлэх тул ийм аргыг монголчууд нууцаар хэрэглэдэг билээ.

Чухам ийм зорилгоор Бөртэ Ю-Унчиг Хуланы дэргэд шадарлуулжээ.

Ордны дотрох тайган хүнд их хатны үг Тэнгэрийн зарлиг байх ёстой тул Ю-Унчи их хатан Бөртийн зааврыг өнөө Хорезмд ч туйлбартай мөрдөн сахисаар ажээ.

Чингис хаан цэрэг дайны хэрэгтээ дарагдаад гэрийн доторх эмс хатдын хэрүүл зөрчлийг үл анзаарахын дээр гэрийн доторх хэрэгт ямагт Бөртийн үгийг дагах тул ер сэжиглэн ухаж бодсонгүй нь Бөртийг санаснаа гүйцэлдүүлэн Хулангаас өшөө авах сайхан нөхцлийг бүрдүүлжээ.

Чингис хаан Хуланг хөвүүн төрүүлээгүйд туйлын ихээр харамссан билээ.

Бүр зарим шөнө амьгүй хөвүүнээ амь оров, анд дагуулж явав гэж зүүдэлж хонодог байв.

Учир нь Тэмүжиний аваль хатдаас хөвүүн төрөхгүй болсоор уджээ.

Эм бие нь эрийн үрийг тогтоохгүй болсонд Хулан эхний үед зөвхөн өөрийгөө буруутган шаналж байсан нь алгуур өөрчлөгдөж Чингис хааны нас дээр гарч тавь гарсан хойно гэнэ гэнэ эр нөхрийнхөө чадал, чалхад эргэлздэг болжээ.

Энэ бодол нь удах бүр лавшран өөрийн залуу сайхан төрхийг үзэх бүр эр нь түүнийг жирэмслүүлэх чадалгүй мэт санагдан бас нэг зовлон шаналал нэмэгджээ. Чингис хаан Инд мөрнийг уруудан дайн хийсээр одсон хоёр жилд ганцаар гиюүрэн суухдаа сүүлийн энэ бодолдоо бүр бат итгэх болжээ.

Өөр эртэй хавьтаж өөрийн биеийг сорьж үзмээр хүсэл оргиловч ингэх нь амь насны аюултай тул арай ч зүрхлэхгүй байлаа. Өөр эрээс жирэмсэлж Чингис хааныг хуурах нь дэндүү ёс бус аймшигтай нүгэл болно гэж Хулан бодно. Гэвч үрийнхээ зулайг үнэрлэж эх болох хүсэл нь өдөр шөнөгүй зовоон тарчлаах ажээ.

Яг ингэж зовж тарчлан үзэмжит өргөөнд хоригдсон ялтан шиг өдөр өнгөрөөж байх тэр зун Энэтхэгийн аагим халуунаас зугатсан Монголын цэргийн түрүүч Хатан балгасын ойрд буцаж ирсэн нь Өгөдэйн цэрэг байлаа.

Түүний араас монголын бүх цэрэг цувран ирж яваа ажээ. Өгөдэй Аму-Даръя мөрний эрэгт цэргээ амраахаар байрлуулаад хоёр хоносны хойно дайны олзноос олон тооны үнэт бэлгийг авч Хулан хатанд бараалхав.

Чингис хааны эзгүйд Өгөдэйн ингэж бараалхсан нь Хуланд өөрийн нууц хүслийг биелүүлэх сайхан боломж ирэв гэж тэр сүүлийн хэдэн жил баярлаагүйгээ байрлаж Өгөдэйд өөрийн санаж бодсоныг ичиж эрээлэлгүй хэлэхээр шийджээ.

Өгөдэй түүнд дургүй,бас дээр нь түүний үгийг сонсоод хэрхэхийг таахгүй ч Хуланд зорисон санаанаас ухрах хүсэл үгүй байв.

Удахгүй их хаан сууринд Чингис хаан эцгээ залган суух Өгөдэйтэй ингэж хоёр биеэр тухтай уулзах учрал дахин тохиохгүй гэж Хулан айжээ.Харин Өгөдэй, хаан эцгийнхээ хатан учир ёсыг даган ирсэн төдий юм.

Өгөдэйтэй ийн учруулсан нь анх Тэмүжиний асарт очсонтой утга нэгэн санагдаад Хулан эргэлтгүй зоригжжээ.Тэд Хуланы сэрүүн өргөөнд шөнө дөл болтол ярилцаж, бухар дарс шимж, үүрээр Өгөдэй буцжээ.

Үүнээс сар хагасын дараа Чингис хаан Хатан балгасад буцаж ирэхэд Хулан өвчин тусаад хэвтэрт орсон байлаа. Дуу нь цааш орж, турж эцсэн хатнаа Чингис хаан бараг таньсангүй.

Харцнаас нь гэрэл цацарч, омог зориг илрэн байдаг Хулан одоо өд шиг сиймийж, өрөвдмөөр

яс арьс болжээ.

Чингис хаан мэргэч төлөгч бөө нараа цуглуулж даруй Хуланг аврахыг тушаав.

Тэд үзэж мэргэлсний эцэст нэг л зүйлийг санал нэгтгэн илтгэсэн нь Хулан хатан хүний нутаг усны сахиусны хорлол болсон байв. Тэгээд гучин охин, гучин хөвүүнээр тайлга хийхийг зөвлөжээ.

Гэвч Перс гарлын гучин охин, гучин хөвүүнийг алж тахисан ч Хулан илааршиж эдгэсэнгүй. Чингис хааныг ирснээс хойш яг ес дэх хоногийн үүрээр амьсгал хураав. Чингис хаан эхийгээ үхсэнээс ч илүү эмгэнэн гашуудаж их сахлаа ус болтол уйлахыг үзсэн хөвүүд шадруудын элэг эмтэрч гашуудал тайлах ямар зарлиг буулгахыг түгшин хүлээж байв.

-Чингис хаан. Би танд дэмий иржээ. Дайр-Үсэн эцгийгээ ч дэмий алуулжээ.

Мэргэд хүний адил танай цэргийн суманд үхэх ёстой байж. Би өөрийгөө бас таныг зовоолоо. Үрийг тань төрүүлж, өвдгийг тань түшүүлж чадсангүй. Бөртэ хатны хэлснээр би мэргэд хүн тул Тэнгэр лав таалсангүй биз. Энэ насанд заяасан цор ганц эр минь Чингис хаан та байв. Би их нэрийг чинь хугалж, эрхэм биеийг чинь хуурсангүй.

Ингэж үхэх нь миний муугийнх боллоо гэж шивнэсэн нь Хулан хатны сүүлчийн үг байжээ.

Хулан хатны биенээс сүнс нь зайлан дээш нисэн одохыг Чингис хаан олж харжээ.

Хулан гэгч энэ урьхан зантай, турьхан биетэй ч зориг цөс, санаа зорилго их хатандаа ямар их хайртай байснаа Чингис хаан сая сүнснээс хагацсан хүйтэн цогцосыг нь тэвэрч суухдаа л ойлгов. Амьдрал гэдэг зөвхөн ганц дайн тулаан, олз ялалт биш болохыг мэдэрчээ. Түүний сэтгэлийн талыг энэ бүсгүй эзэлж байжээ. Бие сэтгэл нь өвгөрсний дээр, одоо сэтгэл нь хоосрон эзгүйрэхийг мэдрэв. Энэ удаад өш хонзон биш гашуудал, харамсал төрж үхлийн өмнө хүчгүйдэн мөхөсдөхийн зовлонг эдлэж байлаа.Үхлийн өмнө Чингис хааны нэр сүр, хүч чадал, хөрөнгө зоорь, их цэрэг энэ бүгд хумхийн тоос замхрах лугаа адил юу ч биш болохыг үзэв. Өүлэн эх болоод сайн нөхдийн үхлийг ёстой юм шиг андуу санаж явжээ. Гэтэл тэднийг үхэл гэгч тэр аймшигт хүч яг Хуланы адил түүнээс булаан авсныг ойлгов. Бас тэр үхэл өөрт нь ч ойрхон сууж, сүүдэр нь юу юугүй толгой дээр нь тусахыг мэдүүт Чингис хаан Хатан балгасаас даруй зугатан гарч Сыр-даръя мөрний их усыг харж байж сая л ухаан оржээ.

Үхэл ашгүй түүнийг хөөлгүй ард хоцорчээ.Тэв тэнгэр одоо дэргэд байсан болоосой гэж Чингис хаан харамсан боджээ.Гэвч өнгөрч одсон цаг хугацааг хэн ч эргүүлэн авчирч чадахгүй ажээ. Чингис хаан ямар зарлиг буулгахыг хүлээж гурав хонов. Боорчи нар зөвлөөд Хулан хатны шарилыг Хэрлэний хөдөө арал, ихсийн тавьдаг их өтөгт хүргэхээр бэлдэж байжээ. Бас цэргийн тугийг буулгаж их гашуудал зарлав.

Чингис хаан гурав хоног хэнтэй ч уулзалгүй өргөөндөө бүгсэний эцэст Боорчи, Шихихутаг хоёрыг дуудав. Орвол Чингис хаан халамцуу, бүсгүй нөмгөн, орон дээрээ хагас хэвтэж байлаа. Чингис хаан юу гэж зарлиг буулгахыг тэд хүлцэнгүй хүлээв. Тэдний хэн нь ч зориглон дуу гарсангүй. Ямар ч үед үг хэлэх дархан эрхтэй Боорчи хүртэл зүрхлэн ам

нээсэнгүй. Өргөөнд нам гүм.Чингис хааныг халамцуу байхад элдэв үг хэлэх нь ноцтой аюултайг бүгд мэдэх тул ганцхан түүний ам нээхийг тэвчээртэй хүлээн суух ёстой байлаа.

Чингис хаан бодолд автсан шиг эсвэл унтаж байх шиг таг чиг. Гагцхүү нүд нь нээлттэй ганц зүг ширтэнэ.

-Хулан хатны сүнс явахгүй энд хоргодсоор байна гэсэн үг хагас өдөр шахам хүлээсний эцэст Чингис хааны амнаас унав. Тэр согтоогүй эрүүл саруул юм шиг дуугарна.

-Хаан таны үгийг бид анхааралтай сонсож байна гэж Боорчи орж ирснээ, хүлээж удсанаа сануулан аяархан дуугарав.

-Боорчи чи юу гэж Чингис хаан шивнээд огт танихгүй хүн үзсэн шиг түүнийг цоо ширтэхэд цочив.

-Боорчи чи сонсож бай. Хулан хатан бүх насаар энэ нутагт суухыг хүссэн юм. Түүнийг нь ёсоор болго. Хулан хатны дэргэд байсан бүх хүнийг энэ балгастай нь хамт үүрд түүнд үлдээгтүн. Газар дээр, тэнгэрийн дор Хулан хатныг сэтгэл хорогдох юу ч бүү үлдээ. Бүгдийг галд хайлуулж, газарт шингээгтүн. Энэ бол Чингис хааны зарлиг байв.

Дахин хагас өдөр хүлээсэн ч Чингис хаан дахин үг хэлээгүй тул Боорчи, Шихихутаг хоёул чимээгүй гарч хэрхэхийг зөвлөв. Тэдэнд Тэнгэрийн цаазыг зөрчих зүрх нэгэнт үгүй тул Чингис хааны зарлигийг хичээнгүйлэн ёсоор гүйцэтгэв. Хулан хатны хүслийг ёсоор болгон түүнийг Хорезмийн энэ нутагт Хатан балгасын хамт үүрд үлдээж юу ч үгүй болтол галдан шатаав. Ингэхдээ Хатан балгасын бүх иргэд, мал амьтан, Хулан хатны албат шивэгчин эмс, харуул манаа нэг ч хүнийг тэр бүү хэл хичнээн уйлж гуйсан ч Ю-Унчиг ч үлдээсэнгүй.

Тэр тайган эр Хорезмийн энэ балгаст Хулан хатны үхлийн нууцыг хадгалан үхэх ёстой байжээ.

Ю-Унчи үхсэнээр Хулан хатны үхлийн нууцыг ганц Өгөдэй л мэдэх болжээ.Т

үлэгдсэн, шатсан амьтан хүний дуу бүтэн сар тэнгэрт хадаж, бүгд нурам болон дуусаны хойно үнсийг хамж салхинд хийсгэв. Уулын аманд том хар толбо үлдсэний дээр голын эргийн зүлэг зөөн суулгаж ер байгалиас ургасан мэт болгов.

Одоо энд Хулан хатныг дурсуулан санагдуулах юм нэгээхэн ч үлдсэнгүй. Чингис хаан хоёр сарын дараа Хатан балгасын оронд үлдсэн зүлэг ногоон талбайд ганцаар зогсож байв.

Одоо Хулан хатан нь Тэнгэрт гарсанд тэр итгэж байв. Бас хатныхаа хүслийг биелүүлэв хэмээн тайвширч, түүний хойноос дахин гуньж гутрахгүй байхыг өөртөө хатуу тушаав. Мэргэд аймгийн Дайр-Үсэнгийн охин Хуланы амьдрал Хорезмын эзлэгдсэн нутгийн Хатан балгасын хамт утаа болон үнс болон тэнгэр газарт шингэж алга болжээ. Түүнтэй оронд нурж шатсан Хатан балгасын ором дээр шинэ хаврын ногоо урган соёолж байхыг Чингис хаан үзэв.

Энэ уулыг Хатан уул гэж нэрлэхийн Чингис хаан зарлиг болгов. Каспийн тэнгисийн өмнө

хойд тал Энэтхэгийн нутгийн морь хүрч болох бүх газрыг Чингис хааны цэргүүд эзлэн авав. Морины үс мулзлам халуун нар бүгчим агаараас өөр монголын морьт цэргийг зогсоох хүч нэгэнт үгүй болжээ. Чингис хаан Хулан хатныхаа үхлийн гунигийг мартаж бүх цэргээ Перваны хөндийд цуглахыг тушаан Багдад руу одсон Чормогон хорчи, Энэтхэг, Багдад хоёрын дунд орших Ару-Мару-Мараары улсын Абту хотыг эзлэхээр явсан Дөрвөдийн Дөрбэй догшин, Умар зүг Каспийн тэнгэсээс хойш довтолсон Сүбээдэй баатар, Энэтхэг рүү довтолсон Жалайрын Бала ноёныг эргэж ирэхийг тушаан элч элгээгээд хүлээж суув.Хойтон жилийн өвөл Сүбээдэй,Зүчийнхээс бусад бүх цэрэг ирж нийлсэн тул нутгийн зүг хөдөлж Ирчэс мөрөнд зусаад Туулын хар шугуй дахь их ордондоо зургаан жилийн дараа ирж буужээ. Одоо Чингис хааны эзэмшил нутаг газар дундын тэнгисээс зүүн далай хүртэл үргэлжлэх болов. Туулын хойд эрэг дээр Чингис хааны их хүрээ байрлаж ялалт олзоо дааж ядсан цэргүүдийг тал нутаг даяар дуу хуур болон угтан авчээ. Хулан хатны үхлийн тухай мэдээ аль эрт энд хүрч одоо бараг мартагдах дөхсөн байв.

Учир нь мэргэд аймаг сөнөж, Хуланы эцэг болоод удам угсаа нь арилсан тул түүнийг үнэн сэтгэлээс дурсан санах хүн үгүй болжээ.

Хуланы гунигт түүхийг Чингис хаан л мартаж чадахгүй байв.

Учир нь Хулан ганцхан Чингис хааны сэтгэлд л оршиж үлджээ. Хулан хатны өргөөг яг хэвээр нь бариад хүлээж байсанд Чингис хаан хатныхаа өргөөнд орж удаан ганцаар суусан билээ. Гэхдээ тэр гуньж гутарсангүй. Маргааш нь Чингис хааны зарлигаар Хулан хатны өргөөг буулгаж нүднээс далд аваачиж шатаасан билээ.

Мэргэдийн зоригт хатан Хуланы түүх энэ утаатай хамт замхран дуусав гэж Чингис хаан боджээ.

Гэвч тэр эндүүрсэн байлаа.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ЗҮЧИ

Лалын шашинтны нэгдсэн их улс Хорезмын хуучин нийслэл Ургенч бол үнэхээр алдартай хот билээ. Хорезмын их улс хүчирхэгжиж мандахын өмнө Ургенч хот Хорезм нэртэй байв. Нэгдсэн их улс нь энэ хотын нэрийг авснаас хойш Ургенч нэртэй болжээ. Ургенч нь Арал тэнгисийн өмнө талд Аму-Даръя мөрний эрэгт орших бүлгээ.

Ургенч бол хосгүй үзэсгэлэнтэй ховор цэцгэсийн хот гэж олон газрын ирсэн, зорьсон гийчид шагшин магтах ажээ. Хорезмын шинэ нийслэл Самарканд Чингис хааны цэргийн хөлд сүйрч,ойр хавийн хот балгас бүгд эзлэгдэхэд Ургенч хот эсэргүүцэл тэмцлийн ганц тулгуур болж торойн хоцров.

Хорезмын энэ гайхамшигт хот, түүний хавь орчмын нутгийг Чингис хаан Зүчи хөвүүндээ өгсөн байв. Чухам ингэж шилдэг нутаг, хотыг сонгон авч Зүчид талбин өгөх зарлиг буулгасан нь Чингис хаан цаанаа олон давхар ухаан бодол агуулсных юм. Эзлэн авсан газар орон өргөжин тэлж цэргийн хүч нэмэгдэхийн хэрээр хийж гүйцээх олон олон шинэ ажил зорилго нэмэгдэх ажээ. Эдгээрийн дотроос Зүчи хөвүүний тухай бодол санаа сэтгэлээс нь салахгүй болжээ.

Хорезмыг эзлэх их тулааны цус, дуулиан дунд эрхгүй дарагдан намжаад байсан Зүчи, Цагадай хоёрын дундах зөрчил цэрэг дайны үл ялих хэрэг дээрээс улам хурц тод илрэх болсныг Чингис хаан анзаарахгүй байхын аргагүй болжээ. Тэдний бие биеэс илүү гарах хүсэл, хэн хэндээ үл захирагдах үзэл, зөрчил нь Самаркандыг эзлэн авахад бүр ч тод илэрч энгийн олон цэргийн амийг дэмий үрэхэд хүргэв. Ингэж цөөн монгол цэрэг олноор эрсдэх болсныг яавч зүгээр өнгөрөөж болохгүй байлаа.

Хөвүүд нь нэг замын цэрэгт багтан нэгдсэн дайралт, тулаан хийх чадваргүй болох нь илт болжээ. Энэ бол ялалтын сүр хүчийг алдруулж,цэрэг ардын итгэлийг сулруулах аюултай тул Чингис хаан зарлиг болгон Ургенч хавийн газар нутгийг Зүчид хуваан өгсөн нь энэ билээ. Хөвүүдээ аль болох хол,тус тусад нь явуулах нь зөв гэж тэр үзэж байв.

Өгөдэйг их хааны орыг залгамжлуулахаар сонгосноос хойш Зүчи болоод Цагадайн зан үйлд нэгэн тод өөрчлөлт орж байгааг шадрууд нь илтгэх болжээ. Энэ бол тэдний эцгээсээ тусгаарлан бие даах гэсэн эрмэлзэл байлаа. Нэгэнт хаан суудал Өгөдэйнх болсон нь тэднийг ийм алхам руу түлхэж, урьд нь эцгийн хавсрага болж их ялалтын бат суурь болж явсан тэд одоо их бага ч болов өөрийн эзэмшил нутаг, улсаа байгуулах нууц хүсэлд автсаныг Чингис хаан тов тод ойлгож мэджээ.

Чингис хаан эцгийнхээ орыг залгамжлан Их монгол улсын хаан суух гэсэн Цагадай хөвүүнийхээ хүслийг буруутгах аргагүй юм. Гэвч Өгөдэйг хаан ор залгамжлуулахаар шийдсэнээ Тэнгэрийн зарлиг гэж Чингис хаан үзэж байсан тул Цагадайн тухай нэг их санаа зовсонгүй билээ. Тийм ч учраас Зүчи, Цагадай хоёрт шинээр ззлэн авсан Хорезмд нутаг хуваан эзэмшүүлэх нь зөв гэж шийдэв. Энэ нь тэдний зорилго тэмцлийг хурцлан зоригжуулах биз гэж найдах болов. Чингис хаан ч одоо нэгэнт өөрийн цэрэгтэй болсон хөвүүдээсээ хол байх нь зөв гэж боджээ. Чингис хаан эцгийнхээ энэ шийдвэрт Зүчи туйлын баяртай байлаа.

Өөрийн тусгаар улсыг байгуулан суух нь Зүчийн ганц далд хүсэл мөрөөдөл болоод байв. Бас сэтгэлийн гүн дэх арилшгүй гомдол,гүнзгий харууслаа тайлах ганц арга нь ч энэ юм. Өөрийн тусгаар улсыг байгуулж, хэнээс ч хараат бус суухаар Зүчи хатуу шийдсэн байлаа. Тэр ингэж эргэлт буцалтгүй хатуу чангаар зориглон шийдсэн нь Өгөдэйг хаан суурь залгамжлуулахаар сонгоход болсон хэрүүлийн дараа юм.

Тэр өдрийг хүртэл хэрхэн хуурташ, хий хоосон зэрэглээн дунд амьдарч байснаа Зүчи тэгэхэд яс махандаа шингэж ой тойндоо ортол мэдэрч гашуунаар харамсан уйлж билээ.

Чингис хааны өргөөн дэх их зөвлөгөөн өндөрлөж Өгөдэйг хаан суурind залгамжлуулан суулгахаар зарлиг буулгасан нь Зүчийн сэтгэлийн дотор бугшин хуримтлагдсан олон зөрчил гомдлыг зад татаж , илд сэлэм, ирт мэсний эдгэршгүй ил шарх мэт шаналган түүний дөч шахам жилийн үйлт амьдралын бүх зорилго утгыг сарниулан хаяжээ. Чингис хааны хүрээнээс хөдөлж Сэлэнгэ мөрний баруун цутгалан Идэрийн голын хөвөөнд байх өөрийн хүрээ рүү мордохдоо хэрэг болгож Бөртэ ээжтэйгээ ч уулзсангүй нь түүний сэтгэлийн чанад дах зовлон хямрал хичнээн гүнзгийг илтгэнэ.

Тэр хэзээ ч ингэж эхдээ хайр халамжгүй хандаж байгаагүй бөгөөд чухам ингэсэн нь бүх болсон хэргийн учирт эхийгээ буруутган бодсоных байв.

Бүх улсын ихэс дээдсийн өмнө “Мэргэдийн орхидос” хэмээгдэн гутаан доромжлогдож, олон бүгдээр үүнийг илт хүлээн зөвшөөрч байсан төдийгүй бүр Чингис хаан, Цагадайн гашуун үгийг сонсоод огт хилэгнэсэнгүйгээр барахгүй харин битүү дэмжиж зөөлнөөр хандан

-Үүнээс хойш Зүчийг ингэж бүү ад үз гэсэн төдий үг хэлсэн нь Зүчийн уур хилэнг улам ч оволзуулжээ.

Энэ нь Чингис хаан түүнийг өөрийн алтан ургийн дотор нүүдэл дагасан золбин нохой мэт үзэж буй хэрэг гэж Зүчи гомдон гутарчээ.

Маргаангүй үнэн болж батлагдсан, бүр олны өмнө ил зарлагдсан, Чингис хаан хүлээн зөвшөөрсөн түүний мэргэд гарал нь Зүчийг, түүний үр хүүхдийг хэзээ ч алтан урагт багтаан тооцож үзэхгүй гэдгийг нь тодруулж бас Зүчийн удам хэзээ ч их хаанд өргөмжлөгдөхгүйг үнэхээр тодорхой ойлгуулсан билээ. Ийм хэрэг болохыг Зүчи бодоогүй биш бодсон юм. Тийм ч учраас хаан орыг залгамжлан суух итгэл, хүсэл Зүчид угаас хүчтэй байсангүй.

Цагадайтай өрсөлдөн тэмцэлдэхгүй байхыг Бөртэ эх нь хар багаас нь хатуу сурган хүмүүжүүлсэн билээ. Хайртай Бөртэ эхийнхээ сэтгэлийг бодоод тэр Цагадайг өргөмжлөхөд огт татгалзахгүй гэдгээ эхдээ амласан байв. Цагадайг хаан суурind өргөмжлөхгүйн тулд Зүчийн нэр нүүрийг нэг мөсөн барж, үнэн хэрэгтээ түүнийг золиослож байж Өгөдэйг өргөмжлөхөөр Чингис хаан шийдсэнд Зүчи ингэж ихээр гомдож хорссон байжээ.

Зүчийг хаан суурind өргөмжлөхгүйн тулд Цагадай өөрөө ч хаан суурinаас татгалзах болно гэдгийг Чингис хаан тооцжээ. Чухам Цагадайн амаар Өгөдэйг өргөмжлүүлэх нь Чингис хааны зорилго байсныг Зүчи ойлгов. Тэнэг Цагадай Чингис хааны хаясан өөшинд хуурташ Зүчийн нэрийг сонссон даруйд оволзон уурлаад өөрийгөө ч түүнийг ч баллаж орхижээ.

Чингис хаан чухам ингэхийг л хүлээж байжээ.

Ийм замыг сонгон авсан нь Чингис хаан түүнийг хар ялаанаас дорд үзсэний баталгаа гэж Зүчи итгэсэн нь түүний гомдол хорслын эх болов. Энэ бүх гүнзгий гомдол хорслын дунд хамгийн анхлан төрсөн бодол нь эхийгээ үзэн ядах сэтгэл байв. Ийм гашуун доромжлол амссанд орвол ерөөс ертөнцөд хүн болж төрөөгүй нь шулуун мэт.

Төрөхөд минь хаяж орхихгүй яав гэж Зүчи гутран бодож явлаа.

Ийм бодолд түүртэн автсаны улмаас эхийнхээ гэрт оролгүй өөрийн хүрээг зорисон билээ. Гэвч энэ нь үйлийн үрээс зугатаах гэсэн гэнэн оролдлого төдий болохыг зам зууртаа ойлгов. Түр зуурын хямрал, сэтгэлийн хөөрөл, уур бухимдал нь морины явдалд дарагдахад

-Одоо яах вэ гэсэн ганцхан асуулт сэтгэлд нь эргэлдэж байлаа. Түүнд одоо Чингис хааныг дагахаас өөр ямарч амьдрал, зорилго байсангүй. Бас хайрлаж өсгөсөн эхийгээ яав ч гомдоон орхиж болохгүйг ухаарчээ.

Чингис хааны их хүрээнээс мордсон цагаас хойш дэргэд нь сүүдэр шиг дагаж, эцгийнхээ шаналант царайг цогтой хар нүдээр гярхай ажиглаж явсан арван нэгэн настай Бат хөвүүний нь шивнэн хэлсэн ганц үг түүний нүдийг нээж, зүрхийг амилуулах шиг болжээ. Тэр үед Зүчийн баг цэрэг Туул голыг гаталж амарч хонохоор буугаад байжээ. Хээрийн хөнгөн асрын дор Зүчи тэрийн хэвтэж унтах ч биш, зүүдлэх ч бишийн дунд хөвөрсөн бодолд умбажээ.

Шөнө дунд өнгөрч бие чилсэн тул өндийн үзвэл гадаа галын дэргэд Бат хөвүүн нь шөнийн хэвтүүл манаа шиг ганцаар торойн гүн бодолд автан суухыг харжээ. Хөвүүнийхээ энэ эмэгнэлт төрөхийг үзмэгц гэнэт гол нь харлан өрөвджээ. Нялх балчир хөвүүнийхээ сэтгэлийн доторх хямрал, эгдүүцлийг Зүчи зөнгөөрөө мэдээд уяран нулимс урсгав. Гашуудалт сэтгэлийн нь ганц гэрэл гэгээ, ирээдүйн итгэл нь энэ хөвүүн мөн болохыг аянга цахилгаан гялбан нүргэх шиг хормын дотор ухааран ойлгомогц ухасхийн босч очоод Батын толгойг энгэртээ нааж ичиж зовох юмгүй мэгшин уйлжээ.

Хатуу чанга зоригтой, баатар эрсийн манлай, олны үлгэр дууриал болсон эцэг нь ийн хүүхэд адил гомдон уйлахыг үзээд Бат хэргийн цаад учрыг тодорхой сайн мэдэхгүй ч хоёр нударгаа тас зангидан олон үгт Цагадай авгаа үзэн ядаж өш авах халуун хүсэлд шатаж суужээ. Зүчийн ганц тайтгарал Бат хөвүүн нь болов.

Зүчийн нулимст нүд харанхуйд гал мэт шатаж

-Хөвүүн минь, Бат минь сонс. Эцэг чинь их хаан нэр зүүх хувьгүй төржээ. Харин чи бүү осолд. Эцгийн олоогүй нэрийг хөвүүн чи бүү алд. Чамайг их хаан болохгүй бол миний сүнс ч амрахгүй гэж мэд гэж занал хорсол дүүрэн шивэгнэжээ.

Энэ бол Зүчийн гэрээслэл мэт үг байсан юм. Бат ч эцгийн үгний эцсийн үнэ цэнийг үзэж сонссон хэмжээндээ сэтгэлийнхээ хирээр ойлгоно. Харин ч эцгийн итгэлийг дааж их хэргийг гүйцэлдүүлэх хатуу хүсэлд бяцхан зүрх нь хагарах шахан цохилж байв.

-Та бүү санаагаа зовоо. Би таны үгийг осолдохгүй дагана. Би их хаан болно.

Бат хөвүүний нулимс цийлэлзсэн гэрэлт хар нүд өөрийнх нь үгний баталгаа болон гялалзахыг Зүчи үзээд сэтгэл уужирчээ. Алтан улсад гарсан үймээн самууныг дарахаар явсан Сүбээдэй баатрын хамт жил болоод ирсэн Бат хэдий нялх балчирч энэ байтугайг хэлж хийх хүсэл, чадвар дүүрэн болсон билээ.

Батын эцгээсээ дутахгүй эрэмгий баатар болох шинж нь хар багаас тодорсон байв. Зүчи, Бат хөвүүнээ элгэндээ тэврээд үүр цайтал суусан билээ.

Харин Тату эцэг хүү хоёрын тав тухыг алдагдуулахгүйн тулд холд модны дор сууж хоножээ. Эцэг хүү хоёр эзнийхээ сэтгэлийн хямралыг Тату хэнээс ч илүү ойлгодог байв.

Их зөвлөгөөн дээр болсон хэрүүл шуугиан хүрээ даяар тарснаас болоод Бөртийн сэтгэл хямарчээ. Гэтэл Зүчи хөвүүн нь түүнтэй уулзалгүй зугатах мэт одсоныг сонсоод Бөртэ үхэл үзсэн юм шиг царай зэвхийн, зүрх нь түгшин ихэд шаналж бүр хэвтэрт оржээ. Зүчийн ингэсэн нь аймшигт аюулын дохио мэт санагдана. Энэ бол Бөртийн өдий болтол үзэж өнгөрүүлсэн амьдралдаа хүлээж байсан хамгийн аймшигт мөч байлаа.

Нэр нүүр бүтэн,аз жаргалтай амьдралд нь нуугдан байсан зөрчил ганц хормын дотор задран гарчээ. Бөртийн бие сэтгэлээрээ хамгаалан өсгөсөн хөвүүн нь өөрөөс нь зугатан оджээ. Бүх юм Бөртийн санасны эсрэг болов. Чингис хаан түүний хэлснээр өөрийн ууган хөвүүн Цагадайг биш, Өгөдэйг өргөмжилсөн нь Бөртийн шаналалыг даруй хоёр дахин нэмэгдүүлэн цочроосон нь өвчин хөдлөхийг түргэтгэв.

Одоо Бөртэ хөвүүдээ хоорондоо тэрсэлдэн тэмцэлдэхээс түгшин айжээ. Эцгийн хойно хаан суурин суух нь яах аргагүй Цагадай юм. Бөртэ үүнийг хүсч байв. Гэтэл Чингис хаан зөвшөөрсөн мэт байтлаа гэнэт өөрөөс нь далд зөвлөгөөн хийж Өгөдэйг өргөмжилсөн нь, бас тэр хурсан олны өмнө Цагадай илэрхий дээрэнгүй доромжлох үг Зүчид хэлсэн нь Бөртийг энэ мөчид үхэхээс өөр мэхгүй мэт болгов.

Зүчи бол тэртээ тэргүй хаан удмыг залгамжлах ёсгүй гэж Бөртэ үзэж байсан тул түүнд тэгтлээ санаа зовоогүй билээ.

Тийм ч учраас

-Чингис хаан эцэг чинь юу гэнэ. Чи түүнийг л хийх ёстой. Чингис хаан чиний амийг соёрхон өгсөн юм. Чи хэзээ Чингис хаан үх гэнэ. Тэр үед нь өчиггүй үхэх хэрэгтэй гэж хатуу чангаар сургаж хүмүүжүүлсэн тул Зүчид эргэлтгүй итгэж байжээ. Гэтэл сүүлийн хэдэн жил хэн ч сөхөж хэлээгүй, тэр бүү хэл Цагадай өөрөө ч мартсан мэт тайвширсан тэр явдлыг ихэс дээдсийн өмнө, төрийн зөвлөгөөн дээр гарган дурдаж Зүчийн мэргэд гаралтайгаар нь гутаан доромжилсон Цагадайн болчимгүй занг Бөртэ өршөөж чадахгүй байлаа.

Ингэж түргэн гоомой үгнийхээ золиосонд тэр өөрөө ч хаан суудал залгамжлах эрхээ алджээ. Хэвтэрт байх тэр үедээ Цагадайг дуудан ирүүлж уйлж загнав. Цагадай тэртээ тэргүй гэмшиж гутрах нь хэмжээгүй байгааг үзээд Бөртэ хөвүүнээ өрөвдөн хэлэхээр зэхсэн хатуу үгээ татжээ.

Цагадайн догшин, сүрлэг овор дарагдаад сүнс сүлд нь зайлсан мэт царай алджээ. Гэвч гомдолт харцны нь гүнд аймшигт хонзон нуугдахыг Бөртэ олж харав. Тээж төрүүлж,тэвэрч өсгөсөн үрийнхээ сэтгэлийг эх нь биш бол өөр хэн мэдэх билээ. Их эрх мэдэл, эзэн хаан суудал голоо тасалж төрүүлсэн хайртай хөвүүдийг нь хэрхэн дайсан болгож, өөрчлөн хөнөөхийг өнөө Бөртэ өөрийн нүдээр үзэж байв.

Эцгийн суурийг залган их хаан суухын тулд хичээж чармайхыг хичнээн удаа Цагадайд зөвлөж сургаж

-Зүчи ах чинь чамд хэзээ ч саад тотгор болохгүй. Чи эхдээ итгэ. Хаан эцгээ залгамжлах ганц хүн бол чи юм. Хүү минь хичээ гэж хэлснээ санахад Бөртэ одоо Цагадай хөвүүнийхээ өмнө өөрөө ялд унасан мэт санагдана. Цагадайг өргөмжлөхийг Чингис хаан зөвшөөрсөн мэт байсан тул Бөртэ бат итгэсэн билээ. Их итгэл хөсөрдөхөд түүний оронд хорсол, гомдол үлддэгийг тэр голдоо ортол мэдэрч байлаа.

Гэвч одоо эх, хүү хоёр юуг ч өөрчлөн хувиргаж чадахгүй болжээ.

-Чи ганц хором тэвчиж, Өгөдэйн нэрийг дурдахгүй өнгөрч чадсангүй юу гэж шивнэхдээ Бөртэ, Өгөдэйг адилхан л өөрийн хөвүүн мэт санахгүй байв.

-Мэдэхгүй, ижий ... нэг л мэдэхэд ийм явдал болжээ. Би ижий таны захиж сургаснаар явж чадсангүй. Өршөө ...

Цагаадайн энэ үг туйлгүй их гэмшил,харамсал хийгээд сэтгэлийн шаналал дүүрэн сонсогдоно.

-Нааш ир, хүү минь Цагадайн гучин долооны жил орж байгааг хөвүүнийхээ энхрий үнэр нь арилаагүй толгойг элгэндээ тэврэхдээ Бөртэ санав.

-Хүү минь, жил чинь орж байгаа. Болгоомжтой явж үз ...

-За, ижий. Цагадай бол Бөртийн дөрвөн хөвүүд дотроос эхдээ хамгийн их эрхэлж өссөн нь билээ.

-Хаан эцэгтээ бүү гомд. Улам хичээж зүтгэ. Би Зүчи ахад чинь санаа их зовно. Чи бол эцэгтэй хүн. Харин Зүчи ахад чинь надаас өөр хэн ч байхгүй юм. Чи үүнийг үргэлж санаж яв.

-За, ижээ

Догшин түрэмгий хурц халуун зантай Цагадай хэзээ ч ийм дуулгавартай, зөөлөн байсангүй. Чингис хааны гаргасан зарлигийг эргүүлэн өөрчилж чадах ганц хүн бол эх нь гэдгийг Цагадай мэдэх учир ийм торго мэт аашилж байжээ. Харин Бөртэ хөвүүнээ алдаандаа гэмшиж, ухаарч байна гэж уярч ямар ч болов Чингис хаантай энэ тухай эвтэй цаг олж ярина гэж бодож хэвтсэн билээ. Гэвч энэ бол санаа мухардсан эм хүний дэмий бодол төдий юм. Одоо Бөртэ үггүй мордсон Зүчи хөвүүндээ илүүтэй ихээр санаа зовж байв.

Харин Бөртэ болоод бусад бүх хүнийг гайхуулсан нэг хэрэг маргааш өглөө нь болов. Гэнэт одсон Зүчи Бөртийн өргөөний гаднах уяан дээр давхин ирж буусанд бүгд цочин түгшжээ. Олны өмнө ил тодоор “Мэргэдийн орхидос” гэж доромжлогдсон Зүчи яаж ч мэднэ гэсэн түгшүүр, айдас бүгдэд төрөв. Ингэх нь ч аргагүй байв. Яаж ч нууж хаасан Зүчи, Цагадай нарын хэрүүлийн дуулиан аль эрт Чингис хааны хүрээнээс халин гарч сониуч хүүхнүүдийн хэл чихний зугаа болжээ. Хүний мууд дуртай зарим нь энэ хэрүүлийн дараа цус, үхэл гарахыг зөгнөн хүлээж суусан ч байж мэднэ. Зүчи болоод Цагадайн зан ааш ингэхгүй гэхийн аргагүй.

Их аадрын өмнөх шиг түгшүүрт нам гүм эргэн тойрныг эзэлж Зүчийн гэнэт эргэн ирсэн мэдээ Чингис хааны өргөөнд тэр даруй хүрчээ. Энэ үед Чингис хаан Боорчи, Мухулай, Зэлмэ, Хасар,Сүбээдэй,Зэв нарын хамт Хорезмд мордохын өмнө Алтан улсыг хэрхэх тухай зөвлөж суужээ. Хэрүүлийн дараа Чингис хаан хөвүүдээ сэлэм сугалан цусаа урсгах вий гэж үнэндээ эмээж, ийм явдал хэрхэвч гаргуулж болохгүйг Боорчи, Мухулай хоёрт хатуу тушаажээ. Гэтэл огт санаагүй хэрэг болж Зүчи шууд гэрийн зүг явсан билээ. Харин одоо Зүчи гэнэт эргэн иржээ. Замын дундаас яах гэж эргэн ирснийг, ирээд шууд эхийнхээ өргөөнд орсны учрыг тэр дор нь таахад бэрх байлаа.

Тийм ч учраас Чингис хаан чухал зөвлөгөөнөө шууд таслан Боорчийг явуулж учрыг мэдэхийг даалгав.

Ингэх нь зөв байв. Боорчи бол Зүчийн хэргийг төрөхөөс нь эхлээд Чингис хааны өмнө хариуцсан хүн юм.

Хоёулханаа үед Зүчийн талаар үг хэлэх бүрдээ

-Боорчи. Чи миний зарлигийг зөрчиж Зүчийг амьд үлдээсэн хүн гэж заавал дурсан хэлдэг билээ. Боорчи ч үүнийг ойлгоно. Ингэж хэлэхдээ Чингис хаан зэмлэн буруушаах өнгө ер үзүүлдэггүй юм. Харин энэ удаа олны дэргэд дээрх оршлоо хэлсэнгүй зүгээр л -Боорчи чи очиж үз гэжээ. Чингис хаан, Боорчи хоёрын хооронд байх Зүчийн тухай эл нууцыг Бөртэ, Зүчи хоёр мөн л өөрсдийнхөөрөө ойлгох ажээ. Бөртэ ч, Зүчи ч Боорчид их дотно сайхан хандана. Зүчийн хувьд Боорчи бол эх барьж авсан хүн, хүйг нь морины явдал дунд тас хазсан, улаан гараар нойтон нь нүцгэн биеийг нь өвөртөө хийж амьдруулсан ачтан юм.

Энэ тухай Бөртэ, Зүчийг хэзээ ч мартахын аргагүйгээр ярьж өгсөн билээ. Хожим ухаан орсон цагаас Зүчи үргэлж л Боорчийн асрамж, халамжид явжээ. Бас Боорчи бол Сүбээдэй баатрын нэгэн адил Зүчийн байлдах дайтах, цэрэг засах эрдмийн багш нь байв. Тиймээс ч Зүчи, Боорчийг Чингис хаан эцгийн дараагаар үзэж хүндэтгэнэ. Үүнийг мэдэх учраас Чингис хаан Боорчийг Зүчийн болох болохгүй үг, үйлдлээс сэргийлэх гэж яаралтай явуулжээ.

Боорчийг гарахад торгон цэргүүд өргөөг тойрон зогсоод хүлээж байв. Торгон цэргийн мянгатын ноён Үүлэн-Чэрби аль эрт Зүчийн бараанаар сэрэмжлэн цэргээ зассан нь энэ юм. Ингэж хэт болгоомжлон сүр үзүүлэх нь гомдсон Зүчид яавч аятай санагдахгүй гэж Боорчи үзээд торгон цэргүүдийг байранд нь буцааж өдрийн хишигтэн цэргийг ердийн журмаар үлдээхийг тушаажээ. Зүчийн сэтгэлийн гомдлыг сэдрээх өчүүхэн ч сэжиг, хар үүсгэж болохгүйг Боорчи ойлгоно. Зүчи юу ч боллоо гэсэн эцгийнхээ эсрэг хэрүүл зарга үүсгэх хүн биш гэдгийг Боорчи мэдэж байв.

Эхийнхээ хэвтэрт орсныг үзээд Зүчи их сандрав. Ингэнэ гэж санаагүй тул хэл сураггүй явснаас нь болов гэж өөрийгөө буруутгав. Харин Бөртэ Зүчи хөвүүндээ юу гэж хэлэх үгээ олохгүй байв. Зүчи эхийгээ үзээд сэтгэл хямарч хар цагаан таг дуугүй суусаар байжээ. Харин Бөртэ дотроо онгойтол уйлж авчээ. Тэр Зүчид тодорхой юу ч хэлж чадахгүй.

-Хүү минь. Чи надаас болж ийм зовлон доромжлол амсах болжээ. Болсон хэрэгт ганцхан эхийгээ л буруутгаж, гомд. Өөр хэнд ч хар буруу бүү сана. Чингис хаан эцэгтээ, Цагадай дүүдээ муу санахыг чинь би хориглож байна гэж эх нь халуун нулимсаа асгаруулан хэлэхэд эхийнхээ хатан зоригийг мэдсэн Зүчи зүйрлэшгүй ихээр уярч гэмшжээ.

Эхийнхээ юунд санаа нь зовж байгааг Зүчи сайн ойлгож байв. Төрүүлсэн хөвүүд нь хэрүүл тэмцэл хийж, алалдахаас л айж буй. Эхийгээ тайвшруулан амирлуулах нь чухал байсан тул хэлэх үгээ сайтар бодож олов.

-Ээж минь. Та амар бай. Би хэзээд таны хэлснийг мартахгүй санаж явах юм. Би Чингис хаан эцгийн зарлигийг ёсчлон дагах болно. Та тайван байж, биеэ бод гэжээ. Бөртэ Зүчийн үгийг үнэмшиж итгээд уяран уйлжээ. Тийм ээ. Түүний Зүчи хөвүүн эхийн үгнээс гажиж зөрсөн удаа үгүй билээ. Зүчи бол эхийнхээ үг, ухаанаар ярьж, сэтгэж хүмүүжсэн хүн юм.

Гэвч энэ удаа Зүчи хөвүүн нь нэгийг хэлж нөгөөг бодож байгааг Бөртэ даанч мэдсэнгүй. Өгөдэйг хаан сууринд залгамжлуулахаар сонгож, Зүчийг мэргэдийн цустайг олонд тунхагласан хэрүүлээс хойш өнгөрсөн хоёр хоногт дуулгавартай, ухаантай Зүчи хөвүүн нь нэгэнт огт өөр хүн болон хувирсныг Бөртэ таамагласангүй. Зүчи ч дотоод санаагаа сайтар нууж хуучин хэв төрхөө үзүүлнэ.

Энэ амьдрал, хөвүүдийнхээ бодол, хүслийг Бөртэ нэгэнт мэдэхээс өнгөрч, хөвүүд нь эхийн мэдлээс үүрд салж одсоныг Бөртэ мэдэхгүй, мэдэх ч аргагүй ажээ. Ер бүх эх хүн Бөртийн адил юм.

Эх хүн бүр төрүүлсэн үрээ өвгөн болсон ч нялх гэж санасаар байдаг биз. Харин үрс нь өөр өөрийн хүсэл зоригийг даган үүрээ орхих шувуу адил тарж одох бүлгээ. Бөртэ яг л ингэж эрийн цээнд хүрч, эрдэм чадал нь жагссан хөвүүдээ эгээ л эмзэг нялх шиг санасаар байв.

Хэдийгээр Зүчи, Цагадай нарын хэрүүл Боорчийн хүссэнээр элдэв хэл амгүй намжих шиг болсон ч уршиг нь хуурай хөвдөнд алдсан түймэр шиг битүү дотуур уугин ассаар байгааг Чингис хаан тааварлаж байлаа. Энэ түймэр хаана хэзээ илэрч дүрэлзэн асахыг таахын аргагүй ажээ.

Буцаж ирсэн даруйдаа Зүчи хөвүүн нь бараалхах зөвшөөрөл хүссэн нь Чингис хааныг ихэд түгшээв.

Ер ингэж ёсорхдоггүй байсан Зүчи харц албат мэт, харийн элч мэт зөвшөөрөл эрсэн нь тэр өөрийгөө нэгэнт Чингис хаанд хамаагүй хүн мэт үзэж буйгаа илэрхийлж, бас ингэж үзэж байгааг эсэргүүцэж байгаа юм шиг санагдана.

Зүчийн бараалхах гэснийг Боорчи түүнд уламжилжээ.

-Чамд юу гэж хэлэв хэмээн Чингис хаан Боорчийг юу гэж хариулахыг мэдсээр атал дэмий асуув. Ингэж илүү сул үг хэлсэн нь Чингис хааны ухаан мухардан сандарсныг илтгэнэ.

-Тэр хөвүүн надад юу ч тодорхойлон хэлсэнгүй гэж Боорчи өчив.

-Зүчи юу гэж сэтгэв гэсэн Чингис хааны үгийг Боорчи хариугүй орхив. Тэр үнэхээр Зүчийн юу хүссэнийг таамаглаж чадсангүй. Хариу дуугараагүйд нь Чингис хаан хилэгнэсэнгүй. Үнэхээр юу гэхийг хэн ч таасангүй.

Зүчи ер нь ингэж албархаж байсан удаагүй учир энэ явдал Боорчид ч гэсэн хачирхалтай байв.

-Хаан та Зүчийг балчир хүүхэд шиг бүү бод. Бас балмад дайсан шиг ч бүү сана. Зүчи бол Бөртэ хатны амин үр нь юм.

Бас хаан таны харвасан сум шиг хавтай жанжин юм.

Та ингэж бодогтун. Та илүүг сэтгэж, ихийг бүү таамагла.

Зүчи хэзээ ч хаан эцгийнхээ эсрэг хар санахгүй.

Би үүнийг батлана. Бас Бөртэ эх нь ч батлах биз.

Боорчийн энэ ухаант үг бас дээр нь Бөртийг дуртган хэлсэн нь Чингис хааныг эргэлзээг арилгаж ээдсэн сэтгэлийг амирлуулав. Боорчи хэрэгтэй үгийг яг цагт нь олж хэлжээ. Хэрэв Боорчи үгүй байсан бол Чингис хаанд Зүчи өөрийг нь хорлох мэт сэжиг төрөөд бараалхуулахгүйгээр буцаах, бүр алахад ч бэлэн байв. Гэвч Боорчийн үгийг ухаарч Зүчийг бараалхуулах зарлиг буулгав.

Зүчийг босго давмагц Боорчи урьд нь ярилцаж тохирсон мэт үг дуугүй гарч одсон нь Чингис хааныг дахиад л хар сэжигт унагаж, хилэгнэхэд хүргэв. Гэвч нэгэнт нүүр тулсан тул ухрах булзах арга олсонгүй.

Чингис хаан Зүчийг ад шоо үзсэн биш, харин айж сэрдсэн сэтгэлээр анх удаа угтав. Зүчийн хар багаас огт хувираагүй үлдсэн тод цэлмэг харц өнөө ч өөдөөс нь илэн далангүй итгэл төгс ширтэж байх ажээ. Олон жилийн өмнө хорин таван настай идэр Зүчи яг ингэж ширтэн суугаад Ойн иргэдийг дайлан хураах цэргийг удирдуулахыг хүссэн билээ.

Тэр үед Зүчи дээрх үгийг Бөртэ эхийнхээ зааж шаардсанаар хэлсэн билээ. Зүчийн хүсэл гэхээс илүү, Бөртийн энэ шаардлагыг Чингис хаан тэгэхэд эргэлзэхгүйгээр хүлээн авч Зүчид цэрэг захируулан Хөвсгөл нуур, Шишгид гол руу хөдөлгөсөн юм.

Зүчи эцэг эхийн итгэл сэтгэлийг алдалгүй бахархалтай явж ойн иргэд олныг бүр Эрчис мөрөн, Байгаль нуурын орчмын газар нутгийг эзлэн авч эцгийн улсын хаяаг тэлжээ.

Энэ үед Зүчийн цэрэг байлдааны эрдэм, бусдыг дагуулах чадал од мэт гялалзан тодорч олныг бишрүүлсэн билээ.

Одоо Чингис хааны өмнө хорин тавтай идэр залуу биш, дөч дөхөж, дөрвөн улсыг дайлах тулаанд оролцсон их жанжин Зүчи сууж байв.Сэлэм эргүүлж гардан туллаа ч Чингис хаанд үл дийлдэх баатар эр болжээ. Чингис хаан өөрийн хардсан муу бодолд хэтэрхий автсанаас болж эхлээд хэлэх үгээ олохгүй сандарчээ. Зүчийн сэтгэл хөдөлж байгааг бас хэлэх гээд үгээ онож бодож чадахгүй сул дэл үг ярьж суугааг Чингис хаан мэдэв. Ийм үед өөрөө түрүүлж учиртай үгийг хэлж уймарсан сэтгэлийг нь өөрийн зүгт дагуулан авах нь зөв гэж сэтгэв. Үүний тулд идээ, айраг сөгнүүлж өөрт бодох зав олохыг хичээсэн нь оножээ.

Зүчи хаан эцгийн хүндлэлд сатаарч бас баярлаж байгаа нь илт. Чингис хаанд одоо үгээ хэлэх цаг ирэв.

-Зүчи минь. Хүү минь Чингис хаан ингэж хэлээд хэсэг дуугүй суув. Энэ нь өөрийн хэлсэн дээрх хоёр үг Зүчид яаж нөлөөлөхийг хүлээсэн хэрэг юм. Ийн дотно, эерүү зөөлөн хэлсэн

-Хүү минь гэсэн үг Зүчийн хатан зүрхийг ингэж уяраан догдлуулна гэж Чингис хаан бүү хэл Зүчи ч өөрөө таамагласангүй. Гомдсон сэтгэлийн хэлхээс алдарч Зүчийн зүрх жаргалтай догдлон цохилж нүүр нь улайв. Өөрийнх нь бодож хэлсэн үг Зүчийн зүрхийг онож тэдний хооронд байсан эргэлзээ, сэжгийг арчин хаяхыг Чингис хаан мэдэж бас энэ үгэндээ өөрөө багагүй догдлон уярахаа анзаарчээ. Үүнд Чингис хаан ихэд гайхав.

Гэвч гайхаж суух цаг биш тул бодсон үгээ үргэлжлүүлэв.

-Хүү минь. Чи одоо их Монгол улсын алдартай жанжин болжээ. Хийсэн дайн, байгуулсан ялалт чинь чиний нэрээр дуурсагдан үлдэх цаг ирж. Зүчи хөвүүн чи үүнийг үргэлж санаж яв. Чиний ялалт, алдаа эндэгдэл чинь Их Монгол улсын нэр сүртэй шууд холбоотой боллоо. Цагадай ч мөн адил. Одоо ертөнц даяар Чингис хаан намайг харж сонсож байна. Харин миний хийх хэлэхийг хөвүүд та нар гүйцэлдүүлэх учир чиний нэр Чингис хаан эцгийн чинь нэртэй адил боллоо.

Бас Бөртэ эхийн чинь нэртэй холбогдоно. Чиний төлөө эхийн чинь зовсон зүдэрснийг юугаар ч хэмжиж болохгүй. Тийм биз. Зүчи дуугүй толгой дохив.

-Хүү минь. Чи бол миний хөвүүдийн ахмад нь. Чиний хийх, хөдлөх дүү нарт чинь үлгэр болох ёстой. Харьяат, цэргүүддээ бахархал болох ёстой. Та нарын өмнө уужим их газар орон байна. Би энэ ертөнц бүхлээрээ минийх болохыг хүснэ. Чи тэгэж хүсэхгүй гэж үү. Одоо бидэнд хэн саад хийнэ.Энэ ертөнцийг өмнөө сөхрүүлэх цаг миний хайртай хөвүүд та нарын өмнө Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй та дөрвийн өмнө иржээ. Энэ цагийг үзэх гэж Хаан эцэг чинь, хатан эх чинь нүдээ цавчилгүй, нүүрээ арчилгүй зүтгэж ирлээ. Одоо та нарт хэн саад хийж чадна. Та дөрөв адилхан Чингис хааны алтан ургийн хан хөвүүд биш үү. Холыг бодож хоёрыг сэтгэж явагтун.

Чингис хааны энэ бахархалт үгс Зүчийг бүр босон харайтал дэврээв.

-Тийм ээ. Энэ газар орон бүгд Чингис хааных байхыг би хүснэ.

-Суу, Зүчи ээ. Чи хэлэхийн өмнө үгээ сайн бодож сур. Чамайг би ер зэмлэх гэсэнгүй. Чи одоо

хүүхэд биш гэж Чингис хаан зөөлөн аяар зэмлэв. Зүчи ичингүйрэн суув.

Тэр одоо эцгийнхээ үгэнд илбэдүүлж, юу гэж хэлэх гэснээ ч мартах шахжээ.

-Их хаан суух нь угаас Тэнгэрийн зарлиг тул хэн ч бай түүнийг зөрчих эрхгүй болно. Чи ч, Цагадай ч, би ч мөн адил.

-Тийм ээ. Би мэднэ. Хаан эцэг та бүү санаагаа чилээ. Би зарлигийг ёсчлон дагана. Энэ үгийг Зүчи үнэн санаанаас хэлжээ. Нэгэнт Зүчийн үгийг сонссон тул Чингис хаанд санаа зовох юм үгүй болов.

-Хөвүүн чи хэл. Юу хүснэ. Бүү эрээлж нэрэлх. Зүчийн хэлсэн бүгдийг эргэлзэхгүй биелүүлнэ гэж Чингис хаан итгэлтэй боджээ.

Зүчи ч хэлэхийн өмнө хэсэг зуур бодов.

-Хаан эцэг минь. Миний цэрэг эрэлхэг, байлдах сургууль шилдэг. Та үүнийг Алтан улсад үзэж мэдсэн биз ээ.

Зүчи өөрийн шилдэг хоёр түмэн цэргээр бахархах ёстой юм. Түүний цэрэг Алтан улсын гучин том балгасыг дайлан эзэлснийг бүгд батлана. Гэвч Зүчи юу гэх гээд байгааг Чингис хаан таахгүй тул дуугүй суув.

-Миний цэрэг хаа ч хүрсэн үл цуцаж, ямар ч бэхлэлтийг эвдэн сөнөөх болно. Одоо би оньсон харвуул, чөдөр их буу олонтой болсон. Миний цэргүүд шатаагч тостой сум хийж сурч байна. Бас..

-Чи юу хүснэ. Шууд хэлэгтүн гэж Чингис хаан Зүчийн энэ дүйвүүлсэн олон үгэнд төвөгшөөн үгийг нь тасалж асуув. Чингис хаан одоо нэгэнт Зүчээс айж болгоомжлохоо больсон тул сурсан эзэрхүү түрэмгий зан нь дийлжээ. Зүчи хэсэг зуур бодол болов.

-Хүү минь хэл. Гэвч гаргасан алдаагаа Чингис хаан хормын дотор засаж Зүчийг тайтгаруулан дэмжиж дууныхаа өнгийг өөрчлөн ийн хэлжээ.

-Би ... Би Хорезмын нутагт их цэргийн манлай болон орохыг хүснэ. Тэр харийн улс Чингис хааны их цэргийн нэр сүрийг надаас олж хараасай гэж хүснэ. Хамгийн эхний хотыг би өөрийн цэргийн хамт эзлэн авахыг хүснэ гэж Зүчи нэг амьсгаагаар тод хэлээд нэгэнт хүслээ илтгэсэн тул санаа амран хариу хүлээв.

Ингэж хэлнэ чинээ санаагүй тул тэр дороо Чингис хаан шууд дэмжин зөвшөөрөх буюу эсэргүүцэн няцаах аргагүй болжээ. Гэвч ийм чин сэтгэлийн үгийг хариугүй орхих буюу үл тоомсорлон үзэж яавч болохгүй билээ. Бас яагаад Зүчи ингэж хүсч байгааг ч ойлгов. Олны өмнө доромжлогдон алдарсан нэр сүрээ Чингис хаанаас засч залруулахыг шаардаж буй хэрэг юм. Магадгүй ийм үгийг Бөртэ хэлсэн биз гэж бодов.

Гэвч энэ бол Зүчийн ганц биений хүсэл байлаа.

Баруун зүгт хийх их дайны манлайд явах эрхийг олж гэмээ нь Зүчийн сэтгэл амрах байв. Хэрэв Чингис хаан түүнийг хүндэтгэн тоож үздэг бол ингэх ёстой гэж тэр боджээ. Зүчи энэ бүхнийг ганц өөрийн хар толгойн төлөө биш бүр Бат хөвүүнийхээ төлөө хэлсэн билээ. Чингис хааны ууган ач хөвүүдийн дотроос Бат хөвүүнээ ялгаран товойлгохыг Зүчи туйлаас хүсчээ.

Энэ бол өөрийн гашуун хувь тавилангийн эсрэг тэмцэхээр сонгож авсан эцсийн арга зам байлаа. Одоо энэ их дайнд Бат хөвүүнээ алдаршуулан тодруулах их зорилгыг сонгон авчээ. Үүний тулд Зүчи юу ч хийхэд бэлэн байв.

Гэвч Чингис хаан Зүчийн энэ холын бодлыг таасангүй. Ганцхан Зүчийн шаардлага хүсэлд оночтой хариу хэлэхийг л хүсчээ. Чингис хаан Зүчитэй зөрчилдөн муудалцах нь аюултайг ойлгож байсан тул аргагүйн эрхэнд бууж өгч аяар нь байхыг чармайж байлаа. Харин Зүчийн хүсэлтэд ганц хормын дотор хариу хэлэх боломжгүй юм. Учир нь Хорезмын их улсыг дайлах нь ер тоглоом биш билээ. Гэвч дуугүй суух нь Зүчид эвгүй сэтгэгдэл төрүүлэх тул ам нээхээс аргагүй.

Зүчийн энэ хүсэлт олон жилийн өмнө Хүйтэн уулын тулааны үед Хасар Боорчийг цаазлахыг шаардсантай утга нэг байв. Эвгүй буруу үг хэлбэл тэртээ тэргүй эргэж буцаж гомдож бухимдсан Зүчийг цааш түлхэх аюултай билээ.

-Зүчи, хөвүүн минь гэж Чингис хаан өнөөх элгэмсүү зөөлөн үгээ дахин хэрэглэв.

-Би чиний чадал, хүчийг бахдаж байна. Миний их цэргийн хамгийн шилдэг нь чиний засаж хүмүүжүүлсэн цэрэг мөн. Миний бүх цэрэг бүгд ийм байгаасай гэж хүснэ. Гэвч хөвүүн минь. Хорезмын улсын цэрэг, дайтах аргыг бид сайн мэдэхгүй. Тагнуул туршуулын хүний үг сонссоноос цаашгүй. Суурин балгаст зууралдан байлдахдаа сүрхий гэнэ. Бид олноор зөвлөлдөж Хорезмтой хэрхэн тулах аргаа сонгоогүй байна. Би чамайг манлайд явуулахыг сайшаана.

Гэвч би ихийг үзсэн Боорчи, Сүбээдэй, Зэв, Хасар авга чинь юу гэхийг сонсъё. Таньж мэдэхгүй газар орон, уулзаж учраагүй дайсантай хар зоригоор тулна гэдэг нүцгэн биеэр галд орсонтой адил юм. Түрүүлж дайрсныг баатар зоригтон, бахтай жанжин гэж үзэхэд учир дутна. Хөвүүн чи намайг ахмадын үгийг сонстол хүлээ. Би чамайг Хорезмыг эзлэх дайнд шалгаран мандаасай гэж хүснэ.

Миний хөвүүд,чиний дүү нар Зүчи чиний адил ийм хүсэлтэй гэдэгт итгэнэ. Гэвч хөвүүн чи мэдэхгүй газар, танихгүй дайсны өөдөөс түрүүлэн дайрах гэж бүү зүтгэ. Би чиний чин их хүслийг мэдсэн тул баярлаж, сэтгэл ханав. Би хөвүүн чамайг хатан биеэ сүйтгэж хайран нэрээ үрэхийг үл хүснэ. Хөвүүд та нарын амь бие, алдар нэрийг би алтан биетэйгээ, агуу нэртэйгээ адил үзнэ. Гэвч би ихсийн зөвлөгөөн дээр Хорезмд чиний цэргийг манлай болгон илгээхийг илтгэнэ.

Зүчид Чингис хааны үнэн үгийг дуугүй даган зөвшөөрөхөөс өөр юу ч үлдсэнгүй. Хэдий хаан эцэг нь түүний хүсэл бодлыг шууд дэмжээгүй ч энэ яриа Зүчид сайхан сэтгэгдэл үлдээв. Чингис хаан ч баясгалантай болжээ.

Ер тэрээр Зүчийн ухаан, зоригийг бахаддаг билээ.

Бөртэ хатны мэргэд цустай энэ хөвүүн яагаад ч юм бэ хүн хүнээс илүү үнэнч сэтгэлтэй мэт санагддагийн нууцыг Чингис хаан тайлж ядна. Магадгүй үргэлжийн гадуурхагдаж, ил далд ад үзэгдэж байхдаа Чингис хааны төрсөн хөвүүнд ногдох итгэл хайрыг олж авах их хүсэл тэмүүлэлдээ шатаж байдаг нь Тэмүжинд хязгааргүй үнэнч зүтгэх сэтгэлийг төрүүлсэн байж мэднэ.

Хэрэв Зүчи, Чингис хааны төрсөн хөвүүн байсан бол ямар ч эргэлзээгүйгээр өөрийгөө залгамжлуулах байв.

Эцэг эхийн илэрхий хайр, ивээлд бялуурсан Цагадай дэндүү омголон хойрго хөшүүн байдаг бол Зүчи яг л чонын бэлтрэг шиг Тэмүжиний харц, хөдөлгөөн үг бүрийг манаж ам нээн хэлэхээс нь өмнө ухасхийхэд бэлэн эрвэлзэж байдгийг үзэж заримдаа ихэд өрөвдөн хайрладаг байсан билээ.

Бага балчир Зүчи Тэмүжин эцгийнхээ өчүүхэн боловч талархлыг олохын тулд юугаа ч хайрлахгүй тэмцэхэд бэлэн байдаг байв.

Цагадайг нялх ахуйд эрхлүүлэн суухдаа яг хоол горьдсон нохойн гөлөг шиг Зүчи хөвүүн нь толгой гилжийн гунигтайгаар ширтэн суухыг хардагсан.

Залуу гэнэн цагт түүнийг ер тоодоггүй байсан хирнээ одоо нялх балчир Зүчийн тэр гүнзгий гунигт харц одоо хэр гэнэ гэнэ сэтгэлд нь сэвхийн ороход хачин их цочин зүрх нь шимширдэг болсноо Чингис хаан ер ойлгодоггүй байлаа. Нэг их ял зэм хийсэн мэт заримдаа санагдана.

Эцгийн хайр ивээл амсаагүй өссөн өнчин ядуу амьдрал, байнгын аюул, гачаалын дунд өнгөрөөсөн хүүхэд насны нь гунигт дурсамж ингэж Зүчийн гомдолт харцаар илэрдгийг тэрээр таасангүй. Чингис хаан, Зүчи хоёр их адил амьдрал үзсэн мэт санагдана. Ингэж бодоход Зүчийг өрөвдөн хайрламаар ч, хүний сэтгэл зүрх гэдэг эзнийхээ оюун ухаандаа тийм ч амар захирагддаггүй ажээ. Яаж ч ухаан зарж хичээгээд Зүчийг Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүд шигээ хайрлаж үнсэж сураагүй билээ.

Үүнийхээ төлөө хэзээ ч Бөртийн өмнө гэмшиж өршөөл хүсэж байсангүй. Чингэхийг Бөртэ ч шаардсангүй. Өөрийн гурван хөвүүн төрж, өсөж томрох тусам Бөртийн Зүчид тавих анхаарал халамж, хамгаалал сулрах мэт болжээ. Харин Зүчийг төрөхөд түүнийг ал гэж тушаасныг эх хүү хоёр хэзээ ч мэдэхгүй гэдэгт Чингис хаан бат итгэлтэй байв. Учир нь ийм хэцүү нууц хэргийг дэндүү ухаантай Боорчи хэзээ ч задалж хэлэхгүй юм. Өнөөдөр Зүчийн хэлсэн үгийг сонсоод эртний энэ дурсамж сэргэжээ.

Одоо санахад Боорчи түүний хэлснээр Зүчийг алж орхисон бол ядаж зүгээр л төрмөгц нь замын хажуу руу шидэж орхисон бол Чингис хаанд амьдрахад арай л хялбар, Цагадайн хувь заяа ч өөрөөр эргэх байжээ. Боорчийн энэ тэнэг шийдвэр, Тэмүжиний зөөлөн зан нийлээд өнөөдөр, ер нь цаашдаа ямар учир урхаг үүсгэхийг зөвхөн таахаас цаашгүй.

Юутай ч Зүчийн өнөөдөр хэлсэн үг,гаргасан сэтгэлээс үзэхэд тэр лав Чингис хааныг

эсэргүүцэн тэмцэх санаагүй бололтой. Энэ нь ядаж түүнийг түр боловч тайтгаруулж байлаа.

Чингис хаан хэлсэндээ хүрч Зүчийн цэргийг манлайд явуулах бодолтойгоо шадруудтайгаа зөвлөлдөх үедээ ил тод, бүр Зүчийн нүүрэн дээр хэлж Зүчи ч сэтгэл амар болжээ. Одоо хэрхэх ёстой талаар Чингис хаан биш шадар жанжид нь үгээ хэлэх үлдэв.

Мэдээж тэд Чингис хааны үгийг хүлээн авсангүй. Зүчийг тэд арай түргэдэж осолдож мэднэ гэж үзжээ..

-Хорезмыг эзлэх нь хүүхдийн тоглоом биш. Эхний дайралт ямар болох нь дайны эцсийн бүрэн ялалтыг тодорхойлох тул хэн нэгэнд найр тавих нь хортой гэж Сүбээдэй хэлсэн нь олон бүгдийн талархлыг хүлээж Чингис хаан ч толгой дохив. Ингээд бүгд зөвшин туршлагатай алдарт жанжин Зэвийг магнайд илгээхээр тогтов.

Ард нь Сүбээдэйг илгээхээр болсныг эцэст нь Зүчи ч хүлээн зөвшөөрөхөд хүрчээ. Зүчийн хүсэл, шаардлагад шадруудынхаа амаар аятай хариу өгч Зүчийн өмнө өргүй, нэр цэвэр үлдсэндээ Чингис хаан хангалуун инээмсэглэж сэтгэл баяртай болжээ.

Гэсэн ч Зүчийн хүслийг ямар ч болов мартахгүй санаж явсаар Хорезмыг дайлсан эхний жилийн төгсгөлд хуучин нийслэл Ургенч хавийн нутгийг Зүчид өгснөө албан ёсоор зарлан энэ хэргийн учрыг тайлж Зүчийг гомдолгүй болгов хэмээн санасан нь эндүүрэл болжээ..

Зүчи, Цагадай хоёр хамт нэг дор байх нь улам бүр аюултай болсоор байгааг Чингис хаан мэдэж байв. Гэвч Зүчид Ургенчийг өгсөн нь зөв эсэхэд эргэлзэх бас атаархах хүн гарахыг тэр тооцож үзсэнгүй.

Ургенч хавийн нутгийг түүнд өгсөн нь Зүчийн хувьд тун санамсаргүй явдал болсон билээ. Тэр урьд нь эзэлсэн нутаг, олсон олзыг ер минийх гэж санаж байсангүй тул хүн амьтан, ер юуг ч байсан өрөвдөн хайрладаггүй байв. Гэтэл одоо үзэсгэлэнт сайхан Ургенч хот минийх гэж бодохоор харин ч хайрлалтай санагджээ.

Гэвч өөрийн болгон эзэмшихийн өмнө эхлээд Ургенчийг эзлэн авах ёстой. Үүний тулд тэр өөрийн цэргийг Ургенчийн дэргэд аваачжээ. Хорезмын их улсын сүүлчийн бэхлэлт болсон Ургенч үнэхээр үзэсгэлэнтэй хот ажээ. Самаркандаас амь зулбан гарч Чингисийн хааны цэрэгт нохой мэт хөөгдөн зугатсаар Каспийн тэнгисийн нэг жижиг арал дээр нэр төргүй үхсэн Мухамед султаны оронд түүний хүү гавшгай, зоригт эр Желаладдин өргөмжлөгдсөн нь Хорезмын бутарч тарсан цэрэг, ардыг сэхээн зоригжуулж Чингис хааны цэргийг эсэргүүцэх тэмцэл урьд байсангүй тийм их хүчээр өрнөжээ. Газар бүр Монголын цэрэг ихэд хохирох болов.

Цэргийн давшилт ялалт удааширч эхэлсэн нь Чингис хааныг түгшээж, бас үүний хажуугаар Хорезмын ялагдашгүйн баталгаа болсон Ургенчийг Зүчи эзлэн авч чадахгүй удсан нь Чингис хааны хилэнг бадраав. Харин Зүчи цэргийн амийг хохироохоос эмээн буулган авах арга сэдэж зүгээр л бүслэн суусаар хэдэн сар болжээ. Залуу султан Желаладдиний нэр хүнд огцом өсөж тэр одоо даруй зургаан түмэн цэрэгтэй болоод Ургенчийн зүг давшиж очих нь тодорхой болсон тул Чингис хаан зарлиг буулгаж Цагадай, Өгөдэй хоёрыг цэргийн хамт Ургенч руу

даруй очихыг тушаав. Бас цэргийн үйлийг Өгөдэйг шууд захирахыг ч зарлиг болгов.

Ингэх нь Чингис хааны зөв байсан ч өмнө нь Самаркандыг эвдэлгүй эзлэх гэж хөвүүд нь хэрэлдэж зөрчилдсөн нөхцөлийг дахин бүрдүүлэв. Хорезмд хийж буй дайныхаа эцсийн ялалтыг эрхэм болгосноос биш хөвүүд нь юу хүсэж байгааг хайхран үзээгүй түүний энэ шийдвэр тийм ч зөв оночтой биш байлаа. Гэвч түүнийг хэн ч эсэргүүцсэнгүй. Ялангуяа Боорчи юм хэлсэнгүй.

Өөрийн эзэмшлийн хотод бусдын цэргийг оруулахыг Зүчи огт хүсэхгүй байв. Самаркандыг эзлэхэд хайран олон цэргийнхээ амийг дэмий үрсэндээ Зүчи одоо ч харамссаар ажээ. Цэргийн амийг хайрлах нь Зүчийн төрөлх зан хүмүүжил юм. Ургенчийн ойр байрласан Зүчийн хээрийн өргөөнд Өгөдэй ганцаар очиход Зүчи илт таагүй угтав.

Хэд хоногийн өмнө Чингис хааны зарлигийг түүнд хүргэн иржээ. Өгөдэй ахынхаа уур уцаарыг ойлгож мэдэх учир тэсч өнгөрөөж дараа нь Чингис хааны зарлигийг ёс журмын дагуу дахин дуулгав. Тэдний хэн нь ч Чингис хааны зарлигийг эсэргүүцэн буцаах аргагүй билээ.

-Ургенчийг даруй эзлэн авахыг Чингис хаан надад зарлиг болгов. Иймийн тулд хэрхэн довтлохыг зөвшихөөр би ирлээ гэж Өгөдэй болгоомжтой хэлэв.

-Цагадай юунд ирсэнгүй гэж Зүчи бухимдсан хэвээр асуув.

-Та бид тохирвол Цагадай ах бүгдийг зөвшөөрнө гэв. Энэ үг Зүчийг бага боловч тайвшруулжээ.

Угаас Өгөдэй, Зүчид үргэлж хүндэтгэлтэй хандах тул Зүчийн хувьд түүнтэй сөргөлдөн тэмцэлдэх шалтгаан байхгүй байв. Өгөдэй хүлээц тэвчээр ихтэй болохоор Зүчи ахтайгаа юу гэж ярихаа сайн боловсруулан бэлджээ. Үүний тулд Цагадай ахынхаа үг гэж нэгийг ч хэлж болохгүй гэж бодсон нь зөв болжээ. Цагадайд мөн л Зүчид хэлсэн шигээ

-Та бид тохирвол Зүчи ах дагана гэж хэлсэн билээ. Тэр үед Зүчитэй нүүр тулахаас бяцхан эмээж асан Цагадай дуртайяа зөвшөөрч

-За тэгвэл чи явж Зүчитэй тохирч ир. Би та нарын хэлснээр хийе гэжээ. Одоо Зүчи ч зөвшөөрөв.

Өгөдэй ингэж жижигхэн заль хэрэглэж үл эвлэрэх хоёр ахынхаа Ургенч хотыг нэгдэн эзлэх замыг засч чадав. Зүчид харамсалтай ч Ургенч хотыг хоёр дүүтэйгээ хуваах хэрэг тулгарчээ. Эзлэж авсан ч Ургенч түүнийх болж үлдэх тул аль болох эвдэх сүйтгэхгүй эзлэхийг хичээсээр байлаа.

-Өгөдэй. Ургенч бол Чингис хаан эцгээс надад хуваж өгсөн хот гэдгийг бүү март. Эвдэж шатаахыг би үл хүснэ гэж хатуу хэлсэн нь Өгөдэйг баахан тулгамдуулжээ.

-Ах аа санаа бүү зов. Энэ их хотоос юу л үлдэнэ. Та түүнийг бүгдийг авагтун. Харин та бид

гурав Ургенчийг хаан эцгийн заасан хугацаанд эзлэн авах ёстой .

-Хэзээ эзлэн ав гэнэ .

-Арав хоногоос бүү хэтэр гэв. Бид Желаладдинийг хүчирхэгжин нааш давшиж ирэхээс өмнө Ургенчийг ямар боловч эзлэн авах ёстой. Ургенч бууж өгөхгүй ингэж их удах нь дайсанд итгэл төрүүлэх муу нөлөөтэй гэж Чингис хаан хатуу зарлиг буулгав. Бас Желаладдиний туслахаар ирэх замыг таслах хэрэгтэй байна

Энэ үгийг Өгөдэй санаснаас хатуу чанга хэлсэн тул Зүчи бодолд оржээ. Зүчи нэгэнт гарцаагүй байдалд орж Ургенч хот сүйрэн нурах цаг болсныг ойлгон зөвшөөрөхөд хүрэв.

-Зүчи ах аа.Би маргааш өглөө танд давшин орох цагийг хэлье. Би одоо Цагадай ахтай уулзана гэж Өгөдэйг шийдэмгий тулган хэлээд босоход

-Чи өөрийн үзсэнээр хийгтүн гэж Зүчи хашгирчээ.

-Харин хотыг эзэлсний дараа бүх иргэд,эд хөрөнгө таных болно.Би танд амлаж байна гэж Өгөдэй тайтгаруулах мэт хэлээд давхин оджээ.

Цагадай түүнийг бас л баргар царайлан угтав.

-Юу гэнэ. Зүчи ах чинь гэж Цагадай уцаартай,бас даажигнасан мэт асуув.

-Намайг цаг товломогц нэгэн зэрэг дайран орохоор шийдэв.

-Би зөвшөөрнө гэж Цагадай ямар ч тайлбар асуулгүй ингэж хэлэв.

-Харин Ургенч хотыг эзлэн авмагц та бид хоёр цэргээ даруй татан хотоос гарвал зохино. Бид Ургенчээс юу ч авч болохгүй. Ургенч хот бол Чингис хаанаас Зүчи ахад соёрхон өгсөн бэлэг юм. Би сая Зүчи ахтай тэгэж тохирлоо. Та бид хоёр Чингис хааны зарлигийг биелүүлбэл болно биз гэж инээмсэглэхэд Цагадайн нэрэлхүү зан хөдлөөд зөвшөөрчээ.

Өгөдэй ингэж өөрийн санаснаар эмээлийн хоёр бүүрэг шиг болсон ах нараа зохицуулж чадаад Ургенч хотыг довтлон эзлэх бэлтгэлээ шуурхайлав.

Хотыг дайран эвдэх тэргүүн эгнээнд нутгийн иргэдээс дайчилсан хоёр түмэн “үхлийн цэргийг” оруулж араас нь өөрийн цэргээ давшуулж галдагч сумаар зайгүй буудахаар Өгөдэй шийджээ. Өөрийн цэргийг золиослон түрүүлж дайрах нь Өгөдэйд хохиролтой ч Ургенчийг түргэн эзэлж өөрийн чадвар, хүчийг үзүүлэхийг гол болгожээ. Энэ бол Өгөдэйн хувьд хамгийн зөв шийдвэр байв.

Чингис хаан Өгөдэйн юу чадахыг үзэх хүсэлтэй байгаа нь мэдээж билээ. Маргааш үүрээр “үхлийн” цэргүүд Ургенчийн гадаад хэрмийг дайран довтолж биесийн хүүрээр шат хийн авирч эхлэв. Тэдний толгой дээгүүр шатдаг тостой бортого зайгүй нисч Ургенч хот галд авалцан шатаж, гадаад хэрэм нуран унажээ. Ингэж Ургенчийн төлөөх тулаан долоон өдөр, долоон шөнө үргэлжилж гурван түм шахуу монгол цэргийн амийг золиослосны эцэст нь

хотынхон бууж өгөв.

Ургенчийг эзэлсэн тухай мэдээ Чингис хаанд хүрэхэд тэр Тулуй хөвүүний хамт Алтан горхины нуруунд цэргээ амраан сэрүүцэж байлаа. Элчийн баярт мэдээг сонсоод

-Даруй эргэн ирж цэргээ амрааж нийлэгтүн гэж зарлиг буулган элч илгээжээ.

Ургенч унасан нь Хорезмын улс бүрэн мөхсөний баталгаа болов. Одоо нутаггүй, хотгүй болсон Желаладдинийг хөөж устгах үлдэж, түүний хойноос Чингис хаан өөрөө морилохоор шийджээ.

*****

Бүтэн долоон сар үргэлжилж, Чингис хааны хилэнг бадраасан Ургенч хотын төлөөх дайн олон мянган монгол цэргийн амийг золиослосны хүчинд монголчуудын бүрэн ялалтаар төгссөн ч ардаа олон санаандгүй хэргийг үүсгэв.

Эмээлийн хоёр бүүрэг шиг өөд өөдөөс үл харалцах, үл эвлэрэх хоёр ахынхаа арга эвийг олж, гайхмаар амь хайргүй ширүүн эсэргүүцэх Ургенчийнхний эсэргүүцлийн хүчийг дарж, хамгийн удаан ужигран сунжирсан тулааныг ердөө долоон өдөр долоон шөнийн дотор ялалтаар дуусгаж чадсан нь Өгөдэйн нэр сүрийг хэмжээлшгүй ихээр өргөсөн явдал болов.

Энэ нь чухам Өгөдэйг шилж өөрийн хойно хаан суурин өргөмжилсөн Чингис хааны зарлигийн зөвийг давхар баталсан билээ. Чухам ингэх гэж Өгөдэй ухаан, заль ,зориг гурваа шавхсан билээ. Бүх юм санаснаар болж хамгийн анх олдсон боломжийг Өгөдэй дүүрэн ашиглаж олон хүний сэтгэлд ирээдүйн их хаан суурийг эзэлж чадав.

Өөрт зарлигаар оногдсон Ургенчийг эвдэхгүй эзлэн авах гэсэндээ цаг алдан алгуурлаж байснаас болж Зүчи өөрийн нэр хүндийг баахан унагасандаа харамсаад ч барахгүй болжээ. Гэвч Зүчээс илүү харамсаж гашуудсан хүн нь Бат байлаа.

Чингис хаан Ургенчийг эзлүүлэхээр Цагадай, Өгөдэй хоёрыг цэргийн хамт илгээснийг сонсмогц л Бат дуугаа хураан дүнсийснийг Зүчи харж байв. Хорезмын энэ үзэсгэлэнт хот удахгүй эцгийн мэдлийнх болно гэж бодохоос Батын нойр хүрэхгүй байжээ.

Өглөө бүр хотын дэргэдэх өндөрлөгт гарч хотыг ширтэн холын мөрөөдөлд автан зогсдог байлаа.

Зүчи ч Бат хөвүүнийхээ сэтгэлийг ойлгон түүнийг хараад ихэд баясан хуучин гомдлоо мартдаг ажээ.

Зүчи ,Бат хөвүүндээ зүрхний угаас хайртай юм.

Бусад хүүхдүүддээ гаргадаггүй өгөөмөр, бүр хэтэрхий гэмээр хайр халамжийг Батад үзүүлнэ. Үүнийг нь Бөртэ хатан ээж нь илэрхий дэмжин Батыг ач нарынхаа дундаас онцгой үзэн эрхлүүлсэн билээ.

Учир нь Бат бол Бөртийн удмын Уги хатнаас төрсөн юм. Өгөдэй нэгэнт хаан эцгийг залгамжлах нь тодорхой болсон үед Өгөдэйг хэн залгамжлахыг бодох хэрэгтэй байлаа. Өгөдэйн Дөргөнө хатнаас төрсөн хөвүүн нь Гүюг бөгөөд Батаас хоёр ах байлаа.

Чингис хааны зарлигт хэрэв “Өгөдэйн хөвүүд өвсөнд ороовч үхэр тоож идэхгүй, өөхөнд ороовч үнэг тоож шиншлэхгүй аваас миний алтан ургийн дотор сэргэлэн гавшгай хөвүүн эрхбиш олдоно. Тийм үед түүнийг олж өргөмжлөгтүн” гэжээ.

Ийм учир шалтгааны үүднээс Бат хөвүүнээ Чингис хааны ач хөвүүдийн манлай нь болгохыг Зүчи хүсч байлаа.

Зүчийн алдсан нэр төр, эрх ямбыг буцаан авч бас хүсэл мөрөөдлийг гүйцэлдүүлэх ёстой хүн нь Бат хөвүүнээ гэж Зүчи өөрийн олон хөвүүдийн дотроос түүнийг сонгожээ.

Чингис хааны зарлигаар олгосон Ургенч болоод тэр хавийн нутаг хэдий шашин, хэл өөр ч яах аргагүй Зүчийн өөрийн бие даасан улсын эх үндэс, ирээдүйд хөвүүн Батын суурьшин нутаглаж, захиран суух их улсын үүсэл болно гэж сэтгэлийн мухарт шийдэн бодсон тул Зүчи Ургенчийг эвдэхгүй буулган авахыг хичээсэн билээ.

Ууган хөвүүн Ордыгоо Сигнах хотыг захируулан суулгаж үлдээсэн нь ч үүнтэй холбоотой байв.

Арван дөрвөн нас арай хүрээгүй ч Бат эцгийнхээ алс далдын хүслийг аль эрт ойлгож гадарласан төдийгүй Ургенчийн эзэн суухыг тэсч ядан хүлээж байжээ.

Чингис хааны зарлигийг хэн ч зөрчин эвдэж чадахгүй тул Зүчи, Өгөдэй дүүгийнхээ үгийг хаан эцгийн зарлиг шиг л дагаж Ургенчийг өгчээ. Ургенчийг эзлэн авахад хүч хамтрахаас өөр аргагүй болсон ч баян тансаг энэ хотоос олох олзыг хэнтэй ч хуваах хүсэл байсангүй. Харин Өгөдэй хэлсэндээ хүрч Ургенчийг буулган авмагц цэргээ татан хотоос гадагш гарчээ. Цагадай ч мөн адил цэргээ татав. Өгөдэйг хэлсэн үгэндээ хүрдэг хүн болохыг Зүчи ингэж үзжээ. Одоо хотод Батын толгойлсон Зүчийн цэрэг үлдэв.

Ургенчийг алдсандаа гуниж хорссон Бат хөвүүнээ тайтгаруулахын тулд Зүчи Ургенчийг дайрах өөрийн цэргийг Батаар удирдуулсан билээ. Уг нь энэ хэргийг Зүчи өөрөө удирдах байлаа.

Гэвч залуу хөвүүнээ бодол цалгар болуузай гэж сэргийлэхдээ, гуниж гомдсон сэтгэлийг нь тайтгаруулах гэсэндээ их цэргээ анх удаа бие даан удирдахыг зөвшөөрчээ. Энэ бол арван дөрвөн настай Батын хувьд амьдралдаа бие даан хамгийн том тулааныг удирдах болсон хэрэг юм.

Эцгийн энэ үгийг сонсмогц Батын харц ахиад л цог хийморьор дүүрэн гэрэлтэхийг үзээд өөрийн шийдвэрийг зөв гэдэгт эргэлзэхгүй болжээ. Зүчи анх Ойн иргэдийг дайлахаар мордох зарлигийг сонсмогц л яг Батын өнөөдрийнх шиг баясан бахдаж зориг хийморь нь дүрэлзсэнээ санажээ.

Гэвч Бат хөвүүн нь эцэг шигээ гадуурхагдан, доромжлогдохыг үзээгүй ч хожим хойно Цагадай, Өгөдэй, Тулуй нарын хөвүүдэд дарлагдахыг Зүчи тэвчихгүй байлаа.

Тийм учраас л Бат хөвүүнээ арван дөрвөн настай ангир хонгор зүстэйд нь энэ бэрх том тулааныг удирдах эрх олгожээ. Анх мянган цэрэг ахлан Тайчуудтай дайтахаас эхлэн Зүчид зүтгэсэн Хунан, Мүнхэүр, Хэтэ гурван ноён ил далд эсэргүүцэж, элдэв тайлбар хэлсэн ч Зүчи үгнээсээ ухарсангүй.

Чингис хааны зарлигаар Зүчид хуваагдан ирж шадарласан хүмүүс тул энэ гурав хэзээд үнэн үгээ ил хэлдэг билээ.

-Та гурав өөрсдийн цэргийг удирдаж Бат хөвүүний минь тушаалыг хичээн биелүүлэгтүн гэхээс өөр үг Зүчи хэлсэнгүй. Зүчийг нэг үгээ олон дахин давтдаггүй зантайг мэдэх тэд дахин дуугарсангүй тус тусын хүрээнд оджээ. Цэргийн эрдэмд нэвтэрсэн шадар жанжнуудтайгаа зөрж Бат хөвүүнээ ийм хэрэгт томилсондоо Зүчи дотроо эргэлзсээр байсан ч гаднаа эл байдлаа мэдэгдсэнгүй.

Тэгээд ч одоо л Батыг биеийг даалган цэрэг захируулж их тулаанд оруулж сургахгүй бол оройтно гэж бодсоноос гадна хамгийн гол нь Батын урмыг хугалан Чингис хаан болоод авга ах нартаа хонзон санах бий гэж болгоомжилсон билээ. Зүчийн ингэж бодсон зөв байлаа. Бат үнэхээр дотроо уурсан хорссоор байсан ч Өгөдэй авгадаа туйлын хүндэтгэлтэй хандах тул ер муу үг хэлж муухай ааш гаргасангүй тэвчжээ.

Зүчи, Цагадай, Өгөдэй гурвын цэрэг Ургенчийг гурван талаас зэрэг довтлохоор тохирч Өгөдэй цагийг товложээ. Тохирсон ёсоор довтолгоон эхлэхэд Бат өөрийн цэргийг хөдөлгөхгүй зогссоор үлдсэн нь Зүчийг гайхшруулж тэсч чадахгүй өндөрлөгт эзэлсэн байрнаасаа бууж цэргийнхээ тэргүүнд давхин очиход хүргэжээ.

Бат хөвүүнээ цалгардаж осолдов гэж эмээсэн билээ. Гэтэл Бат цэргийн магнайд эргэлзэхгүй догь зогсож “үхлийн цэргүүд” Ургенчийн зүүн хэрмийг дайрахыг хөмсөг зангидан харах ажээ..

Зүчийн цэрэг энэ үед Ургенчийн баруун талд байрлаж байлаа. Эцгийгээ юуны учир сандарсныг Бат ойлгожээ. Зүчийг давхин очиход түүний ам нээхээс урьтан

-Ургенчийг эзлэн авахыг надад даалгасан биш үү гэж хашгирчээ. Батын дуунд хоолоо булаалгасан залуу нохойн хорсол тод сонсдов.

-Тийм ээ. Би хэлснээсээ үл буцна. Ганцхан чамайг юу хийхийг дэргэдээс чинь харахыг хүснэ гэж Зүчи хөвүүнээ тайвшруулан инээв.

Хөвүүн нь ингэж өөртөө итгэлтэй байхыг үзэх Зүчид туйлын таашаалтай байлаа. Арван таван настайдаа Зүчи ийм байж чадаагүй тул Бат хөвүүнээрээ бахархаас өөр аргагүй болов. Зүчи өөрийн амьдралд үзэж эдлээгүй бүхнийг хөвүүндээ эдлүүлэх гэхээс юу ч хийхээс буцахгүй болжээ. Бат юу хийхээ сайн мэдэж байлаа.

Бүрэн бүтэн хэвээр нь буулган авахыг хүсч байсан Ургенч хот одоо зүүн хойт талаасаа шатаж эхлэв. Энэ нь Өгөдэйн цэргийн харвасан шатаагч сумнаас үүдсэн байлаа. Галын дөлөнд тэнгэр улайж шөнө болсон ч тулалдсаар байжээ. Өгөдэй ямар ч үнээр хамаагүй Ургенчийг эзлэн авахаар улайран цэргийн үхэл, сүйрлийг үл тоон довтолно. Харин Бат “үхлийн цэргийн” араас өөрийн цөөн тооны цэрэг явуулаад харин гол цэргээ хүлээлгэн бүтэн өдөр өнгөрөөв.

Зүчи бүү хэл Өгөдэй энэ байдалд гайхан элч давхиулж Зүчийг цэргээ оруулахыг тушаажээ.

Маргааш өглөө нь байдал яг хэвээр Бат гол цэргээ хөдөлгөсөнгүй тул Зүчи Хунан, Мүнхэүр, Хэтэ гурвын хамт цэргээ довтлогоонд оруулахаас өөр үггүйд хүрчээ. Батын энэ хачин авир эцэст нь юунд ч хүргэж болох аюултайг бүгд мэдэж байлаа. Өгөдэйн элч дахин ирж Чингис хааны зарлигийг сануулав. Байдал улам ч хурц боллоо.

Зүчи тэссэнгүй өөрөө цэргээ удирдахаар шийдэв.

Гэвч Бат хөвүүнээ гомдоохыг тэр хүссэнгүй. Зүчийг хээрийн асарт очиход Бат Ургенчийн зүг ширтэн довцогийн дээр морьтой зогсож байлаа.

Чингис хааны зарлигийг ингэж санаатайгаар зөрсөн явдал өмнө нь ер гарч байсангүй. Зүчийн хөвүүнээ гэсэн зөөлөн зан одоо амь насаа алдах аюултай байдлыг үүсгэжээ. Өгөдэй яавч энэ хэргийг хаацайлан өнгөрөөхгүй нь мэдээж. Бага балчир хөвүүн нь гэнэн томоогүйгээсээ болж юу ч хийж мэдэх болжээ. Эцсийн эцэст энэ хэрэг Зүчийн буруугаас болсон тул Чингис хаан түүнд хэрхэн хандахыг хэн ч үл мэднэ. Шадрууд нь яг ингэж хэлсэн билээ.

-Хөвүүн минь. Өгөдэй биднийг цэргээ оруулахыг шаардаж байна гэж Зүчи аль болох зөөлөн хэлэхийг хичээв.

-Одоохон би цэргээ оруулна. Түр хүлээж байг гэж Бат унтуулцав.

-Чи юу хүлээнэ гэж Зүчи оволзож ирсэн уур хилэнгээ арайхийн барьж шивнэв.

-Тэнд хотын зүүн талд монгол цэрэг ихээр сүйрч байгааг чи харахгүй байна уу. Энд дайн болж байна. Цэргээ даруй хөдөлгө. Бидний ингэж байгааг Чингис хаан юу гэж үзэхийг чи мэдэж байна уу чи гэж тэсэж чадсангүй зандрав.

-Би Төмөр-Мэлигийг цэргээ зүүн тийш Өгөдэй, Цагадайн цэргийн зүг татахыг хүлээж байна. Тэгвэл миний цэрэг ямар ч гарзгүйгээр хотод орно гэж Бат хүн итгэхийн аргагүй хүүхдийн гэнэн үг хэлэхэд Зүчи гэнэт дүрсхийн уурлав. Эцэг хүү хоёрын юу хэлэлцэхийг одоо энд хэн ч сонсохгүй, амь сахигч цэргүүд хэдэн алхмын зайтай байлаа.

Бат угийн гавшгай сэргэлэн хүн тул энэ удаа ч эцгийгээ ууртай догшин үг хэлж хилэгнэхээс бас урьтав.

-Та сонс гэж Батын шивнэн хэлсэн нь Зүчийг хэлний үзүүрт гарч ирсэн ширүүн үгээ буцаан залгихад хүргэв. Бат хөвүүн нь ер дэмий сул үг ярьдаггүйг тэр мэднэ. Гэвч түрүүчийн хэлсэн

үгс даанч гэнэн томоогүй санагдсан тул тэвчээгүй билээ. Бат ингэж сэрэмжлэн урьтаж дуугараагүй бол эцгийн амнаас гарах зэмлэлийн үг тэдний хооронд ямар уршиг тарихыг хэн ч таахын аргагүй юм. Цагадай болоод Өгөдэйн цэрэг Ургенчийн хэрмийг зүүн талаас давах гээд өдөр шөнө хоёр хичнээн хохирол үзээд байгаа нь бүхэнд ил энэ үед Зүчийн цэрэг хөдлөхгүй зогсохыг хэн ч байсан тайлбарлан зөвтгөж чадахгүй биз. Чингис хаан үүнийг мэдэхгүй гэж бодох нь хамгийн гэнэн хэрэг юм. Хэрэв тэгвэл Зүчид ямар ял оногдох нь тодорхой.

Гэнэн балчир хөвүүн нь юу сэдэж, тэр эцэст нь ямар ялд унах бол гэж Зүчи эмээж байв. Батын энэ хачин тоглоомыг эцэс болгож өөрийн цэргийг зовтолгоонд оруулахаас өөр зам Зүчид үгүй байлаа. Гэвч тэр хөвүүнийхээ үгийг тэвчин хүлээв.

-Та сонс гэж Бат эцэгтээ дөхөн ирж давтан шивнэв. Бат дахин ам нээхийн өмнө Ургенчийн хэрмийн зүг удаан ширтэв. Батын идэр царай гэнэт дуулган дороос инээмсэглэж үзэгдэхэд Зүчи гайхлаа. Энэ хөвүүн ер нь ухаан санаа эрүүл биз гэсэн бодол төрөх шиг ...

-Аав та харж байна уу. Тэр Төмөр-Мэлиг цэргээ зүүн хэрэм тийш татаж байна гэж Бат догдлон хашгирлаа.

-Чи юу ярина вэ.

-Та хараач дээ. Тэдний өмнө хөндөлдөх хэрмийн дотор болж буй явдал өндөр дээрээс ил үзэгдэнэ. Нээрээ Төмөр-Мэлигийн хамгаалалтын цэргийн хэсэг нь зүүн тийш цувран явцгааж байв. Тэр даруй хагас түмэн цэрэг бий биз.

-Та хар даа, би танд хэлсэн биш үү. Төмөр-Мэлиг цэргээ зүүн тийш татахыг хүлээе гэж.

-Чи юу гээчийг сэдэв гэж Зүчи харсандаа итгэж ядан асуужээ.

-Би Төмөр-Мэлигт таны нэрээр элч илгээж “Ургенч хот бол Чингис хааны зарлигаар Зүчи надад ногдсон газар юм. Тийм болохоор Ургенчийг би бүрэн бүтэн эзэмшиж авахыг хүсэх тул чамайг бууж өгөхийг шаардсан үгээ батлах гэж даруй хагас жил бүслэн суусан билээ. Харин чи миний үгийг үл дагаж одоо нэгэнт Чингис хааны их цэрэг довтлон ирлээ. Чиний үхлийн өдөр болжээ. Нэгэнт Ургенч хот, түүний иргэд чиний мулгуу тэнэгээс болж үгүй болох цаг ирлээ. Эвдэж сүйрсэн Ургенч нэгэнт надад хэрэггүй тул одоо хэрхэхийг миний дүү Цагадай, Өгөдэй хоёр мэдэх боллоо.

Чи ямар жанжин болохоо үзүүлж тэдэнтэй тулалдагтүн. Харин би цэргээ үл хөдөлгөн чамайг хэрхэн тулалдахыг харж байя.

Чи миний өмнөх баруун хэрмийг сахигч цэргээ эргэлзэх юмгүй татаж Цагадай, Өгөдэй нарын эсрэг байлдагтүн” гэсэн бичиг хүргүүлсэн билээ. Одоо тэр цэргээ татаж байна. Төмөр-Мэлиг надад итгэжээ. Гэгээ тасартал хүлээгээд би цэргээ хөдөлгөж Ургенчид орно. Батын энэ үгийг зөв гэж сайшаахад бэрх ажээ.

Атаат дайсныхаа үгэнд итгэн нээрээ үзтэл цэргээ татан баруун хамгаалалтаа хаяж буй

Төмөр-Мэлигийг ч ойлгож ядна. Ухаан, зоригоороо Хорезм улсдаа цуутай Төмөр-Мэлиг жанжин Бат хөвүүний энэ томоогүй үгэнд хууртана гэхэд яагаад ч итгэх аргагүй байлаа. Бат үүнийг дахин тайлбарлаж хэлээгүй учир Зүчи харсандаа итгэхээс өөр аргагүй болов.

Ар талаа хамгаалалтгүй шахам үлдээж Цагадай, Өгөдэй хоёрын эсрэг бүх цэргээ хөдөлгөсөн Төмөр-Мэлигийн үхэл ирж буйг Зүчи ойлгож ,хөвүүнээ яаж ингэж чадсанд гайхаад барсангүй.

Батыг хэрхэн чадав гэж гайхахын огт хэрэггүй байсан бөгөөд Бат хөвүүн нь Чингис хааны дээд удам Добу мэргэний дүү Дува сохорын сүнс байсанд хэргийн учир байсан билээ.

Түүнээс гадна Бат элч болгон илгээсэн өөрийн боол Татугаар Төмөр-Мэлигт өөр юу гэж хэлүүлснээ эцэгтээ хэлсэнгүй. Ургенчийн цэргийн удирдагч зоригт Төмөр-Мэлиг Батын энэ нууц үг, Татугийн ховсонд автсаны учир ийн цэргээ хотын зүүн хэрэмрүү шилжүүлсэн билээ. Эсрэг этгээдийн цэргийг ховсондоо оруулан ухааныг самууруулж дуртай зүгтээ ухрааж, буцааж болох аргыг Бат, гоо ван Мухулайн дэргэд Алтан улсад жил болохдоо сэм үзэж мэдсэн билээ.

Мухулай ван өөрийн дэргэд Нанги хэмээх алдартай ховсчин байдгийг хэнд ч хэлдэггүй чандлан нууцалж байжээ. Нанги уг нь Харлууд овгийн хүн бөгөөд Мухулайд аль долоон наснаас эхлэн зүтгэсэн байжээ. Нанги Зүчийн хөвүүн Батыг дагаж ирсэн Татуг хармагц түүний далд чадлыг мэдэж Мухулай эзэндээ хэлжээ.

Гэвч Бат өөрийн боолыг Мухулайд худалдсангүй.

-Энэ Тату бол Зүчи эцгийн минь зүрх юм гэсэн есөн настай Батын санаандгүй хурц үгийг сонсоод Мухулай дахин ам нээсэнгүй.

Зүчи Татугийн чадлыг мэдэх учраас түүнийг хөвүүндээ өгсөн биз гэж таамагласан Мухулай өөрийн бодлоос ухарч харин ховсчин боолоо хэрхэн ашиглахыг Батад сайтар сургасан билээ. Харин Тату хэмээх тэр хэдэн настай нь үл мэдэгдэх загас мэт үл анивчих нүдтэй эрийн ховсдох эрдмийн тухай энд зөвхөн Бат л мэдэх билээ.

Тату өөрийн энэ далд чадлыг огт мэддэггүй байсан бөгөөд Батыг дагаж Алтан улсад очоод л сая гадарласан ажээ.Мухулай вангийн дэргэдийн ховсчин Нанги Татуд олон зүйл зааж түүний далд чадлыг илрүүлж өгчээ. Харин үүнийг мэдсэн Бат хэзээ ч хэнд ч хэлэхгүй байх тангарагийг Татугаас авчээ. Зүчи эзэн нь хөвүүнээ төрөхөд өөрийн боол Татуг Батад өгснөөс хойш тэд нэг ч өдөр салсангүй арван таван жил дөхөж өнөөдрийг хүрчээ. Ингэж ганц эзэнд захирагдах нь ховсчдын мөрдөх хууль юм.

Татугийн энэ ховсдох нууцыг Зүчи ч мэдэхгүй билээ. Хэрэв ховсдох эрдэм нь олонд ил болбол тэр бүгдийн дайсан болж, амиа алдах энүүхэнд тул Татугийн эрдмийг ганцхан Бат мэдэж, түүний зарлигаар л илбэ шидээ үзүүлэх ёстой ажээ. Үүнийх нь төлөө Бат, Татугийн амь насыг даана. Хөндлөнгийн хүнд Тату бол Батын шадар мэт үзэгдэнэ.

Зүчийн цэрэг Ургенчийн захад ирж буухаас яг хорин найман жилийн өмнө Тэмүжингийн

хүрээнд нэгэн хэрэг мандсан нь Тэмүжин дүү охин Тэмүлэнээ Ихирэс аймгийн Буту гэгчид найрамдан дагасны нь шанд эхнэр болгон өгсөн явдал байлаа. Тэмүлэн энэ үед Тэмүжиний торгон цэрэг Тату гэгч залуу эрд сэтгэлтэй болсон байв.

Тату бол Хасарын их хатан Борогчины дүү тул Тэмүлэний ингэж сэтгэл алдарсныг бас буруутгах үндэсгүй ажээ.

Тату ч Тэмүжиний дүү Тэмүлэн охинд дурлажээ. Гэвч тэд амраглан амьдрах хувьгүй байсан юм. Тэмүлэн Татугийн тухай хэнд ч хэлж болохгүй гэсэн Өүлэн эхийнхээ хаширлан захисныг дагалгүй, Тэмүжин ах нь эцсийн эцэст түүний хайр сэтгэлийг нь ойлгон шийдвэрээ буцаана хэмээн горьдлого тасрахгүй тул өөрийн сэтгэлийн нандин нууцаа Бөртэд дэлгэж туслахыг гуйсан билээ.

Бөртэ Тэмүлэний толгойг энгэртээ нааж удаан суужээ. Гэтэл гадаа Тэмүжиний ирэх сонсодсон тул Тэмүлэн годхийн гарч гүйжээ. Тэмүжин тэдний юу ярилцсаныг шууд мэдэв.

-Бөртэ. Чи бас ээж шиг Тэмүлэнг Бутуд бүү өг гэж намайг ятгах нь уу гэвэл Бөртэ цай аягалж өгөөд дэргэд нь дөхөн сууж, -Тэмүжин. Чи Тэмүлэний хэргийг дэмий нэг хялбар явдал гэж бүү үз. Тэмүлэн Бутуд очихгүй оргон зайлах гэнэ гэв.

-Чи инээд бүү хүрэг. Тэр яаж ингэж чадна. Харин чи цаад хүн нь хэн болохыг мэд.

-Би мэдэж байна ...

-Хэн бэ? -Үгүй ээ. Чи намайг түүний нэрийг хэлэхийн өмнө нэг зүйл амла.

-Чи хэл.

-Чи түүнийг өнөө шөнө үхүүлнэ гэвэл би хэлье. Бөртийн энэ үг Тэмүжинг ихэд цочоов.

-Чи түүнийг өнөө шөнө үхүүлэхгүй бол тэд маргааш оргон зайлах болно. Ингэвэл чиний нэр сүрэнд хар толбо болох биш үү. Тэр бол чиний амь сахигч цэрэг Тату гэнэ.

-Борогчины дүү Тату гэж үү Тэмүжин бодолд унав. Тэр Татуд хайртай юм.

Тату бол өөрөө сайн дураар зүтгэж торгон цэрэгт шилэгдэн тэнцсэн сул ард гаралтай цөөн эрсийн нэг билээ. Торгон цэрэгт зөвхөн ноёдын хөвүүд орох бөгөөтөл Тэмүжиний тушаалаар жирийн ардын хүүхдээс хүсэлтэй, ухаалаг, гавшгайг нь сонгон авах болсон байв. Тэмүжинг хамгаалах гэж үнэн сэтгэлээр зорьж ирэгсдийг тэр онцгойлон үзнэ. Тату бол хамгийн шилдэг цэрэг байв.

Гурван өдөр шөнө нойр хоолгүй явж, зогсож чадах хүн ганцхан Тату билээ. Тайчуудтай хийсэн тулаанд Тату Тэмүжингийн дэргэдээс огт холдохгүй гурав хоносон бөгөөд бороноос түүнийг хамгаалан халх барьж шөнөжин зогсохдоо ганцхан удаа хөлөө сольж гишгэснээс өөр хөдлөөгүйг Тэмүжин нойтон газар дээрээс үзсэн юм. Тату бол үнэхээр шидтэй, тэвчээртэй хүн юм.

Бусад нь нойрмоглон унаж байхад Тату ганцаар нүд цавчихгүй зогсож байдаг байв. Очиж очиж хамгийн хайртай торгон цэрэг нь Тэмүлэн дүүтэй нь сэтгэлийн холбоотой болсныг мэдмэгц Тэмүжин гайхан бодолд унав. Хэрэв Ихэрэс аймгийн Буту албатуудаа дагуулан түүнд дагаж орсныхоо шанд Тэмүлэнг гуйгаагүй бол хэдий ардын хүүхэд ч Татуд дүү Тэмүлэнгээ өгөхөд татгалзах юмгүй санагдана. Гэвч хэрэг нэгэнт иймд хүрчээ.

Цэрэг хүн хэдий зориг, тэвчээр ихтэй, үнэнч сэтгэлтэй ч бүхэл бүтэн аймагтай дүйцэх гэж үү. Ийн санахад Бөртийн шаардсанаар Татуг даруй үхүүлэх нь зөв санагджээ. Бөртэ л ингэж сийрэг ухаантай загнаагүй бол зориг ихт Тату яаж ч мэдэх билээ.

Тату нэгэнт л зориглон зүтгэвэл хэнийг ч хөнөөж мэднэ. Бүр Тэмүжинг өөрийг нь ч хорлож дөнгөх билээ. Ийн санаад Тэмүжин босон харайв.

-Чиний зөв санагдана. Би одоохон Боорчийг явуулж түүнийг сэм бариулъя гээд гарах гэтэл Бөртэ дуудаж түүнийг зогсоов. -Тэмүжин. Чи Боорчийг бүү явуул. Борогчин хэргийн учрыг мэдвэл чамд өшрөх биш үү. Боорчи тэртээ тэргүй чамтай нэр нэг. Ийм хэрэгт Хасарыг зарвал зохино. Борогчин мэдлээ ч Хасарт өшрөхгүй биз. Тэр Татуг өчиггүй үхүүл. Ийм холын нарийн ухаан гаргах хүн Бөртээс өөр үгүй билээ.

Бөртийн хэлсэн үгний цаад гүнзгий санааг ойлгоод Тэмүжин бахдалтайгаар инээж

-Бөртэ. Би чиний хэлснээр хийе.Чи бид хоёр нэг хүн болжээ гэж шивнээд гарчээ.

Тэр шөнө хайртай Тэмүлэнгээ авч оргохоор шийдсэн Татуг Хасар очиж барьж хорьжээ. Тэмүжин түүнийг арай ч алж зүрхэлсэнгүй хайрласан билээ.

Тэмүлэнг Буту Ихэрэс аймаг руугаа авч явснаас хойно Татуг авчир гэж Тэмүжин хэлжээ. Тэмүжин Татуг үгээр үхүүлж, өөртөө зүтгүүлж чадна гэж боджээ. Гэтэл тэр даанч хол андуурсан байлаа.

Тату харгалзагч цэргүүдээс хоёрыг нь улаан гараар хөнөөж, галзуу барс шиг аашилжээ. Нэгэнт энэ хэрэг ийм дуулиантай болсон тул Татуг бусдад нь сургамж болгох үүднээс олны нүдэн дээр ил цаазлахыг Тэмүжин тушаав. Хүрээний захад цаазын тавцан засаж цэрэг, ардыг жагсаав.

Тату зүтгэсэн эзнийхээ илдэнд үхэх болов.

Тэмүжиний цаазнаас одоо түүнийг хэн ч аврахгүй болсныг мэдмэгц дэмий юм хийсэндээ туйлгүй гэмшиж харуусчээ. Амьд явах гэдэг хичнээн үнэтэй, хүслэнтэй болохыг сая л ойлгов.

Амьд л явбал хичнээн ч бүсгүйд дурлаж, хичнээн ч бүсгүйтэй учирч болохыг мэдэв. Хайран сайхан залуу нас, амьдралаа гэнэн болчимгүй үйлдлээсээ болж алдах болжээ. Өтөл муу боол атал өндөр язгуурт бүсгүйд сэтгэл алдарсан нь түүний үхлийн үр болжээ. Үүн шиг харамсал байхгүй билээ.

Гэрийн үүдээр Тэмүжиний дэргэд танил хүмүүс эгнэж, тэдний дунд ээжийнхээ дэргэд зогсох

зургаан настай Зүчийг олж харав. Тату амьд үлдэхсэн гэхдээ Тэмүжиний энэ хөвүүн гүйж ирээд

-Тату ахыг битгий алаач. Надад өгөөч гэж орилж уйлж,тэврэн аваасай гэж шаналан бодож Зүчийг ширтэж байжээ. Учир нь олон хүүхэд дундаас Тату Зүчид ихэд дотноор хандан хайрладаг байжээ. Энэ нь Тэмүлэн Зүчийг хайрладаг байснаас болсон биз. Гэтэл түмнийг гайхуулсан хэрэг болж Зүчи гэнэт ухасхийн түүн лүү гүйж ирэх нь тэр. Бөртэ хашгирав.

-Зүчи ээ. Миний хүү. Зүчи гүйн ирж сөхрөн суусан Татугийн өмнө ирж зогсоод эргэж

-Аав аа! Та энэ хүнийг битгий алаач. Та энэ хүнийг надад өгөөч. Ээж ээ. Та тэгээч дээ.Надад энэ хүнийг өгөөч дээ гэж шингэн хоолойгоор цангинуулан хашгирч гарчээ. Бүгд цочин балмагдаж Бөртэ гүйн ирж Зүчийг гэдрэг татав.

Гэвч Зүчи эхтэйгээ чаргуулдаж Татугийн толгойг тэврээд өнөөх үгээ хашгирсаар ажээ. Тэмүжин тэдэнд ойртож ирэв.

Эргэн тойронд ганцхан Зүчийн хашгирах сонсдоно. Бөртэ ухаан алдталаа айжээ. Томоогүй хөвүүн нь юу хийх нь энэ вэ. Тэмүжинг хилэгнэнэ гэж зүрх нь түг түг цохилон хөвүүнээ хамгаалах мэт тэвэрч аргадав. Гэтэл номхон томоотой Зүчи үгэнд нь орсонгүй. Тэмүжинг ойртон очмогц Зүчи таг дуугүй болов. Гэвч эцгийн өөдөөс ширтсээр байхад Бөртэ хүүгээ хамгаалан ардаа хийжээ.

-Аав аа. Та Татуг битгий алаач гэж Зүчи нулимсаа урсган шивнэв.

-Зүчи нааш ир гэж Тэмүжин дуудав. Тэмүжин анх удаа Зүчи хөвүүнээ бахархан ширтэж байв.

Тэмүжин Татуг алах хүсэл үнэндээ байсангүй боловч Татугийн үйлдсэн хэрэг нэгэнт түүнийг өршөөж болохгүйд хүргэсэн билээ. Гэтэл Зүчи хөвүүн нь түүний энэ далд хүслийг таасан мэт хэлсэн нь Тэмүжинд хачин дотно, бүр бахдалтай санагджээ.

-Тату чи сонс. Би чамайг алах ёстой юм. Гэвч Зүчи хөвүүн минь чамайг амьд үлдээхийг хүсчээ. Чи миний хөвүүнд үүрд үнэнч зүтгэнэ гэж тангараглавал би чамайг өршөөе.

-Би тангараглаж байна гэж Тату амьд үлдсэндээ итгэж ядан Зүчийн өлмийд мөргөжээ.

-Тату чи сонс. Хөвүүн минь балчир байна. Чи одооноос эхлэн Зүчийн боол боллоо. Би чамайг Зүчи хөвүүндээ өгье. Амь чинь Зүчийн гарт гэдгийг бүү март. Тату эхэр татан уйлж байв. Тэмүжин Зүчи хөвүүнээ тэврэн өндөрт өргөв. Олон бүгдээр хүрхрэн сайшааж Зүчийн зориг ухааныг биширчээ.

Энэ бол Зүчийн үеийнхэн дундаас онцгойрон ялгарахын эхлэл болжээ.

Үнэхээр Татуг бүү үхээсэй гэсэн хүн олон байжээ.

Зүчи яагаад ингэснээ ер ойлгоогүй бөгөөд тэр үед Тату ч Зүчийг ховсдоноо мэдээгүй билээ. Тэр мөчөөс хойш Тату хэлсэндээ хүрч Тэмүлэнг үүрд мартаж Зүчийн дэргэд сүүдэр мэт явах

болжээ.

Батыг төрсөн өдөр Зүчи Татуг дуудан

-Энэ өдрөөс эхлэн би чамайг Бат хөвүүндээ өгье. Чи түүний дэргэдээс алхам ч бүү холд. Дэрний нь дэргэд, гэрийн нь үүдэнд хад мэт зогсож, халхавч мэт яв гэж тушаажээ. Зүчийн хэлсэн үг Татугийн хувьд Тэнгэрийн зарлиг юм. Ингэж Тату Зүчийг хайрлан өсгөсөн шигээ Батыг яг төрсөн эх шиг нь маллаж өсгөжээ. Тату бол Батын хувьд эцгийн нь удаах итгэлт нөхөр нь билээ.

Харин Тату өөрийн ховсдох чадварыг мэдэхгүй байсан бөгөөд Зүчийг түүнд Тэнгэр илгээсэн гэж итгэж биширч явжээ. Жамухын шадар Хантөмөрийг унтуулж Зүчи Цагадай хоёрыг оргуулан авчирсан, Наймантай хийсэн тулаанд Зүчийг гарцаагүй үхлээс аварсан гээд түүний ховсны хүчээр болсон олон хэргийг тэр таамагласангүй иржээ.

Хэдий өөрийн нууц чадлыг мэдсэн ч Тату Батад үнэнч зүтгэх сэтгэлээ хувиргаагүй юм. Угаас тэр Зүчид үнэнч зүтгэх тангарагтай бас энэ тангарагаа Батад өгсөн билээ. Татугийн ховсонд хэнийг оруулж яаж ашигласан нь зөвхөн Бат тэр хоёрын л нууц болж үлджээ. Тату Батыг хэлээгүй бол хэнийг ч хэзээ ч үл ховсдоно. Батын үг Татугийн хувьд Тэнгэрийн цааз юм.

Бат эхний үед хүүхдийн томоогүй аашаар олон болохгүй хэргийг Татугаар хийлгэжээ. Аз болоход ховсдуулсан хүн үүнийгээ үл мэддэг нь Бат тэр хоёрт завшаан болжээ. Бас Тату хаширч ухаажсан хүн тул нялх хүүхдийн үгээр юунд бүгдийг хийх билээ.

Хэн нэгэн Татугийн ховсонд орохгүй бол Бат ихэд уурладаг байлаа.

Хорезмд мордохын өмнө болсон найран дээр Тату өөрийн чадлыг үзмээр санагдсанд анх удаа өөрийн хүслээр хийжээ. Чингис хаан өөрийн их хуланд айраг дүүргээд өргөө дүүрэн суусан ихэс дээдсийн дэргэд Батыг дуудан өгсөн нь чухам гайхашигтай явдал болсон билээ.

Чингис хаан хэзээ ч хэнийг ч ингэж онцгойлон үзэж байсангүй тул Бөртэ нүдэндээ итгэсэнгүй.

Зүчи Бат хоёрын баяр бахдал хязгааргүй болжээ. Хайртай хоёр эзнээ ингэж баярлуулсандаа Тату их жаргалтай байлаа.

Харин өөрийн энэ үйлдлээ Чингис хаан ойлгосонгүй уджээ. Юуны учир Батыг олны өмнө онцгойлох болсноо удтал боджээ. Тэгээд Зүчийн өмнө өөрийгөө буруутай гэж бодсоноос ингэв гэж ойлгожээ. Ач нар дотроосоо Батыг онцгойлон үзсэн нь харин ч аятай зүйтэй хэрэг болов гэж баяртай байжээ. Чухам ингэж Батыг олны өмнө өргөмжилсөн нь Тэнгэрийн зарлиг биз гэж итгээд Батыг ихэд тоох болжээ. Татугийн анх удаа өөрийн хүслээр хийсэн энэ ховс хожим хойно Батын амьдралд ямраар нөлөөлөхийг таах аргагүй билээ.

Харин энэ удаа Ургенчийг хамгаалагч Хорезмын жанжин Төмөр-Мэлигрүү Татуг явуулсан нь Батын санаа бөгөөд дайсны хүрээнд илгээсний анхных болжээ. Цагадай, Өгөдэй нар Чингис хааны зарлигаар цэрэглэн ирж тэднээс Ургенчийг булаан авсныг эсэргүүцэх сэтгэл Батыг

ийм алхам хийхэд хүргэв.

Эцэг нь Ургенчийг дайлах цэргээ засахыг түүнд зөвшөөрснийг Бат эцэг нь түүнээс аврал эрсэн хэрэг гэж үзжээ.

Хайртай эцэг нь ямар гарал, цустай, яаж зовж шаналж амьдарсан, эцэст нь яаж доромжлогдон гутаагдсаныг Бат шиг гүнзгий ойлгож, гуниж бухимдсан хүн үгүй байв.

Хэлсэн үг, хийсэн үйлийнх нь төлөө тэр дотроо Чингис хааныг, Цагадайг ч үзэн ядаж байв. Гэвч тэр юу ч хийж үл чадна. Харин одоо Ургенчийг бусдад алдахыг хүссэнгүй. Ургенчийг бусдад алдсанд орвол юу ч үлдээхгүйгээр сүйрүүлэх нь дээр гэж үзжээ. Бас Цагадай, Өгөдэйн цэрэг ч хохирохыг юманд үл тоов.

Татуг Төмөр-Мэлигт илгээсэн нь Батын хийсэн хамгийн анхны осолтой шийдвэр байв. Төмөр Мэлиг Татугийн ховсонд автахгүй бол Тату үхэх нь гарцаагүй. Байдал, үр дагавар нь аюултай хэдий ч Бат зорьж шийдсэнээсээ ухарсангүй. Бат угаас хүний санаагүйг санаж, хийгээгүйг хийх дуртай хөвүүн байлаа. Энэ чанар нь ийм хэцүү, осолтой, хатуу шийдвэр гаргахад хүргэв. Бүх юм санаснаар болж Төмөр-Мэлиг Батын илгээсэн элчийн үг болоод захидалд итгэв.

Захианд дурдсанаас гадна Тату ганц Төмөр-Мэлигт сонсдохоор хэдэн үг нэмж хэлжээ.

-Цагадай, Өгөдэй нар хэдий миний дүү ч гэлээ надтай өрсөлдөн тэмцэлдэгчид юм. Иймд би өөрийн хотыг тэдэнд өгөхийг үл хүснэ. Чи ар талдаа санаа зовох юмгүй тэдний эсрэг байлдагтүн. Чи тэднийг ухрааж чадвал аз чинь болог. Тэднийг ухарсаны хойно чи надад бууж өгвөл би чамд хуучин эрх ямба, цэргийг чинь үлдээж, дэргэдээ авъя. Эс тэгвэл чамд хэний сэлмэнд үхэх чинь хамаагүй биз. Би өөрийн үгний баталгаа болгож дотно шадраа чамд илгээв. Би хэрэв цэрэг хөдөлгөн чамайг довтолбол миний элчийг цавчин алагтүн гэсэн Батын үгийг Зүчийн нэрийн өмнөөс Тату ТөмөрМэлигт өчжээ.

Эхний өдөр Зүчи нээрээ цэргээ хөдөлгөж Ургенчийг баруун талаас довтлоогүй нь итгэхэд хүргэсэн ч дайсандаа итгэнэ гэдэг үхэлтэй адил гэдгийг хашир Төмөр-Мэлиг юу эс андах билээ. Төмөр-Мэлиг Зүчийн элч Татуг дэргэдээсээ үл холдуулав. Зүчийн зүгээс ганц цэрэг ч болов довтлон ирвэл түүнийг алахыг тушаажээ. Зүүн талаас Цагадай, Өгөдэй нарын довтлох дийлдэшгүй болоод цэргийн хагасыг хотын баруун жигүүрт барих нь байдлыг хүндрүүлж цэргийн эсэргүүцлийн хүчийг сулруулсаар байв. Гэтэл тэр Феридон-Гүр жанжнаа эсэргүүцсээр байтал баруун цэргээ татаж Өгөдэйн өөдөөс тулалдахыг тушаав.

Энэ нь Төмөр-Мэлиг Татугийн ховсонд орсных байлаа. Энэ бүх нууцыг Бат эцэгтээ дурссангүй.

Үнэхээр Ургенчийн баруун хэрэм эзгүйрч цөөн цэргээс өөр хамгаалалт үлдсэнгүй. Хүч нэмэгдсэн дайсны эргүүцэлтэй тулсан Өгөдэйн цэрэг ихээр сүйрэх боллоо. Бат шөнө болохыг тэвчээртэй хүлээнэ. Зүчи ч хөвүүний энэ зальт аргыг сайшаав.

Шөнө дунд өнгөрч сар жаргахад Зүчи, Бат хоёрын цэрэг Ургенчийн хэрмийг төвөггүй эвдэн онгойлгоод сэм урсан орлоо.

Хотын тал нь даруй эзлэгдэж харин Төмөр-Мэлигийн цэрэг шивээлсэн хотын зүүн дүүргийг Бат бүхэлд нь галдан шатаахыг тушаав. Галд хуйхлагдаж үхэхээс зугатсан олон цэрэг хэрмээс гадагш үер мэт довтолсонд Өгэдэй, Цагадайн цэрэг хориглож эс чадаад хойш ухрахад хүрэв.

Гэвч Өгөдэй "үхлийн цэрэг" нэмж оруулсан тул Хорезмчууд даруй хоорондоо алалдан сүйрчээ.

Энэ гал, цусны тулаан долоон өдөр долоон шөнө үргэлжилж Ургенчийн үлдсэн цэрэг бууж өгөв. Урчууд, дархчууд, эмс, хүүхдээс бусдыг нь хядаж, Бат Ургенч хотын усны даланг эвдэн Аму Даръя мөрний усыг хотод оруулснаар үлдэгсэд бүгд живж үхжээ. Ургенчийг хэнд ч өгөхгүй гэсэн амандаа Бат ийн хүрэв. Төмөр-Мэлиг Зүчид хуртсандаа өөрийгөө хараасаар үхжээ.

Үхэхийн өмнө Зүчийн элч Татуг шатаасныг Төмөр-Мэлигийн олзлогдсон цэргүүд хэлжээ. Хэд хоногийн турш хайлгасан боловч хөөрхий үнэнч Татугийн яс үс ч олдсонгүй нь энэ удаа түүний ховс амийг нь аварч чадсангүй үхсэн бололтой.

Зүчи Бат хоёр эцгийгээ алдсан мэт өнчрөн гашууджээ. Гэвч Бат Татугийн үхсэнд итгээгүйгээр барахгүй цөхрөлгүй эрж хайсаар байжээ.

Ургенчийг авсан тулаан Монголын олон мянган цэргийн амийг авч өндөрлөв. Гэтэл Ургенчийг авсан тулаан ингээд дууссангүй. Ургенчийг авмагц цэргээ татан ирж нийлэх тухай Чингис хааны зарлигийг эхлээд Өгөдэй, дараа нь Цагадай даган өмнө зүг хөдөлжээ.

Харин Зүчи "Өөрийн эзэмшил нутаг орон, хот газрыг тохинуулна" гэж хэл өгөөд Ургенчээс хойд зүг Каспийн тэнгисийн зүүн биеэр хөдөлж замд таарсан жижиг хот, балгасыг эзлэн явжээ.

Хэдий Ургенчийг Бат эзлэн авсан ч оногдох нэр гавьяа нь Өгөдэйд очсонд Зүчи туйлын их харамсчээ. Бас Батын учир нь үл ойлгогдох хачин шийдвэрээс болж Өгөдэй, Цагадай нарын зүгээс гомдол санал гарахыг ч тэр мэдэж байв. Үнэхээр Өгөдэй Цагадай хоёр уур хилэн дүүрэн буцжээ.

Зүчи балчир хөвүүн Батдаа цэргээ удирдуулж,хотын гурван талаас зэрэг довтлох шийдвэрийг зөрчин алгуурласнаас болж олон цэргийн амь сүйдсэн гэж тэд үзжээ. Тэд үүнд Батыг биш Зүчийг буруутгана. Энэ бол Чингис хааны зарлигийг зөрчсөнтэй адил явдал болжээ.

Хөвүүдийн хоорондох зөрчлөөс үүдэн Ургенчид юу гээч болсныг Өгөдэйг очихоос өмнө Зүчийн дэргэд байсан тагнуул нууц элч илгээн Чингис хааны сонорт хүргэсэн байлаа.

Чингис хаан хөвүүддээ тэр дундаа Зүчид ер ингэж хилэгнэж байсангүй.

Нэг муу өчүүхэн өнчин балгасыг санал нэгдэн эзэлж авч чадалгүй олон цэргийн амь сүйрүүлсэнд хилэгнэж Өгөдэй, Цагадай хоёрыг бараалхуулахгүй хэд хонов.

Чингис хааны дэргэд байх Боорчи, Шихихутаг болоод шадар, хорчингууд ятгаж ядаад үгээ

баржээ.

Чингис хаан хөвүүддээ хилэгнэхээс илүү тэднийг яаж гэсгээх аргаа олохгүйдээ ингэж олон хоног хилэгнэсэн дүртэй суусан билээ.

Бодож бодож хэргийн учрыг нарийвчлан сонсоод гол буруутан нь Зүчийг гэж үзээд Өгөдэй, Цагадай хоёрыг өршөөжээ.Тэд ч өөрсдийгөө цагаатгахын тулд муу үг хайрласангүй. Өөрийн буруутан гэдгээ батлах гэсэн мэт Зүчи түүний зарлигийг дагаж цэрэгтэйгээ ирж нийлсэнгүй зун өнгөрч намар болжээ.

Чингис хаан Зүчийг мартсан мэт болоод сэрүү ормогц цэргээ хоёр хуваан Инд мөрний баруун зүүн эргээр урагшлуулж Хорезмын үлдсэн цэрэг, сүйрсэн хаан Желаладдинийг нэхэн Энэтхэг газрын гүн рүү довтолж одов.

Харин Зүчи нутгийн бууж өгсөн цэргээр хүчээ сэлбэж даруй зургаан түмэн цэрэгтэй болж, Каспийн тэнгисийн зүүн, зүүн өмнө талын нутгийг бүхэлд нь эзлэн авахаар довтолж эхлэв. Энэ бол түүний өөрийн дур хүслээр хийж буй дайн байлаа. Энэ бол Зүчи үндсэндээ Чингис хаанаас тусгаар явах болсноо баталсан хэрэг юм.

Ингэснийхээ төлөө ямар ч гэсгээл цаазанд унахаас тэр эмээсэнгүй. Учир нь Зүчид анх удаа өөрийн эзэлж авсан нутгаа захиран, өөрийн улсыг байгуулах боломж олдсон нь энэ юм. Үүний төлөө амиа үрэхэд бэлэн байв. Жил гаран болоход Зүчийн эзлэн авсан нутаг даруй хоёр дахин нэмэгдэв. Гэвч тэр үүнд сэтгэл ханасангүй.

Харин ч Бат хөвүүн нь Кавказын нурууг давж Сүбээдэйн хамт баруун зүг довтлохыг хүснэ.

Харин Зүчи зэргэлдээх Хивчаг аймгийг эзлэн Уралын нуруунаас баруун тийш орших Оросын хотуудыг нэгтгэн авахаар төлөвлөж байлаа. Каспийн тэнгисийн зүүн хэсгийн нутгийг эзлэн авч дуусгасан нь 1223 оны өвөл болжээ. Эзлэн авсан нутгийн хил хязгаарт харуул томилон суулгаж нутгийн хотуудад хууль цааз, гааль татварын журам тогтоон нэгдсэн улсын хэлбэрт оруулах ажилдаа Зүчи нутгийн иргэдээс дагаж орсон хүмүүсээс шилж сонгон хэрэглэж байлаа. Тусгаар улс болон суухыг хүсэгчид түүний дэргэд нэн олон болсон нь Зүчийн сэтгэлийг бадрааж итгэлтэй болгоно.

Зүчи одоо Чингис хаанаас тусдаа суухаар эргэлт буцалтгүй шийджээ.

Чухам ингэж суу хэмээн Чингис хаан түүнд нутаг хот зааж өгсөн биз хэмээн өөрийн зоргоор үйлдлийг зөвтгөн бодож бас өөрийгөө зоригжуулж байв. Чингис хааны зүгээс сайн муу хэл аль нь ч ирсэнгүй хэсэг зуур таг чиг болсон нь Зүчийг санасанаа тайван гүйцэлдүүлэх сайхан боломж олгожээ.

Гэвч түүний итгэлт шадар Хунан сар бүр нууц элч зарж Зүчийн хүрээнд юу болж байгааг Чингис хаанд илтгэж байгааг тэр таамаглахгүй байв. Зүчи өөрийн үйлдлийг Чингис хааны тагнуул дэргэд байгааг гадарлаж байсан ч хамгийн итгэлт ахмад жанжин Хунанг байна гэж огтхон ч сэжиглэсэнгүй. Тэгээд ч Чингис хаан мэдлээ ч Зүчи айж нэрэлхэхгүй болжээ.

Каспийн тэнгисийн зүүн өмнөд эргийн Авралт булангаас арван бээр зайтай үзэсгэлэнт сайхан Алагтуу уулын уужим бэлийг авируулан хараа бараа сайтай өндөр газар сонгон авч өргөөгөө босгон суув. Зүчи энд өөрийн хаан ордыг байгуулахаар нутгийн урчуудыг дайчлан авчирчээ. Шатааж сүйрүүлсэн Ургенчээс дутахгүй үзэсгэлэнтэй сайхан хот босгох хүсэлд Зүчи, Бат хоюул адилхан автжээ.

Харин Батыг Монголд илгээхээр шийдэв.

Монголд үлдсэн хатад, хүүхдүүд, нааш ирэх хүсэлтэй албатуудаа нүүлгэн авчрах ажлыг түүнд даалгахаар тогтов. Бас Бөртэ ээждээ хэргийн учрыг дуулгаж үгийг нь сонсохыг ч хүсэв. Бат нутагтаа очих хүсэл их байсан ч бас энд хоргодон үлдэх сэтгэл төрж байсанд нэг учир бий билээ. Каспийн тэнгисээс цааш нутаглан суух Хивчаг аймгийн хан Хотиан, Кавказын нурууг даван хөрш Асу аймагт цөмрөн орсон Сүбээдэйн цэргээс айхдаа Зүчитэй найрамдахыг хүсч үзэсгэлэнт Герта гүнжээ их бэлэг, араб үүлдрийн агт морьдын хамт элчээр хүргүүлснээс Герта гүнжийг нь Зүчи Бат хөвүүндээ өгсөн байв.

Тэр хэзээ ч ийм үнэт бэлэг авч байсангүй. Герта бол уг гарал нь хойд Орос улсын эзэн Долгорукий вангийн удам бөгөөд түүний эхийг арван зургаан настайд нь орос жанжин Местслав гэгч Хивчагуудтай найрамдахдаа бэлэг болгожээ.

Герта Хивчаг аймагт төрсөн, орос түрэг цус холилдсон алтан шаргал үстэй, алаг цэнхэр нүдтэй, нуруу өндөр, хөх том, гуя зузаан чухам шим шүүс нь нэвт гэрэлтсэн бүсгүй байв.

Хоёр насаар ах янаглах эрдэмд гаргууд Герта гүнж Батын бие сэтгэлийг эзэмдэн булаажээ.

Ийм амраг бүсгүйгээс хагацна гэхэд Батад их л гачлантай байхыг Зүчи мэдэрчээ. Зүчи дахиад л хөвүүнийхээ аяыг дагав. Монголын нутагт ер үзэгдээгүй өнгө төрхтэй эмээ дагуулан явахыг Зүчи зөвшөөрсөн нь залуу Батад чухам Тэнгэрийн хишиг шиг санагджээ.

Хөвүүнээ баярлахыг үзээд Зүчид үнэхээр жаргалтай байлаа.

Багадаа үзэж, эдлээгүй аз жаргалыг нь Бат хөвүүн нь дүүрэн эдлэх ёстой гэж Зүчи хичээх бүлгээ. Батын төмөр дугуйтай сүйх болоод хамгаалах таван зуун цэрэг бэлэн болж нутгийн зүг сүр бараатай үдүүлэн хөдөллөө.

Зам хол бартаатай лав хэдэн сарын явдал болох биз.

Хэд хоногийн өмнө Зүчийн Бөртэ эхдээ өгөх бэлгийг ачсан хөсөг монголын зүг хөдөлсөн юм.

Бат, Монгол нутагтаа очоод юу хийх, хэнийг нүүлгэн авчрахыг зөвхөн эцэг хүү хоёр л мэдэж байв. Ингэх нь зөв гэж тэр үзсэн билээ. Хөвүүнээ явуулж нэг чухал хэрэг бүтээгээд Зүчи өргөөндөө сая л нэг тухлан амрах шиг болжээ.

Өөрийн байдал, гаргасан шийдвэр, цаашид хэрхэхээ тайван тунгаан бодох цаг өмнө нь ер олдоогүй мэт.

Одоо Зүчи бага биш нутгийг эзлэн авчээ. Баруун зүгт Кавказын нуруу Арал тэнгисийн

хойгуур давшвал шууд Киевийн Орос улсад цөмрөн орж, Газар дундын тэнгис хүрэх зам шулуун ажээ. Мөн хойт зүг Урал мөрнийг гатлан Уралын нуруунаас баруун талаар давшвал оросын олон тусгаар хотуудыг эзлэн хойт хүйтэн тэнгис ч хүрч болох зам нээлттэй. Ийм учраас Зүчи өнөөдрийн байдлаар хамгийн ашигтай байр, нутаг орныг эзлэн авчээ.

Тийм учраас хэдэн жилдээ өөрийн хүчийг бэхлэн, нутгийн цэргүүдийг сургуулилж бэлдэх, өөрийн цэргийг амраах, олз омгоо хуваж тэдний урмыг сэргээх боломжтой, иргэд, харьяатаа Монголоос нүүлгэн авчирч суурьшуулах гээд хийвэл зохих олон ажил овоорчээ. Гэвч Зүчи цуцаж ядарсангүй. Түүнийг өөрийн тусгаар улсыг байгуулах их хүсэл хөтөлж, тэр нойр хоолыг умартсан мэт эзэлсэн нутгаараа дөрөө мултлахгүй явж хэрэг заргыг шүүж, хэрэм хотыг төвхнүүлж, шинэ амьдралыг төлөвшүүлж байлаа.

Энэ зуур Монголын их цэрэг Энэтхэг рүү цөмрөөд буцаж эргээгүй байсан тул Зүчид тайван амар өөрийн улсыг бэхлэх цаг олджээ.

Зүчи өөрийн шинэ хотод “Алтан ордон” гэж нэр өгсөн бөгөөд түүний улс “Алтан ордны улс” гэж дуурсагдах болно гэж шийджээ.

Гэхдээ үүнийгээ хараахан зарлаагүй хүлээсээр байгаа бөгөөд ингэх нь Чингис хааны зүгээс түүний тусгаар улс байгуулахыг юу гэж үзэх нь тодорхойгүйтэй холбоотой билээ.

Чингис хааны дуудсан зарлигийг хэрэгсэхгүй орхиж Ургенч хотын дэргэдээс өөрийн замыг хөөснөөс хойш Зүчи эцэгтэйгээ уулзалгүй даруй хоёр жил болж 1224 оны хавар Бат эх нутгаас инээд хөөр дүүрэн эргэн иржээ. Батаас талын сэрүүн салхи, таана айраг ханхалж байв. Монголоос ирэх нүүдэл, хүний тоо тодорхой болж тэдэнд суух нутаг газрыг бэлдэх ажил Батын ирсний маргаашнаас ундарч эхлэв. Гэвч эцэг хүү хоёр хамгийн гол юмаа яриагүй байв.

Бөртэ эх нь юу гэж хариу хэлсэн бол гэхээс Зүчи сэтгэл түгшин асууж эс түвдэнэ. Батад ч гэсэн шууд ам нээн ярихад тийм ч хялбар бус байлаа.

Батын цуваа Чингис хааны их өргөө, суурин хүрээ байрлах Туулын хөндийд очиход урьд өдөр нь Тулуйн Иранаас илгээсэн бэлэг, элч дөнгөж ирээд хөл хөдөлгөөн ихтэй байжээ. Нутгаас гарснаас хойш таван жил шахахад монголын тал нутаг, Хэрлэн,Туул,Орхон голуудын хөндийд олон зүйл өөрчлөгджээ.

Анх Хорезмд одоход оргүй хоосон байсан газарт одоо түм илүү хүн байнга суух хот Туул голын Хүн чулууны хөндийд босчээ. Айл болгоны үүдэнд хар нөмрөг битүү өмссөн зарц боол бөхөлзөж, мужаан дархчуул ажиллах нь Хорезмоос илгээсэн олзны хүмүүс ажээ.Перс газрын үнэт хивс эдлэл газраар хөглөрч морь малын тохом болжээ. Батын бэлэг монголчуудад төдий л сонин биш, тэд угаас баруун зүгийн баялагт бялууруад байжээ.

Харин Батын дагуулан ирсэн хулсан шар үстэй, цэнхэр нүдтэй Герта гүнжийг барьж үзэх нь холгүй, морьтой явган хушууран дагаж, цэрэг хамгаалалтад саад учруулав.

Батыг хамгийн их хүлээсэн хүн нь Бөртэ байлаа.

Бат Эрчис мөрний хөвөөн дэх эцгийн хүрээнд очиж Уги хатан ижийдээ золголгүй шууд Чингис хааны өргөөнд ирсэн билээ. Уги бол Бөртэ өөрийн хүслээр Зүчи хөвүүндээ сонгон авч өгсөн Хонгирадын Элчи ноёны охин, Бөртэ хатны ойрын хамаатны удам билээ. Тийм учраас аль ч талаар бодсон эхлээд Бөртэ эмэгдээ очиж золгох нь Батын зөв байв. Ингэхийг нь Зүчи захисан юм.

Чингис хааны төв хүрээ, гол улсаа сахин суух Тэмүгэ ноён Батыг хамгийн дээд хүндэлээр угтан тосч авахаар бэлдсэн ажээ. Баруун зүгт байгуулсан их ялалтын амьд гэрч болон ирж буй Бат, Чингис хаан их дайнд мордсоноос хойш дөрвөн жил гаран хугацаанд дайны талбараас нутагтаа эргэн ирж буй хамгийн том зочин байлаа. Тэмүгэ ноён өөрийн торгон цэргээ гурван өртөө газраас угтуулан жагсаагаад тосч байв. Яг л Зүчи өөрөө эргэн ирсэн мэт төв нутаг даяар угтан авсан нь Батыг туйлын ихээр догдлуулжээ.

Өнгөрсөн дөрвөн жил гарны хугацаанд Бат танигдахын аргагүй өөрчлөгдөөд зогссонгүй дэргэдээ харь цусны хатан дагуулсан залуу гацуур шиг гоолиг сайхан эр болсон нь түмний нүд булааж байв. Харин Батыг дагалдсан их хүндлэл, талын нүүдэлчин монголчуудын сонин ахуй төрх Герта гүнжийг гайшруулан баярлуулжээ.

Хатуу тавилангийн эрхээр түүнд заяагдсан эр нөхөр нь анхлан санасанчлан талын зэрлэг догшин удмын балчир хөвүүн биш харин их хааны ач хүү гэдгийг сая л нэг нүдээр үзэж мэдээд Герта дахин өөрийн амьдралдаа харамсан гунихгүй гэж эрс шийджээ. Тэмүгэ ноены хийсэн их найрын дараа л Батад эмэг эхтэйгээ тухтай ярих цаг олджээ. Батын үг бүр Бөртэд сонин, бас аймшигтай сонсдоно.

Хөвүүд нь эцгийнхээ хамт их ялалтыг олжээ. Харин эхлээд Зүчи хөвүүнээ Чингис хааны зарлиг зөрчин хойш үлдэж тусдаа суугааг нь зөвтгөж чадсангүй. Бас Чингис хаан ингэлээ гэж Зүчид хилэгнэн бухимдаагүйд ихэд сэжиглэн гайхжээ.

Ийм хэргийг Чингис хаан зүгээр өнгөрөөнө гэхэд даанч санаанд багтамгүй ажээ.

Тэмүжин чухам юу сэдсэнийг хэн ч таахын аргагүй билээ. Зүчи хөвүүн нь үзэж хараагүй хүний нутагт Каспий хэмээх их тэнгисийн хөвөөнд үүрд суухаар хатуу шийдсэнийг Бөртэ Батын үгнээс олж мэджээ. Зүчи энэ үгийг хэлүүлэхдээ эхээсээ зөвшөөрөл, тусламж эрсэнгүй, зүгээр л хүндэтгэх сэтгэлийн үүднээс эртлэн дуулгаж байгааг ч ойлгов. Бөртэ юу гэхээ мэдэхгүй байв. Ер нь юу ч гэх билээ. Одоо Зүчид юу хийе гэнэ түүний дурын хэрэг болжээ.

Зүчийн бие даан улс засах эрхтэйн баталгаа болсон Бат хөвүүн өмнө нь сууж байхыг Бөртэ харж байв.

Ийм хөвүүний төлөө далайг ч болов гаталж уулыг ч болов нүхлэх багадна. Зүчи хөвүүнээ өөрийн улсыг байгуулж Чингис хаан эцгийн адил нэр алдраа дуурсгаасай гэж Бөртэ хүсчээ. Зүчийн үгийн учрыг, түүний алс цаад бодлыг мэдмэгц Бөртэ анх удаа Зүчи хөвүүндээ сэтгэл зовинохгүй болов. Зүчи хөвүүн нь өөрийн их цэрэгтэй, улстай, өмгөөлж хамгаалах зориг, хүч төгс хөвүүдтэй болжээ. Зүчийн хөвүүдийн сор болсон Батыг хараад бахархаж ханахгүй байлаа.

Чингис хаан Зүчийг зэмлэж буруутгахгүй чимээгүй байгаа нь лав түүнийг тусгаар улсаа байгуулахыг битүүдээ дэмжсэн хэрэг гэж эцэст нь Бөртэ итгэв. Тэмүжин хэрвээ дэргэд байсан бол Бөртэд хэлж ярих юм хичнээн их байна гэх вэ. Гэвч одоо түүнд өөртөө бас Зүчид итгэх л үлджээ. Бодоод бодоод Чингис хаан Зүчийг буруутгах үндэсгүйд итгэн сэтгэлээ амраав.

-Хөвүүн минь юу хийнэ. Өөрөө мэдэг. Чингис хаан эцэг нь ч сайшаан дэмжих биз гэж Бөртэ баясгалантай хэлжээ.

Учир нь Өгөдэйг хаан суурынд залгалжлан суулгахаар сонгосноос хойш Бөртийн сэтгэлийн дотор хуримтлагдан зовоож байсан түгшүүрт бодлууд Батыг үзмэгц замхарч хавар цагийн шинэ соёолох ногоо шиг идэр залуу, ид хавтай ач хөвүүдээ өсч томорсныг үзэхэд Чингис хаан болоод Зүчи, Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдийнх нь залгамж халаа нэгэнт хүчээ авч, урьдын зовлон түгшүүр ул болон элэгдсэнийг мэджээ. Одоо Бөртэд ер санаа зовох юм үгүй мэт санагдана. Зовлонт амьдралын эцэст хөвүүд нь тус тусын их улсыг байгуулан суухыг үзэх хувьтайдаа баясна. Ийм их хувь заяа эх хүн бүрт олдохгүй биз. Бөртэ энэ жил жаран нэгэн нас хүрч байлаа. Гэвч их хааны эзгүйд даруй таван жил шахам хааны ордны дотрох эрхийг барьж Тэмүжиний отгон дүү Тэмүгэгийн хамт ер ажрах сандрах зүйлгүй төв улсаа захиран суусаар байжээ. Бөртийг ард үлдсэнд Чингис хаан ч санаа сэтгэл тайван байх билээ. Хулан хатныг Хорезмын нутагт тансаг ордонд суух болсныг мэдэж байсан ч түүний тухай ёсыг бодон асууснаас хэтэрсэнгүй.

Бас Ургенчийг эзлэн авахаас болоод хөвүүдийнхээ дунд үүссэн хэрүүлийг гадарлаж байсан ч ухаж сонирхсонгүй. Учир нь Чингис хаан “Хээрийн үйлийг хээр шийтгэ. Гэрийн үйлийг гэрт шийтгэ” гэж сургасан тул энэ хэргийг нэгэнт болоод өнгөрсөн явдал гэж үзжээ. Харин Зүчийг өршөөсөн Чингис хаанд ихэд талархжээ. Зүчи хөвүүнээ тусгаар улс байгуулан суухыг дэмжиж өдөөснөөр юунд хүргэж болохоо Бөртэ тэр үед ухаарсангүй.

Харин Батын өгсөн болоод Зүчи хөвүүний нь илгээсэн бэлэг дотроос Хивчаг аймгийн бие өндөр, бөгс том арван залуу охин хамгийн ихээр баярлуулжээ. Учир нь Бөртэ эм бие нь хөгширч дур тачаал буурсан ч, бусдыг тэр дундаа залуу эмс охидыг өөрийн нүдний өмнө эрчүүлд эдлүүлэн харж дураа тайлах донд автах болжээ. Тийм учраас өөрийн ордны дэргэд залуу шивэгчдийг олноор байлгаж шөнөд нь дотоод өргөөндөө авчран шилсэн идэр эрчүүлд өгч эдлүүлэн цэнгэдэг байв. Хэрэв дургүйцсэн юм уу, энэ явдлыг ил тод илчлэхийг оролдогсдыг зүгээр л алуулж орхидог тул эмс, залуус Бөртийн үг, харцаар байх бүлгээ.

Эзэлсэн дайлсан улсуудаас үс, зүс өөр, харь цусны бүсгүйчүүдийг авчруулан хэрхэн янаглахыг харж, дарс шимж суух нь Бөртийн хамгийн дуртай цэнгэл юм. Чингис хаан ч Бөртэ хатныхаа энэ цэнгэлийг сайшаан хөхүүлэх тул түүнд харийн нутгаас эмс охид илгээхээ мартдаггүй байв.

Бөртэ эмэгтэйгээ уулзсаны маргааш нь Бат өөрийн хүрээнд буцжээ.

Зүчи эзэн нь хол харийн нутгийг эзлэн сууж, албат иргэдээ нүүн ирэхийг тушаасныг нүүдлийн ая даахгүй хөгшдөөс бусад нь талархан угтаж их нүүдэлд бэлдэж хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж эхэлжээ. Идэр, Дэлгэрмөрөн, Эг, Шишгэд голын сав нутгаар суурьших

Зүчийн унаган албатын чадалтай, хөлтэй нь Каспийн тэнгисийн зүг нүүхэд бэлэн болжээ..

Түрүүч нь хөдлөхөөс өмнө Бат буцахаар бэлтгэв. Буцахын өмнө эмэг эхтэйгээ заавал уулзах ёстой тул Бөртийн өргөөнд очжээ.

Бат Монголд ирээд сар болох хугацаанд Бөртийн сэтгэлд нэн их өөрчлөлт оржээ.

Зүчийн иргэд алс хол Хивчаг аймаг, Каспийн тэнгис хэмээх их усны зүг нүүх чимээ төв монголын нутгаар нэг тархаж хамаг улсын чихийг дэлдийлгэж, нүдийг бүлтийлгэжээ. Албат иргэдээ нүүлгэн аваачих тухай Бат уулзахдаа дурдсангүйд Бөртэ нэг их юм бодсонгүй. Зүчи хөвүүн нь санасандаа хүрч өөрийн тусгаар улсыг байгуулан суухаар сэтгэл зориг шулуудсанд Бөртэ туйлын баяртай болжээ.

Харин энэ баярын сэтгэлийг цочирдуулсан нэг явдал болов.

Чингис хааны эзгүйд ахуй амьдралын олон хэргийг Бөртэ, улсын их хатны хувьд шийдвэрлэж, зовсон, гачигдсан иргэд албат бараалхан тус, аврал эрэх нь элбэг билээ.

Энэ бол Бөртийн толгой даан шийддэг олон хэрэгт хамаарах тул аль олон жилийн өмнө Есүхэйн гэрт ирснээс хойш хийж дадсан ажил байв. Их хатан Бөртэд бараалхана гэдэг хэр баргийн хүнд тийм ч амар тохиох хувь биш юм.

Ордны даамлууд, олон түшмэл, чербийн даваг давж цөөн тооны онцгой хүндэтгэх шалтгаантай иргэд л Бөртэ хатны их өргөөний босгыг алхах бүлгээ. Бас Тэмүгэ ноён ихэнх хэргийг хамаарах тул түүнд хандагсад бүр ч олон ажээ.

Ийм нэг хуваарьт өдөр Бөртэд Бичэлдэй гэгч залуу цэрэг бараалхах болжээ.

Өргөөний их даамал илтгэснээс үзвэл энэ Бичэлдэй нь Бөртэ хатанд бараалхахаар олон хоног хүсэмжилсэн, ордны гадуур харуулын цэрэг ажээ.

Газар дээр цор ганцаар өнчин, бас Бөртэ хатанд хувийн зүгээс өргөх айлтгал хүсэлт бий гэснийг сонсоод Бөртэ бараалхуулахыг зөвшөөрчээ. Алс газар их дайнд одож олз олж баяжих, гавьяа байгуулж мөнхрөхийг хүсэгсэд ордны хамгаалалт, эх нутгаа сахин үлдсэн цэрэг эрсийн дотор олон байдаг бөгөөд тийм л оргилуун сэтгэлтний нэг биз гэж Бөртэ тааварлаж боджээ.

Орж ирэхийг үзвэл өндөр нуруутай, мөр тэгш, чухам л торгон цэрэгт таарсан залуу байв.

Хүүхэд нялх төрхөө алдаагүй царай нь нүдэнд дулаан, яагаад ч юм бэ нэг л танил төрхтэй тул хэний хүү байх вэ гэж бодсон билээ.

Залуу цэрэг дор сөхрөн мөргөж

-Намайг Бичэлдэй гэдэг. Би ордны гадна харуулын албаны цэрэг юм. Их хатан танд аминчлан хэлэх үг байна гэж өргөөнд байх их даамал, шивэгчин бүсгүйн зүг хяламхийсэн нь хэлэх үгээ хэнд ч сонсгохгүй гэснийх юм. Бөртэ эргэлзэв.

Зүс үзээгүй, огт танихгүй энэ залуу яахыг хэн мэдлээ.

-Чи санаа бүү зов. Хэлэх үгээ хэл. Энэ улсаас бүү нэрэлх. Эд албаа гүйцэлдүүлж байна гэж Бөртэ хэлэв.

-Миний энэ үгийг их хатан танаас өөр хүн сонсох ёсгүй юм аа. Та болгоо гэж Бичэлдэй туйлбартай шаардав. Бөртийн сониуч зан гэнэт хөдлөв. Бөртийн зангахад их даамал хэдий дургүй ч шивэгчинг дагуулан гарчээ.

Бичэлдэй үүд рүү чагнаж, хүний хөлийн чимээ алдрахыг сонсож мэдээд Бөртэд дөхөхөөр урагшлав.

-Хүлээ. Чи наанаасаа хэлэхээ хэл гэж Бөртэ сэрэмжлэв.

-За

Залуу Бичэлдэй Бөртийн үгийг дагав.

-Би чамайг сонсож байна. Юу болов. Хэлэгтүн.

-Их хатан! Би бол мэргэд хүн юм. Энэ үгэнд Бөртэ гэнэт сэрхийн цочлоо.

Чухам яагаад ингэтлээ цочсоноо, сэтгэл түгшүүрлэснээ ойлгосонгүй ч дуугарсангүй.

-Би Мэргэд аймгийн хүн. Би мэргэдийн Чилэгэр бөх гэгчийн ач хөвүүн юм.

Ийм үг сонсоод Бөртэ суудлаасаа өндөсхийлээ. Ийм байх ёсгүй. Мэргэдийн эрчүүд, тэр дундаа Чилэгэр бөхийн удам бүгд сүйрсэн байхад энэ залуу юун дэмий үг хэлэв.

Бөртэ уурлах, учирлахын алиныг ч олж чадсангүй.

-Чи юу … ярина. Чамайг Чилэгэр бөхийн ач гэж хэн итгэнэ. Ийм дэмий үг бүү чалч гэж Бөртэ үнэн санаанаасаа хилэгнэн хашгирав. Гэсэн ч үгээ дуусгалгүй дуугаа намсгав. Тэр дэндүү түргэдэж байгаагаа ойлгожээ.

-Та намайг яаж таних билээ. Их хатан таныг Мэргэд аймгаас буцаан авахад эцэг минь төрөөгүй байжээ. Миний эмэг эх бол Чилэгэр бөхийн гэрт зарцлагдаж байсан шивэгчин Шихүр юм.

Залуу хөвүүний өмнаас гарсан энэ нэр Бөртэд танил байсан нь Бичэлдэйн үгийг анхааран сонсоход хүргэв. Тийм ээ. Бөртэ өрөвч сайхан сэтгэлтэй шивэгчин Шихүрийг мартахын аргагүй билээ. Шихүр бол Бөртийг мэргэдийн Чилэгэр бөхийн гэрт булаагдан очиход эмэгтэй хүний өрөвч сэтгэлээр угтан асарч тойлж, уйлахад нь өрөвдөн хамт нулимс унагасан зөөлөн сэтгэлт бүсгүй юм.

-Эмэг эх Шихүр эзэн Чилэгэр бөхөөс хүүхэд олсон нь миний эцэг Бүргий байжээ.

Харин эцэг минь намайг зургаан настай байхад Алтан улсад алагдсан. Эмэг эхийг хэрэйдийн Жаха-хамбу эзэн олзолж авсан тул эцэг минь тэнд төрж түүний боол болсон. Би ч мөн тэнд төрж сүүлд ЖахаХамбу эзнээ Чингис хаанд дагаж ороход хамт ирсэн билээ. Намайг хэрэйд хүн гэж одоо олноор тооцож буй. Харин намайг яс угсаагаа бүү мартаарай гэж эмэг эх минь сургасан юм. Энэ танихгүй залуугийн үгэнд итгэхгүй байх аргагүй мэт Бөртэд санагдаад тэр бодолд унав. Тоорил хан,Жамуха нар цэргийн хүчээр Бөртийг булаан авснаас хойш Шихүрийн хэрхсэн, амьд үхсэн болохыг Бөртэ өдий болтол мэдээгүй явжээ. Бөртэд тийм боломж олдоогүй билээ.

Харин Шихүр амьд үлдсэн, тэр бүү хэл ач хөвүүн нь энэ Бичэлдэй гэдгийг мэдмэгц сэтгэл хөдлөн догдолжээ. Бичэлдэйн хэлсэнд Бөртэ итгэж орхив.

-Чи юу гэнэ ээ. Бүхнийг надад сайтар ярьж өг гэж Бөртэ залуу хөвүүнд тал өгөн дээш нь дэргэдээ суулгав. …

Хэрэйдийн цэрэг довтлон ирэхэд Чилэгэр бөхөд хаягдсан өрх гэр цөөн албат зарц нь хэрэйдийн Жаха-Хамбын олз болжээ. Чилэгэр бөхийн нялх хөвүүд, аваль эмсийг хүйс тэмтэрч харин зарц шивэгчид нь Жаха-Хамбын гэрт хүргэгджээ.

Жаха-Хамбуд олзлогдсоноос хойш зургаан сарын хойно Шихүр бүсгүй хөвүүн төрүүлсэн нь үнэхээр Чилэгэр бөхийн үр мөн байв.

Чилэгэр бөх гэрийн дотор ёсолж авсан хоёр эмтэй, дээр нь булаагдсан Бөртийг авчирсан ч зүс цэвэр шивэгчин Шихүрийг хүчирхийлэн эдэлж байсныг батлан Бичэлдэйн эцэг Бүргий төржээ.

Жаха-Хамбу өөрийн цэргийн зуутын ноён Хэрсэнд Шихүрийг шагнан өгчээ. Хэрсэнгийн ивээлд орсон Шихүр азгүй төрсөн эмийн ёсоор үйлээ дагав. Хэрсэн догшин сүртэй ч зөөлөн сэтгэлтэйн дээр залуу, царай зүс цэвэр Шихүрийг таалжээ.

Хэрсэн Бүргий хөвүүнд нь ер хатуу сэтгэл гаргасангүй харгалзан өсгөв.

Шихүр, Бүргий хөвүүнээ мэргэдийн Чилгэр бөхийн үр гэдгийг тас нуув. Эс нуувал нялх үрд нь үхэл ирнэ гэдгийг сайн мэднэ. Ерөөс Бүргий хөвүүн нь мэргэд удамтайгаа ч мартаасай гэж хүсжээ. Харин Бүргий хөвүүн нь Хэрсэнгийн ачаар мэргэд гэж ад үзэгдэлгүй өсч удалгүй Тоорил хан дарагдахад тэд бүгдээр Жаха-Хамбу эзнийхээ хамт Чингис хаанд дагаж иржээ.

Энэ үеэс Шихүр холоос ч болов Бөртийн барааг харах болов.

Бас Чилэгэр бөхийн үр Зүчи гарамгай баатар эр болсныг ч үзэв.

Шихүр хэдийгээр харц шивэгчин заяатай, Хэрсэнгийн татвар эм болсон ч гэлээ тийм ч амар хялбар, алмай наазгай хүн биш байжээ. Тэр аливаад ухаан сэргэг хандаж үүсч бий болсон нөхцөлд түргэн дасаж зохицдог бүсгүй юм. Тийм ч учраас өөрийн эзэн Чилэгэр бөхтэй хормой хотоор холбогдож, түүнийг Тэмүжинд алуулсны хойно олзлон авсан Хэрэйдийн Жаха Хамбу ноёны албат Хэрсэнгийн сэтгэлийг татан итгэлийг авч татвар эмийн эрхийг олоод

Хэрсэнгийн хүү охин хоёрыг төрүүлж өрх гэр, өмч малтай ч болжээ.

Шихүр хүүхдүүд дундаасаа Чилэгэр бөхийн үр Бүргий хөвүүнээ амиа тавин хайрлаж түүнийг мэргэд гэж ад үзэгдэх вий гэж алалдахаас бусдыг үзсэн нь яг л Бөртэ Зүчи хөвүүнээ хайрлахтай эгээ адил байв.

Ингэж бие биенээ мэдэхгүй хоёр хөвүүн, үйлт Чилэгэр бөхийн хоёр үр Чингис хааны улсад өсч, үржин өнөө хүрчээ. Зүчийн алдар нэр түгэх бүр Шихүр Бүргий хөвүүнийхээ төлөө санаа зовон түгших, атаархах нь нэмэгддэг байжээ.

Учир нь Бүргий хэдий зоригтой сайн эр болсон ч асарсан эцэг Хэрсэнгийн дор зуутын захирагчаас үл хэтэрнэ. Гэтэл Бүргийтэй яг адил Чилэгэр бөхийн үр Зүчи их Чингис хааны ахмад хөвүүн гэгдэж, алдар нь цууриатсан их жанжин байх нь дэндүү шударга биш санагддаг байв.

Гэтэл өчүүхэн муу эм Шихүр юу хийж чадах билээ. Их хатан Бөртэд ойртож бараалхана гэдэг Шихүрт наранд хүрч, саранд сарвайхтай адил. Бас Хэрсэнгийн нутаг Туул, Орхоны билчэрт тул гэрийн эм Шихүрт дэндүү алс байжээ.

Тэмүжинг их хаанд өргөмжлөх өргөн ёслолын үеэр Бөртэ хатныг тэртээ алсаас ганц удаа барааг нь олж харсан билээ.

Бөртэ хатан түүнд яавч муугаар хандахгүй гэж тэр бодно. Гэвч Шихүрийг Чилэгэр бөхийн үрийг төрүүлснийг Бөртэ хатан хэрхэн хүлээн авах нь сэжигтэй тул эргэлзэж байжээ. Осолдвол Бүргий хөвүүн нь амьгүй ч болж мэднэ. Бүргийг Чилэгэр бөхийн үр гэдгийг мэдвэл Бөртэ яаж ч мэдэх билээ. Энэ бодлоос болж Шихүр яахаа ч мэдэхгүй болоод ойд төөрсөн мэт явтал гай ирж Бүргий хөвүүн нь Алтан улсад яваад амиа алдав.

Бүргийн хөвүүн Бичэлдэйг Шихүр өсгөж хүн болгосон билээ. Тэгээд хэдэн сарын өмнө үхэхдээ Бичэлдэй ачдаа энэ бүх явдлыг ярьж Бөртэ хатанд очиж мөргөхийг гэрээслэжээ. Энэ ёсоор Бичэлдэй өнөөдөр Бөртэд бараалхжээ. Шихүр үхвэл Бичэлдэй ертөнц дээр орь ганцаар үлдэх юм.

Гэтэл түүний цус нэгтэй авга нь ганц Зүчи тул үхсэн ч, сэхсэн ч түүнийг дагахыг эмэг эх нь шаарджээ. Үнэнээ хэлж очвол Бөртэ эрхбиш эм хүн учир ач хөвүүнийг нь хайрлах биз гэж бодсондоо Шихүр ингэжээ. Эцгээс өнчирч бас түшиг тулгуур эмэг эх нь үхсэнд үнсэнд хаягдсан шалз шиг болсон Бичэлдэйд эмэг эхийн үнэмшилгүй боловч үгийг дагахаас өөр арга үлдсэнгүй. Өмнөө суугаа, Батын үеийн идэр хөвүүн Бичэлдэйн үгийг төгс итгэхэд бэрх ч бас худал гэж няцаах хүсэл Бөртэд хүчтэй төрөхгүй байлаа.

Бичэлдэйн урт ярианы дараа Бөртэ дуугүй хэсэг суув.

-Шихүр надад өөр юу хэлэв.

-Бөртэ хатан надад лав сайнаар хандаж, дурсан санах биз. Би Бөртэ хатныг мэргэдэд булаагдаж ирэхэд эхний хэдэн шөнө дандаа цуг хонодог байлаа. Бөртэ хатан ганцхан миний

дэргэд л нулимсаа урсган уйлдаг. Өөр хүний дэргэд уйлдаггүй, хатуу зоригтой хүн байсан юм. Би Бөртэ хатны нулимсыг үзээд тэсэлгүй уйлдагсан. Хүн ирэх чимээнээр бид хоёр нулимсаа арчиж нүүрээ яаран цэвэрлэдэгсэн. Ингэж байхдаа бас болоогүй бие биеээ шоолон инээж чаддаг байлаа. Мөн ч залуу гэнэн тэнэг байжээ. Энэ явдлыг ганцхан Бөртэ хатан бид хоёр л мэдэх юм. Хэрэв Бөртэ хатан чиний үгэнд үл итгэн эргэлзвэл чи энэ үгийг хэлээрэй гэсэн дээ гэж Бичэлдэй гүн санаа алджээ.

Ийм үг сонсмогц Бөртэ, Бичэлдэйн ярьсанд эргэлзэхгүй итгэв. Энэ явдлыг ганцхан Шихүр л мэдэх билээ. Одоо ч тэр цаг нүдэнд харагдах шиг болж зүрх нь догдлон чичирлээ. Шихүрийг гэнэт өрөвдөн харамсаж нулимс нь цийлэлзэн нүд дүүрэв.

-Шихүр эртхэн надад ирэхгүй яав. Би түүнийг асарч хамгаалах байв. Би Шихүрт өртэй хоцорчээ гэж Бөртэ гуниглан хэлжээ.

- Эмэг эх өөрийгөө үхнэ гэж бодоогүй биз. Эмнэг гүү саах гээд өшиглүүлж үхсэн. Харин үхэхийн өмнө надад энэ бүгдийг ярьсан юм.

-Би одоо чамд яаж туслана. Би сайн эмэг эхийн чинь ачийг санаж чамд туслая гэж Бөртэ эргэлзэх юмгүй хэллээ. Бөртэ энэ өнчин хөвүүнд туслая үнэн санаанаас хүсэв. Чилэгэр бөхийн үр болж төрсөн нь юуны буруу билээ.

-Хүү минь. Чи юу хүснэ. Надад хэл.

-Бөртэ хатан ижээ гэж Бичэлдэй итгэлтэйгээр хэлэв. Энэ үг Бөртийг догдлуулав.

-Бичэлдэй бүү эрээл. Чи одоо намайг эмэг эх Шихүрийгээ гэж бод.

-Би эмэг эхийнхээ хүссэнээр Зүчи авгын дэргэд шадарлан зүтгэж нэг удам угсаагаа батлан явахыг хүснэ. Би өвсөн дунд хаяж орхисон өнчин тэвнэ шиг үрэгдэхийг үл хүснэ. Бичэлдэйг ингэж хэлнэ чинээ дааанч санаагүйдээ Бөртэ өөрийгөө ихэд голов.

Хүний хүсэлд хязгаар гэж үгүй болохыг, хүсч мөрөөдөхөд айж ичих зүйл өчүүхэн ч үгүй болохыг Бөртэ үзэв.

Идэр Бичэлдэйн энэ хүслийг Бөртэ буруушаан шүүмжлээгүй ч шууд дэмжин ам алдаж чадсангүй.

-Чи энэ үгээ, өөрийн мэргэд гарлаа надаас өөр хэнд ч бүү хэлэгтүн. Би чамайг сүүлд дуудаж уулзана гэхээс өөр үг дахин хэлж төвдсөнгүй гаргав.

Зүчи хөвүүний нь цус нэгт төрөл гэнэт гарч ирсэн нь Бөртийг эхлээд өрөвдөх сэтгэлд автуулж эцэст нь айлгах юм гэж санасангүй. Цусан төрөл гарч ирснээс илүү тэр Бичэлдэй өөрийгөө Зүчи болоод Батын адил үзэж, зэрэгцэн суух хүслээр дүүрэн байгаа нь бөөн эргэлзээ, бараан бодолд оруулжээ.

Чухам юунд түгшиж, сэтгэл зовсноо сайн ойлгож мэдсэнгүй.

Амьдралдаа үзсэн гунигт түүхийг сөхөж, нууц шархыг дахин сэдрээсэн энэ явдалд Бөртэ ингэж цочирдон шанална гэж бодсонгүй. Төрсөн эхийндээ очоод ирсэн Бат, Бөртэ эмгийнхээ царайг үзмэгц дуу алдав.

-Та өвчин тусаа юу гэж Бат түгшив. Бичэлдэйн тухай Бөртэ хэнд ярих билээ. Ганц өөрийн сэтгэлдээ хураан хуримтлуулсан бодол эргэлзээ нь туйлдуулж Батыг үзмэгц тэнцвэр алдав.

-Хөвүүн минь. Чи сонс. Бөртийн дуу хүн танихын аргагүй өөр сонсогджээ.

Бат эмэг эхийнхээ эл хачин байдалд сандарч цочив. Бөртэ эмэг нь хэзээ ч ийм ядруу дорой байсныг тэр үзсэнгүй.

-Та юу болов. Хэлээч Хар багаас хайрлаж өсгөсөн тул Бөртэ, Бат хоёр бүхнээс илүү дотно, өөриймсөг харьцаатай юм. Бөртэ бол Батын хувьд хамгийн хайртай, эрхэлж өссөн хүн нь билээ. Хайртай эмэг эх нь ийн гуниг зовлонд учирсныг үзээд Бат үнэн сэтгэлээс сандарч айжээ.

-Хөвүүн минь. Бүү санаа зов. Надад ямар нэг зовлон учирсангүй. Харин чамайг буцахыг бодохоор чамтай бас эцэгтэй чинь дахин уулзахгүй мэт санагдаад...

-Бөртэ ижээ. Та юун ойрхон юм бодно. Би таныг өөрийн улсад аваачна. Бүр Каспийн тэнгисийн зөөлөн салхинд сууж, тэнгисийн усанд хөвүүлнэ. Та ер тийм их ус үзээгүй биз. Аав ч удахгүй бас ирнэ. Та ийм ялигүй олиггүй бодолд бүү авт гэж Бат энгүүн хөхүүнээр инээжээ. Нээрээ Зүчи хөвүүнтэйгээ дахин уулзахгүй гэж муу ёрлоод гэж Бөртэ өөрийгөө зэмлэв. Уйтгарлаж, түгшсэнээ нуух гэсэндээ, бас өөрийнхөө энэ уруу дорой байгааг зөвтгөх гэсэндээ хэлсэн энэ үг нь дэмий хэрэг болжээ. Чингис хаан Хорезмыг дагуулж дуусаад эргэн ирэхэд лав Зүчи ирнэ.

Харин Батад Бичэлдэйн тухай хэлэх үү, үгүй юу гэдгийгээ л шийдэж ядан бодсоор байжээ. Эцэст нь хэлэхээр шийдэв. Энэ бол явж явж Бөртийн мэдэж шийдэх ч хэрэг биш, Зүчийн л мэдэх хэрэг юм. Тэгээд энэ тухай хэлүүлэх итгэлтэй сайн элч Батаас өөр хэн байх билээ. Гадна хөндлөнгийн хүнд яаж Бичэлдэйн тухай хэлж болно. Батад учрыг сайтар хэлэх нь зөв байлаа.

Бат идээ будаагаар дайлуулж эцгийн орноос хүндлүүлж суух зуур Бөртэ хэлэх үгээ сайтар тунгаан бодож авчээ. Бат сая ирэхдээ Гертаг Уги хатан эхийнхээ дэргэд үлдээжээ. Олон хоногийн явдлын аяыг тэр бүсгүй яахан тэсэж чадах билээ.

-Бат минь. Хүү чи сонс. Чи бол Зүчи эцгийнхээ хамгийн хайртай хөвүүн. Чингис хааны онцлон тоодог ач хүү шүү. Эмэг эхийн энэ тойруу холын үг нэг чухал зүйл ярихыг ойлгуулав. Тийм болохоор эмэг эхийнхээ дараагийн үгийг Бат анхааран хүлээв.

-Би чамд нэгэн зүйл хэлье. Чи сайн тогтоож ав. Бас гадагш бүү задруул. Нэг ч үг гээлгүйгээр эцэгтээ хэлээрэй. Бичэлдэйн тухай яриаг Бат таг дуугүй сууж сонсов.

Эцэг нь, түүнээс үүдээд Бат өөрөө ямар гарал, цустайгаа тэр сайн мэднэ. Хэн ч түүнийг

мэргэд гэж дурдаж,ад шоо үздэггүй ч эцэг Зүчи болоод Бат өөрөө Их Монгол улсын их хаанд өргөмжлөгдөх эрхгүй болсноо ч мэднэ. Тийм болохоор энэ тухай яриа Батыг нэг их цочоосонгүй. Харин цус нэгтэй үеэл ах гарч ирсэнд баярлах, бухимдахын аль нь болохыг мэдээгүй ч сэтгэлийн дотор үл мэдэгдэх утас доргиж, зүрх нь түргэнээ түг түг цохилохыг мэдрэв.

Үеэл ахтай гэдгээ мэдэх нь тун чиг сонсголтой бөгөөд ямар хүн байгаа бол гэсэн сониуч бодол хүчтэй төржээ. Цусан төрлийн хөвүүн бийг сонсоод Бат Бөртийн бодсон шиг цочирдож гайхаагүй нь Бөртийг харин тайвшруулжээ. Өөрийн цусан гарлыг Бат, Зүчи эцгийнхээ адил эмзэг гүнзгий авч үздэггүй болохыг энэ явдал гэрчилжээ.

Ер нь цаашдаа Зүчийн энэ гарал Батын үр хүүхдийн үед бүр ч мартагдах мэт санагдсан нь Бөртэ Бичэлдэйг хэрхэхээ шийдэхэд туслав.

-Бат. Би чамд тэр Бичэлдэйг өгч явуулъя. Чи эцэгтээ аваачиж өг. Хэрхэхийг Зүчи шийдэг гэв.

-Харин та юу гэж бодно. Бичэлдэйг яах нь зөв бол гэж угийн сэргэлэн Бат асуув. Бөртийн үг Зүчи эцэгт нь лав хүчтэй нөлөөлнө гэдгийг Бат мэдэх тул ингэж асуужээ. Түүнийг буцаж очоод Бичэлдэйн тухай хэлэхэд хамгийн түрүүнд

-Бөртэ ижий юу гэв гэж эцэг нь лав асуух нь гарцаагүй билээ.

-Чиний хаан өвөг, Билгүтэй авга хоёр чинь эх өөртэй эцэг нэгтэй ах дүүс юм. Билгүтэй авга чинь Чингис хаанд яаж зүтгэснийг та нар лав мэдэх биз. Яг үүний адил энэ Бичэлдэй бол чиний эцэг нэгтэй эх өөртэй ах чинь болно. Бичэлдэй чамд яг Билгүтэй, Чингис хаанд зүтгэсэн шиг зүтгээсэй гэж би хүсч байна. Бичэлдэй цус нэгтэй учир чамд хэн хүнээс илүү үнэнч зүтгэх биз. Би түүнд ингэж хэлнэ. Тэр чамд яг л Тату шиг зүтгэг.

Эмэг эхийн энэ үг Батад туйлын дотно, итгэлтэй санагдав. Тату Ургенчид үрэгдсэнийг Бат хэлээгүй юм.

Үнэнч боол Тату үхсэн мэт яс үс ч олдохгүй болсонд Бат одоо ч харамссаар бас түүний үхэлд илгээв гэж өөрийгөө буруутгасаар байсан тул Бичэлдэйг үнэнч зүтгүүлэх гэсэн эмэг эхийн ухааныг шууд дэмжин зөвшөөрөв. Үнэнч нөхөр дэргэд байх хичнээн хэрэгтэйг Бат сайн мэдэх билээ. Сайн нөхөр, үнэнч боол Татугаа алдаж өнчирсөн Батад Бичэлдэйг өөрийн нөхөр болгох хүсэл оргилжээ. Үзэж, танихгүй ч энэ Бичэлдэй Тату шиг үнэнч зүтгээсэй гэж Бат хүсэв.

Тийм учраас

-Би Бичэлдэйтэй хэзээ уулзана. Ямар хүн болохыг би үзмээр байна гэж Бат яаран догдлов.

-Би түүнийг дуудуулсан. Одоо ирнэ. Нэгэнт л цус нэгтэйн учир Бат, Бичэлдэй хоёр харваас л адил төстэй үзэгдэх нь тэднийг тун ч их догдлуулжээ. Харин Бичэлдэй биеэ барьж чадаад эгц ширтэн зогсох нь Батад ч, Бөртэд ч таалагджээ .Бичэлдэй Батаас хоёр насаар ах ажээ.

Бат Монголоос “Алтан ордонд” эргэн ирснийхээ маргааш нь Бичэлдэйн тухай эцэгтээ хэлжээ.

Зүчи хатад, хөвүүд нь, бас албат иргэд нь Монголоос ирэхийг сонсоод хөөрөн догдолсон байв. Эцгийн сэтгэлийн догдолыг дарагдахыг Бат хүлээж нэг хоножээ. Каспийн тэнгисийн зөөлөн долгилохыг харж суугаад Бат эцэгтээ Бөртэ ижийн хэлснийг бүгдийг нэг ч үг гээж орхигдуулалгүй хэлэв.

Бас зам зуур Бичэлдэй түүнд их л дотно сайхан санагдаж, эцэг нь татгалзахгүй бол өөрийн дэргэд авч шадар нөхрийн адил үзэж явахаа ч хэлжээ. Зүчи таг дуугүй суусаар байлаа. Бичэлдэйн тухай сонсоод эцэг нь хөөрөн догдлоно гэж Бат залуу хүний гэгээн дэврүүн сэтгэлээр бодож итгэсэн тул эцэг нь ингэж хүрэн царайлан суухыг үзээд гайхжээ.

Бичэлдэйн гэнэт гарч ирсэн нь Зүчийн дотор ямар гэгч догшин шуурга үүсгэснийг Бат олж харж чадахгүй байв.

-Бат чи юунд нь итгэтлээ баясан инээд алдана. Чи энэ Бичэлдэй гэгчийг хэн гэж санав гэж Зүчи үгээ зөөж, ял асуух мэт тод заналтай дуугаар гэнэт зандрав.

Эцгийнхээ хилэн бадарсан шалтгааныг Бат ойлгосонгүй тул

-Аав аа, энэ Бичэлдэй миний үеэл ах биш гэж үү гэж хэлээд эцгийгээ босон харайхад амаа хамхиж амжсангүй таг болов.

Зүчийн нүд аяганаас бүлт үсрэх нь үү гэмээр дүрлийж хөвүүнээ хурга шүүрэх бүргэдийн адил заамдан аваад сэгсчив.

Эцгээ ингэж уурлахыг бас түүнд ингэж гар хүрэхийг анх удаа үзсэн Бат айж бас гайхжээ.

-Чамайг ингэж ярихыг би хориглоно. Юун мэргэд ... Тэр мэргэд чинь сүйрч сөнөсөн. Одоо энэ ертөнцөд ... ганцхан их улс байгаа. Энэ бол Их Монгол улс. Чи тэр мэргэдийг март. Тэр Бичэлдэй билүү хэн гэнэ түүнийг март. Чи бол Чингис хааны ач хөвүүн ... гэж хашгирч хөвүүнээ тэнгисийн эргийн зөөлөн дулаан элсэн дээр савж унатал алгадаад мордон давхиж оджээ.

Бат, эцгийнхээ хилэгнэсэн учрыг сая л ойлгов. Эцэг нь өөрийгөө Чингис хааны хөвүүн байлгахыг хүссээр ажээ. Батыг Чингис хааны ач хүү гэж батлахын төлөө үүнийг хэлжээ. Бат ингэж эцгийнхээ чанад алсын зорилгыг сая л нэг гүйцэд ойлгож туйлын халуунаар уяран уйлав.

Эцэг нь ганцхан Батыг Чингис хааны ач хүү гэдгийг нотлохын төлөө өөрийгөө золиослож яваа болохыг сая л ойлгов. Тийм ээ, Зүчи яг ингэж бодсон юм. Ургенчийн төлөөх тулаанд цэргээ түүнд өгсний цаад учрыг ч олов.

Бат элсэн дээрээс босохдоо огт өөр хүн болжээ. Түүний зорилго дэндүү тод ойлгомжтой ажээ. Чингис хаан бол ертөнцийн эзэн юм. Гэтэл Чингис хаан эцгийг нь өөрийн ууган

хөвүүн гэж үзэж хаан ороо залгамжлуулсангүй. Тэгвэл энэ алдсан суудлыг Бат л олж авах ёстой биш үү. Үүний тулд Бат мэргэд удмынхаа тухай санах ч хэрэггүй юм. Ганц Бат ч биш бүгд мартах ёстой. Бүр мартуулах ёстойг Бат тодорхой ойлгов. Эцгийн хилэн бадарсаны учир энэ байжээ. Бат өөрийгөө ихэд голж, бас эцэгтээ талархав. Гэвч Бат бас олон зүйлийн учрыг олж, хужрыг тунгааж чадахгүй байлаа.

Өөрийн мэргэд цустайд Бат эцгийнхээ адил харамсан гашуудаж гутардаггүй юм.

Яагаад гэвэл энэ цустай төрснөөсөө болж алдсан юм Батад үгүй, ядаж өсөхөд нь хэн ч түүнийг дарлаж гадуурхаж зовоосонгүй билээ. Гэвч эцгийгээ Чингис хааны ард хаан орыг залгамжлах ёстой хүн гэж үздэг ч нэгэнт эцэг нь мэргэд цустай тул Чингис хаан Өгөдэйг өөрийн залгамжлагчаар сонгосныг зөв гэж дотроо бодож байсан билээ.

Харин Батад Чингис хааны ард түүнийг залгамжлан суухаас илүүтэй өөрийн улсыг үүсэн байгуулах нь бахархалтай, ганц мөрөөдөл болсон үйл хэрэг нь юм. Бат хэзээ нэгэн цагт их цэргээ удирдан довтолж Герта бүсгүйн ярьдаг Орос улсыг эзлэн авч Днепр, Урал, Ижил гурван мөрнөөс цааш бүр баруун зүгт байх Их далайд хүрэхийг хүсч байв.

Тийм учраас Каспийн тэнгисийн эргийн энэ нутгийг эзлэн хүчирхэгжин суух эцгийн бодлыг туйлаас дэмжинэ. Энэ нутаг бол Урал, Ижил, Днепр мөрний сав газрыг довтлоход хамгийн ашигтай байрлал юм. Ийм нутгийг олж суусан эцгийн алс ухааныг биширнэ. Энэ нутаг Батыг тогтоон барих эцсийн нутаг биш гэдгийг ч ойлгоно.

Бат Герта бүсгүйн адил өсгөлүүн биетэй, өндөр хамартай, өтгөн шаргал үстэй бүсгүйчүүл суудаг баруун, хойт зүгт сэтгэл татагдаж байлаа. Бат урьд үзээгүй шинэ нутгийг эзлэн авч их улсаа байгуулан алдар нэрээ Чингис хаан мэт дуурсгахыг хүсч байв. Ийм хүслээ биелүүлэхсэн гэхэд цаг хугацаа дэндүү удаан өнгөрч тэсч ядахдаа эцэг нь ч саадтай санагдан элдвийг бодсон удаатай. Бат үнэхээр яарч байлаа.

Харин цус нэгт үеэл Бичэлдэйн гарч ирсэн нь Батыг эцгийгээ ихээр хүндлэхэд хүргэв. Тийм учраас өнөөдөр түүний төлөө амиа өргөх ганц хүн нь эцгийгээ гэдгийг ч гүнзгий ойлгов. Ийн бодоход тэр даруй мордон эцгийн “Алтан ордон” руу давхижээ.

Ийм бахархалтай давхиж явахдаа хожим хойно их улсаа байгуулж, түүнийгээ сайн эцгийн дурсгал болгон “Алтан ордны улс” гэж нэрлэе гэж Бат шийджээ.

Харин эцгийн хүсэл нь энд Каспийн тэнгисийн эрэг дээр өөрийн “Алтан ордон” хэмээх хот босгох явдал байлаа. Батын их хүслийн дэргэд эцгийн хүссэн нь өчүүхэн ажээ.

Гэвч Бат Зүчи эцгээ бахархан хайрлаж байв.

Бөртэ ижийн нь илгээсэн бэлэг Зүчийн сэтгэлийг үнэхээр догдлуулсан билээ. Тэнд ер байхгүй юм алга.

Дуртай ааруул, сэнгэнэсэн айраг, баавгайн доньт, бугын зуулт юу эс байхгүй гэх билээ. Харин Зүчийн сэвлэгийг алтан хуудсанд боож илгээснийг үзээд бүр ч уярав. Зүчийг таван нас

хүрэхэд найр хийж сэвлэгийг нь үргээснийг саналаа. Энэ бол Ононы эрэгт болсон явдал юм. Бас энэ найранд Жүрхэн аймгийн ихэс уригдаж шөнө нь бөөн хэрүүл зодоон болсныг ч санав.

Бөртэ эхийнх нь үнэр сэнгэнэх сэвлэгээ үнэрлэн суухад нь Бат орж иржээ. Эцгийн хилэн дарагдаж одоо тайвширчээ.

Өргөөнд тал нутгийн агь ганга, айраг цагааны үнэр ханх тавьж байв.

-Би таван настай байжээ гэж Зүчи инээмсэглэв. Эцэг нь тайвширч инээмсэглэж суухыг ашиглан Бат өөрийн алдааг засч авахыг хичээв.

-Аав аа. Та намайг өршөө. Би Бичэлдэйн талаар дэмий үг хэлжээ. Би их бодлоо. Таны хэлснийг зөв гэж бодно. Би Чингис хааны ач хүү юм. Би үүнийг батална. Та бүү эргэлз гэж сөхрөв. Зүчи, Бат хөвүүнийхээ ухаантай үгийг ойшоон сэтгэл тэнэгэр сонсов.

Хүү, эцэг хоёр бие биеийн хүслийг ойлгож байлаа.

Ийм сайн хөвүүн төрүүлж өгсөн байтал би Уги хатнаа дэмий зовоожээ гэж бодов. Зүчийг арван зургаа хүрэхэд Бөртэ эх нь өөрийн төрөлх Хонгирад аймгаас Угийг хатан болгон авч өгсөн билээ. Анх үзээд л тарган цулцгар Уги Зүчид таашаагдсангүй. Харин хөвүүнээ айл болгож бие даалгах гэсэн эхийнхээ хүслийг дагахаас өөр зам Зүчид үгүй билээ. Угид огтхон ч сэтгэлгүйн дээр хүүхэд төрүүлэхгүй удсан нь Зүчийг ингэж хүйтэн хөндий болгосон билээ.

Харин Зүчийг хорин зургаатай байхад төрсөн Батыг Бөртэ Угигаас бараг л булаан авсан юм.

Батыг хайрлах халамжлах хүн Бөртэ болоод Уги эх нь гэдэг нь бараг мартагдах шахаж Бат эхийгээ төдийлөн ойшоож үзэлгүй өссөн билээ. Бат хөвүүн нь Зүчийг сүрхий дуурисан, эгц өндөр нуруутай, сэргэлэн гавшгай эр болон өссөн нь үзтэл Чингис хааны ач нарын сор нь болжээ. Харин Угийн хойно Зүчи Найманы Буйраг ханы удмын эм авч бас Алтан улсын хааны Агч гүнжийг Чингис хаан түүнд өгчээ.

Харин энд Каспийн тэнгисийн зүүн эргийн Алтан ордонд түүний дэргэд түрэг угсааны бага хатан Тод-Ханум байв. Тод- Ханум бол дөрвөн жилийн өмнө Чингис хааны цэрэгт буун өгсөн Хорезмын зүүн хилийн хот Хожент балгасын захирагч Махтур-ужийн охин юм. Махтуруж түрэг угсаатан тул Чингис хааны илгээсэн элчийн үгэнд орж хотоо эсэргүүцэлгүйгээр өгч бага охин арван таван настай Тод-Ханумаа Чингис хааны ууган хөвүүн Зүчид бэлэглэн ураг барилджээ.

Одоо Тод-Ханум бие тулгар тул өдрийг асрагч нарын халамжинд өнгөрөөж байв. Махтур-уж хорезмын эзлэгдсэн нутгаас дайчлагдсан цэргийг захирах болжээ. Харин Зүчийн бусад хатад үр хүүхэд нь Монголоос нүүж одоо нэгэнт Или, Чүй мөрнийг гаталж зам зуур монголын их цэргийн өмнө буун өгч дагаар орсон Хар Кидан улсын хуучин нийслэл Хос балгаст амсхийж байлаа. Тэд энд иртэл дахиад даруй гурван сарын явдал бий.

Зүчи одоо тэдэнд биш Бөртэ эхийнхээ илгээсэн Бичэлдэйг хэрхэх билээ гэж ухаанаа уудалж хол ойрыг бодож суув.

Бичэлдэйг илгээж бүх учрыг Батаас нуулгүйгээр өчсөн эхийнхээ энэ хачин авирт эхлээд гайхсан билээ.

Гайхаад ч зогссонгүй хамгийн эмзэг нууцыг Бат хөвүүнд нь тоочсонд хилэн бадарсан юм.

Зүчи Бөртэ эхдээ гаргасан уураа Бат хөвүүндээ гаргасан байжээ. Хайртай хөвүүндээ гар хүрч орхин давхиж одсондоо сүүлд нь ихэд харамссан ч сая Бат ирж өршөөл эрсэнд тайтгараад дахиад хөвүүнээ гомдоохгүй гэж дотроо тангараглаж суув.

Эх нь Бичэлдэйг илгээхдээ Батаар хэлүүлсэн үгийг дахин санав. Чингис хааны эцэг нэгтэй эх өөртэй дүү Билгүтэйн тухай дурдсан нь Бичэлдэйг Батад өгөхийг шаардсан хэрэг юм. Бат ч Бичэлдэйг дэргэдээ авахаас татгалзахгүй гэжээ. Чилэгэр бөхийн бас нэг удам гарч ирснийг илгээсэн нь эх нь Зүчийн удмыг нэгэнт хүлээн зөвшөөрч байгаа бас ивээлдээ авахыг даалгасантай адил байв.

Эх нь хөгширч залуу зандан үеийн тэвчээр зориг үгүй болсныг Зүчи ойлгов.

Хэдэн жилийн өмнө хэн нэгэн би мэргэдийн Чилэгэр бөхийн хөвүүн, түүний үр гэвэл чухам тэр хүнийг эх нь улаан гараар тасчин хаях байсан биз. Харин одоо тэгсэнгүй. Эхийнхээ энэ үйлдлийн цаад санааг ойлгох гэж Зүчи ихэд хичээв. Чингис хаан эцгээсээ тусдаа суухад Зүчид чин үнэнч хүн хэрэгтэй гэдгийг эх нь хэлжээ.

Цусан гарал нэгтэй Бичэлдэйг үнэнч зүтгүүлэхэд дөхөм гэсэн үг юм. Бас Чилэгэр бөхийн үр удам үржиж, амьдраасай гэж хүссэн мэт. Үгүй бол Зүчийн адил алдаршиж мөнхрөөсэй гэсэн мэт.

Бичэлдэйг илгээсэн нь нэгэнт бүхэнд ил болсон тул Зүчийг өөрийн мэргэд цуснаас бүү ичиж эмээ гэсэн захиас ч юм шиг ойлгогдохоор ажээ.

Бодож үзээд Бичэлдэйг илгээсэн нь түүнийг Чингис хаанаас нэгэнт хараат биш, тусгаар явахыг шууд сайшаасан явдал гэж Зүчи ойлгожээ. Бөртэ эхийнхээ чин үнэн санааг Зүчи зөв мэджээ. Бөртэ хэдий Батад хэлээгүй ч дотроо яг ингэж бодсон билээ.

Зүчи хөвүүн нь нэгэнт өөрийн тусгаар улсыг байгуулах цаг болсон гэж үзсэн учраас Билгүтэйн тухай дурдан Бичэлдэйг үнэнч зүтгүүл гэж хэлжээ. Зүчи нэгэнт Чингис хааны төрсөн үр биш учраас одоо Чингис хаанаас тусгаарлахад саад болох зүйлгүй болжээ. Бөртэ эх нь түүнийг олон жил өмгөөлж хамгаалж ирсэн бөгөөд одоо цаашид хэрхэхийг өөрөө мэд гэж Бичэлдэйг гэрээс мэт илгээжээ. Зүчи эхтэйгээ уулзалгүй даруй таван жил дөхжээ. Энэ нь Монголын их цэрэг Хорезм улстай дайтахаар гарснаас хойш юм. Батын үгээр бол эх нь их л өтөлж бие нь ч бас сайнгүй бололтой.

Болдогсон бол Зүчи эх нутаг руугаа өнөө ч хамаагүй давхин очмоор ажээ.

Гэвч эзлэн суусан нутгийн бүх хот дайны хөлд эвдрэн нурсан, аж ахуй, ардын амьдрал, мөргөлийн үйлийг сэргээн хуучин хэвэнд нь оруулах гээд дор дороос ундрах их ажлаа хаяж яахан одох билээ.

Бас зарим нэг хот балгаст түүний цэргийг эсэргүүцэн тэмцэж бослого самуун гарах нь элбэг тул хар нүд хамхиж болохгүй байлаа. Нутгийн иргэдээс дайчилсан цэрэг үнэнч сэтгэлгүй, өөрийн ардын эсрэг хөдөлгөхөд хуурамч хуумгай хандаж, хуйвалдан үгсэх аюултай нь цөөн Монгол цэргийн хүчийг тарамдуулна. Яг ийм явдал эзлэн авсан Зарнук балгаст болж, тэнд байсан цэргийн монгол жанжинг дайчилсан цэргүүд самууран алсан хэрэг мандсан нь Зүчийг түгшүүлсэн билээ.

Хэрэв Зүчи мөч алдан алмайрвал Хорезмын иргэд түүнийг эсэргүүцэн босоход бэлэн байгаа нь яг л шатдаг тостой торхон дээр суусан мэт болгоно. Нутгийн иргэд бүгдээр Зүчийг булаан эзлэгч гэж үзэх ажээ. Харин Зүчи тэгэж бодсонгүй тул татвараа бууруулах, лал болоод загалмайн шүтлэгтнүүдийн мөргөл хийхийг чөлөөтэй болгох зэрэг аль болох нутгийн ард иргэдэд таалагдах арга сэдэж байв.

Ямартай ч эзлэн суусан нутгийн хэмжээнд хилийн харуул байгуулж, хотуудад тус тусын хотоос олны хүндлэл хүлээсэн ахмадуудаас шилж захирагч томилсон нь хамгийн зөв алхам болжээ.

Зүчийн тусгаар улс байгуулах хэрэг бага боловч ахиж урагшилсаар, нутгийн иргэд Зүчийг өөрийн хаан гэж үзэх нь олширсоор байжээ. Энэ бол 1224 оны өвлийн эхэн сар юм.

Харин Бичэлдэйтэй Зүчи уулзсангүй. Учир нь Зүчи өөрийн удмыг дахин санах, тэр тухай хэн нэгэн санах, мэдэхийг огт хүссэнгүй. Батыг дуудаж түүнд хатуу тушаав.

-Бат. Чи Бичэлдэйг өөрийн гараар хэнд ч мэдэгдэлгүй үхүүл. Зүчийн энэ хатуу үгийг сонсоод Бат дуугүй суусаар байлаа. Нүдэнд дулаахан тэр залуу Батад таалагдах тул эцгийн энэ тушаалыг биелүүлэхэд хэцүү байв. Гэвч эцгийн тушаалыг зөрчих эрх үгүй.

-Бат чи юунд эсэргүүцэх мэт дуугүй сууна гэж Зүчи зандрав.

-Би эсэргүүцэх бодол огт үгүй. Харин яаж алъя гэж бодож байна.

-Чамд яаж ч хайран санагдсан чи түүнийг алагтүн. Энэ бол ганцхан Бат чиний төлөө юм. Хожим хойно миний үхсэний дараа чамд гэнэтийн дайсан дэргэдээс гарахыг би үл хүснэ. . .

Зүчийн энэ үгийг зөвшөөрөхгүй байхын аргагүй юм. Эцэг нь үнэхээр түүний төлөө л үүнийг хийх билээ.

-За би тэр Бичэлдэйн толгойг танд авчирч үзүүлье ...

Бат яг л ингэж боджээ. Бодсоноо үнэнээр хэлэв.

-Би тэр Чилэгэр бөхийн үрийн толгойг үзэхийг хүсэхгүй. Чи түүнийг алж чоно, нохой ухаж гаргаж чадахааргүй гүнд бул. Эсвэл хүүрийг нь шатаа гэж Зүчи бухимдан хашгирав.

-За ...

Би таны хэлснээр хийе. Эцгийн уур хилэнгээс дайжин түргэн зайлахаас өөр арга Батад

байсангүй.

-Байз. Чи хүлээ гэж Зүчи Батыг гарахын даваан дээр хашгирчээ ...

Зүчи хүүгийнхээ дэргэд үсрэн ирж түүнийг багалзуурдан алах нь уу гэмээр нүүр тулан амьсгаадан зогсов.

-Байз. Би тэр Бичэлдэйг өөрийн гараар хөнөөе. Чи үүнийг бүү хий. Тэнгэр чамд хилэгнэж мэднэ. Харин би юунаас айна ...

Чи яв ...

Бат дув дуугүй гарч явлаа. Зүчи үнэхээр Батад муу юм болохоос эмээжээ.

Уур хилэн, үзэн ядахын галд шатсандаа хөвүүндээ гай чирэх шахсанаа тэр ухаарчээ.

Үнэхээр Бат Бичэлдэйг алсан бол Батад гарцаагүй муу юм тохиох байжээ. Эцсийн мөчид Зүчи үүнийг ухаарч хөвүүнээ хайрласан сэтгэл нь аварч тус болов. Бөртэ эхийнхээ үг, гэрээсийг зөрчин тэр шөнө Зүчи Бичэлдэйг цавчин алаад уулын жалганд булж орхив.

Бичэлдэйг алсан ч Зүчийн сэтгэл тайвширсангүй уур цухлаар дүүрсээр ажээ. Эцэст нь үдэш өргөн найр, бүжиг цэнгээн үүсгэв. Турк, перс эмсийн нүцгэн бүжиглэхийг дув дуугүй гөлрөн ширтэж суух эцгээ хараад Бат голоо тасартал өрөвдөн хайрлаж байлаа. Ширүүн огцом зантай ч гайхалтай тэвчээртэй эцэг нь түүнд ямар их хайр, халуун итгэлээ зориулж байдгийг тэр үзэв.

Зүчийн сэтгэл Бичэлдэйг алсандаа харамсан гашуудаж байгааг ганцхан хөвүүн Бат нь мэдэж байв. Магадгүй эцэг нь Бичэлдэйг алахыг огтхон ч хүсээгүй байж магад. Ганцхан түүний ирээдүйн сайн сайхны төлөө өөрийн сэтгэлийг золиослов гэж Бат өрөвдөн бодож суув. Эцгийн сэтгэлийн нууц шаналал хямрал Батыг ч эзэмдэв.

Торгон цэргийн харуул гүйн ирж Чингис хааны элч ирснийг илтгэх хүртэл Зүчи ингэж түүдгийн гал ширтэн суусаар байлаа.

Тэр юунд ингэж харамсаж, хайртай хүнээ үхүүлсэн мэт гунигт автан суугаагаа өөрөө ч ойлгосонгүй.

Сэлэмний хурц ирэн дор гулзасхийн мэдрэгдсэн идэр залуу Бичэлдэйн зөөлөн цогцос одоо болтол атгасан гарын хуруунд мэдрэгдээд болсонгүй. Тэр хөвүүн дөнгөж арван наймтай байжээ.

Хожимдсон хойно юунд тэр амьтныг хөнөөв гэж гаслан бодсоор суув.

-Чингис хааны элч гэж өргөөний даамал хүндэтгэлтэйгээр зарлахад л сая Зүчи толгой өргөн харлаа.

Түүнээс таван алхмын цаана их түүдгийн гэрэлд нэгэн үлэмж биетэй эр зогсоно ...

-Зүчи таны амрыг айлтгая. Би их Чингис хааны захидлыг танд хүргэж ирлээ. Ингэж хэлээд элч үгнийхээ баталгаа болгон Чингис хааны тамгатай тохой урт цул алтан гэрэгээ галын гэрэлд дээш өргөв ...

-Есөнтэй гээд Зүчи өндийв.

Энэ бол Чингис хааны их шадар Урианхайн Зэлмийн хөвүүн Есөнтэй байв. Зүчи тэд тоглож өссөн билээ. Есөнтэй ирсэн нь Зүчийн хувьд баяртай хэрэг болжээ. Зүчи Есөнтэйгөөс дөрөв ах ч тэд чухам нүд нээхээс цуг өссөн билээ. Тэмүжиний хүрээнд Зүчийн хамгийн дотно үерхэн нөхөрлөсөн нь Есөнтэй байлаа. Тэд Зүчийг арван зургаа хүрч цэрэг ахлан мордох хүртэл хамт байжээ. Есөнтэй нас бие гүйцмэгц Чингис хааны торгон цэрэгт орж, 1206 онд шадар торгон цэргийн мянганы ноёноор томилогдон Алтан улс болоод Харлагийг дарахад оролцсон баатар эр билээ.

Зүчийн амьдралын нууцыг хар нялхаас эцгийн амнаас сонсож мэдсэн нь түүнийг Зүчид ингэж дотно нөхөрсөгөөр хандах болгожээ. Багадаа тэр Зүчийг гадуурхагдаж зовохыг нь үзэж ямагт түүнд туслахыг хичээсээр ирсэн юм.

Эцэг Зэлмэ нь ингэхийг Есөнтэйд сургасан билээ. Ер нь Тэмүжинээс бусад бүх хүмүүс бүр Хасар хүртэл Зүчид үргэлж найртай сайхан сэтгэлээр хандаж үргэлж тусалж дэмжихийг хүсдэг байсан нь Бөртийн ухаан, тэвчээрийг хүндэтгэж байдгийн илрэл байв. Зовсон ядарсанд туслах нь ерөөсөө монгол хүний төрөлх шинж биз ээ.

Харин Хорезмд ирснээс хойш Зүчи, Есөнтэй хоёр уулзалгүй гурван жил гаран болжээ. Тэдэнд ярих юм даанч их байлаа. Бүжиг найраа орхин тэд Зүчийн өргөөнд орлоо. Идээ будаа дэлгэж Чингис хааны элчийг дайлах нь зүйн хэрэг юм. Ургенчийн дэргэд байхад Чингис хаан элч илгээж Ургенчийг авмагц цэргээ татан ирж нийлэхийг зарлиг болгосон ч Зүчи эзэлсэн нутгаа тохинуулах их ажил байсан тул яваагүй билээ.

Түүнээс хойш Чингис хаан цэргээ авч Инд мөрнийг уруудан дайлаар яваад хоёр жил шахам болж сая л Перваны хөндийд эргэн ирснийг Есөнтэй Зүчид мэдэгдэв. Одоо Перваны хөндийд Монголын их цэрэг цуглаж байгаа ажээ.

Цэргээ авч ирж нийлэгтүн гэсэн цөөн үгтэй зарлигт их хааны тамга дарсан байв.

-Надаас өөр хэн очоогүй байна.

-Сүбээдэй, Зэв хоёр нааш эргээгүй бололтой. Бас Багдадын Халифт явсан Чормогон хорч, Энэтхэг рүү давшсан Бала ноён ирээгүй байна. Бүгдэд элч илгээсэн ... -

Их цэргийг нэг дор цуглуулж яана. Эсвэл өөр зүг их дайнд мордох болов уу

-Миний сонссоноор их цэрэг Монголдоо буцна гэнэ.

-Хэзээ гэж Зүчи айсан мэт сэртэсхийв.

-Чи юунд цочив. Чи буцах хүсэлгүй байна уу ... гэж Есөнтэйг асуухад Зүчи тэр дороо хариу

хэлж төвдсөнгүй. Чингис хаан Монголдоо буцах зарлиг буулгавал хэрхэх билээ гэж боджээ.

-Би ч бушуухан л нутагтаа буцах минь. Энэ элсэн дунд уушиг минь шатаж дуусав. Булгийн цэнгэг ус залгилж модны сүүдэрт нам унтахсан гэж хүснэ гэж Есөнтэй Зүчийн бодолд саад хийхгүй гэсэн мэт шивнэв. Зүчи түүний энэ үгийг сонсохгүй мэт сууна.

-Чи юу бодов оо... -Би яг чамтай адил хүснэ. Энэ бол Зүчийн ам дагуулсан үг байв. Уг нь тэр би нутагтаа суухыг хүснэ гэж шууд хэлмээр байвч арай л зүрхэлсэнгүй. Учир нь тэр Есөнтэйд итгэж өгөхгүй байв.

Есөнтэй бол Чингис хааны хамгийн үнэнч нөхөр Зэлмийн хөвүүн дээр нь Чингис хааны амь сахигч торгон цэргийн мянганы ноён хүн тул илүү ихийг чалчихыг хүссэнгүй. Гэвч Есөнтэй бол нулимсыг нь арчиж, нууц гомдлыг нь хуваалцсан багын анд нь байв. Ийм хоёр салаа бодлын дунд Зүчи тэлээ хурга шиг тэлэгджээ. Есөнтэйг ирнэ гэж санаагүй ч гэнэ гэнэ түүнийг дэргэдээ байсан болоосой гэж Зүчи хүсдэг билээ. Ингэх учир байлаа. Өөрийг улсыг байгуулахын хамгийн гол үндэс нь хүчирхэг цэрэг юм. Нутгийн иргэдээс дайчилсан цэргийг яг өөрийн монгол цэрэгтэй адил дайн байлдаанд сургахгүйгээр юу ч хийж үл чадна. Энэ хэргийг хэрэгжүүлэхэд чухам Есөнтэй шиг авъяастай цэргийн эрдэмд суралцсан итгэлтэй анд хэрэг болно. Есөнтэйг дэргэдээ авч цэргийн хэргийг захируулан хөвүүн Батдаа хавсруулах хүсэл төрсөөр удсан юм. Гэтэл дээд Тэнгэр түүнийг мэдсэн мэт Есөнтэй хүрч ирэв.

-Есөнтэй. Чи өөрөө нааш ирнэ гэв үү. Эсвэл ...

Есөнтэй Зүчийн үгийн утгыг шууд ойлгов.

-Зүчи. Би уг нь ирэхийг хүсэв. Гэвч миний мянгат одоо Чингис хааны бие, өргөөг хамгаалдаг болсон тул би байлдах ч эрхгүй уйтгарлах болсон. Харин сая Чингис хаан юу бодсоныг бүү мэд. Гэнэт намайг чамд илгээх зарлиг буулгажээ. Бодвол хаантан чи бид хоёрыг уулзахсан гэснийг мэдсэн биз ээ гэж Есөнтэй инээн хэлэв.

Үнэндээ Чингис хаан Перваны хөндийд ирмэгц Зүчид элч илгээхээр шийдсэн юм.

Харин хэнийг илгээхээ олон өдөр боджээ. Зүчи зарлигийг дагаж Ургенчээс цэргээ авч ирээгүйг Чингис хаан өнгөн дээрээ үл тоомсорлох мэт байсан ч энэ хэргийг нэг ч мөч мартаагүй билээ. Эзэлсэн нутгаа төвхнүүлэх гэсэн Зүчийн үгийг тэр бас ойлгож хүндэтгэжээ. Энэ нь шинэ нутаг орныг эзлэхээс ч дутахгүй төвөгтэйг тэр мэднэ. Гэвч ингэж Зүчийн хийснийг зөвшөөрсөн мэт боловч зарлигийг зөрчин том толгой гаргаж ирээгүйд нь эгдүүцэн хилэгнэсээр байжээ.

Чингис хааны энэ битүү бухимдлыг Боорчи, бас Цагадай, Өгөдэй, Тулуй нараас өөр хэн ч мэдсэнгүй.

-За яах вэ. Зүчи хүссэн зүгтээ яваг. Гэвч нэг өдөр буруу замаар будаа тээвэл буцахдаа шороо тээнэ гэдэг болох бий гэж заналтай шивэгнэснийг тэр дөрөв сонссон билээ. Гэвч хэн нь ч Зүчийг хамгаалах юм уу буруушаах үг дуугарсангүй.

Учир нь тэр өдөр Чингис хаан туйлын хилэнтэй байжээ.

-Чингис хаантны бие лагшин тунгалаг сайн буйзаа гэж Зүчи асуув.Ингэж ёсыг бодон асуухдаа Зүчи цаанаа юу бодож байгааг Есөнтэй гадарласан тул түүний хүсч байсан хариуг хэлэв.

-Чингис хаан ойрд их хилэнтэй байгаа. Хулан хатны үхлээс хойш бие сэтгэл нь баахан хямарч буй бололтой. Нэг л тайван биш болсон. Хол газар энэ хар халуунд эцэж ядраа ч биз дээ.

-Хулан хатныг тэнгэрт хальсанд намайг очсонгүй гэж Чингис хаан лав их хилэгнэсэн байх даа гэж Зүчи хэлэхэд Есөнтэй,

-Чи энэ удаа заавал очихгүй бол болохгүй биз гэж анхааруулав. Энэ нь Есөнтэй өөрийн мэдэхийн хирээр Зүчид ирэх аюулаас урьдчилан сануулах гэсэн үг байв. Зарлигийг даган очоогүйд Чингис хаан түүнд хилэгнэсээр байгаа нь нэгэнт тодорхой болжээ. Зүчи уг нь бүх зүйл мартагдан өнгөрсөн гэж бодож,ингэж итгэхийг оролдсоор байсан билээ. Гэтэл хэрэг түүний бодсон шиг тийм ч амар хялбар биш бололтой.

Бас үүнээс илүү ихийг Есөнтэйгөөс асууж болохгүй гэж шийдэв.

-За чи өнөөдөр тухалж алжаалаа тайлж үз. Би чамайг чилээхээ больё гэж Зүчи хэлэхэд

-Чиний хэлснээр болъё. Харин чи яаж миний алжаалыг тайлна гэв. Энэ юу гэсэн үг болохыг Зүчи ойлгов.

-Би Зүчи чиний энэ газарт шигдэн суусны учрыг олох гэж хүснэ. Лав бүсгүйчүүд нь амттай биз.

-Чи хэл. Ямар бүсгүйг чи хүснэ.

-Орос гэж Есөнтэй эргэлзэж бодсонгүй өчив.

-Чи орос эм элбэг гэж санав уу. Гэхдээ өгвөл ганцаасаа гэдэг бил үү. Би багын ганц нөхөр чамд өөрийн орос эмийг бэлэглэе. Чи буцахдаа авч яваарай. Нутагтаа аваачиж гайхуул гэж Зүчи баясгалантай хөхрөв. Тэр үнэхээр татвар орос эмээ Есөнтэйд бэлэглэхээр шийдсэн билээ. Есөнтэйг орос эм эдлэн, тачаал сэрэлд нь автсан тэр шөнө Зүчи унтаж чадсангүй.

Шөнө дунд өнгөрснөөс хойш Батыг дуудан сэрээв. Бат ч даруй иржээ...

-Чингис хааны элч маргааш буцах тул би чамтай зөвлөх хэрэг гарлаа. Эцэг нь ингэж шөнө дөлөөр чухал хэрэг зөвлөхөөр дуудсан нь Батад бахтай сайхан санагджээ. Шадруудаасаа хэнийг нь ч дуудсангүй.

-Бат. Хүү минь. Чи анхааралтай сонс. Сонссоноо цааш нь хэнд ч бүү мэдэгд. Энэ хэргийг зөвхөн чи бид хоёр л мэдэх ёстой юм. -За. Аав аа...

-Чингис хаан Есөнтэйг элч болгон илгээжээ гэж Чингис хааны цөөн үгтэй захидлыг өгөв. Бат гүйлгэн уншаад,

-Цэргээ авч ир гэнээ. . . гэж гайхсандаа нүд нь томров.

-Тийм ээ. Намайг цэргээ авч ир гэжээ. Бас Киевийн зүг явсан Сүбээдэй, Багдадаас Чормогон, Энэтхэгээс Балаг ч дууджээ.

-Юу болов.

-Их цэргээ авч Монгол нутагтаа буцах гэнэ.

-Тийм үү. Тэгвэл бид наашаа дэмий нүүдэл хийжээ. Одоо буцна ...

-Чи хүлээ ... Тэд ирдгээрээ ирэг ... Би Монголд буцахгүйгээр шийдлээ. Энд сууж, өөрийн улсыг байгуулна. Би өдий болтлоо Чингис хаан эцэгт зүтгэж, их улсыг байгуулахад хүчээ өглөө. Одоо үлдсэн насаа өөрийн улсыг байгуулахад зориулна. Намайг Зүчи хаан гэж өргөмжлөөсэй гэж би хүснэ. Хөвүүн чи юу гэж бодож байна гэж Зүчи яарч юманд хөөгдсөн мэт амьсгаадан асуув. Түүний сэтгэл хөвчрөн донсолжээ.

- Би таны төлөө уулыг давж усыг гатална. Би тантай хамт Уралын нуруунаас цааш, Кавказын нуруунаас хойшхи нутгийг хураан авахыг хүснэ. Би Гертагийн уугуул нутагт очихыг хүснэ гэж Бат сэтгэл хөдлөн итгэл төгс хэлэв. Герта гүнж бол эхийн талын удмыг хөөвөл Эрээн мөрний Прусс үндэстэн ажээ. Гертагийн хэлснээр тэр холын нутаг цаг агаар зөөлөн, бас Балтын тэнгис хэмээх их ус байдаг гэхийг Бат мэдсэн тул ийн хэлжээ.

-Хөвүүн чиний үгийг сонсоод би сэтгэл ханалаа.

-Харин Чингис хааны зарлигт юу гэж хэлнэ. Яагаад очихгүй гэж хэлэх вэ гэж Бат сэрэмжлэн асуув. Хамгийн зовлонтой нь энэ хэрэг юм. Нутаг буцахгүй шалтгаанаа зөв ойлгуулж хэлэхгүй бол Чингис хааны уур хилэнг бадрааж бүх хэрэг нурж үхэлд ч хүрч мэдэх билээ. Эцэг хүү хоёр хоёул үүнийг ойлгож байлаа. Тусгаар улс байгуулах тухай шууд дурдаж болохгүй. Чингис хаан үүнийг талархан дэмжихгүй гэж сэжиглэж байлаа. Бас зарлигийг зөрчин очихгүй гэхэд түүнээс ч илүү аюултай. Зүчи яах учраа олохгүй учир Батыг дуудсан билээ. Маргааш Есөнтэйг буцахад заавал нэг учир хэлж захидал илгээх хэрэгтэй болжээ. Тусгаар улс болох хүсэл хичнээн амттай ч үүнийг биелүүлэхэд хичнээн хэцүү болохыг тэд ойлож байлаа.

Цэрэг хөдөлгөж харийн улс аймгийг эзлэн авах хялбар ажээ. Харин Чингис хааны их нэр сүр, хүчнээс ангижирч сална гэдэг бүтэшгүй бэрх болох нь тов тодорхой болжээ. Монголоос их нүүдэл нэгэнт хөдөлсөнийг Чингис хаан сонсож мэдэхгүй байх гэж үгүй. Зүчийн өмнө хоёр зам үлдэв.

Нэг бол Чингис хааны зарлигийг үггүй дагаж амьдрах, үгүй бол тусгаар улсаа байгуулахын төлөө эцсээ хүртэл зүтгэх хоёрын аль нэгийг сонгох болжээ.

Зүчи их сонголтын өмнө иржээ.

Энэ мөчийг үзтэл тэр дөчин хоёр жилийн зовлонтой, бахархалтай амьдрал туулжээ.

Дэргэд нь Зүчийн ирээдүйн гэрэл гэгээ болсон Бат хөвүүн нь түүний шийдвэрийг хүлээн идэр залуу насны халуун хүсэл гэрэлтүүлэн зогсоно.

Чингис хаан Бөртэ эхийн хэлснээр Зүчид амь амьдралыг соёрхон өгсөн ч хаан алдрыг булаан авсан билээ.

Зүчид энэ их алдрыг өөрийн хүчээр булаан авах ганц зам үлдээжээ. Одоо Зүчи яг энэ хүсэл болсон замынхаа эхэнд хэн ч булаан авч үл чадах ганц залгамжлагч, өмөг түшиг болсон Бат хөвүүнийхээ хамт зогсож байв. Түүний одоо гаргах шийдвэр, сонгох замаар Бат хөвүүн нь явах болно.

-Бат хөвүүн минь, чи юу хүснэ ...

Эцгийн энэ гэнэтийн ба учир нь тодорхойгүй асуулт Батыг цочирдуулав. Батад хүсэл олон бий. Гэвч бодсоны эцэст эцэг нь түүнээс ямар хариу хүлээж байгааг ойлгов.

-Би өөрийн улсыг байгуулж их хаан болохыг хүснэ гэж эргэлзээгүй тод хэлэв. Батын үг Зүчийн хүссэн хариу мөн байлаа.

Зүчи таатайгаар инээж хөвүүнээ тэврэв. Зүчи юу хийх, юу хэлэхээ сайн мэдэж авчээ. Өглөө болмогц Зүчи Чингис хааны элч Есөнтэйг хүлээж суув. Чингис хааны шадар Есөнтэйн эцэг Зэлмэ саа өвчинд нэрвэгдээд одоо цэрэг дайнаас алс хол өөрийн хуваарьт нутаг баруун Хянганы нурууны Айраг гэгч жижиг нуурын хөвөөнд өмхий шавраар биеэ эмчилж суугаа билээ.

Эцэг Зэлмийн зүтгэл, гавьяаг өвлөж авсан Есөнтэй бол Чингис хааны итгэлтэй хүмүүсийн нэг яах аргагүй мөн бөгөөд нэр нөлөө нь ч цэргийн дотор багагүй юм. Зэлмийг ийн нутаг буцсанаас хойш Чингис хаан болоод Боорчи бусад ахмад хүмүүс Есөнтэйг Зэлмийн ороор үзэж түүнд ихэд анхаарал, хүндэтгэлтэй хандах болсноор хуучин багын анд Есөнтэйн сэтгэлд ямар өөрчлөлт орсныг Зүчи анзаарч мэдсэнгүй. Бодож бодож Есөнтэйд итгэх хэрэгтэй гэж шийдэв.

Тусгаар улс байгуулахад Есөнтэйн хүч чухал юм.

Ер нь ганц Есөнтэй ч биш одоо Чингис хааны дэргэд алба хашиж буй хэд хэдэн хүнийг өөртөө урвуулан дагуулах хэрэгтэй байв. Энэ хэргийг гүйцэлдүүлж чадах ганц хүн нь анд Есөнтэйг гэж Зүчи үзжээ. Есөнтэй Чингис хаанд зүтгээд мянганы ноёноос их дээш дэвших боломж бага учраас Зүчийн дэргэд ирж түүний улсын цэргийн бүх хэргийг эрхлэхийг яавч хүснэ гэж тооцов.

Энэ нь Бат хөвүүний нь дараах эрхтэн болно гэсэн үг юм. Бас Есөнтэйгөөр уламжлуулан талийгч Хуйлдарын хөвүүн Оготур, Боорчийн дүү Үүлэн Чербиг өөрийн дэргэд авчирч чадвал нэн сайн гэж бодов. Бас Сүбээдэй баатрын тусыг олох нь ч чухал байв.

Сүбээдэй бол үл таних баруун зүгийн улс аймагт хамгийн хол довтлон одсон тэр газрыг хамгийн сайн мэдэх хүн юм.

Зүчи цэргээ засч бэхлээд Оросын урд хязгаарыг сахин суугч Асу аймгийг довтлон эзлэхээр төлөвлөж байжээ. Асу аймаг бол орос хэлтэй, суурин амьдрагч иргэд бөгөөд Уралын нурууны баруун талд Урал мөрний дунд биеэр нутаглан суудаг юм. Асу аймгийг эзлэн авбал Хивчаг болоод Орос улсуудтай шууд хил залгана. Асу аймгийн хүчийг авч цэргээ сэлбэвэл Оростой дайтах хүчин бүрдэх билээ. Есөнтэйг орж ирэхээс өмнө Зүчи Сүбээдэй баатарт өөрийн элч болгон Төрөлчи хүргэнээ илгээе гэж шийджээ.

Чингис хаан нутаг буцлаа ч Сүбээдэй эзэлсэн нутгаа сахин тохинуулж үлдэнэ гэж Зүчи итгэж байв.

Нэг улс орныг эзлэн авмагц талж дээрэмдээд буцдаг Чингис хааны энэ нүүдэлчний дайтах аргыг Зүчи таашаахгүй болсоор уджээ. Ингэж дургүйцэх нь ганц Зүчи биш юм. Залуу идэр жанжид цөм л эзлэн авсан нутгийг захиран суухыг хүсч байв. Чингис хааны цэрэг хүчирхэгжин нэр сүр дэлгэрэх хэрээр түүний ихийг бүтээгч, зоригт баатруудад шинэ шинэ газар нутаг нэхэгдэх ажээ. Энэ бол нүүдэлчин аймгийн удирдагчаасаа салан тусгаарлахыг ямагт эрмэлзэж байх язгуур шинж юм.

Энэ салан тусгаарлах үзэл Зүчид бусдаас илүү хүчтэй болжээ. Учир нь тэр Чингис хаантай цусаар холбогдоогүй, Чингис хаан болоод Зүчи хоёрын холбоо, Цагадай, Өгөдэй, Тулуй хөвүүдийг нь бодвол ёс төдий сул байлаа.

Бөртэ хатны бие сэтгэл, ухаан зоригийн хүчээр тогтож байсан Чингис хаан Зүчи хоёрын эцэг хүүгийн хуурмаг, үзэмжийн төдий холбоо тасрах цаг ирэв. Одоо эх нь нэгэнт өөрийн үгийг хэлж Чилэгэр бөхийн удам цус нэгтэй Бичэлдэйг илгээсэн нь Зүчийг ийм алхам хийхэд зоригжуулав. Чингис хаанаас тусгаарлан салахад эх нь яавч эсэргүүцэн зэмлэхгүй ажээ.

Гэвч шалтгаан төвөг их байв. Чингис хаан хилэгнэвэл тэдний хооронд дайн самуун дэгдэхийг ч Зүчи мэдэж үүнээс хамгийн их айн болгоомжлов. Чингэвэл Зүчи ч, Бат ч үхэх юм.

Ийм учраас Зүчи хүссэн хэргээ гүйцээхийн тулд заль хэрэглэн цаг хожих нь зөв гэж үзжээ.

Яаж ч бодсон Чингис хаан энэ нутагт удаан сууж тэсэхгүй нь тодорхой тул үүнээс сайн арга олохгүй биз. Чингис хаан Монгол нутагтаа буцвал Зүчид хэн ч саад хийж чадахгүй билээ. Ингэж бодоод тайвширч үүрээр дугхийгээд сэрэхдээ үзсэн зүүднээсээ их л сэжиглэжээ. Зүүдэнд өнөө Бичэлдэй хөвүүн орж, толгойгүй бие “Миний толгойг өгөөч” гэж хашгиран хөөж, харин Бичэлдэйн толгойг Бат хөвүүн нь Чингис хаанд өргөн барьж байна гэж зүүдэлжээ. Энэ бол яах аргагүй муу ёр юм.

Тэр хөвүүнийг дэмий алав гэж их харамссаар байсан ч одоо нэгэнт оройтжээ.

Зүчи сэлэм далайн Бичэлдэйн хүзүүнд буулгахын өмнө яг ингэж эргэлзэн бодсон ч далайсан гараа татаагүй билээ. Харин сэлмийн ирэнд Бичэлдэйн хүзүүний яс үйрэн хугарахыг сонсож үхлийн аймшигт цохилтыг гар биеэрээ мэдрэхдээ давхийн үс нь арзайж “Дэмий юм хийв” гэж хожимдон боджээ. Тэр нялх хөвүүнийг юунд алав. Ядаж өөр хүнээр ч алуулахад яав гэж шаналан боддог байлаа. Зүчи хүн алчихаад ингэж харамсан шаналсан удаагүй билээ.

Энэ бол үнэхээр муу ёр байсан бөгөөд Зүчи Бичэлдэйг алснаар өөрийн үхлийг даллан дуудсанаа мэдсэнгүй.

Есөнтэйг орж ирэхэд Зүчи бодолд дарагдан сууж байв. Гэвч тэр хоёр үг сольж амжсангүй.

Учир нь Бат эцгийнхээ өргөөнд зөвшөөрөлгүйгээр үсрэн орж иржээ.

-Аав аа. Тату. Тату эргээд иржээ. Амьд. Амьд эргээд ирж гэж Бат инээн хашгирч байв.

Хэн ч хариу хэлсэнгүй. Зүчи ухасхийн гарчээ. Есөнтэй ч гайхан гарав. Юу болоод байгааг тэр ойлгохоо больжээ. Харин бөөн баяр болсон тэднийг харж зогсохдоо нааш гарахад нь Боорчийн хэлснийг боджээ.

”Чи Зүчээс юу ч битгий асууж шалгаагаарай. Тэгвэл цаадах чинь чамд юу ч хэлэхгүй шүү. Тэвчээртэй хүлээ. Өөрөө хэлэхийг нь хүлээгээрэй” гэж Боорчи Есөнтэйг мордохын өмнө өргөөндөө дуудан захижээ.

Боорчийн Зүчид хэрхэн сайнаар ханддагийг Есөнтэй мэдэх билээ.

Харин Чингис хаан яах гэж түүнийг Зүчийн хүрээнд илгээснийг Есөнтэй гадарлаж, бас ингэж их итгэл өгсөнд нь бахархаад барахгүй байсан билээ.

Одоо очоод түүний хэлэх үгнээс Зүчийн амь нас хамаарах болсныг Есөнтэй сайн ойлгож байв.

Бас үүнийг мэдэж байсан учраас Боорчи Есөнтэйд дээрх үгийг хэлжээ.

Чухам юуны учир хэлснийг Есөнтэй ухаж ойлгосонгүй. Их Чингис хааны итгэл,зарлигийг биелүүлэхээс өөр эрхэм хүсэл түүнд байхгүй билээ. Энэ бол түүнд эцгээс нь өвлөгдсөн бат хүмүүжил байв. Зэлмийн хөвүүн Есөнтэйгээс илүү үнэнч хүн олоход үнэхээр хэцүү биз ээ.

Харин Боорчи Есөнтэйг үнэнчээс гадна их шударга хүн гэж тоодог бүлгээ. Харин Татугийн ингэж гэнэт амьд мэнд эргэн ирснийг Зүчи Тэнгэрийн зарлигаар болов гэж итгэжээ. Татуг илгээсэн нь Тэнгэр Зүчийг хүслийг сайшаан дэмжсэний дохио байв.

Тийм учраас Зүчи Есөнтэйд эргэлзээгүй итгэж түүнд өөрийн нууц бодлоо шууд хэлжээ. Есөнтэй нэг ч үг дуугаралгүй сууж Зүчийн үгийг сонсжээ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БООРЧИ

Перваны уужим хөндийд Чингис хааны их цэрэг тал талаас цугларч хуарагнасаар намаржиж, өвөлжөөд хаврын сартай золгов.

Ялалт, олз хоёртоо бялуурсан цэргүүд их тулааны таван жилд хурсан ядрал, зүдрэлээ тайлж хэдэн сар нам жим байцгаах зуураа ханатлаа унтаж бас нутгийн эмстэй ханатлаа зугаацаж авчээ.

Тэр жилийн хавар нь эрт дулаарч бүр аагим халуун шатаж эхлэв. Инд мөрнөөс дөрвөн өртөө газар суваг татан Чингис хааны хээрийн их өргөөний үүдээр урсгаад салхин дээр нь том шүршүүр зоож оньсот хүрдээр ус хөөрөгдөн нарийн ширхэгтэй зөөлөн бороог өдөрт дөрвөн удаа хиймлээр оруулах нь яг л нартай бороо намирах мэт бүлгээ. Каспийн тэнгисийн баруун биеэр хойш довтлон Кавказын их нурууг давж Орос улсыг дайлаад эгэж ирэхгүй болсон Зэв, Сүбээдэй хоёрыг хүлээн их цэрэг ингэж амарч хагас жил суув. Энэ завсар бас ч зүгээр суусангүй Хорезмын эзлэгдсэн хотуудын бүтэн үлдсэнд нь захирагч томилж нутгийн иргэдээс авах татварын хэмжээг тогтоон улсын хууль журмыг мөрдүүлснээр Чингис хааны их гүрний нэг хэсэг болон тогтох амьдрал эхэлжээ.

Юуны өмнө нутгийн имам нарыг сүмд нь ирүүлж шашин мөргөлийг сэргээсэн нь Чингис хааны нэр сүрийг олны дунд сайнаар дуурсгав. Эхлээд Хорезмын султан Желаладдинийг нэхэх нэрээр эхлэсэн довтолгоон Кавказын нурууг давмагц аль эрт наашаа зугатан ирж хоргодсон хэрэйд, мэргэд аймгийн үлдэгдлийг олж устгах нэртэй болон хувирч монголчуудын өөрсдийн довтолгоог зөвтгөх үндэс болж байв.

Зэв, Сүбээдэй хоёр нэгэнт эхэлсэн дайнаа дүүрэн ялалтаар дуусгахын тул морины жолоог эс татан яг л галзуу ноход шиг үсчин Оросын зүро болсон Киев хотын зүг урагшилж байв.

Харин Ургенч хот хавийн нутгийг эзлэн суух эрхийг Чингис хааны зарлигаар хүртсэн Зүчи өөрийн эзэмшлийг төвхнүүлээд эргэж ирэхгүй,уулзахгүй байсаар жил гаран болсон нь Чингис хааны уур цухлыг барж эхлэв. Энэ нутгийн халуун бүгчим агаар, олон жилийн аян дайны алжаалд Чингис хааны бие эрхгүй ядарч нүд аних бүр сэрүүн салхит Хэрлэний хөндий,сэтгэлд дотно Бурхан Халдун уул зүүдлэгдээд бушуухан нутгийн зүг буцахыг хүсч байв. Хулан хатны гэнэтийн үхэл Чингис хааныг ингэж ганцаардлын туйлд хүргэнэ чинээ санасангүй. Гашуудал харуусал өдөр ирэх бүр мартагдан нимгэрдэг атал тэгсэнгүй. Харин ч бүр тодорч Хуланы сүнс Чингис хааны өргөөнөөс гарахгүй болжээ.

Их монгол улстай зэрэгцэн оршиж байсан Аллах тэнгэрийн шүтлэгт Хорезмын хаант улсыг мөхөөн дарсан нь Чингис хааны нэр сүрийг тэнгэрт өргөж Каспийн тэнгисээс цаашхи улс аймгуудад аюул аймшгийг төрүүлэх болсон нь өдөр алгасахгүй ирэх элч нарын үг мэдээнээс илт байлаа. Гэвч энэ бүхэнд, дайны олз, ялалтад Чингис хааны сэтгэл огт хөөрсөнгүй. Дайн тулаангүй хэдэн сарын тайван амьдрал түүнд өнгөрсөн амьдрал болоод ирээдүйгээ цэгнэн бодох боломж олгожээ.

Унасан нутаг, угаасан уснаасаа хэдэн мянган бээрийн алс энэ харийн нутагт хэсэг зуур суухдаа яавч энд суурьшиж амьдарч чадахгүйгээ тэрээр ойлгожээ.

Цэргийн доторх жанжин захирагчдын зарим нь Инд мөрнийг уруудан хүрч үзээгүй Энэтхэг нутгийг эзлэн авч тэгээд хойш эргэн Алтан улсын өмнөд хөрш Сүн улсын урдаас нь дайран эзлэх эцэс төгсгөлгүй аян дайн хийхийг хүсч байгааг ч итгэлт хүмүүсээсээ сонсов. Гэтэл Чингис хаан нутагтаа очиж суухыг юунд ингэтлээ хүсч байгаагаа өөрөө ч ойлгохгүй байлаа.

Эцэж ядарч, өвгөрч хөгширснийх үү. Аль эсвэл ялалт байгуулах их хүсэл нь унтрав уу гэдгийн аль нь болохыг тэр эс мэдэв. Түүнд учрыг хэлж ухааруулах хүн одоо энд хэн билээ. Хар нялхаас цуг зүтгэсэн Зэлмэ саа өвчинд дайрагдан эдгэрч сайжрахгүй болсон тул Отрарын дэргэдээс нутгийн зүг хөнгөн сүйх тэрэгний ачаа болж одов. Одоо дэргэд нь Боорчи л ганцаар торойж үлдэв. Зэв, Сүбээдэй хоёр хөгширсөн ч тэд эргэж харах сөхөөгүй Оросуудтай дайтсаар явна. Харин түмэн торгон цэргээ удирдаж дэргэдээс нь нэг ч мөч үл холдох Боорчи л түүнийг сахиж, хэлбэл сонсож, хэрэлдвэл зөвлөж яваа билээ. Боорчийн үрчлээт нүүр, бөгтийсөн нуруу хийгээд амсхийх ч завгүй бэрх жилүүдэд бавайтлаа ургасан бөөн сахал нь бууралтсаныг үзэх бүр хичнээн жил амьдарч өнгөрөөснөө Чингис хаан ойлгож өөрийгөө толинд харах мэт болдог байв.

Цаг хугацаа гэдэг дааанч хайр найргүй дэндүү харгис хатуу бөгөөд хэн ч байсан, юуг ч болов элээн эмтэлж дуусгадаг, эцэст нь үгүй хийн хумхийн тоос болгодгийг ойлгож мэдрэх бүр эцэсгүй ядрал, хэмжээлшгүй ганцаардалд автах ажээ. Нэг л сэрэхэд Боорчи ч, Зэв ч, Сүбээдэй ч үгүй болно гэж санахад дааанч итгэмгүй, бүр байж болшгүй мэт санагдана. Гэтэл энэ итгэлт нөхөд нь чухам яах гэж ийнхүү энэ биеэ, идэр насаа гамгүй үрж гэмгүй зарж түүнд зүтгэнэ вэ. Ихэр мэт явж, ижил бяруу шиг ноололдож өссөн, илүү бодолгүй идэвхийлэн зүтгэсэн тэднийг үхнэ гэхэд дэндүү хайран. Гэвч хорвоогийн жамыг яалтай билээ.

Дэргэд нь дэнлүү шиг асч явсан Хулан хатан нь өвчнөөр үхэв. Хэн Хуланг үхнэ гэж саналаа. Одоо мөрт инээгээд ороод ирэх юм шиг санагдах нь хачин. Чингис хааныг ийм гунигтай эзэнгүй бодолд автан шаналж хэдэн сарыг ёстой нэг уймарч өнгөрөөснийг хэн ч сэжиглэсэнгүй. Зэв, Сүбээдэй хоёрын ирэхийг хүлээлгүйгээр явж болохгүй гэж Чингис хаан шийдсэн билээ. Учир нь урьд хожид зөвхөн дуулж сонссоноос цаашгүй шинэ газар орны тухай мэдэх хүсэл нь хязгааргүй байлаа.

Харин Зүчид илгээсэн элч Зэлмийн хөвүүн Есөнтэй буцан ирж, Зүчийн хариу захидлыг гардуулсан хойно Чингис хаан гэнэт сэргэн хуучны омголон догшин, сүр хүч дүүрэн төрхөндөө буцаж оров.

Боорчийг дуудан ирүүлж Зүчийн захидлыг Шихихутагаар дуудуулан сонсгожээ.

“Чингис хаан эцэг таны заасан нутгийг үүрд сахиж, захисан сургаалийг баримтлан эцгийн их улсын баруун хаяаг баталж, наран шингэх зүгт өргөтгөж, олны дунд нэр алдалгүй, овсгоотны өмнө хүч алдалгүй явах нь миний ариун үүрэг тул би Хивчаг аймгийн нутгийг эзлэн авч хаан эцгийн заасан Хорезмын нутагтай нийлүүлэн сууя. Энэ зүгт их цэрэг хөдлөх аваас хаан эцэгт хавсарч хавийн улсыг нийлүүлье.Энэхэн зуур босож хаан эцэг таны зарлигаар эргэн хөдөлье гэвч элэг бөөр өвчтэй тул эрхгүй эмнэн сувилууштай” гэж бичсэн тэр захидалаа дагалдуулан Зүчи зуун залуу эм, зуун залуу хөвүүнийг, бас алтаар цутгасан азарганы хамт илгээсэн байв.

-Тэр хөвүүн нутаг буцахгүйгээр шийджээ гэж Чингис хаан огт хилэгнэсэн зүйлгүй энгийн

шивнэв. Гэвч сэтгэлийн гүнд уур бухимдал биш харин яагаад ч юм бэ гомдол гуниг төрөхийг тэр мэдэрчээ. Гэвч захианаас гадна Есөнтэйн амаар өчсөнийг тэдэнд хэлсэнгүй. Хэргийн учир ээдрээтэйн дээр Чингис хаан түүнд хандаж огт үг хэлээгүй тул Шихихутаг даруй гарч явав.

Боорчи үлдээд дуугүй сууж байв. Боорчи ингэж дуугүй суусан ч Зүчид ямар нэг муу юм тохиохыг мэдэрч түгшжээ. Чингис хаан өнгөн дээрээ тайван дөлгөөн төрх үзүүлэвч дотроо бухимдуу байгаа нь мэдэгдэнэ.

-Боорчи чи юу гэж бодно. Энэ Зүчи чиний хүмүүжүүлсэн хүн биз гэж Чингис хаан хэлэхэд Боорчи инээж

-Чингис хаан та ер нь юм мартдаггүй хүн юм даа. Зүчийг энэ дайтай яваа нь ер Сүбээдэй баатарын гавьяа гэж үзэх нь үнэнд илүү нийцнэ гэв.

-Чи шууд хэл. Зүчийн үгийг юу гэж санана. Бүү үгээ булзааруул

-Зүчи нэгийг санаад ийм үгийг илгээсэн биз. Түүнд Хивчаг нутгийг эзлүүлэн суулгагтүн. Угаас хаан таны хуваж өгсөн нутгийг сахин суух гэдэг нь Зүчийн зөв биз

-Боорчи чи ингэж бодно уу гэж Чингис хаан занасан мэт шивнэв.

-Миний зарлигийг даган энд ирж болоогүйг нь чи юу гэж тайлбарлах вэ. Даруй гурван удаа боллоо. Үүнийг Боорчи чи энгийн явдал гэж санаж байна уу.

-Түүний захидалд бие чилүүр байна гэж дурдсаныг та сая сонсов биш үү...

-Тийм ээ. Зүчийн бие чилүүр гэжээ. Тэр үдэш Чингис хаан Зүчийн тухай дахин яриагүй билээ. Гэвч маргааш нь шөнө дунд гэнэт Боорчийг дуудав.

Боорчи тэгэхэд өөрийн цацарт Чормогон хорчийн Багдадаас ирэхдээ бэлэглэсэн бүсгүйтэй амраглаж байсан тул их л төвөгшөөн бухимджээ. Чормогон хорчи Багдадын халифыг дагаар оруулж даахгүй их олзтой ирэхдээ Чингис хаанд гучин эм авчирч бэлэглэснээс нэгийг Боорчид өгсөн билээ. Тэр эм угийн их янаг, дуу ихтэй бөгөөд Боорчи өмнө нь ийм тачаалтай эм үзээгүй тул сүүлийн хэдэн сар түүнээс салахгүй байжээ.

Боорчийг ирэхэд Чингис хаан сарны гэрэлд гадаа цацрын дор сууж байв. Үзвэл тэр ер архи дарс уусан шинжгүй байлаа. Сүүлийн жилд ингэж шөнө дунд дуудсан нь үгүй тул Боорчийн гайхах алмайрах их болжээ. Дэргэд нь суусан хойно

–Миний нойр хүрэхгүй тул чамайг дуудуулав. Чи энд хүний нутгийн ч гэлээ сэрүүн тэнгэрийн дор надтай хамт суу гэж Чингис хаан хэлжээ.

”Нойр хүрэхгүйн учир намайг дуудах нь юув” гэж Боорчи бодсон ч зүгээр нэг дуудахгүйг мэдэх тул юу хэлэхийг хүлээн сурсан янзаар дуугүйхэн сууж байлаа. Чингис хаан түүнийг удаан хүлээлгэсэнгүй.

-Боорчи. Чи энэ нутгийн хамгийн өндөр оргилыг юу гэнэ мэдэх үү.

-Өмнө зүгт харагддаг тэр өндөр уулыг нутгийнхан Барыгжан уул гэдэг юм. Эндээс лав нэг өдөрчийн газарт буй. Хаан та үүнийг асуух гэж намайг шөнө дөлөөр дуудаагүй биз.

-Тийм ээ. Би чамд зарлиг буулгая. Би тэр уулын оргилд гарч Тэнгэрийн үгийг сонсохоор шийдлээ. Чингис хааны энэ үгийг сонсоод Боорчийн сэтгэл хачин ихээр уяран догдолжээ.

-Тэр уул дундаасаа дээш цул элгэн хад. Өндрөөшөө лав гурван мянган сайн алд бий байх. Харахад манай Отгонтэнгэр уулнаас арай л намхан болов уу

-Тэгвэл чи маргаашнаас тэр оргилд гарах оньсон шат хийлгэ. Харин үүнийг хэнд ч бүү мэдүүл...

-За гэж Боорчи ямар ч эргэлзээгүй хэлэв. Үүн шиг бахархалтай зарлиг сонсож байгаагүй мэт санагджээ. Боорчи ч Тэнгэрийн үгийг сонсохыг хүсч байжээ. Чингис хаан ингэж Тэнгэрийн үгийг сонсохоор шийдсэн нь яав ч их цэрэг нутаг буцахын дохио гэж Боорчи таамагласан нь түүнийг ингэж баярлуулсан билээ.

-Тэгвэл чи явж үз. Тэр өндөр хамарт, дуу ихт эмдээ оч гэж Чингис хаан жуумалзав. Боорчи гэдрэг буцав. Ийм баясгалантай зарлиг сонссон нь түүнийг юун эмс хүүхэн бодохтой манатай болгов. Боорчид зарлигийг хэрхэн гүйцэлдүүлэх билээ гэж эргэлзэх буцах сэтгэл огтхон ч төрөөгүй бөгөөд маргааш нь нутгийн уран дархчуул хоёр зуун хүн дайчлан цуглуулж тэдний дундаас хамгийн алдартай Иш-Химам гэгчийг сонгон гурван мянган алд өндөр Барыгжан уулын ноён оргилд хүн гаргах оньсон шат хийхийг тушаажээ.

Боорчи ийн тушаахдаа адуунаасаа морь барьж эмээллэхээс илүүтэйгээр үзсэнгүй нь цугласан уран дархчуулыг ихэд гайхшруулжээ. Гэвч тэдэнд энэ хачирхалтай зарлигийг эсэргүүцэх буюу буцааж хойшлуулах эрх байсангүй. Оргилд урсан гарах шатны оньс, хүрдийг Самарканд хотын цуутай их сүмийг барьсан Иш-Химам гэгч тэр алдартай уран дархан эр удирдан зохиож дууссаны дараа даруй мянга илүү залуусыг Барыгжан уулын хормойд шат бариулахаар илгээжээ. Хол газраас зөөлөн бат бэх урт мод, олс гээд хэрэгтэй бүгдийг Боорчийн зарлигаар ачин авчирчээ.

Чингис хааны эл зарлигийг гүйцэлдүүлэхдээ Боорчоос дутуугүй баярлаж хөөрсөн хүн бол Лалын гүн шүтлэгт уран дархан Иш-Химам юм.

Нэг насаараа лалын шашны олон сүм босгож Аллах тэнгэрийн дор мөнхөрсөнд тооцогдсон энэ хүн урд хожид сонсдоогүй гайхалтай бүтээл хийх хүсэлдээ хөтлөгдөн хязгааргүй урам зоригтойгоор ажиллаж байлаа. Хэдийгээр энэ оньсон шатыг ямар зорилготой хийлгэж буйг Иш-Химам тааварлаагүй ч Хорезмын урчуудын дотроос анх удаа дүүжин өргүүр шат зохиосондоо бахархаж хэдий буруу номтон ч гэлээ Чингис хаанд туйлгүй бишрэлтэй болж, энэ бүтээл нь түүнийг мөнхөд дуурсгана гэдэгт итгэлтэй байлаа.

Энэ бүх ажлыг Боорчийн хяналтын дор түүний дүү Үүлэн чэрби өөрийн мянган торгон цэргийн хамт хамгаалж, зохицуулж байв. Харин өргүүр шатыг мянга илүү мужаан дархчуул

хийж, зургаан сарын дараа бэлэн болсныг Боорчид илтгэв.

Барыгжан уулын бэлийг алсуур тойруулан цэргээр хамгаалсан тул чухам юу хийж байгааг олон хүн үзэж харж чадсангүй. Уулын тэхий дунд элгэн хадан оргилын хөлд байрлуулсан том хүрдийг хоёр талаас нь тавин хүн эргүүлж оргил хүртэл барьсан хашлага дээгүүр хөнгөн сүйх тэрэг олсонд татагдан өгсөх ажээ. Боорчи, ИшХимамын хамт хоёр удаа өгсөж өөрийн биеэр шалгав.

Мөнх цаст оргил дээр гарах сонин ч шатны бат бэх түүнээс илүү сэтгэл зовоох тул энэ бүгдийг Боорчи үл анзаарав.

-Олс тасарвал яана.

-Би давхар олсоор хамгаална. Та санаа бүү зов. Чингис хааны шадар сайд,торгон цэргийн их жанжин Боорчи өөрийн биеэр чухалчлан шалгаж буйгаас чухам яах гэж энэ шатыг хийлгэж буйг Иш-Химам гадарлаж үнэн сэтгэлээс хөөрөн бахдав.

Тэр их Чингис хаанд зориулан оньсон шат урлажээ гэдгээ мэджээ. Иш-Химам бүх л сэтгэлээсээ бишрэн бахдаж өөрийгөө мөнхрөнө гэж санав. Чингис хаан ингэж сэтгээгүй бол Иш-Химам хэзээ ч Барыгжан уулын оройд гарах татуурган хүрдэт шат хийхгүй билээ.

Үнэхээр агуу хүн л агуу санаа сэддэгийг Иш-Химам ойлгож, чухам Аллах тэнгэр ивээсэн мэт баясан хөөрсөн нь хэмжээгүй болжээ.

-Одоо Иш-Химам чамд хэдэн хүн үлдвэл болох вэ ...

-Хүрд эргүүлэх зуун хүн л байхад болно. Харин та бусад хүмүүст лав их шан өгөх биз гэж Иш-Химам хэлжээ.

-Тийм ээ. Иш-Химам. Энд зүтгэсэн бүгд Тэнгэрийн таалснаар хувь хүртэх юм. Харин та зуун хүнээ шилж аваад бусдыг надад өгөгтүн. Би тэднийг их хүрээнд хүргэж зохих шан харамж олгоод тарааж явуулна. Боорчийн үгээр Иш-Химам хүрд эргүүлэх булчин шөрмөс сайн зуун залуу эрийг сонгож аваад бусад хүмүүсээ Боорчид тушаав.

-Та хэзээ эргэж ирэх вэ.

-Хэзээ ч ирж мэднэ. Иш-Химам чи үргэлж л бэлэн байгтүн.

-Өршөөгөөрэй. Чингис хаан өөрийн биеэр залрах буй заа гэж Иш-Химам болгоомжтой шивнэн асуув.

-Чи тэгэж санана уу.

-Тийм ээ. Би ийм их хувьтай төрсөндөө өөрөө ч итгэж чадахгүй байна. Аллах тэнгэр намайг ивээн тэтгэж байгаад харин би итгэлтэй байна гэж хөөрч догдолсон уран дархан аймшиггүйгээр хэлжээ. Харин Боорчи түүний үгэнд дахиж хариу хэлсэнгүй давхин оджээ.

ИшХимам гэгч урлаж дархлах, урьд байгаагүйг бүтээх хэнээ туссан тэр түрэг иран цусны хүн газар сөхрөн сахлаа илбэж

-Аллах тэнгэр минь намайг өршөө. Чингис хааны зарлигийг би таны зарлиг гэж биелүүллээ. Энэ их шатыг би Аллах тэнгэрийн ариун сүм гэж бодож бүтээлээ хэмээн мөргөжээ. Шат хийхэд оролцсон эрчүүдийг урьдаас бэлдсэн их нүхэнд тэр шөнө бүгдийг нь унагаад булж орхижээ. Чингис хааны торгон цэргүүд нэг ч үг дуугаралгүй, чимээ ч гаргалгүй энэ бүгдийг Боорчийн тушаалаар ёсчлон хийгээд Үүлэн чэрбийн өмнө эгнэн жагсаж байв. Харин болж өнгөрсөн бүгдийг Боорчи Чингис хаанд илтгэв.

Харин Чингис хаан Иш-Химамыг өргөөндөө урихыг тушаасан нь Боорчид төдий л таатай санагдсангүй. Иш-Химамыг урихын өмнө Чингис хаан өөрийн биеэр нууцаар очиж татуурган оньст шатыг үзээд сэтгэл ихэд хангалуун болжээ. Иш-Химам өөрийгөө Аллах тэнгэр болоод Чингис хааны ивээлд багтсан хүн гэдэгт бат итгэж байлаа.Тиймгүйсэн бол энэ ертөнцийн талыг байлдан дагуулсан их хаан түүнийг юу гэж орд өргөөндөө урьж хүндэтгэл үзүүлэх билээ.

Чингис хаанд бараалхахын өмнө Иш-Химам барьц алдан тэвдсэн ч Чингис хааны зөөлөн эерүү ааш, үгийг сонсоод тайвширчээ. Иш-Химам ийм тансаг зоогийг урьд өмнө үзсэнгүй.

Мухамед султан ч өөрийн нүүдлийн их асрыг бариулаад ингэж хүндэлсэнгүй билээ.

-Иш-Химам чи одоо хаана сууна гэж Чингис хаан асуув.

-Би ... гээд Иш-Химам түгдрэв. Учир нь түүний төрөлх хот Тахраныг Чингис хааны цэрэг эвдэн сүйтгэсэн байв. Тийм учраас Иш-Химам Чингис хааны энэ асуултанд тэр даруй хариу хэлж чадсангүй гацаж хоцорчээ.

-Чиний хот сүйрчээ гэж Чингис хаан инээв.

-Тийм ээ. Хаантан. Цэргүүд дэмий эсэргүүцсэн юм гэж Иш-Химам тал засав.

-Чи их уран хүн юм. Нэгэнт төрсөн хот чинь үгүй болсон болохоор чи надтай хамт манай нутагт очигтүн. Би өөрийн улсад Бухар, Самарканд шиг сайхан хот байгуулахыг хүснэ. Чи юу гэж санана.

-Хаантан минь. Би бол уран мужаан, дархан хүн тул хаана ч байсан ялгаагүй үзэсгэлэнт орд харш байгуулахыг хүснэ. Энэ бол миний амьдрал юм гэж Иш-Химам баяртай өгүүлэв.

-Тэгвэл чи өөрийн хүссэнээр бас манай монголын талд тохирсон гайхамшигт хот байгуулагтүн. Би чамд юу хэрэгтэйг бэлдэж өгнө гэж Чингис хаан баясгалантай хэлжээ. Чингис хаан үнэхээр монголынхоо тал нутагт ирсэн гийчдийн нүд булаасан тансаг хот байгуулж суурин суухыг хүсч байв. -

Чингис хаантан.

Надад Багдад, Самарканд, Бухар шиг их хотыг удирдан байгуулсан гавьяа зүтгэл үгүй. Гэвч би

хичээе. Та надад газар газраас мэдлэгтэй сайн урчуудыг олж өгөх биз. Би хот босгож чадвал Чингис хаан танд ивээгдсэний ачийг хариулах юм гэж дор мэхийн ёслов. Урлаж бүтэхээс өөр хүсэлгүй энэ хүн Чингис хаанд таалагджээ. Иш-Химамыг үдэхдээ Чингис хаан түүнд Энэтхэг газрын торгон дээл, их алт өгсөнд Иш-Химамын хөл газар хүрэхгүй болжээ. Харин Иш-Химамтай цуг ажилласан урчуудыг Боорчи өөрөөс нь үг зарлиг асуулгүй дур мэдэн бүгдийг нь алсанд Чингис хаан хилэгнэн хоёр өдөр уулзсангүй. Хэдэн муу боолын төлөө ингэж сүйд болсонд Боорчи ч дотроо дургүй хүрч Чингис хааны хилэнг нэг их ойшоож харамссангүй, түүний дараагийн зарлигийг тэвчээртэй хүлээж байв.

Харин Сүбээдэй, Зэв нарын элч ирж тэд Днепр гэх их мөрөнг гатлан Киевийн их вантай тулалдахаар зэхэж буйгаа хэлүүлжээ. Элчийг гэдрэг буцааж

-Өөрсдийн хүссэнээр явагтүн гэж хэлүүлсний дараа л Чингис хаан тайтгарч

-Боорчи. Бид хол явж хот балгас эвдэж үзлээ. Одоо яг тийм хотыг тал нутагтаа босгоё гэж санахгүй болохоор чи аргагүй морин унаатан, модон ташуур тан төдий юм даа гэж зөөлөн зэмлэжээ.

-Хаан таны зарлигийн нуцыг чандлан хадгалахын үүднээс ингэж хийсэн билээ гэж Боорчийг биеэ өмөөрсөнд Чингис хаан хариу хэлсэнгүй өнгөрч Боорчийн сэтгэл ханажээ.

Удалгүй намрын дунд сарын битүүн болж, саргүй нүхэн хар шөнө эхлэхэд Чингис хаан Барыгжан уулын оройд гарахаар шийдэв.Тэр энэ өдрийг мэргэ төлөг үзэж өөрөө тогтоов. Ер нь Чингис хаан аливаа үйлийн эхлэх өдрөө зөв сонгохыг ихэд чухалд үздэг, ихэвчлан өөрөө мэргэлэн тогтоодог тул бүгд түүнийг дагаж сурчээ. Аливаа цэрэг дайны болоод бусад чухал хэргийг эхлэх өдрийг тогтоохдоо Чингис хаан ер алдаж байсангүй. Энэ удаад ч намрын сүүл сарын битүүний өдрийг сонгон авчээ.

Шөнө саргүй тул морины чих ч үл харагдана. Харин энэ шөнө Чингис хааны их өргөөнөөс Барыгжан уулын бэл хүртэл Боорчи өөрийн түмэн торгон цэргээ арван алдын зайтай морьтой нь цувуулан зогсоож тус бүрт бамбар бариулсан нь гурван өртөө илүү газарт гэрэлт зам үүсгэжээ. Морьтой торгон цэргүүдийн барьсан бамбарын гэрэлд Чингис хаан, Боорчи хоёр нумтай хөнгөн сүйхээр давхиж явлаа. Барыгжан уулын бэл хүртэлх явах замыг чулууг түүлгэж хонхор хотгорыг шороо асган тэгшилж зассан билээ. Боорчи аливаа зүйлийг ганц Чингис хааны таалалд нийцүүлж сурсан зангаар юуг ч үл орхигдуулан ширхэгчлэн нямбай бэлддэг ёсоороо энэ бүхнийг олон боолын хүчээр хэдхэн өдрийн дотор амжуулж бэлдсэн байв.

Дөрвөн морь хөллөсөн хөнгөн сүйх торолгүй, донслолгүй довтолгосоор төдөлгүй Барыгжан уулын бэлийг өгсөж элгэн хадан оргилын хөлдэх хүрдэт оньсны дэргэд очиход тэднийг Үүлэн чэрби болоод Иш-Химам нар хүлээж байв. Оргилд гараад буцах болмогц дугтарч дохио өгөх нарийн олсыг Иш-Химам Чингис хаанд үзүүлж, учрыг тайлбарлаад дээш өгсөхөд зориулан угсарсан жижиг сүйхний үүдийг онгойлгов. Тэр сүйхээр Чингис хаан олсоор татагдан өгсөх ажээ. Сүйхний дөрвөн буланд дөрвөн их бамбар зоосон нь хавь орчныг гэрэлтүүлнэ. Боорчийн сэтгэл гэнэт түгшүүртэй болов.

Таньж мэдэхгүй хүний нутагт энэ гүн шөнийн харанхуйд чухам яах гэж ингэж байгаа учрыг

олсонгүй. Гэвч Чингис хааныг хориглох эрх түүнд байсангүй. Ганцхан олс нь тасрах вий, эсвэл оньс нь гацаж эвдрэх вий гэж түгшин байх зуур Чингис хаан ер сэтгэл төвдсөн шинжгүй сүйхэнд орж үүдийг хаагаад.

-За явцгаая гэж хашгирчээ. Цуг яв гэж хэлээгүй тул Боорчи дэмий л сүйхний үүд сайн хаагдсан эсэхийг шалгаж үзэхээс хэтэрсэнгүй. Бурхан халдуныг тахиж оргилд нь гарахад хэн ч Чингис хааныг дагалддаггүй тэр ёсыг Боорчи дагав.

Чингис хаан ч онцгойлж элдэв үг хэлсэнгүй. Иш-Химам хашгирахад хоёр том хүрд тавь тавин хүний хүчээр чахран эргэхүй сүйх дээшлэн өгссөөр харанхуйд үзэгдэхгүй болж, сүүлдээ дөрвөн их бамбар нь од адил гэрэлт цэг болон хувирав. Ямар нэг зүйл болохгүй бол дохио өгч татах ёстой олс хэвээр унжиж, хүрд эргэсээр. Боорчи тэнгэр өөд ширтэж эцэст нь аль нь бамбарын гэрэл, аль нь од болохыг ялгаж танихгүй болмогц гэнэт сэтгэл нь хүйт оргин түгшүүр улам хүчтэй болж байв. Тэр ингэж их айж байсангүй шиг санагдана. Юу гэж Чингис хааныг ганцаар явуулав гэж одоо өөрийгөө харааж зогсов. Тэр ерөөс тайвширч чадахгүй байв.

Ертөнцөд ганцаар хоцрох мэт ийм аймшгийг Боорчи хамгийн анх хэзээ амссанаа саналаа. Тэр шөнө яг ийм нүх мэт харанхуй байсан билээ. Жамухыг Гүр хаанд өргөмжилж найманы Буйруг хаан, тайчуудын Аучу баатар нар цэрэг цуглуулан ахуйд Тэмүжин, Тоорил хантай хавсран тэдэнтэй Хүйтэн ууланд байлдсан тэр шөнө яг ийм нүх мэт харанхуй байжээ.

Өдөржингөө зууралдан тулалдаж харанхуй болсон хойно цэргээ хойш татан өглөөг хүлээхээр хуарандаа цугларвал Тэмүжин Зэлмэ хоёр үгүй болжээ. Бүрий болохын алдад Тэмүжинг шархдан унахыг үзсэн цэргийн хэлэхийг сонсоод Боорчи чухам юу хийх яах учраа олохгүй анх удаа зүрх чичрэн яг өнөөдрийнх шиг балмагдсан билээ. Тэмүжин Зэлмийн хамт алга болсонд тэднийг амьд үлдсэн гэж итгэхээс илүү нэг дор л алагдсан байх гэсэн аймшигт бодол хамгийн түрүүнд хүн бүхний толгойд оржээ.

Хасар болоод бусад нөхдийн сүр сүлд Тэмүжинтэй хамт алга болсон мэт царай алдан гуньж гутарсныг харахад Боорчид бүр ч хэцүү байв. Үнэхээр тэдний хэн нь ч Тэмүжинг үхнэ гэж санаагүй явсан нь ингэж цочирдоход хүргэв. Тэмүжин тэдэнд хичнээн үнэтэй хүн болохыг Боорчи ганц мөчийн дотор мэдэрчээ. Хасарын нүднээс нулимс ус адил урсана.

Боорчи арай ч уйлсангүй.

Тэмүжин алга болсныг, эсвэл үхсэнийг тэр даруй Тоорил хан болоод өөрийн цэргүүдэд дуулгахгүй байх нь зөв гэсэн ганц бодол төржээ. Тэмүжин үхсэн бол яах вэ гэсэн аймшигт бодол тархин дотор нь эргэлдэж бас яахаа ч үл мэднэ. Ганц хормын дотор хүн хичнээн олон зүйл бодож амждагийг тэр үзжээ. Эцсийн эцэст Хасараас өөр дотночлон зөвлөх хүн ч үгүй байв.

Болсон хэрэг явдалд Боорчи ганц өөрийгөө буруутгаж байлаа. Учир нь Тэмүжиний амь насыг хамгаалах ёстой хүн нь Боорчи юм. Гэтэл Хүйтэн уулын тулаанд Жамухын дагуул монгол аймгийн Аучу баатарт жадлагдан мориноос унасан ч Боорчи арай л амиа алдсангүй үлджээ. Түүнийг ингэж явгарч сандраад дайснуудад бүчүүлэн алалдаж байх зуур Тэмүжин нүднээс далд орж хаана байгааг мэдэхийн аргагүй болжээ.

Толгой руугаа илдээр дэлдүүлж ухаан алдан унахдаа Боорчи өөрийгөө үхэв гэж санасан билээ. Гэтэл дуулганыхаа ачаар тэр үхсэнгүй амьд үлджээ. Харин унасан хойно нь жадалж орхиогүй нь гайхалтай. Дуулгын дороос асгарсан цусанд нүүр ам нь будагдаад хүн таних нь бүү хэл, харахын эрхгүй болсон нь түүнийг аварчээ.

Ингэж Боорчи амьд үлдсэн ч Тэмүжин, Зэлмэ хоёр алга болсон нь Боорчид үхсэнээс долоон дор юм болов. Боорчид тулалдааны газар руугаа буцахаас өөр зам үлдсэнгүй.

Үүр цайхаас өмнө Тэмүжинг амьд, үхсэн аль нь ч болов олох ёстойгоо Боорчи мэдэж байв.

Хөл болж олуулаа орилж хашгирч дайсанд сэжиг авахуулахаас сэргийлэн Боорчи, Хасар хоёр итгэлт цөөн нөхдийн хамт явжээ. Хүйтэн уулын хэдэн суга жалга, хүний өөрийн цэргийн хүүр дүүрсэн газраар нүдгүй шөнө тэмтчиж, хүйтэн, бүлээн хүүрийн цустай нүүр амыг тэмтрэн тэмтрэн эржээ. Боорчи тэр хавьд хашгирч болохгүй байв. Тэмүжин шөнө яг шар шувуу шиг харах тул амьд сэргэг байвал эрхбиш тэднийг харна гэдэг л ганц горьдлого байлаа. Хүүрийн дээгүүр биенээс салсан сүснүүд эргэлдэж, дутуу үхсэн биенээс салж чадаагүй сүнс чарлалдан байхыг Боорчи үзэж сонсохгүй нь харин азтай хэрэг болжээ.

Түүнд тийм чадвар байхгүй нь энэ удаа Боорчид тус болов. Эс тэгвэл эргэлдэж, орилолдон чарлах хэдэн мянган сүнсийг үзсэн хэн болов ч солиорч эрүүл ухаанаа алдах байлаа. Боорчийн халуун нулимс цусанд хутгалдсан нүүр рүү нь урссаар байвч -Тэмүжин, Тэмүжин гэж шивнэн гарт дайралдсан хүүрийг эргүүлэн нүүр амыг нь тэмтрэнэ.

Хүүрийн хүйтэн нүүрэнд хүрэх бүр хуйх нь ханзран, үс нь босох шиг болно. Харанхуйд юу ч үл үзэгдэх тул зөвхөн хуруу гарынхаа мэдрэмжинд найдах бүлгээ. Барьж үзээд Тэмүжинг мянган хүний дундаас ч танина гэж өөртөө итгэнэ. Чухам яаж танихаа тэр ойлгосонгүй ч борооны ус, шавар шалбааг дотор мөлхөн ундуй сундуй унасан хүүрнүүдийг тэмтчин урагшилж байв. Гэнэт дулаан бүлээн нүүр гарт тааралдсанд цочин давхийлээ.

-Тэмүжин ... Тэмүжин гэж баярлан шивэгнээд өндийлгөв. Гэвч тэр Тэмүжин биш байлаа.

-Чи хэн бэ ... Тэр цэрэг харанхуйд юуг ч юм бувтнах нь дэргэдээ хүн ирснийг лав мэдсэн бололтой.

-Чи хэн бэ ...гэж Боорчи нүүрэнд нь тулан шивэгнэв. Аманд нь чихээ наан чагнаж байж сая нэг юу гэж бувтнахыг нь олж сонсов.

Тэр цэрэг

-Чи намайг үхүүл... гэж сонсдох төдий шивэгнэх ажээ. Боорчи түүний хэрхэн шархадсаныг мэдэх санаатай гар сунган тэмтрээд цочин ухрав. Тэр цэргийн гэдэс хүү татагдаж дотор эрхтнүүд нь газраар нэг хаягджээ. Өмхий үнэртэж байсныг Боорчи сая л мэдэв. Тэгмэгц хутгаа сугалан түүний хоолойг тэмтэрч байгаад тас хэрчиж буян болоод цааш мөлхөв.

-Тэмүжин, Тэмүжин ... Хэрэв Тэмүжин амьд байдаг л юм бол хэзээ ч дэргэдээс нь холдохгүй гэж тангараглан Тэнгэрийг дуудан Тэмүжинг амьд үлдээхийг гуйж явлаа. Боорч ийнхүү

Тэнгэрээс аврал эрэн дуудсан нь анхных байлаа. Тэнгэр түүнд туслана гэж итгээгүй ч ийм үед өөр хэнээс аврал тусламж эрэхээ тэр даанч мэдсэнгүй. Боорчи мөлхсөөр эцэст нь Онон мөрний хүйтэн усанд тулжээ. Эндээс холгүй Тайчуудын цэргийн хүрээ байгаа билээ. Боорчи Ононы хүйтэн усанд хувцастайгаа булхан ус залгилав. Дотор нь халуун оргин шатах нь арай дээрдэж ухаан санаа нь сэргэх шинжтэй болов. Уснаас цус амтагдах нь Онон цусаар урсаж байх шиг ажээ.

Голын хүйтэн усанд цохигдон жаахан ухаан ороод цаана нааныг сэхээрэн бодох сөхөөтэй болсон Боорчийн сэтгэлийн цочрол, хөөрөл нь дарагдаж юу хийж байгаагаа эргэцүүлж бодов. Энэ гил хар шөнө тэр Тэмүжинд ямар ч тус хүргэж чадахгүйгээр зогсохгүй ингэж нүд сохор, сэтгэл балайгаар иш мухаргүй зориглох нь өөрийн амийг ч алдах бас бусад нөхдийг ч үхүүлд хүргэх аюултайг ойлгов.

Хүний өөрийн цэргийн хүүр тэмтрэн тарж одсон нөхөд нь одоо хаана явааг бүү мэд. Тэднийг үхэхгүй, дайсанд олзлогдохгүй гэх газаргүй.Тэмүжиний үгүй болсны дээр цэргийн сүнс сүлд нь болсон нөхдөө нэмж алдах, бүх юм муугаар эргэсэн тохиолдолд Тэмүжинг залгамжлах ёстой Хасарыг ч хамгаалалтгүй орхисон нь түмэн алдаа болсныг ч тэр сая л ойлгов. Ийн санамагц Боорчи уснаас даруй гарсан ч хаашаа явах учраа олсонгүй.

Гэтэл тэнгэрийн зүүн хойт хаяанд гэрэл тусч удалгүй нэгэн хачин цэнхэр гэрэлт бөмбөлөг түүнийг чиглэн хурднаа ойртон ирэхийг үзээд гайхан зогсов. Боорчи ийм хачин сонин юм урьд нь огт үзсэнгүй тул гайхах, айхын алин болохоо мэдэхгүй мэлэрлээ.Гэрэлт бөмбөлөг түүний толгой дээр ирэхэд Боорчи айж ус руу зугатан оров. Гэтэл бөмбөлөг хөдөлсөнгүй, бүр түүнийг даажигнан харж байх шиг.Боорчи айхаа больж гэрэлт бөмбөлөгийг сайн ажив. Түүний хурц гэрлийн өөдөөс харах нь сохрохтой адил тул тэссэнгүй.

Бөмбөлөг баруун тийш зайлан явснаа түүнийг хүлээх мэт зогсов. Боорчи өөрийн мэдэлгүй түүнд хөтлөгдөн хойноос нь дагажээ. Бөмбөлөг түүнийг дагахад цааш улам хурдлана. Боорчи бүхнийг мартаад хойноос нь гүйж эхлэв. Хүүрэнд бүдэрч унасан ч бөмбөлгөөс хоцрохгүй гүйсээр байв. Бөмбөлгийн гэрэлд зам нь гэрэлтэнэ. Бөмбөлөг зогсоход Боорчи гүйсээр дор нь очиж зогсов. Гэтэл өнөөх бөмбөлөг гэнэт гарч ирсэн шигээ гэнэтхэн алга болов. Эргэн тойрон тас харанхуй боллоо.

Боорчид үүр цайхыг хүлээхээс өөр арга үлдсэнгүй. Тэмүжиний хүүрийг л эрж олох үлдэв гэж тэр гашуудан бодсоор бүр нулимс урсган суув. Боорчи өөрийгөө зөвтгөх, цагаатгах арга олсонгүй. Үүр цайж холын уулсын орой, орчмын газрын бараа тодров.

Тэр Ононы бургастай өндөр эргийн дээр сууж байв. Гэрэл түүнийг энэ хүртэл хөтлөн авчраад алга болжээ. Гэгээ орж даруй нөхдөө олж цэрэгтэйгээ нийлэхгүй бол аюул тулгарах тул буцах, үүний өмнө хаашаа явах, хаана байгаагаа мэдэхийн тулд өндөрлөг газар гарч бараа харах нь зөв гэж боджээ.

Гэтэл тэр нэг ч алхаж амжсангүй зогссон газраа нам хэвтэв. Учир нь нүдний үзүүрт бургас хөдөлж хэн нэгэн явахыг олж харжээ. Боорчид хутганаас өөр зэвсэг үгүй байв. Үнэхээр бургасны завсраар хүн явах нь үзэгдэнэ. Тэр ганцаар бололтойг мэдээд өндийж, -Хөөе. Чи юун хүн бэ гэж аяар хашгирав.

-Боорчи чи юу гэх нь Зэлмийн дуу ажээ. Боорчи ч босч гүйв. Бургаснаас дотуур өмдтэй Зэлмэ гарч уттав.

-Тэмүжин яав Зэлмэ дуугүй гэдрэг явж бургасан халхыг сөхвөл Тэмүжин тунасан цусны дэргэд гулдайн хэвтэх ажээ...

-Үхчихэв үү.

-Унтаж байна. Хамаг цусаа юүлсэн болохоор толгойгоо өргөх тэнхэлгүй болжээ. Би Тэмүжиний цусны талыг уусан биз гэж Зэлмэ тайван инээмсэглэн хэлсэн нь Боорчийг тайтгаруулж тэр дороо сөхрөн суугаад Тэнгэрт мөргөв.

-Чи яаж байна аа.

-Би Тэнгэрт мөргөж байна. Шөнө намайг та хоёрыг эрэн хүүрэн дунд тэнэж явахад Тэнгэр намайг дагуулан энд авчирчээ гэж Боорчи хэлэв. Тэр гэрэл бол үнэхээр Тэв Тэнгэрийн дуудахад ирээгүй Хүйтэн уулын савдаг байсан билээ. Хүйтэн уулын савдаг Тэв Тэнгэрийн хүсэлтийг сонсож мэдээгүй тул хоцорч түүний хүч Тэмүжиний хүзүүн дэх Тэнгэрийн сахиусанд шингээгүй ажээ. Тийм учраас Тэмүжин энд Хүйтэн ууланд шархаджээ. Гэвч үхээгүй нь Хүйтэн уулын савдаг тусласных юм.

Зэлмэ, Боорчи хоёр Тэмүжинг авч тэндээс зайлав. Шөнө салсан нөхөд нь ч удалгүй иржээ.

Хэрэв Боорчи ирээгүй бол Тайчууд гэгээ ормогц нойтон шавар дээр Зэлмийн шөнө үлдээсэн мөрөөр мөшгин тэднийг олж Тэмүжин гарцаагүй үхэх байсан юм.

Шөнө Зэлмэ тайчуудын хүрээ рүү нүцгэнээр сэм очиж хөхүүртэй тараг хулгайлан авчирч цус их алдсанаас болж ам нь анган ёолж бачимдах Тэмүжинд уулгасан билээ. Энэ бол хоёул амь алдаж болох аюултай хэрэг байв. Гэвч үүнээс өөр арга Зэлмэд байсангүй. Үнэхээр өглөө нь голын нойтон шавар дээр Зэлмийн тохой урт нүцгэн тавхайн мөр эзнээ хаанаас ирж, хаана очсоныг илтгэн дурайж байхыг тайчууд үзээд давхилдан ирвэл нуугдсан газар нь тунасан цуснаас өөр юм үлдсэнгүй ажээ. Боорчи хэдийгээр өнөөх цэнхэр гэрэлт бөмбөлгийн учрыг олоогүй ч түүнийг Тэмүжинд туслахаар ирүүлсэн Тэнгэрийн дохио гэдгийг гадарлажээ.

Шөнийн гэрэлт бөмбөлгийг ганц Боорчи харсан биш байжээ. Тэр бөмбөлөг тайчуудын цэргүүдэд үзэгдсэнд тэд сэжиглэн зэвүүцэж, цэргийн төлөгч нь мэргэлж үзсэнд дайсанд дийлдэхийн ёр байсан тул маргааш нь тайчуудын ихэнх нь зугатан тарж одсон билээ. Өөрийнх асарт аваачиж, тойгны халуун шөл уулгасны хойно жаахан тэнхэрч өндийсөн Тэмүжин хэдийгээр гүрээний судсаа хага харвуулж цус ихээр алдан тамирдсан ч хэдэн үг хэлэв.

Санаа зовж шаналсан нөхдийн нь царай гийж сэргэв. Цацарт шархтай Тэмүжиний дэргэд Хасар, Боорчи, Зэлмэ гурав л байлаа. Учир нь Тэмүжиний шархадсаныг олноос нуух ёстой тул ингэж хөл хорьжээ. Тэмүжинг ухаан орж сэргэмэгц л түүний шархадсаны буруутан Боорчийг гэсгээхийг Хасар шууд шаардав. Өөрийн хийхийг умартсан бурууг ганц Боорчи хүлээх ёстой гэж Хасар үзжээ.

Тайчуудын Аучу баатар өөрийн шилдэг цэргүүдийн хамт тэдний эсэргүүцлийг няцааж бүслэн авах аюул илэрхий тулгарсан үед Боорчи Тэмүжиний дэргэд байсан цэргүүдийг удирдан халз тулаанд орсон билээ. Ингэж түргэн шуурхай эсрэг довтлоогүй бол Тэмүжиний гол цэрэг Хүйтэн уулын хавцалд хашигдан сөнөх аюул илэрхий байсан ч Боорчи Хасарын зэмлэлийг эсэргүүцэлгүй дуугүй сонсож өөрийгөө зөвтгөх нэг ч үг унагасангүй. Боорчи ер тийм зантай билээ.

Хасарын үгийг няцаан хэрүүл уруул үүсгэхийг тэр хүссэнгүй. Тэр Тэмүжиний үгийг дагахаар шийджээ. Боорчийн ийн дуугүй зогсохыг буруугаа хүлээж байна гэж Хасар ойлгов. Нэгэнт Боорчийн буруу илэрхий, түүнээс болж Тэмүжин хамгаалалтгүй болж амь эрсдэх дөхсөн нь тодорхой тул Боорчийг үхүүлэх ёстой гэж Хасар шууд тулгав.

Боорчийг ирснээс хойш гэрийн дотрох байр суурь, эрх мэдэл нь илт хумигдаж, Тэмүжин энэ залууд бүгдээс илүү нүүр өгөх болсонд Хасар угаас дургүй байжээ. Тэмүжиний дараагаар өөрөөс нь илүү хүндлэл хүлээсэн Боорчийг одоо л дарж авах ёстой гэж Хасарын дотор бодогджээ. Зэлмэ бол угаас тэдний боол тул ямар ч үед Хасарт хүндэтгэл үзүүлнэ. Харин Боорчи бол тийм биш. Хасарыг өөрөөсөө дорд үзэх мэт санагдах болоод уджээ.

-Хэн хэлсэн үгэндээ эзэн болж үл чадна, тэр хүнийг бусдад дохио санамж болгон үхүүлэх ёстой. Би ч байсан тэгэх болно гэж Хасар шаардав. Тэмүжин бодолд унав. Бусад нь түүний үгийг хүлээн таг дуугүй сууцгаана. Түүний шархадсан нь Тэмүжиний нөхдийн байлдах дайтах арга чадвар, цэргийн сахилга үнэндээ дутуу байгааг илрүүлжээ. Гэвч Боорчийг буруутгах сэтгэл Тэмүжинд огтхон ч төрсөнгүй. Бас Хасарын шаардсан нь ч зөв гэж бодно.

Боорчи бол Тэмүжинд Тэнгэрээс илгээсэн хамгийн анхны ганц үнэнч нөхөр нь юм.

Тэнгэр түүнийг Боорчитой учруулахын тулд Жүрхэн аймгийнхнаар найман шарга агтыг нь хулгайлуулсан гэдгийг Тэмүжин ойлгосон билээ. Гэтэл Хасарын хэлсэн ёсоор Боорчийг шийтгэх нь цэргийн сахилга журмыг бататгах сайн арга, сургамж болох байв. Бас үнэнч нөхөр гэж тал тохой татаж хэнийг ч дээгүүр үзэхгүй чин шударга шинжийг үзүүлэх тул цэрэг ардын дунд Тэмүжиний нэр нүүрийг ч өсгөх юм.

Боорчийг үхүүлэх амархан. Бас тэгэх шалтаг бэлхнээ байв. Боорчи ч үхэхийг үл тооно. Айх ч үгүй биз. Харин Боорчи, Хасар хоёрын хэнийг сонгох вэ гэдгээ шийдэх цаг Тэмүжинд одоо иржээ. Хэрэв Хасарын үгийг дагаж Боорчоос хагацвал хэн түүний орыг нөхөх билээ. Хасар уу. Эсвэл Боорчийг өршөөж Хасарын үгийг няцаавал Хасарын сэтгэлийн дотрох эгдүүцэл нэмэгдэж гэрийн дотор дайсан бий болох аюултай. Хуяг дуулга өмсөлгүй цалгар зан гаргаснаас үүдэж дайсны суманд өртөн шархадсан нь ах дүүгийн холбоо, Өүлэн эхийн нэр сүрийн дор дарагдан явсан далд зөрчил тэмцлийг илрүүлэн гаргаж буйг Тэмүжин харав.

Хэрэв тэр үхсэн бол Хасар нэгэнт өөрийн эрхийн дагуу Тэмүжинг залгамжлах нь гарцаагүй байсан биз. Өөрөө үхэж, хэн нэгэн түүний байр суурийг эзэлнэ гэж Тэмүжин бодохыг ч хүсэхгүй байлаа. Гэнэт төрсөн энэ бодол нь түүнийг ингэж бухимдуулна чинээ санасангүй. Энэ бухимдал эцэст нь Тэмүжиний шийдвэрийн үндэс болсон юм. Хасарын хэлсэн шиг Тэмүжиний үхлийг хүсэх шалтаг Боорчид үгүй. Харин Боорчийг үхүүлэх нь Тэмүжинг хамгаалалтгүй болгох гэсэн Хасарын далд санаа шиг санагджээ. Тэмүжин үхвэл чухам хэнд

ашигтай нь даанч тод ойлгомжтой байлаа.

-Боорчи гэж Тэмүжин арай ядан шивнэв. Бүгд анхааран чагнажээ.

-Боорчи гэж Тэмүжин дахин арай тод хэлээд хагас өндийв.

-Тэмүжин чи олон долоон юм хэлж бүү зовоо. Би өөрийн гэмийг үхэж цагаатгая гэж Боорчи эргэлзэхгүйгээр хэлэв. Хасар бардам инээмсэглэхийг Тэмүжин олж үзэв.

-Боорчи, Хасар, Зэлмэ та гурав сонс. Энэ Боорчи бол Тэнгэрээс заагдаж, түмнээс түрүүлж дэргэд ирсэн ганц нөхөр минь юм. Ийм тулаанд үхэхгүй бие, үрэгдэхгүй амь гэж үгүй. Би өөрийн сэрэмжгүй алмайдаа дайсны суманд өртөв. Би Зэлмийн хэлснээр толгойн дуулгаа өмссөн бол юунд ийм хэрэг болох вэ. Би Хасар дүүгийн үгийг ойлгон сайшааж байна. Хэн ч байсан гэмээ шударгаар хүлээх ёстой юм. Бид Хасарын саяын хэлсэн журмаар цаашид өөрсдийгөө болоод цэргүүдээ хүмүүжүүлбэл зохино. Тийм ээ, Боорчи буруутай. Гэвч тэр торгон цэргээ авч Аучу баатрыг эсэргүүцэн тулаагүй бол бид бүгд үхэж болох байв.

Үүний төлөө Боорчийг бас сайшаавал зохино. Хасар өчигдөр Жамухын гол цэргийг хориглон зогсоох гэж яаж баатарласныг би үзсэн. Чиний хүч, зориг дайсны зүрхийг үхүүлэв. Чамгүй бол би юу хийж чадах билээ. Хасар бол халуун амь, хатан биеэ надад зориулах ёстой дүү минь юм. Чиний байлдах дайтах арга, үл шантрах зориг, цавчих харвах эрдмийг хэн ч үл гүйцнэ. Гэмтэн хүнд гэмийг оноох ухааныг чинь би биширлээ. Чи үүнээс хойш энэ үгээ үргэлж санаж бас үргэлж дэргэд минь байж сануулж явагтүн.

Өнөөдөр бид нар үхэх биш, үрэгдэхгүйн төлөө санаж сэдэх ёстой. Өнөөдрийн өчүүхэн гэмээр, өнгөрсний өш хорслоор өнө ирээдүйн их хэргээ умартахгүй байвал зохино. Үүнийг санагтүн. Би Боорчи чиний хүчээр амь аврагдав гэж санана.

Хэрэв чи нүдгүй хар шөнө Зэлмэ бид хоёрыг олоогүй бол бид тэнд тайчуудад баригдан алагдах байлаа.

Харин чи Тэнгэрийн зааснаар уйгагүй явж олжээ. Би чиний энэ сэргэг байдал, сэтгэлийн үнэнчийг чинь мартахгүй.

Би чиний ачийг яаж хариулах билээ гэж Тэмүжин хамаг тэнхээгээ шавхан хэлээд толгойгоо даахгүй унажээ.

Тэмүжиний энэ үг Хасарт таашаагдаж, Боорчийг уярааж, Хасар болоод Боорчийн хооронд, бас Тэмүжин болоод Хасарын дунд үүссэн зөрчлийг түр намдаан тайвшруулав. Тэмүжин ончтой үг олж хэлжээ. Зэлмэ харин гайхсан дүр эсгэж

-Тэмүжин чи юу ярина. Нөжирсөн цусыг чинь шөнөжин шимж, амь хайргүй явсан миний гавьяаг яана хэмээн баяртайгаар хөхөрч хар саналгүй үнэн бодлоо хэлэв.

-Зэлмэ би чиний тусыг багад үл үзнэ. Хожим хойно есөн удаа ял хэлтрүүлье гэхэд бүгд инээлдэв.

-Би тэгвэл мөнхөрсөн мэт болжээ. Харин чи Боорчийг лавтай надаас илүү үзжээ гэхэд Тэмүжин ер тоглосон янзгүй

-Би биш Тэнгэр ингэж үзжээ хэмээн шивнэхэд хэн ч хариу хэлсэнгүй.

-Боорчи, Зэлмэ та нар сонс. Миний шархадсаныг бусдаас нууцалсан чинь сайн хэрэг. Цаашид ч бүү мэдэгд. Харин намайг харвасан цэргийг амьд үхсэн алин боловч надад авчирч үзүүлэгтүн гэж Тэмүжин тушаажээ.

Тайчуудын хуарагнасан цэрэг тэр шөнө ачаа хөсөг, явдлын ая даахгүй эмс хөгшдөө хаяж зугатан одсон нь Тэнгэрийн аврал байсан боловч Тэмүжиний шархадсан нь олон зүйлийг ойлгуулж, бас олон зүйлийг өөрчлөхийг шаардав.

Юуны түрүүн Тэмүжиний амь нас аймаг, цэргийн бүх амьтай тэнцэхийг ухаарцгаав.

Бас Тэмүжин шархдах буюу үхэхэд хүрвэл цаашид хэрхэх ёстойг хэн ч мэдэхгүй байгаа нь ийм үед дайсны идэш болоход хялбар болохыг илрүүлэв. Бас Тэмүжиний шадар хишигтэн цэргийн байлдааны үеийн сахилга, журмыг бэхлэх хатуу цааз тогтоох, тэднийг сурган хүмүүжүүлэх нь чухал болжээ гэдгийг харуулав. Эцэст нь Тэмүжинг байлдаанд хутгалдан орохыг нэг мөсөн зогсоох хэрэгтэйг ойлгуулав.

Дүү нар болоод нөхдөөс хэн нь ч цэрэг байлдааны хэргийг нэгтгэн удирдах бэлтгэлгүй байгаа нь Тэмүжинг ихэд айлгажээ. Тэднийг бие даан дайтахад сургах, бас дайсныг дарах арга мэх, цэргийн боловсрол, чадлыг сайжруулах нь тулгарсан зорилго болсон байв.

Гэртээ сууж, малаа адуулж, эзнээ дуудсан үед мордож ирдэг иргэн цэргийг, байнгын хатуу сургуультай, дайтах, байлдахаас өөр зорилгогүй байнгын цэргээр солихыг хойшлуулж болохгүй хэрэг гэж тэд шийдсэн нь Тэмүжиний шархадсаны олз байв. Ингэж Тэмүжин нар байнгын цэрэгтэй болох ажлыг шуурхайлсан бөгөөд энэхүү цэргийн цөм нь Тэмүжиний хишигтэн хэмээх торгон цэрэг болж байлаа. Зуут мянганы ноёдын хөвгүүд болон шилдэг гавшгай, амь хайргүй үнэнч тэмцэх дур хүсэлтэй эрсийг сонгон хишигтэн цэргийг байгуулах зарлиг гаргав. Ийнхүү Чингис хааны их аян дайны гол бэрхийг үүрч гадны улсын хүчирхэг цэргийг бут цохисон монголын морьт цэргийн мянгатууд үүсч эхлэв.

Алдаа болгоноос суралцах ёстойг Тэмүжин энд анх удаа нөхөддөө чухалчлан хэлсэн нь тэр өөрөө ч сайтар ухаарч ойлгосны гэрч юм. Урьд тайчуудад олзлогдох үед нь аварч тусалсан зарц Сорхоншар Чулуун, Чимбай хоёр хөвүүнийхээ хамт энэ тулааны дараа дагаж ирсэн нь Тэмүжиний сэтгэлийг туйлын ихээр догдлуулжээ.Сорхоншар бол хэдий боол ч гэлээ Тэмүжинд хамгаас түрүүн их тусыг хүргэж амийг нь аварсан ачтан билээ.

Сорхоншар түүнийг хоёр удаа нуун өнгөрөөж авраагүй бол Тэмүжин тайчуудын Таргудайд алуулж өт хорхойны хоол болох байв. Түүний ачийг хариулах нь Тэмүжиний өдрийн бодол шөнийн зүүд байлаа. Эцэг ах нараасаа тусдаа сууж байсан Сорхоншарын охин Хадааныг нь Мухулай олж ирсэн нь бүр ч баясгалантай хэрэг болов.

Арван хэдэн настай алмай багадаа тайчуудын хүрээнээс амь дүйн оргож ирэхэд нь сэтгэл

гарган асарсан Хадааныг Тэмүжин огтхон ч мартаагүйгээр барахгүй, зүрхний цаана энхрийлэн хүсэмжилж явснаа мэджээ. Цус алдаж сул дорой байсан хэдий ч Тэмүжин Хадаантай амраглан цэнгэхийг хойш тавьсангүй. Хадаан хэдий царай зүс гоо үзэсгэлэн ихгүй ч ид насны шим шүүс бүрдсэн танхил борхон бүсгүй болон хувирчээ.

Хадаан Тэмүжинд хайртай хэвээр ажээ. Тэмүжинд охин биеэ найр тавин өгч эр эмийн үйлийг анхлан амсуулж эдлүүлсэн хүн бол Хадаан байв. Хадааны анхны эр нь Тэмүжин бүлгээ. Тийм болохоор Тэмүжин энэ олон жилийн дотор түүнийг огт мартаагүй бөгөөд бүр сэтгэлийн гүнд хүсэмжлэн явснаа мэджээ. Хадаан эрд гарч айлын эм болжээ.

Гэтэл эр нь өнгөрсөн тулаанд Тэмүжиний цэрэгт алуулжээ. Гэсэн ч Хадаан уй гашуугаа мартаж Тэмүжиний тэврэхэд эсэргүүцсэнгүйгээр барахгүй охин цагийн хонгор зангаараа тачъяадан шунаж биеэ сул тавин өгчээ. Хадаан бол гайхалтай дуулгавартай бүсгүй билээ. Гэвч боолын охинтой шадарлах нь Тэмүжинд зохисгүй байсан тул сэтгэлийн хүслийн чандлан барих ёстой болжээ. Тэмүжин хүслээ тэвчиж Хадааныг гэрт нь буцаав.

Хөөрхий тэр бүсгүй, харцын заяандаа гомдон уйлж явлаа.

Тэмүжиний шаналал ч хязгааргүй байв. Тэдэнд хамт амьдрах заяа байсангүй. Гэвч Хадаан бүх насаараа Тэмүжиний татвар эм шиг явахыг хүсээгүй бөгөөд тэр энэ амьдралаа аз жаргал дүүрэн болгох нэгэн хүсэл зорилго байжээ. Бөртийн хардлага сэжгээс эмээлгүйгээр Хадаан Тэмүжинтэй учрах боломж бүрийг алддаггүй байлаа. Асар их эрх мэдэлтэй бас далд хорон зантай Бөртэтэй эвдрэлцэж эр булаалдан өрсөлдөх нь боолын охин Хадаанд үхэлтэй адил байсан ч Хадаан өөрийн санаанаас буцсангүй.

Их зориг хүслийн нь шагнал болж дөч хүрсэн насандаа Хадаан Тэмүжинээс бие шалтагтай болжээ. Түүний ганц насны хүсэл тэр байсан болохоор бие шалтагтай болсноо мэдмэгц баярлаж хөөрсөндөө учраа олохгүй байлаа. Олдсон үрээ хөвүүн гэдгийг Хадаан зөнгөөрөө мэджээ. Гэвч түүний энэ их баяр хөөр ямар аюул дагуулахыг Хадаан сайн мэдэж байсан билээ.

Бөртийн туршуул эмс эргэлдэж Хадааны хөдлөх гишгэхийг тандаж байдгийг тэр гадарлана. Тэмүжиний хавьтаж ойртсон эмсийг хардаж цагдаж чимээгүйхэн хорлож алдаг нь Бөртийн ганц дуртай ажил болоод удсаныг Хадаан өөрийн нүдээр үзэж мэдсэн тул сэрэмжтэй болжээ. Хэрэв түүнийг Тэмүжинээс бие давхар болсныг Бөртэ мэдвэл золгүй эх үр хоёрт үхлийн аюул тулгарах нь гарцаагүй байлаа.

Сорхоншар Тэмүжинд дагаж ирснээс хойш Бөртэ Хадааныг ихэд халамжлан хүрээнийхээ дотор өөрийн ойр суулгах болсон нь сайн санааных биш Тэмүжиний анхны амраг бүсгүйг хараандаа байлгаж хэзээ жирэмслэхийг нь хүлээсэн хэрэг байлаа.

Тэмүжиний эмс хүүхнүүдтэй орооцолдохыг хорьж цагдах эрхгүй тул харин хавьтсан эмсээс хөвүүн төрүүлэхгүй байлгах нь Бөртийн хийж чадах зүйл байв.

Бөртэ өөрийн хөвүүдэд өрсөлдөгч бий болохыг хэзээ ч зөвшөөрөхгүй билээ.

Өөрт нь болоод хэвлий дэх үрд нь нүүрлээд байсан аюулаас аварч туслах хүн Хадаанд хэрэгтэй байлаа.

Чингис хаанд итгэл олж шадарласан эцэг, ах нартаа Хадаан итгэсэнгүй. Тэд тэртэй тэргүй Бөртийн зарлигаас зөрөх эрхгүй тул түүнийг охиноо дүүгээ гэж хайрлахгүйгээр алж орхих биз гэж Хадаан боджээ. Бас Тэмүжинд ч итгэхгүй байлаа.

Тийм учраас хүсч олсон үрээ зүгээр үхүүлэхийг Хадаан хүссэнгүй. Удах тутам аюултай тул түүнд нэг өдөр ч хүлээх цаг байсангүй. Бие давхар болсныг Бөртэ мэдвэл үхэлтэй адил хэрэг болох байв. Хадаан гэнэт хаашаа алга болсныг Бөртэ яаж ч оролдож хичээгээд олж мэдэж чадсангүй.

Бүх үнэн зовлонгоо тоочин нулимс асгаруулсан Хадааныг үзээд Боорчи удаан татгалзаж чадсангүй. Хадааны дуулгавартай үнэнч зан эртнээс Боорчид таашаагдаж байсан нь түүнийг ийм алхам хийхэд хүргэжээ. Бас Хадаан Бөртэ хоёрын хооронд үүсч бий болох зөрчил тэмцэл эцэстээ юунд хүргэж болохыг урьдчилан таамаглаж сэргийлсэн хэрэг байв.

Боорчийн хувьд юуны түрүүнд Тэмүжиний амар тайван амьдрал хэрэгтэй байсан билээ.

Хадааныг ирснээс хойш Бөртийн зан ааш хэрхэн хувирч байгааг Боорчи анзаарахгүй байхын аргагүй байв.

Тэмүжинг хамгаалж тайчуудын Таргудайн гараас аварч тусалсан Хадаан гэгч гэмгүй бүсгүйг Бөртийн гарт дэмий үрэгдээсэй гэж Боорчи хүссэнгүй. Хамгийн гол нь Тэмүжин Хадаанд хайртайг Боорчи үзэж мэдсэн явдал байв.

Боорчи Хадааныг Алтайн нурууны цаана байх өөрийн хамаатны итгэлтэй айлын хаяанд суулгасан бөгөөд Хадаанаас хөвүүн төрснийг тас нуухаар шийджээ. Харин Хадаан хөвүүн төрүүлснээ Тэмүжинд дуулгахыг чин сэтгэлээс хүссэн ч Боорчи түүний хүссэнээр хийгээгүй бөгөөд хөвүүндээ хэлэхийг ч хориглосон билээ. Ингэх нь хэн хэндээ аюул осол багатай байлаа.

Хадаан гэгч тэр даруу төлөв номхон зантэй бүсгүй Тэмүжиний хөвүүнийг төрүүлсэндээ аз жаргалтай харамсах юмгүй үхжээ.

Харин Хадааны хөвүүн Гэрэгийг арван нас хүрмэгц Боорчи өөрийн дэргэдээс салгаагүй билээ.

Гэрэгийг бүгдээр Боорчийн найманаас олж авсан хүүхэд гэж итгэх бүлгээ.

Тайчууд болоод Жамухын цэргийн орхиж одсон иргэдийг хураан авчирсны дараа олзлогдсон буюу дагаж ирсэн цэргүүдийн дотор Тэмүжинг харваж шархдуулсан хүн байх нь магад тул Тэмүжин тэдний дундуур явж зарим хүнийг бүр тулж очин харж явжээ.

Энд дагаж ирсэн цэргийн нэг болох тайчуудын Зургаадай гэгч эр Тэмүжинг харвасан атлаа айлгүй үлдсэн байжээ.

Зургаадай угийн зоригтой дайнч эр учир Жамуха шиг шөнө дөлөөр зугатаахыг бодсонгүй.

Зугатаасан дорвол дайсандаа алагдахыг тэр дээр гэж үзсэн бөгөөд Тэмүжиний хэрхэхийг хүлээн суужээ. Мөн Тэмүжинг шархдуулснаа ч олж үзэв. Уг нь Тэмүжинг алав гэж санасан билээ. Гэвч Тэмүжин эрүүл саруул явахыг үзээд ончгүй муу харвасандаа ихэд харамсаж суув.

-Хүйтэн уулын тулаанд миний байлдааны ам цагаан хул морины хүзүүг хэн харваж шархдуулав гэж Тэмүжин Зургаадайн өмнө ирээд ойрын хүн л сонсохоор шивнэх шахам асуув.

Боорчи, Хасар, Зэлмэ нар түүнийг залгуулан ПМиний байлдааны ам цагаан морины хүзүүг хэн харваж шархдуулав” гэж дуу дуугаа аван бархиралджээ. Нам гүм боллоо. Дахин хашгирахад нь Тэмүжин чухам юун тухай асууж буйг мэдсэн Зургаадай алгуур босон түүнд дөхөн очив.

Зургаадай, Тэмүжинээс даруй сайн тохой өндөр сүрлэг сайхан эр байв.

-Чи юу гэв хэмээн Тэмүжин эгц ширтэн асуув.

-Би Тайчуудын Зургаадай гэгч билээ. Морины хүзүүг би харважээ.

Алъя гэвэл ал

Алганы төдий газрыг

Алаг болгож өмхийрүүлэх

Алд бие байна.

Аваръя гэж санаад

Амий минь соёрхвол

Халд гэсэн газарт чинь

Харайж очоод би

Хар усыг цалгитал

Хад чулууг хэмхэртэл

Харь дайсныг довтолж

Хаан чамд туслая.

Цээлийг усыг цалгитал

Цэгээн чулууг хагартал

Чин зоригийг гаргаж

Чингис чамд туслая

Хүр гэсэн газарт чинь

Хүрч очоод би

Хүр чулууг хэмхэлье.

Хүний зүрхийг шанталъя гэж шүлэглэн хэлэв.

-Чи яах гэж морийг минь харвав гэж Тэмүжин түүнд бүр нүүр тулж очоод асуув.

-Би алъя гэж харвасан билээ. Зургаадайн энэ чин үнэнч аймшиггүй сэтгэл, цэцэн цэлмэг үг Тэмүжинд таашаагджээ.

-Дайсны хүн дайсагнаж хорлох санаагаа нуух бөгөөтөл харин чи хорлосноо нуухгүй үнэн өчив. Чи шударга, зоригтой хүн юм. Ийм хүнтэй нөхөрлөж болно. Чи миний байлдааны ам цагаан хул морины хүзүүг зэвээр харвасан тул чиний Зургаадай нэрийг халж Зэв гэж нэрлэе.

Чи үгэндээ хүрч дэргэд минь жагсаж зэв мэт хамгаалж яв гэж чамайг өршөөе гэжээ. Учрыг мэдэхгүй хүн морь шархдуулснаар ойлгов. Харин цөөн хүн Зэвийг ямар учиртай ингэж хэлснийг ойлгож байв. Ийнхүү Зэв амь өрсөн байж Тэмүжиний дэргэд ирсний учир энэ юм.

Тэмүжиний энэ гэнэтийн шийдвэр түүний нөхдөд таашаагдсангүй. Хасар эсэргүүцсэнээ илэрхийлж дуугүй эргэн явжээ.

Харин Зэлмэ дуугүй зогсож байв. Өөрийг нь алах гэсэн өстнийг Тэмүжин ийнхүү энэрэн өршөөснийг Боорчи удтал зөвшөөрөн хүлээж чадахгүй Зэвийн хөдлөх, алхахыг хянамгай ширтэж цагдан хянах болжээ. Тэр өчүүхэн төдий сэжиг гарвал Зэвийг дор нь алахад бэлэн байв. Шархадсаныхаа дараа өөрийн амь нас, төр улсын бат бэхийг сахигч шадар торгон цэргийг Боорчиор удирдуулахаар Тэмүжин тогтов. Түүнээс хойш Боорчи Тэмүжиний дэргэдээс холдсонгүй билээ.

Боорчи Тэмүжиний торгон цэргийг удирдах болсон нь түүний нэр нөлөөг нөхдийн дотор илт өргөж Хасарын зэвүүг ихэд хөдөлгөв. Торгон цэрэг бол байнгын цэргийн гол цөм, амин сүнс нь тул Боорчи ингэж Тэмүжиний удаах эрх мэдэлтэн болсон юм.

Уг нь Тэмүжиний удаах эрх дархтан нь Хасар байх ёстой боловч Тэмүжин ингэж шийдсэнгүй. Харин Зэв үнэнч зүтгэх нэгэн үзүүрт зорилгоос өөр далд санаа агуулаагүй ч Боорчи итгэж үнэмшихгүй байдгийг Зэв ч, Тэмүжин ч мэдэх болжээ. Бас дарагдсан дайсны цэргээс урван дагаж ирсэн хүн ганц Зэв биш юм.

Буун өгч үнэнч зүтгэх тангараг өргөгсөд бүгдээр тийм итгэлтэй үнэнч гэдэгт Боорчи үргэлж эргэлзэнэ.

Харыг үзэж хазайж, шарыг үзэж шарвах сэтгэл нэгэнт гаргасан тэд Тэмүжинг хөл алдвал араас нь хутга шаахад хэзээд бэлэн байна гэж Боорчи итгэх тул харуул хамгаалалтыг улам чангаруулан бэхлэв. Удалгүй Тэмүжиний хамгаалалт хамгийн журамтай бат бэх болжээ. Их хаанд өргөмжлөгдсөнөөс хойш Чингис хааны шадар торгон цэргийн тоо түм болж, байнгын цэргийн тоо арван түмд хүрчээ. Боорчи яваандаа Зэвд итгэх болж Зэв ч Чингис хааны унтлагын болоод ёслолын өргөөнд зөвшөөрөлгүй орох болжээ.

Зэв ямар гавшгай баатар болохоо Алтан улсыг дайлахад бахархалтайгаар үзүүлсэн билээ. Зэв ингэж Боорчийн итгэлтэй нөхөр нь болжээ. Боорчийг одоо энд Барыгжан уулын бэлд Чингис хааныг хүлээн түгшиж элдвийн бодолд дарагдан зогсох тэр мөчид Зэв, Сүбээдэй хоёр түүнээс мянган бээрийн цаана Ижил мөрнийг сэм гатлахаар гэтүүлж явлаа.

Харин тэнд Ижил мөрний өргөн хөндийд сартай нам гүм бөгөөд холд Киев хотын их сүмийн хонх дуугарах нь сонсдож байсан билээ.

Монгол цэргийн магнайд Сүбээдэй Зэв хоюул таг дуугүй явж байжээ.

*****

Хорезмын их улсыг эзэлж, Мухамед хаан, болон түүнийг залгамжилсан хаан Желаладдинийг мөхөөж, Хорезмтой хил залгаа Багдад, Энэтхэг зэрэг олон улс, хотыг эзэмшилдээ хураан авсан их ялалтын бахархлыг Хулан хатны гэнэтийн үхэл үргээн зайлуулснаар Чингис хаан тайвширч эс чадаад Тэнгэрт мөргөхөөр шийдсэн нь Боорчийг ингэж ганцаар үлдэхийн аймшигт дахин унагасан ажээ.

Хүрдэнд ороогдон эргэх олсоор татагдсан сүйх дээш өгсөх бүр улам сэргүүн болж салхины хүч нэмэгдэнэ.

Хөлийн доор, толгой дээр ч ёроолгүй харанхуй нөмөрч энэ ертөнцөд гав ганцаар үлдсэн нь Чингис хаанд аймшигтай санагджээ. Иш-Химам гэгч энэ уран дархан буруу тооцсон эсвэл шатны хөндөл, олс гээд аль нэг нь эвдэрч тасарвал Чингис хаан ёроол дээвэргүй харанхуйн дунд ширхэг элс мэт хийсэн мянган алдын дор харанхуйлан байх цавчим байц руу няц унаж үхэх байв.

Уулын оройд дөхөхөд салхины хүч нэмэгдэн сүйх салж унах вий гэмээр салганан үлээгдэхэд дэмий юм хийв гэж харамсах, айх сэтгэл оволзсон боловч Чингис хаанд ухрах буцах хүсэл эс төржээ. Хүсвэл гарт хөврөх олсыг л дугтрахад болно. Түүнийг буцааж буулгана гэдэгт итгэлтэй байв. Боорчийг хуурч болох авч Чингис хаан өөрийгөө хуурахыг үл хүсчээ. Тэр одоо өөрийн хүслийн эрхэнд тэнгэр салхи хоёртой ганцаар хоцорчээ. Сүйх ямар ч болов бэхэлгээнээс мултран хийсэн уналгүй Барыгжан уулын оройд зассан тавцанд хүрч зогслоо. Иш-Химам бүгдийг зөв тооцжээ.

Чингис хаан тавцанд гарлаа.

Тэр одоо гурван мянган алдын өндөрт тэнгэрт зогсож байв. Яг энэ мөчид салхи зогсож сэрүү татсан агаар сэнгэнэсэн нь яг л Бурхан халдун уулын оройд зогсох мэт сэтгэгдэнэ. Чингис

хаан хүссэнээ биелүүлж хүний нутгийн тэнгэрт гарав.

Чингис хаан Барыгжан уулаас дөрвөн зүг найман зовхист өөрийн эзэмшсэн нутгийг бүхэлд нь харж болохоор байв.

Дорноос ойртож буй нарны гэгээг ч олж харав. Холд Каспийн болоод Газар дундын тэнгисийн ус цэнхэртэж байв.

Чингис хаан харанхуйд нэвт харах чадалтай тул бүхнийг алган дээрх шиг үзнэ. Яг одоо Барыгжан уулын ойр орчим харанхуй, түүнээс холдох тутам гэгээтэй үзэгдэх ажээ. Чингис хаан бүсээ тайлж, хүзүүндээ тохоод сөхрөн сууж хоёр гараа дээш сунган

-Дээр хөхрөгч эцэг Тэнгэр минь гэж шивнэв. Энэ бол Тэнгэрийг сэрээн дуудаж буй хэрэг юм.

Алсын үүлс хурдан хурдан эргэлдэн хуйларч Барыгжан уулын зүг, Чингис хааны зүг бөөгнөрөн дөхөхийг тэр үзлээ. Битүү нүргэх дуу сонсдож салхи яг морин хуурын аялгуу шиг, хэн нэгэн амьсгаа шахан хөөмийлөх шиг эгшиглэн үлээв. Энэ бол Тэнгэр түүний үгийг сонсож байгааг илтгэнэ. Хорезмын тэнгэр хилэгнэн түүний үгийг сонсохгүй биз гэж Чингис хаан эмээж байсан билээ.

Гэтэл энэ ертөнцөд тэнгэр ганц байдгийг тэр ингэж мэдэв.

Тэнгэр гэдэг ертөнцийг тольдогч цорын ганц мэлмий болохыг Чингис хаан энд анх удаа бүрэн ойлгожээ.

Тийм учраас хаана ч байсан тэнгэр нэг болох ажээ.

Ганц өөрөө мэдэх тийм нууцаа Тэнгэртэй хуваалцах гэж хүссэн цаг мөч нь иржээ.

Перваны хөндийд суусаар байсан нь зөвхөн Зүчи, Сүбээдэй, Зэв нарын ирэхийг хүлээсэн төдий биш байлаа.

Хулан хатны гэнэтийн үхэлд цочирдсон сэтгэлээ тайвшруулах гэсэн хэрэг төдий ч бас биш юм.Барыгжан уулын оройд ингэж амь дүйн гарсан нь бас өөр учиртай байсан билээ.Гэнэт ард нь чимээ гарч хэн нэг хүний

–Тэмүжин чи юу гэж асуух шиг сонсдоход Чингис хаан айсан цочисондоо зүрх нь салганаж тэр даруй босож эргэн харж чадсангүй хөшжээ. Зөвхөн ”Аллах тэнгэр гэж дэмий дуудаж залбирч мөргөдөггүй ажээ” гэж бодож амжив. Түүний ард Аллах тэнгэр иржээ гэдэгт Чингис хаан бат итгэж байв. Хорезмын тэнгэрт Аллахаас өөр хэн байх билээ.

Барыгжан уулын бэлд түгшүүртэйгээр хүлээн зогсох Боорчи болоод цэргүүдийн дээрээс зөөлөн шиврээ бороо харанхуйд намиран орж эхлэв.Боорчоос алхам ч үл холдох Гэрэг халх авчиран барьсанд Боорчи хэрэгссэнгүй. Боорчи энэ бороонд зүрхэндээ хүртэл нэвт норохыг хүсч байв. Учир нь энэ бороо Чингис хааны үгийг Тэнгэр сонссоны гэрч Монгол нутгийнх нь бороо гэж Боорчи бат итгэж байлаа. Бурхан халдун уулыг тахиж, Чингис хаан Тэнгэрт мөргөхөд яг ийм бороо ордгийг Боорчи мэдэх билээ.Чингис хаан Барыгжан уулнаас өгссөн

шигээ чив чимээгүй бууж ирэв.

Доошлон ирэх сүйхийн бамбарын гэрэлд Чингис хаан үзэгдсэнд Боорчи сая л нэг санаа амарчээ. Бууж ирсний хойно түүний хөмсөг зангидсан догшин сүрлэг царайг хараад Боорчийн тайвширсан сэтгэлд дахин түгшүүр дүүрчээ. Барынжан ууланд гарч Тэнгэрт мөргөхөд ер элдэв явдал тохиолдсонгүй ч Чингис хаан зам зуур нэг ч үг дуугаралгүй явсаар өргөөндөө морилж хэнтэй ч уулзахгүй өдөржин болоод үдэш нь Боорчийг дууджээ. Гэнэтийн ажилundрааж ертөнцөд урьд хожид байгаагүй оньсон шат бүтээлгэн уулын оройд гарсныхаа дараа Чингис хаан ийм хачин зан ааштай болсон нь Боорчийн гайхлыг төрүүлсээр байв. Барыгжан уулнаас эсэн мэнд бууж ирсэн нь Боорчийг тайтгаруулсан ч бас элдвийг шүүмжлэн бодохтой болгожээ.

Бурхан халдун уулын оройд гарч Тэнгэрт мөргөөд бууж ирэх болгондоо Тэмүжин сэтгэл санаа нь сэргэж, тэнгэрийн юу гэж зарлиг болгосныг хөөр бахдал, урам зориг дүүрэн нөхөддөө илтгэдэг байв. Харин Барыгжан хэмээх энэ гурван мянган алд хадан ууланд гарч ирээд ганц ч үг хэлэлгүй өргөөндөө шургасанд Боорчи ихэд алмайран бас түгшүүрлэн гайхсан билээ. Чингис хаан гэнэт дуугаа хураах буюу ихээр инээвэл ер сайн юм болж байсан удаагүй юм. Тэмүжиний эл хачин занг Боорчи болон бусад нөхөд нь эхлээд анзаарч мэддэггүй байсан билээ.

Тэмүжин хүний үгийг сонсоод юу хэлснийг мартсан мэт хөндлөн ширтэн таг чиг суувал дараа нь заавал эсэргүүцэн эгдүүцсэн үг дуугарна.

Эсвэл хүний үгийг сонсоод Тэмүжин гэнэт ихээр инээвэл даруй бушуухан холдон явах буюу болж өгвөл өөр юм ярьж сатааруулах хэрэгтэй. Гэвч ингэсэн ч оройтож дэмий үгнийхээ шанг дориун хүртдэг билээ. Чингис хаан хүний үгийг сонсоод гэнэт ил шууд уурлан хилэгнэх нь ховор. Харин ч ингэж хилэгнэн аашилвал өршөөсөнтэй адил үзвэл зохих ажээ. Удаан дуугүй суух юм уу хөхөрч байхдаа Чингис хаан заавал нэг хорлонтой, муухай харгис шийдвэр бодож олох шиг Боорчид санагддаг билээ.

Тийм ч учраас Барыгжан уулнаас бууж ирээд өдөржин таг чиг суусанд нь их л болгоомжлон сэжиглэн хүлээсэн нь энэ юм. Тэмүжинтэй учирсан анхны өдрөөс эхлэн Боорчи түүний үг, тушаалыг дуугүй даган биелүүлж ирсэн нь Боорчийн хүлцэнгүй доройнх биш, харин Тэмүжиний хийсэн хэрэг, хэлсэн үг бүхэн зөв зүйтэй санагддагийнх байлаа.

Анх адууны билчээрт арван гурван настай Боорчи Тэмүжинтэй тохиолдлоор учирч нөхөрлөжээ.

Эцгээс үлдсэн ганц өмч болох найман шарга агтаа хулгайд алдаад мөрөөр нь мөшгиж явсан Тэмүжин сураг асуухаар хүрч ирэхэд эцгийн мал сүргийг адуулж өглөөнөөс үдэш хүртэл нэг л хэвийн амьдрал ажилдаа уйдсан Наху баяны ганц хүү Боорчи гүү сааж суусан билээ.

Наху баян бол адуу мал арвинтай, ам хэл хурцтай, сэргэлэн овжин ухаантай хүн тул дайсан нөхөр хоёрт тал алддаггүй, зовлон гачаал үзэхгүй амьдарч сурсан нэгэн бөгөөд Боорчи хөвүүнээ ч өөрийн адил засч хүмүүжүүлж иржээ.

Хөвүүн Боорчийн сэтгэлд ямар бодол байсныг Наху баян олж мэдсэнгүй. Боорчи эцгийн хөрөнгийг өвлөн авч тайчуудын Торгон баяны охин сүй тавьсан Гүмүдагаа нас бие гүйцмэгц эхнэр болгон авч суух ёстой байлаа.

Гэтэл Боорчи нэгэнт арван зургаан нас хүрсэн байтал Гүмүда дөнгөж найман настай байжээ. Гүмүда охиныг төрсөн даруй Наху яаран очиж сүй тавихад Торгон баян баярлан угтсан нь тэдний холыг бодсон дотор бодол нь нэгдсэнийх байжээ. Хүүхдүүдээ гэрлүүлэх нь хөрөнгөө нэгтгэн хүчээ зузаатгах, тэгснээр овог аймгийн дотор нэр нөлөөгөө өргөтгөх гэсэн алсын зорилгоос үндэстэй байв.

Нүүдэлчин овгийн амьдралд хамгийн аюултай дайсан нь хөрш нь байдаг жамтай. Хөрштэйгөө худ ураг болох нь дэргэдээ дайсангүй амар амьдрах хамгийн найдвартай арга юм. Энэ л жамын үүднээс Наху баян ганц хөвүүнийхээ ирээдүйн амьдралыг ингэж шийдсэн нь хэдий зөв ч гэлээ идэр залуу Боорчид таалагдсангүй билээ. Гэвч Боорчид өөр амьдрал, өрсөлдөх тодорхой зорилго тэр үед бас үгүй байлаа.

Харин Тэмүжиний давхин ирсэн нь халуун зуны бүгчим өдөр хүслэнт салхи сэрүү татан үлээх шиг сэтгэл сэргээн үзэж эдлээгүй их баяр төрүүлснийг одоо ч Боорчи үл мартана. Бас гүү сааж гэрийн эм шиг суусандаа ихэд ичсэнээ ч үл мартана.

Магадгүй энэ ичсэн сэтгэл нь Тэмүжинд туслах, туслахаас илүү эр хүн гэж харагдах гэсэн хүслийг нь оргилуулсан биз.

Боорчи эцгийн зөвшөөрөх эсэхийг ч хайхралгүй, морио сэлгэн Тэмүжиний хамт үг сураггүй одсон нь амьдралдаа бие даан гаргасан хамгийн анхны эрс зоримог, бас осолтой шийдвэр байсан юм.

Тэмүжинг дагасан нь түүнийг үхэлд ч хүргэж болох байв. Хэрэв эцэг нь мэдсэн бол яавч түүнийг ингэж явуулахгүй байсан билээ.Энэ санамсаргүй зоримог шийдвэр Боорчийн ирэх амьдралыг эцэст нь хүртэл өөрчилсөн юм. Санамсаргүй тохиолдол мэт санагдавч Тэмүжиний гэнэт ирсэн нь ер тохиолдол биш Тэнгэрээс таалан соёрхсон явдал гэдэгт Боорчи эргэлзэхгүй итгэх болжээ. Тэмүжинд Боорчоос өөр үнэнч анд үгүй, Боорчид Тэмүжинд зүтгэхээс өөр эрхэм зорилго үгүй байлаа.

Энэ бол Тэнгэрийн хүсэл юм. Ингэж нөхөрлөснөөс хойш өдгөө хүртэл дөч гаран жил хамт зүтгэхдээ юу эсийг үзэж, юу эсийг хийв дээ. Гэвч би юуны учир Тэмүжинд амиа үл хайрлан зүтгэв гэж эргэлзэн бодсон удаа нэгээхэн ч үгүй юм. Нөхөрлөе хэмээн Билгүтэйг зарж ирүүлсэнд мөн л урьдын адил эцэгтээ хэлэлгүй Тэмүжиний хүрээнд ирснээс хойш тэд хагацсангүй одоо энэ Барыгжан уулын бэлд хамт хүрчээ.

Олон жилийн уртад баяр гуниг, үхэл хагацал хосолсон дайн тулаан мэт амьдралыг өнгөрөөхдөө Тэмүжиний ингэж гансарч царай алдахыг Боорчи ер үзсэнгүй. Лалын шашинтны нэгдсэн улсыг уландаа дэвсэж, өөрийн их улсын хязгаарыг Газрын дундах тэнгис хэмээх их усанд хүртэл тэлсэнд сэтгэл ханаагүй гэхэд хэцүү. Цовоо зантай, адайр ааштай Хулан хатнаа үхсэнд ингэтлээ гуниглана гэхэд итгэмгүй.

Харин Барыгжан уулнаас бууж ирмэгц өргөөндөө морилтлоо нэг ч үг унагасангүй нь яавч сайны ёр биш билээ.

Боорчийг өргөөнд ороход их дэнгийн гэрэл мэлтийж Чингис хаан түүний орж ирэхийг хүлээн сууж байлаа.

-Би хаан таны дуудсан ёсоор ирлээ. Боорчи бүх зүйлийг ёсчлон гүйцэтгэж мэхийн хүндэтгээд зүүн талд гарч суув. Ширээнд тансаг зоог өрсөн нь удаан сууж ярилцахын шинж ажээ.

Чингис хаан бодолд автаж үрчлээт царайд нь зохиогүй мэт харагдах хачин тод хар хөмсөг нь зангирна. Чингис хааны үс, сахал бууралтаж харин хөмсөг нь тод хараараа үлджээ. Чингис хаан үг дуугүй ширээн дэх зоог руу дохив. Боорчи ч элдвийг асууж үг өдсөнгүй. Идээ будаанд хүрсэн болж, дарс аажуухан шимж суув. Тэртээ тэргүй Чингис хааны үгийг хүлээх хэрэгтэй тул яарах сандрах зүйл байсангүй.

-Боорчи чи Отрар хотыг эзлэснийг санаж байна уу гэж Чингис хаан зөөлхөн дуугарав.

-Санаж байна ...

-Хамгийн сүүлд хотын сүмд хэдэн зуун хүн орчихоод бууж өгөлгүй бүр тэндээ шатаж үхсэнийг санаж байна уу

-Саналгүй яах вэ ... Тэнд хүүхэд, эмэгтэй хүн ч хүртэл байсан шүү.

Тийм ээ. Тэр сүмийг яаж шатаж, нурж унан унатал дотроос нь Аллах тэнгэртээ залбирах хүмүүсийн хашгираан сонсодсоор байсныг санахад галд түлэгдэж үхэгсдийн уйлаан чарлаан одоо ч чихэнд нь сонсогдох шиг болж Боорчи мөрөө хавчив.

Хотоос бүтэн үлдсэн тэр лалын шашны сүм нутгийнханд авралын од юм шиг санагдсан биз. Сүмд шургагсад бууж өгсөнгүй тул сүмийг галдан шатаасан билээ. Гал дүрэлзмэгц бүгд гүйлдэн гарч ирнэ гэж монголчууд бахдан хүлээж байв. Гэтэл хэн ч гарч ирсэнгүй. Бүгд Аллах тэнгэртээ залбирсаар шатаж үхэхийг үзжээ. Дөрвөн жил гаруйн өмнө болсон хэрэг явдлыг яах гэж Чингис хаан энэ үдэш цохон асуусны учрыг Боорчи олсонгүй. Бас Чингис хаан чухам юу гэж хариулахыг шаардаж байгааг ухаарсангүй.

-Хаан та юуны учир үүнийг надаас асууна вэ. Үхсэн болгоны учрыг олох гэвэл нас минь хүрэхгүй биз гэж Боорчи хариултаас тойрон гарах арга хайж хэлэв. Боорчийн эл үгэнд Чингис хаан сахал дотроо жуумалзан инээх нь Боорчийн залийг яг таасан хэрэг юм. Бусдыг шоолж дооглосон үедээ Тэмүжин ингэж сахал дороо сэмхэн жуумалзан инээмсэглэдэг билээ.

-Боорчи. Чи юунд ингэж үнэн үг хэлэхээс зайлна вэ. Зах яах вэ. Би чамд учрыг хэлье.

Тэд Чингис хаан намайг Аллах тэнгэрээсээ дорд үзсэн тул амиа хайрласангүй сүмдээ шатаж үхжээ. Чингис хааны энэ үг санаанд оромгүй байсанд Боорчи сандрав.

-Хэрэв тэд намайг үхлээс дээрд үзсэн бол бүгд амиа аврахаар гарч гүйлдэх байлаа.

Чингис хаан надад бууж өгөх нь Аллах тэнгэртэй цуг үхсэнээс дор хэрэг гэж тэд үзжээ.

-Би хаан таны үгийг сайтар ухахгүй байна гэж Боорчи шууд үнэнээ хэлэв.

-Энэ бол суманд оногдож, сэлмэнд цавчигдан үхэхээс огт өөр хэрэг юм. Би үүнийг ойлгосонгүй явжээ. Ингэж хэлээд Чингис хаан гүнзгий санаа алдав. Боорчи түүний ингэж дор орж дорой суухыг үзсэнгүй тул ихэд гайхжээ. Чингис хааны сэтгэлийн гүнд чухам юу өөрчлөгдсөнийг тэр мэдсэнгүй.

-Энэ ертөнцийн бүх хүмүүс намайг аврагч Тэнгэрээ гэж үзэхийг би хүснэ. Чингэхгүй аваас ертөнцийн талыг эзэлж их хаан суухын хэрэг юун. Боорчи чи миний үгийг ухаж ойлгох гэж санаа сэтгэлээ бүү зовоо. Би чамд хэлэхгүй бол өөр хэнд хэлэх билээ. Тэр Аллах гэгч нь Тэнгэр биш аж. Хэрэв Аллах тэнгэр байсан бол сая надтай ярих байв. Гэвч тэр миний үгэнд хариу эс дуугарав. Энэ Хорезмын тэнгэр дүлий аж. Гэтэл тэр Аллах хүмүүний үгийг сонсохгүй мөрт тэд яах гэж түүний төлөө үхэв. Би үүнийг эс ойлгоно гэж Чингис хаан сахлаа илбэн ганцаар ярив.

Ертөнц ганц тэнгэртэй гэж итгэж явсан атал Хорезмын тэнгэр Чингис хааны үгийг сонсоогүй нь түүнийг ингэж гүн бодолд унагасан болохыг Боорчи сая хальт мөлт гадарлаж эхлэв. Бас Хулан хатан газар орны лус савдгийн хорлол болж үхсэнийг ч бодов.

-Чингис хаан та хэрхэх гэж бодно вэ. Бид баруун зүгт зорьсон хэргээ гүйцээж Газрын дундах тэнгис хүртэлх нутгийг, лалын шашинтны их улсыг хураан авлаа. Одоо хэрэг нэгэнт иймдээ хүрсэн тул халуун бүгчим энэ газарт хүн, морио зовоон сул хэвтэхийн хэрэг юун. Их цэрэг нутгаа санаж, чилж гүйцлээ. Тэд бүгдээр их ялалтын баяр хөөрөө ар гэр, амраг садантайгаа хуваалцахыг хүсч байна. Чингис хаан та зарлигаа буулга. Нутагтаа очиж Хэрлэн, Туулынхаа хөвөөнд сэрүүн салхинд цэнгэж суугтун. Ингэхийг бид бүгд хүснэ. Боорчийн энэ үгийг хэлсэний хойно өргөөнд нэг хэсэг нам гүм болов.

Боорчи сүүлийн хэдэн сар сул дэмий суухдаа хэлье гэж бодсоноо сая хэлж санаа нь амрав.

Бас Чингис хаан Тэнгэрээс чухам ийм үг сонссон байх ёстой гэж итгэж байв.

Боорчи Алтайн нурууны ардах өөрийнхөө өргөө гэртээ очихыг туйлгүй ихээр хүсч байлаа.

Шөнө бүр хөөрхий Гүмүда нь зүүдлэгдэж, хуучин шарх сэдрэн өвдөх шиг сэтгэл шаналан өссөн нутаг нь хүсэгдэх билээ.

Энэ бол түүний өвгөрч, ядарсных байв. Далайсан сэлмээ буулгалгүй шахам явсан таван жил өнгөрч Сыр-Даръя, Аму-Даръя, Инд, Ефрат, Тигр таван их мөрний нутаг, ардыг эзлэн авчээ. Одоо Сүбээдэй, Зэв нар баруун, умар зүг үзээгүй нутгийн гүн рүү зөөлөн модонд цүүц шаах адил ярган давшсаар ажээ. Тэд эргэж буцахаас нэгэнт өнгөрчээ. Цусны үнэр авсан өлсгөлөн чоно шиг улайран довтолж байгааг Боорчи мэдэж байв. Сүбээдэйн оронд Боорчи байсан ч чингэх байсан биз ээ. Цус, ялалтын амтанд согтуурсан нохдыг гэдрэг огцом татвал эргэж эзнээ ноцох ч аюултай.

Яг ийм явдал Алтан улсыг дайлахад болсныг Боорчи санаж байлаа.

Алтан хаан их бэлэг сэлт илгээн Чингис хаанд дагаж орохыг гуйсанд зөвшөөрч цэргээ татах зарлиг буулгасан нь Хятадын олон хотыг эзлэн авч ялалт олзонд шунасан цэргийн дотор эгдүүцэл зэвүүцэл төрүүлснийг тэр яахин мартана. Бүр баруун замын цэргийн жанжид Чингис хааны зарлигийг зөрчин Шар мөрний хойд нутгийг түйвээн явсан хэрэг гарсан юм. Тэднийг Чингис хаан олны өмнө зэмлэн буруушаагаад ял хэлтрүүлсэн ч сүүлд нь хүн явуулж толгойлогчдыг нь хөнөөсөн билээ.

Чингис хааны энэ үйлдлийг Боорчи илт таашаасангүй. Учир нь Алтан хааны хуурмаг заль, бэлэг, зүс гоо гүнжид хууртагдсан Чингис хааныг дотроо буруутгасан билээ.

Гэтэл жилийн хойно Алтан хаан дахин самуун дэгдээж Сүн улсад илгээсэн монголын элчийг замаас нь барьж хороосон хэрэг дэгдэж Монголын их цэрэг дахин Цагаан хэрмийг давсан билээ. Алтан хааны заль мэхэнд авталгүй эхний цохилтоор л түүнийг мөхөөх байсан гэдэг нь бүхэнд ил болсон ч Чингис хаан дахин цэрэглэн хөдөлж довтлох зуураа бас л Алтан хааны үгэнд автаж, хөвүүнээ зуун нөхдийн хамт илгээж найрамдахыг гуйсанд зөвшөөрч дахин цэргээ татав. Чингис хаан өөрийн алдааг ингэж дахин давтав. Үүнээс үүдэн багагүй хэрүүл, самуун дэгдэж олны аминд хүрсэн юм. Монголын цэргийн удирдагчдын дотор Алтан улсыг нэг мөсөн мөхөөхийг хүсэгчид давамгайлж байсан ч эрхгүй Чингис хааны зарлигийг дагасан билээ.

Алтан улсыг дахин дахин өршөөж цэрэг моридоо зовоосон Чингис хааны эл хөнгөн хуумгай мэт санагдах шийдвэрийн цаад санаа зорилгыг Боорчи ойлгоогүйгээр барахгүй дотроо буруутган бодсоор яваа билээ. Алтан улс өнөөг хүртэл хэвээр оршсоор, дагасан нэртэй боловч дотоодын самуун дэгдсээр байгаа, тэнд Мухулай цөөн цэргийн хамт эсэргүүцэн дарах гэж хүрч ядаж, хөдөлж цөхөж байв.

Хорезмын улсыг эзлэн авмагц даруй буцахгүй бол Алтан улсын зүгээс ар хударгаар төв Монгол руу довтлохгүй гэх баталгаа үгүй. Бас дээр нь Тангуд улс дайсан болсныг мартах аргагүй юм. Эртний хэлхээ холбоотой Алтан улс Тангуд хоёр эвсэн ар хударгаар довтолбол юу болох нь ойлгомжтой. Монголын цэргийн гол хүч энд байгаа тул Тэмүгэ ноёны цөөн цэрэг их эсэргүүцлийг үзүүлж үл чадах тул хялбархан автах байв. Энэ нь ар гэр, алтан нутгаа эзгүй сул орхисонтой үлгэр нэг юм.

Үүнд Боорчи маш их санаа зовж байсан тул энэ үдэш ам нээвэл уушиг нээ гэгчээр нэг мөсөн сайн хэлж авчээ.

-Боорчи чи, намайг хэн гэж санав гэж Чингис хаан зэмлэсэн өнгөтэй хариу асуусан ч хилэгнэх цухалдах шинж үзүүлсэнгүй. Тэмүжин нөхөрлөсөн цагаасаа хойш хоёулханаа байхдаа Боорчид хатуу үг хэлж хилэгнэж үзээгүй билээ. Харин олны дунд хамаг уур хилэн, омог, муу үгээ Боорчид хандан гаргах нь элбэг. Энэ нь тэдний хооронд тогтсон нэг ёсхы итгэл бусад нөхдөө айлгах, сургамжлах, хууль цаазыг бэхлэх нэг сайн арга болжээ.

Хамгийн дотно нөхөр Боорчидоо ингэж хатуурхан, хилэгнэх нь бусдыг шууд загнаж, донгодсоноос илүү ихээр айлган хүмүүжүүлдэг байлаа.

Тэмүжин ганцхан Боорчид л үнэн сэтгэлээс итгэдэг байв. Тэр Боорчиос өөр хэнийг ч ингэж сэтгэлийн мухарт хоргүй сэтгэлээр итгэн зөвшөөрч үл чадна. Энэ их итгэл Тэмүжинээс биш Боорчийн хиргүй тунгалаг сэтгэлээс үүсэн гарсныг харин Тэмүжин ойлгодоггүй байлаа. Ингэж бодохын учир нь Боорчийг түүнд туслуулахаар Тэнгэрээс илгээсэн гэж итгэдэг болсонтой нь холбоотой юм. Тийм ч учраас Боорчийг үнэнч зүтгэх тангарагтай хүн гэж тооцно. Чингис хаан Боорчийн саяын хэлсэн үгийг бодохгүй биш бодсоор байсан тул шинэ ховор санаа гэж гайхсангүй. Тэр угаас Монголдоо буцахыг хүсч байсан билээ. Перваны хөндийд суусаар даруй жил шахаж эзэлсэн булаасан хот, иргэдийг хууль журмаар зохицуулан төвхнүүлэх ажил ид зүгшрэн ундарч байв. Одоо Сүбээдэй, Зүчи хоёрын цэрэг эргэж ирвэл нутгийн зүг хөдлөхөд бэлэн болжээ.

Зүчийн бие чилээрхэж их хөл хорьж хөдөлж чадахгүй суугаагаа Есөнтэйгөөр бичиг илгээн хэлүүлснийг Чингис хаан үнэмшихэд бэлэн байсан ч Есөнтэй Зүчийн хэлснийг бүгдийг Чингис хаанд илтгэсэн нь чухам аянга ниргэх шиг цочирдуулжээ.

Харин Есөнтэйг Зүчийн нууц бодлыг хэнд ч хэлэхгүй байхыг зарлиг болгожээ. Зүчи үнэхээр толгой мэдэн тусгаар улс байгуулахаар зориглоно гэхэд Чингис хаан эхлээд итгэхийг хүсэхгүй байжээ.

Гэтэл Эрчис мөрний сав газраар нутаглаж байсан Зүчийн албат иргэд их хүрээ эмс хүүхэд нь наашаа нүүж ирснийг Тэмүгэ элч илгээн мэдэгдсэн нь аргагүй Есөнтэйн хэлсэнд итгэхэд хүргэжээ.

Зүчи юу сэдэж байгааг Чингис хаан гадарлаж эхэлсэн нь даруй нутгийн зүг хөдлөхөд саад болжээ.

Үнэндээ Сүбээдэй ямар төөрөх биш түүнийг орхин буцах ёстой юм. Зүчийн дэргэд байх Чингис хааны тагнуул хэл ирүүлснээр Зүчи үнэхээр хэвтэрт орж, өргөөнөөсөө ч цухуйхгүй болсныг баталсан ч Чингис хаан итгэсэнгүй. Хүний хүү хүрэн бөөртэй гэдэг болов гэж тэсч чадахгүй бухимдсаар болдог бол өөрөө Зүчийн тэнд цэрэглэн очмоор санагдах болсон ч тэвчжээ.

Зүчийг зүгээр орхин нутаг буцах аргагүй болсон нь тодорхой байлаа. Зүчийн тухай бодсоноо тэр хэнд ч хэлсэнгүй, бас хэнээс ч асуусангүй.

Зүчи ингэж гэнэт өөрийг нь хаяхаар шийдсэнийг мэдмэгц Чингис хаанд урьд өмнө үзээгүй хачин мэдрэмж төржээ. Энэ бол гомдол харуусал юм. Түүний зарлигийг хүндэтгэн Зүчи цэргээ авч ирэх ёстой юм. Зүчи ирье гэвэл хүүрээ ч болов ачаад ирэх ёстой гэж Чингис хаан бодсон нь түүнийг ингэж хилэгнүүлж бас гомдоход хүргэв.

Барыгжан ууланд гарч мөргөсөн ч түүнд цэцэн ухаан авчирсангүй. Энэ нь Бөртийг буцаан авсан шөнө Мэргэдийн нутагт болсонтой адил хэрэг болжээ. Тэр шөнө Тэнгэр түүнд хариу хэлсэнгүйн адил энэ удаа бас л таг чиг өнгөрөв.

Бодож үзвэл Зүчийн тухай Тэнгэр юу ч гэж хэлэхгүй өнгөрдөг ажээ. Энэ нь Чингис хааныг өөрөө шийд гэсэн үг юм.

Зүчийг төрмөгц алах тухай анх Тэмүжиний өгсөн зарлигийг Боорчи биелүүлээгүй нь өнөөгийн хэргийн үндэс болжээ.

Тийм ч учраас Боорчийг дуудсан билээ. Харин Чингис хаан юу гэж зарлиг буулгахаар дуудсаныг Боорчи таагаагүй ч яг одоо Зүчийн тухай, түүний хүнд өвчинд нэрвэгдсэн тухай бодож суужээ.

Яагаад ч юм бэ энэ үдэш тэдний хооронд чухам Зүчийн тухай яриа болно гэж битүүдээ таамаглаж суулаа.

Бүх байдлыг эрэгцүүлэн бодож үзвэл Зүчээс өөр ингэж Чингис хааныг бодолд унагах зүйл үгүй байв. Энэ олон жилийн гүн нөхөрлөлийн дунд Чингис хааныг Боорчитой бусдаас илүү холбон гагнасан хүн нь Зүчи болохыг тэд урьд нь ер бодож үздэггүй байжээ.

Зүчи гэгч энэ хөвүүн Бөртэд олдсон нь, бас Зүчийг төрмөгц алахыг Боорчид тушаасан нь бүгд л тохиолдол мэт бодогдоно.

Гэвч энэ бол тохиолдол биш үйлийн үр байсныг тэд бас л тунгаасангүй. Тэмүжин болоод Боорчийн хүн чанар, бие биендээ итгэх их итгэлийг шалгах гэж Тэнгэрээс Зүчийг илгээжээ. Хэрэв Боорчи Зүчийг гарсан дор нь Тэмүжиний хэлснээр алж орхисон бол тэдний амьдрал, тэмцэл цаашид хэрхэн өрнөх байсныг одоо хэлэхэд бэрх юм. Үйлийн үрийг угаас өөр бусад үйл явдал тохиолдлоор орлуулан нөхөх аргагүй байдаг билээ.

Одоогоос яг дөчин хоёр жилийн өмнө мэргэдийн дарагдаж сүйрсэн хүрээний дэргэдээс Боорчи тулгар биетэй Бөртийг дагуулан мордсоноо санав. Тэр өдрийн явдлыг Боорчи хэзээ ч мартаж чаддаггүй юм. Мартахын аргагүй үйл явдал учраас тэр биз. Мэргэдийн ам цагаан морь гөрөөсөн хэлбэрт адуу тул эцэж цуцахыг мэдэхгүй довтолгоно.

Мэргэдийн хүрээнээс гарснаас хойш морины ам таталгүй довтолгосон гуравдахь өдөр Зүчи төржээ.

-Боорчи. Зогсооч. Үхлээ гэж Бөртэ өрөвдөлтэйгээр бархирсаар авч зогссонгүй. Гэвч Бөртэ мориноос унасан тул яах ч аргагүй болжээ. Бөртэ ухаан алджээ. Дагалдан явсан хэдэн цэрэг гүйцэн ирэв. Мориноос унахад нь Бөртийг үхэв гэж сандарсан учир ийн зогсчээ. Бөртэ үхсэнгүй, харин ч хормойн доогуур урсах цус, усан дунд сарвалзан чарлах хүүхдээ үзээд цочин алмайрсныг харав.

Морины давхиан дунд эмээл дээр төрсөн хөөрхий үрээ үхлээс хамгаалах ганц арга нь мориноосоо унах байжээ. Бөртэд өөрийгөө бодох зав байсангүй. Зөвхөн төрсөн үрээ л бэртээж гэмтээхгүйг хичээсэн билээ. Мориноос унасан ч хүүхэд нь амьд үлджээ.

Ийм үед яах ёстойг Боорчи, мэдсэнгүй. Бөртэ хэдийгээр огт дуугараагүй ч “Хүүхдийг минь авраач” гэж гашуун нулимс гаслант харц нь гуйж байхад Боорчи чухам л Тэнгэрт хөтлөгдөх шиг нэг л мэдэхэд улаан нялцгай амьтныг гартаа шүүрэн авчээ.

Хүйг нь тас хазаад Боорчи улаан нялзрай амьтныг арвалзуулан алган дээр өргөв. Одоо

түүнийг хажуу тийш шидэх л үлдэв. Халуун биетэй өмөлзөн бархирах тэр хүүхэд хөвүүн байсан нь хамгийн түрүүнд нүдэнд туссан ганц ойлгогдох тэмдэг байв. Энэ явдал хормын төдий болсон ч Бөртэд хичнээн удах шиг болжээ. Боорчи хүүхдийг нь одоохон няц шидэх юм шиг санагдсан боловч юу ч дуугарч чадсангүй. Харин Боорчи харж харж улаан нүцгэн тэр амьтныг энгэрээ яран өвөртөө хийхэд нь Бөртэ сая санаа амран эхэр татан уйлсан билээ.

Одоо болтол Боорчийн цээжинд Зүчийн улаан нялзрай бие, гар хөл анх хүрсэн нь мэдрэгдэх шиг болдог юм.

Тэндээ буудаллан гал түлж, Бөртийг амрааж бас шинэ төрсөн хөвүүнийг амлуулж хоножээ.

Мэргэдийн Чилэгэр бөхийг хичнээн ч үзэн ядсан эх хүний ёсоор Бөртэ шинэ үрээ үзмэгц ухаангүй хайртай болов.

Хөвүүн эхийнхээ уургийг хөхөж, Бөртэ хайрлан инээмсэглэн ширтэж хэвтэхийг үзээд Боорчи “Энэ хөвүүн хэрэв хүн болбол түүнийг өөрийн хүүхэд шиг хамгаалж явъя” гэж өөртөө тангарагласан билээ. Боорчи энэ тангарагаа өнөө хүртэл эвдсэнгүй.

Харин хамгийн гайхалтай нь Тэмүжин эргэн ирээд Бөртийн хөвүүн төрүүлснийг, бас Боорчи түүнийг алсангүйд ер уурлаж хилэгнээгүй, таг дуугүй өнгөрчээ. Зүчи ингэж хүн болсон билээ. Зүчид үхэл үнэхээр ойрхон байв.

Нялх балчир Зүчийг Тэмүжин юу юугүй алчих юм шиг Боорчид санагдсан үе олон. Гэвч муу юм болсонгүй. Магадгүй Тэмүжин Боорчийн сэтгэлийг бодсон ч байж мэднэ. Ер нь Тэмүжин тэгэж хэлэхгүй л бол Тэмүжиний юу бодож санаж байгааг таахын аргагүй билээ. Харин Зүчийн хэрхэн төрснийг Бөртэ хөвүүндээ хэлсэн байжээ. Үүнээс хойш Боорчи, Зүчийг өөрийн хөвүүн шиг үзэх болсон бас нэг шалтгаан нь түүний ёсолж авсан болоод татвар эмсээс өдий болтол хөвүүн төрөөгүй явдал юм.

Зүчийг алж орхисон бол Боорчи лав хөвүүнтэй болох байсан биз гэж бодсон удаа ч олон.

Гэвч Зүчийг амьд үлдээсэндээ Боорчи өдий олон жил болоход нэг ч удаа харамссангүй билээ. Зүчи ч ингэж бодох шалтаг гаргасангүй.

Дуулгавартай, тэвчээртэй, ухаантай Зүчи Тэмүжиний бүх дарамт, доромжлолыг тэсэн гарч өөрийгөө хүлээн зөвшөөрүүлж чадсан жанжин болсон юм.

Зүчээр бахархахгүй байхын аргагүй. Зүчийг хэн нэгэн, тэр дундаа Чингис хаан сайнаар дурсах юмуу магтан сайшаах бүр өөрийн хүмүүжүүлсэн жанжин гэж Боорчи дотроо ихэд хөөрөн омогшдог билээ. Чингис хаан Зүчийн тухай хэргийг заавал Боорчитой хэлэлцэж, ер нь Боорчийг Зүчийн эцэг нь юм шиг ханддаг нь түүнийг амьд үлдээсэн явдлыг зөвтгөж сайшаасан хэрэг мэт бодогдоно.

Зүчи Чингис хаанд зүтгэж ихийг бүтээсний дотор ууган хөвүүний хувьд журамтай, шударга, зоригтой байж бусад хөвүүдэд сайн үлгэр үзүүлснийг Чингис хаан хамгаас онцгойлон үнэлдэг байв. Үнэхээр Цагадай, Өгөдэй, Тулуй гурав Зүчийн үлгэр дуурриал дор өсч

хүмүүжсэн юм. Чингис хаан өөрийн сэтгэлийн гүн дэх зөрчлөө нуун Зүчийг магтах өргөмжлөхдөө харамгүй байж чадсанд нь Боорчи их талархалтай байв.

Харин Зүчи Ургенчийн дэргэдээс хөдөлж цэргээ хураан эргэж ирээгүй нь бүгдийг, тэр дундаа Боорчийг хүртэл гайхшруулжээ. Дуулгавартай, Чингис хааны үг, зарлигт бусдаас илүү үнэнч, хүндэтгэлтэй ханддаг Зүчи ингэв гэхэд итгэмгүй. Чингис хаанаас зааж өгсөн нутгийг тохинуулах нь чухал ч Чингис хааны зарлигийг даган ирэх нь ер юунд саад болохгүй явдал байв. Ирээгүйн учрыг Боорчи өөр зүйлтэй тэр дундаа Цагадайтай зөрөлдсөнөөс болов гэж боджээ.

Ургенчийг авахад Зүчи илт дургүйцэн цэргээ оруулахгүй алгуурласнаас Өгөдэй, Цагадай нарын цэрэг ихээр үхсэнийг сонсоод ингэж үзэх болжээ. Ерөөс Ургенчийг авах гэж Цагадай, Өгөдэй хоёрыг илгээсэн нь буруу байлаа. Тэднийг биш ядаж Шихихутаг юмуу, эсвэл Дөрбэй Догшин ч юм уу, Зүчитэй хэл амаа ололцох тийм хүнийг илгээх байсан нь одоо бодоход зөв байжээ.

Хөвүүдийн хоорондох зөрчлөөс болж Зүчи эргэж ирэхгүй шалтаглах болов гэж Боорчи таана.

Тэдний хооронд юу гээч болсныг Өгөдэй Боорчид ер хэлэхгүй тойруулан өнгөрөөнө. Бас Чингис хаан ч гэсэн Боорчиос нуух мэт санагддаг байжээ. Хөвүүдийнхээ хэн нэгнийг илт дэмжих, нөгөөг буруутгах нь зохихгүй гэж Чингис хаан үзсэнээс ингэж тэвчин дуугүй өнгөрснийг Боорчи мэднэ. Тэгээд ч Чингис хаан зөв шийджээ гэж бодсон билээ.

Ургенчийг эзлэн авах гэж юу болсныг байцаан асуусан бол Цагадай, Өгөдэй нар их олон гомдол санал хэлэхэд бэлэн байлаа. Хэрэг явдал ингэж эргэвэл Чингис хаан хөвүүдийнхээ хэн нэгийг дэмжих ёстой болох тул дуугүй өнгөрөөснөөрөө тэр хэцүү асуултаас тойрон гарч чаджээ. Бас үнэхээр эзлэн авсан хуваарьт нутгаа тохинуулах нь ч зөв гэж үзсэн биз. Ингэх нь ер буруу зүйл биш учраас Ургенчээс буцаж ирээгүй Зүчийг тайван орхиж Инд мөрнийг уруудан хөдөлсөн билээ.

Гэтэл тэндээс эргэн ирж бүх цэргээ цуглахыг тушаан дуудсан зарлигийг Есөнтэйгөөр илгээсэн ч Зүчи аргалан ирсэнгүй. Хорезмын улсыг мөхөөсөн их аян дайны эцэст энэ хэргийг өчүүхэн гэж үзэж болохгүй болжээ.

Чингис хаан Зүчид хилэгнэх гомдох хоёрын аль нь болохоо ойлгохгүй мухарджээ. ...

Боорчи өөрийн бодолд автан Чингис хааны өргөөнд байгааг мартсан мэт суув.

Чингис хаан толгой өргөн Боорчийг харав.

-Боорчи. Чингис хаан зөөлөн дуугаар ийн хэлээд сахлаа илбэнэ.

-Боорчи. Чи бидний залуу зандан цаг дуусаж байна даа гэж гунигтай хэлэв.

-Би чамайг олон бэрх зовлонд унагасан биз. Би одоо чамайг нэгэн хэрэгт заръя. Энэ хэрэгт би бодож бодож чамайг илгээхээр шийдлээ гэж Чингис хаан хэлээд дуугүй болов.

-Ямар гэж тодруулан асуух нь илүүц бөгөөд хаашдаа л Чингис хааны хүсэл зарлигийг буцааж үл чадах тул Боорчи дуугүй хүлээв.

Ингэж бодол болж хоёулхнаа суувал эцэст нь заавал нэг сонссон хүн цочмоор, айж зугатмаар, аргадаж гуймаар хэрэг гүйцэлдүүлэхийг тушаах тул юу болохыг бараг таах шиг болоод Боорчийн зүрх түгшин хавиргаа дэлсэж эхлэв. Тэр ямар ч зарлиг сонсоод ингэж түгшиж сандарч яваагүй билээ. Чингис хаан ер нь хэний ч санаагүй аймшигт цээрлэлийг олж сонгохдоо даанч гаргууд хүн юм.

Хорезмд морилохын урьд өвөл өргөөндөө дуудаж оройжин архи дарсаар дайлж элдвийг энгүүн зүгээр хүүрнэж суугаад хэлсэн үгийг нь тод саналаа. Энэ бол Хасарын тухай байв. Чингис хааны хэлэх үг, буулгах зарлиг хэцүү хүнд байх тутам түүнийгээ сайтар ойлгуулах гэж урдаас нь тайлбарлан эсэргүүцэх бүх шалтгаан нөхцлийг арилгахын тулд удаан тайван ухуулан ярьдаг юм.

Зарлигийг биелүүлэх тэр хүнээ зоригжуулах, бас Чингис хаан өөрийгөө энэ хэрэгт буруугүй гэдгийг нотлох гэж ингэх бүлгээ. Хэрэв сонсогч хүн түүний зарлигийг биелүүлэхгүй татгалзвал Чингис хааны бүх нууцыг мэдсэний хувьд үхэх л үлддэг байв. Иймээс хүн үхэхийг яахин хүсэх билээ. Ингэж Чингис хаан өөрийн хэргийг бүтээнэ. Энэ нь түүний шалгарсан арга юм.

Хорезмд дайтах их цэрэг хөдлөхөөс яг хоёр сарын өмнө Боорчийг дуудсан нь тэр байв.

Тэр үдэш Чингис хаан туйлын сайхан ааштай угтжээ. Өдөр нь Зүчи хөвүүнтэйгээ уулзаж түүний үг хүслийг сонссон нь Чингис хааныг баясгажээ. Их цэргийг манлайлан Хорезмд орох хүслээ Зүчийн хэлсэн нь Чингис хаанд үнэхээр тааламжтай байв.

Тийм учраас үүнийг Боорчид дуулгах ёстой гэж үзжээ.

-Боорчи. Чиний хүмүүжүүлсэн Зүчийг би өнөөдөр бахдаж байна. Чи түүнийг амьд үлдээсэн нь сайн хэрэг болжээ. Чи лав далдыг харж, алсыг мэддэг шидтэй биз гэж Чингис хаан хөхөрч угтсан билээ. Зүчийг ийн магтсан нь Цагадайн хатуу үгний дараа хөвүүдийн хооронд бий болсон далд зөрчлийг түр боловч тайтгаруулжээ гэдгийг Боорчи ойлгов. Боорчи ч энэ үгийг сонсоод их л баясав. Ингэх нь аргагүй юм.

Учир нь Зүчийг хэрхэн хүмүүжүүлснийг Чингис хаан сайшаах нь ер бага хэрэг биш байв.

-Суу. Хоёул өнөөдөр сайхан цэнгэе. Сүүлийн үеэс чи бид хоёр ер ингэж суусангүй гэж Чингис хаан сэтгэл тэнэгэр байв.

Тэд чамгүй олон хундага тогтоож, мах зооглов. Гэвч Чингис хаан дэмий нэг ингэж архи дарс болдоггүйг мэдэх тул Боорчи аль болох бага ууж согтохгүйг хичээжээ.

-Хасарын ааш авир тэвчишгүй боллоо. Чингис хаан Боорчийн өөдөөс харж суусная гэнэт ийм үг амнаас унагав.

Үдшийн турш хүлээсэн зовлонт, бас түгшүүрт мөч эхэлжээ. Юу хэлэх гэж Чингис хаан Боорчийг дуудсаныг сая л ойлгов. Боорчи Чингис хааны дараачийн үгийг дуугүй хүлээв.

-Хасар миний төлөө амиа өргөх ёстойгоос бус, миний өмнөөс үг хэлж, үйл дэглэх ёсгүй хүн.

Гэтэл тэр ямагт түрүүлж дуугарч, түрэмгий загнасаар өдий хүрлээ. Чи эс мэдэв гэж үү. Би Өүлэн эхийн сэтгэлийг бодож өрх гэр, өнөр бүлээ гутаахгүй гэж өдий хүртэл тэвчив. Тэмүжин, Хасар хоёрын дундах зөрчил дэндүү гүнзгий, төвөгтэйг хамгийн сайн мэдэх хүн бол Боорчи юм.

Чингис хааны сэтгэлийн дотрох уур бухимдал гэнэт дэлбэрч амьсгаа нь давхцаад ухасхийн өндийж ширээ тулан босов. Боорчи сандран түүнийг тайвшруулж

-Хаантан та бүү ингэж бухимд гэж дэмий л үглэв.

Боорчийн энэ хариугүй дорой байдалд Чингис хаан улам хилэгнэв.

-Хасар бүр галзуурч. Хорезмд их цэрэг хөдөлгөхийг шүүмжилж, намайг дор үзэн үүд хаяж одов.

Чи түүнийг далд оруул.Тайчуудтай байлдах үед намайг шархдахад Хасар чамайг буруутгаж “Үхүүл” гэж шаардсаныг чи мартаагүй биз. Би тэгэхэд чамайг Хасарын сэлэмнээс аварсан. Харин одоо чамд би Хасараас өшөөгөө авах боломж олгоё.

Би Хасарын надад хийсэн гавьяаг хүндэтгэн нэргүй үхлээр биш миний итгэлт нөхөр Боорчийн гараар үхүүлнэ. Хасарыг чамаас өөр хэн үхүүлэх билээ. Одоо Хасарыг чи үхүүл. Хүн нэгэнт хүслээ гүйцээж үгээ хэлсэн бол үхэхэд юунд дургүйцэх билээ. Тэнгэр нэгэнт ингэж таалсан тул хэн түүнийг зөрчинө хэмээжээ.

Чингис хааны даанч дэндүү заналтай хэлсэн үгний цаана Боорчийн үзэж сонсоогүй явдал нуугдаж байгааг Боорчи мэдэрлээ. Чингис хаан уураа гарган тайвширч гэдрэг суув.

Боорчи Алтайн өвөрт өвөлжөөд их чуулганд дуудагдан Чингис хааны хүрээнд ирсээр удаагүй тул түүнийг эзгүй хооронд чухам юу болсныг тааварлахгүй байлаа.

Өгөдэйг хаан сууринд залгамжлуулан суулгахыг зарлиг болгосон явдал Хасарт таалагдсангүйгээр барахгүй гомдол бухимдлыг нь оргилуулсан билээ.

Сонссон үзсэн бүгдээр Чингис хааны залгамжлагчийн тухай шуугиж, энэ явдлын цаана хоцорсон Хасар болоод түүний хөвүүдийн хувь тавилан, ирээдүйг төдийлөн анхаарахгүй байгаа нь Хасарын бухимдлыг оргилуулжээ.

Өгөдэйг хаан сууринд өргөмжилсөн явдлаар далимдуулан Чингис хаан өөрөөсөө хойш зөвхөн алтан ургийн хөвүүдээс хаан сууринд суухаар зарлиг буулгасан нь Хасар болоод бусад дүү нараа, тэдний үр садыг зүгээр л өөрсдийн хавсрага, сул иргэн мэт үзэхээр шийдсэн хэрэг юм. Үүнийг Хасар хэзээ ч зөвшөөрөхгүй билээ.

Түүнийг, хөвүүдийг нь энгийн нэг иргэний адил үзэх нь боолчилж дарласантай агаар нэг санагдаад тэссэнгүй.

Өүлэн эхийн үхлийн дараа Хасарын сэтгэл санаанд гарсан өөрчлөлтийг Чингис хаан цагт нь таан мэдэж түүнийг Алтан улсын зүүн хойт нутгийг эзлэн авах хэргийг найр тавин өгснөөр тэдний хооронд оч өгвөл дүрэлзэн асахад бэлэн байсан их түймрийг түр боловч намжаасан билээ.

Зүүн хойт Хятадыг хялбар дагуулж олон хот балгасыг эзлэн авсан ч Чингис хаан Хасарт тэр нутгаас ганц хот ч болов өмч болгон хуваан өгсөнгүйг Хасар бас тэвчин өнгөрчээ. Удалгүй Хорезмд довтлох шийдвэр гарсныг Хасар эсэргүүцсэн нь тэдний зөрчлийг дахин дэвэргэв.

Таньж мэдэхгүй Хорезмд цэрэг хөдөлгөснөөс цаг алдалгүй Алтан улс, түүний хөрш Сүн улсыг эхлэн эзлэх нь зөв гэж Хасар хатуу зүтгэж байв. Дахин дахин найрамдаж, найрамдах бүр итгэл алдан урвах Алтан улсыг өдөр хүлээлгүй даран сөнөөхийг Хасар шаргуу шаардсаар байлаа. Ийм бодолтой байсан нь ганц Хасар ч биш юм.

Алтан улсыг нэг мөсөн дарж аюулгүй болгох нь хүчирхэг, үл мэдэх Хорезмтой хийх дайны өмнө зайлшгүй хэрэг гэж Хубилай нарын хэсэг жанжин бас Хасарыг дэмжсэн нь Чингис хааны хилэнг бадраажээ. Гэвч тэдний эсрэг илэрхий эсэргүүцэн хэрүүл тэмцэл хийхийг хүссэнгүй. Алтан улсыг дайлах нь зөв ч байж мэдэх юм. Гэвч Чингис хаан Алтан улсыг Хасарын хэлдэг шиг хурдан түргэн эзлэн авах нь юу л бол. Харин Алтан улс хүчээ хуримтлуулан довтолж чадахгүй болсон энэ цагийг ашиглан Хорезмыг дагуулж элчээ алуулсны өшөөг авах нь илүү чухал, алс хол шинэ газарт хөлөө тавьж, нутгаа өргөтгөх илүү боломж олно гэж үзэж байлаа. Үүнээсээ ч ухрахыг үл хүсчээ.

Боорчийг өвөл Алтайгаас ирэхийн өмнө Хасар Чингис хаанд бараалхахдаа юу хэлж ярьсныг тэр бүрэн хэлсэнгүй.

Ер нь энэ яриаг хэзээ ч, хэнд ч хэлэхгүй биз. Харин Боорчи сая хэлсэн үгэнд нь цочирдож бодолд ээрэгдэн суухыг хараад тэр явдлыг санажээ. Хасарыг туйлбартай буруутгах шалтгаангүйгээр алах нь Боорчид хэцүү байгааг Чингис хаан мэдэж байв.

-Боорчи! Чи самуун бодолд автан бүү эргэлз. Хэрэв би их цэргээ Хорезм руу хөдөлгөвөл Хасар өөрийн хүчээр Алтан улсыг довтлон эзлэж авна гэнэ. Чи үүнийг юу гэж санана. Хасар тэгэж чадах уу. Энэ бол тэгэж бараалхахдаа Хасарын хэлсэн олон үгний нэг нь юм.

Ийм үг сонссоны дараа Боорчи Хасарыг өмгөөлж чадахгүйг Чингис хаан мэдэж байлаа. Үнэхээр энэ үгийг сонсоогүй бол Боорчи Хасарыг алахгүй байх олон шалтгаан, түүний их гавьяаг дурдан хэлэхээр бэлтгэж байсан билээ. Чингис хаан Боорчийн юу бодож, юу хэлэхийг шууд хараад л гадарлана.

Хэрэв Чингис хаан зарлиг буулгаагүй байхад Хасар Алтан улсыг довтолбол үүнийг юу гэж нэрлэхийг Боорчи мэднэ.

Энэ бол хаан төрийн эсрэг улаан цайм самуун гаргасантай адил хэрэг юм. Хасар ингэж хэлж,

бас хийж чадахыг Боорчи мэдэх тул сэтгэлд нь могой орчих хүйт оргиод явчихыг мэдэрчээ.

Бас Чингис хаан түүгээр юу хийлгэх гэж буйг сая л жинхэнэ ёсоор ойлгов.

Эхлээд тэр Чингис хааныг ятган тайтгаруулж чадна гэж бодож, бүр итгэж байсан юм. Одоо гэнэт энэ байдалдаа эргэлзэж эхлэв. Хасарыг өмөөрөх нь хаан төрийнхөө эсрэг самуун дэгдээхийг дэмжсэн хэрэг болох байв. Энэ ах дүү хоёр хэзээ л алалцах бол гэсэн хөндүүр болгоомжлол олон жилийн турш Боорчи, Зэлмэ нарыг түгшүүлсээр байсан бөгөөд тэр үйл лайн цаг нь иржээ.

Болох болохдоо Чингис хаан энэ хэргийг Боорчиор гүйцэлдүүлэхийг хүсчээ. Яг энэ үед тэр саа өвчин туссан Зэлмэд атаархах шиг болжээ. Одоо түүнд ухарч буцах,булзаж бултах арга нэгэнт байхгүй байлаа.

-Тэмүжин. Чингис хааны алдар гуншинг умартан ингэж дуудахдаа Боорчид нэгэнт эргэлзэж тээнэгэлзэх зүйл үгүй болсон байв.

-Тэмүжин. Хасарыг алах тийм хялбар биш. Хэрэв тэр нэгэнт Алтан улсад толгой даан довтлохоор шийдсэн бол үүнээсээ ухрахгүй.

Гэхдээ Хасар бол Боорчи биш.

Тэр бол Чингис хаан таны төрсөн дүү, Есүхэй баатарын хөвүүн.

Их Монгол улсад хамгийн их гавьяатны нэг. Нэр өндөр, нөлөө хүч их. Хөвүүд нь гавшгай. Тэмүжин чи намайг Хасарыг яаж үхүүлнэ гэж бодно. Чи хэлээч...

-Би чамд хүн яаж үхүүлэхийг заах гэж үү. Чи юу ярина.

-Гэвч Тэмүжин чи нэгийг лав бодсон биз. Би чиний хэлснээр хийе. Түүнийг ёс бусаар үхээсэй гэж чи лав хүсэхгүй биз. Бас Хасарыг зүгээр нэг хүний нүдэн дээр цаазлах юм уу, андууран харваж болохгүй санагдана. Сүүлд үүсэх будлиан самууныг яах вэ. Миний амь ер хайран биш. Харин Чингис хааны их нэр хайран болно.

Боорчийн энэ ухаантай үгийг Чингис хаан хүндэтгэн сонсжээ.

-Тийм ээ. Хасарыг үхүүлэх амар биш. Тийм болохоор л чамд хэлэв. Хасар өөрийн үхлээр л үхмээрсэн. Тэгвэл надад хоргүй юм. Үүнийг чи л хийж чадна. Харин тэр жил Зүчийг төрөхөд амьд үлдээсэн шигээ хялбар бүү бодоорой. Барын сүүлнээс баривал бүү тавь. Үхтэл нь атгаад бай гэдэг биз.

Би чамд сануулга болгож Зүчийг хамт туслуулъя. Зүчээс бүү нуу. Энэ хэргийг Зүчи бид гурав л мэдэг. Энэ хэрэгт Зүчийг туслуулбал тэр надад улам ч итгэн дотносох биз.

Ингэж Хасарын амьдрал шийдэгдэв.

Чингис хаан ингэж шийдсэнийг Боорчи зөв гэж эргэлтгүй дэмжсэн бөгөөд ерөөсөө Хасар үг

хэл,үйл хөдлөлөөсөө болж өөрөө л үхэл рүүгээ очсон гэж үзжээ.

Эргүнэ мөрний эхээр байх нутагтаа буцаж харьсныхаа дараа Хасар гэнэт үхсэн нь Боорчи болоод Зүчийн хийсэн хэрэг гэдгийг тэднээс гадна ганцхан Чингис хаан мэдэж байлаа.

Хорезмд их цэрэг хөдлөхөөс хоёрхон сарын өмнө энэ хэрэг болсон бөгөөд Чингис хаан улс даяар их гашуудал зарлахыг хориглож нам гүм өнгөрөөгөөд Хасарын хөвүүдийг дуудан авчирч сайн эцгийн нэрийг өргөж явахыг захиж, эцгийнхээ хүслийг та нар биелүүлэх ёстой гэж Алтан улсад явах Мухулайд тэднийг өгснөөр Чингис хаан нэг насанд заяасан хамгийн хүчтэй өрсөлдөгчөөсөө нэр бүтэн салж амарсан билээ.

Харин өнөөдөр энэ Перваны хөндийд хиймэл борооны чийгтэй агаар сэнгэнэх өргөөнд Чингис хаан Зүчийн тухай олон сайхан үг хэлж магтах хиймэл хуурамч зангийн цаана чухам ямар санаа нуугдаж байгааг мэдрэх шиг болоод Боорчи өөрийн эрхгүй Хасарын үхлийг санажээ.

Хэрэв Чингис хаан Зүчийг үхүүл гэвэл Боорчи хэлэх үгээ олж ядна. Чингис хааны үгний цаана яг ийм санаа цухалзсаар байсныг Боорчи мэдэж байлаа.

“Тэнгэр минь.Надад туслаач. Зүчийг бүү үхүүлээч” гэж Боорчи дотроо Тэнгэрээс гуйн залбирч суув.

Боорчи олон жилийн өмнө “Тэмүжинг бүү үхүүлээч” гэж Хүйтэн уулын бэлд Тэнгэрт гуйн мөргөснөө саналаа.

Тэгэхэд Тэнгэр түүний гуйлтыг сонсож гэрэлт бөмбөлөгөө илгээж Тэмүжинг аварсан билээ. Одоо яг тийм явдал болоосой гэж хүсч байв.

Боорчийг ингэж хачин мэлгэр царайлан тооно өөд гөлрөн суухыг Чингис хаан үзээд маш их гайхжээ.

-Боорчи. Чи яав... Сүнс сүг үзсэн юм шиг зэвхий царайлах чинь ...

Боорчи сая дотор бодлоосоо салж хаана суугаагаа ухаарчээ.

-Хаан та намайг ямар хэрэгт зарах гэж байгааг би тааж ядна. Зовлонгийн түргэн нь дээр гэдэг биз гэж Боорчи хэлсэн нь Чингис хааныг “Бүү уд. Үгээ шууд хэл” гэсэнтэй адил сонсогдов. Чингис хаан Боорчийн үгийг ойлгож инээмсэглэв.

-Боорчи. Чи миний хэлэх үгийг сонсоод лавтай баярлах биз. Би чамайг ер баярлуулж байсан удаагүй биш үү.

Чингис хааны сэтгэл дүүрэн хэлсэн энэ үг Боорчийг сэргээх биш харин ч хуучин гунигт түүхийг санагдуулсан тул тэр гүнзгий санаа алдав.

-Яав чи. Би чамд бахтай сайхан үг хэлж байхад санаа алдаж гуниглах чинь. Би буруу зөрүү үг хэлэв үү. Чи хэл гэж Чингис хаан Боорчийн урамгүй гунигтай байдлыг үзээд бухимдан

шалжээ.

-Би эртний дэмий явдлыг саналаа. Чи Гүмүдаг очиж авчир гэхдээ яг ийм үг хэлсэн билээ.Тэр явдал санагдаад гэж Боорчи үнэнээ хэлэв. Өргөөнд гэнэт түгшүүртэй нам гүм боллоо. Чингис хаан Боорчийн энэ гэнэтийн үгэнд балмагдан харц буулгаж бодолд автав.

Тэгээд Боорчийг аргадаж тайтгаруулах санаатай

-Боорчи. Би тэр явдлыг яаж мартана. Би л чамд тэгэж хэлээгүй бол, ядаж хэд хоногийн дараа хэлсэн бол ер ийм явдал болохгүй байв. Энэ хэрэгт чи ганцхан намайг буруутгах ёстой юм гэв.Чингис хааны энэ харамслын үг Боорчийн сэтгэлийн тэвчээрийг барагдуулжээ.

Боорчийн уусан архи гэнэт дээш өгсөн ходоодноос тархинд гарч зүрх нь урагдах шиг шимшрэн шархирч, нулимс нь халуу оргиулан нүд дүүрлээ. Яаж ч хүчлээд нулимс нь түүнд дийлдсэнгүй эзэнгүй мэт урсан гарчээ.

-Чи битгий уйл. Боорчийн том том дусал нулимсыг Чингис хаан харж чадсангүй дальдрав.

Энэ бол хамгийн аймшигт явдал байсан юм. Боорчи түүнийг санахгүй гэж, эргэж дурсахгүй юмсан гэж хичнээн жил хичээж, сэтгэлээ хүчээр барьсаар ирсэн билээ. Гэтэл одоо гэнэт биеэ барьж дийлэхээ болиод анх удаа хүүхэд адил гашуунаар мэгшин уйлав. Бүр эхэр татан уйлжээ.

Чингис хаанд хэлэх үг, тайтгаруулах арга даанч олдсонгүй.

Тайчуудыг дарсны хойтон зун Ононы Сэрүүн булгийн эхэнд зусч байх үед, нэг өдөр Тэмүжин яг өнөөдрийнх шиг үгийг Боорчид хэлсэн билээ.

Боорчи тэгэхэд хорин дөрвөн настай байв.

-Боорчи. Чи миний хэлэх үгийг сонсоод лавтай баярлах биз. Би чамайг ер баярлуулж байсан удаагүй биш үү гэж Тэмүжинг инээмсэглэн хэлэхэд Боорчи чухам юу гэхийг таасангүй.

-Чиний сүй тавьсан Гүмүда одоо арван зургаан нас хүрчээ. Чи Гүмүдагаа авчирч бага эхнэрээ болгох цаг чинь болсон биш үү. Эсвэл чи мартав уу... Энэ үгэнд Боорчи үнэхээр их баярласан билээ. Танхил бага насанд Наху эцгийнхээ сүй тавьсан Гүмүдаг яахан мартах билээ. Тэмүжиний аймагт ирж арваад жил болоход Боорчи нэгэнт Бөртийн садангийн Оюутцэцэн бүсгүйг эхнэр болгон авч охин үртэй болсон ч Гүмүдаг мартсангүй.

Гүмүда нэгэнт балчир байсан, бас Тэмүжин тэд тайчуудтай дайтаж байсан зэргээс болоод Боорчи Гүмүдагийн тухай ам нээж дуугарахгүй байжээ. Учир нь Гүмүдагийн эцэг Торгон баян бол тайчуудын дунд нэртэй хүн билээ. Дайснаасаа эхнэр авахыг хэн таашаах вэ гэж Боорчи болгоомжилж байсан хэдий ч нэг ч мөч Гүмүдагаа мартсангүй явжээ.

Харин Тэмүжин түүний бодсоныг нэвт харсан мэт ингэж хэлсэн нь туйлын сэтгэл догдлом баяртай хэрэг болжээ.

-Боорчи чи яв. Гүмүдагаа очиж авчир. Тэр одоо нэгэнт нас бие гүйцэж үзэсгэлэнтэй эм болоо биз. Удвал өөр хүнд өгч мэднэ. Одоо бид тайчуудын гол хүчийг нэгэнт дарсан болохоор чи очиж Гүмүдаг авчир гэж Тэмүжин хэлсэн билээ. Ингэхийг Өүлэн эх ч дэмжин сайшааж байв.

Дийлдсэн тайчуудын иргэдийг хураан авсан ч Торгон баяны хүрээг тэд довтлоогүй нь сайн болжээ.

Тийм болохоор Торгон баян Тэмүжинтэй эвссэн Боорчийг талархалтай угтах нь гарцаагүй гэж тэр бодсон нь ямар аймшигтай алдаа болсныг одоо ч санахад эмгэнэлтэй. Тийм ч учраас Боорчи сэтгэлийн хөвч тасран гаслан уйлсан билээ.

Ялалтандаа дэндүү эрдэж итгэсэн нь Боорчийг дөнгөж таван цэргийн хамт Торгон баяны хүрээ рүү явахад хүргэв. Хэн ч түүнийг сэрэмжлүүлж сануулсангүй. Ганцхан Оюутцэцэн л эм хүнийхээ атаач зангаар өөр эхнэр буулгахаар явж буй эр нөхрөө таашаасангүй үлдсэн ч гаднаа баяр хөөртэй үджээ. Тэмүжин ч, хэн нь ч муу юм санасангүй.

Боорчи, Торгон баяны хүрээнд очиж багын сүйт Гүмүдагаа үзээд хэмжээлшгүй их аз жаргалтай болжээ. Гүмүда үнэхээр арилгасан сонгино шиг хаанаас ч харсан цэвэрхэн бүсгүй болон өсчээ. Торгон баян эртний сүйгээ мартаагүй ажээ. Боорчийг бөөн баяр болон угтаж гурав хоног найр цэнгэл хийж, охиноо ёс төртэй өгөв. Гүмүдагийн гэнэн ялдам аашинд автаж гурав хоноходоо Боорчи аваль эхнэр Оюутцэцэндээ огтхон ч хайр сэтгэлгүйгээ ойлгов. Амьсгалд хиртэж, алганд бяцармаар эмзэг, энхрий Гүмүдаг үзээд хайр дурлал гэдэг ийм шаналгаатай, бас энхрий нялх байдаг гэж санасангүй явснаа л ухаарчээ.

Боорчи дэндүү хайрласандаа болоод Гүмүдаг эрийн ёсоор эдэлж, охин биеийг нь эвдэж зүрхэлсэнгүй. Тэр зүгээр л галын гэрэлд Гүмүдагийн гоо царайг ширтэн нойргүй хонодог байв. Хол ойрд зард гарч эхэлсэн Тэмүжиний шадар нөхөр Боорчид Гүмүда яг л хүүхэд шиг эрхлэн дурлажээ. Торгон баян ч хүчирхэг хамгаалагчтай боллоо гэж баярлав. Гэвч Боорчи, Гүмүда хоёрын дэндүү нялх эмзэг дурлал ердөө л хэдхэн хоногийн настай байв.

Боорчийг Торгон баяныд ирсэн сураг хавь орчмын тайчуудын хүрээнд тарж Тэмүжинд ялагдсандаа өс санасан Таргудай залуу эрсийг турхиран Боорчийн замыг отож байжээ.

Тэдний хувьд Боорчоос өшөө авах нь Тэмүжинээс өшөө авсантай адил хэрэг байлаа.

Боорчи Гүмүдаг авч гэрийн зүг хөдөлсний маргааш тэд Таргудайн отоонд орж баригдав.

Тайчууд юу хийхээ аль эрт төлөвлөсөн байлаа. Дагалдагч хэдэн цэрэг төдөлгүй алагдаж, Боорчи олон хүний эсрэг яаж ч эс чадаад эцэст нь хүчинд автан баригдав. Боорчийг шууд алчихаагүйн учир тэр дороо тодорхой болжээ. Тайчууд үг дуугарч яах вэ, ийх вэ гэж ярилцсан ч үгүй. Боорчийг харуулж байгаад хайртай Гүмүдаг нь нүцгэлэн ээлжлэн хүчирхийлж бахаа хангаад өрөөсөн хөлнөөс нь модны мөчрөөс дүүжилж орхив.

Хээрийн тансаг цэцэг шиг ариухан Гүмүдагийн царай хормын дотор өнгө алдан гэрэл бөхөхийг харахад нүд хальтирна.

Гүмүда бараг амь тавьсан байв. Боорчийг модтой хүлж Гүмүдагийн толгойн дор хаяжээ.

Тэд явахдаа Боорчи, Гүмүда хоёрын гүрээний судсыг тас хэрчихээ мартсангүй. Тайчууд нэг ч үг дуугаралгүй явж одоход Боорчи, Гүмүда хоёрын цус нийлэн урссаар хоцров.

Хайртай, дэндүү хайртай Гүмүда нь харсаар байтал бүх цусаа дусал дуслаар юүлж удаан үхжээ.

Гүмүдагийн цус Боорчийн толгойруу асгарсаар гэрэлт хар нүд нь унтарч, цусандаа норсон гэзэг нь нүүрийг нь сэрвэгнүүлсээр байлаа. Боорчи ч бас үхэж байв.

Харин түүнийг мод налуулж суулгаад хүлсэн нь аврал болж арай ч цусаа юүлж дуусаагүй байхад эрлийн хүн таарч Гүмүдаг таньснаар Торгон баяныд хэл өгч, Боорчи аврагдсан ч ийм аймшигт үхлийг үзсэн Торгон баян тэссэнгүй зүрх нь хагарч үхээд, эхнэр нь солиорсон билээ. Гүмүдагийн энэ аймшигт үхлийг Боорчи ганцхан Тэмүжинд хэлсэн бөгөөд Тэмүжин Боорчиос дутуугүй цочиж Гүмүдагийн үхэлд өөрийгөө буруутгах болжээ. Гүмүдагийн үхэл Боорчид гүнзгий цохилт болж нэг хэсэг тэр ухаан солиотой мэт болоод шөнө хар дарж зүүдлэх нь олширч, бүр сүүлдээ хажуугаар хэвтэх эхнэрээ багалзуурдан алах шахсанаас хойш тэд гэр тусгаарлажээ.

Гүмүдагийн үхсэн нь Боорчийн сэтгэлд байсан эмэгтэй хүнийг хайрлаж энхрийлэх дадал, хүслийг нэгмөсөн үгүй хийсэн билээ. Тэр цагаас хойш Боорчи эм хүнд хөндий хүйтэн хандах болжээ. Энэ нь түүнийг гэр бүлийн амьдралаас холдуулж гэртээ орж эхнэртэйгээ нэг хөнжилд хэвтэх нь жинхэнэ тамлал болон хувирав. Гүмүдаг авахаар яах гэж очив гэж бодох бүр үхэхдээ аврал эрэн ширтсээр байсан хөөрхөн нүд нь, ангалзсаар байсан уруул нь үзэгдээд шөнө орилон босч ирдэг байлаа.

Ингэж Боорчи гэр орны амьдралаас үүрд зугатаах болж бүх цагаа цэрэг дайны хэрэгт зориулах болжээ.

Тэр аль болохоор Гүмүдагийн үхлийг санахгүйг хичээдэг билээ. Тэмүжин ч Боорчийг аль болох дэмжих, санаа сэтгэлийг нь тайван байлгахыг хичээнэ. Харин өнөөдөр санамсаргүй хэлсэн үг тэдний сэтгэлийн шархыг ийн сэдрээжээ.

Боорчи гэнэт уйлахаа больж аягатай архи авч гуд залгилаад ер юу ч болоогүй юм шиг

-Тэмүжин чи юу хийхээ даруй хэл. Шөнө дуулаа. Маргааш би эртхэн мордсугай гэхдээ Боорчи Зүчийг бодож байв.

-За яамай, чи ашгүй тайвшрав уу. Одоо би чамд дахиж Гүмүдаг сануулахгүй.

-Чи юу хүссэнээ хэл. Юу ч байсан би биелүүлнэ гэхдээ Боорчийн дотор хэнээс ч юм бэ өшөө авах гашуун хүсэл оргилсоор байгааг мэдлээ.

-Би чамайг ... Сүбээдэйн тийш илгээе.

-Юу гэнэ ээ гэж Боорчи үнэнээсээ гайхан дуу алдлаа.

-Чи шинэ нутаг билчээр, хот балгас үзэж хийморио сэргээж уйтгараа үргээж үз.

Сүбээдэй, Зэв хоёр чи бид хоёрын нэгийг очихоос нааш ирэхгүй бололтой. Чи очиж тэр айхтар зуудаг нохдыг оросын боривноос салгаж авчир. Тэгээд тэднийг ирмэгц харьцгаая.

-Хаантан та. Чи үнэн хэлнэ үү гэж боорчи сая л хаана байгаагаа ухаарах шиг хэлэв.

-Тийм ээ. Би үнэн хэлж байна. Чи торгон цэргээсээ өөрийн хүссэнээр авч одогтүн. Харин Сүбээдэй, Зэв хоёртой нийлээд бүр цаашаа явчихав. Тэднийг дагуулж авчир. Ирсэн хойно нь би тэр айхтар зуудаг нохдыг сайн залхаая гэж Чингис хаан хөхрөв.

-Зүчийг ал гэж хэлээгүйд нь Боорчи сэтгэл цэлмэн баярлаж Гүмүдагийн үхлийн тухай гунигт бодлоос бага боловч салав.

Тэгээд Тэнгэр Зүчийг харжээ гэж талархан бодов.

Орос гэж ямаршуухан улс байдгийг үзэх хүсэл Боорчид нэн их байсан билээ.

Боорчи дотроо Сүбээдэй, Зэв хоёрт атаархаж байсан тул Чингис хааны энэ зарлигт их баярлажээ.

Бас дээр нь Чингис хаан Зүчи хөвүүнээ хөнөөх сэтгэл үгүй байгааг мэдэж авав. Би дэмий харджээ гэж Боорчи бодсон юм.

Тэр шөнө, Боорчи догдлон хөөрч, маргааш эцгийгээ дагаж аянд мордох гэж байгаа балчир банди шиг нойргүй хонов.

Асарт нь өнөө өндөр хамарт, их дуут харь цусны бүсгүй нүцгэн тэлчилж хэвтэнэ. Боорчи түүнийг ч тоосонгүй хөлбөрсөөр байлаа.Энэ шөнө Боорчи сэтгэл хөдлөн баярлаад зогссонгүй тун ч ихийг тунгаан боджээ. Сонссон баярт мэдээгээ хуваалцах дотно хүнгүй яваагаа өнөө шөнө л голдоо ортол мэдэрчээ.

Боорчи энэ газар дээр цор ганцаар хоцорчээ.

Гүмүдагаас хойш тэр дахин ямар ч эмийг тийм гүнзгий дотноор хайрласангүй.

Хайрлая гээд ч түүний сэтгэл нэгэнт хоосорсон байжээ. Гэтэл дасаж сурсан амьдралаа өөрчлөх хүсэл яагаад, хаанаас ингэж оргилоод байгааг Боорчи ойлгосонгүй үүр цайлгажээ. Арван гурван настайдаа анх Тэмүжинг даган явсан шигээ эрс шийдвэрийн өмнө тулж ирснээ Боорчи гэнэт ойлгов.

Тэр жирийн хүн шиг хайрлаж дурлаж, үр хүүхдээ өсгөж, дэргэдээ дагуулан явахыг хүсч байжээ. Харин одоо хүссэнээ биелүүлэх тийм цаг хугацаа үлдсэнгүй. Боорчи Тэмүжинд атаархах шиг болов. Гэвч энэ бодлоосоо айжээ. Гэтэл Тэнгэр түүнд хилэгнэж хөвүүн заяасангүй нь гачлантай. Энэ бол түүний гуниг харууслын үндэс байлаа.

Боорчи нэгэн зүйлийг санамагц цочин өндийжээ. Бүр бодох бүр зүрх нь догдлон чичирч

байжээ. Энэ бол олон жил өөрөөсөө ч нууж явсан бодол юм. Одоо түүнд эргэж буцах, эргэлзэн тээнэгэлзэх цаг нэгэнт үгүй болсныг сайтар мэдэж байв. Тийм учраас алгуурлаж хойшлуулахыг хүссэнгүй босож зэргэлдээ асарт унтаж байсан Гэрэгийг дуудан босгов. Бас өнөөх Багдадын эмийг ч эмсийн гэрлүү хөөж явуулав.

Үүр цайж тэнгэрийн баруун хаяа цайрчээ.

Гэрэг хэзээ ч сэргэг байдаг зангаараа нүдээ гялалзуулан орж ирэв.

Одоо Гэрэг хорь хүрч, галзуу барын аманд гараа хийхээс буцахгүй ааг омог дүүрэн насан дээрээ яваа билээ.

Чингис хааны их торгон цэргийн хамгийн шилдэг зуутыг захирч Боорчийн дэргэдээс алхам ч холдохгүй явсаар уджээ.

Харин ингэж үүр цүүрээр дуудсанд Гэрэг огт гайхсангүй. Ижийгээ нас барахад Гэрэг есөн настай байсан бөгөөд хойтон жил нь Боорчи түүнийг дэргэдээ авчирч шадар цэргээрээ маллуулжээ.

Эцэг нь хэн болохыг Гэрэг эхээсээ асуусан ч үгүй, бас эх нь хэрэг болгож хэлсэнгүй үхжээ.

Тийм учраас Гэрэг эх эцгийн элбэрэл хайраас хол хөндий яг л эзнийхээ турхирахыг хүлээгч зуудаг нохой шиг болон хүмүүжжээ.

Гэрэгт Боорчи эзний нь үг зарлигаас эрхэм гэгээн зүйл энэ газар дээр үгүй юм.

Боорчи эзнийхээ зарлигийг биелүүлэх нь түүний ганц хүсэл жаргал билээ. Одоо ч тийм л сэтгэлээр юу хэлэхийг нь хүлээн сууж байв. Боорчи Тэмүжиний энэ нууц хүүг удаан ажиглав. Гэрэг эхийгээ илүү дуурайжээ.

Харин доош тонгойн суугааг нь хальт харвал Тэмүжиний залуугийн төрх танигдах ажээ.

Гэрэг бол хувь заяагүй хөвүүн гэж Боорчи түүнийг үргэлжид өрөвдөн боддог билээ. Хэрэв Гэрэгийг Тэмүжиний хөвүүн гэдгийг Бөртэ мэдсэн бол тэр аль эрт алагдах байсан гэдэгт Боорчи одоо ч эргэлзэхгүй итгэсэн хэвээр байв.

Тийм учраас Боорчи Гэрэгийн хэн болохыг нуусан бөгөөд одоо ч илчлэхийг хүссэнгүй. Боорчи Тэмүжиний хөвүүн Гэрэгийг үүрд булаан авахаар шийджээ. Боорчи аз жаргалтай амьдрахыг хүсч байв.

-Гэрэг хөвүүн минь сонс.

Энэ хэдэн үгийг хоолой давуулан хэлэх гэж Боорчи цай чанахын дайтай хугацаанд амьсгал түгжин суув.

Ийм үг хэлж үзээгүйн дээр бас түүний үгийг Гэрэг хэрхэн хүлээн авах нь эргэлзээтэй байсан нь түүнийг ингэж шаналгажээ.

Харин одоо нэгэнт хэлж чадаад санаа амарчээ. Гэрэг зарлиг сонсдог ёсооroo тонгойн суусаар байгаа нь Боорчид түүний царай зүс хэрхэн хувирахыг харах боломж олгосонгүй. Боорчи л өөрөө догдлон чичирсээр байжээ.

Гэрэг Боорчийн дараагийн үгийг хүлээн суусан хэвээр ажээ.

-Гэрэг чи үүнээс хойш бүү ингэж тонгойн суу. Боорчи үгээ үргэлжлүүлж чадалгүй тасалжээ. Учир нь Гэрэг толгой өргөн түүнийг эгц ширтжээ. Гэрэгийн харцанд гайхсан шинж илэрнэ. Боорчи түүний энэ харцнаас цочиж бүр түгшин нүд буруулжээ.

Учир нь түүний өөдөөс хорин настай Тэмүжин ширтэж байх шиг үзэгджээ. Гэвч Боорчид санаснаасаа ухрах хүсэл төрсөнгүй. Тэгээд Гэрэгийг эгц ширтэж байгаад

–Хөвүүн минь. Чи миний хэлэхийг сонс. Чи бол миний төрсөн хөвүүн юм. Эх чинь чамд лав энэ тухай хэлээгүй биз. Одоо чи нэгэнт нас бие жагсаж, ухаан чинь тэгширчээ. Энэ өдрөөс хойш чи Чингис хааны шадар сайд Боорчийн хөвүүн мэт явагтүн.Би хөгширч байна. Харин Гэрэг чи Зэлмийн хөвүүн Есөнтэйн адил эцгийгээ залгамжлах болно. Би чиний тухай Чингис хаанд айлтгаж чамайг өөрийн дор мянганы ноёноор өргөмжилнө. Чи миний үхсэний дараа Алтайн түмнээ захирч эцгийгээ залгамжлан сууж үр хүүхэд чинь ч энэ мэтээр явах болно. Боорчи миний үр удам үеийн үед тасрахгүй мөнх үргэлжлэх болно гэж шөнөжин бодсон үгээ хэлж санаа амраад толгой өргөвөл Гэрэгийн нулимс мэлтэрсэн нүдийг олж харжээ.

Боорчийн зүрхний угт нэг утас тонхийн дуугарч тасрах шиг болоод нулимс нь сул асгараад өөрөө ч мэдэлгүй гараа сунгаж

–Хөвүүн минь. Нааш ир гэж шивнэжээ. Гэрэг хүүхэд адил мөлхөн ирээд Боорчийн өвдгийг тэврээд гашуунаар бархиран уйлж

–Аав минь.Та юуны учир намайг ингэж удаан залхаасан юм бэ гэж шивнэсээр байжээ.

Хатуу бэрх хүмүүжилтэй Гэрэгийг ингэж уйлна чинээ санаагүй учир Боорчи туйлын ихээр сандарч бүр яах ч учраа ололгүй таг суужээ. Гэвч тэд хурдан тайвширчээ. Гэрэгийн энэ нулимс итгэл Боорчийг нэг мөсөн эзэмдэж, одоо тэр Гэрэгийг өөрийн төрсөн хөвүүн гэдэгт бат итгэлтэй болжээ. Боорчи аз жаргалтай байлаа.

Хөвүүн үртэй байх гэдэг хичнээн их хувь зохиол болохыг Боорчи ингэж нэг үзэж мэдэрчээ. Одоо түүний өнгөрүүлсэн болоод үлдсэн амьдралын нь зорилго утга, нартай өдөр мэт тод томруун болов. Гэрэгийн аз жаргалд хэмжээ байсангүй.

Анх арван настайд нь дагуулан явсан Боорчи эзэн нь эцэг нь байгаасай гэсэн далд хүсэл сэтгэлийг нь нэвт эзэмдсээр ирснийг Гэрэг өөрөө ч мэдэхгүй явсан нь Боорчийн үгийг сонсоод тэгэж бахардан баярлахад хүргэжээ. Хатуу харгис, хайр энэрэлгүй сэтгэл, хүмүүжил нь нэгэн мөчийн дотор зөөлрөн өөрчлөгдөж тэр өөр хүн болон хувирч байх нь Гэрэгт тод мэдрэгдсэн билээ.

Хүний үрийг чонын үүрэнд аваачиж хаялаа ч түүний сэтгэлээс эх эцгээ хайрлаж хүсэх дадал нь хэзээ ч үл арилахын адил хар нялхаас дэг чанга цэргийн амьдралд нухлагдсан ч эх эцгээ хүсэмжлэх, эрхэлж үнсүүлэх хүүхэд зан нь Гэрэгээс огтхон ч хаягдсангүй харин ч сэтгэлийн гүнд улам хүчтэй болсоор ирснийг өөрөө ч мэдсэнгүй билээ. Харин Боорчи хэргийн учрыг удаашруулж өөрийгөө зовоохыг хүссэнгүй тул Гэрэгийн тухай Чингис хаанд тэр өдрөө мэдүүлжээ.

Хэдийгээр энэ олон жил өөрийн төрсөн үрийг хэл чимээгүй дарагдуулан явсны учрыг Боорчи итгэж үнэмшихээр тайлбарлаагүй ч Чингис хаан мөн л Боорчийн адил догдлон хөөрчээ. Чингис хаан Боорчийг аз жаргалтай байгаасай гэж үнэн сэтгэлээс хүсэх учир даруй Гэрэгийг дуудан ирүүлжээ.

Гэрэг хэзээ ч Чингис хаанд ингэж биеэр бараалхаж байсангүй тул ихэд балмагджээ.

Харин Чингис хаан Гэрэгийг үзмэгцээ түүнийг Боорчийн үр гэдэгт эргэлзэхгүй итгэжээ. Танил дотно төрхтэй нүдэнд дулаахан царайтай тэр залуу түүний үнэнч нөхөр Боорчийн хөвүүн байхаас өөр арга байсангүй.

Гэрэгийг үзээд Чингис хааны баяр бахдал улам нэмэгджээ. Боорчи ч Чингис хааныг итгүүлж чадсандаа тайвшран баярлажээ.

-Чиний эцэг Боорчи бол дээд Тэнгэрээс надад хуваж өгсөн миний ганц үнэнч нөхөр минь юм.

Би Боорчи болон бусад нөхдийн хүчээр энэ их улсыг байгууллаа. Харин чи Боорчи эцгээ залгамжлан миний төлөө зүтгэгтүн.

Би чамайг их торгон цэргийн мянганы ноёноор өргөмлөж сайн эцгийнхээ хувь хишгийг үеийн үед үрийг үрд эзэмшиж явах зарлиг буулгая гэж Чингис хаан бахархалтай хэлжээ.

Чингис хааны энэ зарлигийг Шихихутаг тэр өдөрт нь олонд тунхагласан бөгөөд энэ өдрөөс эхлэн Боорчи болоод Гэрэгийн шинэ аз жаргалтай амьдрал эхлэсэн билээ. Юм ингэж санаанд оромгүйгээр хурдан тэгэхдээ ийм сайн сайхнаар хувирч өөрчлөгдөнө чинээ Боорчи санасангүй.

Бас Гэрэгийн олон олон асуултанд хариу өгч өөрийн үзээгүй амьдралыг зохион ярих хэрэг хамгийн түрүүнд Боорчид тулгарчээ. Эхтэй нь хэрхэн учирсан бас яагаад түүнийг орхин явсан юуны учир өөрийн хөвүүн гэдгээ нуусан гээд бүх зүйлийн учрыг Гэрэгт тайлбарлах хэрэгтэй болжээ.

Гэрэг бүхнийг мэдэж, өөрийн ээдрээтэй хувь тавилангийн үнэн учрыг тодруулж ойлгохыг хүсэх нь зүйн хэрэг болжээ.

Энэ бол дайсантай нүүр тулан байлдахаас хэдэн хувь хэцүү хэрэг тул Боорчи Гэрэгийн шаардлагад алгуур тайван хандаж бас түүний баярласан дэврүүн сэтгэлийг гомдоохгүйг хичээж байлаа. Харин Сүбээдэйн араас явахдаа Гэрэгийн мянгатыг дагуулан явахыг Чингис

хаан зарлиг болгосон нь эцэг хүү хоёрыг жаахан сатааруулж,Боорчид аврал болжээ. Боорчид Гэрэгийн амьдралыг үнэмшилтэй тайлбарлах хугацаа олджээ.

Явах газар хол, хэдийгээр эзлэгдэн бууж өгсөн ч эсэргүүцлийн самуун газар сайгүй дэгдсээр тул тэр Гэрэгийн шилдэг торгон цэргийг дагуулах нь гарцаагүй зөв байжээ. Боорчийг Сүбээдэйн тийш Орос газарт илгээх зарлиг буулгаснаасаа хойш Чингис хаан бас л нойргүй хонох болжээ. Боорчийг мордох хүртэл түүнд бодож шийдэх юм их байлаа. Боорчийг явчихвал Хорезмын энэ бүгчим харанхуй тэнгэр дор гав ганцаар хаягдах мэт сэтгэгдээд тэр өөрийгөө ер ойлгохгүй болжээ.

Боорчи гэнэт өөрийн хөвүүнийг зарласан нь ингэж шаналах үндэс болсон гэдэгт итгэхийг хүссэнгүй. Боорчийг түүнтэй булаацалдах хүн гэнэт гарч ирсэнд Чингис хаан ихэд цочирдсон билээ. Үүнээс өмнө Боорчийг ер хүн биш юм шиг, үр хүүхэд, ар гэргүй мэт сэтгэж,зарж сурсан сэтгэлд нь одоо тэр өөрийн хөвүүнийг хайрлана, хөвүүнийхээ төлөө санаа зовон зүтгэнэ гэж бодохоор Боорчи дахин түүнд эргэж ирэхгүй одох мэт хачин бодол төрөх болжээ.

Бас энэ олон жилийн хугацаанд Боорчи ингэж таг дуугүй явсан мөртөө гэнэт Сүбээдэйн зүг одохын өмнө өөрийн хөвүүн гэж нэг цэргийг зарласан нь цаанаа сэжигтэй санагдаад болсонгүй. Гэвч одоо түүнд энэ тухай хэлж зөвлөх хүн даанч байсангүй.

Шихихутагийн хэлснээр Гэрэгийг Найманы нутгаас Боорчи өөрөө олсон нь үнэн ажээ. Харин түүний төрсөн үр гэдгийг хэн ч батласангүй гэж Шихихутаг хэлжээ. Боорчийг явуулах болсон нь гарцаагүй хэрэг болохоор яах ч арга байсангүй. Боорчийг явмагц хэн ч түүнийг хамгаалахгүй юм шиг хар төрсөн нь улам гүнзгийрчээ.

Бас Боорчи, Зүчийн адил хэзээ ч эргэж ирэхгүйгээр түүнийг хаян одох мэт санагдаад уур хилэн нь гэнэ гэнэ оволзоно. Чингис хаан өөрийн сэтгэл санаанд гарсан гүн өөрчлөлтийг анзаарч мэдэхгүй байжээ.

Чингис хаан агуу их нэр сүрийнхээ буулган дор ядарч, хязгааргүй их ганцаардалд автсанаа даанч ойлгосонгүй.

Ойлгох ч аргагүй болжээ.

*****

Сүбээдэйн илгээсэн элчийн зааснаар Перваны хөндийгөөс хойш Каспийн тэнгисийн баруун талаар өгсөн Боорчийн явах зам тодорхой болжээ. Дайн хийж ойр зуурын хотуудыг эзлэн тулалдаж явахад туулсан замын урт, эзэлсэн газрын уудмыг тэр бүрий анзаардаггүй ажээ. Харин одоо явах болтол Хорезм гэгч хичнээн том улсыг эзлэн буулгаж авснаа Чингис хаан ч, Боорчи ч ойлгох шиг болжээ.

Чингис хааны цэрэг нутгаас гарсаар 1223 оны эцэс гэхэд зүүн хойт талаараа Сыр дарья мөрөн, зүүн өмнөд талаараа Инд мөрөн, хойт талаараа Арал болоод Каспийн тэнгис, баруун хойт талаараа Азарбайжан, баруун талаараа Багдадын халифат улс, өмнөд талаар Энэтхэгийн далайд хүрсэн уудам их нутгийг эзлэн авсан байлаа.

Монгол болоод Хорезмын хооронд орших Хар кидан, Уйгар, Харлаг улсууд нэгэнт Чингис хаанд дагаар орсон тул одоо Их монгол улсын нутаг дэвсгэр Хятадын зүүн далайгаас Газар дундын тэнгис хүрч, Шар мөрнөөс хойш Сибирийн их хөвч хүртэл тэлжээ. Харин одоо Зүчийн цэрэг Каспийн тэнгисийн зүүн талаар Сүбээдэйн цэрэг баруун талаар нь хойш давшиж, Урал, Днепр, Ижил мөрний хоорондох үржил шимт уужим их талд амьдран суугч Асу, Сасу, Болгар, Орос, Мэжигэд, Мажар, Хивчаг, Ханлин, Кивамен зэрэг аймаг улсуудыг эзлэн авахаар урагшилж байв.

Шуурга мэт давшиж яваа Сүбээдэйн цэргийг гүйцэхийн тулд Боорчид даруй хэд дахин түргэн явах хэрэг тулгарчээ. Үүний тулд зам зуур тохиох эзлэгдсэн хотуудад хамгаалан сууж үлдсэн монгол цэргийн ноёдод урьдчилан элч илгээж бэлтгүүлэв. Хот болгонд Боорчийн цэрэгт шаардлагатай агт сайн морь,хоол хүнс бусад зүйлийг бэлэн болгох зарлиг хүргүүлжээ. Ийм бэлтгэл хангагдах хүртэл Боорчид хийж гүйцэтгэх ажил олон үлдээд байлаа.

Тэр юуны өмнө Чингис хааны нэгэн гайхалтай зарлигийг гүйцэлдүүлэх хэрэгтэй болжээ. Барыгжан уулын нэрийг өөрчлөн түүнийг Тэнгэр уул хэмээн нэрлэж, оргилд нь хүн гарахыг цаазалсан зарлиг Чингис хаан буулгасныг даруй олон түмэнд зарлан тунхаглаад байлаа. Харин Боорчид нууцаар зарлиг болгосон ёсоор мөнөөх Иш – Химамын урласан оньсон шатыг шатаах болжээ. Уг нь Боорчи энэ шатыг үгүй болгохыг хүсээгүй билээ. Учир нь энэ шат бол Иш-Химам гэгч үнэн сэтгэлт уран дарханы гайхамшигтай, хараад ханамгүй бүтээл юм.

Чингис хаан гэнэт ийм хачирхалтай зарлиг буулгасныг Боорчи гайхан эгдүүцсэн ч түүнээ ил гарган мэдэгдсэнгүй.

Иш-Химам Чингис хааны зарлигаар Монголын талд их хот барихаар явах болоод хот барих ажлын дадлагатай урчуудыг цуглуулан бэлтгэж байгаа билээ. Нэгэнт Чингис хаан зарлиг болгосон тул ИшХимамыг дуудан авчирч энэ тухай хэлэхээс өөр арга Боорчид байсангүй. Хэл чимээгүй шатааж болох байсан ч Боорчи яагаад ч юм тэгэж чадсангүй. Харин Чингис хааны эл зарлигийг сонсоод номхон дөлгөөн зантай тэр уран дарханы хэрхэн цочирдон хэлмэгдэхийг Боорчи гадарлаж байлаа.

Иш-Химам бол үнэнч шударга зантайн дээр Чингис хаанд тоогдсондоо хөл нь газар хүрэхгүй хөөрч байсан тул Боорчийн дээрх үг газар цөмөрч галав юүлсэнтэй адил сонсогджээ. Тэнгэр уулын оройг хүртэл босгосон тэр оньсон шат бол ИшХимам энэ яваа насандаа дахиад хэзээ ч барьж босгож чадахгүй, бас түүний бодсоноор өөр хэн ч бүтээж чадахгүй тийм мөнхийн бүтээл юм.

Чингис хаан зарлиг буулгаж, Хорезмын бүх урчуудыг нэгэн дор цуглуулж Иш-Химамд тушаагаагүй бол өөр хэн ч ийм шатыг урлана гэж сэтгэхгүй байсан гэж бодох учир хичнээн түмэн гэмгүй хүмүүсийн алж, төрөлх улсыг нь үнсэн товрог болгон түйвээн сөнөөсөн Чингис хааныг сэтгэлдээ өршөөн хэлтрүүлээд зогсохгүй бүр шүтэн бишрэх болсон билээ. Хэзээ ч, хэн ч сэтгэж урлаагүй ийм аварга шат хийх санааг өдөөж барьж босгох хөрөнгө хүчийг хайргүй зориулсан Чингис хаан бол Иш-Химамын хувьд Аллах тэнгэрээс дутахгүй агуу их хүчтэн, ариун дээд явдалтан болжээ.

Хэрэв Чингис хаан байгаагүй бол ийм аварга том, энэ ертөнцийн хамгийн өндөр шатыг хэн ч

хэзээ ч дархлахгүй байсан билээ. Гэтэл одоо өөрийнх нь оюун ухаан ур чадлаар бүтээгдсэн энэ гайхамшгийг шатаах гэдэг юу гэсэн үг болохыг Иш-Химам ойлгож мэдэрмэгц Боорчийн өлмийд ухаангүй мэт унажээ. Өөрөө зарлиг буулгаж бүтээлгэчихээд дараа нь түүнээ устгах зарлиг буулгасан Чингис хааны ухааныг Иш-Химам ойлгож чадсангүй.

Иш-Химам бүү хэл дэргэд нь шадарлаж бүх насаараа зүтгэсэн Боорчи ч ойлгохгүй байгаагаа чин үнэнээр өчжээ. Чингис хааны энэ зарлигийг зөв гэж бодохгүй байгаагаа Боорчи Иш-Химамаас нуусангүй. Уран дархан хүнийг монголчууд угаас хүндлэн үздэг тул эзлэн авсан улс орноос ийм хүмүүсийг юуны түрүүнд олзлон авч ашигладаг тэр л ёсоор Боорчи, Иш-Химамд хүндэтгэлтэй хандаж байлаа.

Бас ИшХимамын хагас жил хүрэхгүйн дотор удирдан барьж босгосон тэр өндөр шат бол үзсэн хүн гайхаж, үзээгүй хүн сонсовч итгэмгүй гайхамшиг болохыг Боорчи эрхгүй хүлээн зөвшөөрч бас тэр шатаар гарч Тэнгэр уулын оройд гарснаа хувь зохиол гэж бодох билээ.

-Би өөрийн биеэр Чингис хаанд бараалхаж учирлан гуйя гэж Иш-Химам гуйжээ. Харин Боорчи энэ талаар Чингис хаанд дахин илтгэх санаагүй байсан болохоор зөвшөөрсөнгүй.

-Иш-Химам чи нулимс урсган бүү бухимд. Чингис хаан чамд монголын тал нутагт их хот цогцлоон босгох зарлиг буулгасан биш үү. Чи ийм өчүүхэн зүйлд харамсах явдалгүй.Чи Чингис хааны зарлигаар энэ байтугай гайхамшгийг бүтээх болно. Чингис хаан нэгэнт л ингэж шийдсэн бол илүү үг зарж түүнийг бүү хилэгнүүл. Чиний хар толгойд хор болж мэднэ. Би чамд сайн санах тул үүнийг хэлж байна гэж Боорчийн ухуулсныг Иш-Химам аргагүй зөвшөөрчээ.

Үнэхээр Чингис хаан ингэж шийдсэн бол хэн ч өөрчилж чалахгүй биз ээ. Гэвч Аллах тэнгэртээ хандан гуйж аврал хүсэхээр Иш-Химам шийджээ. Бүтээсэн шатнаас хагацах хүсэл түүнд байсангүй.

-Шатыг хэзээ шатаах вэ гэж Иш-Химам арга барагдан асуув.

-Иш-Химам.Чи тэр шатыг шатаж үнс болохыг үзэх гэж юунд хүснэ. Чи даруй монголын зүг мордогтүн. Би чамайг явмагц шатыг шатаая гэж Боорчи түүнийг өрөвдөн хэлжээ.

-Боорч сайд аа. Би танаас нэг зүйл гуйя. Та зөвшөөрөөч. Иш-Химамыг ялтай зүйл гуйхгүй гэж Боорчи санасан тул толгой дохив.

-Хэлэгтүн

-Боорчи сайдаа. Би өөрийн хийсэн шатаар дахин нэг өгсөж Тэнгэр уулын оройд гарвал болох болов уу Боорчи үүнийг сонсоод тэр дороо зөвшөөрч чадсангүй.

Учир нь Чингис хаан морилж Тэнгэртэй ярьсаны дараа тэр уулын оройд дахин хүн гарахыг цаазалсан тул Иш-Химамын хүсэлтийг зөвшөөрч болохгүй байлаа.

-Боорчи сайд аа. Та намайг гарав гэж Чингис хаанд айлтгахын хэрэггүй биз. Одоо тэр шатыг

нэгэнт шатаах тул дахин хэнд ч хэрэггүй болжээ. Харин би өөрийнхөө шатаар дахин нэг өгсөхийг хүснэ. Хожим хойно энэ гайхамшигт шатаар Иш-Химам гэгч дархан хамгийн сүүлчийн удаа гарчээ гэж хүмүүс дурсан ярьж байгаасай гэж хүсч байна гэж Иш-Химам, Боорчийг эргэлзэж байгааг мэдээд хэлжээ.

Иш-Химамын энэ хүсэлд хортой зүйл үгүй тул Боорчи зөвшөөрөв.

-Чи тэгвэл хэзээ гарна гэвэл

-Та хэзээ шатыг шатаана.Тэр өдөр л гаръя гэж Иш-Химам эргэлзсэнгүй хэлэв.

-За тэгвэл би хэлье

-Би Боорчи сайд танд гүнээ талархаж байна гэж Иш-Химам сахлаа дахин дахин илбэн бөхөлзөх нь ихэд баярласныг илтгэнэ.

Боорчи ч энэ гэмгүй, зүтгэлтэй уран дарханыг баярлуулсандаа сэтгэл хангалуун байлаа.

Иш-Химамыг гарч одсоны дараа Чингис хааны элч ирэв.

Чингис хаан түүнийг өргөөндөө дууджээ. Яаран очвол их өргөөний гадна тойрогт огт үзээгүй хийцийн төмөр дугуйт сүйх, өндөр хөлтэй урт хүзүүтэй олон сайхан агт, хар хувцас нөмгөн өмссөн загалмайтны шашны лам, хэд гурван хүн ирсэн харагджээ.

Их өргөөнд орвол Чингис хаанаас гадна бичгийн түшмэл Елюй-Чуцай,Шихихутагийн хамт сууж байлаа. Гаднаас зочин ирсний учир түүнийг дуудуулсныг Боорчи таамаглажээ.

-Энэ элээ шиг нэвсгэр амьтад чинь юун улс хаанаас гараад ирэв гэж Боорчи эрээлэх юмгүй шууд асуув. Түүний энэ задгай үгэнд Чингис хаан инээмсэглэж нөгөө хоёр нь дуугарсангүй.

-Рим хэмээх улсын их ламтны элч надад бараалхах гэж ирээд хэрхэхийг зөвлөх гэж Боорчи чамайг дуудсан юм гэж Чингис хаан хэлэв.

-Их сайхан агттай юм.Тэр Рим гэдэг улс чинь эндээс хир хол юм бэ дээ гэсэн Боорчийн үгэнд “Очоод эзлээд авчихвал яасан юм бэ”гэсэн омогтой санаа тод илрэнэ.

-Рим хэмээгч улс нь эндээс баруун зүгт байх Газар дундын тэнгисийн хойг дээр оршигч улс юм. Мянган жилийн өмнө Римчүүд энэ газрыг бүхэлд нь эзлэсэн хүчирхэг гүрэн байсан гэнэ. Харин монголчуудын өвөг дээдэс Хүннү гүрний хаад довтлон ирж тэр Римийн их улсыг мөхөөжээ. Одоо энэ Рим загалмайн шашныг шүтэн суугч жижиг улс болсон гэнэ. Харин тэр шовх оройтой сүмд мөргөгч загалмайн шашин бол хуучин Римийн их гүрний эзэлж байсан бүх нутаг оронд шүтдэг шашин болжээ.

Загалмайн шашны лам нар цэрэг цуухгүй ч их эрх мэдэлтэй, олон улсын жолоог өөрийн шашны нөлөөнд барьдаг гэжээ.

Тийм болохоор энэ хар хувцаст лам нарыг төрийн элч гэж үзэх нь зүйтэй гэж Елюй-Чуцай

үгээ зөөн хэлэв.

ЕлюйЧуцай гэгч энэ эр Алтан улсыг анхлан дайлахад Чингис хаанд сайн дураар дагаж ирсэн ордны түшмэл бичгийн хүн тул уншсан сонссон арвин бас аливааг давхар хорон санаагүй байгаагаар нь үнэлж цэгнэн шударгаар хэлэх тул ихэд үнэлэгдэн Чингис хааны ордны дотрох бичиг хэргийн их түшмэлд өргөмжлөгджээ.

Энэ удаад ч Елюй-Чуцайн үгийг бүгд анхааралтай сонсож Шихихутаг тэмдэглэн авчээ. Монголчуудын дээд өвөг Хүннү нарын их байлдан дагуулалт одоо нэгэнт домог болон хоцроод хүчирхэг Хүннү гүрнээс тоос ч үлдээгүй байхад түүнд дарагдан мөхсөн гэх Римчүүд өнөөг хүртэл оршин байсаар зогсохгүй, тэр хүннүчүүдийн үр удам болох их Чингис хаанд элч илгээсэн болохыг мэдэхэд хэнд ч сонин санагдах ажээ.

Чингис хаан хэний ч байсан аливаа элчид их л хүндэтгэлтэй ханддаг бөгөөд одоо ч энэ байдлаараа сонсож мэдэхээс цаашгүй Рим гэгч улсын ламын элчийг төрийн элчийн ёсоор бараалхуулах зарлиг буулгав. Харин ингэхдээ Боорчийг байлцуулсан нь нэг талаас түүнд хүндэтгэл үзүүлсэн нөгөө талаас одоо Сүбээдэйн араас явах замд нь хэрэг болно гэж бодсоных байв. Чингис хаан ингэж өөрт нь ялимгүй ч болов хүндлэл үзүүлэх бүрт Боорчи баярлан бахаддаг байв. Чингис хаан ч Боорчийн сэтгэлийг ойлгоно .Ер нь Чингис хааныг Боорчи шиг, Боорчийг Чингис хаан шиг ойлгодог мэддэг хүн үгүй юм.

Илүү дутуу олон үг ярьж ам уралдахгүй ч аливааг зөвлөхөд Боорчи дуугүй ч гэсэн сууж байвал гаргасан шийдвэр нь үнэн баттай болох шиг Чингис хаанд санагддаг билээ. Боорчи таг дуугүй суух нь зөвшөөрсний тэмдэг тул Боорчийг ингэж дуугүй сонсон суухад Чингис хаан туйлын дуртай байлаа. Харин Боорчи, Гэрэг хэмээх хөвүүнтэй болсноосоо хойш олон үгтэй, жаахан давилуун түрэмгий зантай болсныг хэн ч анзаарсангүй ажээ. Өөрийн зан аашинд гарсан энэ өөрчлөлтийг Боорчи ч мэдсэнгүй.

Эртний хүчирхэг түүхтэй Рим гэгч улсын элч ирсэн нь Чингис хааны сүр хүч Адриатын тэнгис хүртлэх үлдсэн бүх аймаг улсыг донслоон айлгасны тэмдэг байв. Дорно зүгээс гэнэт хуй салхи шиг довтлон ирээд лалын шашинтны нэгдсэн улс Хорезмыг дөрөвхөн жилийн дотор мөхөөн эзлэн авсан талын нүүдэлчин аймгийн тухай мэдээ салхи мэт тарж тэдний догшин түрэмгий авир, дайнч шийдэмгий төрхийг Хорезмоос зугатан очсон хүн бүхэн батлан ярьсаар Монголчуудын тухай одоо балчир хүүхэд ч сонсоод айхаар болжээ.

Хэрмийн доторхи халуун ханзтай шавар чулуун оромжинд нүүхгүй сууж, гарахгүй амьдрагч суурин соёлтой иргэдэд морь унаж мод тохож газраас ургах мэт гэнэт тал талаас орилолдон гарч ирэх тэр аймшигт монголчууд яг л зэрлэг догшин амьтад, өлсгөлөн араатан мэт сэтгэгдэх ажээ. Ийм байдлыг баруун зүг цөмрөн довтолж байгаа Сүбээдэйн ялгуусан баатар цэрэг бүрэн харуулж байлаа.

Римийн их ламтны элч өрөөсөн хөмсөгтэй, этгээд царайтай Авраам Даяан гэгч ихийг үзэж дол цохисон, дал хол гарсан ч хөнгөн шаламгай еврэй гарлын энэ эр эхлээд Азарбайжаны Лилпур балгасыг эзлээд байсан Сүбээдэйтэй уулзсан ажээ. Алтан улстай хийсэн анхны дайнд зүүн хөлийн өсгийгөө тас цавчуулж доголон болсон Сүбээдэй төмөр хөө хуягаа хангинуулан хазганан алхах нь газар доргиж байх мэт бөгөөд элч нар ихэд сүрдсэн ч харин үзсэн зовсон

нь их Даяан огт ажиггүй зогсжээ.

Үнэхээр Авраам Даяан лам үхэж хүртэл үзсэн билээ. Тиймээс Чингис хааны догшин төрхт жанжин Сүбээдэйн өнгөн гаднах байдлаас айж сүрдсэнгүй, дагуул шавь нараа зоригжуулж зогсжээ. Харин ч энэ Сүбээдэй олон жилийн өмнө Тангудын Ашиг балгасын ойр анх учирсан монголоос тийм ч догшин сүрлэг үзэгдсэнгүй билээ. Сүбээдэй баруун зүгийн олон хот балгасыг эзлэж энэ нутгийн хүн зоны аяг жаягийг мэдэх болсон тул Даяаны үгийг анхааран сонсоод тэр дор нь хариу өгчээ.

Харин тэгэхдээ Чингис хаанд бараалхахын өмнө түүний шадар жанжин Боорчид бараалхахыг зөвлөжээ.

-Манай Рим улсын их ламтан монголчууд та нартай дайсагнах хүсэлгүй гэж элчийн хэлснийг сонсоод Сүбээдэй

-Энэ Рим улс хүртэл хэдий хир зайтай бол гэж уйгар хэлмэрчээс асуужээ.

-Одоо та бидний байгаа Лилпур балгасаас даруй мянга шахам бээрийн зайтай болов уу гэжээ.

-Тэгвэл миний цэрэг саадгүй явбал хоёр сарын дараа танай хотод хүрэх юм байна.

Миний цэргийг очиход хаалгаа дэлгэн найртайгаар угтагтүн. Тэр үед би эдний нөхөр, дайсан алин болохыг хэлье гэж Сүбээдэй ихээр инээжээ. Харин уйгар хэлмэрч Сүбээдэйн энэ үгийг яг ёсоор нь орчуулж чадсангүй билээ.

Гэвч төмөр хувцаст,өрөөсөн нүдэт энэ доголон монгол жанжин чухам юун тухай, юу гэж хэлснийг түүний дууны өнгө, нүдний харц ,инээднээс нь Даяан төвөггүй ойлгосон ч огт ойлгоогүй, мэдээгүй царай гарган өнгөрөөжээ. Римийн их ламтны тагнуул, элч болж дорно зүгийн бараг бүх улсад зорчсон Даяан энэ байтугай их үгтэй хаан эзэнтэй уулзаж байсан тул Сүбээдэйн давилуун үгэнд гайхсангүй. Олсон өчүүхэн ялалтаа үүрдийнх мэт санах нь жирийн цэргийн удирдагчдын өвчин байдгийг тэр сайн мэдэх билээ.

Сүбээдэй бол Даяаны нүүр тулан уулзсан хоёрдох монгол хүн юм.

Учир нь Шар мөрнөөс хойш амьдран суугч нүүдэлчин аймгуудын нутгаар тэр очиж байсангүй. Очих хэрэг ч гарсангүй. Очсон элч нарын үгнээс сонсвол тийш зүглэх нь ер үхсэнтэй адил гэлцжээ. Тэр нүүдэлчдийг Даяан хээр билчих зэрлэг гөрөөсний адил үл тоомсорлон үздэг байжээ.

Гэтэл өнөөх зэрлэг араатан мэт нүүдэлчдийг Тэмүжин гэгч нэгэн баатар эр нэгтгэн хурааж улс байгуулаад хэдхэн жилийн дотор ойрын хөрш, хүчирхэг Зүрчид, Тангуд, Уйгар, Харлаг, Кидан улсуудыг эзлэн дагуулсан сураг холын Римийн улсад дуулдсаар удаж, энэ нь тэдний сэтгэлд гайт Хүннүгийн сүнс сүүдрийг дахин амилуулжээ.

Тэмүжиний толгойлсон монголчууд ингээд зогссонгүй бүр Каспийн тэнгис хүртэл довтлон ирээд лалын шашинтны Хорезм улсыг сөнөөсөн нь загалмайн шашинтнуудын хувьд хэдий

сайшаалтай ч зуны тэнгэрээс цас унасантай адил цочмог санаандгүй явдал болжээ. Тийм учраас хүчирхэг дайсны өмнө хүлцэнгүй зогсох нь Даяаны цорын ганц зөв зам байв.

Үүнээс гадна их ламтны өгсөн нууц даалгаврын чухлыг бодсон ч Монголчуудын гашуун үг, давилуун занг тэвчин өнгөрөөх ёстой байлаа. Тийм ч учраас Сүбээдэйн бардам их үгийг өчүүхэн жанжны хөөрүү омголон зангийн илрэл төдий хэрэг гэж үзжээ.

Даяан бол Римийн их ламтны шадруудаас дорно зүгийн шар арьстнуудыг хамгийн сайн мэдэх цөөн хүний нэг билээ.

Тийм учраас хэний ч үл мэдэх Чингис хаантай уулзаж ирээдүйд тохиолдож мэдэх довтолгооноос улс болоод шашин соёлоо хамгаалан сэргийлэх арга замыг хайх үүрэг түүнд тохоогджээ.

Сүбээдэйн эзлэн аваад байсан Лилпур балгасаас Гүржийн Тифлис хотыг дайран Кавказын нурууг давж Афганы Перваны хөндийд суугаа Чингис хааны хээрийн өргөөнд ирэх хүртэл Сүбээдэйн шийтгэн олгосон алтан пайзыг үзүүлснээр Римийн ламтны элч нарт өчүүхэн ч саад учирсангүй тул Даяан нүүдэлчин монголчуудын энэ ухаанд багагүй биширчээ.

Олон улс дамжсан холын аян замд дайран өнгөрөх боомт, хотуудын харуул хамгаалалтыг ингэж энгийн бөгөөд шуурхай зохион байгуулсныг тэр хаана ч үзсэнгүй тул ихэд гайхан бахаджээ. Сүбээдэйн өгсөн, дээр нь Чингис хааны зарлиг тамгыг сийлсэн тохой хирийн алтан пайзыг үзүүлмэгц тэдний явах замын бүх саад шалгалт хормын дотор үгүй болж байлаа. Бас өртөө улааг гавшгай зохион байгуулж тэдэнд бараг хоол идэх цаг гарахгүй шахам түргэнээр унааг нь юүлж байсан нь харин ч төвөгтэй мэт санагджээ.

Үнэхээр Монгол цэргийн түргэн гавшгай зохион байгуулалт, сахилга баттай байдал нь түүнийг ихэд бишрүүлжээ.

Талын энэ нүүдэлчдийг тийм дорд үзэж болохгүй бололтойг Даяан ойлгож байлаа. Зам зуур Хорезмын хотуудын амьдрал сэргэж дайны түймэр утаа униар дарагдаж эхлэсэн нь илт байв.

Тэр бүү хэл Чингис хаан урьдын хаадаас бага татвар тогтоож, хэн ч болов дуртай шашинаа шүтэхийг зөвшөөрсөнд хүмүүс харин ч талархалтай байгаа нь ажиглагджээ.

Лалын шашинтны улсад загалмайн шашныг дэлгэрүүлэхийг зөвшөөрсөн нь Даяаныг юу юунаас илүүтэй гайхашруулжээ.Даяан Чингис хааны хээрийн хүрээнд хүрмэгц алтан пайзаа харуулын ахлагч Есөнтэй гэгчид үзүүлж Чингис хаанд бараалхах хүслээ илтгэжээ. Дахиад л өнөөх шидэт пайзныхаа хүчээр хүрээний дотогш саадгүй нэвтэрчээ.

Тэднийг тусгай гэрт оруулж Елюй-Чуцай гэгч түшмэл ирж тэдний ирсэн хэргийн учрыг байцаан асуужээ.

Харин Сүбээдэйн хэлснээр Боорчитой уулзаагүй нь өөрийн их ламтны нэр сүрийг өргөх гэсэн Даяаны их санаа байв.

Тэр өөрийн их ламтныг Чингис хаанаас дээгүүрт бодсоор байлаа. Ер нь тэр дотроо Чингис хаан гэгч болон эдгээр монголчуудыг дорд үзсээр байсан бөгөөд ганцхан тэдний дэндүү зэрлэг догшин авиртайг сонссон тул дэмий ихэмсэглэн хайран амиа золиослохоос болгоомжлон тэвчиж явжээ.

Түүнээс биш дорно зүгийн Алтан улс, Сүн улсын их хаадтай уулзаж хэрэг хэлцэж явсан түүнд энэ зэргийн нүүдэлчин омгийнхонд дорд үзэгдэн бөхөлзөх нь тэвчиж болшгүй хэрэг юм. Гэвч элч хүн очсон улсын ёсыг дагах нь хууль тул яалтай билээ. Даяан уйгар хэлмэрчээ дагуулан Чингис хаанд бараалхахаар очив.

Явах замд хиймэл бороо шир шир дусалж байсан нь дахиад л алмайруулав.

Тэр амьдралдаа хиймэл бороо оруулахыг анх үзжээ. Гэвч ингэж бороо оруулж болохыг түүний үл тоомсорлогч нүүдэлчин Шихихутаг санаачилсныг харин мэдсэнгүй

.Арван таван газрын хэл мэддэг, Хималайн их нурууны хойт урд талд оршигч бүх улс орныг нүхлэсэн Даяан нүүдэлчин аймгуудын их хаан Тэмүжиний алтан цацарт хөл тавих нь энэ ажээ. Тэр ороод нүд дастлаа юу ч дуугарсангүй. Бас хэтэрхий дор мэхийсэнгүй. Сурсан зангаар хормын дотор цацрын дотрох байдлыг гүйлгэн харж амжив.

Чингис хаан цацрын хойморт Хорезмын султан Мухамедийн их алтан сэнтийд заларчээ. Хаана ч байхгүй уран хийцтэй энэ цул алтан сэнтийг Даяан таньж байв. Мухамед султан Самарканд дахь өргөөндөө энэ сэнтийдээ залраад түүнтэй ярилцаж байжээ.

Тэр үед Даяан Египетийн баян худалдаачны дүрээр Хорезмд тагнуул хийж явсан билээ. Чингис хаан түүнд ер онцгой сэтгэгдэл төрүүлсэнгүй. Ядарч аяншсан царайтай буурал сахалтай тэр хүн нүүдэлчдийн догшин хаан гэхээсээ илүү Тангудын жирийн худалдаачны төрхтэй үзэгджээ.

Даяан бусад хүний адил Чингис хааны тухай сураг ховоор санаандаа бий болгосон хий дүрд итгэж явснаа ойлгов.

Чингис хааны баруун талд урт хар сахалтай өнөөх Елюй-Чуцай харин зүүн талд нь нэгэн үл танигч хүн суусныг Сүбээдэйн ярисан Боорчи гэгч биз гэж таажээ. Үнэхээр Елюй-Чуцайн танилцуулснаар Боорчи сайд ажээ. Боорчийн дор бийр янтай зэхэн суусан идэрхэн эр нь Шихихутаг гэх ажээ.

Елюй-Чуцай түүний тухай хаандаа танилцуулав бололтой хэдэн үг хэлээд Даяанд дохио өгөв. Чингис хааны ордны ёс дэглэм аливаа соёлтой улс гүрнийхээс хоцорч дор орох шинжгүйг тэр мэдээд өөрөө ч ёс алдахгүйг хичээжээ. Тийм ч учраас өөрийн ирсэн хэргийн учрыг уйгар хэлмэрчээрээ дамжуулан уламжилсанд Елюй-Чуцай алга дэлгэн өөрөөс арай дор суухыг урьжээ.

Тансаг зандан ширээ зөөлөн олбогт сандал нь үзтэл дорно зүгийн гайхамшигт хийцтэй бөгөөд Зүрчидийн алтан улсын хааны ордны тавилгатай адил санагджээ. Елюй-Чуцай нэг зүйл хэлснийг хэлмэрчээс сонсвол ирсэн хэргийн учрыг Чингис хаанд айлтга гэсэн ажээ.

Елюй-Чуцайн дууны өнгө хэдий зөөлөн намдуу ч өмнө уулзсан доголон Сүбээдэйн дуутай адил түрэмгий шаардсан аястай байхыг Даяан мэдэрч өөрийн эрхгүй босож мэхийв. Ингэх нь хэдий доромжлолтой ч төрийн ёсыг дагах нь түүний үүрэг билээ.

-Манай Римийн эзэнт гүрэн бол энэ газрын хамгийн эртний агуу их түүхтэй улс юм.

Мянга гаран жилийн тэртээ манай Рим энэ газрыг бүхэлд нь эзэлсэн их гүрэн байжээ .Тэр цагт танай монголчуудын дээд өвөг Хүннү гүрний хаан Атилла цэрэглэн нүүж ирээд манай Римийн эзэнт гүрнийг мөхөөв гэж түүх шаштирт тэмдэглэжээ. Гэвч Римийн их улс Атилла хааны хүчинд дарагдан сөнөсөнгүй. Өөрсдийн дотроо эв эвдрэлцэн эрх булаалдсанаас болж дарагджээ.

Хэдий тийм ч тэр цагийн Хүннү гүрнээс зөвхөн нэр л үлдэв. Харин манай улс өнөөг хүртэл тогтносоор биднийг аврагч Исус Христийн ариун сургаал энэ гэзрын бүх улсыг нэгтгэн ивээн тэтгэсээр иржээ. Бид хэл угсаа ямар ч байсан Ертөнцийн эзний гэгээн сургаал, хэмжээлшгүй авралын дор амьдран суух ёстой юм. Манай их ламтан та нарыг ч мөн адил ертөнцийн эзний авралд багтаасай гэж хүсэх тул намайг элч болгон илгээлээ. Танай тал нутгийн Хэрэйд аймаг Исусын ариун сургаалийг дагаж Ертөнцийн эзний ивээлд багтаж байсныг би та бүхэнд сануулж байна гэж Даяан давилуун хэлээд хэлмэрчээ харжээ.

Энэ бол түүний хэлэх үгийн оршил байв. Хэлмэрч түүний сая хэлснийг дамжуулсны хойно цацарт хэсэг зуур нам гүм болов.

Анх удаа Чингис хааны үгийг сонсож ухааныг мэдэх цаг ирлээ. Нүүдэлчдийн хаан Тэмүжин гэгч энэ хүн чухам ямаршуухан ухаан санаатай эр бол гэхээс Даяан тэсч ядав. Хүний эхлэн хэлсэн хэдэн үгнээс ухаан санааных нь хэр хэмжээг мэдэж таньж чаддагтаа тэрээр туйлын ихээр бахархан бардамнадаг бөгөөд ингэж шинжихдээ хэзээ ч алдаж байсангүй гэж өөрийгөө дөвийлгөдөг билээ. Тийм учраас энэ бүдүүлэг зэрлэг нүүдэлчдийн хааныг ямар хүн болохыг мэдэх гэж яарчээ.

Гэтэл бүх юм түүний санаснаар болсонгүй. Түүний үгийг хэлмэрчийн дамжуулсны хойно Чингис хааны зүүн талд суугч гэнэт дуугарсан нь арслан архирах мэт сонсогдсонд сая л түүнийг сайтар анхааран харжээ. Энэ бол Боорчи байв. Даяаны нүдэнд энэ нимгэн дээлтэй, үрчлээт царайтай эрийн зүүн чихний омогноос доогуур зурайх гүнзгий улаан сорви хамгийн түрүүнд тусжээ. Даяан түүнийг танив. Даяан бол үзсэн харснаа хэзээ ч андуурч мартдаггүй гаргууд ойтой хүн билээ. Тэр андуурсангүй.

Одоо тэр хүний нүд хөмсөг нь ч сэтгэлд тодрон буув. Чингис хааны шадар сайд Боорчи гэгч энэ эр олон жилийн өмнө Тангуд улсын Ашиг балгасын ойр анх учирсан тэр хүн мөн мэт гэнэт санагдахад айх гайхах зэрэгцжээ. Гэвч одоо эртний тэр дурсамжид автан суух хором даанч байсангүй. Уйгар хэлмэрч Боорчийн хэлснийг орчуулжээ.

-Чиний тэр Ертөнцийн эзэн гэгч чинь хэн бэ. Танай улсын хаан юм уу. Тэр юун их нэртэй юм бэ. Улаан сорвитын архирах мэт дуугарсан нь ингэж асуусан хэрэг байжээ.

”Би зүүдэлж байгаа биш биз”гэж Даяан бодож байсан ч Боорчийн асуулт дэндүү гэнэтийн,

бас дэндүү болхи шулуун байсан нь түүнийг сандаргав. Энэ бол зэрлэг нүүдэлчин л асууж болох үг байлаа.

”Та нар Ертөнцийн эзнийг мэдэхгүй хаана явсан улс вэ” гэж сөргүүлэн асуумаар байсан ч тэвчив. Ийм бүдүүлэг, ийм ичгүүр сонжуургүй, аймшиггүй асуулт Даяан өмнө нь сонсож байсангүй. Бас талын зэрлэг нүүдэлчидтэй буруу ярьж эхлэснээ ч ойлгов. Монголчууд, хятадуудтай адил мэдэмхий нэрэлхүү биш болохыг ухаарав.

Тэгээд Боорчид Ертөнцийн эзэн гэж хэн болохыг ойлгуулах гэж бодолхийлэв. Даяан хэзээ ч ийм гэнэтийн хэцүү асуултад хариулж байсангүй мэт санагджээ. Ер нь Ертөнцийн эзэн гэж хэн бэ гэж тэр өөрөөсөө ч асууж байсангүй.

-Ертөнцийн эзэн Исус Христос бол гэж Даяан сүмд цугласан сүсэгтнүүдийн өмнө хэлдэг үгээ хэлэх гэтэл Боорчи түүний үгийг таслан дахин архирав. Уйгар хэлмэрч даруй орчуулжээ.

-Чи Ертөнцийн эзэн гэж юун дэмий үг байн байн чалчина вэ. Энэ ертөнцөд ганцхан эзэн байх ёстой юм.

Одоо чи Ертөнцийн эзэн их Чингис хааны өмнө зогсож байна. Хэрвээ чи их Чингис хаанаас өөр Ертөнцийн эзэн гэж өөрийгөө тооцогч байгааг мэдэх аваас түүнийгээ бидэнд зааж өгөгтүн. Бид даруй очиж эрэгчин эмэгчинээ үзэлцье.

Чиний тэр эзэн лав үүнийг хүсэж чамайг явуулсан биз. Харин элчээ илгээж найрамдъя гэснийг үзэхэд ялимгүй амьтан бололтой. Гэвч сайхан сэтгэлээр элч илгээсэн аваас бид ад үзэх явдалгүй. Харин танай улс хүртэл эндээс хэдий хол байна.

Боорчи яг өнөө доголон Сүбээдэйн адил үг хэлснийг Даяан сонсоод энэ хол газар бие, морио зовоон дэмий иржээ гэж ойлгов. Монголчууд үгсэн нэгдсэн мэт нэг зүйлийг хатуу шаардсан нь бүх газрыг нэгтгэн захирах явдал эдний ганц бодлого болохыг гэрчилнэ.

Доголон Сүбээдэй өөрийн зоргоор дэмий чалчаагүйг мэдээд эдгээр нүүдэлчид ийм холын хатуу зорилготойд ихэд гайхжээ.

Талын зэрлэг монголчуудыг шашин сурталдаа дагуулан авах гэсэн их ламтаны зарлиг хад мөргөн бутрах тэнгисийн ус адил бутран сарнихыг тэр өөрөө үзэв. Эдэнтэй илүү үг ярьж сөргөлдөх нь харин ч тэдэнд Римийг довтлох санааг төрүүлэх аюултай болохыг Даяан ойлгов. Боорчийн ил шулуун үгэнд эсэргүүцэх буюу тайлбарлах хариу өгөх ямарч боломж түүнд үлдсэнгүй

.Одоо түүнд зөвхөн элчийн нэрэн дор өөрийгөө хамгаалан авч гарахын тулд инээж бөхөлзөхөөс өөр зам үгүй болжээ.

Харин энэ бэрх байдлаас түүнийг Чингис хаан өөрөө аварсан нь гайхалтай хэрэг боллоо. Боорчи гэгч энэ мунхаг амьтан зөвхөн өөрийнхөө бодсоныг хэлсэн ажээ. Даяан дахин амьсгаа аван тайтгарав. Шашин нэгтнээ нүүдэлчдийн довтолгооноос авран сэргийлэх ариун үүргээ биелүүлэхийн төлөө бүхнийг тэвчих ёстойг нь Чингис хаан түүнд сануулах шиг санагджээ.

-Танай их ламтан чухам юуг хүснэ вэ гэж Чингис хаан зөөлхөн асуув. Чингис хааныг ийм аядуу нам дуутай гэж Даяан огт санаагүй тул түүний асуусныг эхлээд ойлгохгүй хэсэг тулгамдсан ч ”Чингис хаан нь арай илүү ухаантай юм” гэж ихэмсэглэн боджээ.

Гэвч энэ асуулт зөөлөн хэдий ч Боорчийнхтой адил хэцүү тулгасан асуулт байв.

-Хэл яриа, зүс царай ялгаагүй энэ газрын дээр амьдрагч хүмүүн бүр ертөнцийн эзний ивээл дор дайн самуунгүй амьдран суухыг манай их ламтан хүсдэг юм гэж Даяан тайван, сандарч тэвдсэн зүйлгүй сууж хариулав.

Монголчуудаас хэн нь ч тэр дороо хариу хэлсэнгүй. Энэ нүүдэлчдийг одоо л нэг өөрийн үгэнд барьж авлаа хэмээн тэр баярласан билээ. Монголчуудын чимээгүй болсон нь Чингис хааныхаа үг хэлэхийг хүлээсэн хэрэг байв.

Тэд хэдий зэрлэг нүүдэлчид ч гэлээ ордны дэг ёсонд амархан, хурдан дассан нь илт байв. Энэ байдлыг үзээд Даяан өөрийн эрхгүй хүндэтгэх сэтгэгдэл төрж байжээ.

-Танай их ламтан ухаантай, сайхан сэтгэлтэй хүн бололтой. Түүний хүсэл надад таашаагдаж байна.

Би дайн самууныг үл хүсэх учир энэ Хорезмд ирлээ. Хорезмын хаан Мухамед миний илгээсэн жирийн худалдаачдыг алсан тул би өөрийн эрхгүй их цэргээ хөдөлгөн ирж ял асуухаас өөр аргагүй болов. Миний сайхан сэтгэлд хэн ч бай, энэ Мухамед шиг бас түүнийг залгамжлан суусан Желаладдин шиг хандана, тэр үхдэл болж улсаа хураалгах болно. Миний улс баян, цэргийн хүч дийлдэшгүй. Надад бусдын газар нутаг, эд баялаг хэрэггүй .Би ганцхан энэ газар дээр дайн самуунгүй энх амгалан байхыг хүсч биеэ зовоож цэргээ хохироож явна. Хорезмын хаан Мухамед Аллах тэнгэрээ дуудсаар миний цэргийн өмнө мөхөж сүйрлээ.

Аллах тэнгэр нь түүнд тусалсангүй. Та нар ч хар буруу санавал мөн үүний адил болох нь гарцаагүй.

Миний их цэрэг довтлон орвол танай тэр ертөнцийн эзэн Исус чинь та нарыг авран хамгаална гэж чи санана уу. Чин үнэнээр нь хэлэгтүн гэж Чингис хаан асуухдаа ивээнгүйгээр инээмсэглэж байсан нь Даяаныг хариу олохгүй гэдгийг лавтай мэдэж байх шиг санагджээ.

Чингис хаан өнөөдөр угаас туйлын баяр хөөртэй байжээ. Учир нь тэр Боорчийг Сүбээдэйн хойноос илгээхдээ хэлэх үгээ урд шөнө нь бодож олсон байжээ. Харин Даяан Чингис хааны хэцүү бэрх асуултад хариулахын өмнө оюун ухаанаа хөвчлөн байж сайтар бодов. Түүнийг монголчууд шавдуулсангүйгээр барахгүй Елюй-Чуцай идээ зоогт урьсан нь түүнд бодох боломж олгосон ордны түшмэлийн нарийн арга болохыг мэдээд түүнд гүн талархлтай болжээ. Энэ монголчууд санаснаас тийм ч амар хоол биш болохыг Даяан перс газрын идээ будаа зооглож суухдаа бодож байв.

Гэвч Елюй-Чуцай хоолой засаж түүнээс хааныхаа үгний хариуг нэхэв. Өөрийгөө ертөнцийн эзэнтэй эн тэнцүүд үзэх нүүдэлчдийн их эзэн Чингис хаантай үг хэлээ ололцох нь туйлын хэцүү, бүр боломжгүй хэрэг юм гэдгийг тэр одоо мэдэрч байлаа.

- Манай их ламтаны хүсэл бол ертөнцийн эзний зарлиг юм.Ертөнцийн эзэн бидэнд амьдрах арга зааж өгсөн шигээ бас энх амар амьдрах аргыг зааж өгчээ. Хэлмэрчийн дамжуулсныг сонсоод Боорчийн гар хөдөлж Даяаны үгийг тасалдуулсан нь тэр үг хэлэх зөвшөөрөл хаанаасаа хүссэн хэрэг юм. Харин Чингис хаан Боорчийн хэлэхийг сонсохыг хүсчээ.

-Ламын элч чи.Чингис хааны үгийг дутуу ойлгов уу. Эсвэл чи албаар зөрүүдлэн зүтгэнэ үү. Үгүй бол уйгар хэлмэрч чи буруу зөрүү үг хэлж элчийг төөрөгдүүлнэ үү. Наад элч чинь яагаад ингэж Ертөнцийн эзэн гэж байн байн давтан чалчина вэ.

Энэ Хорезмынхон өөрсдийн Аллах тэнгэрийг мөн л ертөнцийн эзэн гэж залбирч мөргөж гуйсаар бидэнд дарагдсан. Биширч шүтсэн иргэд албатаа хамгаалж эс чадвал хэн түүнийг Ертөнцийн эзэн гэж үзэх вэ. Хэрвээ наад ламын чинь хэлээд байгаа шиг Христос бил үү тэр эзэн нь тийм сүрхий хүчирхэг юм бол бидэнд түүнийгээ үзүүлэг. Бидэнтэй ирж хүчээ үзэг гэсэн биш үү.

Үгүй бол түүнийг Ертөнцийн эзэн гэж бүү дуудагтүн.

Манай Хэрэйд аймгийн Тоорил хан христийг шүтэж модон загалмай гэрийнхээ үүдэнд өлгөөд юу хожив.

Газар дээр булш бунхан ч үгүй үхсэн. Тэгэхээр хар хувцаст чи Ертөнцийн эзэн гэж гарт үл баригдаж, нүдэнд үл үзэгдэх дэмий юм ярьж цагийг бүү бар. Харин танай улс манай Чингис хааныг дагаж ивээлд нь багтвал бид танай улсыг хамгаалан авч жаргаан сууя. Би удахгүй Чингис хааны зарлигаар баруун зүг одно. Тэгэхдээ Сүбээдэй баатрын тэндээс цэрэг илгээн танай их ламтан чин үнэнээсээ найрамдъя гэсэн эсэхийг шалган үзье. Чи манай цэргийг газарчлан дагуулж яв гэж Боорчи сүртэй хэлсэнд уйгар хэлмэрч сүрдэн хормой чичрүүлж зогсжээ.

Боорчийн энэ үг Елюй-Чуцайг баахан гайхашруулж харин Чингис хаанд таашаагдахыг Даяан анзаарчээ.

-Элч чи үнэхээр эв найрыг хүсч ирсэн бол өөрөө манай цэрэгт хотынхоо хэрмийн их хаалгыг дэлгэж өгөгтүн гэж Чингис хаан Боорчийн үгний дараа хэлжээ. Ийм гэнэн бөгөөд тэнэг, бас гэнэтийн шаардлагыг элч болж зарагдан элдэв хүмүүстэй нүүр тулж явахдаа тэр огт үзсэнгүй билээ.

Энэ Чингис хаан өөрийгөө Ертөнцийн эзэн гэж үнэхээр итгэснээс зайлахгүй ажээ.

Хаана байгаа Рим, хэзээ хүрэх монголын цэрэг билээ. Гэвч Чингис хааны үгэнд хариу хэлэхгүй байх эрх түүнд даанч байсангүй. Болдогсон бол тэр энэ ихэмсэг тэнэг нүүдэлчдийн цацрыг орхин одмоор санагдана.

-Манай улсын хил хүртэл хол зайтай. Тэгээд зам зуурын улс аймгийн эсэргүүцэл их тул Чингис хаан таны энэ зарлигийг түргэн зуур биелүүлэхэд хэцүү байх болов уу. Харин би даруй гэдрэг буцаж Чингис хаан таны энэ үгийг их ламтандаа уламжлан хариуг илгээе. Таны их цэрэг бидэнтэй найрамдахаар очих аваас бид лавтай хотынхоо хаалгыг дэлгэн угтах болно

гэж Даяаны хэлснийг Чингис хаан сонсоод

-Элч чи бүү санаа зов. Бидэнд хол газар гэж үгүй. Гагцхүү элч чи миний цэргийг нутагтаа дагуулан очихоос айж буйг би харж байна. Энэ нь ч зөв биз. Их ламтандаа үнэнч зүтгэх сэтгэлийг чинь би үнэлж байна. Хожим нэг өдөр монгол цэрэг танай хотын дэргэд хүрээд танай их ламтаны үнэн үгийг сонсохоор асуух болно. Тэр цагт өнөөдрийн хэлсэн үгээ бүү мартаарай гэж их ламтандаа хэлэгтүн. Чиний үгийг их ламтаны үг гэж би ойлгов. Дараа уулзахад өнөөдрийн үгээ мартсан байвал харин ял асуух болно гэдгийг бас сануулагтүн

Энэ үгээр уулзалт гэнэт өндөрлөж Даяан Чингис хаанд бэлгээ гардуулах л үлдэв. Бэлгийг Чингис хаан өөрийн биеэр хүлээн аваагүй нь түүний улсыг, их ламтныг монголчууд хэрхэн үзэж байгаагийн илрэл байв. Сая бараалхаад хэлсэн түүний үг Чингис хаанд онцгой сэтгэгдэл төрүүлж чадаагүйг Даяан ойлгов.

Их ламтаны бэлгийг Шихихутаг, Гэрэг гэгч залуу ноёны хамт хүлээн авчээ.

Аллах тэнгэр, Исус тэнгэр хоёрыг үл тоомсорлогч, өөрсдийгөө тэднээс дээгүүрт үзэгч Чингис хаан гэгчид бараалхаж,үгийг нь сонссон Даяан гайхах эгдүүцэх зэрэгцсээр байв. Хорвоогийн хэрэг явдал юутай хурднаа хувиран өөрчлөгдөнө вэ.

Тангудын Ашиг балгасын ойр Прескучи нэрт хэрмэл худалдаачны дүрээр тагнуул хийж яваад хээрийн дээрэмчдэд баригдан хамаг бараагаа дээрэмдүүлсэн нь санагдав. Тэгэхэд Даяан үхэлтэй нүүр тулгарч Исус тэнгэрийн авралаар амьд үлдэв гэж итгэсээр өнөөг хүрсэн билээ. Гэтэл үхлээ хүлээн элсэнд булаатай хэвтэж байхад нь давхин ирээд элснээс сугалан авч аварсан улаан сорвит монгол эрийг чухам Исус тэнгэрийн элч гэж итгэн түүнд бишрэн өдөр алгасахгүй залбиран мөргөж ирсэн билээ.

Амийг нь аварсных төлөө тэр Исус тэнгэрийн элчид сайн сайхныг хүссэн нь тоогүй байв. Гэтэл түүнийг аврагч Исус тэнгэрийн элч өнөөдөр Чингис хааны дэргэд шадарлан суухыг үзжээ. Бүр тэр Исус тэнгэрийн элчийг Чингис хааны их шадар сайд Боорчи гэдэг ажээ. Чингис хаантай хийсэн хүнд хүчир уулзалтынхаа сэтгэгдлээс Даяан алгуур салж тэр өнгөрсөн явдлыг сая л нэг санахтайгаа болов

Энэ явдал одоогоос хориод жилийн өмнө 1205 оны хавар болсон ажээ. Найман улсыг мөхөөж иргэдийг нь хураан авсан Тэмүжин их цэргийн хамт Алтайн нурууны өвөрт өвөлжөөд хаваржиж байв. Хаврын урь орж эхэлсэн нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Боорчи, Зэлмэ нарын дунд нууц яриа болсон нь Тангуд улсад цэргээ оруулж байдлыг туршин тагнах тухай байв.

Тал нутгийн монгол аймгууд Тэмүжиний дор нэгдэж цэргийн хүч их болоод байсан нь дараагийн олз омгийг хаанаас эрэх вэ гэсэн далд хүслийг бүгдийн сэтгэлд сэм ургуулжээ. Цэргийн хүчээр булаан авахын амтанд тэд нэг мөсөн шунан дурлаад байсан нь яг л цусны амт мэдэрсэн араатны хүслийг ундрааж байлаа. Ийм үед цэргийн чадварыг шалган турших бас сургах нь зайлшгүй болжээ. Амьд хурга авчиран бэлтрэгээ сургадаг чонын аргыг хэрэглэхээр Тэмүжин шийджээ.

Одоо тал нутгийг хүрээлэн суугч суурин иргэдийн хот балгасыг эзлэн авах нь зайлшгүй

байлаа. Гэвч тал газарт морин дээр сэлэм жад, нум сумаар дайтаж сурсан монгол цэрэгт шавар хэрмийг дайран эзлэх туршлага арга байсангүй.

Сургаж заах чадвартан ч үгүй байв. Бас тэднийг яаж хамгаалж бэхлэн суудгийг ч үзсэн мэдсэн хүн ховор байлаа.

Яг ийм зорилгыг хэрэгжүүлж, хурга шиг ноолж болох улс бол Тангуд гэж Тэмүжин нар үзжээ.

Тангуд улсад хүрэхэд энэ Алтайн нуруунаас хамгийн дөт байлаа.

Гэвч Тангудад их хүчээр шалтгаангүй довтлох нь бас галаар тоглох шиг аюултай хэрэг юм.

Тангудтай их дайн үүсгэвэл Алтан улс хүч хавсрах тул Тангудыг их хүчээр дайлах гэсэн зарим нөхдийн үг, хүслийг няцаахаас өөр аргагүй болжээ. Гэвч хэн хэнээ гомдоохгүй арга олсон нь хамгийн шилдэг мянган цэргийг шилэн авч Тангудын хойт талын хот балгасыг сэм довтлон туршихаар шийдсэн явдал байв. Энэ цэргийг Боорчи удирджээ.

Хэрэйдийн Тоорил ханы хөвүүн Сэнгүм ,Тангудын Ашиг балгасын хавиар тэнүүчлэн яваг эрж олох зорилготой гэж зар тараагаад Боорчийн цэргийг Тангудын хилийг давуулсан билээ.Энэ бол хуурамч зорилгоор халхавчлан харь улсад хийсэн Тэмүжиний анхны дайн байлаа. Яг ингэж явахдаа Сэнгүм нарт талагдсан хэдэн худалдаачидтай таарсан нь Даяан, түүний дагуулууд байжээ.

Нүүр толгойг нь цухуйлган элсэнд булж орхих нь дээрэмчдийн хамгийн шилдэг хорон аллага билээ.

Халуун наранд хатаж үхэх нь хамгийн бэрх тамлал юм. Харин аз болоход Боорчийг очиход Даяаны нүдийг шувуу арай ухчихаагүй байжээ. Цуг явсан хоёрын нь нүдийг аль эрт шувуу амьдаар нь орилуулан ухаж идэхийг Даяан үзжээ. Одоо түүний ээлж иржээ. Хар шувуу толгой дээр нь ирж суухад Даяан эцсийн хүчээ шавхан Исус тэнгэрээ дуудаж аврал энэрэл гуйжээ

.Хар шувууны эвэр хошуу зүүн хөмсөгийг нь ханз татан авахад Даяан бараг ухаан алджээ. Исус тэнгэр түүний дууг сонссонгүй ажээ. Исус тэнгэрт итгэж явсан нь талаар болохыг гашуудан мэдрэх даанч гашуун байсансан. Гэвч цөхөрсөнгүй дуудсаар байв. Дараа нь юу болсныг Даяан яг л зүүдэлж байх шиг үзжээ. Хүзүү хоолойдоо аймшигт улаан сорвитой Исус тэнгэрийн элч хүрч ирээд түүнийг элснээс сугалан аварч амьдралыг эргүүлэн өгөөд хэрэг болгож нэрийг нь ч асуулгүй, ирсэн шигээ гэнэт алга болоход Даяан уйлан мөргөсөөр хоцорчээ.

Ингэж Исус Христос түүний үнэнч зүтгэснийг нь үнэлэн аварч өршөөв гэж Даяан эргэлтгүй итгэсэн билээ.

Хоёр нөхөр нь шувуунд нүдээ ухуулж азтай Даяан зүүн хөмсөггүй хоцорчээ. Харин сохорч үлдсэн хоёр нөхрөө Ашиг балгасын дэргэд эзгүй газар өөрөө хутгалан хороосон билээ. Үүнийг хэн ч үл мэднэ. Сохорсон тэднийг маллаж явах арга түүнд байсангүй. Тэднийг төөрч

эсвэл ангаж тарчилж үхэх аюулаас гэтэлгэсэн гэж одоо ч өөрийгөө цагаатган бодсоор ажээ.

Харин өнөөг хүртэл Исус тэнгэрийн элч гэж санаж явсан тэр улаан сорвит хүнтэй уулзах, аварч өршөөсөнд нь талархах эсэхээ шийдэж чадахгүй эргэлзсээр байв. Улаан сорвитой тэр эрийг Исусын элч гэж итгэж явсан тул Боорчийг Чингис хааны их шадар сайд байсанд ихэд балмагджээ. Учир нь өнгөрсөн тэр явдал Авраам Даяаны сэтгэлд дэндүү гүнзгий ул мөр үлдээсэн байв. Тэр үед Даяанд үхэхэд ердөө хэдхэн хором үлдсэн байсан билээ. Харсаар байтал хэдэн хар шувуу нисэн ирж хоёр нөхрийн нь толгой дээр суугаад нүдийг нь ухаж эхлэхэд тэдний аймшигтайгаар хашгирах одоо ч чихэнд нь сонсогдох ажээ. Тэд зүгээр л албат зарц, Исус тэнгэрт гүнзгий сүсэг бишрэлгүй хүмүүс байсан нь хар шувуунд нүдээ ухуулан тамлуулахад хүргэсэн хэмээн одоо ч тэр итгэх бүлгээ.

Харин Даяан Ертөнцийн эзэн, аврагч тэнгэр Исус Христосыг зай завгүй дуудан мөргөж залбирал уншлагаа таслаагүй нь түүнийг амьдаараа нүдээ ухуулахаас аварчээ.

-Аврагч тэнгэр Исус минь. Үнэнч шавь намайг үхлээс авраач гэж гуйсаар байсанд нөхдийнх нь дөрвөн халуун нүдийг ухаж идээд нисэн ирж толгой дээр нь суумагц хөмсөгийг нь зулгаан идэж эхлэсэн шувууд гэнэт нисэн одоод бүрэлзсэн нүдэнд нь Тэнгэрээс морьтон баатар бууж ирэх нь үзэгджээ. Энэ бол Исус тэнгэрийн илгээсэн аврагч элч байв. Даяаны зүрхний цохилт удаашраад тэр үхэж байсан билээ. Харин энэ бүх явдал хойт насанд нь болж байна гэж боджээ. Ухаан балартсан түүнийг элснээс сугалан гаргахыг, булгийн цэнгэг ус цээжийг нь онгойлгон цутган орохыг мэдэж сэхээ оржээ.

Өмнө нь аврагч Исус тэнгэрийн элч сууж байв. Зүүн чихний омогноос доош гүнзгий улаан сорвитой бас их зөөлхөн дулаан харцтай тэр хүн чухам амилсан Исус Христос шиг үзэгджээ. Даяаны цус, нулимс холилдон урсаж, элчийн өлмийгөөс адис авснаа л санадаг билээ. Исус Христос амьд хүний эгэл дүрээр оршдог, зовж шаналсан шавь нараа үргэлж авран хамгаалж байдгийг Даяан ингэж өөрийн биеэр үзжээ.

Түүнийг аварсан тэр Тэнгэрийн элч бол Исусын арван гурван шавийн нэг зоригт Шолом мөн болохыг сүүлд Римд ирсэн хойноо эртний судар үзэж байгаад Даяан гэнэт олж мэджээ. Зоригт Шолом яг тэр Тэнгэрийн элч шиг зүүн чихнийхээ омогноос доош гүнзгий улаан сорвитой байлаа. Аврагч Исусын элч Шолом өөрийн биеэр морилон ирж Тангудын цөлд учирсан үхлээс аварсан тухай Даяаны бичсэн ном Исус Христосыг шүтэгчдийн дунд алдаршин тархаж аврагч Исусын тухай жинхэнэ үнэн магтаал болон дуурсагдсанаар барахгүй Даяан ч ертөнцийн эзний жинхэнэ үнэнч шавийн ёсоор нэрд гарч төдөлгүй Римийн их ламтанд шадарлан хамгийн алдартай номлогчийн хувиар шилэгдэн харийн оронд элчээр томилогдох болсон билээ.

Тэр цагаас хойш Даяан Римийн хамгийн алдартай хүний нэг болсон юм. Аврагч Исус тэнгэр өөрийн үнэнч шавь зоригт Шоломыг илгээн түүнийг хамгаалан авснаар Даяан өөрийгөө Ертөнцийн эзний ивээлд багтан нэрд гаран тодорсон гэж чин үнэнээр итгэн биширч иржээ.

Гэтэл өнөөдөр түүний чин үнэн бишрэлд хэзээч үл мартагдахаар гүн шингэсэн аврагч Исусын элч зоригт Шолом, Чингис хааны дэргэд шадарлан суухыг үзээд учраа олохоо болив. Үнэхээр сэтгэл санаагаа барьж, удирдан жолоодож сурсан хүний ёсоор элчийн журмыг бат

сахин үг хэлэлцэж чаджээ. Есөнтэйн тушаалаар олгосон сэрүүн гэрт орж ганцаар үлдмэгцээ Даяан хөлгүй мэт сөхрөн унажээ. Түүний гайхашрал эргэлзээнд хязгаар байсангүй. Тээшээ ухаж, хэзээ ч орхилгүй нандигнан авч явдаг өөрийн дурсамж номлолоо гарган үзэв.

Эхний нүүрэнд өөрийн гараар зурсан Ертөнцийн эзэн Исус тэнгэрийн элчийн зураг байдгийг айсан мэт нээжээ.

Зургийг үзмэгц тэр гашуунаар эхэр татан хашгираад ухаан алдан унав. Тэр яах аргагүй Чингис хааны шадар сайд Боорчийн хөргийг зурсан байжээ. Түр зуур ухаан балартаад сэргэхдээ Авраам Даяан хэмжээлшгүй их айдаст автсан байв. Чингис хааны болоод түүний шадар сайд Боорчийн хэтэрхий түрэмгий давилуун зан гэнэт аврагч Исустай холбоотой мэт санагдаад тэр ийнхүү үлэмж ихээр айн балмагджээ.

Талын нүүдэлчдийн их хаан Тэмүжиний дэргэд аврагч Исусын элч зоригт Шолом өөрийн биеэр заларч суугааг үзээд Даяаны ухаан ингэж самуурах нь аргагүй билээ.Тохиолдол биш үү гэж өөрийн самуурсан ухааныг цэгцлэхийг хүчлэн оролдсоор байвч хэт их итгэл бишрэл нь аврагч Исусын эсрэг сэтгэж чадахгүйд хүргэжээ. Залбирч мөргөсний нь бас итгэж биширсний нь хариуд элчээ илгээн үхлээс аварсан, өнөөг хүртэл амьдралыг нь хөтлөн зааж ухааруулан гэгээрүүлж байгаа аврагч Исуст итгэхгүй байхын арга даанч байсангүй.

Итгэхгүй байна гэдэг өөрийн үзсэн амьдрал, итгэл үнэмшилээс урвана гэсэн үг байлаа.

Эцсийн эцэст Даяан өөрийн итгэл бишрэлд хөтлөгджээ. Энэ бол түүний төрсөн өдрийн төөрөг тавилан байжээ. Хээр талын зэрлэг бүдүүлэг нүүдэлчин аймгууд гэнэт хүчирхэгжин энэ хүртэл довтлон ирж лалын шашинтны их улс Хорезмыг сөнөөн дарсан нь Ертөнцийн эзний хүсэл зарлигаар хийгдэж байгаа хэрэг гэж бодохоос өөр аргагүй мэт санагджээ.

Тэгээд ч энэ зэрлэг бүдүүлэг нүүдэлчид аврагч Исусын ивээл дэмжлэгийг олохгүйгээр яахин ингэж баян хүчирхэг Хорезмыг сөнөөж чадах билээ. Харин ч Ертөнцийн эзэн өөрийн үнэнч шавь нараа хамгаалан энэ нүүдэлчдийн гараар буруу номтон лалын шашинтнуудыг даруулсан нь нэгэнт тодорхой санагджээ.

Тийм ч учраас Чингис хааны дэргэд өөрийн үнэнч шавь зоригт Шоломыг илгээн суулгажээ хэмээн Даяан хэргийн цаад учрыг тайлан ойлгомогцоо чухам яагаад Чингис хаан Ертөнцийн эзний өмнөөс ярьж байсныг мэджээ. Чингис хаан энэ газар дэлхийн өөр өөр шашин сурталтай улс орнуудыг илбэн тохинуулж, эзлэн дагуулж байгаа нь Ертөнцийн эзэн, Исус Христосын зарлиг болохыг ойлгов. Энэ тухай Исусын ариун сударт тов тодорхой өгүүлсэн байдгийг Даяан гэнэт ухаарчээ.

Бүхнийг аврагч Тэнгэр Ертөнцийн эзэн тэрбээр талын нүүдэлчдийн эзэн Тэмүжинг буруу номтнуудыг даруулахаар газарт илгээжээ. Ертөнцийн эзний их хүч ивээлийг олсон Чингис хааны өмнө лалын шашинтны улс Хорезм, Багдад, дараа нь Каспийн болоод Газар дундын тэнгисийн хойгуур орших улс аймгууд ээлж дараалан дарагдан мөхөх тавиланг Даяан одоо тод харж байлаа. Харин тэр өөрийгөө энэ ертөнцийн хамгийн азтай хүнд тооцов.

Ертөнцийн эзэн үнэхээр түүнийг онцлон үзэж ивээлдээ багтаасанд дахин итгэв. Тэр

Ертөнцийн эзний элчтэй хоёр дахиа уулзав. Ийм хүн загалмай шүтлэгтний дотор түүнээс өөр байхгүй гэдэгт тэр итгэлтэй байлаа. Энэ бол түүнийг Римийн их ламтаны залгамжлагч байх ёстойг батлах мэт санагдах ажээ. Маргааш өглөө нь Авраам Даяан унтаад сэрэхдээ төрөл арилжсан байв.

Тэр энэ мөчөөс эхлэн Ертөнцийн эзний элч Чингис хааны гэгээн үйлсэд мөнхөд зүтгэхээр шийдэв. Чингис хааны цэргийг Римд очиход найр тавин хэрмийн хаалгаа дэлгэн угтана гэж амлаад морджээ. Аврагч Исусын элч Боорчи түүнийг танисангүйд, бас үдэж өгсөнгүйд Даяан огтхон ч гомдсонгүйгээр барахгүй ингэх нь зүй ёсны хэрэг гэж боджээ.

Энэ мөчид Ертөнцийн эзний элчтэй пахин учраад буцаж яваа Авраам Даяан шиг аз жаргалтай, зорилго итгэл төгс хүн газар дээр байхгүй байсан бизээ. Рим хүртэл нойр хоолгүй довтолгосон нь их ламтандаа Ертөнцийн эзний элчийн зарлигийг даруй хүргэхийн тулд юм. Ертөнцийн эзний элчтэй уулзаж Чингис хааны үнэн зорилгыг ухаарсан нь түүнийг дахин алдаршихын эхлэл болно гэж бодохоос даанч бахархалтай сайхан байжээ.

Тэр одоо зуу биш, бүр хоёр зуу наслахыг хүсч байв.

Авраам Даяан хэмээх жүүд гаралтай, загалмайн шашны тэрхүү номлогчийг явсны маргааш шөнө лалын шашин, Аллах тэнгэрийг шүтэгч түрэг иран гаралтай уран дархан ИшХимам Боорчийн хамт Тэнгэр уулын зүг явж байлаа.

Иш-Химамын сэтгэлд гүн өөрчлөлт гарсныг хэрэв өдөр байсан бол Боорчи анзаарч харах байлаа.

Гэвч түнэр харанхуй шөнө бүх үнэн зүйлсийг халхлан нууж байжээ. Харин Боорчи маргааш нь Сүбээдэйн зүг морин цагт хөдлөхөөр бэлэн болжээ. Иш-Химамын бүтээсэн шатыг шатаамагц Боорчи Чингис хаанд бараалхан түүний сүүлчийн зарлиг захиасыг сонсох ажээ

Боорчийн сэтгэл тэнүүн өөдрөг байв. Түүнд гуних гутрах үндэс өчүүхэн ч байсангүй. Тэр маргааш шинэ газар орныг туулан явах гэж байхад баясан бахдахаас өөр яах билээ. Гэрэг хөвүүн нь гол цэргээ ачаа хөсгөө удирдан өглөө эрт замд гарсан байлаа. Гэрэг хөвүүнийхээ баяртай царайг хараад Боорчи амьдралдаа анх удаа эцэг хүний ёсоор жаргалтай болсон билээ. Энэ бол түүний хувьд урд өмнө эдлэж үзээгүй жаргал байлаа.

Шатыг шатаахад бэлтгэх зарлиг хүлээсэн Үүлэн черби аль эрт шатыг газрын тосоор нэвчүүлж бэлджээ. Одоо ганцхан гал хүргэх л үлдээд, Боорчи сайдыг хүлээж байв. Энэ өчүүхэн хэргийг заавал Боорчи өөрийн биеэр хүрэлцэн ирж харахын учрыг Үүлэн черби ойлгосонгүй билээ. Зам зуур Иш-Химам юу ч дуугарсангүйд Боорчи түүний сэтгэлийг ойлгох тул түүнийг зовоож дуугарсангүй явсаар шатны дэргэд иржээ.

Үүлэн черби тэднийг угтан авахад яг шөнө дунд болж нүдгүй хар шөнө нөмөрчээ. ”Энэ шатны дэргэд ирэхэд заавал саргүй шөнө таарах юм даа” гэж Боорчи боджээ. Шатны сүйхэнд суухын өмнө Иш-Химам нэг зүйл хэлэх гээд байгааг мэдсэн Боорчи баахан гайхаж Үүлэн чербиг холдохыг тушаав.

-Иш-Химам чи бүү ай. Би чамайг ер шатаачихгүй. Чи харин даруй эргэж ир. Чамайг бууж ирмэгц шатаамц гэж Боорчи түүнийг тайвшруулав. Яагаад ч юм бэ Боорчи өөрийгөө ИшХимамын өмнө буруутай мэт санах болсон тул ингэж зөөлөн дуугарчээ. Бамбарын гэрэлд Иш-Химамын нүд гялалзаж амьсгаа нь давхацсан мэт ам нь ангалзаж байх нь үзэгджээ. Төлөв даруу энэ уран дарханыг ингэж үхэл үзсэн мэт догдлон чичирч байхыг Боорчи өмнө нь үзсэнгүй болохоор ихэд гайхжээ.

-Боорчи сайдаа. Би танд гомдох санах зүйлгүй. Гэвч би дахин эргэж ирэхгүй.Би өөрийн бүтээсэн энэ шаттай хамт үүрд шатахыг хүснэ. Өөрийн бүтээсэн энэ шатыг үнс болон шатахыг би яавч өөрийн нүдээр харж чадахгүй. Үүний оронд үхсэн минь дээр юм. Үүний төлөө Аллах тэнгэр танай Чингис хааныг өршөөхгүй. Чингис хаан үйлдсэн нүглийнхээ хорыг өөрөө амсах болно. Би түүнийг Аллах тэнгэрт айлтгаж гэсгээн цээрлүүлэхийг хүсэхээр явлаа. Аллах тэнгэрээс илүү хүчтэн энэ газарт байхгүй гэдгийг би Чингис хаанд үзүүлнэ. Та миний энэ үгийг Чингис хаандаа айлтгахтун. Миний хэлэх үг дууслаа гээд Иш-химам толгой дээрээ хувинтай тос асгаад шатанд суужээ.

-Боорчи сайдаа. Хүрдийг эргүүл гэж цэргүүддээ тушаагтун гэж Иш-Химам хашгирчээ. Цэргүүд бэлэн байлаа. Боорчи энэ гэнэн тэнэг дарханы хөөрүү үгийг огт тоосонгүй хойш ухарч цэргүүдэд дохио өгөв. Хүрд чахран эргэж Иш-Химам харагдахгүй болов. Гэнэт Боорчийн эгдүү хөдөлж Үүлэн чербийн барьж байсан бамбарыг аваад шатанд хүргэв. Тосонд нэвчсэн шат дүрэлзэн асч гал дээш өгсөн төдөлгүй галд автсан Иш-Химам аймшигтайгаар хашгирах сонсогджээ. Гэвч Иш-Химам унаж ирсэнгүй.

-Иш-Химам. Чи эндүүрч. Чи тэр Аллах тэнгэртэйгээ хэзээ ч уулзаж чадахгүй гэж Боорчи хорсон шивнэжээ.

Шат дөлөнд автан яг галт могой шиг үзэгдэнэ. Шат шөнөжингөө шатаж харин өглөө гэхэд уулын бэлд овоолсон үнс болон хоцорчээ. Харин уулын орой хүртэл элгэн хадан дээр шатсан ормоор хар мөр үлдсэнийг хэзээ хойно болтол нутгийн иргэд Химамын зам гэж нэрлэсээр байхыг хэн ч таасангүй.

Ингэж Иш-Химам гэгч уран дархан Аллах тэнгэртэй уулзаж Чингис хаантай заргалдсан эсэхийг хэн ч мэдэхгүй хоцорчээ.

Тэр шөнө Чингис хаан ордноосоо холдон явж шат хэрхэн шатахыг ойроос харсаар нойргүй хоножээ.

Одоо бүх зүйл түүний хүссэнээр болж Тэнгэр уулын оройд хүний хөл нэгэнт хүрэхгүй болжээ. Өүлэн эх нь дэргэд байсан бол түүний хийснийг хараад лавтай сайшаан магтах байсан даа гэж яагаад ч юм бэ бодож байв. Учир нь Өүлэн эх нь түүнийг Тэнгэрээс харж байсан билээ. Харин Боорчи үүр цайсан хойно иржээ.

-Хаантан.Би морин цагт мордоно гэхээс өөр үг хэлсэнгүй. Боорчийн сэтгэл тавгүй болжээ. Гэмгүй дарханыг дэмий шатааж алсандаа тэр харамсаж байлаа. Гэвч үүнийгээ Чингис хаанд цухуйлгасангүй. Бас Иш-Химамын хэлсэн үгийг ч тас нуун өнгөрөөхөөр шийджээ. Элдэв тэнэг амьтдын үгийг сонсгож Чингис хааныг чилээхийг хүссэнгүй. Бас тэр Аллах тэнгэрээс ч

айсангүй.

-Сүбээдэй чамайг ирнэ гээд нүдээ хөхөртөл харуулдан суугаа биз. Боорчи чи замдаа бүү саат. Би чамайг мордмогц их цэргээ хөдөлгөн нутгийн зүг явна. Та нар Эрчис мөрний хөндийд биднийг гүйцэж очигтүн. Бид тэнд хүрээд та нарыг хүлээн өвөлжинө. Тэгээд хойтон зун гэхэд Монгол нутагтаа хүрнэ гэж Чингис хаан газрын зураг харж суугаад хэлжээ.

Тэр үед Чингис хаан Боорчи хоёр задгай алтан асрын дор цайлж суужээ.

-За би хаан таны хэлснээр явъя. Сүбээдэй, Зэв нар ч ингэнэ биз

-Би чамайг өөрийн биеэр үдэж өгнө. Хоюул өртөө гөзар хамт явъя. Чи түүнээс цааш шувуу мэт нисэгтүн.

-Хаантан та ингэж биеэ чилээх хэрэг юу байх билээ.Би..

-Боорчи чи хүлээ. Би морин дээр гарч хийморио сэргээх нь муу явдал биш шүү. Би морь унасангүй бараг сар боллоо гэхэд Боорчи дахин эсэргүүцсэнгүй. Чингис хаан зөвхөн морь унахын тулд түүнийг ингэж үдэж өгөх гээгүйг гадарласан ч Тэмүжинээр үдүүлэх нь туйлын бахархалтай хэрэг тул дуртай байжээ. Өртөө газар тааваар явахдаа Чингис хаан Боорчи хоёр чухам юу ярилцсаныг хээрийн салхинаас өөр хэн ч сонссонгүй. Чингис хааны хүсэл энэ байсан билээ. Түүний хэлснийг ганц Боорчи л мэдэх ёстой гэж тэр олон хоногийн өмнө шийдсэн тул ингэж хэрэг болгон Боорчийг үджээ.

Боорчийн цэрэг тоос манаруулан далд ортол Чингис хаан мориноос буулгүй харж зогсов.

Одоо түүний сэтгэл тайвшран амрав. Дээд Тэнгэрээс түүнд хуваагдаж ирсэн ганц нөхөр Боорчи нь түүний хамгийн хэцүү зарлигийг биелүүлэхээр давхин одохыг тэр харж байлаа. Тэдний дээр Хорезмын халуун тэнгэр манарч монгол морьдын хөлөөр боссон тоос шавар хотын дээгүүр суунаглана. Боорчийн баг цэрэг морины амыг сул тавин давхиж явлаа. Дөчин хэдэн жилийн өмнө Боорчи, бие тулгар Бөртийг дагуулаад яг ингэж эргэж харалгүй давхиж явсан билээ.

Яг тэр үеийнхтэй адил одоо түүнд Чингис хааны хэцүү зарлигийг биелүүлэх л үлджээ.

Чингис хааны одоогийн зарлиг яг тэр эрт цагийнхтай адил Зүчийн тухай байлаа. Чингис хаан Боорчийг өөрийн биеэр үдэж өгсний нууц энэ билээ. Боорчид одоо ухрах буцах зам үлдсэнгүй. Тийм боломжийг Чингис хаан түүнд үлдээсэнгүй.

”Есүхэйн Тэмүжин чи айхтар чоно юмдаа” гэж Боорчи морины давхил дунд инээмсэглэн бодож явжээ.

Энэ бол тэдний чин сэтгэлийн яриа байсан тул үг бүр нь Чингис хаанд эм мэт шингэж тэр үзтэл сэргэн омогшжээ.

Хорезмоос ирж Тангудад мордох хүртлээ Боорчитой ингэж дотносон ярилгүй удсандаа Чингис хаан гайхсаар байжээ.

Зүчийн үхлээс хойш тэдний хооронд үл үзэгдэх хөшиг татсан мэт болоод Боорчитой хоёул үлдэнэ гэхээс тэр ихэд халгах болжээ.

Энэ нь Зүчийн тухай түүний бодлыг Боорчи одоо ч шүүмжлэн хэлнэ гэж айсаар байсных билээ. Энэ явдлаас хойш Чингис хаан өөрийгөө Боорчийн өмнө буруутай гэж бодох нь улам гүнзгийрчээ. Урьд Гүмүдад учирсан явдалд өөрийгөө буруутгах нь их байсан билээ. Энэ сэтгэл Боорчи өөрийн өргөмөл хөвүүнтэй болсноор нэлээд илааршиж байсан ч Зүчи өвчнөөр үхсэн нь сэтгэлийн хуучин шархыг дахин сэдрээжээ.

Ер нь Боорчийг Зүчийн тийш илгээсэн нь буруугаар зогсохгүй Боорчийн сэтгэлд ямар гүнзгий цохилт болсныг таамаглах бүрдээ Чингис хаан Боорчийг өрөвдөн өөрийгөө буруутгадаг байжээ. Зүчид Боорчи өөрийн хөвүүн шиг ханддагыг мэдэх мөртлөө түүнийг ийм бэрх хэрэгт зарсанд нь Боорчи түүнийг үзэн ядах ч энүүхэнд билээ. Зүчийг өвчнөөр үхнэ чинээ хэн санах билээ. Гэтэл Боорчи өнгөрсөн хоёр жил хар цагаан, сайн муу үг ер унагасангүй. Бас Зүчийн яаж үхсэнийг бас Зүчитэй юу ярьснаа ч нарийн тодорхой хэлэлгүй дөлсөөр иржээ.Чингис хаан энэ тухай зүрхлэн асууж чадахгүй байжээ.

Харин өнөөдөр нэгэнт нүүр хагарч бага залуу насны явдлаа дурссан сэтгэлээ уудлан үнэн үгээ хэлэх зоригтой болгожээ.

-Боорчи. Чи намайг харааж зүхсэн ч би үл гомдоно. Би чамаар хүчрийг хийлгэж, хүндийг үүрүүлжээ. Би чиний хамаг амьдрал, аз жаргалыг булаан авч, нүүрээ тахлуулж нүглээ хаалгаж ирлээ. Би одоо чиний төлөө юу хийвэл зохино. Чи хэлээч. Чи хүснэ вэ гэж Чингис хаан босож зогсоод хэлэв. Боорчи дуугарсангүй.

-Боорчи. Би чамайг аз жаргалгүй амьдарч тэгээд бас намайг харааж зүхэж үхээсэй гэж үл хүснэ. Чиний өтөлж өвгөрөхийг харах бүр өвчин шархандаа шаналсан царайг чинь харах бүр би чамайг ийм болгож орхисондоо гэж бодохоор яс минь янгинах шиг болдог болжээ. Би чамайг үхвэл яана гэж өглөө сэрэх бүрдээ бодох боллоо. Бас чамайг харах бүрдээ би яах гэж энэ их улсыг байгууллаа гэж харамсах боллоо. Би ганц чиний биш хичнээн олон сайн нөхрийнхөө амийг золиослов гэж санах бүр чамайг аз жаргалгүй үхэх вий гэж зовох боллоо.

Чингис хаан энэ үгийг харуусал гэмшил дүүрэн хэлэв.

-Тэмүжин. Чи элдвийг бодож биеэ бүү зовоо. Чи биднийг үхэл тийм ч амар дийлэхгүй. Санаа бүү зов. Үхэх гэдэг санааных гэж Тэв Тэнгэрийн хэлснийг санана уу. Миний төлөө бүү сэтгэлээ шаналга. Би аз жаргалтай байна. Миний энэ амьдрал Тэнгэрийн зарлиг учир надад харамсах зүйл нэгээхэн ч үгүй юм. Харин ч ийм хувь заяа хайрласан Тэнгэрт баярлах ёстой юм. Би одоо Тэнгэрээс заяасан хөвүүнтэй болов. Үүнээс илүү аз жаргал надад хэрэггүй. Одоо Чингис хааны зарлигийг биелүүлэхээс өөр аз жаргал надад үлдсэнгүй. Идэр омголон явахыг чинь үзэв. Эзэнт улсаа байгуулж их хаан суухыг үзэв. Энэ болтол зүтгэв. Би өөрөөр яаж амьдарна.

Боорчийн энэ үгэнд Чингис хаан сэтгэл ханаад баяртай инээмсэглэж:

-Боорчи. Чи бидэнд ингэж суух хоног цөөхөн үлджээ. Чиний өвчин шаналалаа нуух гэж шүд

зууж яааг надаас өөр хэн ч үл мэднэ. Миний өвчин шаналлыг чамаас өөр хүн мэдээсэй гэж би үл хүснэ. Хулангийн авын үед мориноос унаснаас болж цээжээр хатгах нь дуу алдмаар, ухаан балартмаар хүчтэй болсоор байна. Би чам шиг тэвчээртэй байж үл чадах тул энэнээс хойш яах билээ гэж санаа зовох боллоо. Чи намайг яах гэж энд гарцаар өдөржин суугаа гэж санана вэ. Энд ганцаар суухад миний ёолохыг салхинаас өөр хэн ч сонсохгүй юм. Би миний ёолохыг монгол нутгийн минь салхи, Тэнгэр бүү сонсог гэсэндээ энэ Тангудад суусаар байна. Хөвүүд, нөхөд минь миний ёолж арчаагаа алдан доройтохыг бүү үзэг гэсэндээ энд ганцаар хүн чулуу мэт суух боллоо. Миний өвчин илааршин наашлах янзгүй ажээ. Харин ч би эрт үхэх байжээ. Гэтэл Хулан хатан ирж надад бага боловч амьдрал өгөв. Амьдрал, цаг хугацаа гэдэг ямар үнэтэй байдгийг би одоо л ойлгож байна. Би хичнээн их цагийг дэмий сул өнгөрөөгөө вэ. Би өвчнийхөө тухай ганцхан чамд л хэлэв. Чамд хэлсэнд өвчин минь намдах шиг боллоо. Миний өвчинг ганцхан чи л мэдэх болллоо. Миний өвчин чамтай хамт үхэх биз гэжээ.

-Тэмүжин. Би чамд нэг зүйл хэлье

Бие чилээрхэж байхад олон долоон юм бүү бод. Тэр тусмаа өнгөрсөн баларсан түүхийг бүр бүү бод. Сэтгэлээ зугаацуул.

Өвчнөө март. Наадам цэнгэл зохио. Цэргүүдийнхээ хийморийг сэргээж Тангудын Буур хааныг цочтол наадам хийе. Уйтгарлан суухаа боль. Урьдын Тэмүжинг мартаж угийн Чингис хаан мэт байгтун.

-Боорчи чиний хэлснээр хийе. Чи сая хэлснээ үйлдэгтүн. Харин наадам цэнгэлээ Бат хөвүүнийг ирэхээр болъё.

Харин түүний өмнө Яргай балгасыг эзлэн авч Буур хааныг явах газаргүй болгогтун. Буур хааныг бүү үхүүл. Түүнийг миний өмнө өөрөө мөлхөж иртэл нь сахиж суугтун гэж Чингис хаан зарлиг болгов.

Түүний Тангуд улсад өөрийн биеэр хэрэг болгон морилон ирсний учрыг Боорчи сая л тод ойлгов. Буур хаанаас өшөөгөө авч бах таваа хангах гэж Чингис хаан энд иржээ. Түүнээс биш Тангудыг мөхөөхөд Буур хааны хотыг л эзлэн авбал болох боловч Чингис хаан ганцхан Буур хааны суугаа хотыг тойрон бусад зах хязгаар хот балгасыг эзлэн цаг алдсаар байгаагийн учир энэ ажээ.

Буур хааныг өөрөө ирж амь гуйхыг хүлээж байгаа нь тодорхой болов.

Тангудыг мөхөөх дайныг Чингис хаан өөрийн хүслээр сунжруулж байв. Ингэх нь Монголын цэрэгт хохиролтойг Чингис хаан тоосонгүй. Бас Тангуд улсыг эзлэн авч сүрээ үзүүлэх нь дараа Алтан болоод Сүн улстай дайтахад чухал байв.

Тангуд бол Хорезмыг дорно зүгийн улсуудтай холбож байдаг худалдааны гол зам газар билээ. Тангуд улсыг эзлэн авахад Алтан болоод Сүн улсууд баруун зүгтэй холбоо тасрах болно. Бас Тангуд улсыг эзэлснээр одоохондоо найрамдалтай байгаа Сүн улстай эвсэн тэдний нутгаар дамжин Алтан улсын баруун өмнө талаас довтлох боломж нээгдэнэ гэж Чингис хаан бодсон байв. Тийм учраас Сүн улсын хаанд Тангудаас олзолсон их бэлэг илгээж хуучин

найрамдалтай байснаа батлан захидал хүргүүлсний хариуг хүлээж байв. Одоо Чингис хааны ухаанд Хималайн их уулсын өмнө хойд талын газар орныг өөрийн улстай нэгтгэх их төлөвлөгөө нэгэнт бэлэн болжээ. Энэ бол Буддаг шүтэгч улс орнууд байв.

Тангуд улс бол энэ их дайны үед их цэргийг хүнс хоолоор хангах газар, бэлтгэлээ базаах нутаг болох юм. Тийм учраас Тангудыг дахин сэхэхгүйгээр дарж эзлэн авах нь чухал байв. Тангуд улс дарагдвал баруун зүгээс дайчилсан цэргийн ирэх зам дөт шулуун болох билээ. Ирээдүйн их дайны давшилтын төлөвлөгөөг зохиож элдвийг нягтлан суух нь Чингис хааны өвчнөө мартах ганц арга болжээ. Түүний тушааснаар Алтан,Сүн улсад илгээсэн тагнуулууд эргэн ирээд эдгээр улсын нутаг орны байдал, гол мөрөн, уул даваа зам, харгуйн зураг үйлдэж эхэлжээ.

Анх Хорезмыг довтлохдоо бүрэн хэрэглэсэн энэ арга туйлын ашигтай зүйл болох нь нэгэнт батлагдсан юм. Хорезмд довтлохын өмнөх гурван жилд баруун зүгт худалдаачны дүрээр аялсан Чингис хааны тагнуулуудын цуглуулсан мэдээ их довтолгооныг бэлтгэх гол чиглэл баримжаа болсон ажээ. Тагнуулын албыг өргөжүүлж түүнд өргөн эрх мэдэл олгоод олон хэлийн зүг зүгийн улс хотуудаас үнэнч албатуудыг шилэн авч хэрэгтэй нутаг оронд илгээдэг болов. Энэ нууц албыг одоо Зэлмийн хөвүүн Есөнтэй толгойлох болжээ. Есөнтэй бол итгэлтэй үнэнч бас ухаантай хүн гэдгээ нэгэнт Чингис хааны өмнө баталсан билээ. Ингэж Тангудад Монголын их цэрэг дорно зүгт хийх их аян дайндаа алгуур тайван дайтаж, байгаа нэрийн дор нууцаар бэлтгэж байлаа. Гэвч дорно зүгт Алтан улсад довтлох энэ нууцыг одоохондоо ганцхан Чингис хаан л мэдэж байв. Ихэнх цэргүүд, жанжид Тангудыг эзлэн авч талж дээрэмдээд нутаг буцна гэж бодож байлаа. Ерөөс нүүдэлчний дайн ийм байдаг билээ. Гэтэл цаг өөр болж нэг удаа булаан дээрэмдэх биш байнга өөртөө зүтгүүлэх, татвар авах хэмжээг тогтоон нэгдсэн улсын журамд оруулахын тулд дайн хийх хэрэгтэй болсон нь нэгэнт тодорхой байв. Үүний тулд хүчирхэг цэрэгтэй байх ёстой. Их цэрэг дайтаж байлдаж байвал хүчирхэг болно гэж Чингис хаан бодох учир их цэргийг амарч, морио таргалуулахаас бусад цагт аялан дайтаж байх ёстой гэж үзнэ.

Бас их цэргийг нэгтгэн өөрийн дор захирч дайн тулаанд байлгах нь шадар, сайдууд өөр хэнд ч гэсэн тусгаар явж бие даах хүсэл зориг төрөх явдлыг хязгаарлах хамгийн сайн арга гэж итгэнэ. Энэ бол арван таван наснаас хийсэн их бага олон дайн тулаанаас олсон ухаан байв. Анх арван таван настайдаа Тэмүжин, Тоорил хааны хүрээнд жил хагас суусан билээ. Энэ хугацаанд Тэмүжин өмнө нь сураагүй, үзээгүй олон зүйлийг үзэж сурчээ. Тоорил хан ухаантай сүрхий хүн байсан тул Есүхэйн хөвүүнийг ирэхэд нь шинжээд ихэд тоож "Энэ Тэмүжин юм дуулгах хүн болно" гэж олны дэргэд ил тод шууд үнэлсэн нь түүнд өөртөө итгэх их сэтгэлийг төрүүлсэн билээ. Тэгэхэд Тэмүжин Тоорилын хөвүүн Сэнгүмийн хамт Түбэгэн аймгийн цөөн бүл иргэдийг дайран дээрэмдсэн нь түүний амьдралдаа үзсэн хамгийн анхны тулаан байсан юм. Тэд олон адуу, үхэр олзлон авч Тоорил хан тулааны олзыг хуваахдаа нэгэн сайхан саарал морь Тэмүжинд өгсөн нь түүний анхны олз байв. Бүх төрсөн ах дүү нараа ад үзэн заримыг нь алж, заримыг нь хөөж явуулсан Тоорил ханы эл үйлдлийг Тэмүжин тэр үедээ ер зөвтгөн бодоогүйгээр барахгүй дотроо үргэлж шүүмжилдэг байв.

Өөр зуурдаа, халуун ам бүлдээ эвтэй байх нь хүчирхэг байхын гол үндэс гэж Тэмүжин хар багаасаа үзэж, өсөж хүмүүжсэн нь Өүлэн эхийн нөлөө байсан ч бас ах дүү гэдэг хамгийн

аюултай өширхөг дайсан болдгийн учрыг сайтар ойлгож авсан билээ. Тэгээд Тоорил ханы ах дүү нараа хядсаны учрыг сүүлд ойлгож мэджээ. Харин харь омгийн юм уу өөрийн омгийн жирийн ардын хөвүүдээс аль шударга зоригтойг нь сонгон дэвшүүлж ашиглах замыг сонгосон нь түүний ухааных байв. Нөхөд гэдэг нь эрх мэдэл ил шууд булаалдах нь ховор, бас тэдэнд ингэх өрсөлдөх үндэс шалтгаан багатай хэрэг байв. Нөхдийнхөө гавьяа чадлыг ил тод, шударгаар үнэлэх нь л гол байдаг билээ. Яг ийм нөхдийг Тэмүжин сонгон олж чадсандаа бахдан баясаад ханадаггүй бөгөөд тэр өөрийгөө хүн шинжиж танихдаа гаргууд гэж үнэнээсээ итгэдэг байв.

Тэмүжиний хар багын энэ чанар их хаан суухад нь хамгаас ихээр хэрэг тус болжээ. Гэтэл одоо элсүүлж хүмүүжүүлж авсан, ихийг бүтээлцсэн тэр нөхдийн ихэнх дайнд үхэж үрэгдээд эсвэл хөгширч өвгөрсөөр дуусчээ. Дэргэд нь ганц Боорчи л үлдэв. Тийм ч учраас амьд үлдсэн Сүбээдэй, Мухулай нарыг дуудуулжээ. Магадгүй сүүлчийн удаа уулзацгаах биз гэдгээ ч мэдэж байв.

Бие нь муудаж, өвдсөнөөс хойш Чингис хаан ууртай уцаартай болсон ч бас их уяруу зөөлөн болжээ. Тэр сав л гэвэл өнгөрсөн амьдрал, үнэнч нөхдөө дурсан санах болов. Бас хэн нэгнийг дэмий үхүүлж үр удмыг нь тасалсан байх бий гэж элдвийг хөөн шүүн бодож суух болжээ. Энэ бол үхлээ мэдэрсэн хүний зан юм.

Хулангийн авын үеэр түүн рүү дайрсан тэр хар азарга бол үхэл байв. Харин азаар мориноос унаж бас Хулан хатны сүнс тэр азаргыг алснаар Чингис хаан аврагджээ. Гэнэт ирэх үхлийн учир шалтгааныг мэдээд Хулан хатны сүнс салахгүй дагаж явсныг Чингис хаан огт мэдээгүй билээ. Хар азарганы омруунд зоолттой байсан тэр хутга Хулан хатных байсныг Чингис хаан сайн таньсан билээ. Мориноос унасан түүнийг Хулан хатны нь сүнс хамгаалан авч, олон зэрлэг адгуусны хөлд гишгэгдэн үхэхээс аварч бас хар азаргыг хутгалан алжээ. Энэ бол гарцаагүй болсон хэрэг учраас өөрийн бэртсэнд тэрээр хэнийг ч буруутгах ёсгүй гэж шийдсэн билээ. Бүх зүйл Хулан хатны сүнсний ачаар сайнаар төгссөн ч үхэл өөрт нь их ойрхон ирснийг Чингис хаан мэдэрч байлаа. Тийм учраас үхэл авч явахаас өмнө санасан бүгдээ амжуулах гэж яарч байв

Гэтэл амьдрал түүний санаснаар хурдан түргэн хөдөлж урагшилж өгөхгүй ажээ. Харин Хулан хатныхаа сүнсийг дахин хүрээд ирээсэй, үзэгдээсэй гэж хичнээн хүлээсэн ч ирсэнгүй өвөл өнгөрч хавар болжээ. Үхэл гарцаагүй ирэхийг мэдүүлсэн нэгэн учралыг Чингис хаан өөрөөсөө ч нууж байсан билээ. Есүй хатан нь шаардсанаар Чингис хааны сүнсийг дуудуулсанд бие нь илааршиж өвчин намдсан нь түүний сэтгэлээс үхлийн тухай бодлыг түр боловч холдуулж мартуулжээ.

Чингис хаан дахиад л мориндоо мордож урьдын адил итгэл зориг төгс дүрдээ орлоо.

Энэ бол Батад хэл хүргээд Гэрэгийн буцаж ирсний дараа болжээ.

Бүх юм Чингис хааны бодсоноор болж сарын дараа Тангудын их уст Хөх нуурын эрэг дээр байрлаж асан хээрийн хүрээнд Алтан улсаас Мухулай түүний дараа Каспийн тэнгисийн дэргэдээс Бат, Сүбээдэй хоёр иржээ.

Үүний өмнө Тангудын баруун болоод баруун өмнө зүгийн хот балгасыг буулган авсан Цагадай, Өгөдэй хоёр ирээд байжээ. Өргөн дэнжид задгай алтан асрын дор идээ будаа засаад тэдний ирснийг тэмдэглэн их найр хийжээ. Чингис хааны зүүн талд Цагадай, Өгөдэй, Толуй хөвүүд, Есөнмөнх, Гүюг, Мөнх, Бат, Бүри, Годан, Хубилай зэрэг ач хөвүүд, баруун талд Боорчи, Мухулай, Сүбээдэй дараалан бусад шадар жанжид суужээ. Харин Есүй хатан түүнтэй зэрэгцэн сууж байв. Ингэж нэг бүгдээр цуглан энгүүн сайхан хөөрөлдөн сууя гэсэн нь Чингис хааны их хүсэл байжээ. Тэр хүслээ биелүүлсэндээ сэтгэл ханажээ. Ач нар нь нас бие гүйцэж ахмад нь нэгэнт хорин хоёр гурав хүрснийг үзээд тэр өөрийгөө хичнээн удаан амьдарсныг ойлгов.

Чингис хааны зүүн талд түүний их үйлсийг залгамжлагч хөвүүд ач нар нь суухыг харахад тэднээс их гэрэл цацарч байх шиг санагдана. Ач нар нь нүдээ гялалзуулж сэтгэл нь хөдөлсөн янзтай ч ихэд хичээн төлөв дуугүй сууцгаана.

Харин түүний баруун талд түүнтэй хамт өсөж тэмцэж ихийг бүтээсэн хөгшид өвгөчүүл суусан нь Чингис хааны өнгөрсөн бөгөөд одоо цаг нь байв. Боорчийн бодол болсон эгэл дүр, Мухулайн ухаалаг нүд, дулаан царай, Сүбээдэйн цочиж сүрдмээр догшин төрх, Шихихутагийн болгоомжтой, зальжин харц гээд аль хүүхэд цагийнх нь шинж ер өөрчлөгдөөгүй мэт үзэгдэнэ.

Ийм нөхөдтэй байхад ертөнцийн талыг хураан авахад юухан байх вэ гэж омогшин бодмоор санагдах ажээ.

Одоо Боорчи, Мухулай, Сүбээдэй нарын цаг хүссэн хүсээгүй өнгөрч байгааг мэдэрч суухад аймшигт гуниг төрөх ажээ.

Харин идэр хойч үе, ач хөвүүдээ харахад энэ гуниг харамсал эрхгүй мартагдана. Чингис хаан энэ найрын үед олон үг ярьсангүй, иймэрхүү санаа бодолд эзлэгдэн нэг инээж нэг гуниглан суужээ. Нөхөд нь тус тусын явдал түүхээ хөгжилтэй чөлөөтөй сайхан хөөрөлдөж, бага идэр насаа дурсан суухыг сонсоогүй ихэд уджээ. Нөхөд нь цугласан нь Чингис хааныг Тэмүжин болгон буцаан хувиргаж сэтгэл санаа нь өөрчлөгдөхийг тэр мэдэрч байв. Тэр одоо багын үнэнч нөхдөө Тэмүжиний нүд сэтгэлээр харж суув.

Алтан улсад самуун гарч түүнийг дарах гэж хуруугаа мулталж, хумсаа эмтэлж байснаа Мухулай ярих ажээ.

Жалайрын Цагаангуа гэгч өөрийн хөвүүн Мухулайг дагуулан ирж Тэмүжинд бэлэглэсэн нь Мухулайн амьдралын эргэлтийн үе болжээ. Мухулай бол далдын юмыг тааж мэддэг зөн совинтой цөөхөн хүний нэг байлаа. Тэмүжинг хамгийн хаан болохыг урьдчилан хэлсэн гурван хүний нэг нь Мухулай юм. Тайчу,Сачабэх хоёроор толгойлуулсан Жүрхэн аймаг Тэмүжинг эсэргүүцэн эв эвдрэн тэмцээд дарагдахад Мухулай, эцгээ даган иржээ. Жалайр овгийн Цагаангуа уг нь Боржигон аймгийн боол байсан боловч сүүлд нь Жүрхэнд худалдагдаж сул иргэн болсон байжээ. Жүрхэний дагаж ирсэн иргэдээс залуу эрсийг дайчлан түмэн цэрэг болгоход хэнээр толгойлуулах тухай асуудал Тэмүжиний өмнө тулгарчээ. Уг нь Жүрхэн овгийнхныг Хасарт өгье гэж Тэмүжин дотроо шийдэж байжээ. Учир нь Жүрхэн овгийнхон угийн хэрүүлч заргач, омогтой зоримог эрс олонтой тул тэднийг өөртөө ойр

байлгах нь хожим осол аюул ихтэй гэж болгоомжлоход хүргэжээ. Бас ингэхийг Тэв Тэнгэр бөө зөвлөсөн байв. Толгойлогчид нь алагдаж омог нь дарагдсан жүрхэнийхнийг Хасарт өгөх нь гарцаагүй зөв зам байсан бөгөөд хэрүүл тэмцэл болбол Хасарт л төвөг чирэгдэл учрах болохоос Тэмүжинд хор хөнөөл ирэхгүй бүлгээ. Ингэж бодсон учраас Тэв Тэнгэрийн үгийг дагажээ.

Харин Цагаангуа Зэвгээ, Мухулай хоёр хөвүүнээ дагуулж ирэхэд арван долоон настай Мухулай Тэмүжинд ихэд таалагдаж удтал бодсоны эцэст урьдын шийдвэрээс ухрахад хүрчээ. Мухулай гэгч тэр хөвүүн тун онцгой содон цаанаа нэг хүн татах увидастай мэт санагдаад болсонгүй. Бат чийрэг биетэй ч, ухаан заль нуугдсан тод хурц харцтай нүд нь тэгэж онцгой санагдсаныг хожим тэр ойлгосон билээ. Тэр шөнө Цагаангуагийн хөвүүн Мухулайн дүр төрх зүүдэнд нь солонго мэт үзэгдсэн нь Тэмүжиний сэтгэлийг эргэлзээг арилгаж маргааш нь түүнийг эцгийн нь хамт өргөөндөө дуудуулан ирүүлэв. Шөнө зүүдэнд үзэгдсэн солонго бол Мухулайг Тэмүжинд илгээсэн Тэнгэрийн дохио байжээ.

Омог зориг ихт Жүрхэн овгийн түмэн цэргийг дөнгөж арван долоон настай Мухулайд захируулахаар өгсөн нь бүгдийн нүдийг бүлтийлгэсэн хачирхалтай шийдвэр байв. Тэр дундаа Тэмүжинд сайн дураар дагаж ирсэн жүрхэний баатар эрс, ноёд ихсийн дургүйцэл эсэргүүцэлтэй тулгарсан билээ. Гэвч Тэмүжинг шүүх, эсэргүүцэх зоригтон ялагдсан жүрхнийхний дотроос гарсангүй. Учир нь тэдний сүр сүлд, сүнс хийморь нь болсон баатар Бүрибөхийг Тэмүжин заль зохион Бэлгүтэйтэй барилдуулж нурууг нь хугалан үхүүлсэн учир Жүрхэн овгийнхны омог зориг, эсэргүүцэх сэтгэл нь нэгэнт дарагдаад байжээ.

Эхлээд Бүрибөхийг үхүүлэхийг Тэв Тэнгэр нэгэнт Тэмүжинд хэлжээ. Ингэж нэгэнт сүлд хийморь нь дарагдсан тул Жүрхэн овог аюулгүй болжээ. Арван долоон настай, боолын хөвүүн Мухулайд итгэхгүй хүн олон байсан ч түүний нууц далд чадлыг Тэмүжин урьдаар тааж мэдсэн нь одоо нэгэнт тодорхой болжээ.

Мухулай Жүрхэн овгийн цэргийг итгэлтэйгээр засаад зогссонгүй удалгүй Тэмүжиний гарамгай жанжнуудын нэг болов.

Түүний байгуулсан гавьяаг дурдаж баршгүй гэж одоо Тэмүжин нөхдөө хараад бодож суув. Анх Далан нөмрөгт татаарын цэрэгтэй байлдахад чухам Мухулай дэргэд нь байгаагүй бол Тэмүжин гарцаагүй үхэх байв. Морио шархдуулж татаарын цэрэгт бүслэгдээд юу юугүй цавчуулан үхдэгийн даваан дээр гэнэт тэнгэр дуугарах шиг нижэгнэсэн нь Мухулай хашгиран дайрч ирсэн хэрэг байв. Мухулай татаарын цэргийг хага зүсэн өвс шиг ханаруулан цавчиж зам гаргаад Тэмүжиний дэргэд ирж мориндоо сундлаад мөн л тэр янзаар дайран гарч аварчээ. Тэгэхэд Мухулай өөрийн харцаар хүн үхүүлж чаддагийг Тэмүжин анх үзэж мэлрэн гайхсан билээ. Ийм чадалтай ид шидтэй хүн байна гэдэгт Тэмүжин итгэхээс өөр аргагүй болжээ.

Тэмүжиний шүтэн биширдэг Тэв Тэнгэр бөө ч хүнийг харцаараа үхүүлж чадахгүйг тэр мэдэх билээ. Тэр шөнө Мухулайг илгээсэнд талархан Тэнгэрт мөргөжээ.

Хожим тайчуудтай тулалдахад Сорхоншарын охин Хадааныг булаан амьд мэнд аварч гарсан хүн нь мөн Мухулай юм.

Хадаан болоод Тэмүжиний сэтгэлийн далд холбоог өөрийн зөн совингоор ойлгон мэдэрсэн Мухулай, эр нь алагдаж үхлийн аюулд учирсан Хадааныг олж аварчээ.

Хадаантай уулзсан нь Тэмүжины хувьд хэзээ ч мартагдахгүй азтай хувьтай тохиол гэж тэр үзэх учир Мухулайд талархах нь улам их болжээ. Тайчуудын олзноос Сорхоншар гэгч боолын ачаар аврагдаад гэрийн зүг явж байхдаа түүний охин, хонгор зөөлөн ааштай Хадааныг эхнэрээ болгон авна гэж тангарагласан билээ. Үүнийгээ ч хагацахын өмнө Хадаанд хэлжээ.

Учир нь Хадаан бол бие сэтгэлээ хамгийн анх Тэмүжинд өгсөн охин байлаа. Таргудайн явуулсан эрлийнхэн Тэмүжинг ололгүй давхин одсоны дараа хураалттай ноосонд нуугдаж хэвтсэн Тэмүжин, Хадаан хоёр өөрсдийн огт мэдэхгүй тийм гайхалтай сэтгэлд автжээ. Зуны бүгчим халуунд ноос онгичихоос төвөгшөөсөн цэргүүд жадаар сийчсэнд Тэмүжин өртөөд шанааруу нь цус урсаж байжээ. Харин Хадаан түүний цусыг хэлээрээ долоож түүнээс болоод хоюул биесээ хүсэх солиорсон дурлалд автжээ.

Халуун ноосон дунд нүцгэн хөлбөрч хүний ёсоор эр эмийн үйлийг анх хийжээ. Хорвоод ийм аз жаргал шаналгаат дурлал байдгийг тэд мэдэхгүй байлаа. Тэдний дурлал аз жаргал ердөө л хоногийн настай байв. Тэмүжинд дурлах биш амьд үлдэх нь чухал байлаа. Түүнд анхны хайраа, амраг хонгор Хадааныг орхин явахаас өөр арга байсангүй. Тэмүжинг хайгсад Сорхоншарын гэрт хэзээ л бол хэзээ дахин ирж мэдэх байв.

Тайчуудын хүрээнээс мултарч Бөртийг эхнэрээ болгож Боржигон аймгаа нэгтгэтлээ Тэмүжин нэг ч өдөр хайртай Хадааныг мартсангүй санасаар байжээ. Эм хүнд ганц хормын дотор ингэтлээ сэтгэл алдарч болохыг Тэмүжин дахиад хэзээ ч үзээгүй билээ.Тайчуудтай тулалдахын өмнө Хадааныг заавал олж авна гэж Тэмүжин бат шийдээд байсан ч амь мэнд уулзах эсэхтээ эргэлзсээр байв. Бас Хадааны тухай бодлоо хэнд ч хэлэлгүй байсан билээ. Гэвч Тэмүжиний сэтгэлийн далд нууцыг Мухулай яаж мэдсэнийг тэр анзаарсангүй. Хадаан бол Тэмүжиний хувьд онцгой учиртай хүн билээ. Тийм учраас энэ тохиолдлыг Тэмүжин одоо ч гайхан биширсээр явдаг юм.

Анх арван долоотой Мухулайг Жүрхэн овгийн цэргийг толгойлуулахаар томилоход түүний харцанд дүрэлзсэн тэр гал одоо ч Мухулайн нүднээс тод гэрэлтсээр байхыг Чингис хаан олж үзжээ. Мухулай одоо нэгэнт хөгширч түүний хөвүүн Бор идэр насны жанжин болсон нь өнөө эцгийнхээ дор сууж байлаа. Борын дэргэд Зэлмийн хөвүүн Есөнтэй түүний дээр Боорчийн хөвүүн Гэрэг тэдний хамгийн сүүлд Сүбээдэйн хөвүүн Урианхайдай суух ажээ. Чингис хаан тэднийг хараад бахдах сэтгэлээ барьж дийлэмгүй санагдав.

Түүний их хэргийг удирдан үргэлжлүүлэх ухаан зориг дүүрэн гурван үеийн эрс одоо өмнө нь сууж байв.

Харин Есөнтэй болоод Урианхайдайн хөвүүд энэ найранд орсонгүй. Учир нь тэд одоо балчир гэлгүй эцэг өвгөдөө орлон гэрийн гаднах хэргийг зохицуулж байжээ. Шинэ залуу үе, шинэ жанжин баатрууд өвс ногоо адилаар ар араасаа урган төлжиж тэдэнтэй хамт шинэ зорилго ундарч шинэ дайн хийх хүсэл цуг урган гарч буйг Чингис хаан ойлгож байв.

Харин түүний нөхдийн дундаас хамгийн ихээр шархдаж гэмтсэн нь Сүбээдэй байжээ.

Зүүн нүдээ хар илгээр таглаж боосон угийн догшин сүрлэг Сүбээдэй хөгширч түмэн үрчлээ болоод хүүхэд хараад айж уйлмаар, хөгшид эмс цочиж хашгирмаар үзэгдэнэ. Бас болоогүй инээх нь яг л саа өвчин туссан хүн мэт харагдах тул Чингис хаан сахлын дор инээмсэглэн харж суув. Зэлмэ,Сүбээдэй гэгч төрсөн ах дүү хоёр ингэж хэдэн үеэрээ Тэмүжинд амь биеэ зориулах учиртай байжээ. Харин саа өвчинд нэрвэгдсэн ах Зэлмэ нь ирж чадахгүй болжээ.”Би Зэлмэтэй уулзахгүй биз” гэж Чингис хаан гуниглан бодож суув. Киевийн ван хэрхэн бууж өгсөн, түүнийг хоёр хүүгийнх нь хамт цаазалснаа бахархалтайгаар ярьж суугаа Сүбээдэйг хараад Чингис хаан нэгэн зүйлийг тод ойлгож авав.

Энэ бол нөхдөө бахдаж тэдний хүч үгүй бол их хаан сууж чадахгүй байснаа ойлгосон явдал юм.

Өрөөсөн нүдэт бас хазгар энэ Сүбээдэй бол бага хүчээр дайсны олон цэрэгтэй байлдахдаа гаргууд ёстой нэг чөтгөр шиг арга мэхтэй хүн билээ.

Тийм ч учраас Сүбээдэйг хамгийн холын аян дайнд илгээдэг билээ. Найманы Хүчүлүгийг Сүбээдэй бүр Инд мөрний хөндий хүртэл элдэн хөөж сөнөөгөөд ирснийг бахархахгүй, тоохгүй байхын аргагүй юм. Таван улсын нутаг орноор хөндлөн гулд явж хоёр жил хөөсөөр Хүчүлүгийг сөнөөсөн нь ганц Сүбээдэйн хийж чадах хэрэг байлаа. Ийм хэрэгт Сүбээдэйг ямар ч эргэлзээгүйгээр томилсон бөгөөд дараа нь Хорезмыг эзлэн аваад Орост цөмрөн тагнуул туршуулын дайнд илгээсэн нь түүний гайхамшигтай чадварыг үнэлсэнтэй холбоотой юм. Орост цөмрөн орсон нь бас л ганц Сүбээдэйн чадах хэрэг байв. Сүбээдэй ингэж таньж мэдэхгүй газар оронд цөмрөн орж хүч илүү дайсантай аймшиггүй тулж, ялан дийлдэг нь чухам түүний Тэнгэрийн ивээлд багтсаных биз гэж итгэх билээ.

Ерөөс түүний нөхөд өөр өөрийн чаддаг мэддэгээрээ түүнийг их хаан суухад харамгүй зүтгэжээ. Мухулай, Алтан улсад арван хэдэн жил сууж эсэргүүцэл бослого бүрийг өөрийн цөөн цэргээр дараад одоо нэгэнт Алтан улсын эрлэг гэгдэх болжээ.

Хасарыг үхүүлсний хойно түүнийг Алтан улсыг ерөнхийлөн захирах сайдаар томилж улсын Гоо ван цол олгон суулгасан нь Алтан улсад толгойгоо өндийлгөх боломж олгохгүй хэрэг болсон билээ. Мухулай ингэж чаджээ. Мухулайн ач гавьяагаар Чингис хаан баруун зүгт ар талдаа сэтгэл санаа зовох зүйлгүй байлдаж их ялалт олсон юм.

Өнөөдөр, өөрийн амьд үлдсэн гарамгай нөхдөө цуглуулаад Чингис хаан ийн найрлаж суугаа нь Тэнгэрийн ивээлээр олдсон ховор алтан хором байв. Үүнийг хэн хэн нь сайтар ойлгож байлаа. Их найрын дундуур Чингис хааны их сүр хүчийг баталсан нэгэн хэрэг болов. Энэ нь Чингис хаанд бараалхахаар Багдадын Халифийн элч ирсэн хэрэг байв. Гэрэгийн байцаан мэдэж уламжилснаар тэр элч Туулын хөндийдөх их ордонд очиж Бөртэ хатанд бараалахаад нааш зам заалган хүрч иржээ. Багдадаас гараад жил шахам явсан тэр элч Чингис хаанд лал мөргөлтний тэргүүн халифынхаа захидлыг гардуулах хүсэлтэй гэжээ.

Чингис хааны сэтгэлд Хорезмын Перваны хөндийд байхад ирж бараалхсан Римийн ламын элч өнөөх өрөөсөн хөмсөгт, өл халзан Авраам Даяан гэгч санагджээ. Бас Боорчи ч тэр явдлыг санасан бололтой

-Тэр элчийг хэн гэнэ гэж асуужээ.

-Ирсэн элчийн нэрийг Ал Каийд гэнэ. Идэр насны хүн байна гэж Гэрэг хэлжээ. Багдадын халифын элч энд ирснийг сонсоод Цагадай хамгийн ихээр гайхсан ч дуугарсангүй суужээ. Бүгд Чингис хааныг зарлигийг хүлээв.

-Боорчи. Чи Цагадайн хамт Багдадын элчийг сайхан угтан уулзаж үгийг сонсогтун. Биднийг гэж энэ хол ирж байгаа бүхнийг бид нөхрөө гэж угтан авах нь чухал гэж Чингис хаан урамтай хэлжээ.

-Бид одоо уулзах уу гэж Цагадай яаран өндөлзөж асуув.

-Бүү яар. Уулзах гэсэн бол хүлээнэ биз. Маргааш бологтун. Эсвэл хэд хоног хүлээг гэж Чингис хаан зарлиг буулгасан тул Боорчи

-Элчийг тухтай амраа гэж Гэрэгт хэлэв. Гэрэг үүргээ биелүүлэхээр даруй гарч оджээ. Харин Чингис хаан өнөө бэлэн үгт Даяаны тухай бодож суужээ. Маргааш нь Боорчи, Цагадай хоёр Багдадын халифын элчтэй уулзаад Чингис хаанд бараалхаж учрыг мэдүүлж Халифын захидлыг орчуулсныг уншин сонсгов.

Тэр захидалд "Аллах тэнгэрийн ивээл дор оршин байсан Хорезм улс мөхөж султан Желаладдин сураггүй болжээ.

Гэвч улс нь мөхөж хаан нь зугатсан ч лалын мөргөлт олон түмэн нутаг газартаа суусаар байх биз. Лалын мөргөлт сүсэгтэн олныг авран гийгүүлэх ариун үүргийг Аллах тэнгэрээс Багдадын халиф надад өгсөн билээ. Энэ зарлигаар Аллах тэнгэрийн ариун орон Багдадаас лалын мөргөлт Хорезм улсын султаныг сонгон баталж түүнд Аллахын тэнгэрийн авралын баталгаа болсон тамгыг олгож түүгээр дамжуулан лалын мөргөлт сүсэгтэн олноо жолоодон суух эрхтэй болдог жамыг дагасаар даруй мянган оныг үзжээ. Одоо Хорезм улс нэгэнт Чингис хаан таны Их Монгол улсын баруун хаяа болжээ. Багдадын халиф надад Чингис хаан тантай эвдрэлцэн дайсагнах бодол өчүүхэн ч үгүй юм. Ийм сэтгэлийн үүднээс таны жанжин Чормогон хорчийг хэдэн жилийн өмнө Багдадын ойр морилон ирэхэд найрсаг сайнаар угтан авч хаан танд өчүүхэн бэлгийг өргөн найрамдалтай явахаа баталсан билээ .Одоо ч энэ санаа хувираагүйг батална. Гэвч бид Аллах тэнгэрийн ариун зарлигийг эвдэх өөрчлөх эрхгүй юм.

Одоо Хорезмын өмнөд нутгийг захиран суугаа таны хөвүүн Цагадайг бид хуучин султаны адил үзэн гүн хүндэтгэлтэй хандаж байна. Үүнийг Цагадай хаан бэлхнээ батлах буйзаа. Бид Цагадай хаанд лалын шашны ариун тамгыг шийтгэн олгож түүнийг султан мэт хүндлэн үзэж эрхийг бариулахад татгалзах гэдийх зүйл өчүүхэн ч үгүй. Гэтэл Цагадай хаан нэгэнт манай лалын шашинд дагаж орох эсэх нь мэдэгдэхгүй удаж байгаа нь биднийг хүчир байдалд оруулаа.

Цагадай хаанд цэрэг хүч их байвч тэр нэгэнт лалын мөргөлтөн биш нь бид түүнд ариун тамгаа шийтгэн олгох аргагүй болгож байна.Ард нийтээр шүтэн биширч ивээлд нь багтсан Аллах тэнгэрийн мөргөлтөн болж Халифын тамгыг гардан авахгүйгээр лалын олон мөргөлтнийг зүй ёсоор захиран суухад бэрх болох нь гарцаагүй. Бид таны хөвүүн Цагадай

хааныг лалын мөргөлтөн болбол өчүүхэн ч эргэлзгүйгээр ариун тамгаа олгох билээ. Чингэвэл Цагадай хааныг Хорезм даяар шүтэн дагаад зогсохгүй лалын мөргөлтний бусад улсуудад ч нэр алдар нь сайнаар дуурсагдан их хүчийг олох нь гарцаагүй билээ. Цагадай хаан лалыг мөргөлтөн болж султан алдрыг хүртэх аваас нийт лал мөргөлтний улсууд амарлин жаргах эх үндэс болох билээ.

Чингис хаан та эл учрыг болгоож мэргэн шийдвэрээ талибах бизээ гэж элчийг илгээв4 хэмээжээ.Бичгийг сонсмогц Чингис хаан бодолд оров. Энэ бол зөөлөн алгуур аястай ч шашин мөргөлийн нэр барьсан тулган шаардсан бичиг байв.

-Цагадай чи юу гэж гэж санана гэж Чингис хаан удаан суусангүй асуув. Хаан эцэг нь ингэж асууна гэж Цагадай шөнөжин бодож хоносон билээ. Халифын захидалд түүнийг Хаан хэмээн өргөмжлөн дурдсан нь Цагадайд ихэд сонсголонтой дуулдсан бөгөөд бас энэ захидалд түүний цаашид хэрхэхийг тов тодорхой өгүүлсэн мэт санагдаад сэтгэл хөдлөн нойргүй шахам хоносон билээ.

Үнэхээр Цагадайд өөрийн улсыг байгуулж Хаан эцгийнхээ адил Их хаан суух цаг нэгэнт ирсэн гэж итгэж байжээ.

Гэвч Хаан эцэг нь юу гэж үзэхийг таах аргагүй тул хий хөөрөн догдлохоо тэвчих ёстойгоо ойлгожээ. Энэ бол тун осолтой тоглоом байв. Илэрхий тусгаар бие даасан бодлого барихыг Чингис хаан хэзээ ч үл тэвчдэгийг мэдэх тул түрүүлж хамаагүй дэл сул үг унагаж өөрийгөө илчлэхгүй байх нь хамгийн чухал гэж тэр үзжээ.

-Миний үзвэл энэ лалын шашинтан мөргөлчдийн амьдрах байдал сэтгэн бодох нь биднээс эрс өөр. Тэд Аллах тэнгэртээ даанч хатуу итгэдэг юм. Тэдэнд Аллах тэнгэрээс өөр хүчтэн, авралтан байхгүй гэж Цагаадайн хэлэхэд

-Одоо ч тэгэж санасаар гэж үү гэж Чингис хаан асуусан нь Цагаадайн үгэнд бухимдсаных байв. Өөрийн эзлэн авсан нутгийн албат иргэд түүнийг биш харин өнөөх Аллах тэнгэр гэгчийг шүтсээр байгаа нь Чингис хаанд огтхон ч таалагдсангүй.

-Лалын мөргөлтнүүд газраар нэг таржээ. Энэ Тангуд улсын баруун талын хотуудын иргэдийн ихэнх нь лалын мөргөлтэй юм гэж Цагадайн булзах маягтай өгүүлэв. Чингис хаан бодолд автжээ.

-Тэр элч бас заавал надад бараалхах хүсэлтэй гэв үү гэж Чингис хаан асуув.

-Тийм ээ. Гэвч надтай уулзсан нь түүнд болох биз гэж Цагадай санаагаа шууд хэлжээ. Учир нь Цагадай лалын мөргөлтнийг өөрийн албат боол гэж үзэж байв. Багдадын халифын элчийг Чингис хаанд бараалхуулах нь өөрийг нь дорд үзсэн хэрэг болно гэж тэр боджээ.Цагадайн энэ туйлын болгоомжгүй үг Чингис хааны хилэнг хөдөлгөж мэдэх байсан тул Боорчи болгоомжлон Цагадайд харцаар сануулсан боловч оройтжээ.

-Багдадын халиф нэгэнт лал мөргөлтний тэргүүн байгаад бас Чингис хаан надад захидал бариулан элч илгээжээ гэж Чингис хаан шивнэв. Цагадай буруу үг хэлж хаан эцгийгээ

хилэгнүүлсэндээ айж цочоод тоош тонгойв.

Гэвч Чингис хаан тэр дороо тайвшраад

-Халифын элчийг надад бараалхуул гэж зарлиг болжээ.

Харин бараалхуулахын өмнө Гэрэгийг дуудан өнөөх элчийн ямархуу ааш аягтай хүн болохыг асууж сонсжээ.

Учир нь Гэрэг тэр элчийг ирснээс хойш нүд салгахгүй ажиглан мөрдөж байжээ. Ирсэн элч буюу Чингис хааны хүрээнд гаднаас ирэгсдийг ингэж тагнаж мөрдөх нь эртнээс тогтсон хатуу ёс, торгон цэргүүдийн нэг үүрэг байлаа. Энэ дагуу Гэрэг ажиглаж мэдсэнээ өчжээ. Ал Каийд гэгч тэр элч өглөө үдэш бүр хавтгай модонд хутга зоох сургууль тогтмол хийдгийг сэм харж мэдсэн нь хамгийн хачирхалтай хэрэг шиг Гэрэгт санагджээ

-Тэр элч сүсэгтэн гэхээсээ алуурчин мэт санагдав гэж Гэрэг санаснаа нуулгүй хэлжээ.

-Түүнийг надад бараалхуулахдаа хутгыг авч сайтар нэгжигтүн. Миний дэргэд Мухулайг бай гэж хэл гэж Чингис хаан хэлэв. Гэрэгийн болгоомжлуулсныг үл хайхран тэрээр Багдадын элчийг хүлээн авчээ. Эгмээ хүрсэн өтгөн хар сахалтай цагаан алчуураар толгойгоо ороосон тэр элч үнэхээр зоригтой дайчин эрийн шинжтэй үзэгдэнэ. Угтан авах хүндэтгэх ёслол дуустал Чингис хаан үг дуугарсангүй.

-Ал Каийд гэж чиний эцгийн өгсөн нэр үү гэж Чингис хаан гэнэт асуужээ. Чингис хааны энэ санаандгүй энгийн асуулт Ал Каийдийг бяцхан сандраажээ. Ийм асуултаар яриа эхлэнэ гэж тэр даанч санасангүй. Түүний ингэж цочиж сандрахыг Чингис хаан ажиглав. Үнэхээр түүний ямар нэртэйг Чингис хаан мэдлээ гэж үү гэсэн бодол төрсөн тул элч тэрхэн зуур бодоод ийм өчүүхэн зүйлийг нуух нь утгагүй гэж үзэв.

-Тийм ээ.Чингис хаантан.Намайг уг нь Махмуд Аббас гэдэг юм. Би Мисир хүн л дээ. Багдадын халифын ордонд шадарлах болсноос хойш Ал Каийд гэж нэртэй болсон юм. Ал Каийд гэж эртний араб хэлээр Аллахын аврагч гэсэн үг гэж тэр дахин ийм гэнэтийн асуулт гарахаас сэргийлэн бүгдийг урьдчилан хэлжээ. Энэ нь зөв болж Чингис хаан түүнээс дахин элдэв зүйл асуусангүй ч Ал Каийд их л сэжигтэй болжээ. Чингис хаан түүнээс зүгээр нэг ингэж асуугаагүй гэж бодож суув .

-Элч ээ.Би танай Халифын сайхан сэтгэлээр илгээсэн захидлыг уншлаа. Та нарын шүтэн биширдэг тэр гэгээн Мухамед гэгч одоо хаана сууна. Чи түүнтэй уулзаж байсан байлгүй гэж Чингис хаан ярианы дундуур асуусан нь Ал Каийдийг хүнд байдалд оруулаа. Чингис хаан ингэж асуух нь аргагүй байлаа. Хорезмыг эзлэн аваад лал мөргөлтнүүдийн хөөрхий номхон байдлыг, шашин шүтлэгтээ хэт ихээр мунхарсныг үзээд тэднийг ингэж бишрүүлсэн Мухамед гэгч хэн болохыг мэдэх гэж олон нэртэй имамтай уулзаж ярьсан бөгөөд эцэст нь энэ бол хэн нэгний санаанаасаа зохиосон үлгэр болохыг олж мэджээ.

Барыгжан уулын оройд гарч Аллах тэнгэр гэгчтэй уулзах гэсэн боловч тэр нь байгаагүй тул ийн асуужээ. Чингис хаантай уулзсан лалын мөргөлтөн бүр түүний энэ асуултанд хариулж

чадаагүй бөгөөд өнөөдөр энэ Ал Каийд ч үгээ олж хэлж чадсангүй. Шашин гэгч ийм хоосон зүйл болохыг Чингис хаан мэдсээр авч харин хүмүүс бүгдээр түүнийг шүтэн биширсээр, түүний төлөө амиа өгсөөр байгааг л ойлгохгүй байжээ. Мухамед бол мянган жилийн өмнө амьдарч байсан Христос болоод Буддагийн адил хүн. Харин үзэл сургаал нь олон түмнийг авран гийгүүлсээр байгааг Чингис хаанд тайлбарлахаас өөр арга Ал Каийдад олдсонгүй.

Бас Чингис хаан гэгч тэнэг монгол энийг хэзээ ч ойлгохгүй гэж бодож байв. Гэвч Чингис хааны энэ ил шулуун үг сэтгэлд нь хачин дотно дулаан санагдахыг мэдэрчээ. Лалын мөргөлтнүүдийн гэгээн шүтээн Мухамед гэгч байгаагүй гэж ингэж хэлэх зоригтон Чингис хаанаас өөр хаана ч байхгүй гэдэгт Ал Каийд итгэж байв.

Өөрийнх нь санааны мухрын орь ганц нууц хүслийг Чингис хаан ийн таах мэт хэлсэн нь түүнийг баярлуулж бас ихээр айлгав. Учир нь Ал Каийд хаад, эздийг нь алах замаар ямар ч улс гүрэн, үзэл бодлыг устгаж бас эзлэн дагуулж болно гэж төрөлхөөсөө итгэсэн нэгэн байв. Гэвч ганц хар биений нь хүчин чадал мөхөс тул санаа нэгтнээ цуглуулан хүчирхэг төмөр цэрэг байгуулахыг хийрхэн мөрөөдөгч байжээ. Тэр өөрийн дор ямарч аймшигтай аллага хийхээс буцахгүй үнэнч нөхөдтэй болж хамгийн их хаадыг устган ертөнцийг өөрийн өмнө сөхрүүлэн мөнхрөхийг хүсэж төлөвлөж байгаа ажээ. Ертөнцийг захирахын тулд хаадаас нь эхлэн алах нь хамгийн богино бөгөөд зөв зам гэж үздэг ажээ. Энэ нууц хүслээ биелүүлэхийн тулд Багдадын халифын дэргэд түүний итгэлийг олж шадарлажээ. Хорезмын хаан Желаладдин болон Багдадын халифын хооронд үүссэн зөрчил түүнд нэр нүүр олох сайхан боломж олгожээ. Хорезмын Желаладдин хааны талын нэр нөлөө бүхий хэд хэдэн хүнийг алж тусалсан нь түүнийг халифын нууц алуурчны зиндаанд хүргэжээ. Харин түүний дараагийн зорилго нь Хорезмыг захиран үлдсэн монголчуудын хаан Цагадайг алах хэрэг байв. Хэрэв Хорезмд байгаа монголчуудын хаан Цагадайг алчихвал сүйрч доройтсон Хорезм Багдадын мэдэлд орох нь гарцаагүй бөгөөд ингэж чадвал монголчуудын хүчээр лал мөргөлтнүүдийг нэгтгэх үүд нээгдэх юм.

Цагадайг алахыг Багдадын халиф зөвшөөрч байснаа эцсийн мөчид ухарч эхлээд хүчирхэг Монголчуудыг лалын мөргөлд дагуулан оруулах замыг сонгож Ал Каийдийг нааш илгээжээ. Юуны өмнө Чингис хааны ойр дэргэд шадарлаж түүнд зүтгэж байгаа олон лал мөргөлтнүүдийг талдаа татах нь хамгийн чухал гэж Халиф үзжээ. Халифын бодол зөв байв. Хэрвээ ингэж чадвал Монголчуудын хүчээр өөрийн нэрийн дор дорно болоод өрнө дахиныг нэгтгэн захирч бүгд Аллах тэнгэрийн дор нэгдэх билээ. Энэ бол Багдадын халифын хүсэл юм. Гэтэл Чингис хаан хэзээ ч лалын мөргөлийг тоож үзэхгүй нь тодорхой болжээ.

Ал Каийд Чингис хаанд туйлгүй ихээр атаархаж байв. Түүнд Чингис хаан шиг их цэрэг байсан бол тэр муу Багдадын халифыг хамгаас түрүүнд үхүүлж эмс хатдыг нь эзэмдэх байв.Ийм нэг этгээд гаж донтон түүний өмнө лалын мөргөлтний дүрээр сууж байгааг Чингис хаан гадарласангүй билээ.

-Багдадын халифын захидлын хариуг Цагадай нутагтаа очоод өгнө гэж Чингис хаан хэлснээр тэдний уулзалт өндөрлөв. Харин Ал Каийд Чингис хааныг алахаар шийджээ. Түүний хамгийн өст дайсан нь Чингис хаан гэдгийг Ал Каийд ойлгожээ. Энэ ертөнцийн хамгийн хүчирхэг хааныг алснаар Ал Каийдийн нэр үүрд мөнхрөнө гэж санав. Ийм боломж ганцхан удаа олдох бизээ. Тэгмэгц Ал Каийд баяртай болж Чингис хаан гэгч агуу хаантай учруулж

түүний мөнхрөх замыг нээсэн Аллах тэнгэртээ хашгиран мөргөжээ. Ал Каийд энд Чингис хаантай хамт үхэхээр шийдэв. Түүний агуу их нэр төрийн мандах цаг, мөнхрөх хором энд иржээ. Ал Каийд ганцхан үүний төлөө зорьж тэмүүлж амьдарсан билээ. Тэр Ал Каийд нэрнийхээ учрыг тайлж Аллах тэнгэрээ аврахаар эргэлтгүй шийджээ.

Өргөөнд Боорчи, Цагадай хоёрыг орж ирсний дараа түрүүнээс хойш ганц үг дуугараагүй Мухулайгаас

-Чи юу гэж санана гэж Чингис хаан асуужээ. Чухам түүний үгийг сонсох гэж л энд суулгасан билээ. Мухулай гэрэлт нүдээрээ хаан эзнээ харж суугаад бодсон ч үгүй

-Ийм хүнийг үтэр түргэн тонилговол зохино. Тэр хаан таныг алахыг хүсч байна гэж шууд хэлэв. Хэн ч юу ч хэлсэнгүй.

Мухулай өөрийн далдыг таадаг зөн совингоороо эзэн хаанаа аварсан нь энэ юм.

-Лалын мөргөлтний дунд ийм хүн олон болж мэднэ. Цагадай дүү чи болгоомжтой байгтүн гэж Мухулай дахин хэлэхэд ч дуугарцгаасангүй. Чингис хаан юу гэхийг хүлээж байв.

-Цагадай. Би Мухулайн адил санана. энэ Ал Каийд гэгч яг алуурчны нүдтэй юм. Тэр нэгэнт тусгаар улсын элч тул энгийн нэг алуурчны адил үзэж үл болно. Элчийг даруй хүндтэйгээр үдэн мордуул. Харин итгэлтэй хүмүүсээ дэргэд нь дагалдуулж яг Багдадын хэрмийн гадна хүргээд түүнийг хороогтүн.Харин Багдадын халифад ямар хариу өгөхийг би Цагадайг буцахаас өмнө хэлнэ гэжээ.Маргааш өглөө сэрэхэд Ал Каийдийг үдэх гэж торгон цэрэг жагсаж бас Багдад хүртэл дагалдан явах баг цэрэг бэлэн болсон байсан нь хэн нэгэн Ал Каийдийн нууц бодлыг таасан мэт болжээ.Аллага хийх замаар ертөнцийг захирах донтон Ал Каийд гэгч ингэж Багдадын хэрмийн гадна үхдэл болон аймшигт мөрөөдөлтэйгөө хамт булагджээ.

Тэр амьсгал хураатлаа Чингис хааныг алах их хүсэлдээ шатсаар, өөрийн үхэж байгаад огт итгэхгүй байсаар гол нь тасрахыг Цагадайн хөвүүн Есөнмөнх гайхан харж байжээ. Ингэж удаан амь тавьдаг, долоон голтой хүнийг огт үзсэнгүй байжээ. Толгой нь биенээс тасарсан мөрт нүд нь анивчин ам нь ангалзаж ямар нэг зүйлийг хашгирсаар байжээ. Энэ бол гарцаагүй зөв шийдвэр байсан гэдэгт Боорчи итгэлтэй байлаа.

Учир нь Мухулай ер хоосонгүй, ойр зуурын юм мэдэж, таадаг тул ингэжээ.

Элч бүр янз янзын санаа өвөрлөж ирэх юмдаа гэж Боорчи боджээ. Загалмайн мөргөлтний тэргүүн Римийн их ламын элч Авраам Даяан гэгч тэр сэтгэлийн хөөрөлтэй эрийг заль зохиож сайхан бэлэн үг хэлээд бултан алга болов гэж Боорчи боддог ажээ.

Уг нь Боорчид Даяаны ирсэн Римд очих хүсэл их байсан билээ. Сүбээдэйг Калка голын хөндийд Киевийн их вангийн цэрэгтэй тулалдаж Орос, Хивчагийн нэгдсэн цэргийг хиар цохин сөнөөгөөд байхад Боорчи, Гэрэгийн хамт очжээ.

Голын хөндий дагаад морьтой явж болохын аргагүйгээр орос, хивчаг цэргийн хүүр овоорсныг

тэд зайчлан явсаар арайхийн хүрчээ. Тэр үдэш Сүбээдэй орос, хивчагийн олзлогдон бууж өгсөн цэргийн ван, ноён сурвалжит зуун хүнийг газарт хэвтүүлээд дээр нь шал тавьж, ширээ идээ засаад Боорчийг хүндэтгэн найр хийжээ. Нутгийн шар үст бүсгүйчүүдийг авчирч өмнөө бүжиглүүлж, дараа нь тэднийг өөрийн цэргүүдэд шагнан таракаж өгчээ.

Орос бүсгүйчүүдийн орилолдох тэр шөнөжингөө тэнгэрээр нэг хадсаар байжээ. Тэд үүр цайтал найрлаж харин шалны доороос “Помогите” гэж хашгирах дуу тод сонсогдсоор байснаа сүүлдээ шивнэх төдий болж эцэст өнөө орос ноёд бүгд дарагдан үхжээ. Ийнхүү Калка голын хөвөөнд орос ноёдоор амьд ширээ засаж найрлан суухдаа Римд очих хүсэлтэйгээ Боорчи Сүбээдэйд хэлжээ. Сүбээдэй энэ үед амьд могой авчруулаад зүрхийг нь сугалан авч архинд хийгээд түүнийг дайлах гэж байжээ.

- Биеийн чалханд гайхалтай эм гэдэг юм даа гэж Сүбээдэй бахархан хэлээд аягатай улаан архиа цустай гараар барьжээ.

Боорчи эргэлзсэнгүй залгиж орхив. Могойн зүрх хэлэн дээр нь тогтоод булхалзан цохилж байх нь мэдрэгдээд хоолой давав. Ходоодонд орсон хойно нь ч могойн зүрх цохилоор байв.

- Чи миний хэлснийг сонссонгүй юу гэж Боорчи хэлэв. Сүбээдэй могойн зүрх сугалахдаа амтшин сатаарсан тул Боорчийн үгийг анзааракгүй байжээ.

- Чи юу гэнэ гэж Сүбээдэй өрөөсөн нүдээрээ цоо ширтэв.

- Рим гэгч улсыг би үзэхийг хүснэ гэж Боорчи шууд хэлэв.

- Чи тэнд очиж яана.

- Өнөө Римийн ламын элч Даяан гэгч намайг урьсан юм.

-Биднийг очвол хэрмийнхээ үүдийг нээж угтана гэсэн билээ. Хэрэв тэр Римийн их лам тийм их нөлөө эрхтэй нь үнэн бол юуны түрүүнд түүнийг эзлэн авбал зохино гэж Боорчи хэлэв. -

Чиний ингэж бодох чинь яг зөв байна. Би ч бас тэгэж бодож байна. Уг нь одоо эндээс ухасхийвэл ч юу байх вэ дээ. Чи бид Чингис хааныхаа зарлигийг дагахгүй бол яаж болно. Ер нь очсон хойноо энэ бүгдийг Чингис хаанд айлтган нааш дахин ирвэл зохино гэж Сүбээдэйн хэлснээр тэдний Римийн тухай яриа төгссөн билээ. Үнэхээр Чингис хааны нутаг буцах зарлигийг зөрчих эрх тэдэнд байсангүй. Ингэж Даяаны үнэн хэлсэн эсэхийг мэдэх боломж Боорчид олдсонгүй.

Гэвч Даяан гэгч тэр өрөөсөн хөмсөгт эр одоо нэгэнт үгүй болсныг Боорчи мэдсэнгүй. Ертөнцийн эзэн аврагч Исүсийн элчтэй уулзаж гэгээрсэндээ солио туссан Даяан өөрийн үзэл бишрэлдээ хөтлөгдсөн чигээр Римд очиж их ламдаа бараалхан Перваны хөндийд Исүсийн элч Чингис хаан морилон ирж лалын шашинтнуудыг гэсгээн дараад байгааг үзсэнээ бахархал дүүрэн өчжээ. Чингис хаан бол Исүс Христосын авралд багтсан Тэнгэрийн элч болохыг батлан хэлсэн түүний үг Римийн хамба ламын өргөөг эвдэн бусниулах шиг болжээ.

Талын зэрлэг нүүдэлчид Исүс тэнгэрийн элч байх нь загалмайн мөргөлтний ихэс дээдэст үзээгүй доромжлол байсан тул бүгд нэгэн дуугаар хөөрхий Даяаныг талын зэрлэг нүүдэлчдийн мэхэнд унаж тэдний тагнуул болов гэж үзжээ. Энэ солиорсон мэдээ олонд тархвал түймэр мэт аюултай гэж хамбын зөвлөл хуралдан шийдээд шөнө нь түүнийг баривчлан хорьж маргаашнаас нь тэрслүү үзэлт, буруу номтон болсныг зарлав. Даяаныг Римийн төв талбайд их түүдгийн дээр шатаан алав.

Ертөнцийн эзний элч улаан сорвит монгол эр Боорчи Тэнгэрээс буун ирж аврана гэж итгэн залбирсаар загалмайн шашны үнэн сүсэгт Даяан гэгч эр шатаж үхжээ. Түүнийг үхсэний дараа бүх ном сургаалыг нь хаман авч шатаан устгажээ. Даяаны шавь нар, эхнэр хүүхдийг нь ч мөн адил алжээ. Ингэж талын нүүдэлчдийн хаан Тэмүжинг Ертөнцийн эзний элч байсныг мэдэж байсан цорын ганц хүн үгүй болов. Одоо Даяанытг Рим даяар хараан зүхэж байгааг Боорчи мэдсэнгүй билээ. Римд байсан Сүбээдэйн нууц тагнуул Авраам Даяаны тухай энэ гунигт түүхийг хожим нотолжээ.

Лалын мөргөлтний ариун төв гэгдэх Багдадын халифын элч, урт хар сахалтай, толгойгоо цагаан даавуугаар ороосон Ал Каийд гэгч эрийг үдэж өгөхдөө энэ элчид ямар хувь заяа тохиох гэж буйг Боорчи харин мэдэж байлаа.

*****

Багдадын элчийг буцсаны дараа Чингис хаан, Мухулай, Сүбээдэй гурвыг Боорчи өөрийн хээрийн өргөөнд хүлээн авч дайлжээ. Энэ бол жирийн нэг дайлж, цайлсан хэрэг биш юм. Ийм дайллага жирийн уулзалтын үеэр Чингис хааны үйл, бодлогын далд учир начир тодрон гарч боловсрогддог билээ. Нэгэнт хийдгээ хийж үеэ өнгөрөөж буй тэдэнд бодох санах, хийх гүйцээх хэрэг тун олон байлаа. Бас ингэж найр наадам үүсгэх нь Чингис хааныг өвчнөө мартан илааршихад тустай гэж үзжээ.

Тэр үдэш Боорчи тэднийг өөрийн гараар сорс хийж дайлсан нь бүгдэд таалагдсан бөгөөд Онон, Хэрлэн, Туулын хөндийгөөр өнгөрөөсөн идэр залуу насыг нь эрхгүй санагдуулжээ. Тэд Боорчийн өргөөнд тухтай сайхнаар ярилцаж суув.

Найрын дундуур гараад орж ирсэн Боорчи ихэд ёсорхон

- Чингис хаантан. Танд нэг хүн бараалхахаар иржээ гэж мэдэгдэв.

-Өнөө орой хэнтэй ч уулзахгүй хэдүүл дотно сайхан наргия гэж тогтсон биш үү. Маргааш бол гэж Гэрэгт хэл гэж Чингис хаан ундууцжээ.

-Хаантан энэ хүн тантай уулзах гэж тун олон жил явжээ.Бүр жаран найман жил явсан гэнэ гэж Боорчийн огт тоглосон янзгүй хэлэхэд бүгд гайхав.

-Хэн бэ тэр чинь.

-Та үзмэгц таних биз гэнэ.

-Яах вэ уулзах нь зөв үү. Та нар юу гэж бодно.

-Ийм чухал зочныг хүлээлгэж болохгүй гэж санана гэж Боорчи бусдаа төлөөлөн хэлэхэд

-Тэгвэл оруул гэж Чингис хаан зөвшөөрөв. Боорчи гарч, юүдэн нөмөрсөн, таягтай хүнийг дагуулан орж ирэв.

Өргөөнд бамбар дүрэлзэвч гэрэл нь үл хүрэлцэх тул тэд өнөө хүнийг үзмэгц таньсангүй. Бас тэр хүний нүүр царай нь юүдэн дороос сайн харагдахгүй байжээ. Өнөө хүн хөлөө арайхийн зөөх нь шархтай бололтой гэж бодогдмоор ажээ.

-Ертөнцийн хаадын хаан Их Чингис хаан таны амар амгаланг эрье. Боол чинь хөл нугарахгүй өвчтэй тул хаан танд сөхөрч үл чадна. Өршөөгтүн гэж өнөө хүн хэлэв. Бүгд үзэхээр өндийжээ. Чингис хаан бүр ухасхийн босоод

-Боол гэнэ ээ гэж хашгирчээ. Тэр андуурсангүй. Энэ бол Зэлмэ байв. Тэмүжиний унаган боол Жарчудай дарханы хөвүүн урианхайн Зэлмэ ирсэн нь үхдэл амилаад босоод ирсэн мэт цочмоор хэрэг болжээ.

-Ах аа гээд Сүбээдэй үсрэн босов. Чингис хаан даруй түүнд дөхөн очив.

- Зэлмэ. Чи юу. Эсвэл би зүүдэлж байна уу гэж Чингис хаан хашгирав. Түүний сэтгэл догдлон хөдөлжээ.

- Тийм ээ. Хаан та зөв таньжээ. Би таны боол Жарчудайн Зэлмэ байна гэж Зэлмэ хөл дээрээ арайхийн тогтож ядан шивнэв.

Их хүчилсэндээ түүний хөлс дусаж хөл нь чичирч байв. Тэр Чингис хаантай босоо уулзахыг хүссэн тул өвчтэй биеэ ингэж зовоож эцсийн хүчээ шавхжээ. Үүнийг мэдэж байсан Боорчи түүнийг хөтлөн Чингис хааны сууж байсан сэнтийд өргөх шахам суулгав.

-Хаантан өршөө. Миний хөл нугарахгүй тул би аргаа барж Хаан таны сэнтийд суув. Уг нь би хэвтмээр санагдана. Гэвч би та нарын дэргэд яаж хэвтэх билээ гэж Зэлмэ шивнэв.

Бүгд хэлэх үгээ олохгүй догдолж хөөрчээ. Хамгийн түрүүнд Сүбээдэй ахтайгаа очиж золгов.

Сүбээдэй ахтайгаа уулзсангүй найман жил болжээ.

-Би дүү чамтай уулзахгүй гэж санаж явлаа гэж Зэлмэ нулимс унагав. Бүгдийн нүд нулимсаар дүүрчээ.

-Би хаан таны заасан нутаг Хянганы нурууны ар Айраг нуурын дэргэд үхэж эс чадлаа. Та нарыг энд цугларав гэж сонсоод үхлээс зугатааж биеэ зовоож нааш ирлээ. Бусдыг дуудаад намайг хүн гэж тоож хэл өгдөггүй байжээ. Та гэж Зэлмийн гомдон хэлсэн нь аргагүй тул хэн ч тайлбар хийж чадахгүй болжээ. Чингис хаан Мухулай, Сүбээдэй нарыг дуудсаныг Есөнтэй хөвүүн нь хэл хүргүүлж, яаж ийгээд ирэхийг хүсчээ.

Есөнтэй, эцгийнхээ сэтгэлийг сайн мэдэх сүрхий ухаантай хүн тул олон жил ганцаар хэвтсэн эцгийгээ өрөвдсөн учир ингэжээ. Тэгээд Зэлмэ замдаа үхэхийг үл тоон нааш гарсан нь энэ байв. ”Би замд үхвэл миний хүүрийг Чингис хаанд үзүүлж хаана оршуулахыг түүгээр заалга” гэж албатууддаа тушаагаад ухаантай, ухаангүй хоёрын хооронд Тангудад арайхийн иржээ.

Зэлмийн өвчин нэн хүнд тул тэр олон үг ярисандаа ядраад амьсгаадаж зөвхөн шаналгаатай, чимээгүй инээмсэглэхээс цаашгүй ажээ.

-Зэлмэ чамайг хараад миний сэтгэл ханав. Чамайг дуудаагүй нь зөвхөн чиний биеийг бодсоных юм. Би ер нь сар бүр чамд хишиг хүртээхээ мартаагүй шүү. Чамайг үзмэгц би нутагтаа харихыг яасан их хүснэ. Зэлмэ чамайг хараад бадмалсан зул шиг бага нас минь санагдав. Есүхэй эцгийгээ хорлуулаад орилж хэвтсэн Тэмүжинг би одоо харж байна. Тэр гашуун нулимс аманд амтагдаж хоолой хорсгож байна. Би энэ нулимсны амтыг яаж мартана. Би энэ газрын бүх амтат дарсыг уув. Тэр дарс болгоноос миний нулимс амтагдах шиг болдог юм. Тэр нулимс миний цусанд нэвчсэн бололтой. Зэлмэ чи тэр гашуун нулимсыг амтлуулав.

Зэлмэ чи миний дэргэд суугаад нулимсыг минь арчиж байж билээ гэж Чингис хаан өнгөрснийг дурсан санаад нулимс урсган хэлжээ.

-Би танд хамгийн гашуун дурсамжийг санагдуулжээ. Есүхэй эцэг чинь үхэхэд “Одоо өнчин бид яана. Ингээд бүгд үхнэ дээ” гэж бодсонсон. Гэтэл үхсэнгүй өдий хүрлээ. Би уг нь хаан танд Сүн улсыг хурааж өгье гэж их хүссэнсэн. Гэвч Тэнгэр миний хүслийг таалсангүй. Одоо хөвүүд, ач нар минь дутууг гүйцээж дундуурыг дүүргэнэ биз. Ер нь ертөнцийн хагасыг тэдэнд үлдээх нь зөв. Есөнтэй хөвүүн намайг орлон морийг чинь хөтөлж өргөөг чинь сахиж явна. Үүнээс илүү би юу хүснэ. Хөвүүнээ үзэв, дүү Сүбээдэй чамайг үзэв. Өвгөн болсон Боорчи,Мухулай нөхрөө үзэв. Хаан таны дэргэд ирж гэгээн дүрийг чинь харлаа. Одоо би үхэхэд харамсах зүйлгүй болов. Амьд явах цөөн хэдэн хоногийг минь Хаан эзэн та авагтүн. Би одоо амьдарч ханав гэсэн нь Зэлмийн сүүлчийн үг байжээ.

Түүний энэ үгэнд сэтгэл хөдөлсөн тэд удтал дуугүй суув. Зэлмийг гэнэт амьсгаагүй болсныг Боорчи түрүүлэн мэдэв.

Зэлмэ нэгэнт амьсгал хураажээ. Гурван настай Зэлмэ хөвүүнээ Жарчудай дархан Тэмүжинг төрөхөд боол болгон бэлэглэснээс хойш тэд хагацсангүй билээ. Зэлмэ ингэж жаран найм наслав. Тэмүжин эзэндээ хиргүй үнэнч сэтгэлээр зүтгээд өнөөдөр дэргэд нь ирж үхэв.

-Хэлээ залгиж үхжээ гэж Боорчийг шивнэхэд бүгд түүний дэргэд сөхрөн суужээ.

Чингис хааны харамсал гэмшил хичнээн их байгааг түүний сул асгарах нулимс илчилж байв.

-Урианхайн сайн Зэлмэ чи элгийг минь эмтэлж яагаад үхэв. Чи үхлийг өөрийн дэргэж дуудан ирүүлэгч шидтэн байсныг би мэдсэнгүй явжээ. Хэн чам шиг ингэж чадна. Чи залуу насаа дурсаж ганц шөнө хуучилж суухгүй юунд ингэж яаран одов.

Чи амалсандаа хүрэлгүй юунд намайг орхив. Чи миний хойно үхэх ёстой бишүү. Чи яаж үхэхийг надад заалгүй юунд үхэв.

Чи үхлээс айлгүй түүнийг өөрийн эрхэнд оруулж чаддаг байжээ. Та нар харцгаа. Энэ хүн миний их улсыг байгуулаад амиа өргөв. Үүнийг бүү март. Та нарын өмнө Урианхайн Жарчудайн хөвүүн Зэлмэ хэвтэж байна. Бүх цэргийг жагсаагтун. Би Зэлмийн үхлийг өөрийн биеэр зарлана гэж Чингис хаан хашгираад бахардан унажээ. Зэлмийн үхэл ганц Чингис хааныг биш бүгдийг ихэд цочоожээ.

Зэлмийг яг үхсэн газарт нь гэртэй нь онголох зарлигийг Чингис хаан буулгаж ёсоор болгов.

Зэлмийн үхэлд цочирдсон Чингис хааны бие дахин чилээрхэж хэвтэрт орсон нь бүгдийг түгшээв.

Гэвч Чингис хааны бие чилээрхсэнийг нууцалж байв. Зэлмийн үхэл Чингис хааны үхлийн хоёрдох дохио байсныг тэр ойлгожээ. Мориноос унаж бэртсэн нь эргэн илаарших янзтай байсан ч Зэлмийн энэ гэнэтийн үхэл сэтгэл санааны тэнцвэрийг алдагдуулжээ. Чингис хаан одоо өөрийн үхлийг хүлээж байв. Зэлмийн энэ сайн дурын зоримог үхэл Чингис хааны үзэл бодлыг гүнзгий ихээр өөрчилжээ. Үхэхэд бас учир байжээ. Үүнийг Чингис хаан бодсонгүй ажээ.

Одоо Чингис хаан хэрхэн үхэх тухай бодох болов. Жамуха яах гэж хэрцгий догшноор цаазлахыг шаардаж байсан учрыг ойлгов. Яаж үхсэнээр нь хүнийг хэмжиж, үнэлж болох мэт санагдаад байлаа. Зэлмэ шиг хэлээ залгиж үхэхэд зүрх зориг, тэвчээрээс гадна олон жилийн дасгал сургууль хэрэгтэйг ойлгов. Олон жил хэвтэрт байхдаа сургуулилсаар Зэлмэ хэлээ залгиж чадах болсныг ч ойлгов. Бас Жамухын хүслийг биелүүлж хэлснээр нь далан агтны сүүлнээс зүүж алаагүйдээ ч харамсав. Жамухын үхэхийн өмнө хэлсэн үг санагджээ. ”Хүссэнээрээ үхэж болохгүй тийм цаг чамд ч ирнэ. Тэр цагт намайг ойлгох болно” гэж Жамуха хэлсэн билээ. Чингис хаанд яг Зэлмийн адил өөрийн дураар шийдсэн үедээ үхэх хязгааргүй их хүсэл төрж байв. Гэсэн ч бас үхэхгүй мөнх амьдрах хүслийг түүний их сүр, нэр төр оргилуулах тул тэрээр үхэл, мөнх амьдрах хүсэл хоёрын дунд сэтгэл хоёрдсоор байлаа. Тэнгэрээс ирүүлж буй үхлийн дохио дэндүү тод ойлгомжтой байгаа нь түүнийг үхэлдээ бэлдэхийг өөрийн эрхгүй шаардсаар байв. Харин нэгэн зүйлийн учрыг тод ойлгож авчээ.

Зэлмэ зүтгэн ирж дэргэд үхсэн нь өөртөө үлдсэн цөөн боловч хоног хугацаагаа түүнд үлдээснийг мэджээ. Хэрэв Зэлмэ ирж түүний орноос амиа өргөөгүй бол тэр үдэш Чингис хааныг үхэл авч одох байжээ. Ийм нэг учрыг мэдсэн нь Чингис хааныг яарахад хүргэв. Зэлмэ унаган боолын тангараг ёсоор эзэн Тэмүжинийхээ төлөө үлдсэн амьдралынхаа цөөн хоногоо зориулжээ. Нөхөд нь түүнийг үхүүлэхийг хүсэхгүй байгаад Чингис хаан туйлын ихээр уяран догдолж байв. Гэвч түүнд үхлийг ялах хүсэл оргилсон хэвээр ажээ. Өнөөг хүртэл зүдэрч байгуулсан хүчирхэг улс, их эрх мэдэл нь үхлийг ч болов дийлэх хүслийг оргилуулж тэр үхэхгүй юм шиг санахад хүргэжээ.

Чингис хаан болоод түүний шадрууд мөнх амьдрах арга замыг уйгагүй эрэн сүвэгчилж байлаа.

Тийм ч учаас Перс, Орос, Хятад газрын нэртэй зартай эмч домч, төлөгчдийг цуглуулан авчрав. Тангудын нийслэл Жинсинфу балгасыг бүслэж суух ахуйд Чингис хааны өргөөний дэргэд газар газрын зуу гаруй оточ мэргэд, ид шидэтнүүд цугларaад байв. Тэдний хэн нь ч

мөнх насыг амлаж чадахгүй байлаа

Тангудын бараг бүх хот балгас эзлэгдэн ганц Жинсинфу л үлджээ.

Тангудын нутагт Монголын цэрэг багтах шингэх газаргүй болсон тул Чингис хаан дараагийн төлөвлөснөө гүйцэлдүүлж эхлэв. Өгөдэйн цэрэг, Мухулайн цэрэгтэй хүч хавсран Алтан улсын Жишижоу, Линьтафу, Тажоу, Хэжоу, Сининь, Дэшюнь хотуудыг эзлэн авсанд Чингис хаан хөдөлж Алтан улсын Люнаньшань ууланд гарч зусав. Энд арай сэрүүн тул биеэ сувилан тэнхрүүлэхэд дөхөмтэй ажээ.

Чингис хаан хүссэндээ хүрч Люнаньшань ууланд байхад нь бүтэн сар бүслэгдэн сууж хамаг цэргээ алдсан Тангудын Буур хаан хөвүүд,хатад эмсээ дагуулан хотоосоо гарч ирж буун өгөв. Энэ мэдээг тэр даруй Чингис хаанд хүргэжээ. Буур хааны эцсийн бэхлэлт Жинсинфу балгасыг Цагадай бүсэлж суусаар байжээ. ”Буур хааныг өртөө газраас явган явуулж өдрийн газраас өвдгөөр мөлхүүлж үзэгдэх газраас элгээр хэвтүүлж надад бараалхуул. Тэр Чингис хаан намайг хэр удаан хүлээлгэснээ өөрийн зовлогоор үзэг” гэсэн Чингис хааны зарлигийг Гэрэг Цагадайд хүргэж иржээ.

Ингээд улсаа алдсан Буур хаан зуны аагим халуунд хатад хөвүүдээ дагуулан өртөө газраас явган алхаж өдрийн газрыг дөрвөн хөллөн туулж өндөр бэлийг элэглэн мөлхөж бараад гуйвж, дайвсан амьтад гурван өдрийн хойно арайхийн Чингис хааны хүрээний захад очив. Чингис хаан түүнийг шадар, хөвүүдийн хамт их өргөөндөө хүндэтгэлтэйгээр хүлээж байв. Өмссөн хувцас нь урагдаж өмнө бие нь нүцгэрсэн тэднийг тэр чигээр бараалхуулав. Харин замд Буур хааны хатад хөвүүд охидоос үлдсэн хоцорсон бүгдийг Гэрэг өөрийн гараар цавчин алжээ. Монгол болоод Тангуд улсын хооронд үргэлжилсэн хорин жилийн дайн ингэж Тангуд улсын бүрэн мөхлөөр дуусах өдөр ирж Буур хаан их үгнийхээ золиос болж явган нүцгэн мөлхсөөр Чингис хаанд мөргөв.

Буур хаанд үхэх хүсэл байсангүй.

Уг нь Монголын цэргийг дайран ирэхэд урьд хэдэнтээ аргалсан ёсоороо бэлэг сэлт өргөн бууж өгсөн бол Тангуд улс мөхөхгүй бас хэдэн жил болох байлаа. Гэвч Буур хаан хөөрүү, нэрэлхүү зандаа хөтлөгдөж бас цэргийн тоо олондоо эрдэн шадар түшмэлийнхээ ойворгон занд автан дэмий эсэргүүцсэн нь Тангуд улсыг мөхөөхөд хүргэж Алтан улс гол холбоотноо алдан баруун тал нь нүцгэрэн гар мухар болжээ.

Буур хаан өртөө газраас мөлхөн ирж улсынхаа тамгыг тушаасан нь Алтан улсад үхлийн дохио боллоо.

Буур хаан алтан тамгаа Чингис хаанд өргөн барив. Тангуд улсын төрийн тамгыг Тулуй хураан авчээ.

-Тангуд улсын Буур хаан би хаадын хаан Их Чингис хаанд Гэйхүү хатныхаа хамт мөргөж байна. Тангуд улсын эзэн дээдсээс өвлөн ирсэн шүтээн алтан тамгыг Танд өргөн ивээлд тань багтахаар ирлээ. Миний улс нэгэнт хүчинд автан Чингис хаан таны их улсын дээвэр доор бүтнээр орлоо. Хэрхэхийг Чингис хаан таны зарлиг мэдэг гэж Буур хаан Гэйхүү хатны хамт

мөргөжээ. Чухам ингэхийг Чингис хаан хүсэж Тангудын халуун нутагт бүтэн жил хагас тэвчин суусан билээ.

- Буур хаанд хэл.Энэ мөчөөс хойш Тангуд гэж улс үгүй болсон тул Тангуд гэж дахин бүү хэлэхтүн.

Улс чинь нэгэнт үгүй болсон тул Буур хаан нэрийг чинь өөрчилж чамайг Шударга гэж нэрлэе. Одоо чи нэгэнт миний албат болсон тул тэр баруун талд миний ач нарын дор суугтүн гэж Чингис хаан зарлиг болгов. Балчир ач нарын зүгээс хэн нэг нь жиг жиг хөхрөх сонсдоод чимээгүй болжээ. Навсарч цоорсон хувцастай Буур хаан үнэхээр гутамшиг, инээдтэй үзэгджээ.

Уг нь тэр ингэж доромжлогдож байхаар үхэх байжээ. Гэвч тэр амьд явахыг хүсчээ. Амьд явах хүсэл нь лав Тангуд улстай тэнцэж байлаа. Тэр өөрийн амийг бүтэн улсаараа арилжив. Удалгүй Монгол хуурч дуучид орж ирээд ая дуу өргөжээ. Энэ нь Тангуд улсын мөхлийн дуулал болон сонсдов. Шударга нэртэй болсон Буур хааны хатан Гэйхүү тэсэлгүй уйлжээ

.Алтан хааны гүнж энэ бүсгүй цэвэр үзэсгэлэнтэй нас залуу ажээ. Урт ёслол дуусав. Ийм урт ёслолыг зохиосон нь Тангудын Буур хааныг залхаан тавлах нэг арга байлаа. Ёслолын дараа Шударга хаан хүний ёсоор босож ингэж хүндэтгэл үзүүлсэнд талархан бөхийв.

-Шударга чи газар нутаг, тэмээ малаар арвин, шавар оромжинд шавалдан суугч тангуд иргэнийг надад дагаар оруулан амирлуулсанд би чамайг сайшаан шагнах ёстой юм. Би чамайг өөрийн үнэнч шадрын ёсоор үзэж өөрийн охин Тэнүүнбилэгийг чамд хатан болгон шагнан өгье гэж Чингис хаан хэлэв. Чингис хааны энэ үгэнд бүгд цочиж, Есүй хатан бараг муужран унах дөхжээ. Дөнгөж арван тав хүрч буй хамгийн хайртай, энхрий охиноо ингэж эсэргүүцэн тэмцээд эцэст нь ичгүүр гутамшигтайгаар бууж өгч буй дайсандаа шагнан өгсөн нь байж боломгүй доромжлол мэт ойлгомжгүй санагдсан ч хэн ч дуугарч түвдсэнгүй.

- Чиний үр удмыг миний шадрын үр удам гэж миний Алтан ургийн үр сад үеийн үед асарч явах болно. Чиний үр удам үеийн үед миний охин Тэнүүнбилэгийн боол болж босгоны дэргэд сууж зүтгэгтүн гэж Чингис хаан үргэлжлүүлэн зарлиг болгожээ. Тэнүүнбилэг охиныг уйлуулан авчирч Шударгын дэргэд суулгав. Есүй хатан арай л уйлсангүй. Чингис хааны энэ зарлиг олны дургуйцлийг төрүүлж байгаа нь илт байсан ч тэр огт анзаарч тоосонгүй.У

чир нь бүх хэргийг тэр нэгэнт дотроо аль эрт шийдэн тооцсон байжээ.

-Тэнүүнбилэг охин минь бүү уйл. Чи бол миний охидын дотроос ухаан эрдэм, уран гоолигоороо онцгой нь билээ.

Би энэ Шударгын гавьяаг үнэлж чамайг шиллээ. Би чамд хайртайн учир бас Есүй хатан эхийн чинь ухаан саруулыг, улсдаа зүтгэснийг үнэлсний учир би чамайг энэ Шударгад өгч байна. Чи энэ өдрөөс эхлэн Тангудын хааны хатны эдэлж байсныг эдэлж, өмчилж байсныг авагтун. Жинсинфү балгасыг эзэмшин суугтун. Тангуд иргэдийг захиран халамжлагтүн. Энэ өдрөөс эхлэн Тэнүүнбилэг чиний зөвшөөрөл зарлиггүйгээр тангуд иргэнийг хуваж зөөхийг би цаазлаж байна. Чи дайнд нэрвэгдсэн тангуд иргэдийг асарч тэднийг их улсдаа зүтгүүл.

Чингис хааны далд бодлыг сая л нэг ойлгож сонссон бүгд инээмсэглэн царай тэнийлгээд Есүй хатан амьсгаа авч нулимсаа арчжээ.Шударга бүр ч сэтгэл ханав. Чингис хаан гэнэт өөрийн хайртай охиноо өгсөн нь Тэнгэрийн аврал болж сохорсон биш завшив гэдэг болжээ. Тийм учраас Шударга үсрэн босож Чингис хааны хөлд мөргөөд

- Чингис хаан таны ивээлд би сэтгэл ханав. Алтан урагт чинь багтаж авралд чинь шүтэж явахаа тангараглая гэж хашгирчээ.

Гэвч тэр дэндүү яарчээ. Харин Шударгын ийм хачин авирласанд Гэйхүү хатан нь тэвчиж эс чадаад өөрийн хэлээр нэг зүйлийг тэчьяадан зандарсан ч тэр эмийн бухимдлыг хэн ч тоосонгүй өнгөрчээ. Чингис хаан тааламжтайгаар инээмсэглэж байв.

Сэтгэл нь үнэхээр тэнүүн сайхан болжээ.

-Шударга чи сонсож бай. Хэн боловч зүтгэлийн хирээр харамж хүртэж, нүглийн хирээр гэсгээл амсахыг би Тэнгэрийн зарлиг гэж санана. Тийм учраас Шударга чиний гавьяаг үнэлэв. Харин би чиний өдүүлсэн ялыг тоочье гэвэл нэгэнт өөртөө итгэлтэй болж хуурсан Шударга

-Би таны чин шударга үзлийг бахдаж байна гэж бөхийв.

Чингис хааны сэтгэлд олон жил хадгалагдан эссэн аймшигт хорслын төгсгөл ойртож байгааг Боорчи гадарлаж байв.

Чухам үүний учир Тангудад алгуурлан суусныг ч ойлгов. Хорсол заналаа тайлж өшөө авах үедээ Чингис хаан хэрхэн аз жаргал дүүрэн болохыг тэр харж байлаа.

-Чи намайг олон жилийн өмнө Хорезмд морилохдоо нэг замын цэрэг гарга гэхэд "Хүч хүрэхгүй бол дайнд мордох хэрэг юун" гэж их үг хэлээд тоомсорлосонгүй ял хийжээ. Бас өнгөрсөн намар цэргээ татаж бууж өг гэхэд үл тоон Аша хамбыг илгээн үлэмж цэргийн амийг сүйтгэв. Энэ хоёр гэмд чинь ямар ял олгохыг чи хэл гэж Чингис хаан зандрав.

Хэлмэрч даруй орчуулан хэлэхэд Шударгын царай зэвхийрчээ.

-Чингис хаан та болгоо.Таныг Хоремзд морилоход би хаан оронд нэгэнт суугаагүй байсан билээ.Тэр их үгийг Аша хамба жанжин хэлснийг би сонссон. Харин өнгөрсөн хавар Аша хамба л цэрэг хөдөлгөн эсэргүүцэхийг шаардсанд би түүнийг ятгаж дийлээгүй билээ. Энд миний хамаарах хэрэг гэж юу байх билээ гэж өөрийгөө өмөөрөв.

-Би чамтай танай улсын үйлдсэн ялыг хэлэлцэж байна. Танай улс надтай эртнээс дайсан болов. Бүр эртнээс та нар миний дайсан Сэнгүмийг ивээн орогнуулж ирсэн. Бас дагаж ороод найрамдсан мөртөө Алтан улстай эвсэн тэдний самууныг дэмжиж Мухулайтай дайтаж байсныг сануулъя. Чи хаан хүн тул улсынхаа ялыг үүрэх ёстой. Үүний тулд хаан суудаг юм.

Хаан сууна гэдэг ямба эдлэхийг биш ял үүрэхийг хэлдэг гэдгийг чи мэдэж ав.

-Би бүтэн улсын урьд өмнийн хаадын ялыг үүрэх нь шударга бус болно. Би үүнийг хэрхэвч

зөвшөөрөхгүй гэж Шударга орилов. Гэвч тэр оройтжээ. Түүний үхэл нэгэнт иржээ.

-Шударга чи бүү балмагд. Энд чиний зөвшөөрөл хэрэг болохгүй. Санаа бүү зов. Нэгэнт танай улсаас миний өмнө үйлдсэн нүгэл их тул би чамайг цаазаар аваачна. Хаан хүн гавьяа ч эдлэх, гай ч үүрэх ёстой юм. Чиний өдөөсөн дайнд үрэгдсэн олон олон тангуд иргэний сүнс баярлах биз. Үүнийг одоо хороо гэж Чингис хаан зарлиг болгомогц Гэрэгийн торгон цэрэг ухасхийн орж ирээд Шударгыг барьж авчээ.

-Наадахаа хаан хүний ёсоор цусгүй үхүүл. Хүндтэй оршуул гэмэгц Шударгад дахин дуугарах сөхөө өгсөнгүй.

Айсандаа болоод Шударгын шээс савиран урсахыг бүгд харав. Торгон цэргүүд түүний нурууг даруй хугалж алаад чирч одов. Гэйхүү хатан бархиран уйлж гарч гүйжээ. Чингис хааны энэ гэнэтийн үйлдэл бүгдийг гайхуулж бас Тэнүүнбилэг охиноо Шударгад өгсний цаад учир тодорсон нь олныг бишрүүлжээ.

-Харин тэр Шударгын эмийг бүү хоригтун. Хаа хүртэл гүйх юм бол үзье. Эрээс зугатаад эм хүн хаа холдоно. Их сайндаа Хөх нууранд үйж үхнэ биз гэж Чингис хаан хөхөрчээ. Үнэхээр эр нь нүдний өмнө үхэхийг харсандаа ухаан самуурсан Гэйхүү хатан Хөх нууранд үйж үхжээ.

Хайртай Тэнүүнбилэг охиноо Тангудын хааны сууринд суулгасан Чингис хааны ухаанд Есүй хатан биширч талархалтай байгаагаа илэрхийлж инээмсэглэн ёсолжээ. Есүй хатнаа баярлуулья гэж бодсоор яваад сая л нэг санасандаа хүрсэндээ Чингис хаан ч баяртай болжээ. Хэрэв Гэйхүү хатан үхээгүй бол түүнийг Тулуй хөвүүндээ өгье гэж Чингис хаан бодож байжээ.

Гэвч бүх юм санаснаар болсонгүй тэр эм үхсэнд ихэд гонсойжээ. Харин Тангуд иргэнээс Есүй хатан болоод Боорчи, Мухулай хоёрт түм түмийг өгөв.

Тэнүүнбилэг охин нь Тангудын хааны ордонг эзлэн сууж суурин тангуд иргэдийг захирах болов.

Чингис хааны энэ зарлигийг хэн ч эсэргүүцсэнгүй ч Тангудын нутгийн ихэнхийг эзлэн авсан Цагадай, Өгөдэй хоёрт таашаагдсангүй билээ. Ингэж Тангуд улс мөхөв.Одоо Их Монгол улсын өмнөд хил Хималайн их уулстай нийлжээ.

Чингис хаан Тангудыг өөрийн санаснаар мөхөөсөндөө бахдаж хөөрөөд сэтгэл нь олзруугаа үсрэхээр булчин шөрмөсөө хураасан ирвэсийн адил хөвчирчээ. Түүний сэтгэлд ялж дийлэх, эзлэн булаах их хүсэл түймэр мэт дүрэлзэн байлаа.

Тангудыг мөхөөсний их ялалтын бахдал хөөрлийн эрчээр тэр Алтан улсыг эзлэн авахыг хүсч байв.

Тангуд улс мөхсөн нь Алтан хааныг үхтэл айлгаж тэр нийслэлээ бүр дорно зүг рүү нүүлгэсэн мэдээг тагнуул хүргэж иржээ.

Алтан улсын мөхөл нэгэнт иржээ.Одоохондоо Сүн улстай эвдрэлцэх нь ашиггүй тул Тангуд улсыг мөхөөсөн тухай мэдэгдэх элчийг их бэлгийн хамт Сүн улсын хаанд дахин илгээв. Энэ бол Сүн улсын нутгаар дамжин Алтан улсыг санаандгүй байгаа талаас нь цохих бэлтгэл байв. Алтан улс хойт хил дээрээ хамаг цэргээ татсан нь Чингис хааныг өмнө болоод баруун талаас довтлохгүй гэж санасных байв. Ийм цагийг ашиглан Алтан улсыг гэнэгүй талаас нь довтлохоор Чингис хаан шийджээ.

Түүний ууараг тархи ийм эрч хүчтэй, цэцэн цэлмэг байгаагүй мэт санагдана. Сүүлийн хэд хоногт урьд өмнө нь ойлгож мэдээгүй байсан олон чухал учрыг тодруулан ойлгожээ. Ингэж оюун ухаан нь хэт сэргэг цэлмэг болсон нь үхлийн гуравдах дохио болохыг тэр ойлгохгүй байв. Харин ч эргээд илааршиж байна гэж хууртан бодож ялах дийлэх их хүсэлд автжээ.

Түүнд ялалт амжилт нь тод харагдаж байв.

Тэр өөрийгөө үхэхгүй гэдэгт дахин итгэлтэй болжээ.

*****

Батын дагуулууд дунд ирсэн нэг хүнийг хэн болохыг таниад Чингис хаан ихэд цочирдон гайхжээ. Тангудыг мөхөөсөн их баярын дунд Батын дэргэдээс алхам холдохгүй сүүдэр мэт даган явсан хүн бол Зүчийн боол Тату байв.

Нүүрний нь баруун тал түлэгдэн шатаад аймшигтай таталдан эдгэсэн Тату нэг хажуугаас нь харвал цоо эрүүл хүн шиг нөгөө сорвитой талаас үзвэл чөтгөр шулам мэт ажээ. Ингэж нүүр царай нь өөрчлөгдөж хувирсан Татуг танимагц Чингис хаан Боорчийг дуудав.

Нэгэнт үхсэн гэж бодож итгэж явсан Тату амьд төдийгүй Батыг дагаж ирсэн нь Чингис хааныг хилэгнэхэд хүргэв.

Тату аль эрт үхэх ёстой байжээ. Чухам Алтан улсад өөрийн хүчээр цэрэглэн орохоор шийдээд нутаг буцсан Хасарыг хэнд ч сэжиг авахуулахгүйгээр алж чадах хүн бол Тату гэж Зүчи үзсэн билээ. Хасар юу сэдэж, тэгээд юуны учир түүнийг хөнөөх хэрэгтэй болсныг Чингис хаан өөрөө Зүчид хэлжээ. Түүний ярихыг Зүчи дуугүй сонсож суусан билээ.

- Ийм хүнд бэрх хэргийг ууган хөвүүн чамд итгэн даатгахаас өөр арга надад үгүй юм. Чамаас өөр итгэлтэй хүнийг би олохгүй биз гэж Чингис хааныг хэлэхэд Зүчийн нүд баяр бахдал, омог зоригоор дүүрэн гэрэлтэхийг Боорчи харж байжээ. Чингис хаан нэг сумаар хоёр туулай буудахаар шийдсэнийг Боорчи сая л ойлгов. Хасарын үхлээр Зүчийн алдагдсан итгэлийг буцаан олохыг тэр хүсчээ. Эзэнт улсынхаа төр, их хааныхаа өөдөөс тэрсэлсэн хэн боловч үхэх үйлтэйг Зүчи ч ойлгон эцгийнхээ үгийг шууд дэмжив.

Алтан улсын зүүн хойт нутгийг эзлэн сууж өөрийн улсыг байгуулах гэж Хасар авга нь шийдсэн нь их гэрийн зүүн ханыг буулган зөөсөнтэй утга нэг болох тул Зүчи эцгийнхээ шийдвэрийг зөв гэдэгт огтхон ч эргэлзээгүй бөгөөд энэ нууц бөгөөд чухал хэргийг түүгээр итгэн гүйцэлдүүлэхээр болсон нь Чингис хаан түүнд бусдаас илүү итгэж байгаа хэрэг гэж үзэн баярлажээ.

Харин Хасарыг хэрхэн хэл амгүй үхүүлэхийг Чингис хаан хэлсэнгүй билээ. Зүчи, Боорчи хоёр зөвлөлдөөд Зүчийн хэлсэн ёсоор хийхээр болж Чингис хаанд айлтгасанд тэр зөвшөөрчээ. Ингээд Зүчи, Хасарын их хатан Борогчины дүү, өөрийн боол Татуг дуудан ирүүлжээ. Тату, Зүчи эзнийхээ зарлигийг ганц үг ган хийн эсэргүүцсэнгүй.

Амийг нь аварсан эзний үг Татуд Тэнгэрийн зарлиг билээ. Тату Хасарыг хадам ах минь ч гэж бодсонгүй. Яагаад түүнийг үхүүлэх болсныг асуух эрх бас сонирхол ч байсангүй. Хасарын өргөө гэрт орж гарахад хэн ч сэжиглэхгүй цөөхөн хүний нэг бол Тату гэдгийг Зүчи сайн мэдэж байв. Хасар, Борогчин хоёр Татуд ихэд сайнаар ханддагийг ч тооцжээ. Хэрэв хэрэг илэрч мэдэгдвэл Тату хэргийг задлахгүйгээр үг дуугүй үхнэ гэдгийг ч мэдэж байв. Энэ учрыг ч Зүчи түүнд хатуу хэлжээ.

Зүчи эзнийхээ төлөө амиа өгөх нь Татугийн эрхэм дээд хүсэл, түүний ачийг хариулсан хэрэг болно гэж Тату харин ч баяртай болжээ. Гэвч Тату угийн зоригтой гавшгай хүн тул энэ бэрх хэргийг яаж хийхийг өөрөө сайтар бодож төлөвлөжээ.

Үнэхээр Татуг очоод буцсаны маргааш шөнө Хасар өргөөндөө үхээд хоносон билээ.

Замаас эргэн шөнө буцаж очоод Хасарын өргөөний гадна харуулыг ховсдон унтуулаад өөрийн хүссэнээр хийж орхисныг хэн ч мэдэж сэжиглэсэнгүй. Тэр бүү хэл зүүн хавирганы завсраар шаааааасан хулсан зүүний орыг хэн ч үзэлгүй өнгөрчээ.

Уулын модонд хүлээж байсан Зүчи, Татуг дагуулан буцжээ.

Харин ингэхдээ Татуг үхүүлэх Чингис хааны зарлигийг биелүүлсэнгүй ажээ.

Чингис хаан Хасарын үхлийн шалтгааныг хэн нэгэн илрүүлэн дэлгээсэй гэж хүсээгүй тул Татуг үгүй хийх зарлиг буулгасан бөгөөд Зүчи ёсоор болгосон гэж хэлсэн атал өнөө Тату амьд явахыг үзээд ингэж хилэгнэсэн билээ.

Гэхдээ хэргийн гол нь Татуг амьд үлдээсэнд биш болохыг Чингис хаан ойлгож байв. Хамгийн гол учир нь тэр нэгэн өдөр Хасарын хэлсэн үгэнд байсан билээ. Татуг үзээд өнгөрсөн тэр явдал санагдсан нь Чингис хааныг аймшигтайгаар хар даран зүүдэлж байх шиг болгожээ.

Чингис хаан тэр өдрийн явдлыг яагаад ч мартаж тайвширч болохгүйг Татуг үзмэгц ойлгожээ.

...Хасарыг орж ирмэгц түүний сэтгэлийн хөдлөлийг Чингис хаан тод харжээ. Энэ явдал Хорезмыг дайлахаар шийдсэн Их хуралдайн дараахан болжээ.

Хасар Чингис хааны дайллага хүндлэлд тушигдан ам нээж төвдсөнгүй хэсэг зуур болов. Хүнд хэцүү яриа болохыг ах дүү хоёр хоёул мэдэж сэтгэл түгшиж байлаа. Хасарын үр удмыг алтан урагт үл тооцон Их Монгол улсын хаан сууринд суух эрхгүй болгосон зарлиг нь энэ байтугай хэцүү бэрхшээл учруулахыг Чингис хаан нэгэнт тооцсон тул Хасарын юун тухай ярихыг таамаглаж байв. Харин энэ удаа тэр түрүүлж дуугарахыг бодсонгүй.

Түүний үг Хасарын сэтгэлийн бухимдлыг цочроож мэдэх билээ. Тийм учраас Чингис хаан огт

өөр зүйл хүүрнэж ажиггүй суужээ. Бас дээр нь Хорезмд цэрэг оруулахыг Хасар эрс эсэргүүцсэн нь тэднийг хэрэлдүүлэх нэг сэжүүр болжээ. Чингис хаан яаж ч бодоод Хасарын юу гэж хэлж, юун тухай ярихыг таамаглаагүй ч ямартаа ч Хорезмд орох цэргийн нэг замыг Хасараар толгойлуун жаахан буулт хийж түүнийг тайвшруулах хуучин сайн аргаа сэдэж суужээ. Гэтэл яриа огт санаандгүй байдлаар эхэлжээ.

Хасар тийм ч удаан тэсвэрлэж чадсангүй. Түүний ингэж хүлээн тэвчсэн нь эрх биш Хаан ахыгаа хүндэтгэн бас болсон хэрэг явдлын талаар түрүүлэн үг хэлж түүнийг тайтгаруулах байх гэж найдаж байсных билээ. Гэтэл Чингис хаан тэр талаар огт үг хэлсэнгүй өөр зүйлийг ярьж булзааруулж байх нь ер өөрийн шийдвэрт эргэлзэж тээнэгэлзсэн шинжгүй Хасарыг хүн гэж тоохгүй байгааг илтгэжээ. Хасар ч юу гэж хэлж ярихаа олон өдөр бодож шийдсэн байв.

Харин Хасарын үг Чингис хааныг гайхуулахаасаа илүү айлгаж түгшээсэн билээ.

-Ахаа. Би танд Тэнгэрийн зарлигийг дуулгахаар ирлээ гэж Хасар тод хэлэв. Хасар Тэнгэрийн зарлиг гэж хэлж байхыг Чингис хаан хэзээ ч сонсоогүй тул энэ үгэнд цочиж огт таамаглаагүй яриа өрнөхийг мэдэрч яагаад юм бэ айжээ. Гэтэл түүнийг хамгаалах хэн ч үгүй тэд хоёулхнаа байсан нь ингэж айх шалтаг болов.

Гэвч хариу үг хэлсэнгүй.

-Тэнгэр нэгэнтээ зарлиг буулгаж Хасар намайг улсын эрхийг барина гэлээ. Би Тэнгэрийн зарлигийг дагахгүй байж яахан болох билээ. Харин би ах тантай өрсөлдөн эрх булаалдах гэсэн санаа өвөрлөсөнгүйгээр өнөөг хүрлээ. Өсөхдөө тавьсан тангаргаа би өнөө ч хүртэл санаж бас сахиж байна. Гэвч би Хаан ах таныг сандраахгүй, хамаг их улсаа бусниулахгүйгээр Тэнгэрийн зарлигийг дагахаар шийдлээ.

Хаан ах таны буулгасан зарлиг ёсоор Хасар би болоood миний үр удам Их Монгол улсад нэргүй, эрхэм дээд язгуургүй энгийн дорд сул иргэн мэт үзэгдэх боллоо. Би ах танаас сүүлдэж төрснөөс өөр ялгүй тул зүтгэн байгуулсан гавьяа минь Их Монгол улсад үнэлэгдэх ёстой гэж үзнэ.

Би өөрийн үр удмыг нэргүй явж гэргүй үрэгдээсэй гэж үл хүсэх тул энэ үгийг хэлж байна.

Та миний оронд байсан бас л ингэх бизээ. Би өнөөдрөөс хойш ах танаас ам асууж зарлиг сонсохгүйгээр явахаар шийдлээ. Надад өөрийн албат иргэд үнэнч цэргүүд бий. Би энэ бүхнийг бүлээн цусаа урсгаж бүтэн биеэ үрэн явж олжээ. Би Хаан ах таны хамаг их улсыг сандраахгүй хаяа нийлэн явахаар шийдлээ. Нэгэн цагт би Хаан ах таны зарлигаар Зүрчидийн Алтан улсын зүүн хойд нутгийг эзлэн хураасан билээ.

Одоо би тэр нутгаа эзэмшин сууж өөрийн улсыг байгуулья. Өргөн их улсын чинь зүүн хилийг сахиж, зэрэгцэн эв найртай явья. Би эзэлсэн улсаас цэрэг нэмэн дайчилж Алтан улсын үлдсэн нутгийг хураан авч нэгэн цагт бидний өвөг дээдсийг тамлан хороосон Алтан улсаас өшөө авч дуусгая. Есүхэйн хоёр хөвүүний байгуулсан хоёр их улс зэрэгцэн оршиж үр удам минь мөнхөд та биднийг залгамжлан бидний нэрийг дуурсган суувал бид Тэнгэрийн зарлигийг дагасан хэрэг болно.

Түмэн үеийн бахархал болох биш үү. Хасар өөрийн үгэнд хөөрөн догдолж бүр босож зогсчээ. Чингис хаан ч босов.

Тэд яг л тулалдах гэж байгаа мэт хэрэн зогсчээ.

-Ах та баруун зүгт уужуу тайван явж их газрыг эзлэн авах хэргээ ардаа санаа зовох зүйлгүй гүйцэлдүүлэгтүн.

Харин би өөрийн улсын хүчээр Алтан улс болоод Солонгосыг эзэлж харин дараа нь хоёул хүч хавсран Сүн улсыг зэрэг дайран мөхөөе. Ингэвэл энэ газар бүхлээр та бид хоёрын гарт орох үүд нээгдэнэ. Бид одоо хүчтэй болжээ. Хамаг хүчээ ганц зүгт зарж алгуурлан цаг алдалгүй зэрэг явж ихийг эзэлье. Энэ нарны дор Есүхэйн хөвүүдийн хоёр их улс зэрэгцэн оршихыг үзээд эх эцэг хоёр минь баярлан жаргах бус уу.

Би тавь гартлаа Тэмүжин ах танд зүтгэв. Одоо үр хүүхдийнхээ төлөө зүтгэх цаг минь иржээ.

Хаан ах та, Тэмүгэ дүүг албат цэргийн нь хамт надад өг. Би Хаан ах танд зүтгэсэн шиг Тэмүгэ надад зүтгэг. Би түүнд өөрийн улсад их эрх олгож өөртөө хавсруулья.

Бас Мухулайг надад өгөгтүн. Тэр Алтан улстай байлдах их туршлагатай тул би түүний хүчийг авахыг хүсч байна.

Өөр хүсэх зүйл надад үгүй. Би таны амийг хэдэнтээ аварсан гавьяатай хүн. Хаан ах та зарлиг буулгаж Их хуралдайг зарлаж миний тусгаар улсыг ил тодоор тунхаглаасай гэж би хүснэ.

Миний улсыг хаан таны зарлигаар Хасар их улс гэж нэрлэе. Хаан ах та энэ бүхнийг өөрийн зарлигаар батлан тунхаглах аваас сая Тэнгэрийн зарлиг болох билээ. Олон жилийн өмнө Хасар чамайг улсын эрхийг барина гэж Тэнгэр хэллээ гэж Хөхөчүгийн хэлсэнд би ихэд уурлаж Тэмүжин ахтай эвдрэлцүүлэн алалдуулах муу арга сэдэв гэж санасан билээ. Ах та ингэж санасныг би мэдэж байна. Гэтэл Тэнгэрийн зарлигт намайг Хаан ахтайгаа өрсөлдөн тэмцэхийг бус өөрийн тусгаар улс байгуулахыг хэлжээ. Би үүнийг саяхан л ойлгож мэдэв. Газар орон ийм уудам байхад ах та бид хоёр зэрэгцэн сууж зөрөлдөн тэмцэхийн хэрэг юун.

Та бид хоёр их улсыг байгуулвал энэ ертөнц бүхэлдээ Есүхэйн хөвүүдийн мэдэлд хураагдах болно. Чухам энэ тухай Алангуа эхийн тухай болоод Буянтай өвгөний тухай домогт дурдсаныг мэдээд Өүлэн эх маань бидэнд өгүүлжээ.

Энэ домгийг үнэн болгох цаг одоо нэгэнт ирэв гэж хэлээд Хасар сая л нэг тайвширчээ.

Чингис хаан хойморт зогссон чигээр бодолд автжээ.

Хасарын хэлсэнд ер эвгүй хорон санаа эвдрэлцлийн шинж илэрсэнгүй. Бас яг Хасарын хэлснээр ингэж хийх нь зүйтэй мэт санагдсан билээ. Хасар өөрийн улсыг байгуулвал болохгүй юмгүй бас тэр ингэх эрхтэй юм .Тэр нэгэнт ингэж шийдсэн бол Хасарт хэн ч саад хийж чадахгүй хэрэг байв.

Ийм зорилго, үнэн зөв шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцэх өчүүхэн төдий шалтаг тэр үед

Чингис хаанд олдсонгүй тул

-Хасар чи зөв боджээ. Тусгаар их улс байгуулахыг санасан чинь сайн хэрэг болжээ. Чи ч үүнийг чадах билээ.

Би Их хуралдайг хуралдуулж зарлиг буулгая. Чи өөрийн улсыг хэлснээрээ нэрлэгтүн.

Харин Их хуралдай хуралдаж намайг зарлиг буулгатал энэ бүхнийг чандлан нууцлах нь зөв. Цагаан хэл ам хүрч болно.

Дүү чиний тусгаар улс байгуулах хүслийг хорон санаатан ашиглаж биднийг эвдрэлцэв хэмээн мушгин гуйвуулж мэдэх тул би ингэж бодов гэж хэлсэнд Хасар түүний үгийг сайшаан зөвшөөрч баяр хөөр дүүрэн нутгаа зорьсон билээ.

Дээрх үгийг Чингис хаан үнэн сэтгэлээс бүр яг ингэж хийхээр шийдсэн мэт хэлсэн билээ.

Гэвч Хасарт хэлсэн үг нь түүний их хүсэл, үйлийг түр хугацаагаар саатуулж цаг хожсон төдий арга болоод өнгөрөх учиртай байжээ. Хасарт яав ч тусгаар улс байгуулах эрх олгож болохгүй байв. Чингэвээс зовж байгуулсан улсаа эвдэн нураасантай үлгэр нэг болох юм. Зөвхөн нэгтгэж нэг гарын дор захируулахыг хүсэж зүтгэсээр ирсэн мөртлөө Хасарын хатуу үг, хар зоригоос айж эцэст нь их зорилгоосоо ухрахыг тэр хүссэнгүй.

Хасарт тусгаар эрх өгвөл Тэмүгэ болоод Хачиуны үр удам юу гэх вэ. Энэ газар орныг нэгтгэхгүйгээр амар амгалан оршиж чадахгүй гэж Чингис хаан үзэх тул Хасарын үйлдлийг газар авахуулахгүй зогсоохоос өөр зам олсонгүй.

Өөрийн их улсын ирээдүйн энх амар амьдрал, бүрэн бүтэн оршин байх нөхцөлийг хамгаалахын тулд салан тусгаарлах гэсэн хэнийг ч болов найр тавин өршөөхгүй байх ёстойг тэр ойлгосон билээ. Үүнээс үүдээд Хасарын тэрхүү зоримог хүсэл зорилгыг үл тэвчин бухимдах болж яарч тэвдэх нь нэмэгджээ.

Хасар түүний зарлигийг хүлээлгүйгээр Алтан улсад довтлон орвол юу болох билээ. Эсвэл өөрийн улсыг дур мэдэж тунхаглан зарлавал яана гэж бодохоос байж суухын аргагүй болжээ. Хасар чухамдаа яг Тэв Тэнгэрийн адил түүний сэтгэлийн доторх дайсан болжээ. Түүнтэй илээр тэмцэлдэн булаалдах нь босгосон улсаа нураасантай адил агаад Их Монгол улсын дотор Чингис хаанаас гадна Хасар шиг эрх мэдэлтэй бөгөөд өөрийн хүчирхэг цэрэгтэй хүн нэг ч үгүй байсан нь Чингис хааныг мухардуулж байв. Бас Хасарыг шууд эсэргүүцэж түүнтэй эвдрэлцэхгүй аятай үг хэлэн аргалан тайвшруулж явуулсан нь зөв болов гэж Тэнгэрт талархан мөргөжээ.

Хасарыг нэг удаа улсын эрх барина гэж Тэв Тэнгэр бөө үнэн хэлжээ гэдэгт Чингис хаан дахин итгэв.

Иймээс хэлсэн үг, амласан зүйлд нь Хасар итгэж тайвшраад буй чухам энэ цагт л түүнийг нэгмөсөн үгүй хийх нь ганц зөв зам гэж Чингис хаан эргэлтгүй шийджээ.

Яг энэ үед Боорчи Алтайн өвөр дэх хүрээнээсээ Чингис хааны хүрээнд ирсэн нь Тэнгэрийн таалснаар болов гэж Чингис хаан баярлажээ.

Хэрэг явдал Чингис хааны санаснаар болж тэр өөрийн улсыг бутрах аюулаас сэргийлж Хасарыг хэл амгүй үхүүлж чадав.

Гэвч тусгаар улс байгуулах хүсэл ганц Хасарт байгаагүй нь лавтайг тэр таамаглажээ. Иймээс салж тусгаарлах гэсэн хэнийг ч болов эзэнт улсын эв нэгдэл, их зорилгынхоо дайсан гэж үзэж өршөөхгүй байхаар Чингис хаан эргэлт буцалтгүйгээр шийдэж хожим хойшид зарлиг болгон хэрэгжүүлэхээр тогтжээ. Энэ бол зөвхөн ганц түүний бодол биш шадрууд нь ч дэмждэг Их Монгол улсын төрийн бодлого болсон байлаа. Гэтэл ийм нууц чухал хэргийн амьд гэрч үлдсэнийг үзээд өнгөрсөн тэр эмзэг явдал эрхгүй санагдан Чингис хаан цочиж хирдхийсэн нь энэ юм.

Бас Зүчи түүний зарлигийг биелүүлэхгүй байсан нь ганц Хорезмд болсон хэрэг биш гэдэг нь тодорхой болсон бөгөөд энэ явдал түүнийг гунигт бодолд автуулжээ. Түүний үг, зарлигийг Тэнгэрийн зарлиг адил олон бүгдээр үг дуугүй биелүүлэн дагадаг гэж итгэж явсан нь худал болохыг үзээд цочирдон хилэгнэж Боорчийг дуудсан билээ. Зүчийн буруу үйлдлийг Боорчи үүрэх ёстой гэж Чингис хаан үзжээ. Чингис хааны ааш авир, аливаа мэдрэмж нэн хурц болсныг ажигласан Боорчи түүний хилэгнэхийг үг дуугүй хүлцэн сонсож байв. Тавин жил тохой салалгүй зүтгэсэн энэ хугацаанд Чингис хаан анх удаагаа Боорчид ийнхүү хилэгнэсэн учрыг ч Боорчи таамаглажээ. Бас Чингис хааны хартай, болгоомжтой занг шүүмжлэн гайхаж суув.

-Чи тэр боолыг дарай үхүүл. Харин Бат, Хасарын үхлийн талаар сэжиг авч мэдэх тул болгоомжтой байгтун гэж Чингис хаан жаахан тайвшраад хэлжээ.

Ерөөс Чингис хаан өөрийгөө буруутгахыг үл хүсэх тул аливаа явдлыг нууцлах зантай байсан нь насны эцэс ойртож өвгөрөх тусам гүнзгийрээд бүр сүүлдээ хардаж сэрдэх, хааж нууцлахын дон болон хувирчээ. Үүнийг Боорчи мэдэх тул түүний зарлигийг үг дуугүй хүлээн авав.

Боорчи тэр даруй Баттай уулзжээ. Бат Боорчийг эцгийнхээ адил нэн их хүндэтгэх тул асарт нь өөрийн биеэр морилон ирсэнд нь хөөрч баярласан билээ. Боорчийг очиход асрын үүдэнд өнөө үйлт Тату чөтгөр царайлан зогсож байв.

-Энэ Тату чамд тийм их үнэтэй хүн үү гэж Боорчи үгийн далимд асуув. Учир нь Татуг Батад өгсөн учрыг, бас Тату эцэг хүү хоёрт хэрхэн зүтгэж байсныг Боорчи мэдэх тул болгоомжилж байв.

Харин Бат, Боорчийн ийн сонирхсоныг огт өөрөөр тааварлаж эхлээд Мухулайн адил Татуг худалдан авахыг хүсч байна гэж ойлгожээ.

-Энэ Тату бол Зүчи эцгийн минь зүрх юм гэж хэлсэн Батын сүржин үгийг сонсоод Боорчи туйлын их гайхжээ.

Гэвч Чингис хааны зарлигийг зөрчих эрх байсангүй. Бас Татуг заавал үхүүлэх учиртайг ч Батад тайлбарлаж ойлгуулах арга олдсонгүй.

-Бат. Чи энэ боолоо нутаг руугаа даруй буцаа гэсэнд Бат их гайхжээ.

-Чингис хаан энэ боолын аймшигт царайг үзээд нүднээс нь далд оруулахыг надад тушаав. Чи одоо түүнийг явуул. Би Чингис хаанд нүднээс далд болгов гэж айлтгая гэж Боорчи шууд тулгав. Татуг үхүүлэх гэвэл түүн шиг хялбар зүйл үгүй ч ингэх хүсэл Боорчид огт төрсөнгүй нь гайхалтай. Тату шиг үнэнч боолыг олоход бэрх, бас түүнийг үхүүлэхийг Бат хэзээ ч үл зөвшөөрөхийг сая анзаарч мэдсэн тул түүнд үүнээс өөр арга олдсонгүй билээ. Харин Бат хэргийн учир зөвхөн Татугийн түлэнхий нүүрэнд ч биш, цаана нь огт өөр эмзэг шалтгаан байгааг ойлгожээ. Тийм биш бол Боорчи сайд ингэж өөрийн биеэр заларч ирэхгүй билээ. Боорчи яаж ч дүйвүүлээд түүний ийнхүү хүрч ирсний гол учир нь Тату болохыг Бат мэдэрч байсан ч асууж төвдсөнгүй.

Боорчийн хэлсэн ёсоор тэр даруй Татуг буцаав. Харин Боорчи Чингис хаанд

-Татуг нүднээс далд болгов гэж айлтгажээ. Харин Чингис хаан огт хариу хэлсэнгүй нь түүний хилэн дарагдаагүйг гэрчилнэ.

Загасан нүдэт Тату Тэнгэрийн авралд багтсан хүн болохоо дахин баталж гуравдах удаагаа ингэж үхлээс аврагдав.

Ургенчид галд шатан үхдэгийн даваан дээр Батын тушаалаар эвдсэн далангийн ус оволзон ирээд галыг унтраасан ч Тату сувгаар урсан холд хаягдсан билээ. Тал бие нь шатсан Татуг нутгийн гэмгүй түрэг иргэн олж асарч аварчээ. Тэр түрэг хүний оромжинд нэрээ бас хаанахын хэн гэгч болохоо санатлаа Тату жил гаран элий балай хэвтсэн билээ.

Татуг буцсаны дараа Бат, Сүбээдэй хоёр явах хүсэлтэй байгаагаа Чингис хаанд айлтгасан нь түүнийг бодолд оруулжээ.

Үнэхээр ч Бат, Сүбээдэй хоёр буцах хэрэгтэй нь тодорхой байв. Зүчийн улс эзгүй үлдээд даруй хэдэн сар болсон тул ингэхээс өөр аргагүй юм. Харин буцах тухай үгийг Сүбээдэй биш Бат хэлжээ. Чингис хаан Сүбээдэйг дуудан зөвлөлдөв.

Зүчийн улсыг хөвүүн Батад нь өвлүүлэн үлдээхийг Сүбээдэй зөвлөөд Батын тухай сайхан үг хэлж түүнийг улсаа авч явж чадахыг баталжээ. Бат тэгэхэд дөнгөж арван найман нас өнгөрч байсан билээ.

Сүбээдэйтэй ийнхүү зөвлөлдсөний хойно Чингис хаан эргэлзэх зүйлгүй болжээ. Бат ч үнэхээр яарч байв. Учир нь Чингис хааны зарлигийг дагаж Алтан ордноос мордох үед хайртай Герта хатан нь бие тулгар байсан бөгөөд одоо төрөх нь хэзээ мөдгүй болсон тул хөвүүн төрүүлээд байгаасай гэж ихэд хүсч байлаа. Чингис хаан Батыг буцахаар шийдсэнийг сайшаасан агаад харин энэ тохиолдолыг ашиглан сүүлийн сард бодож тогтсон нэгэн хэргийг гүйцэлдүүлэхээр шийдэв. Энэ бол өнөө хэр эзлэн нэгтгэсэн их улсаа хөвүүддээ хуваан эзэмшүүлэх явдал байв.

Тэдний эзэмшин суух нутаг орныг өөрийн зарлигаар шийдэн бататгаж хуваан өгөх нь хожим хойшид өөр хоорондоо хомголзон хэрүүл зарга үүсгэх, эвдрэн булаалдах муу үйлийн үндсийг нэг мөр үгүй болгоно гэж тэр итгэх болжээ. Нэгэнт болох үйлээс тойрч гарах аргагүй гэдгийг ч ойлгожээ. Биеийн байдлаа бодвол ерөөс хөвүүдтэйгээ, тэр дундаа Баттай дахин уулзаж учиртай үгийг хэлэлцэх боломжгүй болохыг гэрчилж байсан нь бас ингэж шийдэхэд нөлөөлжээ. Чингис хаан ийн шийдэхийн өмнө олон талаас нь шигшин бодож шинжин үзээд өөрийн шийдвэрийн зөв бурууг нягталсан билээ. Шадар нөхөд нь бүгд нэгэн дуугаар сайшаав. Өөрөө мэрэглэн үзвэл таатай сайхан төлөг буужээ .Бас урьд шөнө зүүдээ манаж хоновол Өүлэн эх нь залуу үзэсгэлэнтэй дүрээрээ Есүхэй эцгийг нь их аянаас ирэхэд уяан дээрээ угтан тосож байна гэж зүүдлээд бүр ч баясан итгэжээ.Тэр эцэг эх хоёроо хамт байгаагаар огт зүүдлэж байгаагүй бөгөөд ингэж зүүдэлснээ түүний шийдвэрийг Өүлэн эх, Есүхэй эцэг нь талархан дэмжиж байгаа хэрэг гэж боджээ.

Өглөө нь Люньаньшань ууланд үүл хуралдаж солонго татсан байлаа.

Энэ бол Тэнгэр түүний шийдвэрийг сайшааж буйгийн дохио байсан тул нэгэнт эргэлзэх зүйлгүй болоод Цагадай, Өгөдэй,Тулуй хөвүүдээ Зүчийн хөвүүн Батын хамт дуудан ирүүлжээ. Өргөөнд тэд хүлээж байтал Чингис хаан орж ирэв.

Түүний хамт Боорчи Мухулай, Сүбээдэй, Шихихутуг бас нас балчир гэлгүй Тулуйн бага хөвүүн таван настай Аригбөх хүртэл алтан ургийн бүх ач хөвүүд орж ирсэнд тэд их гайхжээ. Тэдний араас өөр хэн ч орж ирсэнгүй.

-Сууцгаа гэж Чингис хаан тушаав. Гэвч хөвүүд нь хэрхэн суух учраа олж цөхжээ.

-Бат чи эцгийнхээ сууринд суу гэж Чингис хааны хэлсэн нь хэргийн учрыг тайлах шиг болжээ.

Батыг зүүн талд Өгөдэй авгынхаа дор суу хэмээн Шихихутаг урихад өнөөдөр ямар нэгэн чухал яриа болохыг энэ содон явдал батлав. Учир нь Батаас ахмад Цагадайн Есөнмөнх, Өгөдэйн Гүюг нас чацуу Тулуйн Мөнх, Өгөдэйн Годун гээд бусад ач хөвүүд зогсож хоцорчээ. Чингис хаан хоймрын сэнтийд залрахад түүний баруун талд Цагадай, Тулуй, зүүн талд Өгөдэй Бат хоёрыг суулгасан байлаа. Бүгдийг суусны хойно Чингис хаан үгээ хэлэв. Тэр олон үг нуршсангүй шууд л гол зүйлээ хэлнэ гэж шийджээ.

-Бөртэ эх чинь байсан бол ингээд бид халуун бүлээрээ цуглав. Миний одоо хэлэх үгийн гэрч болгон та нарыг хожим хойно мартаж цалгардах аваас сануулж яваг гэж би энд Боорчи, Мухулай, Сүбээдэй, Шихихутаг нарыг зориуд байлгаж байна.

Энэ дөрөв бол миний хэлснийг хэзээ ч мартаж, бас осолдож зөрчихгүй итгэлтэй нөхөд минь юм. Би эдгээр нөхдийнхөө өмнө та нарт зарлигаа буулгая. Бат хөвүүн нас бие гүйцэж,эр зориг, эрдэм чадал жигдрэн их цэргийг засаж, улсыг удирдах чадлаа харуулсан тул өнөөдрөөс эхлэн би түүнийг Зүчи эцгийнхээ сууринд сууж байхыг зарлиг болгож байна.

Энэ өдрөөс эхлэн Бат, Зүчийн эзэлсэн нутгийг үрийн үрд захиран суух болно. Үүнийг та нар сайтар мэдтүгэй.

Хаан миний нэр сүр ,цэргийн хүч их ч хүмүүний бие мөнх бус. Би энэ ертөнцийн таван өнгө, дөрвөн хэлийн дөчин улсыг нэгтгэн хураав. Зүүн зүгт Гуулин улс,баруун зүгт Энэтхэг, Инд мөрөн,Багдад,Кавказын уул,Каспийн тэнгис өнгөртөл умард зүгт Байгаль далай, Саяны уулыг өнгөртөл өмнө зүг Шар мөрнийг өнгөрч Хималайн уулсыг хүртэл өргөн их газар нутаг, үй олон улс иргэнийг нэгтгэх гэж халуун цусаа хөртөл хатан биеэ харьтал зүтгэсний учир юу вэ. Та нар юу гэж санана гэж Чингис хаан бахтай сайхан хэлээд дуугүй болов.

Хөвүүд, ач нарын хэн ч дуугарсангүй. Бүгд жижиг томгүй даруу төлөв сууж Чингис хааны үгийг шимтэн сонсч байлаа. Чингис хаан ч ямар нэгэн хариу хүлээгээгүй тул үгээ цааш үргэлжлүүлэв. Харин ганц Шихихутаг л Чингис хааны үг бүрийг хөх дэвтэртээ бичиж авах ажээ.

-Тиймээ. Та нар өөр өөрийнхөөрөө бодох биз. Гэвч та нар нарийн учрыг олохгүй.Энэ бол алтан ургийн хөвүүд та нарын төлөө юм.Миний хөвүүд, ач нар цаашид Чингис хааны алтан ургийн үр сад хэмээгдэн бүхэнд хүндлэгдэж нэртэй төртэй баян цатгалан амьдрахын тулд юм. Тэнгэрийн ивээлд орших газар орныг миний их нэрийн дор нэгтгэн амирлуулахын тулд юм.

Үүнийг та нар мартаж үл болно. Үр ачдаа захиж нэгэнт миний зарлиг сургаалаар хураасан улсын хил хязгаарыг өргөтгөн тэнгэрийн хаяа хүртэл дайлан явцгааж эзлэн нэгтгэгттүн. Үүний тулд би та нарыг цуглуулав. Миний хойно Өгөдэй хаан сууринд сууж бусад нь түүнд нэгэн үзүүрт сэтгэлээр хүчин зүтгэлээ өгөгтүн. Цагадай, Алтайгаас Аму дарья мөрөн хүртэлх нутгийг авагтун. Өгөдэй Уйгар газар Ил мөрөн, Тарвагатайн уулсын хавийн нутгийг эзлэн суу.

Тулуй чи отгон хөвүүний ёсоор гурван голын Монгол нутгаа мэд. Харин Бат чи эцгийн оронд Саяны уулсаас Кавказын уулс хүртэлх газрыг авч тус тусдаа өргөтгөн явсугай. Та нарын эзлэн суусан нутгийг та нарын үр хүүхэд Есөнмөнх, Гүюг, Мөнх гээд ууган ач хөвүүд ахлан ач нар маань уламжлан эзэмшиж суух биз. Миний эзэлсэн нутаг өргөжин тэлж байвал миний сүнс сүлд бахархан баясах болно гэдгийг бүү март. Миний энэ гэрээсийг миний алтан ургийн үр удам үүрд даган мөрдөж байхыг би зарлиг болгож байна. Алтан ургийн хөвүүд дотроос эрх биш ухаантай гавшгай эрдэм төгс нэгийгээ шилж хаан сууринд өргөмжлөгтүн. Өргөмжилсөн бол түүнийхээ үг зарлигийг Тэнгэрийн зарлиг гэж даган биелүүлэгтүн. Ингэж чадвал Чингис хаан миний алтан ураг энэ газрыг мөнхөд захиран суух нь гарцаагүй. Миний энэ зарлигийг хөх дэвтэрт бичиглэн үрийн үрд, үеийн үед хүртэл дагаж мөрдөгтүн. Бас энэ зарлигийг чихээр сонссон бүгдийн нэрийг бичиж батлагтүн. Хожим үгээ мартаж миний зарлигийг зөрчсөн хүн гарваас энэ дэвтрийг үзүүлж үгийг нь мэдүүлж шударгаар яллагтүн. Энэ зарлигийг хэн хэрхэн дагаж мөрдөж буйг Боорчи болоод Шихихутагийн үр удам хянан явагтүн. Одоо их цэргээ засаж Алтан улс руу хөдөлгөхөд бэлдэгтүн.

Их цэргийг Өгөдэй захир. Цагадай баруун замын цэргийг, би Тулуйн хамт зүүн замын цэргийг удирдъя. Хөвүүдээ тус тусын цэрэгт хамт авч явцгаа гэж Чингис хаан зарлиг болов.

Чингис хаан Өүлэн эхийнхээ ярьсан Буянтай өвгөний домгийг үнэн болгож энэ газрыг өөрийн хөвүүддээ хуваан өгөв.

Өүлэн эх нь хичнээн холыг харж тэр домгийг ярьсныг Чингис хаан гайхан бишрээд барахгүй байлаа. Одоо түүний хөвүүд энэ газрыг өөрсдийн нэрээр нэрлүүлэн мөнхлөөсэй гэж хүсэж байв.

Дэмий яарч Зүчи хөвүүнээ хардан үйлийг нь барсандаа ихэд харамсжээ.

Хөвүүд нь эцгийнхээ адил их хаан суухыг хүсэх эрхтэйг бас ингэх ёстойг тэр даанч хожуу ухаарчээ.

Гэвч Чингис хааны нүүрэн дээр Монголчууд зөвхөн Орхон, Онон, Хэрлэн, Туул, Сэлэнгэ таван голын энгээр биш энэ хавтгай газрыг бүхлээр нь эзлэн суух болгосондоо бахархаж хожим хойно түүний тухай яг өнөө Буянтай өвгөний домог мэт үе дамжуулан хүүрнэнэ гэж итгэж байв. Ийнхүү бүх зүйл тодорхой болов.

Бат алтан ургийн дотор лавтай Тулуйн дараа зиндаалах эрхтэй болж их хааны ач хөвүүдийн манлайд суух нь гарцаагүй болжээ. Ингэж санаагүй байсан Батын сэтгэл ихэд хөдөлсөн ч ахмад хөвүүд биеэ барин дуугүй сууцгаав.

Өгөдэй, Цагадай хоёр хэн маань үг хэлэх вэ гэж түргэн зуур харц солилцоод нэгэнт ахмад хөвүүн тул Цагадай хариу хэлэхээр хоолой засч амжаагүй байтал энд байсан ач хөвүүдийн хамгийн балчир Аригбөх гэнэт

-Өвөг эцэг тэгээд хэзээ үхэх вэ гэж цангинуулан хашгирч бүгдийг цочоожээ. Дэргэд нь зогсож байсан Хубилай ах нь учрыг мэдэх болсны хувьд бушуухан амыг нь дараад авчээ. Гэсэн ч дурааараа эрх танхи өссөн Аригбөх тийм амар бууж өгсөнгүй

-Үхэх гэж байгаа хүн чинь л ингэж ярьдаг биздээ гэж Хубилайн гарыг зайлуулан хашгирч амжжээ. Сандарсан Тулуй гараар дохисонд Хубилай, Хүлэгү хоёр эрх дэггүй дүүгээ суганаас нь өргөн гарчээ. Гэсэн ч Аригбөх

-Та нар өвөг эцгийн үхэх гэж байгааг мэдэхгүй байгаа юм уу. Тэгвэл өвөг эцэг үхэх гэж байгаа юм байна. Түүнийгээ та нараас нуугаад байна шүү дээ. Өвөг эцгийг битгий үхүүлээч дээ. Аав аа, та өвөг эцгийг битгий үхүүлээрэй. Би танд хэллээ шүү гэж хашгирсаар гарчээ. Аригбөхийн энэ санаадгүй ааш яг тэнгэр ниргэж аянга буусан мэт бүгдийг цочоож гэрт түгшүүртэй нам гүм боллоо. Аригбөх хүүхдийн зөн совингоор болох гэж буй аймшигт хэргийг мэдсэнээ нуулгүй хэлсэн нь энэ байв. Хэн нь ч юу гэж хэлэх арга учраа тэр дороо олсонгүй. Цагадай хэлэх гэж байсан үгээ мартжээ. Хөвүүд нь яаж сандран барьц алдахыг Чингис хаан харлаа.

Тэдний хэн нь ч түүний үхлийг төсөөлөхгүй, ямар ч бэлтгэлгүй байгааг ингэж санаандгүй мэдсэн нь Чингис хааныг хирдхийлгэжээ. Тэднийг хараад надаас хойш энэ хэд маань яана даа гэж бодох бүр зүрх нь шимширч тэдний энэ аргаа барсан байдлыг харсаар суух тэвчээр барагдан

–Хүүхдийн үгээр үг хийгээд яах вэ. Надад санаа зовох явдалгүй. Би үхэх болоод энэ үгийг хэлсэнгүй. Та нарын зорилгыг тод болгохын тулд хэллээ. Одоо явцгаа. Харин Бат чи үлд

гэжээ. Бүгд дув дуугүй гарцгаав.

Өөрийнхөө үхлийн тухай ингэж гэнэт илэн далангүй сонсоод Чингис хаан ч тайвширч чадахгүй болжээ. Бат үлдээд өвөг эцгийнхээ буурал үст тэргүүн, үрчлээт нүүрийг өрөвдөж харамссан харцаар сэм ширтэн дуугүй хүлээн сууж байв.

Чингис хаан өвөг нь үхнэ гэж санахад Батад аймшигтай, ямар ч хамгаалалтгүй өнчрөн хоцрох мэт сэтгэгдэж байжээ. Чингис хаан эцэст нь хүчлэн биеэ барив. Түүний өмнө харих гэж яарсан залуу хөвүүн сууж байгааг тэр харж байлаа. Чингис хаан ч бас яарах хэрэгтэй болжээ. Нялх балчир Аригбөхийн хэлсэн үгс Тэнгэр түүнийг яаруулж байгаагийн дохио болжээ.

-Хөвүүн чи улаан бар өдрийн морин цагт Монгол нутгаа зорь. Нутагтаа бүү уд. Даруй өөрийн хүрээ рүү морд. Одоо чамайг хүн бүхэн Батхаан гэж нэрлэх болно. Чи энэ нэрийг батлан авч авах биз. Чамд эцгээс өвлөсөн ухаан чадал бий. Би чамд эргэлзэхгүй байна. Чамд хэлэх, хүсэх зүйл байвал эрээлэлгүй хэлэгтүн гэж Чингис хаан Батыг эгц ширтэж байгаад хэлэв.

Бат бол угаас хийморьтой, хар багын нүдэнд унаж бусдаасаа тодорсон хөвүүн билээ. Чингис хаан одоо түүнийг бахархан ширтэж байв. Бат баруун хөлөө өвдөглөн сууж

-Хаан эцгийн зарлигт баясан талархаж байна. Би таны их нэр сүрийг хэзээ ч хугалж унагахгүй авч явна гэдгээ тангараглая. Эцгийн хураасан улсын хилийг баруун зүгт тэлж гадаад их далайд хүргэхээ би Танд амлаж байна. Би хэнээс ч тус дэм авахыг үл хүснэ. Би өөрийн чадал ухаанд л итгэнэ гэж нүдээ гялалзуулан хэлэхдээ гэнэт Зүчи эцэгтэйгээ хачин адил харагдсанд Чингис хааны зүрх хөндүүрлэж дуу алдан ёолоод нам суужээ. Гэвч ухаан нь саруул байлаа.

Бат сандран дэргэд нь ойртов.

-Хөвүүн чи бүү сандар. Би зүгээр. Харин чиний үг намайг баярлуулж сэтгэл минь ханав. Хүн хамгийн түрүүнд өөртөө л итгэж найдах хэрэгтэй юм. Чамд өөрөөс чинь илүү үнэнч нөхөр, итгэлтэй туслагч хаанаас ч үл олдоно.

Чиний эцэг, миний ууган хөвүүн Зүчи арван хоёрхон настайдаа миний зарлигаар дайсны цэргийн хүрээнд амиараа дэнчин тавиад аймшиггүй очиж байлаа. Тэгэхэд эцэг чинь тэнд хэд хоноxдоо ганц ч удаа дугхийж сэрэмж алдалгүй оргох мөчийг хүлээж байгаад дайсны хүрээнээс балчир дүүгээ аваад зайлан гарч чадсан юм.

Миний хөвүүн Зүчи үнэхээр гайхалтай гарамгай баатар байлаа. Хөвүүн чи эцгээсээ илүү баатар болоорой гэж шивнэв.

Энэ үгэнд Бат урамшин

-Та надад итгэж болно. Би эцэг шигээ баатар болно. Харин эцэг шигээ эрт үхэхийг үл хүснэ гэж хэлжээ. Уг нь Бат ингэж хэлнэ гэж огт санаагүй тул санамсаргүй унагасан энэ үгэндээ өөрөө ч цочиж харамсжээ. Гэвч хэлсэн үгээ буцаан залгиж болдоггүйгээс хойш эцгийнхээ үхлийн нууцыг тээж цээжээ өвтгөн явснаа бүгдийг хэлье гэж гэнэт шийджээ.

Чингис хаан Батын үгэнд айхтар сүрхий эмзэглэж цочоогүй ч хар багадаа эцгээс өнчирсөн түүнийг ихэд өрөвджээ.

-Эцэг чинь идэр сайхан насандаа хүнд өвчинд нэрвэгдсэн дээ. Өвчинг юу ч үл дийлнэ гэж тэрээр аргадангүй хэлэв.

- Би эцгийгээ өвчнөөр үхсэнд хэзээ ч үл итгэнэ гэж Бат биеэ барьж дийлсэнгүй хоолой зангируулан шивнэв. Тэр дахин үг дуугарвал асгартал уйлахад бэлэн байлаа.

-Чи юуны учир ингэж хэлнэ вэ. Чи яаж ингэж хэлж зүрхэлнэ вэ гэж хэлэх зуураа Чингис хаан, Батын энэ үгэнд цочин зүүгээр хатгуулсан мэт болжээ. Бас эцгийнхээ үхэлд Бат түүнийг шууд буруутгаж байх шиг санагдаад гэнэт хилэн бадарчээ. Гэвч Батыг загнаж зандарч зүрхэлсэнгүй. Эцгээс хагацахын зовлонг өөрөө бас үзсэн тул Батыг ийм үед загнах нь арай хатуудна гэж бодоод тэвчин биеэ барив. Гэвч зүрх сэтгэл нь түгшин дотор нь түлэгдэх мэт хорсон өвдсөөр байлаа.

-Та надад бүү хилэгнэ. Би төрсөн хөвүүний хувьд эцгийнхээ үхлийн шалтгааныг олох гэж бодож болохгүй гэж үү.

Та Есүхэй өвгийг татаарт хорлогдоход над шиг ингэж гуниж шаналаагүй гэж үү. Та яг над шиг эцгээсээ цаг бусаар амь хагацсан бус уу. Та ахмад хөвүүн Зүчээ юунд өөрийн оронд хаан сууринд суулгахаар зарласангүй вэ. Тэгсэн мөрт та түүнийг гайхамшигтай баатар гэж бахдах нь юу вэ. Хаан сууринд суулгахгүйн тулд хорлосон бус уу. Танд тэгэж санагдахгүй байна гэж үү хэмээн Бат нэг л мэдэхэд аймшиггүйгээр хэлж орхижээ. Эцгийгээ гэнэт үхсэнээс хойш дотроо эргэлзэн шаналж зүрхээ шархлуулан бодож, дотроо хадгалж явсан үгээ ийнхүү нэгмөсөн хэлж санаа амрав. Одоо юу ч болбол болог. Үхвэл ч үхье гэж омогшин бодсон ч сэтгэл түгшжээ.

Гэвч хэлсэн үгэндээ харамсах мөч нэгэнт оройтжээ. Батын амь нас хутганы ирэн дээр байлаа. Одоо Чингис хаан юу гэж хэлэхээс л бүх зүйл шалтгаалах боллоо. Бат үүнийг гэнэт ухаарч даруй сэхээрээд дэмий үгнийхээ төлөө уучлал эрэхэд ч бэлэн байв. Тэр дэндүү түргэджээ. Чингис хааны зан аашийг сайн мэддэг эцэг нь ганц үүнээс л болгоомжлон ирж уулзахгүй байсныг мэдсээр байж ингэж хэлдэг ёроолгүй тэнэг амьтан гэж өөрийгөө хараавч оройтжээ. Хайртай Зүчи эцгийнхээ амиараа дэнчин тавин байж авч өгсөн улсыг алдаж ч мэдэх байдалд орсноо Бат ухаарав. Эцэг нь ямар нууц хадгалж, ямархан учир шалтгааны улмаас гэртээ хэвтсээр эцэс болсныг мэдэх ганц хүн бол Бат юм. Эцэг нь чухамдаа түүний төлөө амиа үрсэн байхад хүү нь хэрэг учрыг чанад ухааран өөртөө хадгалж, хазгай гишгэж илүүг хэлэх ёсгүй атал Бат өчүүхэн зүйлд сэтгэлээ тэвчин барьж чадсангүй алдав. Хэрэв эцгийнхээ өндийн босох ч чадалгүй мэт болж өвдсөн дүр эсгэн баашилсны цаад нууцыг Бат мэдэж байсныг Чингис хаан гэнэт ойлговол түүнийг урвагчийн адил үзнэ гэдгийг тэр гэнэт ухаарчээ.

Гэвч энэ нь залуу хөвүүний хожимдсон гэмшлээс өөр юу ч биш байлаа. Батын амьдралдаа үзсэн хамгийн аймшигт мөч эхлээд байгааг тэр зөнгөөрөө мэдэрч байв

Иймээс тэр Чингис хааны царайг харан хэлэх үгээ бодож зогсов. Харин Чингис хаан гэнэт

дүрсхийн уурласангүй нь завшаан болж Бат жаахан ч гэсэн тайвширчээ.

-Бат чи юу ярина. Хаан ширээнд сууна гэдэг санаснаар болдог хэрэг биш. Баатар зориг, бардам зангаар хаан болдоггүй юм. Өгөдэй авга чинь өрөөлд элэгтэй, цэрэгтээ элбэрэлтэй, эрдэм чадал бусдаасаа илүү тул Тэнгэрт тоогджээ. Ганцхан Тэнгэрийн зарлигаар л хаан болдог жамтай. Бат чи мөн ийм байх аваас хожим их хаан болно. Чи зөвхөн өш гомдол өвөрлөсөн балчир сэтгэлийн улмаас л ингэж бодсон байна. Чамд хэцүү байгааг би сайн мэдэж байна. Эцгээс хагацах шиг эмгэнэл хаа ч үгүй. Та Есүхэй өвгийн өшөөг аваагүй гэж үү гэж чи надаас асуух байх.

Тиймээ. Есүхэй эцгийг минь заналтайгаар хорлосон татаар аймаг үгүй болсон. Үүнийг би эцгийгээ алуулсны өш хонзонгоор хийсэн юм биш. Татаарууд Тэнгэрт тэрсэлж бидний өвөг дээдсийг Алтан улсад барьж өгсний учир гэсгээгджээ.

Одоо Алтан улс ч үгүй болно. Бат хаан чи сонс. Чи одоо нэгэнт хаан болов. Хаан хүнд хэлэх хэлэхгүй үг, хийх хийхгүй үйл гэж бий. Чи одооноос эхлээд хар толгойгоо бус хамаг улсаа бодох ёстой. Хувийн өчүүхэн хүсэл бодлоо хазаарлаж хамаг олны хүсэл жаргалыг эрхэм болговол хаан алдар чамд өөрөө ирэх болно.

Хөвүүн чи үүнийг бүү март.

Бат хаан чамайг би энэ өдрөөс эхлэн эцгийнхээ үхлийн тухай элдвийг бодож эрээгүй ярихыг цаазалж байна.

Эцгийнхээ үхлийг март. Бүү харамс. Өс бүү сана. Эцэг чинь өвчнөөр үхсэн. Чи миний зарлигийг дага. Үгүй бол…гэж Чингис хаан зүрхшиж сүрдэм хатуу хэлээд үгээ таслан хүндээр амьсгаадаж Батыг заамдан авч сэгсчив.

-Сонсож байна уу чи. Миний зарлигийг дага. Чи нэгэнт өнгөрсөн үеийг бүү эргэж дурс.

Зөвхөн урагшаа, ирээдүй рүү хар. Мэдэв үү. Март. Мартах ёстойг мартаж эс чадвал чи хэзээ ч их хаан болж чадахгүй.

Бат хаан чи миний зарлигийг ойлгов уу гэж Чингис хааны бахардан хашгирсан нь нэн аймшигтай болсонд Бат айсандаа өөрийн эрхгүй өвдөг сөхрөн суужээ.

-Хаантан таны зарлигийг би хичээн дагая.

-Бат хаан. Би хэлсэндээ хүрдэг хүнд дуртай. Чи нэгэнт Тэнгэрт ивээгдсэн тул хаан алдрыг олов.

Үүнээс өөр чамд юу хэрэгтэй юм бэ. Сайн эцгийнхээ ясыг бүү өндөлзүүл хэмээн Чингис хааны хашгирах дэндүү заналтай байсан тул Бат

-Өршөө.Хаантан. Таныг ингэж их хилэгнүүлсэнд өршөө. Би эцэгтээ хайртай тул тэсэлгүй ийн хэллээ гэж үнэнээсээ асгаруулан уйлжээ. Өмнө нь сөхрөн суугаад эхэр татан тонгойсон Батын нулимсыг хараад Чингис хаан сая л ухаан оржээ. Тэгээд Батыг гэнэт өрөвдөн гол нь харлаж

тэврэн авав. Бат айсандаа, бас эцгийгээ санаж өнчирснөөс сэтгэлийн тэнхээ нь тасарч явсан тул түүнийг өрөвдөн энхрийлэхэд сэтгэл нь дэнсэлж бүр гомдолтойгоор улам их мэгшин уйлсаар байсанд Чингис хаан түүнийг ер хориглосонгүй толгойг нь элгэндээ тэврээд тайвширтал нь суув.

Батын хэлсэн үг, сэтгэлийн гүн дэх далд бодол нь Чингис хааныг ихэд түгшээжээ. Эцгийнхээ үхэлд хэн нэгнийг, тэр дундаа өөрийг нь буруутган бодож явааг олж мэдсэн нь ингэж цочирдоход хүргэв. Батын энэ өс хонзон эцэстээ юунд хүргэж болохыг ч тэр ойлгожээ.

Эцгийнхээ өвчнөөр үхсэнийг нууц аллага байсан гэж бодсоор байгаа Батыг хатуу чангаар буруутгаж чадаагүй ч бас ингэх шалтгаан байсныг, бүр энэ шалтгаан нөхцлийг нь тэр өөрөө үүсгэсэн мэт санагдаад тайвширч чадсангүй тул шөнө дунд өнгөрснийг ч үл тоон Боорчийг дуудуулжээ. Боорчийг яах гэж дуудаж байгаагаа өөрөө сайн мэдээгүй ч сэтгэлд нь хурсан айдсаас тэр л нэг холдуулж хамгаалах юм шиг санажээ. Сэтгэлд нь цэвдэг хүйтэн айдас хүйдэс хэсэг бусгаар хурсаар байгаа нь ойртон буй үхлийн сүүдэр гэдгийг Чингис хаан сайн мэдэрч байв.

Үнэнч боол Зэлмийн нь үлдээж өгсөн амьдралын цөөн хоногууд өнгөрч байгааг тэр мэдэхгүй байв. Хэрэв Өүлэн эх нь амь насаа таслан түүнд үлдээгээгүй бол , Хулан хатны нь сүнс ирж авраагүй бол, бас Зэлмэ өөрийнхөө амьдралын үлдсэн цөөн хоногийг түүнд өгөөд хорвоогоос сайн дураараа яваагүй бол Чингис хаан аль эрт үхэх байв.

Түүний амьд байсаар буй нь хайртай Өүлэн эх, үнэнч нөхдийн нь сэтгэлийн хүч, бас Тэнгэрийн хүсэл байлаа.

Чингис хаан өөрийн үхлийн энэ мэт нарийн нууцыг мэдэрч ойлгох аргагүй ч үхнэ гэдгээ бат мэдэж байсан тул өчүүхэн төдий зүйлийг ч орхигдуулахгүйгээр өөрийн санаснаар хийж шийдэх гэж яарч байлаа. Тийм ч учраас өглөө болтол хүлээх цаг түүнд байсангүй. Чингис хаан гадаа гарч хэсэг зогсов.

Ийм амгалан нам гүм, агуу гайхамшигт газар дэлхийгээс хагацна гэхэд даанч харамсалтай санагджээ.

Тэнгэрт саргүй тул нүхэн харанхуй орчлонг нөмөрчээ. Гагцхүү түг түмэн одод тэртээ дээр анивчин гялалзах нь алс холоос түүнийг дуудах мэт санагдана. Гэтэл газрын гүнээс бөөгийн дуудлага, хэнгэргийн чимээ урсан гарах шиг болсноо бүр тов тод сонсдож эхлэв. Энэ бол Тэв Тэнгэр бөө болохыг Чингис хаан дор нь танижээ. Чингис хаан энэ мөчид зүрх нь оволзон булгилж цээжээ дэлбэлэх гэж буй мэт дэлсэж байхыг мэдэрсэн ч энэ нь баярлах, айхын алинаас үүдэлтэй болохыг таасангүй.

Ашгүй яг энэ үед үнэнч нөхөр Боорчи нь яарсаар хүрч иржээ.

Тэрээр Чингис хааныг харанхуй шөнө ганцаар гадаа зогсож байхыг үзээд ихэд гайхаж

-Хаантан. Юу болов. Шөнө дунд гэнэт дуудахаар тань бүр сэтгэл түгшиж муу совин татаад. Сүүлийн үед би ер ингэж цочин сандарч үзсэнгүй. Бүр айх ч шиг хэмээн дуу алджээ. Нээрээ

ч Боорчийг энэ удаагийнх шиг ингэж түрүүлэн дуу алдаж олон үг хэлэхийг Чингис хаан үзээгүй тул бас гайхжээ. Харин хачирхалтай нь өнөө Тэв Тэнгэрийн бөөлөх дуу Боорчийг ирмэгц огт сонсогдохгүй болов.

-Боорчи чи ер нь айдаг юм уу гэж Чингис хаан инээмсэглэн асуугаад өргөөндөө оржээ.

Боорчи ч хойноос нь орж тэд сууцгаав. Чингис хаан дахин дуугарахгүй байхаар Боорчи

-Та миний зүрх зоригийг асуух гэж энэ шөнө дунд дуудав уу. Би таны ямар ч зарлигийг гүйцэлдүүлэхдээ айж сандарч явсангүйг Та мэднэ. Юуны учир ингэж шөнө дунд дуудсанаа хэлээч хэмээн болгоомжтойхон асуужээ. Учир нь Боорчид нэг л ёозгүй муу совин татаад байлаа. Огт санаандгүй байтал Чингис хаан эцсийн гэрээс мэт үгийг хөвүүд, ач нартаа хэлсэний дээр балчир Аригбөхийн хашгирсан нь бүгдийг сандралд оруулжээ. Чингис хааны өргөөнөөс гараад тэд бүгд цуглан хэрхэхээ ярилцсан ч олигтой шийдвэр гаргаж чадсангүй. Юутай ч Чингис хаан өөрийн үхлийг нэгэнт мэдэж буйг бүгдээр хүлээн зөвшөөрсөн билээ.

Тэгээд Чингис хаан Тэнгэрт халих аваас яах, юу хийх ёстойг урьдчилан бэлтгэхийг Өгөдэй, Шихихутаг хоёрт даалгажээ.

Ингэж хөвүүд, шадрууд нь түүний үхэлд бэлдэж эхлэснийг Чингис хаан гадарласангүй.

-Боорчи.Би чамайг нутагтаа буцахыг тушааж байна. Бүр Бурхан халдун ууланд оч гэж Чингис хаан ямар ч оршил тайлбаргүй шууд хэлсэнд Боорчи эхлээд буруу сонсов гэж бодсоноо сүүлд нь Чингис хааны ухаан самуурав гэж санажээ. Гэтэл Чингис хаан өмнөхөө дахин давтаад элдэв тайлбар хэлсэнгүй тул

-Нутагтаа буц гэв үү Та. Яах гэж тэр билээ. Их цэрэг хэдхэн хоногийн дараа Алтан улсын Түрэмгий балгасыг дайлна.

Ийм хэргээс намайг зайлуулж гэрт минь буцаах ямар хэрэг болов. Би ямар гэм ялд унав. Хаан та намайг хөгшин гэж, хоёр гар минь илдээ өргөж даахгүй боллоо гэж бодон голов уу. Эсвэл Зэлмийн адил санаснаараа үхэж чадахгүй гэж сонжив уу.

Би хаан таны хишигтэн цэргийн ноён. Шадар сайд. Их эзэн Чингис хааны амь насыг даасан хүн. Гэтэл ийм үед таныг орхиж одно гэдэг юу гэсэн үг вэ. Арван хэдтэй, ангир зүстэй алтан үеэсээ хаан таныг дагав. Таны биеийг орхиж цалгардсан нэг ч хоног надад үгүй. Гагцхүү таны зарлигаар Киевийн дэргэд байсан Сүбээдэй, Хивчагийн тал дахь Зүчийн өргөөг зорихдоо л хэдэн сар хол байжээ. Би таныг ийн зарлиг буулгасанд гайхаад учраа ч олохгүй байна. Ар гэр, Ауараг ордонд муу үйл болов уу. Бөртэ хатнаас муу хэл ирэв үү гэж Боорчи нэг л мэдэхэд өөрийн эрхгүй олон үг урсгав.

Боорчийг гэнэт ийнхүү догдлон хөөрч залуу хөвүүн шиг оволзон омогтой шартай үг хэлсэнд Чингис хаан гайхаад

-Тайвшир Боорчи. Чи чинь юу болоод үгийн зөрөөгүй хашгичаад эхлэв. Би чамайг ийм ёс журамгүй мэт байхыг ер үзсэнгүй. Эсвэл би зүүдлэж байна уу гэсэнд Боорчи сая л Чингис

хааны өмнө бүр босоод зогсчихсоноо анзаарч ихэд гайхан өвдөг сөхрөн буцаж суужээ.

-Та нар чинь юу болов. Намайг үг хэлэхээр л эвэртэй туулай үзсэн мэт байцгаах болж. Эсвэл миний улаан нүүрэн дээр үхэл нь ирэв гэж бичээстэй байна уу. Эргэн тойрны юмс өөр болоод ч байх шиг. Хажуугаар нь Боорчи чи юу ч вэ дээ. Залуу хөвүүн шиг дүрсхийх чинь хэмээн Чингис хаан түүнийг зэмлэжээ. Боорчи ч өөрөө чухам яагаад ингэж битүү хатуу үг хэлснийхээ учрыг олохгүй гайхжээ.

-Боорчи чи аан гэж бай. Ер чиний хэлсэн шиг зүйлийг би бодсон нь үгүй. Чи надад нүүр алдаж гэм ялд унах нь бүү хэл, миний амь нас, алдар нэрийг минь сахиж хар нүдээ анивхийлгүй хатан биеэ амсхийлгүй явааг чинь би яаж мартана. Хэрлэнгийн хөдөө арлын ордон хийгээд Туулын хөвөөн дэх Бөртийн ордонд муу юм огт болсонгүй. Харин… гээд Чингис хаан үгээ тасалсанд Боорчи дахиад л тэссэнгүй өндөлзөж

-Хаан та шууд хэлэгтүн. Миний зүрх хатуу үгэнд хад чулуу шиг дассан. Бүү түвдэгтүн гэжээ.

-Боорчи. Чи битгий хашгичаад байгаач. Тайван сууж сонс. Би Хэрлэнгийн хөдөө арал, Дэлүүн болдогтоо буцсугай гэж шийдлээ гээд Чингис хаан тооно өөд харжээ. Тоононоос цааш харанхуйн дунд тас хар, урт гонзгой дүрс харлан байсан нь түүний үхэл болохыг одоо Чингис хаан мэдэж байв. Гэвч тэр үхэл түүнээс бас ч хэдэн алхам зайтай байлаа. Чингис хаан үхлээс ер айхгүй болжээ. Учир нь одоо түүний дэргэд үнэнч нөхөр Боорчи нь сууж байлаа.

-Хаан та их цэргээ орхиод уу. Би ойлгож ядаж байна. Таныг нутагтаа буцвал их цэргийн… гэтэл Чингис хаан түүний үгийг таслав.

-Монголын их цэргийг хэн ч зогсоож үл чадна. Чингис хаан би ч зогсоохоос өнгөрсөн. Чи бидний өсгөж хүмүүжүүлсэн залуу идэр жанжид, тэдний эрэлхэг цэргүүд яг л уулын голын хүчит урсгал шиг түрхэрч байна. Тэр их хүчит урсгалын өмнө тэсч үлдэх нэгээхэн ч боомт, бэхлэлт цайз, улс орон үгүй болжээ. Харин би л тэр их эрчит урсгалд саад тушаа болох болов.

Миний бие Тэнгэрээр тэтгүүлж нөхдөөр дэмжүүлж Их Монгол улсыг байгуулав. Одоо би өөр юуг хүснэ гэжээ.

Боорчи Чингис хааны энэ үгийн цаад санааг сайтар ухан ойлгосонгүй.

-Хаан таныг их цэргээ орхиод нутаг буцахад хүрвэл Алтан улс юу гэж үзэхэв. Айж хулчийн дайлах зориг мохов гэх бус уу. Эсвэл бие чилээрхэж… гээд Боорчи хоолойдоо тулж ирсэн дараагийн үгийг зориглон хэлэлгүй буцаан залгисан мэт дуугүй болов. Гэвч Чингис хаан түүний хэлж чадаагүй үгийг зөнгөөрөө тааж мэдээд

-Үхэв гэнэ гэж үү. Чиний хэлэх гэсэн үг чинь үнэн. Гэвч миний буцсаныг хээрийн салхи, хэлгий шаазгай ч мэдэх учиргүй.

Би ийм зарлиг буулгая. Тэгвэл чи яахав.

-Нэгэнт Та ингэж зарлиг буулгавал би юу хэлэхсэн билээ. Тэгвэл бид хэзээ хөдлөх вэ. Ядаж

Түрэмгий балгасыг эвдэхийг үзэхсэн.

-Боорчи чи юун өчүүхэн зүйл хүснэ. Чи улаан гал дүрэлзэж утаа униар манаран, манай цэргийн өмнө шавар хэрэм нурж унахыг үзээгүй гэж үү.

-Би дахиад чингэхийг үзэхгүй мэт санагдсан тул хэлэв. Та хэзээ мордохыг зарлиг болгоно. Би бэлдье.

-Чи морь өдрийн морин цагт хөдлөгтүн. Харин би чамайг Бурхан халдунд хүрч намайг угтан авахад бэлэн болмогц эндээс довтолгоё.

-Урьд нь хэзээ ч ингэж байсангүй тул нэн хачирхалтай байна. Бөртэ хатан, Отчигон авга чинь биднийг их аянаас угтсаар нэгэнт ёс дэглэм хатуу тогтсон бус уу. Та намайг юунд ийнхүү өөрийн дэргэдээс холдуулах мэт түрүүлж одохыг тушаана гэж Боорчи сэтгэл дундуур байгаагаа нууж үл чадан өгүүлэв. Морь өдөр гэдэг нь ердөө гурав хоногийн дараа болох тул Боорчи ийнхүү гомдолтой байжээ. Уг нь тэр их цэргийн хамт Алтан улсыг дайлан сөнөөнө гэж балчир хүүхэд шиг баярлан догдолж байсан билээ.

-Боорчи.Чи байлдаж дайтахаас өөрийг бодохгүй байсаар наад тархи толгой чинь тараг айргийн сав мэт болов уу.

Чингис хаан би хамгийн сүүлчийнхээ аян дайнаас нутагтаа харьж явна. Энэ Тангуд улсад ирсээр жил хагас болов. Одоо би Дэлүүн болдогоосоо дахиж явахгүй. Тиймийн учир би чамайг урьдчилан илгээж байна. Хаана буух, хаана угтах хийгээд хаана, хэрхэн суух энэ бүгдийг Наху баяны ганц хүү хөлөг баатар Боорчи чи шийдтүгэй. Үүнийг би хүсч байна. Чиний засч заасан бууринд би мөнх суухаар шийдэв. Үүнийг чамаас өөр хэн хийнэ. Би ч чамаас өөр хэнээр хийлгэнэ. Миний өсгөсөн, өргөсөн нөхөд чамаас бусад нь бараг бүгд үгүй болов. Тэдэнгүйгээр би одоо юу хийж чадна. Бат хөвүүний хэлсэн үгнээс хойш би ихийг бодох болов. Тэр хөвүүн хорин настай Тэмүжинг, бас Зүчийг санагдуулав. Миний удамд энэ зовлон юунд үл тасарна. Надаас хойш миний үр удам өс хонзон санахгүй амьдраасай гэж би хүснэ. Хорвоог би нэгэнт элээв. Харин одоо энэ хорвоо намайг идэж, эвдэж дуусгахыг харж байна. Би чадах бүхнээ хийв.

Хожим намайг үр сад минь лав хараахгүй биз. Харааж нулимах тэнэгүүд гарлаа ч тэд цөөн байх биз гэж найдна. Би хамаг Монголын хөх гүрнийг хан хорвоогоос хэзээ ч арилахгүйгээр бат байгуулав. Үүнээс өөр би юу хийж чадна. Ганц биеийн чадлаар биш гавшгай нөхдийн хүчээр үүнийг гүйцэлдүүлэв. Одоо хөвүүдийн минь цаг болжээ. Морины явдал даахгүй өтөл би хүүхэд нохойн доог, хөнгөн тэрэгний ачаа болохоосоо өмнө нутагтаа харьж үүрд суусугай. Тэнгэрийн зарлигийг зөрчин байж Тангудад ирсэн минь миний алдаа болов. Гэвч хийвэл бүү ай. Айвал бүү хий гэдэг биз. Иймийн тулд би чамайг түргэвчлэн мордохыг тушаав. Би их яарч байна. Намайг хэн нэгэн элдэн хөөж би түүнээс зугатааж байх шиг санагдах болов. Одоо надад Тэнгэрт гарч энэ ертөнцийг бүтнээр нь харахсан гэсэн хар багынхаа тэр орь хүслийг биелүүлэх л үлдлээ…

Чингис хаан чухам юуны тухай ярьж байгааг Боорчи ойлгох тул түүнийг өрөвдөн тэсгэлгүй бэрхээр шаналжээ. Гэвч түүнд яах ч арга байсангүй. Зөвхөн дэмий тайтгаруулах л үлджээ.

-Хаантан Та юунд ингэтлээ яарнав. Нутагтаа буцах даанч сайхан. Гэтэл зорьсон хэргийн эцэст хүрэлгүй замаас буцах гэж яарах чинь юув. Үүнийг чинь л би гайхаж байна. Боорчийн энэ дэмий хоосон, аргаа барсан үгийг Чингис хаан тоож хариу хэлсэнгүй нь түүнийг улам ч арчаагүй дорой байдалд хүргэж тэр өөрийгөө үзэн яджээ.

-Тэгвэл нутагт хүрээд миний юу хийхийг хэлэгтүн гэж Боорчи өөрөө ч мэдэлгүй омогтой хэлэв.

-Чиний юу хийхийг би яаж мэднэ. Би өөртөө биш зөвхөн олны сэтгэлд л хаан байхыг хүснэ. Би ингэж чадсан бол арван дөрвөн наснаас цэрэг засаж төрийн төлөө биеэ золиосолсны хэрэг тэр. Чи яг ингэж үйлдэгтүн. Өөр би юу хэлнэ. Боорчи чи бид хэд Бөртийг буцааж аваад Бурхан халдун ууланд нэг сайхан ойн цоорхойд сууж юу хэлэлцэж байснаа санана уу. Өнөө Зэлмийн буга алдаг өдөр

-Би санаж байна. Яаж мартах билээ. Тэмүжин чиний юу хэлснийг ч санаж байна. Миний бие хэзээ ч үгүй болж мэднэ.

Тэр үед энэ ойн цоорхойд бунхлагтун. Сүнс амармаар сайхан хангай гэснийг чинь ч санаж байна.

-Тэгвэл сэтгэл минь ханав. Одоо надад үхлээс айж, нүглээс ичих юм үгүй боллоо. Харин Бөртэд өгсөн тангаргаа эвдсэн нэг явдал бий. Гэвч тэрийг Бөртэ ойлгох биз. Дэргэд байсан бол хэдэн дулаан үг хэлэхсэн. Би түүнийгээ хаяж явсаар энэ насыг дуусгах учиртай байжээ. Би өөрийнхөө буулгасан зарлигийн төлөө харамсаж явсангүй. Харин Зүчи хөвүүнээ хөнөөх зарлиг буулгасандаа л их харамсаж байна. Би ухаан суухгүй, хүнд итгэхгүй хэвээрээ үлдэж. Хүнд өвчинд нэрвэгдээд ирж чадахгүй болов гэсээр байхад нь үл итгэж чамайг илгээсэндээ одоо харамсаж байна. Гэтэл хөөрхий тэр хөвүүн өвчинд шаналсаар үхэв. Харин Бат хөвүүн нь надаас эцгийнхээ амийг нэхэж байдаг. Би ийм болчимгүй хэрэг үйлджээ. Зүчийг өвчнөөр үхсэнийг мэдсээр атал Батын өмнө би буруутан мэт хэлэх үг ч олдсонгүй. Надаас хойш Бат бас хэнийг эцгийнхээ үхэлд буруутгаж юу хийх бол гэхээс сэтгэл шимширч зүрх өвдөөд үхэхэд ч хэцүү боллоо гэхийг сонсмогц Боорчийн үс нь босч үхээр үзсэн мэт царай нь зэвхийрчээ.

-Юу гэнэ ээ. Тэр хөвүүн үүний учрыг яаж мэдээ вэ. Мэдэх учиргүй биш үү гэж Боорчи дуу алдахдаа зүрх сэтгэлд нь хүйт дааж айдас дүүрэхийг мэдэрчээ.

-Алдсан хүн арван тамтай гэдэг бил үү. Бат одоо ухаан суужээ. Эцэг Зүчийгээ, миний оронд хаан ширээ залгамжлах ёстой эцгийнхээ дараа тэр өөрөө бас хаан ор суух ёстой гэж үзэж байна. Уг нь ингэх ёстой ч байсан юм. Гэтэл би Зүчийг өөрийн оронд хаан ширээнд суулгаж яаж чадна. Миний хөвүүд бүгдээрээ л надад хэрэгтэй. Би бүгдэд нь хайртай юм.

Зүч хөвүүн мэргэдийн цусанд төрсөн нь түүний буруу гэж үү. Зүчийг би буруутгаж яаж чадна. Тэр энэ хорвоод амьдрах гэж ирээд өөрийгээ үхлээс булааж төрсөн баатар байв. Би Зүчид өөрийн хөвүүд шиг дастлаа удсан. Гэвч тэр намайг өөрийнхөө хүчээр итгүүлсэн юм.

Хорьхон настай залуу Зүчи миний өөдөөс огт цавчихгүй ширтэж байгаад "Эцэг минь би ойн

иргэдээс алс явж аймаг улсыг хурааж ирье. Одоо би хорин нас хүрэв. Таны хөвүүн болохоо нэг бол баталсугай, эсвэл амь өрсөн тулаанд үхье" гэж тов тод хоолойгоор өөртөө итгэлтэй бөгөөд хатуу чанд хэлэхэд нь Зүчийн миний хөвүүн болох хүсэл нь халуу шатах мэт мэдрэгдэж сэтгэл зүрх минь урагдаж байв. Би түүний хүсэлтийг аргагүйдэн зөвшөөрсөн. Зөвшөөрөхгүй байх ч аргагүй байсан юм даг.

”Зүчи чамайг амьд ирвэл өөрийн хөвүүнээ гэж үүрд нэг санаагаар тооцох болно” гэж би тэгэхэд дотроо тангаргаласан юм. Зүчи ч ямаршуу баатар эр болохоо харуулсан. Би бүр заримдаа Зүчид атаархдаг байв. Тэр бол ухаан чадал тэгш төрсөн баатар, Тэнгэрээс надад илгээсэн элч шиг санагддаг. Би Зүчид хайртай, магадгүй бусдаас ч илүү хайртай байв.

Гэвч хураасан улсынхаа нэгдмэл байдлын төлөө, алтан ургийнхаа төлөө түүнийг алахаас өөр зам надад байгаагүй юм.

Ийм зовлонг надаас өөр хэн гэтэлж чадна. Аз болоход тэр зовлонт хөвүүн өвчнөөр үхэх ёстой байж. Гэтэл Бат намайг эцгийгээ алсан гэж сэжиглэж байгаа нь аймшигтай. Хожим хойно алтан ургийн хөвүүд, ач нар алалцаж ясыг минь өндөлзүүлэх бий гэж би ихэд зовно.

Хожим юу болохыг Зүчи ухаан, совин хоёроороо мэдээд газрын холыг зорьж Хивчаг руу одсон. Энэ нь ч зөв гэж би бодсон билээ. Зүчийн судсаар хэний цус булгилж буйг мэдэх болсон цагаасаа Цагадай түүнийг огт үзэж чаддаггүй, арай гэж тэвчдэг байсан юм. Цагадайн ааш зан хэзээнээсээ бэрх. Намайг үгүй бол тэд галзуу ноход шиг хэмлэлдэн хоолой гүрээгээ тас таталцахад ч бэлэн байсан. Хөөрхий Зүчи хөвүүн өөрийн хувь заяаг дагаж эзэндээ зодуулсан нохой шиг гомдолтой гасалсаар салж одсонсон. Түүнээс хойш бид уулзалдаагүй. Хамгийн сүүлд уулзсан хүн нь чи.

Зүчи лав өөрийн улсыг байгуулахыг хүссэн биз. Одоо Бат хөвүүн нь эцгийнхээ хүслийг гүйцээг.

Батын өмнө өргөн уудам нутаг газар бий. Гэвч түүний улс Их Монгол улсын баруун хязгаар л байхаас биш хэзээ ч тусгаар улс болох ёсгүй. Миний их улсыг тасчин хуваж булаалдан салгахыг би тэвчихгүй.

Тийм хүсэлтэн буй аваас хэн ч бай Тэнгэрийн цаазанд унах болно. Хасар ч, Зүчи ч ялгаагүй гэж Чингис хаан гэнэт бухимдан хилэгнэж бахардах шахан өгүүлжээ.

Чингис хааныг тайтгаруулах хэрэгтэй байлаа.

-Тиймээ. Зүчийг яахин мартаж болох билээ

Мартахын аргагүй хүмүүн гэж байх. Тэр бол Зүчи юм. Би бол түүнийг бүр ч мартах учиргүй хүн. Анх морины явдал дунд хөнгөрөхдөө Бөртэ тэнхэл нь барагдаж аргаа бараад мориноос унахад нь би Зүчийг үхээ биз гэж бодож билээ. Морьдын тоосон дунд унаад хүй тасраагүй хэвтэж байсан тэр улаан нялзрай амьтныг замаас зайлуулах санаатай алган дээрээ авахад учиргүй бархирч байсансан. Тэгэхэд л Тэмүжин чиний зарлигийг би амьдралдаа цорын ганц удаа зөрчиж хүйг нь тас хазаад өвөртөлсөн билээ. Би тэр үед чиний хэлснээр түүнийг эзгүй

хээр газар хөсөр шидэж орхисон бол хорвоо дээр Зүчи гэх хүн байхгүй, хожим нь Хаан та ингэж шаналахгүй байв гэж би гэмшин бодно. Гэвч энэ хорвоогийн элдэв учрыг хэн урьдчилан тааж мэдэх билээ. Алганд минь арвалзан бархирах тэр нялх амьтныг хажуу тийш нь шидчих зүрх хүрээгүй юм. Уургийг нь дөнгөж амлуулаад бүтэн өдөр давхин Хэрлэнгийн эрэгт буухад огт дажгүй тарвалзан уйлж байсан билээ. Тэгэхэд би “Энэ хөвүүнийг хүн болдог л юм бол хамгаалж явсугай” гэж өөртөө тангарагласан юм.

Хаан та тэгэхэд Зүчийг голж хаясан бол би авах байв. Тийм ч учраас Ойн иргэдийг дайлахад би гуйж цуг явсан.

Ухаандаа түүнийг хамгаалсан санаатай юм. Яагаад ч юм бэ чи түүнийг юу юугүй хорлох гээд байх шиг санагддагсан.

Зүчи ч үүнийг мэддэг байсан даа.

-Чамд тэр өөрөө тэгэж хэлэв гэж үү.

-Зүчи тэгэж хэлэх хүн биш.

-Боорчи. Байз, байз. Ингэхэд чи ер нь Зүчийг үхсэн гэж надад худал хэлсэн хүн биш биз. Гэнэтхэн тэгэж бодогдоод явчих чинь. Түүнийг өвчнөөр үхэв гэж чи надад худал хэлсэн мэт санагдана. Чингис хааны энэ санаандгүй үгийг сонсоод Боорчи эргэлзэж орхив. Батын тухай түүний хэлсэн болон одоо энэ хэлж байгаагаас үзэхэд Чингис хаан түүнийг ингэж шөнө дөлөөр дуудсаны бас нэг учир тодрох шиг болжээ. Тэдний хамт байх хугацаа нэгэнт дуусч байгаа нь нуух аргагүй үнэн болж байхад сэтгэлдээ зовлон тээж явахын хэрэг юу билээ гэж Боорчи бодов. Бас тэр нууцыг Чингис хаан хэдийн мэдчихээд түүнийг сорьж сонжиж суугааг ч хэн мэдлээ. Ер нь тэрээр хэзээний тэгэж хүнийг сорьж туршиж байдаг, хэнд ч үл итгэгч, сэжигч зантай билээ. Тэгээд ч одоо Боорчид айж ичих хэрэг нэгэнт үгүй болсон нь илт байв.

-Зүчийн үхсэн нь гарцаагүй үнэн. Харин өвчнөөр үхсэн нь худал. Үүнийг би ганцаараа л мэдэх юм гэж Боорчи хэдэн жил өөрөөсөө ч бараг далдлан хадгалж явсан нууцаа шуудхан түс тас хэлэв. Чингис хаан харин Боорчийн төсөөлөн хүлээсэн шиг тэгтлээ цочиж хилэгнэх байдал гаргасангүй, санаснаас ихэд тайван сууж,сонсоод

-Үхсэн. Гэхдээ өвчнөөр үхсэн нь худал гэж чи юу ярина. Энийг чинь би юу гэж ойлговол зохихыг хэлээч гэжээ.

-Хаан та Зүчийг буруу санаа агуулсан ахул өөрийн үзэмжээр хороох ёстой бол хороохыг надад тушаасан бус уу.

-Чи юу ярина. Хивчагаас буцаж ирээд чи надад Зүчи өвчнөөр нас барав гэсэн тул бүхэл улсаараа их гашуудал зарласан бус уу.

-Хаантан Та юу айлдана. Миний зарлигаар Зүчийг хороов гэж Та зарлах байсан гэж үү. Хөвүүнийг чинь хороов гэж хэлэх үг миний аманд яахин багтах билээ гэж Боорчи гашуудалтай шивнэв. Хэсэг зуур нам гүм болжээ. Чингис хааны гар салганан нүд нь

аяганаасаа бүлтрэн гарах нь үү гэмээр бүлтийж нэг юм хэлэх гэсэн бололтой ам нь хэд ангалзсанаа юу ч дуугарч чадалгүй ширээ тулан босоод ирэв. Боорчи ч үсрэн босчээ. Чингис хаан чив чимээгүй ойртон ирээд түүнийг заамдан авав. Нүд нь галзуурсан мэт дүрлийж ам нь ангалзах нь аймшигт үгс хашгирч байх мэт. Гэвч түүний дуу гарахгүй бөглөрчээ. Чингис хааныг ингээд үхэх нь үү дээ гэж Боорчи сүнсээ зайлтал айх мөртөө дэмий юм хэлэв гэж харамсах ч сөхөө байсангүй. Чингис хааны царай хөхрөн амьсгаа нь тасалдахад Боорчи аргаа барж өөрийн мэдэлгүй алгадаад авчээ.

Чингис хаан сая л нэг цочин цээжний нь бөглөө онгойж арай ядан амьсгаа аваад

-Чи намайг хуурчээ хэмээн байдаг хоолойгоороо хилэнтэйгээр хашгирчээ. Түүний дууг сонсоод Боорчи тайвшрав.

Сая түүнийг алгадаагүй бол Чингис хаан амьсгал нь бөглөрөн хормын дотор үхэх байв.Харин Боорчи учрыг тэр дор нь ухааран хэрхэхийг зөв сэтгэж түүнийг үхлээс зайлуулжээ. Үхлийн хар сүүдэр алгуур холдон одов.

-Чи миний зарлигийг зөрчиж аймшиггүйгээр хуурсан байна. Би чиний аль үгэнд итгэнэ. Хэлээч гэж Чингис хаан бухимдан өгүүлээд түүнийг дахин заамдан авав.

-Би чамайг өөрийн гараар багалзуурдан ална. Миний хөвүүнийг алсны чинь төлөө алах болно. Би чамайг Зүчийг авчир гэсэн биш үү. Чи ч түүнийг даруй дагуулан авчирна гэж амласан биш үү гэсээр үгээ ч дуусгалгүй Боорчитой зууралдсан чигээрээ ухаан балартан суужээ. Гэвч тэр дороо сэргэж өндийн суув. Чингис хаан тэрхэн хооронд тайвширсан нь гайхалтай ч Боорчи тайвширч чадахгүй байлаа.

-Намайг алах ч багадна. Гэвч би Хаан таны зарлигийг дагахгүй байж яахин чадна. Энэ муу мойног гар яасан их нүгэл үйлдэв. Нүгэл нүглийн дотроос орчлонд ирэхэд нь тосч авсан гараараа түүнийг хөнөөх гэдэг юутай аймшиг. Тэр өдрөөс хойш би огт өөр хүн болчих шиг л санагдсан даа. Би Хаан таны сэтгэлийг шархлуулахгүй л гэсэндээ “Өвчнөөр үхэв” хэмээсэн билээ. Бас үнэхээр өвчнөөр үхсэн мэт л хороосон. Үүнээс өөрөөр би яах билээ. Би үйлээ л дагасан. Одоо ч дагахад бэлэн. Наху баян эцгийнхээ адууг эзгүй хээр орхиод чамайг дагахдаа л би ингэж шийдсэн буй. Намайг албал алтугай. Одоо надад үхэхэд хайран бус.

-Чи Зүчийн тухай чин үнэнийг хэлэгтүн. Миний сэтгэлийг бүү дурс.

-Таны сэжиглэн бодсон бүгд үнэн байв. Зүчи “Бие өвчлөв” гэж зар тараагаад гэртээ бүгэж, Хаан таныг нутаг буцахыг хүлээхээр шийдсэн байв. Есөнтэй Танд чухам үнэнийг хэлжээ. Зүчи ч надад тэгэхэд бүх үнэнээ хэлж бас намайг дэргэдээ үлдэхийг ч ятгасан. Тэр бүгдийг сайтар төлөвлөсөн байлаа. ”Бие муудав” гэсэн нь хаан эцэгтэйгээ олны нүдэн дээр эвдрэлцэхээс зайлсхийхийн тулд байжээ.

Бас намайг хараад л яах гэж ирснийг минь дор нь мэдсэн дээ. ”Хаан эцэг чинь хилэгнэж даруй ирэхийг тушаав” гэхийг минь сонсоод сууж сууж "Боорчи ахай.Би энэ улсыг байгуулах гэж цусаа урсгаж, цулбуураа хумилгүй явлаа. Би өөрийн байгуулсан улсдаа ясаа тавья даа" гэсэн юм. Би юу ч хэлж чадаагүй. Ер нь юу ч хэлэх билээ.

Бид хоёр Каспийн тэнгисийн зэгст хөвөөгөөр морьтой зэрэгцэн галигуулж явлаа. Зүчи их цэргээ тал дүүртэл жагсаагаад "За Боорчи ахай. Таны өмнө миний их цэрэг байна. Энэ цэрэг надтай цуг Каспийн тэнгисийн зүүн эрэг, Хивчагийн талын гурван их голын хот балгасыг дайлан авч нэгтгэсэн юм. Надад одоо ямар ч улс аюултай биш. Миний цэрэг зоригтой, хурдан гавшгай, надад үхтлээ үнэнч тэмцэнэ. Би ийм цэргүүдээс хагацах дааанч хайран. Би Бөртэ эхийнхээ үгийг л дагая. Би эхийнхээ сэтгэлийг зовоож үл чадна.

Ээж минь надад “Зүчи хүү минь. Чи бол Тэмүжин эцэг, Бөртэ ээждээ зовлонгоос олдсон үр нь юм. Тэмүжин эцэг чинь чамайг хүн болог гэж эгэмнээс чинь татаж энгэртээ нааж, хөлийг чинь дөрөөнд гарыг чинь ганзганд хүргэж өгсөн юм. Энэ хүний гарт чиний амь нас байгаа гэдгийг бүү март. Чи бол эцгийнхээ дайны сахиус болох ёстой. Тийм болохоор хөвүүн чи эцгийгээ дуудахад ирж, дохиход зогсож бай. Чи үх гэвэл дуугүй л үхэх ёстой” гэж үргэлж сургасан юм. Би Боорчи таныг алах шиг амархан юм алга. Бас цэргээ хөдөлгөж Туулын хөндийг дайлах ч амархан байна.

Гэвч тэгэж түмний шившиг болж хаан эцгийн хайран нэрийг үрж, хамаг Монголын хана туургыг эвдээд яана. Би хаан эцгийн өршөөлөөр хүн болсон. Одоо түүний хүслээр үхсүгэй. Хаан эцэг минь намайг сайн хөвүүн байсан даа гэж хайрлаж яваасай гэж хүснэ. Өөр хэлэх зүйл надад үгүй. Би одоо дөнгөж дөч хэвийж байна. Хамаг Монголын их үйлсэд миний амь нас хэрэгтэй бол автугай. Хамаг Монголын төлөө ганцхан Зүчи би ч биш, хэрэгтэй болвол түм түмэн Зүчи харамсах юмгүй амиа өгөх биз гээд инээж байсан даа.

Би одоо Бөртэ хатны ухааныг эрхгүй бишрэн гайхна. Халуун амь, бүлээн цусаа таслан байж өгөөд хорвоод төрүүлсэн хонгор үрээ эх хүн яаж ийнхүү хатуу бэрхээр засан хүмүүжүүлж чадав хэмээн Боорчи шивнэн өгүүлжээ. Энэ үед Чингис хааны эмгэнэл хязгааргүй болоод бүр эхэр татан уйлж байв.

-Миний байгуулсан улсыг Бат хөвүүн минь засна биз. Харин хаан эцэгт хэлэгтүн. Бат бол Зүчи биш тул түүнийг бүү гадуурхагтун. Миний байгуулсан улсыг өөрийн чадлаар өргөтгөн их улсын баруун хаяаг батлан сахиж сууг. Түүнийг бүү хорло гэж гуйгаарай. Намайг төрөхөд үгүй хийж орхиогүй тул би хаан эцэгтээ их өртэй хүн. Тэр намайг соёрхож амьдрал өгсөн. Би эхийн захиснаар түүнд үнэнч зүтгэв. Одоо үх хэмээсэн тул би үхье. Харин би өөрийн амийг егүүтгэж үл чадна гэж тод хэлээд давхиад явсан.

-Дуустал ярь. Би тэвчиж сонсоно.

-Зүчи намайг дэргэдээ үлдэж их улс хамтран байгуулахаар зүтгээч гэсэн. Түүнд үхэх хүсэл огтхон ч байхгүйг би харж байлаа. Зүчээс өөр овилогогүй хүн байсан бол аль эрт хаан танаас туурга тусгаарлан улсаа зарлах байв. Гэтэл тэр хаан таныг хүндэтгэн аядуу зөөлөн хүмүүжилтэй зандаа хөтлөгдөн бүгдийг хаан танд зовлон учруулалгүй бага багаар хийхийг зорьжээ. Тэр надтай хамт нааш ирэхгүй нь тодорхой болсон тул надад өөр арга үлдсэнгүй. Би Зүчийн үгийг сайшааж үлдэхээр болоод түүнийг хуурч алсан билээ. Би түүнийг шөнө унтаж байхад нурууг нь хугалж орхисон гэж Боорчи үгээ зөөн байж арайхийн хэлж дуусгав.

Энэ үед харамсаж гашуудсандаа түүний ухаан балартаж байжээ. Чингис хаан ч чимээгүй уйлсаар байлаа.

Хүчирхэг түрэмгий агаад омог бардам зантай, хэн нэгэнд нулимсаа үзүүлэх нь байтугай сандарч тэвдэж, айж балмагдаж байгаагаа ч хүнд харуулахгүй байхыг хар багаасаа сурч, үргэлж сүрдэж бишрэм байж чаддаг Чингис хаан бяцхан хүүхэд мэт енгэнэтэл уйлж халуун нулимсаа хүнээс нуухгүй асгаруулан байхыг харсан хүн гайхаж алмайрахаасаа сэтгэл эмтэрч уяран өрөвдмөөр харагдах ажээ.

-Боорчи чи миний нулимсыг үз. Ус байна уу гэхэд мөлхөн очиж арчин үзэв.

Чингис хааны нүднээс үнэхээр ус биш цус урсан гарч байх ажээ. Тэр зүрхээрээ мэлмэрэн цусаар уйлж байлаа. Түүний хийсэн аян дайны хөлд дайрагдаж Монголын эсрэг мөчөөрхөн Мөнх Тэнгэрийн зарлигийг аймшиггүй сөрж хар толгойдоо лай хураагаад Чингис хаанд бууж өгөөгүйн учир түүнийг хилэгнүүлж овог удмаараа хүйс тэмтрүүлсэн түмэн хэлийн хэчнээн хүний зүрхнээс гуниг гаслан, өшөө хорсол нэвт шингэсэн ийм нулимс цусан зам татуулан урсаа бол гэсэн аймшигт бодол толгойд нь өөрийн эрхгүй зурсхийн орж ирсэнд зэвүүцэн хирдхийсэн Боорчи

-Цус байна. Одоо дахин уйлахгүй биз. Сайн уйл.

Таны хөвүүдээс хамгийн гайхамшигтай нь Зүчи байсан юм даа. Гэтэл би тэр хөвүүнийг чинь алж амьдын хар нүгэлд унав. Харин одоо үнэн учрыг Танд хэлж миний санаа амарлаа. Энэ аймшигт нууцыг Та бид хоёроос өөр хэн ч үл мэднэ. Намайг хэрхэхээ Та мэд хэмээн мөргөжээ.

-Миний нүднээс гашуун нулимс биш зүрхний минь сүүлчийн цус дусал дуслаар асгарч байна. Надад үлдсэн балга цус ингээд дуусч байна. Өүлэн эхийн минь надад хайрласан амьдралыг тэтгэгч халуун урсгал ийнхүү тасарч байна Боорчи. Би их нүгэлтэй, үйлийн үртэй хүн юм. Юуны учир би хөвүүнээ алав.

Яах гэж. Хураан авсан нутаг орон багадсан мэт Зүчээс юугаа харамлав. Би сая улсаа хөвүүддээ хуваан өгөв. Тэр үед би Зүчээс яагаад харамлав. Би юуны учир ингэж өөрчлөгдөнө вэ. Зүчийн амьдад ийн сэтгэхгүй яав. Над шиг мунхаг хүн үгүй биз.

Өүлэн ижий минь хичнээн жилийн өмнө миний өнөө хийхийг урьдчилан сануулжээ. Тэр Буянтай өвгөний тухай домогт миний хийхийг заажээ. Гэтэл би ухаарсангүй. Чингис хаан шархдаж улангассан араатан мэт гаслан бархирна.

Түүний эмгэнэл, харуусал, үзэн ядалтыг харах бүү хэл, уйлж гаслах дууг нь сонсоход бэрх ажээ.

-Би хэзээ, хэнд, ямар нүгэл хийсний лайгаар ийм хүнд ялд унав. Хайртай Бөртийнхөө амин ганц үрийг нь юунд би хөнөөв.

Би юуны тулд гүрний хаан болж энэ их улсыг хураав. Гэмгүй хөвүүнээ туурга тусгаарлахыг санаархсаны нь төлөө хөнөөхийн тулд уу. Боорчи, чи хэлээч. Би яах ёстой байв. Боорчид хариу хэлэх чадал нэгэнт үгүй болсон тул чимээгүй болжээ.

Чингис хаан гэнэт дахин догширч

-Чи юунд хөвүүнийг минь хөнөөв. Цэргийг нь хөдөлгөж Монгол нутагтаа дагуулан ирэхгүй яав, чи. Би түүнтэй тулалдаж хэн нь амьд үлдэхээ үзсэн бол дээр байж. Тэгсэн бол би Зүчийн гарт үхэхэд харамсах зүйл үгүй байв. Би Зүчи хөвүүнийхээ амиар юу олов. Их улсаа хураахад минь нөхөр болооч гэснийг нь ашиглан мэхэлж, санаандгүй байсан хөвүүнийг минь чи хороожээ. Би энэ үгийг чинь сонссон хойноо хатан Бөртийнхээ царайг яаж харна. Эх хүн зөн совингоороо мэддэг байж. Гэтэл би гэдэг тэнэг толгой иймхэн юмны учир олохгүй өдий олон жил хуурташ явжээ. Боорчи чи намайг гутаан доромжлов. Итгэлт нөхөр Боорчи чи, намайг илжигнээс дор үзэв. Би чамайг нүдэндээ үзэхийг ч үл хүснэ. Чи үтэр түргэн далд ор. Зайл. Тонил. Боорчи чимээгүй босч явав.

-Амьд дээрээ зайл. Боорчийг гарахын алдад Чингис хаан

-Боорчи хүлээ. Би үгээ дуусгаагүй байна гэсэн тул тэр эргэж суужээ. Хоюул учраа олохоо байж элий балай болон солиорсон мэт болжээ. Боорчи бушуухан тэндээс холдохын түүс болж байв. Угаас гансарч гашуудан хилэгнэж галзуурсан Чингис хааныг тэсч харах, тэвчиж сонсохын аргагүй болж байв.

-Би сонсож байна. Хаантаан. Чингис хаан гэнэт хаанаас ч юм урд нь Боорчийн огт үзэж хараагүй шүр мэт туяарсан жижиг улаан чулуу гаргаж ирээд духандаа хүргэж, зүрхэн тус газраа хэсэг зуур барьж байснаа зүүн гартаа тас атган нүдээ аньж чимээгүй болов. Боорчи ч дахин үг дуугаралгүй Чингис хаан нүдээ нээж түүнийг харах хүртэл тэвчээртэй хүлээж байлаа.Чингис хааны тас атгаастай зүүн гар гэнэт нэвт гэрэлтэн байхыг Боорчи олж үзжээ.Тэрхэн зуур гэнэт дотор нь онгойсон мэт болж бяцхан тайвшраад саяхан л үхдэл адил өгөр зэвхий болчихсон байсан царай зүс нь хүртэл гийж уужирсан Чингис хаан

-Зүчийн үхлийг чи үүрд март. Чи түүнд огт буруугүй. Сэтгэлээ тайван байлга. Харин нутгийн зүг явахаа бүү март.Х элсэн цагт явж үз. Одоо явж амар гэжээ. Чингис хааны энэ гэнэтийн гэмээр тайвшруулах үгэнд сэтгэл багахан уужирсан ч дөнгөж саяхан итгэлт нөхөр нь бүү хэл элэг буруутан ч хараад өрөвдөж харуусмаар гаслан гашуудаж, хилэгнэн догширч байсан багын андаасаа нэг л холдомгүй санагдахад

- Үүр цайтал бас ч зай байна. Танд бараа болж хэсэг зуур хүлээзнэе. Хаан таны цухал жаахан ч гэсэн дарагдаг гэв.

- Би одоо чамд Чингис хаан биш болсон. Хоёулаа анх Хэрлэнгийн эрэг дээр уулзсан Тэмүжин, Боорчи хоёроороо л үлдье. Тэмүжиний энэ элэг дэвтээм ээнэг дотно үгийг сонсоод

-Тийм бол сайнсан гэж Боорчи тайтгаран инээжээ. Хэдий инээж сэтгэл санаа тайвширсан мэт боловч дахин хэзээ ч уулзахгүйгээр салж хагацах гэж байгаагаа хэн хэн нь зөн совин, зүрх сэтгэлээрээ тод мэдрээд үгээр хэлэхэд хэцүү их гунигт автжээ. Энэхүү хагацлын өгүүлшгүй гунигийн дэргэд амьд яваа насандаа тэдний үзэж эдлэсэн зовлон шаналал харин жаргал шиг санагдана.

Тэд нэг их юм яримаар байсан ч нэг насаар салахгүй хамт явсан тул ярих хэлцэх юм нэгэнт үгүй болж дууссан мэт байх ажээ. Зөвхөн хагацахын тулд ингэж олон жил тохой залган зүтгэсэн мэт санагдах нь даан ч харамсалтай. Гэвч тэд цуглуулж хураасан алт эрдэнэс, цуурайтаж мандсан алдар нэрийн алийг ч үл тоон гуйлгахгүй ирж ялгахгүй аваад явдаг аймшигт үхлийн өмнө хүчгүйдэн бууж өгч байгаагаа зөвшөөрч ойлгож чадахгүй байв. Хараалт тэр үхэл ердөө хэдхэн алхамын зайнд ирчихээд аль хэдийн халуун сэтгэл, хатан зүрхэнд нь хар сүүдрээ тусгаад байгааг учир мэдэхгүй балчир хүүхэд ч гуниг хургаагүй нүдээрээ хирдхийн харахаар тод байлаа. Одоо үхлийг буцаах хүч нэгэнт үгүй болсон байв. Үүнийг Чингис хаан мэдэж байсан тул бүх аргаа хэрэглэн үхлээс зугатаахыг хичээж байв.

-Боорчи. Миний сэтгэл тайвширч цэвэршив. Их улсынхаа төлөө хийсэн үйл тул би Хасарын төлөө ч, Зүчийн төлөө ч харамсахгүй байх нь зөв юм. Чи ч өөрийгөө бүү буруутга гэж Чингис хаан тайвшраад хэлэв. Гэвч тэд хоюул Зүчийн үхэлд буруугүй гэдгээ даанч мэдэхгүй байлаа. Чилэгэр бөхийн удам Бичэлдэй хөвүүнийг цавчин алахдаа үхлийн аймшигт дуу хөдлөгөөнийг мэдэрснээс болж Зүчи хачин ихээр айж цочсон бөгөөд сүүлд нь Бичэлдэйн үхэлд харамсан шаналсаар байсан нь Зүчийн сүнс зайлснаас болсон байв.

Хийх ёсгүй үйлийг хийсэн нь Зүчийн үйлийн үр болж тэр мөчид түүний сүнс дахин эргэж ирэхгүйгээр зайлсан байжээ.Үүнийг хэн ч мэдэх аргагүй юм. Бат хөвүүнийхээ ирээдүйн сайн сайхан, тусгаар их улсын төлөө Бичэлдэйг үхүүлэв хэмээн итгэж явсан нь Зүчийн үхлийг дахин хоёр жил саатуулжээ. Боорчи яаралгүй дахин нэг хоног тэвчсэн бол Зүчи өөрөө үхэх байв.Гэвч энэ нууцыг зөвхөн Тэнгэр л мэдэх тул Боорчид юуны буруу байх билээ.

-Тэмүжин анд минь. Би чамайг яаж орхиж явна гэж чи санав гэж Боорчи арга барагдан шивнэжээ.

”Тэмүжин анд” гэсэн үг сэтгэлд хичнээн ойр, уяралтай сайхан сонсдохыг Чингис хаан сэтгэл дэнслэн анзаарчээ.

-Удахгүй уулзах тул сэтгэлээ бүү зов доо, Боорчи минь.

-Тиймээ. Чи бид хоёр удахгүй уулзах нь гарцаагүй. Би үүнд итгэж байна…

Хаа нэгтэй холоос бөөгийн хэнгэрэг дуугарах сонсодсонд тэд чимээгүй болжээ. Боорчи ч үүнийг тов тодхон сонсов.

-Ойрноос нэг хэрмэл тэнүүлч ингэж хүссэн газраа, хүссэн цагтаа бөөлж явдаг болсон гэнэ гэж Боорчи хэлжээ. Харин Тэмүжин түүний хэлснийг сонсоогүй мэт

-Чи явахдаа хишигтэн цэргийнхээ хагасыг дагуул. Одоо дахиад уулзахгүйгээр яв. Хоюул Бурхан халдун ууландаа дахин уулзъя гэв.Боорчи удалгүй Чингис хааны өргөөнөөс гарч явахад нэгэнт үүр цайж бас нэгэн өдөр эхэлж байв. Тэд ингэж өнөө салаад маргааш уулзах мэт хагацжээ. Энэ бүхэн Тэнгэрийн зарлиг байсан тул хэн нь ч зөрчсөнгүй билээ. Тавин жил хамт зүтгэсэн тэднийг хагацуулах нь ганцхан үхэл боловч бас дахин уулзуулах нь үхэл юм. Тийм учраас Боорчи нутагруугаа яаран морджээ. Боорчийн ийн гэнэт явсны нарийн нууцыг Өгөдэйгөөс өөр хүн мэдсэнгүй.

Тэв Тэнгэрийн сүнс эргэн ирснийг Чингис хаан мэдэрчээ. Гэвч Тэв Тэнгэр яагаад ч юм бэ, түүнийг тойрон хүрээний гадуур эргэлдэж зөвхөн ирснээ мэдэгдэх төдий байлаа. Тэв Тэнгэр түүнд туслах гэж ирсэн гэдэгт Чингис хаан эргэлзэж тээнэгэлзэхгүй итгэж байв. Үнэхээр үхлийн сүүдэр ойртон ирэхэд хаа холд хэнгэрэгийн дуу сонсогддог бөгөөд үхэл ч даруй холдон оддог ажээ.

Сүүлийн хэдэн өдөр Чингис хаан Өүлэн эхийнхээ өгсөн Тэнгэрийн тэмдгийг гараасаа нэг мөч ч салгахгүй болсон бөгөөд Хулан хатныхаа хутгыг бүсэндээ байнга зүүдэг болжээ.

Хулангийн ав хомрогын үеэр түүн рүү дайрсан өнөөх аймшигт хар азарганы зүрхэнд зоолттой байсан хутга бол Хулан хатны нь хутга болохыг Чингис хаан андууралгүй таньсан билээ.

Учир нь Хорезмын хаан Мухамедийн эх Туракина хатны зүүж явсан энэ хутгыг Хулан хатан гуйсаар байж авсан юм.

Ингэхэд нь Чингис хаан маш их дургүйцэж яг адилхан хутга хийлгэж өгье гэсэн ч зөвшөөрөөгүй тул аргаа барж билээ.

Тэгээд эрх дураараа хатан нь чухам юунд нь болоод ингэтлээ шохоорхсоныг мэдэх гэж тэр хутгыг ихэд анхааран үзсэн тул тэр хожим хойно ч андуурахгүй болжээ. Гэтэл Хулан хатан нь ганцхан түүнийг аврах гэж л энэ хутгыг зүтгэн зүтгэн байж авсныг сая л нэг мэджээ. Энэ явдал бол Тэв Тэнгэр бөөгийн хэлснээр Тэмүжин, Тэнгэрт ивээгдсэний баталгаа гэж итгэжээ.

Харин үхэл гарцаагүй ирэхийн дохио бол Тэв Тэнгэрийн түүнд өгсөн Тэнгэрийн сахиус алга болсон явдал байлаа.

Тэр сахиусны нууцыг ганц Тэмүжин өөрөө л мэдэх тул алга болсныг нь хэнд ч хэлсэнгүй. Хулангийн авын үеэр догшин хулангийн хөлд өртөн тасарч алга болсон байх гэж таахаас өөр арга үгүй байлаа. Чингис хааны бие болоод сэтгэл санаа хямарч эхэлсний үндэс нь Тэнгэрийн сахиусаа гээснээс болсон гэдэгт тэрээр итгэж байлаа. ”Нутагтаа суу” гэж Өүлэн эх нь Тэнгэрийн нэрээр Барыгжан уулын оройд гарахад захисан нь чухам энэ явдлыг зөгнөсөн хэрэг байжээ. Одоо тэрээр харамсавч нэгэнт оройтжээ. Түүнийг Мөнх Тэнгэр ч үхлээс хамгаалахгүй болжээ. Тэнгэрийн сахиусны хүчээр Чингис хаан хичнээн удаа үхлээс аврагдсаныг тооцоолж хэлэхийн аргагүй байлаа. Тангудыг зорилгүй Тэнгэрийн зарлигийг дагаж нутагтаа суусан бол хэзээ үхэх байсныг бас тодорхойлон хэлэх аргагүй ч нэгэнт буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөрөхөөс өөр замгүй болжээ.

Үхэл хаяанд нь ирчихсэн байгаа нь тодорхой болмогц хүссэнээрээ үхэх хүсэл тэсгэлгүй оргилдог ажээ.

Яг ийн санагдахад Чингис хаан өөрийн эрхгүй Жамухыг дурсан санадаг бөгөөд түүнийг хүссэнээр нь үхүүлээгүйдээ харамсан дэмий зүйл хийжээ хэмээн үе үе гэмших болжээ. Ер нь энэ хэд хоногт Чингис хаан өөрийгөө таних, ойлгохоо нэгэнт больсон байлаа. Эргэн тойрныхон нь ч үүнийг мэдээд түүнтэй маш болгоомжтой харьцаж, бараг зугатаах болжээ. Хаан эцгийгээ эмчлэн сувилахын тулд Өгөдэй хөвүүн нь тэргүүлэн бүгдээрээ бололцоотой бүхнийг хийж байлаа.

Харин Боорчийг Гэрэгийн хамт Монгол нутаг руугаа явсны хойно Алтан улсаас нэгэн өвгөн лам ирж Чингис хаанд бараалхах хүслээ илэрхийлжээ. Есөнтэйн тагнуул туршуулуудын хэлснээр энэ өвгөн лам үхсэнийг ч босгодог шидтэй домч гэж алдаршсан хүн байжээ. Үүнийг шалгаж тогтоомогц Өгөдэй Чингис хаанд айлтгав. Чингис хаан бие тавгүйрхсэнээс хойш энэ тэр отчийн өгсөн эмнээс өөрөө сэжиглэн уухгүй болжээ. Тэрээр хүн бүр өөрийг нь хорлон үхүүлэх бий гэж муу санаж байсан нь эдгэрч тэнхрэхэд нь илэрхий саад болж байлаа. Энэ бол түүний үхлийн эрхэнд орж эхэлсний цаад шалтгаан болохыг Чингис хаан ойлгосонгүй. Халуун ханиад туссан нь ужгирсаар байгааг ч тэр ойшоож үзсэнгүй билээ.

-Өгөдэй чи түрүүлэн уулзаж бай.Би дараа нь оръё гэж Чингис хаан хэлсэн нь ер өмнө нь тохиолдож байгаагүй явдал бөгөөд Өгөдэй ч огт юм бодоогүй ажээ. Хаан эцгийн хэлсэн ёсоор Өгөдэй тэр ламтай уулзав. Олон жил даяанч хийж Буддаг шүтэн гэгээрсэн гэх тэр нанхиад өвгөн нээрээ л хүний сэтгэлийг татмаар ариун дүртэй нь өөрийн эрхгүй шүтэн бишрэх сэтгэл төрүүлэх ажээ. Өгөдэй ёс алдахгүй гэж ламтай ойр зуурыг туршин ярилцжээ.

Өнөө ламыг Учан арш гэх агаад тэр арш Өгөдэйн үгийг сонсож суугаад

-Та залуу хүн гэхэд ухаантай хүн юм. Би таныг их хаан эцгийнхээ нэр сүрийн доор бүх юмыг хялбархнаар бүтээсээр өтөлсөн болов уу гэж бодсон юм. Тань шиг хувь зохиолтой хүмүүс ихэвчлэн ухаан санаа нь хөгжөөгүй, бодол сэтгэл нь түгжигдмэл, голдуу өөрийгөө ихэд бодож биеэ тоосон мулгуу амьтад болсон байдаг юм гэвэл Өгөдэй

-Та намайг бодоод арай зөөлрүүлж хэлж байгаа юм биш биз. Би танд яг тийм хүн шиг санагдаж байна уу. Та үнэнээ шууд хэлбэл сайнсан. Би ил үнэн үгэнд дуртай. Чингис хаан эцэг маань биднийг ингэж хүмүүжүүлсэн юм. Та айх явдалгүй. Үнэн санаагаа хэлэгтүн гэжээ.

-Би үхлээс айдаг наснаасаа өнгөрсөн хүн тул ямар ч их хаанаас үл айна. Бас үнэн үг хэлэхээс ч үл айна. Та миний хэлсэнд итгэж болно. Би дөрвөн улсын хэл нэвтэрхий мэднэ. Монголчууд та нарын хэл заншлыг би хамгийн эрт сурсан.

Учир нь танай өвөг дээдэс цаг үргэлж л миний удмынхны гэр оронг уулгалан дайрч хүнс, үр тариаг дээрэмддэг байв.

Одоо цөлмөн дээрэмдэхээс хэдийн хэтрээд бүр нутаг орныг минь эзлэн суухаар ирж байна. Харин таны эцэг Чингис хаан эрдэм номтой, ухаантай хүмүүсийг үнэлж түшдэг, үг сургаалийг нь хүндлэн дагадаг гэж сонссон тул би өөрийн нүдээр үзэж, биеэр уулзахаар ирлээ. Би дорно дахины бүх газар орноор зорчиж бумбын болоод Буддагийн ном сургаалыг үзсэн хүн хэмээн ярьж байтал Чингис хаан гэнэт орж иржээ. Нанхиад арш босч мэхийв.

Чингис хаан огтхон ч ёс төр гүйцэлдүүлэлгүй гайхмаар хүйтэн царай гарган суужээ. Өгөдэй хаан эцгийгээ бүр ойлгохоо больжээ.

-Эрхэм нанхиад хүн таны алдрыг дуулсан тул би уулзахыг зөвшөөрсөн билээ. Би танаас хэдэн зүйл асууя.

-Хаан та намайг шалгаж сорих гэв үү гэсэнд Чингис хаан

-Үгүй. Би нанхиад хүн чиний үнэн үгийг сонсох гэж хүснэ. Би сая чиний ярихыг зах зухаас сонсов. Миний өвөг дээдэс чиний удмыг дээрэмдсээр иржээ гэв үү. Тэгвэл танай нанхиад иргэд малчин монголчууд бидний бэлчээр газрыг сэм сэмээр эзлэн түрж элсний нүүдэл шиг чив чимээгүй өдөр хоногоор ахих тул хэчнээн таслаж зулгаавч үндэс яргаж үрээ цацсаар байдаг хогийн ургамал мэт тэднийг бид үтэр хөөн зайлуулах нь зөв буй заа гэж хилэнтэй асуужээ. Чингис хааны хүйтэн царайлсны учир энэ байжээ. Уг нь Чингис хаан аливаа элч хийгээд өргөө ордныг нь өөрөө зорьж ирэгсдэд дандаа сайнаар ханддаг заншилтай мөртөө нанхиад аршийг үзээд ийнхүү хилэгнэсэн нь түүний хэлсэн их үгнээс болжээ.

Гэтэл хөгшин арш их хаанаас огт айж сүрдсэнгүйгээр барахгүй

-Нүүдэлчин омгийн байнгын довтолгооноос хамгаалах гэж манай хаад их Цагаан хэрмийг барьсан нь одоо ч таны өмнө давшгүй даваа, дарагдашгүй хүч болон хөндөлдөж буй. Та үүнийг яах гэж барьсан гэх бол. рай Монголчууд үүнийг барьсан гэхгүй байлгүй дээ гэж ихэд даажигнан асуужээ. Чингис хааны өмнөөс ийн аймшиггүй дуугарах зоригтон байна гэж огт санаагүй Өгөдэй энэ хөгцөн шүдэт хөгшин аршийн хэгжүүн үгнээс болж хаан эцэг нь хилэгнэн догширч биеэ муутгахаас их эмээж байв.

-Та үнэн үгэнд тун ойрхон байна. Үнэндээ бол энэ их Цагаан хэрмийг биднээс айсан нанхиадын хаад барьсан юм биш. Нанхиадуудыг хойд зүг хорхой адил мөлхөж хорт могой шиг гулсаж ирэхээс болгоомжлон та нар өөрсдөө давж ирэхээргүй тэр шавар хэрмийг нүүдэлчин омгийнхон бид та нараар бариулсан юм . Энэ цагаан хэрэм та нарыг биднээс биш харин биднийг та нараас хамгаалж байгаа биш үү.

-Таны хэлж буй бол зоосны нэг тал. Зоосыг газар хаяхад аль ч талаараа унаж мэднэ.

-Одоо бидэнд тэр шавар хэрэм хэрэггүй. Ертөнцийн бүх улс хоорондоо эв найрыг сахиж нэгэн дээвэр доор Чингис хааны Их Монгол улсад нэгдэн дайн дажингүй энх амар амьдрах цаг ирж байна.

-Таны зориг, зорилго хоёр их гэдгийг би гадарлана. Та мөнх бус. Таны энэ их хүч ч мөнх байхгүй.

Ертөнцөд мөнх юм гэж үгүй тул Хаан таны сүр хүч, хураасан их улс нэг л өдөр үгүй болно.

-Гэвч газар дэлхий байсаар, хүн зон амьдарсаар, тэмцсээр, улс гүрнээ байгуулсаар байх биз. Тийм болохоор ямар юм мөнхрөх, юу нь ул мөргүй үгүй болох тухай та бид маргаад яах вэ. Мөнхрөхийг хүсэхгүй хэн байна. Та ч мөнхрөхийг хүсч буй.

-Тиймээ. Хүн угаасаа үхэхийг үл хүснэ. Тэгэхдээ үхлийн хажуугаар өнгөрөх хүн нэг ч үгүй. Харин хүний сайн үйл мөнх биш юм гэхэд олон зуун жилээр үлдэж болно. Та одоо цагаан хэрмийг хар. Дахин хэдэн зуун жил болоход байж л байна.

Түүний адил Хаан та ч сайн үйл бүтээе гэвэл болох биз. Хэрэв та одоохон их цэргээ гэдрэг

татан бидний нанхиад улсыг амар тайван орхивол тэр таны бүтээх хамгийн их ариун үйлс болохсон. Би үүнийг л таниас хүсэх гэж өдөр шөнийг ялгалгүй зүтгэж өвгөн биеэ чилээн зовоосоор хүрч ирэв. Бид цагаан хэрэмнийхээ хойно урд талд аль аль нь амар жимэр амьдран сууцгааж болно шүү дээ.

-Ийм хэргийг би тантай хэлцэх ёсгүй. Алтан улс бол монголчуудыг хэдэн үеэрээ түйвээн бусниулж түрэмгийлэн хорлосоор ирсний ялыг тантай хэлэлцэх билүү би. Ухаантай зоригтой эрчүүдийг маань алан хядаж, уяхан туяхан бүсгүйчүүдийг нь булаан эмлэж,удам сайт мал сүргийг нь уулгалан дээрэмдсээр ирсэн биш үү, та нар. Би үүнийг тэвчин суухын аргагүй. Ертөнцийг нэгтгэн нэгэн жолоогоор залж хүн зоныг нь амирлуултал миний санаа үл амарна. Энэ хэргийг би эс гэхэд миний хөвүүд гүйцэлдүүлэх биз. Та энэ хэрэгт ухаан зарах хэрэггүй.

-Өвгөн арш би Хаан таны саруул ухаанд найдан энэ үгийг хэлсэн билээ. Нэгэнт тохиосон үйлийг дагахаас өөр замгүй.

Магадгүй таны асаасан талын их түймэр их далайн ус хүрч байж унтрах буй. Бас салхи эргэвэл таны өргөөг ч агшин зуур өршөөлгүй түймэрдэж мэднэ.

-Та их мэргэн ухаантай үг хэлэв. Би таныг их тоож байна. Таны сурсан үзсэн их биз.

-Тийм ээ. Би хатангир хүнийг таргалуулж халзан хүнд үс ургуулахаас эхлээд аливаа муу муухайгаас ангижруулах, түүний дотор өвдөх өвчин, өршөөлгүй зовлонгоос гэтэлгэх хүртэл олон эрдэм үзлээ. Сансар огторгуйн явдал, сар нарны хөдөлгөөн гээд надад үзээгүй, судлаагүй зүйлгүй.

-Яах гэж энэ их юмыг сурах гэж бие сэтгэлийг чилээн зүтгэнэ, Та. Хэнд хэрэг болно гэж ийнхүү нэгэн биенд хэтийдэм ихийг хураана, Та. Өвгөн арш танд үр хүүхэд гэж бий юу

-Эрдмийг энэ биендээ хэрэглэх гэж сурах бага хэрэг. Би бусдад хүртээх гэж, эртний заяатай нанхиад улсаа баян хүчирхэг, бялхам тансаг байгаасай. Алтан улсын савраас мултарч амар тусгаар болоосой гэсэндээ үсээ цайж үеэ мойнийтол суув. Би хүсвэл таны дэргэд шадарлан суухад ч татгалзах зүйлгүй.

-Миний санахад та нанхиад улсынхаа төлөө зүтгэвэл зүйтэй буй заа. Харин та хүнийг өвдөх зовлонгоос хэрхэн салгана вэ. -Энэ амархан. Би нэгэн шидэт үрэл бүтээсэн юм. Бумбын сургаалийн ид шид шингэсэн энэ үрлийг хүртсэн хүн хормын дотор Тэнгэрийн оронд очдог. Ямар ч зовлон шаналал үгүй. Энэ бол зовж шаналсан, амьдрах итгэлгүй болсон хөөрхий ядуусыг аврах буян болох сайн үйл юм гэсэнд түүний яриа Чингис хаанд таалагдав бололтой магнай нь тэнийгээд -Би таныг хүндэтгэн зоог барья.Та татгалзахгүй буй заа гэж Өгөдэйг зангахад тэр гарч тэд хоёул үлдэв

-Ухаантай хүнтэй үг солиход үүлтэй тэнгэр цэлмэх мэт оюун санаа онгойно. Та тэр шидэт үрлийнхээ хүч чадлыг надад үзүүлж болох уу гэж Чингис хаан Өгөдэйг гарсан даруй яаран асуужээ.

-Энэ бол би танд л итгэж хэлсэн нууц шүү. Хаан төрийг барина гэдэг хүчир ажил. Магадгүй

ийм үрэл танд хэрэг болж мэдэх юм.Би танд тусалж болно.Та шан харамж гэх зүйлгүй. Энэ байна гээд арш уутнаас үрэл гаргаж өгчээ.

-Та хэрэглэмэгц ухаан санаа цэлмэн гэгээрээд даруй ариун хутгийг олж аливаа бүх өвчин зовлон мартагдан илаарших болно. Би таныг бие чилээрхэн тавгүй байгааг дуулаад ингэж сайхан сэтгэл өвөрлөн ирлээ. Та наад үрлээ хүртмэгц ямар шидтэйг тэр дороо үзэх болно.

-Тийм үү. Та тэгвэл надад хоёрыг өгнө үү.

-Хоёрыг турших хэрэггүй. Нэг л байхад хангалттай. Та итгэлтэй байж болно.

-Хаан би ч ганцыг хүртэхэд болно гэж үү.

-Та их наргианч хүн юм. Та адилхан л мах цусанд төрсөн хүн. Нэг л болно.

-Би эргэлзэж байна.Би үзээгүй тул итгэмгүй байна.

-Та наад үрлээ амандаа хийгээд үзэгтүн.Тэгвэл та миний хэлсэнд итгэх болно. Гаднаас идээ будаа оруулж ирсэн тул тэдний яриа тасарчээ. Өгөдэйг гар гэсэн тул тэр ч гайхсаар гарчээ. Эцэг нь энэ нанхиад арштай юуг ингэтлээ нууцлан ярьсаар байгааг тэр ойлгож яджээ.

-Нанхиад хүн чи мөнхрөх хүн нэг ч үгүй гэж хэлэв үү.

-Тиймээ энэ ертөнцөд мөнх зүйл үгүй.

-Нанхиад хүн чи буруу л ярьж байна. Их хэргийн төлөө өөрийн аз жаргал эд хөрөнгө нэр төрөөсөө татгалзан үхэж чадвал тэр бас мөнх нас болно.

-Ингэж итгэж үхсэн хүн хичнээн олныг тоолж яаж барна. Тэдний хэд нь эдүгээ мөнхөрснийг хэн яаж мэднэ. Хаантан та ийм аргаар мөнхрөх гэвэл алдаа болно. Гэхдээ танд ийм зориг зүрх байгаа гэдгийг би харж байна.

-Хүн хэрэгтэй цагт л үхэж сурах хэрэгтэй. Би ч, та ч, бүгд тэгэх ёстой.

-Санаснаар үхнэ гэдэг өчүүхэн төдий зоригийн хэрэг шүү дээ.Г эхдээ би хаан тантай маргах хүсэл үгүй байна. Би тантай санаа бүрэн нэг байна. Амтат идээ будаагаар дайлсанд талархаж байна.

-Та аль нутгийн хүн бэ.

-Би өмнө зүгийн Шэнлүшаан уулын хүн. Тэнд миний төрсөн нутаг буй.Шэньлюля гэж тосгон буй. Аав минь тэнд илжгэнд хөллөсөн анжсаар газар хагалдаг байлаа. Би аавдаа тусалж, илжгийг нь тууж өгдөгсөн.

-Аав тань тэнгэрт хальсан буй заа.

-Тиймээ. Аав минь олон жилийн өмнө нас элж, шарилыг нь Шэнлүшаан уулын энгэрт

оршуулсан. Би ч гэсэн хэзээ нэгэн цагт тэр ууланд эцгийнхээ дэргэд нутаглахсан гэж хүсдэг юм.

-Би таныг хүссэн ёсоор тань Шэнлүшаан ууланд эцгийн тань хажууд оршуулахыг зарлиг болгомц.

-Шэнлүшаан уул хүртэл газар хол, зам зуур олон боомт бэхлэлт нанхиадын шилдэг цэргүүд тосч буй тул таны зарлигийг биелүүлэх боломжгүй л болов уу

-Та битгий санаа зов. Бүтэхгүй зүйлийг би юу гэж зарлиг болгох вэ.Харин та надаас хүсэх зүйлээ хүссэн тул би танд нэгэн хүсэлт тавья гэж Чингис хаан хэлсэнд арш жаахан гайхсан ч их л даруухан аар

-Би биелүүлж дөнгөх болов уу гэжээ.

-Тэр амархан гээд Чингис хаан хундаганд дарс дүүргээд дотор нь үрлээ хийв.

-Та энэ дарсыг тогтооно уу. Энэ дарс бол хүний хүслийг хангагч Монгол газрын идээ юм. Дотор нь таны шидэт үрлийг хийсэн. Идээ эзнээ таньдаггүй гэдэг юм гээд барьжээ.

-Хаантан та юу хүснэ вэ. Миний өгсөн үрэл хор шүү дээ гэж нанхиад арш балмагдан хашгирч босон харайжээ.

-Би нанхиад хүн чамайг зовлонгоос гэтэлгэхээр шийдлээ. Би ухаантай хүнийг хүндэтгэнэ. Тийм учраас өөр үхлийг бус, таны өөрийн зохион бүтээсэн энэ үхлийг танд зориулж байна. Би таны хүсэл ёсоор Шэнлүшаан ууланд эцгийн тань дэргэд оршуул гэж тушаамц.

- Та намайг ингэж алах хэрэггүй. Би таны дайсан биш. Би үхэх болоогүй.

-Та нанхиад улсын төлөө зүтгэнэ гэв. Тэгвэл удахгүй тэр нанхиад улс тань Алтан улстай хамт үүрд үгүй болно. Бас та манай цэргүүдэд тас цавчуулж үхэхгүйгээр эндээ хүндтэйгээр үхэх нь дээр буй. Уугтун. Та нанхиад улсынхаа төлөө тогтоогтун гэж Чингис хаан туйлын таашаалтайгаар хэлээд хундагатайгаа барин аршын дэргэд очив.

-Хаан та үнэн хэлж буй биз. Би үхэхээс үл айна. Нанхиад улсынхаа төлөө би тогтооё. Чи хэзээ ч миний улсыг дийлэхгүй биз гээд өвгөн арш хорыг даруй уужээ. Хормын төдий чимээгүй байснаа дотор нь бачууран цээж хүзүү хоолойгоо урж

-Чи талын зэрлэг махчин. Гэмгүй улс орныг сөнөөн устгагч араатан. Чиний өмнө ганцхан үхэл сүйрэл л бий. Чи ертөнцийн хамаг сайхныг сүйрүүлэн хөнөөгч. Чамайг хараал идэг гэж өөрийн хэлээр галзуурсан мэт орилсон тул Өгөдэй орж иржээ. Чингис хаан инээж гар өргөн Өгөдэйг хүлээ гэж дохижээ.

-Чи үхлийн муугаар үхнэ. Чамайг миний үр удам, чиний сүйтгэсэн улс иргэдийн үр удам үргэлж хараах болно. Чи бол хүн биш, алуурчин гэж хашгираад ширдгэн дээр унаж тэр дороо амьсгал нь тасарчээ. Өгөдэй гайхсан ч юм асууж амжсангүй.

-Би энэ нанхиад хүний үнэн дүрийг үзэв. Чи ч үзэв. Нанхиад хүний үнэн дүр энэ ажээ. Намайг хорлох гэж ирээд өөрөө тэр хорондоо үхэв. Энэ нанхиадын хүүрийг Шэнлүшаан ууланд эцгийн нь дэргэд нутаглуул. Би амласан юм.

Би Алтан хааны илгээсэн хорыг түүний элчид уулгаж хөнөөв. Тэр намайг хорлон алах гэж энэ аршийг илгээжээ. Одоо тэр аюул өнгөрөв. Сэтгэл минь ханав хэмээн Чингис хаан ихэд сэтгэл бахтай хэлсэнд Өгөдэй

–Та яаж мэдэв гэж ихэд гэмшин асуужээ.

-Хөвүүн чи бүү сэтгэлээ зовоо. Та нар үүнийг мэдэх аргагүй. Харин надад Тэнгэр хэлжээ гээд Чингис хаан гар сунган Тэнгэрт залбирчээ. Өгөдэй гайхах үл итгэх хослон зогсов.

-Одоо би тэдэнд үнэн дүрээ үзүүлсүгэй. Түрэмгий балгасыг эвдэн сүйтгэ. Хэнийг ч байсан амьд бүү үлдээ. Хэн нь махчин араатан болохыг үзсүгэй. Бушуул. Цэргээ хөдөлгө гэж хашгираад Чингис хаан ухаан алдан унажээ.

...Цэв цэнхэр тэгсэн мөртөө гайхалтай тунгалаг манан дунд Тэмүжин хаашаа ч юм бэ давхиж оржээ. Бөртэ өлгийтэй нялх хүүгээ тэврэн зам тосон зогсож байлаа. Энэ замаар Тэмүжин нөхдийн хамт эргэн ирэх ёстой ажээ. Нээрээ ч удалгүй алсад морин төвөргөөн сонсдов. Бөртэ чимээ чагнан сэтгэл догдлоод

-Хөвүүн минь чи сонсож байна уу. Аав чинь чамайг төрлөө гэж мэдээд ийм хурдан эргээд иржээ. Чи хар даа тэр.

Аав чинь тайчуудын Таргудайг дараад иржээ. Тэр ачаа хөсөг морь малыг нь хар. Лавтай аав чинь их олзтой, ирмүүн баяртай ирж явна. Чи их азтай хүү юм даа. Чи аавынхаа дайснаа дарсан өдөр мэндэлжээ. Аавдаа бас ялалт авчирчээ. Аав чинь яасан их баярлах бол гэж өлгийтэй хүүхэдтэйгээ ярьж зогсохыг Тэмүжин харж байв.

Тэмүжин Хасарын хамт түүний дэргэд давхин очив.

-Чи яагаад энд ганцаараа зогсоно вэ.

-Би чамайг бусдаад түрүүлж тосоё гэж санаад ...

-Яасан болгоомжгүй юм бэ. Тайчууд бидний араар явж байвал яана. Үүнээс хойш бүү ингэж хүрээнээс хол яв гэж Хасар түрүүлэн хашгирчээ..

-Тэмүжин чи хар даа. Чи дахиад хүүтэй боллоо.

-Хүү юу гэж Тэмүжин баяртай хэлээд үнсэв.

-Надад баатар эр хэрэгтэй. Миний хүсэл лав биелнэ.

-Тэмүжин хүүдээ нэр өгөөч

-Аав нь чамайг Өгөдэй гэж нэрлэе. Өгөдэй, Өгөдэй гэж хөвүүнийхээ чихэнд хашгирна.

-Тэмүжин би чамайг үхэв гэж зүүдэллээ. Үүнээс хойш гэртээ суу. Би чамайг гуйя гэж Бөртэ уйлсанд

-Тэгвэл би мөнхрөх нь л дээ гэж Тэмүжин хөхөрч байв. Энэ үед Боорчи, Зэлмэ нар ирэв.

-Харцгаа та нар. Энэ Тэмүжин ахын хөвүүн Өгөдэй. Бид Тайчуудтай тулалдаж байх зуур хөвүүн мэндэлжээ.

Тэмүжин ах гурван хөвүүнтэй болов. Өгөдэй, Өгөдэй, Өгөдэй гэж Хасар хашгирсаар байтал өнөөх цэнхэр манан хийсэн одоод оронд нь гэрийн унь тооно тодорчээ.

”Хасар чи юунд ингэж түрүүлэн дуугарч түрэмгий загнана вэ. Өгөдэй чинь миний хөвүүн биш үү” гэж бодоод Чингис хаан сэргэжээ. Газар доргин хөдөлж байх нь гэр тэрэг явж буйг гэрчилнэ. Ухаан алдаад сэргэж буйгаа Чингис хаан мэдэв.

Бас хойд насандаа түр очоод эргэж ирснээ гадарлав. Тэнд Хасар түүнийг хүлээж байгааг сая харжээ.

Одоо үхэл яг тоононы ирмэг дээр суугаад далбилзан хөдөлж, бас их доогтойгоор инээж байгаа нь тов тод танигдаж байв.

Хасар дүү нь болоод Бөртэ зүүдэнд орсон нь үхлийн эцсийн дохио болохыг Чингис хаан ойлгов. Чингис хаан насан эцэслэж байгааг Бөртэ зөнгөөрөө мэдээд яг энэ мөчид ухаан балартан унасанд Туулын хөндийн хүрээ даяараа түүнийг сэхээх гэж сандарч байцгаажээ. Үхлийн дохио Бөртэд адилхан үзэгджээ. Бөртийн яаж тарчилж байгааг Чингис хаан мэдэрч байв.

Түүнийг үхэхэд хамгийн ихээр гашуудан шаналах ганц хүн бол Бөртэ юм. Үхэл алгуур холдоход Өгөдэй дэргэд нь ганцаар сууж байхыг харжээ. Амжих хэрэгтэй гэж Чингис хаан шаналан бодов.

-Өгөдэй. Би чамайг дуудав. Би сая чамайг бас ижийг чинь зүүдлэв. Би Бөртэ хатан эхийг чинь санав. Үхэл одоо намайг нэхэн энд иржээ. Тэр миний сүнсийг авч явахаар хүлээж ядан байна. Хөвүүн чи сайн сонс. Хөвүүн минь надаас хойш эхийгээ сайтар асар. Би их хаан суусан ч эхийг чинь ер жаргаасангүй. Бүтэн биеийг нь дөрөв хуваж зовоов. Тийм бус уу. Би эхтэй чинь уулзаж чадахгүй тул миний ингэж хэлснийг эхдээ дамжуулаарай. Арван настай Бөртэ охиныг би одоо тод харж байна. Тэр намайг лав өршөөх биз.

-Хаан аав та санаа бүү зов. Та нутагтаа очно. Ээж таныг тосч авна… гэхдээ Өгөдэйн нүднээс нулимс асгарсаар ажээ.

-Тийм бол сайнсан. Би ээжийн чинь өвдгийг нь дэрлэж хэвтээд үсээ самнуулах дуртай юм. Ингэж үсээ самнуулж хэвтсэнгүй хичнээн удав. Би ээжид чинь залуу үедээ нэг тангараг тавьсан юм. Тэр тангаргаа няцсан тул би их нүгэлтэй хүн шүү. Хүү чи мэдэж ав.

-Та юу ярина...

-Би Бөртэд боолынхоо охинтой самуурахгүй гэж тангаргаласан юм. Тэр тангаргаа би эвдсэн. Гэвч тэр хүүхэн үхсэн.

Бөртэ ээж чинь ямар их тэвчээртэй, ухаантайг чи мэдэхгүй. Ээж чинь миний бие сэтгэлийн тал нь юм. Бөртэ энд байвал би лав ингэж хэвтэхгүй. Хүнд авааль эхнэр шиг хүн хаана олдоно. Ядарсан ч, задарсан ч үрийн минь эх л дэргэд байж баяр гунигийг цуг хуваалцана. Тийм тул би Бөртийг яаж мартана. Хөвүүн чи Тулуй дүүгээрээ ээжийгээ асруул. Отгон хөвүүн голомтоо сахиг. Тэр голомтыг эх чинь нэг насаараа манаж суув. Одоо бүү осолд. Бүү цалгард. Зөвд зөөлөн, бурууд хатуу бай. Цэргээ асар. Цэргийг эс асарвал чи яаж жанжин болно. Ухаантныг түш, уруудсаныг эргүүл. Ард олон идэх хоолтой, элбэг баян бол чиний улс бат бэх байх болно.

Цагадай ах чинь түргэн зантай, түрэмгий ааштай ч буулт нь зөөлөн. Түүнийг аяар нь байлга.

Тулуй лав чиний үгнээс үл зөрнө.

Батыг чи Зүчи ахынхаа адил хүндэтгэж өөрийн хүү Гүюгийн адил захирч яв. Батын сэтгэл тогтворгүй болж мэднэ. Сүбээдэйг Батын дэргэдээс бүү холдуул.

Боорчийг аливаад бүү албад. Тэр үхтлээ юу хүссэнээ хийж яваг. Залуу халуун насны итгэлт олон нөхдөөс минь одоо тэр л ганцаар үлдэв. Би түүний хамаг аз жаргал, хайран сайхан залуу насыг булаан авчээ. Тэр ийм үйлтэй байж.

Боорчийг эцгийн адил асар. Чи Гэрэгийг бас сайн асар. Гэрэг бол Боорчид тэнгэрээс заяасан ганц үр нь юм шүү. Түүнийг бүү үхүүл. Чи өөрийн охидоос нас бие гүйцмэгц Гэрэгт өг. Боорчи лав баярлана.

Билгүтэй авгынхаа үр удмыг сайтар асар. Билгүтэй надад өргөсөн тангаргаа эвдэлгүй үхтлээ үнэнч зүтгэснийг бүү умарт.

Хасар авгын чинь үр сад өрсөлдөн тэмцэлдэж магад. Тэднийг Хөлөн буйрын талаас бүү нааш өнгөрөө. Тэнд нь суулгагтүн.

-За.Таны хэлснээр би бүгдийг хийе ...

-Чи өнөөдрөөс хаан мэт явагтун. Хүний тусыг бага гэлгүй амь тавьж хариул. Цэргийн дотор баатар бодлогыг сахь. Төрийн үйлд төв чигийг эрхэмлэ. Энэ дөрвийн нэгийг ядаж эрхэмлэн явбаас эр хүнд нэг насны үйлс болно. Би арван дөрвөн наснаас цэргийг засч, төрийг хүчирхэг түвшин байлгахыг хичээв. Би таван өнгө, дөрвөн хэлийн их бага дөчин улсыг хураан нэгтгэв. Гэвч одоо бодвоос тун бага зүйлийг амжуулжээ. Амарч цэнгэсэн минь хэтэрч алт шиг өдрүүдээ дэмий үрсэн байна. Харин юуны учир хүн болж хүзүү сээр холбосныхоо учрыг ойлгосон минь гавьяа болно. Би хөвүүд та нарт энэ ертөнцийг эзлэн нэгтгэх их замыг нээж өгөв.

Одоо Цагадайн өмнө лалын мөргөлтний бүх улсыг нэгтгэх зам нээлттэй боллоо. Түүнийг баруун урагш давшуулж юуны түрүүн тэр Багдадын их үгт халифыг дайлан дарж түүнээс султан цол олгодог дархан эрхийг нь даруй хураан ав. Тэгээд цааш Улаан тэнгисийг өнгөрч Мисир орныг эзлэн ав гэж даалга.

Батын өмнө загалмайн мөргөлтний улсууд бүгд сүйрэн унах үүд нээлттэй бий. Тэр хөвүүнийг Сүбээдэйн хамт явж загалмайн мөргөлтний бүх улсыг нэгтгэн их улсад захируулахыг захь. Хамгийн эхлээд дотроо эв түнжингүй байгаа Орос улсын талыг эзлэн авч дараа нь оросыг оросоор нь даруулагтүн.

Харин хөвүүн чи өөрөө энэ дорно зүгийн улс орон, Буддад шүтэгч улсуудыг хураан авагтүн. Алтан улсын бүх шилдэг цэрэг Дунгуан боомтод бий. Дунгуан бол өмнөө их уултай умартаа их мөрнөөр хашигдсан эзлэхүйеэ бэрх боомт. Харин Сүн улстай найрамдлаа батлаад нутгаар нь дайран гарч Алтан улсын өмнөөс довтолбол тэд Дунгуан боомтоос цэргээ санд мэнд гарган өмнө зүг татна. Тэр үед нь амжиж довтлон дарвал зохино. Тулуй дүүгээ чи өөртөө хавсруул. Харин Тулуй дүү чинь эх Монгол нутагтаа эцэг өвгөдийнхөө шарилыг сахин сууг. Энэ Монгол нутаг чинь ядрахад хоол, явгарахад морь, унтахад гэр чинь болох юм. Тэгээд хөвүүн чи миний хэлснээр хийж тэр Христос, Будда, Мухамед гурвыг Мөнх Тэнгэрийн хүчин дор нэгтгэн үнэн сүсэгтнүүдийг нь хураан захирч суу. Ер хүмүүний сэтгэл санааг дагуулвал үйл нь аяндаа дагана гэдэг юм. Миний алтан ургийн хөвүүд та нарт бурханы, загалмайн, лалын мөргөлтөн иргэдийг тус тусын нутагт нь нэгтгэн Мөнх Тэнгэрийн хүчин дор захиран суухыг Тэнгэр зарлиг болгожээ. Үүнийг бүү март. Хэзээ ч бүү цалгардаж осолд. Чамд хаана ч, хэнд ч байхгүй хүчирхэг их цэрэг, сэтгэл санаа нэгдсэн албат иргэдтэй, дэлхийд жишиггүй Их улсыг өөрийн биеээр хүлээлгэн өгөв.

Одоо хөвүүн чамайг юуны учир хаан суурind шилэн өргөмжилсний учрыг хэлье. Энэ учрыг ганц би л мэдэх юм.

Чамд бусад ах дүү нараасаа онцгойрч Тэнгэрт тоогдсон хоёр үйл бий.

Нэгд, чи намайг Алтан улсад дайтаж явахад “Одоо энэ Алтан улстай дайтах нь цаг болоод цэргийн гарз болно. Харин баруун зүгийн улсууд дотроо эв нэгдэлгүй, хэрүүл тэмцэл ихтэй тул эзлэхэд хялбар “гэж үнэн санааг хэлж үйлс ялалтын үүдийг нээж туслав.

Хоёрт, “Хаан эцэг та өөрөө зорин очиж байлдан эзлэх цагаа эцэслэж харин энэ газрын хүмүүс өөрсдөө Таныг зорин хуйлран ирж нэгдэх тийм улсыг байгуулж Орхоны хөндийд Хархорум гэдэг их хотыг цогцлоон ертөнцийн төв болгоё” хэмээн алс ирээдүйн замыг заасан мэргэн үг хэлэв.Y үний тулд би чамайг эргэлзэх зүйлгүйгээр хаан суурind сонгосон билээ. Би чиний хэлснийг бүрэн гүйцэлдүүлж чадсангүй. Харин чи өөрийн хэлснийг марталгүй энэ мэт мэргэн санаагаа хэрэгжүүлэн Хархорум төвтэй нэгэн их улсыг газар дээр байгуул. Хархорумыг цогцлоох Орхоны мөндий бол газар дэлхийн их хүч гайхамшигтайгаар хурсан урам зориг сэргээж, ухаан бодол саруулсгах увьдис шидтэй, өөдөлж мандахын хишиг буян төгс нутаг шүү.

Чухам тэр л газар алтан ургийн аз хийморь төгс бадарч Их улсын нийслэлийг зорьсон газар газрын олон хэл, шүтлэг мөргөлтний хөл тасрахгүй байхыг би одоо тодоос тод харж байна.

Тэндээс нийслэлээ бүү хөдөлгөөрэй. Осолдож хөдөлгөх аваас алс хэтдээ Монголын заяа хазайж Их улсын минь сүр хүчин, алдар суу сарних вий. Түрэг болоод Хүннүгийн үеэс тэнд их улсын нийслэл байжээ. Үүнийг үүрд санаж үрийн үрд уламжлан захиж үлдээ. Чингис хаан миний нэрийг хэзээ ч муугаар бүү дуудуул.

Миний бие үгүй боловч Чингис хааны их суу алдар Тэнгэр мэт олон монголчуудыг үүрд ивээж мөнхрөх болно…

Би Алтан улсын ганц нэг боомтыг өөрийн биеээр авч эс чадсандаа харамсаж байна. Гэвч нэгэн бие дуусавч надаас дутахгүй хөвүүд, ач үрс минь их хэргийг гүйцээн миний хүрээгүйд хүрч, амжаагүйг гүйцэлдүүлнэ биз. Их хаан ор суух хөвүүн чи туйлаас хичээ…

-Хаан эцэг минь. Би хичээнгүйлэн сонсч байна гэж Чингис хааны амьсгаа дарахын хооронд Өгөдэй бишрэн шивнэжээ.

-Бүх цэргийг дээд доод гэлгүй их цаазад захируул. Сайдыг санааны туйлд бүү хүргэ. Түшмэдийг манлайн суудалд бүү суулга. Сайд, түшмэд чинь санааны туйлд хүрч, суудлын дээдэд сууваас санаа нь цадаж чармайн зүтгэх нь багасаад улс төрд хохиролтой, хүмүүжил сурталд муу нөлөөтэй болно. Хөвүүн чи одоо Их хаан болов. Үүнийг бүү март.

Өглөө бүр нойрноосоо сэрүүт Их хаанд дүйх агуу үйлсийн тухай бодож бай. Боорчи, Мухулай хоёр зөв явдлыг минь зөвшөөрөн тэтгэж, буруу явдлыг буцаан зогсоож энэ их суурин хүргэв. Хөвүүн чамд чухам ийм үнэнч нөхөр амь мэт чухал. Төр, цэргийг хэрхэн засахыг Боорчийн амьд ахуйд түүнээс асуугтун. Би хийдгээ хийв. Одоо цаг минь болов. Үүнээс илүү удвал би та нарт гай болно. Намайг босго…

Өгөдэй эцгийгээ өргөн босгов.

-Үгээ хэлж сэтгэл минь амрав. Намайг үхсэн хойно бунхлахдаа энийг зүүн гарт минь атгуулаарай. Энэ бол миний төрөхдөө атгаж төрсөн Тэнгэрийн тэмдэг юм. Үүний ачаар би чадал хүчин мөхөсдөхийн цагт баатрын тэнхэл авч, бодол санаа ахардан мухардваас саруул ухааны авшиг хүртэж, амин насны гал бөхөх цаг ирсэн энэ өдрүүдэд ч үүнээс ухаан, тэнхээ сэлбэн аймшигт үхлийн өөдөөс дальдрахгүй харж, оюун сэтгэл хиргүй цэлмэг байсаар хорвоогоос явах мөч тулав. Одоо би Тэнгэрийн их хүчийг үүнээс авах хүсэлгүй болов. Иймээс би үүнийг биенээсээ салгаж байж л энэ хорвоог орхих учиртай. Харин миний захиж хэлсэнчилэн үүрдийн амгаланг олсныхоо дараа би үүнийг орчлонд анх ирсэн шигээ зүүн гартаа атган мөнхрөх ёстой юм шүү. Өүлэн эхийнхээ аминчлан захиж хэлснээр энэ Тэнгэрийн тэмдгийг нүд үзэж, хөл хүрэхгүй газарт би өөрийн хамт авч явья. Намайг бунхлахдаа Тэнгэрийн тэмдгийг зүүн гарт минь атгуулаарай. Би Өүлэн эхийнхээ ухааныг дөнгөж сая л нэг гүйцэв гэж Чингис хаан хэлээд шүр мэт улаан өнгөтэй Тэнгэрийн тэмдгийг их л нандигнан Өгөдэйд өгчээ.

-Атга. Хүнд бүү үзүүл. Улайдсан мэт халуун тэр чулуу Чингис хааны гараас шилжингүүтээ өнгө нь бүдгэрч байхыг Өгөдэй ажиж амжив. Гарын алга нь аймшигтайгаар түлэгдэн хорсохыг Өгөдэй тэвчжээ.

-Хаан эцэг минь би бүгдийг таны айлдсанаар гүйцэлдүүлье.

-Одоо чи миний морийг авчруул.

-Хаан эцэг минь

Та ийм байж яаж морь унана. Тэргэнд явбал амар бус уу.

-Хөвүүн чи миний хэлснийг хийгтүн. Сүүлчийн хүслийг минь сөрж бүү цааргал. -Их цэргийг зогсоож таны морийг авч ирье. -Байз хүлээ. Их цэргийг бүү зогсоо. Миний бие самуурах юу ч биш. Их цэргийг надаас болж бүү зогсоо. Их цэрэг зогсоно гэдэг Монголын их улсад үхэлтэй адил. Хөвүүн чи үүнийг хэзээ ч бүү март. Би толбот бор морьтойгоо их цэргийн манлайд явсугай. Хөвүүн чи хаан сууриндаа суу. Намайг Тэнгэрийн орон хүлээж байна. Би морьтойгоо, цэрэгтэйгээ хамт явсугай. Их цэргийг бүү зогсоо. Намайг Тэнгэрт одоход үдэх хүндэтгэлийн цуваа болог. Надаас хойш ч их цэргийг бүү зогсоо гэсэн нь Чингис хааны хүчээ шавхан хэлсэн эцсийн үг болов.

Түүний зүрх хаяа нэгхэн тасалдангуй цохилж байсан ч тэр өөрт шингэн үлдсэн Тэнгэрийн их хүчээр үхэлтэй тэмцэж байв. Чингис хаан энэ орчлонг орхин одохынхоо өмнө ийнхүү санасан бүгдээ хийж санаа нь амрав. Одоо ганцхан хүсэл л үлдэв.

Энэ бол түүний олон хоногийн турш бодсон хэрэг байлаа. Чингис хаан Жамуха шиг хүний зааснаар биш, өөрийн хүссэнээр үхэхээр хатуу шийдсэн билээ. Тэр цаг одоо ирэв. Тэр үхлээс хүчтэй гэдгээ харуулахыг туйлын ихээр хүсч байв. Бие махбоди нь аль эрт түүний ухаанд захирагдахгүй болж бүх хөдөлгөөн нь зогсжээ. Гэвч түүний ууараг тархи асар их хүч гарган ажилласаар байлаа. Гадаа морь хангинатал янцгаах нь сонсдов. Чингис хааныг түүний Их цэрэг, эрмэг хөлөг нь дуудаж байгаа нь энэ юм. Оюун ухаан нь эцсийн хүчээ дайчлан өөрийн биенд хуримтлагдан байсан Тэнгэрийн их хүчийг нэгмөр шавхан гаргажээ. Чингис хааны биенээс ялгаран гарсан энэ их хүчинд хуй салхи хормын дотор дэгдэн өргөөний дээвэр туургыг хийсгэн одох мэт болов.

Одоо түүний нүдний нь өмнө бүх зүйл ил тод харагдана. Холгүй их цэрэг хөврөн урагшлах нь үзэгдэв. Чингис хаан огт эрүүл хүн шиг цэгц шулуун алхан очоод мориндоо мордов. Өгөдэйн зарлигаар хэн ч түүнд ойртсонгүй. Чингис хаан одоо юу ч олж харахгүй болжээ. Түүнд ганцхан нүд сохлом цагаан гэрэл үзэгджээ.

” Би хүслээрээ үхэв.Үхэл цагаан өнгөтэй байдаг аж” гэж бодсон нь түүний эцсийн бодол байв.

Олон агт, түм түмэн цэргийн жагсаалын манлайд явж сурсан толбот бор морь нь харахын зуургүй цахилан давхиж цэргийн цувааны түрүүнд гармагцаа тайвширч их цэргийн цувааг манлайлан товор товор алхлав. Яг энэ үес Чингис хааны сүнс биеэс салж Тэнгэрт хөөрчээ. Цэргийн цувааны эхэнд явж байсан Тулуйн хөвүүн Хубилай гэнэт жагсаалын эхнээс бөөн гал тэнгэрт хөөрөхийг хараад

-Хараач. Тэр галыг. Тэнгэрт гал хөөрч байна гэж цангинуулан хашгирчээ. Гэвч энэ гал

түүнээс бусад хүмүүсийн нүдэнд харагдаагүйд урамгүй болов. Өнөө гал ч төдөлгүй үзэгдэхээ больжээ. Чингис хааны сүнс биенээс тасран ийнхүү Тэнгэрийн орныг зорин одсон билээ. Тэр сүнс дахин газарт эргэж буухгүйгээр одсон бөгөөд сая өндрөөс харахад энэ газар хавтгай биш бөөрөнхий, бас хүрд мэт эргэлдэж байхыг олж үзээд их гайхжээ.

Чингис хааны сүнс Тэнгэрт үүрд одсоноор олон монголчууд Мөнх Тэнгэрт тэтгэгдэх ариун хутагийг газрын дээр эгнэгт олжээ... хэмээн хичээнгүйлэн бичээд олон хоног цомцойн суусаар ядарч, гар, нүд нь ихэд чилсэн өвгөн буурал бичээч тэрбээр хөшсөн биеэ хөдөлгөн суниажээ.

Гэвч ингэснээр түүний олон жилийн хүчир хөдөлмөр дуусаагүй тул дэнгээ сэргээж дахин нэг шинэ хуудас цаас авч бийрээ бэхэнд нийлээд “ЧИНГИС ХААНЫ НУУЦ ТҮҮХ” гэж томоор дурайлган бичиж гарчиг болгоод бас нэгэн цаасан дээр

“Энэхүү түүхийг зөвхөн Танд зориулан бичиглэв. Та үүнийг уншин болгоогоод магтан сайшаах буюу хилэгнэн хараахаа түр тэвчин азнаж саруул мэргэн ухаандаа сайтар тунгаан бодогтун. Хүмүүний амьдралын чанад нууцыг хэн ч үл мэднэ. Гагцхүү Мөнх Тэнгэрийн эрхшээлд орших тул Та ухаан сэтгэлийнхээ хязгааргүй орчлонг оюуны зулаар гэгээрүүлэн байж тэрхүү чанад нууцыг няцаж цуцалгүй эрж хайгтүн.Нууцыг тайлмагц Та Мөнх Тэнгэрийн ивээлд багтах буйзаа”

гэж хэн нэгэнд зориулсан зурвас бичээд сая л санаа амран нэг насны хэргээ бүтээсэн хүний өөдрөг хангалуун сэтгэлтэйгээр нам унтжээ.

Маргааш нь олны анхаарлыг татахгүй газраар Хааны ордонд нэвтрэн орох, эсвэл Мөнх хаанд уг түүхийг өөр итгэлтэй хүнээр дамжуулан олны нүдэнд үзүүлэлгүйгээр хүргэх аргыг эрэлхийлэхээр Хархорум хотын их зээл, хааны ордныг зорьжээ.

Франц дархан Бушьегийн урласан далавчит охин тэнгэр бүрээ татаж буй дүрстэй, луун толгойт мөнгөн модны дэргэдүүр өнгөрч явтал олон торгон цэрэг дагуулсан үзэсгэлэнт хөвүүн давхин ирэхэд тэнд байсан түмэн хэлийн улс бүгд сөхрөн мөргөжээ. Шүд нь гэрэлтэж, нүд нь гялалзсан тэгш өндөр биетэй хар арьстан цэргүүд хөвүүнийг дагалдсан нь өвгөн бичээчийг алмайруулжээ. Учир нь тэр гэртээ шигдэн суусаар хэдэн жил тойрсон тул Хархорум хотод энэ мэт шинэ зүйл бий болсныг мэдсэнгүй байжээ. Энэ бол Мөнх хааны бага хөвүүн Сэрихин ажгуу.

Хан хөвүүн Хархорум хотын их зээлийг чиглэн оджээ. Мөнх хааны бага хөвүүн, сэргэлэн цовоо Сэрихинийг эрээн мяраан бараа таваар сонирхон, хамгаалагч торгон цэргүүдээс сатааран холдсон үеэр нь сэм дуудаж уулзаад түүнд нэгэн алтан зоос үзүүлж

-Үүнийг би Мөнх хаанд заавал өгөх учиртай юм. Сайн хөвүүн чи Хаан эцэгтээ осолдолгүй хүргэж өг. Харин энэ зоосыг чи өөрөө шанд нь аваарай хэмээн бас нэг мөнгөн зоос өгөөд “Энэ баринтигтай судрыг хэнд ч мэдэгдэж үзэгдэлгүй хаан эцэгтээ аваачиж өгөөрэй. Хөвүүн чи үзтэл сэргэлэн, нүдэндээ галтай, нүүрэндээ цогтой, баатар хүн болох эр байна. Чи үүнийг эцэгтээ хүргэж өгөөд хэнд ч хэлэлгүй эргэж ирэгтүн. Ирэхээр чинь би чамд үүнийг өгнө” хэмээн нэгэн гялалзсан гоё алтан шагай үзүүлжээ.

“Баатар эр болно” хэмээн зөгнөж хэлсэн тэрхүү нүдэнд дулаахан өвгөний үгэнд урамшин баясч алтан шагай шанд нь авахыг бодсон балчир хөвүүн Сэрихин тэрхүү алтан зоос хийгээд баринтигтай судрыг тансаг бөгөөд элбэг хувцсандаа сайтар нуугаад -Та надад итгэж болно. Би баатар хүний ёсоор осолдолгүй эргэж ирнэ. Үүнийг би хаан эцэгтээ дор нь хүргээд өгчихнө хэмээн цовоо дуугаар итгэлтэй хэлээд хэвлүүхэн нь аргагүй ордон руугаа давхижээ. Хар арьст цэргүүд ч дагалджээ.

Харин өнгөрсөн хойно өвгөн бичээч осолтой зүйл хийснээ гэнэт ухаарч өөрийгөө зэмлээд барсангүй. “Өөрийн биеэр хүргэж өгвөл чанд нууцыг нэгд нэгэнгүй мэдэхийн учир амь насанд осол болох вий гэсэндээ балчир нялх хөвүүнд их нууцыг даатган өгч хар толгойдоо уучлашгүй ял хураав, би. Тэртэй тэргүй хөгшин хонины насгүй болсон би юундаа ингэтэл хоргодоо вэ. Ээ халаг хохой минь” хэмээн гэмшин гасласаар суув.

Сэрихин хөвүүн эргэж ирэхгүйд өвгөн бичээчийн тэвчээр барагдан бүхий энэ үес түүний итгэж илгээсэн балчир элч аль хэдийн хаан эцгийнхээ гарт мөнөөх алтан зоос, баринтигтай судар, болон жич зурвас сэлтийг хүний нүд хариулан байж оруулж өгөөд сайшаал магтаал сонсохын зэрэгцээ бяцхан байцаагдаж зогсов. Сэрихиний авчирсан тэрхүү алтан зоосны нэг талд “Аугаа их эзэн хаан Чингис” хэмээн араб үсгээр бичсэн байх ажээ. Харин Сэрихинд өгсөн мөнгөн зоосон дээр нь “Эрхэм дээд эзэн Чингис хаан” гэсэн үг дурайн байсныг хэн ч мэдсэнгүй өнгөрсөн билээ.

“ Энэхүү түүхийг зөвхөн Танд зориулан бичиглэв…” хэмээн эхлэсэн зурвасыг уншиж суусан Мөнх хаан хөвүүн рүүгээ гайхаж сонжсон байдлаар хараад

-Энэ зоос, зурвас, баринтигтай судрыг чамд хэн, хаана өгөв хэмээн асуужээ.

- Нэг өвгөн их зээл дээр явахад намайг сэмхэн дуудаж өгөөд хэнд ч үзүүлэлгүй нууж Хаан эцэгтээ осолдолгүй хүргээрэй гэсэн юм. Алтан зоос өгөхдөө тэр танд өртэй л гэсэн шүү дээ. Бас намайг баатар хүн болно гэсэн ..

-Тийм ээ.Тэр надад өртэй байж магадгүй юм. Тэр одоо хаа байна.

-Мэдэхгүй ээ. Надад үүнийг өгчихөөд л яваад өгсөндөг хэмээн Сэрихин хөвүүн анх удаа Хаан эцэгтээ худлаа залж орхиод сандарсандаа нүүр нь улайхыг ажсан Мөнх хаан

-За яахав. Харин энэ явдал чи бид хоёрын нууц болж үлдэг. Хэнд ч бүү хэлээрэй. Ээж, ах нартаа ч гэсэн…

Чи одоо ордноос хамаагүй бүү гарч яв хэмээжээ.

“Нууцыг нь хадгална, удахгүй эргээд ирнэ” гэж өнөөх өвгөнд амалчихсан Сэрихин хөвүүн “За” хэмээн доройхон дуугарчээ. Үүнээс хойш хэд хоногийн дараа нэр үл мэдэх тэрхүү хичээнгүй даруу бичээчийн ирүүлсэн дээрх “Чингис хааны нууц түүх-“ийг энэ үес Их Монгол улсын хаан суурин залран байсан Мөнх хаан шөнөжин сууж, бие лагшин хийгээд саруул мэлмийгээ чилээн байж ихэд шимтэн уншиж дуусаад босч бие тэнийлгэн “Түмэн амгалант” ордныхоо цонхоор харвал Хархорум хотод аль хэдийнээ өглөөний нар мандан

гийгээд баруун этгээдэд байх их хатдын ордны алтан ганжирт дээвэр нүд гялбааж бас харийн иргэдийн суудаг тансаг хүрээний зүгээс загалмайт сүмийн хонхон дуу дүнгэнэх, лалын мөргөлтнийг залбиралд дуудан уянгалах тод содон дуу, худалдаачдын эд бараагаа магтаж ам өрсөлдөн хашгирах далан хэлийн шаагиан шуугиантай холилдон сонсдох авай.

Төдөлгүй ордны шадар сайд орж ирээд харийн элч, худалдаачид зэрэг хүмүүс их хаанд бараалхах цагийг хүлээн чилж байгааг сануулахад Мөнх хаан

-Тэд жаахан хүлээг. Их хаанд бараалхах гэдэг санасан зоргоор болдоггүйг ухаарна биз хэмээхдээ Хархорум нийслэл рүү нь харийнхан өөрсдөө тал талаасаа цувж байх цагийг урьдчилан харж асан их Чингис хааны зөн совин, ухаан билгийг биширч түүний гэрээсийг чанд биелүүлэх цаг өөрт нь ирснийг сүслэн бодож зогслоо. Мөнх хаан ордны хишигтнээс хамгийн итгэлтэй хоёр хүнийг сонгож ирүүлэхийг тушаажээ. Удалгүй хамгийн нууц үйлд голдуу зарагддаг найдвартай хоёр цэрэг ирсэнд Мөнх хаан хөвүүн Сэрихинийг эвтэйхэн шалгааж байгаад хэлүүлсэн өнөөх өвгөний төрх байдал, царай зүсийг дурдан хэлж хаана суудаг, хэн болохыг олж тогтоохыг чандлан тушаагаад үүнийгээ хэнд ч мэдэгдэхгүй байхыг хатуу сануулжээ. Мөнх хаан баринтигтай судрыг уншиж дууссан даруйдаа мөнөөх бичээчийг олж шан хишиг харамгүй хүртээх, нөгөөтэйгүүр Чингис хааны алтан ургаас хаан ор суусан хүн л ганцаар нягтлан унших учиртай тэр нууц түүхийн нарийн ширийнийг чандлан хадгалах учрыг бодолцон хэрхэхийг шийдэхээр хамгийн итгэлтэй хүнээ илгээн ийнхүү эрэл хайгуул болсонд өнөөх үл танигдах өвгөн бичээч нэн зожиг ганцаар хүн байсан агаад харийнхны хүрээнд амьдардаг байсан нь тодорхой болж хэн ч түүний тухай мэдэхгүй байжээ. Гагцхүү мөнөөх өвгөнийг “Үхээд гурав хоножээ” гэсэн баттай боловч бүтэлгүй хэл мэдээг хоёр хишигтэн нь Мөнх хаанд дуулгасан тул тэрээр эрлээ мухарлан санаа амраад бүрлээчийг Орхон мөрний уужим хөндийд хүндтэй нутаглуулж дээр нь ямар ч бичиг тэмдэггүй чулуун хөшөө босгохоор зарлигласныг ёсоор болгосон билээ

”Чингис хааны нууц түүх” нэртэй уг бичмэлд өгүүлснийг уншихад үүнийг бичиглэсэн тэр өвгөн бичээч Чингис хаантай ихэд дотно ойр явсан нэгэн болох нь илт байв. Гэвч Мөнх хаан хичнээн ч тунгаан бодоод тэр бичээчийн хэн болохыг таасангүй.

Бас тэрээр Хархорум хотын харийн иргэд оршин суудаг тансаг хүрээнд даяанч мэт гав ганцаар суудаг байсан хийгээд их эзэн Чингис хааны амьд сэрүүн ахуйд цутгасан араб бичигтэй алтан зоосыг Мөнх хаанд өгүүлсний нарийн учрыг ч тайлах арга байсангүй.

Ийнхүү нэгэнт Тэнгэрийн оронд одсон тэрхүү бичээчийн хэн болохыг мэдэх хүн огт гарсангүй.

Тэрээр ганц биеэр амар тайван амьдардаг, Хар хорумыг байгуулахаас эхлээд л энд суурин суусан хүмүүн байжээ гэхээс өөрийг олж мэдэж чадсангүй өнгөрөв.”Чингис хааны нууц түүх”-ийн бүх нууцыг үл таних тэр бичээч ийнхүү өөртөйгөө хамт энэ хорвоогоос авч оджээ. Ийнхүү үл таних бичээчийн илгээсэн товчхон зурваст өгүүлснээр Мөнх хаанд ганцхан өөрийнхөө ухаан сэтгэл хийгээд Мөнх Тэнгэрийн эрхшээлд итгэх л үлджээ.

Мөнх хаан тэр даруйдаа ордны шадар нэгэн бичээчийг дуудан ирүүлж өөрөө хажуугаас нь огт холдолгүй сахин байж уг нууц түүхийг нягт нямбай сийрүүлэн бичүүлж дуусгаад түүний ар

гэр, эхнэр хүүхдэд нь элбэг дэлбэг бэлэг сэлт, алт мөнгийг хангалттай хүргүүлээд мөнөөх бичээийг хол газар хугацаагүй нууц албанд явсан хэмээн хэлүүлснээс хойш түүнийг үзсэн харсан хүн нэгээхэн ч үгүй бүлгээ.

Харин түүний нямбайлан сийрүүлсэн “ Чингис хааны нууц түүх”-ийг “Алтан ургийн бичээс”тэй хамт тусгайлан хадгалж зөвхөн Их Монгол улсын хаан суурind залрагсад л нээн уншиж болохыг Мөнх хаан хатуу чанд зарлиг болгосон нь Чингис хааны тавьдугаар он буюу христийн тооллын нэг мянга хоёр зуун тавин зургаан он байв.

Энэ үед Хархорум хот “Чингис хааны нууц түүх”-д дурдсанчлан бурхны, загалмайн, лалын шашинтны цорын ганц нэгдсэн мөргөлийн газар, албан харилцаа, арилжаа худалдааны нэгэн чухал зангилаа гэгдэж Чингис хааны захиж гэрээслэн үлдээснээр ертөнцийн төв болоод байлаа. Энэхүү нэгдсэн нэг ертөнц бол Чингис хааны туйлын хүслэн байв.

Өөрийнх нь хүслийг түүний үр удам алгасран цалгардуулалгүй биелүүлж нэр алдрыг нь дуурсган яваг Чингис хааны сүнс Дээд Тэнгэрээс бахдан харж байгааг Мөнх хаан зөнгөөрөө мэдэж байв.

ТӨГСӨВ.